



МОНГОЛ УЛСЫН
ШҮҮХИЙН ЁС ЗҮЙН ХОРОО

**МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН
ШҮҮГЧИЙН САХИЛГЫН ХЭРГИЙГ ХЯНАН
ШИЙДВЭРЛЭСЭН ШИЙДВЭРИЙН ЭМХЭТГЭЛ**

**Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал,
Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал,
Улсын Дээд шүүхийн тогтоол
2017-2019 он**

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



Global Affairs Affaires mondiales
Canada Canada



The Asia Foundation

Канадын гадаад хэргийн яамны дэмжлэгтэйгээр “Азийн сан”-аас хэрэгжүүлж буй “Ардчилсан оролцоотойгоор төрийн албанд сайн засаглал, ил тод байдлыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд энэхүү “Монгол улсын шүүхийн Шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэсэн шийдвэрийн эмхэтгэл”-ийг хэвлэн гаргав.



МОНГОЛ УЛСЫН
ШҮҮХИЙН ЁС ЗҮЙН ХОРОО

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН
ШҮҮГЧИЙН САХИЛГЫН ХЭРГИЙГ ХЯНАН
ШИЙДВЭРЛЭСЭН ШИЙДВЭРИЙН ЭМХЭТГЭЛ

Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал,
Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал,
Улсын Дээд шүүхийн тогтоол
2017-2019 он

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

Хянасан: Шүүхийн Ёс зүйн хорооны
Ажлын албаны дарга Н.Ганбаатар

Хэвлэлд бэлтгэсэн: Референт А.Энхбаатар
Шинжээч Ч.Ханддулам
Референт А.Баасанжав
Референт Ж.Халиун
Референт Б.Энхбаатар

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Цаасны хэмжээ: А4
Хэвлэлийн хуудас: 55
Хэвлэсэн тоо: 600

“УРАНГАР ПРЕСС” ХХК-д хэвлэв.

ГАРЧИГ

	Дугаар	Огноо	Хуудас
ӨМНӨТГӨЛ			7
1.Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал	05	2017.01.13	8
2.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал	221/ЁМ2017/0006	2017.04.06	12
3.Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол	254	2017.06.28	18
4.Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал	25	2017.02.17	22
5.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадал	221/ЁМ2017/0010	2017.05.10	27
6.Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал	27	2017.03.30	32
7.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал	221/ЁМ2017/0013	2017.06.08	43
8.Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал	28	2017.03.30	47
9.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал	221/ЁМ2017/0011	2017.05.18	55
10.Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол	305	2017.09.20	60
11.Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал	45	2017.06.09	64
12.Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал	47	2017.07.05	81
13.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал	221/ЁМ2017/0001	2017.09.26	89
14.Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол	517	2017.12.12	94
15.Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал	49	2017.07.05	99

16.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал	221/ЁМ2017/0018	2017.10.04	106
17.Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол	503	2017.12.04	109
18.Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал	52	2017.07.05	113
19.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал	221/ЁМ2017/0021	2017.11.02	122
20.Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол	14	2018.01.10	127
21.Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал	61	2017.10.27	132
22.Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал	64	2017.11.17	150
23.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал	221/ЁМ2018/0004	2018.02.13	163
24.Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол	188	2018.04.23	167
25.Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал	78	2018.10.29	172
26.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал	221/ЁМ2018/0028	2018.12.20	185
27.Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол	38	2019.02.13	190
28.Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал	54	2018.09.21	195
29.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал	221/ЁМ2019/0007	2019.02.01	204
30.Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол	110	2019.04.15	207
31.Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал	75	2018.10.19	210
32.Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал	13	2018.03.02	214

33.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал	221/ЁМ2018/0011	2018.05.02	223
34.Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол	298	2018.06.27	228
35.Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал	79	2018.10.19	231
36.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал	221/ЁМ2018/0027	2018.12.05	237
37.Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол	33	2019.02.13	241
38.Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал	77	2018.10.19	247
39.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал	221/ЁМ2019/0004	2019.01.10	251
40.Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал	23	2018.03.30	255
41.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал	221/ЁМ2018/0019	2018.07.04	270
42.Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал	73	2018.10.19	277
43.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал	221/ЁМ2018/0001	2018.12.26	292
44.Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал	24	2018.03.30	299
45.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал	221/ЁМ2018/0017	2018.06.21	304
46.Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал	87	2018.11.16	310
47.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал	221/ЁМ2019/0003	2019.01.10	315
48.Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал	43	2018.06.13	321
49.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал	221/ЁМ2018/0025	2018.08.22	334



50.Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол	453	2018.11.14	342
51.Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал	19	2018.03.16	347
52.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал	221/ЁМ2018/0012	2018.05.02	352
53.Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал	47	2018.06.26	355
54.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал	221/ЁМ2018/0026	2018.08.23	361
55.Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал	16	2018.03.02	365
56.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал	221/ЁМ2018/0015	2018.05.16	372
57.Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал	90	2018.11.16	375
58.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал	221/ЁМ2019/0010	2019.02.21	381
59.Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал	01	2018.01.26	384
60.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал	221/ЁМ2018/0006	2018.04.05	395
61.Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал	30	2018.04.13	404
62.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал	221/ЁМ2018/0392	2018.07.05	411
63.Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал	74	2018.10.19	419
64.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал	221/ЁМ2019/0009	2019.02.20	426
65.Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол	137	2019.05.06	431

ӨМНӨТГӨЛ

Шүүгч Ёс зүйн зөрчил гаргасан гэж иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдээс 2017, 2018 он, 2019 оны эхний хагас жилд гаргасан гомдлыг шалгаж, шийдвэрлэсэн Шүүхийн Ёс зүйн хорооны сахилгын шийтгэл ногдуулсан магадлал, мөн тус магадлалд давж заалдах журмаар гаргасан гомдлыг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх, Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим хянасан шийдвэрүүдийг нийтийн хүртэл болгож эмхэтгэн хоёр дахь ботийг Танд толилуулж байна.

Шүүхийн Ёс зүйн хороо 2017, 2018 он, 2019 оны эхний хагас жилд буюу нэг жилд дунджаар давхардсан тоогоор 360 гаруй шүүгчид холбогдох 240 орчим гомдлыг хүлээн авч хянан шалгах ажиллагаа явуулж тэдгээрийн 150 гаруй гомдолд буюу 62.5 хувьд сахилгын хэрэг үүсгэхээс татгалзаж 70 гомдолд буюу 27.75 хувьд сахилгын хэрэг үүсгэн шалгаж түүний 68.46 хувь буюу 73 шүүгчид сахилгын шийтгэл ногдуулжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалыг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд давж заалдах, Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд хяналтын журмаар гаргасан гомдлыг шийдвэрлэсний дараа Шүүхийн Ёс зүйн хорооны хүчин төгөлдөр шийдвэрээр нийт гомдлын 5.41 хувь, сахилгын хэрэг үүсгэсэн тогтоолын 13.33 хувь, сахилгын шийтгэл ногдуулсан магадлалын 21.05 хувь буюу 14 шүүгч сахилгын шийтгэл бодитоор хүлээжээ.

Энэхүү эмхэтгэл нь шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, шүүгчийн ёс суртахууныг дээшлүүлэх, ёс зүй, түүнтэй холбоотой шийдвэрийг судалгааны эргэлтэд оруулах, олон нийтийн хяналтыг тогтоох, шүүхийн практик судлалд хувь нэмэр оруулах зорилготой болно.

Эмхэтгэлд багтсан шийдвэрүүд нь шүүгчийн Ёс зүйн сургалтад кейс болгон ашиглах, шүүгчийн ёс зүй, хариуцлагатай холбоотой хууль тогтоомжийг боловсронгуй болгох, шүүхийн үйл ажиллагааг олон нийт хянах, улмаар шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой гэдэгт итгэж байна.

Бидний санаачилгыг дэмжин хамтран ажилласан Азийн сангийн болон Ёс зүйн хорооны ажлын албаны ажилтнуудад талархсанаа илэрхийлье.

ШҮҮХИЙН ЁС ЗҮЙН
ХОРООНЫ ДАРГА

Н.ЭРДЭНЭЦОГТ



МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЁС ЗҮЙН ХОРООНЫ МАГАДЛАЛ

2017 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Ш аймаг дахь Сум дундын Иргэний
хэргийн анхан шатны шүүхийн шүүгч
Б.М-д сахилгын шийтгэл ногдуулах тухай

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааныг тус хорооны дарга Н.Эрдэнэцогт даргалж, гишүүн Б.Уранцэцэг, О.Мөнхсайхан, Ч.Оюунцэцэг, В.Жавхлан, Д.Сүнжид, А.Доржготов нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны тэмдэглэл хөтлөгчөөр шинжээч А.Энхбаатар, референт Ж.Халиун, гомдол гаргагч М.Х, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч Ц.Д нарыг /онлайнаар/ оролцуулан Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдааны танхимд хийв. Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 185 дугаар тогтоолыг Шүүхийн Ёс зүйн хорооны гишүүн А.Доржготовын илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Иргэн М.Х, Ц.Д нар Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан гомдолдоо: "Ш аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016.05.30-ны өдрийн 00261 дугаартай шийдвэрийг эс зөвшөөрч давж заалдах гомдол гаргасан. Гэтэл уг гомдлыг хуульд байхгүй заалтаар шүүгч Б.М нь 2016.06.14-ний өдрийн 01337 дугаар захирамжаар хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн. Мөн тус захирамжид гомдол гаргах эрхгүй болохыг дурдаж шийдвэрлэсэн. Шүүгч Б.М нь иргэн миний Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан эрхийг зөрчиж байна. Мөн хуулийн 49.1-д "Шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдана" гэснийг зөрчсөн. Ш аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх нэхэмжлэгч М.Х-гийн нэхэмжлэлийг шийдвэрлэхдээ хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн. Иймд шүүгч Б.М-д сахилгын хэрэг үүсгэн шалгуулахаар гомдол гаргаж байна" гэжээ.

Шүүгч Б.М Шүүхийн Ёс зүйн хороонд ирүүлсэн тайлбартаа: "...Тус хэргийг товлосон хугацаанд шүүгч Ц.О даргалж, шүүгч Д.К, Б.М нарын бүрэлдэхүүнтэйгээр шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж шүүхээс 2016.05.30-ны өдрийн 00261 дугаар шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, үлдсэнийг нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Уг шийдвэрийг эс зөвшөөрч гаргасан гомдол дээрээ нэхэмжлэгч нь тус шүүхээр хянан шийдвэрлэгдсэн хэргийн 2014.11.12-ны өдрийн 73 дугаар эвлэрүүлэн зуучлалын дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээг баталгаажуулах тухай шүүгчийн захирамжаар баталгаажсан 6.088.000 төгрөг, бусад зардал 198.000 төгрөг, нийт 6.286.000 төгрөгийг хэрэгсэхгүй болгосон шийдвэрийн хэсэгт давж заалдах гомдол гаргасан байсан. Ингээд 2016.06.14-ний өдрийн 01337 дугаар шүүгчийн захирамжаар "...Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх нь шүүгчийн захирамжийг санаатайгаар биелүүлээгүй гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн ба шүүгчийн захирамжаар баталгаажсан 6.286.000 төгрөгтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлээгүй болно. Иймд нэхэмжлэгч М.Х-гийн шүүхэд гаргасан гомдлын шаардлага нь тус эрүүгийн хэрэгт хамааралгүй, Улсын

тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасан улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөх үндэслэлд хамаарахгүй байх тул нэхэмжлэгч М.Х-гийн давж заалдах шатны шүүхэд гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзах үндэстэй байна." гэж үзэж нэхэмжлэгч, түүний өмгөөлөгч нарын давж заалдах журмаар гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзсан. Тэгээд нэхэмжлэгч, түүний өмгөөлөгч нарт захирамжийг гардуулсан бөгөөд тэд чимээгүй гараад явцгаасан. Ингээд би тэд нарыг учрыг нь ойлгосон гэж бодсон. Гэтэл Шүүхийн Ёс зүйн хороонд гомдол гомдол гаргасан байна. Ямар ч үндэслэлгүйгээр ийм зүйл бичиж, гүтгэн шүүгчийн нэр хүндэд халдаж байгааг ойлгохгүй байна. Миний бие аливаа хэрэг маргааныг хуульд нийцүүлэн шийдвэрлэж шүүгчийн ёс зүйн хэм, хэмжээ шударга ёсыг чанд сахиж ажиллаж байгаа бөгөөд цаашид ч сахин ажилласаар байх болно." гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 185 дугаар тогтоолоор шүүгч Б.М-д сахилгын хэрэг үүсгэж шийдвэрлэжээ.

Шүүгч Б.М нийт гишүүдийн хуралдаанд гаргасан гомдолдоо: "...Шүүхээс шийдвэрийг нэхэмжлэгч М.Х, түүний өмгөөлөгч Ц.Д нарт 2016.06.03-ны өдөр гардуулсан бөгөөд нэхэмжлэгч М.Х нь 2016.06.07-ны өдөр шийдвэрийг эс зөвшөөрч давж заалдах журмаар гомдол гаргасан. Нэхэмжлэгч нь анхан шатны шүүхийн шийдвэрийн "Эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээг баталгаажуулсан 6.088.000 төгрөг гаргуулах" тухай шаардлагыг хэрэгсэхгүй болгосон хэсэгт давж заалдах гомдол гаргасан байсан. Гомдол гаргагч нь ИХШХШТХ-ийн 57 дугаар зүйлийн 57.4-т зааснаар анхан шатны шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа хэмжээгээр буюу 6.286.000 төгрөгт ногдох улсын тэмдэгтийн хураамжийг урьдчилан төлөөгүй учир миний бие 2016.06.14-ний өдрийн 01337 дугаартай шүүгчийн захирамжаар нэхэмжлэгч М.Х-гийн давж заалдах журмаар гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзсан. Өөрөөр хэлбэл М.Х-гийн давж заалдах гомдол нь ИХШХШТХ-ийн 162 дугаар зүйлд заасан шаардлага хангаагүй байсан тул энэхүү шаардлагыг хангуулахаар хуульд заасны дагуу хуулийн шаардлага хангуулах үүднээс давж заалдах журмаар гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзсан. Гомдол нь шаардлага хангаагүй бол ИХШХШТХ-ийн 164 дүгээр зүйлийн 164.3-т зааснаар гомдлыг хүлээн авахаас татгалзах тухай шүүгчийн захирамж гаргаж тус захирамжид гомдол гаргах журмыг хэрхэн зөрчсөн, түүнийг хэрхэн арилгах талаар заадаг." гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдаанаар гомдлыг хэлэлцээд ҮНДЭСЛЭХ нь: Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 185 дугаар тогтоолоор Ш аймаг дахь сум дундын иргэний хэргийн шүүгч Б.М-д сахилгын хэрэг үүсгэсэн байна. Шүүхийн Ёс зүйн хорооны тогтоолд "шүүгч Б.М нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 164 дүгээр зүйлийн 164.3 дах хэсэгт "Давж заалдах гомдол гаргахад энэ хуульд заасан журмыг баримтлаагүй бол шүүх гомдлыг хүлээн авахгүй бөгөөд энэ тухай шүүгч захирамж гаргана" гэж заасныг зөрчсөн үндэслэл тогтоогдоогүй байхад огт өөр хуулийн заалтыг удирдлага болгон давж заалдах гомдлыг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэснийг илт хууль зөрчсөн гэж дүгнэхээр байна. "Шүүгч Б.М нь дээрх хэргийг өөрийн биеэр илтгэн, шүүх хуралдаанаар хянан шийдвэрлүүлсэн мөртөө иргэний хэргийн зохигчдын гаргасан давж заалдах гомдлыг өөрөө оролцохгүйгээр, бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэх ёстой байтал өөрөө дангаараа хянаж 2016 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 153/Ш32016/1337 дугаар захирамж гаргасан нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 171 дүгээр зүйлийн 171.1 дэх хэсэгт "Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт энэ хуулийн 170.1-д заасны дагуу гаргасан гомдлыг 14 хоногийн дотор тухайн хэргийг хянан шийдвэрлэж байгаа шүүгчийг оролцуулахгүйгээр 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр

дараах байдлаар хянан шийдвэрлэж тогтоол гаргана.” гэж заасныг ноцтой зөрчсөн байна.

Шүүгч Б.М-г “Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгч хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, хууль дээдлэх, үнэнч шударга байх, аливаа асуудалд бодитой хандах, хараат бус байх, ... зэрэг зарчмуудыг хувийн зан чанар болгож төлөвшүүлнэ”, мөн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд нь хяналт тавих үүрэгтэй.” гэж заасныг тус тус зөрчсөн гэж үзжээ.

Шүүгч Б.М эдгээр үндэслэлийг үл хүлээн зөвшөөрч, “...Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1-д заасан журмаар гаргасан гомдол, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 161 дүгээр зүйлийн 161.1 дэх хэсэгт заасан журмаар гаргасан гомдол хоёр өөр ойлголт, Шүүхийн Ёс зүйн хороо нь давж заалдах шатны журмаар гаргасан гомдлын бүрдэл хангагдаагүй тохиолдолд ямар хуулийн ямар заалтаар шүүх бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэдэг гэж дүгнэсэн нь ойлгомжгүй байх тул Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 185 дугаартай тогтоолыг хүчингүй болгож өгнө үү” гэжээ.

Сахилгын хэрэгт авагдсан баримтаар дараах байдал тогтоогдсон байна. Үүнд:

Шүүгч Б.М иргэн М.Х-гийн К.Д-д холбогдуулан гаргасан нэхэмжлэлийг 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 2553 дугаар захирамжаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж байжээ. Захирамжийн үндэслэлд “М.Х-гийн шүүхэд гаргасан нэхэмжлэлд дурдсан үйл баримтын талаар хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр байх тул” нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэлтэй гэж үзжээ.

М.Х, түүний өмгөөлөгч Ц.Д нарын гомдлоор захирамжийг хянан хэлэлцээд Ш аймгийн Ф сум дахь Сум дундын шүүхийн 2016 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор Ш аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 1553 дугаартай шүүгчийн захирамжийг хүчингүй болгожээ. Энэхүү тогтоолд “нэхэмжлэгч М.Х эрүүгийн хэргийн улмаас учирсан хохирлоо шүүхэд нэхэмжлэл гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Өөрөөр хэлбэл нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг шүүхээр шийдвэрлүүлэх үндэслэлтэй байхад нэхэмжлэлийг бүхэлд нь хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн нь үндэслэлгүй” гэжээ.

М.Х-ийн нэхэмжлэлтэй хэргийг шүүхэд хянан хэлэлцэж Ш аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 5 дугаар сарын 30-ны өдөр дугаар 153/ШШ2016/00261 шийдвэр гарч Иргэний хуулийн 232 дугаар зүйлийн 232.6, 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1 дэх хэсэгт заасныг баримтлан хариуцагч К.Д-аас 3,444,000 төгрөг гаргуулан нэхэмжлэгч М.Х-д олгож, нэхэмжлэлийн шаардлагаас 6,286,000 төгрөгт холбогдох хэсгийг хэрэгсэхгүй болгожээ. Шүүхийн шийдвэрт М.Х-ыг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.7-д зааснаар улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдсөн болохыг заан дурджээ. Шүүх бүрэлдэхүүнд шүүгч Ц.О, Д.К,Б.М нар оролцож хэргийг шийдвэрлэжээ.

Шүүхийн дээрх шийдвэрт М.Х давж заалдах гомдол гаргасан байх бөгөөд шүүгч Б.М “Давж заалдах журмаар гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзах тухай” 2016 оны 6 дугаар сарын 14-ний өдөр 153/Ш32016/01337 дугаар шүүгчийн захирамж гаргахдаа “М.Х-гийн шүүхэд гаргасан гомдлын шаардлага нь тус эрүүгийн хэрэгт хамааралгүй, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасан улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөх үндэслэлд хамаарахгүй тул М.Х-гийн давж заалдах шатны шүүхэд гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзах үндэслэлтэй” гэжээ.

Гэтэл тэрээр шүүх бүрэлдэхүүнд оролцож гаргасан шүүхийн шийдвэрт, мөн “Иргэний хэрэг үүсгэх тухай” түүний өөрөө гаргасан 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 153/ШЗ2016/00366 дугаар захирамжид тус тус “Нэхэмжлэгч улсын тэмдэгтийн хураамж төлөхөөс чөлөөлөгдсөн болохыг” дурдан заасан байх бөгөөд, харин давж заалдах гомдлыг энэ үндэслэлээр хүлээн авахаас татгалзсан, улмаар зохигчид шүүгчийн захирамжид гомдол гаргах эрхгүйгээр шийдвэрлэж хэргийг давж заалдах шатаар хэлэлцүүлэх боломжгүй болгожээ.

Шүүгч Б.М-ийн эдгээр үйлдэл нь Монгол Улсын үндсэн хуулиар баталгаажсан иргэний үндсэн эрх, эрх чөлөө, түүний дотор хэрэг маргаанаа шударгаар шүүлгэх, шүүхийн шийдвэрийг давж заалдах гомдол гаргах эрхийг ноцтой зөрчсөн байна.

Шүүгч Б.М-д сахилгын хэрэг үүсгэх тухай Шүүхийн Ёс зүйн хорооны тогтоолд ёс зүйн зөрчлийн талаар оновчтой тодорхойлоогүй, дэлгэрэнгүй бус бичсэн нь уг тогтоолыг хүчингүй болгох тухай гомдолд бичсэн хүсэлтийг хүлээн авч хангах үндэслэл болохгүй, харин шүүгч Б.М-г “Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгч хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, хууль дээдлэх, үнэнч шударга байх, аливаа асуудалд бодитой хандах, хараат бус байх, ... зэрэг зарчмуудыг хувийн зан чанар болгож төлөвшүүлнэ”, мөн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд нь хяналт тавих үүрэгтэй” гэж заасныг тус тус зөрчсөн гэж үзсэн үндэслэл бүхий болжээ. Иймээс Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5.7.1-д зааснаар түүнд сахилгын шийтгэл ногдуулах нь зүйтэй гэж үзэв.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35, 36 дугаар зүйл, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйл, Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.1, 5.13-т заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Ш аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М-д сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Энэ магадлалын хувийг шүүгч болон гомдол гаргагчид хүргүүлэхийг Шүүхийн Ёс зүйн хорооны Ажлын албанд даалгасугай.

3.Шүүгч, гомдол гаргагч нар магадлалыг гардан авснаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

УИХМН
СУДАЛГААНЫ САН

ДАРГАЛАГЧ

Н.ЭРДЭНЭЦОГТ

ГИШҮҮН

А.ДОРЖГОТОВ



ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ
МАГАДЛАЛ

2017 оны 4 сарын 06 өдөр

Дугаар 221/ЁМ2017/0006

Улаанбаатар хот

Ш аймаг дахь Сум дундын Иргэний
хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М-д
сахилгын шийтгэл ногдуулсан Шүүхийн Ёс зүйн
хорооны магадлалын тухай

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааныг шүүгч О.Номуулин даргалж, шүүгч Э.Халиунбаяр, шүүгч Б.Тунгалагсайхан нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн дарга Г.Отгон-Өлзий, гомдол гаргагч М.Х, гомдол гаргагчийн өмгөөлөгч Ц.Д нарыг оролцуулан хийж, Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 05 дугаар магадлалыг эс зөвшөөрч шүүгч Б.М-ийн гаргасан давж заалдах гомдлоор, М.Х, түүний өмгөөлөгч Ц.Д-ийн гомдолтой, Ш аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М-д холбогдох сахилгын хэргийг шүүгч Б Тунгалагсайханы илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 05 дугаар магадлалаар Ш аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М-д сануулах сахилгын шийтгэл ногдуулж шийдвэрлэжээ

Шүүгч Б.М гомдолдоо: "М.Х-гийн нэхэмжлэлтэй, К.Д-д холбогдох 9.532.000 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлийг 2016 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр хүлээн авч, 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр иргэний хэрэг үүсгэж, шүүх хуралдааныг 2016 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 13 цаг 30 минутад товлон хянан шийдвэрлэсэн.

Тус иргэний хэргийн нэхэмжлэлийн шаардлага нь:

а. Эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээг баталгаажуулах тухай шүүгчийн захирамжаар баталгаажуулсан 6.088.000 төгрөгийг гаргуулах,

б. Эрүүгийн хэрэгт хууль зүйн туслалцаа үзүүлсэн өмгөөлөгчийн хөлс 400,000 төгрөг гаргуулах,

в. Ш аймгийн Ф сум дахь Сум дундын шүүхэд гомдол хэлэлцэхэд очсон зардал 198,000 төгрөг гаргуулах,

г. 6,088,000 төгрөгийг хугацаанд нь төлөөгүй учир өдөрт 0,3%-иар тооцож хүү 3,044,000 төгрөгийг гаргуулах тухай юм.

Тус хэргийн нэхэмжлэлийн шаардлагын нэг нь эрүүгийн хэрэгт хууль зүйн туслалцаа үзүүлсэн өмгөөлөгчийн хөлс 400,000 төгрөг гаргуулах тухай байсан тул Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1-д зааснаар шүүх бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэсэн.

Хэргийг товлосон хугацаанд шүүх бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэж шүүхээс 2016 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 153/ШШ2016/00261 дугаартай

шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, үлдсэнийг нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Шүүхээс шийдвэрийг нэхэмжлэгч М.Х, түүний өмгөөлөгч Ц.Д нарт 2016 оны 6 дугаар сарын 03-ны өдөр гардуулсан бөгөөд нэхэмжлэгч М.Х нь 2016 оны 6 дугаар сарын 07-ны өдөр шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч, "Эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээг баталгаажуулсан 6,088,000 төгрөг гаргуулах" тухай шаардлагыг хэрэгсэхгүй болгосон хэсэгт давж заалдах гомдол гаргасан байсан.

Гомдол гаргагч нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.4-т зааснаар анхан шатны шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа хэмжээгээр буюу 6,286,000 төгрөгт ногдох улсын тэмдэгтийн хураамжийг урьдчилан төлөөгүй учир миний бие 2016 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 153/ШЗ2016/01337 дугаартай шүүгчийн захирамжаар нэхэмжлэгч М.Х-гийн давж заалдах журмаар гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзсан.

Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгч М.Х-гийн давж заалдах гомдол нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 162 дугаар зүйлд заасан шаардлага хангаагүй /улсын тэмдэгтийн хураамж төлөөгүй/ байсан тул энэхүү шаардлагыг хангуулахаар хуульд заасны дагуу гомдлыг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамж гаргасан Гэтэл:

Нэг.Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалын Үндэслэх хэсэгт "шүүгч Б.М нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 164 дүгээр зүйлийн 164.3 дахь хэсэгт заасан давж заалдах гомдол гаргахад энэ хуульд заасан журмыг баримтлаагүй бол шүүх гомдлыг хүлээн авахгүй бөгөөд энэ тухай шүүгч захирамж гаргана гэж заасныг зөрчсөн үндэслэл тогтоогдоогүй байхад огт өөр хуулийн заалтыг удирдлага болгон давж заалдах гомдлыг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэснийг илт хууль зөрчсөн гэж дүгнэхээр байна." гэжээ.

Давж заалдах журмаар гаргасан гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 163 дугаар зүйлийн 163.1-д зааснаар анхан шатны шүүхийн шүүгч хүлээн авдаг. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.4-т зааснаар анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалд гомдол гаргаж байгаа этгээд шийдвэр, магадлалыг хүлээн зөвшөөрөхгүй байгаа хэмжээгээр улсын тэмдэгтийн хураамжийг тооцон төлдөг.

Давж заалдах гомдол нь хуульд заасан шаардлагыг хангаагүй бол анхан шатны шүүхийн шүүгч Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 164 дүгээр зүйлийн 164.3-т зааснаар гомдлыг хүлээн авахаас татгалзах тухай захирамж гаргаж, тус захирамжид гомдол гаргах журмыг хэрхэн зөрчсөн, түүнийг хэрхэн арилгах талаар заадаг.

Миний бие нэхэмжлэгчийн давж заалдах гомдлыг хянан шийдвэрлээгүй. харин гомдол гаргагчийн давж заалдах журмаар гаргасан гомдол нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмыг баримтлаагүй. өөрөөр хэлбэл улсын тэмдэгтийн хураамж төлөөгүй байсан тул хүлээн авахаас татгалзсан. Зохигч улсын тэмдэгтийн хураамж төлөөгүй нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 164 дүгээр зүйлийн 164.3-т заасан журмыг зөрчсөн үндэслэлийн нэг юм.

Давж заалдах журмаар гомдол гаргаж байгаа этгээдээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 162 дугаар зүйлийн 162.4-т зааснаар улсын тэмдэгтийн хураамжийг урьдчилан төлүүлнэ гэж заасан атал Шүүхийн Ёс зүйн хорооноос шүүгчийг яагаад хуульд заасан заалтыг зөрчсөн үндэслэл тогтоогдоогүй байхад давж заалдах журмаар гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн нь хууль зөрчсөн гэж үзсэн нь ойлгомжгүй байна.

Хоёр.Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалын Үндэслэх хэсэгт “шүүгч Б.М нь дээрх иргэний хэргийг шүүх хуралдаанд өөрийн биеэр илтгэн. шүүх хуралдаанаар хянан хэлэлцүүлж шийдвэрлэсэн мөртөө иргэний хэргийн зохигчдын гаргасан давж заалдах гомдлыг өөрөө оролцохгүйгээр, бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэх ёстой байтал өөрөө дангаараа хянаж 2016 оны 6 дугаар сарын 14-ний өдөр 153/ШЗ2016/01337 дугаартай захирамж гаргасан нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 171 дүгээр зүйлийн 171.1 дэх хэсэгт заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт энэ хуулийн 170.1-д заасны дагуу гаргасан гомдлыг 14 хоногийн дотор тухайн хэргийг хянан шийдвэрлэж байгаа шүүгчийг оролцуулахгүйгээр 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр дараах байдлаар хянан шийдвэрлэж тогтоол гаргана гэж заасныг ноцтой зөрчсөн.” гэжээ

Нэхэмжлэгч М.Х нь анхан шатны шүүхийн шийдвэрт давж заалдах журмаар гомдол гаргасан. Харин шийдвэр гаргаснаас бусад тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой бусад асуудлыг шийдвэрлэсэн шүүгчийн захирамжид гомдол гаргаагүй болно.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1-д заасан журмаар гаргасан гомдол, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 161 дүгээр зүйлийн 161.1 дэх хэсэгт заасан журмаар гаргасан гомдол нь хоёр өөр ойлголт юм.

Өөрөөр хэлбэл, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1-д заасан журмаар гаргасан гомдлыг нэхэмжлэгч М.Х гаргаагүй байхад Шүүхийн Ёс зүйн хорооноос Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 171 дүгээр зүйлийн 171.1 дэх хэсэгт заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт энэ хуулийн 170.1-д заасны дагуу гаргасан гомдлыг 14 хоногийн дотор тухайн хэргийг хянан шийдвэрлэж байгаа шүүгчийг оролцуулахгүйгээр 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ гэж дүгнэсэн нь үндэслэлгүй байна

Харин нэхэмжлэгч М.Х-гийн давж заалдах журмаар гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамжид гомдол гаргасан бол энэ нь жинхэнэ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 171 дүгээр зүйлийн 171.1 дэх хэсэгт заасан гомдол болох бөгөөд энэ гомдлыг тухайн хэргийг хянан шийдвэрлэж байгаа шүүгчийг оролцуулахгүйгээр 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх ёстой.

Гурав.Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалд “тус хэргийг хянан шийдвэрлэсэн шийдвэр, иргэний хэрэг үүсгэсэн захирамжаар нэхэмжлэгчийг улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлсөн бөгөөд давж заалдах шатны шүүхэд гаргасан гомдлыг энэ үндэслэлээр хүлээн авахаас татгалзсан, улмаар тус захирамжид гомдол гаргах эрхгүйгээр шийдвэрлэж хэргийг давж заалдах шатаар хэлэлцүүлэх боломжгүй болгожээ.” гэжээ.

Нэхэмжлэгч анх шүүхэд нэхэмжлэл гаргахдаа бүхэлдээ эрүүгийн хэргээс учирсан хохирол гэж улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлүүлэх хүсэлттэй орж ирсэн. Иймд миний бие шүүгчийн захирамжаар улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлсөн.

Харин хэргийг хянан шийдвэрлээд М.Х-гийн шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлага нь:

а. Эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээг баталгаажуулах тухай шүүгчийн захирамжаар баталгаажуулсан 6,088,000 төгрөгийг гаргуулах,

б. Эрүүгийн хэрэгт хууль зүйн туслалцаа үзүүлсэн өмгөөлөгчийн хөлс 400,000 төгрөг гаргуулах.

в. Ш аймгийн Ф сум дахь Сум дундын шүүхэд гомдол хэлэлцэхэд очсон зардал 198,000 төгрөг гаргуулах,

г. 6,088,000 төгрөгийг хугацаанд нь төлөөгүй учир өдөрт 0,3 хувиар тооцож хүү 3,044,000 төгрөгийг тус тус гаргуулах тухай маргаан болохыг тодруулж, шүүх хуралдаанаар нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, үлдсэн “Эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээг баталгаажуулсан 6,088,000 төгрөг гаргуулах” тухай шаардлагыг хэрэгсэхгүй болгосон ба нэхэмжлэгч зөвхөн энэ хэсэгт давж заалдах гомдол гаргасан.

Иймд миний бие Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.4-д зааснаар шийдвэрийн хүлээн зөвшөөрөхгүй байгаа буюу “Эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээг баталгаажуулсан 6,088,000 төгрөгийг хэрэгсэхгүй болгосон хэсэгт гомдол гаргаж байгаа 6,088,000 төгрөгт ногдох тэмдэгтийн хураамжийг төлөх ёстой гэж үзсэн.

Хэрэв энэхүү хэсгийг мөн л эрүүгийн хэргээс учирсан хохирол гэж үзэж байсан бол улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлүүлэх хүсэлтээ нэхэмжлэгч, түүний өмгөөлөгч гаргахгүй яасан юм бэ.

Шүүхийн Ёс зүйн хороо “...тус захирамжид гомдол гаргах эрхгүйгээр шийдвэрлэж хэргийг давж заалдах шатаар хэлэлцүүлэх боломжгүй болгожээ” гэж дүгнэсэнд тайлбар гаргахад:

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1-д зааснаас бусад захирамжид энэ зүйлд заасан журмын дагуу гомдол гаргах эрхгүй байдаг. Миний гаргасан 2016 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 153/ШЗ2016/01337 дугаартай нэхэмжлэгч М.Х-гийн давж заалдах журмаар гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамжийн удирдлага болгосон заалтууд нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1-д заасан зүйл заалтуудад хамрагдахгүй байсан тул “тус захирамжид гомдол гаргах эрхгүй” гэж бичсэн.

Нэхэмжлэгч нь тус захирамжид зааснаар улсын тэмдэгтийн хураамжаа төлөөд гомдлоо гаргавал давж заалдах шатны шүүхэд гаргасан гомдлыг хүлээн авна.

Эцэст нь хэлэхэд, миний бие Л аймгийн уугуул иргэн, дөрвөд ястан хүн. Энэ хэргийн зохигчид нь Ш аймгийн казах ястан хүмүүс. Би эдгээр хүмүүсийг огт танихгүй, шүүх хуралдаанд орохдоо харсан. Би энэ хэрэгт хувийн сонирхол гаргаагүй, шударга бус хандаагүй. Би зөвхөн хуульд заасан заалтыг биелүүлэхийг нэхэмжлэгчээс шаардсан.

Нэхэмжлэгч давж заалдах гомдол гаргахдаа хуульд заасан улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөх үндэслэлд хамрагдахгүй байсан учир тэмдэгтийн хураамжийг төлүүлэх шүүгчийн захирамж гаргасан. Одоо ч анхан болон давж заалдах шатны шүүхүүд энэхүү хуулийн шаардлагыг хангаагүй бол шүүгч дангаар гомдлыг хүлээн авахаас татгалзсан захирамж гаргадаг. Ганц манай шүүх биш бүх иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхүүд хуульд заасан заалтын дагуу бүрдэл хангагдаагүй давж заалдах журмаар гаргасан гомдлыг шүүгч дангаар хянан шийдвэрлэж, захирамж гаргадаг. Иймд Шүүхийн Ёс зүйн хороо “анхан шатны шүүхэд улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдсөн нь давж заалдах шатны шүүхэд гомдол гаргахад мөн тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөх үндэслэл болно” гэж үзсэнийг үндэслэлгүй гэж үзэж байгаа тул Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 05 дугаар магадлалыг хүчингүй болгож өгнө үү” гэжээ.

ХЯНАВАЛ:

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн

дугаар магадлалаар Ш аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М-д үндэслэлгүйгээр сахилгын шийтгэл ногдуулсан байх тул магадлалыг хүчингүй болгож, М.Х, түүний өмгөөлөгч Ц.Д нарын гомдлыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэлээ.

М.Х, түүний өмгөөлөгч Ц.Д нарын гомдлоор Шүүхийн Ёс зүйн хороо шүүгч Б.М-г өөрийн шүүх бүрэлдэхүүнд оролцож гаргасан шүүхийн шийдвэр, иргэний хэрэг үүсгэх тухай шүүгчийн захирамжид тус тус "Нэхэмжлэгч улсын тэмдэгтийн хураамж төлөхөөс чөлөөлөгдсөн" болохыг дурдан заасан атлаа энэ үндэслэлээр давж заалдах гомдлыг хүлээн авахаас татгалзаж, зохигчдыг шүүгчийн захирамжид гомдол гаргах эрхгүйгээр шийдвэрлэж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 171 дүгээр зүйлийн 171.1. иргэний гомдол гаргах эрхийг ноцтой зөрчсөн, энэ нь Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг зөрчсөн ёс зүйн зөрчил гэж үзэж, сануулах арга хэмжээ авсан нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2, 37 дугаар зүйлийн 37.1, 37.1.1-д заасантай нийцэхгүй байна.

Шүүгч Б.М нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 162 дугаар зүйлийн 162.4-д заасныг удирдлага болгон нэхэмжлэгч М.Х-гийн Ш аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 153/ШШ2016/00261 дүгээр шийдвэрийг эс зөвшөөрч гаргасан гомдлыг "шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа хэмжээгээр улсын тэмдэгтийн хураамжийг урьдчилан төлөөгүй" гэсэн үндэслэлээр хүлээн авахаас татгалзах тухай захирамж гаргажээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 164 дүгээр зүйлийн 164.3-т "Давж заалдах гомдол гаргахад энэ хуульд заасан журмыг баримтлаагүй бол шүүх гомдлыг хүлээн авахгүй бөгөөд энэ тухай шүүгч захирамж гаргана." гэж зааснаар анхан шатны шүүхийн шүүгч зохигчдын гаргасан давж заалдах гомдол нь хуульд заасан журмыг баримталсан эсэхийг хянаж, уг журмыг баримтлаагүй бол гомдлыг хүлээн авахаас татгалздаг.

Хуулийн дээрх зохицуулалтын дагуу шүүгч Б.М нь нэхэмжлэгч М.Х-гийн давж заалдах журмаар гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзах тухай захирамж гаргасан байх бөгөөд уг захирамжид Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1 -д зааснаар гомдол гаргах эрхгүй. Ийнхүү гомдол гаргах эрхгүй тул мөн хуулийн 171 дүгээр зүйлийн 171.1-д зааснаар 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэх боломжгүй. Гэтэл Шүүхийн Ёс зүйн хороо шүүгч Б.М-г нэхэмжлэгч М.Х-гийн гомдлыг өөрөө оролцохгүйгээр бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэх ёстой байтал өөрөө дангаараа хянаж шүүгчийн захирамж гаргасан нь хуулийн дээрх заалтыг ноцтой зөрчсөн" гэж буруутгасан нь үндэслэлгүй, мөн "Зохигчид шүүгчийн захирамжид гомдол гаргах эрхгүйгээр шийдвэрлэж хэргийг давж заалдах шатаар хэлэлцүүлэх боломжгүй болгосон" гэж хуулийг буруу тайлбарлан шүүгчид сахилгын арга хэмжээ авчээ.

Түүнчлэн гомдол гаргагч М.Х нь "тухайн иргэний хэрэгт миний гомдол гаргах эрхийг хязгаарласан, миний эрх зөрчигдөж хохирсон" гэж тайлбарлах боловч М.Х, К.Д нар нь 6,088,000 төгрөгийн хэмжээнд тохиролцож, эвлэрлийн гэрээ байгуулсныг баталгаажуулсан Сум дундын ... дугаар шүүхийн шүүгчийн 2014 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 73 дугаар захирамж хуулийн хүчин төгөлдөр байна

Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгч М.Х-гийн анх нэхэмжилсэн үнийн дүн болох 9,532,000 төгрөгийн шаардлага бүхэлдээ хангагдсан, нэхэмжлэгчид ашигтай эерэг шүүхийн шийдвэр гарсныг дурдах нь зүйтэй.

Нөгөө талаар Монгол Улсын Шүүхийн Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 2-т “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил ур чадвар, дадлага туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй 5.1 дүгээр зүйлийн 6-д “Шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаанаас бусад ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдлыг Шүүхийн Ёс зүйн хороо харьяалан шийдвэрлэнэ” гэж зааснаар Шүүхийн Ёс зүйн хороо нь зөвхөн шүүгчийн ёс зүйн зөрчилд хамаарах асуудлыг хянан шийдвэрлэх учиртай.

Харин шүүгчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хууль, журамд заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө ёс зүйн зөрчилд буруутган, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг тайлбарлан хэрэглэж, эл асуудлаар дүгнэлт өгөх үндэсгүй юм Учир нь зохигчдын гаргасан давж заалдах гомдлыг хүлээн авах эсэх нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэглэх шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой

Иймд, шүүгч Б.М-г хувийн зан чанар болгож төлөвшүүлэх зарчмуудыг зөрчиж, хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх үүргээ биелүүлээгүй гэж буруутган, сануулах сахилгын арга хэмжээ авсан Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал, мөн хорооны шүүгчид сахилгын хэрэг үүсгэсэн тогтоолыг тус тус хүчингүй болгож шийдвэрлэх нь зүйтэй байна.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1, 121 дүгээр зүйлийн 121.1.1 дэх заалтыг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 05 дугаар магадлал, Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 185 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгож М.Х, түүний өмгөөлөгч Ц.Д нарын Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хороонд ирүүлсэн гомдлыг хэрэгсэхгүй болгосугай.

2.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1-д зааснаар шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх есгүй хуулийг хэрэглэсэн, хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, төсөөтэй харилцааг зохицуул хуулийг буруу хэрэглэсэн, хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн нь шүүхийн шийдвэр гарахад нөлөөлсөн гэж үзвэл магадлалыг гардан авсан, эсхүл хүргүүлснээс хойш 14 хоногийн дотор Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд гомдол гаргах эрхтэй.

ОИН.МН
СУДАЛГААНЫ САН

ШҮҮГЧ

О.НОМУУЛИН

ШҮҮГЧ

Э.ХАЛИУНБАЯР

ШҮҮГЧ

Б.ТУНГАЛАГСАЙХАН



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ХЯНАЛТЫН ШАТНЫ ЗАХИРГААНЫ
ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2017 оны 6 сарын 28 өдөр

Дугаар 254

Улаанбаатар хот

Иргэн М.Х, өмгөөлөгч Ц.Д нарын гомдолтой
сахилгын хэргийн тухай

Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааныг Танхимын тэргүүн М.Батсуурь даргалж, шүүгч Л.Атарцэцэг, Х.Батсүрэн, Г.Банзрагч, Б.Мөнхтуяа нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн дарга С.Баяртуяа, гомдол гаргагч М.Х, өмгөөлөгч Ц.Д нарыг/онлайнаар/ оролцуулан хийж, Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 05 дугаар магадлал, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн 221/ЁМ2017/0006 дугаар магадлалтай, иргэн М.Х, өмгөөлөгч Ц.Д нарын гомдолтой, Ш аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М-д холбогдох сахилгын хэргийг М.Х, түүний өмгөөлөгч Ц.Д нарын хяналтын журмаар гаргасан гомдлоор шүүгч Х.Батсүрэнгийн илтгэснээр хянан хэлэлцэв.

Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 05 дугаар магадлалаар: Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35, 36 дугаар зүйл, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйл, Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.1, 5.13-т заасныг удирдлага болгон Ш аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М-д сануулах сахилгын шийтгэл ногдуулсан байна.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн 221/ЁМ2017/0006 дугаар магадлалаар: Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 05 дугаар магадлал, 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 185 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгож, М.Х, түүний өмгөөлөгч Ц.Д нарын Шүүхийн Ёс зүйн хороонд ирүүлсэн гомдлыг хэрэгсэхгүй болгосон байна.

Нэхэмжлэгч М.Х, түүний өмгөөлөгч Ц.Д нар хяналтын журмаар гаргасан гомдолдоо: “Шүүхийн Ёс зүйн хорооны 185 дугаар тогтоол, 05 дугаар магадлалаар шүүгчийн ёс зүй зөрчсөн, түүнд сахилгын сануулах шийтгэл оногдуулсныг эс зөвшөөрч Ш аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М-ийн гомдлын тайлбар, Эрүүгийн 201521000242 хэргийн сэжигтэн яллагдагч К.Д-г иргэний хэргийн хариуцагч болгон тайлбарласан байдаг. Гомдол гаргагч М.Х Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42, 43 дугаар зүйлд заасан хохирогч, иргэний нэхэмжлэгч байсан.

Монгол Улсын Анхны Ардчилсан сонгууль болж, байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан Өршөөл үзүүлсэн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8.1, 10.7.1-д заасны дагуу эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон нь тухайн гэмт хэргийн улмаас бусдад учруулсан гэм хорын хохирлыг нөхөн төлөхөөс чөлөөлөгдөхгүй гэж заасан. Иргэн хохирлоо Иргэний

хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуульд заасан журмын дагуу нэхэмжлэл гаргах эрхтэй гэж заасан. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 117 дугаар зүйлд заасан иргэний нэхэмжлэгчээр тогтоогдсон хохирогч М.Х мөн хуулийн 122, 123 дугаар зүйлд зааснаар шүүхэд нэхэмжлэлээ гаргаж шүүхээр хангуулах эрхтэй байгаа тул Өршөөлийн хуульд заасан журмаар иргэний нэхэмжлэлээ гаргаж, сэжигтэн яллагдагч К.Д-ээс гэм хорын болоод ЭБШ ажиллагааны зардалд 9,532,000 төгрөг нэхэмжилсэн нэхэмжлэлээс Ш аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх 3,044,000 төгрөгийн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, үлдсэн 6,260,000 төгрөгийн хохирлыг хэрэгсэхгүй болгосон тул Ш аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасан.

Хохирогч М.Х-гийн давж заалдах гомдлыг тус шүүхийн шүүгч Б.М 2016 оны 6 дугаар сарын 14-ний өдөр 153/ШЗ2016/01337 дугаар захирамжаар хүлээн авахаас татгалзсан тул нэхэмжлэгч М.Х, түүний өмгөөлөгч Ц.Д бид Шүүхийн Ёс зүйн хороонд гомдол гаргасан. Бидний гомдлыг Шүүхийн Ёс зүйн хороо Монгол улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 167 дугаар зарлигаар батлагдсан Шүүхийн Ёс зүйн дүрмийн 4.6.1-д заасны удирдлага болгож Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35, 36 дугаар зүйл, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйл, Шүүгчийн Ёс зүйн хорооны дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4.1, 13 дугаар зүйлийг удирдлага болгож оногдуулсан сахилгын шийтгэл үндэслэлтэй байхад Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдаанаас гаргасан 221/ЁМ2017/0006 дугаар магадлалыг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1, 121 дугаар зүйлийн 121.1-д заасныг удирдлага болгохдоо дараах алдаа гаргасан магадлалд гомдож байна.

Захиргааны хэргийн давж заалдах шүүх хэрэглэвэл зохих хууль хэрэглээгүй талаар: Эрүүгийн 201521000242 дугаар хэргийн хохирогч иргэний нэхэмжлэгч М.Х эрүүгийн хэргийн улмаас өөрт учирсан гэм хор хохирогчоо хохирлоо төлүүлэхээр иргэний хэргийн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 117 дугаар зүйлд зааснаар иргэний нэхэмжлэгчээр тогтоогдсон. Мөн хуулийн 122, 123 дугаар зүйлд зааснаар хохирлоо төлүүлэхээр иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргасан байхад Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх Эрүүгийн байцаан шийтгэх хууль баримтлаагүй Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль баримталж 2017 оны 4 дүгээр сарын 06-ны өдөр гаргасан 221/ЁМ2017/0006 дугаар магадлалыг гаргасанд гомдож байна. Захиргааны хэргийн давж заалдах шүүх хэрэглэх ёс зүй хууль хэрэглэсэн талаар: Эрүүгийн 201521000242 дугаар хэргийн хохирогч иргэний нэхэмжлэгч М.Х иргэний нэхэмжлэлийг шийдвэрлэхдээ 33 дугаар зүйлд заасныг үндэслэж шүүгч Б.М-д сахилын хэрэг үүсгэж, мөн хорооны 2016 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 185 дугаар тогтоол, 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 05 дугаар магадлалын заалт хуульд нийцэж байхад шүүгч Б.М-ийн гомдлоор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх 2017 оны 4 дүгээр сарын 06-ны өдөр 221/ЁМ2017/0006 дугаар магадлал гаргаж Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 05 дугаар магадлал, 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 185 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгосныг бүхэлд нь эс зөвшөөрч дараах үндэслэлээр Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэж тухайн хуулийн 119 дүгээр зүйлийн 119.5-д зааснаар дараах үндэслэлээр гомдол гаргаж байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 57, 163, 164 дугаар зүйлд заасан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хууль баримталсныг хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн гэж гомдож байна. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан иргэний нэхэмжлэгчийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуульд заасан иргэний хэргийн нэхэмжлэгч болгож захиргааны хэргийг давж

заалдах шүүх магадлалд буруу тайлбарласан гэж гомдож байна. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан иргэний нэхэмжлэгчийг шүүх хангах үүрэгтэй байхад Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан иргэний нэхэмжлэл гаргасан иргэний нэхэмжлэлийг хангаж байгаагаар захиргааны хэргийн давж заалдах шүүх буруу тайлбарласанд гомдож байна. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гомдол гаргагч шүүгч Б.М нь захиргааны хэргийн давж заалдах шүүхийн 2017 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн хуралд нэхэмжлэгчээр оролцох ёстой байсан бөгөөд Монгол улсын Шүүхийн Ёс зүйн хорооны тогтоолд гарын үсэг зурсан гишүүд Монгол улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 5 дугаар магадлалд гарын үсэг зурсан Н.Эрдэнэцогт, А.Доржготов нар хариуцагчаар оролцох ёстой байтал гомдол гаргагч шүүгч Б.М, хариуцагч Н.Эрдэнэцогт, А.Доржготов нарын төлөөлөгчгүй зөвхөн гуравдагч этгээдээр оролцох ёстой М.Х, түүний өмгөөлөгч Ц.Д нартай шүүх хурал шүүгч О.Номуулин, шүүгч Э.Халиунбаяр нар гуравдагч этгээдтэй мэтгэлцэж шийдвэрээ гаргасныг шүүх хуралдааны бичлэгээс харж болно. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хуралдаан хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчиж давж заалдах шүүхийн магадлал гарсан гэж гомдож гомдол гаргав.” гэжээ.

ХЯНАВАЛ

Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 185 дугаар тогтоол, 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 05 дугаар магадлалыг тус тус хүчингүй болгож, М.Х, түүний өмгөөлөгч Ц.Д нарын гомдлыг хэрэгсэхгүй болгосон Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.1, 121.2-т заасантай нийцсэн байна.

Хэрэгт авагдсан баримтаас үзэхэд, иргэн М.Х, К.Д нар 2014 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр “Эвлэрлийн гэрээ” байгуулж, 6,088,000 төгрөгийг 2014 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор М.Х-д бэлнээр төлөхөөр тохиролцон, уул гэрээг Сум дундын ... дугаар шүүхийн шүүгчийн 2014 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 73 дугаар захирамжаар баталгаажуулж, захирамжийг талууд сайн дураараа биелүүлээгүй тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 741 дүгээр зүйлийн 741.8-д заасны дагуу шүүхийн шийдвэрийн нэгэн адил албадан гүйцэтгэхээр мөн захирамжид заажээ.

Гэтэл М.Х 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр “дээрх шүүгчийн захирамжаар баталгаажуулсан 6,088,000 төгрөгийг К.Д-ээс гаргуулах”, мөн “...гэрээнд заасан хугацаанд төлөөгүй төлбөрийн хүү 3,044,000 төгрөг, өмгөөлөгчийн хөлс 400,000 төгрөг, замын зардал 198,000 төгрөг гаргуулах” нэхэмжлэлийг Ш аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргаж, тус шүүхийн 2016 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 153/ШШ2016/00261 дүгээр шийдвэрээр “...6,088,000 төгрөгийн төлбөрийг К.Д-ээс гаргуулах шаардлагаар Эвлэрлийн гэрээ байгуулж, шүүгчийн захирамжаар баталгаажсан тул дахин нэхэмжлэл гаргах эрхгүй” гэж хэрэгсэхгүй болгосон байна.

М.Х, түүний өмгөөлөгч Ц.Д нар дээрх шүүхийн шийдвэрийн “нэхэмжлэлийн зарим шаардлагыг хэрэгсэхгүй болгосон хэсэгт” давж заалдах журмаар гомдол гаргасныг Ш аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М, 2016 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 153/ШЗ2016/01337 дугаар захирамжаар “...улсын тэмдэгтийн хураамж төлөөгүй” гэсэн үндэслэлээр гомдлыг хүлээн авахаас татгалзаж, мөн шүүгчийн захирамжид гомдол гаргах эрхгүй болохыг дурджээ.

Үүнийг М.Х, түүний өмгөөлөгч Ц.Д нар "...гомдлыг үндэслэлгүйгээр буцааж давж заалдах гомдол гаргах эрхийг зөрчсөн, шүүгч Б.М өөрийн хууль бус захирамжаа нуухын тулд гомдол гаргах эрхгүй гэж дурдсан..." гэж Шүүхийн Ёс зүйн хороонд гомдол гаргасан байна.

Монгол Улсын Шүүхийн Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 5.1 дүгээр зүйлийн 6-д заасны дагуу Шүүхийн ёс зүйн хороо нь шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаанаас бусад ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдлыг харьяалан шийдвэрлэх бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан шүүгчийн мэргэжлийн ур чадвар, дадлага туршлагатай холбоотой алдаа зөрчлийг шийдвэрлэхгүй юм.

Тухайн тохиолдолд, шүүгч Б.М-ийн "давж заалдах гомдлыг хүлээн авсан, гомдлыг хуульд заасан журмыг баримтлаагүй гэж хүлээн авахаас татгалзсан" үйлдэл нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 161 дүгээр зүйлийн 161.2-т "Давж заалдах гомдлыг шийдвэр гаргасан шүүхээр дамжуулан гаргана", 163 дугаар зүйлийн 163.1-д "Давж заалдах гомдлыг хэргийг хянан шийдвэрлэсэн анхан шатны шүүгч ... хүлээн авч, ... танилцуулна", 163.3-т "Анхан шатны шүүх давж заалдах гомдолд улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, гаргасан тайлбарыг хавсарган хэргийн хамт гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 3 хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд хүргүүлнэ" гэж заасан иргэний хэрэг хянан шийдвэрлэсэн шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаа байна.

Гэтэл Шүүхийн Ёс хороо "шүүгч Б.М өөрийн илтгэж шийдвэрлэсэн хэрэгт гаргасан зохигчдын гомдлыг өөрөө дангаар шийдвэрлэж Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 171.1-д заасныг ноцтой зөрчсөн" гэж үндэслэлгүй дүгнэлт хийж, хууль бусаар шүүгч Б.М-д сахилгын арга хэмжээ авсан байх бөгөөд энэ талаарх давж заалдах шатны шүүхийн дүгнэлт зөв байна.

Мөн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гомдол гаргах харилцааг зохицуулсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1 дэх хэсэгт "давж заалдах гомдлыг хүлээн авахаас татгалзсан" шүүгчийн захирамжид гомдол гаргаж болохоор заагаагүй тул шүүгч Б.М 2016 оны 153/ШЗ2016/01337 дугаар захирамжид "гомдол гаргах эрхгүй" гэснийг буруутгах үндэслэлгүй, энэ нь ёс зүйн зөрчил биш юм.

Шүүхийн Ёс зүйн хороо маргааны үйл баримтад үндэслэлтэй дүгнэлт хийгээгүй, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох заалтыг буруу хэрэглэсэн байх тул тус хорооны тогтоол, магадлалыг хүчингүй болгосон давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэлээ.

М.Х, түүний өмгөөлөгч Ц.Д нар Ш аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 153/ШШ2016/00261 дүгээр шийдвэрт хуульд заасан журмыг баримталж давж заалдах гомдол гаргах эрхийг энэхүү тогтоол хязгаарлахгүй болохыг дурдах нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн үзэв.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.2.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 221/ЁМ2017/0006 дугаар магадлалыг хэвээр үлдээж, иргэн М.Х, өмгөөлөгч Ц.Д нарын гомдлыг хангахгүй орхисугай.

ТАНХИМЫН ТЭРГҮҮН

М.БАТСУУРЬ

ШҮҮГЧ

Х.БАТСҮРЭН



МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЁС ЗҮЙН ХОРООНЫ МАГАДЛАЛ

2017 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

Ш аймаг дахь Сум дундын эрүүгийн
хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Д.Г, Л.У
нарт холбогдох сахилгын хэргийн тухай

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааныг гишүүн Н.Эрдэнэцогт даргалж, гишүүн Ч.Оюунцэцэг, Д.Сүнжид, Э.Энхтуяа, Б.Уранцэцэг нарын бүрэлдэхүүнтэй, шүүгч Д.Г, хяналт шалгалт хариуцсан референт Б.Энхбаатар, хуралдааны тэмдэглэл хөтлөгчөөр шинжээч А.Энхбаатар нарыг оролцуулан, Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдааны танхимд хийж, Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 183 дугаар тогтоолоор шүүгч Д.Г, Л.У нарт сахилгын хэрэг үүсгэснийг ёс зүйн хорооны гишүүн Б.Уранцэцэгийн илтгэснээр хянан хэлэлцээд **ТОДОРХОЙЛОХ** нь:

Шүүхийн Ёс зүйн хороонд Хүний эрхийн үндэсний комисс гаргасан гомдолдоо: “Комисст хандаж МӨХ-ны гишүүн, өмгөөлөгч К.Б , Б.Ц нар “ШШГЕГ-ын харьяа Хорих ... ангид хоригдож буй С.А нь 2013 оны 08 дугаар сарын 16-ны өдөр З.Б-ийн биед хүнд гэмтэл санаатай учруулсан гэмт хэрэгт холбогдон 2014 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 32 дугаар шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн тусгай ангийн 96 дугаар зүйлийн 96.1 дэх хэсэгт зааснаар 3 жил 6 сарын хорих ялаар шийтгүүлсэн. Энэ хугацаанд давж заалдах, хяналтын шатны шүүхүүдэд гомдол гаргаж энэхүү хэрэг 2 жил гаруйн хугацаанд эцэслэн шийдвэрлэгдээгүй байсан болно. Улмаар 2015 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Улсын Дээд шүүх хэргийг хяналтын журмаар хянан хэлэлцээд 311 дүгээр тогтоолоор анхан болон давж заалдах шатны шүүхийн тогтоол, магадлалыг хүчингүй болгож, анхан шатны журмаар шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаан шийдвэрлэсэн байхад 2015 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр Ш аймгийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Л.У нь 112 дугаартай захирамжаар эдлээгүй үлдсэн ялаас 2 жилийг өршөөн хасаж, тус шүүхийн шүүгч Д.Г нь 2015 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 422 дугаар захирамжаар хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллах шийдвэрийг тус тус гаргасан нь шүүхийн ажилчдын хариуцлагагүй хайнга байдлаас нэг гэмт хэрэгт 2 удаа шийтгэх тогтоолоор ял оногдуулж алдаа дутагдлаа нуун дарагдуулж байна...” хэмээн дурджээ.

Гомдлын дагуу холбогдох баримт, материалыг судлан үзэхэд Улсын Дээд шүүх С.А-д холбогдох эрүүгийн хэргийг хяналтын журмаар хянан хэлэлцэж, 2015 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 311 дүгээр тогтоолоор анхан болон давж заалдах шатны шүүхийн тогтоол, магадлалыг хүчингүй болгож, эрүүгийн хэргийг анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаан шийдвэрлэжээ. Гэтэл Ш аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн

шүүгч Л.У 2015 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 112 дугаар захирамжаар С.А-ийн эдлээгүй үлдсэн ялаас 2 жилийг өршөөн хасаж, тус шүүхийн шүүгч Д.Г 2015 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 422 дугаар захирамжаар түүнийг хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллах шийдвэр гаргаж С.А-г гэм буруутай эсэх нь шүүхээр эцэслэн шийдвэрлэгдээгүй байхад түүнийг гэм буруутайд тооцсон байна.

... Иймд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь хэсэгт зааснаар Комиссын гишүүний бүрэн эрхийн дагуу С.А-г хүнд гэмт хэрэгт холбогдуулан шалгахдаа гэм буруутай эсэх нь шүүхээр эцэслэн шийдвэрлэгдээгүй байхад анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг үндэслэн ялыг өршөөн хасаж, хугацаанаас өмнө тэнсэн суллах шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах саналыг хүргүүлж байна." гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хороонд шүүгч Ц.М ирүүлсэн тайлбартаа: Сум дундын ... дүгээр шүүхээс Сум дундын ... дугаар шүүхэд 2015 оны 6 дугаар сарын 02-нд шилжиж ирсэн С.А-д холбогдох эрүүгийн хуулийн 96 дугаар зүйлд заасан хэргийг шүүгч Л.У хуваарийн дагуу хүлээн авч илтгэн шүүгч Л.Ц, Ж.Б нарын бүрэлдэхүүнтэйгээр 2016 оны 6 дугаар сарын 25-ны өдөр 90 дугаартай шийтгэх тогтоолоор шийдвэрлэсэн.

Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд шүүгч Л.У 2015 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр ялтан С.А-ийн ялаас өршөөн хассан шүүгчийн захирамж гаргасан.

Тухайн үед өмгөөлөгч К.Б, Б.Ц нарын гомдлоор Улсын Дээд шүүх хэргийг хянахаар хүлээн аваад байсныг шүүгч мэдээгүй /ялтан хяналтын гомдлоосоо татгалзсан гэж өршөөлд хамрагдах хүсэлтээ илэрхийлсэн. Энэ байдлыг нь өмгөөлөгч нар мэдээгүйн улмаас хяналтын шүүхэд гаргасан гомдлоосоо татгалзаагүй/ байсан.

Улсын Дээд шүүх хэргийг хянаад 2015 оны 11 дүгээр сарын 11-нд шийтгэх тогтоол, магадлалыг хүчингүй болгосон байдаг.

Шүүгч Д.Г 2015 оны 12 дугаар сарын 14-нд ялтан С.А-г ялаас хугацааны өмнө тэнсэн сулласан.

Улсын Дээд шүүхээс С.А-д холбогдох хэргийг шуудангаар ирүүлснийг тус шүүх 2015 оны 12 дугаар сарын 17-нд хүлээн авсан. Улмаар прокурор эсэргүүцэл бичиж өршөөл үзүүлэх, ялаас хугацааны өмнө суллах захирамжуудыг тус тус хүчингүй болгож хэргийг анхан шатны шүүх хуралдаанаар дахин хянан шийдвэрлэж 2016 оны 03 дугаар сарын 21-нд шийтгэх тогтоол гаргасан. Шийтгэх тогтоол нь хүчин төгөлдөр байна.

... ялтан хуулийн дагуу дахин хянан магадланд орж хугацаанаас өмнө тэнсэн суллагдсан болно." гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хороонд шүүгч Д.Г ирүүлсэн тайлбар болон нийт гишүүдийн хуралдаанд гаргасан тайлбартаа: "Миний бие 2015 оны 12 дугаар сарын 14-нд хорих ангид ял эдэлж байсан С.А-г ял эдлүүлж байсан Хорих анги болон хяналт тавьж байсан прокурорынх нь саналын дагуу хуульд заасан үндэслэлээр ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллаж шийдвэрлэсэн бөгөөд түүний хувийн хэрэг материалд Монгол Улсын Дээд шүүхэд гомдол гаргасан талаар ямар ч материал байгаагүй, энэ талаар хорих анги болон прокурор огт дурдаагүй, шүүгч мэдэх боломжгүй байсан бөгөөд шийтгэх тогтоол хүчингүй болсныг С.А-д холбогдох хэрэг 2015 оны 12 дугаар сарын 17-нд тус шүүхэд ирэхэд нь мэдсэн болно.

Би санаатайгаар С.А-ийн эрхийг зөрчиж, эрх зүйн байдлыг нь дордуулж, хохирол учруулъя гэж бодоогүй, зөвхөн хуульд заасан журмын дагуу шударга ажиллая гэж санаж ажил үүргээ гүйцэтгэсэн тул энэ байдлыг минь харгалзан сахилгын хэрэг үүсгэхгүйгээр шийдвэрлэж өгөхийг хүсье. Миний хувьд С.А-д холбогдох дээрх асуудлыг шийдвэрлэхдээ шүүхэд ирүүлсэн хувийн хэрэгт авагдсан баримтын хэмжээнд хянан шийдвэрлэсэн гэв.

Шүүхийн Ёс зүйн хороонд шүүгч Л.У ирүүлсэн тайлбартаа: "...шүүгчийн туслах Э.А нь шүүх хуралдааны товыг оролцогч нарт 2016 оны 6 дугаар сарын 13-ны өдөр утсаар мэдэгдэж тов мэдэгдэхэд хэлсэн хүсэлт тайлбарыг бичээд баримтыг хэрэгт хавсаргажээ. Уг баримтад өмгөөлөгч Б.Ц нь шүүх хуралдаан давхацсан тул хуралд оролцох боломжгүй гэж мэдэгдсэн ба өмгөөлөгч К.Б нь би хуралд орохгүй Б.Ц орох байх гэсэн бөгөөд шүүх шүүгдэгчээс 2 өмгөөлөгч чинь хоёулаа шүүх хуралдаанд орох юм уу гэрээ байгуулсан зүйл байна уу гэж асуухад К.Б өмгөөлөгч шүүх хуралд ирэх байх Б.Ц өмгөөлөгчийг мэдэхгүй байна. Өмгөөлөгч нартай сайн холбогдож чадаагүй гэжээ. Өмгөөлөгч нар нь үйлчлүүлэгч нараасаа шүүх хуралдаанд орсон шат болгоноос хөлс авдаг нийтлэг үзэгдэл байдаг тул бид шүүгдэгч С.А-г өмгөөлөгчтэйгөө хөлс мөнгөө өгөөгүй, тодорхой тохиролцож шийдээгүй байна гэж үзэн, шүүгдэгчийг өмгөөлүүлэх эрхээр хангаж, хуралдааныг хойшлуулсан. Хэрэв яг гэрээ ёсоор өмгөөлөгч Б.Ц нь шүүгдэгчийн өмгөөлөгчөөр шүүх хуралдаанд оролцох байсан бол шүүх хуралдааныг хойшлуулж буй тодорхой шалтгааныг үндэслэн баримтаа хавсарган заавал бичгээр ирүүлэх үүрэгтэй гэтэл утсаар би боломжгүй гэсэн байдаг. Иймээс би шүүгдэгчийг товлосон өмгөөлөгчгүй байна өмгөөлөгчийг нь сайн тодруул гэж туслах Э.А-д хэлсэн. Туслах маань н.Г өмгөөлөгч С.А-ийн өмгөөлөгчөөр ажиллахаар болсон хэргийн материалтай танилцуулж, шүүх хуралдааны товыг мэдэгдсэн гэж хэлсэн. Ингээд хуралдаан бэлэн болж дараагийн шүүх хуралдаан 2016 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 14 цаг 30 минутад хуралдааныг эхэлсэн. Ингэхэд шүүгдэгчийн өмгөөлөгч Д.Г оролцсон бөгөөд шүүгдэгч болон шүүгдэгчийн өмгөөлөгч нар нь шүүх хуралдааны ирцтэй холбогдуулан ямар нэгэн санал хүсэлт гаргаагүй тул шүүх хуралдааныг хийсэн.

Шүүх шүүгдэгчийн эрх зүйн ойлголт ядмаг байдлыг далимдуулдаг байгууллага биш харин өмгөөлөгч нар нь үйлчлүүлэгчийнхээ эрх зүйн мэдлэг ядмагийг мэдэж ойлгож байсан бол харин ч хуралтай гээд тов мэдэгдээд байсан хойшлуулсан уу, хэзээ хүртэл хойшилсон. Намайг оролцуулах болсон уу яах бол гэж үйлчлүүлэгчтэйгээ ярьж санаа тавих үүрэгтэй. Гэтэл тэгж санаа тавиагүй байж шүүх рүү дайрч шүүхийг дандаа хууль зөрчиж үйл ажиллагаа явуулдаг мэтээр гомдол гаргасан байна.

Шүүх хуралдаанд К.Б, Б.Ц нартай адил мэргэжил мэдлэгтэй өмгөөлөгч хүн хэргийн материалтай танилцаж гарын үсгээ зураад шүүх хуралдаанд гаргах саналгүй гэсэн байх тул шүүх заавал К.Б, Б.Ц өмгөөлөгч нарт хуралдааны товыг мэдэгдэж хуралдаанд оролцуулах үүрэггүй болно." гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны гомдол хянан хэлэлцэх хуралдаанаар хэлэлцээд ҮНДЭСЛЭХ нь:

Шүүхийн Ёс зүйн хороонд Хүний эрхийн үндэсний комиссоос шүүгч Д.Г, Л.У нарт холбогдуулан "хариуцлага тооцуулах тухай" гэсэн гомдлыг гаргажээ.

С.А нь 2013 оны 8 дугаар сарын 16-ны өдөр З.Б-ийн биед хүнд гэмтэл санаатай учруулсан гэмт хэрэгт холбогдон Ш аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2014 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 32 дугаар шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн тусгай ангийн 96 дугаар зүйлийн 96.1 дэх хэсэгт зааснаар 3 жил 6 сарын хорих ялаар шийтгүүлжээ. Улмаар

2015 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Улсын Дээд шүүх хэргийг хяналтын журмаар хянан хэлэлцээд 311 дүгээр тогтоолоор анхан болон давж заалдах шатны шүүхийн тогтоол, магадлалыг хүчингүй болгож, анхан шатны журмаар шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаан шийдвэрлэсэн байхад Ш аймаг дахь Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Л.У нь 2015 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр 112 дугаартай захирамжаар С.А-ийн эдлээгүй үлдсэн ялаас “Өршөөл үзүүлэх тухай хууль”-ийг үндэслэн 2 жилийг өршөөн хассан.

Үүний зэрэгцээ тус шүүхийн шүүгч Д.Г аймгийн прокурорын саналыг үндэслэн 2015 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 422 дугаар захирамжаар С.А-г хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллах шийдвэрийг гаргасан байна.

Ийнхүү шүүгчдийг дурдсан үйл ажиллагааг явуулж байх үед С.А-ийн өмгөөлөгч Б.Ц, К.Б нараас хяналтын журмаар гаргасан гомдлын дагуу С.А-д холбогдох эрүүгийн хэргийг Ф аймгийн шүүхийн тамгын газар 2015 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 199 тоот албан бичгээр Улсын Дээд шүүхэд хэргийг хүргүүлжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 183 дугаар тогтоолоор шүүгч Д.Г, Л.У нарт Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 3.3.1-д "Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй" гэснийг зөрчсөн гэж үзээд сахилгын хэрэг үүсгэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанаар шүүгч Д.Г нь 2015 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 422 дугаар захирамжаар хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллах шийдвэр гаргахдаа Ш аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд аймгийн прокурорын газраас ирүүлсэн ялтны хувийн хэрэг, холбогдох баримтыг үндэслэн асуудлыг шийдвэрлэсэн бөгөөд эдгээрт эргэлзээ төрүүлэх ямар нэгэн үндэслэл байхгүй байсан, энэ нь шүүгчийн хууль хэрэглээ, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамааралтай асуудал тул шүүгч Д.Г-т шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн гэж үзэж, сахилгын хэрэг үүсгэсэн нь үндэслэлгүй байна гэж бүрэлдэхүүн дүгнэв.

Харин шүүгч Л.У нь С.А-д холбогдох эрүүгийн хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэсэн шүүгчийн хувьд Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2007 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Эрүүгийн хэргийн хөдөлгөөний стандарт”-ын 6.3.4-т заасан гомдол эсэргүүцлийг хүлээн авсан өдөрт нь тухайн хэргийг хянан шийдвэрлэсэн шүүгч эсхүл түүний туслахад шилжүүлнэ гэсний дагуу гомдолтой танилцаагүйгээс С.А-ийн эрх зөрчигджээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 183 дугаар тогтоолоор шүүгч Л.У-д Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 3.3.1-д “Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй” гэснийг зөрчсөн гэж үзэж сахилгын хэрэг үүсгэсэн нь үндэслэлтэй байх тул түүнд сахилгын шийтгэл ногдуулах нь зүйтэй гэж нийт гишүүдийн хуралдаанаас үзэв.

Харин гомдолд шүүгч Д.Г, Л.У нар нь шүүх хуралдаанд өмгөөлөгч оролцуулаагүй гэх шүүгдэгч С.А-ийн эрхийг зөрчсөн гэх гомдол нь үндэслэлгүй байна гэж дүгнэсэн нь зүйтэй байна.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35, 36 дугаар зүйл, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйл, Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5.7.1, 5.7.2, 5.13-т заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Ш аймгийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Л.У-д сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Ш аймаг дахь Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Д.Г-т холбогдох сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгосугай.

3. Энэ магадлалын хувийг шүүгч болон гомдол гаргагчид хүргүүлэхийг Ажлын албанд даалгасугай.

4. Шүүгч болон гомдол гаргагч энэ магадлалыг эс зөвшөөрвөл хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.

ДАРГА

Н.ЭРДЭНЭЦОГТ

ГИШҮҮН

Б.УРАНЦЭЦЭГ



ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ
МАГАДЛАЛ

2017 оны 5 сарын 10 өдөр

Дугаар 221/ЁМ2017/0010

Улаанбаатар хот

Ш аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн
анхан шатны шүүхийн шүүгч Д.Г, Л.У нарт холбогдох
сахилгын хэргийг хянасан магадлалын тухай

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааныг шүүгч С Мөнхжаргал даргалж, шүүгч Д Батбаатар, Э.Лхагвасүрэн нарын бүрэлдэхүүнтэй, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Б.Наранцэцэг, шүүгч Л.У-гийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Х.Б нарыг оролцуулан, Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн "Ш аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Д.Г, Л.У нарт холбогдох сахилгын хэргийн тухай" 25 дугаар магадлалыг шүүгч Л.У-гийн гомдлоор, шүүгч Э.Лхагвасүрэнгийн илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Нэг. Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 183 дугаар тогтоолоор:

"Ш аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Д.Г, Л.У нарт холбогдох сахилгын хэрэг үүсгэж" шийдвэрлэжээ.

Хоёр. Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 25 дугаар магадлалаар:

"1.Ш аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Л.У д сахилгын шийтгэл ногдуулж, Ш аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Д.Г-т холбогдох сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгож" шийдвэрлэжээ.

Гурав. Дээрх магадлалыг эс зөвшөөрч шүүгч Л.У 2017 оны 3 дугаар сарын 24-ний өдөр Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гаргасан гомдолдоо:

"... Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 183 дугаар тогтоолоор шүүгч Д.Г, Л.У нарт шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 3.3.1-д "Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй." гэснийг зөрчсөн гэж үзээд сахилгын хэрэг үүсгэсэн Уг гаргасан гэх зөрчил нь С.А-д холбогдох шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болоогүй байхад шүүгч Л.У өршөөлийн тухай хуульд зааснаар 2 жилийн хорих ялыг эдлэх ялаас өршөөн хассан, шүүхийн шийтгэх тогтоол хүчингүй болсны дараа шүүгч Д.Г ялтныг эдлэх ялаас хугацааны өмнө тэнсэн сулласан гэх зөрчлөөр буюу 2 шүүгч хоёулаа хүчин төгөлдөр бус шийтгэх тогтоолоор ялтныг өршөөлийн хуульд хамруулсан адил агуулгатай зөрчлөөр сахилгын хэрэг үүсгэсэн

Энэ сахилгын хэрэг үүсгэснийг 2 шүүгч эс зөвшөөрч нийт гишүүдийн хуралдаанд гомдол гаргаж, гомдлыг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд шүүгч Д.Г өөрийн

биеэр оролцож, шүүгч Л.У миний хувьд шүүх хуралдаан хийхээр товлосон мөн бага насны хүүхэд ханиадтайгаас хоногоор орхиж явах боломжгүй байсан тул Д.Г шүүгчтэй ярилцаад хуралдааныг хойшлуулъя гэхэд Д.Г шүүгч "...үгүй ээ, цагаан сараас өмнө энэ асуудлаа дуусгамаар байна. Чи бид хоёрт үүсгэсэн сахилгын хэрэг адил агуулгатай юм чинь үндэслэлээ сайн нотолсон баримтаа тайлбарын хамт ёс зүйн хороонд явуулсан болохоор би орчихъё" гэж нэг ёсондоо адилхан хоёулаа хүчин төгөлдөр бус шийтгэх тогтоолоор өршөөлийн хууль хэрэглэсэн, зөрчлийн утга нь адил юм чинь адилхан л шийдвэрлэнэ хурал хойшлуулж яахын гэхээр нь зөвшөөрч, өөрийн биеэр очоогүй юм нэг шүүгч маань шүүх хуралдаанд оролцсон юм.

Гэтэл уг хуралдаанаар шүүгч Д.Г-д холбогдох сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгоод хуралдаанд очоогүй миний биед сануулах сахилгын шийтгэл авсан хуралдаанд өөрийн биеэр ирээгүйд нь сахилгын арга хэмжээ авлаа гэсэн ойлголтыг төрүүлэхээр байсан тул энэ шийдвэрийг үндэслэлгүй гэж үзэж байна.

Шүүхийн Ёс зүйн хорооны сахилгын шийтгэл ногдуулсан үндэслэл нь "...шүүгч Л.У нь С.А-д холбогдох эрүүгийн хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэсэн шүүгчийн хувьд Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2007 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Эрүүгийн хэргийн хөдөлгөөний стандартын 6.3.4-т "Гомдол эсэргүүцлийг хүлээн авсан өдөрт нь тухайн хэргийг хянан шийдвэрлэсэн шүүгч эсхүл түүний туслахад шилжүүлнэ" гэсний дагуу гомдолтой танилцаагүйгээс С.А-ийн эрх зөрчигджээ. Иймээс Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 3.3.1-д "Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх үйл ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй" гэснийг зөрчсөн гэж үзэж "...сахилгын хэрэг үүсгэсэн нь үндэслэлтэй байх тул түүнд Сахилгын шийтгэл ногдуулах нь зүйтэй" гэж үзэж сануулах сахилгын шийтгэл ногдуулсан.

Энэхүү стандартаар бол хэргийг шийдвэрлэсэн шүүгч гэвэл хүнд зүйл ангитай эрүүгийн хэргийг 3 шүүгч бүрэлдэхүүнтэй шийдвэрлэсэн ба шүүгч Л.Ц, Ж.Б, Л.У нарын бүрэлдэхүүнтэй шийдвэрлэсэн. Иймээс энэ стандартаар шийдвэрлэсэн бүх шүүгчид хэргийг шилжүүлэх боломжгүй бөгөөд мөн тухайн хэргийг шийдвэрлэсэн шүүгч нарт уг хэргийн шийтгэх тогтоол, магадлал хүчингүй болсон гэдгийг огт танилцуулж, аль алинд нь хэргийг шилжүүлээгүй. Тухайн үед анхан шатны эрүүгийн хэргийн шүүхийн Ерөнхий шүүгчийн туслах байсан Н.М хэргийг хүлээж аваад хавтаст хэрэг болон гомдлыг шийдвэрлэсэн шүүгч нарт танилцуулалгүй Улсын дээд шүүх рүү хүргүүлжээ. Энэ нь доор дурдсан хэрэг материалыг хүлээн авсан, танилцуулсан тухай баримтуудаар нотлогдож байна.

Энэхүү шүүхийн Тамгын газрын хариуцлагагүй эрүүгийн хэргийн стандартаа барьж ажиллаагүйгээс уг эрүүгийн хэрэгт хяналтын журмаар гомдол гаргасан гэдгийг би мэдээгүй, мэдэх боломжгүй байсан.

Хэргийн тухайд Сум дундын ... дугаар шүүхийн эрхээр шүүгч Л.У илтгэж, шүүгч Л.Ц, Ж.Б нарын бүрэлдэхүүнтэй 2015 оны 6 дугаар сарын 24-ний өдөр 90 дугаартай шийтгэх тогтоолоор шүүгдэгч С.А-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 96 дугаар зүйлийн 96.1 дэх хэсэгт зааснаар гэм буруутайд тооцож 3 жил 6 сарын хорих ялыг жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлэхээр шийдвэрлэсэн. Ингээд шүүгдэгчийн өмгөөлөгч Б.Ц, К.Б нар давж заалдах гомдлыг 2015 оны 7 дугаар сарын 20-ны өдөр гаргаж 2015 оны 7 дугаар сарын 29-ний өдөр давж заалдах шатны шүүх рүү хүргүүлж давж заалдах шатны шүүх 2015 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж 2015 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр анхан шатны шүүх рүү хэргийг хүргүүлсэн.

Давж заалдах шатны шүүхийн магадлалыг өмгөөлөгч Б.Ц, К.Б нар эс зөвшөөрч 2015 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр гомдол гаргасныг Ш аймаг дахь

Сум дундын Эрүүгийн хэргийн шүүх 2015 оны 10 дугаар сарын 8-ны өдөр хүлээн авчээ “Эрүүгийн хэргийн хөдөлгөөний стандарт”-ын 6.3.4-т “Гомдол эсэргүүцлийг хүлээн авсан өдөрт нь тухайн хэргийг хянан шийдвэрлэсэн шүүгч, эсхүл түүний туслахад шилжүүлнэ.” гэсний дагуу шүүгч Л.У, түүний туслах Э.А нарт шилжүүлж өгөх байтал шилжүүлээгүй энэ тухай огт мэдэгдээгүй.

Иймээс би давж заалдах шатны шүүхэд хяналтын журмаар гомдол гаргасан гэдгийг мэдээгүй, мэдэх боломжгүй байсан.

Энэ нь хавтаст хэргийн ар талд хэргийг хүлээн авч, хүргүүлсэн тухай тэмдэглэдэг дардсаар 2015 оны 8 дугаар сарын 7-ны өдөр П аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх шүүгч Б.Д-гийн нэрээр хүлээн авч, уг хэргийг анхан шатны шүүхэд хүргүүлсэн тэмдэглэгээгүйгээр хавтаст хэрэг 2015 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Улсын дээд шүүх гэдгээр, мөн анхан шатны шүүхэд хэрэг анх ирэхэд хүлээж авсан Ерөнхий шүүгчийн туслах давж заалдах шатны шүүхээс таны илтгэж шийдвэрлэсэн хэрэг хэвээр шийдвэрлэгдэж ирсэн байна гэдгийг танилцуулж “Анхан шатны шүүхэд гомдол, эсэргүүцэл, өргөдөл хүсэлт хүлээн авсан бүртгэл”-ийн дэвтэрт гарын үсэг зуруулаагүй.

Мөн уг гомдлыг “Эрүүгийн хэргийн хөдөлгөөний стандарт”-ын 6.5-т зааснаар шүүгч Л.У-гийн туслах Э.А гомдол эсэргүүцлийг хүлээн авсан өдөртөө тухайн хэргийн бусад оролцогчдод танилцуулж, танилцуулсан тухай баримтыг бусад оролцогчдоос гаргасан тайлбартай хамт хэрэгт хавсарган Ерөнхий шүүгчийн туслахад өгөх ёотой байтал тухайн үед Ш аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн туслахаар ажиллаж байсан Н.М гомдлыг оролцогчдод танилцуулаад хэргийг Улсын дээд шүүх рүү Ерөнхий шүүгчийн албан тоотоор хүргүүлсэн байна.

Иймээс шүүгч Л.У би энэ тухай мэдээгүй, надад мэдэгдээгүй, өөр шүүгч дээр эр тусмаа Ерөнхий шүүгч түүний туслах дээр байгаа хэрэгт ямар хүсэлт гомдол ирснийг би огт мэдээгүй, мэдэх боломжгүй байсан.

Иймд өөрийгөө Эрүүгийн хэргийн хөдөлгөөний стандартын 1.3.4-т заасныг зөрчсөн гэж үзэхгүй байна. Эрүүгийн хэргийн хөдөлгөөний стандартыг шүүхийн Тамгын газар мөрдлөг болгон ажиллахгүй Ерөнхий шүүгчийн туслах гомдлыг хүлээн авч хэргийг шийдвэрлэсэн шүүгч түүний туслахад хэргийг өгөхгүйгээр гомдлыг хүргүүлж ийм асуудал үүсгэсэн нь Тамгын газрын ажлын хариуцлагатай холбоотой байна.

Иймээс шүүгч энэ алдаа зөрчлийн хариуцлагыг хүлээх нь зохисгүй. 2015 оны 11 дүгээр сарын 6-ны өдөр 112 дугаар захирамжаар “шийтгэх тогтоол” хүчин төгөлдөр болоогүй байхад өршөөл үзүүлэх тухай хуулийг хэрэглэж 2 жилийн ялыг өршөөн хассан сахилгын зөрчил гаргасан гэж дүгнэвэл уг зөрчлөөр 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр сахилгын хэрэг үүсгэж, 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдөр сануулах сахилгын шийтгэл ногдуулсан. Үүнээс харахад сахилгын зөрчлийг гаргаснаас хойш 1 жил 3 сарын дараа шийтгэл оногдуулсан нь мөн хууль зүйн үндэслэлгүй шийдвэр болсон гэж үзэж байна.

Иймд Шүүхийн Ёс зүйн хорооны сануулах сахилгын шийтгэл ногдуулсан 2017 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 25 дугаартай магадлалыг хүчингүй болгож өгнө үү” гэжээ.

ХЯНАВАЛ:

Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалд "...шүүгч Д.Г нь 2015 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 422 дугаар захирамжаар хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллах шийдвэр гаргахдаа Ш аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд аймгийн прокурорын газраас ирүүлсэн ялтны хувийн хэрэг, холбогдох баримтыг үндэслэн асуудлыг шийдвэрлэсэн бөгөөд эдгээрт

эргэлзээ төрүүлэх ямар нэгэн үндэслэл байхгүй байсан, энэ нь шүүгчийн хууль хэрэглээ, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамааралтай асуудал тул шүүгч Д.Г-д шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн гэж үзэж, сахилгын хэрэг үүсгэсэн нь үндэслэлгүй байна” гэж дүгнэн түүнд холбогдох сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгосон атлаа харин шүүгч Л.У-г С.А-д холбогдох эрүүгийн хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэсэн шүүгчийн хувьд Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2007 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Эрүүгийн хэргийн хөдөлгөөний стандарт”-ын 6.3.4-т заасан гомдол, эсэргүүцлийг хүлээн авсан өдөр нь тухайн хэргийг хянан шийдвэрлэсэн шүүгч эсхүл түүний туслахад шилжүүлнэ” гэсний дагуу гомдолтой танилцаагүйгээс С.А-ийн эрх зөрчигджээ...” гэж дүгнэн түүнд сануулах сахилгын шийтгэл ногдуулсан нь үндэслэлгүй болжээ.

Учир нь шүүгч Л.У-д сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болсон дээрх стандартын 6.3.2-т “...хяналтын журмаар гаргасан гомдол, -ыг тухайн шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн туслах хүлээн авах...”, 6.3.4-т “Гомдол, -ыг хүлээн авсан өдөрт нь тухайн хэргийг хянан шийдвэрлэсэн шүүгч, эсхүл түүний туслахад шилжүүлнэ” гэж зохицуулсан байх бөгөөд ёс зүйн хорооноос сахилгын хэрэг үүсгэн шалгах явцдаа уг журмын дагуу С.А-ийн өмгөөлөгчдийн гаргасан гомдлыг шүүгч Л.У эсхүл түүний туслахад танилцуулсан эсэхийг шалгаж тогтоогоогүй, энэ талаар ерөнхий шүүгчийн туслах Н.М-ээс тайлбар аваагүй байна.

Гэвч гомдолд хавсаргасан баримтаас үзэхэд анхан шатны шүүхийн 2015 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 90 дугаар шийтгэх тогтоол, давж заалдах шатны шүүхийн мөн оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 137 дугаар магадлалд шүүгдэгч талын өмгөөлөгчдөөс хяналтын журмаар гомдол гаргасныг анхан шатны шүүх 2015 оны 10 дугаар сарын 08-ны өдөр хүлээн авсан байх боловч дээрх стандартын дагуу гомдлыг шүүгч Л.У-д танилцуулаагүй болох нь Анхан шатны шүүхэд гомдол, эсэргүүцэл, өргөдөл, хүсэлт хүлээн авсан бүртгэлийн дэвтрийн 224 дүгээрт тэмдэглэгдсэнээс гадна шүүгч болон шүүгчийн туслахад гомдлыг танилцуулалгүйгээр хэргийн хамт 2015 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 199 дүгээр албан бичгээр Улсын Дээд шүүхэд хүргүүлсэн нь Ерөнхий шүүгч Ц.М-ийн Ёс зүйн хороонд гаргасан тайлбараар тогтоогддог.

Түүнээс гадна ялтан С.А-ийн хувийн хэрэгт анхан болон давж заалдах шатны шүүхийн шийтгэх тогтоол, магадлал авагдсан, Ш аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2015 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 112 дугаар захирамжаас үзэхэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих ангиас "С.А-ийн өршөөлд хамрагдах хүсэлтийг харгалзан Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай Монгол Улсын хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт хамрагдаж байгааг үндэслэн түүний эдлээгүй үлдсэн 2.6 жилийн хорих ялаас 2 жилийг өршөөн хасаж, үлдэх 6 сарын хорих ялыг биечлэн эдлүүлэх” санал гаргасан, прокурорын дүгнэлтэд ялаас өршөөн хасах тухай дээрх саналыг үндэслэлтэй гэсэн зэргээс үзэхэд шүүгч Л.У төдийгүй прокурор, мөн ялтан С.А ч өөрийн өмгөөлөгчдөө хяналтын журмаар гомдол гаргасан талаар мэдээгүй байна.

Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл нэгтгэн боловсруулах газраас Шүүхийн Ёс зүйн хороонд ирүүлсэн Ялтны хувийн хэрэгт С.А-ийн өмгөөлөгчдийн хяналтын журмаар гаргасан гомдлыг түүнд танилцуулсан талаарх баримт байхгүй, энэ нь Ш аймаг дахь шийдвэр гүйцэтгэх алба-хорих ангийн 2017 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 1/134, Ш аймгийн прокурорын газрын 2017 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 7/113, Цагдаагийн ерөнхий газрын МНБГ-ийн Статистикийн хэлтсийн 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 106/218 дугаар албан бичгээр тус тус нотлогддог

Иймд шүүгч Л.У-гийн тухайд С.А-д холбогдох ялаас өршөөн хасах тухай материалыг хүлээн авч 2015 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 112 дугаар захирамж гаргахдаа Ш аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих ... ангийн санал, аймгийн прокурорын дүгнэлт, ялтны хувийн хэрэг, холбогдох баримтад үндэслэсэн байх бөгөөд эдгээрт эргэлзээ төрүүлэх ямар нэгэн үндэслэл байхгүй буюу шүүгч Д.Г-гийн нэгэн адил нөхцөл байдалтай байсан нь тогтоогдож байх тул Шүүхийн Ёс зүйн хорооны тогтоолын шүүгч Л.У-д холбогдох хэсэгт өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэв.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.2, 120 дугаар зүйлийн 120.1 дэх хэсэгт заасныг тус тус удирдлага болгон,

ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 25 дугаар магадлалын Тогтоох хэсгийн 1 дэх заалтыг “Ш аймгийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Л.У д холбогдох сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгосугай” гэж өөрчлөн, бусад заалтыг хэвээр үлдээж, шүүгч Л.У-гийн гаргасан гомдлыг хангасугай.

2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.5, 123 дугаар зүйлийн 123.2 дахь хэсэгт зааснаар давж заалдах шатны шүүх хууль буруу хэрэглэсэн, эсхүл хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн нь шүүхийн шийдвэр гаргахад нөлөөлсөн гэж үзвэл хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч нар магадлалыг гардаж авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор Улсын Дээд шүүхийн захиргааны хэргийн танхимд хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй.

ШҮҮГЧ

С.МӨНХЖАРГАЛ

ШҮҮГЧ

Д.БАТБААТАР

ШҮҮГЧ

Э.ЛХАГВАСҮРЭН

УИХ.МН
СЭВАЛГААНЫ САН



МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЁС ЗҮЙН ХОРООНЫ МАГАДЛАЛ

2017 оны 3 сарын 30 өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

К дүүргийн Иргэний хэргийн анхан
шатны шүүхийн шүүгч Ж.С-д сахилгын
шийтгэл ногдуулах тухай

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааныг тус хорооны дарга Н.Эрдэнэцогт даргалж, гишүүн В.Жавхлан, А.Доржготов, Б.Уранцэцэг, О.Мөнхсайхан нарын бүрэлдэхүүнтэй, гомдол гаргагч З.А-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч Б.Э, шүүгч Ж.С, тэмдэглэл хөтлөгчөөр шинжээч А.Энхбаатар, ажлын албаны дарга Н.Г нарыг оролцуулан Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдааны танхимд хийв. Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 20 дугаар тогтоолыг Шүүхийн Ёс зүйн хорооны гишүүн О.Мөнхсайханы илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Шүүхийн Ёс зүйн хороонд иргэн З.А гаргасан гомдолдоо: "... Шүүгч Ж.С нь шүүгч хүний хувийн амьдралдаа баримтлах зарчмыг зөрчиж Шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг алдагдуулж мэргэжлийн нэр хүндээ үл эрхэмлэн эвлэрүүлэн зуучлагч бусад шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шууд хөндлөнгөөс оролцон нөлөөлж, хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгээ худал мэдүүлж, эвлэрүүлэн зуучлагчид албан үүрэгт нь хамааралгүй даалгавар өгч, хувийн ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж, өөрийн эхнэртээ хууль зүйн зөвлөгөө өгч баримт бичиг өөрийн гараар бичиж боловсруулан бичиж өгч, бусдад эргүүлэн өгөх ёстой эд хөрөнгө болох автомашиныг өгөхгүй байх, бусдыг дарамталж худал хэлж эвлэрлийн гэрээ албадан байгуулж шүүхийн шийдвэрийг хууль бусаар гаргуулсан зэрэг Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.1 дүгээр зүйлийн 1, 4.1 дүгээр зүйлийн 2, 4.2 дугаар зүйлийн 4.2, 4.2 дугаар зүйлийн 5, 4.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэм хэмжээг тус тус зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гаргалаа гэж үзэж энэхүү гомдлыг гаргаж байна. Маш их гомдолтой байна.

Шүүгч Ж.С-д холбогдуулан сахилгын хэрэг үүсгэж хянан шалгаж Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шүүгчийн Ёс зүйн дүрэмд зааснаар зохих сахилгын шийтгэл ногдуулж өгнө үү. Зөрчлийн талаар:

Нийслэлийн Ф дүүрэгт оршин суугч З.А би гэр бүлийн дундын хөрөнгө болох АНУ-аас 2014.08.06-ны өдөр оруулж ирсэн эхнэр С.М-ийн нэр дээр байдаг Toyota RAW-4 маркийн 2012 онд Япон улсад үйлдвэрлэгдсэн, арлын ... дугаартай, улсын-XXX дугаартай, суудлын хар өнгөтэй автомашинаа зарж борлуулахаар Үнэгүй.мн вэйб сайт дээр худалдааны зарыг 2015 оны 8 дугаар сарын эхээр тавьсан. Зар гарсны дараа 2015.08.05-ны өдөр Ж.С эхнэр О.Э-ийн хамт ирж машин үзэж сонирхоод 25,000,000 төгрөгөөр наймаа арилжаа хийхээр бид харилцан тохиролцсон. Ж.С-д миний машины үнийн 10 сая төгрөгт нь Toyota Axio маркийн автомашин оролцуулан бодож, бэлнээр 15 сая төгрөг өгөхөөр болж наймаа хийсэн. Ж.С надад өөрөө тэр оролцуулж байгаа машинаа унаж ирээд 15 сая төгрөг

бэлнээр авчирч тоолж өгсөн. Би машинаа эхнэрээсээ итгэмжлэл авсан байсан учраас автын газар дээр очиж Ж.С-ийн эхнэр О.Э-ийн нэр дээр 2015.08.05-ны өдөр шилжүүлж өгсөн.

Үүнээс хойш 1 жил 3 сарын хугацаа өнгөрсний дараа 2016.11.21-ний өдөр Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны Ө дүүргийн тойрог хариуцсан н.У гэгч намайг дуудсан. Би очиход тэрээр “та О.Э гэгч хүнд 25 сая төгрөгийн төлбөртэй байна, гүйцэтгэх хуудас ирсэн.” гэж хэлсэн. Би түүнд “энэ чинь юу болж байгаа юм бол оо, би шүүх дээр ганц ч удаа очоогүй, намайг дуудаагүй, надад мэдэгдэлгүй шүүхийн шийдвэр гаргачихдаг юм байх даа.” гэхэд уг нь манай Ө дүүргийн тойрогт хамааралгүй л юм байна, та чинь Ф дүүрэгт оршин суудаг хүн байна. Шүүхийн харьяалал нь өөр байна, та гэхдээ нэгэнт шүүхийн шийдвэр гарчихсан учир биелүүлж л таарна” гэж хэлсэн.

Энэ дагуу би өмгөөлөгч Б.Э-д хандаж хууль зүйн зөвлөгөө авч Шүүхийн Ёс зүйн хороонд гомдол гаргах хөөн хэлэлцэх дуусаагүй байна гэдгийг олж илрүүлсэн.

Учир нь би шүүхийн шийдвэр гарсныг мэдээгүй байсан. Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 5.1-3-д заасан гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацаа өнгөрөөгүй байгаа.

Шүүгч Ж.С бид 2 машины наймаа хийж 5 сарын хугацаа өнгөрсний дараа шүүгч Ж.С намайг ажил дээрээ буюу К дүүргийн шүүх дээр дуудаад “машины наймаагаа буцаая ар талын хаалгаар нь шороо ороод байна, та надад 25 сая төгрөгийг минь буцааж өг, би танд хугацаа өгье, 8 сар гэхэд мөнгийг минь өг, хугацаа авахын тулд эвлэрүүлэн зуучлагч н.Т дээр манай авгайтай хамт оч, би ярьчихсан байгаа, өргөдлийг нь би бичээд өгчихсөн байгаа, тэгээд машинаа буцааж ав, тэр хооронд би зун хөдөө машинаа унаад Ш аймаг яваад ирье, мөнгөө олж бай, мөнгө өгөхгүй бол та яадгийг хараарай, би шүүгч хүн шүү гээд үнэмлэх үзүүлээд” дарамтлаад байсан. Би түүнд “чиний өгсөн Toyota Axio маркийн машиныг чинь буцааж өгнө, элэгдэл хорогдлоо тооцно” гэхэд та мөнгөө олчих гээд загнаад гаргаад явуулсан.

Ж.С-ийн зааж өгсөн Ө дүүрэг хариуцсан Б.Т гэгч эвлэрүүлэн зуучлагч дээр явж ороход тэнд Ж.С-ийн эхнэр О.Э ирчихсэн намайг хүлээж байгаа бололтой сууж байсан. Эвлэрүүлэн зуучлагч надад Ж.С-ийн өөрийн гараар бичсэн өргөдлийг үзүүлсэн. Туслах ажилтнаараа эвлэрлийн гэрээ бичээд ир гээд бид 2-ын иргэний үнэмлэхийг авч өгөөд гаргасан. Туслах ажилтан нь эргэж орж ирээд “энэ хүн чинь Ф дүүргийн хүн байна, болохгүй юм байна” гэхэд эвлэрүүлэн зуучлагч “шүүгч хэлсэн юм аа, Ө дүүргээр хаягийг биччих” гээд буцаагаад явуулсан. Туслах ажилтан эвлэрлийн гэрээ бичээд ирсэн. Уг эвлэрлийн гэрээн дээр намайг машинаа буцааж авах талаар бичээгүй, миний хаяг Ф дүүрэг болохоор гэрээний ар талд миний иргэний үнэмлэхийг хуулбарлаагүй байсан ба энэ талаар асуухад “шүүгч тэгж өргөдөл бичсэн байна та 2 чинь тэгж тохирсон юм биш үү, гарын үсгээ зур” гээд албадан гарын үсэг зуруулсан.

Хэд хоногийн дараа би Ж.С-ийн эхнэр О.Э руу утасдаж “би машинаа авч зарж байж мөнгөө өгнө” гэхэд “би мэдэхгүй, манай нөхөртэй ярь, нөхөр л мэднэ” гээд байсан. Нөхөртэй нь ярихаар “дуугүй мөнгөө олоод ир” гээд загнаад байсан. Одоо машиныг шүүгч Ж.С унаж эзэмшиж байгаа. Ж.С-ийн хийлгэсэн Эвлэрлийн гэрээ, гаргуулсан 2 удаагийн шүүгчийн захирамжаар уг автомашин миний эзэмшилд ирэх ёстой юм шиг байгаа юм. Гэтэл Ж.С надад өгдөггүй, заруулдаггүй, өөрөө унаж эзэмшээд яваад байдаг. Надаас болохоор мөнгө нэхээд яваад байгаа.

ПКӨ дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Д.Н-ийн 2016 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 102/Ш32016/07273 дугаартай Талуудын эвлэрлийг баталгаажуулах тухай захирамж, Ө дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч С.О-ийн 2016 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 184/Ш332016/02890 дугаартай Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх тухай захирамж зэргийг гарсныг, шүүх хянан шийдвэрлэснийг би огт мэдээгүй. Сая

2016.11.21-ний өдөр шийдвэр гүйцэтгэгч н.У-аас мэдэж хуулбарлаж авсан. Шүүхийн шийдвэрүүд гаргах гэж байна гэж надад огт мэдэгдээгүй, шийдвэрийг би гардаж хүлээж аваагүй. Одоо бодох нээ шүүгч Ж.С өөрийн ажилладаг шүүхийн эвлэрүүлэн зуучлагч дээр намайг өөр дүүргийн хүн болгож гэрээн дээр бичүүлж оролцсоноос, шүүхээс хууль бус шийдвэрүүдийг гаргуулснаас бүх шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг би мэдээгүй өнгөрсөн байна. Надад шүүх мэдэгдэх боломжгүй болгосон байна.

Би Ф дүүргийн 15-р хороо, 13-хороолол, 6/1 байрны 3 тоот хаалганд оршин суудаг. Энэ хаягтаа 15 жил оршин сууж байгаа. Би эвлэрлийн гэрээ, шүүхийн шийдвэрүүдэд заасан Ө дүүрэг 18-р хороо, 6-р байрны 13 тоотод оршин суудаггүй.

Шүүгч Ж.С нь надад өгсөн Toyota Axio маркийн автомашин, 15 сая төгрөгөө, надаас авсан RAW-4 маркийн машинаа, одоо авна гээд байгаа 25 сая төгрөг зэргээ хөрөнгө орлогын мэдүүлэгтээ үнэн зөв мэдүүлсэн эсэхийг, мөн уг мөнгө, эд хөрөнгийг олсон эх сурвалжийг нь шалгуулах хүсэлт гаргаж байна.

Дээрх үйлдлээрээ шүүгч Ж.С нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.6 дахь хэсэг, 27 дугаар зүйлийн 27.1.8 дахь хэсэг 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийг ноцтой зөрчсөн гэж үзэж байна.

Шүүгч Ж.С нь Ф дүүрэгт оршин суудаг хүнийг өөрийн ажилладаг байсан Ө дүүргийн шүүхийн Эвлэрүүлэн зуучлагчаар худал хаяг тавиулж харьяаллыг зөрчүүлсэн, өөрийн гараар эвлэрүүлэн зуучлагчид өргөдөл бичиж өгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гуравдагч этгээдээр оролцсон, иргэн З.А, би Ф дүүрэгт оршин суудаг байхад шүүгч ажил албан тушаалаа урвуулан ашиглаж шүүхийн харьяалал зөрчүүлж өөрийн хамт ажилладаг шүүгч Д.Н, С.О нараар шүүхийн шийдвэр хууль бусаар гаргуулсан. Шүүгч Д.Н, С.О нар надад юун тухай шийдвэр захирамж гаргах гэж байгаа тухай огт мэдэгдээгүй, гаргасан шийдвэрийг нь би ч гардаж хүлээж аваагүй. Гэнэт л шийдвэр гүйцэтгэгч дуудахаар нь 2016 оны 11 дүгээр сарын 21-ны өдөр очиход 2 ч шүүхийн шийдвэр гаргачихсан, оччихсон байсан.

Шүүгч Ж.С-ийн 1.5 жил унаж эдэлсэн, шороо тоос орсон гээд байгаа түүнд худалдсан RAW-4 маркийн машинаа би эргүүлж авахгүй. Өгөх ч үгүй байгаа. Шүүгч Ж.С нь хууль дүрмээ ноцтой зөрчсөнөөс иргэн надад 25 сая төгрөг төлөх гэм хор учраад байна. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт шүүгчийн гэм буруутай үйлдлээс бусдад учирсан гэм хорыг төр арилгана гэж заасан байна. Төр хариуцна уу, шүүгч Ж.С нь худалдаж авсан машинаа тэр чигт нь авч шийдвэр гүйцэтгэл дээр төлбөрөө авсан гэж бичиж өгнө үү энэ бүхэн хууль дүрмийнхээ дагуу үнэн шударгаар байгаасай гэж хүсэж байна.

Дээр дурдсан үйлдэл эс үйлдэхүйгээрээ Шүүгч Ж.С нь хувийн амьдралдаа баримтлах зарчим, даган биелүүлэх хэм хэмжээг тодорхойлж зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх /Дүрмийн 1.1, 1.3/ зэрэг зарчмуудыг баримтлалгүй, Шүүгч нь бусад шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно. /дүрмийн 4.1-2, 4.2, 4.2.5, 4.5.1 гэсэн заалтуудыг зөрчсөн. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.1, 37 дугаар зүйлийн 37.1.3 дахь хэсэгт заасан сахилгын шийтгэл ногдуулж өгнө үү.” гэжээ.

Шүүгч Ж.С-д гомдолтой танилцаад Шүүхийн Ёс зүйн хороонд ирүүлсэн тайлбартаа: “... би эхнэр О.Э-ийн хамт гэр бүлийн хэрэгцээнд З.А-аас ...ХХХ улсын дугаартай Toyota RAW-4 маркийн машиныг 2015 оны 08 дугаар сарын 05-ны өдөр 25.000.000 төгрөгөөр худалдаж авсан бөгөөд О.Э-ийн өмчлөлийн Toyota Axio маркийн автомашиныг 10.000.000 төгрөгт тооцож, 15.000.000 төгрөгийг бэлнээр З.А-д өгсөн. Уг автомашиныг худалдахдаа “бараг шинэ, аваар осолд орж байгаагүй” гэсэн.

Ингээд уг автомашиныг унаад Ш аймаг, А хотын хооронд 2015 оны 08 дугаар сарын 10-ны өдрөөс 2015 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн хооронд яваад ирэхэд автомашины салонд маш их тоос шороо орж ирсэн тул авто засварын газарт үзүүлэхэд "... авар осолд орсны улмаас хойд талын бензиний банк нь базсан лааз шиг болсон, моторт задаргаа орсон, автомашины кузов бүтэн гажсан, бүтэн замаск, будаг хийлгэсэн байгаа учир шороо тоос орсон..." гэснийг З.А-д 2015 оны 9 дүгээр сарын 01-ны өдөр мэдэгдэж, З.А болон эхнэр О.Э нар 2015 оны 9 дүгээр сарын 01-ны өдөр тохиролцож, өгсөн авсан зүйлээ буцаахаар болсон. Гэхдээ З.А "...төлбөрт тооцон авсан Toyota Axio маркийн автомашиныг зараад оронд нь Land cruiser 100 маркийн автомашиныг авсан, буцааж өгөх боломжгүй байна. 2015 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл хугацаа өгвөл, энэ автомашиныг зараад 25.000.000 төгрөгийг буцааж өгөөд Toyota RAW-4 маркийн машинаа буцааж авъя" гэсэн хүсэлт гаргасныг хүлээн зөвшөөрч 2015 оны 9 дүгээр сарын 01-ны өдөр хэлцэл байгуулж, 2015 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл хугацаа олгосон.

О.Э нь З.А-тай 2015 оны 11-р сарын 30-ны өдрөөс хойш утсаар холбогдож, асуухад "түр хүлээж бай", сүүлдээ утсаа авахгүй болсон тул эвлэрүүлэн зуучлалд 2016 оны 01-р сарын 15-ны өдөр хандсан. Ингээд эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад З.А-ийн "...надад мөнгө байхгүй, 2016 оны 8-р сарын 01-ний өдөр хүртэл хугацаа олгоно уу, наадмын үеэр автомашин сайн зарагддаг тул Land cruiser 100 маркийн автомашиныг зарсны дараа мөнгийг буцаан өгье" гэсэн хүсэлтийг мөн хүлээн зөвшөөрч хугацаа олгож, О.Э, З.А нар 2016 оны 1-р сарын 28-ны өдөр эвлэрлийн гэрээ байгуулж, шүүхээр баталгаажуулсан. З.А нь 2016 оны 8-р сарын 01-ны өдрөөс хойш утсаа салгаад, холбогдох боломжгүй болсон тул О.Э Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай хүсэлт гаргаж шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байгаа.

Дээрх үйл баримтын хүрээнд шүүгч Ж.С нь З.А-ийн гомдолд дурдсанаар ёс зүйн зөрчил, зохисгүй байдал гаргаагүй бөгөөд гэр бүлийн гишүүн болох эхнэр О.Э-д хууль зүйн зөвлөгөө өгч, баримт бичиг боловсруулахад нь тусалж, гэр бүлийн хамтран өмчлөх эд хөрөнгийг эрхлэн хамгаалах эрхээ Шүүгчийн Ёс зүйн дүрмийн хүрээнд хэрэгжүүлсэн болно.

З.А-ийн гомдолд "... шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг алдагдуулж, мэргэжлийн нэр хүндээ үл эрхэмлэн эвлэрүүлэн зуучлагч, шүүгчид хөндлөнгөөс нөлөөлж, хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгээ худал мэдүүлж, бусдад өгөх ёстой авто машиныг буцаан өгөхгүй байх, бусдыг дарамталж эвлэрлийн гэрээ албадан байгуулж шүүхийн шийдвэр хууль бусаар гаргуулсан" гэсэн, "... шүүгч Ж.С нь наймаа хийснээс хойш 5 сарын дараа намайг ажил дээрээ буюу К дүүргийн шүүхэд дуудаж, машины наймаагаа буцаая, 25 сая төгрөг буцааж өг, би танд хугацаа өгье, 8 сар гэхэд мөнгийг өг, хугацаа авахын тул эвлэрүүлэн зуучлагч дээр манай авгайтай оч, би ярьсан байгаа, өргөдлийг нь бичээд өгсөн, тэр хооронд би зун машинаа унаад хөдөө Ш аймаг яваад ирье, мөнгө олж бай, мөнгө өгөхгүй бол та яадгийн хараарай, би шүүгч хүн шүү гээд үнэмлэхээ үзүүлээд дарамталсан, Toyota Axio маркийн автомашиныг чинь буцааж өгнө гэхэд загнаад гаргаад явуулсан" гэж үндэслэлгүй, худал тайлбар гаргаж Ж.С-ийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон байна.

1.Ж.С миний бие шүүгчийн үнэмлэхээ З.А-д үзүүлэх байтугай гэр бүлийн гишүүдээс өөр хэн нэгэнд үзүүлээгүй, биедээ ч авч явдаггүй. Мөн шүүгчийн албан тушаал эрхэлдэг болохыг хүнд мэдэгдэхгүй байхыг хичээдэг ба шүүгчийн албан тушаал эрхэлдэг болохыг гомдолд дурдсанаар З.А-д хэлээгүй, мэдэгдээгүй болно.

2.Ж.С нь З.А-г ажил дээрээ дуудаж уулзаагүй. /Байгууллагын камераас үзэх боломжтой/. Түүнтэй 3 удаа уулзсан. Эхнэр О.Э-тэй автомашин худалдан авах, буцаахаар тохиролцох үед Ингэж уулзалдах үед бид хэрэлдэж, маргалдаагүй,

гомдолд дурдсанаар "... би шүүгч байна, мөнгөө өгөхгүй бол яахыг хараарай" гэх зэргээр Ж.С нь балмад, ёс зүйгүй үйлдэл хэзээ ч гаргаагүй, гаргах ч үгүй.

3. Уг автомашиныг 2015 оны 8 дугаар сарын 05-ны өдөр худалдан аваад, Ж.С нь гэр бүлийн хамт уг машинаар Ш аймаг яваад ирэхдээ автомашины доголдлыг олж мэдээд 2015 оны 9 дүгээр сарын 01-ны өдөр З.А-д энэ талаар мэдэгдэж, талууд энэ өдрөө гэрээгээ цуцалж, өгсөн авснаа буцаахаар тохирсон. Гэтэл гомдолд "... 5 сарын дараа намайг ажил дээрээ буюу К дүүргийн шүүхэд дуудаж машины наймаагаа буцаая, 25 сая төгрөг буцааж өг, би танд хугацаа өгье, 8 сар гэхэд мөнгийг өг, хугацаа авахын тулд эвлэрүүлэн зуучлагч дээр манай авгайтай оч, би ярьсан байгаа, өргөдлийг нь бичээд өгсөн, тэр хооронд би зун машинаа унаад хөдөө Ш аймаг яваад ирье, мөнгө олж бай, мөнгө өгөхгүй бол та яадгийг хараарай, би шүүгч хүн шүү" гэх зэргээр огт үндэслэлгүй, худал зүйл зохион бичиж, гүтгэн доромжилж байгаа болох нь талуудын хооронд байгуулсан гэрээ, хэлцэл, эрхийн акт, түүнд бичигдсэн тайлбар зэргээр нотлогдоно.

4. Ж.С нь гомдолд дурдсанаар эвлэрүүлэн зуучлагч, шүүгч нарт нөлөөлөх ямар нэгэн үйлдэл гаргаагүй бөгөөд ёс зүйн дүрэм болон холбогдох хуулийг зөрчөөгүй, хөрөнгө орлогын мэдүүлгээ хуульд заасан журмын дагуу мэдүүлсэн байгаа,

Ж.С нь шүүгч албан үүргээс бусад үйл ажиллагаанд хувийн амьдралдаа шүүгчийн баримтлах ёс зүй, зарчим, даган биелүүлэх хэм хэмжээг зөрчөөгүй болно." гэжээ.

Эвлэрүүлэн зуучлагч Б.Т тайлбартаа: "ПКӨ дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх дэх эвлэрүүлэн зуучлалд 2016 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр өргөдөл гомдлын бүртгэлийн 107 дугаарт бүртгэгдсэн О.Э-ийн өргөдөл эвлэрүүлэн зуучлагч Б.Т-д хуваарийн дагуу хуваарилагдаж ирсэн байна.

Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад уригдах тал З.А-тай6504 дугаарын утсаар холбогдож, уулзалтад биеэр оролцох товыг талуудад мэдэгдэж 2016 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр, машин ба төлбөрийн талаар талууд харилцан ярилцаж тохирч сайн дурын үндсэн дээр эвлэрлийн 60 дугаар бүхий гэрээг байгуулсан. Уг эвлэрлийн гэрээг тус шүүхийн шүүгчийн 2016 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 07273 дугаар бүхий захирамжаар баталгаажуулсан болно.

Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд өргөдөл гаргагч О.Э, уригдсан тал З.А нар өөрийн биеэр оролцож, тайлбараа бичгээр гаргаж өгсөн болох нь материалд хавсаргасан баримт, уулзалтын тэмдэглэлээс харагдана. З.А нь уулзалтын явцад өөрийн оршин суугаа хаягаа шилжилт хөдөлгөөн хийгдээгүй, Ө дүүрэг, 18 дугаар хороо, 6-р байрны 13 тоот гэж уулзалт хийхийг зөвшөөрч, бичиг баримтаа маргааш авч ирж өгнө гээд өгөөгүйгээс шүүхэд материалыг шилжүүлсэн. Тухайн үед шүүгч Ж.С ажиллагаанд нөлөөлөөгүй, эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хуульд заасны дагуу явагдсан гэж үзнэ гэжээ. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны 2016 оны 15-ны өдрийн 107 дугаар хавтаст хэргийн хуулбарыг хавсаргасан байна." гэжээ.

Шүүгч С.О-ийн туслах Д.Л ирүүлсэн тайлбартаа: "ПКӨ дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх дэх Эвлэрүүлэн зуучлалын Эвлэрлийн гэрээ байгуулсан материалыг Ө дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч С.О нь 2016 оны 08 дугаар сарын 22-ны өдөр хүлээн авч, 2016 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 02890 дугаар шүүгчийн захирамжаар гүйцэтгэх хуудас бичсэн байна. Гүйцэтгэх хуудсыг 2016 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр хүлээлгэн өгсөн болно." гэжээ.

Шүүгч Д.Н туслах Ц.Э гаргасан тайлбартаа: "ПКӨ дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн туслах Ц.Э миний бие 2016 оны 02 дугаар сарын 02-ны өдөр тус шүүхийн Эвлэрүүлэн зуучлалаас ирүүлсэн 2016 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 60 дугаартай О.Э-ийн өргөдөлтэй, эвлэрэлд уригдсан тал З.А нарын хооронд байгуулсан эвлэрлийн гэрээг хүлээн авч хуульд заасны дагуу

шүүгчийн захирамжийн төсөл боловсруулан шүүгч Д.Н-д танилцуулснаар 2016 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 102/Ш32016/07273 дугаар талуудын эвлэрлийг баталгаажуулах тухай шүүгчийн захирамж гарсан. Ингээд мөн өдөр тус шүүхийн эвлэрүүлэн зуучлагчид хүлээлгэн өгсөн болно.” гэжээ.

Эвлэрүүлэн зуучлагчийн туслах Х.Н ирүүлсэн тайлбартаа: “ПКӨ дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх дэх Эвлэрүүлэн зуучлалд 2016 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр хүлээн авч, Эвлэрлийн гэрээ байгуулсан материалыг Ө дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч С.О нь 2016 оны 8 дугаар сарын 22-ны өдөр хүлээн авч, 2016 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн 02890 дугаар шүүгчийн захирамжаар гүйцэтгэх хуудас бичсэн байна. Гүйцэтгэх хуудсыг 2016 оны 9 дүгээр сарын 07-ны өдөр хүлээлгэн өгсөн болно.

Шүүгч Д.Н-ийн 2016 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 7273 дугаартай эвлэрлийн гэрээг баталгаажуулсан захирамжийг уригдсан тал З.А-д гардуулахаар 2016 оны 3 дугаар сарын 10, 17-ны өдрүүдэд ...6504 дугаарын утас руу залгахад утсаа аваагүй тул захирамжийг гардуулан өгөөгүй болно.” гэжээ.

Шүүгч Ж.С-ийн эхнэр О.Э тайлбартаа: “...З.А-аас Toyota RAW-4 машиныг гэр бүлийн хэрэгцээнд 2015 оны 8-р сарын 05-ний өдөр 25.000.000 төгрөгөөр худалдаж авахдаа гэр бүлийн дундын хөрөнгө болох Toyota Axio маркийн машиныг 10.000.000 төгрөгт тооцож, 15.000.000 төгрөгийг бэлнээр З.А-д өгсөн. З.А нь Toyota RAW-4 машинаа зарахдаа осол аваарт ороогүй гэсэн боловч худалдаж авсны дараа хөдөө яваад ирэхэд тоос шороо салонд орж ирээд байсан тул автомашины засварын газар үзүүлэхэд уг машиныг осол аваарт орсны улмаас бүтэн будаг, засвар хийлгэсэн, машины хойд талаас их хүчтэй мөргүүлсэн байна гэсэн.” З.А-д энэ тухайгаа мэдэгдэж бид хоёр 2015 оны 9-р сарын 01-ны өдөр өгсөн авсан зүйлээ буцаахаар тохирсон. Тухайн үед би өөрийн Toyota Axio маркийн машинаа буцааж авъя гэхэд З.А хүнд зараад оронд нь Ланд Круйзер маркийн машин авсан. Энэ машинаа зараад 25.000.000 төгрөгийг буцааж өгье, надад хугацаа өгөөч би 2016 оны 8-р сарын 01-ны өдөр гэхэд мөнгийг төлж барагдуулна гэсэн тул түүнд итгээд хугацаа олгож, бид эвлэрлийн гэрээ байгуулж эвлэрүүлэн зуучлалаар орсон. “...З.А нь 2016 оны 8-р сарын 01-ний өдөр гэхэд миний мөнгийг өгөөгүй бөгөөд утсаа салгаад холбогдохгүй алга болсон тул шийдвэр гүйцэтгэлд хандсан боловч одоог хүртэл төлбөрөө төлөөгүй л байгаа.”

З.А нь уг төлбөрөө төлөхөөс зайлсхийж, Шүүхийн Ёс зүйн хороонд үнэнд нийцэхгүй худал, тайлбар, гомдол гаргасан байна. Миний нөхөр Ж.С нь З.А-д шүүгчээр ажилладаг талаар хэлж байгаагүй, З.А-ийн гомдолд дурдсанаар түүнийг сүрдүүлж, дарамтлаагүй бөгөөд З.А нь огт үндэслэлгүй, худал зүйл бичиж миний нөхөр Ж.С-г гүжирдэж, гүтгэсэн байна.

Би нөхрийнхөө хамт З.А-тай өмнө нь уулзахад бид ерөөсөө муудалцаагүй бөгөөд, З.А нь наймаагаа буцаана, 25.000.000 төгрөгийг өгөөд машинаа буцааж авна гэж тохирсон атлаа, одоо төлбөр төлөхөөс зайлсхийхийн тулд ийм зүйл бичсэн байна. Миний нөхөр Ж.С нь гэр бүлийн дундын эд хөрөнгөө хамгаалахын тулд надад хууль зүйн зөвлөгөө өгч, баримт бичиг боловсруулахад тусалсан нь шүүгчийн ёс зүйн зөрчил гаргаагүй гэж бодож байна.” гэжээ.

Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны Ө дүүргийн 129 дүгээр тойргийн шийдвэр гүйцэтгэгч Э.У Шүүхийн Ёс зүйн хороонд өгсөн тайлбар: “... Захирамжтай хамт гүйцэтгэх хуудас ирэхдээ Ө дүүргийн 18 дугаар хорооны харьяалалтай ирсэн. Уг хаяг дээр нь очиход хүн байхгүй байсан. Иймд өөрийнхөө холбогдох утсаа хаалганд нь наагаад явсан түүнээс хойш тэр өдрийн орой нэг хүн залгаад энэ байранд би 7-8 жил амьдарч байна. Тийм айл байхгүй гэж хэлсэн тул төлбөр авагч О.Э-тэй утсаар ярьж З.А-ийн эхнэрийн утсыг авч түүгээр дамжуулан З.А-тай холбогдсон.

"... Манайд гаргасан хүсэлтэд төлбөр төлөгчийн холбоо барих утас, хаяг тодорхой бус байсан тул мэдэх утсыг нь авсан. О.Э-аас яагаад Ө дүүргийн хаягтай байсан юм бэ гэхэд хариу хэлдэггүй юм. О.Э Ө дүүргийн харьяалалгүй гэдгийг сайн мэдэж байсан.

Ажиллагааны явцад Ф дүүргийн харьяалалтай болох нь тогтоогдсон. Улсын бүртгэлд бүртгэгдсэн 15 дугаар хороондоо бүртгэлтэй боловч түүндээ оршин суудаггүй. Ф дүүргийн 25 дугаар хорооны 83 дугаар байранд одоо амьдардаг..." гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 20 дугаар тогтоолоор шүүгч Ж.С-д сахилгын хэрэг үүсгэж шийдвэрлэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдаанаар гомдлыг хэлэлцээд ҮНДЭСЛЭХ нь:

К дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ж.С "...шүүгч хүний хувийн амьдралдаа баримтлах зарчмыг зөрчиж Шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг алдагдуулж мэргэжлийн нэр хүндээ үл эрхэмлэн эвлэрүүлэн зуучлагч бусад шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шууд хөндлөнгөөс оролцон нөлөөлж, хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгээ худал мэдүүлж, эвлэрүүлэн зуучлагчид албан үүрэгт нь хамааралгүй даалгавар өгч, хувийн ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж, өөрийн эхнэртээ хууль зүйн зөвлөгөө өгч баримт бичиг өөрийн гараар бичиж боловсруулан бичиж өгч, бусдад эргүүлэн өгөх ёстой эд хөрөнгө болох автомашиныг өгөхгүй байх, бусдыг дарамталж худал хэлж эвлэрлийн гэрээ албадан байгуулж шүүхийн шийдвэрийг хууль бусаар гаргуулсан" гэх агуулгатай гомдлыг З.А Шүүхийн Ёс зүйн хороонд гаргажээ.

Нэг. "Шүүгч Ж.С намайг ажил дээрээ буюу К дүүргийн шүүх дээр дуудаад "машины наймаагаа буцаая ар талын хаалгаар нь шороо ороод байна, та надад 25 сая төгрөгийг минь буцааж өг, би танд хугацаа өгье, 8 сар гэхэд мөнгийг минь өг, хугацаа авахын тулд эвлэрүүлэн зуучлагч н.Т дээр манай авгайтай хамт оч, би ярьчихсан байгаа, өргөдлийг нь би бичээд өгчихсөн байгаа, тэгээд машинаа буцааж ав, тэр хооронд би зун хөдөө машинаа унаад Ш аймаг яваад ирье, мөнгөө олж бай, мөнгө өгөхгүй бол та яадгийг хараарай, би шүүгч хүн шүү гээд үнэмлэх үзүүлээд дарамтлаад байсан" гэж гомдолд бичсэн ч энэ тухай нотлох баримт гаргаж өгөөгүй бөгөөд шүүгч Ж.С үүнийг үгүйсгэсэн тайлбар ирүүлсэн. Шүүгч Ж.С нь З.А-г К дүүргийн шүүх дээр дуудаж уулзсан, ийм агуулгатай зүйл хэлсэн, шүүгчийн үнэмлэхээ үзүүлсэн гэсэн нь нотлогдохгүй байна.

Гомдол шалгагч Н.Г тус шүүхийн 2016 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн Шүүхийн байрны гадна болон дотор камерын бичлэгийг авахаар Тамгын газрын Зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн Г.О-оос асуухад "7 хоногийн бичлэгийг гаргаж өгөх боломжтой, түүнээс өмнөх боломжгүй хард нь дүүрээд автоматаар бичлэг устаад явдаг." гэжээ.

Хоёр. "Шүүгч Ж.С ...эвлэрүүлэн зуучлагчид ...шууд хөндлөнгөөс оролцож нөлөөлсөн, ...эвлэрүүлэн зуучлагчид албан үүрэгт нь хамааралгүй даалгавар өгсөн, ...эвлэрүүлэн зуучлагчаар худал хаяг тавиулж харьяаллыг зөрчүүлсэн" гэж гомдолд бичсэн нь нотлогдохгүй байна. Эвлэрүүлэн зуучлалд гаргасан О.Э-ийн анхны өргөдөлд /сахилгын хэргийн 25 хуудас/ иргэн З.А-ийн оршин суугаа хаягийг Ө дүүргийн 18 дугаар хороо 6 дугаар байр 13 тоот гэж буруу хаяг бичсэнийг шүүгч Ж.С үгүйсгэхгүй байгаа боловч энэ нь шүүгч Ж.С эвлэрүүлэн зуучлагчид нөлөөлснийг нотлохгүй юм. 2016 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 60 дугаартай эвлэрлийн гэрээ нь хаягийн зөрчилтэй байхад үүнийг нягтлан шалгаагүй, залруулаагүй гарын үсэг зурсан Эвлэрүүлэн зуучлагч Б.Т-ийн үйл ажиллагаатай холбоотой гомдлыг гаргах эрх нь гэрээний аль ч талд нээлттэй байна. Нөгөө талаар, энэхүү

эвлэрлийн гэрээнд З.А өөрөө гарын үсэг зурсан байх бөгөөд үүнийгээ үгүйсгэхгүй байна. Шийдвэр гүйцэтгэгч Э.У-ийн тайлбарт "... О.Э-аас яагаад Ө дүүргийн хаягтай байсан юм бэ гэхэд хариу хэлдэггүй юм. О.Э Ө дүүргийн харьяалалгүй гэдгийг сайн мэдэж байсан" гэсэн нь шүүгч Ж.С-г буруутгах үндэслэл болохгүй. Учир нь, эвлэрлийн гэрээнд шүүгч Ж.С бус харин түүний эхнэр О.Э гарын үсэг зуржээ. Иймд, эвлэрлийн гэрээнд буруу хаяг бичигдсэнд шүүгч Ж.С-г буруутгах үндэслэл байхгүй байна.

Гурав. "Шүүгч Ж.С ...бусад шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шууд хөндлөнгөөс оролцон нөлөөлсөн," "... иргэн З.А, би Ф дүүрэгт оршин суудаг байхад шүүгч ажил албан тушаалаа урвуулан ашиглаж шүүхийн харьяалал зөрчүүлж өөрийн хамт ажилладаг шүүгч Д.Н, С.О нараар шүүхийн шийдвэр хууль бусаар гаргуулсан." гэж гомдолд бичсэн нь нотлогдохгүй байна.

ПКӨ дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Д.Н-ийн 2016 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 102/ШЗ2016/07273 дугаартай Талуудын эвлэрлийг баталгаажуулах тухай захирамж, Ө дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч С.О-ийн 2016 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 184/ШЗ32016/02890 дугаартай Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх тухай захирамж тус тус гаргасан байна. Гэвч, эдгээр захирамжийг гаргахад шүүгч Ж.С нөлөөлсөн гэдгийг нотлох баримт байхгүй байна.

Дөрөв. Гомдолд "Шүүгч Ж.С ... өөрийн эхнэртээ хууль зүйн зөвлөгөө өгч баримт бичиг өөрийн гараар бичиж боловсруулан бичиж өгсөн, ...Эвлэрүүлэн зуучлалд өөрийн гараар өргөдөл бичиж өгсөн" гэжээ. Шүүгч Ж.С "Гэр бүлийн дундын өмч болох хөрөнгийг хамгаалах талаар эхнэр О.Э-д зөвлөгөө өгөх, баримт бичиг боловсруулахад туслах нь шүүгчийн ёс зүйн дүрэм зөрчөөгүй," түүний эхнэр О.Э "Миний нөхөр Ж.С нь гэр бүлийн дундын эд хөрөнгөө хамгаалахын тулд надад хууль зүйн зөвлөгөө өгч, баримт бичиг боловсруулахад тусалсан" гэх тайлбаруудыг гаргасан байна. Шүүгч Ж.С эхнэр О.Э-дээ хууль зүйн зөвлөгөө өгсөн, бичиг баримт боловсруулахад тусалсан нь шүүгч Ж.С, түүний эхнэр О.Э нарын тус тусын тайлбараар нотлогдож байгаа боловч энэ үйлдэл нь шүүгчийн ёс зүйн зөрчил болохгүй. Учир нь, Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 4.2 дугаар зүйлийн 5-д "Шүүгч нь өөрийн хамаарал бүхий этгээддээ хууль зүйн зөвлөгөө өгөх, баримт бичиг боловсруулах, хянах ажиллагаа явуулж болох боловч тэдгээрийн хуульчаар ажиллаж болохгүй" гэж заасан. Шүүгч Ж.С өөрийн эхнэр О.Э-г шүүх эсхүл эвлэрүүлэн зуучлагчийн өмнө төлөөлөх зэргээр түүний хуульчаар ажилласан гэдэг нь нотлогдохгүй байна.

Тав. "Шүүгч Ж.С нь хууль дүрмээ ноцтой зөрчсөнөөс иргэн надад 25 сая төгрөг төлөх гэм хор учраад байна" гэх гомдол нь үндэслэлгүй байна. Учир нь, иргэн О.Э, иргэн З.А нарын 2016 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр байгуулан баталгаажуулсан 60 дугаартай эвлэрлийн гэрээний үр дүнд шүүгчийн эвлэрлийг баталгаажуулах, иргэн О.Э-ийн хүсэлтээр шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай захирамж гарч шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах болсон нь шүүгч Ж.С-д хамааралгүй байна.

Зургаа. "Шүүгч Ж.С нь надад өгсөн Toyota Axio маркийн автомашин, 15 сая төгрөгөө, надаас авсан RAW-4 маркийн машинаа, одоо авна гээд байгаа 25 сая төгрөг зэргээ хөрөнгө орлогын мэдүүлэгтээ үнэн зөв мэдүүлсэн эсэхийг, мөн уг мөнгө, эд хөрөнгийг олсон эх сурвалжийг нь шалгуулах хүсэлт гаргаж байна" гэж гомдолд бичжээ. Шүүгч Ж.С Авлигын эсрэг хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шүүгчийн ёс зүйн дүрэмд заасан хөрөнгө орлогын мэдүүлгээ үнэн зөв мэдүүлэх үүргээ биелүүлээгүй ёс зүйн зөрчил гаргасан нь дараах байдлаар нотлогдож байна.

Шүүгч Ж.С эхнэр О.Э-ийн хамт гэр бүлийн хэрэгцээнд З.А-аас-XXX улсын дугаартай Toyota RAW-4 маркийн машиныг 2015 оны 08 дугаар сарын 05-ны өдөр 25.000.000 төгрөгөөр худалдаж авсан бөгөөд О.Э-ийн өмчлөлийн Toyota Axio маркийн автомашиныг 10.000.000 төгрөгийн төлбөрт тооцож, бэлнээр 15 сая төгрөгийн хамт З.А-д шилжүүлсэн нь Худалдах, худалдан авах гэрээг цуцлах тухай 2015 оны 09 дүгээр сарын 01 -ний өдрийн О.Э болон З.А нарын гарын үсэг зурж тохиролцсон бичиг (хэлцэл), 2016 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр ПКӨ дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх дэх Эвлэрүүлэн зуучлагчид гаргасан О.Э-ийн өргөдөл, 2016 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны уулзалтын тэмдэглэл, 2016 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр байгуулан баталгаажуулсан 60 дугаартай эвлэрлийн гэрээ, гомдол гаргагч З.А-ийн 2016 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн гомдол, шүүгч Ж.С-ийн 2016 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн тайлбар, О.Э-ийн 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн тайлбар зэрэг нотлох баримтаар тогтоогдож байна.

Шүүгч Ж.С “Албан тушаалтны 2015 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг”-ийг бичгээр үйлдэж, “мэдүүлгийг үнэн зөв мэдүүлсэн” хэмээн 2016 оны 02 дугаар сарын 01-ны өдөр гарын үсэг зуржээ. Шүүгч Ж.С энэхүү мэдүүлгийн 2 дугаар хуудаст эхнэр О.Э-ийн нэрийг бичиж, 6 дугаар хуудас дахь “Хөрөнгө борлуулсны орлого” хэсэгт “эхнэр О.Э-ийн эзэмшлийн Тоёота Аксио маркийн автомашиныг худалдаж, зөрүүлээд RAW-4 маркийн машин худалдаж авсан” гэж бичжээ. Мөн, мэдүүлгийн 8 дугаар хуудас дахь “3.2.2. Тээврийн хэрэгсэл” хэсэгт “Toyota RAW-4 2012.01.01” машиныг 30.000.000.0 төгрөгийн зах зээлийн үнэлгээтэй гэж бичсэн байх бөгөөд эх үүсвэрийн тайлбарт “Худалдаж авсан, 2015.09.22 өдөр эхнэр О.Э-ийн өмчлөлийн Toyota Axio маркийн автомашиныг 15 сая төгрөгөөр тооцож, эхнэр О.Э 15 сая төгрөгийн цалингийн зээл авч уг RAW-4 маркийн автомашиныг 30 сая төгрөгөөр худалдаж авсан” гэж бичжээ. Дээр дурдсанчлан RAW-4 маркийн автомашиныг 25 сая төгрөгөөр худалдан авсан боловч шүүгч Ж.С энэ машиныг 30 сая төгрөгөөр худалдан авсан хэмээн худал мэдүүлжээ. Шүүгч Ж.С-ийн 2015 оны үндсэн цалин, түүнтэй адилтгах орлого 34.417.088 төгрөг, сарын дундаж цалин 2.868.090 төгрөг байжээ. Түүний худал мэдүүлсэн 5 сая төгрөг нь түүний сарын цалингаас 1.74 дахин их байна.

Түүнчлэн, шүүгч Ж.С “Албан тушаалтны 2015 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг”-ийн 11 дүгээр хуудас дахь “3.2.8 Зээл” хэсэгт Хадам эцэг н.О-оос худалдан авсан орон сууцны үлдэгдэл 100.000.000 төгрөгийг зээлийн хүүгүйгээр 4 жилийн хугацаанд авсан тухайгаа бичсэн боловч RAW-4 маркийн автомашиныг худалдан авахад хэрэглэсэн гэх эхнэр О.Э-ийн 15 сая төгрөгийн цалингийн зээлийн талаар мэдүүлэгтээ бичээгүй байна. Эхнэр О.Э-ийн цалингийн зээл гэгдэх 15 сая төгрөг нь түүний сарын цалингаас 5.22 дахин их байх бөгөөд үүнийг мэдүүлгийнхээ зээл хэсэгт тайлбарлан бичээгүй байна.

RAW-4 маркийн автомашиныг худалдан авахад хэрэглэсэн 15 сая төгрөгийг эхнэрийнхээ цалингийн зээлээр авсан гэх боловч энэ зээлийг өгсөн зээлдүүлэгчийн нэр, хаяг, анх авсан зээлийн хэмжээ, тухайн жилд зээлийн хүүд төлсөн дүн, зээл авсан болон төлж дуусах огноо, зориулалт, зээлийн барьцаа батлан даагч гэсэн мэдээллийг мэдүүлэгтээ огт бичээгүй учраас энэ зээлийг мэдүүлсэн гэж үзэх үндэслэлгүй юм.

Шүүгч Ж.С RAW-4 маркийн автомашиныг худалдан авсан үнийн дүнгээ 5 саяар илүү мэдээлсэн, эхнэр О.Э-ийн 15 сая төгрөгийн цалингийн зээлийн талаар зохих ёсоор мэдүүлээгүй нь дараах хууль, журам, дүрэмд заасан хөрөнгө, орлогоо үнэн зөв мэдүүлэх үүргийг зөрчсөн:

1. Авлигын эсрэг хуулийн 10.2-т “Мэдүүлэг гаргагч нь өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлого, зээлийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй /Энэ хэсгийг 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/”

2. УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05-р тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журмын 4.4.2-т Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийнхээ “Хөрөнгө, зээл” хэсэгт “өөрийн болон гэр бүлийн гишүүдийн зээлийн талаарх мэдээллийг мэдүүлэх бөгөөд бусдаас зээлсэн бэлэн мөнгө, хөрөнгийн дүн, хугацаа, зээл, зээлийн хүүгийн дүн, зориулалтыг бичнэ;”¹

3. 2012 оны Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1- т “Шүүгч нь Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан журмын дагуу хөрөнгө орлогын мэдүүлэг, хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг үнэн зөв гаргаж өгөх үүрэгтэй;”

4. 2014 оны Монгол Улсын Шүүхийн Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 4.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгч нь өөрийн хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ холбогдох хууль тогтоомжид заасны дагуу үнэн зөв мэдүүлнэ;”

5. 2013 оны Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 16.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгч нь өөрийн хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгээ тогтмол, үнэн, зөв мэдүүлж, манлайлна.”

Түүнчлэн, RAW-4 маркийн автомашиныг худалдан авахад хэрэглэсэн 15 сая төгрөгийн эх үүсвэрийг тодорхой бичээгүй нь шүүгч Ж.С Авлигын эсрэг хуулийн 13.7-д “Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын эх үүсвэрээ бодитой, үнэн зөв тайлбарлах үүрэгтэй” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Бусад төрийн албан хаагчдаас өндөр ёс зүйн шаардлага биелүүлэх үүрэгтэйн хувьд шүүгч хүн Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар хүлээлгэсэн үүргээ зохих ёсоор бүрэн биелүүлэх замаар төрийн бусад албан хаагчдад үлгэр дуурайлал болох ёстой. Түүнчлэн Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд “төрийн улс төр, захиргаа, тусгай албан тушаалд байнга, эсхүл түр хугацаагаар томилогдсон” албан хаагч хамаарна гэж Авлигын эсрэг хуулийн 4.1-д заасан бөгөөд шүүгч нь төрийн тусгай албан тушаал хашиж буй тул энэ хуулийн үйлчлэлд хамаарна (2002 оны Төрийн албаны тухай хуулийн 8.1.1). Иймээс, бүх шүүгч хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах зэрэг энэ хуульд заасан үүргийг биелүүлж ирсэн.

Хэрэв шүүгч хөрөнгө, орлогын мэдүүлгээ үнэн зөв мэдүүлдэггүй бол уг шүүгчийг үнэнч, шударга, зарчимч зан чанартай эсэхэд төдийгүй хэрэг маргааныг хуулийн дагуу шийдвэрлэдэг эсэхэд олон нийт эргэлзэхэд хүрнэ. Өөрийн болон гэр бүлийн гишүүнийхээ хөрөнгө, орлого, зээлийг мэдүүлэх, түүний эх үүсвэрийг бодитой, үнэн зөв тайлбарлах талаар хуульд тодорхой заасан байхад, шүүгч үүргээ зөрчих нь шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг сэвтүүлсэн үйлдэл учраас бусдад материаллаг хохирол учруулсан эсхүл албан тушаалын гэмт хэрэгтэй холбоотой эсэхээс үл хамааран сахилгын шийтгэл хүлээлгэх үндэслэл болно.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35, 36 дугаар зүйл, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйл, Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5.7.1, 5.13 дах заалтыг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

¹ Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргагч нарт зориулсан гарын авлага, Эмхэтгэсэн: Б.Өлзий, Б.Эрдэнэцэцэг, Ц.Баасандэлгэр (Монгол Улсын Авлигатай тэмцэх газар, 2013), хуудас 54; Авлигын эсрэг эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл, Эмхэтгэсэн: Д.Цэнд-Аюуш, Л.Нарантуяа, Д.Балдандорж (Монгол Улсын Авлигатай тэмцэх газар, 2016), хуудас 367

1.К дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ж.С-д сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Энэ магадлалын хувийг шүүгч болон гомдол гаргагчид хүргүүлэхийг Ажлын алба /Н.Г/-д даалгасугай.

3.Шүүгч, гомдол гаргагч магадлалыг эс зөвшөөрвөл гардан авснаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ

Н.ЭРДЭНЭЦОГТ

ГИШҮҮН

О.МӨНХСАЙХАН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ
МАГАДЛАЛ

2017 оны 6 сарын 08 өдөр

Дугаар 221/ЁМ2017/0013

Улаанбаатар хот

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны
2017 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн
27 дугаар магадлалын тухай

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааныг шүүгч Г.Билгүүн даргалж, шүүгч Б.Тунгалагсайхан, шүүгч Э.Зоригтбаатар нарын бүрэлдэхүүнтэй, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Н.Батзориг, гомдол гаргагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч Б.Э нарыг оролцуулан хийж. Монгол Улсын Шүүхийн ёс зүйн хорооны 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн "К дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ж.С-д сахилгын шийтгэл ногдуулах тухай" 27 дугаар магадлалыг гомдол гаргагч З.А-ийн гаргасан давж заалдах гомдлоор шүүгч Э.Зоригтбаатарын илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 21 дугаар магадлалаар К дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ж.С-д сануулах сахилгын шийтгэл ногдуулжээ

Гомдол гаргагч З.А давж заалдах гомдолдоо: "... Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 27 дугаартай магадлалыг эс зөвшөөрч ёс зүйн хороонд гомдол гаргагч би дараах үндэслэлээр энэхүү гомдлыг гаргаж байна

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааны магадлалд К дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ж.С нь "... RAW-4 маркийн автомашиныг 25 сая төгрөгөөр худалдан авсан боловч шүүгч Ж.С энэ машиныг 30 сая төгрөгөөр худалдан авсан хэмээн худал мэдүүлжээ.

Шүүгч Ж.С-ийн 2015 оны үндсэн цалин түүнтэй адилтгах орлого 34,417.088 төгрөг сарын дундаж цалин 2,868,090 төгрөг байжээ. Түүний худал мэдүүлсэн 5 сая төгрөг нь түүний сарын цалингаас 1,74 дахин их байна. ...эхнэр О.Э-ийн 15 сая төгрөгийн цалингийн зээлийн талаар мэдүүлэгтээ бичээгүй байна. Эхнэр О.Э-ийн цалингийн зээл гэгдэх 15 сая төгрөг нь түүний сарын цалингаас 5,22 дахин их байх бөгөөд үүнийг мэдүүлгийнхээ зээл хэсэгт тайлбарлан бичээгүй байна ... шүүгч Ж.С RAW-4 маркийн автомашиныг худалдан авсан үнийн дүнгээ 5 саяар илүү мэдээлсэн, эхнэр О.Э-ийн 15 сая төгрөгийн цалингийн зээлийн талаар зохих ёсоор мэдүүлээгүй нь дараах хууль, журам, дүрэмд заасан хөрөнгө, орлогоо үнэн зөв мэдүүлэх үүргийг зөрчсөн шүүгч үүргээ зөрчих нь шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг сэвтүүлсэн үйлдэл учраас бусдад материаллаг хохирол учруулсан эсхүл албан тушаалын гэмт хэрэгтэй холбоотой эсэхээс үл хамааран сахилгын шийтгэл хүлээлгэх үндэслэл болно... гэсэн дүгнэлтийг хийсэн боловч иргэн З.А миний түүнд

2015 оны 8 дугаар сарын 05-ны өдөр өгсөн одоог хүртэл 1 жил 9 сарын хугацаанд унаж хэрэглэж байгаа 25 сая төгрөгийн үнэ бүхий RAW-4 маркийн автомашины талаар буюу надад учруулсан материаллаг хохирлын талаар ямар нэгэн дүгнэлт хийсэнгүй.

Одоог хүртэл энэ шүүгчээс машинаа авч чадахгүй хохирч байна. Хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх бид Үндсэн хуульдаа зарчимтай. Гэтэл энэ зарчим шүүгч хүнд үйлчилдэггүй юм байна Яагаад гэвэл шүүгч Ж.С автомашины наймаагаа буцаах болсон. Шүүгч Ж.С надад мэдэгдүүлэлгүй шүүхийн шийдвэр "намайг 25 сая төгрөг эхнэр О.Э-дээ төл" гэсэн шийдвэр гаргуулсан.

Буцаасан наймааныхаа зүйл болох автомашиныг надад буцааж өгөлгүй 2 жил шахам унаж хэрэглэж байгаа. Нэгэнт миний автомашиныг 2 жил шахам унаж хэрэглэсэн болохоор би одоо биетээр нь буцааж авах боломжгүй юм

Мөн Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүд "Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35, 36 дугаар зүйл, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйл, Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5.7.1, 5.13 заалтыг" тус тус хэрэглэж К дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ж.С-д сануулах сахилгын шийтгэл ногдуулсан боловч гомдол гаргагч би "огцруулах" шийтгэл ногдуулж өгнө үү гэж байхад сануулах шийтгэлийнхээ Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1 /сануулах/ дэх хэсгээ ч хэрэглэсэнгүй, мөн уг хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.3 /огцруулах/ дахь хэсгийг огт хэрэглэсэнгүй.

Шүүгч Ж.С нь Авлигын эсрэг хуулийн 10 2, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоол, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Монгол Улсын Шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 4.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 16.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн нь түүнийг шүүгчийн ажил албан тушаалаас огцруулах үндэслэл болно гэж үзэж байна.

Гомдлын шаардлага:

1.Буцааж өгнө гээд буцааж өгөхгүй 1.9 жил унаж хэрэглэж байгаа RAW-4 маркийн 2012 онд япон улсад үйлдвэрлэгдсэн, хар өнгийн, -XXX улсын дугаартай, суудлын зориулалттай, ...арлын дугаартай тээврийн хэрэгслийн бодит хохирол болох 25 сая төгрөгийг шүүгч Ж.С-ээс Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3.7 дахь хэсэгт зааснаар гаргуулж өгнө үү.

2.Ж.С-д Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37 1.3 дахь хэсэгт зааснаар огцруулах сахилгын шийтгэл ногдуулж ёс хорооны магадлалд өөрчлөлт оруулж өгнө үү" гэжээ.

ХЯНАВАЛ

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.3 дахь хэсэгт заасны дагуу хэргийг давж заалдах гомдолд дурдсан үндэслэлээр хянаад Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэв

Шүүхийн Ёс зүйн хороо иргэн З.А-аас ирүүлсэн гомдлын дагуу 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 27 дугаартай магадлалаар шүүгч Ж.С-д сахилгын шийтгэл ногдуулсан байна.

1.З.А давж заалдах гомдолдоо "Буцааж өгнө гээд өгөхгүй 1 жил 9 сар унаж хэрэглэсэн RAW-4 маркийн Япон улсад үйлдвэрлэгдсэн, хар өнгийн, ...XXX улсын дугаартай, суудлын зориулалттай, ...арлын дугаартай тээврийн хэрэгслийн бодит хохирол болох 25 сая төгрөгийг шүүгч Ж.С-с Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106 3.7 дахь хэсэгт зааснаар гаргуулж өгнө үү." гэжээ.

Хэрэгт авагдсан нотлох баримтаас үзвэл Ж.С нь гэр бүлийн хэрэгцээнд З.А-аас ...XXX улсын дугаартай Toyota RAW-4 маркийн машиныг 2015 оны 8 дугаар сарын 05-ны өдөр 25 сая төгрөгөөр худалдан авсан байх бөгөөд төлбөрт О.Э-ийн өмчлөлийн Toyota Axio маркийн машиныг 10 сая төгрөгт тооцож өгөөд нэмж 15.000.000 төгрөгийг өгсөн байна З.А нь одоо дахин 25 сая төгрөгийг шүүгч Ж.С-ээс гаргуулж өгнө үү гэж давж заалдах гомдолдоо дурджээ. Өөрөөр хэлбэл З.А нь /шүүгч Ж.С-ийн тайлбартаа дурдсанаар “аваарт орж хойд талын бензиний банк базсан лааз шиг болсон, моторт задаргаа орсон, машины кузов бүтэн гажсан, бүтэн замаск, будаг хийлгэсэн” машинаа Toyota RAW-4 маркийн машинаар сольж, мөн 15 сая төгрөг нэмж авсан, одоо дахин 25 сая төгрөг авахыг хүсэж байна.

Энэхүү үндэслэлийг давж заалдах шатны шүүх хүлээн авах үндэслэлгүй бөгөөд Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалд өөрчлөлт оруулах боломжгүй.

1.Давж заалдах гомдолд "шүүгч Ж.С-д Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.3 дахь хэсэгт зааснаар огцруулах сахилгын шийтгэл ногдуулж, Ёс зүйн хорооны магадлалд өөрчлөлт оруулж өгнө үү" гэснийг хүлээн авах боломжгүй байна.

Учир нь шүүгч Ж.С Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн "Зээл" хэсгийг буруу мэдүүлээгүй байна.

Гэтэл Шүүхийн Ёс зүйн хороо "эхнэр О.Э-ийн 15 сая төгрөгийн цалингийн зээлийн талаар мэдүүлэгтээ бичээгүй." байгааг зөрчил гэж үзсэн байх бөгөөд улмаар энэ нь Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.2. Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журмын 4.4.2-г зөрчсөн, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, Монгол Улсын Шүүхийн шүүгчийн ес зүйн дүрмийн 4 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 16.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн "зөрчил мөн" гэсэн дүгнэлтэд хүрчээ.

"Эхнэр О.Э-ийн 15 сая төгрөгийн цалингийн зээлийн талаар мэдүүлэгтээ бичих байсан эсэх" нь шүүгч Ж.С-г зөрчил гаргасан эсэх талаар дүгнэхэд гол ач холбогдолтой байна.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар тогтоолын хавсралтаар "Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт" мөн "Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам"-ыг баталсан байна Чухамхүү дээрх 05 дугаар тогтоолоор мэдүүлгийн маягтыг баталсан төдийгүй, аль хэсэгт юу, юуг хэрхэн мэдүүлэх, ямар хугацаанд мэдүүлэх зэргийг зааж өгсөн байна

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журмын 4.4.2-т "Зээл" Үүнд зөвхөн өөрийн зээлийн талаарх мэдээллийг мэдүүлэх бөгөөд бусдаас зээлсэн бэлэн мөнгө, хөрөнгийн дүн, хугацаа, зээл, зээлийн хүүгийн дүн, зориулалтыг бичнэ, гэж хоёрдмол утгагүй заасан байна. Өөрөөр хэлбэл шүүгч Ж.С Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын дагуу эхнэр О.Э-ийн зээлийн талаар мэдүүлэх үүрэггүй байна. Нэгэнт эхнэрийн зээлийн талаар мэдүүлэх үүрэггүй тул түүний эх үүсвэрийг тайлбарлах шаардлагагүй юм.

Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалаас үзвэл "Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг "Авлигын хэрэг эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл 2016 он" зэрэг албан бус эх сурвалжийг ашиглан "эхнэрийнхээ зээлийг мэдүүлэх үүрэгтэй" гэж дүгнэсэн нь буруу болжээ. Дээрх дүгнэлтээс улбаалан Авлигын эсрэг хуулийн 10

дугаар зүйлийн 10.2, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журмын 4.4.2, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, Монгол Улсын Шүүхийн Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 4.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 2013 оны Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 16.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн "зөрчил мөн" гэсэн буруу дүгнэлтэд Шүүхийн Ёс зүйн хороо хүрчээ.

Мөн магадлалд 15 сая төгрөгийн эх үүсвэрийг бичээгүй Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын эх үүсвэрээ бодитой, үнэн зөв тайлбарлах үүрэгтэй" гэсэн заалтыг зөрчсөн байна гэж буруу дүгнэжээ. Учир нь "үнэн зөв мэдүүлэх үүрэг" болон "бодитой, үнэн зөв тайлбарлах үүрэг" гэсэн 2 өөр ойлголтын ялгааг анхаараагүй байна. Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтыг ойлгож хэрэглэхдээ мөн зүйлийн 13.6 дахь заалттай уялдаатай хэрэглэхээр байна

Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Энэ хуулийн 4.1-д заасан этгээд хөрөнгө, орлогын мэдүүлгээ хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл эх үүсвэрийг нь заагаагүй буюу түүнийг хэрхэн олсон талаар тайлбар гаргаагүй бол Авлигатай тэмцэх газар тухайн мэдүүлэг гаргагчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг шалгана" гээд 13.7-д "Мэдүүлэг гаргагч хөрөнгө орлогын эх үүсвэрээ бодитой үнэн зөв тайлбарлах үүрэгтэй" гэжээ. Өөрөөр хэлбэл хөрөнгө, орлогын мэдүүлгийг шалгах үед "мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын эх үүсвэрээ бодитой, үнэн зөв тайлбарлах үүрэгтэй" байна Шүүгч Ж.С-ийн тухайд дээрх тохиолдол үүсээгүй байхад "үнэн зөв тайлбарлах үүрэг"-ээ зөрчсөн гэж дүгнэх боломжгүй

Нөгөө талаар Улсын Их Хурлын тогтоолоор батлагдсан мэдүүлгийг бөглөх / тайлбар хэсэгт юу бичих талаарх/ асуудалд хөрөнгө, орлогын мэдүүлгийг шалгах ажиллагааны үед тайлбар гаргахдаа хүлээх үүргийг хамаатуулсан нь буруу байна.

2002 оны Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 85 дугаар зүйлийн 85.3 дахь хэсэгт заасны дагуу тус шүүх "хэргийг бүхэлд нь хянан үздэг" байсан зохицуулалт 2016 оны 7 сарын 01-ний өдрөөс эхлэн "хэргийг давж заалдах гомдолд дурдсан үндэслэлээр хянах" болж өөрчлөгдсөн /2016 оны Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.3 дахь хэсэг/ тул давж заалдах гомдолд дурдсан үндэслэлээр хэргийг хянаад магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлээ.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.1 дэх заалтыг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 27 дугаар магадлалыг хэвээр үлдээж, гомдол гаргагч З.А-ийн давж заалдах гомдлыг хангахгүй орхисугай.

2.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.5 дахь хэсэгт заасны дагуу магадлалыг эс зөвшөөрвөл хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч гардан авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй.

ШҮҮГЧ

Г.БИЛГҮҮН

ШҮҮГЧ

Б.ТУНГАЛАГСАЙХАН

ШҮҮГЧ

Э.ЗОРИГТБААТАР



МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЁС ЗҮЙН ХОРООНЫ МАГАДЛАЛ

2017 оны 3 сарын 30 өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

Ф дүүргийн Иргэний хэргийн анхан
шатны шүүхийн шүүгч Ч.М-д
сахилгын шийтгэл ногдуулах тухай

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааныг Ёс зүйн хорооны гишүүн Н.Эрдэнэцогт даргалж, гишүүн А.Доржготов, О.Мөнхсайхан, Б.Уранцэцэг, В.Жавхлан нарын бүрэлдэхүүнтэй, шүүгч Ч.М, хуралдааны тэмдэглэл хөтлөгчөөр ажлын албаны шинжээч А.Энхбаатар, хяналт шалгалт хариуцсан референт А.Баасанжав нарыг оролцуулан тус хорооны хуралдааны танхимд хийв

Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 199 дүгээр тогтоолыг эс зөвшөөрч нийт гишүүдийн хуралдаанд шүүгч Ч.М-ээс гомдол гаргасныг гишүүн В.Жавхлангийн илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Гомдол гаргагч Х.Т Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан гомдолдоо: Миний бие 2015.03.27-ны өдөр өөрийн хууль ёсны итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулж дүүргийн шүүхэд “ННН” ... уран сайхны киноны найруулагч У.У, уг киноны зохиолч А.Г нарт холбогдуулан хариуцагч нар нь дээрх киног бүтээж олон нийтэд дэлгэснээр Д.Х-ийн гэр бүл болох Х.Т, Х.Я, Х.Э нарын нэр төр, алдар хүндэд халдсан үйлдэл гаргасан болохыг тогтоолгох тухай нэхэмжлэлийн шаардлага гаргасан болно.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад:

Энэхүү хэрэг Дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ч.М-т хуваарилагдан 2015.04.03-ны өдөр иргэний хэрэг үүсгэгдсэн бөгөөд хэрэг хянан шийдвэрлэгдэх ажиллагааны явцад нэхэмжлэгч талаас 2015.10.09-ны өдөр шинжээч томилуулах хүсэлт гаргасан болно.

2015.10.09-ний өдөр шүүхийн дугаар 102/ШТ2015/00851 тоот тогтоол гарч хүсэлтийг хангахаас татгалзаж шийдвэрлэсэн болно. ИХШХШТхуулийн 170-р зүйлд заасан гомдол гаргах эрхгүй.

2015.10.23-ны өдөр шүүхийн дугаар 102/ШТ2015/00851 тоот тогтоолд нэхэмжлэгч талаас ИХШХШТХ-ийн 124 дүгээр зүйлд заасны дагуу хүсэлт гаргасан болно.

2015.11.04-ний өдөр шүүхийн дугаар 102/ШТ2015/00930 тоот тогтоол гарч хүсэлтийг хангахаас татгалзаж шийдвэрлэсэн болно.

2016.01.13-ны өдөр нэхэмжлэгч талаас 2 дахь удаа шинжээч томилуулах хүсэлтийг гаргасан.

2016.01.13-ны өдөр шүүхийн дугаар 102/ШТ2016/00074 тоот тогтоол гарч хүсэлтийг хангахаас татгалзаж шийдвэрлэсэн болно. ИХШХШТХ-ийн 170-р зүйлд заасан гомдол гаргах эрхтэй.

2016.01.21-ний өдөр нэхэмжлэгч талын зүгээс шүүхийн дугаар 102/ШТ2016/00074 тоот тогтоолд гомдол гаргасан.

2016.02.18-ны өдөр шүүхийн дугаар 102/ШТ2016/00180 тоот тогтоол гарч хүсэлтийг хангахаас татгалзсан дугаар 102/ШТ2016/00074 тоот тогтоолд өөрчлөлт оруулж уг тогтоолын 1-р заалтын "...шинжээч томилуулах тухай нэхэмжлэгч талын гаргасан хүсэлтийг хангахгүй орхиж..." гэсэн хэсгийг хүчингүй болгож шийдвэрлэсэн.

2016.04.27-ны өдрийн шүүх хуралдаанаар шинжээч томилж шүүхийн дугаар 102/ШТ2016/00502 тоот тогтоол гарсан болно. ИХШХШТХ-ийн 170-р зүйлд зааснаар гомдол гаргах эрхтэй.

2016.05.09-ний өдөр хариуцагч нарын итгэмжлэгдсэн төлөөлөгч нь шүүхийн дугаар 102/ШТ2016/00502 тоот тогтоолд гомдол гаргасан.

2016.05.19-ний өдөр шүүхийн дугаар 102/ШТ2016/00588 тоот тогтоол гарч гомдол гаргах хуульд заасан хугацаа хэтрүүлсэн гэдэг үндэслэлээр гомдлыг хэлэлцэхээс татгалзаж шүүхийн дугаар 102/ШТ2016/00502 тоот тогтоол хэвээр үлдсэн.

Шүүхийн дугаар 102/ШТ2016/00502 тоот тогтоолын тогтоох нь хэсгийн 1-д "Х.Т ийн нэхэмжлэлтэй У.У нарт холбогдох "ННН" уран сайхны киног бүтээж, олон нийтэд дэлгэснээрээ нэхэмжлэгчийн болон тэдний гэр бүлийнхний нэр төр, алдар хүндэд халдсан болохыг тогтоолгох тухай иргэний хэрэгт нэхэмжлэгч талын хүсэлтийг хангаж, шинжээчээр ААА-г томилсугай гэжээ.

Мөн тогтоох нь хэсгийн 7-д "Шүүхийн тогтоолыг ААА-д хүргүүлэхийг шүүгчийн туслах А.О-д даалгасугай" гэжээ.

Нэхэмжлэгч талын зүгээс өнөөдрийг хүртэл шүүхэд удаа дараа хандаж шинжээчийн дүгнэлт ирсэн эсэхийг тодруулахад шүүхийн тогтоолоо шинжээч байгууллагад хүргүүлсэн байгаа харин дүгнэлт ирээгүй байна. иймд хэрэг сэргээгдээгүй гэсэн тайлбарыг өгдөг байсан. Аргаа барж шинжээч байгууллага болох ААА-ийн бичиг хэрэгт хандаж шүүхийн 102/ШТ2016/00502 тоот тогтоол очсон эсэхийг тодруулахад манай байгууллагад шүүхийн ийм тогтоол ирээгүй гэдгээ илэрхийлсэн болно.

Энэ тухай Ф дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ч.М шүүгчийн туслахад мэдэгдэхэд хавтаст хэргийн материалаа шүүж үзээд явуулаагүй байна. дахин хүргүүлье гээд 2016.07.21-ний өдөр шүүхээс дахин бичиг гаргасан нь хавтаст хэргийн материалд авагдсан байдаг.

Гэтэл мөн л шинжээч байгууллага шүүхийн дээрх тогтоол ирээгүй, манай байгууллага энэхүү хэрэг дээр ямар нэгэн шинжээчийн ажиллагаа явуулаагүй гэдгээ илэрхийлсэн болно. Улмаар дахин Ф дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ч.М шүүгчийн туслахад мэдэгдэхээр тус шүүх дээр очиход шүүгчийн туслах амралтаа авсан, түүнийг орлож байгаа хүн байхгүй, хэрэг түдгэлзсэн байгаа учраас ямар нэгэн хүсэлт, гомдол хүлээн авч ажиллагаа хийхгүй гэж тайлбарладаг болно.

2016.08.31 -ний өдрийн байдлаар нэхэмжлэгч талын зүгээс Ф дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн бичиг хүргэгч Б.М-тай ажлын байран дээр нь уулзаж шүүхийн 102/ШТ2016/00502 тоот тогтоолыг шинжээч байгууллага болох ААА-д албан ёсоор хүргэж өгсөн эсэхийг тодруулж. явуулсан бичгийн бүртгэлийн дэвтрээс нь шүүлт хийлгэхэд дээрх тогтоолыг хүргэж өгсөн, хүлээн авсан гэсэн тэмдэглэл огт байхгүй байсан болно

Гэтэл Ф дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ч.М нь шинжээч томилсон 102/ШТ2016/00502 тоот тогтоолоо шинжээч байгууллага болох ААА-д бүтэн 4 сарын хугацаанд хүргэгдээгүй байхад тогтоолын биелэлтээ хангуулах тал дээр ямар нэгэн арга хэмжээ аваагүй байгаад гомдолтой байна

Монгол Улсын Шүүхийн Шүүгчийн Ёс зүйн дүрмийн Нэгдүгээр бүлгийн 1.3 “Шүүгчийн баримтлах зарчим” 1.3.1-т ‘ Шүүгч нь хууль дээдлэх, ... үүрэгт ажилдаа хариуцлагатай хандах ...’, Гуравдугаар бүлгийн 3.3 “Албаны чиг үүрэгтээ хандах” 3.3.1-т “Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй” гэсэн заалтуудыг зөрчиж шүүгчийн ёс зүйн ноцтой алдаа гаргаж байна.

Энэхүү хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэгч талаас 2015.10.09-ны өдөр анх шинжээч томилуулах хүсэлтийг гаргасан гэдгийг дээр дурдсан бөгөөд шүүх хүсэлтийг хангахгүй орхисон тогтоолоо гомдол гаргах эрхгүй гаргаж хууль хэрэглээний алдаа гаргаснаас үүдэж дахин шинжээч томилуулах хүсэлт гаргаж тэр нь шийдвэрлэгдэх гэж явсаар 2016.04.27-ны өдрийг хүрсэн. Энэ бүх хугацаа нь нэхэмжлэгчийн хувьд маш хохиролтой байна. Шүүхэд манай гэр бүлийн гишүүдийн нэр төрд нь халдаад байна. үүнийг тогтоогоод өгөөч гэж нэхэмжлэл гаргаснаас хойш хэрэг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай нотлох баримт болох шинжээчийн хүсэлтийг шийдвэрлүүлэх гэж бүтэн 6 сар, шийдвэрлүүлээд шинжээч байгууллагад нь тогтоолыг нь хүргүүлж чадахгүй 4 сар гаруй хугацаа өнгөрч байна. Шүүхээс шалтгаалсан энэ бүх хугацаанд манай гэр бүлийн гишүүдийн нэр төр сэвтсэн хэвээр байгаад маш их гомдолтой байна.

Иймд Ф дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ч.М-т шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан сахилгын хариуцлага тооцож өгнө үү” гэжээ.

Шүүгч Ч.М Шүүхийн Ёс зүйн хороонд ирүүлсэн тайлбартаа: “... Шинжээч томилсон шүүхийн тогтоолыг шинжилгээний байгууллагад өдийг хүртэл хүргүүлээгүй 4 сар болсон гэж гомдлын үндэслэлээ тодорхойлжээ. Нэхэмжлэгч талын хүсэлтээр шинжээч томилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг 2016 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр түдгэлзүүлсэн. Уг тогтоолд хариуцагч нарын итгэмжлэгдсэн төлөөлөгч гомдол гаргаж, тухайн гомдлыг хэлэлцэхээс татгалзсан тогтоол 2016 оны 5 дугаар сарын 19-ний өдөр гарсан.

Гомдол хэлэлцэхээр хэргийг шилжүүлж авсан шүүгч тогтоолын хамт хэргээ 2016 оны 5 дугаар сарын 27-ны өдөр буцаан ирүүлж, шүүхийн зохион байгуулалттай холбоотойгоор хэргийг дахин хуваарилалтад оруулахаар шүүхийн Тамгын газар битүүмжилж авсан. Ф дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний тогтоолын дагуу 2016 оны 6 дугаар сарын 02-ны өдөр хэрэг хуваарилагдаж ирсэн.

Шүүгчийн туслах Э.О нь шинжилгээний байгууллага болох ААА-д шүүхийн тогтоол хүргүүлэхээр албан тоот төлөвлөж, Ерөнхий шүүгч Ж.Э-р гарын үсэг зуруулахаар 2016 оны 5 дугаар сарын 31-ний өдөр хүргүүлсэн боловч уг албан тоотод гарын үсэг зурагдаж яваагүй болохыг миний бие 2016 оны 8 дугаар сарын 31-ний өдөр мэдсэн болно.

Туслах Э.О-с тодруулж асуухад “өмнө нь тоот явуулсан гэж бодож байсан. гэтэл шинжилгээний байгууллагад ирээн бичиг хүргэгчид өгсөн боловч очоогүй байна гэнээ” гэсэн.

Миний бие 2016 оны 6 дугаар сарын 13-ны өдрөөс 17-ны хооронд орон нутгийн сургалтад хамрагдсан. 2016 оны 7 дугаар сарын 13-ны өдрөөс 7 дугаар сарын 26-ны өдрүүдэд АНУ-д шүүхийн тогтолцоотой танилцах сургалтад хамрагдсан бөгөөд 2016 оны 8 дугаар сарын 01- ний өдрөөс 26-ны өдөр хүртэл Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу ээлжийн амралттай байсан.

Шинжилгээний байгууллага болох ААА нь танай 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн албан бичгийг аваад хариу мэдэгдэхэд бид Х.Т-ийн талд байна, шинжээчээр яруу найрагч н.Г-г томиллоо гэсэн албан тоот ирүүлж байхыг харвал шинжээч томилсон шүүхийн тогтоол шинжилгээний байгууллагад очсон болох нь

харагдаж байна. Шинжээчийн дүгнэлт удаашралтай байгаа нь шүүхийн тогтоол хугацаа хожимдож хүрснээс гадна шинжилгээний байгууллагын үйл ажиллагаатай холбоотой болно.

Шүүгчийн туслах Э.О нь 2016 оны 5 дугаар сарын 06-ны өдрөөс шүүгчийн туслахаар ажиллаж байгаа бөгөөд түүнийг сургах, чадавхжуулах талаар шүүгчийн зүгээс өдөр тутам шаардлага тавин сурган ажиллаж байна. Тайлбартай холбоотой нэмэлт баримт гаргаж өгнө гэжээ.

Шүүгчийн туслах Э.О Шүүхийн Ёс зүйн хороонд ирүүлсэн тайлбартаа: Ф дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд шүүгчийн туслах ажилтай Э.О би 2016 оны 5 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн Ч.М шүүгчийн туслахаар томилогдон ажиллаж эхэлсэн.

Х.Т-ийн нэхэмжлэлтэй У.У нарт холбогдох иргэний хэрэгт 2016 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр шинжээч томилж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн байдаг бөгөөд шинжээч томилсон шүүхийн тогтоолд хариуцагчийн өмгөөлөгч Ч.Ө гомдол гаргаж, 2016 оны 5 дугаар сарын 19-ний өдөр шүүх бүрэлдэхүүн гомдлыг хянан хэлэлцэхээс татгалзсан.

Шинжээч томилсон тогтоолыг 2016 оны 5 дугаар сарын 26-ны өдөр албан бичгээр хүргүүлэхээр бэлдсэн боловч шүүхийн харьяаллаар хэргийг хуваарилахаар бүх хэргийг тамгын газраас хураан авч хуваарилалтад оруулсантай холбоотойгоор албан бичгийг хүргүүлэхээ мартсан байсан. 2016 оны 7 дугаар сарын эхээр бичиг хүргэгчид өгч бичгийг хүргүүлсэн боловч ААА-д очоогүй байсан. 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдөр дахин албан бичгээр тогтоолыг хүргүүлсэн боловч мөн л очоогүй байсан. Энэ хугацаанд шүүгч АНУ-руу сургалтаар явсан байсан. 2016 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс шүүгч ээлжийн амралтаа авч, би 2016 оны 8 дугаар сарын 04-ний өдрөөс ээлжийн амралтаа авсан. Ээлжийн амралт дуусаж 2016 оны 8 дугаар сарын 25-ны өдрөөс ажилдаа ороход нэхэмжлэгч талаас тогтоол ААА-д очоогүй байна гэсэн учир тогтоол болон албан бичгийг хуулбарлан, хуулбар үнэн дарж 8 дугаар сарын 31-ний өдөр бичиг хүргэгчээр дахин хүргүүлсэн. ААА-ээс Х.Т-ийн гаргасан нэхэмжлэл зөв гэсэн утга бүхий албан бичгийг 2016 оны 9 дүгээр сарын эхээр ирүүлсэн бөгөөд шүүгч шинжээчийн дүгнэлт ирүүлэх ёстой гэсэн учир албан бичгийг авч ирсэн хүнээр буцаалгаж, шинжээчийн дүгнэлтийн хамт ирүүлэхийг сануулан явуулсан. Одоогийн байдлаар ААА-аас дүгнэлтийг ирүүлээгүй байна" гэжээ.

Шүүгч Ч.М Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанд гомдол гаргах нь:

Сахилгын хэрэг үүсгэсэн тогтоолд гомдол гаргах тухай:

Ф дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ч.М миний хянан шийдвэрлэж байгаа Х.Т-ийн нэхэмжлэлтэй У.У, А.Г нарт холбогдох хэргийн оролцогчоос Шүүхийн Ёс зүйн хороонд гомдлыг хэлэлцээд 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 199 тоот тогтоолоор сахилгын хэрэг үүсгэсэн.

Дээрх тогтоолд шүүгч миний зүгээс эс зөвшөөрч. дараах тайлбарыг гаргаж, нийт гишүүдийн хуралдаанд биечлэн оролцох хүсэлттэй байна

Шүүхийн Ёс зүйн хороонд гомдлыг хэлэлцээд 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 199 тоот тогтоолоор шүүгчийг Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь шүүгчийн өөр бусад ажлаас ямагт илүү чухал гэдгийг ухамсарлаж, түүний эрхлэх бусад үйл ажиллагаа, хувийн амьдрал нь мэргэжлийн үүрэгтэй нь зөрчилдөх нөхцөл байдал бий болгохоос зайлсхийнэ", 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй", 6 дахь хэсэгт "Шүүгч өөрийн удирдлага дор ажиллаж байгаа алба хаагчдад ажил мэргэжилдээ үнэнч байх, чин сэтгэлээсээ хандаж ажиллахыг

шаардаж, өөрийн эргэн тойронд ёс зүйн эрүүл орчныг бүрдүүлнэ" гэсэн 3 заалтыг зөрчсөн гэж дүгнэж, сахилгын хэрэг үүсгэсэн болно

Шүүгч миний бие Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 199 тоот тогтоолын дагуу нийт гишүүдийн хуралдаанаар хэлэлцэхдээ тогтоолд заасан 3 үндэслэл бүрэн тогтоогдож байгаа эсэх, хугацаа хэтрэлтийн асуудалд шүүгчийн тайлбарласан нөхцөлд байдал хүндэтгэн үзэх шалтгаанд тооцогдож болох эсэхийг харгалзахыг хүндэт гишүүдээс хүсэж байна.

Нэхэмжлэгч талын хүсэлтээр шинжээч томилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ФОС дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн тогтоолоор түдгэлзүүлсэн. Уг тогтоолд хариуцагч нарын итгэмжлэгдсэн төлөөлөгч гомдол гаргаж, тухайн гомдлыг хэлэлцэхээс татгалзсан тогтоол 2016 оны 5 дугаар сарын 19-ний өдөр гарсан.

Гомдол хэлэлцэхээр хэргийг шилжүүлж авсан шүүгч нь О дүүргийн шүүхийн байранд ажилладаг бөгөөд гаргасан тогтоолын хэргийн хамт 2016 оны 5 дугаар сарын 27-ны өдөр /миний бие Ф дүүргийн шүүхийн байранд ажилладаг/ буцаан ирүүлж, шүүхийн зохион байгуулалттай холбоотойгоор хэргийг дахин хуваарилалтад оруулахаар шүүхийн Тамгын газар битүүмжилж авсан. Ф дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний тогтоолын дагуу 2016 оны 6 дугаар сарын 02-ны өдөр хэрэг дахин хуваарилагдаж ирсэн.

Шүүгчийн туслах Э.О-д шинжилгээний байгууллага болох ААА-д шүүхийн тогтоол хүргүүлэхээр албан тоот төлөвлөж, Ерөнхий шүүгч Ж.Э-ээр гарын үсэг зуруулахаар 2016 оны 5 дугаар сарын 31-ний өдөр өгсөн бөгөөд 6 сарын эхээр асуухад туслах надад явуулсан гэж хэлсэн учир тогтоолыг шинжилгээний байгууллагад очсон эсэхийг магадлах шаардлагагүй болсон. 2016 оны 8 дугаар сарын 31-ний өдөр шүүгчийн туслахын өрөөнд нэг эмэгтэй маргалдаад зогсож байхад учрыг нь тодруулбал, нэхэмжлэгч Х.Т-ийн өмгөөлөгчийн туслах гэж танилцуулсан бөгөөд ААА-д шүүхийн тогтоол одоог хүртэл очоогүй байна гэж хэлсэн.

Туслах Э.О-оос чи 6 сард явуулсан гэж байсан, яагаад очоогүй байгаа талаар тодруулж асуухад "өмнө нь тоот явуулсан шиг санаад танд явуулсан гэж хэлсэн. Шинжилгээний байгууллагад ирээгүй гэж нэхэмжлэгчийн өмгөөлөгчийн туслах таныг эзгүйд ирэхээр нь 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдөр дахин тоот төлөвлөж, ерөнхий шүүгчээр гарын үсэг зуруулж, тогтоолоо хуулбарлан, хуулбар үнэн дарж, төвийн бичиг хүргэгч н.М-аар хүргүүлсэн. Гэтэл очоогүй байна гэж байна" гэсэн. Шинжилгээний байгууллагаас манайд ирээгүй гэж албан ёсоор мэдэгдээгүй.

Ер нь дээрх шинжээч томилсон тогтоол 2016 оны 6 дугаар сарын 3-нд шинжилгээний байгууллагад хүргэгдэх ёстой байсан 6 сарын эхээр туслах маань явуулсан гэсэн тул би хэргийг нь шалгах шаардлагагүй. Миний бие 2016 оны 6 дугаар сарын 13-ны өдрөөс 17-ны өдрийн хооронд орон нутгийн сургалтад хамрагдсан. 2016 оны 6 дугаар сарын 20-ны өдрөөс 2016 оны 7 дугаар сарын 08-ны өдрийг дуустал ажиллахад энэ талаар ямар нэгэн гомдол санал гараагүй.

Миний бие 2016 оны 7 дугаар сарын 13-ны өдрөөс 7 дугаар сарын 26-ны өдрүүдэд АНУ-д шүүхийн тогтолцоотой танилцах сургалтад хамрагдсан бөгөөд 2016 оны 7 дугаар сарын 27-29-ний өдрүүдэд ажиллаад, 8 дугаар сарын 01-ний өдрөөс 26-ны өдөр хүртэл Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу ээлжийн амралттай байсан.

Шинжээч томилсон тогтоол шинжилгээний байгууллагад 4 сарын дараа очсон биш юм.

Нэгд, Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 3.1 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг хэрхэн яаж зөрчсөн буюу биелүүлээгүй талаар үндэслэл бүхий дүгнэлт хийгээгүй гэж үзэж

байна. Энэ заалтыг гадаад, дотоодын сургалтад хамрагдсан, ээлжийн амралттай байсан гэх тайлбарт маань холбогдуулж хийсэн дүгнэлт гэж ойлгож байна.

Гомдолд, шүүгч нь шүүхийн тогтоолыг хуульд заасан хугацаанд гаргаагүй гэж гомдоогүй, өөрийн зүгээс хуулийн дагуу хийх ёстой ажлаа бүрэн хийж гүйцэтгэсэн. Тогтоолыг хүргүүлэх, хүргэж өгөх нь шүүгчийн туслах, шүүхийн бичиг хүргэгчийн ажил бөгөөд шүүгч сургалтад хамрагдах, амралттай байх нь тогтоолыг шинжилгээний байгууллагад хүргүүлэхэд саад болохгүй, харшлахгүй юм. Гэтэл тайлбарт үндэслэн Шүүгчийн ёс зүйн дүрмийн энэ заалтыг зөрчсөн гэж дүгнэж байгаа нь үндэслэлгүй бөгөөд тухайн хэм хэмжээтэйгээ зөрчилдсөн байна гэж үзэж байна.

Хоёрт, гуравт Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 1 болон 6 дахь заалтыг зөрчсөн талаар нотлох баримтад үндэслэл бүхий дүгнэлт хийгээгүй байна.

Шүүгчийн хувьд шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолын биелэлтэд нь хяналт тавих үүрэгтэй бөгөөд шүүгчийн туслахаас асуухад тогтоолоо явуулсан гэсэн. Энд шүүгч сургалтад сууснаараа, ээлжийн амралтаа авснаараа хяналт тавих үүргээ хэрэгжүүлээгүй гэж дүгнэх нь өрөөсгөл юм.

Шүүгчийн туслахаас яагаад ийм асуудал үүссэн талаарх тайлбарыг Ёс зүйн хороонд гаргаж өгсөн.

Шүүгчийн туслахыг Шүүхийн Тамгын газраас сонгон шалгаруулж, ажилд авдаг. Энэ үйл ажиллагаанд шүүгч оролцдоггүй, шүүгчийн туслах албан тушаалд ажиллаж байгаа алба хаагч нь төрийн албаны шалгалт өгсөн, хууль зүйн дээд боловсролтой, чин үнэнчээр, шударгаар төрийн албанд зүтгэхээр тангараг өргөсөн хүмүүс ажиллах ёстой бөгөөд би өөрийн туслахаар ажиллаж байгаа Э.О-д энэ утгаар нь итгэж, түүний хэлсэн тайлбарыг нь үнэн зөв гэж үзсэн.

Хуульд нийцсэн болон хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу ажлаа зохих ёсоор хийсэн, шаардсан ба шинжилгээний байгууллагад шүүхийн тогтоол хугацаа хэтрүүлж очсонд шүүгчийн алдаатай үйл ажиллагаа байхгүй гэж үзэж, Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 199 дугаар тогтоолыг хүчингүй болгож, үүсгэсэн сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү.

Жич: Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанд биечлэн оролцох хүсэлттэй байгаа тул хуралдааны товыг мэдэгдэж, оролцох боломж олгож өгнө үү гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанаар гомдол гаргагчийн гомдол, шүүгчийн тайлбар болон давж заалдсан гомдол, уг хэрэгт тус хорооны хянан шалгах ажиллагаагаар цугларсан баримтуудыг хэлэлцээд ҮНДЭСЛЭХ нь:

Шүүгч Ч.М нь Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанд тус хорооны 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 199 дүгээр тогтоолыг эс зөвшөөрч уг тогтоолд заасан 3 үндэслэл байгаа эсэх, хугацаа хэтрэлтийн асуудалд хүндэтгэн үзэх шалтгаан байгаа эсэх талаар гомдол гаргасан байна.

Монгол Улсын Шүүхийн Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 3.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн, мөн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1, 3.3 дугаар зүйлийн 1 дэх заалтыг биелүүлээгүй гэх үндэслэлээр тус хорооны 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 199 дүгээр тогтоолоор шүүгч Ч.М-д сахилгын хэрэг үүсгэн шийдвэрлэжээ.

Гомдол гаргагч Х.Т "... шүүгч Ч.М нь шинжээч томилсон 102/ШТ2016/00502 дугаар тогтоолоо шинжилгээний байгууллагад бүтэн 4 сарын хугацаанд хүргэгдээгүй байхад тогтоолын биелэлтээ хангуулах талаар ямар нэгэн арга хэмжээ аваагүй" тул сахилгын хариуцлага тооцуулах тухай гомдлыг гаргажээ.

"ННН" ... уран сайхны киноны найруулагч У.У, уг киноны зохиолч А.Г нарт холбогдуулан хариуцагч нар нь дээрх киног бүтээж олон нийтэд дэлгэснээр Д.Х-

ийн гэр бүл болох Х.Т, Х.Я, Х.Э нарын нэр төр, алдар хүндэд халдсан үйлдэл гаргасан болохыг тогтоолгох тухай нэхэмжлэл шүүгч Ч.М-т хуваарилагдаж, 2015 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр шүүгчийн захирамжаар иргэний хэрэг үүсгэж, улмаар 2016 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр 102/ШТ2016/00502 дугаар шүүхийн тогтоол гарч нэхэмжлэгчийн хүсэлтийг хангаж шинжээч томилж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн байна.

Шинжээч томилсон шүүхийн тогтоолд хариуцагчаас гомдол гаргаснаар тухайн шатны шүүх хянаж, 2016 оны 05 дугаар сарын 19-ний өдөр уг тогтоолыг хэвээр үлдээжээ.

Гомдол гаргагчаас шүүх гаргасан тогтоолоо томилсон шинжилгээний байгууллагад хүргүүлээгүй, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих үүргээ шүүгч зохих ёсоор биелүүлээгүй бусдын эрх ашгийг хохироож байна гэж гомдоллож байгаа нь үндэслэлтэй байна.

Шүүгч Ч.М нь шүүхийн зохион байгуулалттай холбоотойгоор хэргийг дахин хуваарилалтад оруулахаар шүүхийн Тамгын газар битүүмжилж авсан Ф дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний тогтоолын дагуу 2016 оны 6 дугаар сарын 02-ны өдөр хэрэг хуваарилагдаж ирсэн Туслах Э.О-оос тодруулж асуухад “өмнө нь тоот явуулсан гэж бодож байсан, гэтэл шинжилгээний байгууллагад хүргүүлэх материал бичиг хүргэгчид өгсөн боловч очоогүй байна гэнээ” гэсэн, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдөр дахин тоот төлөвлөж, тогтоолоо хуулбарлаж, хуулбар үнэн тэмдэг дарж хүргүүлсэн.

Миний бие 2016 оны 6 дугаар сарын 13-ны өдрөөс 17-ны хооронд орон нутгийн сургалтад, 2016 оны 7 дугаар сарын 13-ны өдрөөс 7 дугаар сарын 26-ны өдрүүдэд АНУ-д шүүхийн тогтолцоотой танилцах сургалтад тус тус хамрагдсан бөгөөд 2016 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс 26-ны өдөр хүртэл ээлжийн амралттай байсан гэж шалтгаанаа тайлбарлажээ.

Шүүгчийн туслах Э.О нь шинжилгээний байгууллага болох ААА-д шүүхийн тогтоол хүргүүлэхээр албан тоот төлөвлөж, Ерөнхий шүүгч Ж.Э-ээр гарын үсэг зуруулахаар 2016 оны 5 дугаар сарын 31-ний өдөр хүргүүлсэн. Тухайн байгууллагад очоогүй гэдгийг мэдэж, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдөр дахин албан бичгээр тогтоолыг хүргүүлсэн боловч мөн л очоогүй байсан.

Миний ээлжийн амралт дуусаж 2016 оны 8 дугаар сарын 25-ны өдрөөс ажилдаа ороход нэхэмжлэгч талаас шинжээч томилсон тогтоол ААА-д очоогүй байна гэсэн учир тогтоол болон албан бичгийг хуулбарлан, хуулбар үнэн тэмдэг дарж, 8 дугаар сарын 31-ний өдөр бичиг хүргэгчээр дахин хүргүүлсэн гэсэн тодорхойлолтыг тус хороонд гаргажээ.

Хугацаа хэтрэлтийн асуудалд шүүгчийн тайлбарласан нөхцөл байдлыг хүндэтгэн үзэх шалтгаантай байсан гэж үзэх боломжгүй бөгөөд шүүгч Ч.М 2016 оны 6 дугаар сарын 02-ны өдөр хэрэг дахин хуваарилагдаж ирсэн. 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдөр дахин тоот төлөвлөж, тогтоолоо хуулбарлаж, хуулбар үнэн тэмдэг дарж хүргүүлсэн гэж, шүүгчийн туслахын тайлбарлаж байгаагаар 2016 оны 5 дугаар сарын 31-ний өдөр хүргүүлсэн. Тухайн байгууллагад очоогүй гэдгийг мэдэж, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдөр дахин албан бичгээр тогтоолыг хүргүүлсэн боловч мөн л очоогүй байсан. 2016 оны 8 дугаар сарын 25-ны өдрөөс намайг ажилдаа ороход нэхэмжлэгч талаас шинжээч томилсон тогтоол ААА-д очоогүй байна гэсэн учир тогтоол болон албан бичгийг хуулбарлан, хуулбар үнэн тэмдэг дарж, 8 дугаар сарын 31-ний өдөр бичиг хүргэгчээр дахин хүргүүлсэн гэж тус тус тайлбарласнаас үзэхэд шинжээч томилсон тогтоолыг хүргүүлсэн хугацааны хувьд зөрүүтэй байна.

Шүүгч Ч.М нь шинжээчээр ААА-г томилсон 2016 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн шүүхийн тогтоолыг шинжээчид хүргүүлэх болон хэргийн хөдөлгөөнийг

удирдах шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохих хугацаанд нь хийгээгүй орхигдуулсан, хэрэг хянан шийдвэрлэх хуулийн хугацааг баримтлах үүргээ хангалтгүй биелүүлсэн зэргээр шүүгч нь хууль дээдлэх. үүрэгт ажилдаа хариуцлагатай хандах, мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүргээ хэрэгжүүлээгүй Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1, 3.3.1 заалтыг биелүүлээгүй гэж үзэхээр байна

Монгол Улсын Шүүхийн Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 3.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь шүүгчийн өөр бусад ажлаас ямагт илүү чухал гэдгийг ухамсарлаж, түүний эрхлэх бусад үйл ажиллагаа. хувийн амьдрал нь мэргэжлийн үүрэгтэй нь зөрчилдөх нөхцөл байдал бий болгохоос зайлсхийнэ.” гэж, 3.3 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “Шүүгч өөрийн удирдлага дор ажиллаж байгаа алба хаагчдад ажил мэргэжилдээ үнэнч байх, чин сэтгэлээсээ хандаж ажиллахыг шаардаж,...”, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй”, гэж тус тус заасныг шүүгч нь хангаж ажиллах учиртай.

Иймд шүүгч Ч.М-д сахилгын хэрэг үүсгэсэн Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 199 дүгээр тогтоолыг үндэслэлтэй гэж нийт гишүүд дүгнэв.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2, 36 дугаар зүйлийн 36.1.1, 37 дугаар зүйлийн 37.1.1, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйл, Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5.7.1, 5.13-т заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Ф дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ч.М-д "сануулах" сахилгын шийтгэл ногдуулсугай.Энэ магадлалын хувийг шүүгч, гомдол гаргагчид хүргүүлэхийг тус хорооны ажлын алба / Н.Г/-д даалгасугай.

2.Энэ магадлалын хувийг шүүгч, гомдол гаргагчид хүргүүлэхийг тус хорооны ажлын алба /Н.Г/-д даалгасугай.

3.Шүүгч, гомдол гаргагч магадлалыг эс зөвшөөрвөл гардан авснаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.

ДАРГАЛАГЧ

Н.ЭРДЭНЭЦОГТ

ГИШҮҮН

В.ЖАВХЛАН

УИХ.МН
СҮДАЛГААНЫ САН



ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ
МАГАДЛАЛ

2017 оны 5 сарын 18 өдөр

Дугаар 221/ЁМ2017/0011

Улаанбаатар хот

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны
2017 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн
28 дугаар магадлалын тухай

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааныг шүүгч Э.Зоригтбаатар даргалж, шүүгч Г.Билгүүн, шүүгч Э.Халиунбаяр нарын бүрэлдэхүүнтэй хийж, Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн “Ф дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ч.М-д сахилгын шийтгэл ногдуулах тухай” 28 дугаар магадлалыг шүүгч Ч.М-ийн гаргасан гомдлоор, шүүгч Э.Халиунбаярын илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 28 дугаар магадлалаар: Ф дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ч.М-д “сануулах” сахилгын шийтгэл ногдуулж шийдвэрлэжээ.

Шүүгч Ч.М шүүхэд гаргасан гомдолдоо: “...Шүүхийн Ёс зүйн хорооны тогтоол, Магадлалаар шүүгчийг Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 3.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь шүүгчийн өөр бусад ажлаас ямагт илүү чухал гэдгийг ухамсарлаж, түүний эрхлэх бусад үйл ажиллагаа, хувийн амьдрал нь мэргэжлийн үүрэгтэй нь зөрчилдөх нөхцөл байдал бий болгохоос зайлсхийнэ”, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй”, 6 дахь хэсэгт “Шүүгч өөрийн удирдлага дор ажиллаж байгаа алба хаагчдад ажил мэргэжилдээ үнэнч байх, чин сэтгэлээсээ хандаж ажиллахыг шаардаж, өөрийн эргэн тойронд ёс зүйн эрүүл орчныг бүрдүүлнэ” гэсэн 3 заалтыг зөрчсөн гэж дүгнэж, сахилгын хэрэг үүсгэж, сануулах сахилгын шийтгэл ногдууллаа.

Шүүгч миний бие Шүүхийн Ёс зүйн хорооны энэхүү дүгнэлтэд заасан 3 үндэслэл бүрэн тогтоогдож байгаа эсэх, хугацаа хэтрэлтийн асуудалд шүүгчийн тайлбарласан нөхцөл байдал нь хүндэтгэн үзэх шалтгаанд тооцогдож болох эсэхийг харгалзаагүй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа хэтрэлтийн асуудалд /гомдолд хороонд хандаж бичсэн Шүүхийн шинэтгэлтэй холбогдуулан дүгнэж шийдвэрлэснийг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх бүрэлдэхүүн ёс зүйн зөрчил үү, мэргэжлийн хариуцлагын алдаа юу, шүүгчээс хамаарахгүй нөхцөл байдал байна уу, хөөн хэлэлцэх хугацаа зэрэг байдлаар зааглан дүгнэж үзэхийг хүсэж байна.

Үйл баримт болон гомдлын үндэслэлийн талаар товч тайлбарлавал:

Нэхэмжлэгч талын хүсэлтээр шинжээч томилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ФОС дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 4

дүгээр сарын 27-ны өдрийн тогтоолоор түдгэлзүүлсэн. Уг тогтоолд хариуцагч нарын итгэмжлэгдсэн төлөөлөгч гомдол гаргаж, тухайн гомдлыг хэлэлцэхээс татгалзсан тогтоол 2016 оны 5 дугаар сарын 19-ний өдөр гарсан.

Гомдол хэлэлцэхээр хэргийг шилжүүлж авсан шүүгч нь Ф дүүргийн шүүхийн байранд ажилладаг бөгөөд гаргасан тогтоолын хэргийн хамт 2016 оны 5 дугаар сарын 27-ны өдөр /миний бие Ф дүүргийн шүүхийн байранд ажилладаг/ буцаан ирүүлж, шүүхийн зохион байгуулалттай холбоотойгоор хэргийг дахин хуваарилалтад оруулахаар шүүхийн Тамгын газар битүүмжилж авсан. Ф дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний тогтоолын дагуу 2016 оны 6 дугаар сарын 02-ны өдөр хэрэг дахин хуваарилагдаж ирсэн

Шүүгчийн туслах Э.О-д шинжилгээний байгууллага болох ААА-д шүүхийн тогтоол хүргүүлэхээр албан тоот төлөвлөж, Ерөнхий шүүгч Ж.Э-ээр гарын үсэг зуруулахаар 2016 оны 5 дугаар сарын 30-ны өдөр өгсөн байсан бөгөөд хэрэг хуваарилагдаж ирсний дараа 6 сарын эхээр асуухад туслах надад "шинжээч руу тогтоолоо явуулсан" гэж хэлсэн.

2016 оны 8 дугаар сарын 31-ний өдөр шүүгчийн туслахын өрөөнд нэг эмэгтэй маргалдаад зогсож байхад учрыг нь тодруулбал, нэхэмжлэгч Х.Т-ийн өмгөөлөгчийн туслах гэж танилцуулсан бөгөөд ААА-д шүүхийн тогтоол одоог хүртэл очоогүй байна гэж хэлсэн.

Би шүүгчийн туслах Э.О-оос "чи 6 сард явуулсан гэж байсан, яагаад очоогүй байдаг юм бэ" гэж тодруулж асуухад "өмнө нь тоот явуулсан шиг санаад танд явуулсан гэж хэлсэн. Шинжилгээний байгууллагад ирээгүй гэж нэхэмжлэгчийн өмгөөлөгчийн туслах таныг эзгүйд ирэхээр нь 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдөр дахин тоот төлөвлөж, ерөнхий шүүгчээр гарын үсэг зуруулж, тогтоолоо хуулбарлан, хуулбар үнэн дарж, төвийн бичиг хүргэгч н.М-аар хүргүүлсэн Гэтэл очоогүй байна гэнэ" гэсэн тайлбар өгсөн. Үүнийг зөвхөн нэхэмжлэгчийн өмгөөлөгчийн туслах гэх хэргийн оролцогч биш хүний мэдээллээр ярьж байгаа. Харин Шинжилгээний байгууллагаас манайд ирээгүй гэж албан ёсоор мэдэгдээгүй.

Ер нь дээрх шинжээч томилсон тогтоол 2016 оны 6 дугаар сарын 03-нд шинжилгээний байгууллагад хүргэгдэх ёстой байсан. 6 сарын эхээр туслах маань явуулсан гэсэн тул би хэргийг нь шалгах шаардлагагүй. Миний бие 2016 оны 6 дугаар 13-ны өдрөөс 17-ны өдрийн хооронд орон нутгийн сургалтад хамрагдсан. 2016 оны 6 дугаар сарын 20-ны өдрөөс 2016 оны 7 дугаар сарын 08-ны өдрийг дуустал ажиллахад энэ талаар ямар нэгэн гомдол санал гараагүй.

Миний бие 2016 оны 7 дугаар сарын 13-ны өдрөөс 7 дугаар сарын 26-ны өдрүүдэд АНУ-д шүүхийн тогтолцоотой танилцах сургалтад хамрагдсан бөгөөд 2016 оны 7 дугаар сарын 27-29-ний өдрүүдэд ажиллаад, 8 дугаар сарын 01-ний өдрөөс 26-ны өдөр хүртэл Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу ээлжийн амралттай байсан.

Шинжээч томилсон тогтоол шинжилгээний байгууллагад 4 сарын дараа очсон биш юм.

Нэгд, Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 3.1 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг хэрхэн яаж зөрчсөн буюу биелүүлээгүй талаар үндэслэл бүхий дүгнэлт хийгээгүй гэж үзэж байна. Энэ заалтыг гадаад, дотоодын сургалтад хамрагдсан, ээлжийн амралттай байсан гэх тайлбарт маань холбогдуулж хийсэн дүгнэлт гэж ойлгож байна.

Гомдолд, шүүгч нь шүүхийн тогтоолыг хуульд заасан хугацаанд гаргаагүй гэж гомдоогүй, өөрийн зүгээс хуулийн дагуу хийх ёстой ажлаа бүрэн хийж гүйцэтгэсэн. Тогтоолыг хүргүүлэх, хүргэж өгөх нь шүүгчийн туслах, шүүхийн бичиг хүргэгчийн ажил бөгөөд шүүгч сургалтад хамрагдах, амралттай байх нь тогтоолыг шинжилгээний байгууллагад хүргүүлэхэд саад болохгүй, харшлахгүй юм. Гэтэл тайлбарт үндэслэн Шүүгчийн ёс зүйн дүрмийн энэ заалтыг зөрчсөн гэж дүгнэж

байгаа нь үндэслэлгүй бөгөөд тухайн хэм хэмжээтэйгээ зөрчилдсөн байна гэж үзэж байна.

Хоёр, гуравт, Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 1 болон 6 дахь заалтыг зөрчсөн талаар нотлох баримтад үндэслэл бүхий дүгнэлт хийгээгүй байна.

Шүүгчийн хувьд шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолын биелэлтэд нь хяналт тавих үүрэгтэй бөгөөд шүүгчийн туслахаас асуухад тогтоолоо явуулсан гэсэн. Энд шүүгч сургалтад сууснаараа, ээлжийн амралтаа авснаараа хяналт тавих үүргээ хэрэгжүүлээгүй гэж дүгнэх нь өрөөсгөл юм.

Шүүгчийн туслахаас яагаад ийм асуудал үүссэн талаарх тайлбарыг Ёс зүйн хороонд гаргаж өгсөн.

Шүүгчийн туслахыг Шүүхийн Тамгын газраас сонгон шалгаруулж, ажилд авдаг Энэ үйл ажиллагаанд шүүгч оролцдоггүй, шүүгчийн туслах албан тушаалд ажиллаж байгаа алба хаагч нь төрийн албаны шалгалт өгсөн, хууль зүйн дээд боловсролтой, чин үнэнчээр, шударгаар төрийн албанд зүтгэхээр тангараг өргөсөн хүмүүс ажиллах ёстой бөгөөд би өөрийн туслахаар ажиллаж байгаа Э.О-д энэ утгаар нь итгэж, түүний хэлсэн тайлбарыг нь үнэн зөв гэж үзсэн.

Хуульд нийцсэн болон хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу ажлаа зохих ёсоор хийсэн, шаардсан ба шинжилгээний байгууллагад шүүхийн тогтоол хугацаа хэтрүүлж очсонд шүүгчийн алдаатай үйл ажиллагаа байхгүй гэж үзэж, Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн сахилгын хэрэг үүсгэх тухай 199 дугаар тогтоол, 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн сахилгын шийтгэл ногдуулах тухай 28 тоот Магадлалыг хүчингүй болгож, үүсгэсэн сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү" гэжээ.

ХЯНАВАЛ

Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 28 дугаар магадлалыг шүүгч Ч.М-ийн гомдлоор хянан хэлэлцээд түүний гомдлыг хангаж шийдвэрлэх нь зүйтэй гэж үзлээ.

Шүүхийн Ёс зүйн хороонд Х.Т нь шүүгчид сахилгын хэрэг үүсгүүлэхээр хандах болсон үндэслэлээ "... шүүгч Ч.М нь шинжээч томилсон 102/ШТ2016/00502 тоот тогтоолыг шинжээч байгууллага болох ААА-д бүтэн 4 сарын хугацаанд хүргэгдээгүй байхад тогтоолын биелэлтээ хангуулах тал дээр ямар нэгэн арга хэмжээ аваагүй байгаад гомдолтой байна. Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.3.1-д "шүүгч нь хууль дээдлэх, ... албан үүрэгт ажилдаа хариуцлагатай хандах, мөн 3.3 дугаар зүйлийн 1-д "шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд нь хяналт тавих үүрэгтэй" гэсэн заалтуудыг шүүгч Ч.М зөрчиж ёс зүйн ноцтой алдаа гаргаж байн" гэж тодорхойлжээ.

ФОС дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн "Шинжээч томилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх" тухай 2016 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 102/ШТ2016/00502 дугаар тогтоолоор иргэн Х.Т-ийн нэхэмжлэлтэй У.У нарт холбогдох иргэний хэрэгт нэхэмжлэгч талын хүсэлтийг хангаж, шинжээчээр ААА-г томилжээ.

Улмаар дээрх шүүхийн тогтоолыг хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ч.Ө-ийн гомдлоор хянан хэлэлцээд ФОС дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн "Гомдол хэлэлцэхээс татгалзах" тухай 2016 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 102/ШТ2016/00588 дугаар тогтоол гарчээ.

Дээрх үйл баримтаас үзэхэд "иргэн Х.Т-ийн нэхэмжлэлтэй У.У нарт холбогдох иргэний хэргийг Ф дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний тогтоолын дагуу 2016 оны 6 дугаар сарын 02-ны өдөр надад дахин хуваарилсан" гэх шүүгч Ч.М-ийн тайлбар үндэслэлтэй байна

Мөн шүүгч Ч.М нь 2016 оны 6 дугаар сарын 13-17-ны өдөр хүртэлх хугацаанд орон нутгийн сургалтад хамрагдсан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2016 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 93 дугаар тушаалаар Америкийн Нэгдсэн Улсад 2016 оны 07 дугаар сарын 14-ний өдрөөс 7 дугаар сарын 24-нийг өдрийг хүртэлх хугацаанд тус улсын шүүхийн тогтолцооны үйл ажиллагааг судлах, туршлага солилцох сургалтад хамрагдсан, 2016 оны 8 дугаар сарын 01-26-ны өдрүүдэд Хөдөлмөрийн тухай хуульд заасан ээлжийн амралтыг эдэлсэн болох нь хэрэгт авагдсан нотлох баримтуудаар тогтоогдсон.

Шүүгч Ч.М-ийн “шүүгчийн туслах Э.О-д шинжилгээний байгууллага болох ААА-д шүүхийн тогтоолыг хүргүүлэхээр албан бичиг төлөвлөж, ерөнхий шүүгч Ж.Э-ээр гарын үсэг зуруулахаар 2016 оны 5 дугаар сарын 30-ны өдөр өгсөн байсан ба хэрэг дахин хуваарилагдаж ирсний дараа 6 дугаар сарын эхээр асуухад туслах надад “шинжээч байгууллагад шүүхийн тогтоолоо явуулсан” гэж хэлсэн” гэсэн тайлбарыг гаргасан.

Шүүхийн Ёс зүйн хороонд “... шинжээч томилсон тогтоолыг 2016 оны 5 дугаар сарын 26-ны өдөр албан бичгээр хүргүүлэхээр бэлдсэн боловч шүүхийн харьяаллаар хэргийг хуваарилахаар бүх хэргийг Тамгын газраас хураан авч хуваарилалтад оруулсантай холбоотойгоор албан бичгийг хүргүүлэхээ мартсан байна. 2016 оны 7 дугаар сарын эхээр бичиг хүргэгчид өгч бичгийг хүргүүлсэн боловч ААА-д очоогүй” гэсэн тайлбарыг шүүгчийн туслах Э.О ирүүлсэн байна.

Эдгээр тайлбаруудаас үзэхэд ФОС дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн “Шинжээч томилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх” тухай 2016 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 102/ШТ2016/00502 дугаар тогтоолыг шинжээчээр томилогдсон байгууллага болох ААА-д 4 сарын хугацаанд хүргүүлээгүй гэх үйлдэл нь шүүгч Ч.М-ийн шууд буруутай үйл ажиллагаанаас болсон гэх үндэслэл хэрэгт авагдсан нотлох баримтаар тогтоогдохгүй байна.

Тиймээс Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 1-д “шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд нь хяналт тавих үүрэгтэй”, мөн зүйлийн 6-д заасан “шүүгчийн өөрийн удирдлага дор ажиллаж байгаа алба хаагчдад ажил мэргэжилдээ үнэн ч байх чин сэтгэлээсээ хандаж ажиллахыг шаардах, өөрийн эргэн тойронд ёс зүйн эрүүл орчныг бүрдүүлнэ” гэж заасныг шүүгч Ч.М зөрчөөгүй гэж үзлээ.

Тодруулбал, дээрх нөхцөл байдал нь “шүүхийн тогтоолыг шинжээч байгууллага болох ААА-д хүргүүлэх ажиллагааг хийхийг шүүгчийн туслахад даалгаж, шаардлага тавьж байсан” гэх шүүгч Ч.М-ийн тайлбар, мөн шүүгчийн туслах Э.О-ийн “шүүхийн харьяаллаар хэргийг хуваарилахаар бүх хэргийг Тамгын газраас хураан авч хуваарилалтад оруулсантай холбоотойгоор албан бичгийг хүргүүлэхээ мартсан байна. 2016 оны 7 дугаар сарын эхээр бичиг хүргэгчид өгч бичгийг хүргүүлсэн” гэсэн тайлбар зэргээр нотлогдож байгаа.

Нөгөөтээгүүр Монгол Улсын Шүүхийн Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн шүүгчийн эрхэмлэх зарчмыг, 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн шүүгч нь хэргийн оролцогчтой харилцах харилцааны соёлыг эзэмших байх, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх биелэлтэд хяналт тавих үүргээ шүүгч биелүүлээгүй, мөн шүүгч нь энэхүү дүрмийн заалтуудыг зөрчсөн үйлдэл, үйл ажиллагаа гаргасан, явуулсан гэх үндэслэл баримтаар тогтоогдоогүй байна.

Иймд Ф дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ч.М-т сануулах сахилгын шийтгэл ногдуулсан Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 28 дугаар магадлалыг хүчингүй болгож, шүүгч Ч.М-ийн гомдлыг хангаж шийдвэрлэв.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.1, 121.1.1 дэх заалтыг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 28 дугаар магадлалыг хүчингүй болгож, шүүгч Ч.М-ийн гомдлыг хангасугай.

2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.5 дахь хэсэгт заасны дагуу магадлалыг эс зөвшөөрвөл хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч гардан авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй.

ШҮҮГЧ

Э.ЗОРИГТБААТАР

ШҮҮГЧ

Г.БИЛГҮҮН

ШҮҮГЧ

Э.ХАЛИУНБАЯР



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ХЯНАЛТЫН ШАТНЫ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2017 оны 9 сарын 20 өдөр

Дугаар 305

Улаанбаатар хот

Шүүгч Ч.М-д холбогдох сахилгын
хэргийн тухай

Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн шүүх хуралдааныг шүүгч Х.Батсүрэн даргалж, шүүгч Л.Атарцэцэг, Б.Мөнхтуяа, Д.Мөнхтуяа, Ч.Тунгалаг нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн дарга А.Батдэлгэр, шүүгч Ч.М-ийн өмгөөлөгч З.У нарыг оролцуулан хийж, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 221/ЁМ2017/0011 дүгээр магадлалыг эс зөвшөөрч гомдол гаргагч Х.Т-ийн хяналтын журмаар гаргасан гомдлоор Х.Т-ийн гомдолтой, Ф дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ч.М-д холбогдох сахилгын хэргийг шүүгч Ч.Тунгалагийн илтгэснээр хянан хэлэлцэв.

Гомдол гаргагч Х.Т Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан гомдолдоо: ... Шүүгч Ч.М нь шинжээч томилсон 502 дугаар тогтоолыг шинжээч байгууллага болох ААА-д бүтэн 4 сарын хугацаанд хүргэгдээгүй байхад тогтоолын биелэлтээ хангуулах тал дээр ямар нэгэн арга хэмжээ аваагүй байгаад гомдолтой байна. Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3.1-д "шүүгч нь хууль дээдлэх, ...албан үүрэгт ажилдаа хариуцлагатай хандах, мөн 3.3 дугаар зүйлийн 1-д "шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд нь хяналт тавих үүрэгтэй" гэсэн заалтуудыг зөрчиж ёс зүйн ноцтой алдаа гаргаж байна" гэжээ. ТОДОРХОЙЛОХ нь:

Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 199 дүгээр тогтоолоор Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйл, Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 4.6 дугаар зүйлийн 1-д заасныг тус тус удирдлага болгон гомдол гаргагч Х.Т-ийн гомдлоор Ф дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ч.М-д сахилгын хэрэг үүсгэсэн байна.

Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 28 дугаар магадлалаар Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2, 36 дугаар зүйлийн 36.1.1, 37 дугаар зүйлийн 37.1.1, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйл, Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5.7.1, 5.13-т заасныг тус тус удирдлага болгон шүүгч Ч.М-д "сануулах" сахилгын шийтгэл ногдуулж шийдвэрлэжээ.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх шүүгч Ч.М-ийн гаргасан гомдлоор хэргийг 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр хянан хэлэлцээд 221/ЁМ2017/0011 дүгээр магадлалаар Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 3 дугаар

сарын 30-ны өдрийн 28 дугаар магадлалыг хүчингүй болгож, шүүгч Ч.М-ийн гаргасан гомдлыг хангаж шийдвэрлэсэн байна.

Гомдол гаргагч Х.Т хяналтын журмаар гаргасан гомдолдоо: "...Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалын хянавал хэсэгт: "...мөн шүүгч Ч.М нь 2016 оны 6 дугаар сарын 13-ны өдрөөс 6 дугаар сарын 17-ны өдрийг хүртэлх хугацаанд орон нутгийн сургалтад хамрагдсан, ...АНУ-д 2016 оны 7 дугаар сарын 14-ний өдрөөс 7 дугаар сарын 24-ний өдрийг хүртэлх хугацаанд сургалтад хамрагдсан, 2016 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс 8 дугаар сарын 26-ны өдрүүдэд ээлжийн амралт эдэлсэн болох нь хэрэгт авагдсан нотлох баримтуудаар тогтоогдсон, "...шүүгч Ч.М-ийн туслах Э.О-д шинжээч байгууллагад шүүхийн тогтоолыг явуулсан эсэхийг тодруулахад 6 сарын эхээр тогтоолоо явуулсан гэж хэлсэн гэсэн тайлбарыг гаргасан...", "...эдгээр тайлбаруудаас үзэхэд ФОС дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн "Шинжээч томилж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх" тухай 2016 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 102/ШТ2016/00502 дугаар тогтоолыг шинжээчээр томилогдсон байгууллагад 4 сарын хугацаанд хүргүүлээгүй гэх үйлдэл нь шүүгч Ч.М-ийн буруутай үйл ажиллагаанаас болсон гэх үндэслэл хэрэгт авагдсан нотлох баримтаар тогтоогдохгүй байна..." гэжээ.

Миний бие иргэн хүнийхээ хувьд ойлгохдоо энэ хэргийг хариуцаад, хуулийн дагуу ажиллагаа хийгээд шийдвэрлүүлэх гэж тухайн шүүгчид хуваарилагддаг байх гэж ойлгож байна. Түүнээс шүүгч ажилтай байсан учраас уг хэрэг нь хаана яаж байгаа, ажиллагаа нь зогсонги байна уу, үгүй юу, тухайн шүүгчид хамаагүй гэж ойлгож болохгүй юм. Гэтэл энэ хэргийн ажиллагаа зогсох учиргүй гэж ойлгож байна. Монгол Улсын Үндсэн хуульд төрийн байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй явагдах, хууль дээдлэх, шүүхийн шийдвэр заавал биелэгдэх ёстой гэсэн ойлголтууд байдаг.

Гэтэл шүүгч нь би амралт, чөлөөтэй байсан учраас энэ хэргийн асуудал надад хамаагүй мэтээр тайлбар өгч, шүүх тэрийг нь "үндэслэлтэй байна" гэж шийдэж иргэдийгээ хохироосон шүүх байна гэж үнэндээ санаанд буухгүй байна. Шүүгчийн ёс зүйн дүрмийн Нэгдүгээр бүлгийн 1.3-т "шүүгчийн баримтлах зарчим", 1.3.1-д "шүүгч нь хууль дээдлэх, ...үүрэгт ажилдаа хариуцлагатай хандах...", Гуравдугаар бүлгийн 3.3-т "албаны чиг үүрэгтээ хандах" 3.3.1-д "шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй" гэж заасныг зөрчиж шүүгчийн ёс зүйн алдаа гаргаж байна.

Шүүхэд "манай гэр бүлийн гишүүдийн нэр төрд нь халдаад байна, эрх маань зөрчигдөөд байна, үүнийг тогтоогоод өгөөч" гэж нэхэмжлэл гаргаснаас хойш хэрэг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай нотлох баримт болох шинжээчийн хүсэлтийг шийдвэрлүүлэх гэж бүтэн 6 сар, шийдвэрлүүлээд шинжээч байгууллагад нь тогтоолыг нь хүргүүлж чадахгүй 4 сар, нийт 10 сар гаруй хугацаа өнгөрч байна.

Шүүхээс шалтгаалсан энэ бүх хугацаанд манай гэр бүлийн гишүүдийн нэр төр сэвтсэн хэвээр байгаад маш их гомдолтой байна. Иймд шүүгч Ч.М-д Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан сахилгын хариуцлага тооцож, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож өгнө үү гэжээ.

ХЯНАВАЛ:

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгох нь зүйтэй гэж хяналтын шатны шүүх үзлээ.

Монгол Улсын Шүүхийн Ёс хороо нь Ф дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ч.М-д холбогдуулан иргэн Х.Т-ийн гаргасан "шүүгч Ч.М нь хэрэг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай шинжээч томилуулах тухай миний хүсэлтийг шийдвэрлэх гэж 6 сар, шийдвэрлээд шинжээч томилсон

тогтоолоо шинжээчид хүргүүлэлгүй 4 сар гаруй болж байна..., шүүгчийн энэ байдал нь Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.3.1-д "шүүгч нь ...хууль дээдлэх,... үүрэгт ажилдаа хариуцлагатай хандах...", 3.3.1-д "шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй" гэснийг зөрчсөнийг тогтоож, сахилгын хариуцлага тооцуулах" тухай гомдлыг шалгаж шүүгч Ч.М-д сахилгын хэрэг үүсгэж, "сануулах" шийтгэл ногдуулсан нь хууль зүйн үндэслэлтэй болжээ.

Шүүгчийн Ёс зүйн хороо иргэн Х.Т-ийн гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагааг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 167 дугаар зарлигаар баталсан "Шүүхийн Ёс зүйн хорооны дүрэм"-д заасан журмын дагуу явуулж, шүүгч болон гомдол гаргагчийн эрхийг хязгаарласан, зөрчсөн алдаа гаргаагүй байна.

Монгол Улсын Шүүхийн Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.4-т "Шүүгч хуульд тусгайлан ёс зүйн зөрчил болохоор заасан болон энэ дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг ёс зүйн зөрчил гэж үзнэ" гэж тодорхойлж, Шүүгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд баримтлах ёс зүйн талаар: 3.3.1-д "шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй" хэмээн заажээ.

Сахилгын хэргийн материалаас үзвэл, шүүгч Ч.М нь гомдол гаргагч Х.Т-ийн нэхэмжлэлтэй У.У, А.Г нарт холбогдох "нэр төр, алдар хүндэд халдсан үйлдэл гаргасан болохыг тогтоолгох" тухай иргэний хэрэгт нэхэмжлэгчийн хүсэлтээр шинжээч томилсон 2016 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 102/ШТ2016/00502 дугаартай тогтоолоо шинжээчид зохих хугацаанд нь хүргүүлэх арга хэмжээ аваагүй, хүргэгдэлгүйгээр 2016 оны 8 дугаар сарын 31-нийг хүрсэн байхад зохих хяналт тавиагүй, тогтоолын биелэлтийг хангуулах ажиллагаа хийгээгүй зэрэг нь тогтоогдсон байна.

Иймд, шүүгчийн уг эс үйлдэхүй нь Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 3.3.1-д заасан хэм хэмжээг зөрчсөн ёс зүйн зөрчил болохыг Шүүхийн Ёс зүйн хороо зөв дүгнэж, шүүгчид "сануулах" сахилгын хариуцлага хүлээлгэсэн нь зөрчлийн шинж байдалд тохирсон гэж үзнэ.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх "... хэрэг дахин хуваарилагдаж ирсний дараа 6 дугаар сарын эхээр асуухад туслах надад шинжээч байгууллагад тогтоолыг хүргүүлсэн гэж хэлсэн, ... шүүгчийн туслах нь албан бичгийг хүргүүлэхээ мартсан, 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн албан бичгийг хүргүүлсэн боловч шинжээчид очоогүй байсан" гэх шүүгч болон шүүгчийн туслахын тайлбарт үндэслэн "шинжээч томилсон шүүхийн тогтоол"-ыг 4 сарын хугацаанд шинжээчээр томилсон байгууллагад хүргүүлээгүй асуудалд шүүгч Ч.М-г шууд буруутгах үндэслэл баримтаар тогтоогдохгүй байна гэж дүгнэхдээ сахилгын хэрэгт авагдсан баримтуудыг зөв үнэлж чадаагүй, Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.3.1-д заасан "хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагаа нь" хэргийн хугацаа, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахтай холбоотойгоор шүүгчийн гаргаж буй шийдвэр, түүний биелэлтийг хангуулах зэрэгт хамааралтай болохыг анхаараагүй байна.

Өөрөөр хэлбэл, 2016 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн "шинжээч томилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх тухай" тогтоолд шүүхийн тогтоолыг гардан авсан өдрөөс хойш 15 хоногийн хугацаанд дүгнэлт гаргаж шүүхэд ирүүлэхийг шинжээчид мэдэгдсэн, үүний биелэлтийг хангуулах талаар шүүгч Ч.М нь хуульд заасан ямар нэгэн ажиллагаа огт хийгээгүй байсан нь тогтоогдсон, тэрээр 2016 оны 6 дугаар сард 5 хоног орон нутгийн сургалтад, 7 дугаар сард 14 хоног АНУ- д сургалтад хамрагдаж "чөлөөтэй" байсан, 8 дугаар сард ээлжийн амралтаа эдэлсэн зэрэг нь хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаатай / тогтоолыг хүргүүлэх/ холбогдуулан даалгасан ажиллагааг шүүгчийн туслах

хэрхэн гүйцэтгэж байгаад хяналт тавих үүргээс чөлөөлөхгүй, шүүгч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ “шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь шүүгчийн өөр бусад ажлаас ямагт илүү чухал гэдгийг ухамсарлах” шүүгчийн ёс зүйг баримтлах учиртай.

Дээрх үндэслэлээр Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, гомдол гаргагч Х.Т-ийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангах нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэлээ.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.2.3-т заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 221/ЁМ2017/0011 дүгээр магадлалыг хүчингүй болгож, Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 28 дугаар магадлалыг хэвээр үлдээсүгэй.

ДАРГАЛАГЧ ШҮҮГЧ

Х.БАТСҮРЭН

ШҮҮГЧ

Ч.ТУНГАЛАГ

UIN.MN
СУДАЛГААНЫ САН



МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЁС ЗҮЙН ХОРООНЫ МАГАДЛАЛ

2017 оны 6 сарын 09 өдөр

Дугаар 45

Улаанбаатар хот

Ф аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн
анхан шатны шүүхийн шүүгч Н.Б-д сахилгын
шийтгэл ногдуулах тухай

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааныг тус хорооны дарга Н.Эрдэнэцогт даргалж, гишүүн О.Мөнхсайхан, Ч.Оюунцэцэг, В.Жавхлан, А.Доржготов нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны тэмдэглэл хөтлөгчөөр ажлын албаны шинжээч А.Энхбаатар, хяналт шалгалт хариуцсан референт А.Баасанжав, шүүгч Н.Б /онлайнаар/ нарыг оролцуулан Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдааны танхимд хийв.

Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 69 дүгээр тогтоолыг Шүүхийн Ёс зүйн хорооны гишүүн О.Мөнхсайханы илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Ф аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, гомдол гаргагч М.М Шүүхийн Ёс зүйн хороонд 2017 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр ирүүлсэн гомдолдоо: “Тус аймаг дахь Цагдаагийн газраас 2017 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн нэр дээр ирүүлсэн албан мэдэгдлийг, тус аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Н.Б нь шүүгчийн нэр хүндэд халдсан, сөргөөр нөлөөлж болзошгүй мэдээллийг өөрийн цахим хаягаар олон нийтэд тараасан байж болзошгүй тул холбогдох материалын хамт хүргүүлэв” гээд дараах албан мэдэгдэл болон цахим сүлжээгээр тараасан байж болзошгүй гэх материалыг хавсаргасан байна.

Ф аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч М.М-ийн нэр дээр тус аймаг дахь Цагдаагийн газраас 2017 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр ирүүлсэн албан мэдэгдэлд: “Цагдаагийн газрын Жижүүрийн шуурхай албаны 7044102 дугаарын утсанд 2016 оны 12 дугаар сарын 24-ны шөнө 04 цаг 40 минутад шүүгчийн туслах Ц.У нь шүүгч Н.Б-ын эрх чөлөөнд халдлаа гэсэн дуудлагыг тухайн өдөр Шүүхийн байранд харуулын үүрэг гүйцэтгэж байсан Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэсгийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч М.М-аас мэдээлсний дагуу жижүүрийн албанаас шуурхай очиж шалгахад:

1.Тухайн өдөр нэр бүхий шүүгч, шүүгчийн туслах нар Ф сумын Н нэгдүгээр багт байрлах "333" зоогийн газарт шөнийн 04 цаг хүртэл хугацаанд үйлчлүүлж, улмаар гудамж талбай, олон нийтийн газарт хэрүүл маргаан үүсгэж шүүгчийн туслах Ц.У нь шүүгч Н.Б-ыг хавсарч унаган эрх чөлөөнд нь халдаж танхайрсан.

2.Дуудлагын дагуу тусламж үзүүлэхээр шуурхай очсон цагдаагийн алба хаагчдыг шүүгч Н.Б нь та нар Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах

хэсгийн цагдаа нараа бүгдийг нь дууд, би тэднээр хамгаалуулна гэсэн хууль бус шаардлагыг тавьсан зөрчлүүд тогтоогдсон.

Энэхүү нөхцөл байдал Шүүгч, шүүхийн байгууллагын ажилтан нараас архи, согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэсэн үедээ, гудамж талбай, олон нийтийн газар хэрүүл маргаан үүсгэх, бусдын эрх чөлөөнд халдах, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зэрэг захиргааны зөрчлүүдэд удаа дараа холбогдох, Шүүхийн байгууллагын нэр хүнд, шүүгчийн ёс зүйг зөрчөөд зогсохгүй, гэмт хэрэг, зөрчилд холбогдох, гэмт халдлагад өртөж хохирох илүү ноцтой үр дагаварт хүргэж болзошгүй байна. Шүүх, Шүүгчийн аюулгүй байдлыг хангах журмын 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэгт "Цагдаагийн байгууллага шүүн таслах ажиллагаатай холбогдуулан шүүгч, шүүх бүрэлдэхүүн, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учирсан эсхүл учирч болзошгүй бодит нөхцөл байдал үүсвэл шүүгч өөрийгөө болон гэр бүлийн гишүүн, эд хөрөнгөө хамгаалалтад авхуулах тухай хүсэлтийг үндэслэн уг журмын 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэгт зааснаар хамгаалалтад авах шийдвэр гарсны дараа гэрээ байгуулж, хамгаалалтыг зохион байгуулах үүрэгтэй" гэж заасан. Гэтэл шөнийн цагаар, согтууруулах ундаагаар үйлчлэх цагийн хуваарийг тогтоосон хууль, журмыг зөрчүүлэн үйлчлүүлж, олон нийтийн газар хэрүүл маргаан үүсгэн Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэсгийн цагдаа нараар хамгаалуулна, тэд нарыг дууд гэсэн шаардлага тавьж байгаа нь Хууль зүй дотоод хэргийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2016 оны А/40, 113 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан Шүүх, Шүүгчийн аюулгүй байдлыг хангах журамд нийцэхгүй байна.

Иймд цаашид шүүгч, шүүгчийн туслах, ажилтан нараас хууль, журам зөрчсөн аливаа үйлдэл гаргуулахгүй байх талаар удирдлага, зохион байгуулалтын тодорхой арга хэмжээг авч, хуульд заасан хугацаанд албан ёсоор хариуг ирүүлнэ үү.

Жич: Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд зааснаар тогтоосон цагийн хуваарийг зөрчиж үйл ажиллагаа явуулсан "ЗЗЗ" зоогийн газарт АСТТХ-ийн 16.1.5 дахь хэсэгт зааснаар 50,000 /Тавин мянга/ төгрөгийн торгуулийн арга хэмжээ ногдуулж, зөрчлийн талонд нь сануулсан, шүүгчийн туслах Ц.У-ын гудамж талбай, олон нийтийн газарт хэрүүл маргаан үүсгэж, шүүгч Н.Б-ын эрх чөлөөнд халдаж танхайрсан гэх асуудалд захиргааны зөрчлийн хэрэг бүртгэлт явуулж байгаа болно" гэжээ.

Гомдол гаргагч М.М "шүүгч Н.Б нь шүүгчийн нэр хүндэд халдсан, сөргөөр нөлөөлж болзошгүй мэдээллийг өөрийн цахим хаягаар олон нийтэд тараасан байж болзошгүй" гэх материалыг гомдолдоо хавсарган ирүүлжээ. Шүүгч Н.Б "Ф-ын муу мэдээ" бүлгийн нийтэлсэн дараах постыг өөрийн фейсбүүк хуудастаа олон нийтэд хуваалцжээ (хийжээ): "Аймгийн Засаг дарга төсвийн мөнгөөр байр авсан МУУ мэдээ байна.

Жаахан ажил хийе гэхээр эдийн засгийн хямрал гэж ам нээх болгондоо ярьж байдаг хүмүүс маань өөртөө зарцуулах болохоор хамаагүй бололтой. Аймгийн 2017 оны төсвийн тодотгол дээр Аймгийн Засаг дарга Г.Б өөртөө албан тушаалын байр авахаар улайран зүтгэсээр батлуулсан байна.

Засаг дарга маань уг нь өөртөө хангалттай мөнгөтэй хүн дээ. Өмнөх жилүүдэд "PPP" ХХК-ийн орлогын 50 хувийг аймгийн төсөвт төвлөрүүлж бүтээн байгуулалтын ажлаа хийдэг байсан. Гэтэл шат шатны шүүхээр явсаар байгаад тус хувийг бууруулж аймагт орох орлогыг 3-хан хүн хувааж авдаг болсон. Түүний нэг бол Г.Б 17.5 хувийг эзэмшдэг. Тус дүнгээр бодоод үзэхэд 2016 онд 5 тэрбумын шлам борлуулсан. Үүний 17.5 хувь гэхээр 875,0 сая төгрөг болж байна. Ийм их орлоготой мөртөө ядруу төсвийн 52.0 сая төгрөгөөр байр авахыг эсэргүүцэж байгаа бол SHARE хийцгээнэ үү.

АЙМГИЙН 2017 ОНЫ ТӨСВИЙН ТОДОТГОЛЫН ТӨСӨЛ

1	ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	
1.1	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд:	19,900.00
1.1.1	Үйл ажиллагааны зардал /Хуралдааны зардал/	10,000.00
1.1.2	ИТХ-ын Тэргүүлэгчдийн зөөврийн компьютер худалдан авах	9,900.00
1.2	Аймгийн Засаг даргын Тамгын газар	17,000.00
1.2.1	Архивын тасгийн үйл ажиллагааны зардал	7,500.00
1.2.2	Аймгийн ЗДТГ-ын урд оны өр	9,500.00
1.3	Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн хуралд:	37,296.00
1.3.1	Олон нийтийн цагдаагийн урамшуулал	37,296.00
1.4	Хот тохижилт, үйлчилгээний газарт:	19,718.50
1.4.1	Ойн зурвасын хамгаалалтын зардал /Цалин/	19,718.50
	ДҮН	93,914.50
2	АНГИЛАГДААГҮЙ ЗАРДАЛ	
2.1	Засаг даргын Тамгын газрын орон сууц худалдан авах /Засаг даргын/	52,000.00
2.2	Засаг даргын Тамгын газрын автомашин	17,000.00
2.3	Цагдаагийн газрын орон сууц худалдан авах	52,000.00
2.4	Шүүхийн Ерөнхий шүүгчийн орон сууц худалдан авах	52,000.00
2.5	МХА-ны тоног төхөөрөмж худалдан авах	15,000.00
2.6	Татварын хэлтсийн халаалтын засвар	18,000.00
2.7	Онцгой байдлын албан хаагчдад орон сууцны дэмжлэг үзүүлэх	48,000.00
2.8	Аймгийн прокурорын газрын дээврийн засварын ажил	31,500.00
2.9	Цагдаагийн газрын "Police repair" төхөөрөмж	9.790.00

Шүүгч Н.Б “Ф-ын муу мэдээ” бүлгийн нийтэлсэн дээрх постыг өөрийн фейсбүүк хуудсаар олон нийтэд хуваалцах (share хийх)-даа дараах сэтгэгдлийг бичсэн байна: “Эмнэлэг, цагдаагийн ажилчдын гэж орон сууц барьсан биз дээ. Ф-ийн шүүхэд л гэхэд 8 айлын ажилчдын орон сууц байдаг. ЗДТГ-т ч бас байрны хэрэг юу байдаг юм бэ. Орон нутгийн иргэд нь л ажиллаж байгаа гэж бодно. Өөр бас нэлээд хэдэн байр байдаг л байхдаа 2.1, 2.3, 2.4 дэх зардлаар өөр аймагтаа хэрэгтэй зүйл хиймээр юмаа. 156,0 сая төгрөгөөр юу хийж болох вэ. Хагархай замаа засварлах. Гэр хорооллын гэрэлтүүлгээ олшруулах. Замын тэмдэг тэмдэглэгээг нэмэгдүүлэх. Гудамж талбайн тохижилт ногоон байгууламжийг нэмэх гэх мэтийн жижиг ажлуудаас эхлээд төрийн байгууллагуудын урсгал засварууд, 3 дугаар сургуулийн спортын заал гээд зөндөө л хийх хөрөнгө оруулах юм байна даа. Ядахдаа л спорт хорооны агаар чийгшүүлэгчээ засмаар байна. Тэмцээнээр улс даяараа харсан шүү дээ.”

“ДДД” гэх фейсбүүк нэртэй хүний тайлбарын дараа шүүгч Н.Б дараах тайлбарыг хийжээ: “Хүний амьдрах нөхцөлийг шийдэх нь нэн чухал нь ч чухал гэхдээ эдгээр байгууллагуудад зөв зүгээр хоосон байр байж байгааг би сонссон бас мэдэх юм. Цуглуулсан төсвөө, миний татварт өгсөн татварыг энэ мэтээр үрээрээ гэж би лав иргэдийн төлөөлөгчөө сонгоогүй учраас л би ийм постыг хийлээ.”

Шүүгч Н.Б Шүүхийн Ёс зүйн хороонд 2017 оны 3 дугаар сарын 23-ны өдөр гаргасан тайлбартаа: “Ф аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч М.М гийн Шүүхийн Ёс зүйн хорооны дарга Н.Эрдэнэцогтод уламжилсан 2017 оны 01 сарын 31-ний өдрийн 14 дугаартай албан бичиг болон түүнд хавсаргасан Ф аймаг дахь цагдаагийн газрын 2017 оны 01 сарын 03-ны өдрийн 5/02 дугаартай "Албан мэдэгдэл", фейсбүүк сошиал сүлжээнээс хуулбарлаж авсан гэх материалыг Шүүхийн Ёс зүйн хорооны ажлын албанаас гардуулж өгсөнтэй танилцлаа.

Үндсэн хоёр асуудлаар миний биеийг Шүүгчийн Ёс зүйн дүрмийг зөрчсөн гэж хандсан байна.

оны 12 сарын 24-ний өдөр тус шүүхээс шинэ жилийн баярын үйл ажиллагааг 333 зоогийн газарт явуулсан. Үйл ажиллагаа өндөрлөж хүмүүс явсан хэдий ч бидний хэдэн хүмүүс үргэлжлүүлэн тухайн газарт байсан. Тус зоогийн газрыг хариуцаж байгаа хүн нь манай шүүгчийн туслах болон зохион байгуулагч нартай найз нөхөд гээд тэд цагийг сунгах эсэхийг шийдвэрлэсэн юм. Тодорхой хэмжээний архи хэрэглэсэн боловч бүгд согтоогүй байсан. Бид бүхэн тарж харьцгаах гээд тухайн газраас гарахад шүүгчийн туслах тухайн газрыг хариуцдаг найзтайгаа маргаад байсан учир боль гэж хориглосноос болж намайг хавсарч унагасан. Шүүхийн байрны жижүүрийн утас руу залгаж болсон асуудлыг хэлэхэд байж байгаарай эргээд хариу өгнө гэсэн. Удалгүй цагдаагийн машин ирж цагдаа нь ирээд зүгээр бол бос гэсэн. Миний зүгээс тухайн албан хаагчаас намайг ингээд унасан байсан гэдгийг баримтжуулж зураг авах, эсхүл тэмдэглэл үйлдэхгүй юм уу гэхэд тийм шаардлагагүй гэхээр нь би уг нь шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэсэг рүү гээ л хэлсэн юм сан гэхэд тухайн алба хаагч тэд нарыг чинь дуудах юм уу гэхээр нь тэг гэхэд нэг байгууллагын хүмүүс байж хоорондоо учраа олоод явцгаа гээд яваад өгсөн. Бид ч тэнд удаагүй тарцгаасан.

Болсон үйл явдал ийм байхад цагдаагийн байгууллагын нөлөө бүхий зарим хүмүүсийн хэтрүүлсэн байдлаар бичсэн мэдэгдлийг миний хувьд гайхаж байна. Тус мэдэгдэлд бичигдсэнчлэн миний зүгээс "та нар Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэсгийн цагдаа нараа бүгдийг нь дууд, би тэднээр хамгаалуулна" гэж шаардаагүй юм.

Үүнээс бус миний хувьд Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах журмыг уншиж судалсан, хэзээ ямар нөхцөлд хамгаалалт авах, ямар журмаар хамгаалуулах вэ гэдгийг ойлгож мэдэж байгаа хүн шүү дээ.

Фейсбүүк сошиал сүлжээгээр шүүгчийн нэр хүндэд халдсан сөргөөр нөлөөлөх мэдээллийг тараасан гэх асуудал нь миний хувьд хэн нэгнийг гүтгэсэн, хэн нэгэн рүү чиглэсэн, хэн нэгнийг буруутгасан гэх мэт зүйл хийгээгүй. Иргэн хүнийхээ хувьд сонгосон ИТХ-ийн шийдвэрийг зөв байгаасай, манай аймаг орон нутагт хэрэгтэй байгаа зүйл рүү хөрөнгө оруулалт хийгээсэй гэж хийсэн пост нь Шүүгчийн ёс зүйн дүрмийн 2.4 дүгээр зүйлд заасныг зөрчөөгүй гэж би үзэж байгаа. Миний бичсэн пост нь шүүгч, шүүхийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй, харин зарим эрх бүхий албан тушаалтны сэтгэлд эмзэглэл төрүүлж байгаа бололтой.

Энэ постыг хийснийхээ төлөө би тодорхой эрх бүхий хүмүүсээс энэ миний буруу гэж уучлал гуйгаагүй, уулзаагүй гэх байдлаар Шүүхийн Ёс зүйн хороонд бичүүлж байгаад харамсаж байна.

Зарим хүмүүсийн надад хандаж тавьсан санал, хууль бус байдлыг үнэн бодит байдлаар нь шударгаар хэлсэн энэ байдлаасаа болж тэдгээр хүмүүсийн өстөн маягийн хүн болж, эртнээс дарж номхруулж авна гэсэн башир аргад нь өртөж байгаадаа сэтгэл дундуур байна.

Тэдгээр хүмүүс надын эсрэг байх тодорхой шалтгаан бүхий ашиг сонирхолтой, энэ байдлаараа нэгдэж ийм ажиллагаа хийж байгаа нь энэ орон нутагт хуулийн байгууллагад ажиллаж байгаа албан хаагч нарт харагддаг л зүйл.

Мөн энэ орон нутагт хуулийн байгууллагуудын албан хаагч нарын биеэ үл ойшоосон байдал, үл ойлголцол, цагдаагийн байгууллагын алба хаагч нарын эр чадалтай гэдгээ бусад хуулийн байгууллагадаа үзүүлэх гэсэн байдал зэрэг нь хурцадмал байдаг гэдгийг энд тэмдэглэе.

Архи, согтууруулах ундаа хэрэглэсэн нь миний буруу. Архи ууж бусдад сөрөг ойлголт төрүүлэх байдал гаргасандаа харамсаж байна. Цаашид энэ мэт байдлаар хүний амьд идэш өгөөш болохгүйн төлөө би хичээж ажиллаж, амьдрах болно.

Би өөрийн биеэр Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдаанд оролцож бусад байдлыг тайлбарлах, мөн шаардлагатай тохиолдолд нэмэлт тайлбар гаргах болно” гэжээ.

Шүүгч Н.Б Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанд 2017 оны 05 дугаар сарын 16-ны өдөр гаргасан гомдолдоо:

“Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 4 сарын 13-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор Ф аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Н.Б надад сахилгын хэрэг үүсгэн шийдвэрлэсэнд гомдол гаргаж байна.

Үндэслэл нь: миний биеийг 2015 оны 12 сарын 16-ны өдөр согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил гаргасан, Ф аймгийн Засаг даргын цагийн хязгаар тогтоох тухай захирамжийг зөрчин шүүхийн захиргааны ажилтнуудын хамт согтууруулах ундааны зүйл хэрэглэж олон нийтийн газар зохисгүй байдал гаргасан.

Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.3.1-т "шүүгч нь ...төвийг сахисан байр сууринаас хандах, ... мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх зэрэг зарчмуудыг хувийн зан чанар болгож төлөвшүүлнэ" мөн дүрмийн 2.3.1-т "шүүгч нь зохисгүй байдал гаргаж болохгүй бөгөөд бусдад ийнхүү ойлгогдохоос зайлсхийнэ." Шүүгчийн баримтлах зарчим, нийгмийн харилцаанд шүүгчийн баримтлах ёс зүйг зөрчсөн байна гэж сахилгын хэрэг үүсгэсэн байна.

Миний бие согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчилд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд зааснаар торгуулах, эрх хасуулах арга хэмжээ авхуулсан байхад тухайн зөрчилд дахин арга хэмжээ авахаар сахилгын хэрэг үүсгэж байгаад гомдолтой байна. Нэг зөрчилд нэг л удаа нэг л төрлийн хариуцлага хүлээх нь шударга ёсны зарчмын гол үндэс гэж би боддог. Мөн шүүгчийн ёс зүйн дүрмийн 5.1.3, 5.1.5 дахь заалтыг зөрчиж байгааг анхаарч үзнэ үү.

Ф аймгийн засаг даргын "цагийн хязгаар тогтоох тухай" захирамжийг зөрчин шүүхийн захиргааны ажилтнуудын хамт согтууруулах ундааны зүйл хэрэглэж олон нийтийн газар зохисгүй байдал гаргасан гэх асуудал нь Ф аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, ажилтнуудын шинэ жилийн баярын үйл ажиллагаа болж баяр тэмдэглэсэн нь надад сахилгын хэрэг үүсгэх үндэслэл биш гэж үзэж байна. Миний бие өөрөө бусдын халдлагад өртөж, түүнийгээ шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэлтсийн алба хаагчид мэдэгдсэн нь эцэс сүүлдээ өөрөө сахилгын хэрэг үүсгүүлэх ийм байдалд хүрч байгаад гомдолтой байна. Цагдаагийн байгууллагын ажилтны буруу ойлголтоос ийм байдал үүссэнд харамсаж байна.

Мөн Ф аймгийн цагдаагийн газрын мэдэгдэл нь яагаад заавал Ф аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгчид гэж ирсэн нь ямар учиртай талаар, цагдаагийн газраас миний биеийг ёс зүйн зөрчил гаргасан гэж мэдэгдэл бичсэн юм бол Шүүхийн Ёс зүйн хороонд, эсхүл миний харьяалагддаг Ф

аймаг дахь эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчид гаргаагүйг би гайхаж байна.

Үүнтэй холбоотой асуудлыг би өөрийн биеэр тайлбарласан. Тайлбарлах ч болно. Ёс зүйн хороонд гомдол гаргасан гэж намайг дарамтлах гэсэн бусдын явуулга ч явж байхыг үгүйсгэхгүй нөхцөл байдал бий болоод байгааг, мөн Шүүхийн Ёс зүйн хороонд бичсэн гэж шүүгч нарыг хэн нэгэн дарамтлах явдал цаашид даамжирч болзошгүйг тэмдэглэмээр байна.

Миний хувьд архи, согтууруулах ундааг тэр болгон хэрэглээд байдаггүй, цаашид ч хэрэглэхгүйгээр ажиллаж амьдарна.

Иймд Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 4 сарын 13-ны өдрийн 69 дугаар тогтоолыг хянаж өгнө үү.

Нийт гишүүдийн хуралдаанд биечлэн оролцож нөхцөл байдлыг тайлбарлана” гэжээ.

Шүүгч Н.Б шүүгчийн ёс зүйг зөрчсөн тухай гомдлыг шалгах явцад дараах баримт, мэдээллийг цугларсан байна: Цаг тогтоох тухай Ф аймгийн Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/783 дугаартай захирамж, мөн Л суманд Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй цэгүүдийн цагийн хуваарийг 09.00-01.00 цагийн хооронд байхаар тогтоосон хавсралтын хуулбарууд, Иргэн Н.Б-ын гомдол, мэдээлэлтэй танилцаад Л сумын Н нэгдүгээр баг “333” ресторан нь 2016 оны 12 дугаар сарын 23-ны шөнө Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчиж цагийн хуваарь хэтрүүлэн үйл ажиллагаа явуулсан зөрчил гаргасан тул Б.Х-д холбогдох захиргааны зөрчлийг хянан шалгах ажиллагааг эхлүүлэх талаарх Захиргааны зөрчлийг хянан шалгах тухай тэмдэглэл (2016 оны 12 дугаар сарын 26-ны өдөр)-ийн хуулбар, Захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг Н.Б-аас хүлээн авсан тухай тэмдэглэл (2016 оны 12 дугаар сарын 25-ны өдөр)-ийн хуулбар, Л сумын Н нэгдүгээр баг “333” ресторан нь 2016 оны 12 дугаар сарын 23-ны шөнө Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчиж цагийн хуваарь хэтрүүлэн үйл ажиллагаа явуулсан, Б.Х-д холбогдох Захиргааны зөрчлийн тухай тэмдэглэл (2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр)-ийн хуулбар, Захиргааны зөрчлийн талаар Н.Б-аас асуусан тэмдэглэл (2016 оны 12 дугаар сарын 25-ны өдөр)-ийн хуулбар, Захиргааны зөрчлийн талаар Б.Х-аас асуусан тэмдэглэл (2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр)-ийн хуулбар, Захиргааны зөрчлийн талаар Ц.У-аас асуусан тэмдэглэл (2017 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр)-ийн хуулбар, Ц.У-д холбогдох захиргааны зөрчлийн шийдвэрлэлтийн бүртгэлийн хуулбар, Ф сумын Н нэгдүгээр баг “333” ресторан нь 2016 оны 12 дугаар сарын 23-ны шөнө Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчиж цагийн хуваарь хэтрүүлэн үйл ажиллагаа явуулсан Б.Х-ыг 50.000 төгрөгөөр торгох тухай Захиргааны шийтгэл ногдуулах тухай шийдвэр (2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр)-ийн хуулбар, 2016 оны 12 дугаар сарын 23-ны шөнө 04.00 цагийн орчимд Л сумын Н нэгдүгээр баг “333” рестораны гадаа архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ бусадтай маргалдаж бусдын амгалан тайван байдал алдагдуулсан зөрчил гаргасан Ц.У-ыг 6.000 төгрөгөөр торгох тухай Захиргааны шийтгэл ногдуулах тухай шийдвэр (2017 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр)-ийн хуулбар, Ц.У-ын үйлдсэн гурван удаагийн захиргааны зөрчил, түүнд авсан арга хэмжээний талаар Ф аймаг дахь цагдаагийн газрын замын цагдаагийн тасгаас тус аймгийн сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Б.Г-д хүргүүлсэн албан мэдэгдэл (2016 оны 02 дугаар сарын 09-ний өдөр)-ийн хуулбар, Н.Б-ын согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил, түүнд авсан арга хэмжээний талаар Ф аймаг дахь цагдаагийн газрын замын цагдаагийн тасгаас тус аймгийн сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Б.Г-д хүргүүлсэн албан мэдэгдэл (2016 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр)-ийн

хуулбар, Ф аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн зохицуулагч цагдаагийн ахмад М.Д-ээс 2017 оны 03 дугаар сарын 14-ний өдөр авсан тайлбар (асуулт тавьж тайлбар авсан Шүүхийн ёсны хорооны Ажлын албаны хянан шалгагч референт Ж.Халиун, тэмдэглэл хөтөлсөн А.Энхбаатар), Ф аймгийн Л сум дахь “333” зоогийн газрын эзэн иргэн Б.Х-ээс 2017 оны 03 дугаар сарын 14-ний өдөр авсан тайлбар (асуулт тавьж тайлбар авсан Шүүхийн ёсны хорооны Ажлын албаны хянан шалгагч референт Ж.Халиун, тэмдэглэл хөтөлсөн А.Энхбаатар), Ф аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга Д.У-аас 2017 оны 03 дугаар сарын 14-ний өдөр авсан тайлбар (асуулт тавьж тайлбар авсан Шүүхийн ёсны хорооны Ажлын албаны хянан шалгагч референт Ж.Халиун, тэмдэглэл хөтөлсөн А.Энхбаатар), Ф аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн туслах Ц.У-аас 2017 оны 03 дугаар сарын 14-ний өдөр авсан тайлбар (асуулт тавьж тайлбар авсан Шүүхийн ёсны хорооны Ажлын албаны хянан шалгагч референт Ж.Халиун, тэмдэглэл хөтөлсөн А.Энхбаатар), Ф аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Н.Б-ын шүүн таслах ажиллагааны чанарын судалгаа зэрэг.

Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдаанаар гомдлыг хэлэлцээд ҮНДЭСЛЭХ нь:

Ф аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, гомдол гаргагч М.М Шүүхийн Ёс зүйн хороонд 2017 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр ирүүлсэн гомдолдоо “Тус аймаг дахь Цагдаагийн газраас 2017 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн нэр дээр ирүүлсэн албан мэдэгдлийг” дурдаж хавсралтаар хүргүүлсэн байх бөгөөд уг албан мэдэгдэлд “Энэхүү нөхцөл байдал Шүүгч, шүүхийн байгууллагын ажилтан нараас архи, согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэсэн үедээ, гудамж талбай, олон нийтийн газар хэрүүл маргаан үүсгэх, бусдын эрх чөлөөнд халдах, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зэрэг захиргааны зөрчлүүдэд удаа дараа холбогдох, Шүүхийн байгууллагын нэр хүнд, шүүгчийн ёс зүйг зөрчөөд зогсохгүй, гэмт хэрэг, зөрчилд холбогдох, гэмт халдлагад өртөж хохирох илүү ноцтой үр дагаварт хүргэж болзошгүй байна” гэжээ. Мөн, Ерөнхий шүүгч М.М “тус аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Н.Б нь шүүгчийн нэр хүндэд халдсан, сөргөөр нөлөөлж болзошгүй мэдээллийг өөрийн цахим хаягаар олон нийтэд тараасан байж болзошгүй тул холбогдох материалын хамт хүргүүлэв” гээд холбогдох материалыг хавсаргасан байна.

Ерөнхий шүүгч М.М-аас Шүүхийн Ёс зүйн хороонд ирүүлсэн гомдлын дагуу Шүүгчийн Ёс зүйн хороо холбогдох шалгалтыг явуулж, баримт, мэдээлэл цуглуулжээ. Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор Ф аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Н.Б-ыг шүүгчийн ёс зүйн зөрчил гаргасан гэж дүгнээд түүнд сахилгын хэрэг үүсгэсэн нь үндэслэлтэй байна.

Нэг. 2000 оны Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлд “6.5. Аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч харьяалах нутаг дэвсгэртээ согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг тогтооно” гэсэн хэсгийг 2015 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар нэмж баталсан байна. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6.5-д болон бусад хуульд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд Ф аймгийн Засаг дарга Цаг тогтоох тухай 2016 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/783 дугаартай захирамжийг гаргаж, уг захирамжийн хавсралтаар Л суманд Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй цэгүүдийн цагийн хуваарийг 09.00-01.00 цагийн хооронд

байхаар тогтоосон байсан. Гэтэл, Л сумын Н нэгдүгээр баг “333” зоогийн газар нь 2016 оны 12 дугаар сарын 23-ны шөнө Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчиж цагийн хуваарь хэтрүүлэн үйл ажиллагаа явуулсан Б.Х-ыг 50.000 төгрөгөөр 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр торгожээ. 2016 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн шөнө “333” зоогийн газар Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Ф аймгийн Засаг даргын захирамжаар тогтоосон цагийн хуваарийг зөрчин шөнийн 01.00 цагаас хойш ажиллаж байх үед шүүгч Н.Б, Ф аймгийн орлогч прокурор н.Б, шүүгчийн туслах н.Б, н.С, н.Э, Ц.У зэрэг хүмүүс уг зоогийн газарт согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн байх бөгөөд хоорондоо маргалдсан гэж үзэхээр байна (Захиргааны зөрчлийн талаар Н.Б-аас асуусан 2016 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн тэмдэглэл, Сахилгын хэргийн 21-22 дахь тал). “333” зоогийн газрыг хариуцан ажиллуулдаг Б.Х-ийн тайлбараар эдгээр хүмүүс “Дотроо хэрүүл хийгээд байх шиг байсан ... Согтуу улсууд манай ширээнд байсан халуун савыг хагалсан байсан. Тэрийгээ төлсөн (Сахилгын хэргийн 36 дахь тал).” Мөн, шүүгч Н.Б “Бид бүхэн тарж харьцгаах гээд тухайн газраас гарахад шүүгчийн туслах тухайн газрыг хариуцдаг найзтайгаа маргаад байсан учир боль гэж хориглосноос болж намайг хавсарч унагасан” гэсэн тайлбар өгчээ. Шүүгчийн туслах Ц.У-аас “Н.Б тай яагаад муудалцсан бэ” гэж асуухад “Н.Б шүүгч бид хоёр үл ойлголцоод болоод сүртэй зүйл болоогүй” гэсэн хариулт хэлжээ (Сахилгын хэргийн 42 дахь тал).

Монгол Улсын Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 2.3 дугаар зүйлийн 1-д “Шүүгч нь зохисгүй байдал гаргаж болохгүй бөгөөд бусдад ийнхүү ойлгогдохоос зайлсхийнэ” гээд “зохисгүй байдал” гэдгийг Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1.9-д тодорхойлсон утгаар ойлгоно гэж бичжээ. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1.9-д зааснаар “зохисгүй байдал” гэж хууль, хянан шийдвэрлэх ажиллагааны хэм хэмжээ, уг дүрмийг зөрчсөн, эсхүл шүүгчийн хараат бус, зарчимч, төвийг сахих байдлыг алдагдуулсан аливаа үйлдэл, эс үйлдэхгүйг хэлэх бөгөөд уг зүйлийн 1.4-т “зарчимч байдал” гэж хууль болон энэ дүрэмд заасан зарчмаа хэлбэрэлтгүй баримталж, үнэнч, шударга, ёс зүйн өндөр шаардлага хангасан байхыг хэлнэ гэж тодорхойлжээ.

Эрүүгийн болон бусад хууль зөрчсөн эсэхийг шийдвэрлэх чиг үүрэгтэй шүүгч Н.Б нь Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн дагуу батлагдсан цагийн хуваарийг хэтрүүлэн ажиллаж байсан зоогийн газарт бусадтай хамт согтууруулах ундаа хэрэглэж, Ц.У-тай маргаан үүсгэсэн байна. Шүүгч Н.Б эдгээр үйлдлээрээ хууль зөрчсөн үйл ажиллагаанд оролцсон, дэмжсэн, өөхшүүлсэн бөгөөд хууль дээдлэх зарчмыг бүрэн хүндэтгэдэггүй гэх ойлголтыг олон нийтэд төрүүлсэн учраас энэ нь шүүгчийн албан тушаалд тавигдах ёс зүйн өндөр шаардлагад нийцэхгүй юм. Иймд, шүүгч Н.Б зохисгүй байдал гаргаж, тийнхүү ойлгогдож, Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 2.3 дугаар зүйлийн 1-ийг зөрчжээ. Мөн, шүүгч Н.Б-ийн дээрх үйлдлүүд нь шүүгч зохисгүй байдлаас ангид байдаг гэсэн олон нийтийн итгэл, эерэг үнэлэмжийг алдагдуулсан тул Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.3.1-т “Шүүгч нь мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх” зарчмыг хувийн зан чанар болгож төлөвшүүлнэ гэснийг зөрчсөн байна.

Хоёр. Шүүгч Н.Б нь төвийг сахих, хараат бус байх зарчмуудыг тууштай баримталдаггүй гэсэн ойлголтыг олон нийтэд төрүүлжээ. “Төвийг сахих” гэж хэрэг, маргааны аль нэг талыг ялгаварлан гадуурхахгүй, түүнчлэн шүүгчийн зүгээс аливаа хууль зүйн асуудал, түүнийг шийдвэрлэхтэй холбоотой талуудын байр суурийг бүрэн сонсох, бодож эргэцүүлэх, хүлээн зөвшөөрөх эрмэлзэлтэй байхыг ойлгодог (Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1.10). Хараат бус байдал гэдэг бол бусдын нөлөөнд автахгүйгээр өөрийн

үндэслэлтэй итгэлээр шийдвэр гаргах байдал юм. Шүүгч Н.Б Ф аймгийн орлогч прокурор н.Б-тэй олон нийтийн газар шөнө дунд хүртэл хамт байж согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн (Сахилгын хэргийн 21, мөн Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны тэмдэглэл) нь прокурор н.Б-ийн яллах дүгнэлт үйлдсэн эсхүл түүний хяналт тавьсан эрүүгийн хэргийг хараат бусаар, төвийг сахиж шийдвэрлэнэ гэсэн олон нийтийн итгэлийг эвдсэн байна. Учир нь, уг үйлдэл нь шүүгч Н.Б болон орлогч прокурор н.Б хоорондоо ойр дотно харилцаатай, шүүгч Н.Б эрүүгийн хэргийг шийдвэрлэхдээ яллах талд тал засаж, энэ талын байр суурийн нөлөөнд автаж магадгүй гэсэн үндэслэл бүхий эргэлзээг үүсгэжээ.

Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 2.3 дугаар зүйлийн 1 болон Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1.9-д зааснаар шүүгчийн хараат бус, төвийг сахих байдлыг алдагдуулсан гэж ойлгогдох аливаа үйлдэл, эс үйлдэхүй нь зохисгүй байдал гаргасан гэж ойлгогддог тул шүүгч Н.Б нь шүүхийн захиргааны ажилчдын хамт орлогч прокурор н.Б-тэй хуулийн дагуу тогтоосон цагийн хуваарийг хэтрүүлэн шөнө дунд хүртэл олон нийтийн газар согтууруулах ундаа хэрэглэснээрээ Шүүгчийн ёс зүйн дүрмийн 2.3 дугаар зүйлийн 1-д “Шүүгч нь зохисгүй байдал гаргаж болохгүй бөгөөд бусдад ийнхүү ойлгогдохоос зайлсхийнэ” гэснийг зөрчжээ.

Шүүгч нар өөрийн шүүх хуралд оролцох болон оролцох магадлалтай прокурор, өмгөөлөгч нартай хамтран шинэ жил тэмдэглэх, нийлэх, согтууруулах ундаа хэрэглэх нь шүүгчийн хараат бус, зарчимч, төвийг сахих байдлыг алдагдуулсан зохисгүй гэж ойлгогдох үйлдэл, эс үйлдэхүй болох боломжтой. Иймд, Ф аймаг дахь шүүхүүдийн шүүгч нар зохисгүй гэж ойлгогдох ийм үйл ажиллагаанд оролцсон байж болзошгүй мэдээлэл цугларсан тул энэ тал дээр цаашид анхаарах нь зүйтэй гэж бүрэлдэхүүн дүгнэв. Жишээлбэл, Ф аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга Д.У-ийн хэлснээр тус аймаг дахь “шүүх, прокурор, өмгөөлөл 3 нийлээд Сөүл гээд буудалд шинэ жилээ тэмдэглэсэн” бөгөөд энэхүү шинэ жилийн арга хэмжээнд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийнхэн оролцоогүй гэжээ (Сахилгын хэргийн 41 дэх тал). Шүүгч Н.Б 2016 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Зөрчлийн талаарх тэмдэглэлд “2016 оны 12 дугаар сарын 12-ны өдөр хувийн асуудлаар ажлынхаа хэсэг хүмүүстэй Л сумын I баг 333 зоогийн газарт нийлсэн юм” гэж хэлсэн бол Шүүхийн Ёс зүйн хороонд 2017 оны 03 дугаар сарын 23-ны өдөр гаргасан тайлбартаа Ф аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн эрүүгийн хэргийн анхан шатны “шүүхээс шинэ жилийн баярын үйл ажиллагааг 333 зоогийн газарт явуулсан” гэжээ (Сахилгын хэргийн 12 дахь тал). Шүүгч Н.Б 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдрийн Нийт гишүүдийн хуралдаан дээр “Тусдаа шинэ жил тэмдэглэх асуудал гараад 24-нд эрүүгийн шүүхийнхэн шинэ жилээ тэмдэглэсэн тэр үйл ажиллагаанд хууль эрх зүйн хэлтсийн дарга, аймгийн орлогч прокурор, манай тамгын газрын хүмүүст шагнал урамшуулал гардуулах үйл ажиллагаа болно гээд 333 зоогийн газар шинэ жилийн үйл ажиллагаа тэмдэглэсэн” гэж мөн хэлсэн.

Гурав. Цагдаагийн газрын Жижүүрийн шуурхай албаны 7044102 дугаарын утсанд 2016 оны 12 дугаар сарын 24-ний шөнө 04 цаг 40 минутад шүүгчийн туслах Ц.У нь шүүгч

Н.Б-ийн эрх чөлөөнд халдлаа гэсэн дуудлагыг мэдээлсний дагуу жижүүрийн албанаас шуурхай очиж шалгаад хоёр зөрчлийг тогтоосон гэжээ (Ф аймаг дахь Цагдаагийн газрын 2017 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн Албан мэдэгдэл, Сахилгын хэргийн 3 дахь тал). Энэ албан мэдэгдэлд дурдагдсан нэг зөрчил нь “Дуудлагын дагуу тусламж үзүүлэхээр шуурхай очсон цагдаагийн алба хаагчдыг шүүгч Н.Б нь та нар Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэсгийн цагдаа нараа

бүгдийг нь дууд, би тэднээр хамгаалуулна гэсэн хууль бус шаардлагыг тавьсан” гэх асуудал юм. Хэдийгээр шүүгч Н.Б “Миний зүгээс тухайн албан хаагчаас намайг ингээд унасан байсан гэдгийг баримтжуулж зураг авах, эсхүл тэмдэглэл үйлдэхгүй юм уу гэхэд тийм шаардлагагүй гэхээр нь би уг нь шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэсэг рүү гээ л хэлсэн юм сан гэхэд тухайн алба хаагч тэд нарыг чинь дуудах юм уу гэхээр нь тэг гэхэд нэг байгууллагын хүмүүс байж хоорондоо учраа олоод явцгаа гээд яваад өгсөн” гэсэн тайлбар өгсөн (Сахилгын хэргийн 12 дахь тал) боловч түүнийг хууль бус шаардлага цагдаад тавьсан гэсэн зөрчил нотлогдохгүй байна.

“Тухайн өдөр нэр бүхий шүүгч, шүүгчийн туслах нар Ф сумын Н нэгдүгээр багт байрлах “333” зоогийн газарт шөнийн 04 цаг хүртэл хугацаанд үйлчлүүлж, улмаар гудамж талбай, олон нийтийн газарт хэрүүл маргаан үүсгэж шүүгчийн туслах Ц.У нь шүүгч Н.Б-г хавсарч унаган эрх чөлөөнд нь халдаж танхайрсан” гэсэн өөр нэг зөрчлийн талаар Ф аймаг дахь Цагдаагийн газрын 2017 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн Албан мэдэгдэлд дурджээ (Сахилгын хэргийн 3 дахь тал). Н.Б-ын гомдлын дагуу шалгаад 2016 оны 12 дугаар сарын 23-ны шөнө 04.00 цагийн орчимд Л сумын Н нэгдүгээр баг “333” зоогийн газрын гадаа архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ бусадтай маргалдаж бусдын амгалан тайван байдал алдагдуулсан зөрчил гаргасан хэмээн Ц.У-ыг 6.000 төгрөгөөр торгож шийтгэжээ (Захиргааны шийтгэл ногдуулах тухай 2017 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн шийдвэр, Сахилгын хэргийн 29 дэх тал).

Ф аймаг дахь Цагдаагийн хэсгийн байцаагч, цагдаагийн ахмад Г.А-ын асуултад шүүгч Н.Б хариулахдаа “Манай туслах Ц.У бол надтай 3, 4 дэх удаагаа барилцаж авч байгаа юм. Би бол Ц.У-т гар хүрсэн удаагүй,” “Энэ хүний ёс зүйтэй л холбоотой асуудал байгаа юм. Өөрөө эхэлчхээд буцаагаад цохиод авахаар бөөн юм болж гэмтэж бэртлээ гэдэг юм”, “Энэ хүний асуудлыг цааш нь авч хэлэлцэхгүй ингээд хаячихдаг болохоор энэ асуудлыг материалжуулж шийдвэрлүүлэх нь зүйлтэй байх. Ер нь бол удаа дараа ийм юм болж байлаа. Намайг бол энэ явдлаас өмнө 2 удаа барьж авсан, өөрийг нь цохихоор зодуулсан болдог. Ийм л ... байгаа юм” гэж хариулжээ (Захиргааны зөрчлийн талаар Н.Б-аас асуусан 2016 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн тэмдэглэл, Сахилгын хэргийн 21, 22 дахь тал).

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаан дээр шүүгч Н.Б шүүгчийн туслах Ц.У өөрийг нь цохихоор буцаагаад цохиж байсан гэдгээ мөн хүлээн зөвшөөрсөн. “2 удаа энэ хүн таны биед халдсан эргүүлээд та цохисон гэдэг зүйлийг энэ тэмдэглэлд 2 удаа хэлсэн байна. Энэ талаар тус тусад нь ярина уу? Яагаад харилцан цохисон вэ?” гэсэн Шүүхийн Ёс зүйн хорооны гишүүний асуултад шүүгч Н.Б дараах хариулт өгчээ: “Урьдын асуудал 2014, 2015 онд болсон. Ц.У омголон түргэн ааштай хүн л дээ. Өөрийнхөө үйлдлийг зөв гэж ойлгодог. Зарим үед хамт олны дунд сөрөг уур амьсгал бүрдүүлдэг. Тэрийг хэлэхээр эсэргүүцэж жаахан маргадаг. Барьж аваад эхлээд нэг цохихоор нь буцаагаад цохисон. Ерөнхий шүүгчид хэлэхэд наадах чинь ч намайг цохисон адил нэгнээ цохисон гэдэг ийм асуудал болдог. Үүнээс хойш Ц.У-тай ярилцаад ойлголцох шаардлага байхгүй юм байна холхон шиг байя гэдэг ойлголттой байгаа. Ерөнхий шүүгчид танай туслах намайг ингэлээ гэхэд Ц.У-г дуудаад яагаад ингэж байгаа юм бэ гэхэд ийм асуудлаас болж үл ойлголцоод бариад авсан цохихоор намайг зөрүүлээд цохисон би ч адил цохиулсан гэдэг (Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн Нийт гишүүдийн хуралдааны тэмдэглэл).”

Шүүгч Н.Б-ын тайлбаруудаар шүүгчийн туслах Ц.У шүүгч Н.Б-ийн эрх чөлөөнд удаа дараа буюу наад зах нь гурван удаа халдсан гэх бөгөөд энэ үед шүүгч Н.Б шүүгчийн туслах Ц.У-г хариу цохиж байжээ. Шүүгч Н.Б шүүгчийн туслах Ц.У-тай удаа дараа маргалдаж, өөрийнх нь эрх чөлөөнд халдахад энэ талаар

цагдаад мэдэгдэх, Ц.У-т сахилгын арга хэмжээ авхуулахаар Шүүхийн тамгын газрын даргад албан ёсоор хандах зэргээр хууль ёсны арга хэмжээ авах бүрэн боломжтой байсан ч ийм арга хэмжээ аваагүй байна. Үүний оронд шүүгч Н.Б Ц.У-г хариу цохиж байсан нь шүүгчийн хувьд зохисгүй үйлдэл юм. Учир нь, шүүгчийн туслах Ц.У-ийн шүүгч Н.Б-ийн эрх чөлөөнд халдсан үйлдлүүд нь хууль бус боловч шүүгч Н.Б уг хууль бус үйлдлийн хариуд Ц.У-г цохих замаар адилхан хууль бус арга удаа дараа хэрэглэсэн байна. Аливаа хүчирхийллийг хүчирхийллийн аргаар шийдвэрлэхийг хууль дээдэлсэн нийгэмд хүлээн зөвшөөрөх ёсгүй учраас ийм аргыг шүүгч сонгох нь зохисгүй бөгөөд зүй бус авир юм.

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1.9, 1.4-т зааснаар шүүгчийн хууль бус, зарчимч бус үйл ажиллагаа нь зохисгүй байдалд тооцогддог учраас шүүгч Н.Б-ийн шүүгчийн туслах Ц.У-г удаа дараа хариу цохиж байсан үйлдэл нь Монгол Улсын Шүүгчийн ёс зүйн дүрмийн 2.3 дугаар зүйлийн 1-д “Шүүгч нь зохисгүй байдал гаргаж болохгүй бөгөөд бусдад ийнхүү ойлгогдохоос зайлсхийнэ” гэсэн заалт, мөн Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27.1.19-д “шүүгч хэргийн оролцогч болон бусад этгээдтэй албан үүргийн хувьд харилцахдаа зүй бус авирлах”-ыг шүүгчид хориглосныг зөрчжээ.

Дөрөв. Ерөнхий шүүгч М.М-аас Шүүхийн Ёс зүйн хороонд хандаж ирүүлсэн 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 14 тоот албан бичигт “Шүүгч Н.Б нь шүүгчийн нэр хүндэд халдсан, сөргөөр нөлөөлж болзошгүй мэдээллийг өөрийн цахим хаягаар олон нийтэд тараасан байж болзошгүй” гэж зааж Аймгийн Засаг дарга Г.Б-тэй холбоотой олон нийтийн цахим сүлжээгээр шүүгч Н.Б-аас илэрхийлсэн хэмээн фейсбүүкээс авсан 4 хуудас баримт ирүүлсэн байна. Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 69 дүгээр тогтоолд энэхүү албан бичиг, хавсралт баримтыг “Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 3.1 дэх хэсэгт заасан Шүүгчийн ёс зүйтэй холбогдуулан албан тушаалтнаас гаргасан гомдол буюу шүүгч Н.Б-ийн талаар гаргаж байгаа гомдол гэж үзэхгүй” гээд энэ талаар дүгнэлт хийгээгүй нь алдаатай болжээ. Учир нь, шүүгч Н.Б-ийн фейсбүүк постын талаарх Ерөнхий шүүгч М.М-аас ирүүлсэн албан бичиг, түүнд хавсаргасан баримт нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 33.1-д заасан Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн тухай гомдолд хамаарах бөгөөд байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн гомдлыг “хүсэлт” гэсэн нэр томъёогоор уг хуулийн 34.1-д илэрхийлсэн байна. Иймд, Шүүхийн Ёс зүйн хороо шүүгч Н.Б-ийн фейсбүүк постын талаар дүгнэлт хийх шаардлагатай.

Шүүгч Н.Б “Ф-ын муу мэдээ” бүлгийн нийтэлсэн дараах постыг өөрийн фейсбүүк хуудастаа олон нийтэд хуваалцжээ (share хийжээ):

“Аймгийн Засаг дарга төсвийн мөнгөөр байр авсан МУУ мэдээ байна. Жаахан ажил хийе гэхээр эдийн засгийн хямрал гэж ам нээх болгондоо ярьж байдаг хүмүүс маань өөртөө зарцуулах болохоор хамаагүй бололтой. Аймгийн 2017 оны төсвийн тодотгол дээр Аймгийн Засаг дарга Г.Б өөртөө албан тушаалын байр авахаар улайран зүтгэсээр батлуулсан байна. Засаг дарга маань уг нь өөртөө хангалттай мөнгөтэй хүн дээ. Өмнөх жилүүдэд “PPP” ХХК-ийн орлогын 50 хувийг аймгийн төсөвт төвлөрүүлж бүтээн байгуулалтын ажлаа хийдэг байсан. Гэтэл шат шатны шүүхээр явсаар байгаад тус хувийг бууруулж аймагт орох орлогыг 3-хан хүн хувааж авдаг болсон. Түүний нэг бол Г.Б 17,5 хувийг эзэмшдэг. Тус дүнгээр бодоод үзэхэд 2016 онд 5 тэрбумын шлам борлуулсан. Үүний 17,5 хувь гэхээр 875,0 сая төгрөг болж байна. Ийм их орлоготой мөртөө ядруу төсвийн 52 сая төгрөгөөр байр авахыг эсэргүүцэж байгаа бол SHARE хийцгээнэ үү.”

Шүүгч Н.Б Б-ын муу мэдээ бүлэгт буй Засаг даргыг буруутгасан постыг өөрийн фейсбүүк хуудсаар олон нийтэд хуваалцах (share хийх)-даа дараах сэтгэгдлийг бичжээ: “Эмнэлэг цагдаагийн ажилчдын гэж орон сууц барьсан биз дээ. Б-ын

шүүхэд л гэхэд 8 айлын ажилчдын орон сууц байдаг. ЗДТГ-т ч бас байрны хэрэг юу байдаг юм бэ. Орон нутгийн иргэд нь л ажиллаж байгаа гэж бодно.

Өөр бас нэлээд хэдэн байр байдаг л байхдаа 2.1, 2.3, 2.4 дэх зардлаар өөр аймагтаа хэрэгтэй зүйл хиймээр юмаа. 156,0 сая төгрөгөөр юу хийж болох вэ. Хагархай замаа засварлах, Гэр хорооллын гэрэлтүүлгээ олшруулах, Замын тэмдэг, тэмдэглэгээг нэмэгдүүлэх, Гудамж талбайн тохижилт ногоон байгууламжийг нэмэх гэх мэтийн жижиг ажлуудаас эхлээд төрийн байгууллагуудын урсгал засварууд, ... дугаар сургуулийн спортын заал гээд зөндөө л хийх хөрөнгө оруулах юм байна даа. Ядахдаа л спорт хорооны агаар чийгшүүлэгчээ засмаар байна. Тэмцээнээр улс даяараа харсан шүү дээ."

"ДДД" нэртэй хүний тайлбарын дараа шүүгч Н.Б дараах тайлбарыг хийжээ:

"Хүний амьдрах нөхцөлийг шийдэх нь нэн чухал нь ч чухал гэхдээ эдгээр байгууллагуудад зөв зүгээр хоосон байр байж байгааг би сонссон бас мэдэх юм. Цуглуулсан төсвөө, миний татварт өгсөн татварыг энэ мэтээр үрээрээ гэж би лав иргэдийн төлөөлөгчөө сонгоогүй учраас л би ийм постыг хийлээ."

Шүүгч Н.Б дээрх мэдээллийг фейсбүүкээр бусадтай хуваалцсан нэг пост, мөн нэмэлт тайлбар (коммент) бичсэн гэдгээ хүлээн зөвшөөрсөн (Сахилгын хэргийн 12-13 дахь тал, Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны тэмдэглэл, Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн нийт гишүүдийн хуралдааны тэмдэглэл) бөгөөд сахилгын хэрэгт хавсаргагдсан пост болон комментын агуулгыг үгүйсгээгүй болно.

Ф аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга Д.У-аас гаргасан тайлбарт "2017 оны 02 дугаар сарын эхээр аймгийн ИТХ-ын ээлжит хурал хуралдаж төсвийн тодотгол оруулж цагдаа, шүүхийн дарга нарын албан тушаалын байрны асуудлыг шийдвэрлэхэд зориулж төсөвт тодорхой хэмжээний мөнгөн дүнг тусгаж өгсөн. Гэтэл шүүгч Н.Б нь тогтоол нь хүчин төгөлдөр болоогүй байхад фейсбүүкээр эсэргүүцэж "... нийгмийн асуудлыг шийдвэрлэхгүй үргүй зарцууллаа" гэх мэтээр үзэл бодлоо илэрхийлж байгаа нь хувь хүн талаасаа байгууллагынхаа гаргаж байгаа шийдвэрийг эсэргүүцсэн эсэргүүцлээ нийтэд цацав уу даа гэж бодогдсон, олон нийтийн хэрэгслээр хүмүүст буруу ташаа ойлголт өгсөн" гэжээ.

"Аймгийн 2017 оны төсвийн тодотгол дээр Аймгийн Засаг дарга Г.Б өөртөө албан тушаалын байр авахаар улайран зүтгэсээр батлуулсан," "Засаг дарга маань ...Ийм их орлоготой мөртөө ядруу төсвийн 52,0 сая төгрөгөөр байр авахыг эсэргүүцэж байгаа бол SHARE хийцгээнэ үү" зэрэг улс төрийн бодлогын маргаан үүсгэхүйц, Засаг даргыг буруутгасан шинжтэй мэдээг олон нийтийн цахим сүлжээгээр олон нийтэд хуваалцаж дэмжсэн пост бичсэн нь шүүгч Н.Б Засаг дарга, түүний тамгын газартай холбоотой хэрэг дээр төвийг сахиж чадна гэсэн олон нийтийн итгэлийг сэвтээсэн учраас энэ нь шүүхийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлнө. Үүгээрээ шүүгч Н.Б нь төвийг сахих зарчмыг баримталдаг гэсэн шүүгчийн нэр хүндийг сэвтээсэн байна.

Мөн, шүүгч Н.Б-ийн фейсбүүк хуудсаараа хуваалцсан мэдээнд "Өмнөх жилүүдэд "PPP" ХХК-ийн орлогын 50 хувийг аймгийн төсөвт төвлөрүүлж бүтээн байгуулалтын ажлаа хийдэг байсан. Гэтэл шат шатны шүүхээр явсаар байгаад тус хувийг бууруулж аймагт орох орлогыг 3-хан хүн хувааж авдаг болсон" гэж бичжээ. Ийм мэдээ нь аймгийн төсөвт төвлөрүүлдэг байсан орлогыг бууруулж гурван хүн хувааж авдаг болоход гурван шатны шүүхийг ашигласан бөгөөд шүүх ийм буруу зүйлд ашиглагддаг мэт сэтгэгдлийг төрүүлжээ. Шүүгч хүн бусад шүүх, шүүгчийн шийдвэрийг үл хүндэтгэсэн мэдээг бусадтай олон нийтийн цахим сүлжээгээр хуваалцсан нь өөрөө шүүх, шүүхийн шийдвэрийг үл хүндэтгэдэг гэсэн ойлголтыг

олон нийтэд төрүүлж, үүрэгт ажилдаа хүндэтгэлтэй ханддаг эсэхэд олон нийт эргэлзэх байдлыг бий болгожээ.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2-т зааснаар “шүүх эрх мэдлийн бие даасан, шүүгчийн хараат бус, халдашгүй байдлын үндсэн зарчмаас хамааран” “иргэдэд улс төрийн асуудлаар байр сууриа илэрхийлэх” шүүгчийн иргэний эрхэд хязгаарлалт тогтоодог. Ийм хязгаарлалтын нэг бол Шүүгчийн ёс зүйн дүрмийн 2.4.1-ийн “шүүгч олон нийтийн цахим мэдээ, мэдээллийн сүлжээ ашиглахдаа шүүх, шүүгчийн нэр хүндэд харшилсан, эсхүл шүүхийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх санал, сэтгэгдэл... мэдээ, мэдээлэл байршуулахыг хориглоно” гэсэн заалт юм. Шүүгч Н.Б шүүхийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, шүүх, шүүгчийн нэр хүнд харшилсан мэдээг бусадтай хуваалцаж, дэмжсэнээрээ хууль болон дүрмийн эдгээр заалтуудыг зөрчжээ.

Тав. Шүүгч Н.Б 2015 оны 12 дүгээр сарын 16-ны өдөр согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ маркийн ХХХ улсын дугаартай тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил гаргасны улмаас 2016 оны 01 дугаар сарын 10-ны өдөр Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасны дагуу 6 сарын хугацаагаар тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулж, 384,000 төгрөгөөр торгуулах шийтгэл хүлээжээ. Шүүгч Н.Б нь ийм зөрчил гаргаж хариуцлага хүлээж байсан гэдгээ өөрөө хүлээн зөвшөөрсөн (Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны тэмдэглэл).

Шүүгч Н.Б согтууруулах ундаа уусан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон дээрх зөрчил гаргаж, тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулах шийтгэл хүлээсэн талаар Ф аймаг дахь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгаас Ф аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Б.Г-д 2016 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн албан мэдэгдлээр мэдэгдэж байжээ. Гэвч, Ерөнхий шүүгч Б.Г энэ талаар Шүүхийн Ёс зүйн хороонд гомдол, хүсэлт гаргаж мэдэгдэх зэргээр шаардлагатай арга хэмжээ аваагүй байна. Ерөнхий шүүгч Б.Г Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Шүүгч нь бусад шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг үл тэвчинэ.” гэж заасныг мөрдөж ажиллах хэрэгтэйг дурдах нь зүйтэй.

Н.Б нь харьяаллын дагуу хуваарилагдаж ирсэн согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсонтой холбоотой гарсан эрүүгийн хэрэг болон захиргааны зөрчлийг шийдвэрлэдэг шүүгч хүн. Тодруулбал, тэрээр Ф аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд шүүгчээр ажиллаж, эрүүгийн хэрэг болон захиргааны зөрчил хянан шийдвэрлэдэг. Жишээлбэл, шүүгч Н.Б 2014 онд захиргааны зөрчлийн 70 хэрэг хүлээн авч 70-ыг шийдвэрлэж байжээ.

Согтууруулах ундаа хэрэглэсэн хүн самбаачлах, өөрийгөө удирдах чадвараа алддаг учраас энэ үедээ тээврийн хэрэгсэл жолоодвол өөрийнхөө төдийгүй бусдын амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгөнд ноцтой хохирол учруулах бодит эрсдэл үүсгэдэг учраас согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодохыг хатуу хориглож, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 7.3-т “тээврийн хэрэгсэл жолоодож яваа хүн” “согтууруулах ундаа хэрэглэхийг хориглоно” гэж заажээ. Энэхүү хориглолтыг зөрчвөл захиргааны хариуцлага хүлээлгэдэг, мөн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журмыг зөрчих гэмт хэргийг согтуугаар үйлдсэн бол илүү хүнд ялаар шийтгэдэг.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт “Согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон” бол “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, жолоодох эрхийг зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хасах

шийтгэл оногдуулна" гэж заажээ. Согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчлийг хянан шийдвэрлэх бүрэн эрхийг цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан хэрэгжүүлдэг боловч энэ талаарх шийдвэрт давж заалдах гомдлын талаар зохих дээд шатны эрх бүхий албан тушаалтны гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагааны талууд тухайн орон нутгийн шүүхэд гомдол гаргах эрхтэй (Захиргааны хариуцлагын тухай хуулийн 10, 19 дүгээр зүйл).

Монгол Улсын Эрүүгийн хуулиар тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журмыг зөрчих гэмт хэргийг согтуугаар үйлдсэн бол илүү хүндрүүлж үздэг. Шүүх ял оногдуулахдаа согтуурсан буюу мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэнийг хүндрүүлэх нөхцөл байдалд хамруулан үздэг (2002 оны Эрүүгийн хуулийн 56.1.10). Мөн, жолооч хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас бусдын бие махбодод хүндэвтэр гэмтэл, эсхүл үлэмж хэмжээний хохирол учирсан бол тээврийн хэрэгслийг хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих гэмт хэрэгт тооцож ял шийтгэл оногдуулдаг бөгөөд энэ хэргийг согтуугаар үйлдсэн бол илүү хүнд ялаар шийтгэдэг (2002 оны Эрүүгийн хуулийн 215.1, 2015.2).

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн хувьд Н.Б нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчилд гаргасан гомдлыг эсхүл согтуугаар үйлдсэн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журмыг зөрчих гэмт хэргийг шийдвэрлэдэг. Согтууруулах ундаа хэрэглэсэнтэй холбоотой зөрчил, гэмт хэргийг шийдвэрлэдэг шүүгч Н.Б өөрөө согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон нь согтууруулах ундаа хэрэглэхтэй холбоотой зөрчил, гэмт хэргийн учир холбогдол, хүний амь нас, эрүү мэнд, өмч хөрөнгийн үнэ цэнийг ойлгож хүлээн зөвшөөрдөг эсэхэд төдийгүй энэ төрлийн маргааныг хуулийн дагуу төвийг сахиж, шударгаар шийдвэрлэх эсэхэд олон нийт үндэслэлтэйгээр эргэлзэхэд хүргэжээ. Шүүгч иргэдийн нэгэн адил хуулийг ягштал биелүүлэх төдийгүй энэ тал дээр олон нийтэд үлгэр дуурайл болж байж, шүүх иргэн, байгууллага хууль биелүүлсэн эсэх маргааныг төвийг сахиж, шударга, хараат бусаар хянан шийдвэрлэдэг гэсэн олон нийт итгэлийг олж авдаг. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож бусдад хохирол учруулсан эсэх, хүний амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгийг хохироосон эсэх зэрэг хэргийг өдөр тутам шийдвэрлэдэг шүүгч байж Н.Б бусдад буруу үлгэр дуурайл үзүүлжээ.

Монгол Улсын шүүхэд ажиллаж буй аливаа шүүгч Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 16.1-д заасанчлан “Шүүгч би шүүх эрх мэдлийн ариун журамт үүрэг, Монгол Улсын Үндсэн хуульт байгуулал, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, хуулийг дээдлэн хамгаалж хэрэг, маргааныг хэнээс ч хараат бус, зөвхөн Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд нийцүүлэн шийдвэрлэж, шүүгчийн ёс зүйг чанд сахиж явахаа ард түмэндээ батлан тангараглая” гэсэн шүүгчийн тангарагтаа үнэнч байх үүрэгтэй. Гэвч, шүүгч Н.Б хуулийг дээдлэн хамгаалах үүргээ умартаж согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон хууль бус үйлдэл гарган, улмаар Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1-д заасан “хууль дээдлэх, мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх” зарчмуудыг, мөн уг дүрмийн 2.3-т “Шүүгч нь зохисгүй байдал гаргаж болохгүй” гэж заасныг тус тус зөрчиж байжээ.

Шүүгч жирийн иргэний адил хууль биелүүлэх үүрэгтэй бөгөөд үүнийг зөрчвөл хуульд заасан хариуцлага хүлээхээс гадна уг үйлдэл нь шүүгчийн ёс зүйг зөрчсөн бол давхар сахилгын хариуцлага хүлээдэг. Жишээлбэл, захиргааны зөрчил болон гэмт хэрэг нь давхар ёс зүйн зөрчил болох боломжтой. “Нэг зөрчилд давхар хариуцлага хүлээлгэж болохгүй” гэдэг бол нэг ёс зүйн зөрчилд хоёр удаа сахилгын хариуцлага хүлээлгэж болохгүй гэдгийг илтгэдэг гэдгийг дурдах нь зүйтэй.

Зургаа. Ф аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Б.Г- туслах Ц.У найман удаа арга хэмжээ авхуулж байжээ:

1.Ц.У нь 2016 оны 12 дугаар сарын 23-ны шөнө 04.00 цагийн орчимд Л сумын Н нэгдүгээр баг "333" зоогийн газрын гадаа архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ бусадтай маргалдаж бусдын амгалан тайван байдал алдагдуулсан зөрчил гаргасан тул 6.000 төгрөгөөр торгуулсан (Захиргааны шийтгэл ногдуулах тухай 2017 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн шийдвэр, Сахилгын хэргийн дахь тал 29),

2.Ц.У нь 2016 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн 00:00 цагт согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ Магк-х маркийн ... ХХХ улсын дугаартай тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцон хайс мөргөсөн зөрчил гаргасны улмаас 2016 оны 02 дугаар сарын 17-ны өдөр Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасны дагуу 6 сарын хугацаагаар тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулж, 384.000 төгрөгөөр торгуулсан (Захиргааны зөрчлийн шийдвэрлэлтийн бүртгэлийн хуулбар, Сахилгын хэргийн 26 дахь тал; Ф аймаг дахь цагдаагийн газрын замын цагдаагийн тасгаас тус аймгийн сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Б.Г-д 2016 оны 02 дугаар сарын 09-ний өдөр хүргүүлсэн албан мэдэгдлийн хуулбар, Сахилгын хэргийн 32 дахь тал),

3.Ц.У нь 2015 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 22:10 цагт 1-р багт согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг эсэргүүцэж эрх чөлөөнд халдсан зөрчил гаргаж 2015 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр торгуулийн арга хэмжээ авагдсан, эрүүлжүүлэгдсэн (Захиргааны зөрчлийн шийдвэрлэлтийн бүртгэлийн хуулбар, Сахилгын хэргийн 26 дахь тал; Ф аймаг дахь цагдаагийн газрын замын цагдаагийн тасгаас тус аймгийн сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Б.Г-д 2016 оны 02 дугаар сарын 09-ний өдөр хүргүүлсэн албан мэдэгдлийн хуулбар, Сахилгын хэргийн 32 дахь тал),

4.Ц.У нь 2014 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 14:00 цагт согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил гаргаж Захиргааны хариуцлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан (Захиргааны зөрчлийн шийдвэрлэлтийн бүртгэлийн хуулбар, Сахилгын хэргийн 26 дахь тал; Ф аймаг дахь цагдаагийн газрын замын цагдаагийн тасгаас тус аймгийн сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Б.Г-д 2016 оны 02 дугаар сарын 09-ний өдөр хүргүүлсэн албан мэдэгдлийн хуулбар, Сахилгын хэргийн 32 дахь тал),

5.Ц.У нь 2013 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 20:45 цагт 9 дүгээр багт согтуугаар танхайрсан, хэл амаар доромжилсон зөрчил гаргасан тул 4000 төгрөгөөр торгуулсан (Захиргааны зөрчлийн шийдвэрлэлтийн бүртгэлийн хуулбар, Сахилгын хэргийн 25 дахь тал),

6.Ц.У нь 2015 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 23:00 цагт согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ бусдын амгалан тайван байдал алдагдуулсан, агсан тавьсан гэсэн үндэслэлээр саатуулагдаж эрүүлжүүлэгдсэн (Захиргааны зөрчлийн шийдвэрлэлтийн бүртгэлийн хуулбар, Сахилгын хэргийн 26 дахь тал),

7.Ц.У нь 2013 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 01:00 цагт гэмт хэрэг зөрчилд өртөж болзошгүй гэсэн үндэслэлээр саатуулагдаж эрүүлжүүлэгдсэн (Захиргааны зөрчлийн шийдвэрлэлтийн бүртгэлийн хуулбар, Сахилгын хэргийн 25 дахь тал),

8.Ц.У нь 2013 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 23:15 цагт ... дүгээр баг "БББ" супер маркетэд согтуугаар танхайрсан зөрчил гаргасан тул 4000 төгрөгөөр торгуулсан (Захиргааны зөрчлийн шийдвэрлэлтийн бүртгэлийн хуулбар, Сахилгын хэргийн 25 дахь тал).

Дээр дурдсан баримтаас харахад шүүгчийн туслах Ц.У нь байнга согтууруулах ундаа хэрэглэдэг зөрчил гаргадаг гэж үзэхээр байна. Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ хоёр удаа тээврийн хэрэгсэл жолоодсон, үүнийхээ нэг дээр хайс мөргөсөн, нэг удаа цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг эсэргүүцэж эрх чөлөөнд нь халдсан, хоёр удаа бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан, хоёр удаа танхайрсан, үүнийхээ нэг дээр бусдыг хэл амаар доромжилсон, эдгээр зөрчилдөө тухай бүртээ захиргааны хариуцлага хүлээсэн, гурван удаа эрүүлжүүлэгдэж байжээ. Мөн, шүүгч Н.Б-ийн эрх чөлөөнд өмнө нь хоёр удаа халдаж, харилцан цохилцож байсан тухай тайлбарыг шүүгч Н.Б хийсэн. Хуулийг ноцтой зөрчсөн ийм зөрчлийг шүүхийн захиргааны ажилтан байнга гаргаж ирсэн нь шүүх, шүүгчид, шүүхийн захиргааны ажилтны нэр хүндийг унагажээ. Учир нь, хуулийг байнга зөрчдөг хүнийг шүүхийн захиргааны ажилтнаар ажиллуулдаг шүүх иргэд, байгууллага хууль зөрчсөн эсэх маргааныг шударгаар төвийг сахиж шийдвэрлэж чадах уу гэсэн эргэлзээг олон нийтэд үүсгэдэг.

Шүүгчийн туслах Ц.У-ийн үйлдсэн гурван удаагийн захиргааны зөрчил, түүнд авсан арга хэмжээний талаар Ф аймаг дахь цагдаагийн газрын замын цагдаагийн тасгаас тус аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Б.Г-д албан мэдэгдлийг 2016 оны 02 дугаар сарын 09-ний өдөр хүргүүлж байсан ч түүний эдгээр зөрчилтэй холбогдуулан сахилгын шийтгэл ногдуулаадахаар хандсан тухай баримт шалгалтын явцад цуглараагүй байна. Иймд Ерөнхий шүүгч Б.Г “Шүүгч өөрийн удирдлага дор ажиллаж байгаа албан хаагчдад ажил мэргэжилдээ үнэнч байх, чин сэтгэлээсээ хандаж ажиллахыг шаардаж, өөрийн эргэн тойронд ёс зүйн эрүүл орчныг бүрдүүлнэ” гэсэн үүргээ биелүүлж, шүүхийн захиргааны ажилтны ёс зүйг ноцтой зөрчсөн байж болзошгүй асуудлаар Шүүхийн захиргааны тухай хуулийн дагуу зохих албан тушаалтанд хандан шийдвэрлүүлэх нь зүйтэй байжээ. Шүүгчийн туслах Ц.У шүүхийн захиргааны ажилтны ёс зүй, тухайлбал Шүүхийн захиргааны тухай хуулийн 29.1.4-т “ажлын бус цагаар шүүхийн нэр хүндэд харшлах аливаа зохисгүй байдлыг гаргахгүй байх,” 29.1.5-д “шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа байгууллагад ажиллаж байгаадаа хүндэтгэлтэй хандаж, ажлын байр, олон нийтийн дунд биеэ зөв авч явах” зэрэг шаардлагуудыг ноцтой зөрчсөн байх тул энэ талаар Ф аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Б.Г тус шүүхийн тамгын газрын дарга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Т.М нарт тус тус мэдэгдэх нь зүйтэй гэж үзэв.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйл, 36 дугаар зүйлийн 36.1.1, 37 дугаар зүйлийн 37.1.2, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйл, Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.1, 5.13-г заасныг удирдлага болгон

ТОГТООХ нь:

1.Ф аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Н.Б-д 6 сарын хугацаагаар 20 хувиар цалинг бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Энэ магадлалын хувийг шүүгч болон гомдол гаргагчид хүргүүлэхийг Ажлын албанд даалгасугай.

3.Шүүгч, гомдол гаргагч магадлалыг эс зөвшөөрвөл гардан авснаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

4.Энэхүү магадлалын хувийг Ф аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Б.Г, тус шүүхийн Тамгын газар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Т.Мэндсайханд хүргүүлсүгэй.

ДАРГАЛАГЧ

Н.ЭРДЭНЭЦОГТ

ГИШҮҮН

О.МӨНХСАЙХАН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЁС ЗҮЙН ХОРООНЫ МАГАДЛАЛ

2017 оны 7 сарын 05 өдөр

Дугаар 47

Улаанбаатар хот

Л аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн
анхан шатны шүүхийн шүүгч Б.Г-д
сахилгын шийтгэл ногдуулах тухай

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааныг Ёс зүйн хорооны гишүүн

Н.Эрдэнэцогт даргалж, гишүүн О.Мөнхсайхан, Ч.Оюунцэцэг, Н.Ганбаяр, А.Доржготов нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны тэмдэглэл хөтлөгчөөр ажлын албаны шинжээч А.Энхбаатар, хяналт шалгалт хариуцсан референт А.Баасанжав, шүүгч Б.Г, гомдол гаргагч Ч.Ч нарыг цахимаар оролцуулан Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдааны танхимд хийв.

Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 90 дүгээр тогтоолыг эс зөвшөөрч нийт гишүүдийн хуралдаанд гомдол гаргасныг Шүүхийн Ёс зүйн хорооны гишүүн Н.Ганбаярын илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Гомдол гаргагч Ч.Ч Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан гомдолдоо:

Л аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Г нь иргэн Ч.Ч миний биед холбогдох бусдыг гутааж, гүтгэсэн хуурамч мэдээ, мэдээллийг олон нийтэд тараасан зөрчлийг хянан шийдвэрлэхдээ дараах ёс зүйн зөрчлийг гаргасан байна. Үүнд:

Хэргийг хянан шийдвэрлэхдээ Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.14-т заасан "өөрөө өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шүүх ажиллагаанд биеэр оролцох" эрхийг бүдүүлгээр зөрчиж Сонгуулийн тухай хуулийн 70.5.13 дахь заалтыг зөрчсөн гэж үзэж захиргааны хариуцлага ногдуулсан. Тухайн үед Сонгуулийн тухай хуульд заасан захиргааны зөрчил, хэрэг маргааныг сонгуулийн цаг хугацаа, нөхцөл байдалтай холбогдуулан шуурхай шийдвэрлэх зөвлөмжийг улс орон даяар өгсөн байсан. Гэвч хэдий шуурхай шийдвэрлэх зарчим баримталж байсан ч энэ нь хүний эрхийг зөрчих, эрхээр хангахгүй байх үндэслэл биш юм.

Миний бие 2016 оны 8 дугаар сарын 11-ний өдөр зөрчилтэй холбоотой тайлбарыг цагдаад өгсөн байдаг ба шүүгч Б.Г нь 2016 оны 8 дугаар сарын 12-ны өдөр шүүх хурлыг хийж надад хариуцлага ногдуулсан байдаг.

Шүүгч Б.Г-ийн гаргасан Л аймгийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 43 тоот шийтгэвэрт шүүгч тодорхойлохдоо ... сонгуулийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1- д "Нам, Эвслийн сонгуулийн штабын бүрэлдэхүүнд нам, эвслийн дарга, түүнтэй адилтгах албан тушаалтнаас гадна түүний ажилтан хамаарна" гэж заасан байгаад Ч.Ч хамаарахгүй байна. Учир нь Ч.Ч нь тухайн үед Л аймгийн АН-ын дарга, дэд дарга, ажлын албаны ажилтнаар ажиллаж байгаа, Л аймгийн ИТХ-

ын даргаар ажиллаж байсан бөгөөд Л аймгийн ИТХ-ын сонгуулийн 26-р тойрогт нэр дэвшиж байжээ" гэж дурдсан байдаг.

Уг хэрэгтэй холбогдуулсан байцаалтыг Ч.Ч надаас Л аймгийн Цагдаагийн хэлтсийн мөрдөн байцаагч Я.Б 2016 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн үд орчимд авсан. Энэ үед би өгсөн тайлбартаа энэ бол иргэн болон нэр дэвшигч Ч.Ч-ийн хүсэл зоригоор хийсэн асуудал бишээ гэдгийг тайлбарлаад надад энэ мэдэгдэл хийх үүргийг намаас өгсөн энэ бол Л аймгийн Ардчилсан намын улс төрийн мэдэгдэл гэж мэдүүлэг өгсөн. Мэдүүлэг өгөх үед би мөрдөн байцаагчид энэ мэдэгдлийг би нам төлөөлж хийх эрхтэй хүн юм гэдгээ тайлбарлаад холбогдох баримт өгөх боломжтойгоо хэлсэн.

Мөрдөн байцаагч энэ бол таныг анх удаагаа байцааж байгаа асуудал таны анхны мэдүүлгийг шүүгчид танилцуулаад эргэж танд танилцуулна тэр үед та баримтаа нэмж өгч болно гэж надад тайлбарласан. Энэ мэдэгдэл намын мэдэгдэл байсан, надад хамаарахгүй асуудал гэж мэдүүлэг өгсөөр байхад шүүгч энэ мэдэгдлийг хэн захиалсан, ТВ-ийн төлбөр хэн төлсөн, Ч.Ч нам төлөөлөх хүн мөн эсэх, намаас Ч.Ч-д мэдэгдэл хийх үүрэг өгсөн эсэхийг тодруулахгүйгээр надад хариуцлага хүлээлгэсэн үйлдлийг нэг талыг барьсан, шүүгчийн ёс зүйн алдаатай үйлдэл гэж би үзэж байна.

Ингэхдээ хавтаст хэрэг шүүхэд шилжсэн, хурлын тов тогтоосон, эрх, үүрэг тайлбарлах, шүүх хуралдаа биечлэн оролцох эсэх, өмгөөлөгч авах эсэх талаар огт мэдэгдэж асуугаагүй юм.

Гэтэл "Захиргааны хариуцлагын тухай хууль"-ийн 9 дүгээр зүйлд Зөрчил гаргасан этгээд 1/ зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд биеэр оролцох, 2/ нотлох баримттай танилцах, 3/ зөрчлийн талаар тайлбар өгөх, нотлох баримт, хүсэлт гаргах, 4/ хууль зүйн туслалцаа авах эрхтэй гэж заасныг шүүгч зөрчсөн.

"Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм"-ийн 1 дүгээр зүйлийн 1.3-т "Шүүгч нь хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, хууль дээдлэх, үнэнч шударга байх, аливаа асуудалд бодитой, төвийг сахисан байр сууринаас хандах, хараат бус байх, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандах, нууцыг задруулахгүй байх, мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх зэрэг зарчмуудыг хувийн зан чанар болгож төлөвшүүлнэ", 3.3-т "Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй" гэж тус тус заасан.

Энэ нь шүүгч Үндсэн хуульд заагдсан миний эрхийг зөрчихөөс гадна хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандах үүргээ огт биелүүлээгүй гэж үзэхээр байна.

Энэ маргаануудад хариуцагч Ч.Ч миний цагдаагийн байгууллагаар шалгуулан шүүхэд шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн Л аймгийн ИТХ-ыг сонгох сонгуулийн 26 дугаар тойрогт надтай өрсөлдсөн С.А-ийн талаарх зөрчлийн маргааны хэрэг байсан юм. Л аймгийн сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн надад өгсөн мэдээллээр Ч.Ч миний гаргасан гомдлыг шийдвэрлүүлэхээр харьяаллын бус Ц аймгийн сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд шилжүүлсэн байсан. Би шүүхээс учрыг нь лавлахад таны С.А-ийн талаар цагдаад гаргасан зөрчлийн хэрэг шүүгч Б.Г--д хуваарилагдсан боловч Б.Г шүүгч би "Ч.Ч аймгийн ИТХ-ын дарга байхдаа С.А-ийн талаар гаргасан эрүүгийн хэргийн өмгөөлөгчөөр ажиллаж байсан тул энэ хэргийг шийдвэрлэхээс татгалзаж байна" гэсний дагуу Ц аймгийн шүүхэд шилжүүлсэн гэсэн тайлбар өгсөн.

Шүүгч Б.Г нь миний гаргасан С.А-д холбогдох хэргийг шийдвэрлэхээс татгалзсан атлаа миний талаар шүүхэд гаргасан сонгуулийн хууль зөрчсөн тухай гомдлыг хүлээн авч хариуцагч надаас холбогдох өмнө гаргасан гомдолд дурдсан баримтуудыг гаргуулахгүйгээр яаран сандран шийдвэр гаргасан үйлдэл нь шүүгч болохоос өмнө өмгөөлөгчийн үйлчилгээ үзүүлж байсан үйлчлүүлэгч болох

С.А-д давуу тал /Л аймгийн ИТХ-д сонгогдох/ үүсгэсэн шийдвэрийг шүүгчийн эрх мэдэлдээ тулгуурлан гаргасан хууль бус үйлдэл гэж үзэж байна гэжээ.

Мөн гомдол гаргагч Ч.Ч Ёс зүйн хороонд гаргасан тайлбар, нотлох баримтдаа:

Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн Л аймгийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүгч Б.Г-д холбогдох гомдлыг дахин шалгах аар хойшлуулах тухай 23 тоот магадлалыг 2017 оны 3 дугаар сарын 18-ны өдөр хүлээн авч танилцлаа. Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанаас гаргасан шалган тодруулах шаардлагатай гэсэн дүгнэлтийн хүрээнд дараах тайлбар, нотлох баримтыг хүргэж байна. Миний бие Ч.Ч 2017 оны 02 дугаар сарын 22-ны өдөр Л аймгийн прокурорын газрын дарга Г.Э-д С.А-д холбогдох Эрүүгийн хэргийн тусгай ангийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэгт зааснаар эрүүгийн 201520000017 дугаартай хэрэг үүсгэн шалгах үеийн хэргийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцсон өмгөөлөгч Б.Г-ийн талаарх мэдээллийг гаргаж өгөхийг хүссэн хүсэлтэд прокурорын газраас 5/11 тоотыг надад ирүүлж холбогдох мэдээллийг Шүүхийн Ёс зүйн хороонд эрх зүйн харилцан туслалцах гэрээний хүрээнд гаргаж өгөх боломжтойг тус газрын дарга Г.Э танилцуулсан болно. Мөн Ч.Ч миний С.А-д холбогдуулан гаргасан сонгуулийн хуулийн зөрчилтэй маргааныг харьяаллын бус Х аймгийн шүүхэд шилжүүлсэн шалтгааны тайлбарыг гаргаж өгөх хүсэлтэд Л аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн ерөнхий шүүгч Л.А дараах тайлбарыг 17 тоотоор өгч, мөн эрх зүйн харилцан туслалцах гэрээний хүрээнд Ц аймаг дахь Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс авах боломжтойг танилцууллаа.

Шалган тодруулах үйл ажиллагаанд нотлох баримт болох Л аймгийн Сонгуулийн хорооны гаргасан аймгийн ИТХ-ын 26 дугаар тойрогт нэр дэвшигч Ч.Ч, С.А-д холбогдох баримтуудыг Л аймгийн архиваас авч Шүүхийн Ёс зүйн хороонд уламжилж байна. Нийт 9 ширхэг 16 хуудас баримтыг хавсаргав.

1.Л аймгийн прокурорын газрын дарга Г.Э-д гаргасан хүсэлт 1 хуудас,

2.Л аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн ерөнхий шүүгч Л.А-д гаргасан хүсэлт 1 хуудас,

3.Л аймгийн прокурорын газрын дарга Г.Э-ын 5/11 тоот 1 хуудас,

4.Л аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн ерөнхий шүүгч Л.А-ны 17 тоот 1 хуудас,

5.Л аймгийн Сонгуулийн хорооны 2016 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 06 тоот нэр дэвшигчдийг бүртгэх тухай тогтоол 2 хуудас,

6.Л аймгийн Сонгуулийн хорооны 2016 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн 11 тоот нэр дэвшигчийг бүртгэх тухай тогтоол 2 хуудас.

7.Л аймгийн Иргэдийн төлөөлөгчийн хурлын Сонгуулийн саналын хуудасны загвар 1 хуудас,

8.Л аймгийн Цагдаагийн хэлтэс, Л аймгийн Сонгуулийн хороонд Ч.Ч миний бие С.А-тай холбогдуулан гаргасан гомдол, өргөдөл 4 хуудас.

9.Л аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 32 тоот захирамж, 3 хуудас.

Л аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Г-ийн ёс зүйн зөрчлийг зохих журмын дагуу шалгаж Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан сахилгын шийтгэл ногдуулж өгнө үү гэжээ.

Шүүгч Б.Г Шүүхийн Ёс зүйн хороонд ирүүлсэн тайлбартаа:

Л аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Г миний бие Ч.Ч-ийн гомдлыг 2016 оны 10 дугаар сарын 07-ны өдөр хүлээн авч танилцаад дараах тайлбарыг гаргаж байна.

Ч.Х-ээс Ч.Ч нь Сонгуулийн тухай хууль зөрчсөн талаар гаргасан гомдлыг Л аймгийн Цагдаагийн газраас шалгаж захиргааны зөрчлийн материалыг ирүүлснийг

2016 оны 8 дугаар сарын 11-ний өдөр хүлээн авч хянахад Ч.Ч-ийн гаргасан зөрчил нь нотлогдсон, процессын зөрчилгүй байсан тул 2016 оны 8 дугаар сарын 12-ны өдөр тухайн зөрчилд нь Захиргааны шийтгэл ногдуулж 43 дугаартай шийтгэвэр гаргасан.

Миний бие тус шүүхэд ирсэн Сонгуулийн тухай хууль зөрчсөн талаарх захиргааны зөрчлийн материалыг Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолын дагуу хүлээн авч шийдвэрлэсэн. Ингэхдээ тухайн маргааны онцлогоос хамааран хурдан шуурхай байх зарчмыг баримталж ажиллаж, нийтдээ 40 орчим сонгуулийн маргааныг шийдвэрлэсэн.

Сонгуулийн гэлтгүй аливаа захиргааны зөрчлийн материалыг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэх дэг, дараалал тогтоосон хууль байхгүй тул хуралдаанаар хэлэлцэхгүйгээр шийдвэрлэдэг. Харин гомдол гаргагч, зөрчилд холбогдогчийн зүгээс шүүх хуралдаанд биечлэн оролцох хүсэлт гаргасан тохиолдолд шүүх хуралдааны тов мэдэгдэж, хуралдааныг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан дэгийн дагуу явуулдаг шүүхийн практик тогтсон байдаг. Энэ жишгийн дагуу дээрх зөрчлийн материалыг шийдвэрлэсэн болно.

Зөрчлийн материалд Ч.Ч өмгөөлөгч авсан, шүүх хуралдаанд оролцох талаар гаргасан хүсэлт авагдаагүй, Захиргааны хариуцлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрхийг тайлбарлаж гарын үсэг зуруулсан, зөрчилд холбогдуулан тайлбар авсан, зөрчлийн материал танилцуулж гарын үсэг зуруулсан баримтууд тус тус авагдсан байсан болно.

2016 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 43 дугаартай шийтгэвэрт давж заалдах гомдол гаргасныг ...Эрүүгийн Давж заалдах шатны шүүх 2016 оны 8 дугаар сарын 30-ны өдөр хянаад 30 дугаартай магадлал гаргасан байна.

Магадлалаар анхан шатны шүүхийн шийтгэвэрт хууль хэрэглээний өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн нь дээрх зөрчлийн анхан шатны журмаар хянан шийдвэрлэхдээ процессын алдаа гаргаагүйг нотолж байна.

Ч.Ч нь намайг процессын алдаа гаргасан гэсэн утга агуулга бүхий гомдол гаргасан байгаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй байгаа тул сахилгын хэрэг үүсгэх үндэслэл болохгүй гэж үзэж байна.

Б.Г миний бие Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 23 дугаартай магадлал, гомдол гаргагч Ч.Ч-ийн 2017 оны 3 дугаар сарын 21-ний өдөр гаргасан тайлбар, нотлох баримтуудыг хүлээн авч танилцаад дараах тайлбарыг гаргаж, нотлох баримтын хамт хүргүүлж байна.

Миний бие өмгөөлөгчөөр ажиллаж байхдаа Л аймгийн ИТХ-ын даргаар ажиллаж байсан Ч.Ч-ийн гомдлоор сэтгүүлч С.А-д холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэгт зааснаар эрүүгийн хэрэг үүсгэсэн хэрэгт С.А-ийн өмгөөлөгчөөр ажиллаж байсан.

Уг хэргийг 2015 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 112 дугаартай Прокурорын тогтоолоор хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Ч.Ч нь Л аймгийн ИТХ-ын сонгуулийн 26 дугаар тойрогт нэр дэвшиж байхдаа өрсөлдөгч болох С.А нь Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн талаарх гомдлыг 2016 оны 6 дугаар сарын 20-ны өдөр Л аймгийн Цагдаагийн газарт гаргасныг шалгаж ирүүлснийг 2016 оны 6 дугаар сарын 22-ны өдөр хүлээн авч танилцахад миний урьд нь өмгөөлөгчөөр оролцож байсан С.А-т холбогдуулан Эрүүгийн хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэгт зааснаар эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж, 2015 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 112 дугаартай Прокурорын тогтоолоор хэрэгсэхгүй болгосон хэргийн талаар болон уг хэргийн үйл баримтуудын талаар дурдсан байсан тул 2016 оны 6 дугаар сарын 23-ны өдөр уг зөрчлийн материалыг хянан шийдвэрлэх боломжгүй гэж үзэж татгалзан гарах хүсэлтээ Ерөнхий шүүгчид гаргасан.

Миний хүсэлтийг Ерөнхий шүүгч хүлээн авах нь зүйтэй гэж шийдвэрлэсэн тул уг зөрчлийн материалыг шийдвэрлэх ажиллагаанаас гарсан болно.

Ч.Х-ийн гомдолтой Ч.Ч-д холбогдох захиргааны зөрчлийн материалыг 2016 оны 8 дугаар сарын 11-ний өдөр хүлээн авч танилцахад дээр дурдагдсан С.А-д холбогдох эрүүгийн хэрэгт огт хамааралгүй асуудал байсан тул хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу уг зөрчлийг хянан шийдвэрлэсэн.

Гомдол гаргагч Ч.Ч- гомдолдоо "Шүүгч болохоосоо өмнө өмгөөлөгчийн үйлчилгээ үзүүлж байсан үйлчлүүлэгч болох С.А-д давуу тал /Л аймгийн ИТХ-д сонгогдох/ олгож шийдвэрлэсэн нь шүүгчийн эрх мэдэлдээ тулгуурлан гаргасан хууль бус үйлдэл гэж үзэж байна." гэжээ.

Гэтэл аймгийн ИТХ-ийн сонгууль 2016 оны 6 дугаар сарын 29-нд болоод өнгөрчихсөн байхад 2016 оны 8 дугаар сарын 11-ний өдөр гарсан шийтгэвэр сонгуулийн үр дүнд нөлөөлсөн гэж гомдол гаргаж байгаа нь бодит байдалд үл нийцэх үндэслэлгүй гомдол байгааг анхааран үзэж, сахилгын хэрэг үүсгэхээс татгалзаж өгнө үү. Тайлбарт:

1. 2016 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн "Татгалзан гарах тухай" хүсэлтийн хуулбар,

2. Л аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн 2016 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн "Шүүгчийн татгалзан гарах хүсэлт шийдвэрлэх тухай" захирамжийг тус тус хавсаргав гэжээ.

Шүүгч Б.Г нийт гишүүдийн хуралдаанд гаргасан тайлбартаа:

Л аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Г миний бие Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 90 дүгээртэй тогтоолыг хүлээн аваад дараах тайлбарыг гаргаж байна.

Ч.Х-ээс Ч.Ч нь Сонгуулийн тухай хууль зөрчсөн талаар гаргасан гомдлыг Л аймгийн Цагдаагийн газраас шалгаж захиргааны зөрчлийн материалыг ирүүлснийг 2016 оны 8 дугаар сарын 11-ний өдөр хүлээн авч хянахад Ч.Ч-ийн гаргасан зөрчил нь нотлогдсон, процессын зөрчилгүй байсан тул 2016 оны 8 дугаар сарын 12-ны өдөр тухайн зөрчилд нь Захиргааны шийтгэл ногдуулж 43 дугаартай шийтгэвэр гаргасан.

Миний бие тус шүүхэд ирсэн Сонгуулийн тухай хууль зөрчсөн талаарх захиргааны зөрчлийн материалыг Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор Ерөнхий шүүгчээс бусад шүүгч шийдвэрлэнэ гэж заасны дагуу хүлээн авч шийдвэрлэсэн. Ингэхдээ тухайн маргааны онцлогоос хамааран хурдан шуурхай байх зарчмыг баримтлан ажиллаж, нийтдээ 40 орчим сонгуулийн маргааныг шийдвэрлэсэн.

Тухайн үед Ерөнхий шүүгч Л.А болон миний биеэс өөр шүүгч байгаагүй болно. Захиргааны зөрчлийн материалыг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэх дэг, дараалал тогтоосон хууль байхгүй тул хуралдаанаар хэлэлцэхгүйгээр шийдвэрлэдэг. Харин гомдол гаргагч, зөрчилд холбогдогчийн зүгээс шүүх хуралдаанд биечлэн оролцох хүсэлт гаргасан тохиолдолд шүүх хуралдааны тов мэдэгдэж, хуралдааныг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан дэгийн дагуу явуулдаг шүүхийн практик тогтсон байдаг.

Энэ зөрчлийн материалд Ч.Ч нь өмгөөлөгч авсан, шүүх хуралдаанд оролцох талаар гаргасан хүсэлт авагдаагүй, Захиргааны хариуцлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрхийг тайлбарлаж гарын үсэг зуруулсан, зөрчилд холбогдуулан тайлбар авсан, зөрчлийн материал танилцуулж гарын үсэг зуруулсан баримтууд тус тус авагдсан байсан тул шүүх хуралдаан хийхгүйгээр шийтгэвэр гаргаж шийдвэрлэсэн болно.

2016 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 43 дугаартай шийтгэвэрт давж заалдах гомдол гаргасныг Нийслэлийн Эрүүгийн Давж заалдах шатны шүүх 2016 оны 8 дугаар сарын 30-ны өдөр хянаад 30 дугаартай магадлалаар анхан

шатны шүүхийн шийтгэвэрт хууль хэрэглээний өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн нь дээрх зөрчлийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэхдээ процессын алдаа гаргаагүй, зөрчилд холбогдогчийн эрхийг зөрчөөгүй болохыг нотолж байна.

Ч.Ч нь намайг процессын алдаа гаргасан гэсэн утга агуулга бүхий гомдол гаргасан байгаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй байгаа тул сахилгын хэрэг үүсгэх үндэслэлгүй гэж үзэж байна.

Миний бие өмгөөлөгчөөр ажиллаж байхдаа Л аймгийн ИТХ-ын даргаар ажиллаж байсан Ч.Ч-ийн гомдлоор сэтгүүлч С.А-д холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэгт зааснаар эрүүгийн хэрэг үүсгэсэн хэрэгт С.А-ийн өмгөөлөгчөөр ажиллаж байсан.

Уг хэргийг 2015 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 112 дугаартай Прокурорын тогтоолоор хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Ч.Ч нь Л аймгийн ИТХ-ын сонгуулийн 26 дугаар тойрогт нэр дэвшиж байхдаа өрсөлдөгч болох С.А нь Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн талаарх гомдлыг 2016 оны 6 дугаар сарын 20-ны өдөр Л аймгийн Цагдаагийн газарт гаргасныг шалгаж ирүүлснийг 2016 оны 6 дугаар сарын 22-ны өдөр хүлээн авч танилцахад миний урьд нь өмгөөлөгчөөр оролцож байсан С.А-д холбогдох дээрх хэргийн талаар болон уг хэргийн үйл баримтуудын талаар дурдсан байсан тул 2016 оны 6 дугаар сарын 23-ны өдөр уг зөрчлийн материалыг хянан шийдвэрлэх боломжгүй гэж үзэж татгалзан гарах хүсэлтээ Ерөнхий шүүгчид гаргасан.

Миний хүсэлтийг Ерөнхий шүүгч хүлээн авах нь зүйтэй гэж шийдвэрлэсэн тул уг зөрчлийн материалыг шийдвэрлэх ажиллагаанаас гарсан болно.

Ч.Х-ийн гомдолтой Ч.Ч-д холбогдох захиргааны зөрчлийн материалыг 2016 оны 8 дугаар сарын 11-ний өдөр хүлээн авч танилцахад дээр дурдагдсан С.А-д холбогдох эрүүгийн хэрэгт огт хамааралгүй асуудал байсан тул хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу уг зөрчлийг хянан шийдвэрлэсэн.

Гомдол гаргагч Ч.Ч гомдолдоо "Шүүгч болохоосоо өмнө өмгөөлөгчийн үйлчилгээ үзүүлж байсан үйлчлүүлэгч болох С.А-д давуу тал /Л аймгийн ИТХ-д сонгогдох/ олгож шийдвэрлэсэн нь шүүгчийн эрх мэдэлдээ тулгуурлан гаргасан хууль бус үйлдэл гэж үзэж байна." гэжээ.

Гэтэл аймгийн ИТХ-ын сонгууль 2016 оны 6 дугаар сарын 29-нд болоод өнгөрчихсөн байхад 2016 оны 8 дугаар сарын 11-ний өдөр гарсан шийтгэвэр сонгуулийн үр дүнд нөлөөлсөн гэж гомдол гаргаж байгаа нь бодит байдал үл нийцэх үндэслэлгүй гомдол байна.

Иймд Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 90 дүгээртэй тогтоолыг хүчингүй болгож өгнө үү гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанаар гомдлыг хэлэлцээд **ҮНДЭСЛЭХ** нь:

Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 90 дүгээр тогтоолоор шүүгч Б.Г-д сахилгын хэрэг үүсгэж шийдвэрлэжээ.

Гомдол гаргагч Ч.Ч-ээс "бусдыг гутааж, гүтгэсэн хуурамч мэдээ, мэдээллийг олон нийтэд тараасан, Сонгуулийн тухай хуулийн 70.5.13 дахь заалтыг зөрчсөн гэж үзэж захиргааны хариуцлага ногдуулсан шийтгэвэр гаргахдаа шүүгч Б.Г зөрчилд холбогдогч иргэн Ч.Ч надад мэдэгдээгүй, надад хамааралгүй асуудлаар шийтгэвэр гаргаж шийтгэл ногдуулахдаа Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.14-т заасан "өөрөө өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шүүх ажиллагаанд биеэр оролцох" миний эрхийг зөрчиж, "Захиргааны хариуцлагын тухай хууль"-ийн 9 дүгээр зүйлд Зөрчил гаргасан этгээд 1/ зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд биеэр оролцох, 2/ нотлох баримттай танилцах,

3/ зөрчлийн талаар тайлбар өгөх, нотлох баримт, хүсэлт гаргах, 5/ хууль зүйн туслалцаа авах эрхтэй гэсэн заалтыг зөрчсөн.

Мөн Ч.Ч миний гомдлоор Л аймгийн ИТХ-ыг сонгох сонгуулийн 26 дугаар тойрогт надтай өрсөлдсөн С.А-ийн талаарх цагдаагийн байгууллагаар шалгуулсан зөрчлийн маргааныг шүүхэд ирэхэд нь Ц аймгийн сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд шилжүүлсэн байсан. Шүүхээс “зөрчлийн хэрэг шүүгч Б.Г-д хуваарилагдсан боловч шүүгч нь “Ч.Ч аймгийн ИТХ-ын дарга байхдаа С.А-ийн талаар гомдол гаргасан, С.А-ийн эрүүгийн хэргийн өмгөөлөгчөөр нь би ажиллаж байсан тул энэ хэргийг шийдвэрлэхээс татгалзаж байна” гэсэн тул Ц аймгийн шүүхэд хэргийг шилжүүлсэн” гэсэн. Гэтэл миний талаар шүүхэд гаргасан Сонгуулийн хууль зөрчсөн тухай гомдлыг хүлээн авч яаран сандран шийдвэр гаргасан үйлдэл нь шүүгч болохоос өмнө өмгөөлөгчийн үйлчилгээ үзүүлж байсан үйлчлүүлэгч болох С.А-д давуу тал /Л аймгийн ИТХ-д сонгогдох/ үүсгэсэн шийдвэрийг шүүгчийн эрх мэдэлдээ тулгуурлан гаргасан хууль бус үйлдэл гэж үзэж байна. “Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм”-ийг зөрчсөн гэж үзэж шүүгч Б.Г-ийн ёс зүйн зөрчлийг зохих журмын дагуу шалгаж Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан сахилгын шийтгэл ногдуулж өгнө үү” гэх агуулгатай гомдлыг гаргажээ.

Шүүхийн Ёс зүйн хороо холбогдох шалгалтыг явуулж цугларсан баримтаас үзэхэд Л аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Г 2016 оны 8 дугаар сарын 12-ны өдөр 43 дугаартай шийтгэвэр гаргаж, Ч.Ч-д шийтгэл ногдуулахдаа өөрт нь мэдэгдээгүй, “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, ...хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, ... эрхтэй” гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16. 14 -т заасан заалтыг, Захиргааны хариуцлагын тухай хууль”-ийн 9 дүгээр зүйлд Зөрчил гаргасан этгээд 1/ зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд биеэр оролцох, 2/ нотлох баримттай танилцах, 3/ зөрчлийн талаар тайлбар өгөх, нотлох баримт, хүсэлт гаргах, 4/ хууль зүйн туслалцаа авах эрхтэй гэж заасныг шүүгч хангаагүй зөрчсөн байна.

Монгол Улсад хуульд захирагдах зарчмыг ягштал баримтлахыг шүүгчид үүрэг болгодог. Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2-т төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмын нэг бол хууль дээдлэх гэж заасан бөгөөд шүүн таслах ажиллагаа нь төрийн үйл ажиллагаанд багтдаг учраас энэ зарчмыг шүүгч биелүүлэх үүрэгтэй. Тийм учраас, Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 1-д “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана” гэж заасан. Мөн, хууль дээдлэх зарчим нь процессын хуулиуд болон Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд ч тусгалаа олсон. Түүнчлэн, Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1-д зааснаар “Шүүгч нь хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх хууль дээдлэх, аливаа асуудалд бодитой, төвийг сахисан байр сууринаас хандах, хараат бус байх, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандах” зарчмыг хувийн зан чанар болгон төлөвшүүлэхийг шүүгчид үүрэг болгоод зогсохгүй энэ дүрмийн 3.3 дугаар зүйлд “Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй” гэж тодорхой заасныг зөрчсөн гэж бүрэлдэхүүн дүгнэв.

Ч.Ч миний цагдаагийн байгууллагаар шалгуулан шүүхэд шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн Л аймгийн ИТХ-ыг сонгох сонгуулийн 26 дугаар тойрогт надтай өрсөлдсөн С.А-ийн талаарх зөрчлийн маргааны хэргийг шийдвэрлүүлэхээр харьяаллын бус Ц аймгийн сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд шилжүүлсэн гэсэн гомдол гаргажээ.

Л аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн 2016 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 67 дугаар захирамжаас үзэхэд шүүгч Б.Г “Ч.Ч-ийн гомдлоор С.А-д холбогдох Эрүүгийн хэргийн тусгай ангийн 111

дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэгт зааснаар эрүүгийн хэрэг үүсгэн шалгах байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгчийн хувиар оролцож байсан гэсэн үндэслэл зааж С.А-д холбогдох захиргааны зөрчлийг хянан хэлэлцэх ажиллагаанаас татгалзан гарах хүсэлт гаргасан байх бөгөөд Л аймгийн ИТХ-ын 2016 оны сонгуулийн 26 дугаар тойрогт АН-аас Ч.Ч, бие даагч С.А нар тус тус нэр дэвшиж оролцсон үйл баримт тогтоогдож байна.

Гомдол гаргагч Ч.Ч нь шүүгч Б.Г-г өмнө өмгөөлөгчийн үйлчилгээ үзүүлж байсан үйлчлүүлэгч болох С.А-д давуу тал /Л аймгийн ИТХ-д сонгогдох/ үүсгэсэн шийдвэрийг шүүгчийн эрх мэдэлдээ тулгуурлан гаргасан хууль бус үйлдэл гэж үзсэн байх ба Шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 1-д "Шүүгч нь хэргийн оролцогчдод эрх тэгш, төвийг сахисан, хүнлэг ёсоор хандаж, хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлэхүйц харилцааны соёлыг эзэмшсэн байна." гэсэн заалтыг шүүгч зөрчсөн байна.

Иймээс шүүгч Б.Г-г шүүгчийн ёс зүйн зөрчил гаргасан гэж бүрэлдэхүүн дүгнэв.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйл, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1,2-т заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Л аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Г-д 1 сарын хугацаагаар 30 хувиар цалинг бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Энэ магадлалын хувийг шүүгч болон гомдол гаргагчид хүргүүлэхийг Ажлын албанд даалгасугай.

3.Талууд магадлалыг эс зөвшөөрвөл хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ

ГИШҮҮН

Н.ЭРДЭНЭЦОГТ

Н.ГАНБАЯР

UIN.MN
СУДАЛГААНЫ САН



ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ
МАГАДЛАЛ

2017 оны 9 сарын 26 өдөр

Дугаар 221/ЁМ2017/001

Улаанбаатар хот

Л аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн
анхан шатны шүүхийн шүүгч Б.Г-д сахилгын шийтгэл
ногдуулах тухай магадлалын тухай

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааныг шүүгч Э.Зоригтбаатар даргалж, шүүгч Г.Билгүүн, шүүгч Д.Баатархүү нарын бүрэлдэхүүнтэй, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Б.Будхүү, гомдол гаргагч шүүгч Б.Г нарыг оролцуулан, Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 47 дугаар магадлалыг шүүгч Б.Г-ийн гомдлоор, шүүгч Д.Баатархүүгийн илтгэснээр хянан хэлэлцээд **ТОДОРХОЙЛОХ** нь:

Нэг. Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 90 дүгээр тогтоолоор Л аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Г-д сахилгын хэрэг үүсгэж шийдвэрлэжээ.

Хоёр: Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 47 дугаар магадлалаар Л аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Г-д сахилгын шийтгэл ногдуулж шийдвэрлэжээ.

Гурав. Дээрх магадлалыг эс зөвшөөрч шүүгч Б.Г гаргасан гомдолдоо: Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 47 дугаартай магадлалыг 2017 оны 8 дугаар сарын 02-ны өдөр хүлээн авч танилцаад эс зөвшөөрч уг магадлалыг хүчингүй болгуулахаар гомдол гаргаж байна.

Ч.Х-аас Ч.Ч нь Сонгуулийн тухай хууль зөрчсөн талаар гаргасан гомдлыг Л аймгийн Цагдаагийн газраас шалгаж захиргааны зөрчлийн материалыг манайд ирүүлснийг 2016 оны 8 дугаар сарын 11-ний өдөр хүлээн авч хянаад Ч.Ч-ийн гаргасан зөрчил нь нотлогдсон, процессын зөрчилгүй байсан тул 2016 оны 8 дугаар сарын 12-ны өдөр тухайн зөрчилд нь Захиргааны шийтгэл ногдуулж 43 дугаартай шийтгэвэр гаргасан.

Миний бие тус шүүхэд ирсэн Сонгуулийн хууль зөрчсөн талаарх захиргааны зөрчлийн материалыг Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолын дагуу хүлээн авч шийдвэрлэсэн. Ингэхдээ тухайн маргааны онцлогоос хамааран хурдан шуурхай байх зарчмыг баримтлан ажиллаж, нийтдээ 40 орчим сонгуулийн маргааныг шийдвэрлэсэн.

Сонгуулийн гэлтгүй аливаа захиргааны зөрчлийн материалыг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэх дэг, дараалал тогтоосон хууль байхгүй тул хуралдаанаар хэлэлцэхгүйгээр шийдвэрлэдэг, харин гомдол гаргагч, зөрчилд

холбогдогчийн зүгээс шүүх хуралдаанд биечлэн оролцох хүсэлт гаргасан тохиолдолд шүүх хуралдааны тов мэдэгдэж, хуралдааныг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан дэгийн дагуу явуулдаг шүүхийн практик тогтсон байдаг. Энэ жишгийн дагуу дээрх зөрчлийн материалыг шийдвэрлэсэн болно. .

Зөрчлийн материалд Ч.Ч өмгөөлөгч авсан, шүүх хуралдаанд оролцох талаар гаргасан хүсэлт авагдаагүй, Захиргааны хариуцлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрхийг тайлбарлаж гарын үсэг зуруулсан, зөрчилд холбогдуулан тайлбар авсан, зөрчлийн материал танилцуулж гарын үсэг зуруулсан баримтууд тус тус авагдсан байсан болно.

2016 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 43 дугаартай шийтгэвэрт давж заалдах гомдол гаргасныг ... Эрүүгийн хэргийн Давж заалдах шатны шүүх 2016 оны 8 дугаар сарын 30-ны өдөр хянаад 50 дугаартай магадлал гаргасан байдаг.

Магадлалаар анхан шатны шүүхийн шийтгэвэрт хууль хэрэглээний өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн нь дээрх зөрчлийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэхдээ процессын алдаа гаргаагүй, өөрөөр хэлбэл зөрчилд холбогдогч Ч.Ч-ийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг шүүх зөрчөөгүй болохыг нотолж байна.

Гэтэл Шүүхийн Ёс зүйн хороо магадлалдаа шүүгч Б.Г нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.14, Захиргааны хариуцлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлүүдийг зөрчсөн байна гэж дүгнээд, энэ нь Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1, 3.3 дугаар зүйлүүдийг зөрчсөн гэж үзсэн нь үндэслэлгүй байна. Учир нь ... Эрүүгийн хэргийн Давж заалдах шатны шүүх 2016 оны 8 дугаар сарын 30-ны өдөр хянаад 30 дугаартай магадлалаар шүүх дээрх хуулиудыг зөрчөөгүйг тогтоосон бөгөөд уг магадлал нь шүүхийн эцсийн шийдвэр юм. Шүүхийн шийдвэрээр эцэслэн тогтоогдсон үйл баримт дээр ямар ч байгууллага дахин дүгнэлт хийх ёсгүй юм.

Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 1 дэх заалтыг зөрчсөн гэх зөрчлийн тухайд:

Миний бие өмгөөлөгчөөр ажиллаж байхдаа Л аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар ажиллаж байсан. Ч.Ч-ийн гомдлоор сэтгүүлч С.А-д холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэгт зааснаар эрүүгийн хэрэг үүсгэсэн хэрэгт С.А-ийн өмгөөлөгчөөр ажиллаж байсан. Уг хэргийг 2015 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 112 дугаартай Прокурорын тогтоолоор хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Ч.Ч нь Л аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн сонгуулийн 26 дугаар тойрогт нэр дэвшиж байхдаа өрсөлдөгч болох С.А нь Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн талаарх гомдлыг 2016 оны 6 дугаар сарын 20-ны өдөр Л аймгийн Цагдаагийн газарт гаргасныг шалгаж ирүүлснийг 2016 оны 6 дугаар сарын 22-ны өдөр хүлээн авч танилцахад миний урьд нь өмгөөлөгчөөр оролцож байсан С.А-д холбогдох дээрх эрүүгийн хэргийн талаар болон уг хэргийн үйл баримтуудын талаар гомдолдоо дурдсан байсан тул 2016 оны 6 дугаар сарын 23-ны өдөр уг зөрчлийн материалыг хянан шийдвэрлэх боломжгүй гэж үзэж татгалзан гарах хүсэлтээ Ерөнхий шүүгчид гаргасан.

Миний хүсэлтийг Ерөнхий шүүгч хүлээн авах нь зүйтэй гэж шийдвэрлэсэн тул уг зөрчлийн материалыг шийдвэрлэх ажиллагаанаас гарсан бөгөөд уг зөрчлийн хэрэг нь Х аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд харьяалал тогтоогдож шилжсэн болно.

Ч.Х-ийн гомдолтой Ч.Ч-д холбогдох захиргааны зөрчлийн материалыг 2016 оны 8 дугаар сарын 11-ний өдөр хүлээн авч танилцахад дээр дурдагдсан

С.А-д холбогдох эрүүгийн хэрэгт огт хамааралгүй асуудал байсан тул хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу уг зөрчлийг хянан шийдвэрлэсэн.

Тухайн үед Ерөнхий шүүгч Л.А болон миний биеэс өөр шүүгч томилогдоогүй байсан болно.

Гомдол гаргагч Ч.Ч нь шүүгч Б.Г-г өмнө нь өмгөөлөгчийн үйлчилгээ үзүүлж байсан үйлчлүүлэгч болох С.А-д давуу тал /Л аймгийн иргэдийн Төлөөлөгчид сонгогдох/ үүсгэсэн шийдвэрийг шүүгчийн эрх мэдэлдээ тулгуурлан гаргасан хууль бус үйлдэл гэж үзэж байх ба Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 1-д “Шүүгч нь хэргийн оролцогчдод эрх тэгш, төвийг сахисан, хүнлэг ёсоор хандаж, хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлэхүйц харилцааны соёлыг эзэмшсэн байна” гэснийг шүүгч зөрчсөн байна” гэжээ.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль 2016 оны 6 дугаар сарын 29-нд болоод өнгөрчихсөн байхад 2016 оны 8 дугаар сарын 12-ны өдөр гарсан гарсан шийтгэвэр сонгуулийн үр дүнд нөлөөлсөн гэж гомдол гаргасныг үндэслэлтэй гэх утга агуулга бүхий дүгнэлтийг Шүүхийн Ёс зүйн хороо хийсэн нь үндэслэлгүй байна.

Миний бие С.А-ийн өмгөөлөгчөөр ажиллаж байхдаа ч, энэ зөрчлийн материалыг хянан шийдвэрлэж байхдаа гомдол гаргагч Ч.Ч-тэй огт уулзаагүй юм. Уулзаж харилцаа үүсгээгүй хүн миний талаар сөрөг үнэлэмжтэй байгаа нь намайг Шүүгчийн ёс зүйн дүрэмд заасан харилцааны соёлыг эзэмшээгүй гэж дүгнэх үндэслэл болохгүй гэж үзэж байна.

Иймд Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 47 дугаар магадлалыг хүчингүй болгож өгнө үү” гэжээ.

ХЯНАВАЛ:

Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 47 дугаар магадлалаар Ф аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн шүүхийн шүүгч Б.Г-д “сахилгын шийтгэл” ногдуулсан нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т заасан “Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэнэ” гэсэн зохицуулалттай нийцэхгүй байх тул дараах үндэслэлээр шүүгч Б.Г-ийн гомдлыг хангаж, магадлалыг хүчингүй болгож шийдвэрлэв.

Иргэн Ч.Ч-ээс шүүгч Б.Г-д сахилгын хэрэг үүсгүүлэхээр “Монгол Улсын Үндсэн хуульд заагдсан миний эрхийг зөрчихөөс гадна хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандах үүргээ огт биелүүлээгүй, тус шүүгчийн ёс зүйн зөрчлийг зохих журмын дагуу шалгаж, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан сахилгын шийтгэл ногдуулж өгнө үү” гэсэн гомдол гаргасныг Шүүхийн Ёс зүйн хороо хэлэлцээд 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 90 дүгээр тогтоолоор сахилгын хэрэг үүсгэж, 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 47 дугаар магадлалаар 1 сарын хугацаагаар 30 хувиар цалинг бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан байна.

Л аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Г нь Л аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн Ч.Ч-д холбогдох захиргааны зөрчлийн материалыг хүлээн авч хянаад 2016 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн шийтгэврээр Ч.Ч-д нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 21 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу 4.032.000 төгрөгөөр торгох захиргааны шийтгэл ногдуулсныг Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 50 дугаар магадлалаар шийтгэврийн тогтоох хэсгийн нэг дэх заалтад Ч.Ч-г 4.032.000

төгрөгөөр торгох шийтгэл ногдуулсныг багасган 192.000 төгрөг болгон өөрчилж, зөрчил гаргагч Ч.Ч, түүний өмгөөлөгч Д.Д нарын гаргасан давж заалдах гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэжээ.

Ёс зүйн хэрэгт авагдсан Л аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 43 дугаар шийтгэвэр, ... Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 50 дугаар магадлал, гомдол гаргагчийн болон шүүгчийн тайлбар зэрэг баримтуудаас үзвэл гомдол гаргагч Ч.Ч-ийн шүүгч Б.Г-г Шүүгчийн Ёс зүйн дүрэмд заасан зөрчил гаргасан гэх гомдол нь "шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлсэн эсэх"-тэй холбоотой байх бөгөөд энэ харилцаа нь тухайлбал, Захиргааны хариуцлагын тухай хуулиар зохицуулагдсан шүүгчээс зөрчил хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэх явцтай холбоотой байна.

Шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлсэн эсэхтэй холбоотой гомдлыг давж заалдах, хяналтын журмаар шийдвэрлэх эсхүл хуульчийн хувьд мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил гаргасан эсэхийг Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмээр зохицуулдаг.

Түүнчлэн Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1-д "Шүүгч хуульд тусгайлан ёс зүйн зөрчил болохоор заасан болон энэ дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг ёс зүйн зөрчил гэж үзнэ", 2-т "хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй", 5.1 дүгээр зүйлийн 6-д "Шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаанаас бусад ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдлыг Шүүхийн Ёс зүйн хороо харьяалан шийдвэрлэнэ" гэж зохицуулсан байна.

Гэтэл Шүүхийн Ёс зүйн хороо шүүгч Б.Г-г Захиргааны хариуцлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлүүдийг зөрчсөн байна гэж дүгнэж сахилгын шийтгэл ногдуулсан нь дээрх зохицуулалтуудтай нийцээгүй байна.

Тодруулбал, Захиргааны хариуцлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан зөрчил гаргагчийн зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд биеэр оролцох, нотлох баримттай танилцах, зөрчлийн талаар тайлбар өгөх, нотлох баримт, хүсэлт гаргах, шийтгэл ногдуулсан шийдвэрийг давж заалдах, хууль зүйн туслалцаа авах, эрхээ зөрчигдсэн гэж үзвэл шүүхэд гомдол гаргах зэрэг асуудал нь дээр тайлбарласнаар Шүүхийн Ёс зүйн хорооны хянаж, дүгнэх асуудал биш харин шүүн таслах үүргээ хэрэгжүүлэх шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаа юм.

Иймд иргэн Ч.Ч-ийн гаргасан гомдол нь Сонгуулийн тухай хууль зөрчсөн гомдлын материалыг хүлээн аваад гаргасан шүүгчийн шийтгэврийн талаар буюу шүүгчийн мэргэжлийн ур чадвар, хууль хэрэглээний талаарх гомдол байх тул иргэн Ч.Ч-ээс ирүүлсэн гомдолд үндэслэн шүүгч Б.Г-д сахилгын шийтгэл ногдуулсан ёс зүйн хорооны магадлалыг хүчингүй болгож, үүсгэсэн сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэв.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.2, 121 дүгээр зүйлийн 121.1.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэгт заасныг баримтлан Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 47 дугаар магадлал, мөн Ёс зүйн хорооны 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 90 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.

2.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.5-д зааснаар шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийг буруу хэрэглэсэн, мөн шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн нь шүүхийн шийдвэр гаргахдаа нөлөөлсөн гэж үзвэл магадлалыг гардан авсан, эсхүл хүргүүлснээс хойш 14 хоногийн дотор Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд гомдол гаргах эрхтэй.

ШҮҮГЧ

Э.ЗОРИГТБААТАР

ШҮҮГЧ

Г.БИЛГҮҮН

ШҮҮГЧ

Э.ХАЛИУНБАЯР



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ХЯНАЛТЫН ШАТНЫ ЗАХИРГААНЫ
ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2017 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 517

Улаанбаатар хот

Л аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн
анхан шатны шүүхийн шүүгч Б.Г-д
сахилгын шийтгэл ногдуулах тухай

Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааныг Танхимын тэргүүн М.Батсуурь даргалж, шүүгч Х.Батсүрэн, Б.Мөнхтуяа, Ч.Тунгалаг, Л.Атарцэцэг нарын бүрэлдэхүүнтэй хийж, Ч.Ч-ийн гомдолтой, Л аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Г-д холбогдох Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 221/ЁМ2017/0017 дугаар магадлалыг эс зөвшөөрч гомдол гаргагч Ч.Ч-ээс хяналтын журмаар гаргасан гомдлыг шүүгч Л.Атарцэцэгийн илтгэснээр хянан хэлэлцэв.

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 47 дугаар магадлалаар Л аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Г-д 1 сарын хугацаагаар 30 хувиар цалинг бууруулах сахилгын шийтгэл ногдуулж шийдвэрлэжээ.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 221/ЁМ2017/0017 магадлалаар: Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэгт заасныг баримтлан Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 47 дугаар магадлал, мөн ёс зүйн хорооны 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 90 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болгож шийдвэрлэжээ.

Иргэн Ч.Ч хяналтын журмаар гаргасан гомдолдоо: “Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал нь Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 47 тоот магадлалаар тогтоосон шийтгэлийн үндэслэлд хамааралгүй асуудлаар үнэлгээ хийж уг шийдвэрийг шүүгчийн шүүн таслах үүргээ хэрэгжүүлэх шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаа гэж үзэж дүгнэлт гаргасныг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.5-д заасны дагуу уг шийдвэрийг эс зөвшөөрч хяналтын журмаар гомдол гаргаж байна.

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалын үндэслэх хэсэгт “Гомдол гаргагч Ч.Ч нь шүүгч Б.Г-ийн өмнө өмгөөлөгчийн үйлчилгээ үзүүлж байсан үйлчлүүлэгч болох С.А-д давуу тал үүсгэсэн шийдвэрийг шүүгчийн эрх мэдэлдээ тулгуурлан гаргасан хууль бус үйлдэл гэж үзсэн байх ба Шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 1-д “Шүүгч нь хэргийн оролцогчдод эрх тэгш, төвийг сахисан, хүнлэг ёсоор хандаж, хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлэхүйц харилцааны соёлыг эзэмшсэн байна гэсэн заалтыг зөрчсөн байна” гэж дүгнэсэн. Энэ дүгнэлтийн

талаар захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх авч үзэн үндэслэлтэй эсэхийг тогтоохгүйгээр шүүх ажиллагааны болон хууль хэрэглээний процесст дүгнэлт хийж шийдвэрлэснийг буруу гэж үзэж байна.

Шүүгч Б.Г иргэн Ч.Ч надтай холбогдуулан шүүн таслах шийдвэр гаргахдаа иргэн миний Үндсэн хуулиар олгосон эрхэд бүдүүлгээр хандаж өөрийн үйлчлүүлэгч С.А-д давуу боломж олгохын тулд улайран, яаран сандран хийсэн үйлдэл гэдгийг дараах үндэслэлд тулгуурлан Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хороо шийдвэрлэсэн Л аймгийн цагдаагийн мөрдөн байцаагч Я.Б дуудсаны дагуу би 2016 оны 8 дугаар сарын 11-ний 15 цаг орчимд мөрдөн байцаагчтай уулзсан. Байцаагч шүүхээс тодруулахаар ирсэн материалтай танилцаж мэдүүлэг өгөхийг хүссэн. Би нүдний шилгүй тул уншиж чадахгүй дараа ирье гэхэд танд би уншиж өгье та мэдүүлэг өгчих гэсэн. Би байцаагчийн уншсан зүйлийг сонсоод тайлбар өгсөн. Тайлбар мэдүүлэгтээ иргэн болон нэр дэвшигч Ч.Ч би үүнийг өөрийн дураар хийгээгүй би Ардчилсан намын улс төрийн томилгоотой ажилтан тул намын үүрэг даалгавраар хийсэн, захиалагч нь Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигч С.О-ийн штаб байгаа юм. Мэдээлэл өгөхөөр би телевиз дуудаагүй нэр дэвшигчийн штаб дуудаж төлбөр мөнгийг төлсөн би хүлээхгүй гэдгээ хэлсэн. Би энэ мэдэгдлийн хариуцлагыг хүлээхгүй гэж мэдүүлэг өгсөөр байхад шүүгч Б.Г цагдаад өөрөө шилжүүлэн тодруулсан хэргийн материалын талаар шүүхэд гаргасан тайлбартаа "... Л аймгийн Цагдаагийн газраас шалгаж захиргааны зөрчлийн материалыг манайд ирүүлснийг 2016 оны 8 дугаар сарын 11-ний өдөр хүлээн авч хянаад Ч.Ч-ийн гаргасан зөрчил нь нотлогдсон, процессын зөрчилгүй байсан тул 2016 оны 8 дугаар сарын 12-ны өдөр тухайн зөрчилд захиргааны шийтгэвэр ногдуулсан.." гэжээ. Би цагдаад өгсөн мэдүүлэгтээ энэ мэдэгдлийн хариуцлагыг би хүлээхгүй, би Ардчилсан намын мэдэгдэл болохыг баталсан, нотлох баримтыг шүүхэд өгнө гэдгээ цагдаад хэлээд 2016 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 10 цагийн үед аймгийн архиваас холбогдох баримтаа гаргуулан шүүх рүү явах гэж байтал шүүхээс шийтгэврээ ав гэж утсаар хэлсэн. Би гайхаад шүүх дээр очиход Б.Г шүүгч надад холбогдох хэргийн шийтгэвэр бичээд, ёсчлоод хариуцлага хүлээлгэсэн байдаг. Цагдаад мэдүүлэг өгсөн, шүүхийн шийтгэвэр авсан хугацааг ажлыг цагаар тооцоход ажлын 3 цаг болж байна. Ийм богино хугацаанд би хариуцахгүй гэсэн эсрэг мэдүүлэг цагдаад өгсөн миний мэдүүлэг бүхий асуудлыг надад өөрийгөө өмгөөлөх, холбогдох баримт гаргаж өгөх гэх мэт эрхээ эдлэх боломжгүйгээр хэргийг шийдвэрлэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.14, Захиргааны хариуцлагын тухай хуулийг зөрчсөн юм. Надад ядаж 2016 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн ажлын 8 цагийн хугацаа өгчхөөд энэ хэргийг шийдвэрлэсэн бол би гомдохгүй байсан. Дээрх богино хугацаанд шүүгч хэргийг шийдэж ёсчилсон үйлдэл нь шийдвэрээ урьдчилан бэлтгээд цагдаад ёс төдий өгч тодруулсан үйлдэл гэж үзэж байна.

Шүүгч Б.Г нь шүүхэд гаргасан ёс зүйн алдаа гаргаагүй гэсэн тайлбартаа "2016 оны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийг сонгох сонгууль өнгөрчихсөн байхад 2016 оны 8 дугаар сарын 12-ны өдөр гаргасан шийтгэвэр сонгуулийн үр дүнд нөлөөлөхгүй..." гэж тайлбарласан байна. Хэрвээ Ч.Ч миний бие нэр дэвшигч С.А-д холбогдуулан гаргасан сонгуулийн хууль зөрчсөн маргаан шүүхээр тогтоогдсон тохиолдолд нэр дэвшигч Ч.Ч би аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд сонгогдох боломж сонгуулийн хуулиар байсан. Үүнийг олж харсан шүүгч Б.Г нь өмнө өмгөөлөгч байхдаа үйлчлүүлж байсан үйлчлүүлэгчдээ боломж олгосон гэж үзэхээс өөр тайлбар хийх боломжгүй юм.

Ч.Ч миний бие Л аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийг сонгох сонгуулийн 26 дугаар тойрогт иргэн С.А-тай өрсөлдсөн. 2016 оны сонгуулийн үр дүнгээр нэр дэвшигч С.А нь олонхын санал авч дэмжигдсэн. С.А нь сонгуулийн үед хууль зөрчсөн болох талаар Ч.Ч би Л аймгийн цагдаагийн газарт гомдол гаргаж түүнийг цагдаа шалгаад шүүхэд шилжүүлсэн байдаг. Гэтэл шүүгч Б.Г нь нэр дэвшигч Ч.Ч миний хэргийг хүлээн авч яаран сандран шийдсэн мөртөө өөрийн үйлчлүүлэгч байсан миний гаргасан гомдолтой холбоотой С.А-ийн хэргийг шийдэхээс татгалзсан байсан гэдгээ шүүхэд гаргасан тайлбартаа мэдүүлсэн байна. Үнэхээр шүүгч нь хэргийн оролцогч болох үйлчлүүлэгч бүрдээ тэгш боломж олгох гэж байгаа бол миний хэргийг хүлээн авахаас бас татгалзах байсан.

Шүүгч Б.Г шүүхэд гаргасан тайлбартаа миний үйлчлүүлэгч С.А-д хамаарах "... Эрүүгийн хуулийн тусгай ангийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэгт зааснаар эрүүгийн хэрэг үүсгэсэн хэрэгт С.А-ийн өмгөөлөгчөөр ажилласан. Уг хэрэг 2015 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 112 дугаартай прокурорын тогтоолоор хэрэгсэхгүй болгосон..." гэж илт худал мэдүүлсэн байна. Энэ хэргийн талаар би дээд шатны прокурорт гомдол гаргасан хариу нь ирээгүй байсан үе юм. Мөн миний үйлчлүүлэгч С.А-г холбогдох хэрэгтэй Ч.Ч-ийн асуудал хамааралгүй байсан гэж тайлбартаа мэдүүлсэн байна. Л аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийг сонгох сонгуулийн тойрогт нэр дэвшсэн С.А, Ч.Ч бид хоёулаа сонгуулийн хууль зөрчсөн асуудал шүүхэд хэлэлцэгдэж байсаар байтал яагаад хамааралгүй асуудал болоод байгааг ойлгохгүй байна. Хэн нь олонхын санал авснаас шалтгаалахгүйгээр шүүхээр сонгуулийн хууль зөрчсөн нь тогтоогдсон нэр дэвшигч аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд сонгогдох боломжгүйг шүүгч Б.Г дээд зэргээр мэдэж байснаа яагаад мэдэн будилах болов гэвэл энэ нь үйлчлүүлэгч байсан хүнээ л хуралд сонгуулах гэсэн атгаг санаа байсан гэдгийг харуулж байгаа ба үүнийг Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалаараа нотолж байна.

Л аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 26 дугаар тойрогт нэр дэвшин өрсөлдсөн Ч.Ч, С.А нарын сонгуулийн дүнтэй холбоотой шүүхийн маргааны явцын улс төрийн шалтгаант холбооны дараах хамаарал нь Ардчилсан намын нэрийн өмнөөс улс төрийн мэдэгдэл хийсэн намын ажилтны үйл ажиллагааг нэр дэвшигч, дараа нь жирийн иргэн хийсэн мэтээр гаргасан Захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүх тус тус шийдвэр нь иргэн миний улс төрийн эрхэнд халдсан, хэт нэг талд үйлчилсэн шүүхийн шийдвэр гэж үзэж байна. Дээрх давж заалдах шатны шүүхийн магадлал нь Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалд заасан ёс зүйн зөрчил гэж дүгнэсэн агуулгад хамааралгүй асуудлаар хууль зүйн үндэслэлгүй, хийгдвэл зохих ажиллагааг хийгээгүй, бодит нөхцөл байдлыг бүрэн судлаагүй буруу, зөрчилтэй дүгнэлт гаргаж шийдвэрлэсэн гэж үзэж байна.

Иймд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 221/ЁМ2017/0017 дугаар магадлалыг бүхэлд нь хүчингүй болгож Монгол Улсын Шүүхийн Ёс Зүйн хорооны 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 47 тоот магадлалыг хэвээр үлдээж өгнө үү" гэжээ.

ХЯНАВАЛ:

Хяналтын шатны шүүх дараах үндэслэлээр иргэн Ч.Ч-ийн гаргасан гомдлыг хангах нь зүйтэй гэж үзлээ.

Иргэн Ч.Ч нь "... надад холбогдох зөрчилд арга хэмжээ авах асуудлын шийдвэрлэхдээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчиж, шүүх хуралдаанд оролцох, өмгөөлүүлэх эрхийг эдлүүлээгүй гэснээс гадна

сонгуульд өрсөлдсөн Ч.Ч, С.А нарт тэгш бус хандсан, ... шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн..." гэх үндэслэлээр шүүгч Б.Г-д сахилгын шийтгэл ногдуулахыг хүссэн байна.

Монгол Улсын Шүүхийн Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 2, 5.1 дүгээр зүйлийн 6-д хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага туршлагатай хамааралтай алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй болохыг тодорхой зохицуулжээ.

Иргэн Ч.Ч-ийн гомдолд дурдсан "... Ч.Х-ээс Ч.Ч нь Сонгуулийн тухай хууль зөрчсөн талаарх гомдлыг шүүгч Б.Г хянан шийдвэрлэхдээ шүүх хуралдаанд биечлэн оролцох, өмгөөлүүлэх эрхийг хангаагүй..." гэх үйл баримтыг Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хороо нь ёс зүйн зөрчилд хамааруулж дүгнэсэн нь буруу талаар давж заалдах шатны шүүх зөв дүгнэжээ.

Дээр дурдсан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн асуудлаар хэргийн оролцогч дээд шатны шүүхэд гомдлоо гаргасан, дээд шатны шүүх шүүгчийг уг алдааг гаргасан гэж буруутгаагүй байна.

Өөрөөр хэлбэл шүүгч Б.Г-г Монгол Улсын Шүүхийн Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 1-д "шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй" гэж заасныг зөрчсөн гэж үзэхээргүй байх тул Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хороо шүүгч Б.Г-г дээрх дүрмийн заалтыг зөрчсөн гэж дүгнэсэн нь буруу болжээ.

Харин шүүгч Б.Г нь "сонгуульд өрсөлдсөн Ч.Ч, С.А нартай холбоотой Сонгуулийн тухай хууль зөрчсөн маргааныг шийдвэрлэхдээ Монгол Улсын Шүүхийн Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1-д "... Шүүгч нь хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, хууль дээдлэх, аливаа асуудалд бодитой, төвийг сахисан байр сууринаас хандах, хараат бус байх, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандах..." гэж заасан хэм хэмжээг зөрчсөн талаар Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хороо зөв дүгнэжээ.

Тодруулбал, шүүгч Б.Г нь шүүгчээр томилогдон ажиллахаасаа өмнө иргэн С.А-д хууль эрх зүйн туслалцаа үзүүлж, түүний өмгөөлөгчөөр ажиллаж байсан атлаа, түүнтэй сонгуульд өрсөлдсөн Ч.Ч-д холбогдох тухайн сонгуультай холбоотой маргааныг хүлээн авч шийдвэрлэсэн нь Монгол Улсын Шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 1-д "...шүүгч нь хэргийн оролцогчдод эрх тэгш, төвийг сахисан, хүнлэг ёсоор хандаж, хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлэхүйц харилцааны соёлыг эзэмшсэн байна" гэж заасныг зөрчсөн, энэ нь түүнд сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болохыг давж заалдах шатны шүүх анхаараагүй байна.

Иймээс Ч.Ч-ийн "...шүүгч Б.Г нь С.А-ийн өмгөөлөгчөөр ажиллаж байсан гэх үндэслэлээр С.А-д холбогдох асуудлыг шийдвэрлэхээс татгалзсан атлаа, надад холбогдох гомдлыг өөрөө шийдвэрлэсэн, тэгш боломж олгох гэж байгаа бол миний хэргийг хүлээн авахаас бас татгалзах ёстой байсан ..." гэх гомдол үндэслэлтэй байна.

Дээрх үндэслэлээр давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 47 дугаар магадлалыг хэвээр үлдээх нь зүйтэй гэж дүгнэв.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.2.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон

ТОГТООХ нь;

1.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 221/ЁМ2017/0017 дугаар магадлалыг хүчингүй болгож, Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 90 дүгээр тогтоол, 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 47 дугаар магадлалыг тус тус хэвээр үлдээсүгэй.

ТАНХИМЫН ТЭРГҮҮН

ШҮҮГЧ

М.БАТСУУРЬ

Л.АТАРЦЭЦЭГ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЁС ЗҮЙН ХОРООНЫ МАГАДЛАЛ

2017 оны 7 сарын 05 өдөр

Дугаар 49

Улаанбаатар хот

Ф аймаг дахь сум дундын Иргэний хэргийн
анхан шатны шүүхийн шүүгч А.Ж-д
сахилгын шийтгэл ногдуулах тухай

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааныг Ёс зүйн хорооны дарга Н.Эрдэнэцогт даргалж, гишүүн А.Доржготов, Ч.Оюунцэцэг, О.Мөнхсайхан, Н.Ганбаяр нарын бүрэлдэхүүнтэй, хяналт шалгалт хариуцсан референт Б.Энхбаатар, хуралдааны тэмдэглэл хөтлөгчөөр шинжээч А.Энхбаатар нарыг оролцуулан, Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдааны танхимд хийж, Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн 79 дүгээр тогтоолоор шүүгч А.Ж сахилгын хэрэг үүсгэснийг гишүүн Н.Ганбаярын илтгэснээр хянан хэлэлцээд **ТОДОРХОЙЛОХ** нь:

Шүүхийн Ёс зүйн хороонд иргэн К.Б гаргасан гомдолдоо: “К.Б миний бие Ф аймгийн П сумд амьдардаг. Иргэн Х.Т Ф аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд хандаж нэхэмжлэл гаргаснаар иргэний хэрэг үүсэж миний бие хариуцагчаар татагдсан юм. Монгол Улсын Үндсэн хуульд заасан эрхийнхээ дагуу зөрчигдөж буй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар өмгөөлөгчөөр А.С, С.Н нарыг сонгон авсан юм. Шүүх хуралдаан 2017 оны 3 дугаар сарын 27-ны өдөр өглөө 10 цагт товлогдсон болохыг шүүгчийн туслах ажилтан надад урьдчилж мэдэгдсэн. Тухайн өдөр миний бие чухал ажилтай байсан тул шүүх хуралдаанд биечлэн оролцох боломжгүй болсон. Тийм учраас ИХШХШТХ-ийн 100 дугаар зүйлийн 100.3-т заасны дагуу тус шүүх хурлыг өөрийнхөө сонгож авсан 2 өмгөөлөгчийг минь байлцуулаад миний эзгүйд хийж өгөхийг хүссэн хүсэлтээ албан ёсоор бичгээр гаргаж 2017 оны 3 дугаар сарын 24-ний өдөр шүүгчийн туслах ажилтанд биечлэн очиж өгсөн байсан. Нэгэнт шүүх хуралдаанд биечлэн оролцох боломжгүй болсон учраас шүүхэд хэлэх үг буюу тайлбараа бичгээр гаргаж өмгөөлөгчид өгсөн байсан.

Шүүх хуралдаан болж ИХШХШТХ-ийн 99 дүгээр зүйлийн 99.1-д заасны дагуу нарийн бичгийн дарга шүүх хуралдааны ирцийн талаар танилцуулахдаа миний хүсэлт гаргасан байдлыг хэлсэн байдаг. Ингэхдээ нэхэмжлэгч тал, түүний өмгөөлөгчийн зүгээс хариуцагч намайг шүүх хуралдаанд заавал оролцуулж өгөхийг хүссэн хүсэлтийг шүүхэд тавьсан байна. Тэгэхээр миний сонгож авсан өмгөөлөгчид миний эзгүйд шүүх хуралдааныг хийж өгөхийг хүссэн хүсэлтийг минь танилцуулж, мөн миний шүүхэд бичгээр гаргасан тайлбарыг шүүхэд гаргаж өгчээ. Улмаар даргалагч шүүгч шүүх хуралдааныг түр завсарлуулж “намайг байлцуулахгүйгээр шүүх хурлыг хийж өгөөч” гэсэн хариуцагч миний хүсэлтийг шийдвэрлэхээр зөвлөлдөх тасалгаанд оржээ. Даргалагч шүүгч А.Ж нь зохигчдын гаргасан хүсэлтийг шийдвэрлэхээр зөвлөлдөх тасалгаанд оронгуутаа миний утас руу өөрийнхөө хувийн ...6331 гэсэн утасны дугаараас залгаж “Би А.Ж шүүгч

байна. Чи яг одоо шүүхэд хүрээд ир, тэгэхгүй бол би цагдаа явуулж чамайг албадан авчруулна” гэж хэлсэн юм. Тэгтэл би яахаа мэдэхгүй сандарч, хэчнээн чухал ажилтай байсан ч гэсэн түүнээ орхиж шүүхэд очоод шүүх хуралдаанд оролцсон юм. Би шүүхэд очиход бүгд ихээр гайхан “шүүгч зөвлөлдөх тасалгаанд хүсэлт шийдвэрлэнэ гэж орчхоод чамайг хайж явсан байна шүү дээ. Шүүгч хүсэлт шийдвэрлэхдээ яагаад ингэж удаж байгаа гэж гайхаж байсан. Бараг цаг хүлээлээ...” гэж хэлж байсан. Тэгээд шүүгч А.Ж шүүхийн хэлэлцүүлгийн шатандаа надаас асуулт асуухдаа дандаа тулган шаардаж, хөтөлсөн асуулт тавьж байснаа миний өмгөөлөгч С.Н эсэргүүцэл үзүүлж яагаад тулгаж асуулт тавьж байгаа юм бэ? гэж эсэргүүцэж байсан юм. Гэтэл А.Ж шүүгч нь хувийн ашиг сонирхолтой байжээ. Намайг айлган сүрдүүлж шүүхэд дуудаж авчраад тулгасан, хөтөлсөн асуулт тавьсан. Уг ёсондоо шүүгч зөвлөлдөх тасалгаанд орж гар утсаараа ярих ч эрхгүй байжээ. Гэтэл шүүгч хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэхийн тулд хууль, журмыг санаатайгаар зөрчиж ёс зүйн алдаа гаргасан гэж бодож байна.

А.Ж шүүгчийн хувьд намайг заавал шүүх хуралдаанд албадан оролцуулж надаас тулган шаардсан, хөтөлсөн асуулт тавих хувийн ашиг сонирхолтой байсан гэдгийг хожим мэдсэн. Урьд нь намайг шүүх хуралдаанд албадан авчруулах шүүгчийн захирамж байхгүй байсан бөгөөд намайг төлөөлөн оролцох өмгөөлөгч нар маань байсан учраас санаа зовохгүй байсан. Нөгөөтээгүүр, чухал ажлаас болж тухайн шүүх хуралдаанд оролцох боломжгүй болсон тул шүүхэд хэлэх үгээ бичгээр өгсөн ба миний эзгүйд шүүх хуралдааныг хийхийг зөвшөөрч, хуралдаан хийж өгөхийг хүссэн хүсэлтээ бичгээр гаргаж өгсөөр байхад хууль зөрчиж, зөвлөлдөх тасалгаанд орж над руу гар утсаараа залгаж айлган сүрдүүлсэн. Шүүх хуралдаанд хариуцагчийг заавал албадан оролцуулна гэсэн хуулийн заалт байхгүй, мөн албадан оролцуулах шүүгчийн захирамж байхгүй байхад шүүгч А.Ж эрх мэдлээ хэрээс хэтрүүлэн, дураараа аашилсан.

Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжуудаас үзэхэд хэргийн оролцогчид шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхтэй гэж заасан байдаг. Өөрөөр хэлбэл шүүх хуралдаанд зохигчид заавал оролцохыг үүрэг болгоогүй байна. Үүнээс үзэхэд шүүгч хуульд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг ноцтойгоор зөрчсөн болох нь харагдаж байна. Ардчилсан нийгэмд шударга ёсны баталгаа болж, иргэдэд шударга шүүхийг харуулах үүрэг хүлээсэн шүүгч хүн ингэтлээ нь дорой байсныг анх удаа харж ой гутав. Ийм байдалтай байсан шүүхэд хэн итгэх вэ? Би шударга шүүхээр шүүлгэх эрхтэй. Шүүгч илт нэг талд орж, хувийн ашиг сонирхлын үүднээс хэргийг хянан шийдвэрлэж миний хуулиар олгосон эрх ашиг сонирхлыг зөрчиж их хэмжээний хохирол учруулж байна. Үүнд их гомдолтой байгаа тул шүүгч А.Ж-д яаралтай арга хэмжээ авч өгнө үү.

Түүний энэхүү ёс зүйгүй үйлдлийн талаар танай байгууллагын гаргасан дүгнэлт миний зөрчигдсэн эрх ашиг сонирхлыг сэргээхэд чухал шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл шинээр илэрсэн нөхцөл байдал болж хэргийг дахин өөр шүүгчээр шүүлгэх эрх маань нээгдэх юм.” гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хороонд шүүгч А.Ж ирүүлсэн тайлбартаа: “Ф аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч А.Ж миний бие гомдол гаргагч К.Б-ийн гомдолтой танилцаад дараах тайлбараа хүргүүлж байна.

1.Нэхэмжлэгч Х.Т-ийн нэхэмжлэлтэй, хариуцагч К.Б-д холбогдох өлөн гэдэсний үнээс үлдсэн үнэ болох 4,152,600 төгрөг гаргуулахыг хүссэн тухай иргэний хэргийг Ф аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 212/МА2017/00011 дугаар магадлалаар тус шүүхийн 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 733 дугаар шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин шийдвэрлүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасан байсан.

Уг иргэний хэргийг ИРГЭН-2014 программын дагуу “хүчингүй болсон хэрийг дахин хуваарилсан” бүртгэлээр 2017 оны 02 дугаар сарын 14-ний өдөр хүлээн авч, зохигчдын хүсэлтээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж 2017 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 10:30 минутад хянан хэлэлцэхээр шүүх хуралдаан товлосон боловч шүүх хуралдаанд нэхэмжлэгч Х.Т нь өмгөөлөгч авах хүсэлт гаргасан ба нэхэмжлэгчийн өмгөөлөгч авах хүсэлтийг хангаж шүүх хуралдааныг 2017 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 08:00 цагт хянан хэлэлцэхээр 757 дугаартай шүүгчийн захирамжаар хойшлуулсан болно.

Хойшлуулсан өдөр буюу 2017 оны 3 дугаар сарын 20-ны өдөр 08:00 цагт шүүх хуралдаанаа хийж нарийн бичгийн даргаас ирцээ илтгэхэд хариуцагч ирээгүй ба нэхэмжлэгч болон түүний өмгөөлөгчөөс ирцтэй холбоотой санал хүсэлтийг асуухад хариуцагчийг шүүх хуралдаанд заавал оролцуулж, хариуцагчтай мэтгэлцэх зарчмаар хангах шаардлагатай талаар хүсэлт гаргасан.

Хариуцагч К.Б-д 2017 оны 3 дугаар сарын 13-ны өдөр шүүх хуралдааны товыг мэдэгдэх хуудсаар мэдэгдсэн боловч ямар нэгэн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй ба нэхэмжлэгч нарын шүүх хуралдаанд хариуцагчийг оролцуулж мэтгэлцэх боломжоор хангаж өгөх тухай хүсэлттэй холбоотой ямар санал хүсэлт байгаа талаар хариуцагчийн өмгөөлөгч нараас асуухад

Хариуцагчийн өмгөөлөгч С.Н, А.С нар нь хариуцагч К.Б нь шүүх хуралдааны товыг урьдчилан мэдсэн. “БББ” төслийн ерөнхий менежер өнөөдөр 08 цаг 30 минутаас ААА-аас ирэх учраас онгоцны буудлаас тосож авахаар болсон тул шүүх хуралдаанд оролцох боломжгүй болсон талаар тайлбарласан.

Хариуцагч талаас шинээр нотлох баримт бүрдүүлэх, шүүх хуралдаанд биечлэн оролцох.мэтгэлцээний үндсэн дээр хэргийг шийдвэрлүүлэх талаар хүсэлт гаргасан.

Зохигч нарын дээрх хүсэлтийг хүлээн авч 2017 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 828 дугаартай шүүгчийн захирамжаар шүүх хуралдааныг 2017 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 10:00 цаг хүртэл хойшлуулсан.

Гэтэл 2017 оны 3 дугаар сарын 27-ний өдөр товлосон цагт шүүх хуралдаанаа хийж нарийн бичгийн даргаас ирц илтгэхэд хариуцагч К.Б шүүх хуралдаанд намайг оролцуулахгүй, миний эзгүй үед шүүх хуралдааны хийж өгнө үү гэж хүсэлт ирүүлснийг илтгэсэн.

Хариуцагч К.Б-ийн тус шүүхэд 2017 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн ирүүлсэн хүсэлтдээ “ Миний бие АНУ-аас хэрэгжүүлж буй “БББ” төслийн ерөнхий инженер 2017 оны 3 дугаар сарын 27-ны өдөр өглөө 09 цагт ААА хотоос ирэх тул түүнийг онгоцны буудлаас угтан авах зэрэг чухал бөгөөд хойшлуулшгүй ажил гарсан тул шүүх хуралдаанд оролцох боломжгүйд хүрч байна. Иймд миний эзгүй үед шүүх хуралдааныг хийж хэргийг хянан шийдвэрлэж өгнө үү гэж хүсэлт ирүүлснийг уншиж өгч нэхэмжлэгч болон түүний өмгөөлөгчөөс шүүх хуралдааны ирцтэй холбоотой ямар санал хүсэлт байгааг тодруулахад,

Нэхэмжлэгч болон түүний өмгөөлөгч нарын хариуцагчийг шүүх хуралдаанд биечлэн оролцуулж, мэтгэлцээний үндсэн дээр хэргийг шийдвэрлүүлэх тухай хүсэлт гаргасан,

Хариуцагчийн өмгөөлөгч С.Н нь шүүх хуралдаанд ... дараагийн удаад хариуцагчийг албадан авчруулж байгаад шүүх хуралдаан хийе гэж санал гаргасан. Нэхэмжлэгч болон түүний өмгөөлөгчийн гаргасан хүсэлтийг шийдвэрлэхийн тулд зөвлөлдөх тасалгаанд гарсан.

Хариуцагч К.Б нь 2017 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй байсан ба тэр өдрийн шүүх хуралд түүний өмгөөлөгчөөс нь “БББ” төслийн ерөнхий менежер ААА хотоос ирэх тул түүнийг онгоцны буудлаас угтан авах ажилтай тул ирж чадаагүй гэж тайлбар гаргаж

байсан. 2017 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн шүүх хуралдаанд хариуцагч К.Б нь мөн “БББ” төслийн ерөнхий менежер ААА хотоос ирэх тул түүнийг онгоцны буудлаас угтан авах ажилтай тул оролцох боломжгүй тухайгаа бичсэн ба хүсэлттэй холбоотой нотлох баримтаа ирүүлээгүй байсан.

Тус шүүхийн Иргэний хэргийн шүүх хуралдааны танхим нь зориулалтын зөвлөлдөх тасалгаагүй тул миний бие өрөөндөө ирж хүсэлтийг шийдвэрлэхээр зөвлөлдсөн.

Нэхэмжлэгчийн шүүх хуралдаанд хариуцагчийг заавал оролцуулж, мэтгэлцэх зарчмаар хангах тухай гаргасан хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн тус шүүхийн 2017 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 828 дугаартай шүүгчийн захирамжийн биелэлтийг хангуулахын тулд зөвлөлдөх тасалгаанаас шүүгчийн туслах М.М-ыг дуудаж хариуцагч К.Б-д утсаар залгаж хэдийд шүүх хуралдаанд ирж оролцох боломжтой эсэхийг, шүүх хуралдааныг хойшлуулбал Давж заалдах шатны шүүхийн, Захиргааны хэргийн шүүхийн, Эрүүгийн, Иргэний хэргийн бусад шүүгч нарын зарласан шүүх хуралдааны товыг хараад хэдний өдөр шүүх хуралдааныг тавьж болох эсэх талаар даалгавар өгсөн.

Шүүгчийн туслах М.М ирэхдээ утасгүй ирсэн тул миний бие өөрийнхөө ...6331 дугаар утсаа туслахад өгсөн нь үнэн. Түүнээс биш би хариуцагчтай өөрөө яриагүй. Шүүгчийн туслах хариуцагчтай ярьж К.Б нь төвд буюу Холбооны тэнд явж байна очиж оролцоно, 5 минутын дотор яваад очно гэж хариу хэлсэн байх ба хариуцагчийг хүлээгээд ирсний дараа зөвлөлдөх тасалгаанаас гарч шүүх хуралдаанд орж нэгэнт шүүх хуралдааны танхимд хариуцагч ирж суусан тул шүүх хуралдааныг үргэлжлүүлэн явуулья гэж шүүх хуралдааныг үргэлжлүүлэн явуулсан болно.

Иймд хариуцагчийн гомдол бичсэнчлэн миний бие хариуцагчтай өөрөө яриагүй, тэр хүний айлган сүрдүүлсэн мөн шүүх хуралдаанд тулгасан, хөтөлсөн асуудал огт байхгүй. Намайг тулган хөтөлж асуусан гэвэл шүүх хуралдааны тэмдэглэл болон шүүх хуралдааны бичлэгээс үзэж болох юм.

1. Миний бие хэргийг хянан шийдвэрлэхээр зөвлөлдөх тасалгаанд гарсан үед хариуцагчийн өмгөөлөгч С.Н нь шүүгч бол бид нарт ашигтай шийдвэл гомдол гаргахгүй харин ашиггүй шийдвэрлэвэл гомдол гаргана гэж хэлж байсныг нарийн бичгийн дарга сонссон ба энэхүү асуудлыг холбогдох байгууллагад тусдаа гомдлоо гаргана. Миний бие хэрэгт авагдсан нотлох баримтад тулгуурлаж, хуулийн дагуу нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж зарим хэсгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн ба миний шийдвэрийг эс зөвшөөрвөл давж заалдах журмаар гомдол гаргах эрх нь нээлттэй болно.” гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хороонд шүүгчийн туслах М.М ирүүлсэн тайлбартаа: “Миний бие М.М Ф аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч А.Ж-ийн туслахаар ажилладаг.

2017 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 10:00 цагт нэхэмжлэгч Х.Т-ийн нэхэмжлэлтэй, хариуцагч К.Б-д холбогдох өлөн гэдэсний үнээс үлдсэн үнэ болох 4,152,600 төгрөг гаргуулахыг хүссэн тухай иргэний хэргийн шүүх хуралдаан болсон.

Шүүгч маань зөвлөлдөх тасалгаанд намайг байгууллагын дотоод чатаар дуудаж надад “шүүх хуралдаанд нэхэмжлэгч болон түүний өмгөөлөгч нарын хариуцагчийг шүүх хуралдаанд биечлэн оролцуулж, мэтгэлцээний үндсэн дээр хэргийг шийдвэрлүүлэх тухай” хүсэлт гаргасан. Хариуцагч К.Б-д утсаар залгаж “хэдийд шүүх хуралдаанд ирж оролцох боломжтой” эсэхийг асуу, шүүх хуралдааныг хойшлуулбал Давж заалдах шатны шүүхийн, Захиргааны хэргийн шүүхийн, Эрүүгийн, Иргэний хэргийн бусад шүүгч нарын зарласан шүүх хуралдааны

товыг хараад хэдний өдөр шүүх хуралдааныг тавьж болох эсэх талаар шүүгчээс даалгавар өгсний дагуу хариуцагч К.Б-тэй шүүгчийн утсаар ярьсан маань үнэн.

Би хариуцагчид “нэхэмжлэгч таныг шүүх хуралдаанд заавал оролцуулж шүүх хуралдаан хийж өгөх тухай хүсэлт гаргаж байна. Танд шүүх хуралдаанд ирж оролцох боломж байна уу” гэж асуухад К.Б нь “би аймгийн төвд буюу Холбооны газрын ойролцоо явж байна. Шүүх хуралд очиж оролцоно, 5 минутын дотор яваад очно” гэж хариу хэлсэн болно. Шүүгчид хариуцагч К.Б өөрөө ирж шүүх хуралдаанд оролцохоор болсныг мэдэгдэж, хариуцагч ирэхээр нь шүүх хуралдааны танхимд оруулсан маань үнэн.” гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанаар хэлэлцээд ҮНДЭСЛЭХ нь:

Шүүхийн Ёс зүйн хороонд иргэн К.Б нь шүүгч А.Ж-г шүүгчийн ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдол гаргажээ. Энэхүү гомдлын дагуу явуулсан шалгалтын дүнг хянаж Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн 79 дүгээр тогтоолоор шүүгч А.Ж-Д сахилгын хэрэг үүсгэсэн нь үндэслэлтэй байна.

2017 оны 3 дугаар сарын 27-ний өдрийн 10.00 цагт Ф аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх Х.Т-ийн нэхэмжлэлтэй К.Б-д холбогдох иргэний хэргийг хянан хэлэлцэх шүүх хуралдаан эхлэхэд шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Т.М-ээс хуралдааны ирцийг болон хариуцагч К.Б-ийн “шүүх хуралдаанд намайг оролцуулахгүй, миний эзгүйд шүүх хуралдааныг хийж өгнө үү” гэсэн хүсэлт ирүүлснийг шүүгчид танилцуулсан байна. Нэхэмжлэгч Х.Т болон түүний өмгөөлөгч Х.З нар хариуцагчийг шүүх хуралдаанд оролцуулах хүсэлт гаргаж, харин хариуцагчийн өмгөөлөгчид болох А.С, С.Н нар хариуцагчийн эзгүйд шүүх хуралдаан хийхийг дэмжиж, хариуцагчийг заавал оролцуулах шаардлагагүй гэж үзсэн байна. Шүүгч А.Ж хэргийн зохигч талуудаас гаргасан хүсэлтийг шийдвэрлэхээр зөвлөлдөх тасалгаанд орсон нь тогтоогдож байна. (2017 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн шүүх хуралдааны тэмдэглэлийн 3 дахь тал).

Даргалагч шүүгч А.Ж зөвлөлдөх тасалгаанд орсны дараа шүүгч А.Ж-ийн хувийн6331 гэсэн гар утасны дугаараас хариуцагч К.Б руу залгаж ярьсан гэдэг нь шүүгч А.Ж, түүний туслах М.М, гомдол гаргагч К.Б нарын тайлбараар тогтоогдож байна. Харин6331 дугаартай утаснаас К.Б руу хэн залгасан болон юу хэлсэн талаар зөрүүтэй тайлбарууд өгчээ. Гомдол гаргагч К.Б “Даргалагч шүүгч А.Ж нь зохигчдын гаргасан хүсэлтийг шийдвэрлэхээр зөвлөлдөх тасалгаанд оронгуутаа миний утас руу өөрийнхөө хувийн6331 гэсэн утасны дугаараас залгаж “Би А.Ж шүүгч байна. Чи яг одоо шүүхэд хүрээд ир, тэгэхгүй бол би цагдаа явуулж чамайг албадан авчруулна гэж хэлсэн” гэж тайлбартаа бичсэн. Харин К.Б руу шүүгч А.Ж-ийн6331 дугаараас залгасан нь үнэн боловч энэхүү дуудлагыг шүүгчийн туслах М.М хийж, “хэдийд шүүх хуралдаанд ирж оролцох боломжтой эсэхийг, шүүх хуралдааныг хойшлуулбал Давж заалдах шатны шүүхийн, Захиргааны хэргийн шүүхийн, Эрүүгийн, Иргэний хэргийн бусад шүүгч нарын зарласан шүүх хуралдааны товыг хараад хэдний өдөр шүүх хуралдааныг тавьж болох эсэх” талаар ярилцсан гэсэн тайлбаруудыг шүүгч А.Ж болон шүүгчийн туслах М.М нар ирүүлжээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1-д “Бүх шатны шүүх шийдвэрээ зөвлөлдөх тасалгаанд гаргана,” 94.2-т “Зөвлөлдөх тасалгаанд хэргийг хянан шийдвэрлэх талаар шүүх бүрэлдэхүүний гаргасан санал нууц байна” гэж заасан зохицуулалт нь шүүгчийг нөлөөллөөс ангид гаднын аливаа дарамт, шахалт, сүрдүүлэг болон хувийн сонирхлын үүднээс танил тал харах зэрэг сөрөг нөлөөллөөс тусгаарлаж, бодитой шийдвэр гаргах нөхцөл хангах зорилготой тул шүүгч зөвлөлдөх тасалгаанд гар утастай орох, бусад хүмүүсийг

оруулах, утсаар ярих зэргийг цээрлэх нь шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааны ёс зүйг сахин биелүүлбэл зохих шаардлага юм. Энэ заалтын "санал нууц" гэдэг нь Байгууллагын нууцын тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу шүүхийн байгууллагын "нууц"-д хамаарах тул шүүгч зөвлөлдөх тасалгаанд шүүгчийн туслахтай уулзаж, хэргийн зохигч талтай туслахаараа дамжуулж харилцсан (гомдол гаргагчийн хэлж буйгаар бол өөрөө харилцсан) үйлдэл нь ёс зүйн зөрчил болно.

Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 2.3 дугаар зүйлд "Шүүгч нь зохисгүй байдал гаргаж болохгүй бөгөөд бусдад ийнхүү ойлгогдохоос зайлсхийнэ" гэж заасан. Энэ зүйлийн ишлэлд зохисгүй байдал гэдгийг "Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1.9-д тодорхойлсон утгаар ойлгоно гэж заасан" байх бөгөөд энэ 1.9-д "зохисгүй байдал" гэж хууль, хянан шийдвэрлэх ажиллагааны хэм хэмжээ, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийг зөрчсөн, эсхүл шүүгчийн хараат бус, зарчимч, төвийг сахих байдлыг алдагдуулсан аливаа үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно гэжээ.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.17-д "хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах"-ыг хориглосон. Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана" гэж заасан. Хуульд захирагдаж хэргийг шийдвэрлэхийн тулд шүүгч нь төвийг сахих зарчмыг баримтлах ёстой. Монгол Улсын Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 1-д төвийг сахих шүүгчийн үүргийг заасан. Хэргийн аль нэг талтай нөгөө талыг байлцуулахгүйгээр уулзахыг шүүгчид хориглох замаар түүний төвийг сахисан байдлыг хамгаалдаг. Учир нь шүүгч хэргийн нэг талтай нөгөө талыг байлцуулалгүйгээр уулзсанаар зөвхөн нэг талын үндэслэлийг сонсох эрсдэлтэй бөгөөд уг үндэслэлийг няцаах боломжийг нөгөө талд олгодоггүй. Зөвхөн нэг талын үндэслэлийг сонссоноор шүүгч хууль зүйн болон фактын асуудал дээр алдаатай дүгнэлт гаргах бодит эрсдэлийг бий болгодог. Түүнчлэн, шүүгч нь нэг талтай уулзсанаар авлига эсхүл бусад зүй бус нөлөөнд бодитой автах, эсхүл олон нийтэд тийнхүү ойлгогдох, хардлага төрүүлэх, шүүхэд итгэх бусдын итгэл үгүй болох нөхцөл үүсэх юм. Ийм учир шалтгаанаар, хууль дээдлэх ёстой буюу эрх зүйт төртэй улсад хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзахыг шүүгчид хориглодог. ШЭЗБТХ-ийн 27.1.17-д заасан "хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах" гэдэгт биечлэн уулзах, утсаар ярих, бичих зэрэг аливаа харилцааг багтаадаг.

Шүүгч А.Ж хариуцагч К.Б руу өөрөө залгаж утсаар ярьсан эсэх нь нотлогдохгүй байна. Гэвч, шүүгч А.Ж хариуцагч К.Б руу залгаж утсаар ярьсан гэх ойлголтыг төрүүлсэн нь шүүгч А.Ж шүүх хуралдааныг завсарлуулж зөвлөлдөх тасалгаанд орсон үедээ өөрийн6331 дугаарын дугаараас К.Б руу дуудлага хийгдсэн, улмаар К.Б шүүх хуралдаанд очиж оролцсон үйл баримтаар тогтоогдож байна.

Шүүгч А.Ж нь маргааны нэг талтай нөгөө талыг байлцуулахгүйгээр харилцсан гэсэн ойлголтыг төрүүлж шүүгчийн хараат бус, зарчимч, төвийг сахих байдалд итгэх олон нийтийн итгэлийг хөсөрдүүлсэн учраас тэрээр Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 2.3 дугаар зүйлд буй зохисгүй байдал гаргасан гэж ойлгогдохоос зайлсхийх үүргээ зөрчсөн байна. Мөн, шүүгч А.Ж өөрийн хувийн гар утасны дугаараас маргааны нэг тал руу залгаж ярих байдал үүсгэсэн нь шүүгч төвийг сахиж, хараат бусаар, шударга ажилладаг гэсэн мэргэжлийн нэр хүндийг сэвтүүлж, энэ талаарх олон нийтийн итгэлийг алдагдуулсан байна. Иймд, шүүгч А.Ж нь Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1-ийн "мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх зарчмыг хувийн зан чанар болгож төлөвшүүлнэ," 3.2 дугаар зүйлийн 1-ийн "Шүүгч нь хэргийн оролцогчдод эрх тэгш, төвийг сахисан, хүнлэг ёсоор хандаж, хэргийг

шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлэхүйц харилцааны соёлыг эзэмшсэн байна” гэснийг тус тус зөрчсөн байна.

Шүүгч А.Ж нь Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 2-т “Хэргийн оролцогчдын зүгээс шүүгчийг татгалзахад хүргэх нөхцөл байдлыг өөрийн үг яриа, үйлдлээр бий болгохоос урьдчилан сэргийлж, зайлсхийнэ” гэж заасныг мөн зөрчсөн байна. Учир нь, шүүгч А.Ж өөрийн хувийн гар утасны дугаараар хариуцагч руу өөрөө залгасан гэсэн ойлголт төрүүлсэн нь уг хэргийг төвийг сахиж, хараат бусаар шударга хянан шийдвэрлэх эсэхэд үндэслэл бүхий эргэлзээ үүсгэсэн. Тиймээс, татгалзан гарах үр дагавар бий болгох үйлдэл гаргажээ.

2017 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн Ф аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүх хуралдааны үед “шүүгч А.Ж шүүхийн хэлэлцүүлгийн шатандаа надаас асуулт асуухдаа дандаа тулган шаардаж, хөтөлсөн асуулт тавьж байснаа миний өмгөөлөгч. С.Н эсэргүүцэл үзүүлж яагаад тулгаж асуулт тавьж байгаа юм бэ гэж эсэргүүцэж байсан юм” гэж К.Б гомдолдоо бичжээ. К.Б яг ямар асуулт “тулган шаардсан, хөтөлсөн” шинжтэй байсныг дурдаагүй бөгөөд шүүгч А.Ж хариуцагчаас “тулган шаардсан, хөтөлсөн асуулт” асуусан нь тус шүүх хуралдааны тэмдэглэл болон шалгалтын явцад цугларсан бусад баримтаар нотлогдохгүй байна.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35, 36 дугаар зүйл, 37 дугаар зүйлийн 37.1.1, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйл, Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5.7.1, 5.13-т заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Ф аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч А.Ж-д сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Энэ магадлалын хувийг шүүгч болон гомдол гаргагчид хүргүүлэхийг Ажлын албанд даалгасугай.

3.Шүүгч болон гомдол гаргагч энэ магадлалыг эс зөвшөөрвөл хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.

ДАРГАЛАГЧ

Н.ЭРДЭНЭЦОГТ

ГИШҮҮН

Н.ГАНБАЯР

ОИХ.МН
СУДАЛГААНЫ САН



ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ
МАГАДЛАЛ

2017 оны 10 сарын 04 өдөр

Дугаар 221/ЁМ2017/0018

Улаанбаатар хот

Шүүгчид сахилгын шийтгэл ногдуулсан
Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалын тухай

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааныг шүүгч Ц.Сайхантуяа даргалж, шүүгч Б.Тунгалагсайхан, шүүгч С.Мөнхжаргал нарын бүрэлдэхүүнтэй хийж, Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 49 дүгээр магадлалыг эс зөвшөөрч шүүгч А.Ж-ийн гаргасан гомдлоор, Ф аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч А.Ж холбогдох сахилгын хэргийг шүүгч С.Мөнхжаргалын илтгэснээр хянан хэлэлцэв.

ТОДОРХОЙЛОХ нь:

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 8 дугаар сарын 05-ны өдрийн 49 дүгээр “Ф аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч А.Ж-д сахилгын шийтгэл ногдуулах тухай” магадлалаар Ф аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч А.Ж-д сануулах сахилгын шийтгэл ногдуулж шийдвэрлэжээ.

Шүүгч А.Ж гомдолдоо: "... хүсэлтийг хүлээн авах эсэхийг хянан шийдвэрлэхээр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 105 дугаар Зүйлийн 105 1-д зааснаар шийдвэрлэхээр зөвлөлдөх тасалгаанд гарсан (шүүх хуралдааны танхим зориулалтын зөвлөлдөх тасалгаагүй тул албан конторт зөвлөлдсөн) Улмаар албан конторт хэргийн оролцогч нар болон шүүх хуралдааны оролцогчдыг чирэгдүүлэхгүй, шуурхай, шүүх хуралдааныг товросон хугацаанд хийхийн тулд шүүхийн дотоод чатаар шүүгчийн туслах М.М-ийг дуудаж хариуцагч К.Б нь шүүх хуралдаанд хэзээ биечлэн оролцох боломжтой эсэх, шүүх хуралдааныг хойшлуулбал Давж заалдах шатны шүүх, Захиргааны хэргийн шүүх, Эрүүгийн, Иргэний хэргийн шүүхүүдийн шүүгч нарын зарласан шүүх хуралдааны товыг хараад хэдний өдөр шүүх *уралдааныг тавьж болох эсэхийг тодруул гэхэд, туслах М.М нь өөрийн утасгүй ирсэн ба өрөөнд албаны утас байхгүй тул миний ...6331 дугаарын утсаар хариуцагч К.Б-тэй холбогдоход өөрөө биечлэн оролцохоо мэдэгдсэн байна. Тэгээд хариуцагч К.Б нь шүүх хуралдааны танхимд өөрийн биеэр орж ирснээр, шүүх хуралдааныг хойшлуулахгүйгээр үргэлжлүүлэн явуулж, нэхэмжлэгч хариуцагч нарыг мэтгэлцэх эрхээр нь хангасан болно. Магадлалд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1, 94.2, мөн Байгууллагын нууцын тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг зааснаар шүүгч зөвлөлдөх тасалгаанд шүүгчийн туслахтай уулзаж, хэргийн зохигч талтай туслахаараа дамжуулж харилцсан үйлдэл нь ёс зүйн зөрчил гэжээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1-д зааснаар тухайн хэргийг эцэслэн шийдвэрлэж шийдвэр гаргахаар зөвлөлдөх

тасалгаанд гараагүй, нэхэмжлэгч талын хариуцагчийг шүүх хуралдаанд биечлэн оролцуулж мэтгэлцэх зарчмаар хангаж өгөх тухай гаргасан хүсэлтийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 105 дугаар зүйлийн 105.1-д "хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдсон бусад асуудлын талаар хэргийн оролцогчоос гаргасан хүсэлтийг бусад оролцогчийн саналыг сонсмогц буюу шүүгч даруй шийдвэрлэнэ" гэж заасны дагуу зөвлөлдөх тасалгаанд гарсан бөгөөд Ф аймгийн шүүх бол дотроо аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Ф аймаг дахь Захиргаа, Эрүү, Иргэний гэсэн 4 шүүхтэй мөн шүүх хуралдааны 2 танхимтай, нутгийн онцлогоос шалтгаалан орон тооны нэг орчуулагч зэргээс шүүх хуралдааны танхим болон орчуулагч давхцаж шүүх хуралдаан цагтаа хийх боломжгүй хойшлуулах хүндрэл гардаг тул дээрх шүүхүүдийн шүүгч нарын зарласан шүүх хуралдааны товыг харж өмгөөлөгч, орчуулагч давхцах эсэх, хариуцагч К.Б нь шүүх хуралдаанд хэзээ биечлэн оролцох боломжтой эсэхийг тодруулахын тулд туслахаа байгууллагын дотор чатаар дуудсан.

Шүүгчийн туслах М.М нь хариуцагч К.Б-тэй шүүх хуралдаанд хэзээ ирж оролцох боломжтой эсэхийг тодруулахад шууд ирж оролцохоо мэдэгдсэн байна. Нэгэнт шүүх хуралдаанд хариуцагч өөрийн биеэр биечлэн ирсэн тул шүүх хуралдааныг хойшлуулахгүйгээр үргэлжлүүлэн хуульд заасан журмын дагуу явагдаж тус шүүхийн 2017 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 214 дугаартай шүүхийн шийдвэр гарсан, энэ шийдвэрийг хариуцагч К.Б эс зөвшөөрч давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж, Ф аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхээс 2017 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн шүүх хуралдаанаар хэлэлцэж 62 дугаартай магадлал гарч, магадлалыг хариуцагч эс зөвшөөрч хяналтын журмаар гомдол гаргаснаар Улсын Дээд Шүүхээр хянагдаж байгаа.

Шүүхийн болон шүүгчийн зүгээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хэргийн оролцогчийн эрхийг зөрчөөгүй ба Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлсэн гэж үзэж байна. Хэрвээ Давж заалдах шатны шүүхээс хариуцагчийн гомдол дурдсанчлан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн гэж үзвэл уг хэргийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 167 дугаар зүйлийн 167.1.5-д зааснаар шийдвэрийг хүчингүй болгож дахин шийдвэрлүүлэхээр анхан шатны шүүхэд буцаах боломжтой байсан.

Иймд миний бие Шүүгчийн Ёс зүйн дүрмийн холбогдох заалтуудыг зөрчөөгүй тул Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 49 дугаартай магадлалыг хэрэгсэхгүй болгож өгөхийг хүсье" гэжээ.

ХЯНАВАЛ:

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 17 дугаар магадлал хууль зүйн үндэслэлтэй байх тул хэвээр үлдээж, шүүгч А.Ж-ийн давж заалдах гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэлээ

Ф аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч А.Ж нь 2017 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн шүүх хуралдааны явцад нэхэмжлэгчээс гаргасан "хариуцагчийг шүүх хуралдаанд оролцуулах" хүсэлтийг шийдвэрлэхээр завсарлаж, зөвлөлдөх тасалгаанд орсон үедээ уг асуудлыг хуульд заасан журмаар шийдвэрлэлгүй, өөрийн хувийн гар утсаар хариуцагч К.Б-руу шүүгчийн туслах М.М-аар яриулж, ирүүлэн шүүх хуралдааныг үргэлжлүүлэн хийжээ.

Шүүгчийн энэхүү үйлдэл нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.17-д "хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах"-ыг хориглосон, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1-д "Бүх шатны шүүх шийдвэрээ зөвлөлдөх тасалгаанд

гаргана", 94.2-т "Зөвлөлдөх тасалгаанд хэргийг хянан шийдвэрлэх талаар шүүх бүрэлдэхүүний гаргасан санал нууц байна" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Ёс зүйн хороо уг үйлдлийг Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 2.3 дугаар зүйлд "Шүүгч нь зохисгүй байдал гаргаж болохгүй бөгөөд бусдад ийнхүү ойлгогдохоос зайлсхийнэ" гэж заасныг зөрчсөн "ёс зүйн зөрчил" гэж үзэж сануулах сахилгын шийтгэл ногдуулсныг буруутгах үндэслэлгүй байна.

Шүүгч А.Ж давж заалдах гомдолдоо "... хуулийн 94.1-д зааснаар тухайн хэргийг эцэслэн шийдвэрлэж шийдвэр гаргахаар зөвлөлдөх тасалгаанд ороогүй. ... нэхэмжлэгчийн хүсэлтийг шийдвэрлэхээр орсон" гэх боловч дээрх хуулийн 94.1, 94.2-т заасан заалт нь шүүх хуралдааны үед шийдвэрлэж байгаа бүх шийдвэр, захирамж, тогтоол гаргахад хамаарна.

Мөн гомдолд "...орон нутгийн шүүхийн шүүх хуралдааны танхим орчуулагч хүрэлцээгүй байдал зэрэг шалтгаанаас дараагийн хурал товлохоор хариуцагч хэзээ оролцох боломжтой талаар асуулгасан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийн оролцогчийн эрхийг зөрчөөгүй, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлсэн..." гэжээб

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 105 дугаар зүйлийн 105.1-д зааснаар нэхэмжлэгчийн хүсэлтийг шийдвэрлэхээр зөвлөлдөх тасалгаанд орсон бол тухайн асуудлаа шийдвэрлэх ёстой атал хүсэлтийг шийдвэрлээгүй. Мөн шүүх хуралдааныг хойшлуулах эсэхээ шийдвэрлэснийхээ дараа шүүх хуралдааныг хэзээ товлох талаар хэргийн бүх оролцогчдоос санал асууж товлох боломжтой атал зөвлөлдөх тасалгаанд байхдаа хэргийн нэг оролцогчтой харилцаж "зөвлөлдөх тасалгаанд шүүгч бусадтай харьцахгүйгээр, хараат бусаар шийдвэрээ гаргадаг" гэдэгт итгэх олон нийтийн итгэлийг алдагдуулахаар үйлдэл буюу зохисгүй байдал гаргажээ. Иймд "шүүх хуралдаанд хэргийн оролцогчийг оролцуулж мэтгэлцэх боломжоор хангасан" гэх тайлбар нь дээрх ёс зүйн зөрчлийг зөвтгөх үндэслэл болохгүй.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь.

1. Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 49 дүгээр магадлалыг хэвээр үлдээсүгэй.

2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.5 дахь хэсэгт зааснаар давж заалдах шатны шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн, хууль буруу хэрэглэсэн гэж хэргийн оролцогчид тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч үзвэл магадлалыг гардан авсан эсхүл хүргүүлснээс хойш 14 хоногийн дотор Улсын Дээд шүүхийн захиргааны хэргийн танхимд гомдол гаргах эрхтэй.

ШҮҮГЧ

Ц.САЙХАНТУЯА

ШҮҮГЧ

Б.ТУНГАЛАГСАЙХАН

ШҮҮГЧ

С.МӨНХЖАРГАЛ



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ХЯНАЛТЫН ШАТНЫ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2017 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 503

Улаанбаатар хот

Ф аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн
анхан шатны шүүхийн шүүгч А.Ж-д
холбогдох сахилгын хэргийн тухай

Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааныг Танхимын тэргүүн М.Батсуурь даргалж, шүүгч Л.Атарцэцэг, Г.Банзрагч, Д.Мөнхтуяа, П.Соёл-Эрдэнэ нарын бүрэлдэхүүнтэй хийж, Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 49 дүгээр магадлал, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 221/ЁМ2017/0018 дугаар магадлалыг эс зөвшөөрч шүүгч А.Ж-ийн хяналтын журмаар гаргасан гомдлоор К.Б-ийн гомдолтой, шүүгч А.Ж-д холбогдох сахилгын хэргийг шүүгч Г.Банзрагчийн илтгэснээр хянан хэлэлцэв. ТОДОРХОЙЛОХ нь:

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 49 дүгээр магадлалаар Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйл, 36 дугаар зүйл, 37 дугаар зүйлийн 37.1.1, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйл, Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5.7.1, 5.13-т заасныг тус тус удирдлага болгон Ф аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч А.Ж-д сануулах сахилгын шийтгэл ногдуулжээ.

Шүүгч А.Ж-ийн гомдлоор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хэргийг хянан хэлэлцээд 2017 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 221/ЁМ2017/0018 дугаар магадлалаар Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 49 дүгээр магадлалыг хэвээр үлдээсэн байна.

Шүүгч А.Ж хяналтын журмаар гаргасан гомдолдоо: "... Миний бие Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 49 дүгээр магадлал, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн дугаар 221/ЁМ2017/0018 дугаар магадлалыг тус тус эс зөвшөөрч энэхүү гомдлыг гаргаж байна.

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 49 дүгээр магадлалаар "Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 2.3 дугаар зүйлд буй зохисгүй байдал гаргасан гэж ойлгогдохоос зайлсхийх үүргээ зөрчих", дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1-ийн "Мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх зарчмыг хувийн зан чанар болгож төлөвшүүлнэ", 3.2 дугаар зүйлийн 1-ийн "Шүүгч нь хэргийн оролцогчдод эрх тэгш, төвийг сахисан, хүнлэг ёсоор хандаж, хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлэхүйц харилцааны соёлыг эзэмшсэн байна", мөн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 2-т "Хэргийн оролцогчийн зүгээс шүүгчийг татгалзахад хүргэх нөхцөл байдлыг

өөрийн үг яриа, үйлдлээр бий болгохоос урьдчилан сэргийлж, зайлсхийнэ.” гэснийг тус тус зөрчсөн гэж үзэж сануулах ' сахилгын шийтгэл ноогдуулсан, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс дээрх Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалыг хэвээр баталсан нь үндэслэлгүй байна.

Шүүгч А.Ж би, нэхэмжлэгч Х.Т-ийн нэхэмжлэлтэй, хариуцагч К.Б-д холбогдох өлөн гэдэсний үнээс үлдсэн үнэ болох 4.152.600 төгрөг гаргуулахыг хүссэн тухай иргэний хэргийг 2017 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн шүүх хуралдаанаар хэлэлцэх явцад нэхэмжлэгч болон түүний өмгөөлөгчөөс ирцтэй холбоотой санал хүсэлтийг асуухад хариуцагчийг шүүх хуралдаанд заавал оролцуулж, хариуцагчтай мэтгэлцэх зарчмаар хангах шаардлагатай талаар хүсэлт гаргасан.

Хүсэлтийг хүлээн авах эсэхийг хянан шийдвэрлэхээр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 105 дугаар зүйлийн 105.1-д зааснаар зөвлөлдөх тасалгаанд гарсан (шүүх хуралдааны танхим зориулалтын зөвлөлдөх тасалгаагүй тул албан конторт зөвлөлдсөн). Улмаар албан конторт хэргийн оролцогч нар болон шүүх хуралдааны оролцогчдыг чирэгдүүлэхгүй, шуурхай, шүүх хуралдааныг товлосон хугацаанд хийхийн тулд шүүхийн дотоод чатаар шүүгчийн туслах М.М-ийг дуудаж хариуцагч К.Б нь шүүх хуралдаанд хэзээ биечлэн оролцох боломжтой эсэх, шүүх хуралдааныг хойшлуулбал давж заалдах шатны шүүх, захиргааны хэргийн шүүх, эрүүгийн болон иргэний хэргийн шүүхүүдийн шүүгч нарын зарласан шүүх хуралдааны товыг хараад хэдний өдөр шүүх хуралдааныг тавьж болох эсэхийг тодруул гэсэн. Туслах М.М нь миний өрөөнд өөрийн утасгүй ирсэн ба албаны утас байхгүй тул миний ...6331 дугаарын утсаар хариуцагч К.Б-тэй холбогдоход өөрөө биечлэн оролцохоо мэдэгдсэн байна.

Тэгээд хариуцагч К.Б нь шүүх хуралдааны танхимд өөрийн биеэр орж ирснээр, шүүх хуралдааныг хойшлуулахгүйгээр үргэлжлүүлэн явуулж, нэхэмжлэгч хариуцагч нарыг мэтгэлцэх эрхээр нь хангасан болно.

Дээрх хуралдаанаас 2017 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 214 дугаартай шүүхийн шийдвэр гарсан ба энэ шийдвэрийг хариуцагч К.Б эс зөвшөөрч давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасан.

Ф аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхээс 2017 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн шүүх хуралдаанаар давж заалдах гомдлыг хэлэлцэж 62 дугаартай магадлал гарч, магадлалыг хариуцагч эс зөвшөөрч хяналтын журмаар гомдол гаргаснаар Улсын Дээд шүүхээс дээрх магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн болно.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1-д зааснаар тухайн хэргийг эцэслэн шийдвэрлэж шийдвэр гаргахаар зөвлөлдөх тасалгаанд гараагүй, нэхэмжлэгч талын хариуцагчийг шүүх хуралдаанд биечлэн оролцуулж мэтгэлцэх зарчмаар хангаж өгөх тухай гаргасан хүсэлтийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 105 дугаар зүйлийн 105.1-д “... хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдсон бусад асуудлын талаар хэргийн оролцогчоос гаргасан хүсэлтийг бусад оролцогчийн саналыг сонсмогц буюу шүүгч даруй шийдвэрлэнэ” гэж заасны дагуу зөвлөлдөх тасалгаанд гарсан.

Шүүхийн болон шүүгчийн зүгээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийн оролцогчийн эрхийг зөрчөөгүй ба Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлсэн гэж үзэж байна. Давж заалдах шатны шүүх болон хяналтын шатны шүүхээс хариуцагчийн гомдолд дурдсанчлан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн гэж үзвэл уг хэргийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд

зааснаар шийдвэрийг хүчингүй болгож дахин шийдвэрлүүлэхээр анхан шатны шүүхэд буцаах боломжтой байсан. Иймд миний бие Шүүгчийн Ёс зүйн дүрмийн холбогдох заалтуудыг зөрчөөгүй тул Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 49 дүгээр магадлал, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 221/ЁМ2017/0018 дугаар магадлалыг тус тус хэрэгсэхгүй болгож өгнө үү” гэжээ.

ХЯНАВАЛ:

Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал болон Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал хууль зүйн үндэслэлтэй байна.

Ф аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч А.Ж нь 2017 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн шүүх хуралдааны явцад нэхэмжлэгчээс гаргасан "хариуцагчийг шүүх хуралдаанд оролцуулах" хүсэлтийг шийдвэрлэхээр завсарлаж, зөвлөлдөх тасалгаанд орсон үедээ хүсэлтийг шийдвэрлэлгүй, харин өөрийн гар утсаар хариуцагч К.Б руу ярьсан/яриулсан нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1-д "Бүх шатны шүүх шийдвэрээ зөвлөлдөх тасалгаанд гаргана", 94.2-т "Зөвлөлдөх тасалгаанд хэргийг хянан шийдвэрлэх талаар шүүх бүрэлдэхүүний гаргасан санал нууц байна" гэснийг зөрчсөн байх бөгөөд энэ нь Шүүгчийн ёс зүйн дүрмийн 2.3 дугаар зүйлд "Шүүгч зохисгүй байдал гаргаж болохгүй бөгөөд бусдад ийнхүү ойлгогдохоос зайлсхийх" үүргийг зөрчсөн ёс зүйн зөрчил, энэ талаарх ёс зүйн хорооны болон давж заалдах шатны шүүхийн дүгнэлт үндэслэлтэй.

Харин "утсаар ярьсан/яриулсан" нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.17-д заасан "хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах"-ыг хориглосныг зөрчсөн үйлдэл гэж үзэхээргүй байна. Хэдийгээр хэргийн оролцогчтой утсаар ярих нь "уулзалт"-ын нэг хэлбэр мөн боловч энэхүү зохицуулалтын зорилго нь шүүгч хэргийг хараат бус, хөндлөнгийн байр сууринаас шударгаар шийдвэрлэхийн тулд аль нэг талтай нь уулзаж, хэргийн талаар ярилцах, зүй бус нөлөөнд автахгүй байхад чиглэгдэнэ. Харин А.Ж-ийн хувьд хэргийн оролцогчийг шүүх хуралд оролцуулах үүднээс хурлын товыг тогтоохоор ярьсан/туслахаараа яриулсан нь дээрх хуулийн зорилгод хамааралгүй, гагцхүү шүүх хурлын зөвлөлдөх тасалгаанд хүсэлтийг шийдвэрлэх байтал хэргийн оролцогч руу утсаар ярьсан/яриулсан нь буруу, энэ утгаараа зөрчил болно.

Гэвч энэ нь шүүгчийн гаргасан ёс зүйн зөрчлийг бүхэлд нь үгүйсгэж, сахилгын шийтгэлээс чөлөөлөх үндэслэл болохгүй юм.

Иймээс шүүгч А.Ж-ийн "би ёс зүйн зөрчил гаргаагүй, шүүхийн болон шүүгчийн зүгээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийн оролцогчийн эрхийг зөрчөөгүй ба Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлсэн" гэсэн гомдлыг хангах үндэслэлгүй.

Мөн Ф аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 62 дугаар магадлал болон түүнийг хэвээр үлдээсэн Улсын Дээд шүүхийн тогтоол нь шүүгч А.Ж-ийн ёс зүйн зөрчлийг үгүйсгэх үндэслэл болохгүй.

Дээрх үндэслэлээр шүүх бүрэлдэхүүн Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал болон давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээх нь зүйтэй гэж үзлээ.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.1, 127.2.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 49 дүгээр магадлал, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 221/ЁМ2017/0018 дугаар магадлалыг тус тус хэвээр үлдээж, шүүгч А.Ж-ийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангахгүй орхисугай.

ТАНХИМЫН ТЭРГҮҮН

М.БАТСУУРЬ

ШҮҮГЧ

Г.БАНЗРАГЧ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЁС ЗҮЙН ХОРООНЫ МАГАДЛАЛ

2017 оны 7 сарын 05 өдөр

Дугаар 52

Улаанбаатар хот

Ш аймаг дахь Сум дундын Иргэний
хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М-д
сахилгын шийтгэл ногдуулах тухай

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааныг тус хорооны дарга Н.Эрдэнэцогт даргалж, гишүүн А.Доржготов, Н.Ганбаяр, Ч.Оюунцэцэг, О.Мөнхсайхан нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны тэмдэглэл хөтлөгчөөр шинжээч А.Энхбаатар, референт Ж.Халиун нарыг оролцуулан Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдааны танхимд хийв. Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 6-р сарын 02-ны өдрийн 108 дугаар тогтоолыг Шүүхийн ёс зүйн хорооны гишүүн О.Мөнхсайханы илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Иргэн Х.М Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан гомдолдоо: "Х.М би Ш аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М нь 2017 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 1031 дүгээр шүүгчийн захирамжийг гаргахдаа шүүгчийн ёс зүйн зөрчил гаргасан гэж үзэж энэ гомдлыг гаргаж байна. Үйл баримтын тухай, Ш аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхэд Ш аймгийн П сумын ХХ дугаар багт байрлах П сумын хүүхдийн "ССС цэцэрлэг" /эрхлэгч: М.С/ нэхэмжлэлтэй иргэн Х.М намайг хариуцагчаар татсан "Цэцэрлэгийн эзэмшлийн газрыг албадан чөлөөлүүлэх тухай" иргэний хэргийг хянан шийдвэрлэж байсан болно. Энэхүү хэргийг хянан шийдвэрлэх явцад буюу 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдөр би ТТТ улсад амьдардаг 83 настай төрсөн ээж С.А-гийн тархинд цус харваж, биеийн байдал хүнд байгаа гэсэн яаралтай дуудлагыг хүлээн авч ажлын цаг тарсны дараа тэр шөнийнхөө үүрээр ТТТ улс руу яаралтай явсан билээ. Энэ тухайгаа шүүхэд албан ёсоор мэдэгдэх ямар ч боломжгүй байсан юм.

Намайг ТТТ улсад очиход ээж маань тархиндаа тал цус харвалт өгсөн, ярьж чадахгүй, тал бие нь мэдээгүй, хэвтэрт орсон байсан. Тиймээс би 2 сар гаруй ээжийгээ сахиж байгаад нас барсных нь дараа хөдөөлүүлчхээд Ш аймагт буцаж ирсэн билээ. Ийнхүү би гэртээ ирээд намайг ТТТ улсад байх үед шүүхээр хянан хэлэлцэж байсан дээр дурдсан хэргийг аймгийн Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх шийдвэрлэсэн, мөн шүүхийн шийдвэр нь ... дугаар багийн Засаг дарга Х.К-д байгааг олж мэдсэн болно. Шүүх уг шийдвэрийг Засаг даргад гардуулан өгөхөөр очиход нь тэрээр "Х.М, Б.Г нар ар гэрийн гачигдлаар ТТТ улсад явсан тул хүргүүлэх боломжгүй." гэж уг шийдвэрийг хүргэж ирсэн шүүхийн ажилтан тайлбарлан, хүлээн авахаас татгалзахад тэрээр үл хэрэгсэн шүүгч рүү утсаар яриулж, хүчээр гарын үсэг зуруулж гардуулан өгсөн байдаг. Би ТТТ улсаас ирсэн даруйдаа буюу 2017.03.29-ний өдөр уг шийдвэрийг хүлээн авч, танилцаад давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасан боловч "Гомдол гаргах хугацаа өнгөрсөн тул хүлээж авах боломжгүй" гэсэн хариу өгсөн. Иймээс энэхүү хугацааг

сэргээх хүсэлт гаргахад шүүгч Б.М нь түүнийг хүлээн авахаас татгалзсан захирамж гаргасан болно.

Гомдлын хууль зүйн үндэслэл, би шүүгч Б.М-г уг захирамжийг гаргахдаа Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Шүүгч нь хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх..." зарчмыг зөрчсөн гэж үзэж байгаа юм. Үүнд:

1.Ш аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М 2017 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 1031 дүгээр захирамжийнхаа үндэслэх хэсэгт "... хариуцагч нар оршин суугаа хаягтаа байгаагүй тул тус багийн засаг даргад шийдвэрийг гардуулсан..." гэж болсон үйл баримтын зөвхөн хэлбэр талыг илтэд үндэслэн миний хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон. Тухайлбал, шүүхийн шийдвэрийг хүлээн авах үедээ манай багийн засаг дарга намайг ар гэрийн гачигдлаар буюу хүндээр өвчилсөн, улмаар насан өөд болсон ээжийнхээ асуудлаар ТТТ явсныг тодорхойлон хэлж байсан тухайгаа бичгээр нотолсон, тэр нь миний давж заалдах хугацаа сэргээх хүсэлтийн хавсралт бичиг баримтад байгаа, мөн энэ үйл баримтыг нотолсон бусад бичиг баримтыг огт анхаарч үзээгүй болно.

2.ИХШХШТХ-ийн 120 дугаар зүйлийн 120.3-т "Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч энэ хуулийн 120.2-т "заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн бол хугацаа сэргээлгэх хүсэлтийг анхан шатны шүүхэд гаргах ба хүсэлтийг хангах эсэхийг шуугч захирамж гарган шийдвэрлэнэ" гэж заасан бөгөөд Иргэний хуулийн 82 дугаар зүйлийн 82.4 дэх хэсгийг тайлбарласан, Иргэний хуулийн албан ёсны "Шинжлэх ухааны тайлбар /2010 он/-т "хүндэтгэн үзэх шалтгаан гэдэгт "... хүнд өвчин, бие хамгаалах чадваргүй байдал, урт хугацааны томилолт зэргийг хамааруулан ойлгоно гэсэн бол 2008.05.20-ны өдөр батлагдсан, мөн Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д хүндэтгэн үзэх шалтгаан гэдэгт "... өвчтөн асарсан ..." гэж тодорхойлон заасан байна.

3.Ер нь хүүхэд нь төрүүлсэн эцэг, эхээ асран халамжлах нь, хүндээр өвчилсөн үед асрах, нас барвал оршуулах нь зөвхөн хууль ёсны төдийгүй хүн ёсны журамт үүрэг гэдгийг хуульч шүүгч хүн мэдэхгүй байна гэвэл хэтэрхий гэнэн явдал болох биз ээ.

4.Шүүх захирамжид хаягаа өөрчилбөл энэ тухай шүүхэд мэдэгдэх үүргээ биелүүлээгүй гэжээ. Би хаяг өөрчлөөгүй тэгвэл шүүгч зохиогчдод шүүх хурлын товыг мэдэгдэнэ гэсэн үүргээ биелүүлээгүй шийдвэрийг 2 сар 10 хоног хугацаа хэтрүүлэн гардуулсны хариуцлагыг хэн хүлээх ёстой вэ.

Иймд шүүгч Б.М нь Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.3 зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Шүүгч нь хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх..." зарчмыг зөрчсөн гэж үзэж байгаа юм. Мөн тус дүрмийн 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй" гэж заасан үүргээ биелүүлээгүй ба хэрэг шийдвэрлэхдээ хэт нэг талыг барьж иргэн миний Үндсэн хуулиар хамгаалагдсан "дээд шатны шүүхэд гомдол гаргах" эрхийг ноцтойгоор зөрчсөн гэж үзэж сахилгын шийтгэл ногдуулахыг хүсэж байна" гэжээ.

Шүүгч Б.М Шүүхийн Ёс зүйн хороонд ирүүлсэн тайлбартаа: "Ш аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М би нэхэмжлэгч Ш аймгийн П сумын 2 дугаар цэцэрлэгийн нэхэмжлэлтэй, хариуцагч Х.М , Б.Г , Б.Р нарт холбогдох "П сумын Хүүхдийн ССС цэцэрлэгийн эзэмшил бүхий газрыг чөлөөлүүлэх тухай" иргэний хэргийг 2016.09.12-ны өдөр хүлээн авч, Ш аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016.11.02-ны өдрийн №638 дугаартай шийдвэр гаргасан юм. Энэ Ш аймгийн П сумын ССС цэцэрлэгийн нэхэмжлэлтэй, хариуцагч Х.М , Б.Г , Б.Р нарт холбогдох "П сумын Хүүхдийн ССС цэцэрлэгийн эзэмшил бүхий газрыг чөлөөлүүлэх тухай" иргэний хэрэг нь Ш аймаг

дахь Сум дундын 2013.06.20-ны өдрийн 458 дугаартай шүүгчийн захирамжаар иргэний хэрэг үүсгэснээс хойших 3 жилийн хугацаанд анхан шатны шүүх, давж заалдах шатны шүүх, хяналтын шатны шүүхээр хэд хэдэн удаа хянагдаж байсан ба хамгийн сүүлд Ш аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016.09.01-ний өдрийн №212/МА2016/00039 дугаартай магадлалаар хэргийг дахин шийдвэрлэхээр анхан шатны шүүхэд буцаасан тул тус шүүхийн Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн хэргийг Иргэн-2014 программын дагуу тойргийн журмаар шууд надад хуваарилж, хүлээлгэн өгсөн. Хэрэгт магадлалд заасан болон бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаануудыг хийж дуусгаад шүүх хуралдааны товыг мэдэгдэх гэсэн боловч 2016.10.20-ны өдрөөс хойш хариуцагч Х.М, Б.Г (Х.М-ийн эхнэр) нарын утас холбогдох боломжгүй, гэр нь цоожтой хүнгүй байсан болно. (Баримт 9). Иймээс хариуцагч Б.Г, Х.М нар нь оршин суугаа хаягтаа байгаагүй тул ИХШХШТХ-ийн 77 дугаар зүйлийн 77.6-д зааснаар П сумын ХХ дугаар багийн Засаг даргад шүүх хуралдааны товыг мэдэгдсэн "Шүүхийн мэдэгдэх хуудсыг хүргүүлсэн ба тус багийн Засаг дарга Х.К-т нь хариуцагч нар ТТТ Улс руу явсан тухай тодорхойлолт гаргаж өгсөн.

Хариуцагч Х.М нь тухайн үед ТТТ Улс руу явах гэж байгаагаа шүүхэд мэдэгдээгүй, өндөр настай ээж нь өвдсөн эсэх талаар ямар нэгэн хүсэлт шүүхэд гаргаж байгаагүй явдал нь түүний ИХШХШТХ-ийн 76 дугаар зүйлийн 76.2-т заасан "шүүх хуралдааны товыг шүүхээс асуух", мөн хуулийн 77 дугаар зүйлийн 77.8-д заасан "хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа үед хаягаа өөрчилбөл энэ тухай шүүхэд мэдэгдэх" үүргээ зөрчсөн болохыг нотолж байгаа болно. Иймээс ИХШХШТХ-ийн 100 дугаар зүйлийн 100.3-т зааснаар нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хүсэлтээр хэргийг хариуцагч нарын эзгүйд хавтаст хэрэгт авагдсан баримт нотолгоог үндэслэн хянан шийдвэрлэсэн болно. Улмаар Ш аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016.11.02-ны өдрийн №638 дугаартай шийдвэрийг хуулийн хугацаанд хариуцагч Х.М-ийн өөрт нь гардуулахаар шүүхийн зарлага Р.А түүнийг хэзээ ирэхийг хамаатан садны хүмүүсээс удаа дараа асууж лавлаж байсан боловч түүнийг ТТТ Улсаас ойрын хугацаанд ирэхгүй гэсэн байна. (Энэ тухай шүүхийн зарлага Р.А-ийн бичсэн тайлбарыг хавсаргав.)

Иймээс ИХШХШТХ-ийн 119 дүгээр зүйлийн 119.6, 77 дугаар зүйлийн 77.6-д зааснаар тус шүүхийн 2016.11.02-ны өдрийн 638 дугаартай шийдвэрийг П сумын ХХ дугаар багийн Засаг дарга Х.К-д, 2017.01,13-ны өдрийн 15 цаг 50 минутад гардуулсан болно. Засаг даргад Х.К-д хүч хэрэглэсэн асуудал байхгүй, ИХШХШТХ-ийн холбогдох заалтын дагуу шүүхийн шийдвэрийг гардан авах эрхтэй субъект мөн бөгөөд Засаг дарга Х.К хариуцагч Х.М ТТТ улсаас ирмэгц түүнд шүүхийн шийдвэрийг гардуулан өгсөн байна. Хариуцагч Х.М Ш аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016.11.02-ны өдрийн 638 дугаартай шийдвэрийг эс зөвшөөрч давж заалдах гомдлыг тус шүүхэд 2017.03.31-ний өдөр гаргасан.

ИХШХШТХ-ийн 119 дүгээр зүйлийн 119.6-д зааснаар П сумын ХХ дугаар багийн Засаг дарга Х.К-т шийдвэрийг гардуулсан өдрөөр давж заалдах гомдол гаргах хугацааг тооцох бөгөөд хариуцагч Х.М нь ИХШХШТХ-ийн 120 дугаар зүйлийн 120.2-т заасан давж заалдах гомдол гаргах хугацааг 2 сар 2 хоногоор хэтрүүлсэн тул Х.М-ийн давж заалдах журмаар гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзах тухай тус шүүхийн 2017.04.03-ны өдөр 949 дугаартай шүүгчийн захирамж гарсан байна. Хариуцагч Х.М 2016.10.21-ний өдөр ТТТ улсад яваад, 2017.03.24-ний өдөр ТТТ улсаас ирсэн болох нь түүний Е1736581 дугаартай гадаад паспортын бичилтээр тогтоогдож байгаа боловч тухайн үед буюу 2016.10.21-ний өдөр хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ТТТ улсад явах гэж байгаагаа шүүхэд мэдэгдээгүй, мөн Х.М

ТТТ улсад байх хугацаандаа шүүхэд утас, мэйл, факсаар холбогдох боломжтой байсан боловч ТТТ явсан болон хүндэтгэн үзэх шалтгаан гарсан тухайгаа мэдэгдээгүй тул түүний 2017.04.07-ны өдөр давж заалдах гомдол гаргах хугацааг сэргээлгэх тухай хүсэлт гаргасныг хүлээн авахаас татгалзсан тухай тус шүүхийн 2017 04.10-ны өдрийн 1031 дугаартай шүүгчийн захирамж гаргасан болно. Шүүгч Б.М би хуульд заасан журмын дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулсан болно" гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 6-р сарын 02-ны өдрийн 108-р тогтоолоор шүүгч Б.М-т сахилгын хэрэг үүсгэж шийдвэрлэжээ.

Шүүгч Б.М Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанд ирүүлсэн тайлбартаа: "Ш аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М миний бие 2017 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн Шүүгчийн ёс зүйн хорооны 108 дугаар тогтоолыг эс зөвшөөрч дараах гомдлыг гаргаж байна. Үүнд:

1.Хариуцагч Х.М 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдөр ТТТ улсад яваад, 2017 оны 3 дугаар сарын 24-ний өдөр ТТТ улсаас ирсэн болох нь түүний Е1736581 дугаартай гадаад паспортын бичилтээр тогтоогдож байгаа боловч тухайн үед буюу 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдөр хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ТТТ улсад явах гэж байгаагаа шүүхэд мэдэгдээгүй

Мөн Х.М ТТТ Улсад байх хугацаандаа шүүхэд утас, мэйл, факсаар холбогдох боломжтой байсан боловч өвчтэй байгаа ээжийгээ асарч байгаа тухайгаа мэдэгдээгүй.

Энэ нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.2-т зааснаар шүүх хуралдааны товыг шүүхээс асуугаагүй. мөн хуулийн 77 дугаар зүйлийн 77.8-д зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа үед хаягаа өөрчилбөл буюу ТТТ Улс руу гэр бүлээрээ явах гэж байгааг шүүхэд мэдэгдэх үүргээ хариуцагч Х.М нь зөрчсөн тул ИХШХШТХ-ийн 100 дугаар зүйлийн 100.3- д зааснаар нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хүсэлтээр хэргийг хариуцагч нарын эзгүйд хавтаст хэрэгт авагдсан баримт нотолгоо үндэслэн хянан шийдвэрлэсэн болно.

Ш аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 638 дугаар шийдвэр гараад 5 сар өнгөрсний дараа хариуцагч Х.М нь ар гэрийн гачигдал (ээж нь 2017 оны 2 дугаар сарын 27-ны өдөр ТТТ-д нас барсан) гэх үндэслэлээр гаргасан давж заалдах гомдол болон давж заалдах гомдол гаргах хугацааг сэргээлгэхийг хүссэн хүсэлтийг хуулийн дагуу шүүгчийн захирамжаар шийдвэрлэсэн болно.

2.Хариуцагч Х.М-ийн хүсэлтүүдийг шийдвэрлэсэн тус шүүхийн 2017 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн 949 дугаартай "Давж заалдах журмаар гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзах тухай" шүүгчийн захирамждаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 164 дүгээр зүйлийн 164.3-г, мөн 2017 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 1031 дугаартай "Хүсэлтийг хангахаас татгалзах тухай" шүүгчийн захирамждаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.3-г тус тус удирдлага болгосон. Эдгээр удирдлага болгосон хуулийн зүйл заалтууд нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1-д заасан шүүхийн тогтоол шүүгчийн захирамж, шийтгэвэрт тухайн шатны шүүхэд гомдол гаргах хуулийн зүйл заалтууд ороогүй тул тухайн захирамждаа гомдол гаргах эрхгүй гэж дурдсан.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зүйл заалтыг удирдлага болгон захирамжуудаа гаргасан болно.

Иймд миний бие Монгол Улсын Үндсэн хууль болон Шүүгчийн Ёс зүйн дүрмийн холбогдох заалтуудыг зөрчөөгүй тул Шүүгчийн ёс зүйн хороон ы сахилгын

хэрэг үүсгэсэн 2017 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 108 дугаартай тогтоолыг хэрэгсэхгүй болгож өгнө үү.

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанаар хэлэлцээд ҮНДЭСЛЭХ нь:

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хороонд иргэн Х.М-ээс Ш аймаг дахь Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М нь Шүүхийн ёс зүйн дүрмийн холбогдох заалтуудыг зөрчсөн тухай гомдол гаргасан байна. Энэхүү гомдлын дагуу явуулсан шалгалтын дүнг хянаж Шүүхийн Ёс зүйн хорооны 2017.06.02-ны өдрийн 108-р тогтоолоор шүүгч Б.М-д сахилгын хэрэг үүсгэж шийдвэрлэсэн нь үндэслэлтэй болжээ.

Ш аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М Ш аймгийн П сумын ССС цэцэрлэгийн нэхэмжлэлтэй, хариуцагч Х.М , Б.Г (Х.М-ийн эхнэр), Б.Р нарт холбогдох "П сумын Хүүхдийн ССС цэцэрлэгийн эзэмшил бүхий газрыг чөлөөлүүлэх тухай" иргэний хэргийг 2016.09.12-ны өдөр хүлээн авчээ. Уг хэргийн хариуцагч Х.М 2016.10.21-ний өдөр ТТТ улсад явсан байна. Шүүх хуралдааныг 2016 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 14.00 цагт хийхээр товложээ Шүүгчийн туслах А.А 2016 оны 10 дугаар сарын 25-ны өдөр нэхэмжлэгч болон хариуцагч нарт энэ товыг мэдэгдэхээр утсаар залгасан боловч хариуцагч Х.М, Б.Г нарын утас "холбогдох боломжгүй байсан" тухай тэмдэглэл үйлджээ. П сумын ХХ багийн Засаг дарга Х.К, Х.М , Б.Г нарыг "ТТТ улсад айлчилж яваа болно" гэсэн тодорхойлолтыг 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдөр гаргасан байх бөгөөд дээрх шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсыг хүлээн авч баримт дээр гарын үсэг зуржээ. Иймээс шүүгч Б.М "ИХШХШТХ-ийн 100 дугаар зүйлийн 100.3-д зааснаар нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хүсэлтээр хэргийг хариуцагч нарын эзгүйд хавтаст хэрэгт авагдсан баримт нотолгоог үндэслэн хянан шийдвэрлэж, Ш аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016.11.02-ны өдрийн 638 дугаартай шийдвэр гаргажээ.

Шүүхийн бичиг хүргэгч Р.А 2016.11.16-ны өдөр Ш аймаг дахь сум дундын Иргэний хэрийн анхан шатны шүүхэд гаргаж өгсөн тайлбартаа "Миний бие тус шүүхийн 2016 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 638 дугаартай шийдвэрийг гардуулахаар П сумын ХХ дугаар багт байрлах хариуцагч Х.М, Б.Г нарын гэрт 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр очсон боловч хариуцагч Х.М, Б.Г нарын гэр түгжээтэй байсан. Иймд хариуцагч Х.М, Б.Г нар хаана байгаа тухай Х.М-ийн дүү болох Х.Ю-ээс асуухад тэрээр "Х.М, Б.Г нар ТТТ улсад явсан, ойрын хугацаанд ирэхгүй. Хавар ирэх байх. Миний бие шийдвэрийг авахгүй" гэсэн болно" гэж бичжээ.

Ш аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016.11.02-ны өдрийн 638 дугаартай шийдвэрийг П сумын ХХ багийн Засаг дарга Х.К-д 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр гардуулж гарын үсэг зуруулсан баримтыг Шүүгчийн туслах А.А үйлджээ. Х.М Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан гомдолдоо уг шийдвэрийг хүргэж ирсэн ажилтан "хүчээр гарын үсэг зуруулж гардуулж өгсөн байдаг" гэж бичсэн боловч энэ нь шалгалтын явцад цугларсан баримтаар нотлогдохгүй байна. Х.М 2017.03.24-ний өдөр ТТТ улсаас Монгол Улсад буцаж иржээ. Улмаар, 5-р багийн Засаг дарга Х.К уг шийдвэрийг Х.М-д 2017 оны 3 дугаар сарын 29-ний өдөр гардуулж өгч баримт үйлджээ.

Хариуцагч Х.М Ш аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016.11.02-ны өдрийн 638 дугаартай шийдвэрийг эс зөвшөөрч давж заалдах гомдлыг тус шүүхэд 2017.03.31-ний өдөр гаргасан байна. Шүүгч Б.М ИХШХШТХ-ийн 119 дүгээр зүйлийн 119.6-д зааснаар П сумын ХХ дугаар багийн Засаг дарга Х.К-д шийдвэрийг гардуулсан өдрөөр буюу 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрөөр давж заалдах гомдол гаргах хугацааг тооцож, хариуцагч Х.М

ИХШХШТХ-ийн 120 дугаар зүйлийн 120.2-т заасан давж заалдах гомдол гаргах хугацааг 2 сар 2 хоногоор хэтрүүлсэн гэсэн үндэслэлээр Х.М-ийн давж заалдах журмаар гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзах тухай 949 дугаартай шүүгчийн захирамжийг 2017.04.03-ны өдөр гаргаж, уг захирамжид гомдол гаргах эрхгүй болохыг дурдсан байна.

Хариуцагч Х.М Ш аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016.11.02-ны өдрийн 638 дугаартай шийдвэрт давж заалдах гомдол гаргах хугацааг сэргээлгэх тухай хүсэлтийг 2017.04.07-ны өдөр тус шүүхэд гаргажээ. Шүүгч Б.М “хариуцагч Х.М 2016.10.21-ний өдөр ТТТ улсад яваад, 2017.03.24-ний өдөр ТТТ улсаас ирсэн болох нь түүний Е1736581 дугаартай гадаад паспортын бичилтээр тогтоогдож” байгааг хүлээн зөвшөөрсөн боловч давж заалдах гомдол гаргах хугацааг сэргээлгэх тухай 2017.04 07-ны өдрийн хүсэлт хүлээн авахаас татгалзсан тухай 1031 дугаартай шүүгчийн захирамжийг 2017.04 10-ны өдөр гаргаж, уг захирамжид гомдол гаргах эрхгүй болохыг дурдсан байна.

Х.М 2016.10.21-ний өдрөөс 2017.03.24-ний өдөр хүртэл ТТТ улсад өөрийн ээж болох С.А-г асарсан, нас барсных нь дараа ажил явдалд оролцсон гэж үзэхээр байна. Х.М гомдолдоо дараахыг бичжээ: “Энэхүү хэргийг хянан шийдвэрлэх явцад буюу 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдөр би ТТТ улсад амьдардаг 83 настай төрсөн ээж С.А-ийн тархинд цус харваж биеийн байдал хүнд байгаа гэсэн яаралтай дуудлагыг хүлээн авч ажлын цаг тарсны дараа тэр шөнийнхөө үүрээр ТТТ улс руу яаралтай явсан билээ. Энэ тухайгаа шүүхэд албан ёсоор мэдэгдэх ямар ч боломжгүй байсан юм. Намайг ТТТ-д очиход ээж маань тархиндаа тал цус харвалт өгсөн, ярьж чадахгүй. тал бие нь мэдээгүй. хэвтэрт орсон байсан. Тиймээс би 2 сар гаруй ээжийгээ сахиж байгаад нас барсных нь дараа хөдөөлүүлчхээд Ш аймагт буцаж ирсэн билээ. Ийнхүү би гэртээ ирээд намайг ТТТ улсад байх үед шүүхээр хянан хэлэлцэж байсан дээр дурдсан хэргийг аймгийн Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх шийдвэрлэсэн, мөн шүүхийн шийдвэр нь ХХ дугаар багийн Засаг дарга Х.К-д байгааг олж мэдсэн болно.” Түүнчлэн, Х.М-ийн ээж С.А нь 2017.02.23-ны өдөр ТТТ улсын А хотын Е дүүргийн Х тосгонд нас барсан нь Нас барсны гэрчилгээ, түүний орчуулгаар нотлогдож байна. Мөн, Х.М “Ээжийгээ сахиж байсан үеийн зураг” гэсэн зургийг хавсралтаар ирүүлсэн байна. Үүнээс гадна, ХХ дугаар багийн Засаг дарга Х.К нь Х.М, Б.Г нар “ар гэрийн гачигдлаар ТТТ улсад явсан тул хэзээ ирэх нь тодорхойгүй” гэж Шүүхийн бичиг хүргэгч Р.А-д 2017.01 13-ны өдөр хэлж байсан тухайгаа 2017.03.30-ны өдөр гаргасан тодорхойлолтдоо бичжээ. Шүүгч Б.М, Х.М-ийн ээж С.А-г нас барсан тухай баримтыг хүлээн зөвшөөрсөн бөгөөд Х.М ТТТ улсад ээжийгээ асарч байсан, ажил явдалд нь оролцсон гэдгийг үгүйсгээгүй болно.

Шүүгч Б.М-ийн эсрэг гаргасан гомдлыг шийдвэрлэхийн тулд Шүүгчийн Ёс зүйн дүрэмд тусгасан хоёр янзын зарчмыг тайлбарлах шаардлагатай. Нэг талаас, 2014 оны Шүүгчийн Ёс зүйн дүрэм (цаашид “ШЁЗД” гэх)-ийн 1.4-р зүйлийн 1-д “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй” гэж заасан нь шүүгчийн хууль буруу хэрэглэсэн алдаанд хариуцлага хүлээлгэхгүй байх зарчмыг тунхагласан хэрэг. Энэ зарчим нь шүүгч аливаа хэрэг, маргааныг буруу шийдвэрлээд хариуцлага хүлээчих вий гэсэн айдасгүйгээр хууль зүйн хувьд хамгийн зөв гэсэн үндэслэлийнхээ дагуу хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх боломжийг шүүгчид олгодог учраас шүүгчийн хараат бус байдлын нэг баталгаа болдог билээ. Нөгөө талаас, хуульд захирагдах зарчмыг ягштал баримтлахыг шүүгчид үүрэг болгодог. Монгол Улсын Үндсэн хуулийн 1-р зүйлийн 2-т төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмын нэг бол хууль дээдлэх гэж заасан бөгөөд шүүн таслах ажиллагаа нь төрийн үйл ажиллагаанд багтдаг учраас энэ зарчмыг шүүгч

биелүүлэх үүрэгтэй. Тийм учраас, Үндсэн хуулийн 49-р зүйлийн 1-д “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана” гэж тодорхой заасан Мөн хууль дээдлэх зарчим нь процессын хуулиуд болон Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд ч тусгалаа олсон. Түүнчлэн, ШЕЗД-ийн 1.3-р зүйлийн 1-д зааснаар “хууль дээдлэх” зарчмыг хувийн зан чанар болгон төлөвшүүлэхийг шүүгчид үүрэг болгоод зогсохгүй энэ дүрмийн 3.3-р зүйлд “Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй” гэж тодорхой заасан. Өөрөөр хэлбэл, шүүгч аливаа хэрэг, маргааныг дур зоргоороо биш зөвхөн хуулийг хэрэглэж хууль зүйн үндэслэлээр хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэйг эдгээр эрх зүйн эх сурвалжид бичжээ.

Шүүгчийн хууль буруу хэрэглэсэн алдаанд хариуцлага хүлээлгэхгүй байх зарчим болон хуульд захирагдах зарчим хоёрын зохицлыг хангах нь амаргүй ажил. Эхний зарчмыг хэт баривал шүүгчийн хараат бус байдал нэрийн дор хуульд захирагдалгүй шийдвэр гаргадаг шүүгчийн хариуцлагагүй байдлыг дэвэргэнэ. Хоёр дахь зарчмыг хэтэрхий баривал шүүгчийн хараат бус байдалд халдах эрсдэлтэй. Тиймээс, Шүүхийн Ёс зүйн хорооноос шүүгчийн ёс зүйн онол, олон улсын сайн туршлагад байдаг утгаар энэ хоёр зарчмын уялдааг хангаж хэрэглэх жишиг тогтоож, хэрэгжүүлж ирсэн. Тодруулбал, зөвхөн дараах хоёр нөхцөл хангагдсанаас бусад тохиолдолд шүүгчийн хууль хэрэглэсэн алдаанд хариуцлага хүлээлгэхгүй (ШЕЗД-ийн 1.3 дахь хууль дээдлэх зарчим, 3.3-р зүйл дэх хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх үүргийг зөрчсөний төлөө шүүгчид сахилгын шийтгэл хүлээлгэхгүй): (1) Үндсэн хуулиар илэрхий хамгаалагдсан үндсэн эрх, эрх чөлөөг эдлүүлээгүй (2) хэн ч маргахгүй хуулийн тодорхой заалтыг зөрчсөн, ялангуяа удаа дараа зөрчсөн. Хууль зүйн туслалцаа авах эрхийг нь мэдсээр байж хангахгүй байх, давж заалдах гомдол гаргах эрхийг эдлүүлэхгүй байх нь эхний нөхцөлийн жишээ. Маргааны нэг талтай нөгөө талийг байлцуулахгүйгээр уулзахыг илэрхий хориглосон Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27.1.17-г зөрчиж маргааны нэг талтай ганцаарчлан уулзаж хэргийн талаар ярих нь хоёр дахь нөхцөлийн жишээ.

ИХШХШТХ-ийн 120.2-т “Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч анхан шатны шүүхийн шийдвэрийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор аймаг, нийслэлийн шүүхэд давж заалдах гомдол гаргаж болно,” 120.3-т “Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч энэ хуулийн 120.2-т заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн бол хугацаа сэргээлгэх хүсэлтийг анхан шатны шүүхэд гаргах ба хүсэлтийг хангах эсэхийг шүүгч захирамж гарган шийдвэрлэнэ” гэж тус тус заасан. Хүнд өвчтэй, өндөр настай ээжийгээ асарсан нас барсных нь дараа ажил явдлыг зохион байгуулалцах, оролцохыг хууль зүйн хувьд хүндэтгэн үзэх шалтгаанд тооцдог. Юуны өмнө, Иргэний хуулийн тайлбар бүтээлд Иргэний хуулийн 82 дугаар зүйлийн 82.4 дэх хэсгийг тайлбарлахдаа “Хөөн хэлэлцэх хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар нэхэмжлэгч өнгөрүүлсэн байвал шүүх, арбитр хугацааг сэргээж болдог. Хүндэтгэн үзэх шалтгааныг хуульд тодорхой зааж өгөөгүй хэдий ч үүнд онцгой нөхцөл шалтгаанууд орох нь ойлгомжтой юм. Тухайлбал: хүнд өвчин, бие хамгаалах чадваргүй байдал, урт хугацааны томилолт гэх мэт”² гэжээ. Мөн 2008 Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д хүндэтгэн үзэх шалтгаан гэдэгт “өвчтэй, өвчтөн асарсан...” зэргийг багтаан хуульчилсан байна.

2016.10.21-ний өдөр Х.М хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ТТТ улсад явах гэж байгаагаа шүүхэд мэдэгдээгүй, ТТТ улсад байхдаа энэ шалтгааны нөлөөгөөр холбоо бариагүй гэх үндэстэй боловч хожим уг хүндэтгэн үзэх шалтгаанаа нотолсон учраас уг хүндэтгэн үзэх шалтгаанаар давж заалдах гомдол гаргах

2 Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (УБ, 2010), 144 дэх тал

хугацааг сэргээх боломжтой, үндэслэлтэй байжээ. Өөрөөр хэлбэл, хүндэтгэн үзэх шалтгаан бий болсон үед түүнийг мэдэгдээгүй нь хожим уг шалтгаанаар хугацааг сэргээхэд саад болохгүй.

Шүүгч Б.М хүндэтгэн үзэх шалтгаан байсан нь нотлогдсоор байхад давж заалдах гомдол гаргах хугацааг сэргээх хуулийн тодорхой заалтууд (ИХШХШТХ-ийн 120.3)-ыг хэрэглэхээс татгалзсан захирамж гаргасан байна. Нэгэнт уг захирамжид давж заалдах гомдол гаргах эрхгүйг дурдсан учраас иргэн Х.М Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 14-т тодорхой заасан “шударга шүүхээр шүүлгэх эрх,” ялангуяа “шүүхийн шийдвэрийг давж заалдах.” эрхээ эдлэх боломжгүй болжээ.

Шүүгч Б.М ШЁЗД-ийн 1.3 дугаар зүйлд заасан “хүний эрхэм чанарыг хүндэтгэх” зарчмыг зөрчсөн байна. Хүний эрхэм чанар нь тухайн хүнд болон бусад аливаа хүнд адилхан байдаг. Хүний эрхэм чанарыг хүндэтгэнэ гэдэг бол хүн бүрийн амьдрал адилхан үнэ цэнтэй, чухал гэдгийг хүлээн зөвшөөрнө гэсэн үг. Хүний амьдралд тохиолдох чухал үйл явдлыг өөрийнхөө амьдралд тохиолдсон чухал үйл явдалтай адилаар ойлгож хүлээн авах нь хүний амьдралыг үнэхээр чухал хэмээн үзэж буйг илтгэдэг. Хүний эх эцэг хүндээр өвдөх, нас барах нь ямар ч хүнд тохиолдож болох үйл явдал бөгөөд хүн бүр үүнд өөр өөрийнхөөрөө хариу өгдөг. Олонх хүмүүс хүнд өвчтэй, өндөр настай эцэг эхийгээ асрах, нас барсных нь дараа ажил явдлыг зохион байгуулах, оролцохыг ёс суртахууны үүргээ гэж хүлээн авдаг бөгөөд ийм үүрэг хүний түүхэнд хамгийн эртнээс хүлээн зөвшөөрөгдөж ирсэн билээ. Гомдол гаргагч Х.М эцэг эхийнхээ өмнө хүлээдэг үр хүүхдийн энэ үүргийн талаар “Ер нь хүүхэд нь төрүүлсэн эцэг, эхээ асран халамжлах нь, хүндээр өвчилсөн үед асрах, нас барвал оршуулах нь зөвхөн хууль ёсны төдийгүй хүн ёсны журамт үүрэг гэдгийг хуульч шүүгч хүн мэдэхгүй байна гэвэл хэтэрхий гэнэн явдал болох биз ээ” гэж гомдолдоо бичжээ. Х.М энэхүү хүн ёсны буюу ёс суртахууны үүргээ биелүүлснийг ойлгож хүндэтгэн үзээгүйгээрээ шүүгч Б.М хүний эрхэм чанарыг хүндэтгээгүй байна

Шүүгч Б.М давж заалдах гомдол гаргах хугацааг сэргээлгэх тухай 2017.04.07-ны өдрийн хүсэлт хүлээн авахаас татгалзсан тухай 2017.04.10-ны өдрийн 1031 дугаартай шүүгчийн захирамжаа хоёр үндэслэлээр гаргасан гэснийг хүлээн зөвшөөрөх боломжгүй юм. Нэгд, шүүгч Б.М “тухайн үед буюу 2016 10.21-ний өдөр хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ТТТ улсад явах гэж байгаагаа шүүхэд мэдэгдээгүй.” Гэжээ. Х.М “Энэхүү хэргийг хянан шийдвэрлэх явцад буюу 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдөр би ТТТ улсад амьдардаг 83 настай төрсөн ээж С.А-гийн тархинд цус харваж, биеийн байдал хүнд байгаа гэсэн яаралтай дуудлагыг хүлээн авч ажлын цаг тарсны дараа тэр шөнийнхөө үүрээр ТТТ улс руу яаралтай явсан билээ. Энэ тухайгаа шүүхэд албан ёсоор мэдэгдэх ямар ч боломжгүй байсан” гэж тайлбарласан. Хүнд өвчтэй ээж рүүгээ яаравчлан явж буй ямар ч хүний хувьд энэ тухайгаа шүүхэд даруй мэдэгдэхгүй байх боломжтой учраас Х.М-ийн энэ тайлбарыг үнэн гэж хүлээн авахаас аргагүй.

Хоёрт, шүүгч Б.М “Х.М ТТТ улсад байх хугацаандаа шүүхэд утас, мэйл, факсаар холбогдох боломжтой байсан боловч ТТТ явсан болон хүндэтгэн үзэх шалтгаан гарсан тухайгаа мэдэгдээгүй” гэж бичсэн нь мөн үндэслэлгүй юм. Харин, Х.М “Намайг ТТТ-д очиход ээж маань тархиндаа тал цус харвалт өгсөн, ярьж чадахгүй, тал бие нь мэдээгүй, хэвтэрт орсон байсан Тиймээс би 2 сар гаруй ээжийгээ сахиж байгаад нас барсных нь дараа хөдөөлүүлчхээд Ш аймагт буцаж ирсэн” гэжээ. Хүндээр өвдсөн ээжийгээ асрах, нас барсных нь дараа хөдөөлүүлэх, ажил явдлыг нь зохион байгуулах, оролцох явцад жирийн хүн сэтгэл санааны хувьд хэцүүдэж гашуудсаны улмаас өөр бусад зүйлд анхаарахгүй байх боломжтой учраас Х.М-ийн энэхүү тайлбарыг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй.

Иймд, шүүгч Б.М нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4.1.5-д заасан “мэргэжлийн ёс зүйгээ ухамсарласан, ... хүний эрхийг дээдлэх чадвартай” байх шаардлага, Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3-д заасан "хүний эрх, эрх чөлөө. эрхэм чанарыг хүндэтгэх, хууль дээдлэх зарчим," 3.3 дугаар зүйл заасан "хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх" үүргийг тус тус зөрчсөн учир түүнд сануулах сахилгын шийтгэл ногдуулахаар шийдвэрлэв.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35, 36, 37 дугаар зүйл, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйл, Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.1, 5.13-т заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Ш аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М-д сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Энэ магадлалын хувийг шүүгч болон гомдол гаргагчид хүргүүлэхийг Шүүхийн Ёс зүйн хорооны Ажлын албанд даалгасугай.

3.Шүүгч, гомдол гаргагч нар магадлалыг гардан авснаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ

Н.ЭРДЭНЭЦОГТ

ГИШҮҮН

О.МӨНХСАЙХАН

UIN.MN
СУДАЛГААНЫ САН



ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ
МАГАДЛАЛ

2017 оны 11 сарын 02 өдөр

Дугаар 221 /ЕМ2017/0021

Улаанбаатар хот

Шүүгч Б.М-д сахилгын шийтгэл
ногдуулсан магадлалын тухай

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааныг шүүгч Э.Халиунбаяр даргалж, шүүгч Н.Хонинхүү, шүүгч Б.Тунгалагсайхан нарын бүрэлдэхүүнтэй хийж, Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 52 дугаар магадлалыг эс зөвшөөрч шүүгч Б.М-ийн гаргасан гомдлоор, Х.М-ийн гомдолтой, Ш аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М-д холбогдох сахилгын хэргийг шүүгч Б.Тунгалагсайханы илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 52 дугаар магадлалаар: Ш аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М-д сануулах сахилгын шийтгэл ногдуулж шийдвэрлэжээ.

Шүүгч Б.М гомдолдоо: "... Миний бие хууль болон Шүүгчийн Ёс зүйн дүрмийг чандлан сахиж ажилладаг бөгөөд хэн нэгний нөлөөнд автан, бусдын хууль ёсны эрхээ хамгаалуулахаар шүүхэд хандах эрхийг нь хязгаарласан тохиолдол байхгүй, хууль заасан шаардлагын хүрээнд хэрэг, хүсэлтүүдийг хянан шийдвэрлэсэн тул Ёс зүйн хорооны магадлалыг дараах үндэслэлүүдээр эс зөвшөөрч байна. Үүнд:

Ш аймгийн П сумын ССС цэцэрлэгийн нэхэмжлэлтэй, хариуцагч Х.М, Б.Г , Б.Р нарт холбогдох иргэний хэргийг Ш аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн 212/МА2016/00039 дугаар магадлалаар хэргийг дахин шийдвэрлүүлэхээр анхан шатны шүүхэд буцааснаар тойргийн журмаар шүүгч надад хуваарилагдаж, миний бие 2016 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр хүлээн авч, Ш аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 638 дугаартай шийдвэр гаргасан.

Тухайн хэргийн хувьд хүлээн авсны дараа магадлалд заасан болон бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаануудыг хийж дуусгаад шүүх хуралдааны товыг мэдэгдэх гэсэн боловч 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс хойш хариуцагч Х.М, Б.Г нарын утас холбогдох боломжгүй, гэр нь цоожтой хүнгүй байсан.

Иймээс хариуцагч Б.Г, Х.М нар нь оршин суугаа хаягтаа байгаагүй тул Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.6-д зааснаар П сумын ХХ дугаар багийн Засаг даргад шүүх хуралдааны товыг мэдэгдсэн "Шүүхийн мэдэгдэх хуудас"-ыг хүргүүлсэн ба тус багийн

Засаг дарга Х.К нь хариуцагч нар ТТТ Улс руу явсан тухай тодорхойлолт гаргаж өгсөн.

Хариуцагч Х.М нь тухайн үед ТТТ Улс руу явах гэж байгаагаа шүүхэд мэдэгдээгүй, өндөр настай ээж нь өвдсөн гэх талаар ямар нэгэн хүсэлт шүүхэд гаргаагүй ба Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.2-т заасан "шүүх хуралдааны товыг шүүхээс асуух", 77 дугаар зүйлийн 77.8-д заасан "хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа үед хаягаа өөрчилбөл энэ тухай шүүхэд мэдэгдэх" үүргээ зөрчсөн болно. Өөрөөр хэлбэл "хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа үед хаягаа өөрчилбөл" буюу ТТТ Улс руу гэр бүлээрээ явах гэж байгааг шүүхэд мэдэгдэх, шүүх хуралдааны товыг шүүхээс лавлах үүргээ биелүүлээгүй.

Мөн ТТТ Улсад явах гэж байгаагаа хуульд заасан арга хэлбэрээр мэдэгдэх боломжтой байсан боловч мэдэгдээгүй. мэдэгдэх боломжгүй байсан тухай ямар нэгэн нотлох баримт гаргаж өгөөгүй, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.8-д зааснаар оршин суугаа хаягтаа байгаагүй тул мөн хуулийн 77 дугаар зүйлийн 77.6-д зааснаар П сумын ХХ дугаар багийн Засаг даргад шүүх хуралдааны товыг мэдэгдсэн "Шүүхийн мэдэгдэх хуудас"-ыг хүргүүлсэн. Хэргийн оролцогч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тодорхой эрх, үүрэгтэй оролцдог ба уг эрх, үүргийн талаар хариуцагчид урьд нь танилцуулж, гарын үсэг зуруулсан.

Иймээс шүүх хуралдаанд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 100 дугаар зүйлийн 100.3-т зааснаар "хэргийг хариуцагчийн эзгүйд хавтаст хэрэгт авагдсан баримт нотолгоог үндэслэн хэргийг хянан шийдвэрлэж өгөхийг хүссэн" нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гаргасан хүсэлтийг хүлээн авч хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэн Ш аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 638 дугаар шийдвэрийг гаргасан.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.6, 77 дугаар зүйлийн 77.6-д заасан холбогдох заалтын дагуу тус шүүхийн 2016 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 638 дугаартай шийдвэрийг П сумын ХХ дугаар багийн Засаг дарга Х.К-Д 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр гардуулсан.

Хариуцагч Х.М Ш аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 638 дугаар шийдвэрийг эс зөвшөөрч давж заалдах гомдлыг тус шүүхэд 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдөр гаргасан. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.6-д зааснаар П сумын ХХ дугаар багийн Засаг дарга Х.К-д шийдвэрийг гардуулсан өдрөөр давж заалдах гомдол гаргах хугацааг тооцох бөгөөд хариуцагч Х.М нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.2-т заасан давж заалдах гомдол гаргах хугацааг 2 сар 2 хоногоор хэтрүүлсэн тул Х.М-ийн давж заалдах журмаар гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзах тухай тус шүүхийн 2017 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 949 дугаартай шүүгчийн захирамж гаргасан.

Хариуцагч Х.М 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдөр ТТТ Улсад яваад, 2017 оны 3 дугаар сарын 24-ний өдөр ТТТ Улсаас ирсэн болох нь түүний Е1736581 дугаартай гадаад паспортын бичилтээр тогтоогдож байгаа боловч тухайн үед буюу 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдөр ТТТ Улсад явах гэж байгаагаа шүүхэд мэдэгдээгүй, мөн Х.М ТТТ Улсад байх хугацаандаа шүүхэд утас, мэйл, факсаар холбогдох боломжтой байсан боловч ТТТ явсан болон хүндэтгэн үзэх шалтгаан гарсан тухай мэдэгдээгүй тул түүний 2017 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр давж заалдах гомдол гаргах хугацааг сэргээлгэх

тухай хүсэлт гаргасныг хүлээн авахаас татгалзсан тухай тус шүүхийн 2017 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 1031 дугаартай шүүгчийн захирамж гаргасан.

Уг давж заалдах гомдол гаргах хугацааг сэргээлгэх тухай хүсэлтэд дурдсан үндэслэлүүд нь хүндэтгэн үзэх шалтгаан биш гэж үзээд гомдлыг хүлээн авахаас татгалзах үндэслэлүүдээ захирамждаа тодорхой зааж дурдсан. "Хүндэтгэн үзэх шалтгаан" гэдэгт тухайн хэргийн оролцогчийн өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар өөрөөр хэлбэл, хүндээр өвчилсөн, хорио цээрийн дэглэм тогтоогдсон, байгалийн болон нийтийг хамарсан гамшиг тохиолдсон зэргийг ойлгох ба гомдол гаргах боломжгүй байсныг хариуцагч Х.М тухайн үед буюу 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдөр хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ТТТ Улсад явах гэж байгаага мэдэгдэх боломжтой байсан боловч шүүхэд мэдэгдээгүй, хүндэтгэн үзэх шалтгаан гарсан гэдгийг нотлох баримтаа шүүхэд гаргаагүй тул дээрх байдлаар шийдвэрлэсэн болно.

Хариуцагч Х.М-ийн хүсэлтүүдийг шийдвэрлэсэн тус шүүхийн 2017 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 949 дугаартай "Давж заалдах журмаар гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзах тухай" шүүгчийн захирамждаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 164 дүгээр зүйлийн 164.3-ыг, мөн 2017 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 1031 дугаартай "Хүсэлтийг хангахаас татгалзах тухай" шүүгчийн захирамждаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.3-ыг тус тус удирдлага болгосон. Эдгээр хуулийн зүйл, заалтууд нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт тухайн шатны шүүхэд гомдол гаргах асуудлыг зохицуулсан 170 дугаар зүйлийн 170.1-д байхгүй тул тухайн захирамждаа гомдол гаргах эрхгүй гэж дурдсан.

Иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу явагдах ба миний бие уг хуульд заасан журмын дагуу тухайн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж, хуулийн дагуу шийдвэр, захирамжийг гаргасан.

Шүүгч би Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.3-д заасан "хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, хууль дээдлэх" зарчим, 3.3-д заасан "хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх" үүргийг зөрчөөгүй бөгөөд хавтаст хэрэгт авагдсан баримтуудыг дотоод итгэлээр үнэлэн дүгнэж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж, дээрх шийдвэр, захирамжуудаа гаргасныг ёс зүйн зөрчил гэж үзэж байгааг хүлээн зөвшөөрөхгүй.

Иймд Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 52 дугаар магадлалыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү" гэжээ.

ХЯНАВАЛ:

Шүүхийн Ёс зүйн хороо шүүгч Б.М-г Шүүгчийн Ёс зүйн дүрэмд заасан шүүгчийн хувийн зан чанар болгож төлөвшүүлэх хүний эрхэм чанарыг хүндэтгэх зарчмыг зөрчсөн, хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх үүргээ биелүүлээгүй гэж буруутган, сануулах сахилгын шийтгэл ногдуулахаар шийдвэрлэсэн нь үндэслэл бүхий байх тул магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэлээ.

Иргэн Х.М-ээс Ш аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М-д холбогдуулан "шүүгч Б.М нь 2017 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 1031 дүгээр шүүгчийн захирамжийг гаргахдаа ёс зүйн зөрчил гаргасан, тодруулбал, миний бие Ш аймгийн П сумын хүүхдийн ССС

цэцэрлэгийн нэхэмжлэлтэй иргэний хэрэгт хариуцагчаар оролцож байхдаа буюу 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдөр ТТТ Улсад амьдардаг 83 настай төрсөн ээж С.А-гийн тархинд цус харваж, биеийн байдал хүнд байгаа гэсэн яаралтай дуудлагыг хүлээн авч ТТТ Улс руу яаралтай явсан, энэ тухайгаа шүүхэд мэдэгдэх ямар ч боломжгүй байсан, ...би 2 сар гаруй ээжийгээ сахиж байгаад нас барсных нь дараа хөдөөлүүлчхээд Ш аймагт буцаж ирсэн даруйдаа уг хэргийн шийдвэрийг хүлээн авч, танилцаад давж заалдах гомдол гаргах хугацаа сэргээлгэх хүсэлт гаргасан боловч шүүгч Б.М нь 1031 дүгээр захирамжаар хүсэлтийг хангахаас татгалзсан нь Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг зөрчсөн" гэж гомдол гаргажээ.

Шүүгч Б.М нь 2017 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 1031 дүгээр захирамжаар Ш аймгийн П сумын хүүхдийн ССС цэцэрлэгийн нэхэмжлэлтэй иргэний хэрэгт хариуцагчаар оролцож байсан Х.М-ийн гаргасан сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 638 дугаар шийдвэрт давж заалдах гомдол гаргах хугацаа сэргээлгэх хүсэлтийг "хариуцагч Х.М нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ТТТ Улс явах гэж байгаагаа шүүхэд мэдэгдээгүй, хүндэтгэн үзэх шалтгаан гарсан гэдгийг нотлох баримтаа шүүхэд ирүүлээгүй" гэсэн үндэслэлээр хангахаас татгалзаж шийдвэрлэсэн байна.

Х.М-ийн давж заалдах гомдол гаргах хугацаа сэргээлгэх хүсэлт, түүнд хавсаргасан баримтуудаас үзэхэд тэрээр 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдөр ТТТ Улс руу явж, 2017 оны 03 дугаар сарын 24-ний өдөр ирсэн, түүний төрсөн ээж С.А нь 2017 оны 02 дугаар сарын 23-ны өдөр нас барсан болох нь тогтоогдсон байна.

Гэтэл шүүгч Б.М нь захирамждаа Х.М-ийн хүсэлтэд дурдсан нөхцөл байдал нотлох баримтаар тогтоогдож байгаа талаар дүгнэж үгүйсгээгүй атлаа түүний эцэг, эхийнхээ өмнө хүлээх хүн ёсны бөгөөд ёс суртахууны үүргээ биелүүлснийг хүндэтгэн үзэлгүй, давж заалдах гомдол гаргах эрхийг хязгаарлаж Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1-д заасан шүүгчийн хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх зарчмыг зөрчин, мөн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 1-д заасан хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх үүргээ биелүүлээгүй, энэ талаар Шүүхийн Ёс зүйн хороо үндэслэлтэй дүгнэлт хийжээ.

Шүүгч Б.М гомдолдоо "Х.М нь тухайн үед ТТТ Улс руу явах болсноо шүүхэд мэдэгдээгүй, ТТТ Улсад байх хугацаандаа хүндэтгэн үзэх шалтгаан гарсан тухайгаа утас, мэйл, факсаар мэдэгдээгүй, энэ талаар ямар нэгэн хүсэлт, нотлох баримт ирүүлээгүй, шүүх хуралдааны товыг шүүхээс лавлах үүргээ биелүүлээгүй" гэх боловч Х.М нь хүндээр өвчилсөн ээжийгээ асарч, нас барсны дараа ажил явдлыг нь зохион байгуулалцаж оролцсоны улмаас энэ талаар шүүхэд мэдэгдэх боломжгүй байсан, энэхүү нөхцөл байдлыг шүүгчээс хүндэтгэж үзээгүй байна.

Иймд шүүгч Б.М-д сануулах сахилгын шийтгэл ногдуулж шийдвэрлэсэн Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1-д заасантай нийцэж байх тул магадлалыг хэвээр үлдээж, шүүгчийн гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэв. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.2, 120 дугаар зүйлийн 120.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 52 дугаар магадлалыг хэвээр үлдээж, шүүгч Б.М-ийн гомдлыг хангахгүй орхисугай.

2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.5-д зааснаар шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийг буруу хэрэглэсэн, хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн нь шүүхийн шийдвэр гарахад нөлөөлсөн гэж үзвэл магадлалыг гардан авсан, эсхүл хүргүүлснээс хойш 14 хоногийн дотор Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд гомдол гаргах эрхтэй.

ШҮҮГЧ

Э.ХАЛИУНБАЯР

ШҮҮГЧ

Н.ХОНИНХҮҮ

ШҮҮГЧ

Б.ТУНГАЛАГСАЙХАН



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ХЯНАЛТЫН ШАТНЫ ЗАХИРГААНЫ
ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2018 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Ш аймаг дахь сум дундын Иргэний хэргийн
анхан шатны шүүхийн шүүгч Б.М-д
холбогдох сахилгын хэргийн тухай

Монгол Улсын Дээд шүүхийн шүүгч Л.Атарцэцэг даргалж, шүүгч Г.Банзрагч, Х.Батсүрэн, Д.Мөнхтуяа, П.Соёл-Эрдэнэ нарын бүрэлдэхүүнтэй, тус шүүхийн танхимд хийсэн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанд,

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 52 дугаар магадлал,

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 221/ЁМ2017/0021 дүгээр магадлалтай,

Гомдол гаргагч Х.М-ийн гомдолтой,

Ш аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М-д холбогдох сахилгын хэргийг

Шүүгч Б.М-ийн гаргасан гомдлыг үндэслэн

Шүүгч Х.Батсүрэнгийн илтгэснээр хянан хэлэлцэв.

ТОДОРХОЙЛОХ нь:

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 52 дугаар магадлалаар Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35, 36, 37 дугаар зүйл, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйл, Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.1, 5.13-т заасныг удирдлага болгон Ш аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М-д сануулах сахилгын шийтгэл ногдуулжээ.

Шүүгч Б.М-ийн гомдлоор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хэргийг хянан хэлэлцээд 2017 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 221/ЁМ2017/0021 дүгээр магадлалаар Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 52 дугаар магадлалыг хэвээр үлдээсэн байна.

Шүүгч Б.М хяналтын журмаар гаргасан гомдолдоо: "Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 52 дугаар магадлал, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн дугаар 221/ЁМ2017/0021 дүгээр магадлалыг тус тус хүчингүй болгох тухай гомдлыг гаргаж байна.

Үйл баримтын талаар П сумын ССС цэцэрлэгийн нэхэмжлэлтэй, хариуцагч Х.М-д холбогдох иргэний хэргийг хянан шийдвэрлэх явцад хариуцагч Х.М нь 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдөр ТТТ улс руу зорчин явсан бөгөөд 2017 оны 3 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улсад ирсэн байна

Х.М-д холбогдох иргэний хэргийг шүүх 2016 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр хянан шийдвэрлэж шийдвэр гаргасан ба Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу шүүхийн шийдвэрийг түүний оршин суух багийн Засаг даргад 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр гардуулсан байна.

Хариуцагч уг шийдвэрийг 2017 оны 3 дугаар сарын 29-ний өдөр багийн Засаг даргаас гардан авсан байна.

Х.М-ийн ээж нь 2017 оны 02 дугаар сарын 23-ны өдөр нас барсныг шүүгч 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хариуцагч давж заалдах гомдол гаргахдаа мэдсэн байна.

Шүүгчийн 2017 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн захирамжаар хариуцагч Х.М-ийн давж заалдах гомдлыг хуульд заасан хугацааг хэтрүүлсэн үндэслэлээр хүлээн авахаас татгалзсан байна.

Хариуцагч 2017 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр давж заалдах гомдол гаргах хугацааг сэргээх тухай хүсэлт гаргасныг Шүүгчийн 2017 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 1031 дүгээр захирамжаар хүлээн авахаас татгалзсан байна

Шүүгч хариуцагчийн давж заалдах гомдол гаргах хугацааг сэргээлгэх тухай хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэхдээ:

Хариуцагч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад оршин суух хаягаа өөрчилбөл энэ талаар шүүхэд мэдэгдэх үүргээ биелүүлээгүй,

Хариуцагч Х.М нь өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар, тухайлбал хүндээр өвчилсөн, хорио цээрийн дэглэм тогтоогдсон, байгалийн болон нийтийг хамарсан гамшиг тохиолдсон зэрэг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас гомдол гаргах боломжгүй байсан зэргийг шүүхэд нотлох баримтаар нотлоогүй зэрэг 2 үндэслэлээр хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Гомдлын үндэслэл: Хариуцагч Х.М нь 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдрөөс 2017 оны 3 дугаар сарын 24-ний өдрийг хүртэл ТТТ улсад зорчин явсан бөгөөд түүний ээж нь 2017 оны 02 дугаар сарын 23-ны өдөр нас барж харамсалтай үйл явдал тохиожээ. Х.М нь 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдөр ТТТ улс руу явах болсон шалтгаанаа түүний ээж нь хүнд өвчтэй байсан гэж Шүүхийн Ёс зүйн хороонд тайлбарладаг боловч харин шүүхэд, түүнтэй холбоотой хэргийг хянан шийдвэрлэх явцад энэ талаар мэдэгдээгүй байна.

Шүүгч хариуцагчийн ээж нас барсныг 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хариуцагч давж заалдах гомдол гаргахад мэдсэн бөгөөд түүний хугацаа хэтрүүлж мөн өдөр гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзсан нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хууль ёсны байх зарчимд нийцэх юм.

Х.М д холбогдох анхан шатны шүүхийн 2016 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн шийдвэрийг шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.3, 119.4-т заасан хугацаа өнгөрсний дараа мөн зүйлийн 119.5-д зааснаар 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр хариуцагчийн оршин суух газрын буюу ХХ дугаар багийн Засаг даргад гардуулсан бөгөөд мөн өдрөөс эхлэн хариуцагч Х.М-ийн уг шийдвэрт давж заалдах гомдол гаргах 14 хоногийн хугацаа тоологдохоор Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119.7, 120 дугаар зүйлийн 120.2-т заасан байна

Хариуцагч оршин суугаа хаягтаа байгаагүй, түүнчлэн тэрээр шүүх хуралдаанд биечлэн оролцоогүй тул түүнд гардуулах ёстой шийдвэрийг түүний оршин суугаа газрын багийн Засаг даргад гардуулсан шүүхийн үйл ажиллагаа нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119.5-д заасан зохицуулалтад нийцсэн, хууль ёсны үйл ажиллагаа юм.

Үүнээс дүгнэвэл, хариуцагч Х.М нь шүүхийн шийдвэрийг гардан авсанд тооцох буюу шийдвэрийг багийн Засаг даргад гардуулсан 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэх давж заалдах гомдол гаргах 14 хоногийн хугацаанд, тодруулбал 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрөөс 2017 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийг хүртэл хугацаанд тэрээр давж заалдах гомдол гаргах эрхээ хэрэгжүүлж чадаагүй хүндэтгэн үзэх шалтгаан байгаа эсэхийг л шүүгч “гагцхүү хуульд захирагдах” үүргийнхээ хүрээнд хянан үзэж, түүний хугацаа сэргээлгэх тухай хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн юм. Энэ талаар буюу иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог зохицуулалтын талаар Шүүхийн Ёс зүйн хороо болон Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх анхаарсангүй, дүгнэлт хийсэнгүй.

1.Хариуцагч давж заалдах гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэх боломжтой хугацаанд буюу 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрөөс 2017 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийг хүртэл хугацаанд ТТТ улсад байсан бөгөөд “энэ хугацаанд хариуцагчийн ээж нь хүндээр өвчилж байсан хүндэтгэн үзэх шалтгаантай” гэж тайлбарлах боловч энэ талаар шүүхэд мэдэгдээгүй, бас нотлоогүй тул шүүх үндэслэлгүйгээр түүний энэ байдлыг хүндэтгэн үзэх шалтгаанд тооцох боломжгүй юм Харин хариуцагч ТТТ улсад байх хугацаандаа, дээр дурдсан хугацаанд өмгөөлөгч болон бусад этгээдээр төлөөлүүлэн, эсхүл факс болон шүүхийн цахим шуудангаар дамжуулаад давж заалдах гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэх боломжтой байсан. Тиймээс шүүх дээрх хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаантай байсан талаар шүүхэд нотлох үүргээ хариуцагч биелүүлээгүй гэж түүний гомдол гаргах хугацааг сэргээлгэх тухай хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

2.Х.М-ийн ээж нь 2017 оны 02 дугаар сарын 23-ны өдөр нас барсан нь харамсалтай, тодорхой эрх, үүргийг хэрэгжүүлэхэд саад болсон хүндэтгэн үзэх шалтгаанд хамаарах үйл явдал мөн боловч энэ нь хариуцагчийн давж заалдах гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэх 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрөөс 2017 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийг хүртэл хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаанд тооцогдох эсэхийг шүүхээс дүгнэх шаардлагатай юм. Хариуцагч Х.М нь шийдвэрийг гардаж авснаас хойш буюу түүнд шийдвэрийг гардуулсанд тооцох багийн Засаг даргад шийдвэрийг гардуулсан 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэх 14 хоногийн хугацаанд хариуцагч хуульд заасан давж заалдах гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэхэд саад болсон, хэрэгжүүлэх боломжийг нь хязгаарласан хүндэтгэн үзэх шалтгааныг шүүхэд нотлоогүй учраас түүний уг 14 хоногийн хугацааг сэргээлгэх тухай хүсэлтийг шүүгч хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн юм. Харин хариуцагчийн ээж 2017 оны 02 дугаар сарын 23-ны өдөр нас барсан нь цаг хугацааны хувьд 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрөөс 2017 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийг хүртэл хугацаанд хамаарахгүй байх тул Х.М-ийн давж заалдах гомдол гаргах хугацааг сэргээх үйл баримт бүхий үндэслэл болохгүй юм.

3.Шүүгч надад Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.3-т заасан “хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, хууль дээдлэх зарчим, ... зэргийг хувийн зан чанар болгож төлөвшүүлнэ.”, 3.3.1-д “Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй.” гэж заасныг зөрчсөн гэж сануулах сахилгын шийтгэл ногдууллаа. Миний бие Шүүгчийн ёс зүйн дүрмийн дээрх заалтуудыг зөрчөөгүй, харин ч хэрэгжүүлж ажилласан бөгөөд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу, хуулийг чанд сахиж явуулсныхаа төлөө уг сахилгын шийтгэлийг хүлээж байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа нь талуудын позитив болон диспозитив эрхээ хэрэгжүүлсний үндсэн дээр мэтгэлцэх зарчмын дагуу явагддаг онцлогтой бөгөөд хариуцагчийн хуульд зааснаар шийдвэрийг гардаж авсан, эсхүл гардаж авсанд тооцсон өдрөөс хойш 14 хоногийн дотор давж заалдах гомдол гаргах эрх нь хуульд тодорхойлсон позитив эрхүүдийн нэг юм.

4.Түүнчлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан /хариуцагчаас гаргасан хүсэлтийг шийдвэрлэх/ шүүгчийн хууль хэрэглэж гаргасан шийдвэрийг иш үндэс болгож түүнд ёс зүйн, сахилгын шийтгэл ногдуулсан нь Үндсэн хуулиар тодорхойлсон шүүгчийн хараат бус байдлыг зөрчсөн зөрчил бөгөөд шүүгчид хууль буруу хэрэглэсэн гэсэн үндэслэлээр сахилгын шийтгэл ногдуулж болохгүй. Миний бие гагцхүү хуульд захирагдаж, Үндсэн хуулиар хамгаалагдсан хараат бус байдлаа хамгаалан сахиж, хуулийн дагуу шийдвэр гаргасан ба иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтыг иш үндэс болгохгүйгээр, хариуцагч Х.М-ийн гомдолд өнгөцхөн дүгнэлт хийж, шүүгчид сахилгын шийтгэл ногдуулсанд, түүний уг шийдвэрийг бүхэлд нь агуулгаар нь хянаж үзээгүй Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалд дээрх үндэслэлээр хяналтын журмаар гомдол гаргалаа гэжээ.

ХЯНАВАЛ

Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал болон Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал хууль зүйн үндэслэлтэй байна.

Ш аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М нь 2017 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 1031 дүгээр захирамжаар иргэн Х.М-ны давж заалдах гомдол гаргах хугацааг сэргээлгэх тухай хүсэлтийг хангахаас татгалзаж шийдвэрлэжээ. Иргэн Х.М нь Ш аймгийн П сумын Хүүхдийн ССС цэцэрлэгийн нэхэмжлэлтэй иргэний хэрэгт хариуцагчаар татагдсан бөгөөд хэргийг хянан шийдвэрлэх явцад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдрөөс 2017 оны 3 дугаар сарын 24-ний өдрийг хүртэл гадаадад байсан нь хэрэгт авагдсан баримтуудаар тогтоогджээ.

Хүнд өвчтэй, өндөр настай ээжийгээ асрах, нас барсных нь дараа ажил явдлыг зохион байгуулах, оролцох нь хүндэтгэн үзэх шалтгаанд тооцогдох бөгөөд шүүгч Б.М-д Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д заасан “мэргэжлийн ёс зүйгээ ухамсарласан, ... хүний эрхийг дээдлэх” шаардлага, Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.3-д заасан “хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, хууль дээдлэх зарчим”, 3.3-д заасан “хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх” үүргийг тус тус зөрчсөн гэж үзэн сануулах сахилгын шийтгэл ногдуулахаар шийдвэрлэсэн Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал, захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал үндэслэлтэй байна.

Иймээс шүүгч Б.М-ийн “Миний бие гагцхүү хуульд захирагдаж, Үндсэн хуулиар хамгаалагдсан хараат бус байдлаа хамгаалан сахиж, хуулийн дагуу шийдвэр гаргасан ба иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтыг иш үндэс болгохгүйгээр, хариуцагч Х.М-ийн гомдолд өнгөцхөн дүгнэлт хийж, шүүгчид сахилгын шийтгэл ногдуулсанд, түүний уг шийдвэрийг бүхэлд нь агуулгаар нь хянаж үзээгүй гэсэн гомдлыг хангах үндэслэлгүй.

Дээрх үндэслэлээр шүүх бүрэлдэхүүн Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал болон давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээх нь зүйтэй гэж үзлээ.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.1, 127.2 1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 52 дугаар магадлал, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 221/ЁМ2017/0021 дүгээр магадлалыг тус тус хэвээр үлдээж, шүүгч Б.М-ийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангахгүй орхисугай.

ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ

Л.АТАРЦЭЦЭГ

ШҮҮГЧ

Х.БАТСҮРЭН



МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЁС ЗҮЙН ХОРООНЫ МАГАДЛАЛ

2017 оны 10 сарын 27 өдөр

Дугаар 61

Улаанбаатар хот

ФХС аймгийн Иргэний хэргийн
давж заалдах шатны шүүх (хуучин нэрээр)-ийн
шүүгч П.Д-д сахилгын шийтгэл ногдуулах тухай

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааныг тус хорооны дарга Н.Эрдэнэцогт даргалж, гишүүн В.Жавхлан, А.Доржготов, Ч.Оюунцэцэг, О.Мөнхсайхан нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны тэмдэглэл хөтлөгчөөр шинжээч А.Энхбаатар, референт Ж.Халиун, гомдол гаргагч П.О, шүүгч П.Д (өөрийн хүсэлтийн дагуу онлайнаар), түүний өмгөөлөгч Х.Ц нарыг оролцуулан Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдааны танхимд хийв. Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 108 дугаар тогтоолоор үүсгэсэн сахилгын хэргийг Шүүхийн Ёс зүйн хорооны гишүүн О.Мөнхсайханы илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ НЬ:

Иргэн П.О 2016 оны 5 сарын 17-ны өдөр Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан гомдолдоо: "... Миний бие иргэн Б.Б-ээс зээлийн гэрээний үүргийг гүйцэтгүүлэх нэхэмжлэл гаргаж, Сум дундын ХХ дугаар шүүх 2015 оны 3 дугаар сарын 13-ны өдөр нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн. Улмаар энэ шийдвэр 3 шатны шүүхээр хянагдаж хүчин төгөлдөр болсон.

Энэ нэхэмжлэлийг гаргасан үеэс эхлэн хариуцагч Б.Б сөрөг нэхэмжлэл гаргасан бөгөөд энэ нь тусдаа иргэний маргаан болон үргэлжилсээр өнөөдрийг хүрч байна. Энэ хэргийн анхны шүүхийн шийдвэр 2015.11.13-ны өдөр гарч нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон. Гэтэл уг шийдвэрийг давж заалдах шатны шүүх 2016.01.06-ны өдөр хүчингүй болгож хэргийг дахин шийдвэрлүүлэхээр буцаасан. Уг хуралдааныг шүүгч П.Д даргалсан.

Энэхүү давж заалдах шатны шүүх хуралдаан болсны дараа буюу 2016.02.24-ний өдөр "ННН" дэлгүүрт шүүгч П.Д надтай таарч "хэрэг чинь юу болж байна, чамтай холбогдъё." гээд миний утасны дугаарыг авсан. Би П.Д шүүгчийг урд нь огт таньдаггүй байсан бөгөөд шүүх хуралдаан дээр анх харсан.

Ингээд 2016.02.26-ны өдөр4655 гэдэг дугаараас П.Д шүүгч над руу залгаж "орой уулзъя" гэсэн. Тэр орой эмнэлгийг урд талын хашаанд намайг хүлээгээд зогсож байсан бөгөөд тэндээс П.Д шүүгчийн машинд суун, аймгийн зүүн захад ГГГ дугаар цэргийн ангийн хажууд очин 2 цаг гаруй ярилцаж танилцсан юм. Энэ хугацаанд бид хувийн амьдралаа ярилцсан бөгөөд П.Д шүүгч "яг одоо надад 1 сая төгрөг хэрэгтэй байна, би чамд энэ хэрэг дээр тусалъя, чи надад тусал, ойрын үед чи надад 20 сая төгрөг олж өг, Эрдэнэтээс миний бичсэн номын мөнгө орж ирнэ, тэр үед эргэж зохицуулъя, н.Э шүүгчид хэрэг чинь хянагдаж байгаа юм байна, н.Э шүүгч өглөө болгон миний өрөөнд орж ирж хэргээ асуудаг, би хэлье" гэдэг санал тавьсан.

Миний хувьд надаас мөнгө нэхэмжилж буй Б.Б-ээс ямар ч мөнгө авсан асуудал байдаггүй тул шүүх үнэнийг тогтооно гэж бодож байсан тул хэн нэгнээр энэ хэргийг аргалуулах санаа байгаагүй учраас "надад 20 сая төгрөг байхгүй ээ, харин одоо хэрэгтэй байгаа 1 сая төгрөгийг чинь хүүхдийн сургалтын төлбөрөөсөө өгч тусалъя" гээд маргааш нь буюу 2016.02.27-ны өдөр ККК АТМ-ээс 1 сая төгрөг бэлнээр авч өгсөн. Энэ өдөр мөн л П.Д шүүгч өглөөнөөс эхлээд над руу хэд хэдэн удаа залгаж энэ мөнгийг авсан.

Үүнээс хойш П.Д шүүгч надтай холбогдон үл хөдлөх хөрөнгөө банкны барьцаанд тавиад өг гэж мөн миний ажиллуулдаг тусалъя ширээ сандал, тоног төхөөрөмж зэргийг хэрэглэх зэргээр надтай холбогдож байсан.

П.Д шүүгч надаас авсан 1 сая төгрөгөө хугацаандаа өгөөгүй учраас 2 хоног утасдаж, нэхэж авсан.

Дээрх хэргийг анхан шатны шүүх 2016.03.10-ны өдөр өмнөхийн адил нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Нэхэмжлэгчийн гомдлын дагуу давж заалдах шатны шүүх хуралдаж 2016.05.11-ний өдөр болж, иргэн П.О надтай өөрөө ярьж танилцан, надаас элдэв тусламж хүсэж байсан нөгөөх шүүгч П.Д нь хуралдааныг даргалан, өөрөө илтгэн, хуралдааны явцад илт намайг буруутгаж, Б.Б-д давуу байдал олгосоор байгаад нэхэмжлэлийн шаардлагаас огт үндэслэлгүйгээр 79 сая төгрөгийг надаас гаргуулахаар шийдвэрлэлээ.

... Энэ миний таамаглалаас зөрөөгүй юм.

Ийм байдал яагаад үүсэв. Асуултын хариулт маш тодорхой. ... зээлүүлсэн 1 сая төгрөгөө нэхэж авсан, нэхсэн 20 сая төгрөгийг нь өгч чадахгүй гэсэн, банкны барьцаанд үл хөдлөх хөрөнгөө тавиагүй зэргээс минь шууд холбоотой.

Шүүхийн шинэтгэл явагдаж, шүүхэд итгэх, шударга шүүхээр хэргээ шийдвэрлүүлэх үйл явц эрчимжиж буй өнөө цагт Монгол Улсын нэрийн өмнөөс шийдвэр гаргадаг хамгийн шилдэг шүүгч шүүхэд ажиллаж, иргэдийн зөрчигдсөн эрх, эрх чөлөөг хамгаалж байх нь шүүгчид тавигдах нэн тэргүүний шаардлага гэж жирийн иргэн би ойлгодог.

... надтай танилцаад сууж байхдаа "... одоо шүүхийн бүтэц өөрчлөгдөөд давахын шүүх нэг даргатай болох гэж байгаа, би хүмүүстэй ярьж хөөрсөн, эндээ үлдэнэ..." гэж ярьсан бөгөөд энэ үеэс миний шүүхэд итгэх үнэлэмж буурч П.Д шүүгчийг ёс зүйн хувьд шүүгч хүнд байх наад захын шаардлагыг хангахгүй хүн гэдэг нь харагдсан.

... Ерөнхий шүүгч П.Д-д хуульд заасан хариуцлага ногдуулна уу" гэжээ.

Иргэн П.О 2016 оны 6 сарын 09-ний өдөр гаргасан нэмэлт тайлбартаа: "... 2016.02.27-ны өдрийн орой харанхуй болж байхад надаас 1 сая төгрөгийг авахдаа өөрийнхөө гэрт байдаг охиныг явуулж мөнгө авхуулсан. Мөнгө гэж хэлэх үедээ намайг дансаа өгөөч гэж хэлэхэд "чи намайг хоолгүй болгох нь уу" гээд инээж байсан зэрэг нь миний гайхширлыг үнэхээр их төрүүлж байсан." гэжээ.

Иргэн П.О-ийн нөхөр Б.Г 2016 оны 6 сарын 09-ний өдөр бичгээр гаргасан тайлбартаа: "Б.Г би П.О-ийн нөхөр бөгөөд 2016.02.26-ны өдрийн орой ажил тарсны дараа П.О шүүгч П.Д-тай уулзана гээд гарсан бөгөөд энэ хооронд би хэд хэдэн удаа залгаж байсан. Эхнэр П.О нь шүүгч П.Д-д хүүхдийн сургалтын төлбөр болох 1 сая төгрөгийг өгөөд буцааж авсан. Мөн аймагт болсон ДДД-ийн баяраар манай "ССС" кафены сандал ширээ юмсыг хэрэглэн буцааж авчрахад нь би тоолж хүлээж авч байсан. Нэг залуу охин 2 авчирч өгсөн" гэжээ.

Шүүгч П.Д 2016 оны 6 сарын 20-ны өдөр Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан тайлбартаа: "...Тус шүүхэд Б.Б-ийн нэхэмжлэлтэй П.О-д холбогдох хэргийг 2015.12.16-ны өдөр хүлээн авч, 2016.01.06-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн ХХША-ны зөрчлийг үндэслэн анхан шатны шүүхэд дахин шийдвэрлүүлэхээр буцаасан, энэ хэрэг нэхэмжлэгчийн гомдлоор давж заалдах шатны шүүхэд

2016.04.12-нд ирснийг хүлээн авч 2016.05.11-ний өдөр хэлэлцэн анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулан шийдвэрлэсэн. П.О-ийн гомдолд дурдсан 2016 оны 02 дугаар сарын сүүлчээр "ННН" дэлгүүрт П.О-той таарч тухайн үед төрсөн ах П.Б-гийн бие тааруухан байгаа талаар яриад өнгөрсөн. П.О-ийн дугаарыг ахаасаа авч холбогдон түрээслүүлэх байр, кафед нь хоол хийлгэх, хийлгэхгүй, аяга, таваг, хийн плитк, хувин, сав зэрэг гал тогооны зүйлүүдийг түүнээс авах эсэх, буцааж хэзээ өгөх гэх мэт асуудлын талаар П.О-той хүү Б.М-ийн4655 дугаарын, төрсөн эгч П.М-ийн зээ охин хамт амьдардаг А.Н-ийн7907 дугаарын, хүргэн ах Ж.Д-гийн төрсөн дүүгийн хүү мөн тухайн үед хамт амьдарч байсан Б.Б-ийн6771 дугаарын утаснаас дээрх асуудлаар удаа дараа ярьж байгаад П.О-ийн кафены гал тогооны зүйлийг авч хэрэглэсэн. Олон танил найз нөхдийн гуйлтаар мөнгө авч өгөх, мөнгөний боломжтой үед бусдад зээлүүлэх, зээлэх тохиолдлууд байсан. Дээрх тохиолдолд өөрөө болон дүү Б.Б, А.Н нараар мөнгийг авхуулах, хүргүүлэх, өөрөө очиж өгөх, авах, буцааж өгөх асуудал байсан. Би П.О-оос яах гэж юуны төлөө ямар зорилгоор тэр хүний үл хөдлөх хөрөнгийг барьцаалуулахыг шаардах билээ. Түүнд ямар үл хөдлөх хөрөнгө байсныг мэдэхгүй, мэдэх ч шаардлага байгаагүй" гэжээ.

Иргэн Б.Б 2017 оны 02 сарын 13-ны өдөр Шүүхийн Ёс зүйн хороонд бичгээр гаргасан тайлбартаа: "2016 оны 3 дугаар сарын 5-8-ны өдрүүдэд У суманд ДДД-ийн баяр арга хэмжээ болж уг баяраар гадаад, дотоод, ААА хотоос хүмүүс ирж үзсэн билээ. Уг ДДД баярыг үзэхээр манай хамаатан ах, дүү, найз нөхдөө дагуулан ирсэн. ДДД-ийн баярын үеэр буудал, зоогийн газрууд захиалга дууссан учир ирсэн ах, дүү нараа хаус түрээслэн хоол ундыг нь хийж өгсөн. Олон хүн байсан учир аяга таваг, гал тогооны зүйл хэрэг болсон учир П.Д эгчийг олоод өгөөч гэж гуйсан. Ингээд П.О гэдэг хүний кафены ширээ сандал, гал тогооны зүйлсийг ашигласан. Эдгээр хүмүүсийн хоол унд зардал, мөнгөний тооцоог би гаргаж хийсэн бөгөөд П.Д эгчид хамааралгүй" гэжээ.

Иргэн Р.Б 2017 оны 02 сарын 17-ны өдөр Шүүхийн Ёс зүйн хороонд бичгээр гаргасан тайлбартаа: "Р.Б миний бие 2016.03.05-08-ны өдрүүдэд Ф аймаг руу ДДД баярт эхнэр, хүүхэд, ээж, эгч, найз нөхөд зэрэг хүмүүстэй ООО хийд үзэн У суманд очиж аялсан. Бид олуулаа очихоор болсон тул урьдчилан буудал захиалахаар Б.Б-д хандсан. Ингээд Ф аймаг руу хөдлөхөөс өмнө гэр хороололд 2 давхар хаус байна гэхээр нь түрээслэхээр болсон. Ингэхдээ нэгэн кафены аяга, таваг авч хэрэглэсэн. П.Д-д ямар нэгэн хамаарал байхгүй" гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 08 сарын 30-ны өдрийн 108 дугаар тогтоолоор шүүгч П.Д-д дараах үндэслэлээр сахилгын хэрэг үүсгэжээ: Гомдол гаргагч П.О нь ФХС аймгийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх /хуучин нэрээр/-ийн ерөнхий шүүгч П.Д нь өөртэй нь уулзаж 1 сая төгрөг авсан, 20 сая төгрөгийг нэхсэн, нэхсэн мөнгийг нь өгч чадаагүй болохоор хууль бус шийдвэрийг гаргасан, кафены тоног төхөөрөмж, эд хогшил үнэгүй хэрэглэсэн гэх агуулга бүхий гомдлыг Шүүхийн Ёс зүйн хороонд гаргажээ.

Гомдол гаргагч П.О-ийн гомдолд дурдагдсан 2016 оны 02 дугаар сарын 24-ний өдөр "ННН" дэлгүүрт П.О нь шүүгч П.Д-тэй уулзсан, мөн шүүгч П.Д нь гомдол гаргагч П.О-руу удаа дараа хүүгийнхээ утсаар ярьсан, П.О-ийн ажиллуулдаг кафены ширээ, сандал, тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүйгээр авч ашигласан гэх үйлдлүүд нь гомдол гаргагч П.О-ийн Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан тайлбар, түүний нөхөр Б.Г-ийн бичгээр гаргасан тайлбар, шүүгч П.Д-гийн Шүүхийн Ёс зүйн хороонд бичгээр ирүүлсэн тайлбар, Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн гомдол хянан хэлэлцэх хуралдааны тэмдэглэл зэргээр нотлогдож байна.

Дээрх үйлдлүүд нь шүүгч П.Д-г Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.17-д "хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах", мөн хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.18-д "шүүгч нь хэргийн оролцогч болон бусад этгээдтэй харилцахдаа шүүхийн нэр хүнд, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сөргөөр нөлөөлж болох хувийн харилцаа тогтоох", Монгол Улсын Шүүхийн Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 3.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь шүүгчийн өөр бусад ажлаас ямагт илүү чухал гэдгийг ухамсарлаж, түүний эрхлэх бусад үйл ажиллагаа, хувийн амьдрал нь мэргэжлийн үүрэгтэй нь зөрчилдөх нөхцөл байдал бий болохоос зайлсхийнэ", мөн дүрмийн 3.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Шүүгч хэргийн оролцогч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдтэй хувийн харилцаа тогтоох, шууд болон шууд бусаар тусламж авах, хувьдаа ашиг олох, төлбөргүй буюу хөнгөлөлттэйгөөр үйлчлүүлэх зэрэг хууль бус хангамж эдлэх зэргээр албан тушаалын нэр хүндийг ашиглан ямар нэгэн давуу байдал бий болгохыг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн гэж дүгнэхээр байна.

Гомдол гаргагч П.О нь шүүгч П.Д-д 1 сая төгрөг өгсөн, түүнээс 20 сая төгрөг нэхсэн гэх асуудлын тухайд, хэдийгээр8990 дугаараас4655 дугаар луу 2016 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 18 цаг 05 минутад нэг удаа, 2016 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 11, 12 цагуудад 2 удаа залгасан тухай утасны биллийн баримт, ККК банкны АТМ-ээс 2016 оны 02 дугаар сарын 27-ны өдөр авсан 1 сая төгрөгийн баримт байгаа, 2016 оны 02 дугаар сарын 24-ний өдөр Ф аймгийн У суманд байрлалтай "ННН" дэлгүүрт П.О, П.Д нар уулзсан, 2016 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн орой утсаар ярьж эмнэлгийн урд талын хашаанд намайг хүлээгээд зогсож байсан бөгөөд тэндээс П.Д шүүгчийн машинд суун, аймгийн зүүн захад ГГГ дугаар цэргийн ангийн хажууд очин 2 цаг гаруй ярилцаж танилцсан, ингэж уулзахад нь Ф аймгийн Замын цагдаагийн хэлтсийн ажилтан н.Б нь ерөнхий шүүгч П.Д-гийн машиныг зогсоож бичиг баримтыг нь шалгаж байсан, 2016 оны 02 дугаар сарын 27-ны өдөр шүүгч П.Д-гийн гэрт нь байдаг А.Н гэх хүн ирж 1 сая төгрөг бэлнээр аваад явсан, мөн гэрт нь байдаг Б.Б гэгч нь 1 сая төгрөгийг буцааж өгсөн, иргэний хэрэгт туслалцаа үзүүлье гэж амласан гэх зэрэг нь цугларсан баримтаар нотлогдохгүй байна.

Харин дээр дурдсан асуудлаар мөрдөн байцаалт явуулах, нотлох баримт цуглуулах эрх Шүүхийн Ёс зүйн хороонд олгогдоогүй, шалгаж тогтоох боломжгүйгээс гадна Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй тул эдгээртэй холбоотой нотлох баримтыг холбогдох хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх нь зүйтэй гэж бүрэлдэхүүн дүгнэлээ" гэжээ.

Шүүгч П.Д Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 8 сарын 30-ны өдрийн 108 дугаар тогтоолыг эс зөвшөөрч 2016 оны 10 сарын 05-ны өдөр Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанд гаргасан гомдолдоо: "Шүүгч П.Д би гомдол гаргагч П.О-той 2016.02.24-ний өдөр тааралдаж ярилцсан, өөрийнх нь кафены хэрэгслийг дүү нартаа үнэ төлбөргүйгээр зуучлан хэрэглүүлэхээр түүнтэй удаа дараа утсаар ярьсан зэрэг нь танилын хувиар харилцсан ба гомдол гаргагч П.О-д холбогдох иргэний хэрэг 2016.01.25-ны өдөр анхан шатны шүүхэд очсон байсан учир хэргийн оролцогчтой нэг талыг байлцуулахгүйгээр уулзсан, хувийн харилцаа тогтоосон, үнэ төлбөргүйгээр үйлчлүүлсэн гэх нөхцөл байдал үүсээгүй, ийм ч санаа зорилго байгаагүй.

Сахилгын хэрэг үүсгэж шүүгч намайг буруутгаж байгаа нь гомдол гаргагчийн эсрэг шүүх бүрэлдэхүүн шийдвэр гаргасан тохиолдолд үндэслэгдэх учиргүй гэж үзэж байна.

Ажилтан Ж.Халиун нь гишүүнийг удирдамж чиглэл өгөөгүй, Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмээр түүнд ийм эрх олгогдоогүй байхад дур мэдэн шалгах үйл

ажиллагаа явуулж, өөрийн сайн дураар санаачлан хийсэн ажиллагаа болсон бөгөөд энэ нь холбогдох дүрэм, хуульд нийцээгүй, хэт нэг талын эрх ашгийг хамгаалж, нөгөөг буруутгах шинжтэй нотлох баримт бичгийг бүрдүүлж, 108 дугаар тогтоолын төслийг өөрөө боловсруулж, хуралдаанд түүний агуулгыг уншин танилцуулж албажуулсан байна. Мөн гомдол гаргагч П.О-той удаа дараа уулзсан ба тэр тухай тэмдэглэл үйлдээгүй, 2016.06.09-ний өдөр манай дүү А.Н-тэй утсаар ярьж 1 сая төгрөгийг авсан гэж нотлохыг оролдсон, н.Б гэдэг цагдаа руу утсаар ярьсан талаар тэмдэглэл хөтөлсөн байгаа ба гомдол гаргагч П.О-оос нэмэлт тайлбар, түүний нөхөр Б.Г-ээс тайлбар гаргуулсан байдаг.

Ажилтан Ж.Халиун нь П.О-ийн гомдолд зээлсэн мөнгө буцааж авсан тухай дурдсан асуудлыг шалгаж тогтоох боломжтой байсан ба энэ үйл ажиллагаа огт хийгдээгүй байгаа нь мөнгө зээлсэн, буцаан авсан асуудал нь гүтгэлэг болохын нотолгоо юм.

Ж.Халиун нь П.О-той илүү дотно харилцсан гэж үзэхээр байдлыг бий болгож түүний гомдлыг үнэн зөв гэж батлахыг оролдож холбогдох хууль дүрмийн шаардлага хангахгүй нотлох баримт цуглуулж, өөрийн хувийн дүгнэлтээ ёс зүйн хороонд танилцуулж, ёс зүйн хорооноос гарах шийдвэрийг урьдчилан бэлтгэж тогтоолын агуулгыг уншин танилцуулж, түүнийхээ дагуу ёс зүйн хорооноос хууль, дүрэмд нийцээгүй үндэслэлээр сахилгын хэрэг үүсгэх шийдвэр гаргах үндэслэлийг бий болгосон, шударга шийдвэр гаргасан шүүгч намайг хэт буруутгасан юм уу гэсэн бодол төрж байгаа ба энэ шийдвэрт гомдолтой байна. Иймд 108 дугаар тогтоолыг хүчингүй болгож өгнө үү" гэжээ.

Шүүгч П.Д нь 2016 оны 10 сарын 17-ны өдөр Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанд гаргасан хүсэлтдээ: "... Дор дурдсан үндэслэлээр хүсэлт гаргаж байна.

1.Ф аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд хөтлөгдөж буй хэргийн хөдөлгөөний бүртгэлийг бусад баримтыг тус шүүхийн бүртгэлийг баримтаар нь гаргуулж материалд хавсарган өгнө үү.

2.Гомдол гаргагч П.О-д хариуцагдах хэргийн 2016.05.11-ний өдрийн шүүх хуралдааны бүрэлдэхүүнд оролцсон шүүгч нараасаа тайлбар гаргуулах, шүүх хуралдааны хэлэлцүүлгийн үед болсон нөхцөл байдлыг тогтоох,

3.2016.05.11-ний өдрийн шүүх хуралдааны бичлэгт үзлэг хийж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа зөрчигдсэн эсэх болон гомдол гаргагч П.О-ийн эрхийг зөрчсөн нөхцөл байдал байсан эсэх,

4.Гомдол гаргагч П.О-ийн гомдолд дурдсан 1 сая төгрөг зээлсэн, 20 сая төгрөг нэхсэн гэх асуудлыг тус хорооны ажилтан Ж.Халиуны явуулсан ажиллагааг хүлээн зөвшөөрөх боломжгүй учир дараах ажиллагааг явуулж өгнө үү. А.Н-ийн ярьсан зүйл тэмдэглэлд бичигдсэнтэй тохирч байгаа эсэхийг тодруулах, 1 сая төгрөг гомдол гаргагчаас авсан эсэх, дүү Б.Б-ээс тайлбар авч өгнө үү.

5.Хуралдаанаас өмнө хэргийн нотлох баримттай танилцуулж, хуралдааны товыг боломжит хугацаанд мэдэгдэнэ үү" гэжээ.

2016 оны 12 сарын 08-ны өдрийн Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааны 53 дугаар магадлалаар П.Д-ийн дээрх хүсэлтийг дараах байдлаар шийдвэрлэжээ: "Шүүгч П.Д-ээс 2016.10.17-ны өдөр гаргасан хүсэлтийнхээ 1, 2 дахь хэсгээс татгалзаж буйгаа хуралдааны явцад илэрхийлэв. Хүсэлтийн 4 дэх хэсгийг хүлээн авахаас татгалзах нь зүйтэй гэж бүрэлдэхүүн үзэв. Учир нь: 1 сая төгрөг өгч авсан, 20 сая төгрөг нэхсэн эсэх асуудлыг холбогдох хууль, хяналтын байгууллага руу шилжүүлэхээр Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 108 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн байна. Ийнхүү шилжүүлэхээр шийдвэрлэсэн нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 3-т "өөрийн эрх

хэмжээнд хамаарахгүй бөгөөд албан ёсоор нийтэд зарласан асуудлаар гаргаагүй өргөдөл, гомдлыг харьяалах газар нь 3 хоногийн дотор шилжүүлнэ” гэж заасанд нийцжээ. Тиймээс, Хүсэлтийн 4 дэх хэсэгт “А.Н-ийн ярьсан зүйл тэмдэглэлд бичигдсэнтэй тохирч байгаа эсэхийг тодруулах, 1 сая төгрөг гомдол гаргагчаас авсан эсэх, дүү Б.Б-ээс тайлбар авч өгнө үү” гэсэн хүсэлтийг хангах шаардлагагүй юм. Хүсэлтийн 5 дахь хэсэгт дурдсан эрхээ эдлэх нь шүүгч П.Д-д нээлттэй байх бөгөөд тус хорооны хуралдааны товыг түүнд боломжит хугацаанд мэдэгдсэн байна. Харин, “2016.05.11-ний өдрийн шүүх хуралдааны бичлэгт үзлэг хийж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа зөрчигдсөн эсэх болон гомдол гаргагч П.О-ийн эрхийг зөрчсөн нөхцөл байдал байсан эсэх” тухай шүүгч П.Д-ийн хүсэлтийн 3 дахь хэсгийг хүлээн авч хангах, дахин шалгах нь зүйтэй гэж бүрэлдэхүүн үзэв. Иймд, шүүгч П.Д-д холбогдох сахилгын хэргийг хэлэлцэх Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааныг хойшлуулахаар шийдвэрлэв.” гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны 2017.02.17-ны өдрийн 20 дугаар магадлалд: “... Дээр дурдсанчлан шүүгч П.Д нь ШЭЗБТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1.17, 27.1.18, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.1.3, ШЭЗД-ийн 2.3 дугаар зүйл, 3.1 дүгээр зүйлийн 1, 2, 3.2 дугаар зүйлийн 1, 3.3 дугаар зүйлийн 1, 2-т заасан үүргүүдээ зөрчиж шүүгчийн ёс зүйн ноцтой зөрчил гаргасан байна. Тиймээс, шүүгч П.Д-г огцруулах сахилгын шийтгэл (арга хэмжээ) оногдуулах нь зүйтэй гэж бүрэлдэхүүн дүгнэв.” гэжээ.

Шүүгч П.Д Шүүхийн Ёс зүйн хорооны 2017.02.17-ны өдрийн 20 дугаар магадлалыг эс зөвшөөрч, 2017.03.27-ны өдөр Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргажээ.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017.05.16-ны өдрийн 0343 дугаар магадлалд: “Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 20 дугаар магадлалыг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.3 дахь хэсэгт заасны дагуу хянан хэлэлцээд шүүгч П.Д-ийн гаргасан сахилгын шийтгэлийг хөнгөрүүлж өгнө үү ... гэх давж заалдах гомдлыг дараах үндэслэлээр хангаж, түүнд ногдуулсан сахилгын шийтгэлийг өөрчилж шийдвэрлэлээ.

Гомдол гаргагч иргэн П.О нь “... шүүгч П.Д өөртэй нь удаа дараа утсаар ярьж уулзсан, кафены тоног төхөөрөмж. эд хогшлыг авч хэрэглэсэн, 1 сая төгрөг авсан, нэхэж байж буцааж авсан, 20 сая төгрөгийг нэхсэн, нэхсэн мөнгийг нь өгч чадаагүй болохоор хувийн ашиг сонирхлыг нь биелүүлээгүйн төлөө шүүх хуралдааны явцад илт буруутгаж, нэхэмжлэгч Б.Б-д давуу байдал олгож нэхэмжлэлийн шаардлагаас огт үндэслэлгүйгээр 79 сая төгрөгийг надаас гаргуулахаар шийдвэрлэж миний эрхэнд бүдүүлгээр халдсан шүүгчийн ёс зүйн зөрчил гаргасан тул сахилгын шийтгэл ногдуулна уу гэсэн агуулгаар Шүүхийн Ёс зүйн хороонд гомдол гаргажээ.

Шүүхийн Ёс зүйн хороо 2016 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 108 дугаар тогтоолоор гомдол гаргагч П.О-ийн гомдол дурдагдсан “шүүгч П.Д-ийн гомдол гаргагч П.О-той удаа дараа утсаар ярьсан, уулзсан, түүний ажиллуулдаг кафены ширээ сандал, тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүйгээр авч ашигласан гэх үйлдлүүд нь гомдол гаргагчийн болон түүний нөхрийн тайлбар, мөн шүүгч П.Д-гийн бичгээр ирүүлсэн тайлбар хуралдааны тэмдэглэлээр нотлогдож байна. Шүүгчийн дээрх үйлдлүүд нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын Шүүхийн Шүүгчийн Ёс зүйн дүрмийн холбогдох заалтуудыг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй гэж дүгнэн тус зөрчлүүдэд нь холбогдуулан сахилгын хэрэг үүсгэсэн байх ба гомдол гаргагчийн “шүүгч надаас 1 сая төгрөг авсан 20 сая төгрөг нэхсэн” гэх гомдлын тухайд “цугларсан нотлох баримтаар нотлогдохгүй тус асуудлаар мөрдөн байцаалт явуулах, нотлох баримт цуглуулах эрх Шүүхийн Ёс зүйн хороонд олгогдоогүй, шалгаж тогтоох боломжгүйгээс гадна Эрүүгийн хуульд заасан гэмт

хэргийн шинжтэй байж болзошгүй эдгээртэй холбогдох нотлох баримтыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх нь зүйтэй гэж дүгнэжээ.

Улмаар Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 05/143 дугаар албан бичгээр П.О-ийн гомдлын хуулбарыг холбогдох баримтын хамт ЧЧЧ газарт хүргүүлсэн байна.

Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 20 дугаар магадлалаар "шүүгч П.Д нь хэргийн оролцогчтой удаа дараа уулзсан.түүний ажиллуулдаг кафены эд зүйлсийг эвч хэрэглэсэн нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.17-д "хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах 27.1.18-д шүүгч нь хэргийн оролцогч болон бусад этгээдтэй харилцахдаа шүүхийн нэр хүнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сөргөөр нөлөөлж болох хувийн харилцаа тогтоохыг хориглоно, Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 2-т хэргийн оролцогчдын зүгээс шүүгчийг татгалзахад хүргэх нөхцөл байдлыг өөрийн үг яриа, үйлдлээр бий болгохоос урьдчилан сэргийлж зайлсхийнэ. 3.1 дүгээр зүйлийн 2-т Шүүгч хэргийн оролцогч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдтэй хувийн харилцаа тогтоох, шууд болон шууд бусаар тусламж авах, хувьдаа ашиг олох, төлбөргүй буюу хөнгөлөлттэйгөөр үйлчлүүлэх зэрэг хууль бус хангамж эдлэх зэргээр албан тушаалын нэр хүндийг ашиглан ямар нэгэн давуу байдал бий болгохыг хориглоно", 3 1 дүгээр зүйлийн 1-т "Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь шүүгчийн өөр бусад ажлаас ямагт илүү чухал гэдгийг ухамсарлаж түүний эрхлэх бусад үйл ажиллагаа хувийн амьдрал нь мэргэжлийн үүрэгтэй нь зөрчилдөх нөхцөл байдал бий болгохоос зайлсхийнэ, мөн 3.2 дугаар зүйлийн 1-д хэргийн оролцогчдод эрх тэгш төвийг сахисан ёсоор хандах үүргээ зөрчсөн байна гэж тус тус дүгнэснийг, түүнчлэн гомдол гаргагч П.О-г "хэргийн оролцогч" гэж үзсэнийг үгүйсгэх үндэслэл тус тус тогтоогдохгүй байна.

Ф аймаг дахь сум дундын анхан шатны шүүх 2015 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр иргэн Б.Б-ийн нэхэмжлэлтэй хариуцагч П.О-д холбогдох иргэний хэргийг хянан хэлэлцээд 401 дүгээр шийдвэртэй хэргийг ФХС аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх 2016 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр хянан хэлэлцэж, /шүүх хуралдааныг шүүгч П.Д даргалсан/ 203/МА2016/00001 магадлалаар анхан шатны шүүхийн 401 дүгээр шийдвэрийг хүчингүй болгож хэргийг дахин хэлэлцүүлэхээр мөн шүүхэд нь буцааж шийдвэрлэжээ.

Шүүгч П.Д дээрх хэргийн шүүх хуралдаан болсны дараа тус хэрэг Ф аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхээр дахин хянан хэлэлцэгдэж, /анхан шатны шүүх хэргийг 2016 оны 3 дугаар сарын 10-ны өдөр дахин хянан хэлэлцэж 136 дугаар шийдвэр гарсан/ дахин ФХС аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх 2016 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн /шүүгч П.Д шүүх хуралдааныг даргалсан/ шүүх хуралдаанаар хянан хэлэлцэгдэх хүртэлх хугацаанд тус хэргийн хариуцагч П.О-той уулзсан, удаа дараа утсаар ярьсан, түүний ажиллуулдаг кафены тоног төхөөрөмжүүдийг авч хэрэглэсэн болох нь гомдол гаргагчийн болон шүүгчийн өөрийнх нь тайлбар, бусад гэрчүүдийн тайлбар зэрэг баримтуудаар тогтоогдсон байна.

ФХС аймгийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн шүүгч П.Д даргалж хийсэн шүүх хуралдаанаар хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж шийдвэрлэсний дараа тус хэрэг анхан шатны шүүхээр хянан хэлэлцэгдэх нь тодорхой улмаар хэргийн оролцогчдоос шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрөх тохиолдолд хэрэг дахин давж заалдах шатны шүүхээр хянан хэлэлцэгдэх, түүнчлэн тийнхүү хэлэлцэгдэх тохиолдолд шүүгч шүүх бүрэлдэхүүнд оролцох боломжтой өөрөөр хэлбэл, тус хэрэг анхан шатны шүүхээр хянан хэлэлцэгдэж, хэргийн оролцогчдоос давж заалдах гомдол гаргаагүйн улмаас шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон нөхцөл байдал үүсээгүй байх үед болсон

үйл баримтын талаарх гомдолтой холбогдуулан Шүүхийн Ёс зүйн хороо гомдол гаргагч П.О-г "хэргийн оролцогч" гэж үзсэнийг буруутгах үндэслэлгүй байна.

Хэдийгээр гомдол гаргагчийн гомдолд дурдсанчлан шүүх хуралдаан дээр илт буруутгаж, үндэслэлгүйгээр 79 сая төгрөг гаргуулж шийдвэрлэсэн, хэргийн оролцогчтой харилцсанаар хараат бус байдлаа алдсан нөлөөнд автсан" гэх нөхцөл байдлыг Шүүхийн Ёс зүйн хороо тогтоогдсон гэж дүгнээгүй боловч хэрэг эцэслэн шийдвэрлэгдээгүй өөрийнх нь ажиллаж буй шүүхээр дахин хянан хэлэлцэгдэх өөрөө шүүх бүрэлдэхүүнд оролцох боломжтой нөхцөл байдалд хэргийн оролцогчтой удаа дараа утсаар ярьж уулзаж, түүний хувийн эд зүйлийг авч хэрэглэсэн шүүгч П.Д-ийн үйлдлүүдийг Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шүүгчийн ёс зүйн дүрэмд заасан "шүүгчийн ёс зүйн зөрчил"-д тооцсон Шүүхийн Ёс зүйн хорооны дүгнэлт үндэслэлтэй байх боловч шүүгчийн ёс зүйн зөрчлийн шинж байдал, зөрчлийг шүүгч анх удаа болон давтан үйлдсэн байдлыг харгалзан үзэж хуулиар тогтоосон сахилгын арга хэмжээг Шүүхийн Ёс зүйн хороо сонгож хэрэглэх боломжоо зүй ёсоор хэрэгжүүлээгүй байна гэж давж заалдах шатны шүүх үзлээ.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д "Шүүгч энэ хууль, шүүгчийн ёс зүйн дүрэм шүүхийн байгууллага дахь хөдөлмөрийн харилцааг зохицуулсан хуулиар тогтоосон журмыг зөрчсөн бол түүнд дор дурдсан сахилгын арга хэмжээний аль нэгийг авна. 37 1 1-д сануулах, 37 1.2-т зургаан сар хүртэл хугацаагаар 30 хүртэл хувиар цалинг бууруулах", 37 1.3-д "огцруулах" гэж зааснаас үзвэл хэрэв шүүгч хууль дүрмээр тогтоосон ёс зүйн зөрчлийг гаргасан нь тогтоогдсон бол түүнд /шийтгэл/ тохирох сахилгын арга хэмжээг сонгон авч сахилгын шийтгэл ногдуулах боломжтой байхад Шүүхийн Ёс зүйн хороо зөрчлийг давтан үйлдсэн талаар заагаагүй атлаа шүүгч П.Д-д сахилгын арга хэмжээний хамгийн хүнд хэлбэр болох "шүүгчийн албан тушаалаас огцруулах арга хэмжээг авсан нь /шийтгэл ногдуулсан/ Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлд 26.1-д тухайн зөрчлийн шинж байдал, түүний анх буюу давтан үйлдсэнийг харгалзан ... сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулна" гэж заасантай нийцээгүй байна.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-д "Энэ хуулийн 35.1-д заасан магадлалыг маргааны оролцогч тэдгээрийн төлөөлөгч өмгөөлөгч эс зөвшөөрвөл уг магадлалыг гардан авснаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй гэж Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалд гомдол гаргах журмыг хуульчилжээ.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 112 дугаар зүйлд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн анхан шатны журмаар хянан шийдвэрлэх маргааны төрөлд шүүгчийн ёс зүйн зөрчилд холбогдох маргаан буюу Шүүхийн Ёс зүйн хорооны шийдвэр, үйл ажиллагаатай холбоотой маргаан гэж заагаагүй байна. Иймээс захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар тогтоосон анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах шатны шүүх хянан шийдвэрлэхээр заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журамд нийцүүлэн Шүүхийн Ёс зүйн хорооны сахилгын хэргийг хянан шийдвэрлэх тус хорооны магадлалын сахилгын шийтгэл ногдуулсан хэсэгт өөрчлөлт оруулж шийдвэрлэх үндэслэлтэй гэж үзсэн болно.

Иймд шүүх бүрэлдэхүүн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.3-д "хууль буруу хэрэглэсэн бол давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүх ... шийдвэрийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь өөрчлөх эрхтэй гэж заасны дагуу зөрчлийг давтан үйлдээгүй байдлыг нь харгалзан Шүүхийн Ёс зүйн хорооны шүүгчид ногдуулсан сахилгын арга хэмжээг зургаан сарын хугацаагаар 30 хувиар цалинг бууруулах" болгож өөрчлөн шүүгч

П.Д-ийн сахилгын арга хэмжээг өөрчлөн хөнгөрүүлж өгнө үү гэх гомдлыг хангаж магадлалын тогтоох хэсэгт зохих өөрчлөлтийг оруулахаар шийдвэрлэв.” гэжээ.

Гомдол гаргагч П.О Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017.05.16-ны өдрийн 0343 дугаар магадлалыг эс зөвшөөрч, 2017.06.27-ны өдөр Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд гомдол гаргажээ.

Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2017.09.25-ны өдрийн 320 дугаар тогтоолд: “Хяналтын шатны шүүх дараах үндэслэлээр Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 20 дугаар магадлал, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 221/МА2017/0343 дугаар магадлалыг тус тус хүчингүй болгож, хэргийг Шүүхийн Ёс зүйн хороогоор дахин хэлэлцүүлэхээр буцааж шийдвэрлэлээ.

Шүүхийн Ёс зүйн хороо иргэн П.О-ийн гомдолтой, шүүгч П.Д-д холбогдох сахилгын хэргийг хянан хэлэлцээд 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 20 дугаар магадлалаар шүүгч П.Д нь “хэргийн нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай уулзсан”, “шүүхийн нэр хүнд, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сөргөөр нөлөөлж болох хувийн харилцаа тогтоосон”, “шүүгчээс татгалзахад хүргэх үг яриа, үйлдэл гаргасан”, “.../хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас/ татгалзан гараагүй”, “хэргийн оролцогчоос тусламж авч давуу байдал бий болгосон”, “шүүгчийн мэргэжлийн үүргээ чухалчлаагүй”, “зохисгүй байдал гаргасан, төвийг сахиагүй” гэх зөрчил гаргасныг тогтоон, “ёс зүйн ноцтой зөрчил гаргасан” гэх үндэслэлээр “шүүгчийн албан тушаалаас огцруулах”-аар шийдвэрлэсэн, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх уг магадлалыг хянаад “.../зөрчил тогтоосон/ Шүүхийн Ёс зүйн хорооны дүгнэлт үндэслэлтэй боловч/... албан тушаалаас огцруулах арга хэмжээ авсан нь Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д ...заасантай нийцэхгүй” гэх үндэслэлээр “... сахилгын арга хэмжээг өөрчилж, ... зургаан сарын хугацаагаар 30 хувиар цалинг бууруулах сахилгын арга хэмжээ ногдуулж ...” шийдвэрлэжээ. Шүүгч П.Д давж заалдах шатны шүүхийн магадлалд хяналтын журмаар гомдол гаргаагүй, хяналтын шатны шүүх хуралдаан дээр шүүгч П.Д, түүний өмгөөлөгч Х.Ц нараас “...магадлалыг хүлээн зөвшөөрч байгаа” талаар тайлбар гаргаж байх тул хяналтын шатны шүүхээс шүүгч П.Д нь дээр дурдсан “ёс зүйн зөрчил гаргасан эсэх”, Шүүхийн Ёс зүйн хороо болон давж заалдах шатны шүүхээс “ёс зүйн зөрчилтэй” холбоотой холбогдох хууль, “Шүүгчийн ёс зүйн дүрэм”-ийн заалтыг зөв тайлбарлан хэрэглэсэн эсэх асуудлаар дүгнэлт хийх шаардлагагүй гэж үзлээ.

Давж заалдах шатны шүүх Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг тус тус буруу тайлбарлан хэрэглэсэн талаар: Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д “Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн гэж үзсэн иргэн, албан тушаалтан, хуулийн этгээд шүүгчид сахилгын хэрэг үүсгүүлэхээр Ёс зүйн хороонд гомдол гаргах”-аар, 36 дугаар зүйлийн 36.1-д “ёс зүйн хороо сахилгын хэргийг хянан хэлэлцээд ... /сахилгын шийтгэл ногдуулах эсэх/ шийдвэрийг гаргах”-аар. 37 дугаар зүйлийн 37.1-д “шүүгч энэ хууль, шүүгчийн ёс зүйн дүрэм ...журмыг зөрчсөн бол түүнд /хуульд заасан/ сахилгын арга хэмжээний аль нэгийг авах”-аар зааснаас үзвэл, шүүгчийн ёс зүйн зөрчилд сахилгын хариуцлага хүлээлгэх эрхийг Шүүхийн Ёс зүйн хороонд хуулиар тусгайлан олгосон байна.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д захиргааны хэргийн шүүх нь “нийтийн эрх зүйн маргаан”-ыг хянан шийдвэрлэхээр заасан, энэ хүрээнд маргаан бүхий захиргааны актын хууль зүйн үндэслэлийг шүүх шалган тогтоох үүрэгтэй, харин, хуульд тусгайлан заагаагүй тохиолдолд тухайн актыг “хуульд нийцүүлэн” өөрчлөх эрхгүй болно. Өөрөөр

хэлбэл, төрийн албан хаагчид сахилгын аливаа хариуцлага ногдуулах эрхийг захиргааны хэргийн шүүхэд хуулиар олгоогүй байхад сахилгын хариуцлага ногдуулсан захиргааны актад холбогдох маргааныг хянан шийдвэрлэхдээ уг актаар ногдуулсан сахилгын хариуцлагын төрөл, хэлбэрийг шүүх өөрчлөн тогтоох эрхгүй тул “шүүгчийн албан тушаалаас огцруулах” сахилгын шийтгэл ногдуулсан Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 20 дугаар магадлал “хуульд нийцсэн эсэх, шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн эсэх” маргааныг хянахдаа актаар ногдуулсан сахилгын хариуцлагын төрлийг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс “зургаан сарын хугацаагаар 30 хувиар цалинг бууруулах” болгон өөрчилсөн нь буруу байна. Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “...зөрчлийн шинж байдал. түүнийг анх буюу давтан үйлдсэнийг харгалзан ... төрийн жинхэнэ албан хаагчид ... /хуульд заасан/ сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулна” гэж заасан нь захиргааны хэргийн шүүхэд олгосон эрх хэмжээ биш тул эрх бүхий этгээдээс төрийн албан хаагчид ногдуулсан сахилгын шийтгэлийн төрлийг “зөрчлийн шинж байдалд тохироогүй” гэх үндэслэлээр шүүх өөрчлөн тогтоосон нь уг хуулийн заалтыг давж заалдах шатны шүүх буруу тайлбарлан хэрэглэсэн гэх үндэслэл болно.

Давж заалдах шатны шүүх дээрх байдлаар маргааны үйл баримтуудад холбогдолтой материаллаг хуулийн заалтуудыг буруу тайлбарлан хэрэглэж, шүүхийн эрх хэмжээг хэтрүүлсэн байх тул Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 221/МА2017/0343 дугаар магадлалыг “хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх” хуулийн шаардлагыг хангаагүй гэж үзэхээр байна.

Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 20 дугаар магадлалын талаар: Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 20 дугаар магадлалаар “... Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн ... 37 дугаар зүйлийн 37.1.3, 37.2 дахь заалт...”-ийг тус тус баримталж шүүгч П.Д-г “шүүгчийн албан тушаалаас нь огцруулж” шийдвэрлэжээ.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “шүүгчийг Монгол Улсын Үндсэн хууль болон энэ хуульд заасан үндэслэлээр албан тушаалаас нь чөлөөлж, огцруулах”-аар, 18.4.2-т “... сахилгын шийтгэл хүлээсэн шүүгч нэг жилийн дотор сахилгын шийтгэл дахин хүлээсэн бол шүүгчийг огцруулах”-аар тус тус заасан, тухайн тохиолдолд Шүүхийн Ёс зүйн хороо маргаан бүхий актыг гаргахдаа хуулийн уг заалтад хэрхэн нийцэж байгаа талаар дүгнэлт хийгээгүйгээс “огцруулах” сахилгын шийтгэл биелэгдэх боломжтой эсэх нь тодорхойгүй болжээ.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.3-т “... шүүгч энэ хууль, шүүгчийн ёс зүйн дүрэм ... зөрчсөн бол түүнд ... /огцруулах/ сахилгын арга хэмжээ .../ авч болох”-оор, 37.2-т “.../огцруулах/ сахилгын арга хэмжээ оногдуулсан тохиолдолд Шүүхийн ерөнхий зөвлөл Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх”-ээр тус тус заасан нь, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйлийн Шүүхийн Ёс зүйн хорооны дарга, гишүүний бүрэн эрхийг тодорхойлсон хэм хэмжээ нь “шүүгчийг зөвхөн хуульд заасан үндэслэлээр огцруулах” зарчим. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4-т тусгайлан заасан зохицуулалтыг үгүйсгэх үндэслэл болохооргүй байна. Иймд, хяналтын шатны шүүхээс хэргийг эцэслэн шийдвэрлэх боломжгүй, хэргийг дахин хэлэлцүүлэхээр Шүүхийн Ёс зүйн хороонд буцаах нь зүйтэй гэж үзлээ.” гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдаанаар сахилгын хэргийг хэлэлцээд ҮНДЭСЛЭХ НЬ:

Гомдол гаргагч П.О нь ФХС аймгийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх (хуучин нэрээр)-ийн Ерөнхий шүүгч П.Д өөртэй нь уулзаж 1 сая төгрөг авсан, 20 сая төгрөгийг нэхсэн, нэхсэн мөнгийг нь өгч чадаагүй болохоор хууль бус

шийдвэр гаргасан, кафены гал тогооны хэрэгсэл үнэ төлбөргүй хэрэглэсэн гэх агуулга бүхий гомдлыг Шүүхийн Ёс зүйн хороонд гаргажээ. Энэхүү гомдлын дагуу хийсэн шалгалтын дүнг хянаж, Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 8 дугаар сарын 30-ны өдөр шүүгч П.Д-д сахилгын хэрэг үүсгэж шийдвэрлэсэн бөгөөд Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 20 дугаар магадлалаар шүүгч П.Д-г шүүгчийн ёс зүйн ноцтой зөрчил гаргасан гэж үзээд түүнд огцруулах сахилгын шийтгэл (арга хэмжээ) ногдуулахаар шийдвэрлэжээ.

Шүүгч П.Д Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 20 дугаар магадлалыг эс зөвшөөрч, 2017 оны 3 дугаар сарын 27-ны өдөр Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж, улмаар Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 0343 дугаар магадлалаар Шүүхийн Ёс зүйн хорооны 20 дугаар магадлалын тогтоох хэсэгт зохих өөрчлөлтийг оруулахаар шийдвэрлэсэн байна. Гомдол гаргагч П.О Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 0343 дугаар магадлалыг эс зөвшөөрч, 2017 оны 6 дугаар сарын 27-ны өдөр Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд гомдол гаргажээ. Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2017 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 320 дугаар тогтоол шүүгч П.Д-гийн сахилгын хэргийг дахин хэлэлцүүлэхээр Шүүхийн Ёс зүйн хороонд буцаасны дагуу тус хороо нийт гишүүдийн хуралдаанаараа уг хэргийг хянан хэлэлцэж шийдвэрлэв.

Цугларсан баримтуудаас үзэхэд Нэхэмжлэгч П.О-ийн нэхэмжлэлтэй, хариуцагч Б.Б-д холбогдох, хариуцагчийн сөрөг нэхэмжлэлтэй иргэний хэргийг шийдвэрлэсэн Сум дундын ХХ дугаар шүүх (хуучин нэрээр)-ийн 2015 оны 3 сарын 13-ны өдрийн 88 дугаар шийдвэрт гаргасан зохигчдын давж заалдах гомдлоор Иргэний хэргийн давж заалдах шатны 3 дугаар шүүх (хуучин нэрээр) 2015 оны 5 сарын 4-ний өдөр уг хэргийг хянан хэлэлцэж, 14 дугаартай магадлал гаргаж, дээрх 88 дугаар шийдвэрийг хүчингүй болгож, уг хэргийг дахин хянан шийдвэрлүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасан байна. Давж заалдах шатны шүүхийн энэхүү хуралдаанд тухайн шүүхийн Ерөнхий шүүгч П.Д уг хэргийг илтгэсэн байна. Энэ хэрэг дэх П.О-ийн нэхэмжлэл болон Б.Б-ийн сөрөг нэхэмжлэлийг хамтад нь багтаан хэлэлцэж байгаад “хэргийн оролцогчийн хүсэлтээр тусгаарлажээ (2016 оны 12 сарын 8-ны өдрийн Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдааны 53 дугаар тэмдэглэлийн 11 дэх хуудас, Сахилгын хэргийн 126 дахь хуудас).”

Б.Б нь Сум дундын ХХ дугаар шүүх (хуучин нэрээр)-ийн 2015 оны 3 сарын 13-ны өдрийн 88 дугаар шийдвэрт тэмдэглэгдсэн дээрх сөрөг нэхэмжлэлийн агуулгаараа Ф аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд П.О-д холбогдуулж нэхэмжлэл гаргаж, улмаар иргэний хэрэг үүссэн байна. Ингээд Ф аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх Б.Б-ийн нэхэмжлэлтэй, хариуцагч П.О-д холбогдох энэ хэргийг 2015 оны 11 сарын 13-ны өдөр шийдвэрлэж 143/ШШ2015/00401 дугаартай шийдвэр гаргаж, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгожээ. Улмаар, нэхэмжлэгч Б.Б давж заалдах гомдол гаргасан байна. Тиймээс, ФХС аймгийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх (хуучин нэрээр) уг хэргийг 2016 оны 1 сарын 16-ны өдөр хянан хэлэлцээд 203/МА2016/00001 дугаартай магадлал гаргаж, уг хэргийг дахин хянан шийдвэрлүүлэхээр Ф аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд буцаажээ. Давж заалдах шатны шүүхийн 2016 оны 01 сарын 16-ны өдрийн энэхүү хуралдааныг тус шүүхийн Ерөнхий шүүгч П.Д даргалсан байна.

2016 оны 01 сарын 16-ны өдрийн ФХС аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх (хуучин нэрээр)-ийн хуралдаан болсны дараа буюу 2016 оны 2 сарын сүүлээр (02 сарын 24-ний өдөр) “ННН” дэлгүүрт шүүгч П.Д хариуцагч П.О-той таарч ярилцсан нь П.О-ийн гомдол болон шүүгч П.Д-гийн тайлбар зэргээр тогтоогдож

байна. Үүнээс хойш шүүгч П.Д нь хариуцагч П.О-ийн ажиллуулдаг кафены гал тогооны хэрэгсэл (ширээ, сандал, аяга, таваг, хийн плитка, хувин, сав зэрэг)-ийг “үзэх, өгөх, авах эсэх” зэрэг асуудлын талаар П.О-той удаа дараа утсаар ярьжээ (Шүүгч П.Д-гийн 2016 оны 10 сарын 5-ны өдөр Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан нэмэлт тайлбарын 2 дахь хуудас, Сахилгын хэргийн 102 дахь хуудас). Шүүгч П.Д үүнийгээ хүлээн зөвшөөрч дараахыг өгүүлжээ: “Гомдолд дурдсан цаг хугацааны үеэр манай аймагт зохион байгуулагдах дэлхийд данслагдах “ДДД”-ийн баяр болох гээд гадна, дотно зочин гийчин, жуулчин ихтэй ганц надад ч биш аймаг орон нутагт ачаалалтай байсан үед хол ойроос ирсэн ах дүү, төрөл садан, найз нөхдийг байрлуулах түрээсийн байр, хооллуулах газар хайж хэд хэдэн газраар явж, сураглах үед П.О-ийн кафег тохижилт сайн гэж сонссон учир П.О-ийн дугаарыг ахаасаа авч холбогдон түрээслүүлэх байр, кафед нь хоол хийлгэх, хийлгэхгүй, аяга, таваг, хийн плитк, хувин, сав зэрэг гал тогооны зүйлүүдийг түүнээс авах эсэх, буцааж хэзээ өгөх гэх мэт асуудлын талаар П.О-той хүү Б.М-ийн4655 дугаарын, төрсөн эгч П.М-ийн зээ охин хамт амьдардаг А.Н-ийн7907 дугаарын, хүргэн ах Ж.Д-гийн төрсөн дүүгийн хүү мөн тухайн үед хамт амьдарч байсан Б.Б-ийн6771 дугаарын утаснаас дээрх асуудлаар удаа дараа ярьж байгаад П.О-ийн кафены гал тогооны зүйлийг авч хэрэглэсэн юм” гэжээ (Шүүгч П.Д-гийн 2016 оны 6 сарын 20-ны өдөр Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан тайлбарын 2 дахь хуудас, Сахилгын хэргийн 37-38 дахь хуудас).

Шүүгч П.Д П.О-той нэг удаа тохиолдлоор ННН дэлгүүрт уулзаж ярилцжээ. Үүнээс гадна хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас гадуур хоёр удаа өөрөө санаачилж уулзжээ. Шүүгч П.Д П.О-той удаа дараа утсаар ярьж байгаад П.О-ийн кафены гал тогооны хэрэгслийг өөрөө очиж авч, дүү нартаа үнэ төлбөргүйгээр хэрэглүүлсний дараа мөн өөрөө буцаан өгсөн байна (Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдааны 2016 оны 12 сарын 8-ны өдрийн 53 дугаар тэмдэглэлийн 10 дахь хуудас, Сахилгын хэргийн 125 дахь хуудас).

Шүүгч П.Д “Би [П.О-той] холбогдсон, аяга, тавгийг нь хэрэглэсэн” гэдгээ өөрөө хүлээсэн (2016 оны 8 сарын 30-ны өдрийн хуралдааны 108 дугаар тэмдэглэлийн 3 дахь хуудас, Сахилгын хэргийн 77 дахь хуудас) бөгөөд ДДД-ийн баяр үзэх, аялахад нь зориулж дүү нартаа гал тогооны хэрэгслийг хэрэглүүлжээ. Мөн, шүүгч П.О гал тогооны хэрэгслийг хэрэглэхдээ П.О-д үнэ төлбөр өгөөгүй байна. Шүүгч П.Д энэ талаар хэлэхдээ: “Энэ хүнээс аяга тавгийг нь авч хэрэглээд тухайн үед хөлс хүч яахав чи кафедаа эсвэл ажиллуулаад өгөөч би тэр олон хүн хаана хооллуулах юм гээд үнэнээ хэлсэн чинь би тогоо таслуулсан н.Д эгч чадахгүй та хэрэглэх юмаа хэрэглээрэй хөлс хүч нь яах юм гэсэн. Надаас нэг төгрөг ч гараагүй (2016 оны 8 сарын 30-ны өдрийн хуралдааны 108 дугаар тэмдэглэлийн 3 дахь хуудас, Сахилгын хэргийн 77 дахь хуудас).”

Шүүгч П.Д П.О-той удаа дараа утсаар ярьж, уулзаж, гал тогооны хэрэгслийг нь авч хэрэглэсний дараа Ф аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх 2016 оны 3 сарын 10-ны өдрийн 143/ШШ2016/00138 дугаартай шийдвэрээрээ Б.Б-ийн нэхэмжлэлтэй, хариуцагч П.О-д холбогдох хэргийг дахин шийдвэрлэж, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ. Нэхэмжлэгч Б.Б-ийн давж заалдах гомдлоор ФХС аймгийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх (хуучин нэрээр) 2016 оны 5 сарын 11-ны өдөр уг хэргийг хянан хэлэлцэж, анхан шатны шүүхийн 143/ШШ2016/00138 дугаартай шийдвэрийн тогтоох хэсгийн заалтад өөрчлөлт оруулж, 203/МА2016/00041 дугаартай магадлал гаргажээ. Давж заалдах шатны шүүхийн энэхүү хуралдааныг Ерөнхий шүүгч П.Д мөн даргалахын зэрэгцээ уг хэргийг өөрөө илтгэсэн байна.

Шүүгч П.Д нь дээр дурдсан үйлдлүүдээрээ (1) хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзахгүй байх, (2) шүүхийн нэр хүнд, хэрэг хянан

шийдвэрлэх ажиллагаанд сөргөөр нөлөөлөх хувийн харилцаа тогтоохгүй байх, (3) шүүгчээс татгалзахад хүргэх үг яриа, үйлдэл бий болгохгүй байх, (4) хэргийг шударгаар шийдвэрлэхэд үндэслэл бүхий эргэлзээ байвал татгалзан гарах, хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх, (5) хэргийн оролцогчоос тусламж авахгүй байх, (6) шүүгчийн мэргэжлийн үүргээ чухалчлах, (7) зохисгүй байдал гаргахгүй байх бөгөөд тийнхүү ойлгогдохгүй байх, төвийг сахих үүргүүдээ зөрчиж шүүгчийн ёс зүйн ноцтой зөрчил гаргажээ гэж бүрэлдэхүүн дүгнэв. Эдгээр зөрчлийг тус бүрд нь авч үзье.

1. Хэргийн нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай уулзсан тухай:

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль (ШЭЗБТХ)-ийн 27 дугаар зүйлийн 27.1.17-д "хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах"-ыг хориглосон заалтыг шүүгч П.Д зөрчжээ. Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана" гэж заасан. Хуульд захирагдаж хэргийг шийдвэрлэхийн тулд шүүгч нь төвийг сахих зарчмыг баримтлах ёстой. Монгол Улсын Шүүгчийн ёс зүйн дүрэм (ШЁЗД)-ийн 3.2 дугаар зүйлийн 1-д төвийг сахих шүүгчийн үүргийг заасан. Хэргийн аль нэг талтай нөгөө талыг байлцуулахгүйгээр уулзахыг шүүгчид хориглох замаар түүний төвийг сахисан байдлыг хамгаалдаг. Учир нь, шүүгч хэргийн нэг талтай нөгөө талыг байлцуулалгүйгээр уулзсанаар зөвхөн нэг талын үндэслэлийг сонсох эрсдэлтэй бөгөөд уг үндэслэлийг няцаах боломжийг нөгөө талд олгодоггүй. Зөвхөн нэг талын үндэслэлийг сонссоноор шүүгч хууль зүйн болон фактын асуудал дээр алдаатай дүгнэлт гаргах бодит эрсдэлийг бий болгодог. Түүнчлэн, шүүгч нь нэг талтай уулзсанаар авлига эсхүл бусад зүй бус нөлөөнд бодитой автах, эсхүл олон нийтэд тийнхүү ойлгогдох, хардлага төрүүлэх, шүүхэд итгэх бусдын итгэл үгүй болох нөхцөл үүсэх юм. Ийм учир шалтгаанаар, хууль дээдлэх ёстой буюу эрх зүйт төртэй улсад хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзахыг шүүгчид хориглодог. ШЭЗБТХ-ийн 27.1.17-д заасан "хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах" гэдэгт биечлэн уулзах, утсаар ярих, бичих зэрэг аливаа харилцааг багтаадаг.

Хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзахыг хориглосон хориглолт нь хоёр төрлийн хэрэг дээр үйлчилдэг. Нэгд, шийдвэрлэгдээгүй хэргийн нэг талтай нөгөө талыг байцуулахгүйгээр шүүгч уулзаж болохгүй. Шүүхийн процесст хэрэг үүсгэснээс (эхэлснээс) хойш давж заалдах, хяналтын шатаар хянагдаж дуусах (эсхүл гомдол гаргах хугацаа дуусах) хүртэл аливаа хэрэг нь шийдвэрлэгдээгүйд тооцогддог. Жишээлбэл, шүүгчид өөрт нь хуваарилагдан ирсэн хэргийн нэг талтай нөгөө талыг байлцуулахгүйгээр харилцаж болохгүй. Үүнээс гадна бусад шүүгчид хуваарилагдсан шийдвэрлэгдээгүй хэрэгт дээрх хориглолт үйлчилнэ. Учир нь, шүүгч уг хэргийг бүрэлдэхүүнээр шийдвэрлэх эсхүл хянах нөхцөл үүсвэл түүнд оролцох, өмнөх шүүгчээс татгалзсаны дараа өөрт нь дахин хуваарилагдах, илтгэх зэрэг боломж бий учраас төвийг сахих байдлаа хадгалах үүднээс бусад шүүгч дээр байгаа хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай тухайн этгээд нь хэргийн зохигч гэдгийг шүүгч өөрөө мэдэж байгаа нөхцөлд шүүгч харилцаж болохгүй. Түүнчлэн, давж заалдах эсхүл хяналтын шатны шүүх бүрэлдэхүүн хэргийг дахин шийдвэрлүүлэхээр анхан шатны шүүх рүү буцаасны дараа давж заалдах эсхүл хяналтын шатны тухайн бүрэлдэхүүний шүүгч уг хэргийн нэг талтай харилцах нь шийдвэрлэгдээгүй хэргийн нэг талтай нөгөө талыг байлцуулахгүйгээр уулзсанд тооцогдоно.

Хоёрт, шүүхээр хянан шийдвэрлэгдэх нь урьдчилан мэдэгдэж байгаа боловч үүсгээгүй байгаа хэргийн нэг талтай шүүгч харилцах нь зохисгүй гэсэн ойлголтыг төрүүлдэг учраас хориглогддог бөгөөд ШЁЗД-ийн 2.3 дугаар зүйлд "Шүүгч нь зохисгүй байдал гаргаж болохгүй бөгөөд бусдад ийнхүү ойлгогдохоос зайлсхийнэ"

гэж заасан. Үүнийг хориглохгүй бол талууд эсхүл өмгөөлөгчид шүүгч тодорхой үйл баримтад хуулийг хэрхэн хэрэглэх вэ гэдэг талаарх шүүгчийн байр суурийг урьдчилан сонсох, улмаар хөндлөнгийн, төвийг сахисан шүүхээр бус, харин өөрт хамгийн ашигтай шийдэл гаргах шүүх, шүүгчийг сонгож хэргээ шийдвэрлүүлэхийг оролдох эрсдэл үүсгэдэг. Шүүгч шүүхээр шийдвэрлэгдэх нь урьдчилан харагдаж байгаа ч эхлээгүй байгаа хэргийн нэг талтай харилцаж хэргийн агуулгатай холбоотой зөвлөгөө өгсөн бол төвийг сахисан байдлаа алдсан эсхүл тийнхүү ойлгогдох учраас шүүгч уг хэргийг шүүхээр шийдвэрлэхэд оролцохоос татгалзах ёстой.

Шүүгч П.Д нь шийдвэрлэгдээгүй хэргийн нэг тал болох П.О-той нөгөө тал болох Б.Б-г байцуулахгүйгээр удаа дараа утсаар ярьж, гурван удаа биечлэн уулзсан нь ШЭЗБТХ-ийн 27.1.17-д заасан шаардлагыг ноцтой зөрчжээ. Хэргийн нэг тал гэдэгт бие биеийнхээ эсрэг маргаж буй талууд, иргэний хэргийн хувьд зохигчдыг ойлгоно. Шүүгч П.Д П.О-той утсаар ярих, биечлэн уулзах үед П.О нь Б.Б-ийн нэхэмжлэлтэй хэргийн хариуцагч буюу хэргийн нэг тал байсан. Б.Б-ийн нэхэмжлэлтэй хариуцагч П.О-д холбогдох иргэний хэрэг үүсгэгдэж, анхан шатны шүүхээр 2015 оны 11 сарын 13-ны өдөр шийдвэрлэгдсэн бөгөөд зохигчийн давж заалдах гомдлын дагуу уг хэргийг хянаж анхан шатны шүүхэд буцаасан давж заалдах шатны шүүхийн бүрэлдэхүүнд шүүгч П.Д даргалагчаар оролцсон. Уг хэрэг шүүхээр бүрэн шийдвэрлэгдээгүй анхан шатны шүүх рүү буцаагдсан байсан бөгөөд зохигчийн гомдлын дагуу давж заалдах журмаар дахин хянагдвал уг бүрэлдэхүүнд орох үндэслэл бүхий магадлал байсаар байхад шүүгч П.Д хэргийн хариуцагч П.О-той удаа дараа утсаар ярьсан, биечлэн уулзсан байна. Өөрөөр хэлбэл, шүүгч П.Д уг хэргийг анхан, давж заалдах, хяналтын шатаар бүрэн шийдвэрлэгдэж дуусах хүртэл, улмаар тодорхой хугацаанд шүүгч нь хариуцагч төдийгүй нэхэмжлэгч талтай харилцах ёсгүй байсан.

Б.Б-ийн нэхэмжлэлтэй, хариуцагч П.О-д холбогдох хэрэг давж заалдах шатны шүүхээс буцаж, анхан шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хийгдэж байгааг шүүгч П.Д мэдэж байсан бөгөөд үүнийгээ ч хүлээн зөвшөөрч "Нэг дороо байгаа учраас мэдэхээс ч өөр аргагүй" гэж хэлсэн байна (Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдааны 2016 оны 12 сарын 8-ны өдрийн 53 дугаар тэмдэглэлийн 13 дахь хуудас, Сахилгын хэргийн 128 дахь хуудас)." Шүүгч П.Д нь өөрөө даргалсан хуралдаанаараа хэргийг анхан шатны шүүх рүү дахин шийдвэрлүүлэхээр буцаасан бөгөөд давж заалдах журмаар хэрэг нь дахин хянагдах боломжтой, дахин хянагдвал өөрөө бүрэлдэхүүнд нь орох боломжтой байхад хэргийн нэг тал буюу хариуцагч П.О-той удаа дараа утсаар ярьж, гурван удаа уулзсан байна. Дахин давж заалдах гомдол гарсан тохиолдолд шүүгч П.Д уг хуралдаанд оролцох, даргалах нь тодорхой байжээ. Б.Б-ийн нэхэмжлэлтэй, хариуцагч П.О-д холбогдох хэрэг шүүхэд шийдвэрлэгдэж байх үед ФХС аймгийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх (хуучин нэрээр)-д 4 шүүгч ажиллаж байсан бөгөөд Ерөнхий шүүгч хуралдааныг тогтмол даргалахаар шүүгчдийн зөвлөгөөнөөр тогтож, тухайн үеийн Ерөнхий шүүгч П.Д өөрөө хуралдаанаа тогтмол даргалж байжээ (Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдааны 2016 оны 12 сарын 8-ны өдрийн 53 дугаар тэмдэглэлийн 10-11 дэх хуудас, Сахилгын хэргийн 126 дахь хуудас)."

2. Шүүхийн нэр хүнд, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сөргөөр нөлөөлж болох хувийн харилцаа тогтоосон тухай:

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.18-д "шүүгч нь хэргийн оролцогч болон бусад этгээдтэй харилцахдаа шүүхийн нэр хүнд, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сөргөөр нөлөөлж болох хувийн харилцаа тогтоох"-ыг хориглосон байна. Шүүгч П.Д өөрөө П.О-той "тангилын хувиар харилцсан," "найз нөхөд тангилын тохиолдсон асуудлаар хандсан хандлага байсан, гуйсан" гэдгээ

зөвшөөрсөн (Шүүгч П.Д-гийн 2016 оны 10 сарын 5-ны өдрийн Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанд гарсан давж заалдах гомдлын 2 дахь хуудас, Сахилгын хэргийн 27 дахь хуудас; 2016 оны 12 сарын 8-ны өдрийн Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдааны 53 дугаар тэмдэглэлийн 3, 12 дахь хуудас, Сахилгын хэргийн 118, 127 дахь хуудас). Мөн, шүүгч П.Д 2016 оны 10 сарын 5-ны өдөр Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанд гаргасан давж заалдах гомдлынхоо 2 дахь хуудаст “би гомдол гаргагч П.О-той 2016.2.24-нд тааралдаж, ярилцсан, өөрийнх нь кафены хэрэгслийг дүү нартаа /үнэ төлбөргүйгээр/ зуучлан хэрэглүүлэхээр түүнтэй удаа дараа утсаар ярьсан зэрэг нь танилын хувиар харилцсан ба гомдол гаргагч П.О-д хариуцагдах иргэний хэрэг 2016.01.25-ны өдөр анхан шатны шүүхэд очсон байсан” гэж бичжээ.

Шүүгч П.Д хэргийн оролцогч болох хариуцагч П.О-той удаа дараа утсаар ярьж, гурван удаа уулзаж, түүний гал тогооны хэрэгслийг авч дүү нартаа үнэ төлбөргүйгээр хэрэглүүлж буцааж өгснөөрөө шүүх хараат бус, төвийг сахиж, шударгаар ажилладаг гэсэн олон нийтийн итгэлийг унагаж, шүүхийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөх хувийн харилцаа үүсгэжээ. Ингэснээр шүүгч өөрийн хянан шийдвэрлэсэн хэргийн оролцогчтой өөрөө санаачилж харилцдаг, үнэ төлбөргүй тусламж гуйдаг, авдаг гэсэн ойлголтыг олон нийтэд төрүүлсэн төдийгүй ийм зөрчлийг бодитой гаргажээ. Мөн, шүүгч П.Д-гийн дээрх үйлдлүүд нь түүнийг татгалзах үндэслэлийг бодитой бий болгосон учраас үүнийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сөргөөр нөлөөлж болох хувийн харилцаа тогтоосон гэж үзэв.

3. Шүүгчээс татгалзахад хүргэх үг яриа, үйлдэл гаргасан

Шүүгч П.Д нь Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 2-т “Хэргийн оролцогчдын зүгээс шүүгчийг татгалзахад хүргэх нөхцөл байдлыг өөрийн үг яриа, үйлдлээр бий болгохоос урьдчилан сэргийлж, зайлсхийнэ” гэж заасныг мөн зөрчсөн байна. Учир нь, шүүгч П.Д нь давж заалдах журмаар хянахад оролцсон хэргийн хариуцагч П.О-той удаа дараа утсаар ярьж, гурван удаа уулзсан, гал тогооны хэрэгсэл авч бусдын хувийн ашиг сонирхол (дүү нарынхаа ДДД баяр үзэж амрах хэрэгцээ)-ын төлөө хэрэглүүлсэн нь хожим уг хэргийг давж заалдах журмаар дахин хянан хэлэлцэх үед шүүгч П.Д төвийг сахиж, шударгаар шийдвэрлэх эсэхэд үндэслэл бүхий эргэлзээ үүсгэсэн. Тиймээс, татгалзан гарах үр дагавар бий болгох үйлдэл гаргажээ.

4. Татгалзан гаргаагүй тухай: Дээрх байдлаар П.О-той харилцсан, тусламж авсан боловч шүүгч П.Д 2015 оны 5 сарын 11-ний өдөр ФХС аймгийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх /хуучин нэрээр/ хуралдааныг даргалахын зэрэгцээ өөрөө илтгэж хэргийг шийдвэрлэсэн байна. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.1.3-т шүүгч “хэргийн оролцогчтой хувийн харилцаатай түүнчлэн уг хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал” шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болохгүй гэж хуульд зааж зохицуулсан. Шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болохгүй талаар үндэслэлээ өөрөө танилцуулах үүрэгтэй. Гэвч, шүүгч П.Д нь хэргийн оролцогч П.О-той хэрэг хянан шийдвэрлэх явцад танилын хувиар удаа дараа утсаар ярьж, гурван удаа уулзсан, гал тогооны хэрэгслийг авч хэрэглэсэн учраас тухайн хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ үүсгэжээ. Ийм хувийн шинж чанартай харилцаа нэгэнт үүссэн учраас тухайн хэргийг шүүгч П.Д төвийг сахисан байр сууринаас шударгаар шийдвэрлэхэд эргэлзэх үндэслэлтэй бөгөөд жирийн иргэний хувьд тийнхүү ойлгогдохоор байсан учраас уг хэргийг давж заалдах журмаар хянах хоёр дахь хуралдаанд 2016 оны 5 сарын 11-ний өдөр оролцох, илтгэх, даргалахаас татгалзах ёстой байжээ. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх

тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.1.3-д заасан үндэслэлээр шүүгч татгалзан гараагүй нь ШЁЗД-ийн 3.3 дугаар зүйлийн 1-д “Шүүгч хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй” гэж заасныг давхар зөрчсөн байна.

5.Хэргийн оролцогчоос тусламж авч давуу байдал бий болгосон тухай:

Шүүгч П.Д нь Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүгч хэргийн оролцогч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдтэй хувийн харилцаа тогтоох, шууд болон шууд бусаар тусламж авах, хувьдаа ашиг олох, төлбөргүй буюу хөнгөлөлттэйгөөр үйлчлүүлэх зэрэг хууль бус хангамж эдлэх зэргээр албан тушаалын нэр хүндийг ашиглан ямар нэгэн давуу байдал бий болгохыг хориглоно.” гэж заасныг мөн зөрчжээ. Юуны өмнө, шүүгч П.Д нь хэргийн оролцогч П.О-той удаа дараа утсаар ярьсан, гурван удаа уулзсан, тусламж гуйсан учраас түүнтэй хувийн харилцаа тогтоосон талаар дээр дүгнэсэн.

Шүүгч П.Д хэргийн оролцогч П.О-оос ДДД-ийн баярыг дүү нартаа үзүүлэхэд зориулан гал тогооны хэрэгсэл авч хэрэглүүлсэн нь тусламж авч давуу байдал бий болгосонд тооцогдоно. П.О үнэ төлбөргүйгээр гал тогооны хэрэгслийг шүүгч П.Д-д өгч хэрэглүүлсэн нь тухайн хэргийг анхан шатны шүүх дахин шийдвэрлэсний дараа давж заалдах шатанд хянагдвал уг хуралдааныг даргалах Ерөнхий шүүгч П.Д-д нөлөөлөх зорилготой байсан гэж харагдах эрсдэлийг үүсгэжээ. Өөрөөр хэлбэл, шүүгч П.Д энэ үйлдлээрээ П.О өөрийнх нь шийдвэрт нөлөө үзүүлэхүйц байр суурьтай гэсэн ойлголтыг бий болгожээ.

Шүүгч П.Д нь шүүгчийн албан тушаалын нэр хүндийг ашиглаж хэргийн оролцогч П.О-оос гал тогооны хэрэгсэл гуйсан бөгөөд тусламж авч, төлбөргүйгээр дүү нартаа хэрэглүүлжээ. Өөрөөр хэлбэл, дүү нарынхаа ДДД-ийн баяр үзэх, амрах хувийн ашиг сонирхлыг хангахад шүүгчийн нэр хүндийг ашиглаж П.О-той харилцаж, тусламж авсан үйл баримт тогтоогдож байна.

6.Шүүгчийн мэргэжлийн үүргээ чухалчлаагүй талаар

ШЁЗД-ийн 3.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь шүүгчийн өөр бусад ажлаас ямагт илүү чухал гэдгийг ухамсарлаж, түүний эрхлэх бусад үйл ажиллагаа, хувийн амьдрал нь мэргэжлийн үүрэгтэй нь зөрчилдөх нөхцөл байдал бий болохоос зайлсхийнэ” гэсэн заалтыг шүүгч П.Д мөн зөрчжээ. Учир нь, шүүгч П.Д өөрийн дүү нартаа ДДД-ийн баярт туслах нь шүүгч П.Д-гийн хувийн амьдралын асуудал мөн боловч хянасан болон дахин хянах боломжтой эцэслэн шийдвэрлэгдээгүй хэргийн нэг тал болох П.О-оос гал тогооны хэрэгсэл авч дүү нартаа хэрэглүүлсэн нь түүний шүүгчийн төвийг сахих, шүүхийн нэр хүндийг эрхэмлэх зэрэг мэргэжлийн үүрэгтэй зөрчилдөх нөхцөл байдлыг үүсгэсэн байна. Өөрөөр хэлбэл, шүүгч П.Д шүүгчийн мэргэжлийн үүрэг нь дүү нартаа туслахаас илүү чухал гэдгийг ухамсарлаж, хэргийн нэг талаас гал тогооны хэрэгсэл гуйхгүй, авч хэрэглүүлэхгүй, уулзахгүй байх ёстой байжээ.

7.Зохисгүй байдал гаргасан, төвийг сахиагүй

ШЁЗД-ийн 2.3 дугаар зүйлд “Шүүгч нь зохисгүй байдал гаргаж болохгүй бөгөөд бусдад ийнхүү ойлгогдохоос зайлсхийнэ” гэж заасан. Энэ зүйлийн ишлэлд зохисгүй байдал гэдгийг Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1.9д тодорхойлсон утгаар ойлгоно гэж заасан байх бөгөөд энэ 1.9-д “Зохисгүй байдал” гэж хууль, хянан шийдвэрлэх ажиллагааны хэм хэмжээ, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийг зөрчсөн, эсхүл шүүгчийн хараат бус, зарчимч, төвийг сахих байдлыг алдагдуулсан аливаа үйлдэл, эс үйлдэхгүйг ойлгоно гэжээ. Шүүгч П.Д нь хэргийн оролцогч П.О-той удаа дараа утсаар ярьж, уулзаж, үнэ төлбөргүй тусламж гуйж, авснаараа ШЭЗБТХ болон ШЁЗД-ийн дээр дурдсан заалтуудыг ноцтой зөрчиж шүүгч шүүгчийн хараат бус, зарчимч, төвийг сахих байдалд итгэх олон нийтийн итгэлийг хөсөрдүүлсэн

зохисгүй байдал гаргажээ. Үүгээрээ шүүгч П.Д нь ШЁЗД-ийн 3.2 дугаар зүйлийн 1-д заасан “хэргийн оролцогчдод эрх тэгш, төвийг сахисан” ёсоор хандах үүргээ зөрчсөн байна.

Хөөн хэлэлцэх хугацаа тасалдсан тухай

Шүүгч П.Д-гийн өмгөөлөгч Х.Ц нийт гишүүдийн хуралдаан дээр Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5.17-д “Шүүгчид холбогдох сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш зургаан сар, зөрчил гарснаас хойш нэг жил өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулахгүй” гэж заасан учраас шүүгч П.Д-д сахилгын шийтгэл ногдуулж болохгүй талаар хэлсэн нь үндэслэлгүй байна. Учир нь, Шүүхийн Ёс зүйн хороо Шүүгчийн ёс зүйн дүрэмд дурдсан хөөн хэлэлцэх хугацааны дотор гомдлыг хүлээн авснаар Иргэний хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэгт зааснаар хөөн хэлэлцэх хугацаа тасалдана гэж Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол³ болон Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалаар⁴ удаа дараа шийдвэрлэж байсан. Иймд, шүүгч П.Д 2016 оны 2 сараас 5 сард явуулсан үйл ажиллагаагаараа шүүгчийн ёс зүйн зөрчил гаргасан гэх гомдлыг гомдол гаргагч П.О 2016 оны 5 сарын 17-ны өдөр буюу дээр дурдсан хөөн хэлэлцэх хугацааны дотор Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан байх тул хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн гэж үзэхгүй юм. Мөн, Шүүхийн Ёс зүйн хороо нь шүүгчийн ёс зүйн зөрчил гаргасан шүүгчид сахилгын шийтгэл ногдуулахад хөөн хэлэлцэх хугацаа үйлчлэхгүй тухай хэд хэдэн шийдвэр гаргаж байсныг дурдах нь зүйтэй⁵.

Цалинг бууруулах сахилгын шийтгэл оногдуулах тухай

Дээр дурдсанчлан шүүгч П.Д нь ШЭЗБТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1.17, 27.1.18, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.1.3, ШЁЗД-ийн 2.3 дугаар зүйл, 3.1 дүгээр зүйлийн 1, 2, 3.2 дугаар зүйлийн 1, 3.3 дугаар зүйлийн 1, 2-т заасан үүргүүдээ зөрчиж шүүгчийн ёс зүйн ноцтой зөрчил гаргасан байна. Тиймээс, шүүгч П.Д-д зургаан сарын хугацаагаар цалинг 30 хувиар бууруулах сахилгын шийтгэл (арга хэмжээ) ногдуулах нь зүйтэй гэж бүрэлдэхүүний олонх дүгнэв.

Сахилгын хэргийг дахин хэлэлцсэн бүрэлдэхүүний олонх шүүгч П.Д гийн үйлдсэн зөрчил нь шүүгчийн ёс зүйн ноцтой зөрчил мөн боловч түүнийг огцруулах шийтгэл ногдуулах хэмжээний ноцтой бус гэж үзсэн. Иймд, Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2017 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 320 дугаар тогтоолд дурдсан шүүгчид огцруулах сахилгын шийтгэл ногдуулахтай холбоотой хуулийн заалтууд, тухайлбал Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.4.2, уг хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.3, 37.2, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйлийг хэрхэн хэрэглэх талаар тайлбарлах, дүгнэлт хийх шаардлагагүй гэж үзэв.

Гомдолд дурсан бусад асуудлын талаар

Шүүгч П.Д П.О-оос 1 сая төгрөг өгч авсан, 20 сая төгрөг нэхсэн эсэх талаар гомдолд дурдсан байдаг. Эдгээр асуудлаар мөрдөн байцаалт явуулах, нотлох баримт цуглуулах эрх Шүүхийн Ёс зүйн хороонд олгогдоогүй, шалгаж тогтоох боломжгүйгээс гадна Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй тул эдгээртэй холбоотой нотлох баримтыг холбогдох хууль, хяналтын байгууллагад шилжүүлэхээр Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 8 сарын 30-ны өдрийн 108 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн нь зөв болжээ. Энэ тогтоолын дагуу эдгээр асуудлыг харьяаллын дагуу ЧЧЧ газар руу шилжүүлсэн нь Иргэдээс

3 Жишээлбэл, Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2016.10.12-ны өдрийн 297 дугаар тогтоол.

4 Жишээлбэл, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016.07.01-ний өдрийн 221/ЁМ2016/0017 дугаартай магадлал.

5 Жишээлбэл, Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2016.05.20-ны өдрийн 34 дүгээр магадлал

төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 3-т “өөрийн эрх хэмжээнд хамаарахгүй бөгөөд албан ёсоор нийтэд зарласан асуудлаар гаргаагүй өргөдөл, гомдлыг харьяалах газар нь 3 хоногийн дотор шилжүүлнэ” гэж заасанд нийцжээ. ЧЧЧ газар болон бусад холбогдох байгууллагаас уг асуудлыг шийдвэрлэсний дараа Шүүхийн Ёс зүйн хороонд уг асуудлаар дахин гомдол гаргах эрх нь гомдол гаргагч П.О-д нээлттэй болохыг тэмдэглэх нь зүйтэй.

“Иргэн П.О надтай өөрөө ярьж танилцан, надаас элдэв тусламж хүсэж байсан” шүүгч П.Д 2016 оны 5 сарын 11-ний өдрийн давж заалдах шатны шүүх “хуралдааныг даргалан, өөрөө илтгэн, хуралдааны явцад илт намайг буруутгаж, Б.Б-д давуу байдал олгосоор байгаад нэхэмжлэлийн шаардлагаас огт үндэслэлгүйгээр 79 сая төгрөгийг надаас гаргуулахаар шийдвэрлэлээ” гэж П.О гомдолдоо бичжээ. Шүүхийн ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаан Шүүгч П.Д-гийн хүсэлтийн дагуу 2016 оны 5 сарын 11-ний өдрийн шүүх хуралдааны бичлэг, тэмдэглэлд үзлэг хийлгэж шалгасан боловч шүүгч П.Д энэ хуралдааны явцад хариуцагч П.О-г илт буруутгасан, нэхэмжлэгч Б.Б-д давуу байдал олгосон хандлага гаргаагүй байна. Тийм учраас, гомдлын энэ хэсгийг нотлогдоогүй гэж бүрэлдэхүүн үзэв.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35, 36 дугаар зүйл, 37 дугаар зүйлийн 37.1.2, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйл, Шүүхийн ёс зүйн хорооны дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.1, 5.13-т заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Ф аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч П.Д-д зургаан сарын хугацаагаар 30 хувиар цалинг бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Энэ магадлалын хувийг шүүгч болон гомдол гаргагчид хүргүүлэхийг Ажлын албанд даалгасугай.

3.Шүүгч, гомдол гаргагч нар магадлалыг гардан авснаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ОИХ.МН
СУДАЛГААНЫ САН

ДАРГАЛАГЧ

Н.ЭРДЭНЭЦОГТ

ГИШҮҮН

О.МӨНХСАЙХАН



МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЁС ЗҮЙН ХОРООНЫ МАГАДЛАЛ

2017 оны 11 сарын 17 өдөр

Дугаар 64

Улаанбаатар хот

А дүүргийн Иргэний хэргийн анхан шатны
шүүхийн шүүгч Х.Э-д сануулах
сахилгын шийтгэл ногдуулах тухай

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааныг Шүүхийн Ёс зүйн хорооны дарга Н.Эрдэнэцогт даргалж, гишүүн Н.Ганбаяр, А.Доржготов, О.Мөнхсайхан, Ч.Оюунцэцэг, Д.Сүнжид, Э.Энхтуяа, В.Жавхлан нарын бүрэлдэхүүнтэй, хяналтшалгалт хариуцсан референт Б.Энхбаатар, хуралдааны тэмдэглэл хөтлөгчөөр шинжээч А.Энхбаатар, гомдол гаргагч өмгөөлөгч Г.Б, шүүгч Х.Э нарыг оролцуулан, Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдааны танхимд хийж, шүүгч Х.Э-д сахилгын хэрэг үүсгэсэн Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 9 дүгээр сарын 08-ны өдрийн 144 дүгээр тогтоолыг ёс зүйн хорооны гишүүн В.Жавхлангийн илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Шүүхийн Ёс зүйн хороонд өмгөөлөгч Г.Б гаргасан гомдол болон хуралдаанд гаргасан тайлбартаа: “А дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Х.Э нь “ССС” ХХК-ийн нэхэмжлэлтэй “ННН” ХХК-д холбогдох ерөнхий захирлыг томилсон тогтоолтой холбоотой маргааныг хянах явцдаа нэхэмжлэгч талаас гаргасан ТТТ улсын иргэн Ш-ийг Монгол Улсын хилээр гарах хөдөлгөөнд хилийн хориг тавьж /түдгэлзүүлж/ өгнө үү” гэх хүсэлтийг 2017.05.24-ний өдрийн 102/ШЗ2017/07373 тоот захирамжаар шийдвэрлэжээ.

Уг захирамж нь илтэд үндэслэл муутай, нэг талд үйлчилсэн түүнд давуу ашиг сонирхлын зөрчлийг агуулсан бусдад нөлөөлөх байдлыг бий болгосон, нэг талыг хууль ёсны эрх ашгийг бодитойгоор хохироосон байх тул дараах үндэслэлээр гомдол гаргаж байна.

Шүүгч хүсэлт шийдвэрлэх тухай захирамж гаргаж, захирамжийн үндэслэх хэсэгтээ “... иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд хариуцагч, түүний төлөөлөгчийн хилээр гарах эрхийг хориглох хуулийн зохицуулалт байхгүй юм. ...” хэмээн гадаадын иргэний хилээр орж гарах хууль ёсны эрх ашиг сонирхлыг зөрчих эрх иргэний шүүхэд байхгүй гэдгийг тодорхойлсон мөртөө үндэслэх болон захирамжлах хэсэгтээ Ш-г Монгол Улсын хилээр гарахыг түдгэлзүүлэхийг хүссэн хүсэлтийг хүлээн авч, уг хүсэлтийг Иргэний харьяалал шилжилт, хөдөлгөөний ерөнхий газарт хүргүүлэх нь зүйтэй гэж үзэв ... гэж захирамжилсан гадаадын иргэний эрх Ш-ийн ашиг сонирхлыг ноцтой зөрчсөн. Гадаадын иргэн, харьяатын газарт нөлөөлсөн захирамж болсон байна. Хэдийгээр шүүгч “... бичиг буюу хүсэлт хүргүүлсэн захирамж гаргасан.. надад хүний хилээр гарах эрхийг хязгаарлах эрх байхгүй...” гэсэн байр суурьтай байгаа боловч бусдын хүсэлтэд санаа тавин эрх бүхий байгууллагад хүргүүлж байгаа, захирамжаа ойлгомжгүй байдлаар гаргаж харьяаллын бус хүсэлтийг

хаана гаргах ёстойг зөвлөн эрх бүхий байгууллагад хүргүүлж байгаа нь шүүхэд хэзээ ч байхгүй шуудан хүргэгчийн үүрэг гүйцэтгэсэн нь Ш-д нөхцөл байдлыг үүсгэсэн.

Шүүгчийн энэхүү захирамжийг “иргэний хилээр гарах эрхийг хориглосон захирамж” гэж ойлгосон гэдгээ нотлон Гадаадын иргэн харьяатын газар / ГИХГ/-ын даргын 2017.06.07-ний өдрийн А/273 тоот тушаал гарсан.

Мөн “... Энэхүү захирамжийг нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хүсэлтийн хамт Иргэний харьяалал шилжилт, хөдөлгөөний ерөнхий газарт хүргүүлэх ажиллагааг хийж гүйцэтгэхийг шүүгчийн туслах Д.Г-д даалгасугай ... гэж захирамжлах хэсэгтээ эрх бүхий байгууллагын нэр усыг буруу бичсэн болон захирамжлах хэсэгтээ дурдаад байгаа “... захирамжийг ... хүсэлтийн хамт ... хүргүүлэх ...” гэснээ зөрчин ганцхан захирамжийг хүргүүлсэн нь Гадаадын иргэн харьяатын газрыг төөрөлдүүлэх санаа зорилгыг Х.Э анхнаасаа агуулсан байгааг харуулж байна.

Гадаадын иргэн харьяатын газар “...бид төөрөлдсөн ...” гэдгээ нотлон ярихдаа “... шүүгч хэрвээ гадаадын иргэний хилээр гарах эрхийг хязгаарлаагүй бол юу гэж бидэнд захирамжийг хүргүүлэх юм бэ ... мөн иргэний маргаанд оролцож байгаа нэхэмжлэгчийн хүсэлтийг бидэнд хүргүүлээгүй ... уг нь бол хуулийн этгээдийн маргаанд иргэн хамааралгүй гэдгийг бид ойлгож байгаа ... гэхдээ бид одоо тушаалаа хүчингүй болговол ... бид гадаадын иргэний хохирлыг төлөх эрсдэлд хүрнэ ...” гэх мэтчилэн тайлбарлаж байгаа нь шүүгч Х.Э албан үүргийн хувиар оногдоогүй хийх ёсгүй үйлдлийг үйлдэж Гадаадын иргэн харьяатын газарт нөлөөлсөн байгааг харуулж байна. Гадаадын иргэн харьяатын газар нэхэмжлэгчийн хүсэлт хүргүүлсэн захирамжийг буруу ойлгосон гэдгээ нотлон тушаалын 1 дэх хэсэгт “... А дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2017.05.24-ний өдрийн 102/Ш32017/07373 дугаарын захирамжийн дагуу...” гэсэн бөгөөд 2 дахь хэсэгтээ “... А дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх /Х.Э/... мэдэгдэн...” гэснээр нотлогдож байгаа. Энэ тухай Гадаадын иргэн харьяатын газар болон манай зүгээс шүүгчид хандан захирамжаа зөвтгөн тайлбарлахыг удаа дараа хүссэн боловч тэрээр нөхцөл байдлыг сайтар мэдэж байгаа боловч нэхэмжлэгч талд ашигтай байдал үүсгэн биднийг хохироох байдлаар хүнд суртал гарган өнөөдрийг хүртэл таг чимээгүй байна.

Энэ нь Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.4.1.11, 1.4.1.9, 1 мөн дүрмийн дөрөвдүгээр ангийн 15 дугаар бүлгийн 15.3.1, 15.6.3, 15.6.4, 15.10.1, 15.10.4 хэсэг, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27.1.1, 27.1.6 хэсэг Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2, 5.1, 6.1, 7.2, 9.1, 14.1.1-д заасан болон бусад холбогдох заалтуудыг ноцтойгоор зөрчсөн байна.

Хуулийн этгээдүүдтэй холбоотой маргаанд Ш-ийн зүгээс саад учруулсан зүйлгүй бөгөөд уг маргаанд “ННН” ХХК-ийг төлөөлөн 2 итгэмжлэгдсэн төлөөлөгч болон өмгөөлөгч оролцож байгаа бөгөөд тэрээр энэхүү маргааны оролцогч биш байхад шүүгч бусдын нөлөөнд автаж ийм үйлдэл гаргасан гэж үзэхэд хүрч байна. Иймд Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 31.1 дэх хэсэгт заасны дагуу Х.Э шүүгчид хариуцлага тооцож өгнө үү.

Жич: Нэхэмжлэгчээс гаргасан Монгол Улсын хилээр гарахыг түр түдгэлзүүлэхийг хүссэн хүсэлтийг хүлээн авч, Гадаадын иргэн харьяатын газарт хүргүүлэх үүрэг байхгүй. Мөн Монгол Улсад Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар гэсэн байгууллага байхгүй, харин Гадаадын иргэн, харьяатын газар гэсэн нэртэй байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа болно. Хариуцагч талаас иргэний хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Ц.Ц-г оролцуулахаар итгэмжлэл олгосон нь энэ хэрэгт Ш-г заавал байлцуулах

шаардлагагүй гэж үзэхээр байна. Мөн шүүгч нь нэхэмжлэгчийн хүсэлтийг хүлээн авч хангаж шийдвэрлэсэн эсвэл, хүргүүлээд байгаа нь тодорхойгүй байдлаар зориуд захирамж гаргаж үүнийгээ мэдсээр байж арилгах арга хэмжээ авахгүй байгаа нь түүнд хариуцлага тооцох үндэслэл бий болсныг харуулж байна.”гэв.

Шүүхийн ёс зүйн хороонд шүүгч Х.Э ирүүлсэн тайлбартаа: “А дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Х.Э би, өмгөөлөгч Г.Б-ийн Шүүхийн ёс зүйн хороонд гаргасан гомдлыг 2017 оны 6 дугаар сарын 27-ны өдөр гардан авч, танилцаад дараах тайлбарыг гаргаж байна.

Нэхэмжлэгч “ССС” ХХК нь хариуцагч “ННН” ХХК болон “ННН” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд холбогдуулан тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 01/16 тоот “ННН” ХХК-ийн Ерөнхий захирлыг сонгох” тухай тогтоолыг хүчингүй болгуулахыг хүссэн нэхэмжлэлийг тус шүүхэд 2017 оны 5 дугаар сарын 04-ний өдөр гаргасан.

Шүүгч миний бие нэхэмжлэлийг хүлээн авч, 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 102/ШЗ2017/06657 дугаартай захирамжаар иргэний хэрэг үүсгэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсан.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад буюу 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдөр болон 5 дугаар сарын 19-ний өдөр нэхэмжлэгч талаас шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулахыг хүссэн хүсэлтийг, 2017 оны 5 дугаар сарын 19-ны өдөр хариуцагчийн төлөөлөгчийн хилээр гарах хөдөлгөөнд хориг тавиулах тухай хүсэлтийг тус тус гаргасан.

Шүүгчийн 2017 оны 5 дугаар сарын 24-ны өдрийн 102/ШЗ2017/07374 дугаартай захирамжаар нэхэмжлэгчийн хүсэлтийн дагуу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт заасны дагуу шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулж шийдвэрлэсэн.

Мөн 2017 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 102/ШЗ2017/07373 дугаартай захирамжаар нэхэмжлэгч талын гаргасан хариуцагч “ННН” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх захирал2095 паспортын дугаартай, ТТТ улсын иргэн Ш-г Монгол Улсын хилээр гарахыг түр түдгэлзүүлэхийг хүссэн хүсэлтийг хүлээн авч, Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газарт хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийн оролцогчид нь тайлбар өгөх, хүсэлт гаргах байдлаар өөрийн байр суурь, хүсэл зоригийг илэрхийлэн оролцдог.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлд хэргийн оролцогчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эдлэх эрхийг тодорхойлсон бөгөөд мөн зүйлийн 25 дугаар зүйлийн 25.1.8-д “хуульд заасан бусад эрх” гэж зохицуулсан тул энэ эрхийг зөвхөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар хязгаарлан ойлгох боломжгүй юм.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2-т гадаадын иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлэх үндэслэлүүдийг заасан ба эдгээр үндэслэлүүд нь эрүүгийн болон иргэний хэрэг маргааны процесс ажиллагаатай холбоотойгоор тухайн процесс ажиллагаа дуусах хүртэл хугацаанд хамаарахаар зохицуулагдсан байна.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1-д “гэмт хэрэгт сэжигтэн, яллагдагчаар татагдсан бол эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн тухайн хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл”, 34.2.2-т “шүүхээр ял шийтгүүлсэн бол ялаа эдэлж дуусах буюу ялаас чөлөөлөх, эсхүл тухайн гадаадын иргэнийг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу харьяалах улсад нь шилжүүлэх хүртэл” гэж тус тус заасан нь нийтийн эрх ашгийг хамгаалах зорилгоор Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх, ял эдлүүлэх

ажиллагаа явуулах хугацаагаар гадаадын иргэнийг Монгол Улсын хилээр гаргахыг түдгэлзүүлэхээр зохицуулсан байна. Мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.3-д “тухайн гадаадын иргэн өөрийнх нь эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хохироож байгаа тухай бусад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас өргөдөл, гомдол гаргасан бөгөөд эрх бүхий байгууллага үүнийг үндэслэлтэй гэж үзсэн бол асуудлыг шийдвэрлэх хүртэл” гэж заасан үндэслэлийг хуулийн 34.2.1, 34.2.2 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд гэж ойлгохоор байгаа буюу хохироосон этгээдтэй холбоотой зөрчигдсэн эрхээ сэргээлгэх Иргэний эрх зүйн харилцаанд уг үндэслэл нь хамаарч байна.

Мөн зүйлийн “эрх бүхий байгууллага” гэдэгт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсэн тухайгаа мэдүүлэхэд түүнийг шийдвэрлэх эрх бүхий байгууллагыг ойлгох бөгөөд Иргэний эрх зүйд бусдын эрх, ашиг сонирхол зөрчигдсэн талаарх маргааныг гагцхүү шүүх шийдвэрлэдэг тул эрх бүхий байгууллагад шүүх хамаарна.

Нэхэмжлэгч “ССС” ХХК нь эрх, ашиг сонирхлоо зөрчигдсэн гэж үзэж шүүхэд нэхэмжлэлээ гаргасан. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.3-т заасны дагуу хариуцагч компанийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээд болох ТТТ улсын иргэн Ш-г Монгол Улсын хилээр гарах хөдөлгөөнийг түр түдгэлзүүлэх тухай хүсэлтийг хүлээн авч, “Гадаадын иргэнийг Монгол Улсаас гарахыг түр түдгэлзүүлэх тухай шийдвэрийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны дарга холбогдох байгууллагын саналыг үндэслэн гаргана” гэж зохицуулсны дагуу нэхэмжлэгчийн хүсэлтийг холбогдох байгууллагад нь хүргүүлсэн болно.

Өөрөөр хэлбэл нэхэмжлэгчийн гаргасан дээрх хүсэлтийн дагуу хариуцагчийн төлөөлөгч Ш-г Монгол Улсын хилээр гарахыг түр түдгэлзүүлэх тухай хүсэлтийг шийдвэрлэх эрх бүхий байгууллага руу хүргүүлсэн.

Гадаадын иргэн, харьяатын газрын 2017 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 1-03/2112 тоотоор ...шүүгчийн 102/Ш32017/07373 дугаартай захирамжийг үндэслэн дээр нэр дурдсан гадаадын иргэний Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлсэн шийдвэр гаргаагүй болно гэсэн хариу ирсэн. Үүний дагуу дахин ямар нэгэн захирамж, албан тоотыг тус байгууллагад дахин хүргүүлээгүй. Гэтэл 2017 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 01/2255 дугаартай албан тоотоор ТТТ улсын иргэн Ш-г Монгол Улсын хилээр гарах хөдөлгөөнийг түр түдгэлзүүлэх тухай шийдвэр гаргасан талаар мэдэгдсэн.

Шүүгч миний бие гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны дотоод дүрэм, журмыг мэдэхгүй бөгөөд тэнд гомдол гаргагчид тайлбарласан тайлбар болон үйл ажиллагаанд миний бие тайлбар өгөх эрхгүй юм.

Мөн 2017 оны 6 дугаар сарын 13-ны өдөр хариуцагч талаас шүүгчийн 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 102/Ш32017/07373 дугаартай шүүгчийн захирамжийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 124 дүгээр зүйлийн 124.1 дэх хэсэгт заасныг баримтлан хүчингүй болгуулахыг хүссэн хүсэлтийг гаргасан.

Шүүгчийн 2017 оны 5 дугаар сарын 24-ны өдрийн 102/Ш32017/07374 дугаартай захирамжаар нэхэмжлэгчийн хүсэлтийн дагуу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт заасны дагуу шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулж шийдвэрлэснийг хариуцагч тал эс зөвшөөрч, 2017 оны 6 дугаар сарын 02-ны өдөр гомдол гаргасны дагуу тус хэрэгт гомдол хянан шийдвэрлэх ажиллагаа явагдахаар хэрэг Ерөнхий шүүгч М.Б-д шилжсэн бөгөөд өнөөдрийн байдлаар гомдол хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгаагүй байгаатай холбогдуулан хэрэг шүүгч

над дээр ирээгүй тул хариуцагч талаас 2017 оны 6 дугаар сарын 13-ны өдөр гаргасан хүсэлтийг шийдвэрлээгүй байна.

Шүүгч миний бие дээрх захирамжийг гаргаснаараа Шүүгчийн ёс зүйн дүрэмд заасан зөрчлийг гаргаагүй болно.

Иймд өмгөөлөгч Г.Б-ийн гомдолд сахилгын хэрэг үүсгэхээс татгалзаж өгнө үү.” гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны гомдол хянан хэлэлцэх хуралдаанаар хэлэлцээд ҮНДЭСЛЭХ нь:

Өмгөөлөгч Г.Б “А дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Х.Э нь “ССС” ХХК-ийн нэхэмжлэлтэй “ННН” ХХК-д холбогдох ерөнхий захирлыг томилсон тогтоолтой холбоотой маргааныг хянах явцдаа нэхэмжлэгч талаас гаргасан ТТТ улсын иргэн Ш-ийг Монгол Улсын хилээр гарах хөдөлгөөнд хилийн хориг тавьж /түдгэлзүүлж/ өгнө үү” гэх хүсэлтийг 2017.05.24-ний өдрийн 102/ШЗ2017/07373 тоот захирамжаар шийдвэрлэжээ. Уг захирамж нь илтэд үндэслэл муутай, нэг талд үйлчилсэн, түүнд давуу ашиг сонирхлын зөрчлийг агуулсан бусдад нөлөөлөх байдлыг бий болгосон, нэг талыг хууль ёсны эрх ашгийг бодитойгоор хохироосон” гэх гомдлыг Шүүхийн ёс зүйн хороонд гаргажээ. Энэхүү гомдлыг шалгасан дүнг хянаж Шүүхийн ёс зүйн хорооны 2017 оны 9 дүгээр сарын 08-ны өдрийн 144 дугаартай тогтоолоор шүүгч Х.Э-д сахилгын хэрэг үүсгэсэн бөгөөд шүүгч Х.Э Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанд 2017 оны 10 дугаар сарын 20-ны өдөр гомдол, 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр нэмэлт тайлбар тус тус гаргажээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанаар сахилгын хэргийг хянан хэлэлцээд тус хорооны 144 дугаар тогтоолыг үндэслэлтэй гэж үзэв.

Нэхэмжлэгч “ССС” ХХК нь хариуцагч “ННН” ХХК болон “ННН” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд холбогдуулан тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 01/16 тоот “ННН” ХХК-ийн Ерөнхий захирлыг сонгох тухай тогтоолыг хүчингүй болгуулахыг хүссэн нэхэмжлэлийг А дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд 2017 оны 5 дугаар сарын 04-ний өдөр гаргасан. А дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Х.Э уг нэхэмжлэлийг хүлээн авч, 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 102/ШЗ2017/06657 дугаартай захирамжаар иргэний хэрэг үүсгэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулжээ.

2017 оны 5 дугаар сарын 19-ний өдөр нэхэмжлэгч талаас хариуцагчийн төлөөлөгчийн хилээр гарах хөдөлгөөнд хориг тавиулах тухай хүсэлтийг гаргасан байна. Шүүгч Х.Э нь 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 102/ШЗ2017/07373 дугаартай захирамжаар нэхэмжлэгч талын гаргасан хариуцагч “ННН” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх захирал2095 паспортын дугаартай, ТТТ улсын иргэн Ш-г Монгол Улсын хилээр гарахыг түр түдгэлзүүлэхийг хүссэн хүсэлтийг хүлээн авч, Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газарт хүргүүлэхээр шийдвэрлэсэн байна. Шүүгч Х.Э нь 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 102/ШЗ2017/07373 дугаартай захирамжийнхаа үндэслэх хэсэгт дараахыг бичжээ:

... Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд хариуцагч, түүний төлөөлөгчийн хилээр гарах эрхийг хориглох хуулийн зохицуулалт байхгүй юм.

Харин Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.3 дахь хэсэгт “тухайн гадаадын иргэн өөрийнх нь эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хохироож байгаа тухай бусад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас өргөдөл, гомдол гаргасан бөгөөд эрх бүхий байгууллага үүнийг үндэслэлтэй гэж үзсэн бол уг асуудлыг шийдвэрлэх хүртэл,” мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсэгт “Гадаадын иргэнийг Монгол Улсаас гарахыг түр

түдгэлзүүлэх тухай шийдвэрийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга холбогдох байгууллагын саналыг үндэслэн гаргана” гэж тус тус заажээ...

Иймд нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гаргасан хариуцагч компани болох “ННН” ХХК-ийн ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх захирал2095 паспортын дугаартай, ТТТ улсын иргэн Ш-г Монгол Улсын хилээр гаргахыг түр түдгэлзүүлэхийг хүссэн хүсэлтийг хүлээн авч, уг хүсэлтийг Иргэний харьяалал шилжилт, хөдөлгөөний ерөнхий газарт хүргүүлэх нь зүйтэй гэж үзэв.

2017 оны 5 дугаар сарын 24-ны өдрийн 102/Ш32017/07373 дугаартай захирамж дахь ТТТ улсын иргэн Ш-г Монгол Улсын хилээр гаргахыг түр түдгэлзүүлэхийг хүссэн хүсэлтийг хүлээн авч, уг хүсэлтийг Иргэний харьяалал шилжилт, хөдөлгөөний ерөнхий газарт хүргүүлэх нь зүйтэй” гэсэн өгүүлбэр нь ТТТ улсын иргэн Ш-г Монгол Улсын хилээр гаргахыг түр түдгэлзүүлэхийг хүссэн хүсэлтийг хангаж шийдвэрлээд хүргүүлсэн эсхүл хангалгүйгээр хүргүүлсэн гэсэн утгын алинаар нь ч ойлгогдохоор болсон байна. Тухайлбал, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Д.М-ийн бие биетэйгээ зөрчилдсөн хоёр өөр байр сууриас харж болно. Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Д.М А дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч М.Б-д 2017 оны 5 дугаар сарын 29-ний өдөр илгээсэн 1-3/2112 дугаартай албан бичигтээ “... Танай шүүгчээс ТТТ улсын иргэн Ш-г гарахыг түдгэлзүүлэх санал гаргаагүй, харин зөвхөн нэхэмжлэгчийн хүсэлтийг уламжилсан байх тул 102/Ш32017/07373 дугаартай шүүгчийн захирамжийг үндэслэн дээр нэр дурдсан гадаадын иргэний гарахыг түдгэлзүүлсэн аливаа шийдвэр гаргаагүй болно.” гэж хэлээд байгууллагын нэрийг буруу бичиж ирүүлснийг дурджээ. Гэвч, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Д.М 2017 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн А/273 дугаар тушаалаараа Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.3 дахь заалт, 34.3 дахь хэсэг, байгууллагын даргын 2017 оны А/111 дүгээр тушаалын 2.1, 2.8-д заасныг тус тус үндэслэн “А дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 102/Ш32017/07373 дугаарын захирамжийн дагуу” ТТТ улсын иргэн Ш-г 2017 оны 6 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн Монгол Улсаас гарахыг түр түдгэлзүүлжээ. Улмаар, Гадаадын иргэн, харьяатын газрын Тамгын газрын дарга М.Т нь А дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Х.Э-д хандан уг газрын даргын 2017 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн А/273 дугаар тушаалын агуулгыг албан бичгээр мэдэгджээ.

Шүүгчийн 2017 оны 5 сарын 24-ний өдрийн 102/Ш32017/07373 дугаар захирамж хууль нийцээгүй талаар дурдан, уг захирамжийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 124 дүгээр зүйлийн заалтын дагуу хянан үзэж хүчингүй болгож өгөх тухай хариуцагчийн өмгөөлөгчийн 2017 оны 6 сарын 13-ны өдрийн болон 2017 оны 8 сарын 02-ний өдрийн хүсэлтүүдийг хангахаас татгалзаж шийдвэрлэсэн. Гэтэл, шүүгч Х.Э 2017 оны 8 сарын 03-ны өдрийн 102/Ш32017/10364 дугаартай шүүгчийн захирамжаараа ТТТ улсын иргэн Ш-г Монгол Улсын хилээр гарах хөдөлгөөнд хориг тавиулах тухай хүсэлтээсээ нэхэмжлэгч татгалзсаныг баталсан байна.

Шүүгч Х.Э-д үүсгэсэн сахилгын хэргийг шийдвэрлэхийн тулд Шүүгчийн Ёс зүйн дүрэм (цаашид “ШЁЗД” гэх)-д тусгасан хоёр янзын зарчмыг тайлбарлах шаардлагатай. Нэг талаас, ШЁЗД-ийн 1.4 дугаар зүйлийн 1-д “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй” гэж заасан нь шүүгчийн хууль буруу хэрэглэсэн алдаанд хариуцлага хүлээлгэхгүй байх зарчмыг тунхагласан хэрэг. Энэ зарчим нь шүүгч аливаа хэрэг, маргааныг

буруу шийдвэрлээд хариуцлага хүлээчих вий гэсэн айдасгүйгээр хууль зүйн хувьд хамгийн зөв гэсэн үндэслэлийнхээ дагуу хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх боломжийг шүүгчид олгодог учраас шүүгчийн хараат бус байдлын нэг баталгаа болдог билээ. Нөгөө талаас, хуульд захирагдах зарчмыг ягштал баримтлахыг шүүгчид үүрэг болгодог. Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2-т төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмын нэг бол хууль дээдлэх гэж заасан бөгөөд шүүн таслах ажиллагаа нь төрийн үйл ажиллагаанд багтдаг учраас энэ зарчмыг шүүгч биелүүлэх үүрэгтэй. Тийм учраас, Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 1-д “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана” гэж тодорхой заасан. Мөн, хууль дээдлэх зарчим нь процессын хуулиуд болон Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд ч тусгалаа олсон. Түүнчлэн, ШЁЗД-ийн 1.3 дүгээр зүйлийн 1-д зааснаар “хууль дээдлэх” зарчмыг хувийн зан чанар болгон төлөвшүүлэхийг шүүгчид үүрэг болгоод зогсохгүй энэ дүрмийн 3.3 дугаар зүйлд “Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй” гэж тодорхой заасан. Өөрөөр хэлбэл, шүүгч аливаа хэрэг, маргааныг дур зоргоороо биш зөвхөн хуулийг хэрэглэж, хууль зүйн үндэслэлээр хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэйг эдгээр эрх зүйн эх сурвалжид бичжээ.

Шүүгчийн хууль буруу хэрэглэсэн алдаанд хариуцлага хүлээлгэхгүй байх зарчим болон хуульд захирагдах зарчим хоёрын зохицлыг хангах нь амаргүй ажил. Эхний зарчмыг хэт баривал шүүгчийн хараат бус байдал нэрийн дор хуульд захирагдалгүй шийдвэр гаргадаг шүүгчийн хариуцлагагүй байдлыг дэвэргэнэ. Хоёр дахь зарчмыг хэтэрхий баривал шүүгчийн хараат бус байдалд халдах эрсдэлтэй. Тиймээс, Шүүхийн ёс зүйн хорооноос шүүгчийн ёс зүйн онолд байдаг утгаар энэ хоёр зарчмын уялдааг хангаж хэрэглэх жишиг тогтоож хэрэглэж ирсэн. Тодруулбал, зөвхөн дараах хоёр нөхцөл хангагдсанаас бусад тохиолдолд шүүгчийн хууль хэрэглэсэн алдаанд хариуцлага хүлээлгэхгүй (тодруулбал, ШЁЗД-ийн 1.3 дахь хууль дээдлэх зарчим, 3.3 дугаар зүйл дэх хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх үүргийг зөрчсөний төлөө сахилгын шийтгэл хүлээлгэхгүй): (1) Үндсэн хуулиар илэрхий хамгаалагдсан үндсэн эрх, эрх чөлөөг зөрчсөн; (2) хэн ч маргахгүй хуулийн тодорхой заалтыг зөрчсөн, ялангуяа удаа дараа зөрчсөн. Хууль зүйн туслалцаа авах эрхийг нь мэдсээр байж хангахгүй байх, давж заалдах гомдол гаргах эрхийг огт эдлүүлэхгүй байх нь эхний нөхцөлийн жишээ. Маргааны нэг талтай нөгөө талыг байлцуулахгүйгээр уулзахыг илэрхий хориглосон Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27.1.17 г зөрчиж маргааны нэг талтай ганцаарчлан уулзаж хэргийн талаар ярих нь хоёр дахь нөхцөлийн жишээ.

Шүүгч Х.Э нь 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдөр ТТТ улсын иргэн Ш-г Монгол Улсын хилээр гаргахыг түр түдгэлзүүлэх санал гаргасан агуулга бүхий 102/Ш32017/07373 дугаартай захирамж гаргаж, уг захирамжийн дагуу ТТТ улсын иргэн Ш-ийг 2017 оны 6 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн Монгол Улсаас гарахыг түр түдгэлзүүлэх тушаалыг Гадаадын иргэн, харьяатын газрын даргын тушаал гаргасан. Шүүгч Х.Э энэ захирамжаараа Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-т “мэргэжлийн ёс зүйгээ ухамсарласан, хүний эрхийг дээдлэх чадвартай,” мөн зүйлийн 4.1.8-т “шүүгчээр ажиллах тухайн дагнасан шүүхийн салбар эрх зүйн мэдлэг, туршлагатай” байна, ШЁЗД-ийн 1.3 дугаар зүйлд заасан “хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, хууль дээдлэх” зарчмууд, мөн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй” гэх заалтыг тус тус зөрчсөн байна. Учир нь, шүүгч Х.Э Үндсэн хууль, Иргэний болон улсын төрийн эрхийн тухай олон

улсын факт, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн тодорхой заалтуудыг баримтлаагүй төдийгүй ТТТ улсын иргэн Ш-ийг “гадаадад явах эрх” болон “аливаа улсыг орхин явах эрх”-ийг илэрхий зөрчсөн гэж бүрэлдэхүүн үзэв.

Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Д.М 2017 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн А/273 дугаар тушаал, түүнийг хүчингүй болгуулах тухай хариуцагчийн өмгөөлөгчийн хүсэлтүүдээс татгалзсан 2017 оны 8 дүгээр сарын 03-ны өдрийн болон 2017 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн шүүгчийн захирамжууд, ТТТ улсын иргэн Ш-г Монгол Улсын хилээр гарах хөдөлгөөнд хориг тавиулах тухай хүсэлтээсээ татгалзсаныг баталсан 2017 оны 8 сарын 03-ны өдрийн 102/Ш32017/10364 дугаартай захирамж зэргээс үзэхэд 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 102/Ш32017/07373 дугаарын захирамж нь ТТТ Улсын иргэн Ш-г Монгол Улсын хилээр гаргахыг түр түдгэлзүүлэх хүсэлтийг хангаж, түүнийг хилээр гарахыг түр түдгэлзүүлэх санал гаргаж Гадаадын иргэн, харьяатын газарт явуулсан агуулгатай болжээ.

Гадаадын иргэнийг Монгол Улсын хилээр гарахыг түр түдгэлзүүлэх санал нь уг иргэний аливаа улсыг орхин явах эрхийг хязгаарлах үр дагавартай байна. Иймд, шүүгч ийм санал гаргахдаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль төдийгүй Монгол Улсын Үндсэн хууль, тус улсын нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний зохицуулалтыг харах шаардлагатай. Учир нь, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1-т “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ,” мөн зүйлийн 2.2-т “Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” гэж тус тус заасан.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактын 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хүн бүр аливаа улсыг, түүний дотор эх орноо орхин явах эрхтэй” гэж заасан бөгөөд Монгол Улс уг фактад нэгдэн орсон учраас өөрийн нутаг дэвсгэрт буй гадаадын иргэдэд энэ эрхийг эдлүүлэх ёстой. Учир нь, Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2-т “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ,” 3-т “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн 18 дугаар зүйлийн 18.5-д “Үндсэн хуулийн арван зургаадугаар зүйлд заасан Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд эдлүүлэхдээ Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний салшгүй эрхээс бусад эрхийн хувьд үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хуулиар зохих хязгаарлал тогтоож болно” гэж заасан ч ТТТ улсын иргэн Ш-г Монгол Улсын хилээр гарахыг түр түдгэлзүүлэх нь “үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалах”-тай холбоотой асуудал гэдэг талаар яригдаагүй учраас ТТТ улсын иргэн Ш-г Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 18-д заасан “гадаадад явах” эрх болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Фактын 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт буй “аливаа улсыг орхин явах эрх”-ийг эдэлнэ.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактаар аливаа улсыг орхин явах эрх нь хэзээ ч хязгаарлагдаж үл болох туйлын эрх биш юм. Уг фактын 12 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Хуульд заасан бөгөөд үндэсний аюулгүй

байдал, нийгмийн хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун буюу бусдын эрх, эрх чөлөө болон энэхүү фактаар хүлээн зөвшөөрсөн бусад эрхийг хамгаалахад [зайлшгүй] шаардлагатай хязгаарлалтаас бусдаар дээр дурдсан эрхийг хязгаарлаж болохгүй.” гэж заасан. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактын Англи эх дээр нь эдгээр зорилгыг хамгаалахад “зайлшгүй” байна гэж бичсэн байдаг⁶ ч НҮБ-ын⁷, Хүний эрхийн үндэсний комиссын⁸ болон Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн⁹ хэвлүүлсэн уг фактын орчуулгад дээрх 12 дугаар зүйлд буй “зайлшгүй” гэсэн маш чухал үгийг орхиж Монгол хэл рүү хөрвүүлсэн байгаагаас уг заалтыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн агуулгаар хэрэглэх, хөгжүүлэх боломжгүй болгож байна. Иймд, аливаа улсыг орхих явах эрхийг хязгаарлаж буй хязгаарлалт нь (1) хуульд заасан байх, (2) энд зөвшөөрөгдсөн зорилгод үйлчлэх төдийгүй (3) эдгээр зорилгын аль нэгийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай байх ёстой. 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 102/ШЗ2017/07373 дугаарын захирамж нь эдгээр гурван шаардлагыг нь хангаагүй байна.

Нэгд, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактын 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн дагуу аливаа улсыг орхин явах эрхийг энд заасан шаардлагаар зөвхөн хуулиар хязгаарлахыг зөвшөөрдөг. Гэвч, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд “аливаа улсыг орхин явах эрх”-ийг хязгаарлах эсхүл ийм үр дагавартай санал гаргах бүрэн эрхийг шүүгчид тусгайлан олгоогүй байна. 2017 оны 5 дугаар сарын 24-ны өдрийн 102/ШЗ2017/07373 дугаарын захирамж нь ТТТ улсын иргэн Ш-ийг Монгол Улсын хилээр гаргахыг түр түдгэлзүүлж шийдвэрлээгүй, харин Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.3 дахь хэсэгт “тухайн гадаадын иргэн өөрийнх нь эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хохироож байгаа тухай бусад иргэн, аж ахуйн нэг, байгууллагаас өргөдөл, гомдол гаргасан бөгөөд эрх бүхий байгууллага үүнийг үндэслэлтэй гэж үзсэн бол уг асуудлыг шийдвэрлэх хүртэл,” мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсэгт “Гадаадын иргэнийг Монгол Улсаас гарахыг түр түдгэлзүүлэх тухай шийдвэрийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга холбогдох байгууллагын саналыг үндэслэн гаргана” гэж тус тус заасны дагуу нэхэмжлэгчийн хүсэлтийг уламжилсан гэж шүүгч Х.Э тайлбарладаг. Гэвч, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар гадаадын иргэний “аливаа улсыг орхин явах эрх”-ийг хязгаарлах, Монгол Улсын хилээр гарахыг түр түдгэлзүүлэх эсхүл ийм санал гаргах бүрэн эрхийг бүрэн эрхийг шүүгчид олгоогүй байна. Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс 2017 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн албан бичигтээ мөн “иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч нь хэргийн оролцогчийн хүсэлтээр аливаа этгээдийг хилээр нэвтрүүлэх эрхийг хязгаарлах эрхгүй байна” гэжээ. Иймд, ТТТ улсын иргэн Ш-г Монгол Улсын хилээр гаргахыг түр түдгэлзүүлэх хүсэлтийг хангаж, түүнийг хилээр гарахыг түр түдгэлзүүлэх санал гаргаж Гадаадын иргэн, харьяатын газарт явуулсан агуулгатай захирамж гаргасан нь хуульд нийцээгүй байна.

Хоёрт, ТТТ улсын иргэн Ш-г Монгол Улсын хилээр гаргахыг түр түдгэлзүүлэх санал гаргах нь “үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам,

6 International Covenant on Civil and Political Rights (1996), united nations Human Rights Office of the High Commissioner, <http://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/CCPR.aspx>

7 Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын факт (1996), Хүний эрх: олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхэтгэл дотор (УБ: НҮБ, 1993), 17

8 Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын факт (1996), Олон улсын хүний эрхийн билл: Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний эмхэтгэл дотор (УБ: ХЭҮК, 2015), 32

9 Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын факт (1996), (Хууль зүйн үндэсний хүрээлэн) <http://www.legalinfo.mn/law/details/1257?lawid=1257>.

эрүүл мэнд, ёс суртахуун буюу бусдын эрх, эрх чөлөө болон энэхүү Фактаар хүлээн зөвшөөрсөн бусад эрхийг хамгаалах”-тай холбоотой байсан эсэх нь тодорхойгүй байна. 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 102/ШЗ2017/07373 дугаарын захирамжид “Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гаргасан хүсэлтийн агуулга нь хэрэг маргааныг шүүхээр хурдан шийдвэрлүүлэх, шүүхээр маргааныг шийдвэрлэхэд учирч болох хүндрэл бэрхшээлээс урьдчилан сэргийлэх агуулгатай байх” гэж бичсэн боловч энэ хүсэлт нь нэхэмжлэгчийн ямар эрхийг хамгаалахтай холбоотой талаар дурдаагүй байна. Хариуцагчийн өмгөөлөгч 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 102/ШЗ2017/07373 дугаарын захирамжийг хүчингүй болгуулах хүсэл гаргахдаа “Хариуцагч талаас иргэний хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Ц.Ц-г оролцуулахаар итгэмжлэл олгосон нь энэ хэрэгт Ш-г заавал байлцуулах шаардлагагүй гэж үзэхээр байна” гэж бичсэн боловч энэ үндэслэлд шүүгч Х.Э ямар ч хариу өгөлгүйгээр уг хүсэлтээс татгалзсан (А дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2017 оны 8 дугаар сарын 03-ны өдрийн 102/ШЗ2017/10365 дугаартай захирамж).

Гуравт, ТТТ улсын иргэн Ш-г Монгол Улсын хилээр гаргахыг түр түдгэлзүүлэх санал гаргах нь зайлшгүй байсан тухай үндэслэлийг 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 102/ШЗ2017/07373 дугаарын захирамжид бичээгүй. Өөрөөр хэлбэл, ТТТ улсын иргэн Ш-г Монгол Улсын хилээр гаргахыг түр түдгэлзүүлэх санал гаргах нь үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун буюу бусдын эрх, эрх чөлөө болон энэхүү Фактаар хүлээн зөвшөөрсөн бусад эрхийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай байсан гэдгийг тогтоогоогүй байна. Зайлшгүй байх шаардлагыг хууль тогтоох төдийгүй гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд баримтлах ёстой гэдгийг НҮБ-ын Хүний эрхийн хороо Ерөнхий тайлбартаа тодорхой бичсэн байдаг. Үүнд:

14.Хязгаарлалт нь зөвшөөрөгдсөн зорилгод үйлчлэх нь хангалтгүй төдийгүй эдгээр зорилгыг хамгаалахад мөн зайлшгүй байх ёстой гэдгийг 12 дугаар зүйлийн 3 дахь хэсэг тодорхой харуулдаг. Хязгаарласан арга хэмжээ нь тохирсон байх зарчимд нийцэх ёстой; хүссэн үр дүнд хүргэж болох арга хэрэгслүүдээс тухайн эрхэд хамгийн бага халдсан байх ёстой; хамгаалагдах гэж буй ашиг сонирхолд тохирсон байх ёстой.

15.Тохирсон байх зарчим нь хязгаарлалтыг тогтоож буй хуульд төдийгүй уг хуулийг хэрэглэж буй захиргааны болон шүүхийн эрх бүхий байгууллагаас хүндлэгдэх ёстой. Эдгээр эрхийг эдлүүлэх, хязгаарлахтай холбоотой аливаа ажиллагаа нь шуурхай явагдах бөгөөд хязгаарласан арга хэмжээг хэрэглэх үндэслэл гаргасан байх баталгааг бүрдүүлэх хэрэгтэй¹⁰

Аливаа улсыг орхин явах үндсэн эрхийг хязгаарлах арга хэмжээ гэдэгт энэ талаарх санал, шийдвэр зэрэг багтана. ТТТ улсын иргэн Ш-г Монгол Улсын хилээр гаргахыг түр түдгэлзүүлэх санал гаргах нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактын 12 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зөвшөөрсөн аль нэг зорилгод үйлчлэхэд чиглэсэн гэдгийг харуулаагүй төдийгүй эдгээр зорилгын аль нэгийг хамгаалахад зайлшгүй гэдгийг үзүүлээгүй байна.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактын Монгол орчуулгад аливаа улсыг орхин явах эрхийн хязгаарлалт нь зөвшөөрөгдсөн зорилгыг хангахад зайлшгүй байх гэсэн агуулга буугаагүй учраас энэ зарчмыг хэрэглээгүй гэдгээр шүүгч Х.Э-г буруутгах нь шударга бус юм. Гэвч, шүүгч Х.Э нь ТТТ улсын иргэн Ш-г Монгол Улсын хилээр гаргахыг түр түдгэлзүүлэх хүсэлтийг хангаж, түүнийг хилээр гарахыг түр түдгэлзүүлэх санал гаргахдаа хуульд заасан байх болон зөвшөөрөгдсөн зорилгод үйлчлэх гэсэн хоёр шаардлагыг баримтлаагүй учраас буруутай гэж үзлээ.

10 General Comment No.27: Freedom of movement (Art.12), CCPR/21/Rev.1/Add.9, 01 Nov 1999,

Дүгнэж хэлбэл, шүүгч Х.Э 2017 оны 5 сарын 24-ны өдрийн 102/Ш32017/07373 дугаар захирамжаараа ТТТ улсын иргэн Ш-ийн “гадаадад явах,” “аливаа улсыг орхин явах” хүний эрхийг нь хүндэтгээгүй учраас Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-т “мэргэжлийн ёс зүйгээ ухамсарласан, хүний эрхийг дээдлэх чадвартай” байх шаардлага, ШЁЗД-ийн 1.3 дугаар зүйлд заасан “хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх” зарчмуудыг зөрчсөн байна. Мөн, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар гадаадын иргэнийг Монгол Улсын хилээр гаргахыг түр түдгэлзүүлэх үр дагавартай санал, шийдвэр гаргах бүрэн эрхийг шүүгчид олгоогүй байхад шүүгч Х.Э нь ТТТ улсын иргэн Ш-ийг түр түдгэлзүүлэх саналыг илэрхийлсэн захирамж гаргасан учраас тэрээр ШЁЗД-ийн 1.3 дугаар зүйлд заасан “хууль дээдлэх” зарчим, мөн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй” гэх заалтыг тус тус зөрчсөн байна. Гадаадад явах эрх болон аливаа улсыг орхин явах эрхийг эрдүүлэх болон хязгаарлахтай холбоотой Монгол Улсын Үндсэн хуулийн болон олон улсын гэрээний тодорхой заалтууд, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар шүүгч олгосон эрх хэмжээний талаарх илэрхий зохицуулалтыг баримтлаагүй учраас шүүгч Х.Э нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-т буй “шүүгчээр ажиллах тухайн дагнасан шүүхийн салбар эрх зүйн мэдлэг, туршлагатай” байх шаардлагыг хангаж ажиллаагүй байна.

Шүүгчийн 2017 оны 5 сарын 24-ны өдрийн 102/Ш32017/07373 дугаар захирамж хууль нийцээгүй талаар дурдан, уг захирамжийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 124 дүгээр зүйлд заалтын дагуу хянан үзэж хүчингүй болгож өгөх тухай хүсэлтийг Ш, өөрийн өмгөөлөгч, төлөөлөгч нарын хамт 2017 оны 6 сарын 13-ны өдөр гаргасан боловч хариуцагч талын энэхүү хүсэлтийг хангахгүй орхисугай гэсэн 102/Ш32017/10365 дугаар бүхий захирамжийг шүүгч Х.Э бараг хоёр сарын дараа буюу 2017 оны 8 сарын 03-нд гаргасан. Уг захирамжид “шүүхээс ТТТ улсын иргэн Ш-г Монгол Улсын хилээр гарахыг түр түдгэлзүүлж шийдвэрлээгүй, харин гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай хуулийн 34.2.3 /2017 оны 5 сарын 18-ны өдрийн өөрчлөлтөөс өмнөх зохицуулалтаар/, 34.3 дахь заалтын дагуу нэхэмжлэгчийн хүсэлтийг уламжилсан”, “шүүгчийн захирамжийг ... илт үндэслэл муутай гарсан гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй” байна гэсэн дүгнэлт хийж хариуцагч талын хүсэлтийг хангахгүй орхижээ.

Хариуцагчийн өмгөөлөгч Г.Б 2017 оны 5 сарын 24-ны өдрийн 102/Ш32017/07373 дугаар захирамжийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 124 дүгээр зүйлийн 124.1 дэх хэсгийн дагуу хүчингүй болгох өөр нэг хүсэлтийг 2017 оны 8 сарын 02-ны өдөр гаргасан байна. Шүүхийн ёс зүйн хорооны гурван гишүүний хуралдаан болох үед буюу 2017 оны 9 дүгээр сарын 08-ны өдөр шүүгч Х.Э 2017 оны 8 сарын 02-ны өдрийн энэ хүсэлтийг шийдвэрлэсэн захирамж гаргаагүй байжээ. Иймийн учир, тус хорооны 2017 оны 9 дүгээр сарын 08-ны өдрийн 144 дугаартай тогтоолд “Захирамжид дээр дурдсан [2017 оны 6 сарын 13-ны өдрийн болон 2017 оны 8 сарын 02-ний өдрийн] хоёр хүсэлтийн алийг нь шийдвэрлэж байгаа талаар тусгагдаагүй байх бөгөөд “хариуцагчийн төлөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч нар шүүхэд гаргасан хүсэлтэд” гэж бичсэн агуулгаас үзвэл 2017 оны 6 сарын 13-ны өдрийн хүсэлтийг шийдвэрлэсэн гэж ойлгогдохоор болжээ” гэж тэмдэглэжээ. Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдаан болсны дараа буюу 2017 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр шүүгч Х.Э нь 2017 оны 8 сарын 02-ны өдрийн хариуцагчийн өмгөөлөгчийн хүсэлтийг хангахаар татгалзсан 102/Ш32017/12699 дугаартай

захирамжаа гаргажээ. Өөрөөр хэлбэл, хариуцагчийн өмгөөлөгчийн 2017 оны 8 сарын 02-ны өдрийн хүсэлтийг хоёр сар шахмын дараа шийдвэрлэжээ.

Нэхэмжлэгч “ССС” ХХК-ийн захирал С.Г “ТТТ улсын иргэн Ш буюу н.И нь манай компанитай ирж уулзан, харилцан тохиролцсон тул түүнийг хилээр гарахыг түр түдгэлзүүлсэн тушаалыг цуцлахад манай тал татгалзахгүй” гэсэн хүсэлтийг 2017 оны 7 дугаар сарын 21-ний өдөр гаргажээ, Энэ хүсэлт гарснаас хойш 14 хоногийн дараа буюу 2017 оны 8 сарын 03-ны өдөр шүүгч Х.Э 102/Ш32017/10364 дугаартай шүүгчийн захирамж гаргаж, ТТТ улсын иргэн Ш-г Монгол Улсын хилээр гарах хөдөлгөөнд хориг тавиулах тухай хүсэлтээсээ татгалзсаныг баталсан байна.

Аливаа улсыг орхин явах эрхийг хязгаарласан санал, шийдвэр гаргахад хүргэсэн үндэслэлийг тодорхой дурдах шаардлагатай ч 2017 оны 5 дугаар сарын 24-ны өдрийн 102/Ш32017/07373 дугаарын захирамжид ийнхүү дурдаагүй байна. Мөн, ТТТ улсын иргэн Ш-г Монгол Улсын хилээр гарахыг түр түдгэлзүүлэх үр дагавартай захирамжийг хүчингүй болгуулах хариуцагч талын хүсэлтээс хангалттай үндэслэл хэлэлгүйгээр татгалзсан. Гэтэл, шүүгч Х.Э 2017 оны 0 сарын 03-ны өдрийн 102/Ш32017/10364 дугаартай шүүгчийн захирамждаа “нэхэмжлэгч нь Монгол Улсын хилээр гарах хөдөлгөөнд хориг тавиулах тухай хүсэлтээсээ татгалзаж байгаагаа илэрхийлсэн” гэж бичээд, ТТТ улсын иргэн Ш-г Монгол Улсын хилээр гарах хөдөлгөөнд хориг тавиулах тухай хүсэлтээсээ татгалзсаныг баталсан боловч мөн л бодитой үндэслэл дурдаагүй байна. Эндээс үзэхэд ТТТ улсын иргэн Ш-г Монгол Улсын хилээр гарахыг түр түдгэлзүүлэх санал гаргах бодит үндэслэл байсан эсэхэд эргэлзээ үүсгэж байна.

Дүгнэж хэлбэл, шүүгч Х.Э нь нэхэмжлэгч талд “үйлчилсэн, түүнд давуу ашиг сонирхлын зөрчлийг агуулсан, нэг талыг хууль ёсны эрх ашгийг бодитойгоор хохироосон” гэх гомдол үндэслэлтэй байна. Учир нь, хариуцагч талын 2017 оны 6 сарын 13-ны өдрийн болон 2017 оны 8 сарын 02-ны өдрийн хүсэлтүүдийг бараг хоёр сарын дараа шийдвэрлэсэн бол нэхэмжлэгч талын хүсэлтийг 14 хоногт илүү шуурхай шийдвэрлэсэн нь нэхэмжлэгч талд тал зассан гэж ойлгогдож байна. Мөн, хуулиар эрх хэмжээ олгоогүй төдийгүй Монгол Улсыг орхин явах эрхийг хязгаарлах үндэслэл байхгүй байхад ТТТ улсын иргэн Ш-г Монгол Улсын хилээр гарахыг түр түдгэлзүүлэх үр дагавартай захирамж гаргасан нь нэхэмжлэгч талд тал засжээ. Иймд, шүүгч Х.Э нь ШЁЗД-ийн 1.3 дугаар зүйлд заасан “үнэнч шударга байх, төвийг сахисан байр сууринаас хандах” зарчмууд, мөн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүгч нь хэргийн оролцогчдод эрх тэгш, төвийг сахисан, хүнлэг ёсоор хандаж, хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлэхүйц харилцааны соёлыг эзэмшсэн байна” гэх заалтыг тус тус зөрчсөн байна.

Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс 2017 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн албан бичигт “А дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Х.Э-гийн мэдлэг, ур чадвар, мэргэшилтэй холбоотой асуудлаар гаргасан ТТТ улсын иргэн Ш-ийн гомдлыг шалгаж шийдвэрлүүлэхээр харьяаллын дагуу шилжүүлэв. Хэрхэн шийдвэрлэсэн талаараа манайд хариу мэдэгдэнэ үү” гэжээ. Иймд, энэхүү магадлалын талаар Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисст мэдэгдэх нь зүйтэй.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1, 35.2, 36 дугаар зүйлийн 36.1.2, 37 дугаар зүйлийн 37.1.1, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйл, Шүүхийн ёс зүйн хорооны дүрмийн 5.7.1, 5.13-т заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1.А дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Х.Э-д сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Энэ магадлалын хувийг шүүгч болон гомдол гаргагчид хүргүүлэхийг Ажлын албанд даалгасугай.

3.Гомдол гаргагч энэ магадлалыг эс зөвшөөрвөл хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.

4.Энэхүү магадлалын хувийг Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисст хүргүүлсүгэй.

ДАРГАЛАГЧ

Н.ЭРДЭНЭЦОГТ

ГИШҮҮН

В.ЖАВХЛАН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ
МАГАДЛАЛ

2018 оны 02 сарын 13 өдөр

Дугаар 221/ЁМ2018/0004

Улаанбаатар хот

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны
2017 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн
64 дүгээр магадлалын тухай

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Батбаатар даргалж, шүүгч С.Мөнхжаргал, шүүгч Д.Баатархүү нарын бүрэлдэхүүнтэй, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Н.Өнө-Эрдэнэ, гомдол гаргагч Г.Б нарыг оролцуулан хийж, Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн “А дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Х.Э-д сахилгын шийтгэл ногдуулах тухай” 64 магадлалыг шүүгч Х.Э-гийн гаргасан давж заалдах гомдлоор, шүүгч Д.Баатархүүгийн илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 64 дүгээр магадлалаар: А дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Х.Э-д сануулах сахилгын шийтгэл ногдуулж шийдвэрлэжээ.

Шүүгч Х.Э давж заалдах гомдолдоо: А дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Х.Э би Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 64 дугаартай магадлалыг 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдөр гардан авч, уг магадлалыг эс зөвшөөрөн, дараах үндэслэлээр гомдол гаргаж байна.

1. Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалын “Үндэслэх” хэсгийн агуулгыг судлан үзвэл, 1/ шүүгчийн захирамжийн агуулга руу орж дүгнэлт хийж, шүүгчийн хараат бус байдалд халдсан, 2/ Гадаадын иргэн, харьяатын газраас гаргасан шийдвэрийн зөв буруугийн асуудлыг дүгнэж эрх хэмжээгээ хэтрүүлсэн, 3/ Эрх зүйн дүгнэлтүүд нь хоорондоо зөрчилтэй, ёс зүйн зөрчилд хамааралгүй эх сурвалжийг иш татаж, шүүгчийг ёс зүйн зөрчил гаргасныг батлах зорилгоор хийсвэрлэн дүгнэсний дээр Шүүхийн ёс зүйн хорооны зарим гишүүд хуралдаан дээр бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ дураараа авирлах, ёс зүйгүй байдал гаргасныг тэмдэглэж байна.

1.1. Шүүгчийн захирамжийн агуулга руу орж дүгнэлт хийж, шүүгчийн хараат бус байдалд халдсан талаар

Магадлалд “Х.Э-д үүсгэсэн сахилгын хэргийг шийдвэрлэхийн тулд “Шүүгчийн ёс зүйн дүрэм”-д тусгасан хоёр янзын зарчмыг тайлбарлах шаардлагатай” нэг талаас Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.4-д заасан “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй” гэснийг дурдаад нөгөө талаас Шүүхийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1-д зааснаар “хууль дээдлэх” зарчим, 3.3 дугаар зүйлд “Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй” гэсэн заалтыг шүүхээс гаргасан

шийдвэр, захирамжийн агуулга руу орж дураараа хийсвэр дүгнэлт хийх эрх Шүүгчийн ёс зүйн хорооны гишүүдэд байгаа гэх ойлголтоор тайлбар хийжээ.

Хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн явуулсан эсэх асуудалд давж заалдах шатны болон хяналтын шатны шүүх тухайн хэргийг бүхэлд нь хянан үзэж, өөрийн эрх хэмжээний хүрээнд дүгнэлт хийж бүрэн эрх хадгалагдаж байгаа. Энэ талаар “Сахилгын хэрэг үүсгэсэн ёс зүйн хорооны 2017 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 144 дүгээр тогтоолд гомдол гаргахдаа дэлгэрэнгүй тайлбар хийсэн тул сахилгын хэрэгт байгаа тайлбарыг дахин бичих шаардлагагүй гэж үзлээ.

Иймд Монгол Улсын Шүүхийн Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.1 дэх хэсгийн “Шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах 1.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй” гэсэн заалтыг Ёс зүйн хороо зөрчсөн гэж үзэж байна.

Дээрх алдаа Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 64 дүгээр магадлалд мөн давтагдаж, шүүгчийн дотоод итгэл рүү халдахдаа ТТТ улсын иргэн Ш-г-ий “гадаадад явах эрх” болон “аливаа улсыг орхин явах эрх” ийг зөрчсөн гэжээ.

Шүүгч Х.Э би ТТТ улсын иргэн Ш-ийн эрхийг хязгаарласан шийдвэр, захирамж гаргаагүй учир ёс зүйн хороо хийсвэрлэсэн дүгнэлтээр хариуцлага хүлээлгэсэн шийдвэр гаргалаа.

1.2. Гадаадын иргэн, харьяатын газраас гаргасан шийдвэрийн зөв буруугийн асуудлыг дүгнэж эрх хэмжээгээ хэтрүүлсэн талаар

Гадаадын иргэн, харьяатын газраас гаргасан аливаа шийдвэрийн талаар шүүхийн ёс зүйн хорооны гишүүд дүгнэлт хийх эрх хэмжээ байхгүй.

Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасан Ёс зүйн хороо үйл ажиллагаандаа хууль дээдлэх, шударга, төв голч байх, гомдлыг хянан хэлэлцэх хүрээ хязгаараас хальсан шийдвэр гаргалаа. Тухайлбал, гадаадын иргэн, харьяатын газрын дарга Д.М-ийн бие биетэйгээ зөрчилдсөн хоёр өөр байр сууриас хөрж болно” гэх зэргээс харж болно. Өөрөөр хэлбэл, гадаадын иргэн, харьяатын газраас гаргасан шийдвэрүүдийн зөв буруугийн асуудалд Шүүхийн Ёс зүйн хороо дүгнэлт хийх эрхгүй юм.

1.3. Эрх зүйн дүгнэлтүүд нь хоорондоо зөрчилтэй, хийсвэрлэсэн дүгнэлт хийсэн талаар

Магадлалд “...түр түдгэлзүүлэхийг хүссэн хүсэлтийг хүлээн авч, уг хүсэлтүүдийг Иргэний харьяалал шилжилт хөдөлгөөний ерөнхий газарт хүргүүлэх нь зүйтэй гэсэн өгүүлбэр нь уг хүсэлтийг хангаж шийдвэрлээд хүргүүлсэн, эсхүл ханалгүйгээр гэсэн утгын алианаар нь ойлгогдохоор болсон байна” гэжээ.

Шүүх хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэргийн оролцогчоос гаргасан аливаа хүсэлтийг хүлээн авсны дараа судлан үзээд хэрхэн шийдвэрлэх нь шүүгчийн эрх хэмжээний асуудал байдаг. Гэтэл “хүлээн авч” гэх үгийг хангасан гэсэн утгаар нь тайлбарлан, ёс зүйн зөрчил гаргасан гэж дүгнэн сахилгын шийтгэл ногдуулсан нь онолын болон эрх зүйн утга агуулгын хувьд зөрчилтэй болж байна.

Нөгөөтээгүүр, “шүүгчийн хууль буруу хэрэглэсэн алдаад хариуцлага хүлээлгэхгүй байх зарчим болон хуульд захирагдах зарчим хоёрын зохицлыг хангах амаргүй ажил” гэж дүгнэсэн нь шүүгч намайг ёс зүйн зөрчил гаргасныг баримтад үндэслэн шийдвэрлэх боломжгүй болсныг хүлээн зөвшөөрсөн гэж үзэхээр байна.

Мөн магадлалд “... утгын алианаар нь ч ойлгогдохоор болсон байна”, “... хоёр өөр байр сууринаас харж болно”, “зарчмыг тунхагласан хэрэг”, “эрх зүйн эх сурвалжид бичжээ”, хоёр дахь нөхцөлийн жишээ”, “илэрхий зөрчсөн”, “агуулгатай болжээ”, “туйлын эрх биш”, “үндэслэл байсан эсэхэд эргэлзээ үүсгэж байна”, “хэргийг

шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлэхүйц харилцааны соёлыг эзэмшсэн байна” гэх заалтыг тус тус зөрчсөн байна” гэх зэргээр таамаглал дэвшүүлсэн олон дүгнэлт хийснийг тэмдэглэж байна.

Шүүгч Х.Э миний бие хэргийг хараат бус байдлаар шийдвэрлэх чин эрмэлзэлтэй ажиллаж ирсэн нь туйлын үнэн. Гэтэл Шүүгчийн Ёс зүйн хороо шүүгч миний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсантай холбогдуулан сахилгын арга хэмжээг үндэслэлгүйгээр ногдуулсныг хүлээн зөвшөөрөхгүй байх тул нягтлан үзэж, тус хорооны 2017 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 64 дүгээр магадлалыг хүчингүй болгож өгнө үү” гэжээ.

ХЯНАВАЛ:

Давж заалдах гомдлын дагуу Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 64 дүгээр магадлалыг хянаад хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэв.

Өмгөөлөгч Г.Б-ээс шүүгч Х.Э-д холбогдуулан "Шүүгч Х.Э нь "ССС" ХХК-ийн нэхэмжлэлтэй, "ННН" ХХК-д холбогдох ерөнхий захирлыг томилсон тогтоолтой холбоотой маргааныг хянах явцад нэхэмжлэгч талаас гаргасан "ТТТ улсын иргэн Ш-г Монгол Улсын хилээр гарах хөдөлгөөнд хилийн хориг тавих"-ыг хүссэн хүсэлтийг захирамжаараа шийдвэрлэхдээ илтэд үндэслэл муутай, нэг талд үйлчилсэн, давуу ашиг сонирхлын зөрчлийг агуулсан бусдад нөлөөлөх байдлыг бий болгосон, нэг талын хууль ёсны эрх ашгийг бодитойгоор хохироосон" гэсэн гомдлыг Шүүхийн Ёс зүйн хороонд гаргажээ.

Ёс зүйн хороо уг гомдлыг шалгаж, шүүгч Х.Э-д сахилгын хэрэг үүсгэж, улмаар Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанаар түүнд сануулах сахилгын шийтгэл ногдуулсан байна.

Хэрэгт авагдсан баримтуудаас үзэхэд шүүгч Х.Э 2017 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 102/ШЗ2017/07373 дугаар захирамж гаргаж, "ННН" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх захирал ТТТ улсын иргэн Ш-ийг Монгол Улсын хилээр гарахыг түр түдгэлзүүлэхийг хүссэн хүсэлтийг хүлээн авч, уг хүсэлтийг Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газарт хүргүүлэхээр шийдвэрлэжээ.

Дээрх шүүгчийн захирамжийг үндэслэн Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/273 дугаар тушаалаар ТТТ улсын иргэн Ш-ийг 2017 оны 06 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн Монгол Улсаас гарахыг түр түдгэлзүүлсэн байна.

Шүүгчийн дээрх захирамжийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 124 дүгээр зүйлийн 124.1 дэх хэсэгт заасны дагуу хянаж, хүчингүй болгуулахыг хүссэн хүсэлтийг 2017 оны 6 дугаар сарын 13-ны өдөр хариуцагч талаас гаргасныг шүүгч Х.Э 2017 оны 8 дугаар сарын 03-ны өдөр хүсэлтийг хангалттай үндэслэл дурдалгүйгээр хангахгүй орхисон захирамж гаргасан, харин нэхэмжлэгч талаас хилээр гарах хөдөлгөөнд хориг тавиулах тухай хүсэлтээсээ татгалзсан хүсэлтийг хүлээн авч, хүсэлтээсээ татгалзсаныг баталсан захирамждаа мөн л бодитой үндэслэл дурдаагүй нь ТТТ улсын иргэнийг хилээр гарахыг түдгэлзүүлэх санал гаргах үндэслэл байсан эсэхэд эргэлзээ үүсгэж байгаа түүнчлэн хариуцагч талын 2017 оны 6 сарын 13-ны өдрийн болон 8 дугаар сарын 02-ны өдрийн хүсэлтүүдийг 2 сарын дараа шийдвэрлэсэн бол нэхэмжлэгч талын хүсэлтийг 14 хоногт шуурхай шийдвэрлэсэн нь нэхэмжлэгч талд илүү хандсан гэж ойлгогдож байна. Энэхүү үйлдэл нь нэг талын хууль ёсны ашиг сонирхлыг бодитойгоор хохироосон гэсэн гомдол үндэслэлтэй гэж дүгнэсэн Ёс зүйн хорооны дүгнэлтийг үгүйсгэх боломжгүй байна.

Шүүгч Х.Э-гийн ТТТ улсын иргэн Ш-ийг Монгол Улсын хилээр гарахыг түдгэлзүүлэхийг хүссэн хүсэлтийг хүлээн авч, холбогдох газарт хүргүүлэхээр шийдвэрлэсэн захирамжийг үндэслэн тухайн иргэнийг хилээр гарах эрхийг түдгэлзүүлсэн, улмаар түдгэлзүүлсэн болохыг Гадаадын иргэн, харьяатын газраас шүүгч Х.Э-д ирүүлсэн 2017 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн 01/225 дугаар албан бичгээр мэдэгдсэн үйл баримт тогтоогдож байх тул "... би ТТТ улсын иргэн Ш-ийн эрхийг хязгаарласан шийдвэр захирамж гаргаагүй, Ёс зүйн хороо хийсвэрлэсэн дүгнэлтээр хариуцлага хүлээлгэсэн шийдвэр гаргасан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд гадаадын иргэнийг 'хилээр гарахыг түр түдгэлзүүлэх хүсэлтийг хүлээн авч, түдгэлзүүлэх үр дагавартай шийдвэр гаргах эрх шүүгчид олгогдоогүй, өөрөөр хэлбэл хариуцагч, түүний төлөөлөгчийн хилээр гарах эрхийг хориглох хуулийн зохицуулалт байхгүй тул "...хэргийн оролцогчоос гаргасан аливаа хүсэлтийг хүлээн авсны дараа судлан үзээд хэрхэн шийдвэрлэх нь шүүгчийн эрх хэмжээний асуудал..." гэх гомдлуудыг хүлээн авах боломжгүй байна.

Шүүгч Х.Э 07373 дугаар захирамжаараа ТТТ улсын иргэн Ш-ийг хилээр гарахыг түдгэлзүүлэх хүсэлтийг хүлээн авч, холбогдох газарт хүргүүлсэн нь Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1-д "шүүгч нь хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, хууль " дээдлэх, үнэнч шударга байх, аливаа асуудалд бодитой, төвийг сахисан байр сууринаас хандах, хараат бус байх, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандах...", мөн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 1-д "Шүүгч нь хэргийн оролцогчдод эрх тэгш, төвийг сахисан, хүнлэг ёсоор хандаж, хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлэхүйц харилцааны соёлыг эзэмшсэн байна", 3.3 дугаар зүйлийн 1-д "Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй" гэж заасан хэм хэмжээг зөрчсөн талаарх Шүүхийн Ёс зүйн хорооны дүгнэлт үндэслэлтэй.

Иймд шүүгч Х.Э-д сануулах сахилгын шийтгэл ногдуулсан Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 64 дүгээр магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэв.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.1 дэх заалтыг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 64 дүгээр магадлалыг хэвээр үлдээж, шүүгч Х.Э-гийн давж заалдах гомдлыг хангахгүй орхисугай.

2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.5 дахь хэсэгт заасны дагуу магадлалыг эс зөвшөөрвөл хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч гардан авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.БАТБААТАР

ШҮҮГЧ

С.МӨНХЖАРГАЛ

ШҮҮГЧ

Д.БААТАРХҮҮ



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД
ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ШАТНЫ ЗАХИРГААНЫ
ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2018 оны 4 сарын 23 өдөр

Дугаар 188

Улаанбаатар хот

Г.Б-ийн гомдолтой, А дүүргийн Иргэний
хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Х.Э-д
холбогдох сахилгын хэргийн тухай

Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх
хуралдааны бүрэлдэхүүн:

Даргалагч: шүүгч Ч.Тунгалаг

Шүүгчид: Л.Атарцэцэг

Б.Мөнхтуяа

Д.Мөнхтуяа

Илтгэгч шүүгч: Г.Банзрагч

Нарийн бичгийн дарга: У.Батцэцэг

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 9 дүгээр сарын 08-ны
өдрийн 144 дүгээр тогтоол,

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 11 дүгээр сарын 17-ны
өдрийн 64 дүгээр магадлал,

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 02 дугаар сарын
13-ны өдрийн 221/ЁМ2018/0004 дүгээр магадлал,

Шүүх хуралдаанд оролцогч:

Гомдол гаргагч: Г.Б

Шүүгч: Х.Э нар,

Шүүгч Х.Э-гийн хяналтын журмаар гаргасан гомдлыг үндэслэн хэргийг хянан
хэлэлцэв.

ТОДОРХОЙЛОХ нь:

Өмнөх шатны шийдвэр

1.Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 9 дүгээр сарын 08-ны
өдрийн 144 дүгээр тогтоолоор: А дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн
шүүгч Х.Э-д сахилгын хэрэг үүсгэсэн.

2.Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 11 дүгээр сарын 17-ны
өдрийн 64 дүгээр магадлалаар: Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35
дугаар зүйлийн 35.1, 35.2, 36 дугаар зүйлийн 36.1.2, 37 дугаар зүйлийн 37.1.1,
Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйл, Шүүхийн Ёс зүйн хорооны
дүрмийн 5.7.1, 5.13-т заасныг тус тус удирдлага болгон А дүүргийн Иргэний хэргийн
анхан шатны шүүхийн шүүгч Х.Э-д сануулах сахилгын шийтгэл ногдуулсан.

3.Захиргааны хэрэийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 02 дугаар сарын
13-ны өдрийн 221/ЁМ2018/0004 дүгээр магадлалаар: Монгол Улсын Шүүхийн ёс

УИХ.МН
СУДАЛГААНЫ САН

зүйн хорооны 2017 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 64 дүгээр магадлалыг хэвээр үлдээж, шүүгч Х.Э-гийн давж заалдах гомдлыг хангахгүй орхисон.

Хяналтын журмаар гаргасан гомдол

4. Давж заалдах шатны шүүх Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалын үндэслэлд эрх зүйн дүгнэлт хийгээгүй орхигдуулсан, холбогдох хуулийг буруу тайлбарлан хэрэглэсэн.

4.1. Давж заалдах шатны шүүхийн магадлалын Хянавал хэсгийн агуулгад тусгагдсан хууль зүйн үндэслэлийг авч үзвэл, холбогдох хуулийг буруу тайлбарлан хэрэглэсэн байна. Тухайлбал, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 124 дүгээр зүйлийн 124.1-д “Энэ хуулийн 123.1-д заасны дагуу гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж илт үндэслэл муутай бол тухайн шүүх бүрэлдэхүүн тогтоол, шүүгч захирамж гарган хүчингүй болгох, эсхүл өөрчилж болно.” гэж заажээ. Энэ дагуу гаргасан шүүгчийн захирамжийн агуулгад дүгнэлт хийж, хянах бүрэн эрх хэмжээ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд байхгүй. Учир нь, тухайн захирамжийг ерөнхий харьяаллын шүүх гаргасан тул харьяаллын хувьд хамааралгүй. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх бүрэн эрхийн хүрээнд шүүгч Х.Э миний бие ёс зүйн зөрчил хэрхэн гаргасан эсэхийг л хянах үүрэгтэй тул иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамааралтай дээрх хуулийг тайлбарлан хэрэглэсэнээрээ алдаа гаргалаа.

4.2. Монгол Улсын Шүүхийн Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1, мөн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 1, 3.3 дугаар зүйлийн 1-д заасан хэм хэмээг зөрчсөн талаарх Шүүхийн Ёс зүйн хорооны дүгнэлт үндэслэлтэй гэж давж заалдах шатны шүүх үзжээ. Харин шүүгч Х.Э миний бие дээрх дүрмийн заалтын аль хэсгийг ёс зүйн ямар зөрчлөөр яаж зөрчсөн гэх үйл баримтыг Шүүхийн ёс зүйн хороо тухайлан тодорхойлоогүй алдааг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх зөвтгөж чадаагүй байна. Учир нь, дүрмийн агуулгаар 1/хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, 2/хууль дээдлэх, 3/үнэнч шударга байх, 4/аливаа асуудалд бодитой, төвийг сахисан байр сууринаас хандах, 5/хараат бус байх, 6/үүрэгт ажилдаа хариуцлагатай хандах, 7/хэргийн оролцогчдод эрх тэгш, төвийг сахисан, хүнлэг ёсоор хандах, 8/хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлэхүйц харилцааны соёлыг эзэмшсэн байна, 9/хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх, 10/биелэлтэд хяналт тавих зэрэг олон төрлийн ашиг сонирхлын шаардлагын хэм хэмжээг шүүгч миний бие бүхэлд нь хэрхэн зөрчсөн, энэ нь яагаад ёс зүйн зөрчил болон хувирч буй хэм хэмжээний шалгуур нь Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал болон Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалд тусгагдаж байж хариуцлага хүлээлгэх учиртай. Иймд шүүгч миний бие дээрх олон төрлийн шалгуурыг бүгдийг нэг захирамжаар зөрчих боломжгүй тул шүүхийн зүгээс асуудлыг хуульд нийцүүлэн нягтлан дүгнэлт хийж чадаагүй гэж үзэж байна. Тухайлбал, “хууль дээдлэх” шаардлагыг хэрхэн зөрчсөн, хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлэхүйц харилцааны соёлыг эзэмшээгүй, биелэлтэд хяналт тавиагүй ямар алдаа гаргасан зэргээр зөрчлийг тодорхойлсон байх ёстой. Нөгөөтэй гүүр “хараат бус байх” шалгуурыг чин шударгаар хангаж ажилласны төлөө эсрэгээрээ миний бие зөрчсөн болж байгаад маш их гомдолтой байна.

5. Давж заалдах шатны шүүх гомдлыг хянан шийдвэрлээгүй алдааны талаар:

5.1. Шүүгч Х.Э миний бие Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 64 дүгээр магадлалыг 1/ шүүгчийн захирамжийн агуулга руу орж дүгнэлт хийж, шүүгчийн хараат бус байдалд халдсан, 2/ гадаадын иргэн, харьяатын газраас гаргасан шийдвэрийн зөв буруугийн асуудлыг дүгнэж, эрх хэмжээгээ хэтрүүлсэн, 3/эрх зүйн дүгнэлтүүд хоорондоо зөрчилтэй, ёс зүйн зөрчилд хамаагүй эх сурвалжийг иш татаж, шүүгчийг ёс зүйн зөрчил гаргасныг батлах зорилгоор хийсвэрлэн

дүгнэсэн гэх үндэслэлүүдээр Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалыг эс зөвшөөрч гомдол гаргасан. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх дээрх гомдлын үндэслэлийг хүлээн авах эсэх талаар огт дүгнэлт хийгээгүй байна. Иймд давж заалдах шатны шүүх Х.Э миний гомдлыг шийдвэрлээгүй гэж үзнэ. Зүй нь тухайн гомдлыг хүлээн авах эсэх, гомдлыг хангахгүй орхих хууль зүйн үндэслэлийг тодорхойлох нь Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн үндсэн үүрэг байх учиртай.

5.2.Хэргийн маргалдагч талуудаас шүүхэд гаргасан хүсэлтийг шүүгч шийдвэрлэх үүрэгтэй. Шүүгчийн ажлын ачаалал, бусад хэрэгт хийх ажиллагаа, олон шүүх хурлын давхцал, ээлжийн амралт зэрэг урсгал ажиллагаанаас хамааран талуудын хүсэлтийг боломжоороо шийдвэрлэж явдаг. Талуудын тэгш байдлыг хангахын тулд аль нэг талын гаргасан хүсэлтийг шийдвэрлэх хоногийг харьцуулан тоолж, адил хугацаатай шийдвэрлэх ёстой гэсэн агуулгаар шүүх дүгнэснийг хүлээн зөвшөөрөхгүй байна. Энэ нь ямар эрх зүйн үндэслэл, журмаар ёс зүйн зөрчил болж буй үндэслэл нь магадлалд тусгагдаагүй ажээ. Энэ утгаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хуулиар тогтоосон хугацаанаас гадна үйл ажиллагааг хугацаанд оруулан тооцох шинэ журам бий болгох эрх Захиргааны давж заалдах шатны шүүхэд байхгүй гэж үзэж байна. Иймд шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх үндсэн зарчим зөрчигдөж байна.

5.3.Нөгөөтэй гүүр шүүхийн хугацаа тоолж буй 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 07374 дугаар шүүгчийн захирамжид хариуцагч гомдол гаргаж, ерөнхий шүүгч хүлээж аваад гомдол хянан хэлэлцэх ажиллагаа явуулж, шүүх хуралдаанаар бүрэлдэхүүнтэйгээр гомдлыг шийдвэрлэсэн ажиллагааны талаарх баримт хэрэгт авагдсан байхад нягтлан судалж үзэхгүйгээр "...хариуцагч талын хүсэлтийг 2 сарын дараа шийдвэрлэсэн бол нэхэмжлэгч талын хүсэлтийг 14 хоногт шуурхай шийдвэрлэж, нэхэмжлэгч талд илүү хандсан гэж ойлгогдож байна" гэж шүүгч намайг буруутгажээ. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гомдол гаргах эрхээ эдэлсэн хариуцагчийн өмнөөс шүүгч намайг ийнхүү хугацаа тоолон буруутгасан нь 1/давж заалдах шатны шүүх хэргийн материалтай бүрэн танилцаж, судлан үзээгүй, 2/Шүүхийн Ёс хороонд хариуцагчийн зүгээс ТТТ улсын иргэнийг Монгол Улсын хилээр гарахыг хориглосон захирамж гаргасан гэх гомдлын үндэслэлийг хянаагүй, 3/ Ёс зүйн хороогоор хянагдсан гомдлоос өөр үндэслэлээр хэргийг шийдвэрлэж эрх хэмжээгээ хэтрүүлсэн, 4/ Ёс зүйн зөрчил, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг ялган зааглаж чадаагүйгээс хууль зүйн үндэслэлгүй шийдвэр гаргалаа.

6.Дээрх үндэслэлээр Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 64 дүгээр магадлал, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 221/ЁМ2018/0004 дүгээр магадлалыг тус тус хүчингүй болгож өгнө үү гэжээ.

ХЯНАВАЛ:

7.Ёс зүйн хорооны магадлал, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байна.

8.“Давж заалдах шатны шүүх Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалын үндэслэлд эрх зүйн дүгнэлт хийгээгүй орхигдуулсан, холбогдох хуулийг буруу тайлбарласан”, “давж заалдах шатны шүүхэд гаргасан гомдлыг хянан шийдвэрлээгүй” гэх / тогтоолын Тодорхойлох хэсгийн 4, 5-д/ шүүгч Х.Э-гийн гомдлыг хяналтын шатны шүүхээс дараах үндэслэлээр хангасангүй. Үүнд:

8.1.Давж заалдах шатны шүүхээс “хариуцагч болон нэхэмжлэгчийн гаргасан хүсэлтийг шийдвэрлэхдээ хангалттай, бодитой үндэслэл дурдаагүй нь ТТТ улсын иргэнийг хилээр гарахыг түдгэлзүүлэх санал гаргах үндэслэл байсан

эсэхэд эргэлзээ үүсгэж байгаа, талуудын хүсэлтүүдийг цаг хугацааны хувьд ялгамжтайгаар шийдвэрлэсэн нь нэхэмжлэгч талд илүү хандсан гэж ойлгогдохоор байна..." гэсэн агуулгатай Ёс зүйн хорооны дүгнэлтийг үгүйсгэх боломжгүй" гэсэн дүгнэлтийг хийсэн нь тус шүүхээс шүүгч Х.Э-гийн үйлдэлд дүгнэлт өгснөөс бус, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 124 дүгээр зүйлийн 124.1 дэх хэсгийн дагуу гарсан шүүгчийн захирамжийн агуулгад дүгнэлт хийж, эрх хэмжээгээ хэтрүүлсэн гэж үзэхгүй тул тогтоолын Тодорхойлох хэсгийн 4.1-д заасан гомдол үндэслэлгүй.

8.2.Ёс зүйн хорооны магадлалаар "шүүгч Х.Э нь нэхэмжлэгчийн хүсэлтийг хүлээн авч, 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 102/ШЗ2017/07373 дугаартай захирамж гаргасан нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар шүүгчид олгоогүй эрхийг эдэлсэн тул Монгол Улсын Шүүхийн Шүүгчийн Ёс зүйн хорооны дүрмийн 1.3 дугаар зүйлд заасан "хууль дээдлэх"; 3.3 дугаар зүйлийн 1-д заасан "хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд нь хяналт тавих үүрэгтэй" гэснийг; хүний /гадаадын иргэний/ гадаадад явах эрх болон аливаа улсыг орхин явах эрхийг эдлүүлэх болон хязгаарлахтай холбоотой Монгол Улсын Үндсэн хуулийн болон холбогдох олон улсын гэрээний тодорхой заалтууд, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар шүүгчид олгосон эрх хэмжээний талаарх илэрхий заалтуудыг зөрчсөн нь "хууль дээдлэх" болон "хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх" гэснийг, хэргийн оролцогчдын хүсэлтийг цаг хугацааны хувьд ялгамжтай байдлаар, бодит үндэслэл заалгүй шийдвэрлэсэн нь "хэргийн оролцогчдод эрх тэгш, төвийг сахисан, хүнлэг ёсоор хандах", "хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлэхүйц харилцааны соёлыг эзэмшсэн байна" гэсэн Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1, 3.2 дугаар зүйлийн 1, 3.3 дугаар зүйлийн 1-д заасан хэм хэмжээг зөрчсөн..." зэргээр нэг бүрчлэн дүгнэсэн байх бөгөөд үүнийг давж заалдах шатны шүүхээс үндэслэлтэй гэж үзсэн нь "эдгээр олон хэм хэмжээг шүүгч миний бие бүхэлд нь хэрхэн зөрчсөн, энэ нь яагаад ёс зүйн зөрчил болон хувирч буйг нэг бүрчлэн тусгаж байж хариуцлага хүлээх ёстой, нэг захирамжаар дээрх олон шалгуурыг зөрчих боломжгүй..." гэх утгатай уг тогтоолын Тодорхойлох хэсгийн 4.2-т заасан гомдлыг хангах боломжгүй.

8.3.Дээр дурдсанчлан давж заалдах шатны шүүхээс шүүгчийн захирамжийн агуулгад нь бус харин шүүгчийн үйлдэлд нь дүгнэлт хийсэн Ёс зүйн хорооны дүгнэлтийг хүлээн зөвшөөрч хэвээр үлдээсэн, шүүгч Х.Э-гийн давж заалдах гомдлын хүрээнд хэргийг хянан шийдвэрлэж, "гомдлыг хүлээн авах боломжгүй" гэсэн дүгнэлтийн үндэслэлээ магадлалд тодорхой заасан байх тул /магадлалын Хянавал хэсэгт буюу 5 дахь хуудасны дээрээсээ 2 дахь догол мөрөнд/ энэ тогтоолын Тодорхойлох хэсгийн 5.1-д заасан гомдол үндэслэлгүй.

8.4.Хэргийн оролцогчдын хүсэлтийг шийдвэрлэсэн цаг хугацаа, үйл баримттай нь холбогдуулан шүүгч Х.Э-г ёс зүйн зөрчил гаргасан гэсэн дүгнэлтийг Ёс зүйн хорооноос хийсэн бөгөөд түүнийг давж заалдах шатны шүүхээс үндэслэлтэй гэж дүгнэсэн нь "шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хуулийн хугацаанаас гадна үйл ажиллагааг хугацаанд оруулан тооцох шинэ журам бий болгосон..." гэж үзэхгүй тул тогтоолын Тодорхойлох хэсгийн 5.2, 5.3-т заасан гомдлыг хангах боломжгүй.

9.Дээр дурдсан үндэслэлээр "давж заалдах шатны шүүх хэргийн материалтай бүрэн танилцаж, судлан үзээгүй, ёс зүйн хорооны магадлалд гаргасан гомдлын үндэслэлийг хянаагүй, Ёс зүйн хороогоор хянагдсан гомдлоос өөр үндэслэлээр хэргийг шийдвэрлэж эрх хэмжээгээ хэтрүүлсэн, ёс зүйн зөрчил, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг ялган зааглаж чадаагүй" гэх /Тодорхойлох хэсгийн 5.3-т/ үндэслэл тогтоогдохгүй байх тул шүүх бүрэлдэхүүнээс шүүгч Х.Э-

гийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангалгүй орхиж, Ёс зүйн хорооны магадлал болон давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээхээр тогтов.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.1, 127.2.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 64 дүгээр магадлал, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 221/ЁМ2018/0004 дүгээр магадлалыг тус тус хэвээр үлдээж, шүүгч Х.Э-гийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангахгүй орхисугай.

ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ

Ч.ТУНГАЛАГ

ШҮҮГЧ

Г.БАНЗРАГЧ



МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЁС ЗҮЙН ХОРООНЫ МАГАДЛАЛ

2018 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 78

Улаанбаатар хот

П дүүргийн Иргэний хэргийн анхан шатны
шүүхийн шүүгч Н.С-д сахилгын шийтгэл
ногдуулах тухай

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааныг тус хорооны гишүүн А.Доржготов даргалж, гишүүн В.Жавхлан, Д.Сүнжид, Ч.Оюунцэцэг, Н.Эрдэнэцогт нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны тэмдэглэл хөтлөгчөөр шинжээч Ч.Ханддулам, референт Ж.Халиун, гомдол гаргагч өмгөөлөгч М.А, С.Э нарыг оролцуулан Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдааны танхимд хийв.

П дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Н.С-д сахилгын хэрэг үүсгэж шийдвэрлэсэн Шүүхийн Ёс зүйн хорооны 2018.07.06-ны өдрийн 117 дугаар тогтоолтой сахилгын хэргийг тус хорооны дарга Н.Эрдэнэцогтын илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Өмгөөлөгч Б.Б, М.А, С.Э нар гомдолдоо: "Б.М-ийн нэхэмжлэлтэй "ННН" ХХК-д холбогдох Иргэний хэргийг хянан шийдвэрлэсэн шүүгч Н.С-ийн Шүүгчийн Ёс зүйн талаарх Бангалорын зарчмын "Шүүгч зөвхөн үйл баримтад хийсэн дүгнэлт болон хуульд тулгуурлан шүүн таслах чиг үүргээ үр нөлөөтэй, шударга, түргэн шуурхай хэрэгжүүлэх", Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1 дүгээр зүйлийн 1,3-д заасан "Шүүгч хууль дээдлэх зарчим", дүрмийн 3 дугаар зүйлийн 3.3-д заасан "Шүүгч хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх", Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.6, 1.7, Шүүгчийн ёс зүйн дүрмийн 2 дугаар зүйлийн 2.3-д заасан "Шүүгч нь зохисгүй үйлдэл гаргахгүй байх" үүргүүдээ зөрчиж, процессын шууд тодорхой заасан заалтыг удаа дараа зөрчсөн төдийгүй хариуцагч талын итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч нарын Үндсэн хуульд заасан хууль зүйн туслалцаа авах, шударгаар шүүлгэх, хөдөлмөрлөх, ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгож, эрхлэх, халдашгүй чөлөөтэй байх зэрэг эрхүүдийг зөрчсөн шүүгчийн ёс зүйн зөрчилд тооцогдох илэрхий мэргэжлийн алдаануудыг санаатайгаар гаргасан үйлдлийг шалгуулахаар энэхүү гомдлыг гаргаж байна.

Шүүгчийн Ёс зүйн зөрчилд тооцогдох илэрхий мэргэжлийн алдаануудыг санаатайгаар гаргасан гэх гомдол гаргах болсон эрх зүйн үндэслэл Шүүгчийн ёс зүйн зөрчил болон мэргэжлийн алдааг хэрхэн зааглах талаар олон улсад тогтож байгаа үзэл баримтлал нь шүүгч: (1) хэн ч ойлгохоор хуулийн заалтыг буруу тайлбарлан хэрэглэсэн, (2) өш хонзон, уур бухимдал, ялгаварлан гадуурхах зэрэг "зүй бус" сэдэлд хөтлөгдөн шийдвэр гаргасан, (3) хүний үндсэн эрх, процессын шаардлагыг зөрчсөн тохиолдолд ёс зүйн зөрчил гэж тооцдог. Гэхдээ үүнээс Монгол Улсад тогтсон жишиг буюу "тодруулбал, зөвхөн дараах 2 нөхцөл хангагдсанаас бусад тохиолдолд шүүгчийн хууль хэрэглэсэн алдаанд хариуцлага хүлээлгэхгүй: (1) Үндсэн хуулиар илэрхий хамгаалагдсан үндсэн эрх, эрх чөлөөг зөрчсөн, эсхүл (2) хэн ч маргахгүй хуулийн тодорхой заалтыг зөрчсөн. ялангуяа

удаа дараа зөрчсөн зэрэг болно. Шүүгч санаатайгаар мэргэжлийн алдаа гаргасан, шууд тодорхой заасан хуулийн заалт болон процесс зөрчсөн, хүний үндсэн эрх, эрх чөлөөг зөрчсөн зэрэг тохиолдолд хариуцлага хүлээлгэдэг. Мөн өмнө илэрхий ИХШХШТХ-ийн шууд тодорхой заасан заалт болон Үндсэн хуульд заасан хариуцагч “ННН” ХХК-ийн эрхийг эдлүүлэхгүй хэт нэг талд давуу байдал олгох зэрэг үйлдэлд нь холбогдуулан энэхүү хэрэгт Шүүгчийн Ёс зүйн хороонд өмнө гомдол гаргаж байсан болохыг дурдах зүйтэй болов уу. Иймд дээрх үндэслэлийн дагуу дараах тодорхой үйл баримтуудад тулгуурлан энэхүү гомдлоо тодорхойлон үндэслэж буйг анхаарч үзнэ үү.

Үндсэн хуулиар илэрхий хамгаалагдсан үндсэн эрх, эрх чөлөөг зөрчсөн гэх үндэслэлийн хувьд: Тус хэргийг 2018.02.28-ны өдөр анхан шатны журмаар хянан хэлэлцэхээр хурлыг товлосон бөгөөд энэхүү хурлыг товлхоос эхлүүлэн шийдвэр уншиж сонсох хүртэлх хугацаанд шүүгч Н.С нь хариуцагч талын Үндсэн хуулиар хамгаалагдсан өмгөөлөгч авах, ажил мэргэжлээ чөлөөтэй сонгож хөдөлмөрлөх, шударгаар шүүлгэх, халдашгүй чөлөөтэй байх, шүүн таслах ажиллагаанд тэгш оролцох, мэтгэлцэх боломжоор хангуулах зэрэг эрхийг ноцтойгоор зөрчсөн.

Өмгөөлөгч М.А, Б.Б нараас шүүх хуралдаан давхацсан үндэслэлээр шүүх хуралдааныг хойшлуулах тухай хүсэлт, өмгөөлөгч Б.О-ийн зүгээс өвчний улмаас шүүх хуралдаанд оролцох боломжгүй тул шүүх хуралдааныг хойшлуулах тухай хүсэлт, итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Э-ийн зүгээс өмгөөлөгчтэйгөө шүүх хуралдаан оролцож, өмгөөлүүлэх эрхээр хангуулах тухай.

Итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Э-ийн зүгээс өмгөөлөгч авах, өмгөөлүүлэх эрхээр хангуулах тухай хүсэлтүүдийг тус тус шүүх хуралдаан эхлэхээс өмнө ирцтэй холбоотой асуудлыг шалгах үед гаргасан. Гэтэл анхан шатны шүүхийн шүүгч Н.С нь: Өмгөөлөгч М.А, Б.Б нараас шүүх хуралдаан давхацсан үндэслэлээр шүүх хуралдааныг хойшлуулах тухай хүсэлтийг 2018 оны 101/ШЗ2018/04059 дүгээр шүүгчийн захирамжаар “Талуудын хүсэлтийг үндэслэн шүүх хуралдааны товыг өөрчлөн тогтоох боломжтой бөгөөд хариуцагчийн өмгөөлөгч Б.Б, М.А нар дээрх хүсэлтийг энэ өдрийн хуралдаанд гаргаж байгаа нь хүндэтгэх шалтгаангүй байна. 3 дүүргийн шүүхэд 2018.02.28-ны өдрийн 08 цаг 30 минутад товлөгдсөн Ц.Б-ийн нэхэмжлэлтэй ООО ТӨҮГ-т холбогдох хэргийн шүүх хуралдаан хойшилсон байна” гэж үзэж хүсэлтийг хангахаас татгалзсан. Гэтэл тус өдрийн шүүх хуралдааныг шүүгчийн нарийн бичиг С.Н нь ажлын 2-3 хоногийн өмнө тулгаж товлосон бөгөөд тус товлосон өдөр нь өмгөөлөгч Б.Б болон М.А нарт өөр иргэний хэргийн шүүх хуралдааны тов товлөгдсөн байсан. Энэ нь 2018.02.28-ны өдрийн 08 цаг 30 минутад 3 дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд Ц.Б-ийн нэхэмжлэлтэй, “ООО” ТӨҮГ-т холбогдох иргэний хэргийн шүүх хуралдаан товлөгдсөн бөгөөд тус хэрэгт өмгөөлөгч М.А болон Б.Б нар нь нэхэмжлэгчийн өмгөөлөгчөөр оролцохоор байсан. Энэхүү иргэний хэргийн шүүх хуралдааныг 20 хоногийн өмнө 02.08-ны өдрийн шүүх хуралдааныг хойшлуулж, товыг мэдэгдсэн шүүх хуралдаан болно. Энэхүү шүүх хуралдаан нь тус өдрийн 08 цаг 30 минутад товлөгдсөн боловч 08 цаг 45 минутад эхэлсэн бөгөөд 09 цаг 20 минутад хүсэлт хэлэлцэхээр завсарласан.

Б.Б өмгөөлөгчийн хувьд: 2018.02.26-ны өдөр Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 15 цагаас “ЛЛЛ” ХХК-ийн нэхэмжлэлтэй хэрэгт нэхэмжлэгчийн өмгөөлөгч, МУ-ын Дээд шүүхэд 13 цаг 30 минутаас н.О-гийн нэхэмжлэлтэй, Ф аймгийн Засаг даргад холбогдох захиргааны хэрэгт хариуцагчийн өмгөөлөгчөөр, 2018.02.27-ны өдөр Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүхэд Ч.Б-гийн нэхэмжлэлтэй, Ф аймгийн Засаг даргад холбогдох захиргааны хэрэгт хариуцагчийн өмгөөлөгчөөр, 3 дүүргийн Иргэний хэргийн Анхан шатны шүүхэд 10 цагаас Я.Ж-ийн нэхэмжлэлтэй иргэний хэрэгт нэхэмжлэгчийн өмгөөлөгчөөр тус тус оролцож байсан бөгөөд энэхүү давчуу товлосон шүүх хуралдаан дээр шүүх хуралдааныг

хойшлуулах тухай хүсэлтийг хоёр өмгөөлөгчийн зүгээс бэлтгэж, холбогдох баримтыг хавсарган итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Э-д өгч шүүх хуралдаан дээр хүсэлтийг гаргуулсан. Гэтэл анхан шатны шүүх нь үндэслэлгүйгээр өмгөөлөгч бидний хүсэлтийг нэгэнт эхэлсэн шүүх хуралдааныг орхиж гарах боломжгүй нөхцөл байдал болон дээр дурдсан үндэслэлүүдийг харгалзан үзэлгүй хэт нэг талыг барьж хүсэлтийг шийдсэн нь үндэслэлгүй болно.

Итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Э миний зүгээс өөрийн 3 өмгөөлөгчийнхөө өгсөн хүсэлтийг шүүх хуралдаан дээр уншиж, энэхүү шүүх хуралдаанд өмгөөлөгч нартайгаа оролцож, өмгөөлүүлэх эрхээр хангахыг шүүхээс хүсэхэд завсарласан байх үедээ шүүгч Н.С өөрийн туслах С.Н-г шүүх хуралдааны танхимд дуудан өмгөөлөгч Б.Б, М.А нарын оролцож байгаа Ж.Ц шүүгчийн шүүх хуралдаан үргэлжилж байгаа эсвэл дууссан талаар лавлаж ирэхийг даалгасан. Хүсэлтийг шийдвэрлээд хэргийн оролцогчид шүүх хуралдааны танхимд орж ирсний дараа шүүгчийг шийдвэрээ уншихаас өмнө шүүгчийн туслах С.Н хурлын зааланд орж ирээд "өмгөөлөгч Б.Б, М.А нарын оролцож буй шүүх хуралдаан хойшлогдсон байна. Өмгөөлөгч Б.Б, М.А нар гадаа хүлээж байна" гэж хэлэхэд шүүгч Н.С санаатайгаар хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хууль ёсны эрхийг эдлүүлэхгүй байх зорилгоор хүсэлтийг хангахаас татгалзаж шийдвэрлэж, хурлыг үргэлжлүүлэхдээ өмгөөлөгч нарыг маань хамт оруулахгүй байхаар шийдвэрлэсэн.

Итгэмжлэгдсэн төлөөлөгч миний хоёр өмгөөлөгчийг "давхацсан гэх шүүх хуралдаан нь хойшлогдсон" гэх үндэслэлээр шүүх хуралдааныг үргэлжлүүлж байгаа тохиолдолд нэхэмжлэгч намайг өмгөөлөгчтэйгөө цааш шүүх хуралдааныг үргэлжлүүлэх эрхийг шүүх хангах үүрэгтэй. Гэтэл миний хоёр өмгөөлөгчийн хурал хойшлогдсон гээд тухайн хоёр өмгөөлөгч нь шүүх хуралдааныг надтай хамт үргэлжлүүлэхээр шүүх хуралдаанд ороод ирсэн байхад шүүгч нь шүүх хуралдаанд өмгөөлөгчөөр оролцохыг хориглож, сонирхогч этгээдээр оролцуулахаар шийдвэрлэсэнд маш их гомдолтой байна. С.Э миний өмгөөллийн хөлсөө төлж, эрх зүйн гэрээ байгуулсан өмгөөлөгч нарыг үндэслэлгүйгээр өмгөөлөгчөөр оролцохыг хориглож, сонирхогч этгээдээр байлцуулсанд гомдолтой байна. Шүүх хуралдааны бүхий л үе шатанд өмгөөллийн хөлсийг төлсөн байсан өмгөөлөгч маань миний хажууд байгаа мөртөө үг ч хэлэх эрхгүйгээр сонирхогч этгээдээр суусан. Шүүгчийн энэхүү үйлдэл нь С.Э миний үндсэн хуульд тусгасан өмгөөлүүлэх эрхийг ноцтой зөрчсөн бөгөөд энэхүү нөхцөл байдалд маш их гомдолтой байна.

Итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Э миний 3 өмгөөлөгчийг ийнхүү дээрх үндэслэлгүй нөхцөл байдлын дагуу шүүх хуралдаанд өмгөөлөгчөөр биечлэн оролцох хүсэлтийг хангахаас татгалзаж шийдвэрлэсний дагуу С.Э миний бие тус шүүх хуралдааныг ганцаараа цааш үргэлжлүүлэх нөхцөл байдал үүссэн. Гэтэл тус хэрэг нь ихээхэн маргаантай, ээдрээ төвөгтэй, 8- аад тэрбум төгрөг буюу үнийн дүн өндөртэй томоохон маргаан байсан бөгөөд энэхүү хэрэгт гурвын гурван өмгөөлөгч авсан нь ийм учиртай болно. Тиймдээ ч тус хуралдаанд оролцох байсан өмгөөлөгч бүр нь өөр өөрийн гэсэн үүрэгтэйгээр шүүх хуралдаанд оролцохоор бэлтгэсэн байсан боловч энэ бүх үүрэг нь ганцхан С.Э миний өмнө тулж ирсний дагуу С.Э миний бие энэ бүх нөхцөл байдлыг зөвөөр шийдвэрлэхээр, итгэмжлэгч этгээдийн үүрэг хариуцлагыг ухамсарласны дагуу "өмгөөлөгч авах хүсэлт"-ийг тавьсан. Гэтэл шүүхээс "энэ эрх үүргээ өмнө нь хэрэгжүүлэх боломжтой байсан" гэх үндэслэлээр хүлээн авахаас татгалзсан. Гэтэл тус өдрийн шүүх хуралдаанд өмгөөлөгчтэй холбоотой эрх үүргээ итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Э миний бие хэрэгжүүлж, М.А, Б.Б, Б.О зэрэг 3 өмгөөлөгчийг авсан байсан. Харин шүүхээс өмгөөлөгч нарын шүүх хуралдаанд биечлэн оролцох хүсэлтүүдийг хангаж шийдвэрлээгүйгээс буюу шүүхийн шийдвэрийн дагуу тухайн мөчид С.Э миний бие өмгөөлөгчгүй, шүүх хуралдаанд оролцох нөхцөл бий болсон. Түүнээс биш итгэмжлэгдсэн төлөөлөгч

С.Э миний бие өмнө ерөөсөө өмгөөлөгч авахгүй байж байгаад шүүх хуралдаан дээр “өмгөөлөгч авъя” гээд ороод ирсэн асуудал биш юм. Ийнхүү дээрх 5 удаагийн үйлдлээр өмгөөлүүлэх, өмгөөлөгч авах. хөдөлмөрлөх, ажил мэргэжлээ чөлөөтэй сонгож, хэрэгжүүлэх. халдашгүй чөлөөтэй байх зэрэг эрхийг үндэслэлгүйгээр зөрчсөн.

Хэн ч маргахгүй хуулийн тодорхой заалтыг зөрчсөн, ялангуяа удаа дараа зөрчсөн гэх үндэслэлийн хувьд: Нэг/ ИХШХШТХ-ийн 91 дүгээр зүйлийн 91.1.3, 92.8-д заасныг тус тус үндэслэн гаргасан тус “П дүүргийн бүх шүүгчдээс татгалзах” тухай хүсэлтийг шийдвэрлэсэн үндэслэлийн хувьд шүүгч нь дараах илэрхий процессын хуулийн тодорхой заалтуудыг удаа дараа зөрчсөн. Тус П дүүргийн иргэний хэргийн бүх шүүгчдээс татгалзах тухай 10 хуудас бүхий хүсэлтийг хариуцагч талаас чухалчлан бэлтгэж. шүүхэд тавьсан бөгөөд “чухалчлан бэлтгэсэн” гэж онцолж буй гол үндэслэл нь тухайн 10 хуудас хүсэлт дээрээс тодорхой харагдах бөгөөд энэхүү гомдолд хавсаргав. Учир нь энэхүү иргэний хэргийг үүсгэхээс авхуулан хэргийг шийдвэрлэж дуусах хүртэл шүүгч нь “Нэхэмжлэгчийн эрх ашгийг нотлох баримтгүйгээр, үндэслэлгүйгээр процессын хуулиар зөрчин байж хангаж байсан атлаа хариуцагчийн гомдол гаргах, ИХШХША-нд оролцох наад захын эрхийг хангахгүй орхихын сацуу процесс зөрчиж, өдөр тутам хийгддэг шүүхийн процессын ажиллагаанд тавигддаг шаардлагуудыг зөвхөн хариуцагч талаас шаардаж, нэхэмжлэгч талаас ерөөсөө шаардахгүй нэг талд илт давуу байдлыг үүсгэж байсныг шүүхийн ажиллагаа бүрд, холбогдох баримтыг үндэслэн тайлбар хийж хүсэлтээ бэлдэн шүүхэд гаргасан билээ.

Гэтэл шүүгч Н.С уг хүсэлтийг шийдвэрлэхдээ: Энэхүү хүсэлтийг шүүгчээс татгалзаж буй буюу өөрөөс нь татгалзаж байна гэж шийдвэрлэсэн /энэхүү хүсэлтийг шийдвэрлэхээр завсарлаж орж ирсний дараа уншиж танилцуулахдаа ийнхүү үндэслэлийг барьж байсан/. Өөрөөр хэлбэл ИХШХШТХ-ийн 92 дугаар зүйлийн 92.8-ийг үндэслэж “бүх шүүгчдээс татгалзсан” хүсэлтийг өөрөөс нь татгалзаж байна гэж илэрхий мэдэн будилж шийдвэр гаргасан. Энэхүү үйлдэл дараах процессын хуулийн холбогдох тодорхой илэрхий заалтыг зөрчсөн.

а/ Шүүгч нь өөрөөс татгалзсан гэж үзэж хүсэлтийг шийдвэрлэсэн байлаа ч ИХШХШТХ-ийн 92 дугаар зүйлийн 92.6-д зааснаар “хэргийг дангаар шийдвэрлэж байгаа шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч шийдвэрлэж захирамж гаргана” гэж заасны дагуу шийдвэрлэх журамтай. Ерөнхий шүүгчийн эрх хэмжээний асуудлыг шүүгч Н.С нь өөрөө хэрэгжүүлж, илт өдөр тутам. тогтмол хэрэглэдэг процессын хуулиа санаатайгаар зөрчиж, шүүхийн бүх шүүгчээс татгалзсан хүсэлтийг өөрийнхөө буюу “шүүгчийн захирамж”-аар шийдвэрлэж, 2018.02.28-ны өдрийн 10/Ш32018/04060 дугаар захирамжийг гаргасан. Энэ утгаараа ерөнхий шүүгчийн захирамж гаргаж шийдвэрлэх асуудлыг хэргийг хянан шийдвэрлэж буй шүүгч захирамж гаргаж шийдвэрлэсэн.

б/ Хамгийн гол нь нэхэмжлэгч талаас хүсэлтээ ИХШХШТХ-ийн 92 дугаар зүйлийн 92.8-ийг удирдлага болгож, албан бичгийн утга гэх хэсэгт “Шүүхийн бүх шүүгчдээс татгалзах тухай” гэж цагаан дээр хараар тодорхойлон бичсэн, энэхүү хүсэлтийг шүүхэд гаргасан. Энэхүү хүсэлтийг ИХШХШТХ-ийн 92 дугаар зүйлийн 92.8-д зааснаар “шүүхийн бүх шүүгчдийг татгалзсан бол шүүгчдийн зөвлөгөөн олонхын саналаар шийдвэрлэн тогтоол гаргана” гэж заасны дагуу шүүгчдийн зөвлөгөөнөөр тогтоол гарган шийдвэрлэх асуудлыг шүүгч Н.С нь өөрөө дур мэдэн “шүүгчийн захирамж”-аар шийдвэрлэж, 2018.02.28-ны өдрийн 10/Ш32018/04060 дугаар захирамжийг гаргаж, тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний эрх хэмжээг эдэлж шийдвэр гаргасан. Ийнхүү хууль тогтоомжоор өөрт нь олгогдоогүй эрх хэмжээг хэрэгжүүлж шүүгчийн захирамж гаргасан бөгөөд захирамжийнхаа үндэслэлийг “хариуцагчийн өмгөөлөгч М.А, Б.Б нар нь шүүх хуралдаанд оролцоогүй

атлаа хүсэлт шийдвэрлэсэнтэй холбоотой шүүхийн бүх шүүгчдийг татгалзах тухай хүсэлтийг ирүүлснийг татгалзах хүсэлт гэж үзэн шийдвэрлэх үндэслэлгүй”, “шүүхийн хүсэлт шийдвэрлэсэнтэй холбоотойгоор шүүгчээс татгалзсан” зэргээр хүсэлтийг хангахаас татгалзаж, 2018.02.28-ны өдрийн 10/ШЗ2018/04060 дугаар “Хүсэлт шийдвэрлэх тухай” захирамжийг гаргасан нь ИХШХШТХ-ийн 103 дугаар зүйлийн 103.2- т зааснаар “Татгалзан гаргах хүсэлт гарвал түүнийг энэ хуулийн 92 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ” гэж заасныг зөрчиж, ИХШХШТХ-д тусгагдаагүй журмыг өөрөө санаачлан зохиож, шийдвэрлэсэн.

в/Хамгийн гол нь энэхүү хүсэлтийг хангаагүй орхисон гол үндэслэл нь “хариуцагчийн өмгөөлөгч нар нь шүүх хуралдаанд оролцоогүй атлаа хүсэлт шийдвэрлэсэнтэй холбоотой” шүүхийн бүх шүүгчдийг татгалзах тухай хүсэлтийг ирүүлснийг хүсэлт гэж үзэн шийдвэрлэх боломжгүй” гэжээ. Тус хүсэлтийг хариуцагч талаас өмгөөлөгч Б.Б, М.А, итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Э нар буюу 3 хүн гаргасан /хүсэлтийн хойно гарын үсэг зурагдсан/. Шүүхээс ядахдаа итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Э-ийн гаргасан гэдэг талаас нь хүртэл авч үзэж шийдвэрлэх үүрэгтэй. Мөн тус хүсэлтийг итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Э нь өөрөө биечлэн шүүх хуралдаан дээр амаараа уншиж, шүүхэд гаргасан бөгөөд тус 2018.02.28-ны өдрийн 10/ШЗ2018/04060 дугаар “Хүсэлт шийдвэрлэх тухай” захирамжийн “тодорхойлох нь:” гээд үгний дараа “Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Э шүүх хуралдаанд гаргасан хүсэлтдээ:” гэж захирамждаа бичгийн хэлбэрээр хүртэл тусгасан атлаа ийнхүү энэхүү хүсэлтийг итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Э-ийн гаргасан хүсэлтийн хүрээнд шийдвэрлэхгүй орхигдуулсан илт үндэслэлгүй болно. Ийнхүү С.Э итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хүсэлтийг санаатайгаар шийдвэрлээгүй нь ИХШХШТХ-ийн 25 дугаар зүйлийн 25.1.4-д “энэ хуулийн 91 дүгээр зүйлд заасан үндэслэлээр шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах” эрхтэй гэх заалтыг зөрчсөн.

г/ Хэргийн оролцогчийн статустай байгаа, эрх үүрэг тайлбарлагдсан ямар ч этгээд шүүхэд хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Ямар хариуцагч талаас өмгөөлөгч М.А, Б.Б нараас татгалзсан байсан бол шүүхээс ийнхүү хэргийн оролцогч биш этгээдийн гаргасан хүсэлт гэж үзэж, хангахаас татгалзах үндэслэлтэй. Тэрнээс биш үйлчлүүлэгч нь өмгөөлөгчөөсөө татгалзаагүй байхад шүүхээс өмгөөллийн үйл ажиллагааны хүрээнд үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийн дагуу хуульд зааснаар хэрэгжүүлсэн ажиллагааг “хуульд байхгүй” шүүх хуралдаанд биечлэн оролцоогүй этгээд” гэж үзэж, эрхийг нь хязгаарлах эрх зүйн үндэслэл хаа ч байхгүй болно.

Хоёр. Хариуцагчийн өмгөөлөгчөөр оролцуулахыг хориглон, сонирхогч этгээдээр оролцуулах нөхцөл байдлыг шийдвэрлэхдээ шүүгч нь энэ асуудалд хувийн үзэмжээрээ хандсан. Учир нь шүүх хуралдаанд өмгөөлөгч нарыг хэргийн оролцогчоор оролцуулахгүй, зөвхөн сонирхогч этгээдээр оролцуулах шийдвэрийг гаргахдаа шүүгч нь энэ асуудлыг шийдвэрлэсэн захирамжийг гаргаагүй, мөн ямар хуулийн зүйл заалтыг үндэслэж энэхүү шийдвэрээ гаргаснаа тайлбарлаагүй. Өмгөөлөгчийг сонирхогч этгээдээр байлцуулах тухай үндсэн эрхийг хязгаарласан шийдвэр гаргасан атлаа хавтаст хэрэгт албан ёсоор баталгаажуулаагүй нь ИХШХШТХ-ийн 123 дугаар зүйлийн 123.3-д “Шүүх хуралдааныг хойшлуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх, сэргээн явуулах, татгалзан гаргах тухай хүсэлтийг шийдвэрлэх болон шүүх хуралдааны бусад үед хянан шийдвэрлэж байгаа асуудлаар шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг бичгээр гаргана” гэх заалтыг шууд зөрчсөн. Мөн шүүх хуралдааны тэмдэглэл бичлэгээс үзвэл шүүгч нь өөрийн энэхүү захирамж, шийдвэрийн үндэслэлийг зөвтгөх шалтгаанаар ИХШХШТХ-ийн 98-106 дугаар зүйлд заасан журмыг зөрчиж, шүүхийн нарийн бичгээс ирц танилцуулмагц шууд шүүгчээс татгалзах үндэслэл болон эрх үүргийг

тайлбарлан үүний дараа "Ирцтэй холбоотой" хүсэлт байгааг хэргийн оролцогчоос асуусан. Ийнхүү ирцтэй холбоотой асуудал нь ИХШХШТХ-ийн 99 дүгээр зүйл, 100 дугаар зүйлд заасны дагуу шүүгчээс татгалзах, эрх үүрэг тайлбарлахаас өмнө хийгддэг бөгөөд хариуцагчийн ирцтэй холбоотойгоор ИХШХШТХ-ийн 100 дугаар зүйлийг үндэслэн гаргасан хүсэлтийг 105 дугаар зүйлээр зохицуулагддаг шүүх хуралдаан эхлэхээс өмнө шүүхэд гаргах хүсэлт болгож шийдвэрлэсэн. Ийнхүү ирцтэй холбоотой хүсэлтийг шийдвэрлэсний дараа "бүх шүүгчдээс татгалзах тухай хүсэлтийг үндэслэлгүйгээр өөрөө шийдвэрлэсний дараа хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс шүүгчийн илт процесс зөрчөөд байгаа үйлдэлд холбогдуулж гаргасан шүүгчээс татгалзах тухай дахин гаргасан хүсэлтийг шүүгч нь шийдэхдээ "татгалзах үе шатанд асуухад татгалзаагүй" гэх үндэслэлээр хүсэлтийг хангаагүй. Ийнхүү шийдвэрлэхдээ Захирамж гаргаагүй. Мөн өөрөө дахин ерөнхий шүүгчийн эрхийг эдэлж шийдвэрлэсэн. Гэтэл шүүх хуралдаан нээхэд энэхүү хүсэлтээ гаргаагүй гэдэг үндэслэлээр өөрөөс нь татгалзсан хүсэлтийг шийдвэрлэсэн нь ИХШХШТХ-ийн 92.6. 103.2-ийг тус тус зөрчихийн сацуу, энэхүү хүсэлтийг хүлээн авахаас татгалзаад буй "шүүх хуралдаан нээхээс өмнө асуухад гаргаагүй" гэдэг үндэслэл нь ИХШХШТХ-ийн 92 дугаар зүйлийн 92.1-д заасан "татгалзан гарах үндэслэл шүүх хуралдааны явцад тогтоогдвол тухайн үед нь мэдэгдэж татгалзан гарах үүрэгтэй" гэх заалтыг зөрчиж, шүүгчээс зөвхөн шүүх хуралдаан эхлэхийн өмнөх татгалзан гарахыг асуух үед л энэхүү хүсэлтийг гаргах эрхтэй мэтээр хуулийг санаатайгаар гуйвуулж тайлбарласан үндэслэлгүй болно. Мөн 106 дугаар зүйлийн дагуу хэрэг хэлэлцэж эхлэхээс өмнө 105 дугаар зүйлийн дагуу өмгөөлөгч авах" хүсэлт гаргахад энэхүү хүсэлтийг "өмнө шийдсэн" гээд хүлээн аваагүй болно. Энэ мэтээр хариуцагч талаас гаргасан хүсэлт, эрхээ хангуулахаар хийсэн алхам бүрийг шүүгч нь үндэслэлгүйгээр хангахаас татгалзсан бөгөөд энэхүү шийдвэрээ гаргахдаа дээр дурдсан процессын алдаануудыг гаргасан. 2017.11.15-ний өдөр 3683 тоот шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнд дүгнэлт гаргуулахаар хүргүүлжээ. Үүний дагуу тус ШШҮХ-ээс 2017.11.24-ний өдөр 10/5144 тоот албан бичгээр ШШҮХ-ээс П-ийн ИХАШШ-д танай шүүхийн шүүгч Н.С-ийн 101/Ш/32017/130997 дугаартай захирамжийн дагуу 5686 дугаартай дүгнэлт, шүүх шинжилгээний хуулийн 7.1-д заасны дагуу шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана гэж заажээ. 2017.11.16-ний өдрийн 3683 дугаартай дүгнэлт гаргуулах албан бичгийг үндэслэн дүгнэлт гаргуулах боломжгүй тул шинжилгээ хийхээс татгалзаж буцаасан. Гэтэл шүүгч Н.С 2017.11.29-ний өдөр 101 /111/32017/20335 дугаартай хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээн явуулах тухай шүүгчийн захирамж гаргасан. Уг захирамж дээр гарсан өдрөөс хойш 10 хоногийн дотор тухайн шүүхэд гомдол гаргах эрхтэй талаар дурдсан мөртөө хариуцагч талд танилцуулахгүйгээр яг тухайн өдрөө буюу 2017.11.29-ний өдөр 101/Ш/32017/20336 тоот шүүгчийн захирамж гарч шинжээч томилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх тухай захирамж дахин гаргасан.

Шүүгч Н.С нь Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 зүйлийн 170.1-д шүүгчийн захирамжийн талаар гарсан өдрөөс хойш 10 хоногийн дотор тухайн шатны шүүхэд гомдол гаргаж болно гэж заасан мөртөө хариуцагчийн хууль ёсны эрх ашгийг хангахгүй гомдол гаргах эрхийг хангаагүй Үндсэн хуульд заасан эрхийг хэрэгжүүлэхгүйг П дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүгч Б.М 2018.01.19-ны 101/Ш32018/01625 шүүгчийн захирамжаар харагдана. / Захирамжийг хавсаргав/. Эцэст нь хэлэхэд "Шүүгч нь хэрэг маргааныг дур зоргоороо биш зөвхөн хууль хэрэглэж, шийдвэрлэх" зарчмыг тусгайлан анхаарч өгнө үү. Иймд дээрх үндэслэлүүдийг харгалзан үзэж, П дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Н.С-ийн үйлдлийг шалган тогтоож, холбогдох арга хэмжээг авч өгнө үү" гэжээ.

П дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Н.С тайлбартаа: "...Б.М-ийн нэхэмжлэлтэй иргэний хэрэг нь шүүгчдийн зөвлөгөөний тогтоосон хуваарийн дагуу 2016.12.26-ны өдөр шүүгч Н.С надад хуваарилагдан ирсэн. Дээрх нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.5- д заасан нэхэмжлэгчийг төлөөлөх эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан үндэслэлээр 2016.12.26-ны өдрийн 165 дугаар захирамжаар хүлээн авахаас татгалзахад нэхэмжлэгчийн төлөөлөгч Д.Т уг захирамжид гомдол гаргасан. Шүүгчийн захирамжид гаргасан гомдлыг хэлэлцэх шүүх хуралдаан 2017.01.10-ны өдөр товлогдон мөн өдрийн 26 тоот тогтоолоор нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан захирамжийг хүчингүй болгосон бөгөөд шүүгч тогтоосон хуваарийн дагуу хэргийг хүлээн авсан. Нэхэмжлэгч Б.М-ийн улсын тэмдэгтийн хураамж төлөх хугацааг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэсэн бөгөөд энэ нь нэхэмжлэгчийг улсын тэмдэгтийн хураамж төлөхөөс чөлөөлсөн гэсэн ойлголт биш болно.

Шүүх Б.М-ийн нэхэмжлэлд 2017.01.13-ны өдрийн 1171 дугаар захирамжаар иргэний хэрэг үүсгэн хариуцагч "ННН" ХХК-ийн нэхэмжлэл гардан авах эрх олгосон итгэмжлэлтэй этгээдэд 2017.02.06-ны өдөр, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Э-д 2017.02.07-ны өдөр тус тус нэхэмжлэлийн хувийг гардуулан өгч, зохигчийн эрх, үүргийг тайлбарлаж өгсөн байна. Хариуцагч "ННН" ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч нар нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой дараах хүсэлтүүдийг гаргаж байжээ. Үүнд:

Хариуцагчийн өмгөөлөгч Б.Б нь "Иргэний хэрэг үүсгэх тухай" 2017.01.13-ны өдрийн 1171, шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах тухай 2017.01.13-ны өдрийн 1235 дугаар захирамжуудыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 124 дүгээр зүйлд заасны дагуу хянуулах хүсэлт гаргасан байна. Уг хүсэлтийг 2017.02.23-ны өдрийн 3940 дугаар бүхий захирамжаар хангахаас татгалзсан, өөрөөр хэлбэл хариуцагчийн өмгөөлөгч Б.Б-гийн хүсэлтүүдийг хүлээн авах үндэслэлгүй гэж үзсэн. Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Э-ийн 2017.01.13-ны өдрийн 1235 дугаар бүхий шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авсан захирамжид гомдол гаргах хугацаа сэргээлгэх хүсэлтийг хүлээн авч 2017.02.24-ний өдрийн 4080 дугаар захирамжаар уг захирамжид гомдол гаргах хугацааг сэргээсэн байна. Хариуцагч тал шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах тухай 2017.01.13-ны өдрийн 1235 дугаар захирамжид гомдол гаргасан ба тус шүүхийн 2017.03.16-ны өдрийн 125 тоот тогтоолоор "2017.01.13-ны өдрийн 1235 дугаар бүхий захирамжийг хэвээр үлдээж шийдвэрлэжээ. Хариуцагчийн өмгөөлөгч Б.Б 2017.03.15-ны өдөр "Нэхэмжлэгч Б.М-ээр улсын тэмдэгтийн хураамжийг төлүүлэх" хүсэлт гаргасныг 2017.03.28-ны өдрийн 5564 дугаар захирамжаар шийдвэрлэсэн ба нэхэмжлэгч Б.М 2017.03.27-ны өдөр П дүүргийн татварын хэлтсийн ...6167 тоот дансанд улсын тэмдэгтийн хураамжид 58.566.400 төгрөгийг төлсөн байна. 2017.03.30-ны өдрийн 5696 тоот "Шүүх хуралдаанаар хэргийг хэлэлцүүлэх тухай" шүүгчийн захирамжаар дээрх иргэний хэргийг хэлэлцэх шүүх хуралдааныг 2017.04.05-ны өдрийн 10 цаг 30 минутад хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн ба 2017.04.05-ны өдөр товлогдсон шүүх хуралдааныг хариуцагчийн өмгөөлөгч Б.Б-гийн өөр шүүхэд шүүх хуралдаанд оролцоно", хариуцагчийн өмгөөлөгч М.А-гийн "хэргийн материалтай танилцах" хүсэлтүүдийг хүлээн авч хойшлуулжээ. 2017.04.17-ны өдрийн /6823 тоот захирамж/ шүүх хуралдаанаар нэхэмжлэгч талын нотлох баримт гаргуулах, шинжээч томилуулах, хариуцагч талын үзлэг хийлгэх тухай хүсэлтүүдийг хүлээн авч нотлох баримт гаргуулахаар, үзлэг хийхээр, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнг шинжээчээр томилж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг

түдгэлзүүлжээ. Хариуцагчийн өмгөөлөгч Б.Б нь 2017.04.17-ны өдрийн 6823 тоот захирамжид гомдол гаргасны дагуу тус шүүхийн 2017.05.19-ний өдрийн 209 тоот тогтоолоор дээрх 6823 тоот захирамжийг хэвээр үлдээн шийдвэрлэсэн байна.

Б.Б, М.А нар хуралдаан давхацсан үндэслэлээр, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Э нь өмгөөлөгч авах эрхээ эдлэх үндэслэлээр тус тус шүүх хуралдаан хойшлуулах хүсэлт гаргасныг доорх байдлаар шийдвэрлэсэн байна. Үүнд:

Талуудын хүсэлтийг үндэслэн шүүх хуралдааны товыг өөрчлөн тогтоох боломжтой бөгөөд хариуцагчийн өмгөөлөгч Б.Б, М.А нар дээрх хүсэлтийг энэ өдрийн хуралдаанд гаргаж байгаа нь хүндэтгэх шалтгаангүй, мөн тэдний оролцож байгаа гэх 3 дүүргийн шүүхэд 2018.02.28-ны өдрийн 08 цаг 30 минутад товлогдсон Ц.Б-ийн нэхэмжлэлтэй ООО ТӨҮГ-т холбогдох хэргийн шүүх хуралдаан хойшилсон байна. Хариуцагчийн өмгөөлөгч Б.О нь өвчний улмаас ирэх боломжгүй талаараа "ССС" ХХК-ийн эмнэлгийн магадалгаа ирүүлсэн бөгөөд уг магадалгаа нь Хүн амын хөгжил, Нийгмийн хамгааллын сайдын 2015.02.18-ны өдрийн А/30 дугаар тушаалаар батлагдсан "Иргэнд эмнэлгийн хуудас олгох журам"-д заасны дагуу олгогдоогүй байх тул түүнийг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ирэх боломжгүй байсан гэж үзэхгүй. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.2-т зааснаар "Зохигч шүүх хуралдааны товыг шүүхээс лавлах үүрэг хүлээнэ" гэж заасан ба энэхүү лавлагааг хэргийн оролцогч шүүгчийн туслах, шүүхийн мэдээлэл лавлагааны ажилтнаас биечлэн болон утсаар авч болохоос гадна шүүх хуралдаан хэзээ, хаана болох тухай зарыг шүүхийн мэдээллийн самбар, шүүхийн цахим хуудас зэргээс үзэх боломжтой ба хариуцагчийн өмгөөлөгч Б.О нь дээрх үүргээ хэрэгжүүлээгүй байна гэж үзсэн. 2018.02.28-ны өдрийн шүүх хуралдааныг хойшлуулах тухай хариуцагч талын хүсэлтийг хангахаас татгалзахад шүүх хуралдаанд ирээгүй хариуцагчийн өмгөөлөгч М.А, Б.Б нар шүүхээс татгалзсан хүсэлт гаргасныг хариуцагч төлөөлөгч С.Э уншин сонгосон. Шүүх хэргийн оролцогчдоос шүүгчийг татгалзан гаргах үндэслэл байгаа эсэх талаар хуульд заасан шүүх хуралдааны дэгийн дагуу хэргийг агуулгаар хэлэлцэхээс өмнө асуухад хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Э татгалзах зүйлгүй хэмээн хариулсан ба үүнээс хойш хүсэлтийг хангахгүй орхиж шийдвэрлэснийг хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь "татгалзан гарах үндэслэл шүүх хуралдааны явцад тогтоогдвол" гэх үндэслэлд хүсэлтийг шийдвэрлэсэн шүүхийн ажиллагааг хамааруулан шүүхээс, шүүгчээс татгалзсан. Шүүгчийг татгалзан гаргах үндэслэл байгаа эсэхийг шүүх тухайн хэргийг хэлэлцэх ажиллагаанаас өмнө асуух хуульд заасан журам нь шүүх хуралдааныг дээрх үндэслэлээр хойшлуулах боломжийг урьдчилан тогтоосон агуулгатай бөгөөд хариуцагчийн өмгөөлөгч М.А, Б.Б нар нь шүүх хуралдаанд оролцоогүй атлаа хүсэлт шийдвэрлэсэнтэй холбоотой шүүхийн бүх шүүгчдийг татгалзах тухай хүсэлтийг ирүүлснийг татгалзах хүсэлт гэж үзэн шийдвэрлэх үндэслэлгүй гэж үзсэн. Шүүх хуралдааны явцад шүүгчийг татгалзан гаргах үндэслэл илэрвэл хэргийн оролцогч шүүхэд мэдэгдэх боломжтой байх ба харин өөрсдийн хүсэлтийг хангаагүй үйл баримтыг шүүгчийг татгалзан гаргах үндэслэл болгож байгаа нь шүүх хуралдааныг хойшлуулах, шүүхийн үйл ажиллагаанд саад учруулах зорилготой үйлдэл гэж үзэхээр байсан ба хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Э-ийн шүүгчээс, шүүхийн бүх шүүгчдээс татгалзах тухай хүсэлтийг хангах үндэслэлгүй гэж үзсэн. Ингээд 2018.2.28-ны өдрийн /716 дугаар шийдвэр/ шүүх хуралдаанаар Иргэний хуулийн 243 дугаар зүйлийн 243.1, 205 дугаар зүйлийн 205.1-д заасныг баримтлан Б.М болон "ННН" ХХК-ийн хооронд 2012.11.01-ний өдөр байгуулагдсан хувьцаа худалдах, худалдан авах гэрээнээс нэхэмжлэгч Б.М татгалзсан тул "ККК" ХХК-ийн 100 хувийн хувьцаа болон ашигт малтмал ашиглалтын ...59А дугаар бүхий тусгай зөвшөөрөл эзэмших эрхийг иргэн Б.М-д буцаан шилжүүлэхийг хариуцагч "ННН"

ХХК-д даалгаж, нэхэмжлэгч Б.М-ээс 3.300.000 ам доллар буюу 8.209.014.000 төгрөг гаргуулан хариуцагч “ННН” ХХК-д олгож, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-т тус тус зааснаар нэхэмжлэгч Б.М-ийн улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 68.566.400 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээж, хариуцагч “ННН” ХХК-аас 41.203.020 төгрөгийг гаргуулж нэхэмжлэгч Б.М-д олгож шийдвэрлэсэн. Хариуцагч “ННН” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч нарын гаргасан хүсэлтүүдийг дээрх байдлаар шийдвэрлэж байсан ба дээрхээс үзэхэд тэдэнд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан эрх болон үүргээ хэрэгжүүлэх хугацааг олгож байсан, хэргийн оролцогчийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй болно.

Шүүгч би зөвхөн хуульд захирагдан, шүүгчийн ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж, хуульд заасан үндэслэл журмын дагуу хэргийг хянан шийдвэрлэсэн бөгөөд хариуцагч “ННН” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Э, хариуцагчийн өмгөөлөгч М.А, Б.Б нарын гомдолд дурдсанчлан Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох хууль, Шүүхийн ёс зүйн талаарх Банглорын зарчим, /2002 он/, Шүүгчийн ёс зүйн дүрэм, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм болон холбогдох дүрмийг зөрчиж, шүүгчийн нэр хүндийг унагасан, харш үйлдэл гаргаагүй. /Жич: 2018.02.28-ны өдрийн 716 дугаар бүхий шийдвэртэй иргэний хэргийг зохигчийн хяналтын шатны шүүхэд гаргасан гомдлын дагуу 2018 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 1938 дугаар бүхий албан бичгээр Улсын Дээд Шүүхэд хүргүүлсэн ба шүүгчийн захирамжуудыг хэргээс хуулбарлан өгөх болно." гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны 2018.07.06-ны өдрийн 117 дугаар тогтоолоор шүүгч Н.С-д сахилгын хэрэг үүсгэж шийдвэрлэжээ.

Шүүгч Н.С нийт гишүүдийн хуралдаанд гаргасан гомдолдоо: "Б.М-ийн нэхэмжлэлтэй “ННН” ХХК-д холбогдох иргэний хэргийн шүүх хуралдааныг хариуцагч талын хүсэлт, шүүгчийн захирамжуудад гаргасан тэдний гомдлыг шийдвэрлүүлэхтэй холбоотой нийт 11 удаа хойшлуулж байсан болно. 2018.02.28-ны өдрийн 08.30 цагт товлогдсон шүүх хуралдааны товыг шүүх хуралдаан болохоос 5 хоногийн өмнө талуудад мэдэгдсэн. Уг өдрийн хуралдааныг хариуцагч “ННН” ХХК-ийн өмгөөлөгч Б.О өвчний улмаас, өмгөөлөгч Б.Б, М.А нар хуралдаан давхацсан үндэслэлээр хойшлуулах, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Э нь өмгөөлөгч Б.О татгалзан, өөр өмгөөлөгч авах үндэслэлээр хойшлуулах хүсэлтийг тус тус гаргасан. Хариуцагчийн өмгөөлөгч Б.Б, М.А нар шүүх хуралдаан хойшлуулах хүсэлтийг энэ өдрийн хуралдаанд гаргаж байгаа нь хүндэтгэх шалтгаангүй, мөн тэдний оролцож байгаа гэх 3 дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд 2018.02.28-ны өдрийн 08 цаг 30 минутад товлогдсон Ц.Б-ийн нэхэмжлэлтэй ООО ТӨҮГ-т холбогдох хэргийн шүүх хуралдаан хойшилсон байсан болно. Хариуцагчийн өмгөөлөгч Б.О нь өвчний улмаас ирэх боломжгүй талаараа ССС ХХК-ийн эмнэлгийн магадалгаа ирүүлсэн ба уг магадалгаа нь Хүн амын хөгжил, Нийгмийн хамгааллын сайдын 2015 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн А/30 дугаар тушаалаар батлагдсан “Иргэнд эмнэлгийн хуудас олгох журам”-д заасны дагуу олгогдоогүй байсан тул түүнийг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ирэх боломжгүй байсан гэж үзээгүй. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.2-т зааснаар “Зохигч шүүх хуралдааны товыг шүүхээс лавлах үүрэг хүлээнэ” гэж заасан ба энэхүү лавлагааг хэргийн оролцогч шүүгчийн туслах, шүүхийн мэдээлэл лавлагааны ажилтнаас биечлэн болон утсаар авч болохоос гадна шүүх хуралдаан хэзээ, хаана болох тухай зарыг шүүхийн мэдээллийн самбар, шүүхийн цахим хуудас зэргээс үзэх боломжтой бөгөөд хариуцагчийн өмгөөлөгч Б.О нь дээрх үүргээ хэрэгжүүлээгүй. 2018.02.28-

ны өдрийн шүүх хуралдааныг хойшлуулах тухай хариуцагч талын хүсэлтийг хангахаас татгалзахад шүүх хуралдаанд ирээгүй хариуцагчийн өмгөөлөгч М.А, Б.Б нар шүүхээс татгалзсан хүсэлт гаргасныг хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Э уншин сонсгосон. Шүүх хэргийн оролцогчдоос шүүгчийг татгалзан гаргах үндэслэл байгаа эсэх талаар хуульд заасан шүүх хуралдааны дэгийн дагуу асуухад хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Э татгалзах зүйлгүй хэмээн хариулсан ба үүнээс хойш хүсэлтийг хангахгүй орхиж шийдвэрлэснийг хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь “татгалзан гарах үндэслэл шүүх хуралдааны явцад тогтоогдвол” гэх үндэслэлд хүсэлт шийдвэрлэсэн шүүхийн ажиллагааг хамааруулан шүүхээс, шүүгчээс татгалзсан. Шүүгчийг татгалзан гаргах үндэслэл байгаа эсэхийг шүүх тухайн хэргийг хэлэлцэх ажиллагаанаас өмнө асуух нь хуульд заасан журам нь шүүх хуралдааныг дээрх үндэслэлээр хойшлуулах боломжийг урьдчилан тогтоосон агуулгатай бөгөөд хариуцагчийн өмгөөлөгч М.А, Б.Б нар нь шүүх хуралдаанд оролцоогүй атлаа хүсэлт шийдвэрлэсэнтэй холбоотой шүүхийн бүх шүүгчдийг татгалзах тухай хүсэлтийг ирүүлснийг татгалзах хүсэлт гэж үзэн шийдвэрлэх үндэслэлгүй гэж үзсэн Шүүх хуралдааны явцад шүүгчийг татгалзан гаргах үндэслэл илэрвэл хэргийн оролцогч шүүхэд мэдэгдэх боломжтой байх ба харин өөрсдийн хүсэлтийг хангаагүй үйл баримтыг шүүгчийг татгалзан гаргах үндэслэл болгож байгаа нь шүүх хуралдааныг хойшлуулах, шүүхийн үйл ажиллагаанд саад учруулах зорилготой үйлдэл гэж үзсэн ба хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Э-ийн шүүгчээс, шүүхийн бүх шүүгчдээс татгалзах тухай хүсэлтийг хангах үндэслэлгүй гэж үзсэн байна. Хариуцагч талын шүүх хуралдаан хойшлуулах хүсэлтийг болон шүүх хуралдаанд Оролцоогүй өмгөөлөгч Б.Б, М.А нарын хүсэлтийг шийдвэрлэх үүднээс шүүх хуралдааныг 2 удаа завсарлан хүсэлтүүдийг шийдвэрлэсэн. Хариуцагч талын дээрх 2 хүсэлтийг шийдвэрлэсний дараагаар эдгээр өмгөөлөгч нар шүүх хуралдааны танхимд орж ирэн шүүгч намайг зүй зохисгүй үг хэллэгээр доромжилсон бөгөөд энэ нь шүүх хуралдааны тэмдэглэл болон шүүх хуралдааны видео бичлэгт дэлгэрэнгүй тусгагдсан байгаа болно. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 105 дугаар зүйлд заасны дагуу хэргийг оролцогчоос гаргасан хүсэлтүүдийг шийдвэрлэсэн, хэрэг хэлэлцэх ажиллагаа нэгэнт эхэлсэн тул эдгээр өмгөөлөгч нарыг хуралдаанд оролцуулах боломжгүй бөгөөд хариуцагчийн өмгөөлөгч гэх М.А-г хуралдаанд сонирхогчоор суулгасан болно. Нэхэмжлэгчийн өмгөөлөгч Д.Н: Эрхэм шүүгчээ хэргийн оролцогч биш субъект нотлох баримтыг шинжлэн судлах шаардлага байгаа юм уу гэхэд

Даргалагчаас: Урьд нь өмгөөлөгчөөр оролцож байсан. Энэ удаа сонирхогчоор оролцож байгаа. Хоорондоо зөвлөлдөх эсэх нь өөрсдийнх нь асуудал гэв.

Нэхэмжлэгчийн өмгөөлөгч Д.Н: Шүүгчээ энэ оролцогчийг үг хэлүүлэхээ болиулна уу. Сүүлдээ орилоод байна. Танхимаас гаргая гэв.

Даргалагчаас: М.А өмгөөлөгч сонирхогчоор оролцож байгаа. Хуралдаанд оролцож байгаа бусад оролцогчид садаа болохгүй байдлаар зөвлөлдөхийг үгүйсгэх аргагүй. Бусдад оролцогчдод садаа болсон тохиолдолд танхимаас гаргах асуудал яригдана гэв.

Хариуцагч “ННН” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч нарын хүсэлтүүдийг хэрхэн шийдвэрлэсэнтэй холбоотой шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолуудыг баримтаар өгсөн бөгөөд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан эрх болон үүргээ хэрэгжүүлэх хугацааг олгож байсан, хэргийн оролцогчийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна. Шүүгч би зөвхөн хуульд захирагдан, шүүгчийн ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж, хуульд заасан үндэслэл журмын дагуу хэргийг хянан шийдвэрлэсэн ба хариуцагч “ННН” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Э, өмгөөлөгч М.А, Б.Б

нарын гомдолд дурдсанчлан Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүгчийн ёс зүйн дүрэм, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм болон холбогдох дүрмийг зөрчиж, шүүгчийн нэр хүндийг унагасан, харш үйлдэл гаргаагүй" гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанаар сахилгын хэргийг хэлэлцээд ҮНДЭСЛЭХ нь:

Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 07-р сарын 06-ны өдрийн 117 дугаар тогтоолоор шүүгч Н.С-д сахилгын хэрэг үүсгэсэн нь үндэслэлтэй байна.

Б.М-ийн нэхэмжлэлтэй "ННН" ХХК-д холбогдох иргэний хэргийн шүүх хуралдааныг хариуцагч талын хүсэлт, шүүгчийн захирамжуудад гаргасан тэдний гомдлыг шийдвэрлүүлэхтэй холбоотой нийт 11 удаа хойшлуулж байсан байна. 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 08.30 цагт товлогдсон шүүх хуралдааны товыг шүүх хуралдаан болохоос 5 хоногийн өмнө талуудад мэдэгдсэн байна. Уг өдрийн хуралдааныг хариуцагч "ННН" ХХК-ийн өмгөөлөгч Б.О өвчний улмаас, өмгөөлөгч Б.Б, М.А нар хуралдаан давхацсан үндэслэлээр хойшлуулах, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Э нь өмгөөлөгч Б.О-оос татгалзан, өөр өмгөөлөгч авах үндэслэлээр хойшлуулах хүсэлтийг тус тус гаргасан байна. Хариуцагчийн өмгөөлөгч Б.Б, М.А нар шүүх хуралдаан хойшлуулах хүсэлтийг энэ өдрийн хуралдаанд гаргаж байгаа нь хүндэтгэх шалтгаангүй, мөн тэдний оролцож байгаа гэх 3 дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 08 цаг 30 минутад товлогдсон Ц.Б-ийн нэхэмжлэлтэй ООО ТӨҮГ-т холбогдох хэргийн шүүх хуралдаан хойшилсон байна гэдэг үндэслэлээр шүүгч тухайн хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан байна.

Мөн хариуцагчийн өмгөөлөгч Б.О нь өвчний улмаас ирэх боломжгүй талаараа "ССС" ХХК-ийн эмнэлгийн магадалгаа ирүүлсэн боловч уг магадалгаа нь Хүн амын хөгжил, Нийгмийн хамгааллын сайдын 2015 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн А/30 дугаар тушаалаар батлагдсан "Иргэнд эмнэлгийн хуудас олгох журам"-д заасны дагуу олгогдоогүй тул түүнийг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ирэх боломжгүй байсан гэж шүүгч үзсэн байна.

Энэ талаар болон бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой гомдлын үндэслэлүүд нь шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой байна гэж бүрэлдэхүүн дүгнэв. Монгол Улсын Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т "Шүүгчийн Ёс зүйн дүрмийг зөрчсөн шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэнэ", Монгол Улсын Шүүхийн Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 5.1 дүгээр зүйлийн 6-д "Шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаанаас бусад ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдлыг Шүүхийн ёс зүйн хороо харьяалан шийдвэрлэнэ" гэж тус тус заасан байна.

Харин гомдол гаргагчийн "Итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Э-ийн зүгээс өмгөөлөгч авах, өмгөөлүүлэх эрхээр хангуулах тухай хүсэлтүүдийг тус тус шүүх хуралдаан эхлэхээс өмнө ирцтэй холбоотой асуудлыг шалгах үед гаргасан. ... С.Э миний зүгээс өөрийн 3 өмгөөлөгчийнхөө өгсөн хүсэлтийг шүүх хуралдаан дээр уншиж, энэхүү шүүх хуралдаанд өмгөөлөгч нартайгаа оролцож, өмгөөлүүлэх эрхээр хангахыг шүүхээс хүсэхэд завсарласан байх үедээ шүүгч Н.С өөрийн туслах С.Н-г шүүх хуралдааны танхимд дуудан өмгөөлөгч Б.Б, М.А нарын оролцож байгаа Ж.Ц шүүгчийн шүүх хуралдаан үргэлжилж байгаа эсвэл дууссан талаар лавлаж ирэхийг даалгасан. Хүсэлтийг шийдвэрлээд хэргийн оролцогчид шүүх хуралдааны танхимд орж ирсний дараа шүүгчийг шийдвэрээ уншихаас өмнө шүүгчийн туслах С.Н хурлын зааланд орж ирээд "өмгөөлөгч Б.Б, М.А нарын оролцож буй шүүх хуралдаан хойшлогдсон байна. Өмгөөлөгч Б.Б, М.А нар гадаа хүлээж байна"

гэж хэлэхэд шүүгч Н.С санаатайгаар хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хууль ёсны эрхийг эдлүүлэхгүй байх зорилгоор хүсэлтийг хангахаас татгалзаж шийдвэрлэж, хурлыг үргэлжлүүлэхдээ өмгөөлөгч нарыг маань хамт оруулахгүй байхаар шийдвэрлэсэн. Өөрөөр хэлбэл анхан шатны шүүх хуралдаан эхлээгүй. Ж.Ц шүүгчийн шүүх хуралдаан хойшилсон өмгөөлөгч нар шүүх хуралдаандаа орох гээд хүлээж байхад итгэмжлэгдсэн төлөөлөгч миний сонгон авсан өмгөөлөгч нарыг оролцуулаад шүүх хуралдааныг үргэлжлүүлэх байтал өмгөөлөгчтэйгөө шүүх хуралдаанд оролцох эрхийг маань хангаагүй нь "ННН" ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч миний “өмгөөлүүлэх буюу хууль зүйн туслалцаа авах” эрхийг ноцтой зөрчсөн гэж үзэж байна.

Итгэмжлэгдсэн төлөөлөгч миний хоёр өмгөөлөгчийг “давхацсан гэх шүүх хуралдаан нь хойшлогдсон” гэх үндэслэлээр шүүх хуралдааныг үргэлжлүүлж байгаа тохиолдолд нэхэмжлэгч намайг өмгөөлөгчтэйгөө цааш шүүх хуралдааныг үргэлжлүүлэх эрхийг шүүх хангах үүрэгтэй. Гэтэл миний хоёр өмгөөлөгчийн хурал хойшлогдсон гээд тухайн хоёр өмгөөлөгч нь шүүх хуралдааныг надтай хамт үргэлжлүүлэхээр шүүх хуралдаанд ороод ирсэн байхад шүүгч нь шүүх хуралдаанд өмгөөлөгчөөр оролцохыг хориглож, сонирхогч этгээдээр оролцуулахаар шийдвэрлэсэнд маш их гомдолтой байна. С.Э миний өмгөөллийн хөлсөө төлж, эрх зүйн гэрээ байгуулсан өмгөөлөгч нарыг үндэслэлгүйгээр өмгөөлөгчөөр оролцохыг хориглож, сонирхогч этгээдээр байлцуулсанд гомдолтой байна. Шүүх хуралдааны бүхий л үе шатанд өмгөөллийн хөлсийг төлсөн байсан өмгөөлөгч маань миний хажууд байгаа мөртөө үг ч хэлэх эрхгүйгээр сонирхогч этгээдээр суусан. Шүүгчийн энэхүү үйлдэл нь С.Э миний үндсэн хуульд тусгасан өмгөөлүүлэх эрхийг ноцтой зөрчсөн бөгөөд энэхүү нөхцөл байдалд маш их гомдолтой байна... шүүхээс өмгөөлөгч нарын шүүх хуралдаанд биечлэн оролцох хүсэлтүүдийг хангаж шийдвэрлээгүйгээс буюу шүүхийн шийдвэрийн дагуу тухайн мөчид С.Э миний бие өмгөөлөгчгүй, шүүх хуралдаанд оролцох нөхцөл бий болсон. Түүнээс биш итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Э миний бие өмнө ерөөсөө өмгөөлөгч авахгүй байж байгаад шүүх хуралдаан дээр “өмгөөлөгч авъя” гээд ороод ирсэн асуудал биш юм. Энэ тохиолдолд шүүхээс энэхүү эрх үүргээ өмнө нь хэрэгжүүлэх бүрэн боломжтой гэж үзэж хангахаас татгалзах үндэслэлтэй. Гэтэл яг тухайн шүүхийн шийдвэрийн дагуу өмгөөлөгч наргүй болсон намайг “өмгөөлөгч авах эрхээ” өмнө нь хэрэгжүүлэх боломжтой байсан гэдгээр “өмгөөлөгч авах” эрхийг хангалгүй орхисон нь үндэслэлгүй болно...” гэсэн нь үндэслэлтэй.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 14-т Монгол Улсын иргэний баталгаатай эдлэх үндсэн эрх, эрх чөлөөнд “... хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, ...эрхтэй” гэж заасан байна.

Мөн гомдол гаргагч нар ИХШХШТХ-ийн 92 дугаар зүйлийн 92.8-ийг удирдлага болгон тухайн “шүүхийн бүх шүүгчдээс татгалзах тухай” хүсэлтийг шүүхэд гаргасан байна. Энэхүү хүсэлтийг ИХШХШТХ-ийн 92 дугаар зүйлийн 92.8-д зааснаар “шүүхийн бүх шүүгчдийг татгалзсан бол шүүгчдийн зөвлөгөөн олонхын саналаар шийдвэрлэн тогтоол гаргана” гэж заасны дагуу шүүгчдийн зөвлөгөөнөөр тогтоол гарган шийдвэрлэх байтал шүүгч Н.С 2018.02.28-ны өдрийн 10/ШЗ2018/04060 дугаар захирамж гаргаж, тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний эрх хэмжээг эдэлж шийдвэр гаргасан байна.

Гомдол гаргагчдын “... хууль тогтоомжоор өөрт нь олгогдоогүй эрх хэмжээг хэрэгжүүлж шүүгчийн захирамж гаргасан бөгөөд захирамжийнхаа үндэслэлийг “хариуцагчийн өмгөөлөгч М.А, Б.Б нар нь шүүх хуралдаанд оролцоогүй атлаа хүсэлт шийдвэрлэсэнтэй холбоотой шүүхийн бүх шүүгчдийг татгалзах тухай хүсэлтийг ирүүлснийг татгалзах хүсэлт гэж үзэн шийдвэрлэх үндэслэлгүй”,...

2018.02.28-ны өдрийн 10/ШЗ2018/04060 дугаар “Хүсэлт шийдвэрлэх тухай” захирамжийг гаргасан нь ИХШХШТХ-ийн 103 дугаар зүйлийн 103.2- т зааснаар “Татгалзан гаргах хүсэлт гарвал түүнийг энэ хуулийн 92 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ” гэж заасныг зөрчиж, ИХШХШТХ-д тусгагдаагүй журмыг өөрөө санаачлан зохиож, шийдвэрлэсэн. Мөн дээр дурдаад буй хүсэлтийг хүлээн авахаас татгалзах үндэслэлийг “Ерөнхий шүүгч юм уу, тухайн шүүхийн нийт шүүгчдийн бүрэлдэхүүн л захирамж, тогтоолдоо дурдаж, хариуцагч талын гаргасан хүсэлт. Энэхүү шүүхэд гаргасан 10 хуудас бүхий “шүүхийн бүх шүүгчдээс татгалзах тухай хүсэлтийг шүүгчийн тухайн хурал дээр “хүсэлт шийдвэрлэсэн” ажиллагааных нь хувьд гаргаагүй, буюу анхнаасаа хариуцагч талаас гаргахаас урьдчилан бэлдсэн 10 хуудас бүхий хүсэлт байсан...” гэдэг үндэслэлийг үндэслэлтэй байна гэж бүрэлдэхүүн үзэв.

Иймд П дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Н.С Монгол Улсын Шүүхийн Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1-д “Шүүгч нь хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, хууль дээдлэх, ...зэрэг зарчмуудыг хувийн зан чанар болгож төлөвшүүлнэ”, 3.1 дүгээр зүйлийн 3-т “Шүүгч нь бусад шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно”, 3.3 дугаар зүйлийн 1-д “Шүүгч хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй” гэж заасныг тус тус зөрчсөн байгаа тул түүнд Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан 2 сарын хугацаагаар 20 хувиар цалинг бууруулах сахилгын хариуцлага хүлээлгэх нь зүйтэй гэж бүрэлдэхүүн дүгнэв.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйл, 36 дугаар зүйлийн 36.1.1, 37 дугаар зүйлийн 37.1.1, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйл, Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.1, 5.13-т заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.П дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Н.С-д 2 сарын хугацаатай 20 хувиар цалинг бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Энэ магадлалын хувийг шүүгч болон гомдол гаргагчид хүргүүлэхийг Шүүхийн Ёс зүйн хорооны Ажлын албанд даалгасугай.

3.Шүүгч, гомдол гаргагч нар магадлалыг гардан авснаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ

А.ДОРЖГОТОВ

ИЛТГЭГЧ

Н.ЭРДЭНЭЦОГТ

УИХ МН
СУДАЛГААНЫ САН



ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ
МАГАДЛАЛ

2018 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 221/ЁМ2018/0028

Улаанбаатар хот

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны
2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн
78 дугаар магадлалын тухай

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааныг шүүгч Б.Тунгалагсайхан даргалж, шүүгч Д.Баатархүү, шүүгч Э.Халиунбаяр нарын бүрэлдэхүүнтэй, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Т.Даваажаргал, гомдол гаргагч Б.Б, М.А, С.Э нарыг оролцуулан, Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 78 дугаар магадлалыг эс зөвшөөрч шүүгч Н.С-ийн гаргасан гомдлоор, Б.Б, М.А, С.Э нарын гомдолтой, П дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Н.С-д холбогдох сахилгын хэргийг шүүгч Э.Халиунбаярын илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 78 дугаар магадлалаар: П дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Н.С-д 2 сарын хугацаатай 20 хувиар цалинг бууруулах сахилгын шийтгэл ногдуулж шийдвэрлэжээ.

Шүүгч Н.С шүүхэд гаргасан гомдолдоо: "... 1.Ёс зүйн хороо нь шүүх хуралдааны явц дахь "шүүгчийн харилцаа, биеэ авч яваа байдал" зэрэг ёс зүйн асуудлыг "хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчээс гаргаж буй захирамж, шийдвэр" зэрэгтэй хольж магадлалаа гаргасан гэж үзэж байна.

Магадлал нь бүхэлдээ ямар нэгэн ёс зүйн асуудал, зөрчлийн тухай бус харин хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц дахь шүүгчийн гаргасан захирамж, шийдвэр зэргийн үндэслэлийн талаар дурдаад, ер нь ийм захирамж, шийдвэр гаргах байсан уу, ингэж шийдсэн нь зөв үү гэдэг талаар л дүгнэжээ.

Шүүх хуралдааны болон бусад аль ч үед шүүгч миний бие Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчөөгүй, хэргийн оролцогчийг загнах, зандрах зэргээр ямар нэгэн зохисгүй, ёс зүйгүй үйлдэл гаргаагүй юм. Иймд дүгнэлт хийхийн тулд "бусад шүүгч" гээд байгаа тухайн шүүгчдээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нь хөндлөнгөөс хэзээ, хэрхэн оролцон, нөлөөлөв гэдгийг тогтоох байсан.

Мөн нэг зүйлийн талаар 2 өөрөөр дүгнэсэн дүгнэлт гаргасан гэж үзэж байна.

Шүүгч Н.С надад сахилгын хэрэг үүсгэх тухай 2018 оны 7 дугаар сарын 6-ны 117 тоот тогтоолын үндэслэх хэсгийн 3-д "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.1.3, 92 дугаар зүйлийн 92.8-д заасныг тус тус үндэслэн гаргасан П дүүргийн бүр шүүгчдээс татгалзах хүсэлтийг шийдвэрлэсэн үндэслэл, хариуцагчийн өмгөөлөгч Б.О өвчний улмаас ирэх боломжгүйг нотолсон гэх "ССС" ХХК-ийн эмнэлгийн магадалгааг шүүгч үнэлсэн талаар, мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан шүүгчийн захирамжийн хуулийн

үндэслэлийн талаар гомдол гаргасныг “Гомдолд дурдагдсан шүүгчийн захирамж буруу эсхүл зөв гарсан эсэх асуудал нь Шүүхийн Ёс зүйн хорооны харьяалалд үл хамаарах учраас энэ талаар үнэлэлт дүгнэлт өгөх нь боломжгүй юм. Гомдол гаргагчийн гаргасан дээрх гомдол нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой...” гэж дүгнэсэн.

Гэсэн атлаа 2018.10.19-ний өдрийн 78 тоот магадлалдаа /9, 10 дугаар тал/ дээр дурдсан “Шүүхийн Ёс зүйн хорооны харьяалалд үл хамаарч байгаа, мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой” гэсэн дүгнэлтээ эсрэгээр нь тайлбарлан шүүгчийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүгчийн ёс зүйн дүрэм зөрчсөн гэж үзэн сахилгын шийтгэл ногдуулсан.

2. Энэхүү хэргийн талаар нийт 3 шатны шүүхийн шийдвэр гарсан.

1.	П дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018.02.28-ны 716-р шийдвэр	Нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн.
2.	Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018.04.30-ны 1007 тоот магадлал	Хэргийг оролцогчийн эрхийг зөрчсөн гэж үзэн дахин хэлэлцүүлэхээр буцаасан.
3.	Улсын Дээд Шүүхийн 2018.10.09-ний өдрийн 1350 дугаар тогтоол	Хэргийн оролцогчийн эрхийг зөрчөөгүй гэж дүгнээд магадлалыг хүчингүй болгож анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн.

Ёс зүйн хорооны гишүүд гомдолтой танилцаад хуралдаан зарлаж улмаар хуралдах үед Улсын дээд шүүхийн тогтоол хараахан ёсчлогдоогүй байсан.

Иймд Ёс зүйн хороо тухайн үед хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалд дурдсан “өмгөөлөгч М.А- оролцуулах боломжтой байхад сонирхогчоор суулгасан, итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Э-ийн өмгөөлөгчтэй оролцох хүсэлтийг хангаагүй, ...хэргийн оролцогчийн өмгөөлөгчөөс эрх зүйн туслалцаа авах, шүүх хуралдаанд биечлэн оролцох, ...үг хэлэх, тайлбар өгөх, нотлох баримт гаргах, түүнийг шинжлэн судлахад тэгш эрхтэй оролцох, мэтгэлцэх ... зарчмыг хэрэгжүүлээгүй” гэснийг үндэслэл болгожээ.

Улсын Дээд шүүхийн 2018 оны 10 сарын 09-ний өдрийн 1350 тоот тогтоолоор ... 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр иргэний хэрэг үүсгэсэн. Хэргийг хянан хэлэлцэх шүүх хуралдааныг 5 удаа, гомдлыг хэлэлцэх шүүх хуралдааныг 7 удаа хариуцагч, түүний өмгөөлөгчийн хүсэлтээр 12 удаа хойшлуулсан, ... хэргийн оролцогчийн эрхийг хязгаарласан алдаа гаргаагүй байхад шүүхийг буруутгах үндэслэлгүй юм” гэж дүгнэсэн.

Мөн Улсын Дээд шүүх тогтоолдоо “... өмгөөлөгч нар шүүх хуралдаанд оролцох боломжтой байсан, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч шүүх хуралдааныг хойшлуулах зорилгоор үндэслэлгүй хүсэлт гаргасан гэж үзэхээр байна. Шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 105 дугаар зүйлийн 105.1, 105.2 дахь хэсгийг зөрчөөгүй байна” гэж дүгнэж Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 1007 тоот магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн.

Гэтэл Ёс зүйн хороо хүчингүй болгосон Нийслэлийн шүүхийн магадлалд дурдсан үндэслэлийг иш татаж сахилгын шийтгэл ногдуулсан нь үндэслэлгүй гэж үзэж байна.

3. Энэхүү хэргийн тухайд 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр иргэний хэрэг үүсгэсэн, хэргийг шийдвэрлэх өдөр тухайн нэхэмжлэлд иргэний хэрэг үүсгээд 1

жил, 1 сар, 15 хоногийн хугацаа өнгөрсөн байсан, хэргийг хянан хэлэлцэх шүүх хуралдааныг 5 удаа, хариуцагчийн гаргасан гомдол хэлэлцэх шүүх хуралдааныг 7 удаа буюу зөвхөн хариуцагч, түүний өмгөөлөгчийн хүсэлтээр 12 удаа шүүх хуралдааныг хойшлуулж байсан зэргийг Ёс зүйн хороо анхаарсангүй.

Мөн энэ маргааны тухайд Ёс зүйн хороо “гомдол, нэхэмжлэл гаргах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шийдвэрлүүлэх, эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах нэхэмжлэгчийн эрх” талаас нь дүгнэлт хийхгүйгээр зөвхөн хариуцагчийн хүсэлт бүрийг зөв, буруу эсэх, тухайн хэрэг маргаанд хамааралтай эсэх зэргийг ялгаж салгахгүйгээр хангаж шийдвэрлэх ёстой байсан мэтээр дүгнэсэн нь үндэслэлгүй юм.

Иймд Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 78 дугаар магадлалыг хүчингүй болгож өгнө үү” гэжээ.

ХЯНАВАЛ:

Давж заалдах шатны шүүх Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.3-д зааснаар Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал, түүнд гаргасан шүүгчийн гомдлын хүрээнд сахилгын хэргийг хянаад магадлалыг хүчингүй болгож, шүүгч Н.С-д үүсгэсэн сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгохоор шийдвэрлэлээ.

П дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Н.С-д холбогдуулан гаргасан гомдолд дурдагдсан асуудлыг шүүгчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол гэж үзэх үндэслэлгүй байна.

Учир нь Шүүхийн Ёс зүйн хороонд Б.Б, М.А, С.Э нар нь шүүгчид сахилгын хэрэг үүсгүүлэхээр хандах болсон үндэслэлээ “...Б.М-ийн нэхэмжлэлтэй “ННН” ХХК-д холбогдох иргэний хэргийг хянан шийдвэрлэсэн шүүгч Н.С-ийн шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмын “Шүүгч зөвхөн үйл баримтад хийсэн дүгнэлт болон хуульд тулгуурлан шүүн таслах чиг үүргээ үр нөлөөтэй, шударга, түргэн шуурхай хэрэгжүүлэх”, Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.3, 3 дугаар зүйлийн 3.3, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.6, 1.7, Шүүгчийн ёс зүйн дүрмийн 2 дугаар зүйлийн 2.3-д заасан үүргүүдээ зөрчиж, процессын шууд тодорхой заасан заалтыг удаа дараа зөрчсөн төдийгүй хариуцагч талын итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч нарын Монгол Улсын Үндсэн хуульд заасан хууль зүйн туслалцаа авах, шударгаар шүүлгэх, хөдөлмөрлөх, ажил, мэргэжээ чөлөөтэй сонгож, эрхлэх, халдашгүй чөлөөтэй байх зэрэг эрхүүдийг зөрчсөн шүүгчийн ёс зүйн зөрчилд тооцогдох илэрхий мэргэжлийн алдаануудыг санаатайгаар гаргасан...” гэж тодорхойлжээ.

Б.М-ийн нэхэмжлэлтэй, “ННН” ХХК-д холбогдох “Б.М болон “ННН” ХХК-ийн хооронд 2012 оны 11 дүгээр сарын 01- ний өдөр байгуулагдсан хувьцаа худалдах, худалдан авах гэрээнээс татгалзаж, “ККК” ХХК-ийн 100 хувийн хувьцаа болон ашигт малтмалын9А дугаар тусгай зөвшөөрөл эзэмших эрхийг буцаан иргэн Б.М-д шилжүүлэхийг даалгах” тухай нэхэмжлэлийн шаардлагатай иргэний хэргийг П дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 101/ШШ2018/00716 дугаар шийдвэрээр нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэснийг Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 1007 дугаар магадлалаар “... анхан шатны шүүх хариуцагчийн өмгөөлөгчийг шүүх хуралдаанд оролцуулалгүй, мэтгэлцэх эрхийг нь хязгаарласан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн атлаа сэргээх захирамж гаргаагүй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг ноцтой зөрчсөн...” гэх үндэслэлээр анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцааж шийдвэрлэжээ.

Харин Улсын Дээд шүүхийн хяналтын шатны Иргэний хэргийн шүүх хуралдааны 2018 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 001/ХТ2018/01350 дугаар тогтоолоор "...шүүх Б.М-ийн нэхэмжлэлд 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр иргэний хэрэг үүсгэсэн, хэргийг хянан хэлэлцэх шүүх хуралдааныг 5 удаа, гомдлыг хянан хэлэлцэх шүүх хуралдааныг 7 удаа хариуцагч, түүний өмгөөлөгчийн хүсэлтээр 12 удаа хойшлуулсан, 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн шүүх хуралдааныг хэргийн оролцогчдод 2018 оны 02 дугаар сарын 23-ны өдөр мэдэгдсэн, хэргийн оролцогчийн эрхийг хязгаарласан алдаа гаргаагүй..., хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь өмгөөлөгч М.А, Б.Б нар шүүх хурал давхардсан учраас хуралдааныг хойшлуулах хүсэлт гаргасан тул шүүхийн зүгээс шүүх хуралдаан давхардсан эсэхийг тодруулж, тухайн шүүх дээр явагдсан уг хурал хойшилсон байсан тул хүсэлтийг нь хэрэгсэхгүй болгосон, үүний дараа хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч шүүгч, тухайн шүүхийн бүх шүүгчээс татгалзах хүсэлт гаргасныг... хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ. Уг хүсэлтийг шийдвэрлэсний дараа шүүх хуралдаанд өмгөөлөгч М.А, Б.Б нар орж ирсэн, өмгөөлөгч Б.Б шүүх хуралдааны дэг зөрчсөн тул түүнийг шүүх хуралдааны танхимаас гаргаж, өмгөөлөгч М.А-г шүүх хуралдаанд ирээгүй гэж үзэж, хуралдааныг үргэлжлүүлжээ. Эдгээр нөхцөл байдлаас үзэхэд өмгөөлөгч нар шүүх хуралдаанд оролцох боломжтой байсан, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч шүүх хуралдааныг хойшлуулах зорилгоор үндэслэлгүй хүсэлт гаргасан гэж үзэхээр байна. Шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 105 дугаар зүйлийн 105.1, 105.2 дахь хэсгийг зөрчөөгүй" гэж дүгнэж, шүүхийн магадлалыг хүчингүй болгож анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна.

Дээрх үйл баримтууд болон шүүгчийн гомдол, сахилгын хэрэгт цугларсан нотлох баримтуудыг шинжлэн судлахад П дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Н.С нь иргэний хэргийн хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахдаа хуульд тусгайлан ёс зүйн зөрчил болохоор заасан болон Шүүгчийн ёс зүйн дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг гаргаагүй болох нь тогтоогдож байна.

Тодруулбал, Б.Б, М.А, С.Э нарын Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан гомдол дурдсан "хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам удаа дараа зөрчсөн төдийгүй хариуцагч талын итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч нарын Монгол Улсын Үндсэн хуульд заасан хууль зүйн туслалцаа авах эрхүүдийг зөрчсөн" гэх асуудлаар Улсын дээд шүүхийн хяналтын шатны Иргэний хэргийн шүүх хуралдааны 2018 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 001/ХТ2018/01350 дугаар тогтоолд дүгнэн, үгүйсгэсэн байгаагаас үзвэл шүүгч Н.С-ийг ёс зүйн зөрчил гаргасан гэж үзэх үндэслэлгүй.

Тиймээс Б.Б, М.А, С.Э нарын гомдолд дурдсан үйл баримт, Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалаар шүүгч Н.С нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлээгүй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн, хууль зүйн туслалцаа авах, шударгаар шүүлгэх, хөдөлмөрлөх, ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгож, эрхлэх, халдашгүй чөлөөтэй байх эрхийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1 дүгээр бүлгийн 1.4 дүгээр зүйл "Ёс зүйн зөрчил"-ийн 1-д "шүүгч хуульд тусгайлан ёс зүйн зөрчил болохоор заасан болон энэ дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг ёс зүйн зөрчил гэж үзнэ", 1.4 дүгээр зүйлийн 2-т "Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй" гэж зааснаар гомдол гаргагч нарын гомдолд дурдсан асуудал нь Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1-д заасанд хамаарахгүй гэж шүүх үзлээ.

Иймд Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалыг хүчингүй болгож, шүүгч Н.С-ийн гомдлыг хангаж шийдвэрлэв.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.2, 121 дүгээр зүйлийн 121.1.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19- ний өдрийн 78 дугаар магадлалыг хүчингүй болгож, П дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Н.С-д үүсгэсэн сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгосугай.

2.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.5-д зааснаар давж заалдах шатны шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн, хууль буруу хэрэглэсэн гэж нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нар үзвэл магадлалыг гардан авсан, эсхүл хүргүүлснээс хойш 14 хоногийн дотор Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй.

ШҮҮГЧ

Б.ТУНГАЛАГСАЙХАН

ШҮҮГЧ

Д.БААТАРХҮҮ

ШҮҮГЧ

Э.ХАЛИУНБАЯР



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ХЯНАЛТЫН ШАТНЫ ЗАХИРГААНЫ
ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2019 оны 02 сарын 13 өдөр

Дугаар 38

Улаанбаатар хот

Б.Б, М.А, С.Э нарын гомдолтой, П дүүргийн
Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч
Н.С-д холбогдох сахилгын хэргийн тухай

Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх
хуралдааны бүрэлдэхүүн:

Даргалагч: Танхимын тэргүүн М.Батсуурь

Шүүгчид: Л.Атарцэцэг

Б.Мөнхтуяа

Д.Мөнхтуяа

Илтгэгч шүүгч: Ч.Тунгалаг

Нарийн бичгийн дарга: Э.Номин-Эрдэнэ

Гомдлын үндэслэл: П дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн
шүүгч Н.С-г Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.3, 2 дугаар зүйлийн
3 дугаар зүйлийн 3.3, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах
дүрмийн 1.6, 1.7 дугаар зүйлийг зөрчсөн мэргэжлийн алдаануудыг шалгуулж,
холбогдох арга хэмжээг авхуулах

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-
ний өдрийн 78 дугаар магадлал,

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 12 дугаар
сарын 20- ны өдрийн 221/ЁМ2018/0028 дугаар магадлал,

Шүүх хуралдаанд оролцогч:

Гомдол гаргагч Б.Б, М.А, С.Э нар

Гомдол гаргагч С.Э, М.А нарын гаргасан гомдлыг үндэслэн хэргийг хянан
хэлэлцэв.

ТОДОРХОЙЛОХ НЬ:

Өмнөх шатны шүүхийн шийдвэр:

1.Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын
19-ний өдрийн 78 дугаар магадлалаар П дүүргийн Иргэний хэргийн анхан
шатны шүүхийн шүүгч Н.С-д 2 сарын хугацаатай 20 хувиар цалинг бууруулах
сахилгын шийтгэл ногдуулжээ.

2.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх шүүгч Н.С-ийн гаргасан
гомдлоор хэргийг 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдөр хянан хэлэлцээд 221/
ЁМ2018/0028 дугаар магадлалаар Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны
2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 78 дугаар магадлалыг хүчингүй

болгож, П дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Н.С-д үүсгэсэн сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

Хяналтын журмаар гаргасан гомдол:

3.Гомдол гаргагч С.Э, өмгөөлөгч М.А нар хяналтын журмаар гаргасан гомдолдоо: ... Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх магадлалын хянавал хэсэгтээ: “Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдааны 001/ХТ2018/01350 дугаар тогтоолдоо “... хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь өмгөөлөгч М.А, Б.Б нар шүүх хуралдаан давхардсан учраас хуралдааныг хойшлуулах хүсэлт гаргасан тул шүүхийн зүгээс шүүх хуралдаан давхардсан эсэхийг тодруулж, тухайн шүүх дээр явагдсан уг хурал хойшилсон байсан тул хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон, үүний дараа хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч шүүгч, тухайн шүүхийн бүх шүүгчээс татгалзах хүсэлт гаргасныг... хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ. Уг хүсэлтийг шийдвэрлэсний дараа өмгөөлөгч М.А, Б.Б нар орж ирсэн, өмгөөлөгч Б.Б шүүх хуралдааны дэг зөрчсөн тул түүнийг шүүх хуралдааны танхимаас гаргаж өмгөөлөгч М.А-г шүүх хуралдаанд ирээгүй гэж үзэж, хуралдааныг үргэлжлүүлжээ. Эдгээр нөхцөл байдлаас шүүхэд өмгөөлөгч нар нь хуралдаанд оролцох боломжтой байсан. Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч шүүх хуралдааныг хойшлуулах зорилгоор үндэслэлгүй хүсэлт гаргасан гэж үзэхээр байна. Шүүх Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 105 дугаар зүйлийн 105.1, 105.2 дахь хэсгийг зөрчөөгүй” гэж дүгнэж, шүүхийн магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна”.

4.Дээрх үйл баримтууд болон шүүгчийн гомдол, сахилгын хэрэгт цугласан нотлох баримтуудыг шинжлэн судлахад шүүгч Н.С нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахдаа тусгайлан ёс зүйн зөрчил болохоор заасан болон Шүүгчийн Ёс зүйн дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг гаргаагүй болох нь тогтоогдож байна гэж дүгнэжээ.

5.Хууль тогтоогчоос Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 105.1, 105.2 дахь заалтаараа хэргийн оролцогчоос гаргасан хүсэлтийг шийдвэрлэх журмыг зохицуулсан бөгөөд хуралдааны танхимд орж ирээд байгаа өмгөөлөгчийг шүүх хуралдаанд ирээгүй гэж үзэн, өмгөөлөгчийг эрхийг хязгаарлах зохицуулалт Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд огт байхгүй.

6.Анхан шатны шүүх хуралдаанд итгэмжлэгдсэн төлөөлөгч миний зүгээс тухайн өдрийн шүүх хуралдааныг өмгөөлөгч хурал давхардсан гэх шалтгаанаар хуульд заасан хугацаагаар хуралдааныг хойшлуулж өгөхийг хүссэн, тухайн шүүхийн бүх шүүгчээс татгалзах хүсэлт болон Н.С шүүгчээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.2-т заасны дагуу татгалзах хүсэлтийг тус тус гаргасан.

7.Эхний болон тус шүүхийн бүх шүүгчдээс татгалзах хүсэлтүүдээс шүүгч Н.С нь өөрийн захирамжаар уг татгалзлыг хүлээн авахгүйгээр шийдвэрлэсэн.

8.Эхний хоёр хүсэлтийн хувьд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.6 дахь хэсэгт “хэд хэдэн буюу хэргийг дангаар шийдвэрлэж байгаа шүүгчийг, түүнчлэн шүүх бүрэлдэхүүнийг татгалзан гаргах хүсэлтийг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч шийдвэрлэж захирамж гаргана.”, 92 дугаар зүйлийн 92.8 дахь хэсэгт “Ерөнхий шүүгч дангаар хэрэг хянан шийдвэрлэх явцад түүнийг татгалзсан буюу тухайн шүүхийн бүх шүүгчдийг татгалзсан бол шүүгчдийн зөвлөгөөнөөр олонхын саналаар шийдвэрлэн тогтоол гаргана.” гэж тус тус заасныг ноцтой зөрчсөн үйлдэл болсон.

9. Гурав дахь буюу шүүгч Н.С-ээс өөрөөс нь татгалзаж байгаа хүсэлтийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.2 дахь хэсэгт заасан журмыг мөн л ноцтой зөрчсөн.

10. Энэ нь Монгол Улсын Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.4.1-д “шүүгч хуульд тусгайлан ёс зүйн зөрчил болохоор заасан болон энэ дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг ёс зүйн зөрчил гэж үзнэ.”, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1-д “энэ хуульд заасан өөрийн бүрэн эрхээ урвуулан ашиглах”, 27.1.19-д “шүүгч хэргийн оролцогч болон бусад этгээдтэй албан үүргийн хувьд харилцахдаа зүй бус авирлах”-ыг шүүгчид хориглоно гэж заасныг тус тус зөрчсөн.

11. Шүүгч Н.С-ий дээрх үйлдлүүд нь Монгол улсын Үндсэн хуулиар болон бусад хууль тогтоомжоор баталгаатай эдлэх хэргийн оролцогчийн өмгөөлөгч авах шүүх хуралдаанд өөрийн сонгон авсан өмгөөлөгчтэйгөө оролцох эрхийг бүдүүлгээр зөрчсөн нь хүний эрх, эрхэм чанарыг огт хүндэтгээгүй үйлдэл бөгөөд шүүгч хүнд байж боломгүй хууль дээдлэх гэсэн хамгийн эрхэм чанарыг үл хүндэтгэн шийдвэр гаргасан нь хуульд тусгайлан ёс зүйн зөрчил болохоор заасан хэм хэмжээг зөрчсөн үйлдэл болно.

12. Шүүгч Н.С нь 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн шүүх хуралдаан дээр нэхэмжлэгч н.М-ийн шүүх хуралдаан дээр хэлсэн хэргийн үйл баримтын талаар үнэн зөв мэдүүлсэн, хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий мэдүүлэг нотлох баримтыг Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 96 дугаар 96.2, 96.3 дахь хэсэгт зааснаар хуулиар үүрэг болгоод байхад хуралдааны тэмдэглэлд санаатай, санамсаргүй алин болох нь мэдэгдэхгүй шүүх хуралдааны тэмдэглэлд оруулаагүй орхигдуулсан байгаа нь шүүгч хуралдаан тэмдэглэлийг огт уншиж хянадаггүй эсвэл нэхэмжлэгч талд ашиггүй мэдүүлэг, нотлох баримт байсан тул санаатай орхигдуулсан гэж үзэхээр байна.

13. Энэ нь дүрмийн 3.3.1-д “шүүгч хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй” гэж тусгайлан ёс зүйн зөрчил болохоор заажээ.

14. Итгэмжлэгдсэн төлөөлөгч миний эрхийг хязгаарлахдаа Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 31.1, Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3, 3.3, 3.2.1, 3.3.2, 3.3.6 гэсэн шүүгчийн ёс зүйн дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчин хариуцагч талын Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан үндсэн эрхийг хуульд байхгүй журмаар хязгаарлаж шүүгчийн ёс зүйн дүрмээр илт хориглосон үйлдэл, эс үйлдэхгүйг удаа дараа гаргасан шүүгч Н.С-д маш их гомдолтой байна.

15. Иймд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн 221/ЕМ2018/0028 дугаар магадлалыг хүчингүй болгож, П дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Н.С-д Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.3-т заасан огцруулах арга хэмжээг авч өгнө үү гэжээ.

ХЯНАВАЛ:

16. Б.Б, М.А, С.Э нараас Шүүхийн Ёс зүйн хороонд “...шүүх хуралдаанд өмгөөлөгчөөр оролцохыг хориглож, зөвхөн сонирхогч этгээдээр оролцохыг зөвшөөрснөөр өмгөөлөгчийн өмгөөллийн мэргэжлийн үйл ажиллагаа чөлөөтэй хэрэгжүүлэх, үйлчлүүлэгчээ өмгөөлөх эрхийг илт үндэслэлгүйгээр цагдсан, өмгөөлөгчийн халдашгүй чөлөөтэй байх эрхэнд халдсан, ... өмгөөлүүлэх буюу хууль зүйн туслалцаа авах эрхийг ноцтой зөрчсөн, хэн ч маргахгүй хуулийн тодорхой заалтыг удаа дараа зөрчиж Шүүгчийн ёс зүйн зөрчилд тооцогдох

илэрхий мэргэжлийн алдаануудыг гаргасан шүүгч Н.С-ийн санаатай үйлдлийг шалган тогтоож, холбогдох арга хэмжээ авч өгнө үү” гэх гомдлыг 2018 оны 6 дугаар сарын 05-ны өдөр гаргажээ.

17.Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаар гомдлыг хянан хэлэлцээд 117 дугаар тогтоолоор “...өмгөөлөгч Б.Б, М.А нарын оролцох шүүх хуралдаан давхацсан ч, тэдний эхний оролцсон хуралдаан хойшилж, тухайн хуралдаанд оролцохоор бэлэн ирсэн байхад нь шүүх хуралдаанд оролцуулаагүй” гэх үйл баримт тогтоогдсон, өмгөөлөгчийг шүүх хуралдаанд оролцуулаагүй нь тухайн хэргийн хариуцагч “ННН” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Э-гийн Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургаадугаар зүйлийн 14-т “...хууль зүйн туслалцаа авах эрх”-ийг хязгаарласан гэж дүгнэж, шүүгч Н.С нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д “...хүний эрхийг дээдлэх...” чадвартай байх шаардлага, Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлд заасан “... хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, хууль дээдлэх зарчмууд, 3.3 дугаар зүйлийн 1-д “Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй” гэснийг зөрчсөн гэж үзэж, шүүгчид сахилгын хэрэг үүсгэсэн байна.

18.Мөн, гомдолд дурдсан бусад “шүүх хуралдааны танхимаас өмгөөлөгч Б.Б-г гаргаж, өмгөөлөгчийн халдашгүй чөлөөтэй байх эрхэд халдсан, П дүүргийн бүх шүүгчээс татгалзах тухай хүсэлтийг өөрөө хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахдаа илэрхий мэргэжлийн алдааг удаа дараа гаргасан” гэх асуудлыг Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 2-т “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй” гэж заасны дагуу шүүгчийг ёс зүйн зөрчил гаргаагүй гэж үзжээ.

19.Шүүгч Н.С-д үүсгэсэн сахилгын хэргийг Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар хэлэлцээд 78 дугаар магадлалаар гомдол гаргагч нарын “...шүүх хуралдаанд өмгөөлөгчийг оролцуулаагүй, өмгөөлөгч авах эрхээр хангаагүй”, “... шүүхийн бүх шүүгчдээс татгалзах тухай /өмгөөлөгч М.А, Б.Б нарыг шүүх хуралдаанд оролцоогүй гэх үндэслэлээр/ хүсэлтийг “татгалзах хүсэлт” гэж үзэн шийдвэрлэх үндэслэлгүй” гэж үзсэн зэрэг нь Монгол Улсын Шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар 1, 3.1 дүгээр зүйлийн 3, 3.3 дугаар зүйлийн 1-д заасныг зөрчсөн гэж дүгнэж, шүүгч Н.С-д 2 сарын хугацаатай 20 хувиар цалинг бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан байна.

20.Уг магадлалыг эс зөвшөөрч гаргасан шүүгч Н.С-ийн гомдлоор сахилгын хэргийг хянаж, тус магадлалыг хүчингүй болгож шийдвэрлэсэн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалыг хяналтын шатны шүүх дараах үндэслэлээр хэвээр үлдээж шийдвэрлэлээ.

21.Сахилгын хэргийн материалд авагдсан баримтуудаас үзвэл, гомдлын “... өмгөөлөгч нарын оролцох өөр шүүхэд хэлэлцэгдэх, давхцаж байсан шүүх хуралдаан нь дуусаад шүүгч Н.С-ийн хянан шийдвэрлэх Н.М-ийн нэхэмжлэлтэй “ННН” ХХК-д холбогдох иргэний хэргийн хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн өмгөөлөгч нар нь тус шүүх хуралдаанд оролцохоор ирсэн байхад шүүгч Н.С нь, тэднээс өмнө нь гаргасан “... өмгөөлөгчийн оролцох хуралдаан давхацсан үндэслэлээр шүүх хуралдааныг хойшлуулах тухай хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн” гэж өмгөөлөгч нарыг шүүх хуралдаанд оролцуулалгүй, “сонирхогч”-оор суухыг зөвшөөрсөн, үүний улмаас хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Э-ээс “өмгөөлөгчтэй

оролцох, өмгөөлөгч авах” хүсэлт гаргасныг “ирцтэй холбоотой асуудлыг шийдвэрлэсэн” гэдгээр хүлээж аваагүй, өмгөөлөгч болон итгэмжлэгдсэн төлөөлөгч нараас “П дүүргийн бүх шүүгчээс татгалзах” хүсэлт гаргасныг өмгөөлөгч М.А, Б.Б нарын хувьд хуралдаанд оролцоогүй атлаа “татгалзах” хүсэлт ирүүлснийг “татгалзах хүсэлт”: гэж үзэн шийдвэрлэх үндэслэлгүй” гэж өөрөө хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн үйл баримт тогтоогдсон, уг үйлдлээрээ шүүгч Н.С нь Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1, 3.3 дугаар зүйлийн 1-д заасныг зөрчсөн болохыг Шүүхийн Ёс зүйн хорооны тогтоол, магадлалд зөв дүгнэсэн байна.

22.Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 167 дугаар зарлигаар баталсан “Шүүхийн Ёс зүйн хорооны дүрэм”-ийн “Тав”-ын 5.17-д “Шүүгчид холбогдох сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш зургаан сар, зөрчил гаргаснаас хойш нэг жил өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулахгүй” гэж, Монголын хуульчдын холбооны Шүүгчдийн хорооны Удирдах зөвлөлийн 2014 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 1/08 тогтоолоор баталсан “Монгол Улсын Шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм”-ийн 5.1 дүгээр зүйлийн 3-т “Ёс зүйн зөрчлийг илрүүлснээс хойш 1 сар, зөрчил гаргаснаас хойш 6 сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулж болохгүй” гэж тус тус өөрөөр заажээ.

23.Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмээр тус хорооны бүрэлдэхүүн, чиг үүргийг тодорхойлж, иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдээс Шүүхийн Ёс зүйн хороонд шүүгчийн сахилга, хариуцлага, ёс зүйтэй холбогдуулан гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг зохицуулснаар шүүгчийн ёс зүйтэй холбогдуулан гаргасан гомдлыг тус байгууллагаас хянан шийдвэрлэхтэй холбоотой журмын буюу “процесс”-ийн шинжтэй, харин Шүүгчийн ёс зүйн дүрмээр шүүгчийн баримтлах ёс зүйн хэм хэмжээг тогтоож, ёс зүйн зөрчлийг тодорхойлж, ёс зүйн зөрчил гаргасан шүүгчид хариуцлага ногдуулах хөөн хэлэлцэх хугацаа зэргийг зохицуулсан “материаллаг” шинжтэй эх сурвалжууд бөгөөд шүүх аливаа эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхэд нарийвчилсан эрх зүйн хэм хэмжээ, хэрэв байхгүй бол үүнд батлагдсан эрх зүйн эх сурвалжийг баримтлах нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4, 11.5-д заасан хууль хэрэглээний зарчимд нийцэх учир энэ тохиолдолд шүүгчид сахилгын шийтгэл ногдуулахад Шүүгчийн ёс зүйн дүрмээр тогтоосон хугацааг баримтална.

24. Гэтэл, Шүүхийн Ёс зүйн хороо нь шүүгч Н.С-ийн 2018 оны 2 дугаар сарын 28-ны өдөр гаргасан ёс зүйн зөрчлийг 2018 оны 7 дугаар сарын 6-ны өдөр илрүүлсэн атлаа 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдөр түүнд сахилгын шийтгэл ногдуулж, зөрчлийг илрүүлснээс хойш 3 сар гаруй хугацааны дараа, зөрчил гаргаснаас хойш 7 сар гаруй хугацаа өнгөрсөн байхад хариуцлага хүлээлгэсэн нь буруу, иймээс Ёс зүйн хорооны 78 дугаар магадлалыг хүчингүй болгох үндэслэлтэй.

25.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх, иргэн Б.М-ийн нэхэмжлэлтэй “ННН” ХХК-д холбогдох иргэний хэргийг хяналтын журмаар хянаж гаргасан Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны 2018 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 001/ХТ2018/1350 дугаар тогтоолыг үндэслэл болгож шүүгч Н.С-г ёс зүйн зөрчил гаргаагүй гэж дүгнэсэн нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1-д “давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн магадлалд ... давж заалдах шатны шүүхээс гаргаж байгаа шийдвэр, түүний үндэслэл тусгагдсан байна” гэж заасанд нийцэхгүй, хавтаст хэрэгт авагдсан баримтаар үгүйсгэгдэж байгаа хэдий ч энэ тохиолдлын хувьд

сахилгын шийтгэл ногдуулах хугацаа нэгэнт өнгөрсөн байхад шүүгчид сахилгын ногдуулсан нь буруу тул магадлалыг хэвээр үлдээх нь зүйтэй.

26.Иймд, дээрх үндэслэлээр гомдол гаргагч С.Э, М.А нарын хяналтын журмаар гаргасан “захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, шүүгч Н.С-д огцруулах арга хэмжээ авна уу” гэх гомдлыг хангахгүй орхих нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэлээ.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.2.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 221/ЁМ2018/0028 дугаар магадлалыг хэвээр үлдээж, гомдол гаргагч С.Э, М.А нарын гомдлыг хангахгүй орхисугай.

ТАНХИМЫН ТЭРГҮҮН

М.БАТСУУРЬ

ШҮҮГЧ

Ч.ТУНГАЛАГ



МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЁС ЗҮЙН ХОРООНЫ МАГАДЛАЛ

2018 оны 9 сарын 21 өдөр

Дугаар 54

Улаанбаатар хот

У дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн
шүүгч Б.У-д сахилгын шийтгэл ногдуулах тухай

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааныг тус хорооны дарга Н.Эрдэнэцогт даргалж, гишүүн Ч.Оюунчимэг, А.Доржготов, В.Жавхлан, О.Мөнхсайхан нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны тэмдэглэл хөтлөгчөөр шинжээч Ч.Ханддулам, референт Ж.Халиун нарыг оролцуулан Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдааны танхимд хийв. Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 02-р сарын 03-ны өдрийн 24 дугаар тогтоолыг Шүүхийн Ёс зүйн хорооны гишүүн О.Мөнхсайханы илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Иргэн Н.Э нь Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан гомдолдоо: "...Шүүгч Б.У нь шүүх хурлаа хийхгүйгээр 4 сар болж цаг хугацаагаар хохироосон. Шийдвэрээ 29 хоногийн дараа бэлэн болгож хууль зөрчсөн. Шүүх хурал дээр гаргаж өгсөн нотлох баримтыг аваагүй. Д.Б-ийн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож хохироож шийдвэрлэсэн, Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалаар анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон. Шүүгч Б.У нь ажил мэргэжлийн ур чадваргүй, хууль эрх зүйн мэдлэг нимгэн, бусдын хувь заяагаар тоглож хохироодогт гомдолтой байна. Түүнд сахилгын хэрэг үүсгэж, арга хэмжээ авч өгөхийг хүсье" гэжээ.

Шүүгч Б.У Шүүхийн Ёс зүйн хороонд ирүүлсэн тайлбартаа: "... У дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.У би 2016.08.02-ны өдрийн шүүх хуралдаанаар иргэн Д.Б-ийн нэхэмжлэлтэй иргэний хэргийг хэлэлцэж, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Гомдолд дурдсанаар дургүйцэж, өс хонзон санасан зүйлгүй. Шүүх хурлаа хийхгүйгээр 4 сар болсон гэх тухайд, хэргийг анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн давж заалдах шатны шүүхийн 2016.03.30-ны өдрийн 617 дугаар магадлалд дурдсанаар нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг тодруулах, нэхэмжлэгчийн гаргасан хүсэлтээр нотлох баримт бүрдүүлэх ажиллагааг хийсэн.

Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гаргаж өгсөн 2001.05.07-ны өдрийн огноотой хоёр хуудас баримтыг хэрэгт хавсаргах эсэхийг ИХШХШТХ-ийн 105 дугаар зүйлд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэрлэсэн. Миний бие 2016.08.08-ны өдрөөс ээлжийн амралтаа авсан бөгөөд ээлжийн амралтын эхний өдрүүдэд буюу 2016.08.15-нд шүүхийн шийдвэрийг бэлэн болгосон. Хэргийн ачааллаас хамааран хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахад цаг хугацаа ихээр шаардагддаг билээ. Иймд шийдвэрийг хуульд заасан хугацаанд гаргаж амжаагүй 6 хоног хэтэрсэн байдлыг харгалзан үзэж, иргэн Н.Э-ийн гомдлыг хэрэгсэхгүй болгож өгнө үү" гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 02-р сарын 03-ны өдрийн 24-р тогтоолоор шүүгч Б.У-д сахилгын хэрэг үүсгэж шийдвэрлэжээ. “Гомдол гаргагч Н.Э нь Шүүхийн Ёс зүйн хороонд шүүгч Б.У нь шүүх хурлаа хийхгүйгээр 4 сар болсон, шийдвэрээ 29 хоногийн дараа гаргаж хууль зөрчсөн гэж сахилгын хэрэг үүсгэж, арга хэмжээ авхуулахаар гомдол гаргасан байна.

Шүүгч Б.У Шүүхийн Ёс зүйн хороонд ирүүлсэн тайлбартаа хэргийг анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016.03.30-ны өдрийн 617 дугаар магадлалд дурдсанаар нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг тодруулах, нэхэмжлэгчийн гаргасан хүсэлтээр нотлох баримт бүрдүүлэх ажиллагаа хийсэн, миний бие 2016.08.08-ны өдрөөс ээлжийн амралтаа авсан бөгөөд ээлжийн амралтын эхний өдрүүдэд буюу 2016.08.15-нд шүүхийн шийдвэрийг бэлэн болгосон гэжээ.

Гомдол гаргагч Н.Э-ийн гомдолд дурдсан үндэслэлийн хүрээнд, цугларсан нотлох баримтын хэмжээнд дүгнэхэд шүүгч Б.У нь Д.Б-ийн нэхэмжлэлтэй, Т.Г-д холбогдох иргэний хэргийг шийдвэрлэхдээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1-д заасан хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 60 хоног дотор шийдвэрлэх, мөн хуулийн 119 дүгээр зүйлийн 119.3-т шийдвэр хүчинтэй болсон өдрөөс хойш 7 хоногийн дотор шийдвэрийн агуулгыг энэ хуулийн 118 дугаар зүйлд заасны дагуу бүрэн эхээр нь бичгээр үйлдэж, шүүгч, шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурах, шийдвэрийг гардуулах хуулийн хугацааг хэтрүүлж, шийдвэрийг хугацаанд нь бэлэн болгоогүй байна.

Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1-д шүүгч нь хууль дээдлэх үүрэгт ажилдаа хариуцлагатай хандах, мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх зэрэг зарчмуудыг хувийн зан чанар болгож төлөвшүүлэх нь шүүгчийн баримталбал зохих зарчим болно. Мөн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 1-д заасан шүүгч хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх албаны чиг үүрэгтээ хандах нь шүүгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд баримтлах ёс зүй юм. Шүүгч Б.У Шүүгчийн Ёс зүйн дүрмийн дээрх заалтыг хангаагүй байх тул шүүгчид сахилгын хэрэг үүсгэх нь зүйтэй байна.”

Шүүгч Б.У Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанд ирүүлсэн тайлбартаа: “У дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.У би 2016.08.02-ны өдрийн шүүх хуралдаанаар нэхэмжлэгч Д.Б-ийн нэхэмжлэлтэй хариуцагч Т.Г-д холбогдох Д.Б болон гэр бүлийн 7 ам бүлийн газрын Г-...0447, хувийн сууц Ү-...5437 дугаартай өмчлөх эрхийг сэргээлгэж, Т.Г-ийн хууль бус эзэмшлээс хашаа байшинг чөлөөлүүлэх тухай иргэний хэргийг хэлэлцэж нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Хэргийг Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2016.05.11-ний өдрийн 16858 дугаар захирамжаар Т дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх рүү шилжүүлсэн бөгөөд 2016.05.23-ны өдрийн 1/3176 дугаар албан бичгээр тус шүүхэд хүргэгдэж, улмаар 2016.06.01-ний өдөр шүүхийн бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнөөр У дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хэрэг шилжиж надад хуваарилагдсан.

Миний бие хэргийг хүлээн авч, дээд шатны шүүхээс гарсан тогтоолд дурдсан зөрчлийг арилгах ажиллагааг гүйцэтгэж, нэхэмжлэлийн шаардлагыг тодруулахыг нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Н.Э мэдэгдсэн. Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Н.Э 2016.06.24-ний өдөр нэхэмжлэлийн шаардлагаа тодруулж, нотлох баримтыг шүүхийн журмаар бүрдүүлэх хүсэлт гаргасан. Нэхэмжлэлийн тодруулсан шаардлагыг хариуцагчид 2016.07.18-ны өдөр гардуулан өгч, хариу тайлбар өгөх хугацааг 2016.08.01-ний өдрөөр тогтоосон.

Нотлох баримт гаргуулах нэхэмжлэгчийн хүсэлтийг хангасан 2016.06.28-ны өдрийн 23873 дугаар захирамжийг Нийслэлийн өмчийн харилцааны газар, У

дүүргийн өмч, газрын харилцааны албанд 2016.06.28-ны өдрийн 241, 242 дугаар албан бичгүүдээр хүргүүлсэн бөгөөд У дүүргийн өмч, газрын харилцааны албаны 2016.07.08-ны өдрийн 1495 дугаар албан бичгийг хавсралтын хамт 2016.07.19-ний өдөр, Нийслэлийн өмчийн харилцааны газрын 2016.07.26-ны өдрийн 4/4797 дугаар албан бичгийг мөн оны 7 дугаар сарын 28-ны өдөр тус шүүх хүлээн авсан.”

Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдаанаар гомдлыг хэлэлцээд ҮНДЭСЛЭХ нь:

Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 24 дугаартай тогтоолоор У дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.У-д сахилгын хэрэг үүсгэж шийдвэрлэжээ. Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааны 2017 оны 3 сарын 30-ны өдрийн 33 дугаар магадлалаар шүүгч Б.У-д сануулах сахилгын шийтгэл ногдуулж шийдвэрлэсэн. Шүүгч Б.У нь 2017 оны 3 сарын 30-ны өдрийн Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааны 33 дугаар магадлалыг эс зөвшөөрч давж заалдах гомдлыг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд 2017 оны 4 сарын 27-ны өдөр гаргажээ. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх 2017 оны 5 сарын 30-ны өдөр шүүгч Б.У-д сахилгын шийтгэл ногдуулсан Шүүхийн Ёс зүйн хорооны 33 дугаар магадлалын тухай хянан хэлэлцээд, 33 дугаар магадлалыг хүчингүй болгож, шүүгч Б.У-д холбогдуулан үүсгэсэн сахилгын хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан 221/МА2017/0381 дугаартай магадлал гаргасан байна.

Захиргааны хэргийн завж заалдах шатны шүүхийн 2017 оны 5 сарын 30-ны өдрийн 221/МА2017/0381 дугаартай магадлалд дурдсан асуудлаар нэмэлт шалгалт хийж, шүүгч Б.У-д үүсгэсэн сахилгын хэргийг 2017 оны 10 сарын 27-ны өдөр Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанаар дахин хэлэлцэж, шүүгч Б.У-д сануулах сахилгын шийтгэл ногдуулсан 55 дугаар магадлалыг гаргасан байна. Захиргааны хэргийн завж заалдах шатны шүүх нь шүүгч Б.У-гийн гомдлын дагуу түүнд холбогдох сахилгын хэргийг 2017 оны 12 сарын 27-ны өдөр хянан хэлэлцээд Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 10 сарын 27-ны өдрийн 55 дугаар магадлалыг хүчингүй болгож, шүүгч Б.У-д холбогдох сахилгын хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаах тухай 221/ЁМ2018/0001 дугаар магадлалыг гаргажээ. Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаан нь гомдол гаргагч Н.Э-ийн хяналтын журмаар гаргасан гомдлын дагуу шүүгч Б.У-д холбогдох сахилгын хэргийг 2018 оны 2 сарын 21-ний өдөр хянан хэлэлцээд Захиргааны хэргийн завж заалдах шатны шүүхийн 2017 оны 12 сарын 27-ны өдрийн 221/ЁМ2018/0001 дугаар магадлалыг хэвээр үлдээж, гомдол гаргагч Н.Эр-ийн гомдлыг хангахгүй байх агуулгатай 77 дугаартай тогтоолыг гаргажээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны гишүүний 2018 оны 4 сарын 06-ны өдрийн 20 дугаар захирамжаар Захиргааны хэргийн завж заалдах шатны шүүхийн 2017 оны 12 сарын 27-ны өдрийн 221/ЁМ2018/0001 дугаар магадлал болон Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2018 оны 02 сарын 21-ний өдрийн 77 дугаар тогтоолд дурдсан асуудлаар нэмэлт шалгалт хийж холбогдох нотлох баримт, мэдээлэл бүрдүүлэх даалгаврыг Ажлын албаны хяналт шалгалт хариуцсан референтэд өгсөн. Энэхүү нэмэлт шалгалтын үр дүнд үндэслэн шүүгч Б.У-д холбогдох сахилгын хэргийг Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанаар дахин хэлэлцэж энэхүү магадлалд тусгав.

Шүүгч Б.У 2016 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн шүүх хуралдаанаар иргэн Д.Б-ийн нэхэмжлэлтэй, хариуцагч Т.Г-д холбогдох иргэний хэргийг хэлэлцэж, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна. Энэ хэргийг шийдвэрлэхдээ шүүгч Б.У шүүгчийн ёс зүйн зөрчил гаргасан гэх гурван асуудлыг иргэн Н.Э гомдолдоо дурджээ. Эдгээр гурван асуудлын нэг нь шүүгчийн ёс зүйн зөрчил болох үндэслэлтэй бөгөөд нотлогдож байна. Бусад хоёр асуудал нь үндэслэлгүй бөгөөд нотлогдохгүй байна гэж бүрэлдэхүүн дүгнэв.

Монгол Улсад хуульд захирагдах зарчмыг ягштал баримтлахыг шүүгчид үүрэг болгодог. Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2-т төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмын нэг бол хууль дээдлэх гэж заасан бөгөөд шүүн таслах ажиллагаа нь төрийн үйл ажиллагаанд багтдаг учраас энэ зарчмыг шүүгч биелүүлэх үүрэгтэй. Тийм учраас, Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 1-д “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана” гэж заасан. Мөн, хууль дээдлэх зарчим нь процессын хуулиуд болон Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд ч тусгалаа олсон. Түүнчлэн, Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1-д зааснаар “хууль дээдлэх” зарчмыг хувийн зан чанар болгон төлөвшүүлэхийг шүүгчид үүрэг болгоод зогсохгүй энэ дүрмийн 3.3 дугаар зүйлд “Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй” гэж тодорхой заасан.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.3-т заасан 7 хоногийн дотор шүүгч шийдвэрээ бичгээр үйлдэх үүрэгтэй боловч 7 хоногийг урт хугацаагаар хожимдуулсан эсхүл энэ үүргээ давтан (эсхүл, удаа дараа) зөрчсөн тохиолдолд шүүгчийн ёс зүйн зөрчилд тооцно. Учир нь, Монгол Улсын зарим шүүхийн шүүгч нарын ачаалал хэт их байдаг. Мөн, шүүгч үндэслэлтэй сайн шийдвэр гаргах үүргээ биелүүлэхэд зарим ээдрээтэй хэрэг дээр ихээхэн хугацаа зарцуулах шаардлага үүсдэг. Тиймээс, шүүхийн шийдвэр гаргах хугацааг цөөн хоногоор эсхүл анх удаа хэтрүүлсэн асуудлыг шүүгчийн ёс зүйн зөрчилд тооцож сахилгын шийтгэл хүлээлгэх нь бодитой бус бөгөөд шийдвэрийн чанар, шүүгчийн хараат бус байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Гэхдээ, Шүүхийн Ёс зүйн хорооны энэ байр суурь нь шүүхийн шийдвэрийг хугацаа хожимдуулж гаргахыг зөвшөөрч буй хэрэг биш бөгөөд тухайн тохиолдол бүрд анализ хийж шүүгчийн ёс зүйн зөрчил мөн бишийг шийдвэрлэх ёстой.

Шүүгч Б.У 2016 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн шүүх хуралдаанаар иргэн Д.Б-ийн нэхэмжлэлтэй, хариуцагч Т.Г-д холбогдох иргэний хэргийг хэлэлцэж, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож. У дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 101/ШШ2016/05373 дугаар шүүхийн шийдвэр гаргажээ. У дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн 101/ШШ2016/05373 дугаар шүүхийн шийдвэрийг нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Н.Э 2016 оны 8 сарын 29-ний өдөр, хариуцагчийн өмгөөлөгч Л.Б 2016 оны 9 сарын 12-ны өдөр, гуравдагч этгээдийн өмгөөлөгч Ж.О 2016 оны 9 сарын 06-ны өдөр тус тус гардан авч гарын үсгээ зуржээ.

Гомдол гаргагч гомдолдоо “Шийдвэрээ 29 хоногийн дараа бэлэн болгож хууль зөрчсөн” гэжээ. Харин, шүүгч Б.У 2016 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар Д.Б-ийн нэхэмжлэлтэй, хариуцагч Т.Г-д холбогдох иргэний хэргийг хэлэлцэж гарсан шийдвэрийг 2016 оны 8 дугаар сарын 15-ны өдөр бэлэн болгосон гэдгээ Шүүхийн Ёс зүйн хороонд бичгээр ирүүлсэн хоёр удаагийн тайлбартаа хүлээсэн байна. Өөрөөр хэлбэл, уг шийдвэрийг хүчин төгөлдөр болсон өдрөөс нь хойш 14 хоногийн дараа бэлэн болгосон гэдэг нь нотлогдож байна. Иймд, шүүгч Б.У Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.3-т заасан “шийдвэр хүчинтэй болсон өдрөөс хойш 7 хоногийн дотор шийдвэрийн агуулгыг ... бүрэн эхээр нь бичгээр үйлдэж, шүүгч, шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурна” гэснийг зөрчсөн байна.

Шүүгч Б.У-гийн хувьд шийдвэрээ 7 хоногт бичгээр үйлдэх үүргээ давтан зөрчсөн учраас шүүгчийн ёс зүйн зөрчил гаргасан гэж бүрэлдэхүүн үзэв. Учир нь, шүүгч Б.У Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.3-т “шийдвэр хүчинтэй болсон өдрөөс хойш 7 хоногийн дотор шийдвэрийн агуулгыг ... бүрэн эхээр нь бичгээр үйлдэж, шүүгч, шүүх бүрэлдэхүүн

гарын үсэг зурна” гэснийг урьд нь ноцтой зөрчиж байжээ. “Шүүгч Б.У уг шийдвэрийг долоо хоногийн дотор бус харин найман долоо хоногийн дараа (шүүгч Б.У-гийн бичсэнээр дөрвөн долоо хоногийн дараа) гардаж авах боломжтой болгосон нь шийдвэр гаргах хуулийн хугацааг урт хугацаагаар хожимдуулсан” учраас түүнийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.3-т заасныг ноцтой зөрчсөн гэж Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааны 2016 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 63 дугаар магадлалаар дүгнэж, шүүгч Б.У-гийн цалингийн хэмжээг 2 сарын хугацаагаар 20 хувь бууруулах сахилгын шийтгэл ногдуулжээ. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 02 сарын 15-ны өдрийн 211/МА2017/0141 дугаар магадлалаар шүүгч Б.У-гийн буруугаас болж шүүх хуралдааны тэмдэглэл хуулийн хугацаанд бүрэн гараагүй, шүүхийн шийдвэрийг хүчинтэй болсон өдрөөс нь хойш 7 хоногийн дотор гаргаагүй зөрчлүүд гарсныг хүлээн зөвшөөрсөн боловч Шүүгчийн ёс зүйн дүрмийн 5.1 дүгээр зүйлийн 3-д “ёс зүйн зөрчлийг илрүүлснээс хойш 1 сар, зөрчил гарснаас хойш 6 сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулж болохгүй” гэх хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн гэсэн үндэслэлээр шүүгч Б.У-д холбогдох сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгожээ.

Дүгнэвэл, шүүгч Б.У шийдвэрийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 7 хоногийн дотор бүрэн эхээр нь бичгээр үйлдэх үүргээ хоёр удаа буюу давтан зөрчжээ. Иймд шүүгч Б.У-г Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1-д заасан “хууль дээдлэх” зарчмыг, мөн энэ дүрмийн 3.3 дугаар зүйлд “Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй” гэж заасныг зөрчсөн гэж дүгнэв.

Гомдол гаргагч Н.Э-ээс шүүгч Б.У-гийн талаарх энэхүү гомдлыг гаргах үед Т дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхүүдийн шүүгчид дотроос шүүгч Б.У-тай холбоотой шүүгчийн ёс зүй зөрчсөн тухай гомдол Шүүхийн Ёс зүйн хороонд хамгийн их ирээд байсныг дурдах нь зүйтэй. 2016 оны 01 дүгээр сарын 01-ээс 2017 оны 7 дугаар сарын 01-ийг хүртэлх хугацаанд Т дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нарт холбогдуулан Шүүхийн Ёс зүйн хороонд ирүүлсэн гомдлын мэдээлэл (сахилгын хэрэгт хавсаргасан)-ээс үзэхэд эдгээр шүүхийн нийт 30 шүүгчийг шүүгчийн ёс зүй зөрчсөн гэх гомдол ирснээс 18 шүүгч тус бүрд 1, 6 шүүгч тус бүрд 2, 3 шүүгч тус бүрд 3, 2 шүүгч тус бүрд 4 гомдол ирсэн бол зөвхөн шүүгч Б.У-д холбогдуулсан 8 гомдол ирсэн. Шүүгч Б.У-гийн талаарх эдгээр 8 гомдлоос 5-д нь Шүүхийн Ёс зүйн хороо сахилгын хэрэг үүсгэхээс татгалзаж, 3 гомдолд сахилгын хэрэг үүсгэж, 1 хэргийг хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, 1 хэрэгт цалингийн хэмжээг 2 сар 20 хувь бууруулах сахилгын шийтгэл, 1 хэрэгт цалингийн хэмжээг гурван сар 30 хувь бууруулах сахилгын шийтгэл тус тус ногдуулж байсан. Эдгээр 8 гомдол (сахилгын хэрэгт хавсаргасан)-ыг хэрхэн хянан шийдвэрлэсэн талаар товч тодруулъя.

Шүүхийн Ёс зүйн хорооны 2015 оны 7 сарын 01-ний өдрийн 105 дугаар тогтоол, Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 01 сарын 28-ны өдрийн 16 дугаар тогтоол, Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 10 сарын 06-ний өдрийн 146 дугаар тогтоолоор тус тус шүүгч Б.У-д сахилгын хэрэг үүсгэсэн бол Шүүхийн Ёс зүйн хорооны 2015 оны 10 сарын 01-ний өдрийн 165 дугаар тогтоол, Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 02 сарын 22-ний өдрийн 27 дугаар тогтоол, Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 03 сарын 04-ний өдрийн 39 дугаар тогтоол, Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 11 сарын 10-ны өдрийн 181 дүгээр тогтоол, Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 12 сарын 02-ны өдрийн 195 дугаар тогтоолоор түүнд сахилгын хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны 2015 оны 9 сарын 17-ний өдрийн 50 дугаар магадлалаар Шүүхийн Ёс зүйн хорооны 2015 оны 7 сарын 01-ний өдрийн 105

дугаар тогтоолоор сахилгын хэрэг үүсгэснийг үндэслэлтэй хэмээн үзэж, шүүгч Б.У-д сануулах сахилгын шийтгэл ногдуулсан. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2015 оны 11 сарын 11-ний өдрийн 546 дугаар магадлалаар Шүүхийн Ёс зүйн хорооны 2015 оны 09 сарын 17-ний өдрийн 50 дугаар магадлалыг хүчингүй болгож, шүүгч Б.У-д холбогдох сахилгын хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаажээ. Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 03 сарын 17-ны өдрийн 17 дугаар магадлалаар уг сахилгын хэргийг дахин хэлэлцээд Шүүхийн Ёс зүйн хорооны 2015 оны 07 сарын 01-ний өдрийн 105 дугаар тогтоолоор сахилгын хэрэг үүсгэснийг үндэслэлтэй хэмээн үзэж шүүгчийн ёс зүйн зөрчил гаргасныг тогтоосон ч хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн гэх үндэслэлээр шүүгч Б.У-д холбогдох сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгожээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 04 сарын 15-ны өдрийн 20 дугаар магадлалаар Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 01 сарын 28-ны өдрийн 16 дугаар тогтоолоор сахилгын хэрэг үүсгэснийг үндэслэлтэй хэмээн үзэж, шүүгч Б.У-гийн цалингийн хэмжээг гурван сар 30 хувь бууруулах сахилгын шийтгэл ногдуулжээ. Гэвч, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 06 сарын 16-ны өдрийн 211/ЁМ2016/0015 дугаар магадлалаар Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 04 сарын 15-ны өдрийн 20 дугаар магадлалыг хүчингүй болгож, шүүгч Б.У-д үүсгэсэн сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгожээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 12 сарын 08-ны өдрийн 63 дугаар магадлалаар Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 10 сарын 06-ний өдрийн 146 дугаар тогтоолоор сахилгын хэрэг үүсгэснийг үндэслэлтэй хэмээн үзэж, шүүгч Б.У-гийн цалингийн хэмжээг 2 сарын хугацаагаар 20 хувь бууруулах сахилгын шийтгэл ногдуулжээ. Гэвч, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 02 сарын 15-ны өдрийн 211/МА2017/0141 дугаар магадлалаар шүүгч Б.У ёс зүйн зөрчлүүд гарсныг хүлээн зөвшөөрсөн боловч хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн гэсэн үндэслэлээр шүүгч Б.У-д холбогдох сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгож, Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 12 сарын 08-ны өдрийн 63 дугаар магадлалыг хүчингүй болгожээ.

Шүүгч Б.У ээлжийн амралтаа 2016 оны 8 сарын 08-ны өдрөөс эхлэн мөн оны 09 сарын 05-ны өдөр хүртэл авсан байна. Шүүгч Б.У “Миний бие 2016.08.08-ны өдрөөс ээлжийн амралтаа авсан бөгөөд ээлжийн амралтын эхний өдрүүдэд буюу 2016.08.15-нд шүүхийн шийдвэрийг бэлэн болгосон” гэх тайлбарыг ирүүлжээ. Гэвч, ээлжийн амралт нь шүүхийн шийдвэрийг хуулийн хугацаанд гаргаагүйг зөвтгөх үндэслэл болохгүй. У дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний 2016 оны 06 сарын 02-ны өдрийн 101/ЗТ2016/01451 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Шүүхэд нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, шүүгчид хуваарилах журам”-ын 4 болон 11-т зааснаар ээлжийн амралт эхлэхийн өмнөх ажлын 10 өдөрт болон ээлжийн амралтын үед тухайн шүүгчид нэхэмжлэл, өргөдөл хуваарилахгүй байхаар заасан. Гэвч, тус журамд ээлжийн амралт эхлэхийн өмнөх ажлын 10 өдрөөс өмнө тухайн шүүгчид хуваарилагдсан нэхэмжлэл, өргөдөл, хэргийг хэрхэх талаар зохицуулаагүй байх тул ээлжийн амралт эдлэхтэй холбогдуулан өөрт буй нэхэмжлэл, өргөдөл, хэргийг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэх хариуцлагыг тухайн шүүгч өөрөө хүлээхээр ойлгогдож байна.

Шүүгч Б.У “Хэргийн ачааллаас хамааран хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахад цаг хугацаа ихээр шаарддаг билээ. Иймд шийдвэрийг хууль заасан хугацаанд гаргаж амжаагүй байдлыг харгалзан үзэж, иргэн Н.Э-ийн гомдлыг хэрэгсэхгүй болгож өгнө үү” гэсэн ч шүүгчийн ачаалал нь түүний шийдвэрээ урт хугацаагаар хожимдуулж гаргахыг зөвтгөх үндэслэл болохгүй. Мөн, шүүгч Б.У Д.Б-ийн нэхэмжлэлтэй энэхүү хэргийг шийдвэрлэх үед хэргийн ачаалал хэт их

байсан талаар эсхүл ээдрээ төвөгтэй хэрэг хянан шийдвэрлэхэд дунджаас илүү их зарцуулах шаардлагатай байсан талаар нэг ч нотлох баримтыг Шүүхийн Ёс зүйн хороонд гаргаж өгөөгүй.

Шүүгч Б.У 2016 оны 8 сарын 02-ны өдөр нэхэмжлэгч Д.Б-ийн нэхэмжлэлтэй, хариуцагч Т.Г-д холбогдох иргэний хэргийг шийдвэрлэх үедээ тухайн үеийн У дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн бусад шүүгч нараас илүү өндөр ачаалалтай байсан гэж үзэхээргүй байна. Учир нь, 2016 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс 2016 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хоорондох хугацааны У дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Шүүн таслах ажиллагааны мэдээ (сахилгын хэрэгт хавсаргасан)-д тус шүүхийн нийт 14 шүүгч тус бүрд хуваарилагдсан нэхэмжлэлийн тоо, нийт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тоо, шийдвэрлэсэн хэргийн тоо зэргийг хүснэгтээр гаргасан байна. Тухайлбал, шүүгч З.Б-д 760, шүүгч Б.М-д 772, шүүгч Д.Г-д 837, шүүгч Э.Э-д 847, шүүгч Д.З-д 860 нэхэмжлэл хуваарилагдсан бол шүүгч Б.У-д эдгээр шүүгч тус бүрийнхээс бага буюу 735 нэхэмжлэл хуваарилагдсан байна. Мөн, шүүгч Э.Э 73, шүүгч Д.Ц 70, шүүгч Т.Э 67, шүүгч Д.З 60 хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа тус тус явуулсан бол шүүгч Б.У эдгээр шүүгч тус бүрийнхээс бага буюу 50 хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулжээ. Дурдсан хугацаанд шүүгч Б.У нийт 344 хэрэг шийдвэрлэсэн бол 10 шүүгч түүнээс илүү олон тооны хэрэг шийдвэрлэсэн байна. Эндээс шүүгч Б.У 2016 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс 2016 оны 12 дугаар сарын 18-ны өдөр хүртэлх хугацаанд бусад шүүгчээс илүү ачаалалтай байгаагүй бөгөөд бусад шүүгчтэй харьцуулахад дундаж ачаалалтай ажиллаж байсан гэдэг нь харагдаж байна.

Тус хорооны нэмэлт шалгалтаар У дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 8 шүүгчийн 2016 оны ажлын гүйцэтгэлийг дүгнэсэн баримтын хуулбар(сахилгын хэрэгт хавсаргасан)-ыг хүлээн авав. Энэхүү баримтаас харахад 2016 онд шүүгч Б.У тухайн шүүхийн бусад шүүгчдээсээ илүү ачаалалтай байсан гэдэг нь нотлогдохгүй байна. Тухайлбал, шүүгч Б.У 2016 онд нийт 646 хэрэг, нэхэмжлэл хүлээн авсан бол шүүгч Э.Э нийт 672, шүүгч Д.З нийт 661, шүүгч З.Б нийт 626, шүүгч Б.М нийт 608, шүүгч Л.Э нийт 604, шүүгч Д.Б нийт 586, шүүгч Б.Ц нийт 365 хэрэг, нэхэмжлэл тус тус хүлээн авсан байна. Мөн, шүүгч Б.У 2016 онд нийт 453 хэрэг шийдвэрлэсэн бол шүүгч Д.Б нийт 497, шүүгч Л.Э нийт 459, шүүгч З.Б нийт 454, шүүгч Э.Э нийт 409, шүүгч Д.З нийт 361, шүүгч Б.М нийт 269, шүүгч Б.Ц нийт 175 хэрэг тус тус шийдвэрлэжээ. Түүнчлэн, шүүгч Б.У 2016 онд нийт 2043 тогтоол, захирамж гаргасан бол шүүгч З.Б нийт 3861, шүүгч Б.М нийт 3630, шүүгч Э.Э нийт 2069, шүүгч Д.З нийт 1725, шүүгч Л.Э нийт 1554, шүүгч Д.Б нийт 1447, шүүгч Б.Ц нийт 1118 тогтоол, захирамж тус тус гаргажээ. Эндээс үзэхэд, шүүгч Б.У 2016 онд бусад шүүгчээс илүү ачаалалтай байгаагүй бөгөөд бусад шүүгчтэй харьцуулахад дундаж ачаалалтай ажиллажээ.

Гомдолд "Шүүгч Б.У нь шүүх хурлаа хийхгүйгээр 4 сар болж цаг хугацаагаар хохироосон" гэж буруутгажээ. Энэхүү буруутгал нь нотлогдохгүй байна. Учир нь, уг хэргийг Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2016 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 16858 дугаар захирамжаар Т дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх рүү шилжүүлж, 2016 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 1/3176 дугаар албан бичгээр тус шүүхэд хүргэгдэж, шүүгч Б.У-д хуваарилагджээ. Нэхэмжлэлийн тодруулсан шаардлагыг хариуцагчид гардуулах, хариу тайлбар авах, нэхэмжлэгчийн хүсэлтээр нотлох баримтыг бүрдүүлэх зэргээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж, 2016 оны 8 дугаар сарын 02-ны өдөр хэргийг шүүх хуралдаанаар шийдвэрлэжээ.

Гомдолд "Шүүх хурал дээр гаргаж өгсөн нотлох баримтыг аваагүй" гэжээ. Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гаргаж өгсөн нотлох баримтыг хэрэгт

хавсаргах эсэх нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 105 дугаар зүйлд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэрлэгдэх бөгөөд шүүгчийн эрх хэмжээнд хамаарах асуудал учраас энэ нь тус хорооны харьяалалд үл хамаарна.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35, 36 дугаар зүйл, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйл, Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.1, 5.13-т заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.У дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.У-д сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Энэ магадлалын хувийг шүүгч болон гомдол гаргагчид хүргүүлэхийг Шүүхийн Ёс зүйн хорооны Ажлын албанд даалгасугай.

3.Шүүгч, гомдол гаргагч нар магадлалыг гардан авснаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ

Н.ЭРДЭНЭЦОГТ

ГИШҮҮН

О.МӨНХСАЙХАН

UIN.MN
СУДАЛГААНЫ САН



ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ
МАГАДЛАЛ

2019 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 221/ЁМ2019/0007

Улаанбаатар хот

У дүүргийн Иргэний хэргийн анхан шатны
шүүхийн шүүгч Б.У-д сахилгын шийтгэл
ногдуулсан Шүүхийн Ёс зүйн хорооны
магадлалын тухай

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааныг шүүгч Э.Зоригтбаатар даргалж, шүүгч Э.Лхагвасүрэн, Д.Баатархүү нарын бүрэлдэхүүнтэй, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Н.Өнө-Эрдэнэ, гомдол гаргагч Н.Э-г оролцуулан, Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 54 дүгээр магадлалыг эс зөвшөөрч шүүгч Б.У-гийн гаргасан давж заалдах гомдлыг шүүгч Д.Баатархүүгийн илтгэснээр хянан хэлэлцээд **ТОДОРХОЙЛОХ** нь:

Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 54 дүгээр магадлалаар: У дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.У-д сануулах сахилгын шийтгэл ногдуулж шийдвэрлэжээ.

Шүүгч Б.У давж заалдах гомдолдоо: "...Шүүхийн шийдвэрийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хугацаанд гаргаагүй буюу шийдвэрийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 7 хоногийн дотор бүрэн эхээр нь бичгээр үйлдэх үүргээ хоёр удаа, давтан зөрчсөн хэмжээн магадлалын үндэслэл хэсэгт дүгнэжээ. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ачаалал нь шүүхийн шийдвэрийг хугацаа хожимдуулж гаргахыг зөвтгөх үндэслэл болохгүй. Гэвч тухайн үед хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байсан хэргүүдийг шийдвэрлэх, бичих боловсруулах ажил үргэлжилсээр 2016 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн шүүх хуралдаанаас гарсан шийдвэрийг 2016 оны 8 дугаар сарын 15-ны өдөр гаргасан.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цаг хугацаа ихээр шаарддагийг харгалзаж үзэж, Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 54 дүгээр магадлалыг хүчингүй болгож өгнө үү" гэжээ.

ХЯНАВАЛ:

Иргэн Н.Э-ээс Шүүхийн Ёс зүйн хороонд "... шүүгч Б.У нь шүүх хурлаа хийхгүйгээр 4 сар болж цаг хугацаагаар хохироосон, ...шийдвэрээ 29 хоногийн дараа бэлэн болгож, хууль зөрчсөн. Шүүх хурал дээр гаргаж өгсөн нотлох баримтуудыг аваагүй, ... нэхэмжлэгч Д.Б-н нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, хохироож шийдвэрлэсэн. Шүүгч Б.У-гийн 05373 дугаар шийдвэрийг Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалаар хүчингүй болгосон. Шүүгч Б.У ажил мэргэжлийн ур чадваргүй, хууль эрх зүйн мэдлэг нимгэн ... тул сахилгын хэрэг үүсгэж хатуу арга хэмжээ авч өгнө үү" гэсэн гомдол гаргажээ.

Анх Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор шүүгч Б.У-д сахилгын хэрэг үүсгэж шийдвэрлэсэн байх бөгөөд Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 33 дугаар магадлалаар “сануулах” сахилгын шийтгэл ногдуулсан байна.

Улмаар уг магадлалыг шүүгч Б.У эс зөвшөөрч гомдол гаргасныг тус шүүхийн 2017 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 381 дүгээр магадлалаар Шүүхийн Ёс зүйн хорооны 33 дугаар магадлалыг хүчингүй болгож, шүүгч Б.У-д холбогдуулан үүсгэсэн сахилгын хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцааж шийдвэрлэжээ.

Шүүхийн Ёс зүйн хороо тус шүүхийн магадлалд дурдсан үндэслэлүүдээр нэмэлт шалгалт хийж, 2017 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 55 дугаар магадлалаар шүүгч Б.У-д “сануулах” сахилгын шийтгэл дахин ногдуулсныг тус шүүхийн 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 01 дүгээр магадлалаар Ёс зүйн хорооны 55 дугаар магадлалыг мөн хүчингүй болгон, дахин хэлэлцүүлэхээр буцаасныг Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2018 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 77 дугаар тогтоолоор хэвээр үлдээсэн байна.

Ингээд Шүүхийн Ёс зүйн хороо шүүхийн магадлал болон тогтоолд заасан үндэслэлээр холбогдох нотлох баримтуудыг цуглуулсны үндсэн дээр 2018 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр 54 дүгээр магадлалаар шүүгч Б.У-д сануулах сахилгын шийтгэл ногдуулсан нь дараах байдлаар үндэслэлтэй байна.

Сахилгын хэрэгт авагдсан нотлох баримтаас үзэхэд “шүүгч Б.У Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.3-т “шийдвэр хүчинтэй болсон өдрөөс хойш 7 хоногийн дотор шийдвэрийн агуулгыг ... бүрэн эхээр нь бичгээр үйлдэж, шүүгч, шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурна” гэж заасныг урьд нь ноцтой зөрчсөн, шүүгч Б.У шийдвэрийг 7 хоногийн дотор бус харин найман 7 хоногийн дараа гардаж авах боломжтой болгосон нь шийдвэр гаргах хуульд заасан хугацааг урт хугацаагаар хожимдуулсан” гэсэн үндэслэлээр Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 63 дугаар магадлалаар шүүгч Б.У-гийн “цалингийн хэмжээг 2 сарын хугацаагаар 20 хувь бууруулах” сахилгын шийтгэл ногдуулсныг тус шүүхийн 2017 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 141 дүгээр магадлалаар шүүгч Б.У-гийн гаргасан зөрчлийг хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн гэсэн үндэслэлээр хэргийг нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

Энэ сахилгын хэргийн хувьд шүүгч Б.У өмнө гаргасан зөрчлөө дахин гаргасан болох нь хэрэгт авагдсан баримт болон хэргийн оролцогчдын тайлбараар тогтоогдож байх ба Шүүхийн Ёс зүйн хорооноос гомдолд дурдсан нэхэмжлэгч Д.Б-ийн нэхэмжлэлтэй, хариуцагч Т.Г-д холбогдох иргэний хэргийг шийдвэрлэх үед У дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн нийт шүүгчдийн ажлын ачааллын судалгаа, шүүгч нарт хуваарилагдсан нэхэмжлэлийн тоо, шийдвэрлэсэн хэргийн тоон үзүүлэлтийг гаргуулан авч, бусад шүүгчидтэй шүүгч Б.У-г харьцуулахад илүү ачаалалтай биш, дундаж ачаалалтай байсан болох нь тогтоогдсон байх бөгөөд Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 54 дүгээр магадлалаар “шүүгч Б.У шүүхийн шийдвэрийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 7 хоногийн дотор бүрэн эхээр нь бичгээр үйлдэх үүргээ 2 удаа буюу давтан зөрчсөн” гэж үзэж, Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1-д “хууль дээдлэх” зарчим болон 3.3 дугаар зүйлийн 1-д “Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй” гэж заасныг зөрчсөн зөрчилд “сануулах” сахилгын шийтгэл ногдуулсан нь үндэслэлтэй байх тул магадлалыг хэвээр үлдээж, шүүгч Б.У-гийн давж заалдах гомдлыг хангахгүй орхих нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэв.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1, 120 дугаар зүйлийн 120.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 54 дүгээр магадлалыг хэвээр үлдээж, шүүгч Б.У-гийн давж заалдах гомдлыг хангахгүй орхисугай.

2.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.5 дахь хэсэгт зааснаар давж заалдах шатны шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийг буруу хэрэглэсэн, шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн нь шүүхийн шийдвэр гарахад нөлөөлсөн гэж хэргийн оролцогч болон өмгөөлөгч нар үзвэл магадлалыг гардан авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй.

ШҮҮГЧ

Э.ЗОРИГТБААТАР

ШҮҮГЧ

Э.ЛХАГВАСҮРЭН

ШҮҮГЧ

Д.БААТАРХҮҮ

UIN.MN
СУДАЛГААНЫ САН



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ХЯНАЛТЫН ШАТНЫ ЗАХИРГААНЫ
ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2019 оны 4 сарын 15 өдөр

Дугаар 110

Улаанбаатар хот

Н.Э-ийн гомдолтой, У дүүргийн
Иргэний хэргийн анхан шатны
шүүхийн шүүгч Б.У-д холбогдох
сахилгын хэргийн тухай

Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх
хуралдааны бүрэлдэхүүн:

Даргалагч: Танхимын тэргүүн М.Батсуурь

Шүүгчид: Д.Мөнхтуяа

П.Соёл-Эрдэнэ

Ч.Тунгалаг

Илтгэгч шүүгч: Г.Банзрагч

Нарийн бичгийн дарга: Д.Долгордорж

Гомдлын шаардлага: “У дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн
шүүгч Б.У-гийн Шүүгчийн Ёс зүйн дүрмийг зөрчсөн үйлдлүүдэд сахилгын хэрэг
үүсгэж, хатуу арга хэмжээ авхуулах”

Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 54 дүгээр
магадлал,

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 02 дугаар сарын
01-ний өдрийн 221/ЁМ2019/0007 дугаар магадлал,

Шүүх хуралдаанд оролцогч:

Гомдол гаргагч Н.Э-г оролцуулан,

Шүүгч Б.У-гийн хяналтын журмаар гаргасан гомдлыг үндэслэн хэргийг хянан
хэлэлцэв.

ТОДОРХОЙЛОХ нь:

Өмнөх шатны шүүхийн шийдвэр

1. Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 54
дүгээр магадлалаар: Шүүхийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйл, 36
дугаар зүйл, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйл, Шүүхийн ёс зүйн
дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.1, 5.13-т заасныг тус тус баримтлан У дүүргийн
Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.У-д сануулах сахилгын шийтгэл
ногдуулсан.

2. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 02 дугаар
сарын 01-ний өдрийн 221/ЁМ2019/0007 дугаар магадлалаар: Шүүхийн Ёс зүйн
хорооны 2018 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 54 дүгээр магадлалыг хэвээр
үлдээж, шүүгч Б.У-гийн давж заалдах гомдлыг хангахгүй орхисон.

Хяналтын журмаар гаргасан гомдол

3. “Иргэн Н.Э-ээс Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан гомдлоор У дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.У-д сахилгын хэрэг үүсгэгдэж, тус хорооны 2018 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 54 дүгээр магадлалаар шүүгчид сануулах сахилгын шийтгэл ногдуулсан.

4. 2016 оны 8 дугаар сарын 02-ны өдөр хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, шүүхийн шийдвэрийг мөн оны 8 дугаар сарын 15-ны өдөр бэлэн болгосон. Хөөн хэлэлцэх хугацаа дууссан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цаг хугацаа ихээр шаардагддагийг харгалзан үзэж, Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 54 дүгээр магадлал, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 221/ЁМ2019/0007 дугаар магадлалыг тус тус хүчингүй болгож өгнө үү гэжээ.

ХЯНАВАЛ:

5. Шүүхийн Ёс зүйн хорооны болон давж заалдах шатны шүүхийн магадлал хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байна.

6. Шүүгч Б.У-аас хяналтын журмаар гаргасан гомдолд заасан “хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн”, “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ачаалал их байдаг бодит нөхцөл байдлыг харгалзан үзэж ...” гэсэн утгатай уг тогтоолын Тодорхойлох хэсгийн 4-т заасан хоёр үндэслэл нь дараах байдлаар үгүйсгэгдэж байна.

7. Иргэн Н.Э-ээс Шүүхийн Ёс зүйн хороонд 2016 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр шүүгч Б.У-д холбогдуулан У дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн шүүх хуралдаанаар хэлэлцэгдэж шийдвэрлэгдсэн, Д.Б-ийн нэхэмжлэлтэй, хариуцагч Т.Г-д холбогдох иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотойгоор “шүүгч Б. У нь шүүх хурлаа хийхгүйгээр 4 сар болж цаг хугацаагаар хохироосон, нотлох баримтыг аваагүй, шийдвэрээ 29 хоногийн дараа бэлэн болгож хууль зөрчсөн...” гэсэн үндэслэлээр гомдол гаргасан байна.

8. Уг гомдлын дагуу Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор шүүгч Б.У-д сахилгын хэрэг үүсгэн, улмаар тус хорооны 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 33 дугаар магадлалаар “сануулах” сахилгын шийтгэл ногдуулсан ба түүнээс хойш энэхүү маргаан тасралтгүй үргэлжилж шат шатны шүүхээр хянан хэлэлцэгдсэний эцэст хамгийн сүүлд Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 54 дүгээр магадлалаар шүүгч Б.У-д сануулах сахилгын шийтгэл ногдуулсныг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 221/ЁМ2019/0007 дугаар магадлалаар хэвээр үлдээжээ.

9. Шүүхийн Ёс зүйн хорооны дүгнэсэнчлэн, шүүгч Б.У нь 2016 оны 8 дугаар сарын 02-ны өдөр хийсэн шүүх хуралдаанаас гарсан шийдвэрээ 2016 оны 8 дугаар сарын 15-ны өдөр бэлэн болгосон, түүнийг нь нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Н.Э 2016 оны 8 дугаар сарын 29-ний өдөр хүлээн авсан байна.

10. Иймд, зөрчлийг 2016 оны 8 дугаар сарын 29-ний өдөр гарсан гэж үзвэл, иргэн Н.Э нь шүүхийн шийдвэрийг гардаж авснаас хойш 1 сарын дотор буюу 2016 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр гомдол гаргаж, Шүүхийн Ёс зүйн хорооноос зөрчил гаргаснаас хойш 6 сарын дотор буюу 2017 оны 02 дугаар сарын 03-ны өдөр хэрэг үүсгэж, хянан шийдвэрлэсэн нь Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4, Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 5.1 дүгээр зүйлийн 2-т заасан “зөрчлийг илрүүлснээс хойш 1 сар, зөрчил гаргаснаас хойш 6 сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулж болохгүй” гэсэнд хамаарахгүй, өөрөөр хэлбэл, хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн гэж үзэхгүй.

11.Шүүгч Б.У-гийн хэргийн ачааллын талаар Шүүхийн Ёс зүйн хорооноос шаардагдах нотлох баримтыг хангалттай цуглуулж, харьцуулан дүгнэсэн нь үндэслэлтэй байх тул гомдлын “бодит нөхцөл байдлыг харгалзаж ...” гэсэн үндэслэл үгүйсгэгдэж байна.

12.Мөн Шүүхийн Ёс зүйн хороо болон давж заалдах шатны шүүхээс шүүгч Б.У-гийн ёс зүйн зөрчилд өгсөн бусад дүгнэлт болон хүлээлгэсэн сахилгын шийтгэл нь хууль болон бодит нөхцөл байдалд тохирсон гэж үзлээ.

13.Иймд, шүүх бүрэлдэхүүн шүүгч Б.У-гийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангалгүй орхиж, Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал болон Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээхээр тогтов.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.1, 127.2.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 9 дүгээр сарын 21 -ний өдрийн 54 дүгээр магадлал, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 221/ЁМ2019/0007 дугаар магадлалыг тус тус хэвээр үлдээж, шүүгч Б.У-гийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангахгүй орхисугай.

ТАНХИМЫН ТЭРГҮҮН

М.БАТСУУРЬ

ШҮҮГЧ

Г.БАНЗРАГЧ

UIN.MN
СУДАЛГААНЫ САН



МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЁС ЗҮЙН ХОРООНЫ МАГАДЛАЛ

2018 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 75

Улаанбаатар хот

Ф аймгийн Эрүү, Иргэний хэргийн
давж заалдах шатны шүүхийн Ерөнхий
шүүгч Ё.Б-д сахилгын шийтгэл ногдуулах тухай

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааныг тус хорооны дарга Н.Эрдэнэцогт даргалж, гишүүн В.Жавхлан, А.Доржготов, Д.Сүнжид, Ч.Оюунцэцэг нарын бүрэлдэхүүнтэй, шүүгч Ё.Б, хяналт шалгалт хариуцсан референт Б.Энхбаатар, хуралдааны тэмдэглэл хөтлөгчөөр шинжээч Ч.Ханддулам нарыг оролцуулан, Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдааны танхимд хийж, Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 79 дүгээр тогтоолоор шүүгч Ё.Б-д сахилгын хэрэг үүсгэсэн хэргийг Ёс зүйн хорооны гишүүн Ч.Оюунцэцэгийн илтгэснээр хянан хэлэлцээд **ТОДОРХОЙЛОХ** нь:

Шүүхийн Ерөнхий зөвлөлд Авлигатай тэмцэх газраас шилжүүлж ирүүлсэн 2018 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01/..60 тоот албан бичигт: “Тус газарт иргэнээс ирүүлсэн гомдлын дагуу Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Ф аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч Ё.Б-гийн 2015, 2016 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгалаа.

Шалгалтаар мэдүүлэг гаргагч Ё.Б нь 2015, 2016 оны мэдүүлгийн "тээврийн хэрэгсэл" хэсэгт гэр бүлийн гишүүн эхнэр Л.Т-ийн эзэмшлийн HYUNDAI маркийн Porter загварын бага оврын ...46 ХХХ улсын дугаартай ачааны зориулалттай тээврийн хэрэгслийг мэдүүлээгүй нь Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг зөрчсөн байна.

Ф аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч Ё.Б-гийн гаргасан зөрчил нь бүртгэл, хяналтын байгууллагаас ирүүлсэн мэдээлэл, лавлагаа болон бичгийн нотлох баримт, мэдүүлэг гаргагчийн өөрийнх нь ирүүлсэн тайлбар зэргээр тогтоогдож байх тул Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.8.1 дэх заалтад дурдсаны дагуу хариуцлага тооцуулах үндэслэлтэй байна.

Иймд дээрх хяналт шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал болон Авлигатай тэмцэх газрын бүрэн эрхийн хүрээнд гаргасан шийдвэрийг биелүүлэх, зөрчил гаргасан албан тушаалтанд хуульд заасны дагуу хариуцлага тооцож, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсэгт заасныг үндэслэн 2018 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн дотор тус газарт хариуг ирүүлнэ үү.

Мөн Авлигын эсрэг хууль, тогтоомжид заасан үүргээ биелүүлээгүй, зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцохдоо Захиргааны ерөнхий хууль болон бусад хууль, тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлж, цаашид уг зөрчлийг

давтан гаргахгүй байх чиглэлээр Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан үүргийг хэрэгжүүлэн ажиллах нь зүйтэй болно.” гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хороонд шүүгч Ё.Б ирүүлсэн тайлбартаа: “Миний бие 2015 онд Монголд орж ирсэн HYUNDAI” ачааны96 хөдөлгүүрийн багтаамж "B" 2470 даац 1 тонн, 3 хүний суудалтай, 2002 онд үйлдвэрлэгдсэн Портер ногоон өнгийн машин "ТТТ" А аймгийн танил зах дээрээс 2015 оны 08 дугаар сарын 03-нд 7 сая төгрөгөөр худалдан авч малчин Б.Б-д эзэмшүүлэн өгч 2 жилийн хугацаагаар сарын 300.000 төгрөгийн нөхцөлтэй мал маллуулсны цалиндаа тооцуулж бүр мөсөн өгсөн. 3 дахь жилдээ болж байна. Одоогийн үнэлгээ элэгдэл, хорогдлоо тооцоод 2.700.000 төгрөг орчим үнэлэгдэнэ. Харин давхар өмчлөгчийн нэрийг эхнэр Л.Т-ийн нэр дээр уг машины өмчлөгчөөр нэрийг нь салгаагүй яваа нь үнэн. Учир гэвэл: Эзэмшигч жолооч Б.Б залуу хүн алдаж онох вий эрсдэл гаргах вий, янз бүрийн хулгайн тээвэр, элдэв ачаа бараа ачиж зөрчилд орохоос болгоомжлон давхар хяналтад байлгах зорилгоор эхнэрийг машин өмчлөгчөөр бичиг баримтыг нь нэршлээс нь салгаагүй өдий хүрсэн юм. Жолоочийн хариуцлагын даатгалын гэрээн дээр ч энэ 2 хүний нэршил байгаа /баримтыг хавсаргав/. Бодит байдал дээр тэр үедээ л малаа маллуулж байгаа Б.Б-ийн эзэмшил, захиран зарцуулах эрх нь өмчлөлд бүрэн очсон үйл явдал болж өнгөрсөн тул хөрөнгө орлогын мэдүүлэгтээ тусгаагүй юмаа. Тэрнээс биш өөр ямар нэгэн нууж хуурах санаа зорилго үгүй билээ. Одоо энэ машин нэлээд элэгдэл, хорогдол гарч засвар үйлчилгээ ч шаарддаг болсон. Энэ жилийн хөрөнгө орлогын мэдүүлэгтээ тусгасан болно. Болсон нөхцөл байдлыг үнэн зөвөөр тайлбарласан. Ийм учраас арга хэмжээ авхуулмааргүй л байна.” гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 79 дүгээр тогтоолоор Ф аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч Ё.Б-д сахилгын хэрэг үүсгэж шийдвэрлэсэн байна.

Ф аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч Ё.Б-ээс Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 79 дүгээр тогтоолд тайлбар ирүүлж, хуралдаанд оролцож гаргасан тайлбартаа: Миний бие 2018 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 79 тоот Шүүхийн Ёс зүйн хорооны тогтоолыг эс зөвшөөрч гомдол гаргаж байна.

Учир гэвэл Авлигатай тэмцэх газраас 2018 оны 02 дугаар сарын 14-ний 01/..60 тоот албан бичгээр тус газарт иргэн Ж.О-оос ирүүлсэн гомдлын дагуу авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн миний 2015, 2016 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хянан шалгаж гэр бүлийн гишүүн эхнэр Л.Т-ийн нэртэй Hyundai маркийн портер загварын бага оврын .46 ХХХ улсын дугаартай ачааны зориулалттай тээврийн хэрэгслийг мэдүүлээгүй нь авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг зөрчсөн гэж албан бичгээр шүүхийн ес зүйн хороонд шилжүүлснээр сахилгын хэрэг үүсгэсэнд гомдол гаргаж байна.

Хүндэтгэн үзэх шалтгаан нөхцөл гэвэл: Тэр машиныг малчиндаа эзэмшүүлж, ашиглуулж захиран зарцуулах эрх нь Б.Б-д бүрэн шилжүүлсэн гэж ойлгосноор бодож хөрөнгө орлогын мэдүүлэгтээ тусгаагүйгээр гагцхүү өөрсдийн хяналтад байлгах зорилгоор эхнэрийн нэрийг өмчлөгчөөр нэршүүлсэн гол санаа зорилго нь эзэмшигч Б.Б-г янз бүрийн хууль зөрчиж тээвэр хийхээс болгоомжлоход оршино.

Тэр машин одоо 4 дэх жилдээ малчин Б.Б-д эдлэгдэж, хуучирч, эвдэрсэн, үнэлгээ нь 2,700,000 төгрөгөөр зах зээлд үнэлэгдэж байна

Миний бие багаасаа л эцэг, эхийнхээ сургаалаар зөв төлөвшиж, боловсорч, өсөж, өндийж, улс нийгэмдээ үнэнч, ёс суртахуунтай амьдарсаар өдий хүрсэн, нэр төрдөө маш их хайртай учир гомдож байна

Миний талаар авлигатай тэмцэх газарт мэдээлэл өгч шалгуулснаас хойш хуулийн хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн гэж би ойлгож байна. Энэ тухай авлигатай тэмцэх газраас хугацааны мэдээлэл авах гэтэл хувь хүнд өгөхгүй танай ёс зүйн хорооны албан бичиг ирвэл өгнө гэдэг үндэслэлээр ёс зүйн зөрчлийнхөө хөөн хэлэлцэх хугацааны нотолгоогоо авч чадахгүй байна.

Эцэст нь миний бие хөрөнгө оруулгын мэдүүлгээ жил бүр үнэн зөв гаргаж хуулийн хугацаанд холбогдох газруудад хүргүүлдэг учир гомдолтой байна,

Тэр хөрөнгө орлогын мэдүүлэгтээ мэдүүлээгүй гээд байгаа эхнэрийн нэр дээрх машины хувьд гэвэл учир шалтгаан, санаа зорилгоо тов тодорхой бичсэн.

Надад анхнаасаа нууя гэсэн санаа зорилго, шууд санаа сэдэлт байхгүй гэдгээ бүх тайлбар, мэдүүлэг, нотолгоогоо авлигатай тэмцэх газарт удаа дараа өгсөн болно.

Дээрх үндэслэлүүдээр Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанд гомдол, тайлбараа гаргаж байгааг минь хүлээн авна уу гэв.

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанаар хэлэлцээд ҮНДЭСЛЭХ нь:

Шүүхийн Ёс зүйн хороонд Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс шилжүүлэн ирүүлсэн Авлигатай тэмцэх газрын 2018 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01/60 тоот албан бичигт Ф аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч Ё.Б-д холбогдуулан хариуцлага тооцуулах талаар гомдлыг гаргажээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 79 дүгээр тогтоолоор шүүгч Ё.Б-д сахилгын хэрэг үүсгэж шийдвэрлэсэн нь үндэслэлтэй болсон байна гэж Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанаас дүгнэв.

Авлигатай тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэгт заасны дагуу Авлигатай тэмцэх газраас Ф аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч Ё.Б-гийн 2015, 2016 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгасны дүнд тус шүүгчийн 2015, 2016 оны мэдүүлгийн "тээврийн хэрэгсэл" хэсэгт гэр бүлийн гишүүн эхнэр Л.Т-ийн эзэмшлийн HYUNDAI маркийн Porter загварын бага оврын .46 ХХХ улсын дугаартай ачааны зориулалттай тээврийн хэрэгслийг мэдүүлээгүй нь Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг зөрчсөн болохыг тогтоожээ.

Ф аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч Ё.Б Авлигын эсрэг хуулийн холбогдох заалтыг зөрчсөн нь Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1.3.1-ийн "Шүүгч нь ...хууль дээдлэх, үнэнч шударга байх, ... үүрэг ажилдаа хариуцлагатай хандах, ... мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх зэрэг зарчмуудыг хувийн зан чанар болгож төлөвшүүлнэ", 4.1-т заасан "Шүүгч нь өөрийн хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ холбогдох хууль тогтоомжид заасны дагуу үнэн зөв мэдүүлнэ" гэсэн заалтыг тус тус зөрчсөн гэж үзэв.

Шүүгч Ё.Б шүүхийн Ёс зүйн хороонд ирүүлсэн бичгээр гаргасан тайлбарт болон хуралдаанд гаргасан мэдүүлэгтээ зөрчил гаргасан талаар маргаагүй, энэ хугацаанд шүүгч нь өөрийн эхнэр Л.Т-ийн нэр дээр байгаа эзэмшлийн HYUNDAI маркийн Porter загварын бага оврын .46 ХХХ улсын дугаартай ачааны зориулалттай тээврийн хэрэгслийг 2017 оны хөрөнгө орлогын мэдүүлэгтээ тусгасан байсан болон мөн 2018 оны 9 дүгээр сарын 19-ний байдлаар эхнэр

Л.Т-ийн нэр дээрээс хасуулж, хамтран эзэмшиж байсан Б.Б-ийн нэр дээр ганц хүний өмчлөгчөөр шилжүүлж, мэдүүлээгүй тухай тээврийн хэрэгслийн зөрчлийг арилгасан байгаа /сахилгын хэргийн 30, 31 дэх тал/ нөхцөл байдлыг харгалзан шүүгч Ё.Б-д сахилгын шийтгэлийг ногдуулахаар тогтов.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1, 36 дугаар зүйлийн 36.1.1, 37 дугаар зүйлийн 37.1.1, Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5.7.1, 5.13, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйлийг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Ф аймгийн Эрүү, иргэний хэргийн Давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч Ё.Б-д сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Энэ магадлалын хувийг шүүгч болон гомдол гаргагчид хүргүүлэхийг тус хорооны Ажлын албанд даалгасугай.

3.Магадлалыг эс зөвшөөрвөл гардан авснаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.

ДАРГАЛАГЧ

Н.ЭРДЭНЭЦОГТ

ГИШҮҮН

Ч.ОЮУНЦЭЦЭГ

UIN.MN
СУДАЛГААНЫ САН



МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЁС ЗҮЙН ХОРООНЫ МАГАДЛАЛ

2018 оны 3 сарын 02 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Ш дахь Сум дундын Эрүүгийн
хэргийн анхан шатны шүүхийн шүүгч
Ч.Б-д сахилгын шийтгэл ногдуулах тухай

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааныг хорооны гишүүн А.Доржготов даргалж, гишүүн О.Мөнхсайхан, Ч.Оюунцэцэг, В.Жавхлан, Н.Эрдэнэцогт, Д.Сүнжид нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны тэмдэглэл хөтлөгчөөр ажлын албаны шинжээч А.Энхбаатар, хяналт шалгалт хариуцсан референт А.Баасанжав нарыг оролцуулан Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдааны танхимд хийв.

Шүүгч Ч.Б-ээс Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 199 дүгээр тогтоолыг эс зөвшөөрч нийт гишүүдийн хуралдаанд тайлбар гаргасныг Ёс зүйн хорооны дарга Н.Эрдэнэцогтын илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Гомдол гаргагч С.Э, С.О нар Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан гомдолдоо: С.Э миний бие нь 2017 оны 03 сарын 7-ны өдөр бусдад зодуулж биедээ хөнгөн гэмтэл авч эрхээ хамгаалуулахаар цагдаагийн байгууллагад хандсан. Ингээд хэргийг шалгаж гэм буруутай В.С гэгчийн хэргийг шийдвэрлүүлэхээр шүүхэд шилжүүлсэн. Энэ үед шүүгч Ч.Б-д миний хэрэг шилжсэн. Ингээд анхны шүүх хуралдаан 2017 оны 6 сарын 09-ний өдөр болж тухайн өдөр Ч.Б шүүгч нь В.С-г биш намайг л загнаж байгаад шүүх хуралдааныг дуусгасан. Ингэхдээ намайг хаанаас мөнгө олж шүдээ эмчлүүлээд байгаа юм бэ, яахаараа заавал өндөр үнэтэй солонгос эмнэлэгт шүд хийлгэдэг юм бэ? Шүд чинь 7 хоногийн дотор эдгэх ёстой, юм болгон тарифтай байх ёстой, би энэ талаар мэднэ гэх мэтчилэн намайг загнаж эхэлсэн бөгөөд байж байгаад л В.С-тэй эвлэр гээд шахаад байсан. Ингээд энэ шүүх хурал дээр миний хохирлын баримтуудыг нэхэмжлэх үү үгүй юу гэж надаас баахан асууж байгаад бүгдийг нь хэрэгсэхгүй болгож надад хохирол гаргаж өгөөгүй. Тэгснээ В.С-г төлөх төлбөр байхгүй гэх мэтчилэн бүх талаас нь өмгөөлж хамгийн хөнгөн ял өгсөн. Энэ шүүх хурал дээр илт өөрийн хандлага харилцаагаараа В.С-ийн талд хэргийг шийдвэрлэх гэж байгаа нь мэдэгдэж байсан юм. Надтай байнга дээрэнгүй үгээр харилцаж байсан. Ингээд дээрх шийтгэх тогтоолд би давж заалдах гомдол гаргасан бөгөөд давж заалдах шатны шүүхээс хэргийг хянаад дахин шийдвэрлэх, хууль зөрчсөн байна гэж дүгнэсэн. Ингээд анхан шатны шүүхэд хэрэг ирсэн бөгөөд мөн л нөгөө Ч.Б шүүгчид хэргийг өгсөн.

Бид өмнө нь намайг байнга хашхичиж С-ийн талд илт үйлчлээд байсан тул тэр шүүгчийг татгалзсан боловч хүлээж аваагүйгээр барахгүй дахин хэргийг шийдвэрлэхдээ мөн л харилцаа хандлага ёс зүйн маш том алдаа, дутагдал гаргаж байсан. 2 дахь шүүх хуралдаан 2017 оны 10 сарын 04 -ний өдөр болсон. Энэ үед

чи яг шүд хийлгэсэн юм уу гэх мэтээр дахин дахин асуугаад, хагалгааны зураг үзүүлсэн чинь энэ хагалгаа хийлгэж байгаа хүн чамайг гэж хэн батлах юм бэ, гэж В.С-ийн өмгөөлөгчийн хэлсэн үг болгоноор намайг загнасан. Би хагалгаанд ороод 2-хон хонож байхад миний амыг ангайлгаж цагдаатайгаа хамт үзээд байсан. Би тухайн үед удаан ч ярих боломжгүй байсан, улмаар давахын хурал дээр чи нэг өөр юм ярьдаг гээд л надад хонзогноод байгаа бололтой их аягүйцээд байсан. Бас чи эм авч уусан юм бол ямар эмчийн заавраар авч уусан юм бэ? Эмчийн заавар чинь хаана байна, ууж байгаа эмийнхээ нэрийг тогтооход яадаг юм бэ гэх мэтчилэн намайг бичиг үсэг мэдэхгүй болохоор басамжлан доромжилж мөн л В.С гэгчийн хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн Энэ шүүх хуралдааны ажиллагаанууд бүгд бичлэгт бичигдсэн байгаа тул та бүхэн татаж хянаж ёс зүйгүй шүүгчийн үйлдлийг таслан зогсоож өгнө үү. Би маш их гомдолтой байна. Эрхээ хамгаалуулах гэж хуулийн байгууллагад хандсан болохоос хүнд ялгаварлан гадуурхагдах гэж, бусдад дээрэлхүүлэх гэж би хуулийн байгууллагад хандаагүй ээ. Би бичиг үсэг мэдэхгүй эмийн нэр ч сайн цээжилдэггүй. Гэтэл миний энэ бүх байдлыг миний эсрэгээр ашигласан. Би 2 дахь шүүх хуралдааны шийдвэрийг 2017 оны 10 сарын 30-ны өдөр гардан аваад А хот руу эмчилгээндээ явсан. Ингэхдээ төрсөн эгчдээ шүүхийн тогтоолд давж заалдсан гомдлоо өгөөд аваачаад өгчхөөрэй гэсэн чинь “С.Э-г өөрөө ир гэж хэл, өөрөө ирж өгөх ёстой гээд Ч.Б шүүгч аваагүй. Тухай үед туслахынхаа өрөөнд Ч.Б шүүгч байж байсан. Ингээд гомдол гаргах хугацаа хоцрох гээд байсан тул эгчтэйгээ ярилцаад би А хотоос очих боломжгүй эмчилгээ эхэлсэн байсан тул аймгаасаа шууданд хийлгэсэн. Ингэхдээ шуудангаас дардас дарсан. Гэтэл мөн л миний эмчилгээний баримтуудаас шалтаг гаргаж хэрэгсэхгүй болгодог шигээ хэзээ хаанаас ирсэн нь тодорхой бус шүүхийн бичиг хүргэгчээр дамжаагүй, бүртгэлийн дэвтэрт бүртгэгдээгүй гээд бас л Ч.Б шүүгч хүлээн авахаас татгалзсан хариу өгсөн байна. Би гомдол гаргах хугацаандаа гомдлоо өөрийнхөө боломжоор өөрөө гарын үсэг зурж хүргүүлсэн байхад Ч.Б шүүгч намайг байнгын хавчиж боож, шүүх хуралдаан дээр ч загнаж, ёс зүйн хандлагууд гаргаад байгаа тул энэ шүүгчид арга хэмжээ авч өгөөч гэж хүсэж байна. Би ёс зүйн дүрэм гэдэг зүйлийг авч уншсан гэтэл энэ шүүгч тухайн дүрмийн хэд хэдэн заалтыг зөрчсөн байсан тул энэ гомдлыг гаргаж байна” гэжээ.

Шүүгч Ч.Б Шүүхийн Ёс зүйн хороонд ирүүлсэн тайлбартаа:

С.Э, С.О нараас Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан гомдолтой танилцаж дараах тайлбарыг хүргүүлж байна.

“В.С-д холбогдох Эрүүгийн хэргийг 2017 оны 5 дугаар сарын 29-ний өдөр хүлээн авч 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдрийн № 78 дугаартай шийтгэх тогтоолоор хэргийг шийдвэрлэсэн бөгөөд хохирогч С.Э-г гаргасан гомдлоор Ш аймгийн Эрүү, Иргэний хэргийн Давж заалдах шатны шүүхээр хянагдаж, 2017 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн № 40 дугаартай магадлалаар Ш аймаг дах Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдрийн № 78 дугаартай шийтгэх тогтоолыг хүчингүй болгож дахин хэлэлцүүлэхээр мөн шүүхэд буцааж шийдвэрлэсэн.

Ш аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхээр хянагдаж 2017 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн № 40 дугаартай магадлалд ... шүүх хуралдааны тэмдэглэл, дуу дүрс бичлэг зөрүүтэй ... Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.8 дугаар зүйлийн 1.1,9-д заасныг ноцтой зөрчсөн үндэслэлээр шийтгэх тогтоолыг хүчингүй болгосон.

Мөн Ш аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалд хохирогч С.Э-ийн зүгээс гаргаж өгсөн хохирлын талаарх нотлох баримтуудыг шүүхэд гаргаж өгсөн байхад эдгээр баримтууд нь хэрхэн юуны учир нотлох баримтын шаардлага хангахгүй байгаа талаар үндэслэл бүхий дүгнэлт

хийгээгүй атлаа хэрэгсэхгүй болгосон талаар дурдсан боловч анхан шатны шүүхээс шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн нотлох баримтуудыг хуульд заасны дагуу шүүх хуралдаанаар шинжлэн судалж ЭХХШТХ-ийн 36.7 дугаар зүйлийн 2 дэх хэсгийн 2.1-д зааснаар шийтгэх тогтоолд гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэр хэмжээг нэг бүрчлэн үгүйсгэсэн дүгнэлт хийж тодорхой бичсэн байхад давж заалдах шатны шүүхээс өрөөсгөл дүгнэлт хийсэн гэж үзэж байна.

Ш аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 08 дугаартай тогтоолын хавсралтын 5 дугаар заалтын ё-д "...давж заалдах шатны шүүхээс хүчингүй болж дахин шийдвэрлүүлэхээр буцаасан хэргийг өөр бүрэлдэхүүнээр гэж заагаагүйгээс бусад тохиолдолд хэргийг илтгэсэн шүүгчид өөрт нь буцаан хуваарилах ...зааснаар В.С-д холбогдох хэргийг 2017 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр хүлээн авч, 2017 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн № 179 дугаартай шийтгэх тогтоолдоо ЭХХШТХ-ийн 36.6, 36.7, 36.8-д заасныг нэг бүрчлэн тусгаж хэргийг шийдвэрлэсэн ба оролцогч нарт хуульд заасан хугацаанд шийтгэх тогтоолыг гардуулж, уг шийтгэх тогтоолд гомдол гаргах эрхтэй болохыг дурдаж шийдвэрлэсэн.

Тус шүүх хуралдаанд хохирогч С.Э нь шүүгч Ч.Б-ээс татгалзах хүсэлт гаргасан бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.4 дүгээр зүйлийн 1-д "... хэргийг дангаар шийдвэрлэж байгаа шүүгчийн энэ хуулийн 10.2, 10.2 дугаар зүйлд заасан үндэслэлээр татгалзвал, уг асуудлыг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч танилцуулж шийдвэрлэх..." заасан ба уг хүсэлтийг шийдвэрлэх хүртэл шүүх хуралдааны хуульд заасан үндэслэлээр шүүх хуралдааныг хойшлуулж, 2017 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн № 302 дугаартай Ерөнхий шүүгчийн захирамжаар хүсэлтийг хангахаас татгалзаж шийдвэрлэсэн.

С.Э нь Ш аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасан талаар түүнийг эгч С.О /Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.13-д заасан хэргийн оролцогч биш/ тус гомдлыг авчирч өгсөн бөгөөд шүүгчийн туслах Г.Ч нь хохирогч С.Э нь гомдлыг хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд гомдлоо өөрийн биеэр шүүхэд авчирч өгөх /А хот руу эмчилгээнд явсан/ боломжгүй бол холбогдох баримтуудыг хавсаргаж, баталгаат шуудангаар ирүүлэх талаар хэлсэн боловч түүний төрсөн эгч С.О нь С.Э-ээс гаргасан гэх гомдлыг А хотоос шуудангаар ирүүлснээр дугтуйлж, хаяглаж / С.Э-ийн А хотод эмчилгээнд байгаа нотлох баримт байхгүй/ шүүхийн бичиг хүргэгч Ж.Б-д өгснийг, мөн хохирогчийн өмгөөлөгч П.Ө-ийн гаргасан гомдлуудыг тус шүүхийн бүртгэлд бүртгэж хүлээн авч, Ш аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн шүүхийн анхан шатны шүүхийн 2017 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн № 197 тоот, 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн № 198 тоот албан бичгээр тус тус хариуг өгсөн бөгөөд хохирогч С.Э, түүний өмгөөлөгч П.Ө нарын гомдол гаргах хугацаа дууссан болно.

Түүнчлэн хохирогч С.Э нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.9-д гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хүсэлт гаргах ... зааснаар хохирлын талаар нэхэмжлэх эрхтэй бөгөөд С.Э-ийн шүүхэд гаргаж өгсөн нотлох баримтуудыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.15 дугаар зүйлийн 2-д ...шүүх, прокурор, мөрдөгч нь хууль болон эрх зүйн ухамсрыг удирдлага болгож нотлох баримтыг тал бүрээс нь нягт нямбай, бүрэн гүйцэд, бодит байдлаар нь хянаж үзсэний үндсэн дээр нотлох баримтыг өөрийн дотоод итгэлээр үнэлнэ ... зааснаар шүүхээс хохирогч С.Э-ийн хохирлын баримтууд нь эргэлзээтэй, засвартай байсан тул шүүх хуралдаанаар баримтын талаар тодруулж асууж, нотлох баримтын хүрээнд үнэлж шийдвэрлэсэн болно.

Өөрөөр хэлбэл хохирогч С.Э өөрт учирсан хохирлоо төлүүлэхээр нэхэмжлэх эрхтэй боловч түүний эгч С.О нь энэ хэрэгт дүү С.Э-ийн өмнөөс нотлох баримтуудыг хуурамчаар бүрдүүлэх /ННН эмнэлэгтэй С.О гэрээ хийсэн, хохирогч С.Э гэрээ хийгээгүй, эмчилгээ хийлгэсэн баримт байхгүй, гэрээ хийсэн үнийн дүн засвартай буюу 1,000,000 төгрөгийг 7.000.000 засварласан /, хуульд заасан үндэслэл журмын дагуу олж аваагүй нотлох баримтуудыг нэхэмжлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох шүүгч, шүүхийн ажилтнуудыг хэл амаар доромжлох зэргээр зүй бус үйлдэл гаргаж байсан ба шүүх хуралдааны дэг зөрчих, өөрт шаардлага тавьсан хүнийг ёс зүйгүй харьцсан мэтээр, С.Э нь өмгөөлүүлэх хууль зүйн туслалцаа авах эрхээр хангагдсан атал С.Э-ийн хохирлыг хэрэгсэхгүй болгосон, хохирол гаргаж өгөөгүй гэж дүү С.Э-ийн өмнөөс гомдол гаргаж байна гэж ойлгохоор байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 11.4 дүгээр зүйлийн 2 дэх хэсэгт ... эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг тооцох, санхүүжүүлэх журмыг Засгийн газар батална... гэж тус тус заасан бөгөөд хохирогч С.Э нь өөрийн хүсэл зорилгоо илэрхийлж хуулиар олгогдсон эрхийнхээ хүрээнд өмгөөлөгч сонгон авч, хууль зүйн туслалцаа авахдаа талуудын чөлөөт байдал, тэгш эрхийн зарчмын үндсэн дээр төлбөртэй хийгдсэн хэлцлийн төлбөрийг энэ гэмт хэргийн улмаас учирсан шууд хохирол гэж үзэх боломжгүй ба хохирогчийн өмгөөлөгч П.Ө нь үйлчлүүлэгч С.Э-д хууль зүйн туслалцаа үзүүлснийхээ төлбөрт нь буруу ойлголт төрүүлж үйлчлүүлэгчийнхээ хуульд заасан үндэслэл журмын дагуу олж аваагүй нотлох баримт болон туслалцаа үзүүлсний төлбөрийг буруутай этгээдээр гаргуулахаар хэргийн нэг талын оролцогчийн эрхийг ноцтой зөрчсөн, өмгөөлөгч П.Ө нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан ёс зүйгүй үйлдэл гаргаж байгаа тул өмгөөлөгчийн асуудлыг холбогдох байгууллагад нь хандах болно.

Мөн С.О нь Шүүхийн Ёс зүйн хороонд гомдол гаргаж байгаа нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.13-д ... сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, хуулийн этгээд, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг... зааснаар хэргийн оролцогч биш бөгөөд түүнийг гомдол гаргасан гэж үзэх боломжгүй.

Би Монгол Улсын Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 1-д"... Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй..." гэсэн заалтыг ягштал биелүүлж ажилласан.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-д зааснаар"... Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэнэ..." гэсэн заалт бий.

Монгол Улсын шүүгчийн Ёс зүйн дүрмийн 5.2 дугаар зүйлийн 1-д"...Шүүгч энэхүү дүрмийг зөрчсөн болон Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан сахилгын хариуцлага хүлээлгэнэ..." гэж шүүгчид хүлээлгэх сахилгын хариуцлагын нөхцөл журмыг тодорхойлж өгсөн.

С.Э, түүний өмгөөлөгч П.Ө нарын гаргасан гомдлыг тус шүүхийн бүртгэлд бүртгэгдэж шүүгч хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэж байсан бөгөөд шүүгчид ёс зүйн дүрмийн ямар зөрчил гаргасан талаар гомдолд дурдагдаагүй ба хуульд заасан эрхийг хэрэгжүүлж ажилласнаас биш хэргийн оролцогчийн нэг талд үйлчилсэн зүйл байхгүй болно.

Иймд би хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад ёс зүйн дүрмийг зөрчсөн үйлдлийг гаргаагүй, гэж үзэж байх тул С.Э-ээс шүүгчийн ёс зүйн зөрчил мөн эсэхийг шалгуулахаар Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан гомдлыг үнэн зөвөөр шийдвэрлэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлж,

шүүн таслах ажиллагаанд саад учруулж байгаа дээрх хүмүүсийн хариуцлагагүй үйлдлийг таслан зогсоох уг гомдлыг хэрэгсэхгүй болгож өгнө үү” гэжээ.

Шүүгч Ч.Б нийт гишүүдийн хуралдаанд гаргасан тайлбартаа:

Гомдол хянан хэлэлцэх хуралдаанаас “...Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т заасан Монгол Улсын иргэний үндсэн эрх болох давж заалдах гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх эрхэд хязгаарлалт хийж, хуулийг дээдлэх зарчмыг алдагдуулсан шинжтэй байна.

Шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахдаа Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1-д заасан "Шүүгч нь хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, хууль дээдлэх, ...аливаа асуудалд бодитой, төвийг сахисан байр сууринаас хандах, ...мэргэжлийн нэр хүндийг эрхэмлэх зэрэг зарчмуудыг хувийн зан чанар болгож төлөвшүүлнэ" гэснийг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байх тул сахилгын хэрэг үүсгэх нь зүйтэй гэж бүрэлдэхүүн дүгнэв.

С.Э нь Ш аймгийн Эрүү, Иргэний хэргийн Давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасан талаар түүнийг эгч С.О /Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.13-д заасан хэргийн оролцогч биш/ тус гомдлыг авчирч өгсөн бөгөөд шүүгчийн туслах Г.Ч нь хохирогч С.Э нь гомдлыг хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд гомдлоо өөрийн биеэр шүүхэд авчирч өгөх /А хот руу эмчилгээнд явсан/ боломжгүй бол холбогдох баримтуудыг хавсаргаж, баталгаат шуудангаар ирүүлэх талаар хэлсэн боловч түүний төрсөн эгч С.О нь С.Э-ээс гаргасан гэх гомдлыг А хотоос шуудангаар ирүүлснээр дугтуйлж, хаяглаж/ С.Э-ийн А хотод эмчилгээнд байгаа нотлох баримт байхгүй/ шүүхийн бичиг хүргэгч Ж.Б-д өгснийг, мөн хохирогчийн өмгөөлөгч П.Ө-ийн гаргасан гомдлуудыг тус шүүхийн бүртгэлд бүртгэж хүлээн авч, Ш аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн шүүхийн анхан шатны шүүхийн 2017 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн № 197 тоот, 2017 оны 11 дүгээр сарын 14-ны өдрийн № 198 тоот албан бичгээр тус тус хариуг өгсөн.

Тэгтэл Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 199 дугаар тогтоолд “... шүүгч 2 удаа давж заалдах гомдлыг хүлээн авах боломжгүй гэж 2017.11.14-ний өдрийн 198,201 дугаар бүхий албан бичгээр 2 удаа хариу өгснийг албан шийдвэрлэсэн гэж үзэхгүй бөгөөд шүүгчийн захирамжаар шийдвэрлээгүйгээс Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т ". Монгол Улсын иргэний үндсэн эрх болон давж заалдах гомдол гаргах шударга шүүхээр шүүлгэх эрхэд хязгаарлалт хийж, хуулийг дээдлэх зарчмыг алдагдуулсан шинжтэй байна ..." гэж дүгнэсэн боловч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.8 дүгээр зүйлийн 4-т "...шийтгэх тогтоолыг улсын яллагч, шүүгдэгч, хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч өөрөө гардан авснаас буюу хүргүүлснээс хойш 14 хоногийн дотор давж заалдах гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрхтэй..." гэж заасан ба хохирогч С.Э, түүний өмгөөлөгч П.Ө нарын гаргасан гомдол нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 38.2 дугаар зүйлийн 1-т"... прокурор, дээд шатны прокурор, оролцогч анхан шатны шүүхийн шийдвэрийг гардан авснаас хойш, эсхүл энэ хуулийн 11.9 дүгээр зүйлд заасны дагуу хүргүүлснээс хойш 14 хоногийн дотор давж заалдах гомдол гаргах, эсэргүүцлээ шийдвэр гаргасан анхан шатны шүүхэд бичгээр гаргана.." гэж заасны дагуу оролцогч нар нь өөрийн биеэр гомдлоо /гомдлыг хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд гомдлоо өөрийн биеэр шүүхэд авчирч өгөх/ анхан шатны шүүхэд гаргах эрхтэй талаар хуульчилсан ба хэргийн оролцогч биш хохирогчийн төрсөн эгч С.О гомдлыг авчирч өгсөн нь тухайн хохирогчийн өмнөөс хууль ёсны эрх ашгийг нь хамгаалах эрх олгогдсон этгээд биш/ Өөрөөр хэлбэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 38.2 дугаар зүйлийн 2-т"... цагдан хоригдож байгаа ял шийтгүүлсэн этгээд давж заалдах гомдол гаргасан бол цагдан

хорих байгууллагын захиргаа уг гомдлыг баталгаажуулан, шүүхэд хүргүүлнэ..." гэж заасан нь тухайн хэргийн оролцогчид нь гомдлоо өөрийн биеэр авчирч өгөх эрхтэй гэж ойлгох бөгөөд тухайн гомдолд хохирогч С.Э-ийн гарын үсэг зурсан эсэх нь эргэлзээтэй байсан, түүнчлэн хохирогчийн өмгөөлөгч П.Ө-ийн гаргасан гомдлоо Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 38.1 дүгээр зүйлийн 2-т "... өмгөөлөгч давж заалдах гомдлыг шүүхэд хүргүүлэхээс өмнө өмгөөлж байгаа хүндээ давж заалдах гомдлыг урьдчилан танилцуулсан байна.." гэж заасны дагуу хохирогч С.Э-д танилцуулаагүй байсан тул тус ажиллагааг хийж гомдлоо ирүүлэх, хуульд заасан эрхийг хангуулахаар, мөн давж заалдах гомдол гаргах хугацаа дууссан тул гомдлыг хүлээн авах боломжгүй талаар албан тоотоор хариуг өгсөн ба шүүгч захирамжаараа шийдвэрлээгүйгээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулиар тогтоосон журмыг зөрчсөнөө хүлээн зөвшөөрч байгаа ба Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1-т"... хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй..." гэж заасныг ёс зүйн зөрчил гэж үзэхгүй талаар тусгасан байна.

Гэвч "...иймд шүүгч нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т заасан Монгол Улсын иргэний үндсэн эрх болох давж заалдах гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх эрхэд хязгаарлалт хийж, хуулийг дээдлэх зарчмыг алдагдуулсан шинжтэй байна..." гэснийг зөвшөөрөхгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.14-д заасан иргэний эрх нь "хязгааргүй"олгогдсон эрх биш бөгөөд иргэний эрх нь мөн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан... Үндсэн хууль бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх үндсэн үүргийг ёсчлон биелүүлэхтэй нь салшгүй уялдаатай хэрэгжих эрх юм. Өөрөөр хэлбэл иргэн нь эрхээ хэрэгжүүлэхийн хамт үүргээ зохих ёсоор гүйцэтгэдэг байх учиртай, хууль зөрчих байдлаар "...эрхээ хэрэгжүүлж..." болох тухай ойлголт, жишиг тогтоож болохгүй гэжээ.

Мөн хохирогч С.Э-д, түүний өмгөөлөгч П.Ө нар нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 38.2 дугаар зүйлийн 4-т зааснаар ...давж заалдах гомдол гаргах эсэргүүцэл бичих эрх бүхий этгээд хүндэтгэн үзэх шалтгаанаар давж заалдах гомдол гаргах, эсэргүүцэл бичих хугацааг хэтрүүлсэн бол хэтэрсэн хугацааг сэргээлгэх хүсэлтээ шийдвэр гаргасан шүүхэд гаргана... гэж, мөн хуулийн 38.2 дугаар зүйлийн 5-д "... хугацааг сэргээлгэх хүсэлтийг шүүх хянан шийдвэрлэхдээ хүсэлт гаргасан хүнийг дуудаж тайлбар авч болно. Хугацааг хэтрүүлсэн нь хүндэтгэн үзэх шалтгаантай болохыг хүсэлт гаргасан хүн өөрөө нотолно..." гэж, мөн хуулийн 38.6 дугаар зүйлийн 6-д "... хугацаа хэтрүүлсэн нь хүндэтгэн үзэх шалтгаантай бол хугацааг шүүх сэргээх шийдвэр гаргана..." гэж заасан бөгөөд хохирогч С.Э, түүний өмгөөлөгч П.Ө нар нь хуульд заасан эрхээ хэрэгжүүлж, хүсэлт гаргаж, нотлох баримтаа бүрдүүлэн давж заалдах гомдол гаргах эрх нь нээлттэй бөгөөд шүүхээс тухайн оролцогч нарын эрхийг нь хаасан зүйл байхгүй болно.

Түүнчлэн шүүгч Ч.Б-гийн даргалсан эрүүгийн шүүх хуралдааны дуу, дүрс бичлэгийг үзэж, сонсож судалсан бөгөөд уг шүүх хуралдаан дээр яллагдагч С.Э-ээс асуусан асуултаар "танай хүргэн н.Б, н.О гэдэг хүн таныг авах гэж очсон гээд байна. Та тэглээ хэвтэрт ороод босох чадваргүй байсан юм уу? "Заавал тэд нар таныг очиж авах шаардлага байсан юм уу?" Та шугамынхаа унаанд суугаад ирэх боломж байгаа шүү дээ. Заавал энэ хоёр хүн очих шаардлага байсан юм уу? , "Мал харуулах хоёр хүн аваачаад буцааж хүргэж өгсөн юм уу, гэр бүлийн хүн чинь хаачихаад та энэ хүмүүсээр мал харуулаад байгаа юм бэ?" Таны өвчин чинь тэгж их гэр, орон эзгүй хаях хүнд өвчин мөн юм уу, 7 хоногтоо л эдгэнэ шүү дээ " " Тэгээд юу нэхэмжлээд байгаа юм. Баримттай юм аа нэхэмжил л дээ. Гэр

бүлийн хүн чинь хаана байсан юм Гэр бүлийн хүн чинь малаа харах боломжтой шүү дээ. Наадах чинь хүндэтгэн үзэх шалтгаан мөн юм уу. Хоёулаа энд байх гэсэн юм байгаа юм уу", "Таны хувийн асуудал байна шүү дээ. 2 хүн очоод малыг тань хараад авгайг чинь явуулах нь хэрэгт ач холбогдолгүй" гэх зэргээр дуугаа өндөрсгөж, зандарсан, уцаарласан байдлаар шүүгч харьцсан нь Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 1-нийн "Шүүгч нь хэргийн оролцогчдод эрх тэгш, төвийг сахисан, хүнлэг ёсоор хандаж, хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлэхүйц харилцааны соёлыг эзэмшсэн байна" гэснийг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна гэж дүгнэжээ.

Харин хохирогч С.Э нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.9-д... гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хүсэлт гаргах... зааснаар хохирлын талаар нэхэмжлэх эрхтэй бөгөөд С.Э-ийн шүүхэд гаргаж өгсөн нотлох баримтуудыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.15 дугаар зүйлийн 2-д ...шүүх, прокурор, мөрдөгч нь хууль болон эрх зүйн ухамсрыг удирдлага болгож нотлох баримтыг тал бүрээс нь нягт нямбай, бүрэн гүйцэд, бодит байдлаар нь хянаж үзсэний үндсэн дээр нотлох баримтыг өөрийн дотоод итгэлээр үнэлнэ ... зааснаар шүүхээс хохирогч С.Э-ийн хохирлын баримтууд нь эргэлзээтэй, засвартай байсан тул шүүх хуралдаанаар тодруулж асууж, нотлох баримтын хүрээнд үнэлж шийдвэрлэсэн болно.

Өөрөөр хэлбэл Хохирогч С.Э өөрт учирсан хохирлоо төлүүлэхээр нэхэмжлэх эрхтэй боловч түүний эгч С.О нь энэ хэрэгт дүү С.Э-ийн өмнөөс нотлох баримтуудыг хуурамчаар бүрдүүлэх /ННН эмнэлэгтэй С.О гэрээ хийсэн, хохирогч С.Э гэрээ хийгээгүй, эмчилгээ хийлгэсэн баримт байхгүй, гэрээ хийсэн үнийн дүн засвартай буюу 1.000.000 төгрөгийг 7.000.000 төгрөг болгон засварласан /, хуульд заасан үндэслэл журмын дагуу олж аваагүй нотлох баримтуудыг нэхэмжлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох шүүгч, шүүхийн ажилтнуудыг хэл амаар доромжлох зэргээр зүй бус үйлдэл гаргаж байсан ба шүүх хуралдааны дэг зөрчих, өөрт шаардлага тавьсан хүнийг ёс зүйгүй харьцсан мэтээр, С.Э нь өмгөөлүүлэх хууль зүйн туслалцаа авах эрхээр хангагдсан атал С.Э-ийн хохирлыг хэрэгсэхгүй болгосон, хохирол гаргаж өгөөгүй гэж дүү С.Э-ийн өмнөөс гомдол гаргаж байна гэж ойлгохоор байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 11.4 дүгээр зүйлийн 2 дэх хэсэгт... эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг тооцох, санхүүжүүлэх журмыг Засгийн газар батална... гэж тус тус заасан бөгөөд хохирогч С.Э нь өөрийн хүсэл зорилгоо илэрхийлж хуулиар олгогдсон эрхийнхээ хүрээнд өмгөөлөгч сонгон авч, хууль зүйн туслалцаа авахдаа талуудын чөлөөт байдал, тэгш эрхийн зарчмын үндсэн дээр төлбөртэй хийгдсэн хэлцлийн төлбөрийг энэ гэмт хэргийн улмаас учирсан шууд хохирол гэж үзэх боломжгүй ба хохирогчийн өмгөөлөгч П.Ө нь үйлчлүүлэгч С.Э-д хууль зүйн туслалцаа үзүүлснийхээ төлбөрт нь буруу ойлголт төрүүлж үйлчлүүлэгчийнхээ хуульд заасан үндэслэл журмын дагуу олж аваагүй нотлох баримт болон туслалцаа үзүүлсний төлбөрийг буруутай этгээдээр гаргуулахаар хэргийн нэг талын оролцогчийн эрхийг ноцтой зөрчсөн үйлдэл гаргаж байгаа тул эдгээр үйлдлүүдийг таслан зогсоох, хохирогчоос бүрдүүлэн өгсөн холбогдох баримтыг тодруулж асуусны үндсэн дээр сахилгын хэрэг үүсгэснийг хүлээн зөвшөөрөхгүй байна.

Би Монгол Улсын Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 1-д"... Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй..." гэсэн заалтыг ягштал биелүүлж ажилласан.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-д зааснаар"... Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэнэ..." гэсэн заалт бий.

Монгол Улсын шүүгчийн ёс зүйн дүрмийн 5.2 дугаар зүйлийн 1-"...Шүүгч энэхүү дүрмийг зөрчсөн бол Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан сахилгын хариуцлага хүлээлгэнэ..." гэж шүүгчид хүлээлгэх сахилгын хариуцлагын нөхцөл журмыг тодорхойлж өгсөн.

Хохирогч С.Э, түүний өмгөөлөгч П.Ө нарын гаргасан гомдлыг тус шүүхийн бүртгэлд бүртгэгдэж шүүгч хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэж байсан бөгөөд шүүгчид ёс зүйн дүрмийн ямар зөрчил гаргасан талаар гомдолд дурдагдаагүй ба хуульд заасан эрхийг хэрэгжүүлж ажилласнаас биш хэргийн оролцогчийн нэг талд үйлчилсэн зүйл байхгүй болно. Миний бие нь Шүүгчийн ёс зүйн дүрэм буюу хуульд тусгайлан заасан ёс зүйн зөрчил болохоор заасан болон шүүгчийн ёс зүйн дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гаргаагүй тул Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 199 дугаар тогтоолыг хүчингүй болгож, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанаар гомдлыг хэлэлцээд ҮНДЭСЛЭХ нь:

Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 199 дүгээр тогтоолоор шүүгч Ч.Б-д сахилгын хэрэг үүсгэжээ. Уг тогтоолыг эс зөвшөөрч шүүгч Ч.Б нийт гишүүдийн хуралдаанд тайлбар гаргасан байна.

Шүүхийн Ёс зүйн хорооны гомдол хянан хэлэлцэх хуралдаанаар шүүгч Ч.Б-гийн даргалсан Эрүүгийн хэргийн шүүх хуралдааны дуу, дүрс бичлэгийг үзэж, сонсож судалсан бөгөөд уг шүүх хуралдаан дээр шүүгч Ч.Б яллагдагч С.Э-ээс тодруулж асуусан асуултаа “танай хүргэн н.Б, н.О гэдэг хүн таныг авах гэж очсон гээд байна. Та тэгтлээ хэвтэрт ороод босох чадваргүй байсан юм уу? “Заавал тэд нар таныг очиж авах шаардлага байсан юм уу? “Та шугамынхаа унаанд суугаад ирэх боломж байгаа шүү дээ. Заавал энэ хоёр хүн очих шаардлага байсан юм уу? , “Мал харуулах хоёр хүн аваачаад буцааж хүргэж өгсөн юм уу, гэр бүлийн хүн чинь хаачихаад та энэ хүмүүсээр мал харуулаад байгаа юм бэ?, “Таны өвчин чинь тэгж их гэр, орон эзгүй хаях хүнд өвчин мөн юм уу, 7 хоногтоо л эдгэнэ шүү дээ “Тэгээд юу нэхэмжлээд байгаа юм. Баримттай юм аа нэхэмжил л дээ. Гэр бүлийн хүн чинь хаана байсан юм”, “Гэр бүлийн хүн чинь малаа харах боломжтой шүү дээ. Наадах чинь хүндэтгэн үзэх шалтгаан мөн юм уу. Хоёулаа энд байх гэсэн юм байгаа юм уу, “Таны хувийн асуудал байна шүү дээ. 2 хүн очоод малыг тань хараад авгайг чинь явуулах нь хэрэгт ач холбогдолгүй” гэх зэргээр дуугаа өндөрсгөж, зандарсан, уцаарласан байдлаар харьцсан нь Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 1-д “Шүүгч нь хэргийн оролцогчдод эрх тэгш, төвийг сахисан, хүнлэг ёсоор хандаж, хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлэхүйц харилцааны соёлыг эзэмшсэн байна”, 3.3 дугаар зүйлийн 2-т “Хэргийн оролцогчдын зүгээс шүүгчийг татгалзахад хүргэх нөхцөл байдлыг өөрийн үг яриа, үйлдлээр бий болгохоос урьдчилан сэргийлж, зайлсхийнэ” гэснийг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

Тэрчлэн шүүгч 2 удаа гаргасан давж заалдах гомдлыг хүлээн авах боломжгүй гэж 2017.11.14-ний өдөр 198, 201 дугаар бүхий албан бичгээр 2 удаа хариу өгснийг албан ёсоор хүсэлтийг шийдвэрлэсэн гэж үзэх боломжгүй бөгөөд шүүгч захирамжаар шийдвэрлээгүйгээс Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т заасан Монгол Улсын иргэний үндсэн эрх болох давж заалдах гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх эрхэд хязгаарлалт хийж, хууль дээдлэх зарчмыг алдагдуулсан, Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар

зүйлийн 1-д заасан “Шүүгч нь хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, хууль дээдлэх, ... аливаа асуудалд бодитой, төвийг сахисан байр сууринаас хандах, ... мэргэжлийн нэр хүндийг эрхэмлэх зэрэг зарчмуудыг хувийн зан чанар болгож төлөвшүүлнэ” гэснийг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна. Үүнд:

1. Шүүх хуралдааны дуу дүрс бичлэгээс үзэхэд шүүгч шүүх хуралдаан дээр хэргийн оролцогчтой дуугаа өндөрсгөж зандарсан, уцаарласан, шаардсан байдлаар харьцсан нь бичлэгээр тогтоогдож байна.

2. Хохирогч С.Э эрхийнхээ дагуу давж заалдах гомдол гаргасныг шүүх биечлэн өөрөө хүргэж ирүүлээгүй гэж буруутгаж албан бичгээр хариу өгсөн байна. Давж заалдах гомдол гаргах эрхийг тухайн гомдол гаргагч эдлэх бөгөөд харин хэнээр тухайн гомдлоо шүүхэд хүргүүлэхийг хууль тусгайлан зохицуулаагүй, өөрөөр хэлбэл хуульд заасан шаардлагыг хангасан бол шүүх хүлээн авах үүрэгтэй.

3. Шүүгч Ч.Б давж заалдах шатны шүүхээс өрөөсгөл дүгнэлт хийсэн гэж үзэж байна гэж тайлбартаа дурджээ. Шүүгчээс бусад шүүх, шүүгчийн шийдвэрт үнэлэлт дүгнэлт өгөх нь зохимжгүй байгааг дурдах нь зүйтэй гэж бүрэлдэхүүн үзэв.

Иймд шүүгч Ч.Б-г Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 1-д “Шүүгч нь хэргийн оролцогчдод эрх тэгш, төвийг сахисан, хүнлэг ёсоор хандаж, хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлэхүйц харилцааны соёлыг эзэмшсэн байна”, 2.3 дугаар зүйлийн 1-д “Шүүгч нь зохисгүй байдал гаргаж болохгүй бөгөөд бусдад ийнхүү ойлгогдохоос зайлсхийнэ”, 3.3 дугаар зүйлийн 2-т “ Хэргийн оролцогчдын зүгээс шүүгчийг татгалзахад хүргэх нөхцөл байдлыг өөрийн үг яриа, үйлдлээр бий болгохоос урьдчилан сэргийлж, зайлсхийнэ”, 1.3 дугаар зүйлийн 1-д “Шүүгч нь хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэнэ, хууль дээдлэх, ... мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх зэрэг зарчмуудыг хувийн зан чанар болгож төлөвшүүлнэ” гэснийг тус тус зөрчсөн гэж бүрэлдэхүүн дүгнэв.

Харин шүүгч хэргийг шийдвэрлэхдээ нотлох баримтыг хэрхэн үнэлсэн болон шүүхээс гарч байгаа эрхийн актын хууль зүйн үндэслэл, холбогдох маргааны үйл баримтын талаар Шүүхийн Ёс зүйн хороо үнэлж дүгнээгүй болно.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйл, 36 дугаар зүйлийн 36.1.1, 37 дугаар зүйлийн 37.1.2, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйл, Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.1, 5.13-т заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Ш аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ч.Б-д 3 сарын хугацаагаар 30 хувиар цалинг бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Энэ магадлалын хувийг шүүгч болон гомдол гаргагчид хүргүүлэхийг Ажлын албанд даалгасугай.

3. Шүүгч, гомдол гаргагч магадлалыг эс зөвшөөрвөл гардан авснаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ

А.ДОРЖГОТОВ

ИЛТГЭГЧ

Н.ЭРДЭНЭЦОГТ



ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ
МАГАДЛАЛ

2018 оны 5 сарын 02 өдөр

Дугаар 221/ЁМ2018/0011

Улаанбаатар хот

Шүүхийн Ёс зүйн хорооны
магадлалын тухай

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааныг ерөнхий шүүгч Д.Батбаатар даргалж, шүүгч Э.Лхагвасүрэн, шүүгч С.Мөнхжаргал нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн дарга М.Отгондэлгэр, шүүгч Ч.Б- өмгөөлөгч н.Э нарыг оролцуулан хийж, Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 13 дугаар магадлалыг эс зөвшөөрч шүүгч Ч.Б-гийн гаргасан гомдлоор, шүүгч С.Мөнхжаргалын илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 13 дугаар магадлалаар: Ш аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ч.Б-д 3 сарын хугацаагаар 30 хувиар цалинг бууруулах сахилгын шийтгэл ногдуулжээ.

Шүүгч Ч.Б давж заалдах гомдолдоо: “... Шүүх хуралдааны дуу дүрс бичлэгээс үзэхэд шүүгч шүүх хуралдаан дээр хэргийн оролцогчтой дуугаа өндөрсгөж зандарсан, уцаарласан, шаардсан байдлаар харьцсан нь бичлэгээр тогтоогдож байна

Мөн “Хохирогч С.Э эрхийнхээ дагуу давж заалдах гомдол гаргасныг шүүх биечлэн өөрөө хүргэж ирүүлээгүй гэж буруутгаж албан бичгээр хариу өгсөн байна.

Давж заалдах гомдол гаргах эрхийн тухайн гомдол гаргагч эдлэх бөгөөд харин хэнээр тухайн гомдлоо шүүхэд хүргүүлэхийг хуульд тусгайлан зохицуулаагүй, өөрөөр хэлбэл хуульд заасан шаардлагыг хангасан бол шүүх хүлээн авах үүрэгтэй.” гэж тус тус үзэхдээ:

Хохирогч С.Э-ий давж заалдах гомдол гэгч нь “хуульд заасан шаардлагыг хангасан” эсэхэд үндэслэл бүхий дүгнэлт өгөөгүй, гомдлыг хүлээн авахаас татгалзсан шүүхийн албан бичигт заасан үндэслэлийг гомдлыг шалгах явцдаа шалгаж тогтоогоогүй атлаа “Иймд шүүгч Ч.Б-г Шуугчийн ёс зүйн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 1-д “Шүүгч нь хэргийн оролцогчдод эрх тэгш, төвийг сахисан, хүнлэг ёсоор хандаж, хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлэхүйц харилцааны соёлыг эзэмшсэн байна”, 2.3 дугаар зүйлийн 1-д “Шүүгч нь зохисгүй байдал гаргаж болохгүй бөгөөд бусдад ийнхүү ойлгогдохоос зайлсхийнэ”, 3.3 дугаар зүйлийн 2-т “Хэргийн оролцогчдын зүгээс шүүгчийг татгалзахад хүргэх нөхцөл байдлыг өөрийн үг яриа, үйлдлээр бий болгохоос урьдчилан сэргийлж, зайлсхийнэ”, 1.3 дугаар зүйлийн 1-д “Шүүгч нь хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэнэ, хууль дээдлэх мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх зэрэг зарчмуудыг хувийн зан чанар болгож төлөвшүүлнэ” гэснийг тус тус зөрчсөн

гэж намайг буруутгаж байгааг хүлээн зөвшөөрөх хууль зүйн үндэслэлгүй гэж үзэж байна.

Хохирогч С.Э нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-ын “хэргийн бодит байдлыг тогтооход шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг гаргаж өгч хавтаст хэрэгт бэхжүүлж тусгуулах” 1,9-д “... гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хүсэлт гаргах” гэсэн эрхээ эдэлж учирсан хохирол, нэхэмжлэх зүйлийнхээ талаар нотлох баримтад тулгуурлан ярихгүй, хохирлын баримтууд нь эргэлзээтэй, засвартай байснаас гадна хэрэгт цугларсан нотлох баримтуудаас өөр зүйл ярьж мөн зүйлийн 3 дахь хэсгийн 3.2-ын “хэргийн талаар үнэн зөв мэдүүлэг өгөх” үүргээ зөрчиж байсан тул шүүгчийн зүгээс С.Э-ийн шүүхэд гаргаж өгсөн нотлох баримтуудыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.15 дугаар зүйлийн 2-ын “Шүүх нь хууль болон эрх зүйн ухамсрыг удирдлага болгож нотлох баримтыг тал бүрээс нь нягт нямбай, бүрэн гүйцэд, бодит байдлаар нь хянаж үзсэний үндсэн дээр нотлох баримтыг өөрийн дотоод итгэлээр үнэлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлэхийг зорьж мөн зүйлийн 3-д заасан “Хэрэгт авагдсан нотлох баримтыг харьцуулан шинжлэн судлах, бусад нотлох баримттай харьцуулах, шинэ нотлох баримтыг цуглуулах, нотлох баримтын эх сурвалжийг магадлах аргаар нотлох баримтыг шалгана” гэсний дагуу холбогдох баримтыг тодруулж асуусан, мөн миний ярьсан зүйл, асуусан асуулт шүүх хуралдааны танхимд байгаа оролцогч нарт сонсогдохгүй байсан тул тод чанга дуугарсныг зандарсан, уцаарласан, шаардсан байдлаар харьцсан гэж дүгнэсэнд гомдолтой байна. Энэ нь хохирогчийн хууль зөрчсөн үйлдлүүдийг таслан зогсоох биш шүүгчийн шүүн таслах ажиллагааг хэт буруутгаж хэт нэг талыг өөгшүүлж байгаа хэрэг гэж үзэж байгаа тул хүлээн зөвшөөрөхгүй байна.

Түүнчлэн С.Э-ийн эгч С.О /Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.13-д заасан хэргийн оролцогч биш/-ийн шүүхэд авчирч өгсөн “Э-ийн давж заалдах гомдол” гэгч дээр зурагдсан гарын үсэг нь хэргийн материалд зурагдаж байсан С.Э-ийн гарын үсгээс илт зөрүүтэй, энгийн нүдээр ч ялгаатай нь харагдаж байсан тул шүүгчийн туслах Г.Ч хохирогч С.Э-г хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд гомдлоо өөрийн биеэр шүүхэд авчирч өгөх /А хот руу эмчилгээнд явсан/ хэрэв боломжгүй бол холбогдох баримтуудыг хавсаргаж, баталгаат шуудангаар ирүүлэх талаар зөвлөхөөр эгч С.О нь С.Э-ээс гаргасан гэх гомдлыг А хотоос шуудангаар ирүүлснээр дугтуйлан хаягласан боловч А хотын шуудан хүлээн авч явуулсан дарц, Ш аймгийн шуудан хүлээн авсан дарц байхгүйгээр /С.Э-ийн А хотод эмчилгээнд байгаа нотлох баримт ч байхгүй/ шүүхийн бичиг хүргэгч Ж.Б-д өгснийг, мөн хохирогчийн өмгөөлөгч П.Ө-ийн хуульд заасан хугацаа хэтрүүлэн гаргасан давж заалдах гомдлуудыг тус шүүхийн бүртгэлд бүртгэж хүлээн авч, бичгээр тус тусын хариуг нь өгснийг Монгол Улсын Үндсэн хуулийн хүний эрхтэй холбон дүгнэж шүүгчийг буруутгаж байгааг мөн д хүлээн зөвшөөрөх боломжгүй юм.

С.Э-ийн давж заалдах гомдол гэгчид зурагдсан гарын үсэг эргэлзээтэй байсан, түүнчлэн хохирогчийн өмгөөлөгч П.Ө гаргасан гомдлоо Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 38.1 дүгээр зүйлийн 2-ын өмгөөлөгч давж заалдах гомдлыг шүүхэд хүргүүлэхээс өмнө өмгөөлж байгаа хүндээ давж заалдах гомдлыг урьдчилан танилцуулсан байна” гэж заасныг дагуу хохирогч С.Э-д танилцуулаагүй байсан зэрэг нөгөө талын буруутай үйл ажиллагааг “хүний эрх”-тэй харьцуулан дүгнэж байгаа нь учир дутагдалтай юм.

Энэ бүх хууль бус ажиллагаанд албан тоотоор хариу өгснийг буруутгах нэг үндэслэл гэж үзэж болох боловч энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулиар тогтоосон журмыг зөрчсөн хэрэг болох тул Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.4

дүгээр зүйлийн 1-ийн "... хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй" гэсэн заалтыг Шүүхийн Ёс зүйн хороо харгалзан үзэх ёстой байсан.

Мөн хохирогч С.Э, түүний өмгөөлөгч П.Ө нар нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 38.2 дугаар зүйлийн 4-д зааснаар "Давж заалдах гомдол гаргах эрх бүхий этгээд хүндэтгэн үзэх шалтгаанаар давж заалдах гомдол гаргах хугацааг хэтрүүлсэн бол хэтэрсэн хугацааг сэргээлгэх хүсэлтээ шийдвэр гаргасан шүүхэд гаргаж, нотлох баримтаа бүрдүүлэн давж заалдах гомдол гаргах эрхээ эдлэх нь нээлттэй бөгөөд шүүхээс тухайн оролцогч нарын эрхийг нь хаасан зүйл байхгүй байсныг Шүүхийн Ёс зүйн хороо анхаарч үзээгүйд гомдолтой байна.

Шүүгч Ч.Б миний бие Монгол Улсын Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 1-ийн "... Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй" гэсэн заалтыг ягштал биелүүлж ажилласан бөгөөд шүүгчийн ёс зүйн дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гаргаагүй тул Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 12 дугаар магадлалыг хүчингүй болгож, сахилгын шийтгэл оногдуулсныг хэрэгсэхгүй болгож өгнө үү" гэжээ.

ХЯНАВАЛ:

Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал үндэслэлтэй байх тул хэвээр үлдээж, шүүгч Ч.Б-гийн гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэлээ.

Иргэн С.Э, С.О нар Ш аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ч.Б-д холбогдуулан "... шүүгч Ч.Б нь хохирогч намайг загнаж, нөгөө талд илт үйлчлээд байсан, давж заалдах гомдол гаргах эрхийг боосон, ёс зүйгүй шүүгчийн үйлдлийг таслан зогсоож өгнө үү" гэх гомдлыг Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасны дагуу Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооноос 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 199 дүгээр тогтоолоор шүүгч Ч.Б-д сахилгын хэрэг үүсгэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн 2018 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 13 дугаар магадлалаар иргэн С.Э, С.О нарын гомдолд дурдсан загнасан гэх үйл баримт нотлогдсон, давж заалдах гомдол гаргах эрх зөрчигдөхүйц нөхцөл байдал үүссэн талаар дүгнэж, шүүгч Ч.Б-г ёс зүйн зөрчил гаргасан гэж үзэн "3 сарын хугацаагаар 30 хувиар цалин бууруулах" сахилгын шийтгэл ногдуулжээ.

Шүүгч Ч.Б нь хуулиар үүрэг болгоогүй шаардлагыг хэргийн оролцогчоос шаардаж, 2017 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 197 дугаар албан бичгээр хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд гомдлоо өөрийн биеэр шүүхэд ирүүлэх үүргээ биелүүлээгүй" гэж хохирогч С.Э-ийн давж заалдах гомдлыг буцаасан, мөн хохирогч С.Э-ийн өмгөөлөгч П.Ө-ийн давж заалдах гомдол гаргах "14 хоног"-ийн хугацаа дуусаагүй байхад 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 201 дүгээр албан бичгээр "хугацаа дууссан" гэж гомдлыг дахин буцааж хэргийн оролцогчийн давж заалдах гомдол гаргах эрхийг үндэслэлгүйгээр хязгаарлажээ.

Шүүгчийн энэхүү үйлдлийг Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1-д "Шүүгч нь хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, хууль дээдлэх ... аливаа асуудалд бодитой төвийг сахисан байр сууринаас хандах, мэргэжлийн нэр хүндийг эрхэмлэх зарчмуудыг хувийн зан чанар болгож төлөвшүүлнэ" гэж заасныг зөрчсөн гэж үзсэн Шүүхийн Ёс зүйн хорооны дүгнэлт үндэслэлтэй байна.

Шүүгч Ч.Б давж заалдах гомдолдоо "... С.Э-ийн ... гомдол гэгчид гарын үсэг эргэлзээтэй учир өөрийн биеэр авчирч өгөх, боломжгүй бол шуудангаар ирүүлэхийг, мөн хохирогчийн өмгөөлөгч П.Ө-ийн хохирогчид танилцуулаагүй, хуульд заасан хугацаа хэтрүүлэн гаргасан давж заалдах гомдлуудыг тус шүүхийн бүртгэлд бүртгэж хүлээн авч, бичгээр тус тусын хариуг нь өгснийг Монгол Улсын

Үндсэн хуулийн хүний эрхтэй холбон дүгнэж шүүгчийг буруутгаж байгааг хүлээн зөвшөөрөх боломжгүй юм. ... нөгөө талын буруутай үйл ажиллагааг “хүний эрх”-тэй харьцуулан дүгнэж байгаа нь учир дутагдалтай юм. Энэ бүх хууль бус ажиллагаанд албан тоотоор хариу өгснийг буруутгах нэг үндэслэл гэж үзэж болох боловч энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулиар тогтоосон журмыг зөрчсөн хэрэг болох тул Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1-ийн “... хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй” гэсэн заалтыг Шүүхийн Ёс зүйн хороо харгалзан үзэх ёстой байсан” гэжээ.

Шүүгч Ч.Б-ийн 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 201 дүгээр албан бичигт “шийтгэх тогтоолыг өмгөөлөгч П.Ө нь 2017 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 10.00 цагт хүлээн авч 11 дүгээр сарын 14-ний өдрийн 14 цаг 52 минутад шүүхэд ирүүлсэн талаар дурдсанаас үзвэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 11.1 дүгээр зүйлийн 2-т “Хугацааг тоолж эхэлсэн минут, цаг, хоногийг хугацаа тоолоход оруулахгүй”, 4-т “Хугацааг хоногоор тоолоход уг хугацаа нь сүүлийн хоногийн 24 цагт дуусна” гэж зааснаар хугацаа хэтрээгүй байна.

Үүнтэй агуулга ижил зохицуулалт уг хуулиас өмнө дагаж мөрдөж байсан Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд ч байсан бөгөөд шүүхүүд давж заалдах гомдлыг хүлээн авч давж заалдах шатны шүүхэд хүргүүлэх ажиллагаа байнга хийгддэг тул хугацааг дээрх хуулийн дагуу тооцох явдал нь тогтсон ойлголт байдаг. Иймээс шүүгч Ч.Б-г давж заалдах хугацаа хэтрээгүй байхад “хэтэрсэн” гэж үзсэн, мөн хуулиар шаардаагүй “өөрийн биеэр гомдлоо шүүхэд өгөх” шаардлага тавьсныг хуулийг буруу ойлгож хэрэглэсэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой алдаа гэж үзэхээргүй байх тул дээрх гомдлыг хүлээн авах үндэслэлгүй.

Мөн шүүгч гомдолдоо “... хугацаагаа хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн бол баримтаа бүрдүүлээд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 38.2 дугаар зүйлийн 5, 6-д зааснаар сэргээлгэх хүсэлт гаргаж давж заалдах гомдол гаргах эрх нь нээлттэй бөгөөд шүүхээс тухайн оролцогч нарын эрхийг хаасан зүйл байхгүй ...” гэжээ.

Гомдол гаргах хугацаа хэтрүүлээгүй хэргийн оролцогчийн хувьд дээрх ажиллагаа хийлгэх шаардлагагүй бөгөөд энэ нь шүүгчийн ёс зүйн зөрчлийг үгүйсгэх үндэслэл болохгүй.

Мөн шүүгч Ч.Б нь шүүхуралдаанд эерхэргийн оролцогчдод үг яриа, үйлдлээрээ зохисгүй хандсан нь Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 1-д “Шүүгч нь хэргийн оролцогчдод эрх тэгш, төвийг сахисан, хүнлэг ёсоор хандаж, хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлэхүйц харилцааны соёлыг эзэмшсэн байна”, мөн зүйлийн 2-д “Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бусдад хүнлэг бус хандах, хүний нэр төр, ажил хэргийн нэр хүндийг гутаасан шинжтэй үйлдлийг гаргаж болохгүй” гэж тус тус заасныг зөрчсөн гэж үзсэн Шүүхийн Ёс зүйн хорооны дүгнэлтийг үгүйсгэх үндэслэлгүй байна.

Иймд Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалыг хэвээр үлдээх нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн үзлээ.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 13 дугаар магадлалыг хэвээр үлдээж, шүүгч Ч.Б-гийн гомдлыг хангахгүй орхисугай.

2.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.5-д зааснаар шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийг буруу хэрэглэсэн, мөн шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн нь шүүхийн шийдвэр гарахад нөлөөлсөн гэж үзвэл магадлалыг гардан авсан, эсхүл хүргүүлснээс хойш 14 хоногийн дотор Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд гомдол гаргах эрхтэй.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.БАТБААТАР

ШҮҮГЧ

Э.ЛХАГВАСҮРЭН

ШҮҮГЧ

С.МӨНХЖАРГАЛ



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ХЯНАЛТЫН ШАТНЫ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2018 оны 6 сарын 27

Дугаар 298

Улаанбаатар хот

Шүүхийн Ёс зүйн хорооны
магадлалын тухай

Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны бүрэлдэхүүн:

Даргалагч: Танхимын тэргүүн М.Батсуурь,

Шүүгчид: Л.Атарцэцэг

Г.Банзрагч

Б.Мөнхтуяа

Илтгэгч шүүгч: П.Соёл-Эрдэнэ

Нарийн бичгийн дарга Г.Гантогтох

Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 13 дугаар магадлал,

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн 221/ЁМ2018/0011 дүгээр магадлалтай

Шүүх хуралдаанд оролцогч: Шүүгч Ч.Б-гийн өмгөөлөгч Б.Э-г оролцуулж,

Шүүгч Ч.Б-гийн гомдлыг үндэслэн хэргийг хянан хэлэлцэв.

ТОДОРХОЙЛОХ НЬ:

1. Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 13 дугаар магадлалаар: Ш аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ч.Б-д 3 сарын хугацаагаар 30 хувиар цалинг бууруулах сахилгын шийтгэл оногдуулж шийдвэрлэжээ.

2. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн 221/ЁМ2018/0011 дүгээр магадлалаар: Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 13 дугаар магадлалыг хэвээр үлдээж, шүүгч Ч.Б-гийн гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэжээ.

3. Шүүгч Ч.Б-гийн хяналтын журмаар гаргасан гомдлын агуулгад: Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх миний гомдлыг хянан хэлэлцээд гомдол гаргагч С.Э-ийн өмгөөлөгчийн давж заалдах гомдол гаргах хугацааны талаар голлон дүгнэж, Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалыг үндэслэлтэй гэж үзжээ. Миний бие шүүхэд гаргасан гомдолдоо өмгөөлөгч П.Ө-ийн гомдлыг хүлээн авах боломжгүй болох хууль зүйн үндэслэлийг тодорхой дурдсан билээ.

Гэтэл энэ үндэслэлд тодорхой дүгнэлт хийлгүйгээр намайг буруутгасныг хүлээн зөвшөөрөх боломжгүй юм.

4. Мөн С.Э-ийн давж заалдах гомдол гэгчийг буцаасан шүүгчийн үйл ажиллагааг “...хуулиар үүрэг болгоогүй шаардлагыг хэргийн оролцогчоос шаардаж...” гэж

дүгнэхдээ тэрхүү давж заалдах гомдол нь С.Э-ийн өөрөө өөрийнхөө хүсэл зоригийн дагуу өөрийн нь бичсэн, эсхүл хүлээн зөвшөөрсөн гомдол мөн эсэх, түүнд нь өөрөө гарын үсгээ зурсан эсэхэд хэрэгт цугларсан нотлох баримтад тулгуурлаагүйд гомдолтой байна.

5.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.15 дугаар зүйлийн 2-д “Шүүх нь хууль болон эрх зүйн ухамсрыг удирдлага болгож нотлох баримтыг тал бүрээс нь нягт нямбай, бүрэн гүйцэд, бодит байдлаар нь хянаж үзсэний үндсэн дээр нотлох баримтыг өөрийн дотоод итгэлээр үнэлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлэхийг зорьж, мөн зүйлийн 3-т заасан “Хэрэгт авагдсан нотлох баримтыг харьцуулан шинжлэн судлах, бусад нотлох баримттай харьцуулах, шинэ нотлох баримтыг цуглуулах, нотлох баримтын эх сурвалжийг магадлах аргаар нотлох баримтыг шалгана” гэсний дагуу холбогдох баримтыг тодруулж асуусан, мөн миний ярьсан зүйл, асуусан асуулт шүүх хуралдааны танхимд байгаа оролцогч нарт сонсогдохгүй байсан тул өндөр дуугаар асуулт тавьсныг зандарсан, уцаарласан, шаардсан байдлаар харьцсан гэсэн Шүүхийн Ёс зүйн хорооны дүгнэлтийг шүүх “...хэргийн оролцогчдод үг яриа, үйлдлээрээ зохисгүй хандсан...” гэж дүгнэн зөвтгөсөн нь хэт нэг талыг барьсан дүгнэлт гэж үзэж байна.

6.Энэ бүхнээс үндэслэж шүүгч Ч.Б надад сахилгын шийтгэл оногдуулсан Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалыг хэвээр үлдээсэн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалыг хянан үзэж, хүчингүй болгон, гомдлыг хангасан шийдвэр гаргаж өгнө үү гэжээ.

ХЯНАВАЛ:

7.Шүүхийн Ёс зүйн хорооны болон Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагыг хангасан байх тул гомдол гаргагч шүүгч Ч.Б-гийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэлээ.

8.Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т “шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэнэ” гэж, Шүүгчийн ёс дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1-д “шүүгч нь хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, хууль дээдлэх, аливаа асуудалд бодитой хандах” гэж заасныг шүүгч Ч.Б зөрчсөн тухай дүгнэлт хууль зүйн үндэслэлтэй байна. Учир нь, шүүгч Ч.Б нь хохирогч С.Э-ийн давж заалдах гомдлыг 2017 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 197 дугаар албан бичгээр буцаахдаа “...хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд гомдлоо өөрийн биеэр шүүхэд ирүүлэх үүргээ биелүүлээгүй” гэх үндэслэл заасан нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 38.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 38.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасантай нийцээгүй, хуулиар тусгайлан үүрэг болгоогүй давж заалдах гомдлыг өөрийн биеэр шүүхэд ирүүлэхийг хохирогчоос шаардсан байгаа нь хууль дээдлэх, аливаа асуудалд бодитой хандах зарчимд нийцээгүй, шүүгчийн энэхүү алдаа нь хууль хэрэглээний дүгнэлт биш, харин хуулиар тодорхой тогтоосон, илтэд ойлгомжтой асуудлаар үндэслэлгүй хязгаарлалт тогтоож, хохирогчийн давж заалдах гомдол гаргах эрхийг зөрчсөн шинжтэй, уг алдаа нь шүүгчийн ёс зүйн зөрчилд хамаарч байна.

9.Мөн 2017 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 201 дүгээр албан бичгээр хохирогчийн өмгөөлөгчийн давж заалдах гомдлыг “давж заалдах гомдол гаргах хугацаа дууссан” гэж буцаахдаа хуульд заасан 14 хоногийн хугацааг буруу тооцсон, сүүлийн хоногийн 24 цагт гомдол гаргах хугацаа дуусаагүй байсан, энэ талаарх давж заалдах шатны шүүхийн дүгнэлт зөв болжээ.

10.Гомдол гаргагчийн “гомдол нь С.Э-ийн өөрөө өөрийнхөө хүсэл зоригийн дагуу өөрийн нь бичсэн, эсхүл хүлээн зөвшөөрсөн гомдол мөн эсэх, түүнд нь өөрөө гарын үсгээ зурсан эсэх нь эргэлзээтэй байсан, хэрэгт цугларсан нотлох

баримтад тулгуурлаагүйд гомдолтой байна” гэх гомдлыг хүлээн авах боломжгүй, шүүгчээс энэ үндэслэлээр хохирогч, түүний өмгөөлөгчийн давж заалдах гомдлыг буцаагаагүй буюу гомдол буцаасан албан бичигт заагдаагүй тул маргааны үйл баримтад хамааралгүй, Шүүгчийн ёс зүйн хорооноос ёс зүйн зөрчилд тооцоогүй асуудлаар хяналтын шатны шүүх эрх зүйн дүгнэлт хийх, энэ үндэслэлээр хяналтын гомдлыг хангах хууль зүйн үндэслэлгүй.

11.Шүүгчийн Ёс зүйн хорооноос өөрт олгогдсон эрхийн хүрээнд эрүүгийн хэргийн шүүх хуралдааны бичлэгийг судлан шинжилж, тухайлбал “шүүгч дуугаа өндөрсгөж, зандарсан, уцаарласан байдлаар хандсан” гэж дүгнэсэн нь шүүх хуралдааны бичлэгээр тогтоогдсон, ийнхүү дүгнэхдээ шүүгчийн “эх сурвалжийг магадлах аргаар нотлох баримтыг шалгах, холбогдох баримтыг тодруулж асуух” эрхийг үгүйсгээгүй, гагцхүү шүүгчээс хурал удирдан явуулахдаа үг яриа болон дууны өнгөөр хохирогчтой зохисгүй харьцаж, улмаар шүүгчийн төвийг сахих, хөндлөнгийн байх зарчмыг зөрчсөн байх тул гомдлын 5 дахь хэсэг үндэслэлгүй байна.

12.Иймээс давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэлээ.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.1, 127 дугаар зүйлийн 127.2.1-т заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн 221/ЁМА2018/0011 дүгээр магадлалыг хэвээр үлдээж, Ш аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ч.Б-гийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангахгүй орхисугай.

ТАНХИМЫН ТЭРГҮҮН

ШҮҮГЧ

М.БАТСУУРЬ

П.СОЁЛ-ЭРДЭНЭ

УИХ.МН
СУДАЛГААНЫ САН



МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЁС ЗҮЙН ХОРООНЫ МАГАДЛАЛ

2018 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 79

Улаанбаатар хот

Ш дүүргийн Иргэний хэргийн
анхан шатны шүүхийн шүүгч Ш.О-д
сахилгын шийтгэл ногдуулах тухай

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааныг тус хорооны дарга Н.Эрдэнэцогт даргалж, гишүүн А.Доржготов, В.Жавхлан, Д.Сүнжид, Ч.Оюунцэцэг нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны тэмдэглэл хөтлөгчөөр шинжээч Ч.Ханддулам, референт Ж.Халиун, гомдол гаргагч Д.А, шүүгчийн өмгөөлөгч Д.Н нарыг оролцуулан Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдааны танхимд хийв.

Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ш.О-д сахилгын хэрэг үүсгэж шийдвэрлэсэн Шүүхийн Ёс зүйн хорооны 2018.08.27-ны өдрийн 128 дугаар тогтоолтой сахилгын хэргийг гишүүн Ч.Оюунцэцэгийн илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Иргэн Д.А Шүүхийн Ёс зүйн хороонд ирүүлсэн гомдолдоо: "Миний бие Д.А нь Ш дүүргийн ... хороонд байрлах үйлчилгээний зориулалттай үл хөдлөх хөрөнгийн хууль ёсны өмчлөгч юм. Гэтэл шүүгч Ш.О нь 2017.12.04-ний өдөр 03269 дугаартай илт хууль бус шүүхийн шийдвэр гаргаж намайг хохироолоо. ... Шүүгч Ш.О нь онцгой ажиллагааны журмаар нэхэмжлэгч Я.А, түүний хүүхдүүд болох А.Ч, А.Г нарыг миний үл хөдлөх хөрөнгийн 50 хувийн хууль ёсны өвлөгчөөр тогтоосон байх юм. Шүүхийн шийдвэрийн үндэслэх болон тогтоох хэсэгт Иргэний хуулийн 520.1.1 заасны дагуу дээр дурдсан миний үл хөдлөх хөрөнгийг хууль ёсны өвлөгчөөр нэхэмжлэгчийг тогтоожээ. Миний үл хөдлөх хөрөнгө 2005 онд Д.А би ТТТ улсын Б бидний хөрөнгө байж байгаад Б нь 2012 онд өөрийн өмчлөх эрхээ надад шилжүүлсэн. Үл хөдлөх хөрөнгийн өмчлөгчөөр шүүхийн шийдвэр гарах үед Д.А би байсан. Иргэний хуулийн 520.1.1 хууль ёсны өвлөгч гэдэгт: Нас барагчийн эхнэр, нөхөр төрүүлсэн болон үрчилсэн хүүхэд байхаар заасан бол гэр бүлийн тухай хуульд гэрлэлтээ батлуулсан хүмүүсийг эхнэр, нөхөр гэж ойлгохоор хуульчилжээ. Гэтэл шүүгч гэрлэлтийн баталгаагүй хууль ёсны эхнэр нь мөн гэх нотлох баримт байхгүй байхад нэхэмжлэгчид илт давуу байдал бий болгож миний эрхийг хохироожээ.

Шүүгч хамтын амьдралтай байсныг тогтоосон шүүхийн шийдвэрийг үндэслэсэн нь үндэслэлгүй. Дээрх шүүхийн шийдвэр нь нэхэмжлэгчийн нас барагчийн хууль ёсны эхнэр гэдгийг тогтоож буй үйл баримт биш юм. Түүнчлэн нэхэмжлэгч гэх этгээд өвлөх эрхтэй гэж үзэхийн бол тэрээр Иргэний хуулийн 528.3 зааснаар өвлөх эрхээ алдсан, 528.4 зааснаар хугацаа сэргээлгэх хүсэлтийг шүүхэд гаргаагүй байдаг. Учир нь Б нь 2013.09.26-нд нас барсан бөгөөд тэрээр ТТТ улсад эхнэр хүүхэдтэй хүн байсан. Шүүгчийн дээрх үйлдэл нь хуульд нийцээгүй, шүүгч гагцхүү

хуульд захирагдаж шударга ажиллах ёстой гэж иргэн би үзэж байна. Иймд шүүгч Ш.О-д хариуцлага тооцож өгнө үү" гэжээ.

Шүүгч Ш.О-оос Шүүхийн Ёс зүйн хороонд ирүүлсэн тайлбартаа: "Шүүгч Ш.О би Я.А-гийн нэхэмжлэлтэй хууль ёсны өвлөгч тогтоолгох тухай нэхэмжлэлийг 2017.10.30-ны өдөр хүлээн авч Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан ажиллагаа хийн, 2017.12.04-ний өдөр шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн.

Нэхэмжлэгч Я.А нь Ш дүүрэг, ... хороо, ... хороолол Д байр ... тоотод оршин суудаг, ТТТ улсын иргэн Б-тэй 1998 онд танилцаж хамтын амьдралтай гэр бүлийн харилцаатай байсан, тэдний дундаас 2005.02.11-ны өдөр хүү А.Ч, 2012.08.15-ны өдөр охин А.Г нар төрсөн. ТТТ улсын иргэн Б 2013.09 сард өвчний улмаас нас барсан. ТТТ улсын иргэн талийгаач Б нь Ш дүүрэг ... хорооны нутаг дэвсгэрт байрлах 382, 382/1, 382/2, 384, 384/2, 384/1 байршилтай үйлчилгээний зориулалттай 2016м2 талбайтай үл хөдлөх хөрөнгийн хамтран өмчлөгч байсан, энэ үл хөдлөх хөрөнгийн өмчлөлийн талаар Я.А нь Д.А-д холбогдуулан цагдаагийн байгууллагад гомдол гаргаж, гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр прокурор хэрэг бүртгэлтийн хэргийг хаах тухай тогтоол гаргасан зэрэг үйл баримт нь нэхэмжлэгчийн шүүхэд гаргасан нэхэмжлэл, хүүхдүүдийн төрсний гэрчилгээ, гэрэл зургууд, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, хэрэг бүртгэлтийн хэргийг хаах тухай прокурорын тогтоол, шүүхийн шийдвэр, нэхэмжлэгчийн шүүх хуралдаанд гаргасан тайлбар зэрэг баримтуудаар тогтоогддог. Шүүгч Ш.О би нэхэмжлэгчийн шүүхэд гаргасан нэхэмжлэл, тайлбар, нотлох баримтуудыг үндэслэн шүүхийн шийдвэрийг гаргасан бөгөөд хэргийн оролцогчтой ямар нэг хувийн харилцаагүй, ашиг сонирхлын зөрчилгүй, шүүгчийн ёс зүйн алдаа зөрчил гаргасан зүйл байхгүй болно." гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны 2018.08.27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор шүүгч Ш.О-д сахилгын хэрэг үүсгэж шийдвэрлэжээ.

Шүүгч Ш.О Шүүхийн Ёс зүйн хорооны 2018.08.27-ны өдрийн 128 дугаар тогтоолыг эс зөвшөөрч гаргасан тайлбартаа: "...Шүүгч Ш.О миний бие Шүүхийн Ёс зүйн хорооны 2018.08.27-ны өдрийн 128 дугаар Сахилгын хэрэг үүсгэх тухай тогтоолыг 2018.10.08-ны өдөр хүлээн авч судалж үзээд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 167 дугаар зарлигаар баталсан "Шүүхийн Ёс зүйн хорооны дүрэм"-ийн 4 дүгээр зүйлийн 4.16 дугаар зүйл, мөн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон энэхүү гомдлыг Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хурал /цаашид "Нийт гишүүдийн хуралдаан" гэх/-д гаргаж байгааг хүлээн авна уу.

Шүүхийн Ёс зүйн хорооны Сахилгын хэрэг үүсгэх тухай 128 дугаар тогтоол нь хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий болж чадаагүй гэж үзэж байгаагаа илэрхийлэхийн сацуу Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "... Шуугч хараат бүс байж гагцхүү хуульд захирагдана...", мөн 2 дэх хэсэгт и....хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй...", мөн Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т "...Шүүгч шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ аливаа этгээдээс хараат бус байж, гагцхүү Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлсэн гаргасан, албан ёсоор нийтлэгдсэн бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд захирагдана...", Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 2 дэх хэсэгт "... Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага. туршлагатай холбоотой алдаа нь зөрчилд хамаарахгүй..." гэж заасантай нийцэхгүй байна. Учир нь:

1.Ёс зүйн хорооны тогтоолд гомдол гаргагч Д.А-гийн "...гэтэл шүүгч Ш.О нь 2017.12.04-ний өдөр 03269 дугаартай хууль бус шүүхийн шийдвэр гаргаж

намайг хохироолоо...” гэж дурдсаныг бүрэлдэхүүн хүлээн авсан нь үндэслэлгүй гэж үзэж байна. Монгол Улсын Үндсэн хуулийн тулгуур зарчим болох Арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасны дагуу “... гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно...” улмаар Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3-т “...Шүүгч эрх мэдлээ урвуулан ашигласан, илт хууль бус таслан шийдвэрлэх тогтоол, шийдвэр, шүүхийн бусад акт гаргасан гэмт хэрэгт гэм буруутай нь шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор нотлогдоогүй бол...” гэсэн нь аливаа нэгэн байдлаар түүнийг ямар нэгэн хариуцлагад татах үндэслэлгүй байх бөгөөд энэ нь шүүгчийн халдашгүй байдлыг хангаж хууль тогтоогч болох УИХ-аас хуульчилсан билээ. Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 102/ШШ2017/03269 дугаар шийдвэрийг илт хууль бус болохыг тогтоосон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах, Улсын Дээд шүүхийн хяналтын шатны шүүхүүдийн хуулийн хүчин төгөлдөр магадлал, тогтоол байхгүй болохыг анхааран үзсэнгүй. Мөн гомдол гаргагч иргэн Д.А нь дээрх 102/ШШ2017/03269 дугаар шийдвэрт Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 179 дүгээр зүйлийг баримтлан тус Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хүсэлт гаргасан боловч 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 102/ШТ2018/00161 дугаар хуулийн хүчин төгөлдөр тогтоолоор хүсэлтийг хүлээн авахаас татгалзаж, шийдвэрийг хэвээр нь үлдээсэн, мөн иргэн Д.А нь 102/ШШ2017/03269 дугаарт давж заалдах гомдол гаргасныг тус шүүх хүлээн авч хүргүүлсэн бөгөөд 2018 оны 08 сарын 21-ны өдрийн 777 дугаар Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн захирамжаар ...гомдол гаргах эрхтэй этгээд гэдэг нь тогтоогдоогүй... гэх үндэслэлээр түүний гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзсан үйл баримт байдаг билээ. Дээрх зүйлээс үндэслэн гомдол гаргагчийн “илт хууль бус шийдвэр гаргасан” гэдэг нь ийнхүү үндэслэлгүй байгааг Нийт гишүүдийн хуралдаан хүлээн авна уу.

2. Ёс зүйн хорооны тогтоолд гомдол гаргагч Д.А-гийн “...Я.А, түүний хүүхдүүд болох А.Ч, А.Г нарыг миний үл хөдлөх эд хөрөнгийн 50 хувийн хууль ёсны өвлөгчөөр тогтоосон байх юм Үл хөдлөх хөрөнгийн өмчлөгчөөр шүүхийн шийдвэр гарах үед Д.А би байсан.... Иргэний хуулийн 520 дугаар зүйлийн 520.1.1 хууль ёсны өвлөгч ...хууль ёсны өвлөгч гэдэгт нас барагчийн эхнэр, нөхөр, төрүүлсэн болон үрчилсэн хүүхэд байхаар заасан... Гэтэл шүүгч гэрлэлтийн баталгаагүй хууль ёсны эхнэр мөн гэх нотлох баримт байхгүй байхад нэхэмжлэгчид илт давуу байдал бий болгож миний эрхийг хохироожээ...” гэж дурдаж үүнийг ёс зүйн хорооны бүрэлдэхүүн хүлээн авсан нь үндэслэлгүй гэж үзэж байна

Юуны өмнө хэргийн зохигчид Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт заасны дагуу өөрийн шаардлагын үндэс болж байгаа байдлын талаарх нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх, цуглуулах ба мөн зүйлийн 38.4-т “...хэргийн оролцогч хуурамч нотлох баримт гаргах буюу түүнийг хууль бусаар цуглуулахыг хориглоно...” гэж үүрэгжүүлсэн билээ.

Шүүгчийн зүгээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн заасан эрхийнхээ дагуу үнэлэлт дүгнэлт өгсөн бөгөөд энэ нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зүйл заалтыг зөрчөөгүй ба уг баримтууд хуурамч гэсэн хууль ёсны үндэслэл бүхий шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шийдвэр байхгүй болно. Хэргийн үйл баримт болон иргэн Я.А нь өөрөө болон насанд хүрээгүй 12 настай А.Ч, 5 настай А.Г нарын нэрийн өмнөөс, 2 хүүхдийн аав болох талийгаач ТТТ улсын иргэн Б-гийн хөрөнгийн хууль ёсны өв залгамжлагч нар болохыг тогтоолгох нэхэмжлэлийг гаргасан болохыг Нийт гишүүдийн хуралдаанд танилцуулагдсан

байгаа. Шүүгчийн хувьд Шүүгчийн ёс дүрмийн 3.4 дугаар зүйлд заасны дагуу хуулийн хүчин төгөлдөр шийдвэрийн талаар ямар нэгэн байр суурийг илэрхийлэх эрхгүй байгаа учир дэлгэрэнгүй тайлбарлах боломж байхгүй байсан тул хууль хэрэглээ мөн хэрэгт нэхэмжлэгчээс гаргаж өгсөн нотлох баримтуудыг хэрхэн үнэлсэн талаарх хуулийн хүчин төгөлдөр шийдвэрт тусгалаа олсон учир ийнхүү дэлгэрэнгүй энэхүү гомдолдоо тусгаагүй болохыг дурдаж байна.

Шүүхийн тухай хуулийн 9 дүгээр зүйл болон Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу зохигч, түүний төлөөлөгч болон өмгөөлөгч нар нь мэтгэлцэх зарчмыг " баримтлан, хэргийн үйл баримт, гэм буруу байгаа эсэхийг нотлох болон үгүйсгэх. шүүх хуралдаанд биечлэн оролцох. үг хэлэх, бичгээр тайлбар өгөх, нотлох баримт гаргах түүнийг шинжлэх судлахаар хуульчлагдсан билээ. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд шүүхийн болон шүүгчийн юуг, ямар үйлдэл, эс үйлдэхүйг "нэхэмжлэгчид илт давуу байдал бий болгох,> гэж ойлгох талаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тодорхой заагаагүй бөгөөд хэргийн оролцогч биш этгээдэд эрх, мэтгэлцэх эрх, үүргийг хууль тогтоогч олгоогүй ба Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйл болон 26 дугаар зүйлд заасан эрх, үүргийнхээ хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон тухайн хэргийн зохигчид нь ямар нэгэн гомдол гаргаагүй байгааг анхааралдаа авна уу.

Шүүхийн Ёс зүйн хорооны тогтоолд "...шийдвэрийг гаргахдаа шүүгч Ш.О Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 134.3-т .. заасны дагуу Д.А-г оролцуулах боломжоор хангах хууль зүйн үндэслэлтэй байсан эсэх, ийнхүү оролцуулсан эсэх, улмаар Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "...хүний эрх, эрх чөлөөг ...хүндэтгэх, хууль дээдлэх... зарчмуудыг хувийн зан чанар болгож төлөвшүүлнэ". 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй" гэх заалтуудыг баримталсан эсэхийг тодруулах үүднээс түүнд сахилгын хэрэг үүсгэн шалгах нь зүйтэй гэж бүрэлдэхүүн дүгнэв..." гэсэн нь хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий болоогүй юм. Шүүхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т "...Шүүхээр хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдсон харилцааг гагцхүү хуулиар зохицуулна..." гэж заажээ.Шүүхийн Ёс зүйн хорооны бүрэлдэхүүний тогтоолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх :ай хуулийн 134дүгээр зүйлийн 134.3-т заасныг хэрэглэх хууль зүйн үндэслэлтэй эсэх, ийнхүү оролцуулсан эсэх дээр тодруулах ажиллагааг хийх үүднээс сахилгын хэргийг үүсгэсэн гэж хээр байгаа юм. Учир нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 134 дүгээр зүйлийн 134.3 дэх хэсэгт "...Онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх явцад бусад иргэн, хуулийн этгээдийн эрх хөндөгдсөн тохиолдолд тэдгээр нь гуравдагч этгээдээр оролцуулж болно гэж заажээ.Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасны дагуу бие даасан шаардлага гаргасан эсхүл бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдийн талаар зохицуулагдсан. Бие даасан шаардлага гаргаж тухайн иргэний эрх зүйн маргаанд орох асуудал тухайн иргэн, хуулийн этгээдийн хүсэл зориг байдаг ба хууль тогтоогч нь хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-т "...маргааны талаар бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд..." гэж заасан нь хэнийг, хэрхэн ямар хуулийн шаардлага хангасан тохиолдолд оролцуулж байхыг хуульчилсан билээ. Харин бие даасан шаардлага гаргаагүй этгээдийн хувьд мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3-т заасны дагуу шүүхийн шийдвэр гарахаас өмнө өөрийнх нь болон зохигчийн хүсэлтээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулахаар зохицуулсан юм.Энэ нь гомдол гаргагчийн зүгээс хуульчилсан 2 нөхцөлийг хангаагүй талаар өөрийн гомдолдоо тов тодорхой тусгагдсан ба Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 134

дүгээр зүйлийн 134.1-т "...Онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх хэргийг бусад хууль болон энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол энэ хуулиар тогтоосон ерөнхий журмын дагуу шийдвэрлэнэ..." гэж заасан ба мөн хуулийн 134 дүгээр зүйлийн 134.3 дахь хэсэгт шүүх заавал оролцуулах үүрэг хүлээсэн бус харин иргэн, хуулийн этгээд хүсэлт эсхүл шаардлага гаргах байдлаар уг маргаанд оролцох эрхийг хууль тогтоогч тогтоосон гэж үзэх хууль зүйн үндэслэлтэй юм.

Иймд Шүүгчийн ёс дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг баримталсан эсэхийг тодруулах үүднээс сахилгын хэрэг үүсгэсэн Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолыг хүчингүй болгож өгнө үү гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанаар сахилгын хэргийг хэлэлцээд ҮНДЭСЛЭХ нь:

Иргэн Д.А нь " Ш дүүргийн ... хороонд байрлах үйлчилгээний зориулалттай үл хөдлөх хөрөнгийн хууль ёсны өмчлөгч юм. Гэтэл шүүгч Ш.О нь 2017.12.04-ний өдөр 03269 дугаартай илт хууль бус шүүхийн шийдвэр гаргаж намайг хохироолоо. ...Шүүгч Ш.О нь онцгой ажиллагааны журмаар нэхэмжлэгч Я.А, түүний хүүхдүүд болох А.Ч, А.Г нарыг миний үл хөдлөх хөрөнгийн 50 хувийн хууль ёсны өвлөгчөөр тогтоосон байх юм. ...Шүүгчийн дээрх үйлдэл нь хуульд нийцээгүй, шүүгч гагцхүү хуульд захирагдаж шударга ажиллах ёстой гэж иргэн би үзэж байна. Иймд шүүгч Ш.О-д хариуцлага тооцож өгнө үү" гэсэн гомдлыг тус хороонд гаргаж, Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор иргэн Д.А-гийн гаргасан гомдлыг үндэслэлтэй гэж дүгнэж Ш дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ш.О-д сахилгын хэрэг үүсгэж шийдвэрлэсэн байна.

Цугларсан баримтаас үзэхэд Ш дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 12 сарын 04-ний өдрийн 102/ШШ2017/03269 дугаартай шийдвэрээр "Монгол Улсын Иргэний хуулийн 520 дугаар зүйлийн 520.1.1 дэх хэсэгт зааснаар Ш дүүрэг ... хорооны нутаг дэвсгэрт байрлах ... байршилтай үйлчилгээний зориулалттай 2016м2 талбайтай үл хөдлөх хөрөнгийн хамтран өмчлөгч талийгаач Б-д ногдох хэсгийн хууль ёсны өвлөгч нэхэмжлэгч Я.А, хүү А.Ч, охин А.Г нар болохыг" тогтоож шийдвэрлэжээ. /сахилгын хэргийн 54 хуудас/ Ш дүүрэг ... хорооны нутаг дэвсгэрт байрлах 2016 м2 талбайтай, үйлчилгээний зориулалттай, үл хөдлөх эд хөрөнгийн хууль ёсны өмчлөгч иргэн Д.А ... /нэг иргэний өмч/ тул эрхийн улсын бүртгэлийн Ү-220.....35 дугаарт бүртгэж олгосон, 2014 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн58 дугаар Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ байна. /сахилгын хэргийн 62 дугаар хуудас/

Онцгой ажиллагааны журмаар шүүх эрх үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болгоход нөлөөлөх үйл явдал болох эрх зүйн байдлыг тогтоодог тул энэ хэрэгт эсрэг сонирхол бүхий маргалдагч тал байх ёсгүй. Хэрэв онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх хэрэгт маргаан байвал уг хэргийг шүүх ердийн журмаар хянан шийдвэрлэх учиртай. Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх нотлох баримт хуулийн шаардлагад нийцсэн байх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ерөнхий журамд хамаардаг.

Гэтэл шүүгч нь хүчингүй болсонд тооцсон /сахилгын хэргийн 12-13 дугаар хуудас/ 2005 оны улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэн хэргийг шийдвэрлэж шийдвэр гаргасан байх бөгөөд шүүгч нэхэмжлэгчийн шаардах эрхийг тодорхойлох, хэрэгт эсрэг сонирхол бүхий маргалдагч тал байгаа эсэх талаар уйл баримтыг тодруулах гол баримт болох улсын бүртгэлийн газрын хөрөнгийн талаар лавлагааг

хүсэлт гаргах үеийн байдлаар нэхэмжлэгчээс шүүхэд ирүүлээгүй байхад хэргийг онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэсэн байна. Уг хэргийг шүүх ердийн журмаар хянан шийдвэрлэж маргалдагч тал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож, хуульд заасан эрхийг нь эдлүүлэх, мэтгэлцэх боломжоор хангаагүй нь буруу болжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургаадугаар зүйл, Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ: 3/ хөдлөх, үл хөдлөх хөрөнгө ...өмчлөх, ...эрхтэй гэсэн заалтыг, хөрөнгийн өмчлөгч, гомдол гаргагч иргэн Д.А-гийн өмчлөх эрхийг зөрчсөн байна. Шүүгч нь шүүгчийн ёс зүйтэй, үүрэгт ажилдаа хариуцлагатай байх нь шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх юм.

Үл хөдлөх хөрөнгийн өмчлөгч өөрөө мэдээгүй байхад хөрөнгийг нь бусдыг өвлөх эрхтэй гэж тогтоосон шийдвэрийг гаргаснаараа шүүгч нь шүүгч үүрэгт ажилдаа хариуцлагатай хандах, мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх зарчмуудыг хувийн зан чанар болгож төлөвшүүлнэ гэсэн, мөн шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй гэсэн Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг зөрчсөн үндэслэлээр Ш дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ш.О-д сануулах сахилгын шийтгэл ногдуулахаар Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааны бүрэлдэхүүн дүгнэв.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйл, 36 дугаар зүйлийн 36.1.1, 37 дугаар зүйлийн 37.1.1, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйл, Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.1, 5.13-т заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ш.О-д сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Энэ магадлалын хувийг шүүгч болон гомдол гаргагчид хүргүүлэхийг Шүүхийн Ёс зүйн хорооны Ажлын албанд даалгасугай.

3.Шүүгч, гомдол гаргагч нар магадлалыг гардан авснаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ОИХ.МН
СУДАЛГААНЫ САН

ДАРГАЛАГЧ

Н.ЭРДЭНЭЦОГТ

ГИШҮҮН

Ч.ОЮУНЦЭЦЭГ



ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ
МАГАДЛАЛ

2018 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 221/ЁМ2018/0027

Улаанбаатар хот

Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны
шүүхийн шүүгч Ш.О-д сахилгын шийтгэл
ногдуулсан Шүүхийн Ёс зүйн хорооны
магадлалын тухай

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Батбаатар даргалж, шүүгч Э.Лхагвасүрэн, О.Номуулин нарын бүрэлдэхүүнтэй, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Н.Өнө-Эрдэнэ, гомдол гаргагч Д.А-гийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ж.Б, шүүгч Ш.О-гийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Н нарыг оролцуулан, Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 79 дүгээр магадлалыг эс зөвшөөрч шүүгч Ш.О-гийн гаргасан гомдлыг шүүгч О.Номуулин илтгэснээр хянан хэлэлцэв.

ТОДОРХОЙЛОХ нь:

Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 79 дүгээр магадлалаар: Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ш.О-д Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1-д зааснаар сануулах сахилгын шийтгэл ногдуулж шийдвэрлэжээ.

Шүүгч Ш.О давж заалдах гомдолдоо: "... Шүүхийн Ёс зүйн хороо гомдол гаргагч болон шүүгчийн тайлбар, хэрэгт авагдсан баримтад үндэслэл бүхий дүгнэлт хийгээгүйгээс Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагыг хангаагүй болно. Шүүхийн Ёс зүйн хорооны 79 дүгээр магадлалаар "...шүүгч нь үүрэгт ажилдаа хариуцлагатай хандах, мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх зарчмуудыг хувийг зан чанар болгож төлөвшүүлнэ, шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй гэсэн Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг зөрчсөн" гэж дүгнэн шууд "сануулах" сахилгын шийтгэл ногдуулж шийдвэрлэсэн нь Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасантай нийцэхгүй байх бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан шийдвэр нь алдаатай эсэхээс үл хамааран ёс зүйн зөрчилд тооцогдохгүй болно.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т "... Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэнэ", Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 2-т "... Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй" гэж заасан тул шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан шийдвэр алдаатай эсэхээс үл хамааран мөн хууль хэрэглээтэй холбоотой шүүгчийн үйл ажиллагааг ёс

зүйн зөрчилд тооцохгүй байхаар журамласныг ноцтой зөрчсөн гэж үзэж байна. Гомдол гаргагчийн гомдлоос үзэхэд иргэн Д.А-гийн гомдол нь бүхэлдээ онцгой ажиллагааны журмаар хууль ёсны өвлөгч болохыг тогтоолгох тухай материалыг хүлээн аваад гаргасан шүүгчийн шийдвэрийн талаар буюу шүүгчийн мэргэжлийн ур чадвар, хууль хэрэглээний талаарх гомдол байх тул Ш.О намайг шүүгчийн ёс зүйн зөрчил гаргасан гэж үзэх үндэслэлгүй юм.

Учир нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 135 дугаар зүйлийг зөв хэрэглэсэн эсэхтэй холбоотой асуудал нь шүүгчийн хууль хэрэглэх мэргэжлийн ур чадвартай холбоотой байх тул шүүгчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хууль, журамд заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө ёс зүйн зөрчилд холбогдуулан шалгах эрх Шүүхийн Ёс зүйн хороонд олгогдоогүй болно. Монгол Улсын Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх заалт нь ерөнхий зарчим бөгөөд тухайлсан нэг ёс зүйн зөрчлийг тодорхойлсон зохицуулалт биш бөгөөд дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1-д "...шүүгч хуульд тусгайлан ёс зүйн зөрчил болохоор заасан болон энэ дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг ёс зүйн зөрчил гэж үзнэ" гэж заасан тул шүүгч намайг ёс зүйн дүрэм зөрчсөн гэж үзэх нь энэхүү журамд нийцээгүй гэж үзэж байна.

Түүнчлэн хүсэлт шийдвэрлэхдээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хууль зөрчсөн эсэхийг ёс зүйн хороо харьяалан шийдвэрлэхгүй юм. Учир нь шүүгч нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай, Монгол Улсын Шүүхийн тухай, Авлигын эсрэг болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай зэрэг хуулиудаар хориглосон үйлдэл гаргасан тохиолдолд "хариуцлага хүлээх" бөгөөд эдгээрээс Шүүхийн Ёс зүйн хорооны эрх хэмжээнд хамаарах нь Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн эсэхийг шалгаж, сахилгын шийтгэл ногдуулах асуудал юм. Гэтэл Шүүхийн Ёс зүйн хороо нь дээрх байдлаар хуулийг буруу тайлбарлан хэрэглэж шүүгч намайг ёс зүйн дүрмийг зөрчсөн гэж үзэж "сануулах" арга хэмжээ авсан нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д "...Шүүгч энэ хууль, шүүгчийн ёс зүйн дүрэм, шүүхийн байгууллага дахь хөдөлмөрийн харилцааг зохицуулсан хуулиар тогтоосон журмыг зөрчсөн бол түүнд дор дурдсан сахилгын арга хэмжээний аль нэгийг авна", 37.1.1-д "сануулах" гэж заасантай нийцэхгүй байна. Иймд дээрх зүйлийг үндэслэн сахилгын хэргийг бүхэлд нь хянан үзэж, хуульд болон журамд нийцээгүй Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 79 тоот магадлалыг хүчингүй болгож, шүүгч Ш.О-д холбогдуулан үүсгэсэн сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү" гэжээ.

ХЯНАВАЛ:

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.3 дахь хэсэгт зааснаар Шүүхийн ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 79 дүгээр магадлалыг давж заалдах гомдлын хүрээнд хянан үзэхэд гомдлыг хангах үндэслэл тогтоогдохгүй байна.

Шүүхийн Ёс зүйн хороонд иргэн Д.А-аас шүүгч Ш.О-д сахилгын хариуцлага хүлээлгэхийг хүссэн гомдол гаргаж, үндэслэлээ "Миний бие Ш Дүүргийн ... дүгээр хороонд байрлах үйлчилгээний зориулалттай үл хөдлөх хөрөнгийн хууль ёсны өмчлөгч атал шүүгч нь 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 03269 дугаартай илт хууль бус шүүхийн шийдвэр гаргаж онцгой ажиллагааны журмаар нэхэмжлэгч Я.А, түүний хүүхдүүд болох А.Ч, А.Г нарыг миний үл хөдлөх хөрөнгийн 50 хувийн хууль ёсны өвлөгчөөр тогтоосон байна. Шүүгчийн дээрх үйлдэл нь хуульд нийцээгүй, шүүгч гагцхүү хуульд захирагдаж шударга ажиллах ёстой" гэж тодорхойлжээ.

Шүүгч Ш.О нь Я.А-гийн нэхэмжлэлтэй “хууль ёсны өвлөгчөөр тогтоолгох тухай” иргэний хэргийг онцгой ажиллагааны журмаар хянан хэлэлцээд Ш дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 03269 дүгээр шийдвэрээр “Ш дүүргийн ... дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах 382, 382/1, 382/2, 384, 384/2, 384/1 хаягт байршилтай үйлчилгээний зориулалттай 2016 м.кв талбайтай үл хөдлөх хөрөнгийн хамтран өмчлөгч талийгаач Б ногдох хэсгийн хууль ёсны өвлөгчөөр нэхэмжлэгч Я.А, хүү А.Ч, охин А.Г нарыг тогтоож шийдвэрлэсэн байх бөгөөд уг шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон байна.

Хэрэгт авагдсан баримтуудаас үзэхэд дээрх шүүхийн шийдвэр гарсан цаг хугацаанд уг үл хөдлөх хөрөнгийн өмчлөгч нь Д.А байсан болох нь 2014 оны 8 дугаар сарын 25-ны өдөр олгогдсон Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээгээр нотлогдож байх бөгөөд шүүх 2005 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Д.А болон ТТТ улсын иргэн Б нарыг өмчлөгчөөр бүртгэж олгосон Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг /хүчингүй болгон/ үндэслэн хэргийг шийдвэрлэжээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 133 дугаар зүйлийн 133.1 дэх хэсэгт онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх хэргийг хуульчилж өгсөн бөгөөд хуулийн 135 дугаар зүйлийн 135.2 дахь хэсэгт эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдалд хамаарах нөхцөлүүдийг тодорхойлсон байна.

Хуулийн дээрх зохицуулалтуудад “хууль ёсны өвлөгчөөр тогтоолгох тухай” нэхэмжлэлийн шаардлага бүхий хэрэг хамаарах талаар тодорхой зохицуулаагүй бөгөөд Ш дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 03269 дүгээр шийдвэрт холбогдох хуулийн заалтыг баримтлаагүйгээс хэргийг онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэсэн эсэхийг тодорхойлох боломжгүй болжээ.

Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 2-т “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ес зүйн зөрчилд хамаарахгүй” гэж заасан нь шүүгч аливаа хэрэг маргааныг буруу шийдвэрлээд хариуцлага хүлээнэ гэсэн айдасгүйгээр хууль зүйн хувьд хамгийн зөв гэсэн үндэслэлийнхээ дагуу хэрэг маргааныг хянан шийдвэрлэх боломжийг олгодог.

Энэ утгаараа шүүгчийн хараат бус байдлын баталгаа болдог ч нөгөө талаас шүүгч аливаа хэрэг маргааныг дур зоргоороо бус харин хуульд захирагдаж, хуулийн үндэслэлтэй шийдвэрлэх үүрэгтэй гэж ойлгоно.

Өөрөөр хэлбэл, шүүгч хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан алдаа болгон ёс зүйн зөрчилд тооцогдохгүй гэж давж заалдах гомдолд дурдсанаар ойлгох боломжгүй, харин хуульд захирагдалгүй, хэнд ч тодорхой хуулийн заалтыг илэрхий зөрчсөн, бусдын үндсэн эрх, эрх чөлөөг зөрчсөн тохиолдолд ёс зүйн зөрчил гэж үзнэ.

Дээрхийг дүгнэвэл Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалд тодорхойлсон “хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэж маргалдагч талыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулж хуульд заасан эрхээ эдлэх, мэтгэлцэх боломжоор хангаагүй, гол нотлох баримт болох улсын бүртгэлийн газрын хөрөнгийн лавлагааг хүсэлт гаргах үеийн байдлаар ирүүлээгүй байхад хэргийг онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэсэн буруутай” гэсэн дүгнэлт холбогдох хууль дүрмийг зөрчөөгүй бөгөөд Шүүхийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “үүрэгт ажилдаа хариуцлагатай хандах” зарчимтай нийцээгүй гэж үзсэн нь зөв байна.

Түүнчлэн, үл хөдлөх хөрөнгийн өмчлөгч өөрөө мэдээгүй байхад тухайн хөрөнгийн хууль ёсны өвлөгчөөр тогтоосон шийдвэр гаргасныг шүүгчийн хууль хэрэглэх мэргэжлийн ур чадвартай холбоотой алдаа гэж үзэхгүй, Шүүхийн Ёс зүйн

дүрмийн 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй” гэснийг зөрчсөн ёс зүйн зөрчилд хамаарна.

Иймд Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалыг хэвээр үлдээж, шүүгч Ш.О-ийн гаргасан давж заалдах гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэлээ.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1, 120 дугаар зүйлийн 120.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 79 дүгээр магадлалыг хэвээр үлдээж, Ш.О-гийн гомдлыг хангахгүй орхисугай.

2.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.5 дахь хэсэгт зааснаар давж заалдах шатны шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, хууль буруу тайлбарлаж хэрэглэсэн, төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийг буруу хэрэглэсэн, шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн нь шүүхийн шийдвэр гарахад нөлөөлсөн гэж хэргийн оролцогч болон өмгөөлөгч нар үзвэл магадлалыг гардан авснаас хойш 14 хоногийн дотор Улсын Дээд Шүүхийн Захиргааны хэргийн танхимд хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.БАТБААТАР

ШҮҮГЧ

Э.ЛХАГВАСҮРЭН

ШҮҮГЧ

О.НОМУУЛИН

УИХ.МН
СУДАЛГААНЫ САН



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ХЯНАЛТЫН ШАТНЫ ЗАХИРГААНЫ
ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2019 оны 02 сарын 13 өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны
шүүхийн шүүгч Ш.О-д холбогдох сахилгын
хэргийн тухай

Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх
хуралдааны бүрэлдэхүүн:

Даргалагч: Танхимын тэргүүн М.Батсуурь

Шүүгчид:

Б.Мөнхтуяа

П.Соёл-Эрдэнэ

Ч.Тунгалаг

Илтгэгч шүүгч:

Х.Батсүрэн

Нарийн бичгийн дарга:

Д.Мөнхцэцэг

Гомдлын агуулга: “Миний бие Д.А нь Ш дүүргийн ... хороонд байрлах
үйлчилгээний зориулалттай үл хөдлөх хөрөнгийн хууль ёсны өмчлөгч юм. Гэтэл
шүүгч Ш.О нь 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдөр 03269 дугаартай илт хууль
бус шүүхийн шийдвэр гаргаж намайг хохироолоо”

Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 79 дүгээр
магадлал,

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын
05-ны өдрийн 221/ЁМ2018/0027 дугаар магадлалтай,

Шүүх хуралдаанд оролцогчид:

Гомдол гаргагч Д.А-гийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ж.Б,

Шүүгч Ш.О, шүүгч Ш.О-гийн өмгөөлөгч Н.Б нарыг оролцуулж,

Шүүгч Ш.О-гийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Н-ийн хяналтын журмаар

гаргасан гомдлыг үндэслэн хэргийг хянан хэлэлцэв.

ТОДОРХОЙЛОХ НЬ:

Өмнөх шатны шүүхийн шийдвэр

1.Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 79
дүгээр магадлалаар: Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйл,
36 дугаар зүйлийн 36.1.1, 37 дугаар зүйлийн 37.1.1, Шүүхийн захиргааны тухай
хуулийн 33 дугаар зүйл, Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5 дугаар зүйлийн
5.7.1, 5.13-т заасныг удирдлага болгон Ш дүүргийн иргэний хэргийн анхан шатны
шүүхийн шүүгч Ш.О-д сануулах сахилгын шийтгэл ногдуулжээ.

2.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын
05-ны өдрийн 221/ЁМ2018/0027 дугаар магадлалаар Монгол Улсын Шүүхийн Ёс

зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 79 дүгээр магадлалыг хэвээр үлдээж, шүүгч Ш.О-гийн гомдлыг хангахгүй орхисон байна.

Хяналтын журмаар гаргасан гомдол

3.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 221/ЁМ2018/0027 дугаар магадлалыг 2019 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр хүлээн авч танилцаад, эс зөвшөөрч Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.1 дэх хэсгийг баримтлан дараах гомдлыг үүгээр гаргаж байна.

4.Давж заалдах шатны шүүх хэргийн нөхцөл байдал болон хэрэгт авагдсан нотлох баримтыг тал бүрээс нь бодитойгоор харьцуулан үзэж, үнэлж дүгнээгүйн улмаас магадлал хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий болж чадаагүй байна.

5.Учир нь: Магадлалд “...Шүүхийн Ёс зүйн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй” гэснийг зөрчсөн ёс зүйн зөрчилд хамаарна...” гэжээ.

6.Гомдол гаргагч Д.А нь гомдлын үндэслэлээ “... Ш дүүргийн ... хороонд байрлах үйлчилгээний зориулалттай үл хөдлөх хөрөнгийн хууль ёсны өмчлөгч атал шүүгч хууль бус шүүхийн шийдвэр гаргаж онцгой ажиллагааны журмаар ... миний үл хөдлөх хөрөнгийн 50 хувийн хууль ёсны өвлөгчөөр тогтоосон байна...” гэсэн байдаг.

7.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалд “...Хэрэгт авагдсан баримтуудаас үзэхэд дээрх шүүхийн шийдвэр гарсан цаг хугацаанд уг үл хөдлөх хөрөнгийн өмчлөгч нь Д.А байсан болох нь 2014 оны 8 дугаар сарын 25-ны өдөр олгогдсон Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээгээр нотлогдож байх...” гэсэн дүгнэлтийг хийсэн нь үндэслэл бүхий болж чадаагүй байна.

8.Уг 2014 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ нь улсын бүртгэлийн Ү-.....735 дугаарт бүртгэгдсэн,58 дугаартай байна. Хэрэгт авагдсан Нийслэлийн Ш дүүргийн прокурорын газрын прокурорын 2017 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 425 дугаар тогтоолын 4-т “... Ш дүүргийн цагдаагийн ... дугаар хэлтсээс 2017 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр №14з-3/6015 дугаартай албан тоот “Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн №.....58 дугаартай гэрчилгээг хүчингүй болгуулах тухай” албан тоотыг Ш дүүргийн улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлсэн болно...” гэсний дагуу шүүхийн шийдвэр гарах үед тус 2014 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн58 дугаар үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчин төгөлдөр байсан гэж үзэх үндэслэлгүй байна.

9.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу нэхэмжлэгч Я.А нь өөрийн гаргасан хүсэлт буюу нэхэмжлэлийн шаардлага, түүнийг өөрөө нотлох, нотлох баримт гаргах, цуглуулах үүргээ хэрэгжүүлж нэхэмжлэлд 2005 оны 12 дугаар сарын 01-ний өдөр олгогдсон улсын бүртгэлийн Ү-.....735 дугаартай,11 дугаартай Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хуулийн шаардлага хангасан байдлаар гаргаж өгсөн бөгөөд ийнхүү өөрийн шаардлагын үндэслэлийг бодит байдалд нийцсэн, үнэн зөв болохыг баримтаар тогтоож, хуульд зааснаар нотлох үүргээ хэрэгжүүлэхдээ хуулиар зөвшөөрөгдсөн арга хэрэгслийг ашигласан гэж үзэх тул тус баримтыг хуурамч гэж үзэх үндэслэлгүй байна.

10.Иймд шүүгчээс дээрх нотлох баримтыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасан эрхийнхээ дагуу үнэлэлт дүгнэлт өгсөн бөгөөд энэ нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зүйл заалтыг зөрчөөгүй болно.

11.Дээрх зүйлээс үндэслэн давж заалдах заалдах шатны шүүхийн дүгнэлт үндэслэлгүй байх бөгөөд шүүхийн шийдвэр гарах үед хүчингүй байсан гэж үзэх үндэслэлтэй баримтыг үндэслэн шүүх шийдвэрээ гаргах хууль зүйн үндэслэл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн ердийн болон онцгой ажиллагааны аль ч үе шат, журамд байхгүй болно.

12.Давж заалдах шатны шүүхийн магадлалд "...Хуулийн дээрх зохицуулалтад "хууль ёсны өвлөгчөөр тогтоолгох тухай" нэхэмжлэлийн шаардлага бүхий хэрэг хамаарах талаар тодорхой зохицуулаагүй..." гэсэн нь үндэслэл бүхий байх шаардлагыг хангаагүй байна.

13.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 135 дугаар зүйлд заасан эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоох эрх зүйн үндэслэлийг хуульчлан тогтоосон байдаг бөгөөд тухайн үйл явдлыг тогтоох журмыг хуульд тухайлан заагаагүй тохиолдолд түүнийг шүүх хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэдэг болохыг Эрхэм шүүх бүрэлдэхүүнд тайлбарлах нь илүүц биз ээ.

14.Тухайн үйл явдлыг шүүхээс тогтоолгохоос өөр журмаар уг үйл явдлыг батлах баримт бичиг олж авах боломжгүй болсон тохиолдолд шүүхээс эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоон шийдвэрлэдэг бөгөөд нэхэмжлэгч Я.А нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 135 дугаар зүйлийн 135.2.14 дэх хэсэгт заасны дагуу тогтоох журмыг нь хуульд заагаагүй буюу хууль ёсны өвлөгчөөр тогтоолгох тухай хүсэлт гаргаж, шүүгч түүнийг хуульд заасны дагуу шийдвэрлэснийг буруутгах үндэслэлгүй гэж үзнэ.

15.Магадлалд "...үл хөдлөх хөрөнгийн өмчлөгч өөрөө мэдээгүй байхад тухайн хөрөнгийн хууль ёсны өвлөгчөөр тогтоосон шийдвэр гаргасан..." гэж үзэх боломжгүй байна. Учир нь нэхэмжлэгч Я.А нь Ш дүүргийн ... дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах үл хөдлөх хөрөнгийн хамтран өмчлөгч ТТТ улсын иргэн Б-д оногдох хэсгийн буюу 50 хувийн хууль ёсны өвлөгчөөр тогтоолгох хүсэлтийг гаргаж, шүүх уг хүсэлтийн хүрээнд шийдвэрлэснээс бус тус хөрөнгийн гомдол гаргагч Д.А-д оногдох хэсгийн өмчлөгчийн тухайд ямар нэгэн маргаан, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр байхгүй болохыг шүүх бүрэлдэхүүн анхаарч үзнэ гэдэгт итгэлтэй байна.

16.Түүнчлэн Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн Д А-гийн гаргасан хүсэлтийг хэлэлцэх шүүх хуралдаанд түүний өмгөөлөгчөөр Б.О /үд №...33/ оролцсон байх бөгөөд шүүх хуралдааны 102/ШТ2018/00161 дугаар тэмдэглэлд "...Хүсэлт гаргагчийн өмгөөлөгч: 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн шийдвэрийг Д.А нь Ш дүүргийн Прокурорын газарт хэрэгтэй танилцаж байх үедээ буюу 2018 оны 03 дугаар сарын 29-ний өдөр олж мэдсэн..." болохыг илэрхийлсэн байдаг бөгөөд Д.А нь Шүүхийн Ёс зүйн хороонд 2018 оны 05 дугаар сарын 22-ны өдөр гомдол гаргасан байна.

17.Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5 дугаар зүйлийн 5.17-д "...Шүүгчид холбогдох сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш зургаан сар, зөрчил гаргаснаас хойш нэг жил өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулахгүй..." гэж заасан бөгөөд Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 79 дүгээр магадлалаар "...Ш дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ш.О-д сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай..." гэсэн байдаг.

18.Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хороо нь шүүгчид сахилгын шийтгэл ногдуулах хорооны дүрмээр заасан хугацаа өнгөрсөн байхад сахилгын шийтгэл ногдуулсан нь Ёс зүйн хороо нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, шударга, төв голч байх зарчмаа зөрчиж, хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагыг хангаагүй байна.

19.Дээрх зүйлээс үндэслэн шүүгчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлээгүй гэж үзсэн хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий болж чадаагүй Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 221/ЁМ2018/0027 дугаар магадлалыг хүчингүй болгож өгнө үү.

20.Улсын Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанд биечлэн оролцож нэмэлт тайлбар гаргах эрхээр хангаж хуралдааны товыг урьдчилан мэдэгдэхийг хүсье гэжээ.

ХЯНАВАЛ:

21.Иргэн Д.А-аас Шүүхийн Ёс зүйн хороонд 2018 оны 05 дугаар сарын 22-ны өдөр “Миний бие Д.А нь Ш дүүргийн ... дүгээр хороонд байрлах 382, 382/1, 382/2, 384, 384/1, 384/2 тоот хаягт байршилтай үйлчилгээний зориулалттай үл хөдлөх хөрөнгийн хууль ёсны өмчлөгч атал Ш дүүргийн шүүхийн шүүгч Ш.О нь 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдөр 102/ШШ2017/03269 дугаартай илт хууль бус шүүхийн шийдвэр гаргаж өмчлөгч миний хууль ёсны эрх ашгийг хохироолоо. ... Шүүгч Ш.О нь онцгой ажиллагааны журмаар нэхэмжлэгч Я.А, түүний хүүхдүүд болох А.Ч, А.Г нарыг миний үл хөдлөх хөрөнгийн 50 хувийн хууль ёсны өвлөгчөөр тогтоосон байна. ... Үл хөдлөх хөрөнгийн өмчлөгчөөр шүүхийн шийдвэр гарах үед Д.А би байсан...Шүүгч хамтын амьдралтай байсныг тогтоосон шүүхийн шийдвэрийг үндэслэсэн байгаа нь үндэслэлгүй...Шүүгчийн дээрх үйлдэл нь хуульд нийцээгүй шүүгч гагцхүү хуульд захирагдаж шударга ажиллах ёстой...Иймд Ш дүүргийн шүүгч Ш.О-д хариуцлага тооцож өгнө үү” гэх гомдлыг гаргажээ.

22. Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар дээрх гомдлыг хянан хэлэлцээд мөн өдрийн 128 дугаар тогтоолоор шүүгч Ш.О-д сахилгын хэрэг үүсгэсэн байна.

23.Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ш.О-д холбогдуулан үүсгэсэн сахилгын хэргийг 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдөр Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанаар хэлэлцсэн 79 дүгээр магадлалаар “... Шүүгч хүчингүй болсонд тооцсон 2005 оны улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэн хэргийг шийдвэрлэсэн бөгөөд шүүгч нэхэмжлэгчийн шаардах эрхийг тодорхойлох, хэрэгт эсрэг сонирхол бүхий маргалдагч тал байгаа эсэх талаар үйл баримтыг тодруулах гол баримт болох улсын бүртгэлийн газрын хөрөнгийн талаар лавлагааг хүсэлт гаргах үеийн байдлаар нэхэмжлэгчээс шүүхэд ирүүлээгүй байхад хэргийг онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэсэн, уг хэргийг шүүх ердийн журмаар хянан шийдвэрлэж маргалдагч тал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож, хуульд заасан эрхийг нь эдлүүлэх, мэтгэлцэх боломжоор хангаагүй нь буруу болжээ” гэж үзэж, үл хөдлөх хөрөнгийн өмчлөгч өөрөө мэдээгүй байхад хөрөнгийг нь бусдыг өвлөх эрхтэй гэж тогтоосон шийдвэрийг гаргаснаараа “шүүгч үүрэгт ажилдаа хариуцлагатай хандах, мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх зарчмуудыг хувийн зан чанар болгож төлөвшүүлнэ”, “шүүгч хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй” гэсэн Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг зөрчсөн гэж дүгнэн, шүүгч Ш.О-д сануулах сахилгын шийтгэл ногдуулжээ.

24.Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 79 дүгээр магадлалыг эс зөвшөөрч шүүгч Ш.О гомдол гаргасныг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж уг магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна.

25.Шүүгч Ш.О-гийн гомдлоор Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 79 дүгээр магадлал, Захиргааны хэргийн давж заалдах

шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 221/ЁМ2018/0027 дугаар магадлалыг хянан үзэхэд “нэхэмжлэгчийн шаардах эрхийг тодорхойлох, хэрэгт эсрэг сонирхол бүхий маргалдагч тал байгаа эсэх талаар үйл баримтыг тодруулах гол баримт болох улсын бүртгэлийн газрын хөрөнгийн талаарх лавлагааг хүсэлт гаргах үеийн байдлаар нэхэмжлэгчээс шүүхэд ирүүлээгүй байхад хэргийг онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэсэн...маргалдагч тал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож, хуульд заасан эрхийг нь эдлүүлэх, мэтгэлцэх боломжоор хангаагүй нь буруу, “Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм”-ийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус зөрчсөн гэсэн Шүүхийн Ёс зүйн хорооны болон Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн дүгнэлтүүдийг үгүйсгэх нөхцөл тогтоогдохгүй байхаас гадна “Шүүгч нь ... үнэнч шударга ..., аливаа асуудалд бодитой, ... үүрэгт ажилдаа хариуцлагатай хандах, ...” гэсэн Монгол улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэмд заасан зарчимд нийцсэн байна.

26. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 167 дугаар зарлигаар баталсан “Шүүхийн Ёс зүйн хорооны дүрэм”-ийн “Тав”-ын 5.17- д “Шүүгчид холбогдох сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш зургаан сар, зөрчил гаргаснаас хойш нэг жил өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулахгүй” гэж, Монголын хуульчдын холбооны Шүүгчдийн хорооны Удирдах зөвлөлийн 2014 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 1/08 тогтоолоор баталсан “Монгол Улсын Шүүхийн Шүүгчийн Ёс зүйн дүрэм”-ийн 5.1 дүгээр зүйлийн 3-т “Ёс зүйн зөрчлийг илрүүлснээс хойш 1 сар, зөрчил гаргаснаас хойш 6 сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулж болохгүй” гэж шийтгэл ногдуулах хугацааг өөр өөрөөр тодорхойлжээ.

27. Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмээр тус хорооны бүрэлдэхүүн, ажиллах чиг үүргийг тодорхойлж, иргэн, хуулийн этгээд, албан тушаалтнаас Шүүхийн Ёс зүйн хороонд шүүгчийн сахилга, хариуцлага, ёс зүйн асуудлаар гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг журамласан бол Монгол Улсын Шүүхийн Шүүгчийн Ёс зүйн дүрмээр шүүгч үйл ажиллагаандаа баримтлах ёс зүйн хэм хэмжээг тодорхойлон, ёс зүйн зөрчил гаргасан шүүгчид хариуцлага тооцох хөөн хэлэлцэх хугацааг тусгайлан заасан “материаллаг” шинжийг агуулсан эрх зүйн эх сурвалж юм.

28. Шүүх аливаа эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхдээ тухайн харилцааг зохицуулсан хуулийн хэм хэмжээ, хэрэв байхгүй бол уг эрх зүйн харилцааг нарийвчилсан эрх зүйн эх сурвалжийг хэрэглэх нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4, 11 5-д заасан хууль хэрэглээний зарчимд нийцэх учир шүүгчид сахилгын шийтгэл ногдуулахад Монгол Улсын Шүүхийн Шүүгчийн Ёс зүйн дүрмээр тогтоосон хугацааг баримтлах нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д “Шүүгч Шүүгчийн Ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана”, 32.2-д “Шүүгчийн Ёс зүйн дүрмийг зөрчсөн шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэнэ” гэж заасантай нийцэж байна.

29. Тухайн тохиолдолд шүүгч Ш.О-г 2017 оны 12 дугаар сарын 04- ний өдөр буюу шүүхийн шийдвэр гарсан өдрийг сахилгын зөрчил гаргасан өдөр гэж үзэх бөгөөд үүнээс хугацааг тоолоход 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдөр түүнд “сануулах” сахилгын шийтгэл ногдуулсан нь “Монгол Улсын Шүүхийн Шүүгчийн Ёс зүйн дүрэм”-ийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан хөөн хэлэлцэх хугацаанд нийцэхгүй байна.

30. Тиймээс Шүүхийн Ёс зүйн хорооны болон Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалыг тус тус хүчингүй болгож, шүүгч Ш.О-гийн

итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Н-ийн хяналтын журмаар гаргасан гомдлын агуулгын хувьд зарим хэсгийг хангах нь зүйтэй гэж үзлээ.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.1, 127.2.4-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 79 дүгээр магадлал, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 221/ЁМ2018/0027 дугаар магадлалыг тус тус хүчингүй болгосугай.

ТАНХИМЫН ТЭРГҮҮН

М.БАТСУУРЬ

ШҮҮГЧ

Х.БАТСҮРЭН

UIN.MN
СУДАЛГААНЫ САН



МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЁС ЗҮЙН ХОРООНЫ МАГАДЛАЛ

2018 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 77

Улаанбаатар хот

Т дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны
шүүхийн шүүгч Э.Ч-д сахилгын шийтгэл
ногдуулах тухай

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааныг тус хорооны дарга Н.Эрдэнэцогт даргалж, гишүүн В.Жавхлан, А.Доржготов, Д.Сүнжид, Ч.Оюунцэцэг нарын бүрэлдэхүүнтэй, шүүгч Э.Ч, хяналт шалгалт хариуцсан референт Б.Энхбаатар, хуралдааны тэмдэглэл хөтлөгчөөр шинжээч Ч.Ханддулам нарыг оролцуулан, Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдааны танхимд хийж, Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 95 дугаар тогтоолоор шүүгч Э.Ч-д сахилгын хэрэг үүсгэсэн хэргийг Ёс зүйн хорооны гишүүн Ч.Оюунцэцэгийн илтгэснээр хянан хэлэлцээд **ТОДОРХОЙЛОХ** нь:

Шүүхийн Ёс зүйн хороонд өмгөөлөгч П.Б гаргасан гомдолдоо: "Т дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Э.Ч нь Тээврийн прокурорын газраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.3-д заасан гэмт хэрэгт холбогдуулан үйлдсэн яллах дүгнэлттэй, шүүгдэгч Б.Ц-д холбогдох 201724000379 дугаартай хэргийг хянан шийдвэрлэж 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдөр 25 дугаартай шийтгэх тогтоол гаргасан байдаг.

Дээрх эрүүгийн хэрэгт хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын шатанд мөрдөгч Монгол Улсын иргэн Б.М-г иргэний хариуцагчаар татан оролцуулсан байдаг бөгөөд өмгөөлөгч миний бие түүний өмгөөлөгчөөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон.

Энэхүү Эрүүгийн хэрэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль дараах байдлаар ноцтой зөрчигдсөн байдаг:

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.1 дүгээр зүйлийн 1-д "Мөрдөгч мөрдөн шалгах бүх ажиллагааг хийж дууссан, хэргийн бодит байдлыг бүрэн нотолж тогтоосон гэж үзвэл яллагдагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид хавтаст хэргийн материалтай танилцахыг мэдэгдэнэ", 2-т "Мөрдөн шалгах ажиллагаа дууссаныг мэдэгдсэний дараа яллагдагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний өмгөөлөгчид хавтаст хэргийн материалыг танилцуулах ба энэ тухай тэмдэглэл үйлдэнэ гэж тус тус заасан байна. Гэтэл мөрдөгч энэхүү хэргийг прокурорт шилжүүлэхдээ энэ тухай иргэний хариуцагч Б.М болон түүний өмгөөлөгч П.Б надад огт мэдэгдээгүй, хэргийн материалтай огт танилцуулаагүй.

2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-д зааснаар прокурор мөрдөгчөөс шилжүүлсэн хэргийн талаар "оролцогчийг хавтаст хэргийн материалтай танилцах боломжоор хангасан эсэхийг"-ийг хянан үзэх үүрэгтэй гэж заасан байхад үүнийг зөрчиж энэ хэрэгт

хяналтын прокурор Н.А нь ийнхүү хянан үзэх үүргээ биелүүлэлгүйгээр хэргийг шууд шүүхэд шилжүүлсэн. Мөн анхан шатны шүүх хэргийн шүүхэд шилжүүлсний дараа дээрх нөхцөл байдлыг хянан үзэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-т зааснаар хэргийг прокурорт буцаах боломжтой байхад энэ үүргээ хэрэгжүүлээгүй.

3.Шүүгч Э.Ч нь 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр 1526 дугаартай захирамж гаргаж яллагдагчийг шүүхэд шилжүүлсэн байдаг ба уг захирамж дээрээ иргэний хариуцагч талыг шүүх хуралдаанд оролцуулахгүй байхаар шийдвэрлэж Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14-т заасан "хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох" эрхийг ноцтойгоор зөрчсөн.

4.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т "Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх ба шүүх хуралдааны товыг 3-аас доошгүй хоногийн өмнө талуудад мэдэгдэнэ" гэж заасан байхад шүүгч Э.Ч нь хуулийн энэ заалтыг зөрчиж иргэний хариуцагч болон түүний өмгөөлөгчид шүүх хуралдааны товыг огт мэдэгдэлгүйгээр шүүх хуралдааныг 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдөр хийсэн байдаг ба уг шүүх хуралдааныг хохирогчийн өмгөөлөгчийн хүсэлтээр хойшлуулсан байдаг. 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдөр шүүх хуралдааныг хийхдээ шүүгч Э.Ч нь мөн адил шүүх хуралдааны товыг иргэний хариуцагч Б.М болон өмгөөлөгч надад огт мэдэгдэлгүйгээр хэргийг шийдвэрлэж улмаар иргэний хариуцагч Б.М /тээврийн хэрэгслийн өмчлөгч биш байсаар байхад/-өөс 21,424,148 төгрөгийг гаргуулахаар шийдвэрлэсэн байдаг.

5.Шүүхээс шийтгэх тогтоол гаргасан талаар иргэний хариуцагч талд огт мэдэгдээгүй бөгөөд өмгөөлөгч миний бие шийтгэх тогтоол гарсан талаар хохирогчийн өмгөөлөгч Э.М-ээс мэдэж, 2018 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр шийтгэх тогтоолыг гардаж авсан . Энэ энэ үед хэргийн материалтай анх удаа танилцсан.

Т дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Э.Ч-гийн "Тээврийн прокурорын газраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.3-д заасан гэмт хэрэгт холбогдуулан үйлдсэн яллах дүгнэлттэй, шүүгдэгч Б.Ц-д холбогдох 201724000379 дугаартай хэргийг хянан шийдвэрлэхдээ иргэний хариуцагч талыг шүүх хуралдаанд оролцуулаагүй, иргэний хариуцагчид шүүх хуралдааны товыг хуульд заасан журмын дагуу мэдэгдэлгүйгээр шүүх хуралдааныг хийсэн үйлдэл" нь Монгол Улсын Шүүхийн Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1-д "Шүүгч нь хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, хууль дээдлэх, үнэнч шударга байх, аливаа асуудалд бодитой, төвийг сахисан байр сууринаас хандах, хараат бус байх, үүрэг ажилдаа хариуцлагатай хандах, нууцыг задруулахгүй байх, мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх зэрэг зарчмуудыг хувийн зан чанар болгож төлөвшүүлнэ", 3.3 дугаар зүйлийн 1-д "Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй", мөн зүйлийн 6-д "Шүүгч өөрийн удирдлага дор ажиллаж байгаа алба хаагчдад ажил мэргэжилдээ үнэнч байх, чин сэтгэлээсээ хандаж ажиллахыг шаардаж, өөрийн эргэн тойронд ёс зүйн эрүүл орчныг бүрдүүлнэ" гэж заасныг зөрчсөн ёс зүйн зөрчил гаргасан үйлдэл гэж үзэж байгаа тул үүнийг шалган шийдвэрлэж өгнө үү.

Иргэний хариуцагч Б.М давж заалдах журмаар гаргасан гомдлоосоо татгалзаж энэ хэрэг эцэслэн шийдвэрлэгдсэн ч ёс зүйн зөрчил гаргасан байж болзошгүй шуугчийн асуудлыг хөндөхгүй өнгөрч болохгүй гэсэн үүднээс энэхүү гомдлыг гаргав." гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хороонд шүүгч Э.Ч ирүүлсэн тайлбартаа: "Т дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Э.Ч би өмгөөлөгч П.Б-гийн гаргасан

2018 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн гомдолтой 2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр хүлээн авч танилцаад зохих журмын дагуу тайлбар гаргаж байна.

Тээврийн Прокурорын газраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.3-д заасан гэмт хэрэгт холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн шүүгдэгч Б.Ц-д холбогдох эрүүгийн 2017 2400 0379 дугаартай хэргийг 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр хүлээн авч, нээлттэй хянан хэлэлцээд 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 25 дугаартай шийтгэх тогтоолоор шүүгдэгч Б.Ц-г хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөний улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцож, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.1 дүгээр зүйлийн 1-д заасныг журамлан шүүгдэгчийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.3-д зааснаар тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 3 /гурав/ жилийн хугацаагаар хасаж, 1 жилийн хугацаагаар тэнсэж, Иргэний хуулийн 499 дүгээр зүйлийн 499.1, 505 дугаар зүйлийн 1-д тус тус зааснаар иргэний хариуцагч Б.М-ээс 21.424.148 төгрөгийг гаргуулж хохирогчийн хууль ёсны төлөөлөгч И.С-д олгож, Иргэний хариуцагч Б.М нь гэм буруутай этгээдээс холбогдох нотлох баримтаа бүрдүүлж Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар жич нэхэмжлэх эрхтэй болохыг дурдаж шийдвэрлэсэн билээ.

Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1-д “шүүгч хуульд тусгайлан ёс зүйн зөрчил болохоор заасан болон энэ дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг ёс зүйн зөрчилд тооцно”, мөн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 2-д “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй” гэж тус тус заажээ. Өмгөөлөгч П.Б-гийн гаргасан гомдолтой танилцахад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой гомдол байгаа учир миний зүгээс шүүгчийн ёс зүйн зөрчил гаргаагүй гэж үзэж байна.” гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 95 дугаар тогтоолоор шүүгч Э.Ч-д сахилгын хэрэг үүсгэж шийдвэрлэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанаар сахилгын хэргийг хэлэлцээд ҮНДЭСЛЭХ нь:

Шүүхийн Ёс зүйн хороонд өмгөөлөгч П.Б нь Т дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Э.Ч-д холбогдуулж “шүүгч ёс зүйн зөрчил гаргасан” гэсэн гомдлыг гаргажээ. Гомдолдоо шүүгч Э.Ч нь “Тээврийн прокурорын газраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.3-д заасан гэмт хэрэгт холбогдуулан үйлдсэн яллах дүгнэлттэй, шүүгдэгч Б.Ц-д холбогдох 201724000379 дугаартай хэргийг хянан шийдвэрлэхдээ иргэний хариуцагчид шүүх хуралдааны товыг хуульд заасан журмын дагуу мэдэгдэлгүйгээр, шүүх хуралдаанд оролцуулалгүйгээр шүүх хуралдааныг хийсэн гэсэн агуулга бүхий гомдол гаргажээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 95 дугаар тогтоолоор шүүгч Э.Ч-д Монгол Улсын Шүүхийн Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1, 3.3 дугаар зүйлийн 1, мөн зүйлийн 6-д заасан заалтуудыг зөрчсөн гэж үзэж сахилгын хэрэг үүсгэсэн байна.

Сахилгын хэрэгт цугларсан баримтаас үзэхэд шүүгч Э.Ч нь “Тээврийн прокурорын газраас шилжүүлэн ирүүлсэн шүүгдэгч Б.Ц-д холбогдох эрүүгийн хэргийг хүлээн авч нээлттэй хянан хэлэлцээд 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 25 дугаартай шийтгэх тогтоолоор шүүгдэгч Б.Ц-г хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөний улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцож, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.1 дүгээр

зүйлийн 1-д заасныг журамлан шүүгдэгчийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.3-д зааснаар тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 3 /гурав/ жилийн хугацаагаар хасаж, 1 жилийн хугацаагаар тэнсэж, Иргэний хуулийн 499 дүгээр зүйлийн 499.1, 505 дугаар зүйлийн 1-д тус тус зааснаар иргэний хариуцагч Б.М-ээс 21.424.148 төгрөгийг гаргуулж хохирогчийн хууль ёсны төлөөлөгч И.С-д олгож, Иргэний хариуцагч Б.М нь гэм буруутай этгээдээс холбогдох нотлох баримтаа бүрдүүлж Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар жич нэхэмжлэх эрхтэй болохыг дурдаж шийдвэрлэжээ. /11-13 дугаар хуудас/

Шүүгч нь иргэний хариуцагч Б.М-д шүүх хуралдааны товыг хуульд заасан журмын дагуу мэдэгдэлгүйгээр хэргийг шийдвэрлэж, оролцогчийг хавтаст хэргийн материалтай танилцах боломжоор хангаагүй, шүүх хуралдаанд биеэр оролцох, тайлбар мэдүүлэг гаргах болон өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах хуульд заасан эрхийг эдлүүлээгүй нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйл. Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ: ...14/ Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох,...“ гэж заасныг зөрчсөн, Монгол Улсын Шүүхийн Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1-д "Шүүгч нь хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, хууль дээдлэх, ... аливаа асуудалд бодитой, төвийг сахисан байр сууринаас хандах, ... үүрэгт ажилдаа хариуцлагатай хандах, ... мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх зэрэг зарчмуудыг хувийн зан чанар болгож төлөвшүүлнэ", 3.3 дугаар зүйлийн 1-д "Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй" гэсэн заалтыг тус тус зөрчсөн тул Т дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Э.Ч-д Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1-д заасан шүүгчийн сахилгын хариуцлага болох сануулах сахилгын шийтгэл ногдуулах нь зүйтэй гэж хуралдааны бүрэлдэхүүн дүгнэв.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35, 36 дугаар зүйлийн 36.1.1, 37 дугаар зүйлийн 37.1.1, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйл, Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5.7.1, 5.13-т заасныг удирдлага болгон

ТОГТООХ нь:

1.Т дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Э.Ч-д сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Энэ магадлалын хувийг шүүгч болон гомдол гаргагчид хүргүүлэхийг тус хорооны Ажлын албанд даалгасугай.

3.Магадлалыг эс зөвшөөрвөл гардан авснаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.

ДАРГАЛАГЧ

Н.ЭРДЭНЭЦОГТ

ГИШҮҮН

Ч.ОЮУНЦЭЦЭГ



ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ
МАГАДЛАЛ

2019 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 221/ЕМ2019/0004

Улаанбаатар хот

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны
2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн
77 дүгээр магадлалын тухай

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Батбаатар даргалж, шүүгч Н.Хонинхүү, шүүгч Э.Зоригтбаатар нарын бүрэлдэхүүнтэй, П.Б-гийн гомдолтой, Т дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Э.Ч-д холбогдох, Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 77 дугаар магадлалыг шүүгч Э.Ч-гийн давж заалдах гомдлоор шүүгч Э.Зоригтбаатарын илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 77 дугаар магадлалаар.Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35, 36 дугаар зүйлийн 36.1.1, 37 дугаар зүйлийн 37.1.1, Шүүхийн захиргааны хуулийн 33 дугаар зүйл, Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5.7.1,5.13-т заасныг удирдлага болгон Т дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Э.Ч-д сануулах сахилгын шийтгэл ногдуулж шийдвэрлэсэн байна.

Шүүгч Э.Ч давж заалдах гомдолдоо: Т дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Э.Ч би Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 77 дугаартай магадлалыг 2018 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр хүлээн авч танилцаад дараах гомдлыг гаргаж байна.

Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1-д “шүүгч хуульд тусгайлан ёс зүйн зөрчил болохоор заасан болон энэ дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг ёс зүйн зөрчилд тооцно”, мөн зүйлийн 2-т “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй” гэж тус тус заажээ. Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалд шүүгч Э.Ч нь иргэний хариуцагч (Б.М-д шүүх хуралдааны товыг мэдэгдэлгүйгээр хэргийг шийдвэрлэж эрхийг нь эдлүүлэлгүй Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох... гэж заасныг зөрчсөн гэж дүгнэж, сануулах сахилгын шийтгэл ногдуулсныг үндэслэлгүй гэж үзэж байна.

Шүүгдэгч Б.Ц-д холбогдох хэргийг хянан хэлэлцэхэд иргэний хариуцагч Б.М нь мөрдөн байцаалтад нэхэмжлэлтэй холбоотой материалтай танилцаж 1 мэдүүлэг өгсөн. Шүүхийн хэлэлцүүлэгт оролцох талаар өөрөө ямар нэг хүсэлт гаргаагүй,

түүнийг оролцуулахгүйгээр хэргийг шийдвэрлэх боломжтой гэж шүүх үзэж хэргийг эцэслэн шийдвэрлэсэн.

Иргэний хариуцагч Б.М нь Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан гомдолд дурдсан үндэслэлээр буюу шүүх хуралдаанд оролцуулаагүй гэх үндэслэлээр Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхэд давж заалдах гомдол гаргасан. Улмаар Б.М нь давж заалдах гомдлоосоо татгалзаж, шүүгдэгч Б.Ц-д холбогдох эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон болно.

Иймд миний бие иргэний хариуцагчийн хуульд заасан эрхийг хязгаарласан зөрчил гаргаагүй, мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан гаргасан шүүгчийн шийдвэрийг ёс зүйн зөрчилд хамааруулан үзэж сануулах сахилгын шийтгэл ногдуулсан Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалыг хүчингүй болгож өгнө үү” гэжээ.

ХЯНАВАЛ:

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.3 дахь хэсэгт зааснаар давж заалдах гомдлын хүрээнд хэргийг хянан үзээд дараах үндэслэлээр Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалыг хүчингүй болгож шийдвэрлэв.

Гомдол гаргагч П.Б нь шүүгч Э.Ч-д холбогдуулан “Мөрдөгч хэргийг прокурорт шилжүүлэхдээ энэ тухай иргэний хариуцагч ... өмгөөлөгчид огт мэдэгдээгүй, хэргийн материалтай огт танилцуулаагүй, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-т зааснаар хэргийг прокурорт буцаах боломжтой байхад энэ үүргээ хэрэгжүүлээгүй, ... шүүх хуралдаанд иргэний хариуцагч, түүний өмгөөлөгчийг огт оролцуулаагүй, шүүх хуралдааны товыг мэдэгдээгүй, шийтгэх тогтоол гарсан талаар мэдэгдээгүй” гэх үндэслэлээр Шүүхийн Ёс зүйн хороонд гомдол гаргасныг Шүүхийн Ёс зүйн хорооны тогтоолоор сахилгын хэрэг үүсгэжээ. Улмаар Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 77 дугаар магадлалаар “Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1-д “Шүүгч хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, хууль дээдлэх, ... аливаа асуудалд бодитой, төвийг сахисан байр сууринаас хандах, ... үүрэгт ажилдаа хариуцлагатай хандах, ... мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх зэрэг зан чанаруудыг хувийн зан чанар болгон төлөвшүүлнэ”, 3.3 дугаар зүйлийн 1-д “... Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй” гэж заасныг зөрчсөн” гэж дүгнэн түүнд сануулах сахилгын шийтгэл ногдуулсан байна.

Тус магадлалыг эс зөвшөөрч, шүүгчээс “... Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1-д “шүүгч хуульд тусгайлан ёс зүйн зөрчил болохоор заасан болон энэхүү дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн. үйлдэл, эс үйлдэхгүйг ёс зүйн зөрчилд тооцно”, мөн зүйлийн 2-т “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй” гэж заасан хэмээн гомдол гаргажээ. Түүнчлэн шүүгч Э.Ч нь Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдаанд биеэр оролцож тайлбарлахдаа “Ёс зүйн зөрчил гаргаагүй, харин хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой зөрчил гаргасан гэдгээ хүлээн зөвшөөрч байна” гэж мэдүүлж байсан болохыг дурдах нь зүйтэй.

Хэрэгт авагдсан баримтуудаас үзвэл шүүгч Э.Ч 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдөр шүүх хуралдааныг хийж 25 дугаартай шийтгэх тогтоол гаргасан байна. Уг хэргийн иргэний хариуцагч Б.М-ийн өмгөөлөгч П.Б-гээс шийтгэх тогтоолыг эс зөвшөөрч 2018 оны 01 дугаар сарын 30-ны өдөр давж заалдах гомдол гаргаснаас гадна давж заалдах гомдолд дурдсан үндэслэлээрээ 2018 оны 03 дугаар сарын 28-ны өдөр Шүүхийн Ёс зүйн хороонд гомдол гаргажээ. Шүүхийн Ёс зүйн хороо

2018 оны 05 сарын 25-ны өдрийн 95 дугаар тогтоолоор сахилгын хэрэг үүсгээд улмаар мөн оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 77 дугаар магадлалаар түүнд сахилгын шийтгэл ногдуулжээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн баталсан Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5.17-д “Шүүгчид холбогдох сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш зургаан сар, зөрчил гаргаснаас хойш нэг жил өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулахгүй” гэж заасан байх бөгөөд шүүгч Э.Ч-гийн тухайд 1 жилийн хугацаа өнгөрөөгүй боловч ... “холбогдох сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш зургаан сар” гэсэн хугацаа нь өнгөрсөн байжээ.

Мөн Шүүгчийн Ёс зүйн дүрмийн “Хариуцлага” гэсэн 5.1 дүгээр зүйлийн 3-т “Ёс зүйн зөрчлийг илрүүлснээс хойш 1 сар, зөрчил гаргаснаас хойш 6 сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулж болохгүй” гэсэн 2 хугацааны аль аль нь өнгөрсөн байна.

Давж заалдах шатны шүүх Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.3-д “Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах гомдлын хүрээнд хянах ...” тухай заасан бөгөөд шүүгч Э.Ч хугацааны талаар гомдол гаргаагүй тул цааш нь дэлгэрүүлэн тайлбарлах шаардлагагүй гэж үзэв.

Өмгөөлөгч П.Б-гийн анх гаргасан гомдолд “... мөрдөгч хэргийг прокурорт шилжүүлэхдээ энэ тухай иргэний хариуцагч Б.М болон түүний өмгөөлөгч П.Б надад огт мэдэгдээгүй, хэргийн материалтай танилцуулаагүй, ... шүүгч хэргийг прокурорт буцаах боломжтой байхад энэ үүргээ биелүүлээгүй” гэсэн 2 үндэслэлийг дурдсан байх боловч Ёс зүйн хорооноос дээрх гомдлын үндэслэлд ямар нэгэн дүгнэлт хийгээгүй, энэ үндэслэлээр шүүгчийг буруутгаагүй байна.

Иймд давж заалдах шатны шүүхээс Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалын үндэслэл болсон “шүүх хуралдаанд иргэний хэргийн хариуцагч, түүний өмгөөлөгчийг огт оролцуулаагүй, шүүх хуралдааны товыг мэдэгдээгүй, шийтгэх тогтоол гарсан талаар мэдэгдээгүй” гэсэн зөрчлийн талаар дүгнэлт хийж хэргийг шийдвэрлэв. Өөрөөр хэлбэл шүүгч хэргийг шүүх хуралдаанаар шийдвэрлэхдээ иргэний хариуцагчийг оролцуулаагүй, хурлын товыг мэдэгдээгүй нь “Ёс зүйн зөрчил үү” эсхүл “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан алдаа юу” гэдгийг ялгаж үзэх шаардлагатай байна.

Монгол Улсын шүүхийн Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1-д “шүүгч хуульд тусгайлан Ёс зүйн зөрчил болохоор заасан болон энэ дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг Ёс зүйн зөрчил гэж үзнэ” гэж заасан бөгөөд энэ тохиолдолд Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд болон Шүүгчийн Ёс зүйн дүрэмд “тогтоосон хэм хэмжээ” зөрчсөн зөрчил байгаа эсэх талаар дүгнэлт хийх шаардлагатай байна.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн “Шүүгчид хориглох зүйл” гэсэн 27 дугаар зүйлд нийт хорин төрлийн хориглосон заалт /тогтоосон хэм хэмжээ/ байна. Энэ хорин төрлийн заалтад тус хэргийн гомдол гаргагчийн дурдсан асуудал хамаарах хэм хэмжээг хуульчлаагүй байна. Иймд хуульд бус харин Шүүгчийн Ёс зүйн дүрэмд хориглосон, өөрөөр хэлбэл “тогтоосон хэм хэмжээ байна уу” гэдгийг үзэх шаардлагатай.

Энэ хүрээнд дараах 2 дүрмийг харьцуулан үзэв.

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн “Хууль биелүүлэх, хэрэглэх” гэсэн 15.1 дүгээр зүйлийн 2-т “Шүүгч шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ хууль болон шударга Ёсонд захирагдаж, хуулийг хэрэглэнэ”, Хэлэлцүүлэх эрхийг хангах гэсэн 15.7 дугаар зүйлийн 1. “Шүүгч нь хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиг сонирхол нь хөндөгдсөн аливаа этгээд эсхүл түүний хуульчид хэрэг, маргаанаа хэлэлцүүлэх эрхийг тэгш хангана” гэж заажээ. Харин Шүүгчийн Ёс зүйн дүрмийн

1.3 дугаар зүйлийн 1-д “Шүүгч хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, хууль дээдлэх, ... аливаа асуудалд бодитой, төвийг сахисан байр сууринаас хандах, ... үүрэгт ажилдаа хариуцлагатай хандах, ... мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх зэрэг зан чанаруудыг хувийн зан чанар болгон төлөвшүүлнэ”, 3.3 дугаар зүйлийн 1-д Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй” гэсэн зохицуулалт байна.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн “Шүүгчид хориглох зүйл” гэсэн 27 дугаар зүйл, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 15 дугаар зүйл, Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйл, 3.3 дугаар зүйл зэргийг шүүх харьцуулан үзэв.

Эдгээр зохицуулалт өөр хоорондоо харилцан адилгүй зохицуулалт агуулсан байхад уг хуулиар болон дүрмээр зохицуулагдсан “хэм хэмжээ”-г зөрчсөн гэж үзэж, аль алиныг нь зэрэгцүүлэн хэрэглэх эрх зүйн боломжгүй юм. Давж заалдах шатны шүүх шүүгч Э.Ч-г Ёс зүйн биш харин хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой зөрчил гаргасан, энэ нь Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 2-т “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа”-нд хамаарна гэж үзэв.

Иймд Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 77 дугаар магадлалыг хүчингүй болгох нь зүйтэй гэж үзэв.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.1.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн “Т дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Э.Ч-д сахилгын шийтгэл ногдуулах тухай” 77 дугаар магадлалыг хүчингүй болгож, шүүгч Э.Ч-гийн гомдлыг хангасугай.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.5 дахь хэсэгт заасны дагуу магадлалыг эс зөвшөөрвөл хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч гардан авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.БАТБААТАР

ШҮҮГЧ

Н.ХОНИНХҮҮ

ШҮҮГЧ

Э.ЗОРИГТБААТАР

ОИН.МН
СЭДАЛГААНЫ САН



МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЁС ЗҮЙН ХОРООНЫ МАГАДЛАЛ

2018 оны 3 сарын 30 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

К аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан
шатны шүүхийн шүүгч Ц.О, Б.М нарт сахилгын
шийтгэл ногдуулах тухай

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааныг дарга Н.Эрдэнэцогт даргалж, гишүүн О.Мөнхсайхан, Ч.Оюунцэцэг, В.Жавхлан, А.Доржготов нарын бүрэлдэхүүнтэй, шүүгч Ц.О, хяналт шалгалт хариуцсан референт Б.Энхбаатар, хуралдааны тэмдэглэл хөтлөгчөөр шинжээч А.Энхбаатар нарыг оролцуулан, Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдааны танхимд хийж, Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 172 дугаар тогтоолыг эс зөвшөөрч шүүгч Ц.О, Б.М нарын гаргасан гомдлыг үндэслэн Ёс зүйн хорооны гишүүн А.Доржготовын илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Шүүхийн Ёс зүйн хороонд өмгөөлөгч М.Э: “ЛЛЛ” ХХК-ийн захирал М.О нар гаргасан гомдолдоо: “К аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн үүрэг гүйцэтгэгч Ц.О, шүүгч Б.М нарын шүүгчийн Ёс зүйгүй үйлдэл хэрээс хэтэрч. шударга шүүхээр шүүлгэх хүний Үндсэн хуульд заасан эрхийн зөрчлийг удаа дараа гаргасан шүүгчээр ажиллах ямар ч боломжгүй болохоо дахин дахин харуулсан үйлдлүүдийг гаргаж байгаа тул энэ асуудалд Шүүгчийн Ёс зүйн Хороо, Шүүхийн Мэргэшлийн Хороод анхаарч үзэж эдгээр хүмүүсийг Ёс зүйн хувьд шүүгчийн ажил мэргэжилд тэнцэх эсэхийг тогтоолгохоор гомдол гаргаж байна

... Манай ЛЛЛ ХХК нь К аймгийн Хүнд даацын Тээвэрчид нэгдэж орон нутагт тээврийн үйл ажиллагаа явуулж буй РРР ХХК-тай Ачаа тээврийн гэрээ хийж К аймаг дахь Т уурхайгаас, К аймгийн О сумын П боомтоор нүүрс тээвэрлэх үйлчилгээ үзүүлэх зорилготойгоор тухайн үед 100 гаруй тээвэрчдийн бүртгэлтэй 2010 оны 10 дугаар сарын 28-нд 9 тээвэрчнийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнээ болгон үүсгэн байгуулагчаар Улсын бүртгэлд бүртгүүлсэн нь одоо мөрдөгдөж байгаа Компанийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1-д Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үүсгэн байгуулагчдын тоо 50-иас дээшгүй байна гэсэн хуулийн заалттай нийцүүлсэн нь өнөөгийн өмчлөлийн маргаан, шүүхээр маргалдах эх үүсвэр болсныг дурдах нь зүйтэй байх.

Тухайн хэргийн нэхэмжлэлийг К аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх 2015 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр хүлээн авч, 2015 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр иргэний хэрэг үүсгэсэн.

Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 1-д Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй. Хэргийн оролцогчдын зүгээс шүүгчийг татгалзахад хүргэх нөхцөл байдлыг өөрийн үг яриа, үйлдлээр бий болгохоос урьдчилан сэргийлж,

зайлсхийнэ.” гэж заасныг Ерөнхий шүүгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч шүүгч Ц.О зөрчиж уг хэргийг хэлэлцэх шүүх хуралдааныг товлон зарласны дараа буюу 2017 оны 01 дүгээр сарын 09-ны өдөр хариуцагч М.О намайг өөрөөсөө татгалз гэдэг саналыг тавьсан бөгөөд би хүлээж аваагүй. 2017 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр 3 хариуцагч, тэдгээрийн өмгөөлөгч нар шүүх хуралдаан дээр К аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн бүх шүүгчдийг татгалзан гаргах хүсэлт гаргасан бөгөөд уг хүсэлтийн агуулга нь хариуцагч М.О-гийн төрсөн дүү М.Н нь К аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн иргэний хэргийн шүүгчээр ажилладаг. Хариуцагч М.О нь бусад хариуцагч нараас эсрэг сонирхолтой байгаа нь түүний бичсэн тайлбараар нотлогдож байна...” гэсэн нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйлд “татгалзан гарах үндэслэл”-д хамааралгүй асуудлаар байсан.

Гэтэл шүүгч Ц.О, шүүгч Б.М нар нь .. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүгчийн Ёс зүйн дүрмийг зөрчин 2017 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 15Э/ЗТ2017/00014 дугаар К аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний тогтоолыг /уг татгалзлыг хүлээн авсан/ гаргасан.

Уг тогтоолын үндэслэх хэсэгт дүгнэн шүүгч Ц.О, шүүгч Б.М нар нь өөрсдийгөө татгалзан гаргаж Ёс зүйн ноцтой зөрчил гаргасан.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.3-д “Хэрэв хэн нэгний ах, дүү Монгол Улсын Дээд шүүхийн шүүгч бол шүүгч Ц.О, шүүгч Б.М нарын тогтоолын ойлголтоор Монгол улсад хэрэг маргаанаа шийдвэрлүүлэх боломжгүй болж байгаа нөхцөл байдал харагдаж байна

Шүүгч Ц.О, шүүгч Б.М нар нь хэн нэгэн хамт ажилладаг хүнээс хамаарч хэргийг шударга бусаар шийдвэрлэнэ гэдгээ өөрсдөө хүлээн зөвшөөрсөн энэхүү үйлдэл нь шүүгч хүнд байх боломжгүй ёс зүйн ноцтой зөрчил гэж үзэж байгаа тул гомдлын нэгдэх үндэслэлээ болгож байна...

Шүүгч Ц.О нь ийнхүү Н.Э-гийн нэхэмжлэлтэй хэрэгт ашиг сонирхол байна гэх нөхцөлийг гаргаж, шүүгчийн ёс зүйг зөрчсөн гэж үзэж байна.

...Гомдлыг хэлэлцэх шүүх хуралдааныг даргалагч шүүгч Ц.О, шүүгч Б.М, Л.Т нарын бүрэлдэхүүнтэй хэлэлцсэн бөгөөд татгалзах эсэхийг асуухгүйгээр шүүх хуралдааныг явуулсан бөгөөд хэргийн оролцогч талын хувьд дээрх шүүх бүрэлдэхүүнээс татгалзах дараах үндэслэлүүд байсан

Энэхүү шүүх хуралдаанд шүүх бүрэлдэхүүнийг татгалзах үндэслэл байсан бөгөөд татгалзлын агуулгыг товч байдлаар тодорхойлбол: К аймгийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М-ээс татгалзах үндэслэл нь манай компанийн өмчлөлийн маргаантай асуудлаар иргэний хэрэг болон Захиргааны хэрэг үүсгэн шалгагдаж байтал компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн нэг Н.Г нас барсан тул өв нээгдэх эрх сэргээлгэх үндэслэлээр 2015 оны 10 дугаар сарын 08-ны өдөр түдгэлзүүлсэн байгаа гэтэл Ж.Д-гийн нэхэмжилсэн нэхэмжлэл өмчлөлийн маргаан 2 нь хоорондоо уялдаатай адил хэрэг юм.

Н.Г-гийн нас барсан хэрэгт Б.М шүүгчийн төрсөн ах Б.Б нь Эрүүгийн сэжигтэн ялагдагчаар шалгагдаж байгаа бөгөөд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91-р зүйлийн 91.1.2, 91.1.3-т заасан үндэслэл байх тул энэ хэргийг шийдвэрлэхэд сонирхлын зөрчил илэрч шүүхээс гарсан шийдвэр хүчин төгөлдөр болох эсэх нь эргэлзээтэй тул татгалзах үндэслэлээ болгож байна.

К аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ц.О-оос Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91-р зүйлийн 91.1.3-д заасан үндэслэлээр татгалзаж Н.Э-гийн нэхэмжлэлтэй иргэний хэрэг, Б.Э-гийн нэхэмжлэлтэй иргэний хэргүүдийн шийдвэрлэлт, уг шийдвэрүүд хүчингүй болж байгаа үндэслэлүүдийг харахад энэ хэргийг шударгаар шийдвэрлэхэд эргэлзээ

төрж байгаа тул энэ асуудлуудаар дэлгэрэнгүй тайлбарлаж татгалзах үндэслэлээ тодорхойлж байсан.

Даргалагч шүүгч Ц.О, шүүгч Б.М, шүүгч Л.Т нарын бүрэлдэхүүнтэй 2016 оны 06 дугаар сарын 10-ны өдөр М.О миний шүүгчийн захирамжид гаргасан гомдлыг хэлэлцэх шүүх хуралдааныг шүүгч Ц.О даргалан хэлэлцүүлэхдээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д заасныг зөрчин шүүх хуралдааныг үргэлжлүүлсэн нь дээрх үндэслэлүүдээр шүүх бүрэлдэхүүнээс татгалзах эрхээр хангалгүйгээр шүүх хуралдааныг явуулж гомдол гаргах эрхгүйгээр тогтоол гаргасан нь энэ тогтоол хүчин төгөлдөр эсэх, уг хэргийг хувийн сонирхлоор шийдвэрлэсэн байна гэх хардлагыг төрүүлэх нэг үндэслэл болсныг гомдлын үндэслэл болгож байна.

Түүнчлэн шүүгч Ц.О-гийн 2016 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 153/Ш332016/00744 дугаар шүүгчийн захирамж нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.5-д (Шүүх энэ хуулийн 69.1-д заасан арга хэмжээг авахдаа үйлдвэрлэл, үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, орлого олох эх үүсгэврийг хаах түүнчлэн бүтээгдэхүүн, түргэн муудаж, чанараа алдах зэрэг үр дагаварт хүргэж болохгүй) гэсэн хуулийн заалтыг ноцтойгоор зөрчсөн үйлдэл бөгөөд энэхүү захирамжаа та нар гомдол хүсэлт гаргаад ир гэж байгаад 2016 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн ЛЛЛ ХХК-ийн үүсгэн байгуулагч Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн хүсэлтийн дагуу К аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 96 тоот албан бичгээр К аймаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд "Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах" тухай шүүгчийн захирамжийг түр түдгэлзүүлнэ үү гэж хүргүүлэн шүүгчийн захирамжийг албан бичгээр залруулан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн нэг Н.Г-гийн нас барсан хэрэгт Б.М шүүгчийн төрсөн ах Б.Б нь Эрүүгийн сэжигтэн ялагдагчаар шалгагдаж байгаа бөгөөд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91-р зүйлийн 91.1.2, 91.1.3-д заасан үндэслэл байх тул шүүгч Б.М-г энэхүү үндэслэлээр Ж.Д-ийн нэхэмжлэлтэй М.О холбогдох тамга, гэрчилгээ гаргуулах нэхэмжлэлтэй иргэний хэрэгт татгалзсан татгалзлыг хүлээн авч Ш аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд шилжүүлсэн. Харин шүүгч Б.М энэ үндэслэлээр яагаад өөрөө татгалзан гарахгүй байгааг ойлгохгүй байна

К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ц.О, шүүгч Б.М, шүүгч С.О нарын нэг хариуцагч, нэг нэхэмжлэгчтэй хэргийг хянан шийдвэрлэхдээ гаргаж байгаа ёс зүйн зөрчлүүдийн талаар:

Шүүгч Ц.О, шүүгч Б.М нар нь 2017 оноос хойших хэргүүдийг хүлээн авч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж байгаа ба эдгээр шүүгч нараас өмгөөлөгч Ж.Э татгалзахгүй байгаа нь өмгөөлөгч Ж.Э-ээс хамаарал бүхий нөхцөл бүрдсэн гэж үзэх үндэслэл байна.

Өмнө нь "ЛЛЛ" ХХК-д холбогдох 2 иргэний хэрэгт шүүгч Ц.О, шүүгч Б.М нар өөрсдөөсөө татгалзсан татгалзлыг хүлээн авч Ж аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх, Ш аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхүүдэд шилжүүлэн шийдвэрлэсэн. Татгалзлыг гаргасан үндэслэл нь:

1.Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн нэг Н.Г нас барсан хэрэгт Б.М шүүгчийн төрсөн ах Б.Б нь Эрүүгийн сэжигтэн ялагдагчаар шалгагдаж байгаа бөгөөд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91-р зүйлийн 91.1.2, 91.1.3-д заасан үндэслэл байх тул шүүгч Б.М-г энэхүү үндэслэлээр Ж.Д-гийн нэхэмжлэлтэй М.О-д холбогдох тамга, гэрчилгээ гаргуулах нэхэмжлэлтэй

иргэний хэрэгт татгалзсан татгалзлыг хүлээн авч Ш аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд шилжүүлсэн.

Харин шүүгч Б.М энэ үндэслэлээр яагаад өөрөө татгалзан гарахгүй нэхэмжлэлийг хүлээн авч ажиллагаа явуулж байгаа, хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж шийдвэр гаргах гээд 4 дэх удаагаа шүүх хуралдаан зарлаж байгаа нь ашиг сонирхлын зөрчил үүсгэж байна.

2.62 иргэний нэхэмжлэлтэй “ЛЛЛ” ХХК-ийн хувьцаа эзэмшигчээр тогтоолгох тухай иргэний хэрэгт К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн бүх шүүгчдийг буюу шүүгч Ц.О, шүүгч Б.М нарыг хариуцагч Н.Э, Ж.Д, н.Б /Н.Г-гийн эхнэр/, тэдгээрийн өмгөөлөгч Ж.Э нар шүүх хуралдаан дээр К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн бүх шүүгчдийг татгалзан гаргах хүсэлтийг 2017 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 153/ЭТ2017/00014 дугаар тогтоолоор хангаж шийдвэрлэсэн.

Түүнчлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байсан Н.Г-гийн эхнэр н.Б-гийн өмгөөлөгч Ж.Э нь 62 иргэний нэхэмжлэлтэй “ЛЛЛ” ХХК-ийн хувьцаа эзэмшигчээр тогтоолгох тухай иргэний хэрэгт оролцож, татгалзах хүсэлт гаргасан бөгөөд дээрх үндэслэлээр одоо эдгээр хэргүүдэд шүүгч Ц.О, шүүгч Б.М нарыг татгалзан гаргахгүй байгаа нь К аймгийн Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчид өмгөөлөгч Ж.Э-гийн хүсэлтээс хамаарал бүхий болсон гэдэг үндэслэл, эргэлзээг төрүүлж байна.

К аймаг дахь Сум дундын иргэний анхан шатны шүүхэд шинээр 5 төрлийн нэхэмжлэл үүссэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад байгаа бөгөөд эдгээр хэргүүдэд шүүгч Ц.О, шүүгч Б.М, шүүгч С.О нарын шүүгчийн мэргэжлийн болон ёс зүйн зөрчлийг удаа дараа гаргаж байна. ... Шүүгч Б.М нь 62 хүний нэхэмжлэлтэй хэргийг өөр аймаг руу шилжүүлдэг атлаа Н.Э-гийн нэхэмжлэлтэй 66.700.000 төгрөгийн нэхэмжлэлтэй хэргийг шийдвэрлэх гээд улайраад байгаа нь М.О миний нэхэмжлэлтэй хэргийг хугацаанд нь шийдвэрлэхгүй байгаа нь шударгаар хэргийг шийдвэрлэхэд эргэлзээ төрүүлж байна.

... Нэгтгэх хүсэлтийг шүүгч Ц.О хангаж шийдвэрлэлээ гэсэн боловч шүүгчийн захирамж гардуулахдаа татгалзаж шийдвэрлэсэн байна.

Шүүгч Ц.О, шүүгч Б.М нарыг хариуцагч М.О би Үндсэн хууль бусад хуулийг дээдлэх үзлээс татгалзсан шүүгч гэж энэхүү гомдлыг гаргав. ...Эрхэлсэн ажилдаа мэргэжлийн алдаа дутагдлыг удаа дараа гаргасан дээрх шийдвэр, захирамж, магадлал, тогтоол болон хэргийн материалыг татан авч хянан үзээд гомдол гаргагч ЛЛЛ ХХК-ийн захирал М.О надад албан ёсоор хариу бичгээр өгнө үү.” гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хороонд шүүгч Ц.О ирүүлсэн тайлбартаа “К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ц.О би иргэн М.О Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан гомдолтой танилцаад дараах тайлбарыг гаргаж байна.

К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд ЛЛЛ ХХК-тай холбоотой арваад иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа бөгөөд намайг 2014 онд шүүгчээр томилогдон ажилласнаас хойш ЛЛЛ ХХК-тай холбоотой 3 хэрэг хуваарилагдсан ба гомдол гаргагч М.О нь хариуцагчаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байсан. Үүнд:

Шүүгч миний бие Б.Э-гийн нэхэмжлэлтэй, хариуцагч ЛЛЛ ХХК-д холбогдох тээврийн хөлс 11,256,000 төгрөг, алданги 5,625,000 төгрөг гаргуулахыг хүссэн иргэний хэрэгт нэхэмжлэлийн шаардлагаас 11,256,000 төгрөгийг хангаж, алданги 5,625,000 төгрөгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн /2015 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 348/А дугаартай К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр баримтаар / Энэхүү шийдвэрт нэхэмжлэгч тал давж заалдах гомдол гаргасны дагуу хэлэлцэгдэж, ШЖК аймгийн иргэний хэргийн

давж заалдах шатны шүүхийн 2016 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 14 тоот магадлалаар 16,881,000 төгрөгийг гаргуулж анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан. Хариуцагч тал хяналтын шатны шүүхэд гомдол гаргасан ба 2016 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 001/ХТ2016/00420 дугаартай Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны тогтоолоор магадлал шийдвэрийг тус тус хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцаасан. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хариуцагч М.О буюу ЛЛЛ ХХК нь нийт 5,812,951 төгрөгийг нэхэмжлэгч Б.Э-д олгосон байсан ба дахин хэлэлцүүлж шүүгч би нэхэмжлэлийн шаардлагаас 5 449 049 төгрөгийг нэхэмжлэгчид олгуулах, алданги 5 625 000 төгрөгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. /2016 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 153/ШШ2016/00374 дугаар К аймаг дахь Сум дундын анхан шатны шүүхийн шийдвэр баримтаар/ Энэ шийдвэрт М.О давж заалдах гомдол гаргасан ба К аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 111 тоот магадлалаар хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хариуцагч М.О нь 11 256 000 төгрөгийг нэхэмжлэгч талд төлсөн учраас нэхэмжлэгч Б.Э нь нэхэмжлэлээ буцаан авсан. Б.Э-гийн нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэх ашиг сонирхол байсан гэж өмгөөлөгч н.Э болон тус хэргийн хариуцагч байсан М.О гомдолдоо дурджээ. Шүүгч Ц.О миний бие нь 2 удаа нэхэмжлэлийн шаардлагаас үндсэн мөнгө болох 11 256 000 төгрөгийг хангаж, алданги 5 625 000 төгрөгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байгаа нь хавсаргасан баримтаас харагдана. Давж заалдах шатны шүүх нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангаж миний шийдвэрт өөрчлөлт оруулсан байгаа бөгөөд хариуцагч М.О нь нэхэмжлэгч Б.Э-гийн нэхэмжилсэн төгрөгийг алдангийн хамт бүрэн төлж барагдуулсан тул нэхэмжлэгч нэхэмжлэлээ буцаан авах хүсэлтийг гаргаж шүүгч миний бие 2017 оны 01 сарын 09-ний өдөр нэхэмжлэлийг буцаан авах тухай 153/ШЗ2017/00114 тоот захирамжийг гаргасан./ баримтуудыг хавсаргав.

Н.Э-гийн нэхэмжлэлтэй ЛЛЛ ХХК-ийн захирал М.О-д холбогдох ЛЛЛ ХХК-ийн захирлын 2015 оны 10 дугаар сарын 26-ний өдрийн 51 дүгээр тушаалыг хүчингүй болгуулах тухай иргэний хэргийг хянан хэлэлцэж 2016 оны 02 дугаар сарын 25-ны өдөр хэргийг хэрэгсэхгүй болгох тухай 153/ШЗ2016/00477 дугаартай шүүгчийн захирамжийг гаргасан. Захирамжийг гаргах болсон үндэслэл нь хариуцагч М.О-гийн К аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэгч н.А-гийн 2015 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 01 дугаартай мэдэгдлийг хүчингүй болгуулахаар хариуцагч М.О-гийн талаас К дахь Захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргасан ба хэрэг түдгэлзсэн, мөн К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Д.К-гийн түдгэлзүүлсэн ЛЛЛ ХХК-ийн өмчлөгчтэй холбоотой маргаан шийдэгдтэл энэ хэргийг шийдвэрлэх боломжгүй гэх М.О-гийн тайлбар болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.7-д зааснаар зохигчийн маргаж байгаа зүйл ба түүний үндэслэлийн талаарх өөр хэргийг шүүх шийдвэрлэж байгаа үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Нэхэмжлэгчийн өмгөөлөгч Ж.Э хэргийг хэрэгсэхгүй болгох тухай 153/ШЗ2016/0047 тоот захирамжийг нэхэмжлэгч Н.Э гардаж аваагүй, өмгөөлөгч Ж.Э 2016 оны 03 дугаар сарын 09-нд гардаж авсан, 2016 оны 3 дугаар сарын 08-ний өдөр нь бүх нийтийн амралтын өдөр байсан тул хугацааг сэргээж гомдлыг хүлээн авах хүсэлтийг шүүхэд гаргасан /2016 оны 3 сарын 09-ний өдрийн хүсэлт баримтаар/ Шүүгч би дээрх хүндэтгэн үзэх шалтгааныг харгалзан хүсэлтийг хангаж, гомдол гаргах хугацааг сэргээх тухай захирамжийг гаргасан. /153/ШЗ2016/00622 дугаартай К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамж баримтаар/

Шүүгч би өөрийн шийдвэрийг хэвээр хадгалах хүрээнд гомдол гаргах хугацааг сэргээхгүй байх байсан. Иргэдийн гомдлыг шийдвэрлүүлэх эрхийг хангасан нь Үндсэн хуулиар олгосон эрхийг хангаж буюу шударга шүүхээр шүүлгэх эрхийг илүү хангасан гэж үзэж байна. Шүүгч миний бие талуудад тэгш хандсан. Гомдлыг хэлэлцээд К аймаг дахь О сумын Сум дундын анхан шатны шүүх хүчингүй болгосон тул хэргийг шүүгч би хянан хэлэлцэж, 2016 оны 05 дугаар сарын 23-ны өдөр 153/ШШ2016/00248 дугаартай шийдвэрийг гаргасан ба шийдвэрт хариуцагч М.О давж заалдсаныг Ч аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 01 дугаартай магадлалаар 153/ШШ2016/00248 дугаартай анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэсэн байдаг.

Нэхэмжлэгч Н.Э нь Ч аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалыг эс зөвшөөрч Улсын Дээд шүүхэд гомдол гаргасан байдаг.

2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны тогтоолоор Ч аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 01 дүгээр магадлалыг хүчингүй болгож, К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 153/ШШ2016/00248 дугаар шийдвэрийн тогтоох хэсгийн 1 дэх заалтаас Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх хэсэгт гэснийг хасч, шийдвэрийн бусад хэсгийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.

Н.Э, Ж.Д нарын нэхэмжлэлтэй М.О, Д.Ц нарт холбогдох менежерийн цалин 34,000,000 төгрөг гаргуулах тухай иргэний хэргийг хүлээн авч иргэний хэрэг үүсгэсэн ба 2017 оны 9 дүгээр сарын 27-29-ны өдрийн Ц-д болох иргэний шүүгч нарын сургалт, мөн цааш үргэлжлүүлэн ээлжийн амралтаа авч байгаа тул шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор хэргийг өөр шүүгчид хуваарилагдсан байгаа болно. Хариуцагч М.О, өмгөөлөгч М.Э нар нь Ж.Д, Н.Э нарын нэхэмжлэлтэй М.О-г захирлаар цалинжуулсан 108,000,000 төгрөг гаргуулах тухай иргэний хэрэгт Д.Ц-г менежерээр цалинжуулсан 34,000,000 төгрөг гаргуулах тухай иргэний хэргүүдийг нэгтгүүлэх хүсэлтийг гаргасан ба тус шүүхэд гаргасан нэхэмжлэгч Ж.Д, Н.Э нарын гаргасан нэхэмжлэлтэй иргэний хэргүүд нь тус бүрдээ өөр, өөр хариуцагчтай байна гэсэн үндэслэлээр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.3-т заасан хуулийн шаардлагыг хангаагүй тул хүсэлтийг хангахаас татгалзаж шийдвэрлэсэн Иргэн М.О, түүний өмгөөлөгч М.Э нарын Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан гомдлын шүүгч Ц.О надад холбогдуулан гаргасан хэсэгт дараах тайлбарыг гаргаж байна.

Нэг. Шүүгч Б.М, Ц.О нар К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний 2017 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 153/ЭТ2017/00014 дугаартай тогтоол гаргаж хэн нэгэн хамт ажилладаг хүнээс хамаарч хэргийг шударга бусаар шийдвэрлэнэ гэдгээ өөрсдөө хүлээн зөвшөөрсөн энэхүү үйлдэл нь шүүгч хүнд байх боломжгүй ёс зүйн ноцтой зөрчил гэж үзэж байна гэжээ.

Шүүгч Д.К нь Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Ш аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчээр томилогдоход өв нээгдэх хүртэл үндэслэлээр түдгэлзүүлсэн байсан Ж.Н нарын нэхэмжлэлтэй Х.С нарт холбогдох ЛЛЛ ХХК-ийн хувьцаа эзэмшигчээр тогтоолох тухай иргэний хэрэг шүүгчдийн зөвлөгөөний тогтоолын дагуу хуваарилагдсан. Энэ хэргийг хянан хэлэлцэх шүүх хуралдаан дээр К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн бүх шүүгчдийг татгалзсан татгалзлыг хариуцагч С.Э, эрх залгамжлагч Б.Б, хариуцагч Ж.Д, хариуцагч Н.Э, түүний өмгөөлөгч Ж.Э нар гаргасан бөгөөд хүсэлтийг тус шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөр хянан хэлэлцэж

К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний 2017 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 153/ЭТ2017/00014 дугаартай тогтоолоор хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн. /тогтоолыг хавсаргав/ Шүүгчийг татгалзсан татгалзал нь үндэслэлтэй байна гэж шүүгчдийн зөвлөгөөнөөр үзсэн тул хариуцагч нарын хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн.

Шүүгч Б.М шүүгч дээр хуваарилагдсан Н.Э-гийн нэхэмжлэлтэй, хариуцагч М.О-д холбогдох 66.700.000 төгрөг гаргуулах тухай иргэний хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд гомдол гаргагч М.О, өмгөөлөгч М.Э нарын гаргасан татгалзан гарах үндэслэлүүд нь хуулийн үндэслэлгүй байх тул шүүгчдийн зөвлөгөөнөөс К аймаг дахь анхан шатны шүүхийн бүх шүүгчдийг татгалзан гаргах хүсэлтийг хангахаас татгалзаж шийдвэрлэсэн. /2017 оны 09 сарын 04-ний өдрийн 153/ЭТ2017/00136 дугаартай К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний тогтоол баримтаар/

Хоёр. Шүүгч Ц.О, Б.М нар нь 2017 оноос хойших хэргүүдийг хүлээн авч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж байгаа ба эдгээр шүүгч нараас өмгөөлөгч Ж.Э нь татгалзахгүй байгаа нь өмгөөлөгч Ж.Э-ээс хамаарал бүхий нөхцөл бүрдсэн гэж үзэх үндэслэл байна гэжээ.

Шүүгч надад 2017 оноос хойш М.О-д холбогдох нэхэмжлэгч Ж.Д нарын нэхэмжлэлтэй менежерийн цалин хөлс 34,000,000 төгрөг гаргуулах тухай иргэний хэрэг хуваарилагдсан. Ц-д болох шүүгчдийн сургалт болон ээлжийн амралтаас шалтгаалж уг хэрэг зөвлөгөөний тогтоолоор өөр шүүгчид хуваарилагдсан. Гомдол гаргагч М.О-той холбоотой өөр иргэний хэрэг байхгүй ба 2015-2016 онд над дээр хуваарилагдсан хэргүүд эцэслэн шийдэгдсэн болно. Миний бие нь тус шүүхэд Ерөнхий шүүгчийн үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа бөгөөд тус шүүхийн Ерөнхий шүүгчийг томилогдтол К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн ажлыг хэрхэн сайжруулахад анхаарч, ажлын ачааллыг дааж, туршлагатай ахмад шүүгч нараасаа цаг ямагт суралцахыг хичээж, үүрэг хариуцлагаа ухамсарлан ажиллаж ирсэн. Шүүгч бид нарт хэн нэгнээс хараат байдлаар хэрэг хянан шийдвэрлэх эрх байхгүй. Гомдол гаргагч М.О болон өмгөөлөгч М.Э нар нь К аймгийн Хуульчдын холбооны салбар зөвлөлийн зохицуулагч өмгөөлөгч Ж.Э-гээс гомдолд бичсэн шүүгч нараас яагаад татгалзахгүй байгаа тухай асуултыг асуух нь зүйтэй байх. Миний бие нь 2014 онд, шүүгч Б.М нь 2015 онд, шүүгч С.О нь 2017 оны 6 сард шүүгчээр ажиллаж эхэлсэн бөгөөд тус шүүхийн шүүгч нар нь шүүгчийн ёс зүй, үнэнч шударга байдлыг эрхэмлэн хараат бусаар шүүн таслах үйл ажиллагаагаа хэрэгжүүлж, хуулийг дээдэлж ажилладаг. Тус шүүх дээр өнөөдрийн байдлаар гомдол гаргагч М.О-той холбоотой хэргүүд шүүгч Б.М, шүүгч С.О нарт хуваарилагдсан болно.

Өмгөөлөгч М.Э болон гомдол гаргагч М.О нар нь шүүгч биднийг гүтгэж, Ёс зүйн хороонд өгч байгааг шинэ шүүгч нарыг мохоох зорилготой, хэрэг хянан шийдвэрлэхэд шууд бусаар нөлөөлөх оролдлого хийж байна гэж үзэж харамсаж байна. К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн шүүгч Ц.О миний бие нь албан үүргээ хараат бусаар, үйл баримтын талаар хэрэгт авагдсан нотлох баримт өөрийн үнэлэлт дүгнэлтдээ тулгуурлаж, шүүн таслах үйл ажиллагаагаа шударгаар хэрэгжүүлж ирсэн бөгөөд цаашид улам хичээж ажиллах болно. Шүүгч бидэнд алдах эрх байхгүй билээ.

Гурав. К аймаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд холбогдох шүүхийн 41 дүгээр гүйцэтгэх хуудас, шүүхийн 73 дугаар гүйцэтгэх хуудсыг хүчингүй болгуулах, К аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны 2017 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн ХХХ улсын дугаартай Норд бенз маркийн машиныг битүүмжилж Н.Э-д хүлээлгэн өгсөн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хүчингүй болгуулахыг хүссэн нэхэмжлэлийг 2017 оны 06 дүгээр сарын 21-ний өдөр гаргасныг шүүгч

Ц.О-д хуваарилагдлаа гэсэн боловч шүүгч С.О нь ямар нэгэн шилжүүлж авсан баримтгүйгээр 2017 оны 06 дугаар сарын 28-ны өдөр 153/Ш32017/01334 дугаар захирамжаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан. Энэ нь шүүгч Ц.О шүүгч С.О нар нь хамт ажилладаг гэдгээрээ бие биедээ нөлөөлж ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргасан гэж үзэх үндэслэл болж байна гэжээ.

К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 01 дугаартай Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолын дагуу хэргүүдийг шүүгч нарт хуваарилдаг ба гомдолд дурдсан хэрэг С.О шүүгчид хуваарилагдсан, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан захирамж гарсан болохыг гомдлоос уншиж мэдлээ. Дээрх иргэний хэрэг над дээр хуваарилагдаж ирээгүй болно. Шүүгч С.О нь 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн зарлигаар тус шүүхэд шүүгчээр томилогдоод, шинэ шүүгчийн сургалтад суугаад 6 сараас ажилдаа орж, 2017 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 153/ЭТ2017/00067 тоот шүүгчдийн зөвлөгөөний тогтоолын дагуу С.О шүүгчид хэрэг хуваарилж эхэлсэн.

Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.1 дүгээр зүйлийн 3-д “Шүүгч нь бусад шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно” гэж заасан байдаг ба шүүгч миний бие бусад шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөндлөнгөөс оролцож байгаагүй гэдгийг хамт ажиллаж байгаа хамт олон болон бусад шүүгч нар мэднэ. Шүүгч би хуулийг дээдэлж, зарчим барьж ажилладаг.

Шүүгч би Монгол Улсын шүүгчийн ёс зүйг чандлан сахиж, хэрэг маргааныг, Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд нийцүүлэн шийдвэрлэж шударга ёсыг чанд сахин ажиллаж байгаа бөгөөд цаашид ч өргөсөн тангарагтаа үнэнчээр ажиллах болно. Миний бие нь шүүгчийн ёс зүйг зөрчсөн гэж үзэхгүй байна, гомдол гаргагч М.О-д холбогдох хэргүүд 2015-2016 онд эцэслэн шийдэгдсэн болно.

Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанд гаргасан тайлбараа дэмжиж байна. Сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэж өгнө үү” гэв.

Шүүхийн Ёс зүйн хороонд шүүгч Б.М ирүүлсэн тайлбартаа: К аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М би иргэн М.О, түүний өмгөөлөгч М.Э нарын Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан гомдолтой танилцаад дараах тайлбарыг гаргаж байна

К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд ЛЛЛ ХХК-тай холбоотой нэлээд хэд хэдэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа бөгөөд намайг 2015 онд шүүгчээр томилогдон ажилласнаас хойш ЛЛЛ ХХК-тай холбоотой 2 хэрэг хуваарилагдсан. Үүнд:

-Нэг дэх хэрэг нь 2015 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 01 дугаартай Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолын дагуу хуваарилагдсан ЛЛЛ ХХК-ийн нэхэмжлэлтэй М.О-д холбогдох компанийн тамга тэмдэг, улсын бүртгэлийн гэрчилгээ, газар эзэмших эрхийн гэрчилгээ гаргуулахыг хүссэн иргэний хэрэг байсан ба тус хэргийг 2016 оны 03 дугаар сарын 21-ний өдөр хүлээн авч, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж улмаар хариуцагч М.О-гийн тухайн шүүхийн бүх шүүгчдийг татгалзан гаргасан хүсэлтийг Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор хангаж шийдвэрлэсэн тул тус хэргийг Ш аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд шилжүүлсэн.

-Хоёр дахь хэрэг нь 2017 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 01 дугаартай Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолын дагуу хуваарилагдсан нэхэмжлэгч Н.Э-гийн нэхэмжлэлтэй хариуцагч М.О-д холбогдох тээврийн хөлс 66.700.000 төгрөг гаргуулах тухай иргэний хэрэг юм. Тус хэргийг 2017 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 153/2017ШШ/00442 дугаартай шийдвэрээр хянан шийдвэрлэсэн.

Иргэн М.О, түүний өмгөөлөгч М.Э нарын Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан гомдлын надад холбогдуулан гаргасан хэсэгт дараах тайлбарыг гаргаж байна.

Нэг. Шүүгч Б.М, Ц.О нар К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний 2017 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 153/ЭТ2017/00014 дугаартай тогтоол гаргаж хэн нэгэн хамт ажилладаг хүнээс хамаарч хэргийг шударга бусаар шийдвэрлэнэ гэдгээ өөрсдөө хүлээн зөвшөөрсөн энэхүү үйлдэл нь шүүгч хүнд байх боломжгүй ёс зүйн ноцтой зөрчил гэж үзэж байна гэжээ.

Шүүгч Ц.О-д хуваарилагдсан Ж.Н нарын нэхэмжлэлтэй Х.С нарт холбогдох ЛЛЛ ХХК-ийн хувьцаа эзэмшигчээр тогтоолгох тухай иргэний хэрэгт К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн бүх шүүгчдийг татгалзсан татгалзлыг хариуцагч, түүний өмгөөлөгч нар гаргасан бөгөөд хүсэлтийг шүүгчдийн зөвлөгөөнөөр хянан хэлэлцэж К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний 2017 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 153/ЭТ2017/00014 дугаартай тогтоолоор хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн.

Шүүгчийг татгалзсан татгалзал нь үндэслэлтэй байна гэж шүүгчдийн зөвлөгөөнөөр үзсэн тул хангаж шийдвэрлэсэн бөгөөд хэрэв тус тогтоолыг хүлээн зөвшөөрөхгүй байгаа бол тухайн үедээ гомдол гаргаагүй атлаа одоо яагаад гомдол гаргаж байгааг ойлгохгүй байна.

Хоёр.ЛЛЛ ХХК-ийн хувьцаа эзэмшигч Н.Г-гийн нас барсан хэрэгт шүүгч Б.М-ийн ах Б.Б нь сэжигтнээр шалгагдаж, энэхүү үндэслэлээр Ж.Д-гийн нэхэмжлэлтэй М.О-д холбогдох тамга, гэрчилгээ гаргуулах тухай нэхэмжлэлтэй иргэний хэрэгт татгалзсан татгалзлыг хүлээн авч Ш аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд шилжүүлсэн. Харин шүүгч Б.М энэ үндэслэлээр яагаад өөрөө татгалзан гарахгүй байгааг ойлгохгүй байна гэжээ.

ЛЛЛ ХХК-ийн нэхэмжлэлтэй М.О-д холбогдох компанийн тамга тэмдэг, улсын бүртгэлийн гэрчилгээ, газар эзэмших эрхийн гэрчилгээ гаргуулахыг хүссэн иргэний хэрэг нь тус шүүхийн хэрэг хуваарилах журам, шүүгчдийн зөвлөгөөний тогтоолын дагуу надад хуваарилагдан ирсэн ба тус хэрэгт миний бие хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсан. Улмаар хариуцагч М.О нь “ЛЛЛ ХХК-ийн хувьцаа эзэмшигч Н.Г-гийн нас барсан хэрэгт шүүгч Б.М-ийн ах Б.Б нь сэжигтнээр шалгагдаж байгаа тул илтгэгч шүүгч Б.М-ээ, мөн ... тус шүүхийн бүх шүүгчдээс татгалзаж байна” хэмээн хүсэлт гаргасныг К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөний 2016 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 66 дугаар тогтоолоор хангаж шийдвэрлэсэн.

Б.М миний ах Б.Б нь ЛЛЛ ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байсан Н.Г-ээр өөрийн оффист засвар хийлгэж байгаад үйлдвэрлэлийн осол гарч улмаар Н.Г нь нас барсан. Энэ ослоос болж миний ах Б.Б нь эрүүгийн хэрэгт сэжигтнээр татагдаж, шалгагдаж байсан нь үнэн. ЛЛЛ ХХК-ийн нэхэмжлэлтэй М.О-д холбогдох компанийн тамга тэмдэг, улсын бүртгэлийн гэрчилгээ, газар эзэмших эрхийн гэрчилгээ гаргуулахыг хүссэн иргэний хэрэг нь тэр үед хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байсан ба манай ах Б.Б-г шалгаж байсан асуудал эцэслэн шийдвэрлэгдээгүй байсан. Иймд тус шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөнөөр хэлэлцээд М.О-гийн гаргасан шүүгчийн татгалзлыг хүлээн авсан.

Харин К аймгийн Прокурорын газрын 2016 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 5/93 дугаартай Прокурорын тогтоолоор миний ах Б.Б нь ЛЛЛ ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байсан Н.Г-гийн нас барсан шалтгаанд холбогдолгүй болох нь тогтоогдож, түүнд холбогдох эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон Прокурорын тогтоол хүчин төгөлдөр болсон. Энэхүү тогтоолыг би ах Б.Б-д Прокурорын газраас гардуулсан тогтоолын хувийг авч тайлбарт хавсарган хүргүүлээ.

Нэгэнт манай ах Б.Б нь ЛЛЛ ХХК-ийн хувьцаа эзэмшигч Н.Г-гийн нас барсан шалтгаанд холбогдолгүй нь тогтоогдсон тул энэхүү үндэслэлээр надад болон ЛЛЛ ХХК-д холбогдох хэргийн зохигч нарт шүүгчийг татгалзах үндэслэлгүй болохгүй.

Гурав. Шүүгч Ц.О, Б.М нар нь 2017 оноос хойших хэргүүдийг хүлээн авч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж байгаа ба эдгээр шүүгч нараас өмгөөлөгч Ж.Э нь татгалзахгүй байгаа нь өмгөөлөгч Ж.Э-ээс хамаарал бүхий нөхцөл бүрдсэн гэж үзэх үндэслэл байна гэжээ.

Миний бие хэнээс ч хараат бусаар, шударгаар, хуулийг дээдлэн, өргөсөн тангаргаа ямагт санаж, шүүн таслах ажиллагааг ямагт илүү чухал гэдгийг ухамсарлаж ажиллаж байна. Шүүгч бид нарт хэн нэгнээс хараат байдлаар хэрэг хянан шийдвэрлэх эрх байхгүй. Хэрэв хэн нэгнээс хамаарал бүхий ажиллах бол шүүгч байгаад яах юм бэ. Гомдол гаргагч, өмгөөлөгч М.Э нь энэхүү гомдлоо гаргахдаа үндэслэлтэй, нотолгоотой, баримт дээр үндэслэн үндэслэлтэй зүйл бичих хэрэгтэй. Өмгөөлөгч М.Э нь хуульч хүн. Тэрээр шүүн таслах ажиллагаанд хүндэтгэлтэй хандаж, хуульчийн ёс зүй, өмгөөлөгчийн ёс зүйг чанд баримтлан ажиллах үүрэгтэй. Ийм ёс зүйгүй, шүүгчийн нэр төрд халдсан үйлдлийг шүүгч миний зүгээс тэвчихгүй.

Дөрөв. М.О-гийн нэхэмжлэлтэй Н.Э-д холбогдох Норд бенз ХХХ улсын дугаартай автомашиныг хууль бус эзэмшлээс гаргуулж, М.О-г эзэмшигчээр тогтоолгох тухай нэхэмжлэл, Х.С-ийн нэхэмжлэлтэй Ж.Д-д холбогдох Норд бенз маркийн ХХХ улсын дугаартай автомашиныг хууль бус эзэмшлээс гаргуулж, Х.С-г эзэмшигчээр тогтоолгох тухай нэхэмжлэлтэй иргэний хэргийг шүүгч Б.М иргэний хэрэг үүсгээд өнөөдрийг хүртэл шүүх хуралдааныг зарлаагүй атлаа Н.Э-гийн нэхэмжлэлтэй М.О-д холбогдох 66,700,000 төгрөг гаргуулах тухай иргэний хэргийн шүүх хуралдааныг зарлаж, хэргийг шийдвэрлэх гээд улайраад байгаа гэжээ.

К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 01 дугаартай Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолын дагуу шүүгч Б.М надад М.О-гийн нэхэмжлэлтэй Н.Э-д холбогдох Норд бенз ХХХ улсын дугаартай автомашиныг хууль бус эзэмшлээс гаргуулж, М.О-нг эзэмшигчээр тогтоолгох тухай нэхэмжлэл, Х.С-ийн нэхэмжлэлтэй Ж.Д-д холбогдох Норд бенз маркийн ... ХХХ улсын дугаартай автомашиныг хууль бус эзэмшлээс гаргуулж, Х.С-г эзэмшигчээр тогтоолгох тухай нэхэмжлэл тус тус хуваарилагдан ирсэн ба хоёуланд нь иргэний хэрэг үүсгэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн зарлигаар тус шүүхэд шүүгчээр С.О шүүгч томилогдож, тус шүүхийн шүүгч нарын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор шүүгч нарт өмнө хуваарилагдсан хэргүүдийг ирсэн огноо, цагаар жагсаан хувааж, 2017 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 15Э/ЗТ2017/00067 дугаартай Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолын дагуу шүүгч С.О-д хэрэг хуваарилсан. Энэхүү тогтоолын дагуу шүүгч Б.М надад өмнө хуваарилагдсан Х.С-ийн нэхэмжлэлтэй хариуцагч Ж.Д-д холбогдох Норд бенз маркийн ... ХХХ улсын дугаартай автомашиныг хууль бус эзэмшлээс гаргуулж, Х.С-г эзэмшигчээр тогтоолгох тухай иргэний хэрэг, нэхэмжлэгч М.О-гийн нэхэмжлэлтэй хариуцагч Н.Э-д холбогдох Норд бенз маркийн ХХХ улсын дугаартай автомашиныг хууль бус эзэмшлээс гаргуулж, М.О-г эзэмшигчээр тогтоолгох тухай иргэний хэргүүд шүүгч С.О-д хуваарилагдсан /Энэхүү шүүгчдийн зөвлөгөөний тогтоолыг хавсаргав/.

Иймд эдгээр хэргүүдэд өөр шүүгч ажиллагаа явуулж байгаа болно. Гомдол гаргагч М.Э нь эдгээр хэргүүд нь шүүгч Б.М над дээр байхгүй байгааг мэддэг, 2017 оны 05 дугаар сард өөр шүүгчид шилжээд, өөр шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж байгааг мэддэг атлаа яагаад намайг энэ хэргийг “шийдвэрлэхгүй байна” гэж бичээд байгааг ойлгохгүй байна. Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.1 дүгээр зүйлийн 3-д “Шүүгч нь бусад шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно” гэж заасан байдаг.

Мөн шүүгч Б.М надад 2017 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 01 дугаартай Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолын дагуу хуваарилагдсан нэхэмжлэгч Н.Э-гийн нэхэмжлэлтэй хариуцагч М.О-д холбогдох тээврийн хөлс 66,700,000 төгрөг гаргуулах тухай иргэний хэргийг миний бие Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1-д заасан “нотлох баримт хангалттай бүрдсэн, эсвэл хэргийн хугацаа дууссан тохиолдолд хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай шүүгчийн захирамж гаргана” гэж заасан тул тус хэргийн хугацаа дууссан учир шүүх хуралдааныг товлон зарлаж, шүүх хуралдааныг хийсэн.

Энэхүү иргэний хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай шүүгчийн захирамж гарснаас хойш зохигчдын хүсэлтээр шүүх хуралдаан 4 удаа хойшилж, хэргийг 2017 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр шийдвэрлэсэн. Шүүх хуралдаан дээр хариуцагч М.О, түүний өмгөөлөгч М.Э нар нь илтгэгч шүүгч намайг болон К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн бүх шүүгчдийг ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэж татгалзан гаргах хүсэлт гаргасан бөгөөд татгалзан гаргах хүсэлтийг хангахаас татгалзаж шийдвэрлэсэн. Учир нь Ашиг сонирхлын зөрчил гэдэг нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д зааснаар нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед түүний хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдал үүсэхийг ойлгоно. Гэтэл энэхүү нөхцөл байдал үүссэн эсэх талаар баримт хүсэлтэд авагдаагүй байсан.

Эцэст нь хэлэхэд миний бие Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар томилогдож, Монгол улсын Шүүгчийн тангараг өргөж энэхүү албан тушаал дээр томилогдсоноос хойш 1 жил 10 сар ажиллаж байна. Миний хувьд аливаад хүлээцтэй хандаж, хэрэг, маргааныг зөвхөн Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд нийцүүлэн шийдвэрлэж, шүүгчийн ёс зүйн дүрэм, шударга ёсыг чанд сахиж ажиллаж байгаа бөгөөд цаашид ч сахин ажилласаар байх болно.” гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанаар хэлэлцээд ҮНДЭСЛЭХ нь

Шүүхийн Ёс зүйн хороонд өмгөөлөгч М.Э, “ЛЛЛ” ХХК-ийн захирал М.О нар нь К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн үүрэг гүйцэтгэгч Ц.О, шүүгч Б.М нарт холбогдуулан шүүгчийн ёс зүйн зөрчил гаргасан гэсэн гомдлыг гаргажээ.

Нэг. Нэхэмжлэгч Б.Э-гийн нэхэмжлэлтэй “ЛЛЛ” ХХК-д холбогдох иргэний хэрэгт хариуцагч М.О, түүний өмгөөлөгч Н.О нар нь хариуцагч М.О-гийн дүү Б.Н ШЖК аймгийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч бөгөөд нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч “шүүхэд М.Н шүүгч нөлөөлөөд байгаа тул хэргийг үнэн зөвөөр шийдвэрлэнэ гэж итгэхгүй байгаагаа хэлсэн” тул Иргэний хуулийн 91- р зүйлийн 91.1.3-д заасан үндэслэлээр К аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ц.О болон бусад бүх шүүгчээс татгалзан гаргах хүсэлтийг гаргажээ. Шүүгч Ц.О, Б.М, Д.К нарын бүрэлдэхүүн нь К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2015 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 43 дугаар тогтоолоор уг татгалзан гаргах хүсэлтийг хүлээн авахаас татгалзаж, үүнийхээ үндэслэлийг тайлбарлахдаа “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.1.3-д заасан үндэслэл тогтоогдохгүй байна. ШЖК аймгийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч М.Н нь К аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд ажилладаггүй мөн дээрх хэргийг хянан шийдвэрлэхдээ нөлөөлсөн талаар ямар нэгэн баримтаар тогтоогдоогүй” гэжээ.

Ж.Н нарын нэхэмжлэлтэй Х.С нарт холбогдох ЛЛЛ ХХК-ийн хувьцаа эзэмшигчээр тогтоолгох тухай” иргэний хэрэгт хариуцагч С.Э, Н.Э, Б.Б /эрх залгамжлагч/, Ж.Д, өмгөөлөгч Ж.Э нар нь “хариуцагч М.О бусад хариуцагч нараас эсрэг сонирхолтой байгаа,” “хариуцагч М.О-гийн төрсөн дүү М.Н К аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн иргэний хэргийн шүүгчээр ажилладаг” бөгөөд “шүүгч М.Н нь ...шүүгч Ц.О болон К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх, шүүх бүрэлдэхүүнд нөлөөлөх, түүнчлэн уг хэргийг шударгаар шийдвэрлэх эргэлзээ байвал татгалзах хуулийн заалтын дагуу татгалзаж байна” гэжээ. Шүүгч Ц.О, Б.М нарын бүрэлдэхүүн нь К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 152/ЗТ2017/00014 дугаар тогтоолоор уг татгалзан гаргах хүсэлтийг хүлээн авчээ. Энэ тогтоолынхоо үндэслэх хэсэгт “Хариуцагч М.О-гийн төрсөн дүү М.Н нь К аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд иргэний шүүгчээр томилогдож, К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нартай нэг байгууллагад буюу шүүхийн нэг Тамгын газарт харьяалагдан ажил хэргийн хувьд байнгын харилцаатай, анхан шатны шүүхийн шүүгч нарын шийдвэрлэсэн иргэний хэргийг хянан магадалж ажилладаг.

Хариуцагч С.Э, Н.Э, Б.Б /эрх залгамжлагч/, Ж.Д, өмгөөлөгч Ж.Э нар нь К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн бүх шүүгчдийг Ж.Н нарын нэхэмжлэлтэй Х.С нарт холбогдох ЛЛЛ ХХК-ийн хувьцаа эзэмшигчээр тогтоолгох тухай” иргэний хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар эргэлзэж байх тул Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.3-д заасан “уг хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал” гэсэн үндэслэлээр” уг шүүхийн бүх шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг хүлээн авч хангажээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 14-т “шударга шүүхээр шүүлгэх” үндсэн эрхийг иргэн бүр баталгаатай эдэлнэ гэж заасан. Шударга шүүхээр шүүлгэх эрхийн нэг чухал элемент бол аливаа этгээд хэрэг, маргаанаа төвийг сахисан шүүгчээр шүүлгэх явдал юм. Тийм учраас, шүүгч төвийг сахихгүй эсхүл хувийн сонирхолтой хэргийг шийдвэрлэхгүй байх баталгааг хангах үүднээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91-р зүйлд дараах заалтыг оруулсан, 91.1.Шүүгч дараах үндэслэл байвал хэрэг хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй: 91.1.1.урьд нь уг хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, эвлэрүүлэн зуучлагч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрчийн хувиар оролцсон; 91.1.2.Уг хэргийн болон шүүх хуралдааны оролцогчийн гэр бүл, төрөл, садан бол, эсхүл шүүх бүрэлдэхүүнд хоорондоо гэр бүлийн болон төрөл, садангийн холбоотой хүмүүс орсон байвал; 91.1.3.Хэргийн оролцогчтой хувийн харилцаатай, түүнчлэн уг хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал; 91.1.4.ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдал бий болсон бол.

Эдгээр үндэслэлүүд нь тухайн шүүгч эсхүл зохигч талын санаа бодол гэхээс илүү тухайн нөхцөл байдлыг бүгдийг нь мэдсэн жирийн хүнд шүүгч татгалзвал зохих нөхцөл байдал гэж ойлгогдох үндэслэл байгаа байдал буюу объектив стандартыг илэрхийлдэг. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91.2-т “Энэ хуулийн 84 дүгээр зүйл, 91.1-д зааснаас бусад үндэслэлээр шүүгчийг татгалзаж үл болно” гэж заасан нь уг хуулийн 84 дүгээр зүйл, 91.1-т объектив стандарт агуулагдаж байгааг төдийгүй уг стандартыг хангаснаас бусад тохиолдолд эс татгалзах шаардлагыг илэрхийлдэг. Хэргийг төвийг сахиж, шударгаар шийдвэрлэж чадах эсэхэд жирийн иргэн эргэлзэх үндэслэл байгаагаас бусад тохиолдолд шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарах ёсгүй юм. Тухайн хэргийг

төвийг сахиж, шударгаар шийдвэрлэх эргэлзээ нь үндэслэлгүй байхад татгалзан гарах ёсгүй. Мөн, хэрэг нь хэцүү эсхүл маргаантай гэсэн төдийд ч татгалзан гарах ёсгүй юм. Энэ мэт шалтгаар эсхүл үндэслэл байхгүй байхад татгалзан гарах нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохисгүйгээр удаашруулах, талуудыг чирэгдүүлэх, бусад шүүгчдийн ажлын ачааллыг нэмэгдүүлэх, хүссэн шүүгч дээрээ хэргээ аваачуулах сэдлийг нэмэгдүүлэх аюултай.

Шүүгч Ц.О, Б.М нар “хариуцагч С.Э, Н.Э, Б.Б /эрх залгамжлагч/, Ж.Д, өмгөөлөгч Ж.Э нар нь К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн бүх шүүгчдийг Ж.Н нарын нэхэмжлэлтэй Х.С нарт холбогдох ЛЛЛ ХХК-ийн хувьцаа эзэмшигчээр тогтоолгох тухай” иргэний хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар эргэлзэж байгаа” төдийгөөр тус шүүхийн бүх шүүгчээс татгалзан гаргах хүсэлтийг хүлээн авсан нь объектив стандартаар бус харин эдгээр оролцогчдын санаа бодлоор шийдсэнийг харуулж байна. Шүүгч Ц.О, Б.М нар “Хариуцагч М.О-гийн төрсөн дүү М.Н нь К аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд иргэний шүүгчээр томилогдож, К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нартай нэг байгууллагад буюу шүүхийн нэг Тамгын газарт харьяалагдан ажил хэргийн хувьд байнгын харилцаатай, анхан шатны шүүхийн шүүгч нарын шийдвэрлэсэн иргэний хэргийг хянан магадалж ажилладаг” гэж үзсэнийг үндэслэлтэй гэж хүлээн зөвшөөрөх боломжгүй байна. Учир нь, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91.1-д заасан объектив стандартыг дараах үндэслэлээр хангаагүй байна

Шүүгч Ц.О, Б.М нарынхаар бол хэн нэг зохигчийн гэр бүл, төрөл, садан (төрсөн ах, эгч, дүү зэрэг)-гийн хүн нэг шүүхэд шүүгчээр ажилладаг бол уг шүүхийн бусад шүүгчээр ч хэргээ шийдвэрлүүлэх боломжгүй болно. Жишээ нь, К аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх болон К аймаг дахь Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхтэй адилхан нэг тамгын газар бүхий анхан болон давж заалдах шатны шүүхүүдийн аль нэг шүүгчийн гэр бүл, төрөл, садангийн хүн уг шүүхийн бусад шүүгчээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлэх боломжгүй болно. Мөн, шүүгч нь анхан, давж заалдах болон хяналтын шатны аль нэг шүүхэд бусад шүүгчидтэй хамтран ажилладаг тул тэдгээр шүүгчийн аль нэгэнтэй гэр бүл, төрөл, садангийн харилцаатай хүн хэргээ шийдвэрлүүлэх боломжгүй болно.

“Анхан шатны шүүхийн шүүгч нарын шийдвэрлэсэн иргэний хэргийг хянан магадалж ажилладаг” гэсэн үндэслэлээр анхан шатны шүүхийн шүүгч тухайн давж заалдах эсхүл хяналтын шатны шүүхийн шүүгчтэй гэр бүл, төрөл, садангийн харилцаатай хүнээс татгалзаад байвал ийм хүмүүс Монголын шүүхийн тогтолцоогоор хэрэг, маргаанаа шийдвэрлүүлэх ямар ч боломжгүй болно. Монгол Улсын хэмжээнд ажилладаг Улсын Дээд шүүхийн эсхүл Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн ах, эгч, дүүтэй холбоотой ямар ч хэргийг шийдэх боломжгүй болно. Иймээс, зохигч аль нэг талын төрсөн ах, эгч, дүү давж заалдах шатны шүүхэд ажилладаг байдал нь анхан шатны шүүхийг бүх шүүгчийг татгалзах үндэслэл гэж жирийн иргэний хувьд хүлээн авах боломжгүй. Мэдээж, шүүгч өөрийн төрсөн ах/эгч М.О-д холбогдох хэргийг давж заалдах эсхүл аливаа журмаар хянан шийдвэрлэж болохгүй (Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91.1.2) учраас тухайн хэрэг ирвэл хянан шийдвэрлэхээс шүүгч М.Н татгалзан гарах үүрэгтэй.

Шүүгч нэг шүүхэд ажиллаж буй бусад шүүгчтэй гэр бүл, садан, төрлийн холбоотой хүнтэй холбоотой хэргийг шийдвэрлэх нь уг маргааныг шударгаар шийдвэрлэх эсэхэд эргэлзэх шууд үндэслэл болохгүй. Мөн, анхан шатны шүүхийн шүүгчийн хувьд давж заалдах, хяналтын шатны шүүхэд ажиллаж буй шүүгчтэй гэр бүл, төрөл, садангийн харилцаатай хүнтэй холбоотой хэргийг төвийг сахиж, шударгаар шийдвэрлэх боломжтой. Хэрэв бусад шүүгчийн зүгээс нөлөөлсөн эсхүл

нөлөөлөхийг оролдсон бол тусдаа асуудал билээ. Гэтэл, энэ хэрэгт шүүгч М.Н нь уг хэрэгт нөлөөлсөн эсхүл нөлөөлөхийг оролдсон гэдэг нотлогдоогүй байжээ. Иймд, шүүгч Ц.О, Б.М нар нь шүүгч харьяалал, зохих журмын дагуу хуваарилагдан ирсэн хэргийг заавал шийдвэрлэх үүрэг болон шударгаар шийдвэрлэхэд үндэслэл бүхий эргэлзээ байвал татгалзах үүрэг хоёрын зохист тэнцвэрийг хангаагүй байна.

“Хариуцагч М.О-гийн дүү Б.Н ШЖК аймгийн эрүүгийн хэргийг давж заалдах шатны шүүхийн шүүгч” гэсэн үндэслэлээр нэхэмжлэгч Б.Э-гийн нэхэмжлэлтэй “ЛЛЛ” ХХК-д холбогдох иргэний хэрэгт хариуцагч М.О, түүний өмгөөлөгч Н.О нар бүх шүүгчээс татгалзах хүсэлт гаргахад хангаагүй нь зөв болсон ч үүнтэй адил агуулга бүхий хариуцагч С.Э, Н.Э, Б.Б /эрх залгамжлагч/, Ж.Д, өмгөөлөгч Ж.Э нарын хүсэлтийг хүлээн авсан нь үндэслэлгүй болжээ. “Хариуцагч М.О-гийн дүү Б.Н ШЖК аймгийн эрүүгийн хэргийг давж заалдах шатны шүүхийн шүүгч” гэсэн адилхан нөхцөл байдалд өөр өөр дүгнэлт хийсэн нь үнэнч шударга байдалд үл нийцнэ.

Хоёр. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйлд буй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болохгүй үндэслэлүүд нь шүүгч тухайн хэргийг төвийг сахиж, шударгаар, ашиг сонирхлын зөрчилгүйгээр шийдвэрлэхгүй байдлаас гадна ийнхүү ойлгогдох үндэслэл бүхий байдлыг багтаадаг. Өөрөөр хэлбэл, тухайн хэрэгт ашиг сонирхлын зөрчил эсхүл шударга бусаар шийдвэрлэх байдал гарсан эсэхээс үл хамааран жирийн иргэний хувьд ашиг сонирхлын зөрчилтэй эсхүл шударга бусаар шийдвэрлэх үндэслэл бүхий гэж ойлгогдох нөхцөл байдал үүссэн нь татгалзан гарах үндэслэл болно.

“ЛЛЛ” компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн нэг Н.Г нас барсан хэрэгт шүүгч Б.М-гийн төрсөн ах Б.Б нь эрүүгийн хэргийн сэжигтнээр шалгагдаж байсан үед уг компанитай холбоотой холбоотой хэрэг Ж.Д-гийн нэхэмжлэлтэй М.О-д холбогдох тамга, гэрчилгээ гаргуулах нэхэмжлэлтэй иргэний хэрэгт шүүгч Б.М-г татгалзан гаргах тухай хүсэлт гаргасныг К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөний 2016 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 66 дугаар тогтоолоор хүлээн авч хангаад Ш аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд шилжүүлжээ. Шүүгч Б.М-ийн хувьд уг хэрэгт бодитойгоор ашиг сонирхлын зөрчил эсхүл шударга бусаар шийдвэрлэх байдал гарсан эсэхээс үл хамааран түүний төрсөн ах Б.Б-гийнх нь шалгагдаж буй эрүүгийн хэргийн хохирогчийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж байсан ЛЛЛ компанитай холбоотой хэргийг хянан шийдвэрлэх нь ашиг сонирхлын зөрчилтэй эсхүл шударга бусаар шийдвэрлэх үндэслэл бүхий эргэлзээ жирийн иргэнд үүснэ гэж үзэв.

Шүүгч Б.М энэ үндэслэлээр өөрөө татгалзан гарахгүй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулсан гэж буруутгаж энэ талаар бичсэн гомдол гаргагчийн гомдол үндэслэлтэй байна. Уг хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал эсхүл ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдал бий болсон бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.1.3, 91.1.4 дэх хэсэгт зааснаар шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болохгүй байхаар хуульд зохицуулсан, иймд мөн хуулийн 92 дугаар зүйлийн 92.1-д зааснаар ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдал бий болсон болохыг мэдмэгц мөн хуулийн 92 дугаар зүйлийн 92.1-д зааснаар шүүгч өөрөө татгалзан гарах хүсэлт гарган энэ тухайгаа мэдэгдэж, татгалзан гарах үүрэгтэй байхад шүүгч энэ үүргээ биелүүлээгүй, энэ талаар гаргасан гомдол гаргагчийн гомдол үндэслэлтэй байна.

Иймд, шүүгч Ц.О, Б.М нар “хууль дээдлэх, үнэнч шударга байх, аливаа асуудалд бодитой, төвийг сахисан байр сууринаас хандах зарчмуудыг хувийн зан чанар болгож төлөвшүүлнэ” гэсэн Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3

дугаар зүйлийн 1, мөн “Шүүгч зохисгүй байдал гаргаж болохгүй бөгөөд бусдад ийнхүү ойлгогдохоос зайлсхийнэ” гэсэн дүрмийн 2.3 дугаар зүйлийн 1 дэх заалт, “шүүгч нь хэргийн оролцогчдод эрх тэгш, төвийг сахисан, хүнлэг ёсоор хандаж хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлэхүйц харилцааны соёлыг эзэмшсэн байна” гэсэн уг дүрмийн 3.2 дугаар зүйлийн 1 дэх заалтыг тус тус зөрчсөн гэж бүрэлдэхүүн үзлээ.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35, 36 дугаар зүйл, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйл, Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5.7.1, 5.13-т заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ц.О, Б.М нарт “сануулах “ сахилгын шийтгэл ногдуулсугай

2.Энэ магадлалын хувийг шүүгч нар болон гомдол гаргагчид хүргүүлэхийг тус хорооны Ажлын албанд даалгасугай.

3.Магадлалыг эс зөвшөөрвөл гардан авснаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.

ДАРГАЛАГЧ

Н.ЭРДЭНЭЦОГТ

ГИШҮҮН

А.ДОРЖГОТОВ

UIN.MN
СУДАЛГААНЫ САН



ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ
МАГАДЛАЛ

2018 оны 7 сарын 4 өдөр

Дугаар 221/ЁМ2018/0019

Улаанбаатар хот

Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалын тухай

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааныг ерөнхий шүүгч Д.Батбаатар даргалж, шүүгч Г.Билгүүн, шүүгч С.Мөнхжаргал нарын бүрэлдэхүүнтэй хийж, Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 23 дугаар магадлалыг эс зөвшөөрч шүүгч Б.М, Ц.О нарын гаргасан гомдлоор, шүүгч С.Мөнхжаргалын илтгэснээр хянан хэлэлцэв.

ТОДОРХОЙЛОХ нь:

Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 23 дугаар магадлалаар: К аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ц.О, Б.М нарт “Сануулах” сахилгын шийтгэл ногдуулжээ.

Шүүгч Ц.О давж заалдах гомдолдоо: “...Шүүгч Ц.О надад хуваарилагдсан Ж.Н нарын нэхэмжлэлтэй Х.С нарт холбогдох “ЛЛЛ” ХХК-ийн хувьцаа эзэмшигчээр тогтоолгох тухай” иргэний хэргийг хянан хэлэлцэх шүүх хуралдаан дээр хариуцагч Н.Э, С.Э, Ж.Д, эрх залгамжлагч Б.Б /хариуцагч талийгаач Н.Г-гийн/ болон тэдгээрийн өмгөөлөгч Ж.Э нар нь К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн бүх шүүгчдийг татгалзан гаргах хүсэлтийг Шүүгчдийн зөвлөгөөнөөр хэлэлцээд К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний 2017 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 153/ЭТ2017/00014 дугаар тогтоолоор хангаж шийдвэрлэсэн.

Ж.Н нарын нэхэмжлэлтэй Х.С нарт холбогдох “ЛЛЛ ХХК-ийн хувьцаа эзэмшигчээр тогтоолгох тухай” иргэний хэргийн хариуцагч Н.Э, Ж.Д, эрх залгамжлагч Б.Б /хариуцагч талийгаач Н.Г-гийн эхнэр/, тэдгээрийн өмгөөлөгч Ж.Э нарын “... хариуцагч М.О нь бусад хариуцагч болох Ж.Н, Н.Э, С.Э, эрх залгамжлагч Б.Б, Ж.Д нараас эсрэг сонирхолтой байгаа, М.О-гийн төрсөн дүү М.Н К аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн иргэний хэргийн шүүгчээр ажилладаг бөгөөд шүүгч М.Н нь анхан шатны шүүх, шүүх бүрэлдэхүүнд нөлөөлөх /Ц.О, Б.М/, түүнчлэн уг хэргийг шударгаар шийдвэрлэх эргэлзээ байвал татгалзах хуулийн заалтын дагуу татгалзаж байна” гэх хүсэлтийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 9113-т түүнчлэн уг хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал” гэж заасны дагуу хариуцагч нарын хүсэлт хуулийн үндэслэлтэй байна гэж үзэж, хууль дээдлэх ёсыг баримтлан хамтын зарчмаар шийдвэрлэсэн.

Хариуцагч нар нь гомдол гаргагч М.О-гийн төрсөн дүү шүүгч М.Н-тэй шүүгч Б.М, Ц.О нар нь нэг байранд хамт ажиллаж, ажил хэргийн байнгын харилцаатай шүүгч нарт нөлөөлж болзошгүй нь бидэнд талд эргэлзээ төрүүлж байна гэж тайлбарлаж байв.

Монгол Улсын Үндсэн хуулийн 4 дүгээр зүйлийн 2-т тэгш байдал”, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т “... шударга шүүхээр шүүлгэх эрхтэй”, 16-д “итгэл үнэмшилтэй байх”, “үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх” гэж заасны дагуу шүүгч би талуудад тэгш байдлыг олгож, хариуцагч нарын эрхийг хязгаарлаагүй, эрхийг нь хангаж эргэлзээгүй тэгш байдлыг талуудад олгож, хүсэлтийг хангасан гэж үзэж байна.

Аль ч иргэн шүүхээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлэхдээ шүүх шүүгчид эргэлзэх ёсгүй.

Уг хэрэгт эсрэг сонирхолтой хариуцагч М.О-гийн төрсөн дүү М.Н шүүгч иргэний хэргийг хянан магадалж ажилладаг, нэг Тамгын газарт харьяалагддаг тул анхан шатны шүүгч нартаа нөлөөлж болзошгүй гэж үзээд хэргийн нэг тал эргэлзэж, итгэхгүй шүүгч биднээс татгалзах хүсэлт гаргаж байгаа нь Үндсэн Хуулийн 14 дүгээр зүйлийн 1-т заасан “хүн бүр хууль.шүүхийн өмнө эрх тэгш байна” гэсэн зарчимтай нийцэж байна гэж шүүгч би үзсэн.

Хариуцагч М.О-гийн “миний төрсөн дүү М.Н ШЖК аймгийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч “гэсэн үндэслэлээр Б.Э-гийн нэхэмжлэлтэй “ЛЛЛ” ХХК-д холбогдох иргэний хэрэгт хариуцагч М.О-гийн шүүгчээс татгалзах хүсэлт гаргахад хангаагүй нь зөв болсон ч адил агуулга бүхий хариуцагч С.Э, Н.Э, Б.Б /эрх залгамжлагч/ Ж.Д, өмгөөлөгч Ж.Э нарын татгалзан гарах хүсэлтийг хүлээн авсан байгаа нь буруу байна гэж үзээд Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хороо нь зөрчилд тооцож сануулах шийтгэл ногдуулсанд гомдолтой байна.

Учир нь энэ хоёр хэргийг адил гэж холбон ойлгох нь өрөөсгөл юм. Гомдол гаргагч М.О К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн бүх шүүгчид нь тухайн хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар эргэлзээ байвал энэхүү эргэлзээ нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл бүхий байх ёстой. 2 хэргийн татгалзал шийдсэнийг харьцуулж үзвэл: Шүүгч Д.К, шүүгч Ц.О, шүүгч Б.М нар нь нэхэмжлэгч Н.Э-гийн нэхэмжлэлтэй “ЛЛЛ” ХХК-д холбогдох иргэний хэрэгт хариуцагч М.О, түүний өмгөөлөгч Н.О нарын К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нараас татгалзан гаргах тухай хүсэлтийг шүүгчдийн зөвлөгөөнөөрөө хэлэлцээд “... ШЖК аймгийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч М.Н нь К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд ажилладаггүй мөн М.Н нь эрүүгийн хэргийн шүүхийн шүүгч ...” гэсэн үндэслэлээр 2015 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 43 дугаартай “Татгалзан гаргах хүсэлтийг хангахаас татгалзах тухай” тогтоолыг гаргасан. /уг тогтоолын хуулбарыг зөвлөгөөний тэмдэглэлийн хамт баримтаар хавсарган хэрэгт өгсөн/

Хариуцагч М.О-гийн хүсэлтийг шийдвэрлэж байх үед гомдол гаргагч М.О-гийн төрсөн дүү М.Н нь ШЖК аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхэд ажилладаг, эрүүгийн хэрэг хянан магадалдаг шүүгч байсан.

ШЖК аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх нь анхан шатны шүүхээс тусдаа К аймгийн Ү сумын ... багт цэцэрлэгийн байрыг түрээсэлж буюу өөрийн байранд үйл ажиллагаа явуулдаг байгууллага байсан /фото зургийг баримтаар хавсарган өгсөн/

ШЖК аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх нь Тамгын газар нь тусдаа, Тамгын газрын даргаар Д.Д ажиллаж байсан бөгөөд шүүгч М.Н нь Д.Д даргатай бие даасан тамгын газарт харьяалагдаж байсан .

К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын даргаар Д.Г ажиллаж тус шүүх нь К аймгийн Ү сумын ... багийн нутаг дэвсгэрт байрладаг байсан. /хуучин өөрийн байр фотог баримтаар хавсарган өгсөн/

Шүүгч Д.К нь Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Ш аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчээр томилогдоход “өв нээгдэх хүртэл” үндэслэлээр түдгэлзүүлсэн байсан Ж.Н нарын нэхэмжлэлтэй Х.С нарт холбогдох “ЛЛЛ ХХК-ийн хувьцаа эзэмшигчээр тогтоолгох тухай” иргэний хэрэг нь тус шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний тогтоолын дагуу миний бие Ц.О-д хуваарилагдсан.

Уг хэргийг хянан хэлэлцэх шүүх хуралдаан дээр К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн бүх шүүгчдийг татгалзсан татгалзлыг хариуцагч С.Э, эрх залгамжлагч Б.Б /хувьцаа эзэмшигч байсан талийгч Г-гийн эхнэр/, хариуцагч Ж.Д, хариуцагч Н.Э, түүний өмгөөлөгч Ж.Э нар гаргасан бөгөөд уг хүсэлтийг тус шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөр хянан хэлэлцэж, “... хариуцагч М.О нь бусад хариуцагч нар болох С.Э, Н.Э, эрх залгамжлагч Б.Б, Ж.Д нараас эсрэг тайлбарыг шүүхэд ирүүлсэн, мөн хариуцагч М.О-гийн төрсөн дүү М.Н нь К аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд иргэний хэргийн шүүгчээр томилогдож, К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нартай нэг байгууллагад буюу шүүхийн нэг Тамгын газарт харьяалагдан ажил хэргийн хувьд байнгын харилцаатай анхан шатны шүүхийн шүүгч нарын шийдвэрлэсэн иргэний хэргийг хянан магадалж ажилладаг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.1.3-д заасан “...түүнчлэн уг хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал...” гэсэн үндэслэлээр хариуцагч нарын шүүгчдийг татгалзсан хүсэлтийг хангаж К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний 2017 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 153/ЭТ2017/00014 дугаартай тогтоолыг гаргасан. Энэ тохиолдолд хариуцагч Н.Э, С.Э, эрх залгамжлагч Б.Б, Ж.Д нарт шүүгч Ц.О, Б.М нар нь хэргийг шударгаар шийдвэрлэнэ гэдэгт эргэлзээ төрсөн.

Шүүгчийг татгалзсан татгалзал нь үндэслэлтэй байна гэж шүүгчдийн зөвлөгөөнөөр үзсэн тул хариуцагч нарын хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн бөгөөд энэхүү татгалзлыг шийдвэрлэх үед М.Н шүүгчийн хувьд нөхцөл байдал өөрчлөгдсөн байсан.

Монгол улсын Шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй” гэж заажээ.

Шүүгч би хэргийн оролцогчдын татгалзал хүсэлтийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу шийдвэрлэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсныг ёс зүйн зөрчил тооцсонд гомдолтой байна.

Монгол Улсын Шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 5.1 дүгээр зүйлийн 3-т “... ёс зүйн зөрчлийг илрүүлснээс хойш 1 сар, зөрчил гаргаснаас хойш 6 сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулж болохгүй”, 5 дугаар зүйлийн 17-д “шүүгчид холбогдох сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш зургаан сар, зөрчил гаргаснаас хойш нэг жил өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулахгүй гэж хуульчилжээ. Мөн хөдөлмөрийн тухай хуульд сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 1 сарын хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулж болохгүй гэж заажээ.

Шүүгч Ц.О миний бие нь Монгол Улсын Үндсэн хууль болон бүсэд хуулийг баримталж шударгаар хариуцагч М.О-д холбогдох хэргийн “шүүгчийг татгалзсан” хүсэлтийг шийдвэрлэсэн. М.О-д холбогдох 2 иргэний хэргийг 2015 оноос 2016 онуудад шийдвэрлэж шийдвэр хүчин төгөлдөр болсон. Иймд шүүгч Ц.О миний дээрх үйлдэл нь ёс зүйн зөрчил биш, мөн хөөн хэлэлцэх хугацаа дууссан байх тул

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 23 дугаартай магадлалыг хүчингүй болгож өгнө үү” гэжээ.

Шүүгч Б.М давж заалдах гомдолдоо: “... Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалд шүүгч намайг 2 үндэслэлээр зөрчил гаргасан гэж үзсэн байх бөгөөд нэг дэх үндэслэлд гаргах гомдол нь шүүгч Ц.О-гийн гаргасан гомдолтой адил байх тул миний бие давхардуулан бичихийг хүссэнгүй. Иймд энэхүү үндэслэлд шүүгч Ц.О гаргасан гомдол болон энэ талаар Шүүхийн Ёс зүйн хороонд өмнө гаргасан өөрийнхөө тайлбараа дэмжиж байна.

Миний ах Б.Б нь “ЛЛЛ” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн нэг Н.Г-гийн нас барсан хэрэгт сэжигтнээр шалгагдаж байсан нь үнэн.

Миний ах хүмүүсийг хөлсөлж өөрийн оффист засварын ажил хийлгэж байсан бөгөөд хөлсөөр ажиллаж байсан нэг ажилтан тогонд цохиулж нас барсан нь сүүлд сонсоход ЛЛЛ компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн нэг Н.Г гэдэг хүн байсныг мэдсэн.

Шүүхийн Ёс зүйн хороо нь ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдал бий болсон, болохыг мэдмэгц татгалзан гарах үүрэгтэй гэж заасан байхад шүүгч өөрөө татгалзан гарах хүсэлтээ гаргах ёстой байсан гэж үзжээ.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д зааснаар ашиг сонирхлын зөрчил гэдэг нь нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед түүний хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдал үүсэхийг ойлгоно гэж заажээ. Гэтэл миний ах ЛЛЛ компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний амь настай холбоотой хэрэгт сэжигтнээр татагдаж байсан нь шүүгч надад ашиг сонирхлын зөрчил үүссэн гэж Шүүхийн Ёс зүйн хороо үзэж байгаа нь ойлгомжгүй байна. Тус шүүхэд хариуцагч М.О-той холбоотой нэлээдгүй хэрэг хянан шийдвэрлэгдэж байсан, одоо ч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа. Миний ах тус хэрэгт шалгагдаж байх хугацаанд надад хуваарилагдсан Ж.Д-гийн нэхэмжлэлтэй М.О-д холбогдох тамга, тэмдэг, гэрчилгээ гаргуулах тухай иргэний хэрэгт зохигч тал энэ үндэслэлээр намайг татгалзсан татгалзлыг тус шүүхийн 2016 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 66 дугаартай тогтоолоор хүлээн авсан. Мөн шүүгч Ц.О-д хуваарилагдсан нэхэмжлэгч Ж.Н-ийн нэхэмжлэлтэй, хариуцагч Х.С-д холбогдох ЛЛЛ ХХК-ийн хувьцаа эзэмшигчээр тогтоолгох тухай иргэний хэрэгт К аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн бүх шүүгчдийг татгалзсан татгалзлыг тус шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний 2017 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 153/ЭТ2017/00014 дугаартай тогтоолоор хангаж шийдвэрлэсэн. Учир нь энэ хугацаанд миний ахын хэрэг Цагдаагийн газарт шалгагдаж байсан учир зохигчдоос гаргасан шүүгчдийг татгалзсан татгалзлыг хүлээн авсан.

Дараа нь миний ахын холбогдсон хэргийг Улсын ерөнхий прокурорын газраас шалгаж, хэргийг хэрэгсэхгүй болгосон бөгөөд энэ талаар прокурорын хүчин төгөлдөр тогтоол байгаа. Энэхүү тогтоолын хувийг хэрэгт хавсаргасан.

Удалгүй Н.Э-гийн нэхэмжлэлтэй М.О-д холбогдох 66,700,000 төгрөг гаргуулах тухай иргэний хэрэг надад хуваарилагдсан бөгөөд тус хэргийг миний бие хянан шийдвэрлэсэн. Учир нь миний ах Б.Б ЛЛЛ ХХК-ийн хувьцаа эзэмшигч Н.Г-гийн нас барсан шалтгаанд холбогдолгүй болох нь тогтоогдож, хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байсан.

Би шүүгчээр томилогдоод 2 жил өнгөрч байгаа бөгөөд энэ хугацаанд М.О болон ЛЛЛ ХХК-тай холбоотой гурван хэрэг хянан шийдвэрлэсэн. Одоо ч бас М.О болон ЛЛЛ ХХК-ний талуудын хоорондын маргаантай холбоотой хэргүүд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа, хуваарийн дагуу надад хуваарилагдсан хэргүүд

ч байгаа бөгөөд шүүгч надад хуульд заасан татгалзан гарах үндэслэл байхгүй тул хянан шийдвэрлэнэ гэж үзэж байна. Яагаад гэвэл надад Шүүхийн Ёс зүйн хорооны гишүүдийн үзсэнчлэн ашиг сонирхлын зөрчил байхгүй, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.1, 91.1.4, 92 дугаар зүйлийн 92.1-д заасан үндэслэлүүд ч байхгүй.

Иймд Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалд дурдсан хэргийг бодитойгоор ашиг сонирхлын зөрчил эсхүл шударга бусаар шийдвэрлэх үндэслэл бүхий эргэлзээ үүссэн гэж үзэхгүй байна. Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалын үндэслэл хэсэгт "...уг хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал ... шүүгч өөрөө татгалзан гарах хүсэлт гарган энэ тухайгаа мэдэгдэж, татгалзан гарах үүрэгтэй байхад шүүгч энэ үүргээ биелүүлээгүй" гэжээ. Шүүгчээр томилогдож, тангараг өргөсөн атлаа хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэхдээ эргэлзэх юм бол миний хувьд шүүгч болоод яах юм бэ. Шүүгч өөрөө хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэхдээ эргэлзэх биш хэргийн оролцогчид л шүүгчийг шударгаар шийдвэрлэж чадах эсэхэд нь эргэлзэж байгаа бол тэд нарт татгалзах эрх нь байгаа. Харин энэ татгалзал нь үндэслэл бүхий байх ёстой.

Нөгөө талаар М.О болон түүний өмгөөлөгч М.Э нар шүүгч нарыг ёс зүйн зөрчил гаргасан гэж үзсэн бол зөрчлийг илрүүлснээс хойш 1 сар, зөрчил гаргаснаас хойш 6 сараас илүүгүй хугацаанд гомдлоо гаргах ёстой байсан. Гэтэл энэ хугацаанд гомдлоо гаргаагүй, хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсний дараа гомдол гаргасан явдал нь гомдол гаргагч нар өөрсдөө ямар нэгэн сонирхолтой байсан байна гэж үзэж байна.

Иймд шүүгч Б.М миний дээрх үйлдэл нь ёс зүйн зөрчил биш, мөн хөөн хэлэлцэх хугацаа дууссан байх тул Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 23 дугаартай магадлалыг хүчингүй болгож өгнө үү" гэжээ.

ХЯНАВАЛ:

Шүүгч Ц.О, Б.М нар нь гомдлыг дараах үндэслэлээр хангаж шийдвэрлэлээ.

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хороо нь "...Хэргийг төвийг сахиж, шударгаар шийдвэрлэж чадах эсэхэд жирийн иргэн эргэлзэх үндэслэл байгаагаас бусад тохиолдолд шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарах ёсгүй юм. Шударгаар шийдвэрлэх эргэлзээ нь үндэслэлгүй байхад татгалзан гарах ёсгүй. Мөн хэрэг нь хэцүү, маргаантай гэсэн төдийд ч татгалзан гарах ёсгүй. Энэ мэт шалтгаар эсхүл үндэслэл байхгүй байхад татгалзан гарах нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохисгүйгээр удаашруулах, чирэгдүүлэх, бусад шүүгчийн ачааллыг нэмэгдүүлэх, хүссэн шүүгч дээрээ хэргийг аваачуулах сэдлийг нэмэгдүүлэх аюултай. Шүүгч Ц.О, Б.М нар нь хариуцагч өмгөөлөгч ... нар нь шударгаар шийдвэрлэх эргэлзэж байгаа төдийгөөр тус шүүхийн бүх шүүгчээс татгалзан гаргах хүсэлтийг авсан нь объектив стандартаар бус, харин эдгээр оролцогчдын санаа бодлоор шийдсэнийг харуулж байна" гэж дурдан шүүгч нарыг "ёс зүйн зөрчил" гаргасан гэж үзжээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.1-д "... шүүгч татгалзан гарах үндэслэл"-ийг, харин 92 дугаар зүйлийн 92.2-д шүүгчийг татгалзан гаргах хүсэлт гаргах талаар, 92.5-д "Шүүгчийг татгалзан гаргах тухай асуудлыг үндэслэлтэй эсэхийг түүнийг байлцуулахгүйгээр шүүх бүрэлдэхүүний бусад шүүгчид шийдвэрлэнэ" гэж, 92.8-д "Ерөнхий шүүгч дангаар хэрэг хянан шийдвэрлэх явцад түүнийг татгалзсан буюу тухайн шүүхийн бүх шүүгчдийг татгалзсан бол шүүгчдийн зөвлөгөөн олонхын саналаар шийдвэрлэн тогтоол гаргана" гэж тус тус заасан байна.

Шүүгч Ц.О, Б.М нар нь гомдол гаргагч М.О, түүний өмгөөлөгч Н.О нарын "К аймгийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч М.Н нь М.О-гийн

төрсөн дүү учир нөлөөлнө гэж нэхэмжлэгч тал хэлсэнтэй холбоотой К аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн бүх шүүгчийг иргэний хэргийг шударгаар шийдвэрлэж чадах талаар эргэлзэж татгалзан гаргах хүсэлт гаргасныг болон М.О-гийн хэргийн оролцогч, төлөөлөгчөөр оролцсон өөр хэргийн эсрэг сонирхолтой хэргийн оролцогч, тэдгээрийн өмгөөлөгч нар тухайн үндэслэлээр шүүгч нарыг татгалзан гаргах хүсэлт гаргасныг Шүүгчдийн зөвлөгөөнөөс шийдвэрлэхдээ ялгаатай авч үзэн, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дээрх заалтуудыг тайлбарлан хэрэглэж шийдвэрлэснийг шүүгчийн “ёс зүйн зөрчил” гэж үзсэн нь үндэслэлгүй байна.

Учир нь шүүгч нар хэрэг маргааныг хэцүү, маргаантай гэж, эсхүл М.О-гийн хэргийн оролцогчоор оролцсон зарим хэргийг “зориуд шударга бусаар шийдвэрлэнэ гэдгээ хүлээн зөвшөөрч татгалзан гаргасан хүсэлтийг хүлээн авсан, хэргийн оролцогчид нь адилхан зарим хэргийг хүлээн авч татгалзан гарахгүйгээр шийдвэрлэх гээд улайраад байгаа” гэх М.О-гийн гомдолд дурдсан асуудал нотлогдоогүй байна.

Хэргийн оролцогчийн шүүгчийг болон тухайн шүүхийн бүх шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг бүрэлдэхүүнд орсон бусад шүүгч, тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөн шийдвэрлэхээр заасан хуулийн зорилго, агуулга нь шүүгчийн татгалзан гаргах хэргийн оролцогчийн хүсэлтийг аль болох татгалзагдаж байгаа шүүгчийг оролцуулахгүйгээр бусад шүүгч, эсхүл татгалзагдсан шүүгчээс гадна тухайн шүүхийн нийт шүүгч оролцсон зөвлөгөөнөөр шийдвэрлэдэг нь хэргийн оролцогчийн шүүх, шүүгчид эргэлзэх эргэлзээг арилгах үндэслэл болдог.

Гэтэл тухайн сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн орон тооноос хамаарч шүүгч Ц.О, Б.М нар хэргийн оролцогчдын бүх шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг шийдвэрлэх Шүүгчдийн зөвлөгөөнд өөрсдөө оролцож шийдвэрлэсэн нөхцөл байдал нь хэргийн оролцогчдын эргэлзээг арилгах бус, харин эргэлзээ төрүүлсэн, ёс зүйн хороонд энэ талаар гомдол гаргахад нөлөөлсөн гэж үзэхээр байх бөгөөд шүүгчийн орон тоо, хүрэлцээнээс хамаарсан уг асуудлыг харгалзан үзэлгүй шүүгчийн “ёс зүйн зөрчил” гэж шууд үзэх нь учир дутагдалтай байна.

Монгол Улсын Шүүхийн шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 2-т “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй” гэж заасны дагуу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91, 92 дугаар зүйлийг тайлбарлан хэрэглэхтэй холбоотой асуудал байх тул ёс зүйн зөрчил гэж үзэж сахилгын шийтгэл ногдуулсан нь үндэслэлгүй болжээ.

Мөн шүүгч Б.М-ийн хувьд төрсөн ах нь хэрэгт холбогдсон үед ахынхаа хамааралтай хэргээс татгалзан гаргах хэргийн оролцогчийн хүсэлтийг хангасан, ахад нь холбогдох эрүүгийн хэрэг Прокурорын тогтоолоор хэрэгсэхгүй болгосны дараа цаг хугацааны хувьд дээрх татгалзлыг хүлээн авсан үндэслэл арилсан үед зохих журмаар хуваарилагдсан хэргийг шийдвэрлэхээс татгалзан гарахгүй байгааг “ёс зүйн зөрчил” гэж үзэх үндэслэлгүй байна.

Энэ талаарх шүүгч нарын гаргасан гомдол үндэслэлтэй байх тул Монгол Улсын Шүүхийн ёс зүйн хорооны магадлалыг хүчингүй болгох нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэв.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.1.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 23 дугаар магадлалыг хүчингүй болгож, шүүгч Ц.О, Б.М нарын гомдлыг хангасугай.

2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.5-д зааснаар шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийг буруу хэрэглэсэн, мөн шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн нь шүүхийн шийдвэр гарахад нөлөөлсөн гэж үзвэл магадлалыг гардан авсан, эсхүл хүргүүлснээс хойш 14 хоногийн дотор Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд гомдол гаргах эрхтэй.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.БАТБААТАР

ШҮҮГЧ

Г.БИЛГҮҮН

ШҮҮГЧ

С.МӨНХЖАРГАЛ

UIN.MN
СУДАЛГААНЫ САН



**МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЁС ЗҮЙН ХОРООНЫ МАГАДЛАЛ**

2018 он 10 сарын 19 өдөр

Дугаар 73

Улаанбаатар хот

Ф аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Б.Д, Б.С, Г.Б нарт холбогдох сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгож, Ф аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Л.У-д сахилгын шийтгэл ногдуулах тухай

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааныг тус хорооны дарга Н.Эрдэнэцогт даргалж, гишүүн А.Доржготов, В.Жавхлан, Ч.Оюунцэцэг, Д.Сүнжид нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны тэмдэглэл хөтлөгчөөр тус хорооны ажлын албаны шинжээч Ч.Ханддулам, хяналт шалгалт хариуцсан референт А.Баасанжав нарыг оролцуулан Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдааны танхимд хийв.

Шүүгч Б.Д, Б.С, Г.Б нараас Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 5 дугаар сарын 03-ны өдрийн 75 дугаар тогтоолыг эс зөвшөөрч гомдол гаргасныг гишүүн А.Доржготовын илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Гомдол гаргагч Б.О Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан гомдолдоо: Миний хүү О.У нь 2016 оны 7 дугаар сарын 20-ны өдөр 13 цагийн орчимд А хотоос Ф аймаг руу ээж Ч.О, эхнэр Ж.Ц, хүү У.М, У.М нарын хамт өөрийнхөө ХХХ дугаартай Приус 20 маркийн машинаар тус аймгийн Ж сумын нутагт буюу А-Ф аймгийн чиглэлийн төв магистрал замын 165 тоот километрийн заалт бүхий тэмдэгтээс зүүн зүгт 103 метр зайд зорчиж явахад өөдөөс нь Б.Ц гэгч эмэгтэй ХХХ дугаартай Хайландер маркийн машинаар хурд хэтрүүлэн урсгал сөрж мөргөсний улмаас миний эхнэр Ч.О, ач хүү У.М нар нас барж, хүү О.У, түүний эхнэр Ж.Ц нар хүнд, ач хүү У.М хөнгөн гэмтсэн эрүүгийн хэрэг гарсан юм.

Уг хэргийг тус аймгийн Цагдаагийн хэлтэс болон А хотын Цагдаагийн ... дугаар хэлтэст мөрдөн шалгаад Ф аймаг дахь эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор Б.Ц-гийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 5 жилийн хугацаагаар хасаж, 6 жилийн хохирох ялаар шийтгэсэн болно. Гэвч Б.Ц-д холбогдох эрүүгийн 201623000204 дугаартай хэргийн давах шатны шүүхийн 2017 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн Магадлалаар эрүүгийн анхан шатны шүүхийн дээрх шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг тээврийн прокурорт шилжүүлсэн болон эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Л.У даргалсан 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн шүүхийн тогтоол, тэдгээр шүүх хуралдааны явцад шүүгч Б.Д, Л.У нарын шүүгчид нь хууль, ёс зүйн алдаа зөрчил гаргасан байна. Иймд дараах гомдлыг гаргаж байгаа юм.

Нэг. Шүүгч Б.Д нарын талаар: Ф аймаг дахь Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх хуралдааныг ерөнхий шүүгч Б.Д даргалж, шүүгч Г.Б, Б.С нарын бүрэлдэхүүнтэй хийсэн бөгөөд тэдгээр шүүгчид нь шүүхийн Магадлалдаа "Шүүхийн шинжилгээний хүрээлэнгийн

2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 7149, 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 639 тоот дүгнэлтүүд үндэслэлтэй эсэх нь эргэлзээтэй бөгөөд энэ талаар дахин шинжээч томилуулах талаарх удаа дараагийн хүсэлтийг эцэслэн шийдвэрлээгүй байх тул хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаах нь зүйтэй гэж үзлээ" гэсэн нь үндэслэлгүй, худал зүйл болсон гэж хохирогч бид үзэж байгаа юм. Учир нь мөрдөн байцагч Э.Б-гийн 2016 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн шинжээч томилох тогтоолоор хийгдсэн нэмэлт шинжилгээ болон дахин шинжилгээний дүгнэлтүүд гарснаас хойш шинжээч Ө.Ш-ийн үйлдсэн Шүүх эмнэлгийн задлан шинжилгээний 09шэ/018 дугаартай актад дурдсан талийгаач Ч.О-гийн цус, ходоодны шингэний дээжээс 0.8-0.1 промиллийн спиртийн агууламж илэрсэн гэдэг үндэслэлгүй дүгнэлт болон шинжээч Б.Л-ийн 7149 дугаартай үндэслэлгүй худал дүгнэлт, үүнийг үндэслэн гаргасан шинжээч С.П-гийн 639 тоот О.У-г Замын хөдөлгөөний дүрмийн 2.7-г зөрчсөн байх үндэслэлтэй боловч уг зөрчил нь осол гарахад нөлөөлөөгүй" гэсэн үндэслэлгүй дүгнэлт нь Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Шүүхийн шинжилгээний тухай хуулийн заалтуудыг илэрхий зөрчсөн нь мөрдөн байцаах ажиллагааны явцад нотлогдсон тул хохирогч Б.О, О.У, Ж.Ц нарын хэн нь ч 2016 оны 12 дугаар сараас хойш дахин шинжээч томилуулах хүсэлт гаргаагүй ийм хүсэлт хавтаст хэрэгт огт байхгүй болно.

Иймээс хохирогчид бид давах шатны шүүхийн шүүгчид нь хавтаст хэргийн материалтай бүрэн танилцалгүй, шүүх хурал дээр хохирогч Б.О-гийн хэлсэн тайлбарыг хайхарч үзэлгүй, зөвхөн яллагдагч Б.Ц-гийн өмгөөлөгч Б.М-ийн хавтаст хэргийн баримт, мэдүүлгүүдийг бүрэн судлалгүйгээр "О.У тухайн өдөр согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож явсан" гэх худал мэдээлэлд хөтлөгдөн, түүний нөлөөллөөр тийнхүү буруу ташаа дүгнэн Магадлал гаргасан гэж үзэж байгаа болно.

Талийгаач Ч.О-гийн цус, ходоодны шингэний дээжээс 0.8-0.1 промиллийн спиртийн агууламж илэрсэн "хөнгөн зэргийн согтолттой" гэх Ө.Ш-ийн гарын үсэг бүхий 09шэ/018 дугаартай илт худал дүгнэлтийн талаар давж заалдах шатны шүүхийн шүүх бүрэлдэхүүн тэрхүү Магадлалдаа огт дурдаагүй нь холбогдох хууль, ёс зүйн дүрмийн хэм хэмжээ, заалт, зарчмыг илт зөрчсөн байна.

Хохирогчид бид талийгаач ээж Ч.О, хүү О.У нар архи уудаагүй бөгөөд тухайн осол болсон өдөр ч архи согтууруулах ундааны зүйл ууж хэрэглээгүй, иймд тэдний цусны дээжээс спиртийн агууламж илрэх ёсгүй учраас шинжээч Б.Л, Ө.Ш, С.П нарын тэрхүү дүгнэлтүүдийг огт үндэслэлгүй худал дүгнэлт гэж үзэж байгаа юм. Гэтэл шүүгч Б.Д, Г.Б, Б.С нар нь одоогийн мөрдөж буй Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 8.1-д заасан "Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахдаа Үндсэн хууль, энэ хууль, бусад хуулийн заалтыг чанд сахина", мөн уг хуулийн 15.1 -д заасан "Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхэд шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана" гэснийг зөрчиж, хавтаст хэргийн материалд огт байхгүй зүйлээр тэрхүү 26 дугаартай магадлал гаргасан байна.

Давах шатны шүүх хурал дээр хохирогч Б.О нь шинжээч Ө.Ш, Б.Л, С.П нарын дээрх үндэслэлгүй худал дүгнэлтүүд нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 28.3, 46.2, 46.6, 46.7 дахь заалтууд, Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 14.1.2, 14.1.6, 14.1.7, 15.1.1, 15.1.6, 18.1.8, 17.4 дэх заалтуудыг тус тус зөрчсөнтэй холбогдуулан тодорхой тайлбарласан.

Мөн тэдгээр хуурамч дүгнэлтүүдийг К дүүргийн Цагдаагийн хэлтсийн мөрдөн байцаагч Б.М нь энэ хүн анх хохирогч О.У нараас цусны дээжүүдийг авхуулсан бөгөөд ингэхдээ харин хохирогч Ж.Ц-ээс цусны дээж авхуулаагүй, О.У-гийн овгийг О гэж худлаа бичсэн, мөн К дүүргийн эмнэлэг дээр О.У-гийн дэргэд очсон хэр нь "Би түүнээс хол зогсож байсан" хэмээн худал мэдүүлэг өгсөн зэрэг нь ашиг

сонирхлын зөрчилтэй байж болзошгүй гэж үзсэн тул түүнээс татгалзан өөр мөрдөн байцаагчаар шалгуулахыг хүссэн боловч тус дүүргийн хяналтын прокурор Б.А нь бидний энэхүү хүсэлтийг хангаж өгөөгүй шинжээч Б.Л, Ө.Ш нарт Эрүүгийн хуулийн 254, 272, 268 дугаар зүйл заалтыг зөрчсөн гэдэг үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж шийдвэрлүүлэх тухай хохирогч бидний гомдлоор мөрдөн шалгаж, тус дүүргийн хяналтын прокурор Б.А хянаж шийдвэрлэн хариу мэдэгдэхдээ "шинжээч Б.Л, Ө.Ш нарын хууль, дүрэм, журам зөрчсөн үйлдэлд хариуцлага тооцуулахаар прокурорын шаардлага хүргүүлсэн" гэсэн юм. Хяналтын прокурор Б.А-гийн энэхүү 2017 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр ирүүлсэн мэдэгдэх хуудас болон түүний уг шийдвэрийг хэвээр үлдээсэн К дүүргийн прокурорын газрын дарга Б.П-гийн илгээсэн 2017 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн мэдэгдэх хуудас,

Нийслэлийн прокурор Д.Б-гийн 2017 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн хариу бичгийг хавтаст хэрэгт өгч оруулсан боловч давах шатны шүүгч нар нь шүүх хуралдаанаа завсарлуулан бүтэн гурван цаг гаруй зөвлөлдөхдөө хавтаст хэргийн материалаас тэдгээрийг олж уншилгүй ажилдаа хайхрамжгүй хандсан, эсвэл зориуд тэрхүү үндэслэл муутай магадлалыг гаргасан байна.

Хэрвээ хавтаст хэргийн материалаас прокуроруудын мэдэгдэх хуудаснууд болон ээж Ч.О, хүү О.У нар нь тухайн осол гарсан өдөр архи согтууруулах ундааны зүйл огт ууж хэрэглээгүйг гэрчилсэн цагдаагийн дэд хурандаа Ц.Ө, К дүүргийн эмч Г.А нарын мэдүүлгүүдийг шүүгч Б.Д, Г.Б, Б.С нар уншиж судлаад хуулийн дагуу үнэн бодитой дүгнэлт гаргасан бол эрүүгийн анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх боломж тэдэнд бүрэн дүүрэн байсан. Хэргийн газар дээр анх очсон цагдаагийн дэд хурандаа Ц.Ө мэдүүлэхдээ "Архи дарс уусан хүн мэдэгдээгүй. Ослын газарт очиход архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн хүн харагдаагүй" гээд О.У согтуу байсан эсэх асуултад хариулахдаа "Согтууруулах ундаа хэрэглэсэн ямар нэг шинж тэмдэг мэдэгдээгүй" гэсэн юм. Мөн ослын газарт анх очсон эмч Г.А мэдүүлэхдээ "Приус 20"-ыг жолоодож явсан залуугаас архи согтууруулах ундааны зүйл үнэртэхгүй байсан. Тус осолд орсон хүмүүсээс ямар нэг согтууруулах ундааны зүйл үнэртэхгүй байсан" гэснээс гадна гэрч Н.А нь ч бас яг ингэж хариулсан байв.

Хавтаст хэрэгт байгаа тээврийн прокурор Д.Д, хяналтын прокурор О.Б нар болон Эрүүгийн анхан шатны шүүхэд хандан хохирогч бидний амаар болон бичгээр гаргаж байсан хүсэлтүүд нь Шүүхийн шинжилгээний тэдгээр үндэслэлгүй хууль бус дүгнэлтүүдийн талаар гаргасан гомдлуудыг хуулийн дагуу үнэн зөв хянан шийдвэрлэх, мөрдөн байцаагч, шинжээч нар нь авлига ашиг сонирхлын зөрчилд өртсөн байх магадлалтай тул Авлигатай тэмцэх газартай хамтарч шалгаж шийдвэрлэх, шинжээч Б.Л, Ө.Ш, С.П нарын шинжилгээний дүгнэлтүүд нь гэрчийн мэдүүлгүүд, бусад баримтуудаар нотлогдоогүй тул нотлох баримтын хэмжээнд үнэлэхгүй байх яллагдагч Б.Ц нь тухайн осол болсон өдөр О.У-гийн жолоодож явсан Приус 20 маркийн автомашины өөдөөс замын хөдөлгөөний урсгал сөрж өндөр хурдтайгаар давхихдаа түүнийг шууд мөргөж дайрахгүйгээр буцаад өөрийнхөө явж байсан замын урсгал руу ороод зөрж өнгөрөх боломж бүрэн байсаар байхад энэ боломжоо ашиглаагүй нь санаатайгаар уг гэмт хэргийг үйлдсэн байх үндэслэлтэй тул хуулийн дагуу үнэн зөв шалгаж шийдвэрлэх, Б.Ц нь тухайн гэмт хэргийг үйлдэх үедээ Жолоочийн даатгалын тухай 4.13-т заасан "Жолоочийн хариуцлагын даатгалд даатгуулаагүй жолооч замын хөдөлгөөнд оролцохгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн нь уг гэмт хэргийг үйлдэх үндсэн шалтгаан нөхцөл болсныг хуулийн дагуу үнэн зөв хянаж шийдвэрлэх, ... дүүргийн цагдаагийн хэлтсийн албан бичгээр Гэмтэл согог судлалын үндэсний төвийн архиваас 2016 оны 8 дугаар сард хохирогч Ж.Ц, О.У, талийгаач У.М нарын өвчний түүхийг аваад хавтаст хэргийн материалд оруулалгүй алга болгосон хэргийг мөрдөн шалгаж шийдвэрлэн,

тэдгээр өвчний түүхүүдийг олж хавтаст хэрэгт оруулахыг хүссэн хүсэлтүүд байсан юм. Харин Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчид шинжээч Б.Л, Ө.Ш, С.П нарын хуурамч дүгнэлтүүдийг хуулийн дагуу бодитой авч үзээд, шат шатны прокурорууд нь тэдний "...хууль, дүрэм, журам зөрчсөн үйлдэлд хариуцлага тооцуулах..." гэсэн дүгнэлт гаргасан болон гэрчүүдийн мэдүүлгүүдийг үндэслэн Б.Л, Ө.Ш, С.П нарын худал хуурмаг дүгнэлтүүдийг нотлох баримтын хэмжээнд үнэлэлгүй, хэргийг үнэн зөвөөр шийдвэрлэсэн байв Мөн нийслэлийн прокурор Д.Б-ээс ирүүлсэн мэдэгдэх хуудаст "...шинжээч эмч Б.Л, Ө.Ш, замын цагдаагийн зохицуулагч Н.А нар хууль тогтоомж, түүний дагуу гаргасан дүрэм журмаар тодорхойлсон албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй..." гэжээ. Тиймээс эрүүгийн анхан шатны шүүхийн шүүх бүрэлдэхүүн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 79.4-т зааснаар нотлох чадвараа алдсан шинжээчдийн 7149, 639, 09шэ/018 дугаартай дүгнэлтүүдийг нотлох баримтын хэмжээнд үнэлээгүй гэж үзэх бүрэн үндэслэлтэй болно. Эдгээрээс дүгнэж үзэхэд шүүгч Б.Д, Г.Б, Б.С нар нь эрүүгийн хэргийн давах шатны шүүх хуралдааны "Энэхүү магадлалд гомдол гаргах эрхгүй болно" гэснийхээ далбаан дор хохирогч биднийг улам бүр чирэгдүүлж, сэтгэл санааны дарамт учруулан, хууль зөрчиж мөрдөн байцаагч Э.Б-гийн 2016 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн шинжээч томилох тогтоолоор нэмэлт болон дахин шинжилгээ хийснээс хойш /тэдгээр нэмэлт дахин шинжилгээ нь цусны дээжүүдийг устгасан байснаас болоод үндсэндээ хийгдээгүй/ нэг удаа дахин шинжилгээ хийх хүсэлт гаргаагүй байхад удаа дараа хүсэлт гаргасан мэтээр, бусад баримт, гэрчийн мэдүүлгүүдээр Б.Л, Ө.Ш, С.П нарын шинжилгээний дүгнэлтүүд нь нотлогдоогүй, иймээс нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэх боломжгүй болсон нь хавтаст хэргийн материалд авагдсан баримтуудаас илэрхий харагдаж байгааг үл харгалзан, яллагдагч Б.Ц-д илүү ашигтайгаар үйлчлэх, түүнд холбогдох хэргийн мөрдөн шалгаж шийдвэрлэх хугацааг зориудаар удаашруулах хувийн сонирхлын үүднээс давж заалдах шатны шүүхийн тэрхүү 26 дугаартай магадлалыг гаргасан гэж үзэх үндэслэлтэй байна. Энэ нь өнөөгийн шүүхийн шинэчлэлийн бодлого, зарчмууд болон шүүгч нарт тавигдаж буй хууль, ёс зүйн шаардлагуудтай илэрхий зөрчилдсөн хэрэг болсон тул хохирогчид бид гомдолтой байгаа болно.

Хоёр. Шүүгч Л.У-гийн талаар: Ф аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүх хуралдааныг 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр шүүгч Л.У даргалж 2017/ШЦТ/167 дугаартай тогтоол гаргасан болно. Энэхүү тогтоол нь ялтан Б.Ц-д холбогдох 201623000204 дугаартай эрүүгийн хэргийг өнөөгийн дагаж мөрдөж буй Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн үзэл санаа, зарчим, заалтуудыг бүрэн хэрэгжүүлж чадаагүй, улмаар ялтан ял завших боломж олгосон, хэт нэг талыг баримталсан гэж үзэх үндэслэлтэй тул гомдолтой байна. Үүнд:

Нийслэлийн тээврийн прокурорын газраас ялтан Б.Ц-д холбогдох эрүүгийн хэргийг 2015 оны Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 4.2-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж шүүхэд ирүүлснийг хянаж хэлэлцээд гаргасан шүүгч Л.У-гийн гарын үсэгтэй, 2017/ШЦТ/167 дугаартай, 180/2017/0026/Э индекс бүхий тэрхүү шийтгэх тогтоолын "тогтоох нь" гэсэн хэсгийн 3-т "2002 оны эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.5 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч Б.Ц-д оногдуулсан 6 жилийн хорих ялыг жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлсүгэй", мөн уг хэсгийн 5-д 2002 оны Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 63 дугаар зүйлийн 63.1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Б.Ц-д мөн хуулийн 215 дугаар зүйлийн 215.4 дэх хэсэгт зааснаар 6 жилийн хорих ял оногдуулсан энэхүү шийтгэх тогтоол биелүүлэхийг 2 жилийн хугацаагаар хойшлуулсугай" гэж Эрүүгийн хуулийг буруу хэрэглэн, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.7 дугаар зүйлд заасан "шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй",

"хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн", "хуулийн зүйл, хэсэг, заалтыг буруу тайлбарлаж хэрэглэсэн" заалтуудыг зөрчсөн байна. 2002 оны Эрүүгийн хуулийн 215.4 дэх хэсэгт тодорхойлсон ялын хэмжээ нь өнөөгийн мөрдөж буй Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 4.2-т заасан ялын хэмжээнээс их бөгөөд ялтны эрх зүйн байдлыг дээрдүүлэхгүй, хуулийг буцаан хэрэглэх эрх зүйн боломжгүй атал тийнхүү хуулийг буруу хэрэглэж, 2015 оны Эрүүгийн хуулийн 1.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "...оногдуулах ялыг хөнгөрүүлсэн гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг буцаан хэрэглэнэ." гэснийг зөрчсөн зэрэг нь ялтан Б.Ц-д ял завших, хохирогчдын бүрэн төлөгдөөгүй байгаа гэм хорын хохирлыг төлөхөөс зайлсхийх, оргож зугтаах боломжийг олгосон / шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан 2 жилийн хугацаанд ялтны эрхийн хязгаарлалт байхгүй/ байна.

2.3.Ялтан Б.Ц болон түүний хамсаатнуудын нөлөөгөөр үйлдсэн байх магадлалтай шинжээч эмч Ө.Ш, Б.Л, техникийн шинжээч С.П нарын 7149.09шэ/018, 639 дугаартай дүгнэлтүүдэд талийгаач ээж Ч.О-г хүү О.У-гийн хамт архи ууж согтууран зорчиж явсан мэтээр ИЛТ худал дүгнэлт гаргасан нь шинжээч, мөрдөн байцаагч, цагдаагийн бусад ажилтнуудын оролцоотой, зохион байгуулалттай шинжтэй хууль бус үйлдэл гэж үзэх үндэслэлтэй болно. Гэвч тэдгээрийн хууль бус үйлдлүүдтэй холбоотой шинээр илэрсэн нөхцөл байдлуудыг мөрдөн шалгах ажиллагааны явцад буюу 2017 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн гомдол, хүсэлтүүддээ хохирогч бид тодорхой бичсэн боловч мөрдөн байцаагч, прокурорууд нь хангаж өгөөгүй, мөн шинээр илэрсэн нөхцөл байдлыг үндэслэн Ф аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд хандан 2017 оны 10 дугаар сарын 14-ний өдөр бичсэн 14 төрлийн гомдол, 4 төрлийн хүсэлтүүддээ шинжээч Ө.Ш, Б.Л, С.П, мөрдөн байцаагч Г.П, В.Х нарт одоогийн мөрдөж буй Эрүүгийн хуулийн 21.2, 21.3, 22.1, 22.11 дүгээр заалтуудад зааснаар эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж шийдвэрлэхийг хүссэн хохирогч бидний хүсэлтийг шүүх хангаж өгсөнгүй. Хохирогч бидний 2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн гомдол хүсэлтүүдэд бичсэн баримт, мэдээллүүдийн "хүсэлт" гэсэн хоёр дахь хэсэгт "...Б.Ц-д холбогдох эрүүгийн хэргийг 2017 оны 7 дугаар сарын 1-ээс..." гээд "өмнө"... "байсан" гэж бичсэн үг нь хохирогч бидний сэтгэл санааны тогтворгүй хямралт байдлын улмаас эндүүрч ташаарч бичсэн зүйл /"2017 оны 7 дугаар сараас хойш мөрдөж эхэлсэн" гэж бичих атал үгийн тэрхүү алдаа гаргасан/ бөгөөд харин урьд өмнөх бусад гомдол хүсэлтүүд нь бүгд хуулийн үндэслэлтэй, баримт нотолгоотой байгаа болно.

2.4.Шинжээч Ө.Ш, Б.Л нарын 7149, 09шэ/018 дугаартай шинжилгээний дүгнэлтүүдэд талийгаач ээж Ч.О, хүү О.У нар тухайн өдөр согтуу зорчиж явсан мэтээр илэрхий худал дүгнэснийг хяналтын прокурор болон шүүгч Л.У нар нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан "Шинжилгээний дүгнэлтийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, өмгөөлөгч, прокурор, шүүх заавал баримтлах албагүй боловч дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа бол үндэслэлээ заасан байвал зохино." гэдэг заалтыг баримтлан үндэслэлээ тодорхой зааж өгөөгүй байна.

2.5.Шинжээч нартай холбоотой шинээр илэрсэн нөхцөл байдлаас үзэхэд Шинжээч Ө.Ш нь нэг удаагийн лацгүй ердийн хуруу шилэнд хийсэн О.У нарын цусны дээжийг бүртгэл судалгаанд авалгүй. хүндэтгэх шалтгаангүйгээр 25 хоног саатуулан, хаанахын, хэн гэдэг нь үл мэдэгдэх хүнээр Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн рүү илгээсэн гэх, чухамдаа яг бодитоор илгээсэн эсэх нь ч тодорхойгүй, цусны дээжийг өгч илгээсэн тэрхүү үл мэдэгдэх хүндээ хүлээлгэж өгсөн баримт байхгүй. О.У-гийн цусны дээжийн хэмжээг дагалдах бичигтээ 10 мл гэж бичсэн нь бусад мэдээллүүдээс зөрүүтэй, цусны дээж авхуулсан

тэмдэглэлд О.У нарын цусны дээжийн хэмжээг бичээгүй, мөрдөн байцаагч Г.П 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн шинжилгээ хийлгэх тогтоолдоо цусны дээжийн хэмжээг бас бичээгүй, Г.П-гийн уг тогтоолыг шинжээч Б.Л нь хүлээж аваагүй атлаа 7149 дугаартай дүгнэлтдээ "...тогтоолыг хүлээж авснаар худал бичиж хууран мэхлэхийг оролдсон. Тээврийн прокурорын газрын хяналтын прокурор О.Б-гийн Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд хандан дотоод хяналт шалгалт хийх тухай албан бичгийн хариуг тус хүрээлэнгээс ирүүлээгүй, хавтаст хэрэгт ийм утга бүхий баримт огт авагдаагүй, гэрч Р.Б гэгчээр "...илгээх бичиг ирүүлсэн бол тогтоол ирүүлдэггүй..." гэх мэтээр хууль, журмын эсрэг мэдүүлэг өгүүлсэн, гэрч хохирогч нарыг хамгаалалтад авах тухай хохирогчдын гомдол, хүсэлтийг хангаж өгөөгүй зэрэг илт хууль бус олон үйлдэл гарсан бөгөөд энэ бүхнийг хуулийн дагуу шударгаар хянаж шийдвэрлээгүй нь хавтаст хэргийн баримт мэдээллүүдээс тодорхой харагдаж байгаа болно. Иймээс хохирогчид бид мөрдөн шалгах ажиллагааны явцад талийгаач Ч.О, хүү О.У нарыг зориудаар тэр өдөр согтуу явсан болгож харагдуулахын тулд цусны дээжүүдэд нь архи спиртийн зүйл санаатайгаар хольж хийсэн, үүнийг нь нуун дарагдуулахыг оролдсон зохион байгуулалттай гэмт үйлдэл гэж үзэж байгаа бөгөөд энэхүү шүүхийн тогтоолын дүгнэлтэд ноцтойгоор нөлөөлж болох нөхцөл байдлыг шүүгч Л.У анхаарч үзэлгүй орхигдуулсан байна.

2.6.Нийслэлийн Т дүүргийн Цагдаагийн хэлтсийн С.У гарын үсэгтэй, "...тус хэлтэст шалгах шаардлагатай..." гэсэн агуулга бүхий албан бичгээр 2016 оны 8 дугаар сарын 19-нд Гэмтэл согог судлалын үндэсний төвийн архиваас О.У-гийн өвчний түүхийг хэн гэдэг нь үл мэдэгдэх гарын үсгээр бүртгүүлж аваад алга болгосон хэргийн мөрөөр шалгаж шийдвэрлэхийг хүссэн хохирогч бидний удаа дараагийн гомдол хүсэлтүүдийг мөрдөн байцаагч, хяналтын прокурор болон Тээврийн прокуророос хангаж өгөөгүй, энэ асуудал Улсын Ерөнхий прокурорын газарт хянагдаж эхлэх үед Б.Ц-д холбогдох 201623000204 дугаартай эрүүгийн хэргийг Ф аймаг дахь сум дундын эрүүгийн анхан шатны шүүхэд яаран шилжүүлсэн байх бөгөөд алга болсон тэрхүү өвчний түүхийн талаар эрүүгийн анхан шатны шүүхийн шүүгч Л.У хайхарч үзээгүйд хохирогчид бид гомдолтой байна. О.У-гийн алга болсон өвчний түүхтэй холбоотой хууль бус үйлдлүүд нь нууцын тухай багц хуулийг зөрчөөд зогсохгүй эрүүгийн хэргийн баримт мэдээллийг үрэгдүүлсэн, задруулсан эрүүгийн гэмт хэргийн шинжтэй үйлдэл бөгөөд үүнийг ялтан Б.Ц болон түүний хамсаатнуудаас үйлдсэн эсэхийг зайлшгүй шалгаж шийдвэрлэн, шүүхийн шийтгэх тогтоолын дүгнэлтэд тусгах шаардлагатай гэж үзэж байгаа болно.

2.7.Талийгаач ээж Ч.О, хүү О.У нар тухайн өдөр ослын улмаас хүнд гэмтэж, амь нас үрэгдсэн байдлыг далимдуулан тэднийг согтуугаар зорчиж явсан мэтээр үйлдсэн шинжээчдийн тэдгээр илт худал дүгнэлтүүд болон О.У-гийн дээрх өвчний түүх алга болсонтой холбоотой хууль бус үйлдлүүд нь Б.Ц-гийн ил далд оролцоотойгоор түүний авлига хээл хахуулаар хийгдсэн эсэхийг хохирогчдын гомдол хүсэлтийн дагуу бүрэн шалгаж тогтоогоогүй, 2016 оны 7 дугаар сарын 20-ны өдөр анх хэргийн газрын үзлэгийн үеэр хүрч очсон Б.Ц- нөхөр Б /нэгдүгээр хавтаст хэргийн материалд нөхөр Б гэж худал бичсэн/ болон түүнтэй хамт хэргийн газар К дүүргийн эмнэлэг дээр очсон төрөл садангийнх нь хүмүүсийн талаар хохирогчдын гомдол хүсэлтийн дагуу холбогдох баримт мэдээллүүдийг хавтаст хэрэгт татаж авалгүй, нуун дарагдуулж, мөн Б.Ц нь "Би нөхөртэйгөө ямар нэг харилцаа холбоо байхгүй" гэх мэтээр худал мэдүүлсээр байхад шүүгч Л.У нь 2017/ШЦТ/167 дугаартай, 180/2017/0026/Э индекс бүхий шийтгэх тогтоолдоо "... үйлдсэн гэмт хэрэгтээ чин санаанаас гэмшсэнийг хөнгөрүүлэх нөхцөл байдал болгон харгалзаж..." гэсэн нь үндэслэл муутай юм.

2.8. Шүүх хурлын явцад шүүгч Л.У нь хохирогч Б.О-д хандан "Яллагдагч худал мэдүүлэг өгөх эрхтэй" гэж хэлээд түүний яриаг тасалж байв. Шүүгчийн энэ үг нь яллагдагч, хохирогч нарт илэрхий ялгавартай хандсаны илэрхийлэл бөгөөд одоогийн мөрдөж буй аль ч хуульд "Яллагдагч худал мэдүүлэх эрхтэй" гэсэн зүйл заалт байхгүй байна. Иймд шүүгч Л.У нь хууль, дүрмийн заалтуудыг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй бөгөөд түүний хуулийг буруу хэрэглэсэн болон бусад хууль бус үйлдэл, эс үйлдэхүй нь Ф аймаг дахь сум дундын эрүү, иргэний хэргийн шүүхийн шүүгч Б.Д нарын нөлөөгөөр үйлдэгдсэн байж болзошгүй юм.

Гурав. Хүсэлт:

Ф аймгийн сум дундын эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүгч Б.Д нар болон тус аймаг дахь эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Л.У нар нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн зарчим заалтуудыг /Тухайлбал, уг дүрмийн "Шүүгч нь зохисгүй байдал гаргаж болохгүй бөгөөд тийнхүү ойлгогдохоос зайлсхийнэ", Шүүгч нь шүүх эрх мэдлийг шударга төвийг сахиж хэрэгжүүлнэ", "Шүүгч шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ хууль ёсонд захирагдаж, хуулийг хэрэглэнэ", "Хуульч нь мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хууль зүйн мэдлэг ур чадвартай байж нямбай, хариуцлагатай ажиллана" зэрэг заалтуудыг зөрчсөн, илэрхий зөрчсөн гэж үзэх үндэслэл болж буй дээрх нөхцөл байдал, зөрчлийн хэлбэрүүдийг хууль, дүрмийн дагуу нэг бүрчлэн хянаж, тэдгээр шүүгч нарт хариуцлага тооцон, хохирогч биднийг гомдолгүй болгож өгнө үү гэжээ.

Шүүгч Л.У Шүүхийн Ёс зүйн хороонд ирүүлсэн тайлбартаа:

Ф аймаг дахь Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Л.У миний бие нь Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлийн 4.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт холбогдсон шүүгдэгч Б.Ц-гийн хэргийг хянан шийдвэрлэсэн.

1. Эрүүгийн хууль, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл журмын дагуу Б.Ц-д холбогдох эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэж, шүүгдэгчийн анх удаа болгоомжгүй гэмт хэрэг үйлдсэн, үйлдсэн гэмт хэргээ шударгаар хүлээн зөвшөөрч, учруулсан хохирлыг тодорхой хэмжээгээр тухай бүрд нь төлж байсан зэргийг хуульд заасан үндэслэл журмын дагуу эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдал болгон харгалзсан, мөн шүүгдэгчийн хувийн байдал буюу 3 хүртэл насны хүүхэдтэй эх байсан учраас хуульд заасан үндэслэл журмын дагуу шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулахгүйгээр 2002 оны Эрүүгийн хуулийг хэрэглэж ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан. Энэ нь хууль зөрчсөн үйлдэл биш гэж үзэж байна.

2. Шинжээч Ө.Ш, Б.Л, С.П мөрдөн байцаагч Г.П, В.Х нарт шүүгч Л.У би эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж шийдвэрлэх үндэслэлгүй бөгөөд ийм хүсэлтийг хохирогч шүүх хуралдаанд гаргаагүй болно.

3. Б.Ц-д холбогдох хавтаст хэргийн материал буюу улсын яллагчийн яллах дүгнэлтээр талийгаач Ч.О, хүү О.У нарыг согтуу байсан эсэх энэ нь гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлсөн эсэх талаар дурдагдаагүй тул шүүх заавал хохирогч нарыг гэм буруу байгаа эсэхийг шалгаж тогтоох шаардлагагүй, эсхүл шинжээчийн дүгнэлтийг хохирогчид нийцүүлж заавал шийтгэх тогтоолд дурдаж баримталсан эсэх талаар дүгнэх шаардлагагүй ба энэ гэмт хэрэг нь болгоомжгүй үйлдэгдсэн болно.

4. Хохирогч нарын цусны дээжүүдэд санаатайгаар спиртийн зүйл хольж хийсэн, үүнийг нуун дарагдуулахыг оролдсон зохион байгуулалттай гэмт үйлдэл гэж үзэх эрүүгийн хэргийн шинжтэй нөхцөл байдлыг нотолж болох нотлох баримтууд хавтаст хэрэгт авагдаагүй байсан ба ажлын хариуцлага алдсан зохих албан тушаалтнуудад зохих дээд шатны эрх бүхий этгээдүүд хариуцлага тооцож арга хэмжээ авсан байсан бөгөөд энэ ажлын хариуцлага алдсан байдал нь шүүгдэгч

Б.Ц-тэй ямар нэгэн хэмжээгээр холбоотой, эсхүл Б.Ц зохион байгуулсан гэсэн ямар нэг үндэслэл нотлох баримт байгаагүй.

5.О.У-гийн өвчний түүх нэг хувь нь алга болсон гэх боловч хавтаст хэрэгт хохирогч О.У-гийн өвчний түүх гэсэн нотлох баримт хуульд заасан үндэслэл журмын дагуу хавсаргагдсан, түүнд үндэслэн хүчин төгөлдөр шинжээчийн дүгнэлт гарсан байсан тул шүүх заавал алга болсон гэж хохирогчоос яриад байгаа өвчний түүхийг эрэн хайх ач холбогдол өгөх шаардлагагүй.

6.Шүүгдэгч Б.Ц шүүхийн хэлэлцүүлэгт энэ осол гэмтэл миний буруугаас болсон, би үйлдсэн гэмт хэрэгтээ чин санаанаас гэмшиж энэ хүмүүст учруулсан хохирлыг өөрийн боломжийн хэрээр нөхөн төлж байгаа ба цаашид ч нөхөн төлнө гэж мэдүүлснийг шүүх чин санаанаас гэмшсэн гэж дүгнэсэн бөгөөд шүүгдэгч Б.Ц нь нөхөртэй буюу гэрлэсэн тухай нотлох баримт хавтаст хэрэгт авагдаагүй байсан тул шүүх Б.Ц-г хүүхдийн эцэг гэх хүнтэй харилцаа холбоотой эсэхийг тогтоох шаардлагагүй.

7. Шүүх хуралдаан эхлэхээс л хохирогч Б.О шүүгдэгч рүү дайрч давшилсан агуулгатай " чи 2 дээд боловсрол эзэмшсэн гэж ярьдаг, дээд боловсролтой зураач гээд байсан тэрийгээ яагаад хэлэхгүй байгаа юм бэ, чи нөхөртэй ш дээ осол болсны дараа утсаар ярьсан гэж тэнд байсан хүмүүс хэлдэг, чи худалч уу, угаасаа ийм худлаа ярьдаг зан чанартай юу гэх мэтээр шүүгдэгчийн үйлдсэн гэмт хэрэг болон шүүхийн хэлэлцүүлэгт өгсөн мэдүүлэгтэй холбогдуулан асуулт асуулгүйгээр хувийн байдал руу нь дайрч давшилж тулгасан зохимжгүй асуулт асууж байсан тул шүүх хуульд заасан "талууд шүүх хуралдаанд тэгш эрхтэй оролцоно" гэсэн зарчмыг баримталж хохирогчийн зохимжгүй асуултуудыг хязгаарлаж "Шүүгдэгч өөрийгөө өмгөөлж заавал үнэн зөв мэдүүлэг өгөх үүрэггүй, иймээс шүүхийн хэлэлцүүлэгт өгсөн мэдүүлэгтэй нь холбогдуулж асуултаа асуу, хувийн байдлыг тогтоох шаардлагагүй" гэж хэлсэн болохоос шүүгдэгч худлаа мэдүүлэг өгөх эрхтэй гэж хэлээгүй болно.

8.Уг эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхэд шүүгч Б.Д болон өөр хэн нэгний нөлөө байхгүй бөгөөд шүүгч би хуульд заасан үндэслэл журмын дагуу ажил үүргээ гүйцэтгэсэн болно гэжээ.

Шүүгч Б.Д Шүүхийн Ёс зүйн хороонд ирүүлсэн тайлбартаа:

Ф аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх ерөнхий шүүгч Б.Д, шүүгч Г.Б, Б.С нарын бүрэлдэхүүнтэйгээр Ф аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 31 дүгээр шийтгэх тогтоолыг эс зөвшөөрч, шүүгдэгч болон түүний өмгөөлөгчийн давж заалдах гомдлоор Б.Ц-д холбогдох эрүүгийн хэргийг 2017 оны 5 дугаар сарын 4-ний өдөр хянан хэлэлцэж шүүхээс тогтоол гарахад чухал ач холбогдолтой нөхцөл байдлыг бүрэн шалгалгүйгээр хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагааг гүйцэд биш хийсэн байхад хэргийг эцэслэн шийдвэрлэсэн нь буруу бөгөөд анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол нь хууль ёсны ба үндэслэл бүхий байх хуулийн шаардлагад нийцээгүй гэж үзээд Шүүхийн шинжилгээний хүрээлэнгийн 2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 7149, 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 639 тоот дүгнэлтүүд үндэслэлтэй эсэх нь эргэлзээтэй бөгөөд энэ талаар дахин шинжээч томилуулах талаарх хохирогчийн удаа дараагийн хүсэлтийг эцэслэн шийдвэрлээгүй байх тул хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцааж шийдвэрлэсэн юм.

Хохирогч нь тухайн үед Ёс зүйн хороонд гомдол гаргаагүй хэр нь хэрэгт нэмэлт мөрдөн байцаалт хийгдээд шүүхэд шилжиж ирэхийн /2018 оны 1 дүгээр сарын 3-ны/ өмнөхөн буюу 2017 оны 12 дугаар сарын 28-нд Ёс зүйн хороонд гомдол гаргаж байгаа нь шүүхийн шийдвэрт сэтгэл ханамжгүй учраас, нөгөө талаар хэрэг

эцэслэн шийдвэрлэгдээгүй үед шүүгч нарын хараат бус байдалд нөлөөлөх гэсэн оролдлого гэж үзэж байна.

Хохирогч нь 2016 оны 12 дугаар сараас хойш маргаантай байгаа асуудлаар гомдол хүсэлт гаргаж байгаагүй гэдэг нь худлаа бөгөөд 2017 оны 1 дүгээр сарын 18-нд яллах дүгнэлт үйлдэж хэргийг шүүхэд шилжүүлснээс хойш 1 дүгээр сарын 19, 24, 30-ны өдрүүдэд мөрдөн байцаалт дутуу хийгдсэн талаар удаа дараа гомдол хүсэлт гаргаж байсан. Мөн давж заалдах шатны шүүх хуралдааны үед шүүгдэгчийн өмгөөлөгчийн гаргасан хохирогч У, ээж О нар согтууруулах ундаа хэрэглэсэн байсан эсэхэд эргэлзээтэй талаарх тайлбар, хохирогч Б.О-гийн хохирогч нарын эрхийг ноцтой зөрчсөн талаар гаргасан тайлбар зэргийг харгалзан давж заалдах шатны шүүхээс хэргийг мөрдөн байцаалтад буцаасан юм. Хохирогч нь шүүхийн магадлалын зөвхөн үндэслэх хэсгийн хоёр дахь хэсэгт анхаараад нэгдэх хэсгийн "шүүхээс тогтоол гарахад чухал ач холбогдолтой нөхцөл байдлыг бүрэн шалгалгүйгээр хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагааг гүйцэд биш хийсэн байхад хэргийг эцэслэн шийдвэрлэсэн буруу" гэж үзсэн үндэслэлийг нь анхаарахгүй байгаа нь харамсалтай. Магадлалын дагуу хэрэгт хохирогчийн гомдлуудад дурдсан зарим дутуу ажиллагаануудыг мөрдөн байцаалтад хийгдээд ирсэн байгаа болно.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасан /Хэргийг хуучин хууль мөрдөж байх үед шийдвэрлэсэн/... шүүх нь хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор нотлохын тулд хуульд заасан бүх арга хэмжээг авч сэжигтэн яллагдагч шүүгдэгчийг яллах ба цагаатгах, эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх ба хөнгөрүүлэх нөхцөл байдлыг бүрэн тогтоох үүрэгтэй. Мөн хуулийн 95 дугаар зүйлийн 95.2-т зааснаар шүүх нь хууль болон эрх зүйн ухамсрыг удирдлага болгож нотлох баримтыг тал бүрээс нь нягт нямбай, бүрэн гүйцэд, бодит байдлаар нь хянаж үзсэний үндсэн дээр нотлох баримтыг өөрийн дотоод итгэлээр үнэлж, хэргийг хараат бус байж, гагцхүү хуульд захирагдан шударгаар шийдвэрлэсэн гэж үзэж байна.

Шүүгч Г.Б Шүүхийн Ёс зүйн хороонд ирүүлсэн тайлбартаа:

Шүүгч Г.Б би хохирогч Б.О-гийн Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан гомдлыг 2018.03.19-ны өдөр хүлээн авч танилцаад дараах тайлбарыг гаргаж байна.

Миний бие Ф аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 31 дүгээр шийтгэх тогтоолыг эс зөвшөөрч шүүгдэгч, түүний өмгөөлөгч нарын давж заалдах гомдлоор шүүгдэгч Б.Ц-д холбогдох хэргийг хянан шийдвэрлэх давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдаанд ерөнхий шүүгч Б.Д, шүүгч Б.С нарын бүрэлдэхүүнтэйгээр орж, хэргийг хянан шийдвэрлэсэн.

Давж заалдах шатны шүүх №26 дугаарт магадлалаар хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагааг гүйцэд биш хийсэн, шүүхээс тогтоол гарахад чухал ач холбогдолтой нөхцөл байдлыг бүрэн шалгалгүйгээр хэргийг эцэслэн шийдвэрлэсэн нь буруу бөгөөд анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол нь хууль ёсны ба үндэслэл бүхий байх хуулийн шаардлагад нийцээгүй гэж дүгнээд, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 7149, 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 639 тоот дүгнэлтүүд үндэслэлтэй эсэх нь эргэлзээтэй, энэ талаар дахин шинжээч томилуулахаар хохирогчийн гаргасан хүсэлтийг эцэслэн шийдвэрлээгүй байсан тул хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцааж шийдвэрлэсэн юм.

Хэрэгт авагдсан нотлох баримтаар ХХХ улсын дугаартай саарал өнгийн Тоёота приус 20 маркийн машиныг О.У жолоодож явсан ба тэрээр мөрдөн байцаалт болон шүүхийн хэлэлцүүлэгт "химийн шинжээчийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй. Би согтууруулах ундааны зүйл хэрэглээгүй байсан, дараа нь

намайг архи уусан байсан гэсэн шинжээчийн дүгнэлтийг шүүгдэгчийг гаргуулсан байх гэж бодсон, маш их гомдолтой", хохирогч Ж.Ц-гийн " нөхөр О.У, ээж Ч.О нар согтууруулах ундаа хэрэглээгүй байсан" гэж мэдүүлснээс гадна энэ талаар хохирогч Б.О ч шүүх хуралдаан дээр шинжээчийн дүгнэлтийг зөвшөөрөхгүй талаараа тайлбар мэдүүлэг гаргаж байсан болно.

Иймээс давж заалдах шатны шүүх хуралдааны үед шүүгдэгчийн өмгөөлөгчийн гаргасан "хохирогч У, О нар тухайн үед согтууруулах ундаа хэрэглэсэн" эсэх талаарх тайлбар, хохирогч Б.О-гийн "хохирогч нарын эрхийг ноцтой зөрчсөн" талаар гаргасан тайлбар түүнчлэн хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагааг дутуу хийсэн, шүүхээс тогтоол гарахад чухал ач холбогдолтой нөхцөл байдлыг бүрэн шалгаагүй гэсэн үндэслэлээр хэргийг мөрдөн байцаалтад буцаасан.

Шүүх нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар "хууль болон эрх зүйн ухамсрыг удирдлага болгон нотлох баримтыг тал бүрээс нь нягт нямбай, бүрэн гүйцэд, бодит байдлаар нь хянаж үзсэний үндсэн дээр нотлох баримтыг өөрийн дотоод итгэлээр үнэлэх" ба хараат бус байж, гагцхүү хуульд захирагдан хэргийг шударгаар шийдвэрлэх зарчмыг ханган ажилласан гэж үзэж байна.

Шүүгч Б.С Шүүхийн Ёс зүйн хороонд ирүүлсэн тайлбартаа:

Ф аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Б.С би Ф аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 31 тоот шийтгэх тогтоолыг эс зөвшөөрч хохирогч Б.О болон түүний өмгөөлөгчийн давж заалдах гомдлоор Б.Ц холбогдох эрүүгийн хэргийг 2017 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр хүлээн авч, 2017 оны 5 дугаар сарын 4-ний өдөр ерөнхий шүүгч Б.Д, Х аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүгч Г.Б нарын бүрэлдэхүүнтэй хянан хэлэлцэж, хэргийг илтгэсэн юм. Шүүх бүрэлдэхүүн 26 дугаар магадлалаар Б.Ц-д холбогдох хэргийг мөрдөн байцаалтад буцаасан үндэслэл нь анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол нь хууль ёсны ба үндэслэл бүхий байх хуулийн шаардлагад нийцээгүй, тогтоол гаргахад чухал ач холбогдол бүхий нөхцөл байдлыг бүрэн шалгалгүйгээр мөрдөн байцаалтын ажиллагааг гүйцэд биш хийсэн байхад хэргийг эцэслэн шийдвэрлэснийг буруу гэж үзсэн.

Тухайлбал: Шүүхийн шинжилгээний хүрээлэнгийн 2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 7149, 11 сарын 16-ны өдрийн 639 тоот дүгнэлтүүд үндэслэлтэй эсэх нь эргэлзээтэй, энэ талаар дахин шинжээч томилуулах талаарх хохирогч Б.О-гийн удаа дараагийн хүсэлтүүдийг эцэслэн шийдвэрлээгүй нь хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаах гол үндэслэл болсон гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэсэн юм.

Хохирогч Б.О нь 2017 оны 01 дүгээр сарын 18-нд яллах дүгнэлт үйлдэж хэргийг шүүхэд шилжүүлснээс хойш 01 дүгээр сарын 19, 24, 30-ны өдрүүдэд мөрдөн байцаалт дутуу хийгдсэн талаар удаа дараа гомдол, хүсэлт гаргаж байсан.

Мөн давж заалдах шатны шүүх хуралдаанд О.У, талийгаач н.О нарыг согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхэд эргэлзээтэй талаарх тайлбарууд, Б.О-гийн хохирогч нарын эрхийг ноцтой зөрчсөн гэх талаарх тайлбар зэргийг харгалзан үзсэн юм. Гол нь шүүх бүрэлдэхүүн шүүхээс тогтоол гаргахад чухал ач холбогдолтой нөхцөл байдлыг бүрэн шалгалгүйгээр хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагааг гүйцэд биш хийсэн байхад хэргийг эцэслэн шийдвэрлэсэн нь буруу гэж үзсэний үндсэн дээр хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаасан бөгөөд давж заалдах шатны шүүхийн магадлал дээрх үндэслэлийн дагуу хэрэгт дутуу ажиллагаанууд мөрдөн байцаалтын шатанд хийгдсэн байсан.

Б.Ц-д холбогдох хэрэгт шүүх бүрэлдэхүүнд оролцсон шүүгчдийг хохирогч Б.О татгалзсанаар уг хэрэг одоо Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхэд шилжсэн.

Шүүх бүрэлдэхүүн бид бусдын нөлөөнд үл автан, хараат бус байж, гагцхүү хуульд захирагдан, хэргийг шударгаар шийдвэрлэж, хүний эрх, эрх чөлөөг ноцтой зөрчөөгүй гэж үзэж байна гэжээ.

Шүүгч Б.Д, Б.С нар Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанд гаргасан тайлбартаа:

Шүүхийн ёс зүйн хорооны 2018 оны 5 дугаар сарын 03-ны өдрийн 75 дугаартай Б.Д нарын шүүгчдэд сахилгын хэрэг үүсгэх тухай тогтоолыг эс зөвшөөрч дараах гомдлыг гаргаж байна.

Гомдол гаргагч Б.О нь Б.Д нарын шүүгчдийг Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.6 дугаар зүйлийн 1, 15.1 дүгээр зүйлийн 1.2, 15.2 дугаар зүйлийн 2, 15.4 дүгээр зүйлийн 1 дэх заалтуудыг зөрчсөн талаар гомдол гаргасан байхад Шүүхийн Ёс зүйн хорооны 75 тоот тогтоолд шүүгч нарыг Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2.1, 1.3.1 заалтуудыг зөрчсөн байж болзошгүй гэж дүгнэн сахилгын хэрэг үүсгэсэн нь үндэслэлгүй байна гэж үзэж байна.

Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хүчингүй болгосонд хохирогч О гомдолтой байгаа нь "шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлсэн эсэх"-тэй холбоотой байх бөгөөд энэ харилцаа нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулагдсан шүүгч, шүүх бүрэлдэхүүнээс шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэх явцтай холбоотой билээ. Шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлсэн эсэхтэй холбоотой гомдлыг хяналтын шатны журмаар шийдвэрлэх эсхүл хуульчийн хувьд мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил гаргасан эсэхийг Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмээр зохицуулдаг. Түүнчлэн шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 2-т "хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй", 5.1 дүгээр зүйлийн 6-д Шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаанаас бусад ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдлыг Шүүхийн Ёс зүйн хороо харьяалан шийдвэрлэнэ...", Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 20.3 дугаар зүйлийн 1-д мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил гэдэгт хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбогдсон хууль тогтоомж эсхүл энэ дүрмийн заалтыг 20.5 дугаар зүйлийн 8-д "мэргэжлийн хариуцлагын хороо энэ дүрмийг зөрчсөн эсэх маргаан ... шийдвэрлэнэ" гэж зохицуулснаас үзэхэд иргэн Б.О-гийн гомдлыг Ёс зүйн хороо харьяалан шийдвэрлэх нь эрх зүйн үндэслэлгүй гэж үзэж байна.

Давж заалдах шатны шүүх 26 тоот магадлалаар хэргийн нэмэлт мөрдөн байцаалтад буцаасан нь үндэслэлтэй эсэх, Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон Шүүхийн шинжилгээний тухай хуулийн зохих заалтуудыг зөрчсөн эсэх зэрэг асуудал нь дээр тайлбарласанчлан Шүүхийн Ёс зүйн хорооны хянаж дүгнэх асуудал биш харин шүүн таслах үүргээ биелүүлэх шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаа юм.

Давж заалдах шатны шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ тус шүүхэд гаргасан гомдол эсэргүүцэлд дурдсан зүйлээр хязгаарлахгүй, хэргийг бүхэлд нь хянадаг тул шүүгдэгч хохирогч нарын мэдүүлгүүд, хэрэгт авагдсан нотлох баримтад тулгуурлан хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа дутуу хийгдсэн, шүүхийн шийдвэрт нөлөөлж болох нөхцөл байдлыг бүрэн шалгаагүй байна гэж дүгнэж хэргийг мөрдөн байцаалтад буцаасан. Иймд шүүгдэгч Б.Ц-д холбогдох хэргийг Шүүгчийн ёс зүйн дүрэмд заасан хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, хууль дээдлэх, үнэнч шударга байх, аливаа асуудалд бодитой, төвийг сахисан байр сууринаас хандах, хараат бус байх, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандах, нууцыг задруулахгүй байх, мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх, мөн Шүүхийн ёс зүйн талаарх Бангалорын хараат бус байх, төвийг сахих, үнэнч шударга байх, зохистой

байх, тэгш байх зэрэг зарчмуудыг удирдлага болгон хянан шийдвэрлэснээрээ ёс зүйн алдаа гаргасан гэж үзэхгүй байна.

Давж заалдах шатны шүүх 2017 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн 26 тоот магадлал гарсан ба сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 6 сарын хугацаа өнгөрсөн байна.

Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцааж шийдвэрлэсэн нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийг хэрэглэхтэй холбоотой байх тул иргэн Б.О гомдолд үндэслэн шүүгч шүүгч Б.Д, Б.С, Г.Б нарт үүсгэсэн сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү гэжээ.

Шүүгч Г.Б Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанд гаргасан тайлбартаа:

Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2.1-д заасан "Шүүгч нь хэргийн оролцогчдод эрх тэгш, төвийг сахисан, хүнлэг ёсоор хандаж, хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлэхүйц харилцааны соёлыг эзэмшсэн байна", мөн дүрмийн 1.3.1 -д заасан "Шүүгч нь хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, хууль дээдлэх, үнэнч шударга байх, аливаа асуудалд бодитой, төвийг сахисан байр сууринаас хандах, хараат бус байх, үүрэг ажилдаа хариуцлагатай хандах, нууцыг задруулахгүй байх, мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх зэрэг зарчмуудыг хувийн зан чанар болгож төлөвшүүлнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн байж болзошгүй гэж дүгнэн шүүгч Б.Д, Б.С, Г.Б нарт сахилгын хэрэг үүсгэсэн Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 75 дугаар тогтоолыг эс зөвшөөрч дараах гомдлыг гаргаж байна.

Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хүчингүй болгож хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаахдаа "шүүгчид хэргийн материалтай бүрэн танилцаагүй, хохирогчийн хүсээгүй зүйлээр дүгнэлт хийсэн, анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хүчингүй болгохын тулд үндэслэлгүй дүгнэсэн, магадлалд гомдол гаргах эрхгүй гэж шийдвэрлэсэн, талийгаач хөнгөн зэргийн согтолттой байсан гэх илт худал дүгнэлтийг магадлалдаа огт дурдаагүй зэрэг нь хууль зөрчсөн, ёс зүйтэй үйлдэл биш гэж Б.О гомдолдоо дурджээ.

Тухайн үед хүчин төгөлдөр мөрдөж байсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 308 дугаар зүйлийн 308.2 дахь хэсэгт заасан "давж заалдах шатны шүүх гомдол эсэргүүцэлд дурдсан зүйлээр хязгаарлахгүй, хэргийг бүхэлд нь хянаж үзнэ", мөн хуулийн 95 дугаар зүйлийн 95.1 дэх хэсэгт заасан "шүүх тухайн хэрэгт хамааралтай, хуулийн дагуу цуглуулж бэхжүүлж авсан бүх нотлох баримтыг хэргийг хянан шийдвэрлэхэд хангалттай эсэхийг бүхэлд нь үнэлнэ" гэсэн хуулийн дагуу шүүгдэгч, хохирогч, гэрчүүдийн мөрдөн байцаалт, анхан болон давж заалдах шатны шүүхэд гаргасан мэдүүлэг, тайлбарууд, хэрэгт авагдсан нотлох баримтуудыг шинжлэн судалсны үндсэн дээр Б.Ц-д холбогдох хэрэгт тогтоол гаргахад ач холбогдол бүхий нөхцөл байдлыг бүрэн шалгаагүй, мөрдөн байцаалтын ажиллагаа бүрэн хийгдээгүй байна гэж үзээд тухайн хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаахаар шийдвэрлэсэн. Өөрөөр хэлбэл хэргийг бүхэлд нь хянаад дээрх дүгнэлтийг гаргаснаас биш, зөвхөн давж заалдах гомдол, тайлбарын хүрээнд дүгнээгүй. Түүнчлэн эцэслэн шийдвэрлээгүй хэрэгт шинжээчийн дүгнэлт илт буруу гарсан талаар ч юм уу, гэм буруугийн талаар ямар нэг эрх зүйн дүгнэлт хийх боломжгүй бөгөөд магадлалд гомдол гаргах эрхтэй эсэх нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн хүрээнд шийдвэрлэгдсэн болно.

Шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хуульд нийцсэн эсэх талаар гаргасан дээрх гомдлыг Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2.1, 1.3.1 -д заасан үндэслэлд хамааруулж шүүгч нарт сахилгын хэрэг үүсгэсэн нь үндэслэлгүй гэж үзэж байна. Шүүх хэргийг шийдэхдээ "нэг талыг барьсан, хувийн сонирхлоор хэрэг шийдсэн,

өмгөөлөгчийн тайлбарт хөтлөгдсөн.." гэх гомдол нь тухайн хүний өөрийнх нь дүгнэлт гэж ойлгогдож байна.

Шүүгчийн Ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 2-1 "хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй", мөн дүрмийн 5.1 дүгээр зүйлийн б-д "шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаанаас бусад ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдлыг Шүүхийн Ёс зүйн хороо харьяалан шийдвэрлэнэ" гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанаар гомдлыг хэлэлцээд ҮНДЭСЛЭХ нь:

Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 75 дугаар тогтоолоор шүүгч Б.Д, Б.С, Г.Б, Л.У нарт сахилгын хэрэг үүсгэжээ. Уг тогтоолыг эс зөвшөөрч шүүгч Б.Д, Б.С, Г.Б нар нийт гишүүдийн хуралдаанд тайлбар гаргасан байна. Шүүхийн Ёс зүйн хорооны тогтоол, шүүгчээс нийт гишүүдийн хуралдаанд гаргасан тайлбар, хэрэгт цугларсан бусад баримтад үндэслэн хэргийг хянан хэлэлцээд, Шүүхийн Ёс зүйн хорооны гомдол хянан хэлэлцэх хуралдаанаар шүүгч Л.У-д сахилгын хэрэг үүсгэсэн нь үндэслэлтэй гэж үзэв.

Ф аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх 2017 оны 5 сарын 04-ний өдөр Ц-д холбогдох эрүүгийн хэргийг хянан хэлэлцээд гаргасан магадлалдаа "Б.Ц-д холбогдох эрүүгийн тогтоол гарахад чухал ач холбогдолтой нөхцөл байдлыг бүрэн шалгалгүйгээр хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагааг гүйцэд биш хийсэн байхад хэргийг эцэслэн шийдвэрлэсэн нь буруу бөгөөд анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол нь хууль ёсны үндэслэл бүхий байх хуулийн шаардлагад нийцээгүй, "Шүүхийн шинжилгээний хүрээлэнгийн 2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 7149, 2016 оны 11 дүгээр сарын 16- ны өдрийн 639 тоот дүгнэлтүүд үндэслэлтэй эсэх нь эргэлзээтэй бөгөөд энэ талаар дахин шинжээч томилуулах талаарх хохирогчийн удаа дараагийн хүсэлтийг эцэслэн шийдвэрлээгүй гэх үндэслэлийг тус тус зааж хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаах нь зүйтэй гэж үзсэн улмаар Ф аймгийн сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 31 дүгээр шийтгэх тогтоолыг хүчингүй болгож хэргийг нэмэлт мөрдөн байцаалт хийлгэхээр Тээврийн прокурорын газарт буцаажээ.

Энэ талаар шүүгч Б.Д, Б.С, Г.Б нар Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанд гаргасан тайлбартаа: Давж заалдах шатны шүүх ... тоот магадлалаар хэргийн нэмэлт мөрдөн байцаалтад буцаасан нь үндэслэлтэй эсэх, Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон Шүүхийн шинжилгээний тухай хуулийн зохих заалтуудыг зөрчсөн эсэх зэрэг асуудал нь шүүн таслах үүргээ биелүүлэх шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаа юм. Давж заалдах шатны шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ тус шүүхэд гаргасан гомдол эсэргүүцэлд дурдсан зүйлээр хязгаарлахгүй, хэргийг бүхэлд нь хянадаг тул шүүгдэгч хохирогч нарын мэдүүлгүүд, хэрэгт авагдсан нотлох баримтад тулгуурлан хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа дутуу хийгдсэн, шүүхийн шийдвэрт нөлөөлж болох нөхцөл байдлыг бүрэн шалгаагүй байна гэж дүгнэж хэргийг мөрдөн байцаалтад буцааж шийдвэрлэсэн нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийг хэрэглэхтэй холбоотой гэжээ.

Гомдол гаргагчийн гомдлын агуулга, шүүгчдийн хариу тайлбар, Ф аймгийн Эрүү Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал /2017 оны 5 сарын 04 -ний өдрийн 26 дугаар магадлал/ хүчин төгөлдөр хэвээр байгаа ба түүний үндэслэл зэргийг харьцуулан дүгнэхэд шүүгч Б.Д, Б.С, Г.Б нар нь хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлж, мэргэжлийн үйл ажиллагаа явуулсан байна. Энэ нь Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 2-т заасан "ёс зүйн зөрчилд хамаарахгүй" заалт мөн дүрмийн "Шүүгч хуульд тусгайлан заасан

ёс зүйн зөрчил болохоор заасан болон шүүгчийн ёс зүйн дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн үйлдэл эс үйлдэхгүйг ёс зүйн зөрчил гэж үзнэ” гэсэн заалтуудад тус тус хамаарч байх тул шүүгч Б.Д, Б.С, Г.Б нарт ногдуулсан сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй гэж Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанд оролцсон бүрэлдэхүүн дүгнэв.

Гомдол гаргагч Б.О “...шүүгч Л.У нь ялтанд ял завших боломж олгосон, хэт нэг талыг баримталсан. Шүүх хурлын явцад хохирогч надад хандан “... яллагдагч худал мэдүүлэг өгөх эрхтэй” гэж хэлээд түүний яриаг тасалж байсан. Шүүгчийн энэ үг нь яллагдагч, хохирогч нарт илэрхий ялгавартай хандсаны илэрхийлэл бөгөөд одоогийн мөрдөж буй аль ч хуульд яллагдагч худал мэдүүлэх эрхтэй гэсэн зүйл заалт байхгүй байна гэж гомдолдоо дурджээ.

Шүүгч Л.У шүүгдэгч Б.Ц-д холбогдох эрүүгийн хэргийг 2017 оны 11 сарын 29-ний өдөр хянан шийдвэрлэж Ф аймаг дахь сум дундын шүүхийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолоор түүнийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчсөний улмаас 2 хүний амь нас хохироосон гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцож , 2015 оны эрүүгийн хуулийн 1.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан 2002 оны эрүүгийн хуулийн тусгай ангийн 215 дугаар зүйлийн 215.4 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Б.Ц-гийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 4 жилийн хугацаагаар хасаж ,6 жилийн хорих ялаар шийтгэж, хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг 2 жилийн хугацаагаар хойшлуулсан байна.

Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх дээрх шийтгэх тогтоолыг хянан хэлэлцээд гаргасан Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 3 сарын 13-ны өдрийн 243 дугаар магадлалд “хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхдээ О.Ц-гийн “2 хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан” гэмт хэргийн шинжийг орхигдуулж гэм буруутайд тооцсон, “Ц-гийн гэм буруугийн асуудлыг зөвлөлдөх тасалгаанд орж шийдвэрлээгүй нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 35.27 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгдэгчийн эцсийн үгийг сонссоны дараа шүүх шийдвэр гаргахаар зөвлөлдөх тасалгаанд орох”, 36.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “шүүх шийдвэрээ зөвлөлдөх тасалгаанд хэлэлцэж гаргах” тухай заалтууд хийгээд уг хуулийн 36.1 дүгээр зүйлийн 5 дах хэсэг, 5.1, 5.2, 5.3, 5.4 заалтуудыг зөрчсөн, мөн 36.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт “Шүүх шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон шийдвэрийг шүүх хуралдааны танхимд танилцуулж, тэмдэглэлд тусгуулсны дараа түүнд Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг хэлэлцэх шүүх хуралдааныг үргэлжлүүлэн явуулж болно “ гэж заасныг зөрчсөн зэрэг үндэслэлүүд заан тэмдэглэж , “Б.Ц-д холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэсэн Ф аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 11 сарын 29-ний өдрийн 167 дугаар шийтгэх тогтоолыг хүчингүй болгож Б.Ц-д холбогдох Эрүүгийн хэргийг дахин хянан шийдвэрлүүлэхээр мөн шүүхэд буцаасан байна.

Эдгээр хууль зөрсөн ажиллагаа Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 3 сарын 13-ны өдрийн 243 дугаар тогтоолоор тогтоогдсон, энэ нь Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1-д “Шүүгч нь хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, хууль дээдлэх, аливаа асуудалд бодитой хандах, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандах ,мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх зэрэг зарчмуудыг хувийн зан чанар болгож төлөвшүүлнэ” гэснийг зөрчсөн, дүрмийн 3.3 дугаар зүйлийн 1-д заасан “шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй” гэсэн албаны чиг үүргээ хэрэгжүүлээгүй гэж үзэх үндэслэлтэй.

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн зарчим, заалтуудыг, Тухайлбал, уг дүрмийн “Шүүгч нь зохисгүй байдал гаргаж болохгүй

бөгөөд тийнхүү ойлгогдохоос зайлсхийнэ", Шүүгч нь шүүх эрх мэдлийг шударга, төвийг сахиж хэрэгжүүлнэ", "Шүүгч шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ хууль ёсонд захирагдаж хуулийг хэрэглэнэ", "Хуульч нь мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хууль зүйн мэдлэг, ур чадвартай байж. нямбай, хариуцлагатай ажиллана" зэрэг заалтуудыг мөн " Шүүгчийн ёс зүйн дүрэм"-ийн 3.2.1-д "Шүүгч нь хэргийн оролцогчдод эрх тэгш, төвийг сахисан, хүнлэг ёсоор хандаж, хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлэхүйц харилцааны соёлыг эзэмшсэн байна", гэсэн заалтуудыг шүүгч Л.У мөн зөрчжээ. Шүүгч Л.У Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанд тайлбар ирүүлээгүй болно.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйл, 36 дугаар зүйлийн 36.1.1, 37 дугаар зүйлийн 37.1.2, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйл, Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.1, 5.13-т заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Ф аймгийн Эрүү, иргэний давж заалдах шатны шүүхийн шүүгч Б.Д, Б.С, Г.Б нарт холбогдох сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгосугай.

2.Ф аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Л.У-д сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

3.Энэ магадлалын хувийг шүүгч болон гомдол гаргагчид хүргүүлэхийг Ажлын албанд даалгасугай.

4.Шүүгч, гомдол гаргагч магадлалыг эс зөвшөөрвөл гардан авснаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ

ГИШҮҮН

Н.ЭРДЭНЭЦОГТ

А.ДОРЖГОТОВ

УИИ.МН
СУДАЛГААНЫ САН



ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ
МАГАДЛАЛ

2018 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 221/ЁМ2018/0001

Улаанбаатар хот

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны
магадлалыг хянасан тухай

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Батбаатар даргалж, шүүгч Ц.Цогт, Э.Лхагвасүрэн нарын бүрэлдэхүүнтэй, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Н.Өнө-Эрдэнэ, шүүгч Л.У-гийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Л.Б нарыг оролцуулан, Монгол Улсын шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн “Ф аймгийн Эрүү, Иргэний давж заалдах шатны шүүхийн шүүгч Б.Д, Б.С, Г.Б нарт холбогдох сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгож, Ф аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Л.У-д сахилгын шийтгэл ногдуулах тухай” 73 дугаар магадлалыг шүүгч Л.У-гийн гомдлоор, шүүгч Э.Лхагвасүрэнгийн илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Нэг. Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 75 дугаар тогтоолоор:

“Ф аймгийн Эрүү, Иргэний давж заалдах шатны шүүхийн шүүгч Б.Д, Б.С, Г.Б болон тус аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Л.У нарт сахилгын хэрэг үүсгэж” шийдвэрлэжээ.

Хоёр. Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 73 дугаар магадлалаар:

“Ф аймгийн Эрүү, Иргэний давж заалдах шатны шүүхийн шүүгч Б.Д, Б.С, Г.Б нарт холбогдох сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгож, тус аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Л.У-д сануулах сахилгын шийтгэл ногдуулсан” байна.

Гурав. Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны дээрх магадлалын холбогдох хэсгийг эс зөвшөөрч шүүгч Л.У 2018 оны 12 дугаар сарын 3-ны өдөр Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гаргасан гомдолдоо:

“...Шүүгч Л.У би шүүгдэгч Б.Ц-д холбогдох эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэж 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 167 дугаар шийтгэх тогтоолоор шүүгдэгч Б.Ц-г 2015 оны Эрүүгийн хуулийн 1.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 215 дугаар зүйлийн 215.4-д зааснаар гэм буруутайд тооцож, түүний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 4 жилийн хугацаагаар хасаж, 6 жилийн хорих ялаар шийтгэн, хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг 2 жилийн хугацаагаар хойшлуулж шийдвэрлэсэн.

Энэхүү шийтгэх тогтоолыг хохирогч Б.О эс зөвшөөрч давж заалдсаныг Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх хянан хэлэлцээд 167

дугаар шийтгэх тогтоолоор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-д заасныг зөрчсөн гэж үзэн шийтгэх тогтоолыг хүчингүй болгон тус эрүүгийн хэргийг мөрдөн байцаалтад буцаасан.

Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалаар надад Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1-д “Шүүгч нь хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, хууль дээдлэх, аливаа асуудалд бодитой хандах, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандах мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх зэрэг зарчмуудыг хувийн зан чанар болгож төлөвшүүлнэ”, 3.3 дугаар зүйлийн 1-д “Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж биелэлтэд хяналт тавих үүрэгтэй”;

-Мөн Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн “шүүгч нь зохисгүй байдал гаргаж болохгүй бөгөөд тийнхүү ойлгогдохоос зайлсхийнэ”, “шүүгч нь шүүх эрх мэдлийг шударга төвийг сахиж хэрэгжүүлнэ”, “шүүгч шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ хууль ёсонд захирагдаж хуулийг хэрэглэнэ”, “Хуульч нь мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хууль зүйн мэдлэг, ур чадвартай байж нягт нямбай, хариуцлагатай ажиллана”, “шүүгч нь хэргийн оролцогчдод эрх тэгш, эвийг сахисан, хүнлэг ёсоор хандаж, хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлэхүйц харилцааны соёлыг эзэмшсэн байна” гэж заасныг тус тус зөрчсөн гэж дүгнэн сахилгын сануулах шийтгэл оногдуулсан.

Тэгвэл магадлалын үндэслэл болгоод байгаа Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалд заасан хуулийн заалтууд нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 35.27 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч О.Ц /Ёс зүйн хорооны магадлалд О.Ц гэжээ/ биш Б.Ц-д холбогдох эрүүгийн хэргийн шүүх хуралдааныг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасныг баримтлан хэлэлцүүлж “шүүгдэгчийн эцсийн үгийг сонссоны дараа шүүгч шийдвэр гаргахаар зөвлөлдөнө” гэдгийг хурлын танхимд байгаа хүмүүст зарлан мэдэгдэж зөвлөлдөх тасалгаанд орж, мөн хуулийн 36.5 дугаар зүйлийн 5.1, 5.2, 5.3, 5.4-д заасны дагуу Б.Ц-гийн үйлдсэн гэмт хэрэг нь болгоомжгүйгээр үйлдэгдсэн эрүүгийн гэмт хэрэг мөн, шүүгдэгчийг гэм буруутайд тооцох үндэслэлтэй тул гэм буруутайд тооцож, шүүгдэгчийн үйлдсэн гэмт хэрэг нь 2002 оны Эрүүгийн хуулийн 215 дугаар зүйлийн 215.4-д зааснаар зүйлчлэгдэнэ гэж үзэн 2015 оны Эрүүгийн хуулийн 1.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан зүйлчилж тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 4 жилийн хугацаагаар хасаж, 6 жилийн хорих ял оногдуулан, хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг жилийн хугацаагаар хойшлуулж шүүгдэгчээс 5.238.176 төгрөгийг гаргуулж хохирогч нарт олгохоор, нотлох баримтгүйгээр нэхэмжилсэн 75,0 сая төгрөгийг нотлох баримтаа бүрдүүлсний дараа жич нэхэмжлэх эрхийг нээлттэй үлдээж шийдвэрлэсэн нь 167 дугаар шийтгэх тогтоолын тогтоох хэсэг болон шүүх хуралдааны тэмдэглэлд тусгагдсан шүүгдэгч Б.Ц-гийн шүүх хуралдаанд эцсийн үг болгож хэлсэн “хийсэн хэрэгтээ гэмшиж байна” гэсэн үгээр нотлогдож байна.

Харин Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.1 дүгээр зүйлийн дахь хэсэгт “шүүх шүүгдэгчийг гэм буруутайд тооцсон шийдвэрийг шүүх хуралдааны танхимд танилцуулж, тэмдэглэлд тусгуулсны дараа түүнд Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг хэлэлцэх шүүх хуралдааныг үргэлжлүүлэн явуулж болно” /“үргэлжлүүлэн явуулна” гэж тусгайлан заагаагүй “үргэлжлүүлэн явуулж болно” гэж сонгох санцтайгаар/ гэж заасан тул шүүх хуралдааны хэлэлцүүлгийн шатанд шүүгдэгч Б.Ц нь гэм буруугийн талаар маргаагүй, үйлдсэн гэмт хэргээ хүлээн зөвшөөрч, гэм буруутай үйлдэлдээ гэмшиж буйгаа илэрхийлснийг үндэслэн шүүх шүүгдэгчийг

гэм буруутай эсэх талаар зөвлөлдөхөөр зөвлөлдөх тасалгаанд орох шаардлагагүйгээр гэм буруутай гэж үзээд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 35.27 дугаар зүйлийн 1-д зааснаар шүүгдэгчийн эцсийн үгийг сонссоны дараа шүүх шийдвэр гаргахаар зөвлөлдөх тасалгаанд орж шийдвэрээ 36.5-д зааснаар гаргасан.

Иймээс би өөрийгөө “хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, хууль дээдлэх, аливаа асуудалд бодитой хандах, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандах, мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх зэрэг зарчмуудыг хувийн зан чанар болгож төлөвшүүлнэ”, “хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй” гэсэн албаны чиг үүргээ хэрэгжүүлээгүй” гэж үзсэн үндэслэлүүдийг хүлээн зөвшөөрөхгүй байна.

Мөн би шүүх хуралдааны явцад шүүгдэгч Б.Ц-г “шүүгдэгч нь худлаа хэлэх эрхтэй” гэж огт хэлээгүй харин хуульд заасан “шүүх хуралдаанд оролцогч тал тэгш эрхтэйгээр шүүх хуралдаанд оролцоно” гэсэн зарчмыг баримталж, шүүгдэгч шүүх хуралдаанд заавал үнэн зөв мэдүүлэг өгөх үүрэггүй тул хохирогч та хувийн байдалтай нь холбогдуулахгүйгээр асуултаа өөрөөр асууна уу гэж шүүх хуралдааны дэгтэй холбогдуулан хохирогчид тайлбарлан хэлсэн. Түүнээс биш “шүүгдэгч Б.Ц худлаа ярих эрхтэй шүү, асуултаа зогсоо” гэж хэлээгүй.

Учир нь хохирогч Б.О шүүхэд эрүүгийн хэрэг шилжин ирсэн цагаас л өөрт таалагдахгүй үйлдэл бүр дээр тухайлбал “шүүх хурлыг хурдан товлолоо”, “миний уулзаж хараагүй прокурорыг хуралд оруулах гэж байна”, “би А хотод байна. Би очиж чадахгүй шүүх хурлын тэмдэглэл, шүүгчийн захирамж, тайлбаруудыг над руу факсаар явуул” гэх мэтчилэн шүүхэд ямар нэг давуу эрх эдлэх зорилготой үйлдлүүдийг удаа дараа гаргаж байсан.

Ийм санаа зорилготойгоос шүүх хурал дээр шүүгдэгч рүү хэт дайрч “Чи өмнөх шүүх хуралдаан дээр дээд боловсролтой зураач гэсэн биз дээ. 2 дээд сургууль төгссөн зураач, нэг нь нягтлан бодогч гээд байсан яагаад одоо зураач, дээд боловсролтой гэдгээ хэлэхгүй байгаа юм бэ, 2 өмгөөлөгчтэй байсан биз дээ, чи төрөлхийн худалч зантай юу, чи худлаа яриад байна, чи нөхөртэй ш дээ, чиний нөхөр гээд хүн хэргийн газар ирсэн гээ биз дээ, чамд хорих ял л тохиромжтой, өөр чамайг хүмүүжүүлэхгүй” гэх мэтчилэн дайрсан давшилсан үйлдэл гаргаж байсан тул шүүх зохисгүй үйлдлийг зогсоож асуултаа “шүүгдэгчийн үйлдсэн хэрэгтэй холбогдуулж зохистой асууна уу, шүүгдэгч заавал үнэн зөв мэдүүлэг өгөх үүрэггүй” гэж хохирогчид сануулж хэлсэн.

Шүүгчийн энэ үг “хэргийн оролцогчдод эрх тэгш, төвийг сахисан, хүнлэг ёсоор хандаж, хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлэхүйц харилцааны соёлыг эзэмшсэн байна” гэснийг зөрчсөн үйлдэл гэж үзэхгүй.

Шүүгч хүн шүүх хуралдааны даргалагчийн хувьд шүүх хуралдааны оролцогч нарыг хуралдааны дэгийг сахиулах үүрэгтэй, энэ үүргийнхээ дагуу шүүх хуралдааны оролцогч нарыг тэгш эрхтэй байх нөхцөлийг хангаж хохирогч талд давуу эрх эдлүүлэхгүйгээр шүүх хуралдааны дэгийг сахиулах үйлдэл хийсэн гэж үзэж байна.

Мөн шүүгчид сахилгын хэрэг үүсгэх тухай шүүхийн Ёс зүйн хорооны тогтоолд “Харин дээрх нэр бүхий шүүгч нар гомдол гаргагчийн Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах болон шүүгчийн ёс зүйн дүрмийн зарчим, заалтуудыг зөрчсөн тухай гомдолд тайлбар гаргаагүй гэсэн байсан ба шүүгч нар бүгд гомдол гаргагчийн үндэслэл болгоод байгаа гомдлын агуулга бүр дээр тайлбараа хүргүүлсэн, би ч мөн адил гомдлын агуулгыг тайлбарлан, дугаар бүрчлэн тайлбар гаргасан тул Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах болон шүүгчийн ёс зүйн дүрмийн зарчим заалтуудыг зөрчсөн тухай

гомдолд тайлбар гаргаагүй гэж дурдсан нь үндэслэлгүй, хуульчийн болон шүүгчийн ёс зүйн алдаа гаргаагүй гэдгээ тайлбарлан хүргүүлсэн.

Ёс зүйн хорооны магадлал нь хохирогчийн дэврүүлэн хэлсэн үгэнд хэт автсан гэж үзэхэд хүргэж байна. Ёс зүйн хороонд гомдол гаргагч Б.О нь зөвхөн шүүхийн шийдвэрт гомдолтой байгаа бөгөөд шүүгдэгч Б.Ц-д хорих ял оногдуулах л хүсэлтэйн улмаас шүүгч нарыг хардаж хорих ял оногдуулаагүй шүүгч нарыг бүгдийг нь ёс зүйн алдаа гарсан гэж үзэн гомдол гаргасан бөгөөд сахилгын хэрэг үүсгэсэн шийдвэрийг би мэдээгүй, тайлбар хүргүүлэх боломжгүй байхад надаас ямар нэг тайлбар авалгүйгээр шууд сануулах арга хэмжээ авсан нь үндэслэлгүй.

Би 2018 оны 2 дугаар сарын 20-ны өдрөөс ээлжийн амралтаа аваад улмаар үргэлжлүүлэн жирэмсний амралт авч 2018 оны 5 дугаар сарын 11-ний өдөр А хотын нэгдүгээр амаржих төрөх газар хүүхэд төрүүлж, үргэлжлүүлэн хүүхэд асрах амралтаа аваад А хотын Т дүүрэгт 2018 оны 8 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл оршин сууж байгаад түүнээс хойш 11-06 сартай 3 хүүхдээ асрамжлан Ф аймагт оршин сууж байна.

Сахилгын хэрэг үүсгэсэн хуралдаан болсныг би мэдээгүй, энэ тухай надад мэдэгдсэн зүйлгүй, намайг хүүхдээ төрүүлээд А хотод нялх биетэй төрөөд 10 хоноогүй байхад “Гарт нь” гэсэн бичиг ирлээ танд яаж хүргүүлэх вэ гэж туслах холбогдсон. Сануулах сахилгын арга хэмжээ авах хуралдааныг ч надад мэдэгдсэн зүйлгүй. 2018 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр миний туслах байсан А-гаар дамжуулан энэхүү магадлалыг гардан авч эс зөвшөөрөн гомдол гаргаж байна.

Дээрх давж заалдсан гомдлоо тоймлон цөөн үгээр илэрхийлбэл гомдол гаргагч Б.О нь зөвхөн хорих ял оногдуулж шийдвэрлээгүй шүүхийн шийтгэх тогтоолд гомдсон гомдлын улмаас шүүгч нарыг төсөөллөөр хардаж ёс зүйн алдаа гаргасан гэж үзэн гомдол гаргаад байгаа болохоос шүүгч, шүүхийн үйл ажиллагааны улмаас гомдол гаргагчийн эрх ноцтойгоор зөрчигдсэн, хохирсон зүйлгүй. Гомдол гаргагч нь шийтгэх тогтоолд гомдолтой байгаа тохиолдолд хуульд заасны дагуу шат шатны шүүхэд давж заалдах болон хяналтын журмаар хандах боломжтой.

Иймээс Шүүхийн Ёс зүйн хорооны сануулах шийтгэл оногдуулсан магадлалыг хүчингүй болгож өгнө үү” гэжээ.

ХЯНАВАЛ:

Ф аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Л.У-гийн хянан шийдвэрлэсэн, 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 167 дугаар Б.Ц-д холбогдох 201623000204 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцаасан Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 243 дугаар магадлалд анхан шатны шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн гэж дүгнэхдээ:

-шүүгдэгч Б.Ц-гийн үйлдэлд хамаарах ялын дээд хэмжээ шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27.10 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 4.2-т зааснаар багассан байхад 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 215 дугаар зүйлийн 251.4 дэх хэсэгт зааснаар зүйлчилж Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн;

-Шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль үйлчилж байгаа цаг хугацаанд шүүх Б.Ц-д оногдуулсан хорих ялыг 2002 оны Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлийн

52.5 дахь хэсэгт зааснаар жирийн дэглэмд оногдуулж Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн;

-яллах дүгнэлтэд заасан "...Тоёото приус загварын ХХХ улсын дугаартай тээврийн хэрэгсэлд шууд 7.095.000 төгрөгийн, У.М, Э.Г нарын эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан..." гэх нөхцөл байдлын талаар дүгнэлт хийгээгүй, мөн шийтгэх тогтоолын Тогтоох хэсэгт Б.Ц-гийн 2 хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан гэмт хэргийн шинжийг нь орхигдуулж гэм буруутайд тооцсон;

-хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхдээ Б.Ц-гийн гэм буруугийн асуудлыг зөвлөлдөх тасалгаанд орж шийдвэрлээгүйгээс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 35.27 дугаар зүйлийн 1, 36.1 дүгээр зүйлийн 1, 36.1 дүгээр зүйлийн 5 болон 36.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт "шүүх шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон шийдвэрийг шүүх хуралдааны танхимд танилцуулж, тэмдэглэлд тусгуулсны дараа түүнд Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг хэлэлцэх шүүх хуралдааныг үргэлжлүүлэн явуулж болно" гэж заасныг тус тус зөрчсөн гэж үзсэн байдаг.

Гэтэл давж заалдах шатны шүүхийн магадлалаар тогтоогдсон эдгээр зөрчлийн талаар анх Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн Л.У нарын нэр бүхий 4 шүүгчид "Сахилгын хэрэг үүсгэх тухай" 75 дугаар тогтоолд "...Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох заалтыг ноцтой зөрчсөн нь шүүгч Л.У хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой байжээ" гэж дүгнэсэн атлаа түүнд сахилгын шийтгэл ногдуулсан мөн оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 73 дугаар магадлалд "... Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 243 дугаар тогтоолоор тогтоогдсон дээрх хууль зөрчсөн ажиллагааг гаргаснаараа шүүгч Л.У нь Шүүхийн ёс зүйн дүрмийн болон Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн заалтуудыг зөрчсөн байна" гэж өөр хоорондоо уялдаагүй, зөрчилдсөн дүгнэлт хийсэн байна.

Харин Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн зүгээс шүүгч Л.У эрүүгийн хэргийг шийдвэрлэхдээ гаргасан "зөрчил"-ийг шүүгчийн ёс зүйн бус хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой алдаа, зөрчилд хамааруулах нь зүйтэй гэж үзэв.

Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн тогтоолоор хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан нь үүний хангалттай нотолгоо бөгөөд хэрэв шүүгчийн гаргасан зөрчил нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны гэхээс илүүтэй ёс зүйн зөрчилд хамаарахаар байсан бол энэ нь давж заалдах шатны шүүхээс шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаах шууд үндэслэл болохгүй.

Шийдвэрлэсэн хэрэг нь давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хүчингүй болсныг ёс зүйн зөрчил гаргасанд тооцвол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчих, ёс зүйн дүрэм зөрчихийн ялгаа, үр дагавар үгүй болно.

Тухайлбал, Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1-д "Шүүгч хуульд тусгайлан ёс зүйн зөрчил болохоор заасан болон энэ дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг ёс зүйн зөрчил гэж үзнэ", мөн зүйлийн 2.1 "Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй", 5.1 дүгээр зүйлийн 6-д "Шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаанаас бусад ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдлыг Шүүхийн Ёс зүйн хороо харьяалан шийдвэрлэнэ" гэж зааснаас үзэхэд шүүгч Л.Уянгын гаргасан зөрчил нь ёс зүйн зөрчилд үл хамаарна.

Харин шүүх хуралдааны явцад хохирогч Б.О-д хандаж “...яллагдагч худал мэдүүлэг өгөх эрхтэй гэж хэлсэн...” гэж шүүгч Л.У-г гомдол гаргагчийн зүгээс буруутгадаг боловч энэ талаар сахилгын шийтгэл хүлээлгэсэн тогтоолд огт дүгнээгүй, гэхдээ хавтаст хэрэгт авагдсан Ф аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүх хуралдааны 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн тэмдэглэлийн 10 дахь талд:

“... Даргалагчаас: Хохирогчоо шүүгдэгчийн үйлдсэн гэмт хэрэгтэй нь холбогдуулан мэдүүлгээс нь асууна. Шүүгдэгчийн хувийн байдлыг тогтоох шаардлагагүй. Учир нь шүүгдэгч үнэн мэдүүлэг өгөх үүрэггүй байдаг. Та шүүгдэгчийн мэдүүлэгтэй холбогдуулан асуултаа асуу.

Хохирогч Б.О: Шүүгдэгч нь худлаа яриад байгаа учраас бид уучилж чадахгүй байгаа юм. Шүүгдэгчийн хувийн байдлыг харж бид уучилна. Өөр асуултгүй...” гэсэн нь тус тус бичигдсэн байгаагаас гадна тухайн өдрийн шүүх хуралдааны видео бичлэгийг шүүж үзэхэд шүүгч Л.У гомдолд дурдсан болон шүүгчийн ёс зүйг зөрчсөн яриа, үйлдэл гаргасан гэх нөхцөл байдал тогтоогдсонгүй.

“Шүүгдэгч үнэн мэдүүлэг өгөх үүрэггүй” гэж хэлснийг гомдолд дурдсанчлан “худал мэдүүлэг өгөх эрхтэй” гэсэн утгаар бус харин Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 14/-т “...Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, ...ыг хориглоно”, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Яллагдагч өөрийн эсрэг мэдүүлэг өгөх, гэмт хэрэг үйлдсэн гэм буруугүйгээ, эсхүл хэргийн байдлыг нотлох үүрэг хүлээхгүй”, 3 дахь хэсгийн “Яллагдагчийг өөрийнх нь эсрэг мэдүүлэг авахаар албадахыг хориглоно” гэж заасантай холбож ойлгож болохоор байна.

Түүнчлэн шүүгч Л.У-аас Шүүхийн ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанд тайлбар гаргаагүйг сахилгын хэрэг үүсгэснийг хүлээн зөвшөөрсний илэрхийлэл гэж үзэх, энэ нь түүнд сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болохгүй. Учир нь Б.О-гийн Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан гомдлыг эс зөвшөөрч анх шүүгч Л.У-аас бичгийн тайлбар гаргасан нь сахилгын хэрэг үүсгэсэн тогтоолд тусгагдсан байдгаас гадна энэхүү тогтоолыг 2018 оны 5 дугаар сарын 22-ны өдөр шуудангаар хүргүүлэхээс 11 хоногийн өмнө тэр бээр амаржиж, үргэлжлүүлэн хүүхэд асрах чөлөөтэй байснаас тайлбар гаргаж чадаагүй талаар шүүхэд гаргасан гомдолдоо дурджээ.

Иймд Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалаар шүүгч Л.У-д сануулах сахилгын шийтгэл ногдуулсныг үндэслэлгүй гэж дүгнэн, түүний гаргасан гомдлыг хангаж шийдвэрлэв.

Харин Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 243 дугаар магадлалаар шүүгч Л.У-гийн хэрэг хянан шийдвэрлэхдээ гаргасан зөрчлийг нэгэнт тогтоосон, энэхүү магадлал хуулийн хүчин төгөлдөр байгаа тохиолдолд магадлалд заасан зарим зөрчлийн талаарх түүний гомдлын үндэслэлд тусгайлан дүгнэх шаардлагагүй гэж үзлээ.

Давж заалдах шатны шүүх хуралдааны товыг гомдол гаргагч Б.О-д хуулийн хугацаанд мэдэгдсэн боловч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд оролцоогүй болохыг, хэргийн 92-93 дахь талд авагдсан Шүүхийн Ёс зүйн хорооны гишүүний “Даалгавар өгөх тухай” захирамж огноо, тамгагүй байгааг, мөн магадлалд шүүгдэгч Б.Ц-гийн овгийн үсгийг “О” гэж алдаатай бичсэн зэргийг тус тус тэмдэглэв.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.2, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсэгт заасныг удирдлага болгон,

ТОГТООХ нь:

1. Монгол Улсын шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн “Ф аймгийн Эрүү, иргэний давж заалдах шатны шүүхийн шүүгч Б.Д, Б.С, Г.Б нарт холбогдох сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгож, Ф аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Л.У-д сахилгын шийтгэл ногдуулах тухай” 73 дугаар магадлалын Тогтоох хэсгийн 2 дахь заалтыг хүчингүй болгож, 1 дэх заалтын “...Г.Б, ...” гэсний дараа “Л.У” гэж нэмэн, “3”, “4” дэх заалтын дугаарыг “2”, “3” гэж өөрчлөн шүүгч Л.У-гийн гомдлыг хангасугай.

2. Магадлалын Тогтоох хэсгийн 1 дэх заалтад дээрх байдлаар өөрчлөлт оруулснаар шүүгч Л.У-д холбогдох сахилгын хэрэг хэрэгсэхгүй болох тул сахилгын хэрэг үүсгэсэн Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 75 дугаар тогтоолын түүнд холбогдох хэсгийг хүчингүй болгох шаардлагагүй болохыг дурдсугай.

3. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.5, 123 дугаар зүйлийн 123.2 дахь хэсэгт зааснаар давж заалдах шатны шүүх хууль буруу хэрэглэсэн, эсхүл хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн нь шүүхийн шийдвэр гаргахад нөлөөлсөн гэж үзвэл хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч нар магадлалыг гардаж авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор Улсын Дээд шүүхийн захиргааны хэргийн танхимд хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.БАТБААТАР

ШҮҮГЧ

Ц.ЦОГТ

ШҮҮГЧ

Э.ЛХАГВАСҮРЭН

UIN.MN
СУДАЛГААНЫ САН



МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЁС ЗҮЙН ХОРООНЫ МАГАДЛАЛ

2018 оны 3 сарын 30 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

Ф аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн
анхан шатны шүүхийн шүүгч Т.Э-д сахилгын
шийтгэл ногдуулах тухай

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааныг дарга Н.Эрдэнэцогт даргалж, гишүүн О.Мөнхсайхан, Ч.Оюунцэцэг, В.Жавхлан, А.Доржготов нарын бүрэлдэхүүнтэй, шүүгч Т.Э, хяналт шалгалт хариуцсан референт Б.Энхбаатар, хуралдааны тэмдэглэл хөтлөгчөөр шинжээч А.Энхбаатар нарыг оролцуулан, Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдааны танхимд хийж, Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 32 дугаар тогтоолыг эс зөвшөөрч шүүгч Т.Э-гийн гаргасан гомдлыг үндэслэн сахилгын хэргийг Ёс зүйн хорооны гишүүн В.Жавхлангийн илтгэснээр хянан хэлэлцээд **ТОДОРХОЙЛОХ** нь:

Шүүхийн Ёс зүйн хороонд иргэн С.Э-ээс гаргасан гомдолдоо: “С.Э миний бие нь 2016 оны орон нутгийн сонгуульд Ф аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 5-р тойрогт өөрийн итгэл үнэмшлээрээ аймгийнхаа хөгжлийн төлөө Монгол Ардын Намаас нэр дэвшин, Ардчилсан Намаас нэр дэвшигч З.О-той өрсөлдсөн юм.

Сонгуулийн сурталчилгаа эхэлсэн цагаас дуусах хүртэл хугацаанд АН-аас нэр дэвшигч З.О нь удаа дараа сонгуулийн хуулийг зөрчиж, сонгогчдын саналыг худалдан авах байдлаар бохир арга хэрэглэн 11 хүний саналаар луйвардаж, ялсныг тус тойргийн иргэд гэрчилдэг. Иймд миний бие хууль ёсны дагуу Цагдаагийн байгууллагад гомдол гаргаж, тэрхүү гомдлын дагуу тухайн байгууллагаас шалгасны эцэст нэр дэвшигч З.О-г олон нотлох баримтаар илтэд булхайтай үйлдэл хийснийг илрүүлэн шүүхийн байгууллагад шилжүүлсэн юм.

Гэвч Ф аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүгч Т.Э нь илтэд АН-аас нэр дэвшигчийн талд ажилласан болно. Учир нь Цагдаагийн байгууллагаас холбогдох материал, нотлох баримтыг хавсаргаж өгсөөр байхад авч хэлэлцээгүй, хэргийг хурдан шийдвэрлэхгүй хоног хугацаа хожих зорилгоор цагдаа руу хоёр ч удаа буцааж, хөөн хэлэлцэх хугацааг санаатайгаар хэтрүүлэн 2016 оны 9-р сарын 30-ы өдөр намайг өрөөндөө дуудан ирүүлж, тодруулга хийх нэрээр доог тохуу хийж, "тэгээд нэр дэвшигч сонгуулийн сурталчилгааны хугацаанд хүмүүстэй уулзаж болдоггүй юм уу, намайг дэмжээрэй гэж хэлж яагаад болохгүй гэж, олон хүн цугларсан газар очиж бас болохгүй юу" гэх мэтээр шүүгч хүнээс гарахгүй ёс зүйгүй үйлдлүүд гаргаж, харин хууль зөрчсөн үйлдэл болгон нь бодит баримттай, гэрчтэй байхад З.О-ийн тэгээгүй гэсэн тайлбараар хэргийг хэрэгсэхгүй болгож, нэг талыг барьсан шийдвэр гаргаж, тухайн өдрөө шийдвэр хүлээн авсан хуудсанд гарын үсэг зуруулж шийдвэрээ надад гардуулсан боловч гэнэт засварлах шаардлага гарлаа хэмээн буцаан аваад сарын 5-д надад дахин өгсөнд гомдолтой байна. Мөн хөөн хэлэлцэх хугацааг санаатайгаар дуусган тодруулга хийсэн зэрэг нь шударга

үнэнийг дэнслэгч шүүгчийн ёс зүйд нийцэхгүй тул хариуцлага алдсан шүүгч Т.Э-д арга хэмжээ авч энэ хэргийг нягтлан шалгаж өгнө үү.

Миний хувьд ард иргэдийн төлөөлөл нь хуулийг эрхэмлэн дээдэлж, сонгогчдын итгэлийг хүлээсэн хүн байдаг гэдэгт эргэлзэхгүй байна. Иймд зөв шийдвэр гарна гэдэгт итгэж байна. Гаргасан гомдлоо дэмжиж байна.” гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хороонд шүүгч Т.Э ирүүлсэн болон хуралдаанд гаргасан тайлбартаа: “Ф аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Т.Э миний бие нь иргэн С.Э-гийн Монгол Улсын шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан гомдолтой танилцаад дараах тайлбарыг гаргаж байна. Ф аймаг дахь Цагдаагийн Хэлтсээс 2016 оны 8 сарын 17-ны өдрийн № 34/1053 тоот албан бичигтэй "Тус хэлтэст 2016 оны аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн 5 дугаар тойрогт Монгол Ардын Намаас нэр дэвшсэн С.Э-ээс ирүүлсэн "Ардчилсан намаас нэр дэвшигч З.О нь тойрогтоо хийсэн сурталчилгааны ажилдаа хууль зөрчин бусармаг арга ашигласан нь баримтаар нотлогдож байгаа бөгөөд энэ үйлдэлдээ сонгуулийн тухай хуулийн 70.1.1, 70.1.3, 70.1.7, 70.5.2 дахь заалтуудыг зөрчсөн" гэх гомдлыг хүлээн авч шалгахад нэр дэвшигч З.О-г сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн гэж үзэж арга хэмжээ тооцуулахаар хүргүүлэв" гэх зөрчлийн материалыг 2016 оны 08 сарын 17-ны өдөр хүлээн авсан.

1. 2016 оны 08 сарын 18-ны өдөр холбогдогч З.О гэх хүнийг дуудуулж, шүүгчийн туслах Я.М-ээр тэмдэглэл хөтлүүлэн тайлбар авсан. 2016 оны 8 сарын 18-ны өдөр 03 дугаартай шүүгчийн захирамж гарган тодорхой ажиллагаа хийлгүүлэхээр Ф аймаг дахь Цагдаагийн хэлтэст буцаасан.

2. Ф аймаг дахь Цагдаагийн Хэлтсээс дээрх шүүгчийн захирамжид дурдсан ажиллагаануудыг хийж 2016 оны 9 сарын 27-ны өдөр №34/1260 албан бичгээр ирүүлснийг хүлээн авч 2017 оны 09 сарын 28-ны өдөр холбогдогч З.О гэх хүнийг дуудаж, шүүгчийн туслах Я.М-ээр тэмдэглэл хөтлүүлэн тайлбар авсан. 2016 оны 09 сарын 28-ны өдөр гомдол гаргагч С.Э-ээс тайлбар авахаар шүүгчийн туслах Я.М-ээр дуудуулсан боловч "А хотод хүүхэд хагалгаанд ороод эмнэлэгт байна маргаашаас гарах байх маргааш орой ажил тарахаас өмнө очъё" гэж хэлсэн байна. Мөн 2016 оны 09 сарын 29-ны өдөр дахин дуудуулахад "хүүхэд эмнэлгээс гараад одоо А хотоос гарах гэж байна маргааш өглөө 09 цагт шүүх дээр бэлэн байна" гэж хэлсэн. Энэ талаар тэмдэглэл болгон шүүгчийн туслах Я.М үйлдсэн. Ингээд 2016 оны 09 сарын 30-ны өдөр С.Э гэх хүнээс шүүгчийн туслах Я.М-ээр тэмдэглэл хөтлүүлэн тайлбар авсан. Ингэж тайлбар авахдаа иргэн С.Э гэх хүний гомдолд дурдагдсан шиг доог тохуу хийж "тэгээд нэр дэвшигч сонгуулийн сурталчилгааны хугацаанд хүмүүстэй уулзаж болдоггүй юм уу, намайг дэмжээрэй гэж хэлж яагаад болохгүй гэж хэлж яагаад болохгүй гэж, олон хүн цугларсан газар очиж бас болохгүй юу" гэх зэргээр асуугаагүй болно. Уг хүн нь өгсөн тайлбартайгаа танилцаж хуудас нэг бүр дээр өөрийнхөө гарын үсгийг зурсан.

3. Холбогдогч З.О холбогдох захиргааны зөрчлийн материалыг 2016 оны 09 сарын 30-ны өдөр 04 дугаартай шүүгчийн захирамжаар З.О-г захиргааны хариуцлагаас чөлөөлөх шийдвэр гаргасан. Уг шүүгчийн захирамжийг иргэн С.Э нь 2016 оны 10 сарын 07-ны өдөр гардаж авсан. Уг захирамжийг гардуулсны дараа засварлах шаардлагатай гэж буцаан авсан зүйл байхгүй болно.

Иргэн С.Э нь 2016 оны 10 сарын 10-ны өдөр Ф аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж уг зөрчлийн материалыг Ц аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд шилжүүлсэн байна. Ц аймгийн Эрүү, Иргэний давж заалдах шатны шүүхийн 2016 оны 11 сарын 18-ны өдрийн 74 дугаартай магадлалаар З.О-д холбогдох захиргааны зөрчлийг хэлэлцэж Ф аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2016 оны 09 сарын 30-ны өдрийн 04 дугаартай шүүгчийн захирамжийг хүчингүй болгож

захиргааны зөрчлийн материалыг дахин хэлэлцүүлэхээр Ф аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд буцааж шийдвэрлэсэн.” гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны гомдол хянан хэлэлцэх хуралдаанаар хэлэлцээд ҮНДЭСЛЭХ нь:

Шүүхийн Ёс зүйн хороонд иргэн С.Э нь Ф аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Т.Э-д холбогдуулан “арга хэмжээ авч энэ хэргийг нягтлан шалгаж өгнө үү” гэсэн гомдлыг гаргажээ. Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 02 дүгээр сарын 02-ны өдрийн 32 дугаар тогтоолоор шүүгч Т.Э-д сахилгын хэрэг үүсгэж шийдвэрлэсэн нь үндэслэлтэй байна.

Гомдолд дурдсан үндэслэлийг шалгахад Ф аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр 04 тоот захирамжаар С.Э-гийн гомдлоор З.О-д холбогдох зөрчлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ. Энэхүү захирамжид С.Э давж заалдах гомдол гаргаснаар Цаймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 74 тоот магадлалаар З.О-г захиргааны хариуцлагаас чөлөөлсөн тухай захирамж нь “хууль ёсны бөгөөд үндэслэлтэй байх шаардлага хангаагүй, зөрчил гаргагч болон гомдол гаргагчийг зөрчлийг хянан шийдвэрлэхдээ биечлэн оролцуулаагүй, З.О-д холбогдох зөрчлийн материалд тал бүрээс үндэслэл бүхий дүгнэлт хийгээгүй” гэж дүгнэж, захиргааны зөрчлийн тухай материалыг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаахаар шийдвэрлэжээ. Ф аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 12 дугаар сарын 09-ны өдөр 10а тоот захирамжаар З.О-гийн гаргасан зөрчил нотлогдсон боловч хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр зөрчлийн материалыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Шүүгч шүүгч Т.Э-гийн эсрэг гаргасан гомдлыг шийдвэрлэхийн тулд 2014 оны Шүүгчийн ёс зүйн дүрэм (цаашид “ШЁЗД” гэх)-д тусгасан хоёр янзын зарчмыг тайлбарлах шаардлагатай. Нэг талаас, энэ дүрмийн 1.4-р зүйлийн 1-д “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй” гэж заасан нь шүүгчийн хууль буруу хэрэглэсэн алдаанд хариуцлага хүлээлгэхгүй байх зарчмыг тунхагласан хэрэг. Энэ зарчим нь шүүгч аливаа хэрэг, маргааныг буруу шийдвэрлээд хариуцлага хүлээчих вий гэсэн айдасгүйгээр хууль зүйн хувьд хамгийн зөв гэсэн үндэслэлийнхээ дагуу хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх боломжийг шүүгчид олгодог учраас шүүгчийн хараат бус байдлын нэг баталгаа болдог билээ. Нөгөө талаас, хуульд захирагдах зарчмыг ягштал баримтлахыг шүүгчид үүрэг болгодог. Монгол Улсын Үндсэн хуулийн 1-р зүйлийн 2-т төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмын нэг бол хууль дээдлэх гэж заасан бөгөөд шүүн таслах нь төрийн үйл ажиллагаанд багтдаг учраас энэ зарчмыг шүүгч биелүүлэх үүрэгтэй. Тийм учраас, Үндсэн хуулийн 49-р зүйлийн 1-д “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана” гэж тодорхой заасан. Мөн, хууль дээдлэх зарчим нь процессын хуулиуд болон Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд ч тусгалаа олсон. Түүнчлэн, ШЁЗД-ийн 1.3-р зүйлийн 1-д зааснаар “хууль дээдлэх” зарчмыг хувийн зан чанар болгон төлөвшүүлэхийг шүүгчид үүрэг болгоод зогсохгүй энэ дүрмийн 3.3-р зүйлд “Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй” гэж тодорхой заасан. Өөрөөр хэлбэл, шүүгч аливаа хэрэг, маргааныг дур зоргоороо биш зөвхөн хуулийг хэрэглэж, хууль зүйн үндэслэлээр хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэйг эдгээр эрх зүйн эх сурвалжид бичжээ.

Шүүгчийн хууль буруу хэрэглэсэн алдаанд хариуцлага хүлээлгэхгүй байх зарчим болон хуульд захирагдах зарчим хоёрын зохицлыг хангах нь амаргүй ажил. Эхний зарчмыг хэт баривал шүүгчийн хараат бус байдал нэрийн дор хуульд

захирагдалгүй шийдвэр гаргадаг шүүгчийн хариуцлагагүй байдлыг дэвэргэнэ. Хоёр дахь зарчмыг хэтэрхий баривал шүүгчийн хараат бус байдалд халдах эрсдэлтэй. Тиймээс, Шүүхийн Ёс зүйн хорооноос шүүгчийн ёс зүйн онолд байдаг утгаар энэ хоёр зарчмын уялдааг хангаж хэрэглэх шалгуур тогтоосон. Тодруулбал, зөвхөн дараах хоёр нөхцөлийн аль нэг хангагдсанаас бусад тохиолдолд шүүгчийн хууль хэрэглэсэн алдаанд хариуцлага хүлээлгэхгүй (ШЁЗД-ийн 1.3 дахь хууль дээдлэх зарчим, 3.3-р зүйл дэх хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх үүргийг зөрчсөний төлөө сахилгын шийтгэл хүлээлгэхгүй): (1) Үндсэн хуулиар илэрхий хамгаалагдсан үндсэн эрх, эрх чөлөөг зөрчсөн; (2) хэн ч маргахгүй хуулийн тодорхой заалтыг ноцтой эсхүл удаа дараа зөрчсөн. Хууль зүйн туслалцаа авах эрхийг нь мэдсээр байж хангахгүй байх, давж заалдах гомдол гаргах эрхийг огт эдлүүлэхгүй байх нь эхний нөхцөлийн жишээ. Маргааны нэг талтай нөгөө талыг байлцуулахгүйгээр уулзахыг илэрхий хориглосон Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27.1.17-г зөрчиж маргааны нэг талтай ганцаарчлан уулзаж хэргийн талаар ярих нь хоёр дахь нөхцөлийн жишээ.

Хууль хэрэглээний ямар алдааг шүүгчийн ёс зүйн зөрчилд тооцохыг тогтоох дээрх шалгуурыг Шүүхийн Ёс зүйн хороо төдийгүй Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх болон Улсын Дээд шүүхийн Захиргааны танхим хүлээн зөвшөөрсөн хэд хэдэн шийдвэр гаргасан байдаг. Тухайлбал, Шүүхийн Ёс зүйн хорооны 2016 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 55 дугаартай магадлалаар Захиргааны хариуцлагын тухай хуулийн зөрчлийг хянан шийдвэрлэхдээ “зөрчилд холбогдогчийн шүүх ажиллагаанд биеэр оролцох үндсэн эрхийг зөрчсөн” шүүгчид сануулах шийтгэл ногдуулсан юм. Уг магадлалыг Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2017 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 180 дугаар тогтоолоор хэвээр үлдээж, сануулах сахилгын шийтгэл хүчин төгөлдөр болсон гэдгийг дурдах нь зүйтэй. УДШ-ийн энэ тогтоолдоо “эдгээр процессын ажиллагаанууд нь шүүгчээс өдөр тутамд хэрэг маргаан болгоны хувьд хийдэг, хэнд ч ойлгомжтой, тодорхой, мэргэжлийн ур чадвар, туршлага шаардахааргүй бөгөөд тэдгээрийг хэрэгжүүлээгүй хууль хэрэглээний алдаа биш” хэмээн тусгайлан заасан. Мөн, “Яллагдагч Ч.Э-д батлан даалтад авах таслан сэргийлэх арга хэмжээ авахдаа яллагдагчид эрх, үүргийг нь тайлбарлаж өгсөн эсэхэд хяналт тавиагүй, ...цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахдаа захирамжид гомдол гаргах эрхийг заагаагүй, яллагдагчийн эрүүл мэндийн байдал, сэтгэл санааны хүндрэлтэй байдлыг харгалзан үзээгүй”-ээрээ шүүгчийн ёс зүйн зөрчил гаргасан хэмээн шүүгч Л.Ц-д сануулах сахилгын шийтгэлийг ШЁЗХ ногдуулсан магадлал гаргасныг ЗХДЗШШ болон УДШ-ийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаан тус тус хэвээр үлдээсэн.¹¹

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 4 дүгээр зүйлийн 4.1.5, 16 дугаар зүйлийн 16.1-д тус тус зааснаар шүүгч Т.Э нь “хүний эрх”-ийг хуулийн хүрээнд дээдлэх, хамгаалах үндсэн үүрэгтэй байна. Шүүгч нь зөрчил гаргагч болон гомдол гаргагчийн шүүх ажиллагаанд биеэр оролцох болон хууль зүйн туслалцаа авах үндсэн эрхүүдийг зөрчсөн гэж бүрэлдэхүүн дүгнэв. Ф аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр 04 тоот захирамжаар С.Э-гийн гомдлоор З.О-д холбогдох зөрчлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэхдээ зөрчил гаргагч болон гомдол гаргагч зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаанд биечлэн оролцох болон хууль зүйн туслалцаа авах эрхүүдийг эдлүүлээгүй байна (Ц аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 74 дүгээр магадлал). Тиймээс, Монгол Улсын Үндсэн хуулийн 16.14-д иргэн “хэргээ шүүх ажиллагаанд

11 ШЁЗХ-ны магадлал, Дугаар 74, 2014.11.27; ЗХДЗШШ-ийн магадлал, Дугаар ш/11, 2015.04.15; УДШ-ийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол, Дугаар 145, 2015.06.08.

биеэр оролцох, хууль зүйн туслалцаа авах” үндсэн эрхийг баталгаатай эдэлнэ гэж заасан, Захиргааны хариуцлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлд “зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд биеэр оролцох, нотлох баримттай танилцах, зөрчлийн талаар тайлбар өгөх, нотлох баримт, хүсэлт гаргах, хууль зүйн туслалцаа авах” эрхтэй, мөн хуулийн 17 дугаар зүйлийн 1.6 дахь хэсэгт “холбогдох этгээдэд зөрчлийг хянан хэлэлцэх өдөр, цаг, газрыг мэдэгдсэн эсэх” гэж тус тус заасан хуулийн зохицуулалтыг зөрчсөн гэх үндэслэлтэй байна.

Дээрх нөхцөл байдал, цугларсан материалаас дүгнэхэд Ф аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Т.Э нь шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1.3.1-ийн “Шүүгч нь хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, хууль дээдлэх” гэснийг, мөн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 3.3.1-ийн “Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй” гэснийг зөрчсөн гэж бүрэлдэхүүн дүгнэв. Иймд, шүүгч Т.Э-д Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1-д заасан сахилгын арга хэмжээний сануулах сахилгын шийтгэл ногдуулахаар тогтов.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35, 36 дугаар зүйл, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйл, Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5.7.1, 5.13-т заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Ф аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Т.Э-д “сануулах” сахилгын шийтгэл ногдуулсугай

2.Энэ магадлалын хувийг шүүгч болон гомдол гаргагчид хүргүүлэхийг тус хорооны Ажлын албанд даалгасугай.

3.Магадлалыг эс зөвшөөрвөл гардан авснаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.

ДАРГАЛАГЧ

ГИШҮҮН

Н.ЭРДЭНЭЦОГТ

В.ЖАВХЛАН

UIN.MN
СЭДЭЛГ ААНЫ САН



ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ
МАГАДЛАЛ

2018 оны 6 сарын 21 өдөр

Дугаар 221/ЁМ2018/0017

Улаанбаатар хот

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны
2018 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн
24 дүгээр магадлалын тухай

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааныг шүүгч Ц.Сайхантуяа даргалж, шүүгч Э.Лхагвасүрэн, шүүгч Э.Зоригтбаатар нарын бүрэлдэхүүнтэй, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Т.Даваажаргал, Ф аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Т.Э нарыг оролцуулан хийж, Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн Ф аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Т.Э-д сахилгын шийтгэл ногдуулах тухай” 24 дүгээр магадлалыг шүүгч Т.Э-гийн гаргасан давж заалдах гомдлоор, шүүгч Э.Зоригтбаатарын илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 24 дүгээр магадлалаар: Ф аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Т.Э-д “сануулах” сахилгын шийтгэл ногдуулжээ.

Шүүгч Т.Э давж заалдах гомдолдоо: “Ф аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Т.Э миний бие нь Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 24 дугаартай магадлалыг 2018 оны 5 дугаар сарын 21-ний өдөр хүлээн аваад гомдол гаргаж байна. Үүнд:

Нэг. Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэсэн ажиллагааны талаар:

Ф аймаг дахь Цагдаагийн Хэлтсээс 2016 оны 8 дугаар сарын 17- ны өдрийн №34/1053 дугаартай албан бичигтэй “Тус хэлтэст 2016 оны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн 5 дугаар тойрогт Монгол Ардын намаас нэр дэвшсэн С.Э-с ирүүлсэн “Ардчилсан намаас нэр дэвшигч З.О нь тойрогтоо хийсэн сурталчилгааны ажилдаа хууль зөрчин бусармаг арга ашигласан нь баримтаар нотлогдож байгаа бөгөөд энэ үйлдэлдээ Сонгуулийн тухай хуулийн 70.1.1, 70.1.3, 70.1.7, 70.5.2 дахь заалтуудыг зөрчсөн” гэх гомдлыг хүлээн авч шалгахад нэр дэвшигч З.О-г Сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн гэж үзэж арга хэмжээ тооцуулахаар хүргүүлэв” гэх зөрчлийн материалыг 2016 оны 8 дугаар сарын 17- ны өдөр хүлээн авсан.

2016 оны 08 дугаар сарын 18-ны өдөр холбогдогч З.О гэх хүнийг дуудуулж, шүүгчийн туслах Я.М-ээр тэмдэглэл хөтлүүлэн Захиргааны хариуцлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1, 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-т заасны дагуу тайлбар авсан. Ингээд 2016 оны 08 дугаар сарын 18-ны өдөр 03 дугаартай шүүгчийн захирамжаар уг зөрчлийн хэрэгт тодорхой ажиллагаа хийлгүүлэхээр Ф аймаг дахь Цагдаагийн хэлтэст буцаасан.

Ф аймаг дахь Цагдаагийн хэлтсээс дээрх шүүгчийн захирамжид дурдсан ажиллагаануудыг хийж, зөрчлийн хэргийг 2016 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр №34/1260 дугаартай албан бичгээр ирүүлснийг хүлээн авч 2016 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр холбогдогч З.О гэх хүнийг дуудаж, шүүгчийн туслах Я.М-ээр тэмдэглэл хөтлүүлэн Захиргааны хариуцлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1, 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-т заасны дагуу тайлбар авсан. Мөн 2016 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр гомдол гаргагч С.Э-ээс тайлбар авахаар шүүгчийн туслах Я.М-ээр дуудуулсан боловч А хотод хүүхэд хагалгаанд ороод эмнэлэгт байна. Маргаашаас гарах байх маргааш орой ажил тарахаас өмнө очъё гэж хэлсэн байна. 2016 оны 09 дүгээр сарын 29-ны өдөр дахин дуудуулахад “хүүхэд эмнэлгээс гараад одоо А хотоос гарах гэж байна. Маргааш өглөө 09 цагт шүүх дээр бэлэн байна” гэж хэлсэн. Энэ талаар тэмдэглэл болгон шүүгчийн туслах Я.М үйлдсэн.

Ингээд 2016 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр С.Э гэх хүнээс шүүгчийн туслах Я.М-ээр тэмдэглэл хөтлүүлэн Захиргааны хариуцлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1, 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-т заасны дагуу тайлбар авсан. Ингэж тайлбар авахдаа иргэн С.Э гэх хүний гомдолд дурдсан шиг доог тохуу хийж “тэгээд нэр дэвшигч сонгуулийн сурталчилгааны хугацаанд хүмүүстэй уулзаж болдоггүй юм уу, намайг дэмжээрэй гэж хэлж яагаад болохгүй гэж, олон хүн цугларсан газар очиж бас болохгүй юу” гэх зэргээр асуугаагүй болно. С.Э нь уг тайлбартайгаа танилцаж хуудас нэг бүр дээр өөрийнхөө гарын үсгийг зурсан.

Холбогдогч З.О-г 2016 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр 04 дугаартай шүүгчийн захирамжаар захиргааны хариуцлагаас чөлөөлөх шийдвэр гаргасан. Уг шүүгчийн захирамжийг иргэн С.Э нь 2016 оны 10 дугаар сарын 07-ны өдөр гардан авсан. Дээрх захирамжийг гардуулсны дараа засварлах шаардлагатай гэж буцаан авсан зүйл байхгүй.

Иргэн С.Э нь 2016 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Ф аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж уг зөрчлийн хэргийг Ц аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд шилжүүлсэн байна. Ц аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 74 дугаартай магадлалаар З.О-д холбогдох захиргааны зөрчлийг хэлэлцэж Ф аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2016 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 04 дугаартай шүүгчийн захирамжийг хүчингүй болгож, захиргааны зөрчлийн материалыг дахин хэлэлцүүлэхээр Ф аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд буцааж шийдвэрлэсэн.

Хоёр. Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 24 дугаартай магадлалын талаар:

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 24 дугаартай магадлалд “...Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 4 дүгээр зүйлийн 4.1.5, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт тус тус зааснаар шүүгч Т.Э нь “хүний эрх”-ийг хуулийн хүрээнд дээдлэх, хамгаалах үндсэн үүрэгтэй байна. Шүүгч нь зөрчил гаргагч болон гомдол гаргагчийг шүүх ажиллагаанд биеэр оролцох болон хууль зүйн туслалцаа авах үндсэн эрхүүдийг зөрчсөн гэж бүрэлдэхүүн дүгнэв. Ф аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр 04 дугаарт захирамжаар С.Э-гийн гомдлоор З.О-д холбогдох зөрчлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэхдээ зөрчил гаргагч болон хууль зүйн туслалцаа авах эрхүүдийг эдлүүлээгүй байна. (Ц аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 74 дүгээр магадлал). Тиймээс Монгол Улсын Үндсэн хуулийн 16.14-д иргэн “хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, хууль зүйн туслалцаа

авах” үндсэн эрхийг баталгаатай эдэлнэ гэж заасан, Захиргааны хариуцлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлд “зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд биеэр оролцох, нотлох баримттай танилцах, зөрчлийн талаар тайлбар өгөх, нотлох баримт, хүсэлт гаргах, хууль зүйн туслалцаа авах” эрхтэй, мөн хуулийн 17 дугаар зүйлийн 1.6 дахь хэсэгт “холбогдох этгээдэд зөрчлийг хянан хэлэлцэх өдөр, цаг, газрыг мэдсэн эсэх” гэж тус тус заасан зохицуулалтуудыг зөрчсөн гэх үндэслэлтэй байна.

Дээрх нөхцөл байдал, цугларсан материалаас дүгнэхэд Ф аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Т.Э нь Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1.3.1-ийн “Шүүгч нь хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, хууль дээдлэх” гэснийг, мөн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 3.3.1-ийн “Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй” гэснийг зөрчсөн...” гэж дүгнэн шүүгч Т.Э надад Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх хэсэгт зааснаар сахилгын арга хэмжээний сануулах шийтгэх ногдуулсныг дараах үндэслэлээр эс зөвшөөрч гомдол гаргаж байна. Үүнд:

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 24 дугаартай магадлалаар Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.17 “хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах” гэснийг зөрчсөн гэж дүгнэсэн.

Захиргааны хариуцлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-т “нотлох баримт нэмж бүрдүүлэх шалгаж тодруулах шаардлагатай зөрчлийг 3 хоногийн дотор” гэж заасан байна. Ингээд зөрчил гаргагч З.О, гомдол гаргагч С.Э нараас тайлбар авсан. Тайлбар авахдаа Захиргааны хариуцлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тэмдэглэл үйлдэж тайлбар авсан.

Өөрөөр хэлбэл, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.17 “хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах” гэснийг зөрчөөгүй. Тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Захиргааны хариуцлагын тухай хуулийн дагуу ажиллагаа хийсэн.

Шүүгч нь зөрчил гаргагч болон гомдол гаргагчийг шүүх ажиллагаанд биеэр оролцох болон хууль зүйн туслалцаа авах үндсэн эрхүүдийг зөрчсөн гэж бүрэлдэхүүн дүгнэв. Ф аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр 04 дугаартай захирамжаар С.Э гомдлоор З.О-д холбогдох зөрчлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэхдээ зөрчил гаргагч болон хууль зүйн туслалцаа авах эрхүүдийг эдлүүлээгүй байна. (Ц аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 74 дүгээр магадлал).

Монгол Улсын Үндсэн хуулийн 16.14-д иргэн “хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, хууль зүйн туслалцаа авах” үндсэн эрхийг баталгаатай эдэлнэ” гэж заасан, Захиргааны хариуцлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлд “зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд биеэр оролцох, нотлох баримттай танилцах, зөрчлийн талаар тайлбар өгөх, нотлох баримт, хүсэлт гаргах, хууль зүйн туслалцаа авах” эрхтэй, мөн хуулийн 17 дугаар зүйлийн 1.6 дахь хэсэгт “холбогдох этгээдэд зөрчлийг хянан хэлэлцэх өдөр, цаг, газрыг мэдсэн эсэх” гэж тус тус заасан зохицуулалтуудыг зөрчсөн гэж дүгнэсэн.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх хэсэгт “анхан шатны шүүхийн шийдвэрийг талуудын гаргасан гомдол, прокурорын эсэргүүцлийн үндсэн дээр давж заалдах журмаар хянан шийдвэрлэх” гэж давж заалдах шатны шүүхийн бүрэн эрхийг хуульчилсан байна. Үүний дагуу С.Э гомдлоор Ц аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх 2016 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр З.О-д холбогдох захиргааны зөрчлийн материалыг

хянан хэлэлцээд 74 дугаартай магадлалаар Ф аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр 04 дугаартай шүүгчийн захирамжийг хүчингүй болгож, З.О-д холбогдох захиргааны зөрчлийн материалыг анхан шатны шүүхээр дахин шийдвэрлүүлэхээр буцаасан.

Өөрөөр хэлбэл, Ф аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Т.Э миний 2016 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр 04 дугаар шүүгчийн захирамжид Ц аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх нь дүгнэлтээ хийсэн байхад Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хороо нь магадлалаараа дахин дүгнэлт хийсэн нь буруу байна.

1992 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр Монгол Улсын Үндсэн хууль батлагдсан. Үндсэн хууль нь дээд хүчин чадал бүхий эцэг хууль юм. Шинэ үндсэн хууль батлагдсантай холбогдуулан түүний үзэл санаа зорилгод нийцүүлэн 1992 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр Захиргааны хариуцлагын тухай хуулийг баталсан. Захиргааны хариуцлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Зөрчил гаргасан этгээд эрхээ хамгаалах, зөрчил гаргасан этгээд дараах эрх эдэлнэ” гээд 6 эрхийг хуульчлан өгсөн. Харин уг Захиргааны хариуцлагын тухай хуульд гомдол гаргагч болон хохирогч нь захиргааны зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаанд ямар эрх, үүрэгтэй оролцох талаар зохицуулж хуульчлаагүй, мөн шүүх захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэхдээ шүүх хуралдааны ямар процессоор ажиллагаа явуулах талаар хуульчлаагүй байхад Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хороо нь дээрх хуулиудаас давж тайлбар хийн хэт нэг талыг барьж шүүгч Т.Э надад сануулах сахилгын арга хэмжээ авсан нь үндэслэлгүй юм.

Мөн гомдол гаргагч С.Э нь хууль зүйн туслалцаа авах талаарх хүсэлтийг анхан шатны шүүхэд гаргаагүй болно.

Захиргааны хариуцлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1.6 дахь хэсэгт “холбогдох этгээдэд зөрчлийг хянан хэлэлцэх өдөр, цаг, газрыг мэдэгдсэн эсэх”-ийг зөрчсөн гэж Шүүхийн Ёс зүйн хороо дүгнэсэн. Захиргааны хариуцлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Зөрчлийг хянан шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан дараах нөхцөл байдлыг тогтооно” гэж заасны дагуу зөрчил гаргагч З.О, гомдол гаргагч С.Э нарыг шүүгчийн туслахаар дуудуулан тайлбар авсан. Гэтэл Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хороо нь хэт явцуу хүрээнд уг заалтыг тайлбарласан байна.

Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дахь хууль дээдлэх зарчим, 3.3 дугаар зүйл дэх хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх үүргийг зөрчсөний төлөө сахилгын шийтгэл хүлээлгэхгүй, Үндсэн хуулиар илэрхий хамгаалагдсан үндсэн эрх, эрх чөлөөг зөрчсөн, хэн ч маргахгүй хуулийн тодорхой заалтыг ноцтой эсхүл удаа дараа зөрчсөн... гэх утга бүхий зүйлийг магадлалын үндэслэх хэсэгт дурдсан нь ойлгомжгүй дээрх заалтуудыг зөрчсөн нь ямар нотлох баримтаар нотлогдож сахилгын хэрэг үүсгэсэн нь тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл урьдаас хөдөлбөргүй тогтоогдсон нотлох баримт байхгүй гэж зарчим байхад хийсвэр дүгнэлт хийгээд байгаа нь үндэслэлгүй байна.

Гомдолгаргагч С.Э гэх хүн нь “...” тэгээд нэрдэвшигч сонгуулийн сурталчилгааны хугацаанд хүмүүстэй уулзаж болдоггүй юм уу, намайг дэмжээрэй гэж хэлж яагаад болохгүй гэж хэлж яагаад болохгүй гэж, олон хүн цугларсан газар очиж бас болохгүй юу” гэх мэтээр шүүгч хүнээс гарахгүй ёс зүйгүй үйлдлүүд гаргасан, ...хэт нэг талыг барьсан шийдвэр гаргасан, ...гаргасан шийдвэрээ засварлах шаардлага гарлаа хэмээн буцааж аваад 10 дугаар сарын 05-нд надад өгсөнд гомдолтой байна. Мөн хөөн хэлэлцэх хугацааг санаатайгаар дуусгасан...” гэж гомдол гаргасан байхад Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хороо нь гомдолд дурдагдсан асуудлаар биш өөр асуудлаар арга хэмжээ нь авсан үндэслэлгүй юм.

Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй” гэж заасан байхад гомдол гаргагчийн гомдолд дурдагдсан асуудлаас хэтэрч хэт нэг талыг барьж шийдвэр гаргасан байна.

Монгол Улсын Шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Ёс зүйн зөрчлийг илрүүлснээс хойш 1 сар, зөрчил гарснаас хойш 6 сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулж болохгүй”, Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5.17-д “Шүүгчид холбогдох сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш зургаан сар, зөрчил гарснаас хойш нэг жил өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулахгүй” гэж заасан байхад Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хороо нь хөөн хэлэлцэх хугацааг тооцоогүй, яагаад тооцоогүй талаарх дүгнэлтээ магадлалдаа дурдаагүй байгааг анхаарч үзнэ үү.

Иймд Ф аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Т.Э би Монгол Улсын Шүүхийн шүүгчийн Ёс зүйн дүрмийг зөрчөөгүй тул сахилгын хэргийг бүхэлд нь хянаж, Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 24 дугаартай магадлал хүчингүй болгож, сануулах сахилгын арга хэмжээг хэрэгсэхгүй болгож өгнө үү” гэжээ.

ХЯНАВАЛ:

Иргэн С.Э анх Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан гомдолдоо:

1/ Өрөөндөө дуудаж доог тохуу хийсэн,

2/ Гаргасан шийдвэрээ зассан,

3/ Хөөн хэлэлцэх хугацааг санаатай хэтрүүлсэн гэсэн тодорхой 3 үндэслэл зааж шүүгч Т.Э-г буруутгасан байна.

Шүүхийн Ёс зүйн хороо гомдол гаргагч С.Э гаргасан гомдлыг үндэслэн тухайн зөрчлийг гаргасан эсэхийг шалган тогтоох ёстой. Өөрөөр хэлбэл, Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн “Гомдлыг хүлээн авах, шалгах” гэсэн Гуравдугаар бүлэгт зааснаар Шүүхийн Ёс зүйн хороо нь иргэн С.Э 2017 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр гаргасан гомдлыг шийдвэрлэх ёстой. Гэтэл магадлалд энэхүү 3 үндэслэлийн талаар огт дурдаагүй нь иргэн хүн эрхийнхээ дагуу гаргасан гомдлыг шийдвэрлэхгүй, гаргаагүй гомдлын үндсэн дээр шүүгчид шийтгэл ногдуулсан мэт ойлгогдож байна.

Түүнчлэн Шүүхийн Ёс зүйн хороо нь иргэн С.Э-гийн гаргасан гомдлын гол үндэслэл болох “Өрөөндөө дуудаж доог тохуу хийсэн, гаргасан шийдвэрээ зассан, хөөн хэлэлцэх хугацааг санаатай хэтрүүлсэн” гэсэн үйлдэл нь тогтоогдсон эсэх талаар ямар нэгэн дүгнэлт хийгээгүй байгаа нь буруу болно.

Шүүхийн Ёс зүйн хороо 2018 оны 3 дугаар сарын 30-ны өдөр 24 дугаартай магадлалыг гаргаж, шүүгчид сахилгын шийтгэл ногдуулахдаа “хөөн хэлэлцэх хугацаа”-г анхаараагүй байна. Тус улсын аливаа хуульд /Эрүүгийн хууль, Иргэний хууль, Төрийн албаны тухай хууль, Зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль/ ямар үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэг, зөрчил гэж үзэх вэ, түүнд ямар хугацаанд шийтгэл ногдуулж болох вэ гэсэн асуудлыг зохицуулсан байдаг.

Түүнтэй нэгэн адил Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 167 дугаар зарлигаар батлагдсан “Шүүхийн ёс зүйн хорооны дүрэм”- ийн Тавдугаар бүлгийн 5.17 дугаар зүйлд “Шүүгчид холбогдох сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш зургаан сар, зөрчил гаргаснаас хойш нэг жил өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулахгүй” гэж, мөн Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн Тавдугаар бүлэг 5.1 дүгээр зүйлийн 3-д “Ёс зүйн зөрчлийг илрүүлснээс хойш 1 сар, зөрчил гаргаснаас хойш 6 сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулж болохгүй” гэж тус тус заажээ. Гэтэл 2016 онд

гаргасан гэх зөрчлийн тухай 2017 онд гомдол гаргасныг хүлээн авч, улмаар түүнийг нь шийдвэрлэж, 2018 онд магадлал гаргаж байгаа нь буруу.

2016 оны орон нутгийн сонгууль явагдаж байх үед Зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль бус харин 1992 оны Захиргааны хариуцлагын тухай хууль үйлчилж байжээ. Тухайн хууль материаллаг хуулийн болон процессын хуулийн аль аль шинжийг агуулсан хууль байгаа боловч шүүгч зөрчилд шийтгэл ногдуулахдаа шүүх хуралдаан хийх тухай зохицуулж хуульчлаагүй, зөрчил гаргасан этгээдийн эдлэх эрхийн талаар тухайлан 6 эрхийг хуульчилж өгсөн боловч хохирогчийн эдлэх эрхийн талаар хуульчлаагүй байжээ.

Гэтэл Шүүхийн Ёс зүйн хороо 1992 оны Захиргааны хариуцлагын тухай хуулиар явагдаж буй ажиллагааг “хохирогчийг оролцуулаагүй, үүний улмаас хохирогч эрхээ эдэлж чадаагүй, мэтгэлцэх зарчим хангагдаагүй, үндсэн эрхийн зөрчил байна” гэсэн агуулгаар шүүгчид шийтгэл ногдуулсан нь үндэслэлгүй байна.

Хэрэг хянан шийдвэрлэх процесс ажиллагаа хэдэн онд батлагдсан ямар хуулийг баримтлан явагдаж буйгаас шалтгаалан хэргийн оролцогчийн эрх харилцан адилгүй байж болохоор байна.

Иймд Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 24 дүгээр магадлалыг хүчингүй болгож шийдвэрлэлээ.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.1.1 дэх заалтыг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн “Ф аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Т.Э-д сахилгын шийтгэл ногдуулах тухай” 24 дүгээр магадлалыг хүчингүй болгож, шүүгч Т.Э-гийн гомдлыг хангасугай.

2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.5 дахь хэсэгт заасны дагуу магадлалыг эс зөвшөөрвөл хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч гардан авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй.

ШҮҮГЧ

Ц.САЙХАНТУЯА

ШҮҮГЧ

Э.ЛХАГВАСҮРЭН

ШҮҮГЧ

Э.ЗОРИГТБААТАР

УИХ.МН
СҮДАЛГААНЫ САН



МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЁС ЗҮЙН ХОРООНЫ МАГАДЛАЛ

2018 оны 11 сар 16 өдөр

Дугаар 87

Улаанбаатар хот

П дүүргийн Эрүүгийн хэргийн
анхан шатны шүүхийн шүүгч С.Б-д
сахилгын шийтгэл ногдуулах тухай

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааныг тус хорооны дарга Н.Эрдэнэцогт даргалж, гишүүн А.Доржготов, В.Жавхлан, Д.Сүнжид, Ч.Оюунцэцэг нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны тэмдэглэл хөтлөгчөөр шинжээч Ч.Ханддулам, референт Ж.Халиун нарыг оролцуулан Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдааны танхимд хийв.

П дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч С.Б-д сахилгын хэрэг үүсгэж шийдвэрлэсэн Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолтой сахилгын хэргийг гишүүн Ч.Оюунцэцэгийн илтгэснээр хянан хэлэлцээд **ТОДОРХОЙЛОХ** нь:

Өмгөөлөгч С.Ж Шүүхийн Ёс зүйн хороонд ирүүлсэн гомдолдоо: "Монголын хуульчдын холбооны гишүүн, өмгөөлөгч С.Ж би Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан иргэн Б.Б-д эрх зүйн туслалцаа үзүүлэн ажиллаж байна. Дээрх эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад П дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч С.Б нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм (цаашид "Дүрэм")-ийг илтэд зөрчсөн тул Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 28.1. Дүрмийн 20 4-т заасан үүргийнхээ хүрээнд энэхүү гомдлыг гаргаж байна. Манай үйлчлүүлэгч Б.Б нь П дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүгчийн 2018 оны 5 сарын 15-ны өдрийн 92/2 тоот захирамжаар Цагдан хорих хаалттай ... дүгээр ангид цагдан хоригдож байгаа байна (Уг захирамжид гаргасан гомдлыг Ерөнхий шүүгч шийдвэрлэж шүүгчийн захирамжийг хэвээр үлдээсэн). Хэдийгээр өмгөөлөгч миний зүгээс тус Б.Б-г цагдан хорьсон захирамжийг үндэслэлгүй гэж үзэж байгаа боловч шүүхээс нэгэнт гарсан эцсийн шийдвэрт хүндэтгэлтэй хандаж уг захирамж болон түүний үндэслэлийн талаар санал, хүсэлт гараагүй билээ. Харин манай үйлчлүүлэгч Б.Б-гийн бие муудсан цаашид цагдан хоригдох нь түүний эрүүл мэндэд ноцтой сөрөг нөлөө учруулах магадлалтай байсан тул Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг "...өмгөөлөгч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үед энэ хуулийн 14.1 дүгээр зүйлийн ...1.5-д заасан таслан сэргийлэх арга хэмжээ ... өөрчлөх ... хүсэлтийг шүүхэд гаргаж болно" гэж заасны дагуу цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг бусад хуульд заасан арга хэмжээгээр "өөрчлүүлэх" тухай хүсэлтийг 2018 оны 5 сарын 28-ны өдрийн 16:00 цагт (16:00-16:30 цагийн орчимд) тус шүүхэд гаргасан юм. Улмаар хүсэлт нь шүүгчдийн зөвлөгөөнөөс тогтоосон хуваарийн дагуу цагдан хорих асуудлыг хариуцсан С.Б шүүгчид хуваарилагдсан.

Ийнхүү өмгөөлөгч цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлүүлэх хүсэлтийг шүүхэд гаргасан тохиолдолд тус зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу шүүгч хүсэлтийг хүлээн авснаас хойш 24 цагийн дотор асуудлыг хэлэлцэх шүүхийн хэлэлцүүлгийн товыг гаргаж өмгөөлөгч, прокурорт мэдэгдэх үүрэгтэй билээ. Гэтэл П дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч С.Б-гийн зүгээс шүүхийн хэлэлцүүлгийг хуульд заасан 24 цагийн хугацаанд товлоогүй ба улмаар 2018 оны 5 сарын 30-ны өдрийн 02/719 тоот албан бичгээр хүсэлтийг буцаан хүргүүлээд байна. С.Б шүүгч өмгөөлөгч миний гаргасан хүсэлтийг буцаах болсон үндэслэлүүд нь дараах байдлаар илэрхий үндэслэлгүй байна.

С.Б шүүгчийн хүсэлтийг буцаан хүргүүлсэн албан бичгийн үндэслэл	Тайлбар
Ерөнхий шүүгчийн захирамжид гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрхгүй.	Өмгөөлөгчийн зүгээс Ерөнхий шүүгчийн захирамжид гомдол гаргаагүй ба гэтэл шүүгч өмгөөлөгчийн хуульд заасны дагуу гаргасан хүсэлтийг гомдол хянан шийдвэрлэх журмаас ялгаж зааглаагүй байна.
Цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээг сунгасан шүүхийн шийдвэр нь захирамжид заасан хугацааг дуустал хүчинтэй байна.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хугацаанаас нь өмнө өөрчилж болдог. Гэтэл шүүгч цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ нэгэнт авагдсан бол түүний хэзээ ч өөрчилж болохгүй гэх утгатай хууль бус үндэслэлийг хариундаа дурдсан байна.
...таны хүсэлтийг шүүгч дахин хянах эрхгүй.	Шүүгч хуулиар олгогдсон өмгөөлөгчийн хүсэлтийг шийдвэрлэх чиг үүргээ хэрэгжүүлэхээс шууд татгалзсан байна. Өмгөөлөгчийн зүгээс аль нэг захирамжийг дахин хянуулах асуудал тавиагүй байхад "дахин хянах эрхгүй" гэх үндэслэлээр хүсэлтийг буцаасан нь ойлгомжгүй байна.

Хэдийгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, прокурор, өмгөөлөгчийн хуулийг тайлбарлах, хэрэглэхтэй холбоотойгоор санал, ойлголтын зөрүү гарч болох боловч тохиолдолд С.Б шүүгчийн үйлдэл нь хууль хэрэглээний алдаа гэхээсээ илүүтэй Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль болон дүрэмд заасан зөрчилд хамаарахаар байна.

Тодруулбал:

Д/д	Зөрчил	Тайлбар
1	ХЭЗБ тухай хуулийн 27.1 хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд дараах үйлдлийг хориглоно. 27.1.1 хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчих,	Дүрмийн зөрчил нь шууд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн зөрчил болж байна.
2	Дүрмийн 1.6.1 Хуульч нь мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хууль зүйн мэдлэг, ур чадвартай байж, нямбай, хариуцлагатай ажиллана.	02/719 тоот албан бичгээс үзэхэд С.Б шүүгч нь цагдан хорихтой холбоотой асуудлыг шийдвэрлэх эрх зүйн мэдлэг ур чадваргүй эсхүл мэдлэг ур чадвартай боловч өмгөөлөгчийн гаргасан хүсэлтэд маш хариуцлагагүй хандсан гэж ойлгогдож байна. Хэрвээ шүүгч энэ талаар мэдлэг ур чадвартай бөгөөд асуудалд хариуцлагатай хандсан тохиолдолд хүсэлтийг буцаах бус хуульд заасны дагуу шүүхийн хэлэлцүүлгийг товлох байжээ.

3	Дүрмийн 1.7.1 Хуульч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа чин сэтгэлээсээ хандах бөгөөд хүчин чармайлт гаргаж, шуурхай, зохион байгуулалттай ажиллана.	Шүүгч хүсэлтийг шийдвэрлэх талаар хүчин чармайлт гаргаагүй, харин ч шийдвэрлэхгүй гэсэн арга шалтаг хайсан, хуульд заагаагүй үндэслэлээр хүсэлтийг буцаасан (хуульд хүсэлтийг буцаах талаар зохицуулалт байхгүй). Түүнчлэн хуульд заасан 24 цагийн хугацаанд шүүхийн хэлэлцүүлгийг товлоогүй, хариу өгөөгүй.
4	Дүрмийн 15.1 Шүүгч нь хууль болон энэ дүрмийг биелүүлнэ.	С.Б шүүгч нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27.1 болон Дүрмийг шууд зөрчсөн.
5	Дүрмийн 15.7.1 Шүүгч нь хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиг сонирхол нь хөндөгдсөн аливаа этгээд хуульчид хэрэг маргаанаа хэлэлцүүлэх эрхийг тэгш хангана.	С.Б шүүгч нь 02/719 тоот албан бичгээр өмгөөлөгчийн хүсэлтийг буцаасны улмаас манай үйлчлүүлэгч Б.Б нь өөрийн эрүүл мэнд муудсан асуудлаар хүсэлт гаргах, түүнийгээ шүүхээр хэлэлцүүлэх, шүүгчийн шийдвэрийг эс зөвшөөрвөл Ерөнхий шүүгчид гомдол гаргах зэрэг эрхээ хэрэгжүүлж чадахгүйд хүрч байна.
6	Дүрмийн 15.8.1 Хуульд эсхүл энэ дүрмийн 16.1-16.3 дугаар зүйлд заасны дагуу татгалзсанаас бусад тохиолдолд шүүгч нь хэрэг маргаанаа заавал шийдвэрлэнэ.	Хэрэг, маргаан гэдэг ерөнхий томъёололд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хийгдэх шүүхийн хэлэлцүүлэг мөн хамаарна Шүүгч хуульд заагаагүй үндэслэлээр хүсэлтийг хэлэлцэх буюу шүүхийн хэлэлцүүлгийг хийхээс татгалзсан нь Дүрмийн уг зөрчилд хамаарч байна.
7	Дүрмийн 1.4.1 Хууль мэргэжлийн үйл ажиллагаандаа дараах нийтлэг зарчмыг баримтална, 1.1 хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, 1.2 шударга ёсыг баримтлах, 1.3 хууль дээдлэх,	Шүүгч дээрх үйлдлээр хууль дээдлэх зарчмыг зөрчсөнөөс гадна түүний цаана үйлчлүүлэгчийн эрх зөрчигдөж байна.

Нэгтгэвэл, С.Б шүүгчийн дээрх албан бичиг буюу шийдвэрээс үзэхэд тэрээр цагдан хорих арга хэмжээг "өөрчлөх талаарх хууль зүйн наад захын ойлголтгүй байгаа эсхүл ажил үүрэгтээ хэтэрхий хайнга хандсан эсхүл бусад байдлаар өмгөөлөгчийн хүсэлтийг шийдвэрлэхгүй байх хүсэл зоригтой байсан гэж дүгнэхэд хүргэж байна. Улмаар С.Б шүүгчийн эдгээр үйлдлүүд нь Дүрмийн 20.3 дугаар зүйл, Монголын хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан шийдвэрлэх журмын 1.7-д заасан "зөрчил"-д хамаарч байх түүнд холбогдох хариуцлагыг хүлээлгэж цаашидийм алдаа гарах, шинээр батлагдсан хуулийн талаар буруу жишиг тогтож хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхийг хүсье" гэжээ.

Шүүгч С.Б-ээс Шүүхийн Ёс зүйн хороонд ирүүлсэн тайлбартаа: "2018.05.15-ны өдрийн №92/2 дугаар шүүгчийн захирамжаар яллагдагч Б.Б цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг 1 сараар сунгаж шийдвэрлэсэн болно. Уг шүүгчийн захирамжид яллагдагчийн өмгөөлөгч нараас гомдол гаргасныг П дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч 2018 оны 5 дугаар сарын 22-ны өдөр хянан хэлэлцээд №496 дугаар Ерөнхий шүүгчийн захирамжаар №92/2 дугаартай шүүгчийн захирамжийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна. Дээрх №92/2 дугаартай шүүгчийн захирамж. №496 дугаар Ерөнхий шүүгчийн захирамж. шүүх хуралдааны тэмдэглэл зэргээс үзэхэд яллагдагч Б.Б-гийн өмгөөлөгч нараас Б.Б-гийн эрүүл мэнд муудсан цаашид цагдан хорих нь түүний эрүүл мэндэд ноцтой сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай гэх утга, агуулга бүхий хүсэлт гаргасан байсан. Тиймээс уг асуудлыг нь шүүх шийдвэрлэж мөн Ерөнхий шүүгч хянаж эцсийн шийдвэрийг гаргасан байхад, яг дээрх утга агуулга бүхий хүсэлтийг яллагдагч Б.Б-гийн өмгөөлөгч нараас 2018 оны 5 дугаар сарын 28-ны өдөр

гаргасан билээ. Ерөнхий шүүгчийн №496 дугаартай захирамжийн захирамжлах хэсгийн 2 дахь хэсэгт "Энэхүү захирамжид гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрхгүй болохыг дурдсугай." гэсэн тул шүүгч түүнийг дахин хянан хэлэлцэх эрхгүй юм. Иймээс шүүгч миний бие 2018 оны 5 дугаар сарын 30-ны өдөр 2/719 тоот албан бичгээр яллагдагч Б.Б-гийн өмгөөлөгчид хариу өгсөн юм. Миний бие нь шүүгчээр ажиллаад 5 жил болж байгаа бөгөөд ажиллах хугацаандаа өргөсөн тангарагтаа үнэнч байж, Монгол улсын Үндсэн хууль, Шүүхийн тухай хууль, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шүүгчийн ёс зүйн дүрэм, бусад хууль тогтоомжид заасныг чандлан сахиж хэнээс ч хараат бусаар шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлж ажиллаж байгаа болно. Иймд өмгөөлөгч С.Ж-гийн гаргасан гомдол үндэслэлгүй тул хэрэгсэхгүй болгож өгнө үү." гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 134 дүгээр тогтоолоор шүүгч С.Б-д сахилгын хэрэг үүсгэж шийдвэрлэсэн байна.

Шүүгч С.Б Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанд Шүүхийн Ёс зүйн хорооны 2018.08.27-ны өдрийн 134 дүгээр сахилгын хэрэг үүсгэж шийдвэрлэсэн тогтоолыг эс зөвшөөрч гаргасан тайлбартаа: "П дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч С.Б миний бие нь Шүүхийн Ёс зүйн хорооны 2018.08.27-ны өдрийн 134 дугаартай тогтоолд дараах гомдлыг гаргаж байна.

2018 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн №92/2 дугаар шүүгчийн захирамжаар яллагдагч Б.Б-гийн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг 1 сараар сунгаж шийдвэрлэсэн болно. Уг шүүгчийн захирамжид яллагдагчийн өмгөөлөгч нараас гомдол гаргасныг П дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч 2018 оны 5 дугаар сарын 22-ны өдөр хянан хэлэлцээд №496 дугаар Ерөнхий шүүгчийн захирамжаар №92/2 дугаартай шүүгчийн захирамжийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна.

Дээрх №92/2 дугаартай шүүгчийн захирамж, №496 дугаар Ерөнхий шүүгчийн захирамж. шүүх хуралдааны тэмдэглэл зэргээс үзэхэд яллагдагч Б.Б-гийн өмгөөлөгч нараас Б.Б-гийн эрүүл мэнд муудсан цаашид цагдан хорих нь түүний эрүүл мэндэд ноцтой сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай гэх утга. агуулга бүхий хүсэлт гаргасан байсан. Тиймээс уг асуудлыг нь шүүх шийдвэрлэж мөн Ерөнхий шүүгч хянаж эцсийн шийдвэрийг гаргасан байхад яг дээрх утга агуулга бүхий хүсэлтийг яллагдагч Б.Б-гийн өмгөөлөгч нараас 2018 оны 5 дугаар сарын 28-ны өдөр гаргасан билээ. Ерөнхий шүүгчийн №496 дугаартай захирамжийн захирамжлах хэсгийн 2 дахь хэсэгт Энэхүү захирамжид гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрхгүй болохыг дурдсугай." гэсэн тул шүүгч түүнийг дахин хянан хэлэлцэх эрхгүй юм.

Учир нь: шүүх нэгэнт Б.Б-д цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахад түүний эрүүл мэндийн байдал нөлөөлөх эсэхийг хянан шийдвэрлэж захирамж гаргасан бөгөөд уг захирамжийн тус дүүргийн ерөнхий шүүгч хянаад захирамжийг хэвээр үлдээсэн байхад дахин энэ асуудлыг шүүгч хянах нь Ерөнхий шүүгчийн гаргасан шийдвэрийг хянах нөхцөл байдал үүсэх билээ Монгол улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд яллагдагчийг цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг эцэслэн шийдвэрлэх эрх тус дүүргийн ерөнхий шүүгчид олгогдсон бүрэн эрх юм. Тиймээс яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг шүүгч шийдвэрлэж. Ерөнхий шүүгч түүнийг нь хянаж шийдвэрлэсэн тохиолдолд тухайн яллагдагчийн цагдан хорих хугацаа нь тухайн захирамжид дурдсан хугацаандаа хүчинтэй бөгөөд түүнийг дахин хянах боломжгүй юм.

Иймээс шүүгч миний бие 2018 оны 5 дугаар сарын 30-ны өдөр 2/719 тоот албан бичгээр яллагдагч Б.Б-гийн өмгөөлөгчид хариу өгсөн юм. Миний бие нь шүүгчээр ажиллах хугацаандаа өргөсөн тангарагтаа үнэнч байж, Монгол улсын үндсэн хууль. Шүүхийн тухай хууль. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль. Шүүгчийн ёс зүйн

дүрэм. бусад хууль тогтоомжид заасныг чандлан сахиж, хүний эрхийг дээдлэн, хүний эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэн, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандаж, хэнээс ч хараат бусаар шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд Шүүхийн ёс хорооны 2018 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн тогтоолоор надад сахилгын хэрэг үүсгэснийг эс зөвшөөрч гомдол гаргаж байна" гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанаар сахилгын хэргийг хэлэлцээд ҮНДЭСЛЭХ нь:

Өмгөөлөгч С.Ж-ээс Шүүхийн Ёс зүйн хороонд шүүгч С.Б-д холбогдуулж "...Б.Б-гийн бие муудсан цаашид цагдан хоригдох нь түүний эрүүл мэндэд ноцтой сөрөг нөлөө учруулах магадлалтай байсан тул ...цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг бусад хуульд заасан арга хэмжээгээр "өөрчлүүлэх" тухай хүсэлтийг 2018 оны 5 сарын 28-ны өдрийн 16:00 цагт ...тус шүүхэд гаргасан юм. Улмаар хүсэлт нь ...цагдан хорих асуудлыг хариуцсан С.Б шүүгчид хуваарилагдсан. Ийнхүү өмгөөлөгч цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлүүлэх хүсэлтийг шүүхэд гаргасан тохиолдолд ...шүүгч хүсэлтийг хүлээн авснаас хойш 24 цагийн дотор асуудлыг хэлэлцэх шүүхийн хэлэлцүүлгийн товыг гаргаж өмгөөлөгч, прокурорт мэдэгдэх үүрэгтэй билээ. Гэтэл ...шүүгч С.Б-гийн зүгээс шүүхийн хэлэлцүүлгийг хуульд заасан 24 цагийн хугацаанд товлоогүй ба улмаар 2018 оны 5 сарын 30-ны өдрийн 02/719 тоот албан бичгээр хүсэлтийг буцаан хүргүүлээд байна," "шүүгч С.Б нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм...-ийг илтэд зөрчсөн" гэх гомдлыг гаргаж, Шүүхийн Ёс зүйн хорооны гомдол хянан хэлэлцүүлэх хуралдааны 2018 оны 08 дугаар сарын 27- ны өдрийн 134 дүгээр тогтоолоор П дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч С.Б-д сахилгын хэрэг үүсгэсэн байна.

Сахилгын хэрэгт цугларсан баримтаас үзэхэд шүүгч С.Б нь 2018.05.15-ны өдрийн 92/2 дугаар шүүгчийн захирамжаар Монгол Улсын Эрүүгийн хуулийн 20.3 дугаар зүйлийн 3 дах хэсэг, 22.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан яллагдагч Б.Б-гийн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг 1 сараар сунгаж шийдвэрлэж, уг шүүгчийн захирамжид яллагдагчийн өмгөөлөгч нараас "Б.Б-гийн эрүүл мэнд муудсан цаашид цагдан хорих нь түүний эрүүл мэндэд ноцтой сөрөг нөлөөтэй" гэсэн гомдол гаргасныг П дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч 2018 оны 5 дугаар сарын 22-ны өдөр хянан хэлэлцэж 496 дугаар шүүгчийн захирамж гарч, 92/2 дугаартай шүүгчийн захирамжийг хэвээр үлдээж шийдвэрлэхдээ захирамжлах хэсгийн 2 дахь хэсэгт "Энэхүү захирамжид гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрхгүй" талаар заажээ. /сахилгын хэргийн 19-21-р хуудас/

П дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч С.Б 2018 оны 05 дугаар сарын 30-ны өдөр 02/719 тоот албан бичгээр өмгөөлөгч С.Ж-д "Таны 2018 оны 5 дугаар сарын 28-ны өдөр гаргасан хүсэлттэй танилцлаа. Тус шүүхийн 2018 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн №92/2 дугаартай шүүгчийн захирамжаар яллагдагчаар татагдсан Б.Б-гийн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг 30 хоногийн хугацаагаар сунгаж шийдвэрлэснийг тус шүүхийн Ерөнхий шүүгчийн 2018 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 496 дугаартай захирамжаар хэвээр үлдээж шийдвэрлэжээ. Дээрх Ерөнхий шүүгчийн захирамжид гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрхгүй уг шийдвэр нь эцсийнх байх бөгөөд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг сунгасан шүүхийн шийдвэр нь захирамжид заасан хугацааг дуустал хүчинтэй байна. Иймд яллагдагчаар татагдсан Б.Б-гийн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх тухай таны хүсэлтийг шүүгч дахин хянах эрхгүй байх тул хүсэлтийг буцаан хүргүүлэв." гэж хариу өгсөн байна. /

сахилгын хэргийн 16 дугаар тал/ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.13 дугаар зүйлийн 1.-д “Прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үед энэ хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1.2, 1.3, 1.5-д заасан таслан сэргийлэх арга хэмжээ авах, өөрчлөх, хүчингүй болгох, хугацааг сунгах санал, хүсэлтийг шүүхэд гаргаж болно.” гэж заажээ. Мөн хуулийн 14.13 дугаар зүйлийн 2.-т “Шүүх энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан санал, хүсэлтийг хүлээн авснаас хойш 24 цагийн дотор асуудлыг хэлэлцэх шүүхийн хэлэлцүүлгийн товыг прокурор, өмгөөлөгчид мэдэгдэнэ.” гэж заасныг шүүгч биелүүлээгүй, хууль зөрчиж, өмгөөлөгч С.Ж-ээс ирүүлсэн хүсэлтийг хуульд нийцүүлж шийдвэрлэлгүйгээр түүний хүсэлтийг өмгөөлөгчид албан тоотоор буцааж өгсөн байна. Иймд шүүгчийг Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д “хүний эрхийг дээдлэх чадвартай” байх, Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1-д заасан “хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, ...үүрэгт ажилдаа хариуцлагатай хандах зарчмыг хувийн зан чанар болгон төлөвшүүлэх, Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1-д заасан “хууль дээдлэх” зарчмыг болон 3.3 дугаар зүйлийн 1-д “Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байх тул П дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч С.Б-д Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1-д заасан шүүгчийн сахилгын хариуцлага болох сануулах сахилгын шийтгэл ногдуулах нь зүйтэй гэж Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааны бүрэлдэхүүн дүгнэв.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35, 36 дугаар зүйлийн 36.1.1, 37 дугаар зүйлийн 37.1.1, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйл, Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5.7.1, 5.13-т заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.П дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч С.Б-д сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Энэ магадлалын хувийг шүүгч болон гомдол гаргагчид хүргүүлэхийг Шүүхийн Ёс зүйн хорооны Ажлын албанд даалгасугай.

3.Шүүгч, гомдол гаргагч нар магадлалыг гардан авснаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ

Н.ЭРДЭНЭЦОГТ

ГИШҮҮН

Ч.ОЮУНЦЭЦЭГ

УИИМН
СУДАЛГААНЫ САН



ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ
МАГАДЛАЛ

2019 оны 1 сарын 10 өдөр

Дугаар 221/ЁМ2019/0003

Улаанбаатар хот

П дүүргийн Эрүүгийн хэргийн анхан
шатны шүүхийн шүүгч С.Б-д сахилгын шийтгэл
ногдуулсан Шүүхийн Ёс зүйн хорооны
магадлалын тухай

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Батбаатар даргалж, шүүгч Э.Зоригтбаатар, шүүгч С.Мөнхжаргал нарын бүрэлдэхүүнтэй, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга М.Отгондэлгэр, гомдол гаргагч С.Ж, шүүгч С.Б нарыг оролцуулан, Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 87 дугаар магадлалыг эс зөвшөөрч шүүгч С.Б-гийн гаргасан гомдлыг шүүгч С.Мөнхжаргалын илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 87 дугаар магадлалаар: П дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч С.Б-д Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1-д зааснаар сануулах сахилгын шийтгэл ногдуулж шийдвэрлэжээ.

Шүүгч С.Б давж заалдах гомдолдоо: "...П дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2018 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 92/2 дугаар захирамжаар яллагдагч Б.Б-д авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг 1 сараар сунгаж шийдвэрлэсэн билээ. Уг шүүгчийн захирамжид яллагдагчийн өмгөөлөгч нараас гомдол гаргасныг П дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч 2018 оны 5 дугаар сарын 22-ны өдөр хянан хэлэлцээд 496 дугаар захирамжаар тус шүүхийн шүүгчийн 92/2 дугаартай шүүгчийн захирамжийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна. Дээрх 92/2 дугаар шүүгчийн захирамж, 496 дугаар Ерөнхий шүүгчийн захирамж, шүүх хуралдааны тэмдэглэл зэргээс үзэхэд яллагдагч Б.Б-гийн өмгөөлөгч нараас Б.Б-гийн эрүүл мэнд муудсан, цаашид цагдан хорих нь түүний эрүүл мэндэд ноцтой сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай гэх утга, агуулга бүхий хүсэлт гаргасан байсан. Тиймээс уг асуудлыг нь шүүх шийдвэрлэж, мөн Ерөнхий шүүгч хянаж эцсийн шийдвэрийг гаргасан байхад, яг дээрх утга агуулга бүхий хүсэлтийг яллагдагч Б.Б-гийн өмгөөлөгч нараас 2018 оны 5 дугаар сарын 28-ны өдөр гаргасан. Ерөнхий шүүгчийн 496 дугаартай захирамжийн захирамжлах хэсгийн 2 дахь хэсэгт "Энэхүү захирамжид гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрхгүй болохыг дурдсугай." гэж дурдсан, мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар дээрх Ерөнхий шүүгчийн захирамжид гомдол гаргах эрхгүй тул шүүгч түүнийг дахин хянан хэлэлцэх эрхгүй юм. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 36 дахь заалтад: "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, түүнд

прокурор хяналт тавих, яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, эрүүгийн хэргийг анхан шатны, давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлэх ажиллагааг” ойлгоно гэжээ. Иймд дээрх яллагдагчийн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг сунгасан асуудал нь зөвхөн тус хэргийн мөрдөн байцаалт явуулах ажиллагааны үед хийгдсэн бөгөөд шүүх нэгэнт Б.Б-д цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахдаа түүний эрүүл мэндийн байдалд нөлөөлөх эсэхийг хянан шийдвэрлэж захирамж гаргасан, уг захирамжид гаргасан гомдлыг тус шүүхийн Ерөнхий шүүгч хянаад захирамжийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байхад энэ асуудлыг шүүгч дахин хянаснаар хуульд байхгүй үндэслэл журам аар Ерөнхий шүүгчийн гаргасан шийдвэрийг хянах нөхцөл байдал үүсэх билээ. Монгол улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд яллагдагчийг цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг эцэслэн шийдвэрлэх эрх тус шүүхийн Ерөнхий шүүгчид олгогдсон байна. Тиймээс яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг шүүгч шийдвэрлэж, Ерөнхий шүүгч түүнийг нь хянаж шийдвэрлэсэн тохиолдолд тухайн яллагдагчийн цагдан хорих хугацаа нь тухайн захирамжид дурдсан хугацаандаа хүчинтэй бөгөөд түүнийг дахин хянах боломжгүй юм. Иймд шүүгч миний бие яллагдагч Б.Б-гийн өмгөөлөгчид дээрх асуудлаар 2018 оны 5 дугаар сарын 30-ны өдөр 2/719 тоот албан бичгээр хариу өгсөн юм. Дээрх хариу өгсөн асуудал нь 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэрэглэх, хэрэгжүүлэх буюу мэргэжил, ажлын ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой бөгөөд шүүгчийн ёс зүйн зөрчил гэж миний бие үзэхгүй байна. Мөн Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.4-ийн 2 дахь хэсэгт “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй” гэжээ. Иймд Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 87 дугаартай “сахилгын шийтгэл ногдуулсан” магадлалыг хүчингүй болгож өгнө үү.” гэжээ.

ХЯНАВАЛ:

Дараах үндэслэлээр Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалыг хүчингүй болгож, шүүгч С.Б-д үүсгэсэн сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгов.

Өмгөөлөгч С.Ж-ээс Монголын Хуульчдын холбооны Мэргэжил хариуцлагын хороонд хандаж шүүгч С.Б-гийн “... цагдан хоригдсон Б.Б-д авсан таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлүүлэх хүсэлт гаргасныг урьд нь хэлэлцсэн гэх үндэслэлээр дахин авч хэлэлцэхгүй гэж албан бичгээр хариу өгсөн” үйлдлийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчсөн гэж үзэж өргөдөл гаргасныг тус хорооны сахилгын шинжээчийн 2018 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 04/191 дүгээр албан бичгээр Шүүхийн Ёс зүйн хороонд шилжүүлжээ.

Шүүхийн Ёс зүйн хороо шүүгч С.Б-д сахилгын хэрэг үүсгэж, сануулах сахилгын шийтгэл ногдуулсан байна.

Шүүгч С.Б нь 2018 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 92/2 дугаар шүүгчийн захирамжаар өмгөөлөгч С.Ж-гийн “цагдан хоригдсон Б.Б-гийн таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлүүлэх” хүсэлтийг хэлэлцэж, хангахаас татгалзаж, цагдан хорих хугацааг сунгасан, уг захирамжийг эс зөвшөөрч өмгөөлөгч нараас гомдол гаргасныг П дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч 2018 оны 5 дугаар сарын 22-ны өдөр хэлэлцэж, 496 дугаар захирамжаар шүүгч С.Б-гийн гаргасан 92/2 дугаар захирамжийг хэвээр үлдээжээ.

Өмгөөлөгч С.Ж нь 2018 оны 5 дугаар сарын 28-ны өдөр “Б.Б-гийн эрүүл мэндийн байдал муудаж хорих ... ангийн эмнэлэгт “мэдрэл сульдал”, “зүрхний хэлбэрийн өөрчлөлт” оноштойгоор хэвтсэн, нэг сарын турш тохирохгүй эмчилгээ

хийгдсэн байх магадлалтай, нарийн мэргэжлийн эмчид үзүүлж оношийг зөв тогтоож эмчилгээ хийлгэх нэн тэргүүний шаардлагатай ... таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилж өгнө үү” гэсэн хүсэлт гаргаж, ... дүгээр ангийн эмнэлгийн 2018 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн тодорхойлолтыг хавсаргаж ирүүлснийг шүүгч С.Б нь Ерөнхий шүүгчийн захирамжаар шийдвэрлэгдсэн асуудал гэж үзэж, хэлэлцүүлэхгүйгээр албан бичгээр буцаажээ.

Шүүхийн Ёс зүйн хороо нь шүүгч С.Б-г Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.13 дугаар зүйлийн 1-д “... өмгөөлөгч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үед ... таслан сэргийлэх арга хэмжээг ... өөрчлөх ... хүсэлтийг шүүхэд гаргаж болно” гэж, 14.13 дугаар зүйлийн 2-т “Шүүх ... хүсэлтийг хүлээн авснаас хойш 24 цагийн дотор асуудлыг хэлэлцэх шүүхийн хэлэлцүүлгийн товыг прокурор, өмгөөлөгчид мэдэгдэнэ” гэснийг зөрчиж, С.Ж-гийн дээрх хүсэлтийг хуульд нийцүүлж шийдвэрлэлгүй албан бичгээр буцаасан нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4.1.5, Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1, 3.3 дугаар зүйлийн 1-д заасныг зөрчсөн гэж үзжээ.

Шүүгч С.Б-гийн дээрх үйлдлийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дээрх 2 заалтыг зөрчсөн эсэх, зөрчсөн бол энэ нь ёс зүйн зөрчил мөн эсэхийг авч үзэх шаардлагатай.

Дээрх хуулийн 14.13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалт нь урьд огт гаргаж байгаагүй, эсхүл урьд нь гаргаж байсан нөхцөл байдлаас тухайн нөхцөл байдал нь өөрчлөгдсөн үед, тухайлбал цагдан хоригдсон этгээдийн эрүүл мэндийн хувьд урьд хэлэлцэгдсэн үеэс хойш эрүүл мэндийн байдал өөрчлөгдсөнтэй холбоотой хүсэлтүүдийг хэдийд ч гаргаж болох зохицуулалт байх бөгөөд мөн зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар тухайн хүсэлтийг шүүх 24 цагийн дотор хэлэлцэхээр товлож заавал шийдвэрлэх ёстой байна. Энэ нь цагдан хоригдож байгаа хүний эрхтэй салшгүй холбоотой бөгөөд энэ үүргээ шүүгч биелүүлэлгүй хуулийг зөрчсөн бол шүүгчийг “хүний эрхийг дээдлэх чадвартай байх”, “хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх” үүргээ биелүүлээгүй гэж үзэх үндэслэлтэй.

Харин шүүхийн практикт аль ч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэргийн оролцогчоос урьд нь гаргасан хүсэлтийг шийдвэрлэсний дараа нөхцөл байдал өөрчлөгдөөгүй байхад тухайн хүсэлтээ удаа дараа гаргах тохиолдол олонтоо гардаг бөгөөд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлүүлэх хүсэлтийг урьд гаргаж шийдвэрлүүлсэн асуудлаар дахин гаргавал дээрх хуулийн заалтуудын дагуу хүсэлтийг шүүхийн хэлэлцүүлэг товлон шийдвэрлэх үүрэгтэй гэж үзэхгүй. Учир нь нэгэнт шүүхээр шийдвэрлэгдсэн учраас хүсэлтийг дахин өөрөөр шийдвэрлэх, эсвэл урьд гаргасан шийдвэрээ дахин гаргах боломжгүй буюу шүүгчийн захирамж, тогтоолоор дүгнэж шийдвэрлэх асуудал байхгүй тул шүүхийн хэлэлцүүлэг товлож шийдвэрлэх шаардлагагүй, ач холбогдолгүй байдаг, иймээс албан бичгээр хариу өгч буцаах тохиолдлууд гардаг¹². Үүнийг хууль зөрчсөн, хүний эрхийг дээдлээгүй, ёс зүйн зөрчил гаргасан гэж үзэх нь өрөөсгөл болно.

Иймд шүүгч С.Б-гийн өмгөөлөгч С.Ж-гийн 05 дугаар сарын 28-ны өдөр гаргасан хүсэлтэд хариу өгөхдөө дурдсан Б.Б-гийн эрүүл мэндийн асуудал нь Ерөнхий шүүгчийн 05 дугаар сарын 22-ны өдрийн захирамжаар хянагдаж шийдвэрлэгдсэн асуудал гэж үзэх үндэслэл байсан эсэхийг авч үзэх шаардлагатай гэж үзнэ.

Сахилгын хэргийн материалд авагдсан Ерөнхий шүүгчийн 05 дугаар сарын 22-ны өдрийн ... дугаар захирамжийн тодорхойлох хэсэгт Б.Б-гийн өмгөөлөгч Н.Ц-гийн гомдолд "... Б.Б-гийн эрүүл мэндийн байдал хүндэрлээ гэж олон удаа хэлж байсан, зүрхний даралт өвчнийг заавал нарийн мэргэжлийн эмчилгээ хийлгэх шаардлагатай, эмчийн заавраар эмийг уугаад сайжраагүй. Нарийн мэргэжлийн

12 Ерөнхий шүүгчийн ажлын албаны дарга өмнө гаргасан асуудлыг албан бичгээр буцаах, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг

эмч ирээд буруу эмчилгээ хийгдсэн гэж бүх эмийг сольсон. Буруу эмчилгээ хийгдэж байсан байна. ... Өвчтөний сэтгэл санааг тайван байлгах, амраах, агаарын солилцоо сайтай хүчил төрөгчтэй орчинд байлгах шаардлагатай гэсэн байсан. Мөн мэдрэлийн эмчид хандах шаардлагатай гэсэн байсан. Энэ талаарх баримт хавтаст хэрэгт авагдсан. Зайлшгүй гэх нөхцөл тогтоогдохгүй, эхнэр нь хөл хүнд, эх нь эмнэлэгт хэвтсэн. Дээрх асуудлыг анхаарч таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилж өгнө үү” гэсэн, харин өмгөөлөгч С.Ж-гийн гомдолд Б.Б-гийн эрүүл мэндийн байдлын талаар дурдаагүй, прокурор Д.Ш-ийн тайлбарт "... Б.Б-гийн эрүүл мэнд муудсан дээд шатлалын эмнэлэгт үзүүлье гэсэн санал ирүүлээгүй, тийм учраас таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлүүлэх санал үндэслэлгүй байна ..." гэжээ. Харин уг захирамжийн үндэслэх хэсэгт "... шүүх хүсэлтийг хүлээн авч Б.Б-д урьд авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх үндэслэл тогтоогдохгүй байна гэж үзэж, ... хугацааг сунгуулах прокурорын саналыг хүлээн авч 30 хоногийн хугацаагаар цагдан хорих нь үндэслэлтэй байна гэж шийдвэрлэсэн шүүгч С.Б-гийн гаргасан 92/2 дугаар захирамжийг хүчингүй болгох үндэслэлгүй бөгөөд хэвээр үлдээх нь зүйтэй” гээд өмгөөлөгч С.Ж, Н.Ц нарын гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэжээ.

Мөн өмгөөлөгч С.Ж-гийн 28-ны өдрийн хүсэлтэд хавсаргасан хорих ... дүгээр ангийн нэгдсэн эмнэлгийн эрүүл мэндийн тодорхойлолтод Б.Б нь 5 дугаар сарын 08-ны өдрөөс тус ангийн нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа болохыг тодорхойлов” гэж дурдсанаас үзвэл дээрх 22-ны өдрийн хуралдаан дээр өмгөөлөгч Н.Ц гомдолд дурдсан Б.Б-гийн эрүүл мэндийн байдал өөрчлөгдсөн гэж үзэхээргүй байна.

Харин өмгөөлөгчийн 5 дугаар сарын 28-ны хүсэлтэд дурдсан Б.Б-гийн эрүүл мэндийн асуудал Ерөнхий шүүгчийн явуулсан шүүх хуралдааны үед хэлэлцэгдсэн боловч Ерөнхий шүүгчийн захирамжийн үндэслэх хэсэгт өмгөөлөгч С.Ж, Н.Ц нарын хэн алиных нь гомдолд дурдсан үндэслэл тус бүрийг үнэлж, дүгнээгүй, ерөнхий дүгнэлт хийсэн байх тул өмгөөлөгч С.Ж-гийн 5 дугаар сарын 28-ны өдрийн хүсэлтэд дурдсан Б.Б-гийн эрүүл мэндийн асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн эсэх нь эргэлзээтэй байна.

Эдгээр нөхцөл байдлаас дүгнэвэл өмгөөлөгч С.Ж-гийн 28-ны өдрийн хүсэлтэд дурдсан Б.Б-гийн эрүүл мэндийн асуудал нь урьд хэлэлцэгдэж байгаагүй асуудал биш, урьд нь өмгөөлөгч Н.Ц-гийн гомдолд дурдсан нөхцөл байдлаас илүү хүндэрч өөрчлөгдөөгүй байх тул шүүгч С.Б-г Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.13 дугаар зүйлийг зөрчсөн, хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх үүргээ биелүүлээгүй ёс зүйн зөрчил гаргасан гэж үзэх үндэслэлгүй байна.

Харин эрх, эрх чөлөөгөө хязгаарлуулан цагдан хоригдсон этгээдийн эрүүл мэндийн байдалтай холбоотой хүсэлтийг дээрх эргэлзээтэй байдлыг тодруулсны дараа Ерөнхий шүүгчийн захирамжийн тодорхойлох хэсэгт тусгагдсан гомдлын үндэслэлийг Ерөнхий шүүгч шийдвэрлэсэн эсэх, мөн тухайн үеийн нөхцөл байдлаас өмгөөлөгчийн хүсэлтэд дурдсан үндэслэл өөрчлөгдсөн эсэхийг тогтоосны дараа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.13 дугаар зүйлийн 2-д зааснаар шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх товыг товлох эсэхээ шийдвэрлээгүй нь мэргэжлийн ур чадвартай холбоотой байх тул Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 2-д “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй” гэж заасны дагуу ёс зүйн зөрчилд хамаарахгүй байх тул шүүгч С.Б-гийн гомдлыг хангаж, магадлалыг хүчингүй болгож, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэлтэй байна.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 114.7, 121 дүгээр зүйлийн 121.1.3-д заасныг удирдлага болгон

ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 87 дугаар магадлалыг хүчингүй болгож, шүүгч С.Б-д холбогдуулан үүсгэсэн сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгосугай.

2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.5 дахь хэсэгт зааснаар давж заалдах шатны шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийг буруу хэрэглэсэн, шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн нь шүүхийн шийдвэр гарахад нөлөөлсөн гэж хэргийн оролцогч болон өмгөөлөгч нар үзвэл магадлалыг гардан авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.БАТБААТАР

ШҮҮГЧ

Э.ЗОРИГТБААТАР

ШҮҮГЧ

С.МӨНХЖАРГАЛ

UIN.MN
СУДАЛГААНЫ САН



МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЁС ЗҮЙН ХОРООНЫ МАГАДЛАЛ

2018 он 6 сар 13 өдөр

Дугаар 43

Улаанбаатар хот

П аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн
шүүгч Ц.С-д сахилгын шийтгэл ногдуулах тухай

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааныг тус хорооны дарга Н.Эрдэнэцогт даргалж, гишүүн Д.Сүнжид, Ч.Оюунцэцэг, В.Жавхлан, А.Доржготов нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны тэмдэглэл хөтлөгчөөр ажлын албаны шинжээч Ч.Ханддулам, хяналт шалгалт хариуцсан референт А.Баасанжав нарыг оролцуулан Шүүхийн ёс зүйн хорооны хуралдааны танхимд хийв.

Шүүгч Ц.С-ээс Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 5 дугаар сарын 03-ны өдрийн 71 дүгээр тогтоолыг эс зөвшөөрч нийт гишүүдийн хуралдаанд тайлбар гаргасныг Ёс зүйн хорооны гишүүн В.Жавхлангийн илтгэснээр хянан хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Гомдол гаргагч Ж.Ц, Б.Т нар Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан гомдолдоо:

Гомдлын шаардлага:

Паймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ц.С нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, 27.1.17. Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 4, 3.3 дугаар зүйлийн 1 дэх заалтыг тус тус зөрчиж ёс зүйн зөрчил гаргасан болохыг тогтоолгох, уг зөрчлүүдэд нь огцруулах сахилгын шийтгэл ногдуулах.

Гомдлын үндэслэл:

Иргэн Ж.Ц-ийн нэхэмжлэлтэй дор дурдсан нэхэмжлэлийн шаардлага бүхий захиргааны хэргийг П аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 111/ШШ201 8/0006 дугаартай шийдвэрээр хянан шийдвэрлэсэн болно. Үүнд:

1.П аймгийн Ш сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2015 оны 7-р сарын 4-ний өдрийн "Нөхөн сэргээлт хийлгэх тухай" 2/09 дугаартай тогтоолыг илт хууль бус болохыг тогтоолгох,

2.П аймгийн Ш сумын засаг дарга Д.С болон "ЦЦЦ" ХХК-ийн хооронд 2015 оны 7-р сарын 6-ны өдөр байгуулсан "П аймгийн Ш сумын С-ийн баруун, зүүн салааны уулзвар хэмээх газарт нөхөн сэргээлтээр ажиллах "ЦЦЦ" ХХК, Ш сумын засаг дарга, С багийн засаг дарга нарын хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээ"-г илт хууль бус болохыг тогтоолгох,

3.Дээрх хууль бус тогтоол болон хууль бус нөхөн сэргээлтийн гэрээний улмаас өөрт (газар эзэмшигчид) учирсан хохирлыг Хариуцагч нараар нөхөн төлүүлэх.

1.Хэргийн хөдөлгөөн хянаагүй, хугацаа баримтлаагүй талаар

Шүүх дээрх хэргийг хүлээн аваад шүүгч Ц.С-д хуваарилсан бөгөөд 2017 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр захиргааны хэрэг үүсгэсэн. Шүүх хэрэг үүсгэснээс хойш 306 хоногийн дараа хэргийг шийдвэрлэсэн. Шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх

ажиллагааг 4 удаа түдгэлзүүлсэн, мөн шүүгчийн захирамжид гаргасан гомдлыг давж заалдах шатны шүүхээс шийдвэрлэсэн хугацааг тус тус хасан тооцвол хэрэг үүсгэснээс хойш хэргийг

№	Хугацаатай холбоотой шүүхийн ажиллагаа	Огноо
1.	Хэрэг үүсгэсэн өдөр	2017.04.19
2.	ХХША-г түдгэлзүүлсэн өдөр	2017.06.07
3.	ХХША-г сэргээсэн өдөр	2017.07.25
4.	ХХША-г түдгэлзүүлсэн өдөр	2017.07.31
5.	ХХША-г сэргээсэн өдөр	2017.08.23
6.	ХХША-г түдгэлзүүлсэн өдөр	2017.09.15
7.	Түдгэлзүүлсэн захирамжийг давж заалдах шатны шүүхээс хүчингүй болгоод хэрэг буцаж ирсэн өдөр	2017.11.06
8.	ХХША-г түдгэлзүүлсэн өдөр	2018.01.26
9.	ХХША-г сэргээсэн өдөр	2018.01.22

157 хоногийн дараа шийдвэрлэсэн. Үүнд:

Шүүгчдийн зөвлөгөөний шийдвэрээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг 30 хоногоор сунгасан бөгөөд тийнхүү сунгасан хугацааг нэмэн тооцвол хэрэг хянан шийдвэрлэх 90 хоногийн хугацаа нь 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр дууссан бөгөөд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хугацаа 67 хоногоор хэтэрсэн болно.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхээс шинжээчээр томилогдсон байгууллагууд шинжээчийн дүгнэлт гаргах боломжгүй тухай хариу ирүүлээд байхад шүүх /шүүгч Ц.С/ дахин шинжээчээр томилж хэргийг удаашруулж, зөрчигдсэн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар хандсан нэхэмжлэгчийн эрхийг ноцтой зөрчиж байсан.

Ийнхүү дүгнэлт гаргаж өгөхгүй гээд байхад дахин шинжээчээр томилоод байгаа захирамжид нь гомдол гаргасны дагуу давж заалдах шатны шүүхээс уг захирамжийг нь үндэслэлгүй хэмээн шийдвэрлэж байсан.

Мөн 2017 оны 11 дүгээр сард нэхэмжлэгч, түүний төлөөлөгчийн зүгээс хэрэг шийдвэрлэгдэхгүй удаж байна, хэргийн хугацаагаа баримтлахыг хүссэн хүсэлтийг шүүх /шүүгч Ц.С/-д, мөн энэ асуудалд анхаарлаа хандуулна уу хэмээн тухайн шатны Ерөнхий шүүгчид энэ талаар хандаж байсан боловч хуулийн хугацааг хэтрүүлэн 2018.02.22-ны өдөр хэргийг шийдвэрлэсэн.

Хэдийгээр шүүгч Ц.С нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.4-т заасны дагуу "хэрэг, маргааныг шүүх бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлэхэд оролцох" эрхтэй боловч шүүгч Ц.С-ийн хэргийг хугацаанд нь шийдвэрлээгүй, нэхэмжлэгчийг чирэгдүүлсэн үйлдэл нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1-д "энэ хуульд заасан өөрийн бүрэн эрхээ урвуулан ашиглахыг хориглоно" гэж, Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 1-д "Шүүгч хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Хоёр. Хэргийн оролцогчтой ганцаарчлан утсаар ярьсан үйлдлийн талаар

Шүүгч Ц.С нь хэргийн оролцогч нартай шүүгчийн туслах болон нөгөө талыг байлцуулалгүйгээр хэдийд ч хамаагүй утсаар ярьдаг. Тухайлбал, нэхэмжлэгчийн төлөөлөгч Б.Т руу 2017.11.23-ны өдөр өөрийн5775 дугаартай утсаар холбогдон "ерөнхий шүүгчид яагаад хүсэлт, гомдол өгөөд байгаа юм бэ? хэргийг чинь шийдэх

гээл байна ш тээ" зэрэг зүйлийг ярьсан. Түүнчлэн хожим уг дугаараар нь залгаад хоёр ч удаа Ц.С шүүгчтэй ярьж болж байсан. Ийнхүү хэргийн оролцогч нар руу шүүгчийн туслах болон бусад талуудыг байлцуулалгүйгээр өөрөө залгаж ярьдаг эсхүл хэргийн оролцогчоос залгасан тохиолдолд ярьж байгаа эдгээр үйлдэл нь шүүхэд итгэх итгэлийг сулруулж, хэргийн бусад оролцогчтой ингэж ярьдаг гэж ойлгогдож байгаа болно.

Дээрх үйлдэл нь хэдийгээр зайнаас утсаар ярьж байгаа үйлдэл боловч ганцаарчлан хэргийн талаар ярилцаж байгаа тул Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.17-д "хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах", Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 4-т "Шүүгч хэргийн оролцогчтой ганцаарчлан уулзаж хэргийн нөхцөл байдал, гэм буруугийн талаар ярилцаж болохгүй бөгөөд хэрэв албан ажлын зайлшгүй шаардлагын улмаас хэргийн нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай уулзах бол шүүхийн туслах ажилтан байлцуулах бөгөөд уулзалтын агуулгын талаар тэмдэглэл хөтлөн хэрэгт хавсаргана." гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Дээрх зөрчил нь хэргийн оролцогч нарын хувьд шүүхэд итгэх итгэлийг сулруулсан, санаатай зөрчил тул шүүгч Ц.С-д огцруулах шийтгэл ногдуулах үндэслэлтэй хэмээн үзэж байна.

2.Иймд дээрх нөхцөл байдлыг шалган, дор дурдсан шийдвэрийг гаргаж өгөхийг Шүүгчийн Ёс зүйн хорооноос хүсье. Үүнд:

1.П аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ц.С нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, 27.1.17, Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 4, 3.3 дугаар зүйлийн 1 дэх заалтыг тус тус зөрчиж ёс зүйн зөрчил гаргасан болохыг тогтоолгох,

2.Дээрх ёс зүйн зөрчилд огцруулах сахилгын шийтгэл ногдуулах.

Хүсэлт: Гомдолтой холбоотой материалуудыг хэргийн материалаас татан авах, хэрэв тийм боломжгүй бол гомдол гаргагч нарт мэдэгдэн холбогдох баримтыг гаргуулах, тайлбар авахыг хүсье гэжээ.

Шүүгч Ц.С Шүүхийн Ёс зүйн хороонд ирүүлсэн тайлбартаа:

Нэхэмжлэгч Ж.Ц, Б.Т нарын Шүүхийн ёс зүйн хороонд гаргасан гомдлыг 2017 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн 12 цагт хүлээн авч танилцаад дараах тайлбарыг гаргаж, нийт 158 хуудас нотлох баримтын хамт хүргүүлж байна.

Нэхэмжлэгч Ж.Ц нь тус шүүхэд хандаж, П аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, П аймгийн Ш сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Ш сумын Засаг дарга нарт холбогдуулан П аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, П аймгийн Ш сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Ш сумын Засаг дарга нарт холбогдуулан "П аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн "Журмын үйлчлэлийг сэргээн, нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 9/2 дугаартай тогтоолыг илт хууль бус болохыг тогтоолгох, П аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн "Нөхөн сэргээлт хийх газар, талбайн хэмжээ, солбицол батлах тухай" 54 дугаартай тогтоолын хавсралтын иргэн Ж.Ц-ийн эзэмших эрх бүхий газарт холбогдох хэсгийг илт хууль бус болохыг тогтоолгох, Ш сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн "Нөхөн сэргээлт хийлгэх тухай" 2/09 дугаартай тогтоолыг илт хууль бус болохыг тогтоолгох, Ш сумын Засаг дарга Д.С болон "ЦЦЦ" ХХК-ийн хооронд 2014 оны 7 дугаар сарын 04-ний өдөр байгуулсан "П аймгийн Ш сумын Т-гийн баруун, зүүн салааны уулзвар хэмээх газарт нөхөн сэргээлтээр ажиллах "ЦЦЦ" ХХК, Ш сумын Засаг дарга, С багийн Засаг дарга нарын хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээ"-г илт хууль бус болохыг тогтоолгох, дээрх хууль бус тогтоолууд болон хууль

бус нөхөн сэргээлтийн гэрээний улмаас өөрт учирсан хохирлыг хариуцагч нараар нөхөн төлүүлэх" шаардлага бүхий 2 нэхэмжлэлийг анх гаргасан бөгөөд шүүх 2017 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр захиргааны хэрэг үүсгэсэн¹³.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэгч болон нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нар "П аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 5-р сарын 26-ны өдрийн "Журмын үйлчлэлийг сэргээн, нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 9/2 дугаартай тогтоолыг илт хууль бус болохыг тогтоолгох, тус Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 4-р сарын 16-ны өдрийн "Нөхөн сэргээлт хийх газар, талбайн хэмжээ, солбицол батлах тухай" 54 дугаартай тогтоолын хавсралтын иргэн Ж.Ц-гийн эзэмших эрх бүхий газарт холбогдох хэсгийг илт хууль бус болохыг тогтоолгох" гэсэн нэхэмжлэлийн шаардлагуудаасаа татгалзсан тул тус шүүхийн 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 11/ШЗ2017/0269 дугаар Шүүгчийн захирамжаар нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаасаа хэсэгчлэн татгалзсаныг баталж, холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосон.

Нэг. Гомдолд "хэргийн хөдөлгөөнийг хянаагүй, хугацаа баримтлаагүй" гэжээ.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1-д "Хуульд өөрөөр заагаагүй бол хэрэг үүсгэснээс хойш 60 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ", 63 дугаар зүйлийн 63.3-т "Энэ хуулийн 63.1, 63.2-т заасан хугацааг шаардлагатай тохиолдолд тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс эхний удаа 30 хүртэл хоногоор..сунгаж болно", 40.1-д "Хэрэг хянан шийдвэрлэхэд шинжлэх ухаан, тооцоо, тоо бүртгэл, урлаг, утга зохиол, техникийн зэрэг тусгай мэдлэг шаардагдах асуудлыг тодруулахын тулд хэргийн оролцогчийн хүсэлтээр, эсхүл шүүхийн санаачилгаар шинжээчийг томилж болно", 65.1.7-д "энэ хуулийн 33, 35, 40 дүгээр зүйлд заасан ажиллагаа явуулж байгаа" бол хэрэг хянан шийдвэрлэх хугацааг түдгэлзүүлнэ" гэж заасны дагуу нэхэмжлэгч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гаргасан "Шинжээч томилуулах" хүсэлтийн /хэрэгт байгаа/ дагуу тус шүүхийн 2017 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн 111 /ШЗ2017/01112 дугаар шүүгчийн захирамжаар аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар болон Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрыг шинжээчээр томилж, хэрэг хянан шийдвэрлэх хугацааг түдгэлзүүлсэн¹⁴.

Уг захирамжийн хариу буюу Шинжээчийн дүгнэлтүүд¹⁵, шүүхэд ирж тус шүүхийн 2017 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн захирамжаар түдгэлзүүлсэн хугацааг сэргээсэн¹⁶.

Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Н.Э-гийн гаргасан "Шинжээч томилуулах" хүсэлтийн /хэрэгт байгаа/ дагуу тус шүүхийн 2017 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн 111 /шз2017/0160 дугаар шүүгчийн захирамжаар аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар болон Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрыг шинжээчээр томилж, хэрэг хянан шийдвэрлэх хугацааг түдгэлзүүлсэн¹⁷ Шинжээчийн дүгнэлтүүд¹⁸ /нэг дүгнэлт хэрэгт байгаа/ шүүхэд ирснээр тус шүүхийн 2017 оны 8 сарын 23-ны өдрийн шүүгчийн захирамжаар түдгэлзүүлсэн хугацааг сэргээсэн¹⁹.

Тус шүүхийн 2017.08.25-ны өдрийн зөвлөгөөний тогтоолоор хэрэг хянан шийдвэрлэх хугацааг 30 хоногоор хугацаа сунгасан²⁰.

Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Т-ээс "Шинжээч томилуулах" хүсэлт гаргасныг урьдчилсан хэлэлцүүлгээр хэлэлцэж, тус шүүхийн 2017.9.14-ний

13 Хавсаргасан баримтын 1-8 дугаар тал 3

14 Хавсаргасан баримтын 9-15 дугаар тал

15 Хавсаргасан баримтын 16-17, 21 дүгээр тал

16 Хавсаргасан баримтын 24-28 дугаар тал

17 Хавсаргасан баримтын 18-20 дахь тал

18 Хавсаргасан баримтын 32 дугаар тал

19 Хавсаргасан баримтын 38-43 дахь тал

20 Хавсаргасан баримтын 33-34 дахь тал

өдрийн 111 /шз2017/0209 дугаар захирамжаар хүсэлтийг хангахаас татгалзаж²¹, 9 сарын 15-ны өдрийн 111/шз2017/0212 дугаар захирамжаар шинжээч томилж, ажиллагааг түдгэлзүүлсэн²² бөгөөд уг захирамжуудад гомдол²³ гарч хэргийг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд 9 сарын 20-ны өдрийн тоотоор хүргүүлсэн²⁴.

Давж заалдах шатны шүүхээс захирамжуудыг хянаад 2017.11.10-ны өдөр хэрэг анхан шатны шүүхэд ирж²⁵, тус шүүхийн 2017.11.13-ны өдрийн Шүүгчийн захирамжаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээж²⁶, 2017.12.08-ны өдрийн Шүүгчийн захирамжаар шүүх хуралдааныг товлох урьдчилсан хэлэлцүүлгийг 2017.12.14-ний өдөр хийхээр товлосон²⁷ бөгөөд 2017.12.14-ний өдрийн урьдчилсан хэлэлцүүлэгт нэхэмжлэгч тал нотлох баримт гаргуулах, хариуцагч тал гэрч асуулгах, нотлох баримт хасуулах, нотлох баримт гаргуулах, 10 хоногоор сунгах зэрэг хүсэлтүүд гаргаж, урьдчилсан хэлэлцүүлгийн хугацааг 10 хоногоор сунгаж, 2017.12.25-ны өдрийн урьдчилсан хэлэлцүүлгээр шүүх хурлыг 2018 оны 1 сарын 09-ний өдөр хийхээр товлосон²⁸.

2017 оны 1 сарын 09-ний өдрийн шүүх хуралдааныг хариуцагч талын хүсэлтээр 14 хоногоор хойшлуулж²⁹, 2018.01.23-нд шүүх хуралдааныг товлосон боловч хариуцагч талын хүсэлтээр 30 хоногоор хойшлуулж, шүүх хуралдааныг 2018.02.22-нд хянан шийдвэрлэхээр товлон зарласан³⁰.

Хэрэг хянан шийдвэрлэх хугацаанд нэхэмжлэгч тал нэхэмжлэлийн шаардлагаа өөрчилсөнтэй /хэрэгт байгаа/ холбогдуулан тус шүүхийн 2018 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 111/ШЗ2018/0023 дугаар шүүгчийн захирамжаар Шинжээч томилж, хэрэг хянан шийдвэрлэх хугацааг түдгэлзүүлж³¹, дүгнэлт ирэх хугацааг 2 дугаар сарын 22-ны өдрийн дотор тогтоож, дүгнэлт³² хугацаандаа ирж, 2018 оны 2 сарын 22-ны өдрийн Шүүгчийн захирамжаар хугацааг сэргээж³³, шүүх хуралдаан товлосон цагтаа хийгдэж, хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан хэлэлцэж, нэхэмжлэгчийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн³⁴.

Шүүхийн шийдвэр Уг шийдвэрийг нэхэмжлэгч тал эс зөвшөөрч давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж, хэрэг хянагдаж байгаа болно.

Дээрх нөхцөл байдлаас дүгнэхэд:

Нэхэмжлэлийг хүлээн авч, 2017 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр захиргааны хэрэг үүсгээд 2018 оны 2 дугаар сарын 22-ны өдөр шийдвэрлэх хүртэл нийт 306 хоног, хуульд зааснаар 30 хоногоор сунгасан, үүнээс 3 удаа шинжээч томилж, хэрэг хянан шийдвэрлэх хугацааг түдгэлзүүлэхдээ 2 удаа талуудын хүсэлтээр, нэг удаа шүүх санаачилгаараа шинжээч томилсон, талуудын хүсэлтээр урьдчилсан хэлэлцүүлэг 1 удаа 10 хоногоор, шүүх хуралдаан 2 удаа 14, 30 хоногоор тус тус хойшилсон байх бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх хугацааг түдгэлзүүлж, сэргээсний нийт 128 хоног болон захирамжид гарсан гомдлыг давж заалдах шатны шүүх хянан шийдвэрлэсэн 40 хоног буюу нийт 168 хоног нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, 63 дугаар зүйлийн 63.5,

21 Хавсаргасан баримтын 48-54 дахь тал

22 Хавсаргасан баримтын 55-60 дахь тал

23 Хавсаргасан баримтын 61-66 дахь тал

24 Хавсаргасан баримтын 74 дахь тал

25 Хавсаргасан баримтын 75 дахь тал

26 Хавсаргасан баримтын 79-81 дахь тал

27 Хавсаргасан баримтын 85-86 дахь тал

28 Хавсаргасан баримтын 89-90 дүгээр тал

29 Хавсаргасан баримтын 101-103 дахь тал

30 Хавсаргасан баримтын 114-115 дугаар тал

31 Хавсаргасан баримтын 116-120 дахь тал

32 Хавсаргасан баримтын 121-123 дугаар тал

33 Хавсаргасан баримтын 124-125 дахь тал

34 Хавсаргасан баримтын 126-156 дугаар тал

65 дугаар зүйлийн 65.1.7-д тус тус заасан хугацаанд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хийхгүй байхаар хуульчилсан хугацаанд хамаарч байна.

Хэргийг тал бүрээс нь бодитой үнэлж, шийдвэрлэхийн тулд нотлох баримтыг бүрдүүлэх үүднээс нэхэмжлэгч Ж.Ц, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Т нарын 2018.01.03-ны өдөр гаргасан гэрч асуулгах тухай хүсэлтийн дагуу иргэн Г.Э, Ц.Г, М.У, С.Х, С.Г, Д.М нарыг, хариуцагч Д.С, Ж.У нараас 2018.01 05-ны өдөр гаргасан гэрч асуулгах хүсэлтийн дагуу Д.Д болон нэр бүхий 5 гэрчийг асуусан, мөн энэхүү гэрчүүдээс нэмэлт асуулт асуухаар нэхэмжлэгч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч нараас 2018.01.18-ны өдөр гаргасан хүсэлтүүдийг хангаж, гэрчүүдийг асуух ажиллагааг хийсэн. Мөн нэхэмжлэгч, хариуцагч нарын гаргасан нотлох баримт гаргуулах тухай хүсэлтүүдийн дагуу Ашигт малтмалын газарт 2017.06.07-нд, П аймгийн ИТХ-д 2017.06.07-нд, аймгийн Ш сумын Засаг даргад 2017.06.07-нд, Мэргэжлийн хяналтын газарт 2017.06.07-нд, 2017.07.28-нд, 2017.11.22-нд, аймгийн ЗДТГ-ын хөгжлийн бодлогын хэлтэст 2017.07.28-нд, П аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газарт 2017.06.07-нд, 2017.07.28-нд, 2017.09.20-нд, 2017.11.22-нд, аймгийн Ш сумын ИТХ-д 2017.09.20-нд, аймгийн Ш сумын Байгаль орчны байцаагчид 2017.11.22-нд, "ЦЦЦ цэцэн" ХХК-д 2017.12.18-нд нотлох баримт гаргуулахаар тус тус албан бичиг хүргүүлж нотлох баримт бүрдүүлэх ажиллагаа хийсэн, мөн тус шүүхийн 2018 оны 01 сарын 03-ны өдрийн зөвлөгөөний тогтоолоор шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг томилсон бөгөөд нэхэмжлэгч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гаргасан Шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг тус шүүхийн 2018 оны 01 сарын 18-ны өдрийн зөвлөгөөний тогтоолоор хэрэгсэхгүй болгосон.

Зайлшгүй шаардлагатай нотлох баримтын эх сурвалжийг олох, тухайлбал, Нөхөн сэргээлтийн тайланг гаргуулах хүсэлтдээ хэргийн оролцогчид нотлох баримтын байгаа газрыг буруу заах, нэг байгууллагад байхгүй тохиолдолд дараагийн байгууллагаас шаардах гэх мэтээр, мөн хөдөө орон нутгийн сүлжээгүй газарт байгаа, өөр аймагт байдаг гэрчүүдийг дуудаж асуухад цаг агаарын болон бусад хүндрэл бэрхшээлтэй байсан ч талуудын хүсэлтүүдийг хуулийн хүрээнд хангаж, зохих ажиллагаа хийснийг хэргийн оролцогчид бүгд мэдэж байгаа, мөн холбогдох нотлох баримтуудыг давж заалдах шатны шүүхэд хянагдаж байгаа 5 хавтас хэргээс харж, хуулбарлан авч болно.

"Албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах" гэдгийг Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "албан тушаалын эрх мэдлийг албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийхийг" ойлгоно гэж тодорхойлсон бөгөөд энэхүү хэргийг хариуцан хянан шийдвэрлэх ажиллагааг явуулсан шүүгчийн хувьд миний бие хуульд заасны дагуу нотлох баримтуудыг бүрдүүлэх үүргээ хэрэгжүүлж хянан шийдвэрлэсэн бөгөөд Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1-д зааснаар хуульд заасан бүрэн эрхээ урвуулан ашигласан үйлдэл гаргаагүй бөгөөд, үүнийгээ эрх мэдлээ урвуулан ашигласан үйлдэл гэж үзэхгүй байна.

Хоёр. Хэргийн оролцогчтой ганцаарчлан утсаар ярьсан үйлдлийн талаар:

Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Т нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад 2017 оны 11 сарын 23-ны өдөр тус шүүхийн Ерөнхий шүүгчид болон Тамгын газрын даргад тус тус хүсэлт өгсөн байсан ба үүний дагуу Ерөнхий шүүгч намайг дуудаж уулзсан. Би хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар танилцуулсан.

Мөн энэ өдөр нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Т нь шүүгчийн туслах А.Б-тэй утсаар холбогдож "нэхэмжлэлийн 5 шаардлагын 2 шаардлагаас татгалзсан байхад үүнийг яагаад шийдэхгүй байгаа юм бэ, нотлох баримт

гаргуулахаар шаардаад байхад яагаад баримтуудыг авахгүй байгаа юм бэ, яагаад хэргийг шийдэхгүй байгаа юм бэ" гэх зэрэг зүйлийг асууж ярьсан байсан. Шүүгчийн туслах А.Б "намайг хэлэхээр ойлгохгүй байна, та хэлээд өгөөч" гээд хэргийг аваад миний өрөөнд орж ирсэн.

Хэргийн материалаас Б.Т-гийн утасны дугаарыг туслахаар харуулаад залгаж ярьсан. "Ерөнхий шүүгчид хүсэлт гаргасан байна, нэхэмжлэгч танай талын гаргасан хүсэлтийг шийдвэрлэсэн шүүгчийн захирамжид өөрийн чинь гаргасан гомдлоор хэрэг давж заалдах шатны шүүхэд хянагдахаар 2017 оны 9 сарын 20-нд яваад 11 сарын 10-ны өдөр шүүхэд ирсэн /хэргийн хавтасны ар талын хуудас дахь дардаснаас харж болно/, шүүгчийн захирамжаар татгалзлыг баталсан, холбогдох байгууллагуудаас шаардсан нотлох баримтууд бүгд хэрэгт хавсаргагдсан байна /туслахын хамт хуудсуудыг эргүүлэн олж дугаараар нь хэлж өгсөн/, хэргийг шийдэх гээд ажиллагаа хийж байгаа" гэх зүйлийг ярьсан. Намайг ярихад шүүгчийн туслах А.Б хамт байсан, би хэргийн шийдвэрлэлтийн талаар яриагүй, шүүгчийн туслахын тайлбарлаад ойлгоогүй зүйлийг тайлбарлаж өгсөн бөгөөд энэ талаар шүүгчийн туслах тэмдэглэл үйлдсэн³⁵, Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Т нь Ерөнхий шүүгчид хандаж хүсэлт³⁶ өгсөн байсан тул утсаар ярьсан тухай тэмдэглэлийг уг хүсэлтэд хавсаргаж, Ерөнхий шүүгчид хандсан өргөдөл, гомдол тусдаа байдаг тул уг хүсэлт болон утсаар ярьсан тэмдэглэлийг хэрэгт хийх шаардлагагүй гэж үзсэн болно.

Харин амралтын өдрөөр буюу хагас сайн өдөр намайг гэртээ амарч байхад 7575.... гэх мэдэхгүй дугаараас дуудлага ирснийг автал "Т байна хэргийг хэзээ шийдэх юм бэ, шийдэхгүй бол Улсын Дээд шүүх болон Шүүхийн Ерөнхий зөвлөлд гомдол гаргана шүү" гэж үг хэлэх боломж олголгүйгээр үргэлжлүүлэн хэлсэн, би хариуд нь "ажиллагаа хийж байгаа, таны гомдол гаргах эрх чинь нээлттэй" гэж хэлээд утсаа тасалсан.

Дараагийн удаа мөн амралтын өдөр 7575... гэсэн өмнөхөөс өөр дугаараар залгаж мөн дээрх зүйлийг дахин хэлэхэд нь би мөн адил хариултыг өгсөн. /утасны билл авахаар хүсэлт өгсөн боловч одоогоор ирээгүй байгаа тул ирэнгүүт явуулна/

Би тухайн үед дээрх байдлыг Ерөнхий шүүгчид танилцуулсан, Шүүгчийн ёс зүйн дүрэмд зааснаар нөлөөллийн мэдүүлэг хөтлөх үүрэгтэй ч хэргийн оролцогчид хүндрэл учруулахыг хүсээгүй. Харин Б.Т нь санаатайгаар амралтын өдрөөр өөр өөр дугаараар удаа дараалан залгаж тийм нөхцөл байдал үүсгэх гэж байжээ гэж бодож байна.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.17-д "хэргийн нөгөө талын байлцуулахгүйгээр нэг талтай уулзах", Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2.4-т "Шүүгч хэргийн оролцогчтой ганцаарчлан уулзаж хэргийн нөхцөл байдал, гэм буруугийн талаар ярилцаж болохгүй бөгөөд хэрэв албан ажлын зайлшгүй шаардлагын улмаас хэргийн нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай уулзах бол шүүхийн туслах ажилтан байлцуулах бөгөөд уулзалтын агуулгын талаар тэмдэглэл хөтлөн хэрэгт хавсаргана" гэж заасан бөгөөд миний бие нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Т-тэй ганцаарчлан биечлэн уулзаагүй, мөн хэргийн нөхцөл байдал, гэм буруугийн талаар ярилцаагүй болно.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1-д заасан татгалзан гарах үндэслэл, ашиг сонирхлын зөрчил надад байгаагүй учраас энэ хэргийг хянан шийдвэрлэсэн.

Иймд миний бие нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27 дугаар зүйлийн 27.1.1, 27.1.17, Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2.4 дэх заалтуудыг зөрчөөгүй гэж үзэж байна гэжээ.

35 Хавсаргасан баримтын 158 дахь тал

36 Хавсаргасан баримтын 157 дахь тал

Шүүгч Ц.С нэмэлт тайлбартаа:

Миний бие тус хороонд тайлбараа, нотлох баримтын хамт явуулсан бөгөөд тайлбарт утасны биллийг авахаар холбогдох байгууллагад хүсэлт өгсөн талаар дурдсан. Гэтэл Юнител ХХК-иас "...тухайн харилцагчийн утасны сүүлийн 3 сарын дэлгэрэнгүй биллийг гаргах боломжтой, үүнээс өмнөх сарууд гарах боломжгүй..." гэсэн хариуг өгсөн тул 11 дүгээр сарын ярианы хуулбар гаргах боломжгүй юм байна.

Шүүгчийн туслах А.Б Шүүхийн Ёс зүйн хороонд ирүүлсэн тайлбартаа:

П аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн туслахаар А.Б миний бие 2017 оны 7 дугаар сарын 25-ны өдрөөс 2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийг хүртэлх хугацаанд ажилласан болно.

Ийнхүү ажиллах хугацаанд Ж.Ц-гийн нэхэмжлэлтэй, П аймгийн Ш сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Ш сумын Засаг дарга, Ш сумын С багийн Засаг дарга нарт холбогдох захиргааны хэрэгт нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Т 2017 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр тус шүүхийн Ерөнхий шүүгч С.С-д хүсэлт гаргасан /Ирсэн бичгийн бүртгэлийн 227-д бүртгэгдсэн/.

Миний бие 2017 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 11 цаг 30 минутын орчим Ерөнхий шүүгч С.С-д нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Т-гийн хүсэлт болон Ж.Ц-гийн нэхэмжлэлтэй хэргийг танилцуулсан.

Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Т нь шаардсан нотлох баримтууд хэрэгт байхгүй байна, хэрэг шийдвэрлэхгүй байгаа талаар ярихад нь би тайлбарлаж хэлсэн бөгөөд шүүгчээр тайлбарлуулахаар хэргээ авч орсон.

2017 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 15 цагийн орчим шүүгч Ц.С нь тус шүүхийн 208 тоот өрөөндөө шүүгчийн туслах А.Б намайг байлцуулан нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Т-гийн утасны дугаарын хэргээс надаар харуулан ...729 дугаарын утас уруу залгаж, "хэрэг шийдэхгүй байгаа талаар Ерөнхий шүүгчид хүсэлт ирүүлсэн байна, Б.Т-гийн гаргасан гомдлоор Ж.Ц-гийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг нь давж заалдах шатны шүүхэд хянагдаад 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр шүүхэд ирсэн, мөн таны шүүхэд гаргасан хүсэлтийн дагуу нотлох баримтууд авагдсан, холбогдох ажиллагаа хийгдэж байгаа талаар дурдсан" нь үнэн болно. Миний бие тухайн үед тэмдэглэл хөтөлсөн.

Шүүгч Ц.С нийт гишүүдийн хуралдаанд гаргасан гомдолдоо:

"Гомдол гаргагч нэхэмжлэгч Ж.Ц, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Т нар нь Шүүхийн Ёс зүйн хороонд хандаж, шүүгч Ц.С нь хэргийг хугацаанд нь шийдвэрлээгүй, нэхэмжлэгчийг чирэгдүүлсэн үйлдэл нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1-д "энэ хуульд заасан өөрийн бүрэн эрхээ урвуулан ашиглахыг хориглоно" гэж, Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 1-д "Шүүгч хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй" гэж заасныг тус тус зөрчсөн гэсэн боловч Шүүхийн Ёс зүйн хорооноос хэргийг хугацаа хэрүүлж шийдвэрлээгүй байна гэж үзсэн.

Мөн Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.17-д "хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах", Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 4-т "Шүүгч хэргийн оролцогчтой ганцаарчлан уулзаж хэргийн нөхцөл байдал, гэм буруугийн талаар ярилцаж болохгүй бөгөөд хэрэв албан ажлын зайлшгүй шаардлагын улмаас хэргийн нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай уулзах бол шүүхийн туслах ажилтан байлцуулах бөгөөд уулзалтын агуулгын талаар тэмдэглэл хөтлөн хэрэгт хавсаргана" гэж заасныг тус тус зөрчсөн гэж гомдол гаргасан.

Шүүхийн Ёс зүйн хорооны дүгнэлтэд шүүгч Ц.С-г Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.17, Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2 дугаар

зүйлийн 4 дэх заалтуудыг зөрчсөн эсэх талаар ямар нэгэн дүгнэлт хийгээгүй байна.

Харин шүүгчийг гомдол гаргагчийн үндэслэл болгосон заалтуудаас өөр үндэслэлээр буюу Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2.1, 2.3.1, 3.3.2, 3.3.6 дахь заалтуудыг зөрчсөн гэж сахилгын хэрэг үүсгэснийг дараах байдлаар хүлээн зөвшөөрөхгүй бөгөөд гомдолтой байна.

1.Тогтоолд "...Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 1-д "Шүүгч нь хэргийн оролцогчдод эрх тэгш, төвийг сахисан, хүнлэг ёсоор хандаж, хэргийг татгалзахад хүргэсэн нөхцөл байдлыг үр, яриа, үйлдлээр болон бусад байдлаар ч үүсгээгүй болно.

2.Тогтоолд "... дүрмийн 3.3 дугаар зүйлийн 6-д заасан "өөрийн удирдлага дор ажиллаж байгаа алба хаагчдад ...ёс зүйн эрүүл орчныг бүрдүүлнэ" гэж заасныг тус тус зөрчсөн...", мөн шүүгчийн туслахын хэлснээр хэргийн оролцогчтой утсаар ярьсан нь өөрийн удирдлага дор ажиллаж байгаа алба хаагчдад ёс зүйн үлгэр дуурайл үзүүлээгүй байна..." гэжээ.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.17-д "хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах", Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2.4-т "Шүүгч хэргийн оролцогчтой ганцаарчлан уулзаж хэргийн нөхцөл байдал, гэм буруугийн талаар ярилцаж болохгүй бөгөөд хэрэв албан ажлын зайлшгүй шаардлагын улмаас хэргийн нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай уулзах бол шүүхийн туслах ажилтан байлцуулах бөгөөд уулзалтын агуулгын талаар тэмдэглэл хөтлөн хэрэгт хавсаргана" гэж заасан бөгөөд миний бие нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Т-тэй ганцаарчлан биечлэн уулзаагүй, мөн хэргийн нөхцөл байдал, гэм буруугийн талаар ярилцаагүй болно.

Харин Шүүгчийн ёс зүйн дүрэмд хэргийн оролцогчтой шүүгч албан ажлын зайлшгүй шаардлагын улмаас шүүгчийн туслахыг байлцуулан, тэмдэглэл үйлдэж, утсаар ярьж болох эсэх, энэ нь зөрчил мөн эсэх талаар зохицуулаагүй байна.

Гэтэл миний бие нь албан ажлын зайлшгүй шаардлагын улмаас ажлын цагаар шүүгчийн туслахаа байлцуулан тэмдэглэл хөтлүүлэн, шүүгчийн туслахын тайлбарлаад ойлгохгүй байгаа, хэргийн хугацаа болон шаардсан нотлох баримт авагдаагүй байна гээд бухимдаад байгаа хэргийн оролцогчид тайлбарлаж өгсөн нь шүүгчийн туслахдаа ёс зүйн эрүүл орчныг бүрдүүлээгүй үйлдэл гэж үзэхгүй байна.

Түүнчлэн шүүгчийн туслахын гаргасан "Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Т нь шаардсан нотлох баримтууд хэрэгт байхгүй байна, хэрэг шийдэхгүй байгаа талаар ярихад нь би тайлбарлаж хэлсэн бөгөөд шүүгчээр тайлбарлуулахаар хэргээ авч орсон. 2017.11.23-ны өдрийн 15 цагийн орчим шүүгч Ц.С нь тус шүүхийн 208 тоот өрөөндөө шүүгчийн туслах А.Б намайг байлцуулан нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Т-гийн утасны дугаарыг хэргээс надаар харуулан1729 дугаарын утас уруу залгаж, "хэрэг шийдэхгүй байгаа талаар Ерөнхий шүүгчид хүсэлт ирүүлсэн байна, Б.Т-гийн гаргасан гомдлоор Ж.Ц-гийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг нь давж заалдах шатны шүүхэд хянагдаад 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр шүүхэд ирсэн, мөн таны шүүхэд гаргасан хүсэлтийн дагуу нотлох баримтууд авагдсан, холбогдох ажиллагаа хийгдэж байгаа талаар дурдсан" нь үнэн болно. Миний бие тухайн үед тэмдэглэл хөтөлсөн" гэсэн тайлбарыг шүүгчийн эсрэг сөргөөр ашигласанд гомдолтой байна.

Шүүгчийн туслах нь намайг хэргийн оролцогчтой албан ажлын зайлшгүй шаардлагын улмаас юу гэж ярьсныг, миний бие нь хэргийн оролцогчтой хүнлэг бус харьцаагүй, тэгш бус байдал гаргаж, загнаж, зандраагүй, бүдүүлэг үг, хэллэг хэрэглээгүй, хэргийн гэм буруу, нөхцөл байдлын талаар яриагүй болохыг шүүгчийн туслах А.Б 2 удаагийн тайлбараараа илэрхийлж, гэрчилсэн бөгөөд уг тайлбарт

шүүгчийн энэ үйлдэл нь шүүгчийн туслахад буруу үлгэр дуурайлал болсон талаар дурдсан зүйл байхгүй юм.

3.Тогтоолын үндэслэх хэсэгт "Шүүгч Ц.С нь нэхэмжлэгчийн төлөөлөгч Б.Т руу 2017.11.23-ны өдөр өөрийн5775 дугаартай утсаар холбогдон ярьсан, мөн амралтын өдрөөр буюу хагас сайн өдөр хоёр удаа Б.Т-тэй дахин утсаар ярьсан нь шүүгч төвийг сахих зарчмыг зөрчсөн улмаар шүүгч хэргийн оролцогчийн аль нэг талд ажилласан, төвийг сахиагүй мэт ойлголт төрүүлэх эсхүл тийнхүү хардагдах нөхцөлийг бий болгожээ..." гэсэн нь үндэслэлгүй юм.

Учир нь: 2017 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр миний бие нь нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Т-тэй албан ажлын зайшгүй шаардлагын улмаас ажлын цагаар шүүгчийн туслахаа байлцуулан тэмдэглэл хөтлүүлэн, шүүгчийн туслахын тайлбарлаад ойлгохгүй байгаа, хэргийн хугацаа болон шаардсан нотлох баримт авагдаагүй байна гээд бухимдаад байгаа хэргийн оролцогчид тайлбарлаж өгсөн, энэ талаар тэмдэглэл үйлдсэн талаар дээр дурдсан. Гэтэл ...мөн амралтын өдрөөр буюу хагас сайн өдөр хоёр удаа Б.Т-тэй дахин утсаар ярьсан... гэж амралтын өдрөөр хэргийн оролцогчийн утас руу би өөрөө залгаж ярьсан мэтээр буруутгаж байгаад гомдолтой байна. Би тус хороонд өмнө нь гаргасан тайлбартаа "...амралтын өдрөөр буюу хагас сайн өдөр намайг гэртээ амарч байхад 7575... гэх мэдэхгүй дугаараас дуудлага ирснийг автал "Т байна хэргийг хэзээ шийдэх юм бэ, шийдэхгүй бол Улсын Дээд шүүх болон Шүүхийн Ерөнхий зөвлөлд гомдол гаргана шүү" гэж үг хэлэх боломж олголгүйгээр үргэлжлүүлэн хэлсэн би хариуд нь "ажиллагаа хийж байгаа, таны гомдол гаргах эрх чинь нээлттэй" гэж хэлээд утсаа тасалсан. Дараагийн удаа мөн амралтын өдөр 7575... гэсэн өмнөхөөс өөр дугаараар залгаж мөн дээрх зүйлийг дахин хэлэхэд нь би мөн адил хариултыг өгсөн.

Би тухайн үед дээрх байдлыг Ерөнхий шүүгчид танилцуулсан. Шүүгчийн ёс зүйн дүрэмд зааснаар нөлөөллийн мэдүүлэг хөтлөх үүрэгтэй ч хэргийн оролцогчид хүндрэл учруулахыг хүсээгүй" гэдгээ бичсэн.

Би Б.Т-г залгаж байгааг мэдээгүй, мэдэх ч боломжгүй, би өөрөө залгаагүй, өөр өөр дугаарын утаснаас 2 удаа залгаад үг хэлэх боломж олголгүйгээр загнасан, би сонсож байгаад "хэргийг шийдэх гээд ажиллагаа хийж байгаа, хандах эрх чинь нээлттэй" гэж хэлээд тасалсан, надад Б.Т-г залгуулахгүй байх ямар ч боломж, арга байхгүй гэдгийг анхаарч үзэхийг хүсэж байна.

Дээрх байдлаас дүгнэхэд миний бие нь Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1-д заасан "Шүүгч нь хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, хууль дээдлэх, ...аливаа асуудалд бодитой, төвийг сахисан байр сууринаас хандах, ...мэргэжлийн нэр хүндийг эрхэмлэх зэрэг зарчмуудыг хувийн зан чанар болгож төлөвшүүлнэ" гэсэн заалтыг, мөн дээрх заалтуудыг зөрчөөгүй тул Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 5 дугаар сарын 03-ны өдрийн 71 дугаартай тогтоолыг дээрх үндэслэлүүдээр хүлээн зөвшөөрөхгүй байх тул нийт гишүүдийн хурлаас Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.2-т зааснаар сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү" гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанаар гомдол гаргагчийн гомдол, шүүгчийн тайлбар болон нийт гишүүдийн хуралдаанд гаргасан гомдол, тус хорооны ажлын албаны хянан шалгах ажиллагаагаар цугларсан баримтуудыг хэлэлцээд

ҮНДЭСЛЭХ нь:

Шүүхийн Ёс зүйн хорооны гомдол хянан хэлэлцэх хуралдааны 2018 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 71 дүгээр тогтоолоор П аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ц.С-д сахилгын хэрэг үүсгэжээ.

Уг тогтоолыг эс зөвшөөрч шүүгч Ц.С нийт гишүүдийн хуралдаанд гомдол гаргагчийн үндэслэл болгосон заалтуудаас өөр үндэслэлээр буюу Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2.1, 2.3.1, 3.3.2, 3.3.6 дахь заалтуудыг зөрчсөн гэж сахилгын хэрэг үүсгэснийг зөвшөөрөхгүй гэх шалтгаанаар “түүнд үүсгэсэн сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгуулах” талаар гомдол гаргасан байна.

Нэг. Тэрээр тайлбартаа,

1.Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмаар явуулсан бөгөөд зохигч талуудаас хүсэлт гаргасан хэд хэдэн гэрчүүдийг асуух, эрх бүхий байгууллагуудаас нотлох баримт гаргуулах, шинжээч томилж дүгнэлт гаргуулах зэрэг ажиллагааг хийж, хэргийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хугацааг сунгасан, шүүх хуралдааныг хойшлуулсан зэргээр нийт 306 хоног зарцуулсан. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр буюу үндэслэлгүйгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулаагүй хугацаа байхгүй тул хэргийн хөдөлгөөнийг хянаагүй, хугацаа баримтлаагүй зөрчил гаргаагүй.

Энэ талаар Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 71 дүгээр тогтоолд зөв дүгнэсэн байгааг зөвшөөрч байна.

2.2017 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр миний бие нь нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Т-тэй албан ажлын зайлшгүй шаардлагын улмаас ажлын цагаар шүүгчийн туслахыг байлцуулан тэмдэглэл хөтлүүлж, шүүгчийн туслахын тайлбарлаад ойлгохгүй байгаа, хэргийн хугацаа болон шаардсан нотлох баримт авагдаагүй байна гээд бухимдаад байгаа хэргийн оролцогчид тайлбарлаж өгсөн нь Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх заалтыг зөрчөөгүй гэж үзэж байгаа ба хэргийн нөхцөл байдал, гэм буруугийн талаар ярилцаагүй. Түүнчлэн утсаар ярьсан тэмдэглэлийг хэрэгт хийх шаардлагагүй гэж үзсэн болно.

3."Албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах" гэдгийг Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "албан тушаалын эрх мэдлийг албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийхийг" ойлгоно гэж тодорхойлсон бөгөөд энэхүү хэргийг хариуцан хянан шийдвэрлэх ажиллагааг явуулсан шүүгчийн хувьд миний бие хуульд заасны дагуу нотлох баримтуудыг бүрдүүлэх үүргээ хэрэгжүүлж хянан шийдвэрлэсэн бөгөөд Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1-д зааснаар хуульд заасан бүрэн эрхээ урвуулан ашигласан үйлдэл гаргаагүй бөгөөд үүнийгээ эрх мэдлээ урвуулан ашигласан үйлдэл гэж үзэхгүй байна.

4.Хоёр амралтын өдөр дараалан 2 удаа 7575.... гэх дугаараас залгаж Б.Т гэгч ярьсан ба тухайн үед нь Ерөнхий шүүгчид танилцуулсан, нөлөөллийн мэдүүлэг хөтлөх үүрэгтэй ч хэргийн оролцогчид хүндрэл учруулахыг хүсээгүй гэж тус тус тайлбарласан байна.

Хоёр. Гомдол гаргагчийн гомдлын талаар;

Шүүгч Ц.С Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, 27.1.17, Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 4, 3.3 дугаар зүйлийн 1 дэх заалтыг тус тус зөрчиж ёс зүйн зөрчил гаргасан болохыг тогтоолгох, уг зөрчлүүдэд нь огцруулах сахилгын шийтгэл ногдуулах тухай гомдлын шаардлага гаргасан гэж тайлбарлаад тус хуралдаанд дэмжиж оролцсон.

1.Тус шүүх дээрх нэхэмжлэлийг хүлээн аваад шүүгч Ц.С-д хуваарилсан бөгөөд 2017 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр захиргааны хэрэг үүсгэснээс хойш 306 хоногийн дараа хэргийг шийдвэрлэсэн нь хуульд заасан хугацаа 67 хоногоор хэтрүүлсэн.

Мөн нэхэмжлэгч, түүний төлөөлөгчийн зүгээс 2017 оны 11 дүгээр сард хэрэг шийдвэрлэгдэхгүй удаж байна, хуулийн хугацаагаа баримтлахыг шүүгч Ц.С-д

анхааруулж, хугацаанд хяналт тавих үүргээ хэрэгжүүлэх талаар тухайн шүүхийн Ерөнхий шүүгчид хандаж байсан.

Иймд шүүгчийг хуульд заасан хугацаа баримтлаагүй, хэргийн хөдөлгөөн хянах, хугацаа баримтлах үүргээ биелүүлээгүйгээс хууль дээдлээгүй, хүний эрхийг хүндэтгээгүй ёс зүйн зөрчил гаргасан гэж үзэж байна.

2. Шүүгч Ц.С нь хэргийн оролцогч нартай шүүгчийн туслах болон нөгөө талыг байлцуулалгүйгээр хэдийд ч хамаагүй утсаар ярьдаг. Тухайлбал, нэхэмжлэгчийн төлөөлөгч Б.Т руу 2017.11.23-ны өдөр өөрийн5775 дугаартай утсаар холбогдон "ерөнхий шүүгчид яагаад хүсэлт, гомдол өгөөд байгаа юм бэ? хэргийг чинь шийдэх гээд л байна ш тээ" зэрэг зүйлийг ярьсан.

Ийнхүү хэргийн оролцогч руу өөрөө залгаж ярьдаг эсхүл хэргийн оролцогчоос залгасан тохиолдолд ярьж байгаа эдгээр үйлдэл нь шүүхэд итгэх итгэлийг сулруулж, хэргийн бусад оролцогчтой ингэж ярьдаг гэж ойлгогдож байна.

Дээрх үйлдэл нь хэдийгээр зайнаас утсаар ярьж байгаа үйлдэл боловч ганцаарчлан хэргийн талаар ярилцаж байгаа тул Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.17-д "хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах", Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 4-т "Шүүгч хэргийн оролцогчтой ганцаарчлан уулзаж хэргийн нөхцөл байдал, гэм буруугийн талаар ярилцаж болохгүй бөгөөд хэрэв албан ажлын зайлшгүй шаардлагын улмаас хэргийн нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай уулзах бол шүүхийн туслах ажилтан байлцуулах бөгөөд уулзалтын агуулгын талаар тэмдэглэл хөтлөн хэрэгт хавсаргана" гэж заасныг тус тус зөрчсөн гэж тайлбарлав.

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанаас тус хорооны гомдол хянан хэлэлцэх хуралдааны 2018 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 71 дүгээр тогтоол үндэслэлтэй байх тул шүүгч Ц.С-г сахилгын зөрчил гаргасан гэж үзэж, түүнд сахилгын арга хэмжээ авах нь зүйтэй гэж дүгнэв.

Харин тус хорооны гомдол хянан хэлэлцэх хуралдааны 2018 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 71 дүгээр тогтоолд баримталсан Шүүгчийн ёс зүйн дүрмийн холбогдох заалтуудад залруулга хийх нь зүйтэй байна. Ийнхүү залруулж байгаа нь шүүгчийг ёс зүй зөрчөөгүй гэсэн үг биш юм.

Тус хорооны гомдол хянан хэлэлцэх хуралдаанаар шүүгч Ц.С-г хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг хэтрүүлээгүй байна гэж дүгнэсэн нь үндэслэлтэй байх тул хэргийн хөдөлгөөнийг хянаагүй, хуулийн хугацааг баримтлаагүй гэх гомдол гаргагчийн гомдлын энэ хэсэгт дүгнэлт хийх шаардлагагүй гэж үзэв.

Гомдол гаргагч Б.Т-гийн1729 дугаартай гар утас руу шүүгч Ц.С өөрийн5775 дугаарын гар утаснаас 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 16 цаг 30 минутад залгаж, 1 минут 53 секунд, 2018 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 10 цаг 59 минутад залгаж, 6 минут 21 секунд ярьсан нь тус тус үүрэн телефон компанийн оператораас гаргасан биллээр тогтоогдож байна.

Түүнчлэн шүүгч Ц.С нь хэргийн зохигчтой утсаар ярьсан тэмдэглэлийг хэрэгт хийх шаардлагагүй гэж үзээд хийгээгүй гэж тайлбарлаж байгаагаас үзэхэд сүүлд тус хороонд шүүгчийн туслах А.Б-ээс нөхөж бичсэн шинжтэй ирүүлсэн тайлбарыг нотлох баримтаар үнэлэх боломжгүй байна.

Шүүгч Ц.С нь албан ажлын зайлшгүй шаардлагын үүднээс Б.Т-тэй утсаар ярьсан гэж байгаа боловч шүүгч сахилгын хэрэгт цугларсан нотлох баримтаас зөрүүтэй тайлбарлаж байгаагаас гадна өөр нотлох баримт байхгүй байх тул албан ажлын зайлшгүй шаардлагаар ярьсан гэдэг нь тогтоогдохгүй байна гэж дүгнэв.

Шүүгч Ц.С нь хэргийн зохигчтой утсаар ярьсан тэмдэглэлийг тухайн үед нь хэрэгт хийгээгүй, гаднаас хэргийн зохигч удаа дараа ярьж, шүүгчийн хараат бус байдалд халдаж байхад нөлөөллийн мэдүүлэг хөтлөх үүргээ биелүүлээгүй зэрэг буруутай байна.

Иймд шүүгч Ц.С-г Шүүгчийн ёс зүйн дүрмийн 2.4.3-т “Шүүгч мэдсээр байж олон нийтийн цахим мэдээ, мэдээллийн сүлжээнд хэргийн оролцогчидтой харилцахыг хориглоно /хөдөлгөөнт мэдээллийн сүлжээ/.

Мөн дүрмийн 3.1.2-т “Шүүгч хэргийн оролцогч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдтэй хувийн харилцаа тогтоох,...зэргээр албан тушаалын нэр хүндийг ашиглан ямар нэгэн давуу байдал бий болгохыг хориглоно

Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2.4-т “Шүүгч хэргийн оролцогчтой ганцаарчлан уулзаж хэргийн нөхцөл байдал, гэм буруугийн талаар ярилцаж болохгүй бөгөөд хэрэв албан ажлын зайлшгүй шаардлагын улмаас хэргийн нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай уулзах бол шүүхийн туслах ажилтан байлцуулах бөгөөд уулзалтын агуулгын талаар тэмдэглэл хөтлөн хэрэгт хавсаргана “ гэснийг тус тус зөрчсөн гэж үзэв.

Иймд П аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ц.С-д 3 сарын хугацаагаар 15 хувиар цалинг бууруулах сахилгын шийтгэл ногдуулахаар нийт гишүүдийн хуралдаанаар шийдвэрлэв.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйл, 36 дугаар зүйлийн 36.1.1, 37 дугаар зүйлийн 37.1.2, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйл, Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.1, 5.13-т заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.П аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ц.С-д 3 /гурван/ сарын хугацаагаар 15 /арван таван/ хувиар цалинг бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Энэ магадлалын хувийг шүүгч болон гомдол гаргагчид хүргүүлэхийг Ажлын албанд даалгасугай.

3.Магадлалыг эс зөвшөөрвөл гардан авснаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.

ДАРГАЛАГЧ

ГИШҮҮН

УИХ.МН
Н.ЭРДЭНЭЦОГТ
СЭДЭЛГ ААНЫ САН
В.ЖАВХЛАН



ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ
МАГАДЛАЛ

2018 оны 08 сарын 22 өдөр

Дугаар 221/ЁМ2018/0025

Улаанбаатар хот

П аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны
шүүхийн шүүгч Ц.С-д сахилгын шийтгэл ногдуулсан
Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалын тухай

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааныг шүүгч Э.Лхагвасүрэн даргалж, шүүгч Э.Зоригтбаатар, шүүгч Г.Билгүүн нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн дарга Т.Даваажаргал, гомдол гаргагч Б.Т, шүүгч Ц.С нарыг оролцуулан хийж, Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн “П аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ц.С-д сахилгын шийтгэл ногдуулах тухай” 43 дугаар магадлалыг шүүгч Ц.С-ийн гомдлоор, шүүгч Г.Билгүүний илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Монгол Улсын Шүүхийн ёс зүйн хорооны 2018 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 43 дугаар магадлалаар: П аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ц.С-д 3 /гурван/ сарын хугацаагаар 15 /арван таван/ хувиар цалинг бууруулах сахилгын шийтгэл ногдуулж шийдвэрлэжээ.

Шүүгч Ц.С давж заалдах гомдолдоо: “...Гомдол гаргагч нэхэмжлэгч Ж.Ц, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Т нар нь Шүүхийн Ёс зүйн хороонд хандаж, шүүгч Ц.С нь хэргийг хугацаанд нь шийдвэрлээгүй, нэхэмжлэгчийг чирэгдүүлсэн үйлдэл нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1-д “энэ хуульд заасан өөрийн бүрэн эрхээ урвуулан ашиглахыг хориглоно” гэж, Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 1-д “Шүүгч хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй” гэж заасныг тус тус зөрчсөн гэсэн боловч Шүүхийн Ёс зүйн хорооноос хэргийг хугацаа хэтрүүлж шийдвэрлээгүй байна гэж үзсэн.

Мөн Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.17- д “хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах”, Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 4-т “Шүүгч хэргийн оролцогчтой ганцаарчлан уулзаж хэргийн нөхцөл байдал, гэм буруугийн талаар ярилцаж болохгүй бөгөөд хэрэв албан ажлын зайлшгүй шаардлагын улмаас хэргийн нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай уулзах бол шүүхийн туслах ажилтан байлцуулах бөгөөд уулзалтын агуулгын талаар тэмдэглэл хөтлөн хэрэгт хавсаргана” гэж заасныг тус тус зөрчсөн гэж гомдол гаргасан.

Шүүхийн Ёс зүйн хорооны тогтоолд шүүгч Ц.С-г Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.17, Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 4 дэх заалтуудыг зөрчсөн эсэх, шүүгчийг буруутгаж байгаа үйлдэл нь Шүүгчийн ёс зүйн дүрэмд заасан зөрчил мөн эсэх талаар

ямар нэгэн дүгнэлт хийгээгүй. Харин шүүгчийг гомдол гаргагчийн үндэслэл болгосон заалтуудаас өөр үндэслэлээр буюу Шүүгчийн ёс зүйн дүрмийн 2.3.1-д “Шүүгч нь зохисгүй байдал гаргаж болохгүй бөгөөд бусдад ийнхүү ойлгогдохоос зайлсхийнэ”, 3.2.1-д “Шүүгч нь хэргийн оролцогчдод эрх тэгш, төвийг сахисан, хүнлэг ёсоор хандаж, хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлэхүйц харилцааны соёлыг эзэмшсэн байна”, 3.3.2-т “Хэргийн оролцогчдын зүгээс шүүгчийг татгалзахад хүргэх нөхцөл байдлыг өөрийн үг яриа, үйлдлээр бий болгохоос урьдчилан сэргийлж, зайлсхийнэ”, 3.3.6-д “өөрийн удирдлага дор ажиллаж байгаа алба хаагчдад ...ёс зүйн эрүүл орчныг бүрдүүлнэ” гэж заасныг тус тус зөрчсөн гэж сахилгын хэрэг үүсгэснийг эс зөвшөөрч гомдол гаргасан.

Гэтэл нийт гишүүдийн хурлын магадлалд дээрх үндэслэл болгосон дүрмийн заалтуудад залруулга хийх нь зүйтэй гээд шүүгч Ц.С нь Шүүгчийн ёс зүйн дүрмийн 2.4.3, 3.1.2, 3.2.4 дэх заалтуудыг тус тус зөрчсөн тул 3 сарын хугацаагаар 15 хувиар цалинг бууруулах сахилгын шийтгэл ногдууллаа.” гэжээ. Үүнийг дүрмийн заалтаар авч үзвэл:

1.Шүүгчийн ёс зүйн дүрмийн 2.4.3-т заасан “Шүүгч мэдсээр байж олон нийтийн цахим мэдээ, мэдээллийн сүлжээнд хэргийн оролцогчидтой харилцахыг хориглоно” гэх заалтыг зөрчсөн гэснийг зөвшөөрөхгүй. Учир нь олон нийтийн цахим мэдээ, мэдээллийн сүлжээ гэж интернэт орчин дахь фейсбүүк, твиттер болон интернэт орчны мэдээ, мэдээллийг ойлгох бөгөөд миний бие нь тухайн хэргийн оролцогч нартай олон нийтийн цахим мэдээ, мэдээллийн сүлжээгээр харилцсан үйлдэл байхгүй, энэ талаар гомдол гараагүй, ямар нэгэн нотлох баримт байхгүй, тогтоогоогүй, тогтоогдоогүй тул энэхүү заалтаар буруутгасан нь үндэслэлгүй гэж үзэж байна.

2.Дүрмийн 3.1.2-т заасан “Шүүгч хэргийн оролцогч болон хамаарал бүхий этгээдтэй хувийн харилцаа тогтоох, ...зэргээр албан тушаалын нэр хүндийг ашиглан ямар нэгэн давуу байдал бий болгохыг хориглоно” гэснийг зөрчсөн гэжээ.

Хувийн харилцаа тогтоох гэдэг нь хувь хүмүүс бие хүний хувьд хоорондоо хувийн харилцаа тогтоохыг ойлгоно. Гэтэл миний хувьд албан ажлын зайлшгүй шаардлагын улмаас ажил хэргийн хувиар нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Т-гийн гар утасны дугаарыг хэргээс шүүгчийн туслахаараа харуулан нэг удаа залгаж ярихдаа хэргийн оролцогчид шүүгчийн туслах тайлбарлаад ойлгохгүй байгаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны процесстой холбоотой зүйлийн талаар ярьсан бөгөөд юун тухай ярьснаа шүүгчийн туслахаараа тэмдэглэл үйлдүүлэн баримтжуулсан. Хувийн асуудал яриагүй болох нь шүүгчийн туслахын энэхүү тэмдэглэл, Б.Т-гийн гомдолд дурдсан ...шүүгч “Ерөнхий шүүгчид яагаад гомдол гаргаад байгаа юм бэ, хэргийг чинь шийдэх гээд байна ш дээ”... гэсэн зэргээр давхар нотлогдоно.

Би удаа дараа залгаж ярьсан үйлдэл байхгүй, нотлох баримт байхгүй, үүнийг гомдол гаргагч өөрөө ч хэлж байгаа бөгөөд надад хэргийн оролцогч нартай хувийн харилцаа тогтоосон зүйл огт байхгүй, энэ нь талаар мөн нотлох баримт байхгүй, түүнчлэн албан тушаалын нэр хүндийг ашиглан давуу байдал тогтоосон ямар нэгэн үйлдэл, нотлох баримт байхгүй байхад шалгаж баримтаар тогтоогоогүй асуудлаар ийнхүү буруутгаж байгаа нь үндэслэлгүй юм.

3.Дүрмийн 3.2.4-т заасан “Шүүгч хэргийн оролцогчтой ганцаарчлан уулзаж хэргийн нөхцөл байдал, гэм буруугийн талаар ярилцаж болохгүй бөгөөд хэрэв албан ажлын зайлшгүй шаардлагын улмаас хэргийн нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай уулзах бол шүүхийн туслах ажилтан

байлцуулах бөгөөд уулзалтын агуулгын талаар тэмдэглэл хөтлөн хэрэгт хавсаргана.” гэснийг зөрчсөн гэжээ.

4. Миний бие хэргийн оролцогчидтой хэн алинтай ч уулзаагүй, уулзаагүй учраас хэрэгт хийх тэмдэглэл гараагүй. Уулзаагүй гэдгийг гомдол гаргагч өөрөө хэлдэг, энэ талаар нотлох баримт ч байхгүй тул миний бие дээрх заалтуудыг зөрчөөгүй. Ёс зүйн дүрмийн холбогдох заалт бол хэргийн оролцогчтой ганцаарчлан уулзахыг хориглосон атал ажлын зайлшгүй шаардлагаар утсаар холбогдон өөрийн туслахыг байлцуулан, тэмдэглэл үйлдэж, хэргийг өөрөөс хамаарах шалтгаанаар удаашруулаагүй, ажиллагааг хийж байгаа талаар тайлбарласныг дээрх дүрмийн заалтыг зөрчсөн гэж буруутгаж байгааг зөвшөөрөхгүй.

Тодруулбал, хэргийн оролцогч Б.Т-ээс Ерөнхий шүүгчид хандаж гомдол гаргасны дагуу шүүгч хэргийн оролцогчтой албан ажлын зайлшгүй шаардлагын улмаас утсаар ярьж, түүнийгээ туслахаар тэмдэглэл үйлдүүлсэн, тус тэмдэглэлээ ерөнхий шүүгчид хандсан гомдлын ард хавсаргасан, ерөнхий шүүгчид хандсан гомдол, хүсэлт нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүртгэлээс тусдаа бүртгэлтэй тусдаа хавтаслагддаг, энэ тухай би өмнөх тайлбартаа бичиж, холбогдох баримтуудыг хэрэгт өгсөн.

5. Түүнчлэн магадлалын үндэслэл хэсэгт "...гомдол гаргагч Б.Т-гийн1729 дугаартай гар утас руу шүүгч Ц.С өөрийн5775 дугаарын гар утаснаас 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 16 цаг 30 минутад залгаж, 1 минут 53 секунд, 2018 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 10 цаг 59 минутад залгаж, 6 минут 21 секунд ярьсан нь тус тус үүрэн телефон компанийн оператораас гаргасан биллээс тогтоогдож байна..." гэж хэрэгт цугларсан нотлох баримтыг буруу, зөрүүтэй дүгнэж шүүгчийг үндэслэлгүйгээр буруутгасан.

Нэхэмжлэгчийн төлөөлөгч Б.Т ерөнхий шүүгчид гомдол гаргасны дагуу шүүгчийн туслах А.Б хэргийн хугацаа болон нотлох баримтын талаар тайлбарлаад ойлгоогүй зүйлийг, тайлбарлаж ойлгуулахын тулд албан ажлын зайлшгүй шаардлагын улмаас 2017 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр ажлын цагаар шүүгчийн туслахаа байлцуулан нэг удаа ярьсан бөгөөд тийнхүү ярьснаа тэмдэглэл үйлдэж баримтжуулсан. Ингэхдээ хэргийн нөхцөл байдал, гэм буруугийн талаар болон хэн нэгэнд эрх тэгш бус байдал үүсгэсэн, мөн хувийн харилцааны талаар яриагүй болох нь шүүгчийн туслах А.Б-гийн хөтөлсөн тэмдэглэл, бичгээр гаргасан тайлбар, миний бичгээр өгсөн тайлбар, нийт гишүүдийн хуралдаанд амаар гаргасан тайлбар, мөн Б.Т-гийн гомдол, тайлбар зэргээр давхар нотлогдоно.

Мөн миний бие дээр дурдсанаар нэг удаа ярьснаа баримтжуулсан, өөрөөр дахин хэргийн оролцогч Б.Т-гийн гар утас уруу нь залгаж ярьсан зүйл байхгүй, энэ талаар гомдол гаргагч маргаагүй байхад шүүгчийг удаа дараа залгаж ярьсан гэж ямар ч баримт, үндэслэлгүйгээр хийсвэр дүгнэлт хийсэн.

6. "...Шүүгч Ц.С нь хэргийн зохигчтой утсаар ярьсан тэмдэглэлийг хэрэгт хийх шаардлагагүй гэж үзээд хийгээгүй гэж тайлбарлаж байгаагаас үзэхэд сүүлд тус хороонд шүүгчийн туслах А.Б-ээс нөхөж бичсэн шинжтэй ирүүлсэн тайлбарыг нотлох баримтаар үнэлэх боломжгүй байна..." гэж хэт нэг талыг барьж үндэслэлгүйгээр буруу дүгнэсэн.

7. Дүрмийн 3.2.4-т зааснаас харахад хэргийн оролцогчтой уулзсан тохиолдолд уулзалтын агуулгын талаар тэмдэглэл үйлдэж хэрэгт хавсаргахаар заасан, гэтэл миний бие хэргийн оролцогчтой уулзаагүй, харин ерөнхий шүүгчид хандсан гомдлын байлаа гээд "албан ажлын зайлшгүй шаардлагаар ярьсан" гэдэг нь үгүйсгэгдэхгүй юм.

Учир нь шүүгчийн туслах А.Б-гийн хөтөлсөн 2017 оны 11 сарын 23-ны өдрийн “Утсаар ярьсан тухай тэмдэглэл”-ээр, гомдол гаргагч Б.Т-гийн гомдолд дурдсан ...шүүгч “Ерөнхий шүүгчид яагаад гомдол гаргаад байгаа юм бэ, хэргийг чинь шийдэх гээд байна ш дээ”... гэсэн, мөн миний бичгээр болон амаар гаргасан тайлбар зэргээр “албан ажлын зайлшгүй шаардлагын улмаас ярьсан” гэдэг нь тус тус давхар нотлогдоно.

8. “...Шүүгч Ц.С нь хэргийн зохигчтой утсаар ярьсан тэмдэглэлийг тухайн үед нь хэрэгт хийгээгүй, гаднаас хэргийн зохигч удаа дараа ярьж, шүүгчийн хараат бус байдалд халдаж байхад нөлөөллийн мэдүүлэг хөтлөх үүргээ биелүүлээгүй зэрэг буруутай байна...” гэжээ. Дүрэмд хэргийн оролцогчтой уулзсан тухай тэмдэглэлийг хэрэгт хийхээр заасан энэ талаар дээр дурдсан.

Мөн дээрх хэсэгт шүүгч өөрөө удаа дараа залгаж ярьсан мэтээр дүгнэсэн атлаа энэ хэсэгт ...гаднаас хэргийн зохигч удаа дараа ярьж... гэх мэтээр зөрүүтэй дүгнэлт хийсэн байна.

Би тус хороонд өмнө нь гаргасан тайлбартаа “...амралтын өдрөөр буюу хагас сайн өдөр намайг гэртээ амарч байхад 7575 ... гэх мэдэхгүй дугаараас дуудлага ирснийг автал “Б.Т байна хэргийг хэзээ шийдэх юм бэ, шийдэхгүй бол Улсын Дээд шүүх болон Шүүхийн Ерөнхий зөвлөлд гомдол гаргана шүү” гэж үг хэлэх боломж олголгүйгээр үргэлжлүүлэн хэлсэн би хариуд нь “ажиллагаа хийж байгаа, таны гомдол гаргах эрх чинь нээлттэй” гэж хэлээд утсаа тасалсан. Дараагийн удаа мөн амралтын өдөр 7575... гэсэн өмнөхөөс өөр дугаараар залгаж мөн дээрх зүйлийг дахин хэлэхэд нь би мөн адил хариултыг өгсөн. Энэ талаарх утасны биллийг авах хүсэлт гаргасан боловч 3 сарын хугацаанаас өмнөх биллийг авах боломжгүй гэсэн тул авч чадаагүй болно.

Миний бие хэргийн оролцогчдын утасны дугаарыг мэдэхгүй, хэн залгаж байгааг мэдэх боломжгүй бөгөөд миний гар утас руу залгаад хэрэг шийдвэрлэх юм уу үгүй юм уу, нөхөн сэргээлтийн тайлан, холбогдох нотлох баримтууд шаардсан аваагүй байна, хавтаст хэрэгт байсан нотлох баримтууд алга байна, гаргасан хүсэлтүүд шийдэх юм уу, туслах чинь өгсөн хүсэлт танилцуулдаг юм уу, үгүй юм уу, ямар их уддаг юм бэ, хэрэг шийдэхгүй бол Улсын Дээд шүүх, Шүүхийн Ерөнхий зөвлөлд гомдол гаргана шүү” гэх зэргээр үг хэлэх боломж олголгүйгээр удаа дараа загнасан, би сонсож байгаад “хэргийг шийдэх гээд ажиллагаа хийж байгаа, хаана хандах эрх чинь нээлттэй” гэж хэлээд тасалж байсан. Би тухайн үед дээрх байдлыг Ерөнхий шүүгчид танилцуулсан, Шүүгчийн ёс зүйн дүрэмд зааснаар нөлөөллийн мэдүүлэг хөтлөх үүрэгтэй ч хэргийн оролцогчид хүндрэл учруулахыг хүсээгүй нь миний буруу байгаа боловч ингэснээрээ сахилгын шийтгэл хүлээх үндэслэл болохгүй юм.

Нийт гишүүдийн хурал дээр гишүүд надаас “чи танихгүй дугаар авч ярьдаг юм уу, хэргийн оролцогч гэж мэдэнгүүтээ тасалж болоогүй юм уу, тэгээд 1-5 минут сонсоод байдаг юм уу, тэмдэглэл хөтлөөгүй юм уу” гэх зэрэг асуулт асууж байсан бөгөөд би ах, дүү хамаатан садантай танихгүй дугаар би аваад ярьдаг, тухайн үед би хэргийн оролцогч Б.Т-г гэж мэдээгүй, утасны дугаарыг нь мэдэхгүй, утас автал их бухимдалтай дээрх зүйл ярихыг нь сонсоод дээрх хариултыг өгч утсаа тасалсан.

Тухайн үед миний бие хэргийн оролцогчтой хэргийн гэм буруугийн, шийдвэрлэлтийн талаар, мөн хувийн харилцаа тогтоож, албан тушаалын байдлаа ашиглан давуу байдал бий болгож, тэгш бус, хүнлэг бусаар харьцсан зүйл байхгүй гэдгээ шүүгч өөрөө тайлбар, мэдүүлгээ гаргаад, мөн энэ талаар гомдол гаргагч маргаагүй, ямар нэгэн дуу, дүрс бичлэг болон бусад нотлох баримтаар нотлогдож тогтоогдоогүй байхад хэт нэг талыг

барьж, үндэслэлгүйгээр шүүгчийг буруутгаж, сахилгын хэрэг үүсгэж, шийтгэл хүлээлгэсэнд гомдолтой байна.

Үүнээс гадна Шүүгчийн ёс зүйн дүрэмд хэргийн оролцогчтой шүүгч албан ажлын зайлшгүй шаардлагын улмаас шүүгчийн туслахыг байлцуулан, тэмдэглэл үйлдэж, утсаар ярьж болох эсэх, хэргийн оролцогчийн /мэдэхгүй дугаар/ гаднаас ирсэн дуудлагыг авч ярьж болох эсэх, эдгээр нь зөрчил мөн эсэх талаар, түүнчлэн дүрмийн заалтыг төсөөтэй хэрэглэх талаар ч зохицуулаагүй.

Дээрх байдлаас дүгнэхэд Шүүгчийн Ёс зүйн хорооны 2018 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 71 дугаартай магадлал нь Монгол улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-т "...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэж, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т "Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэнэ." гэж, Шүүгчийн ёс зүйн дүрмийн 2.1-д "...Ёс зүйн хороо үйл ажиллагаандаа хууль дээдлэх, шударга, ил тод, төв голч байх зарчмыг мөрдлөг болгоно." гэснийг тус тус зөрчсөн, мөн утга агуулгын илэрхий алдаатай, хэт нэг талыг барьсан, Шүүгчийн ёс зүйн дүрэмд заасан зөрчил мөн эсэхийг бүрэн гүйцэд, нотлох баримтаар тал бүрээс нь үнэлж, тогтоож чадаагүй, мөн дүгнэлт хийсэн өгүүлбэр нь дараагийн өгүүлбэрээрээ няцаагдсан, эргэлзээтэй, үнэн зөв, шударга дүгнэлт хийгээгүй, шүүгчийн эрх зүйн байдлыг илтэд дордуулсан, үндэслэлгүй гарсан энэхүү магадлалыг хүчингүй болгож, холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү.

Шүүгчийн ёс зүйн дүрмийн 4.7.4-т "Тогтоох хэсэгт гомдлыг шалган шийдвэрлэхэд үндэслэсэн хуулийн болон Шүүгчийн ёс зүйн дүрмийн холбогдох хэм хэмжээг баримтлан, сахилгын хэрэг үүсгэсэн, үүсгэхээс татгалзсан тухай заана..." гэж, 5.8-д "Нийт гишүүдийн хуралдааны магадлал нь удиртгал, тодорхойлох, үндэслэх, тогтоох хэсэгтэй байна. Магадлал нь энэ дүрмийн 4.7.1- 4.7.4-д заасан журамд нийцсэн байна." гэж заасан байхад тус хорооны тогтоол, магадлалын тогтоох хэсэгт ямар ч хуулийн болон дүрмийн заалт баримтлаагүй байна" гэжээ.

ХЯНАВАЛ:

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.3 дахь хэсэгт зааснаар давж заалдах гомдлын хүрээнд хэргийг хянан үзээд дараах үндэслэлээр Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалд өөрчлөлт оруулж шийдвэрлэлээ.

Гомдол гаргагч Б.Т нь шүүгч Ц.С-д холбогдуулан "...хуульд заасан өөрийн бүрэн эрхээ урвуулан ашиглаж, хэргийн хөдөлгөөнд хяналт тавихгүйгээр хэрэг хянан шийдвэрлэх хуульд заасан хугацаанд нь хэргийг шийдвэрлээгүй, мөн шүүхэд итгэх итгэлийг сулруулж, хэргийн оролцогчтой утсаар ярьсан" гэх үндэслэлээр Шүүхийн Ёс зүйн хороонд гомдол гаргасныг Шүүхийн Ёс зүйн хорооны тогтоолоор "...шүүгчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг хэтрүүлээгүй байна" гэж дүгнээд харин "хэргийн оролцогчтой утсаар ярьсан үйлдэлд" холбогдуулан сахилгын хэрэг үүсгэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалаар "хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа хэтрүүлээгүй" гэж дүгнэснийг хэвээр үлдээж, "...шүүгч Ц.С нь Б.Т-тэй утсаар ярьсан хэр нь хэрэгт энэ талаарх тэмдэглэл хийгээгүй нь Шүүгчийн ёс зүйн дүрмийн 2.4.3, 3.1.2, 3.2.4-т заасныг зөрчсөн" гэж дүгнэн түүнд 3 сарын хугацаагаар 15 хувиар цалинг буруулах сахилгын шийтгэл оногдуулсан байна.

Тус магадлалыг эс зөвшөөрч, шүүгч Ц.С "...миний бие тухайн хэргийн оролцогч нартай олон нийтийн цахим мэдээ, мэдээллийн сүлжээгээр харилцсан үйлдэл байхгүй, би удаа дараа залгаж яриагүй, хэргийн оролцогч нартай хувийн харилцаа тогтоосон зүйл огт байхгүй, хэн алинтай ч уулзаагүй, уулзаагүй учраас хэрэгт хийх тэмдэглэл гараагүй. Ёс зүйн дүрмийн холбогдох заалт бол хэргийн оролцогчтой ганцаарчлан уулзахыг хориглосон атал ажлын зайлшгүй шаардлагаар утсаар холбогдон өөрийн туслахыг байлцуулан, тэмдэглэл үйлдэж, хэргийг өөрөөс хамаарах шалтгаанаар удаашруулаагүй, ажиллагааг хийж байгаа талаар тайлбарласныг дээрх дүрмийн заалтыг зөрчсөн гэж буруутгаж байгааг зөвшөөрөхгүй" гэж маргаж байна.

Хэрэгт авагдсан баримтуудаас үзвэл, шүүгч Ц.С нь "Ж.Ц-гийн нэхэмжлэлтэй, П аймгийн Ш сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, тус сумын Засаг дарга, С багийн Засаг дарга нарт холбогдох" захиргааны хэрэгт хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байхдаа тус захиргааны хэргийн нэхэмжлэгч Ж.Ц-гийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Т-тэй 2017 оны 11 дүгээр сарын 23, 2018 оны 02 дугаар сарын 02, 06-ны өдрүүдэд нийт 3 удаа утсаар холбогдон ярьсан болох нь тогтоогдсон, уг үйл баримттай шүүгчээс болон гомдол гаргагчаас маргахгүй байна.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д "Шүүгчид Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалтаас гадна дараах зүйлийг хориглоно", 27.1.17-д "хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах", Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2.4-т "Шүүгч хэргийн оролцогчтой ганцаарчлан уулзаж хэргийн нөхцөл байдал, гэм буруугийн талаар ярилцаж болохгүй бөгөөд хэрэв албан ажлын зайлшгүй шаардлагын улмаас хэргийн нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай уулзах бол шүүхийн туслах ажилтан байлцуулах бөгөөд уулзалтын агуулгын талаар тэмдэглэл хөтлөн хэрэгт хавсаргана" гэсэн зохицуулалт нь шүүгч хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр, нэг талтай ямар нэгэн байдлаар харилцаа холбоо тогтоохгүй байхыг үүрэг болгосон, хориглосон агуулгатай юм. Үүнийг шүүгчээс хэргийн оролцогчтой зөвхөн нүүр тулж уулзах гэсэн ойлголтоор хязгаарлан ойлгож, тайлбарлаж байгаа нь үндэслэлгүй бөгөөд ганцаарчлан харилцах нөхцөл байдал бүрдүүлэн харилцсаныг энэхүү ойлголтод хамааруулан үзэхээр байна. Хэрэв шүүгч хэргийн нэг талтай ганцаарчилсан байдлаар харилцаа тогтоосон бол нөгөө талд мэдэгдэх нь шударга ёсонд нийцэх учраас шүүгчийн туслахаар тэмдэглэл үйлдүүлж, хэрэгт хавсаргадаг байна.

Нөгөөтээгүүр Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.2.1-д "Монгол Улсын Үндсэн хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, холбогдох бусад хууль, Монгол Улсын Олон улсын гэрээ, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм нь энэ дүрмийн эрх зүйн үндэс байна", Хуульчийн мэргэжлийн дүрмийн 15.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Хэрэв шүүгч нь хэрэг, маргааны агуулгатай холбогдуулан нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай санамсаргүй харилцсан бол тухайн харилцааны агуулгыг нэг талд даруй мэдэгдэж хариу өгөх боломж олгоно" гэж заасан.

Гэтэл шүүгч Ц.С нь Б.Т-тэй 3 удаа утсаар холбогдож ярилцсан атлаа энэ талаар тэмдэглэл үйлдэж хэрэгт хавсаргаагүй нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.17, Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2.4-т заасантай нийцэхгүй.

Түүнчлэн шүүгчээс Б.Т-тэй 2017 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр утсаар ярихдаа шүүгчийн туслахыг байлцуулан тэмдэглэл хөтлүүлж, Ерөнхий

шүүгчид гаргасан гомдлын ард хавсаргасан учраас дүрмийн холбогдох заалтыг зөрчөөгүй гэж маргажээ. Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2.4-т заасан "...шүүхийн туслах ажилтан байлцуулан уулзалтын агуулгын талаар тэмдэглэл хөтлөн хэрэгт хавсаргаж" буй шалтгаан нь шүүгч хэргийн нэг талтай ганцаарчлан уулзсан болохыг нөгөө тал мэдэх боломжийг олгож байгаа явдал юм. Иймд шүүгч Ц.С утсаар ярьсан тэмдэглэлийг шүүгчийн туслахаар үйлдүүлж, Ерөнхий шүүгчид гаргасан гомдлын ард хавсаргасан байхыг үгүйсгэхгүй ч хэрэгт хавсаргаагүй тул дээрх шаардлагыг биелүүлсэн гэж үзэхгүй.

Ийнхүү шүүгч Ц.С нь хэргийн нэг тал болох Б.Т-тэй утсаар удаа, дараа холбогдон /өөрөө 1 удаа, Б.Т 2 удаа залгаж/ ганцаарчлан ярилцсан, үүнийгээ нөгөө талд мэдэх боломжийг олгоогүйн улмаас хэргийн оролцогчдод "шүүгч хэргийг шударгаар шийдвэрлэж чадах" эсэхэд эргэлзэх нөхцөл байдлыг бий болгосон гэж үзэхээр байх тул Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2.1-д заасан "Шүүгч нь хэргийн оролцогчдод эрх тэгш, төвийг сахисан, хүнлэг ёсоор хандаж, хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлэхүйц харилцааны соёлыг эзэмшсэн байна" гэж заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

Харин Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалаар шүүгч Ц.С-г Шүүгчийн ёс зүйн дүрмийн 2.4.3 "Шүүгч мэдсээр байж олон нийтийн цахим мэдээ, мэдээллийн сүлжээнд хэргийн оролцогчидтой харилцахыг хориглоно", 3.1.2 "Шүүгч хэргийн оролцогч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдтэй хувийн харилцаа тогтоох, шууд болон шууд бусаар тусламж авах, хувьдаа ашиг олох, төлбөргүй буюу хөнгөлөлттэйгөөр үйлчлүүлэх зэрэг хууль бус хангамж эдлэх зэргээр албан тушаалын нэр хүндийг ашиглан ямар нэгэн давуу байдал бий болгохыг хориглоно" гэж заасныг зөрчсөн гэж дүгнэсэн нь буруу байна.

Учир нь үүрэн холбооны утас нь "олон нийтийн цахим мэдээ, мэдээллийн сүлжээ" гэх ойлголтод хамаарахгүй бөгөөд шүүгч Ц.С-г Б.Т-тэй хувийн харилцаа тогтоосон, албан тушаалын нэр хүндээ ашиглан өөрт ямар нэгэн давуу байдал бий болгосон гэж үзэх нөхцөл байдал хэрэгт авагдсан баримтуудаар тогтоогдоогүй байхад Шүүгчийн ёс зүйн дүрмийн заалтыг буруу тайлбарлан хэрэглэж, маргаан бүхий тохиолдолд хамааруулсан нь үндэслэлгүй болжээ.

Тэрчлэн Шүүгчийн ёс зүйн дүрмийн 5.1.2-т зааснаар шүүгчийн гаргасан зөрчилд сахилгын шийтгэл оногдуулахдаа зөрчлийн шинж байдал, шүүх болон шүүгчийн нэр хүндэд учруулсан хор уршиг, үр дагавар зэргийг харгалзаж, гаргасан зөрчилд нь тохирсон шийтгэл оногдуулах ёстой. Гэтэл энэ тохиолдолд Шүүхийн Ёс зүйн хорооноос шүүгчид 3 сарын хугацаагаар 15 хувиар цалинг бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан нь түүний гаргасан зөрчилд тохироогүй байх тул зөрчлийн шинж, зөрчил гаргах болсон нөхцөл байдал зэргийг харгалзан үзэж, шүүгч Ц.С-д ногдуулсан сахилгын шийтгэлийг сануулах сахилгын шийтгэл болгон хөнгөрүүлэн өөрчлөхөөр тогтов.

Харин Гомдол гаргагч Б.Т нь өөрийн дугаараас шүүгч Ц.С руу 2018 оны 02 дугаар сарын 02, 06-ны өдрүүдэд тус тус залгаж, ярьсан байхад Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалд "...Гомдол гаргагч Б.Т-ийн ...дугаартай гар утас руу шүүгч Ц.С өөрийн ... дугаарын гар утаснаас 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 16 цаг 30 минутад залгаж, 1 минут 53 секунд, 2018 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 10 цаг 59 минутад залгаж, 6 минут 21 секунд ярьсан нь тус тус ... тогтоогдож байна" гэж эсрэгээр нь дүгнэсэн байсныг дурдах нь зүйтэй.

Дээрх үндэслэлүүдээр Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалд холбогдох өөрчлөлтийг оруулж, шүүгч Ц.С-ийн гаргасан давж заалдах гомдлыг хангахгүй орхих нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн шийдвэрлэв.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсэгт заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 43 дугаар магадлалын тогтоох хэсгийн 1 дэх заалтад "...3 /гурван/ сарын хугацаагаар 15 /арван таван/ хувиар цалинг бууруулах..." гэснийг "...сануулах..." гэж өөрчилж, магадлалын тогтоох хэсгийн бусад заалтыг хэвээр үлдээж, шүүгч Ц.С-ийн давж заалдах гомдлыг хангахгүй орхисугай.

2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.5-д зааснаар шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийг буруу хэрэглэсэн, хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн нь шүүхийн шийдвэр гарахад нөлөөлсөн гэж үзвэл маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нар магадлалыг гардан авсан, эсхүл хүргүүлснээс хойш 14 хоногийн дотор Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд гомдол гаргах эрхтэй.

ШҮҮГЧ

Э.ЛХАГВАСҮРЭН

ШҮҮГЧ

Э.ЗОРИГТБААТАР

ШҮҮГЧ

Г.БИЛГҮҮН

ОИХ.МН
СУДАЛГААНЫ САН



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ХЯНАЛТЫН ШАТНЫ ЗАХИРГААНЫ
ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2018 он 11 сарын 14 өдөр

Дугаар 453

Улаанбаатар хот

Ж.Ц, Б.Т нарын гомдолтой, П аймаг дахь
захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч
Ц.С-д холбогдох сахилгын хэргийн тухай

Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх
хуралдааны бүрэлдэхүүн:

Даргалагч: Танхимын тэргүүн М.Батсуурь

Шүүгч: Л.Атарцэцэг
Х.Батсүрэн
Б.Мөнхтуяа

Илтгэгч шүүгч Ч.Тунгалаг

Нарийн бичгийн дарга Ц.Ундрал

Гомдлын үндэслэл: П аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн
шүүгч Ц.С нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27.1.1, 27.1.17, Шүүгчийн
ёс зүйн дүрмийн 3.2.4, 3.3.1 дэх заалтыг тус тус зөрчиж ёс зүйн зөрчил гаргасан
болохыг тогтоолгох, уг зөрчлүүдэд нь огцруулах сахилгын шийтгэл ногдуулах
тухай.

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 6 сарын 13-ны өдрийн 43
дугаар магадлал,

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 8 дугаар сарын
22-ны өдрийн 221/ЁМ2018/0025 дугаар магадлал

Шүүх хуралдаанд оролцогч:

Гомдол гаргагч Б.Т,

Хариуцагч П аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ц.С
нар

Ц.С-ийн гаргасан гомдлыг үндэслэн хэргийн хянан хэлэлцэв.

ТОДОРХОЙЛОХ нь:

Өмнөх шатны шүүхийн шийдвэр:

1.Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 6 дугаар сарын 13-ны
өдрийн 43 дугаар магадлалаар П аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны
шүүхийн шүүгч Ц.С-д 3 сарын хугацаагаар 15 хувиар цалин; бууруулах сахилгын
шийтгэл ногдуулжээ:

2.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх шүүгч Ц.С-ийн гаргасан
гомдлоор хэргийг 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдөр хянан хэлэлцээд 221/
ЁМ2018/0025 дугаар магадлалаар Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны
2018 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 43 дугаар магадлалын тогтоох хэсгийн

1 дэх заалтад "...3 сарын хугацаагаар 15 хувиар цалинг бууруулах..." гэснийг "...сануулах..." гэж өөрчилж, магадлалын тогтоох хэсгийн бусад заалтыг хэвээр үлдээж, шүүгч Ц.С-ийн давж заалдах гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэсэн байна.

Хяналтын журмаар гаргасан гомдол:

3.Шүүгч Ц.С хяналтын журмаар гаргасан гомдолдоо: ... Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2.4-т "Шүүгч хэргийн оролцогчтой ганцаарчлан уулзаж хэргийн нөхцөл байдал, гэм буруугийн талаар ярилцаж болохгүй бөгөөд хэрэв албан ажлын зайлшгүй шаардлагын улмаас хэргийн нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай уулзах бол шүүхийн туслах ажилтан байлцуулах бөгөөд уулзалтын агуулгын талаар тэмдэглэл хөтлөн хэрэгт хавсаргана" гэж заасан байна.

4.Хууль, эрхийн актаар зохицуулсан дээрх зохицуулалт ёс зүйн зөрчил болон хэргийн оролцогчтой биеэр уулзсан талаар нарийвчлан зохицуулж өгчээ. Миний бие нь нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Т-тэй ганцаарчлан уулзаж хэргийн нөхцөл байдал, гэм буруугийн талаар ярилцаагүй тул ёс зүйн зөрчил гаргаагүй болно.

5.Миний бие албан ажлын зайлшгүй шаардлагын улмаас Б.Т-гийн гар утасны дугаарыг хэргээс туслахаар харуулан залгаж, ойлгохгүй байгаа зүйлийг нь "... хэргийн оролцогч нарын гаргасан шинжээч томилох хүсэлтүүдийг шийдвэрлэж, хугацааг түдгэлзүүлж, захирамжуудад гомдол гарч давж заалдах шатны шүүхээр удаа дараа хянагдсан, нотлох баримтууд хэрэгт авагдсан байгаа талаар, баримтууд алга болоогүй, надаас үл хамаарах шалтгаанаар хугацаа удааширч байгаа талаар..." тайлбарлан өгч, энэ тухайгаа шүүгчийн туслахаар тэмдэглэл үйлдүүлсэн. Тэмдэглэлээ ерөнхий шүүгчид гаргасан гомдлын ард хавсаргасан. Миний бие нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.17, Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2.4-т зааснаар нэхэмжлэгчийн төлөөлөгч Б.Т-тэй ганцаарчлан уулзаж, хэргийн нөхцөл байдал, гэм буруугийн талаар яриагүй тул хэрэгт хийх тэмдэглэл гаргаагүй болно.

6.Гэтэл Шүүгчийн ёс зүйн дүрэм зөрчсөн тохиолдолд Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан шийтгэлийг шүүгчид оногдуулахаар заасан бөгөөд хуулийн болон дүрмийн холбогдох заалтад хэргийн оролцогчтой ганцаарчлан уулзсан бол..." гэж тусгайлан, үгчлэн, тодорхой заасан, үүнийг өөрөөр юу гэж ойлгох талаар хуулийн тайлбар болон төсөөтэй хэрэглэх талаар ямар нэгэн тайлбар, зохицуулалтгүй байхад шүүгчийг нэхэмжлэгчийн төлөөлөгч Б.Т-д хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар тайлбарлан утсаар ярьсан үйлдлийг Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.17, Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2.4, 3.2.1 дэх заалтуудыг зөрчсөн гэж Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалд буруу тайлбарлаж хэрэглэсэн, мөн Хуульчийн мэргэжлийн дүрмийн 15.10.2 дахь заалтыг Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн заалтаас дээгүүр тавьж тайлбарлан хэрэглэсэн нь буруу гэж үзэж байна.

7.Миний бие Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2.1-д заасан "Шүүгч нь хэргийн оролцогчдод эрх тэгш, төвийг сахисан, хүнлэг ёсоор хандаж, хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлэхүйц харилцааны соёлыг эзэмшсэн байна" гэснийг зөрчсөн үйлдэл гаргаагүй.

8.Уг захиргааны хэргийг 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдөр 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэхдээ хуульд заасны дагуу нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн бөгөөд анхан шатны шүүхийн шийдвэр давах, хяналтын шатны шүүхэд хянагдаж тус тус хэвээр үлдээж хянан шийдвэрлэгдсэн.

9.Шүүгчийн ёс зүйн дүрмийн 5.1.1-д "Шүүгч энэхүү дүрмийг зөрчсөн бол Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан сахилгын хариуцлага хүлээнэ.",

5.1,3,-т “Ёс зүйн зөрчлийг илрүүлснээс хойш 1 сар, зөрчил гаргаснаас хойш 6 сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулж болохгүй гэж заасан бөгөөд хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоох талаар зохицуулалт байхгүй юм.

10.Дээрх үйлдлийг ёс зүйн зөрчил гэж үзвэл, Зөрчлийг гаргасан гэх хугацаа нь 2017 оны 11 дүгээр сарын 23, 2018 оны 2 дугаар сарын 02, 06-ны өдрүүд бөгөөд гомдол гаргагч 2018 оны 3 дугаар сарын 23-ны өдөр Шүүхийн Ёс зүйн хороонд гомдол гаргаж, тус хороо 2018 оны 5 дугаар сарын 03-ны өдөр сахилгын хэрэг үүсгэж, 2018 оны 6 дугаар сарын 13-ны өдөр сахилгын шийтгэл ногдуулжээ.

11.Иймд Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны магадлал, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалыг тус тус хүчингүй болгож шүүгч Ц.С-д холбогдох сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү гэжээ.

ХЯНАВАЛ:

12.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын Шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн холбогдох зүйл заалтыг маргааны үйл баримтад холбогдуулан буруу тайлбарлаж хэрэглэсэн байх тул шүүгч Ц.С-ийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангаж шийдвэрлэлээ.

13.Иргэн Ж.Ц, Б.Т нараас Шүүхийн Ёс зүйн хороонд шүүгч Ц.С-д холбогдуулан “...Ж.Ц-гийн нэхэмжлэлтэй П аймгийн Ш сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, мөн сумын Засаг дарга болон тус сумын 3 дугаар багийн Засаг даргад холбогдох захиргааны хэргийг хуулийн хугацаанд шийдвэрлэлгүй, нэхэмжлэгчийг чирэгдүүлсэн,... нэхэмжлэгчийн төлөөлөгч Б.Т руу өөрөө утсаар залгаж ярьсан, Б.Т-ээс 2 удаа өөр рүү нь залгахад ярьсан, энэ үйлдэл нь шүүхэд итгэх итгэлийг сулруулж, хэргийн бусад оролцогчтой ч ингэж ярьдаг гэж ойлгогдож байна” гэсэн гомдол гаргаж, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, 27.1.17, Монгол Улсын Шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 4, 3.3 дугаар зүйлийн 1-д заасныг зөрчсөнийг тогтоолгох, огцруулах сахилгын шийтгэл ногдуулахыг хүсжээ.

14.Шүүхийн Ёс зүйн хорооны гомдол хянан хэлэлцэх хуралдаанаас шүүгч Ц.С-ийн хэргийн оролцогч Б.Т-тэй 3 удаа утсаар ярьсан үйлдлийг Шүүгчийн ёс зүйн дүрмийн 2.3 дугаар зүйлийн 1, 3.2 дугаар зүйлийн 1, 3.3 дугаар зүйлийн 6 дахь заалтуудыг тус тус зөрчсөн гэж үзэж, уг гомдлоор сахилгын хэрэг үүсгэсэн, тус хорооны нийт гишүүдийн хуралдаанаас уг үйлдлийг нь Шүүгчийн ёс зүйн дүрмийн 2.4 дүгээр зүйлийн 3, 3.1 дүгээр зүйлийн 2, 3.2 дугаар зүйлийн 4-д тус тус заасан зөрчил гэж үзэж, шүүгчид 3 сарын хугацаагаар 15 хувиар цалин бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан, захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс шүүгч Ц.С-г Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 1 ба 4 дэх заалтыг тус тус зөрчсөн гэж дүгнэж, түүнд хүлээлгэсэн сахилгын шийтгэлийг хүндэдсэн гэх үндэслэлээр “сануулах” болгож хөнгөрүүлсэн байна.

15.Шүүгч Ц.С нь 2017 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр шүүгчийн туслах А.Б-гийн дэргэд хэргийн оролцогч Б.Т руу өөрөө залгаж “...ерөнхий шүүгчид яагаад гомдол гаргаад байгаа юм, хэргийг чинь шийдэх гээд байна ш дээ” гэж ярьсан, хэргийн оролцогч Б.Т нь 2018 оны 2 дугаар сарын 02-ны өдөр болон 2 дугаар сарын 06-ны өдөр тус тус шүүгч Ц.С руу залгаж “...хэргийн хугацаа хэтэрсэн, хүсэлт шийдвэрлэлгүй удаашруулсан, нотлох баримт бүрдүүлэхгүй байгаа” гэх зэргээр ярьсан, уг яриануудын агуулгын талаар гомдол гаргагч Б.Т, шүүгч Ц.С нар маргаагүй байна.

16.Монгол Улсын Шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1-д “шүүгч хуульд тусгайлан ёс зүйн зөрчил болохоор заасан болон энэ дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг ёс зүйн зөрчил гэж үзнэ” гэж

заасан, энэ тохиолдлын хувьд шүүгч Ц.С-ийн хэргийн оролцогчтой 3 удаа утсаар ярьж, өөр дээр нь байгаа хэргийн хугацаа, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар ярилцсан байдал нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.17-д “хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах” хориглолтыг зөрчсөн болон Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 4-т “шүүгч хэргийн оролцогчтой ганцаарчлан уулзаж хэргийн нөхцөл байдал, гэм буруугийн талаар ярилцаж болохгүй бөгөөд хэрэв албан ажлын зайлшгүй шаардлагын улмаас хэргийн нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай уулзах бол шүүгчийн туслах ажилтан байлцуулах бөгөөд уулзалтын агуулгын талаар тэмдэглэл хөтлөн хэрэгт хавсаргана” гэж заасныг зөрчсөн гэж давж заалдах шатны шүүх дүгнэсэн нь уг хууль болон дүрмээр тогтоосон ёс зүйн зөрчилд тооцогдох хэм хэмжээг буруу тайлбарлаж хэрэглэсэн гэж үзнэ.

17.Тодруулбал, хуульд “хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах”-ыг шүүгчид огт хориглосон, харин дүрэмд “тодорхой тохиолдолд хэргийн нэг талтай ганцаарчлан уулзахдаа нөхцөл, шаардлагыг биелүүлээгүй бол ёс зүйн зөрчил болох”-оор заасан, эдгээр зохицуулалт өөр хоорондоо зөрчилтэй байхад уг хуулиар болон дүрмээр зохицуулагдсан “хэм хэмжээ”-г зөрчсөн гэж үзэж, аль алиныг зэрэгцүүлэн хэрэглэх эрх зүйн боломжгүй юм. Мөн шүүгч Ц.С-ийн хэргийн оролцогчтой утсаар ярьсан үйлдлийг “уулзсан”-тай шууд адилтган улмаар хууль болон дүрмийн уг зохицуулалтын агуулгыг дэлгэрүүлэн тайлбарласан нь буруу байхын зэрэгцээ ярилцсан зүйлийн агуулгыг үзэхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой асуудал болохоос хэргийн агуулга, нөхцөл байдлын талаар ярилцаагүй болох нь тодорхой байна. Шүүгчтэй өөрөө утсаар холбогдсон Б.Т нь “хэргийн нөхцөл байдал”-ын талаар ярилцаагүй гэдгээ илэрхийлсэн бөгөөд шүүгч өөртэй нь харилцахдаа Шүүгчийн ёс зүйн дүрмийн дээрх 3.2 дугаар зүйлийн 1-д заасныг зөрчсөн гэж гомдоогүй байхад шүүх өөрийн санаачилгаар уг заалтыг хэрэглэсэн нь буруу.

18.Түүнчлэн, давж заалдах шатны шүүх “хэргийн нэг тал болох Б.Т-тэй утсаар удаа дараа холбогдон ганцаарчлан ярилцсан, үүнийгээ нөгөө талд мэдэх боломжийг олгоогүй /утсаар ярьсан тэмдэглэлийг шүүгчийн туслахаар үйлдүүлж хэрэгт хавсаргаагүй гэж үзсэн/-н улмаас хэргийн оролцогчдод “шүүгч хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх”-д эргэлзэх нөхцөл байдлыг бий болгосон гэж үзэхээр байна гэж дүгнэж, уг дүгнэлтээр шүүгчийг Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 1-д “шүүгч нь хэргийн оролцогчдод эрх тэгш, төвийг сахисан, хүнлэг ёсоор хандаж, хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлэхүйц харилцааны соёлыг эзэмшсэн байна” гэснийг зөрчсөн, ёс зүйн зөрчил гаргасан гэж үзсэн нь үндэслэлгүй болжээ.

19.Шүүгч Ц.С нь хэргийн нэг тал Б.Т-тэй утсаар ярьснаа тэмдэглэж хэрэгт хавсаргаагүйгээс хэргийн нөгөө тал үүнийг мэдээгүй өнгөрөх нь шүүгчтэй өөрөө 3 удаа утсаар ярьсан Б.Т-д “шүүгч хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх”-д эргэлзээ төрүүлсэн гэж дүгнэх нь учир дутагдалтай, хэргийн нөгөө оролцогч уг асуудлаар гомдол гаргаагүй, шүүгчийг "...хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлэхүйц харилцааны соёлыг эзэмшээгүй" гэж буруутгах, уг заалтын хэм хэмжээг зөрчсөн гэж үзэхгүй.

20.Иймд, дээрх үндэслэлээр Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, шүүгч Ц.С-д үүсгэсэн сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгож, түүний хяналтын журмаар гаргасан гомдлыг хангах нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэлээ.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.2.4-т заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 43 дугаар магадлал, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 221/ЕМ2018/0025 дугаар магадлалыг хүчингүй болгож, П аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ц.С-д холбогдох сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгосугай.

ТАНХИМЫН ТЭРГҮҮН

М.БАТСУУРЬ

ШҮҮГЧ

Ч.ТУНГАЛАГ

UIN.MN
СУДАЛГААНЫ САН



МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЁС ЗҮЙН ХОРООНЫ МАГАДЛАЛ

2018 оны 3 сарын 16 өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны
шүүхийн шүүгч Б.М-д сануулах сахилгын
шийтгэл ногдуулах тухай

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааныг дарга Н.Эрдэнэцогт даргалж, гишүүн О.Мөнхсайхан, Ч.Оюунцэцэг, Д.Сүнжид, В.Жавхлан нарын бүрэлдэхүүнтэй, шүүгч Б.М, хяналт шалгалт хариуцсан референт Б.Энхбаатар, хуралдааны тэмдэглэл хөтлөгчөөр шинжээч А.Энхбаатар нарыг оролцуулан, Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдааны танхимд хийж, Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 178 дугаар тогтоолоор шүүгч Б.М-д үүсгэсэн сахилгын хэргийг Ёс зүйн хорооны гишүүн В.Жавхлангийн илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Шүүхийн Ёс зүйн хороонд “ННН” ХХК-ийн захирал М.Г болон өмгөөлөгч Ц.С, Б.О нар гаргасан гомдолдоо: “ННН” ХХК нь 2014 оны 6 сарын 30-ны өдөр дүүргийн Иргэний хэргийн анхан шатны ... дугаар шүүхэд хандан гэрээ хүчин төгөлдөр бусад тооцуулах тухай нэхэмжлэлийн шаардлага гарган хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байсан. Улмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад талууд эвлэрлийн гэрээ байгуулсан гэх үндэслэлээр Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны ... дугаар шүүхийн шүүгчийн 2014 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн “Хариуцагчийн зөвшөөрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай” 4481 дугаартай захирамж гарч нэхэмжлэгч талд гардуулж өгсөн байдаг. Хэргийн материалтай танилцахад дүүргийн Иргэний хэргийн анхан шатны ... дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн 2014 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн “Зохигчдын эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай” 4481 дугаартай захирамж хэрэгт авагдсан байдаг.

Шүүгч Б.Б нь 4481 тоот захирамжаа ИХШХШТХ-ийн 124 дүгээр зүйлд зааснаар илт үндэслэл муутай гарсан гэж үзэж өөрөө хүчингүй болгосон. Гэтэл 2015 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 102/ШТ2015/00387 тоот тогтоолоор шүүгч Н, Ц, О нар хэргийг эцэслэн шийдвэрлэхдээ захирамжид өөрчлөлт оруулан шийдвэрлэсэн нь илт хууль бус юм. Өөрөөр хэлбэл талуудын байгуулсан эвлэрлийн гэрээнд өөрчлөлт оруулах эрх хэмжээ шүүх бүрэлдэхүүнд байхгүй. Эвлэрлийн гэрээнд тусгагдаагүй асуудлыг шүүх бүрэлдэхүүн баталснаар манай компанийн бусад эд хөрөнгө рүү хариуцагч тал халдсан. Мөн шүүхийн шийдвэр тодорхойгүй байсан учраас шийдвэр гүйцэтгэх байгууллага болон газрын алба манай компанийн эрхийг зөрчиж ажиллагаа хийсэн. Нэхэмжлэгч талд шүүхийн шийдвэрийг биелүүлэх ямар ч боломж олгоогүй. Түүнчлэн хэргийн жинхэнэ оролцогч нар эвлэрлийн гэрээ байгуулаагүй байхад эцэслэн шийдвэрлэж байгаа зэргээс үзэхэд дээрх шүүхийн тогтоол нь илт хууль бус шийдвэр болсон байдаг.

102/ШТ2015/00387 тоот тогтоолыг 7 үндэслэлээр хууль зөрчсөн тухай үндэслэл бүхий гомдлыг 2017 оны 5 сарын 02-ны өдөр Ш дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчид хандан гаргахад 2017 оны 6 сарын 21-ний өдрийн 1357 тоот албан бичгээр захирамж, тогтоолоо хянуулах хүсэлтээ тус тусад нь гаргах нь зүйтэй гэж хариу ирүүлсэн. Тиймээс 2017 оны 6 сарын 23-ны өдөр 4481 тоот захирамж болон 102/ШТ2015/00387 тоот тогтоолыг хянуулах гомдлоо тус тусад нь гаргасан. 102/ШТ2015/00387 тоот тогтоолд гаргасан гомдол Б.М шүүгчид, 4481 тоот захирамжид гаргасан гомдол н.Д шүүгчид дараа нь н.У шүүгчид тус тус хуваарилагдсан байна гэх мэдээллийг мэдээлэл лавлагаанаас авсан. Үүний дараа Б.М шүүгчийн туслах Б-тэй удаа дараа манай компанийн итгэмжлэгдсэн төлөөлөгч болон өмгөөлөгч нар утсаар холбогдох болон биечлэн уулзахад шүүгч удахгүй шийднэ гэдэг байсан. Гэтэл 2017 оны 7 сарын 28-ны өдөр Б.М шүүгч гомдлыг шийдвэрлэсэн гэсэн ба шийдвэрийн үндэслэлийг мэдэх гэсэн боловч туслах мэдэхгүй байна гээд хэлэхгүй байсан. Хэд хоногийн дараа манай компанийн итгэмжлэгдсэн төлөөлөгч шүүх дээр очиж шүүгчийн туслах Б-тэй уулзахад гомдлыг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн гэсэн ба та шүүх хуралдаа ороогүй юм уу гэж асуусан байдаг. Шүүх манай компанийн гаргасан гомдлыг шүүх хуралдаанаар бүрэлдэхүүнтэй шийдвэрлэсэн гэх боловч гомдол гаргагч талд шүүх хуралдааны тов мэдэгдээгүй, шүүх хуралд оролцох боломжоор хангаагүй байна.

Үүний дараа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119-р зүйлийн 119.3-т заасны дагуу шүүхийн тогтоолыг гардаж авахаар шүүгчийн туслахаас лавлаж удаа дараа шүүх дээр очиж уулзахад бичгээр гараагүй байсан. Шүүгчийн туслах Б тайлбарлахдаа шүүхийн тогтоол болон шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцах талаар шүүгчид хэлсэн, шүүгч мэдэж байгаа гэх тайлбар хэлсээр 45 гаруй хонож байна.

Шүүхэд иргэн, хуулийн этгээд нь эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар ханддаг. Харин дордуулахаар ханддаггүй гэж ойлгож байна. Гэтэл манай компанийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг шүүх дордуулж, хууль зөрчиж байгаад маш их гомдолтой байна. Хуульд зааснаар гомдлыг ямар хугацаанд шийдвэрлэж, гаргасан шийдвэр нь бичгээр хэзээ гардаг эсэх нь шүүгч Б.М-ийн хувьд хамааралгүй юм байна гэдгийг ойлголоо.

Миний хувьд “ННН” ХХК-ийг хөл дээр нь босгох гэж 20 гаран жил хөлс хөдөлмөрөө дуслуулж хурааж хуримтлуулсан 1 тэрбум гаруй төгрөгийн үнэ бүхий эд хөрөнгөө хууль бус шүүхийн шийдвэрээс болж 16.000.000 төгрөгт алдаж байгаадаа маш их харамсаж, сэтгэл санааны дарамтад орсон.

Иймд шүүгч Б.М нь хууль бус шийдвэр тогтоолыг хаацайлж Монгол Улсын шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 болон 3.3.1-р зүйлийг тус тус зөрчсөн гэж үзэж гомдол гаргаж байна.

Гомдлоо дэмжиж байна. Шүүгч ёс зүйн зөрчил гаргасан тул хариуцлага тооцуулах ёстой гэж үзэж байна.” гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хороонд шүүгч Б.М ирүүлсэн тайлбартаа “Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М би ННН ХХК-ийн захирал М.Г-гийн гаргасан гомдлыг 2017 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр хүлээн авч танилцаад дараах тайлбарыг гаргаж байна. Үүнд:

1.Миний бие ННН ХХК-ийн нэхэмжлэлтэй, Б.М-д холбогдох гэрээ хүчин төгөлдөр бусад тооцуулахыг хүссэн үндсэн нэхэмжлэлтэй, худалдан авсан газар, объектыг албадан чөлөөлүүлэхийг хүссэн сөрөг нэхэмжлэлтэй иргэний хэргийг шийдвэрлэсэн зохигчдын эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны ... дугаар шүүхийн 2014 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн 4481 дүгээр шүүгчийн захирамжид өөрчлөлт оруулсан

Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны ... дугаар шүүхийн 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 102/ШТ2015/00387 дугаар тогтоолыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 124 дүгээр зүйлийн 124.1-д зааснаар хүчингүй болгуулахыг хүссэн нэхэмжлэгч “ННН” ХХК-ийн хүсэлтийг 2017 оны 6 дугаар сарын 29-ний өдөр хүлээн авахад хавтаст хэрэг болон хүсэлтийг хянах бүрэлдэхүүний шүүгч нар байхгүй байсан тул хавтаст хэргийн материалыг архиваас татан авчирсны дараа 2017 оны 7 дугаар сарын 28-ны өдөр тус шүүхийн шүүгч Д.Х, Д.Э нарын хамт Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны ... дугаар шүүхийн 2015 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 102/ШТ2015/00387 дугаар тогтоолыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 124 дүгээр зүйлийн 124.1-д зааснаар хянан үзээд Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 183/ШТ2017/00278 дугаар тогтоолоор нэхэмжлэгчийн хүсэлтийг хангахаас татгалзаж шийдвэрлэсэн болно.

3. Шүүгчийн захирамж болон шүүхийн тогтоолыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 124 дүгээр зүйлийн 124.1 дэх хэсэгт зааснаар хянан үзэхэд шүүх хуралдаанаар хянан хэлэлцдэггүй тул уг хүсэлтийг шийдвэрлэхэд шүүх хуралдааныг товлон зарлаж, зохигчдыг хүсэлтийг хянан хэлэлцэхэд оролцуулах хууль зүйн үндэслэлгүй болно. Иймд шүүх хуралдааны тэмдэглэл хөтлөгдөөгүй тул талуудад танилцуулах боломжгүй юм.

4. Харин миний бие дээрх хүсэлтийг шийдвэрлэсэн шүүхийн тогтоолыг ажлын ачааллын улмаас түргэн шуурхай бичгийн хэлбэрээр гаргаж албажуулаагүй нь үнэн болно. Учир нь миний бие 2017 оны 02 дугаар сард ээлжийн амралтаа эдэлсэн тул амраагүй бөгөөд тус шүүхийн 3 шүүгч 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс, 4 шүүгч 2017 оны 7 дугаар сарын 17-ны өдрөөс, 3 шүүгч 2017 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс тус тус амарсан тул 2017 оны 7 дугаар сарын 16-ны өдрөөс хойш шүүгч Ц.У-гийн хамт шинээр ирсэн нэхэмжлэл, хүсэлт, гомдлыг хүлээн авч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд 2017 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 150 гаруй хэргийн үлдэгдэлтэй ажиллаж байсан, шүүгчийн туслах Б.С нь 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдрөөс жирэмсний амралтаа авч шинээр С.Б-г шүүгчийн туслахаар ажиллуулж эхэлсэн тул эрх зүйн бүхий л актуудыг өөрийн биеэр боловсруулах зэргээс үүдэж удааширсан болно.

Түүнчлэн шүүхийн тогтоолыг албажуулан гаргахад хүсэлтийг шийдвэрлэхэд оролцсон шүүгч Д.Х, шүүгч Д.Э нар нь 2017 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс амраад явсан, 2017 оны 9 дүгээр сард шүүгч нарын сургалтад оролцож тодорхой хугацаагаар байхгүй байсан зэрэг шалтгаан нөхцөл байгааг анхааран үзнэ үү.

Өмнө ирүүлсэн тайлбараа дэмжиж байна. Алдаа гаргасан асуудлаа хүлээн зөвшөөрч байна. Хариуцлага хүлээнэ гэв.

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанд “ННН” ХХК-ийн захирал М.Г гаргасан гомдолдоо: ... шүүгч Б.М нь хуульд заасан журмын дагуу шүүх хуралдаан товлон зарлаагүй, шүүх хуралдаан хийж, тэмдэглэл хөтлөхгүйгээр шийдвэрлэсэн учраас энэхүү үйлдэл нь бас шүүгчийн ёс зүйн зөрчилд хамаарна гэж үзэж байна. Шүүхийн Ёс зүйн хорооны тогтоолын үндэслэх хэсгийг эс зөвшөөрч байх тул гомдлыг хангаж өгнө үү. гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанаар хэлэлцээд ҮНДЭСЛЭХ нь:

Шүүхийн Ёс зүйн хороонд “ННН” ХХК-ийн захирал М.Г нь Ш дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М-д холбогдуулан “...шүүхийн тогтоолыг хуульд заасан хугацаанаас хэт хэтрүүлж, 45 хоногийн дараа гардуулах зэргээр шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн” гэсэн гомдол гаргажээ.

Шүүгч Б.М нь ННН ХХК -ийн хүсэлтийг 2017 оны 6 дугаар сарын 29-ний өдөр хүлээн авч, 2017 оны 7 дугаар сарын 28-ны өдөр шийдвэрлэсэн, шүүгчийн

захирамж болон шүүхийн тогтоолыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 124 дүгээр зүйлийн 124.1 дэх хэсэгт зааснаар хянахад, шүүх хуралдаанаар хэлэлцдэггүй тул уг хүсэлтийг шийдвэрлэхэд шүүх хуралдааныг товлон зарлах, зохигчдыг хүсэлт хянан шийдвэрлэхэд оролцуулах хууль зүйн үндэслэлгүй. Шүүх хуралдааны тэмдэглэл хөтөлдөггүй тул талуудад танилцуулах боломжгүй тухай бичсэн байх бөгөөд энэ талаар Ёс зүйн хорооны хуралдаанд оролцохдоо “хүсэлт шийдвэрлэхэд шүүх хуралдаан хийдэггүй, шүүгчийн өрөөнд асуудлыг шийдвэрлэдэг. Шүүх хуралдааны танхимд хийдэггүй тул түүнийг товлон зарлах, хүсэлтийг шийдвэрлэхэд зохигчид мэдэгдэх, оролцуулах үүрэггүй” болох тухай тайлбарлав.

Шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой дээрх ажиллагаа хууль зөрчөөгүй ч шүүхээс гарч буй эрхийн актыг хуульд заасан хугацаанд бичиж бэлэн болгох, зохигчдод гардуулах буюу хүргүүлэх ажиллагаа хийх үүргээ зөрчсөн гэж үзэхээр байна.

Гомдолгаргагч шүүхийн тогтоолыг хүсэлт шийдвэрлэсний дараа удаашруулсан, хүсэлтийг шийдвэрлэснээс хойш 45 хоног гаргаж өгөөгүй гэж гомдолд бичсэн байх бөгөөд шүүгч тогтоолоо бичиж бэлэн болгож, бүрэлдэхүүний шүүгч нараар баталгаажуулаагүй 75 хоног болсон гэдгээ нийт гишүүдийн хуралдаанд хүлээн зөвшөөрсөн.

Шүүхийн тогтоолыг гаргахгүй удаасан шалтгааныг шүүгч Б.М тайлбарлахдаа шүүхийн тогтоолыг албажуулан гаргахад хүсэлтийг шийдвэрлэхэд оролцсон шүүгч Д.Х, шүүгч Д.Э нар нь 2017 оны 8 дугаар сарын 01- ний өдрөөс амраад явсан, эдгээр болон бусад шүүгч нар амарсантай холбоотой шүүхийн ачаалал их байсан, 2017 оны 9 дүгээр сард шүүгч нарын сургалтад оролцож тодорхой хугацаагаар байхгүй байсан юм. Мөн шүүгчийн туслах жирэмсний амралтаа авсан тул шинээр С.Б-г шүүгчийн туслахаар ажиллуулж эхэлсэн бөгөөд эрх зүйн бүхий л актуудыг өөрөө боловсруулах зэргээс үүдэж удааширсан гэж тайлбарлаж байх боловч шүүгч нарын амралтын хуваарийг ирүүлээгүй, шүүгчийн туслах амралтаа авсан, шинэ туслах ажиллаж эхэлсэн тухай нотлох баримт байхгүй байгаагаас гадна 3 өдрийн сургалтад хамрагдсан талаар болон шүүхийн ажлын ачааллыг харуулсан нотлох баримт нь 75 хоногоор удаашруулах хүндэтгэн үзэх шалтгаан биш гэж дүгнэв.

Иймд дээрх үндэслэлээр сахилгын хэрэг үүсгэсэн 2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн тус хорооны гомдол хянан хэлэлцэх хуралдааны 178 дугаар тогтоол үндэслэл бүхий байна гэж үзэв.

“Шүүгч нь хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх хууль дээдлэх, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандах мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх зэрэг зарчмуудыг хувийн зан чанар болгож төлөвшүүлнэ” гэсэн Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.1 дүгээр зүйлийн 1 дэх заалт, “Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй” гэсэн мөн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 1 дэх заалтыг тус тус зөрчсөн гэж үзэж шүүгч Б.М-д сахилгын шийтгэл ногдуулах нь зүйтэй гэж нийт гишүүдийн хуралдааны бүрэлдэхүүн үзэв.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35, 36 дугаар зүйл, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйл, Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5.7.1, 5.13-т заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М-д “сануулах” сахилгын шийтгэл ногдуулсугай

2.Энэ магадлалын хувийг шүүгч болон гомдол гаргагчид хүргүүлэхийг тус хорооны Ажлын албанд даалгасугай.

3.Магадлалыг эс зөвшөөрвөл хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.

ДАРГАЛАГЧ

Н.ЭРДЭНЭЦОГТ

ГИШҮҮН

В.ЖАВХЛАН



ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ
МАГАДЛАЛ

2018 оны 5 сарын 02 өдөр

Дугаар 221/ЁМ2018/0012

Улаанбаатар хот

Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны
шүүхийн шүүгч Б.М-д сахилгын шийтгэл
ногдуулсан магадлалын тухай

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Батбаатар даргалж, шүүгч Э.Халиунбаяр, шүүгч Б.Тунгалагсайхан нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн дарга М.Отгондэлгэр, гомдол гаргагч “ННН” ХХК-ийн захирал М.Г-гийн өмгөөлөгч Б.О, Ц.С нарыг оролцуулан хийж, Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М-д сахилгын шийтгэл ногдуулах тухай 19 дүгээр магадлалыг шүүгч Б.М-ийн гомдлоор, шүүгч Б.Тунгалагсайханы илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 19 дүгээр магадлалаар: Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М-д “сануулах” сахилгын шийтгэл ногдуулж шийдвэрлэжээ.

Шүүгч Б.М давж заалдах гомдолдоо: “Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М миний бие Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 19 дүгээр магадлалыг эс зөвшөөрч дараах үндэслэлээр гомдол гаргаж байна.

Миний бие ННН ХХК-ийн нэхэмжлэлтэй, Б.М-д холбогдох иргэний хэрэгт нэхэмжлэгч талаас гаргасан Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны ... дугаар шүүхийн 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 102/ШТ2015/00387 дугаар тогтоолыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 124 дүгээр зүйлийн 124.1-д зааснаар хянуулахыг хүссэн хүсэлтийг хянан шийдвэрлэхдээ хүсэлт шийдвэрлэсэн шүүхийн тогтоолыг хуульд заасан хугацаанд бичиж, зохигчдод гардуулан өгөх үүргээ биелүүлээгүй, Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 1-д заасан ёс зүйн зөрчил гаргасан болохоо хүлээн зөвшөөрч, үүний дагуу сануулах сахилгын шийтгэл ногдуулсанд гомдолгүй байна.

Харин шүүгч миний гаргасан ёс зүйн зөрчилд сахилгын шийтгэл ногдуулахад Шүүгчийн ёс зүйн дүрэмд заасан хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн байдлыг анхааран үзээгүй нь хэрэглэх ёстой хуулийг хэрэглээгүй гэх үндэслэлд хамаарч байна. Учир нь “ННН” ХХК нь 2017 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр ёс зүйн зөрчил илэрсэн талаар Шүүхийн Ёс зүйн хороонд гомдол гаргаснаар ёс зүйн зөрчлийг илрүүлсэн гэж үзвэл Шүүгчийн ёс зүйн дүрмийн 5.1 дүгээр зүйлийн 3-д заасан ёс зүйн зөрчлийг илрүүлснээс хойш 1 сар, зөрчил гаргаснаас хойш 6 сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулж болохгүй гэсэн заалтыг Шүүхийн Ёс зүйн хороо зөрчжээ.

Шүүхийн Ёс зүйн хороо нь Шүүгчийн Ёс зүйн дүрмийн зохих заалтыг зөрчсөн гэж үзэж, сахилгын шийтгэл ногдуулсан атлаа уг дүрэмд заасан сахилгын шийтгэл ногдуулж болохгүй хугацааг анхааран үзээгүй нь хуульд нийцэхгүй байна.

Иймд шүүгч миний гаргасан ёс зүйн зөрчилд сахилгын шийтгэл ногдуулах хугацаа өнгөрсөн байхад шийтгэл ногдуулсан тул Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 19 дүгээр магадлалыг хүчингүй болгож, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү” гэжээ.

ХЯНАВАЛ:

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 19 дүгээр магадлалаар шүүгч Б.М-д сахилгын шийтгэл ногдуулахдаа хөөн хэлэлцэх хугацааг хэтрүүлсэн байх тул хүчингүй болгож шийдвэрлэв.

“ННН” ХХК-иас 2017 оны 6 дугаар сарын 22-ны өдөр Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хандан Дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 102/ШТ2015/00387 дугаар тогтоолыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 124 дүгээр зүйлийн 124.1-д зааснаар хянуулах хүсэлт гаргасны дагуу тус шүүхийн шүүгч Б.М-д хуваарилагдаж, 2017 оны 7 дугаар сарын 28-ны өдөр хянан шийдвэрлэсэн байна.

“ННН” ХХК-ийн захирал М.Г-ээс “...шүүгч Б.М нь манай компанийн гаргасан гомдлыг хянан хэлэлцэх шүүх хуралдааны товыг мэдэгдээгүй, шүүх хуралдаанд оролцох боломжоор хангаагүй, ...шүүхийн тогтоолыг хуульд заасан хугацаанаас хэтрүүлж гаргасан” хэмээн гомдол гаргаж, шүүгч Б.М “... шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг хянан үзэхэд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 124 дүгээр зүйлийн 124.1-д зааснаар хянан үзэхэд шүүх хуралдаанаар хянан хэлэлцдэггүй тул шүүх хуралдааныг товлон зарлаж, товыг мэдэгдэх үндэслэлгүй, дээрх хүсэлтийг шийдвэрлэсэн шүүхийн тогтоолыг ажлын ачааллын улмаас түргэн шуурхай бичгийн хэлбэрээр гаргаж албажуулаагүй, ... эрх зүйн бүхий л асуудлыг өөрийн биеэр боловсруулах зэргээс үүдэж удааширсан” гэж тайлбарлажээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 19 дүгээр магадлалаар Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М нь гомдол гаргагчийн хүсэлтийг хянан шийдвэрлэсэн шүүхийн тогтоолыг хуулийн хугацаа хэтрүүлэн боловсруулж, зохигчдод гардуулж, хүргүүлээгүй Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.1 дүгээр зүйлийн 1, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан ёс зүйн зөрчил гаргасан гэж үзэж, сахилгын шийтгэл ногдуулжээ.

Шүүгч Б.М давж заалдах гомдолдоо “... ёс зүйн зөрчил гаргасан болохоо хүлээн зөвшөөрч, үүний дагуу сануулах сахилгын шийтгэл ногдуулсанд гомдолгүй... харин миний гаргасан ёс зүйн зөрчилд сахилгын шийтгэл ногдуулахад Шүүгчийн Ёс зүйн дүрэмд заасан сахилгын шийтгэл ногдуулж болохгүй хугацааг анхааран үзээгүй нь хуульд нийцээгүй” гэснээс үзвэл гомдолд холбогдогч шүүгч нь ёс зүйн зөрчил гаргаснаа хүлээн зөвшөөрсөн, уг зөрчилд сахилгын шийтгэл ногдуулсан үндэслэлтэй маргаагүй байна.

Харин түүний Шүүхийн Ёс зүйн хороо гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчин, сахилгын шийтгэл ногдуулж болохгүй хугацааг баримтлалгүй сахилгын шийтгэл ногдуулсан нь үндэслэлгүй гэх гомдлыг шүүх хүлээн авах үндэслэлтэй байна.

Учир нь Шүүгчийн ёс зүйн дүрмийн 5.1 дүгээр зүйлийн 3-д “Ёс зүйн зөрчлийг илрүүлснээс хойш 1 сар, зөрчлийг гаргаснаас хойш 6 сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулж болохгүй” гэж заажээ.

“ННН” ХХК-ийн захирал М.Г 2017 оны 9 дүгээр сарын 13- ний өдөр шүүгч Б.М-ийн холбогдуулан “шүүхийн тогтоолыг хуулийн хугацаанд албажуулж,

гардуулаагүй” зөрчлийн талаар Шүүхийн Ёс зүйн хороонд гомдол гаргаснаар уг зөрчил тухайн өдөр илэрсэн гэж үзнэ.

Дээрх зөрчил илэрсэн өдрөөс хойш 6 сарын дотор холбогдох этгээдэд сахилгын шийтгэл ногдуулах эсэхийг шийдвэрлээгүй бол үүнээс хойш сахилгын шийтгэл ногдуулж болохгүй.

Гэтэл Шүүхийн Ёс зүйн хороо дээрх шийтгэл ногдуулах хугацааг хэтрүүлэн 2018 оны 3 дугаар сарын 16-ны өдөр шүүгч Б.М-д сахилгын шийтгэл ногдуулсан нь Монгол Улсын Шүүгчийн ёс зүйн дүрмийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь заалттай нийцээгүй байна.

Иймд шүүгч Б.М-ийн гаргасан давж заалдах гомдлыг хангаж, Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 19 дүгээр магадлалыг хүчингүй болгож, шүүгч Б.М-ийн гомдлыг хангаж шийдвэрлэлээ.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.2, 121 дүгээр зүйлийн 121.1, 121.1.1 дэх заалтыг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 19 дүгээр магадлалыг хүчингүй болгож, шүүгч Б.М-ийн гомдлыг хангасугай.

2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.5 дахь хэсэгт заасны дагуу магадлалыг эс зөвшөөрвөл хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч гардан авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.БАТБААТАР

ШҮҮГЧ

Э.ХАЛИУНБАЯР

ШҮҮГЧ

Б.ТУНГАЛАГСАЙХАН

УИИ.МН
СУДАЛГААНЫ САН



МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЁС ЗҮЙН ХОРООНЫ МАГАДЛАЛ

2018 оны 6 сарын 26 өдөр

Дугаар 47

Улаанбаатар хот

Т захиргааны хэргийн анхан
шатны шүүхийн шүүгч Б.М-д сахилгын
шийтгэл ногдуулах тухай

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааныг тус хорооны дарга Н.Эрдэнэцогт даргалж, гишүүн А.Доржготов, В.Жавхлан, О.Мөнхсайхан, Ч.Оюунцэцэг нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны тэмдэглэл хөтлөгчөөр шинжээч Ч.Ханддулам, референт Ж.Халиун, гомдол гаргагч Э.Н, Н.М, шүүгч Б.М нарыг оролцуулан Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдааны танхимд хийв.

Т захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М сахилгын хэрэг үүсгэж шийдвэрлэсэн Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 87 дугаар тогтоолтой сахилгын хэргийг гишүүн Ч.Оюунцэцэгийн илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Иргэн Н.М, Э.Н нар Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан гомдолдоо: Т Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд “ССС” ХХК-ийн нэхэмжлэлтэй Нийслэлийн Засаг дарга, Нийслэлийн Ш дүүргийн Засаг даргад холбогдуулан гаргасан захиргааны хэрэгт “ХХХ” ТББ нь гуравдагч этгээдээр ба гуравдагч этгээдийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Э.Н, өмгөөлөгчөөр Хуульчдын холбооны гишүүн, өмгөөлөгч Н.М нар оролцсон. Шүүх хуралдаан 2018.01.11-ний өдөр болсон ба шүүх хуралдаан даргалагчийн зүгээс нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангаж шийдвэрлэсэн атлаа шийдвэр бичгийн хэлбэрт буухдаа нэхэмжлэлийн шаардлагаас өөрөөр шийдвэрлэгдсэн байдаг.

Нэхэмжлэгчээс нэхэмжлэлийн шаардлагаа Нийслэлийн Ш дүүргийн Засаг даргын 2010.04.05-ны өдрийн “Газар эзэмших эрхийг хүчингүй болгох тухай” 90 дүгээр захирамжийн өөрт холбогдох хэсгийг хүчингүй болгуулахаар, 2017.07.26-ны өдөр Нийслэлийн засаг даргын 2016.02.18-ны өдрийн А/128 дугаар захирамжийн “ХХХ” ТББ-д холбогдох 39114м2 газар олгосон хэсгийг хүчингүй болгуулахаар, 2017.10.16-ны өдөр нэхэмжлэлийн шаардлагаа тодруулахдаа Нийслэлийн засаг даргын 2016 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн “ХХХ” ТББ-д холбогдох /39114 м2 газар олгосон/ хэсгийг хүчингүй болгуулахаар гэж тус тус тодорхойлсон байдаг ба 2018.01.11-ний шүүх хуралдааны явцад шүүх хуралдаан даргалагчаас нэхэмжлэлийн шаардлагыг тодруулж өөрчлөгдсөн зүйл байхгүй талаар хэлж шүүх хуралдаан үргэлжилсэн ба шүүхээс шүүхийн шийдвэрийг танилцуулахдаа нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн гэж танилцуулсан боловч бичгийн хэлбэрт албажсан шийдвэрт Газрын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3, 34 дүгээр зүйлийн 34.1, 40 дүгээр зүйлийн 40.1.5, 61 дүгээр зүйлийн 61.1-д заасныг тус тус баримтлан нэхэмжлэгч ССС ХХК-ий нэхэмжлэлтэй Нийслэлийн Засаг дарга, Ш дүүргийн Засаг даргын 2010.04.05-ны өдрийн 90 дүгээр захирамжийн нэхэмжлэгчид холбогдох, Нийслэлийн Засаг

даргын 2015.12.23-ны өдрийн А/990 дугаар захирамжийн Д.У-д холбогдох хэсгийг бүхэлд нь, Нийслэлийн Засаг даргын .. өдрийн А/128/ дугаар захирамжийн “ХХХ” ТББ-д холбогдох хэсгийг бүхэлд нь Нийслэлийн Засаг даргын 2016.02.18-ны өдрийн АУ128 дугаар захирамжийн “ХХХ” ТББ-д холбогдох хэсгийг нэхэмжлэгчийн эзэмшиж буй газартай давхцаж буй хэмжээгээр тус тус хүчингүй болгосугай гэж шийдвэрлэсэн нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.5-т заасан “Шүүх нэхэмжлэлийн шаардлагын хүрээнээс хэтэрсэн болон хэргийн оролцогчдын маргаагүй асуудлаар дүгнэлт хийж, шийдвэр гаргаж болохгүй”, 108 дугаар зүйлийн 108.2. Шүүхийн шийдвэр танилцуулан сонгосноор хүчинтэй болно. Монгол улсын Шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.2.1 дүгээр зүйлд заасан “...шүүгч нь хэргийн оролцогчдод эрх тэгш, төвийн сахисан, хүнлэг ёсоор хандаж, хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлэхүйц харилцааны соёл эзэмшсэн байна” гэх хуулийн заалтуудыг тус тус зөрчсөн гэж үзэж байна.

Т Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд томилолтоор ажиллаж байсан Б.М нь Ф аймгаас томилолтоор ирсэн ба томилолтын хугацаа нь 2018.01.31-ний өдрөөр дуусгавар болсон. Б.М нь шүүх эрх мэдлээ хэрэгжүүлэх боломжгүй буюу томилолтын хугацаа дууссанаас хойш шүүхийн тэмдэг, шүүгчийн гарын үсэг зурсан дээрх үйлдэл нь Монгол улсын Шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.3.1 дүгээр зүйл, 4 дүгээр зүйлийн 4.8-дах заалтыг зөрчсөн.

Шүүгчийн туслах Д.Э-тэй уулзахад “...шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсгийг бичихдээ шүүгчийн шийдвэрлэсэн хэсгийг авч бичдэг” гэх тайлбар өгсөн. Д.Э нь шүүх хуралдааны тэмдэглэлийг 2018.01.18-ны өдөр шүүгчид өгсөн байдаг байдаг ба шүүхийн шийдвэр 2018.02.06-ны өдөр гарсан, шүүхийн шийдвэртэй уялдуулсан гэх дээрх байдал нь хурлын тэмдэглэлийг шүүгчийн хэлснээр өөрчлөн бичсэн байхаар харагдаж байна.

Дээрх үйлдэл нь Б.М-ийн хувьд Монгол улсын Шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.2.2-т заасан “...шүүгч шүүхийн ажилтан болон өөрийн удирдлага дахь бусад этгээдэд албан үүрэгт нь хамааралгүй үүрэг даалгавар өгөхийг хориглоно” гэдэг заалтыг тус тус зөрчсөн гэж үзэж байна. Иймд дээрх гомдлыг судлан үзэж Б.М нь Т Захиргааны хэргийн анхан шатны шүүгчээр ажиллаж байх хугацаандаа Монгол улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн холбогдох заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэл байгаа тул энэ талаар шалгаж шийдвэрлэж өгнө үү” гэжээ.

Шүүгч Б.М тайлбартаа: “2018.01.11-ний өдөр “ССС” ХХК-ийн нэхэмжлэлтэй Нийслэлийн Засаг дарга, Нийслэлийн Ш дүүргийн Засаг дарга нарт холбогдох хэргийг хянан шийдвэрлэсэн болно. Нэхэмжлэгч нь анх 2015.10.30-ны өдөр нэхэмжлэл гаргасан бөгөөд 2017.07.26-ны өдөр “Нийслэлийн Засаг даргын 2016.02.18-ны өдрийн № А/128 дугаар захирамжийн “ХХХ” ТББ-д холбогдох хэсгийг хүчингүй болгуулах” /хх-234 тал/, 2017.10.16-ны өдөр “Нийслэлийн Засаг даргын 2016.02.18-ны өдрийн № А/128 дугаар захирамжийн ХХХ ТББ-д холбогдох хэсгийг хүчингүй болгуулах, Нийслэлийн Засаг даргын 2015.12.23-ны өдрийн № А/990 дугаар захирамжийн Д.У-д холбогдох хэсгийг хүчингүй болгуулах” /хх-2-149-150 тал/ гэж тус тус нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлж тодруулсан. Шүүх хуралдааны хэлэлцүүлгийн шат эхлэхээс өмнө даргалагчаас, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс, мөн нэхэмжлэлийн шаардлагыг тодруулахад дээрх нэхэмжлэлийн шаардлагуудаа дэмжсэн болно.

Харин шүүх хуралдааны асуулт хариултын шатанд гуравдагч этгээдийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн өмгөөлөгчийн “39114м² газрыг бүхэлд нь хүчингүй болгуулах гээд байна уу, эсхүл хэсэгчлэн хүчингүй болгуулах гээд байна уу” гэсэн асуултад нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч “манайхаас давхардсан

хэсгээрээ гэж тодруулсан байгаа” гэж нэхэмжлэлийн шаардлагаа дахин тодруулсан тул уг шаардлагын хүрээнд хэргийг хянан шийдвэрлэсэн ба Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018.03.15-ны өдрийн №179 дүгээр магадлалаар шийдвэр хэвээр үлдсэн болно” гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 05-р сарын 18-ны өдрийн 87 дугаар тогтоолоор шүүгч Б.М-д сахилгын хэрэг үүсгэж шийдвэрлэжээ.

Шүүгч Б.М Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанд сахилгын хэрэг үүсгэж шийдвэрлэсэн Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 5-р сарын 18-ны өдрийн 87 дугаар тогтоолыг эс зөвшөөрч гаргасан тайлбартаа: "...Миний бие 2018.01.11-ний өдөр "ССС" ХХК-ийн нэхэмжлэлтэй Нийслэлийн Засаг дарга, Нийслэлийн Ш дүүргийн Засаг дарга нарт холбогдох хэргийг хянан шийдвэрлэсэн.

Нэхэмжлэгч нь анх 2015.10.30-ны өдөр гаргасан нэхэмжлэл гаргасан бөгөөд 2017.07.26- ны өдөр Нийслэлийн Засаг даргын 2016.0218-ны өдрийн № А/128 дугаар захирамжийн ХХХ ТББ-д холбогдох хэсгийг хүчингүй болгуулах" / хх-234 тал/, 2017.10.16-ны өдөр 'Нийслэлийн Засаг даргын 2016.02.18-ны өдрийн №А/128 дугаар захирамжийн "ХХХ" ТББ-д холбогдох хэсгийг хүчингүй болгуулах, Нийслэлийн Засаг даргын 2015.12.23-ны өдрийн № А/990 дугаар захирамжийн Д.У-д холбогдох хэсгийг хүчингүй болгуулах /хх-2-149-150 тал/ гэж тус тус нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлж тодруулсан. Шүүх хуралдааны хэлэлцүүлгийн шат эхлэхээс өмнө даргалагчаас нэхэмжлэлийн шаардлагыг дахин тодруулахад дээрх нэхэмжлэлийн шаардлагуудаа дэмжсэн.

Харин шүүх хуралдааны асуулт хариултын шатанд гуравдагч этгээдийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн өмгөөлөгчийн 39114м² газрыг бүхэлд нь хүчингүй болгуулах гээд байна уу эсхүл хэсэгчлэн хүчингүй болгуулах гээд байна уу гэсэн асуултад нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч "манайхаас давхардсан хэсгээрээ гэж тодруулсан байгаа гэж нэхэмжлэлийн шаардлагаа дахин тодруулсан тул уг шаардлагын хүрээнд хэргийг хянан шийдвэрлэсэн бөгөөд шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт энэ талаар тусгасан.

Гэтэл тус хорооны 2018 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн № 87 дугаар Сахилгын хэрэг үүсгэх тухай" тогтоолд намайг шүүх хуралдааны тэмдэглэлийг тухайн хуралдаан дээр яригдаагүй агуулгаар өөрчилсөн буюу өөрчлүүлсэн үйлдлээрээ Монгол Улсын Шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4 2 2 мөн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 6-д заасныг зөрчсөн гэжээ.

Миний бие тухайн шүүх хуралдааны тэмдэглэлийг хөтөлсөн нарийн бичгийн даргад хуралдаан дээр огт яригдаагүй эсхүл яригдсан зүйлийн утга агуулгыг өөрчлүүлсэн, өөрчлөх талаар үүрэг даалгавар өгөөгүй болно.

Мөн намайг тухайн хуралдааны ямар /үг үсэг, өгүүлбэр/-ийн агуулгыг өөрчлүүлсэн огт яригдаагүй зүйлийг яригдсан мэтээр бичихийг даалгасан үйлдэлд буруутгаад байгааг ойлгохгүй байна.

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанаар сахилгын хэргийг хэлэлцээд ҮНДЭСЛЭХ нь:

Т Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М нь “ССС” ХХК-ийн нэхэмжлэлтэй Нийслэлийн Засаг дарга, Нийслэлийн Ш дүүргийн Засаг дарга нарт холбогдох, гуравдагч этгээд “ХХХ” ТББ оролцсон хэрэгт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж, улмаар хэргийг 2018 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр 128/шш2018/0020 дугаар шийдвэрээр шийдвэрлэсэн байна. Гуравдагч этгээдийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Э.Н, өмгөөлөгч Н.М нар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон байна.

Шүүхийн Ёс зүйн хороонд иргэн Э.Н, өмгөөлөгч Н.М нараас шүүгч Б.М Т Захиргааны хэргийн анхан шатны шүүгчээр ажиллах хугацаандаа Монгол Улсын

шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн холбогдох заалтыг зөрчсөн гэж гомдол ирүүлсэн. Үүнд:

Нэгд: "Шүүх хуралдаан 2018 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр болсон ба шүүх хуралдаан даргалагчийн зүгээс нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангаж шийдвэрлэсэн атлаа шийдвэр бичгийн хэлбэрт буухдаа нэхэмжлэлийн шаардлагаас өөрөөр шийдвэрлэгдсэн, шүүхээс шүүхийн шийдвэрийг танилцуулахдаа нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн гэж танилцуулсан боловч бичгийн хэлбэрт албажсан шийдвэрт Газрын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3, 34 дүгээр зүйлийн 34.1, 40 дүгээр зүйлийн 40.1.5, 61 дүгээр зүйлийн 61.1-д заасныг тус тус баримтлан нэхэмжлэгч "ССС" ХХК-ийн нэхэмжлэлтэй Нийслэлийн Засаг дарга, Ш дүүргийн Засаг даргын 2010.04.05-ны өдрийн 90 дүгээр захирамжийн нэхэмжлэгчид холбогдох, Нийслэлийн Засаг даргын 2015.12.23-ны өдрийн А/990 дугаар захирамжийн Д.У-д холбогдох хэсгийг бүхэлд нь, Нийслэлийн Засаг даргын 2016.02.18-ны өдрийн А/128/ дугаар захирамжийн "ХХХ" ТББ-д холбогдох хэсгийг бүхэлд нь, Нийслэлийн Засаг даргын 2016.02.18-ны өдрийн А/128 дугаар захирамжийн "ХХХ" ТББ-д холбогдох хэсгийг нэхэмжлэгчийн эзэмшиж буй газартай давхцаж буй хэмжээгээр тус тус хүчингүй болгосугай гэж шийдвэрлэж хууль зөрчсөн гэсэн гомдол үндэслэлтэй байна.

Т Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар 2018 оны 3 дугаар сарын 29-ний өдөр 2/1219 тоот албан бичгээр иргэн Ш.Н-д гомдолд хариу хүргүүлэхдээ "...шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Д.Э нь ...01 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийн төслийг 01 дүгээр сарын 18-ны өдөр шүүгчид хянуулахаар өгч, 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр шүүх хуралдааны тэмдэглэлийг ёсчлуулж албажуулсан байна. гэсэн, /сахилгын хэргийн 28 дугаар хуудас/

Мөн Т Захиргааны хэргийн анхан шатны шүүх 2018 оны 02 дугаар сарын 15-ны өдөр 1/1475 тоот албан бичгээр "ХХХ" ТББ-д мэдэгдэхдээ "Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 88 дугаар зүйлийн 88.5-д Шүүх хуралдааны тэмдэглэл алдаатай, дутуу бичигдсэн бол шүүгч, шүүх бүрэлдэхүүн өөрийн санаачилгаар, эсхүл шүүх хуралдааны оролцогчийн хүсэлтээр гурван хоногийн дотор засвар хийж, энэ тухай тэмдэглэлд тусгаж, шүүх хуралдаан даргалагч гарын үсэг зурж баталгаажуулна." гэж заажээ. Тус шүүхэд орон нутгаас томилолтоор ажиллаж байсан шүүгч Б.М-ийн томилолтын хугацаа 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тул 2018 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн тэмдэглэлд засвар оруулах боломжгүй байна." гэжээ /сахилгын хэргийн 26 дугаар тал/

Т захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн шүүх хуралдааны дуу, дүрс бичлэгт Шүүхийн Ёс зүйн хорооны референт Ж.Халиун үзлэг хийж тэмдэглэл бичсэн байна. "Шүүх хуралдааны бичлэгт хийсэн тэмдэглэл" гэсэн баримтад "ССС" ХХК-ийн нэхэмжлэлтэй, Нийслэлийн Засаг даргад холбогдох захиргааны хэргийг хянан хэлэлцэх шүүх хуралдааны бичлэгт үзлэг хийлээ.

Үзлэгээр Шүүгч Б.М нь шүүхийн шийдвэрийн агуулгыг танилцуулсан бөгөөд дараа нь шийдвэрт өөрөөр тусгаж бичсэн гэх асуудлыг тодруулах зорилготой болно.

Шүүх хуралдааны бичлэгт: Шүүгч Б.М шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийн агуулгыг танилцуулахдаа "...ЗХХШТХ-ийн 106 дугаар зүйлийн 106.1, 106.3, 106.3.12, тус тус удирдлага болгон нэгдүгээрт нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, гуравдагч этгээдийн бие даасан шаардлагаас Ш дүүргийн Засаг даргын 2016 оны 215 дугаар захирамжийг илт хууль бусад тооцуулахыг хүссэн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож, үлдэх нэхэмжлэлийн шаардлага

болох Нийслэлийн засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 тоот захирамжийг хүчингүй болгуулахыг хүссэн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэж байна" гэжээ. /сахилгын хэргийн 29 дүгээр хуудас/

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.1,- д "Шүүх хуралдаан даргалагч шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийн агуулгыг танилцуулах үүрэгтэй бөгөөд, шаардлагатай бусад асуудлыг тайлбарлан шүүх хуралдааныг хаана." гэж зааснаар шүүгч нь гаргаж байгаа шийдвэрийн тогтоох хэсгийн агуулгыг танилцуулах ажиллагааг хийсэн байна. Шүүх хуралдаан дээр танилцуулсан шийдвэрийн агуулгаа бичгийн хэлбэрт зөв буулгаагүй шүүхээс гаргасан шийдвэр нь шийдвэрийг танилцуулсан агуулгаас зөрүүтэй бичигдсэн нь шүүгч Б.М Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1-д заасан хууль дээдлэх, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандах, мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх зарчим, мөн энэ дүрмийн 3.3 дугаар зүйлд заасан "хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэг" ээ зөрчсөн байна гэж дүгнэв.

Хоёрт, Гомдол гаргагч нараас Ф аймгаас Т Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд томилолтоор ирж ажиллаж байсан шүүгч Б.М нь томилолтын хугацаа 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон байхад шүүх эрх мэдлээ хэрэгжүүлэх боломжгүй буюу томилолтын хугацаа дууссанаас хойш шүүхийн тэмдэг, шүүгчийн гарын үсэг зурж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулсан гэж шүүгчийг буруутгаж гомдол гаргажээ. Шүүгч Б.М нь томилолтын хугацааныхаа дотор буюу 2018.01.11-ний өдөр "ССС" ХХК-ийн нэхэмжлэлтэй Нийслэлийн Засаг дарга, Нийслэлийн Ш дүүргийн Засаг дарга нарт холбогдох хэргийг хянан шийдвэрлэж, дараа нь ёсчилсон байгааг шүүгчийн ёс зүйн зөрчил гэж үзэх боломжгүй юм. Энэ талаар Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 87 дугаар тогтоолд хийсэн дүгнэлт зөв болжээ.

Гуравт, Гомдолд "Шүүгчийн туслах Д.Э-тэй уулзахад "...шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсгийг бичихдээ шүүгчийн шийдвэрлэсэн хэсгийг авч бичдэг" гэх тайлбар өгсөн.Д.Э нь шүүх хуралдааны тэмдэглэлийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр шүүгчид өгсөн байдаг ба шүүхийн шийдвэр 02 дугаар сарын 06-ны өдөр гарсан, шүүхийн шийдвэртэй уялдуулсан гэх дээрх байдал нь хурлын тэмдэглэлийг шүүгчийн хэлснээр өөрчлөн бичсэн гэж харагдаж байна" гэжээ.

Цугларсан баримтаас үзэхэд шүүгч Б.М нь 2018 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн шүүх хуралдааны тэмдэглэлийг тухайн хуралдаан дээр яригдаагүй агуулгаар өөрчилсөн буюу өөрчлүүлсэн гэх үндэслэлтэй байна.

Шүүхийн Ёс зүйн хорооны референт Ж.Халиун шүүх хуралдааны бичлэгт үзлэг хийсэн тэмдэглэл, мөн Т Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын дарга Д.Г-ийн 2018 оны 3 сарын 29-ны өдөр иргэн Ш.Н-д хүргүүлсэн хариу бичигт нарийн бичгийн дарга Д.Э нь ...01 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийн төслийг 01 дүгээр сарын 18-ны өдөр шүүгчид хянуулахаар өгч, 2018 оны 01 дүгээр сарын 31- ний өдөр шүүх хуралдааны тэмдэглэлийг ёсчлуулж албажуулсан.

... Түүнчлэн шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Д.Э Тамгын газарт гаргасан тайлбартаа "...хуулийн хугацаанд тэмдэглэлийн төслийг хянуулахаар шүүгчид өгч, уг тэмдэглэлийн төсөлд оруулсан засварыг нэмж албажуулсан..." гэсэн бөгөөд түүний шүүгчид хянуулахаар өгсөн шүүх хуралдааны тэмдэглэлийн төсөлд нэхэмжлэгчийн гомдолд дурдсан ХХХ ТББ-д холбогдох хэсгийг нэхэмжлэгч эзэмшиж буй хэмжээгээр тус тус хүчингүй болгож" гэх үг бичигдээгүй байжээ" гэсэн байна. /сахилгын хэргийн 28 дугаар хуудас/

Уг шүүх хуралдааны тэмдэглэл нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 88 дугаар зүйлийн 88.1,-д "...шүүхийн шийдвэрийн агуулга, ...тайлбарласан

талаар бичнэ.88.2.-т Шүүх хуралдааныг дуу-дүрсний бичлэгээр баталгаажуулна. ...88.3-т Шүүх хуралдаан дууссан өдрөөс хойш долоо хоногийн дотор тэмдэглэлийг бэлэн болгох ба түүнд шүүх хуралдаан даргалагч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга гарын үсэг зурна. 88.4-т Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцаж болно.

Тэмдэглэлтэй холбогдон гарсан саналыг шүүгч шийдвэрлэнэ. 88.5-д Шүүх хуралдааны тэмдэглэл алдаатай, дутуу бичигдсэн бол шүүгч, шүүх бүрэлдэхүүн өөрийн санаачилгаар, эсхүл шүүх хуралдааны оролцогчийн хүсэлтээр гурван хоногийн дотор засвар хийж, энэ тухай тэмдэглэлд тусгаж, шүүх хуралдаан даргалагч гарын үсэг зурж баталгаажуулна гэсэн хуулийн заалтууд хэрхэн хангагдсан талаар шүүгч хяналт тавих, хуулийн заалт шаардлагыг шүүгч хангаж ажиллаж чадаагүйгээс Монгол Улсын Шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.2.2-т заасан "...шүүгч шүүхийн ажилтан болон өөрийн удирдлага дахь бусад этгээдэд албан үүрэгт нь хамааралгүй үүрэг даалгавар өгөхийг хориглоно," мөн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 6-д "Шүүгчийн өөрийн удирдлага дор ажиллаж байгаа алба хаагчдад ажил мэргэжилдээ үнэнч байх, чин сэтгэлээсээ хандаж ажиллахыг шаардаж, өөрийн эргэн тойронд ёс зүйн эрүүл орчныг бүрдүүлнэ" гэж заасныг тус тус зөрчсөн гэж дүгнэж эдгээр үндэслэлүүдээр Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааны бүрэлдэхүүн шүүгч Б.М-д сахилгын сануулах шийтгэл ногдуулахаар тогтов.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйл, 36 дугаар зүйлийн 36.1.1, 37 дугаар зүйлийн 37.1.1, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйл, Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.1, 5.13-т заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Т захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М-д сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Энэ магадлалын хувийг шүүгч болон гомдол гаргагчид хүргүүлэхийг Шүүхийн Ёс зүйн хорооны Ажлын албанд даалгасугай.

3.Шүүгч, гомдол гаргагч нар магадлалыг гардан авснаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ

Н.ЭРДЭНЭЦОГТ

ГИШҮҮН

Ч.ОЮУНЦЭЦЭГ

УИН.МН
СҮДАЛГААНЫ САН



ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ
МАГАДЛАЛ

2018 оны 8 сарын 23 өдөр

Дугаар 221/ЁМ2018/0026

Улаанбаатар хот

Шүүхийн Ёс зүйн хорооны сахилгын
шийтгэл ногдуулсан магадлалын тухай

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааныг шүүгч Г.Билгүүн даргалж, шүүгч, Э.Зоригтбаатар, Ерөнхий шүүгч Д.Батбаатар нарын бүрэлдэхүүнтэй, Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 47 дугаар магадлалыг эс зөвшөөрч шүүгч Б.М-ийн давж заалдах гомдлоор, өмгөөлөгч Н.М, Э.Н нарын гомдолтой, шүүгч Б.М-д холбогдох сахилгын хэргийг Ерөнхий шүүгч Д.Батбаатарын илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 47 дугаар магадлалаар: “Т захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М-д сануулах сахилгын шийтгэл ногдуулж” шийдвэрлэжээ.

Шүүгч Б.М давж заалдах гомдолдоо: “Миний бие 2018 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр “ССС” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Нийслэлийн Засаг дарга, Ш дүүргийн Засаг дарга нарт холбогдох хэргийг хянан шийдвэрлэсэн.

Нэхэмжлэгч нь 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдөр гаргасан нэхэмжлэл гаргасан бөгөөд 2017 оны 7 дугаар сарын 26-ны өдөр “Нийслэлийн Засаг даргын 2016 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/128 дугаар захирамжийн “ХХХ” ТББ-д холбогдох хэсгийг хүчингүй болгуулах”, 2017 оны 10 дугаар сарын 16-ны өдөр “Нийслэлийн Засаг даргын 2016 оны 02 дугаар сарын 18- ны өдрийн А/128 дугаар захирамжийн “ХХХ” ТББ-д холбогдох хэсгийг хүчингүй болгуулах, Нийслэлийн Засаг даргын 2015 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/990 дугаар захирамжийн Д.У-д холбогдох хэсгийг хүчингүй болгуулах” гэж тус тус нэхэмжлэлийн шаардлагаа тодруулсан.

Шүүх хуралдааны хэлэлцүүлгийн шат эхлэхээс өмнө даргалагчаас нэхэмжлэлийн шаардлагыг дахин тодруулахад дээрх нэхэмжлэлийн шаардлагуудаа дэмжсэн.

Харин шүүх хуралдааны асуулт хариултын шатанд гуравдагч этгээдийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн өмгөөлөгчийн “39114 м² газрыг бүхэлд нь хүчингүй болгуулах гээд байна уу, эсхүл хэсэгчлэн хүчингүй болгуулах гээд байна уу” гэсэн асуутад нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч “манайхаас давхардсан хэсгээрээ гэж тодруулсан байна” гэж нэхэмжлэлийн шаардлагаа дахин тодруулсан тул уг шаардлагын хүрээнд нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн бөгөөд шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт энэ талаар тусгасан.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 20 дугаар зүйлд нэхэмжлэгчийн эрх, үүргийг хуульчилсан ба мөн хуулийн 20.1 1-д “нэхэмжлэлээ

өөрчлөх, түүний шаардлагын хэмжээг ихэсгэх, эсхүл багасгах, нэхэмжлэлээсээ бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн татгалзах, хариуцагчтай эвлэрэх” эрхтэй, мөн хуулийн 106 дугаар зүйлийн 106.5-д “шүүх нэхэмжлэлийн шаардлагын хүрээнээс хэтэрсэн болон хэргийн оролцогчдын маргаагүй асуудлаар дүгнэлт хийж, шийдвэр гаргаж болохгүй”, 108 дугаар зүйлийн 108.1-д “шүүх хуралдаан даргалагч шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийн агуулгыг танилцуулж, шаардлагатай бусад асуудлыг тайлбарлан шүүх хуралдааныг хаана.” гэж тус тус заасан байдаг.

Миний бие шүүхийн шийдвэрийн агуулгыг танилцуулахдаа дээрх нэхэмжлэлийн шаардлагаа тодруулсан хүрээнд буй “нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, гуравдагч этгээдийн бие даасан шаардлагаас Ш дүүргийн Засаг даргын 215 захирамжийг илт хууль бусад тооцуулахыг хүссэн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож, Нийслэлийн Засаг даргын 2017 оны 3 дугаар захирамжийг хүчингүй болгуулахыг хүссэн нэхэмжлэлийн шаардлагыг нь хангаж” шийдвэрлэлээ гэж танилцуулсан болно.

Харин гомдолд дурдсанчлан “Нийслэлийн Засаг даргын 2016 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/128 дугаар захирамжийн “ХХХ” ТББ-д холбогдох хэсгийг бүхэлд нь хүчингүй болгох” гэсэн агуулгаар тайлбарлаагүй бөгөөд зөвхөн дээрх шүүх хуралдаанд нэхэмжлэлийн шаардлагаа дахин тодруулсны дагуу /*манайхаас давхардсан хэсгээрээ гэж тодруулсан*/ нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн бөгөөд энэ нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй гэж бодож байна.

Гэтэл Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 87 дугаар “Сахилгын хэрэг үүсгэх тухай” тогтоол, 2018 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн № 47 дугаар “Сахилгын шийтгэл ногдуулах тухай” тогтоолд намайг шүүх хуралдааны тэмдэглэлийг тухайн хуралдаан дээр яригдаагүй агуулгаар өөрчилсөн буюу өөрчлүүлсэн үйлдлээрээ Монгол Улсын Шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.2.2, мөн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 6-д заасныг зөрчсөн гэжээ.

Би шүүх хуралдаанд огт яригдаагүй, эсхүл яригдсан зүйлийн утга, агуулгыг өөрчлүүлсэн, өөрчлөх талаар шүүх хуралдааны тэмдэглэлийг хөтөлсөн нарийн бичгийн даргад үүрэг даалгавар өгөөгүй бөгөөд шүүх хуралдааны бичлэг /шүүхийн шийдвэрийн агуулгыг тайлбарлаж буй/ хэсэг болон шүүх хуралдааны тэмдэглэл нар зөрүүгүй байхад нарийн бичгийн даргаас тайлбар, мэдүүлэг авалгүйгээр намайг шүүх хуралдааны тэмдэглэлийг санаатайгаар өөрчлүүлсэн гэж буруутгаж байгаа нь үндэслэлгүй.

Иймд Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 87 дугаар “Сахилгын хэрэг үүсгэх тухай” тогтоол, 2018 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 47 дугаар “Сахилгын шийтгэл ногдуулах тухай” тогтоолуудыг хүчингүй болгож өгнө үү” гэжээ.

ХЯНАВАЛ:

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хороо Т Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд албан томилолтоор ажиллаж байсан Ф аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М-г “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад “шүүх хуралдаанд танилцуулсан шийдвэрийн агуулгаа шийдвэрт зөрүүтэй бичсэн, шүүх хуралдааны тэмдэглэлийг хуралдаанд яригдаагүй агуулгаар өөрчилсөн буюу өөрчлүүлсэн” нь Монгол Улсын Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1, 3.3 дугаар зүйлийн 1, 6, 4.2 дугаар зүйлийн 2 дахь заалтыг /Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалд “4 дүгээр зүйлийн 4.2.2” гэж ташаа бичсэн/ зөрчсөн” гэж үзэн сахилгын “сануулах” шийтгэл ногдуулсан нь үндэслэлгүй байна.

Шүүгч Б.М “ССС” ХХК-аас Ш дүүргийн Засаг дарга болон Нийслэлийн Засаг даргад холбогдуулан гаргасан “Ш дүүргийн Засаг даргын 2010 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн “Газар эзэмших эрхийг хүчингүй болгох тухай” 90 дүгээр захирамжийн нэхэмжлэгчид холбогдох хэсгийг хүчингүй болгуулах, газар эзэмших эрхийг сэргээхийг даалгах, Нийслэлийн Засаг даргын 2015 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/990 дүгээр захирамжийн Д.У-д холбогдох хэсэг, 2016 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/128 дугаар захирамжийн “ХХХ” ТББ-д холбогдох хэсгийг тус тус хүчингүй болгуулах, гуравдагч этгээдийн “Ш дүүргийн Засаг даргын 2006 оны 215 дугаар захирамжийг илт хууль бус болохыг тогтоож, хүчингүй болгуулах, Нийслэлийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн “Шүүхийн шийдвэрийг биелүүлэх талаар авах арга хэмжээний тухай” А/103 дугаар захирамжийн “ХХХ” ТББ-д холбогдох хэсгийг хүчингүй болгуулах” бие даасан шаардлагатай захиргааны хэргийг 2018 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэжээ.

Дээрх захиргааны хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдааны хэлэлцүүлгийн явцад нэхэмжлэгчээс нэхэмжлэлийн “Нийслэлийн Засаг даргын 2016 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/128 дугаар захирамжийн “ХХХ” ТББ-д холбогдох хэсгийг хүчингүй болгуулах” шаардлагаа “Нийслэлийн Засаг даргын 2016 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/128 дугаар захирамжийн “ХХХ” ТББ-д холбогдох хэсгийг нэхэмжлэгчийн эзэмшиж буй газартай давхцаж буй хэмжээгээр хүчингүй болгуулах”-аар тодруулсан байх бөгөөд шүүх шийдвэрээ танилцуулахдаа “нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, гуравдагч этгээдийн бие даасан шаардлагаас Ш дүүргийн Засаг даргын 2016 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 215 дугаар захирамжийг илт хууль бусд тогтоолгохыг хүссэн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож, үлдэх нэхэмжлэлийн шаардлага болох Нийслэлийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 тоот захирамжийг хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэж байна” гэж танилцуулсан нь сахилгын хэрэгт авагдсан Т Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүх хуралдааны тэмдэглэл, шүүх хуралдааны дуу-дүрсний бичлэгээр тогтоогдож байна.

Дээрх танилцуулсан шийдвэрээ шүүхийн шийдвэрт болон шүүх хуралдааны тэмдэглэлд “нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, Ш дүүргийн Засаг даргын 2010 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 90 захирамжийн нэхэмжлэгчид холбогдох, Нийслэлийн Засаг даргын 2015 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/990 дугаар захирамжийн Д.У-д холбогдох хэсгийг бүхэлд нь, Нийслэлийн Засаг даргын 2016 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/128 дугаар захирамжийн “ХХХ” ТББ-д холбогдох хэсгийг нэхэмжлэгчийн эзэмшиж буй газартай давхцаж буй хэмжээгээр тус тус хүчингүй болгож, гуравдагч этгээдийн бие даасан шаардлагаас Ш дүүргийн Засаг даргын даргын 2006 оны 9 дүгээр сарын 08-ны өдрийн 215 дугаар захирамжийг илт хууль бус болохыг тогтоож, хүчингүй болгуулахыг хүссэн шаардлагыг хэрэгсэхгүй болгож, Нийслэлийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар захирамжийн “ХХХ” ТББ-д холбогдох хэсгийг хүчингүй болгуулахыг хүссэн шаардлагыг хангасан” гэж тусгажээ.

Үүнээс үзвэл шүүгч Б.М-г “шүүх хуралдаанд танилцуулсан шийдвэрийн агуулгаа шийдвэрт зөрүүтэй бичсэн, шүүх хуралдааны тэмдэглэлийг тухайн хуралдаан дээр яригдаагүй агуулгаар өөрчилсөн буюу өөрчлүүлсэн” гэх боломжгүй, Шүүхийн Ёс зүйн хороо энэ байдалд буруу дүгнэлт хийж, түүнийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай 88 дугаар зүйлийн 88.1-д “Шүүх хуралдааны тэмдэглэлд ... шүүхийн шийдвэрийн агуулга, ... журмыг тайлбарласан талаар бичнэ”, Монгол Улсын Шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1 /Шүүгч хуульд тусгайлан ёс зүйн зөрчил болохоор заасан болон энэ дүрмээр тогтоосон хэм

хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг ёс зүйн зөрчил гэж үзнэ/-д заасан ёс зүйн зөрчил үйлдсэн гэж үзсэн нь үндэслэлгүй байна.

Иймд, дээрх үндэслэлээр шүүгч Б.М-д “сануулах” сахилгын шийтгэл ногдуулсан магадлалыг хүчингүй болгож, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй гэж үзэв.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1, 121 дүгээр зүйлийн 121.1.2 дахь заалтыг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 47 дугаар магадлалыг хүчингүй болгож, шүүгч Б.М-д ногдуулсан сахилгын шийтгэлийг хүчингүй болгож, холбогдох сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгосугай.

2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.5 дахь хэсэгт зааснаар давж заалдах шатны шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн, хууль буруу хэрэглэсэн гэж хэргийн оролцогчид, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч үзвэл магадлалыг гардан авсан, эсхүл хүргүүлснээс хойш 14 хоногийн дотор Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхимд гомдол гаргах эрхтэй.

ШҮҮГЧ

Г.БИЛГҮҮН

ШҮҮГЧ

Э.ЗОРИГТБААТАР

ШҮҮГЧ

Д.БАТБААТАР

UIN.MN
СУДАЛГААНЫ САН



МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЁС ЗҮЙН ХОРООНЫ МАГАДЛАЛ

2018 оны 3 сарын 02-ны өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

П аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн
анхан шатны шүүхийн шүүгч Б.Ц-д сахилгын
шийтгэл ногдуулах тухай

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааныг тус хорооны дарга Н.Эрдэнэцогт даргалж, гишүүн А.Доржготов, Д.Сүнжид, В.Жавхлан, О.Мөнхсайхан, Ч.Оюунцэцэг нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны тэмдэглэл хөтлөгчөөр шинжээч А.Энхбаатар, референт Ж.Халиун, гомдол гаргагч С.О, түүний өмгөөлөгч Ж.С, шүүгч Б.Ц нарыг оролцуулан Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдааны танхимд хийв. П аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Ц-д сахилгын хэрэг үүсгэж шийдвэрлэсэн Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 15 дугаар тогтоолтой сахилгын хэргийг гишүүн Ч.Оюунцэцэгийн илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Иргэн С.О Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан гомдолдоо: "П аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017.09.18-ны өдрийн 151/ШШ2017/00979 шүүхийн шийдвэрт 2017.10.20-ны өдөр гомдол гаргасан (гомдол гаргах хугацаандаа) гэвч шүүгч бидний гомдлыг 2017.10.24-ны өдрийн 151/Ш32017/03326 тоот захирамжаар давж заалдах гомдлыг хүлээн авахаас татгалзах тухай захирамж гарган нэхэмжлэгчийн хуулиар олгосон өөрийн эрх ашгийг хамгаалах, давах, хяналтын шатны шүүхэд гомдол гаргахыг эрхийг хязгаарласан. Ингэхдээ ИХШХШТХ-ийн 57.4-т заасны дагуу давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж байгаа этгээд улсын тэмдэгтийн хураамж төлөх гэсэн зохицуулалтыг баримталсан байна. Гэтэл тус шүүгч нь (Б.Ц) 2017.04.28-ны өдрийн 151/Ш32017/01391 тоот захирамжаар нэхэмжлэгч С.О-гийн бүрдүүлж өгсөн төлбөрийн чадваргүй болохыг нотолсон материалд үндэслэн УТХ-аас чөлөөлсөн байдаг. Шүүхийн жишигт 3 шатны шүүхэд гомдол гаргах, хандах бүрдээ УТХ-аас чөлөөлүүлэх тогтолцоо огт байхгүй, тухай хэрэгт нэхэмжлэгчийг төлбөрийн чадваргүй гэдгийг нотлох баримт хангалттай байгаа, мөн өмнө УТХ-аас чөлөөлсөн захирамж байгаа, өөрөө тус захирамжийг гаргасан. Гэтэл ийнхүү санаатайгаар өөрийн гаргасан шийдвэрт гомдол гаргаж буй хэргийн оролцогчийн эрхийг хязгаарласан үйлдэл гаргасан шүүгчийн үйлдэл нь ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл гэж миний бие ойлгож байна. Учир нь ИХШХШТХ-ийн 164 дүгээр зүйлийн дагуу буюу давж заалдах шатанд гомдол гаргах журам зөрчсөн гэж үзсэн байна. Гэтэл 162.4-т УТХ-ийг урьдчилан төлөх гэж зохицуулсан, харин УТХ-аас аль хэдий нь чөлөөлөгдсөн иргэн дахин УТХ-аас чөлөөлөх хүсэлт, нотлох баримтыг хавсаргаж ирүүлэх талаар зохицуулалт огт байхгүй байхад шүүгч үндэслэлгүйгээр хязгаарласан байдаг. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн зарчим шүүгч өөрт олгосон эрх хэмжээний хүрээнд захирамж гаргах эрхтэй, гэтэл хууль зохицуулаагүй үндэслэлээр нэхэмжлэгчийн эрхийг хязгаарласан нь

шүүгчийн ёс зүйгүй, санаатай үйлдэл гэж бид үзэж байна. Шүүхийн шинэчлэл, ил тод байдал, мөн процессын хууль (2002) батлагдаж аль хэдий нь 15 жилийн хугацаанд үйлчилж байхад энэ мэт хууль хэрэглээний ноцтой, хариуцлагагүй алдаа гаргаж буй, магадгүй санаатайгаар хязгаарласан байх магадлалтай байгаа. Мөн шүүгчийн захирамждаа үндэслэл болгон гаргаж буй ИХШХШТХ-ийн 57.4 дэх зохицуулалт нь тэмдэгтийн хураамжийг зохих журмын дагуу төлсөн иргэдэд үйлчлэх зохицуулалт бөгөөд харин УТХ-аас чөлөөлсөн иргэдэд ИХШХШТХ-ийн 58.3-т заасны дагуу УТХ-аас чөлөөлөгдсөн захирамжтай учир дахин УТХ төлөх, хүсэлт гаргах ёсгүй юм. ИХШХШТХ-ийн 162.4, 164 дэх зохицуулалтад иргэний дахин УТХ-аас чөлөөлөх хүсэлт, холбогдох баримтыг хавсаргах шаардлага огт алга, мөн шүүгчийн УТХ-аас чөлөөлсөн захирамж хүчин төгөлдөр бөгөөд УТХ-аас чөлөөлөх захирамж анхан шатны шүүхийн, давах шатны, эсхүл хяналтын шатны шүүхийн гэх мэтчилэн тус тусад нь гаргах зохицуулалт байхгүй билээ. Нэг хэрэг дотор 3 удаа (шүүхийн шат бүрд) улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлсөн захирамж гаргах боломжгүй. Шүүхэд иргэн нэг удаа өөрийн эрх зүйн байдал буюу төлбөрийн чадваргүй гэдгийг нотлох баримтыг хүргэн, УТХ-аас чөлөөлүүлсэн байхад дахин УТХ-аас чөлөөлөх хүсэлт, материал нэхэж, давж заалдах гомдол гаргах эрхийг хязгаарлаж байгаа нь иргэнийг санаатайгаар чирэгдүүлж, залхаах гэсэн үйлдэл юм. Сүүлийн жилүүдэд Шүүхийн тогтолцоог илүү нээлттэй, хүнд суртал багатай байлгах зорилгыг МУ-ын Ерөнхийлөгч, Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс тавьж тодорхой үр дүнд хүрч байгаа ч энэ мэт иргэдийг санаатайгаар чирэгдүүлэх, эрхийг хязгаарлах үйлдэл гарсаар байгаа гэдгийг хэлмээр байна. Орон нутгийн шүүх, шүүгчид хууль хэрэглээний анхан шатны мэдлэг, чадвар сул байгаа нь энэ үйлдлээс харагдаж байна. Тиймээс шүүгчийн мэргэжлийн ур чадвар, ёс зүйн зохих хэм хэмжээг зөрчсөн П аймгийн сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Ц-д зохих журмын дагуу арга хэмжээ авч, хязгаарлагдсан эрх, хууль ёсны ашиг сонирхлыг минь сэргээж өгөхийг гүнээ хүндэтгэн хүсэж байна" гэжээ.

Шүүгч Б.Ц тайлбартаа: "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.3-т Нэхэмжлэгч төлбөрийн чадваргүй болох нь түүний тайлбар, бусад нотлох баримтаар тогтоогдсон буюу хуульд заасан бусад үндэслэл байвал түүнийг улсын тэмдэгтийн хураамж төлөхөөс шүүгчийн захирамжаар чөлөөлнө" гэж заасан. С.О-гийн 22,350,200 төгрөг гаргуулах нэхэмжлэлийн шаардлагад төлөх улсын тэмдэгтийн хураамж болох 269 701 төгрөг төлөх үүргээс түүний хүсэлтээр, нотлох баримтыг үндэслэн тус шүүхийн шүүгчийн 2017.04.28-ны өдрийн 151/Ш32017/01391 тоот иргэний хэрэг үүсгэх захирамждаа чөлөөлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулснаар 1 хавтас хуудас бүхий хэргийг 2017.09.18-ны өдөр хянан хэлэлцэж шийдвэрлэсэн бөгөөд тэрээр шүүхийн шийдвэрийг 2017.10.09-ний өдрийн 16 цаг 05 минутад өөрийн биеэр шүүхэд хүрэлцэн ирж гардан авсан. Нэхэмжлэгчийг анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргахад тэмдэгтийн хураамжаас чөлөөлсөн нь давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргахад мөн адил чөлөөлсөн гэж үзэж, ойлгож, бичиж байгаа С.О, түүний өмгөөлөгч Ж.С нарын гомдол хууль зүйн үндэсгүй юм. Харин давж заалдах журмаар гомдол гаргахад Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай 162 дугаар зүйлийн 162.4-т давж заалдах журмаар гомдол гаргаж байгаа этгээдээс энэ хуулийн 57.1, 57.4-т заасан журмаар улсын тэмдэгтийн хураамжийг урьдчилан төлүүлнэ. Хуулийн 57.4-т анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалд гомдол гаргаж байгаа этгээд шийдвэр магадлалыг хүлээн зөвшөөрөхгүй байгаа хэмжээгээр улсын тэмдэгтийн хураамжийг тооцон төлнө гэж тус тус заасан байна. С.О нь эрхэлсэн ажилгүй, тогтмол орлогогүй байгаа нь хүндэтгэн үзэх шалтгаанд тооцох үндэслэлгүй бөгөөд харин ч мөнгөн төлбөрийн

шаардлагад төлөх тэмдэгтийн хураамжаас үндэслэлгүйгээр чөлөөлөх нь хүн бүр шүүхийн өмнө тэгш байх зарчим мөн шүүгч гагцхүү хуульд захирагдах тухай хууль дээдлэх зарчим зөрчигдөх юм. Түүнчлэн С.О-гийн өмгөөлөгч Ж.С нь давж заалдах журмаар гаргасан гомдлыг хуулийн хугацаа хэтрүүлж шүүхэд ирүүлсэн мөн энэ гомдолдоо тэмдэгтийн хураамж төлөөгүй. төлөх үүргээс чөлөөлүүлэх хүсэлт болон нотлох баримтаа ирүүлээгүй болно. Миний хувьд Шүүгчийн ёс зүйн дүрэм заалтыг зөрчөөгүй, ямар нэгэн үйлдэл эс үйлдэхүй гаргаагүй, хуулиар олгогдсон эрхийн дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж шийдвэрлэсэн болно. Гомдолд дурдсан асуудал нь ёс зүйн зөрчилд хамааралгүй гэж үзэж байна. Шүүгчийн хувьд шүүгчийн ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах үүрэгтэй энэ үүргээ хэрэгжүүлж ажилласан. Харин хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд заасны дагуу явуулж байгаа үйлдэлд гомдол гаргаж байгаа нь Шүүгч миний хууль ёсны эрх, хараат бус байдалд халдсан үйлдэл үйл ажиллагаа бөгөөд Шүүгчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад аливаа хэлбэрээр нөлөөлсөн гэж үзэхээр байгаа тул энэхүү гомдлыг гаргахад хууль зүйн туслалцаа үзүүлж буй өмгөөлөгч Ж.С-ийн үйлдэл мөн "тэмдэгтийн хураамжаас чөлөөлөхгүй бол Ёс зүйн хороонд хандана гэсэн" нэхэмжлэгч С.О-гийн үйлдэлд нөлөөллийн мэдүүлэг хөтлөх, мөн өмгөөлөгчийн мэргэжил үйл ажиллагаандаа тэнцэх эсэх талаар Хуульчийн мэргэжлийн хариуцлагын хороонд гомдол гаргана гэж бодож байна. Иймд дээрх иргэний гомдлоор сахилгын хэрэг үүсгэх үндэслэлгүй ба гомдлыг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэнэ үү" гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 15 дугаар тогтоолоор шүүгч Б.Ц-д сахилгын хэрэг үүсгэж шийдвэрлэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны гомдол хянан хэлэлцэх хуралдааны 2018 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 163 дугаар тогтоол, иргэн Д.Б-ээс Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан гомдол болон шүүгчийн тайлбар, тус хорооноос явуулсан хяналт шалгалтын ажиллагаагаар цугларсан баримтуудыг хэлэлцээд ҮНДЭСЛЭХ нь:

Иргэн С.О Шүүхийн Ёс зүйн хороонд "...бидний давж заалдах гомдлыг шүүгч Б.Ц хүлээн авахаас татгалзах тухай шүүгчийн захирамж гарган нэхэмжлэгчийн хуулиар олгосон өөрийн эрх ашгийг хамгаалах, давах, хяналтын шатны шүүхэд гомдол гаргах эрхийг хязгаарласан... Тиймээс шүүгчийн мэргэжлийн ур чадвар, ёс зүйн зохих хэм хэмжээг зөрчсөн П аймгийн сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Ц-д зохих журмын дагуу арга хэмжээ авч, хязгаарлагдсан эрх, хууль ёсны ашиг сонирхлыг минь сэргээж өгөхийн г хүсч байна." гэсэн агуулгатай гомдол гаргажээ.

Шүүгч Б.Ц тайлбартаа "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.3-д Нэхэмжлэгч төлбөрийн чадваргүй болох нь түүний тайлбар, бусад нотлох баримтаар тогтоогдсон буюу хуульд заасан бусад үндэслэл байвал түүнийг улсын тэмдэгтийн хураамж төлөхөөс шүүгчийн захирамжаар чөлөөлнө" гэж заасан. С.О-гийн 22,350,200 төгрөг гаргуулах нэхэмжлэлийн шаардлагад төлөх улсын тэмдэгтийн хураамж болох 269 701 төгрөг төлөх үүргээс түүний хүсэлтээр, нотлох баримтыг үндэслэн тус шүүхийн шүүгчийн 2017.04.28-ны өдрийн 151/Ш32017/01391 тоот иргэний хэрэг үүсгэх захирамждаа чөлөөлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж, хэргийг 2017.09.18-ны өдөр шийдвэрлэсэн. С.О-гийн өмгөөлөгч Ж.С нь давж заалдах журмаар гаргасан гомдлыг хуулийн хугацаа хэтрүүлж шүүхэд ирүүлсэн,... мөн энэ гомдолдоо тэмдэгтийн хураамж төлөөгүй. төлөх үүргээс чөлөөлүүлэх хүсэлт болон нотлох баримтаа ирүүлээгүй болно. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай 162 дугаар зүйлийн 162.4-т давж заалдах журмаар гомдол гаргаж байгаа этгээдээс энэ хуулийн 57.1, 57.4-т заасан журмаар улсын тэмдэгтийн хураамжийг

урьдчилан төлүүлнэ. Хуулийн 57.4-т анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалд гомдол гаргаж байгаа этгээд шийдвэр магадлалыг хүлээн зөвшөөрөхгүй байгаа хэмжээгээр улсын тэмдэгтийн хураамжийг тооцон төлнө гэж тус тус заасан байна. Иймд дээрх иргэний гомдлоор сахилгын хэрэг үүсгэх үндэслэлгүй гэжээ.

Сахилгын хэрэгт цугларсан баримтаас үзэхэд дараах үйл баримт тогтоогдож байна.

Нэхэмжлэгч С.О-гийн нэхэмжлэлтэй "PPP" ХХК, "ТТТ" ХХК-уд болон тэдний захирлуудад холбогдуулж өөрийн нөхөр талийгаач М.Ц-гийн амь нас хохирсонд хариуцагч нарыг буруутайд тооцож хохирол, олговор гаргуулах тухай агуулгатай нэхэмжлэлд шүүгч Б.Ц 2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр 0391 дүгээр шүүгчийн захирамжаар иргэний хэрэг үүсгэхдээ нэхэмжлэгчийн "...5 хүүхэдтэй, 3 хүүхэд 18 насанд хүрээгүй, өрх толгойлсон ажилгүй, орлогогүй, нийгмийн байдал эмзэг бүлэгт багтах болсон гэсэн хүсэлт, болон нотлох баримтыг үндэслэн үнэлж нэхэмжлэгчийг улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулсан байна.

П аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 00979 дугаартай шүүхийн шийдвэрээр уг хэргийг шийдвэрлэж, шүүхийн шийдвэрийг нэхэмжлэгч С.О-д 2017 оны 10 дугаар сарын 09-ний өдөр гардуулсан, улмаар нэхэмжлэгчийн өмгөөлөгч шүүхэд давж заалдах гомдлыг шуудангаар хүргүүлжээ. /хэргийн 12-18 дугаар тал/

Бүртгэл №3 гэсэн баримтын 96-д бүртгэгдсэн байдлаас үзэхэд 2017 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 10.00 цагт шүүхэд давж заалдах гомдол ирсэн гэж бүртгэгдсэн, шүүгч мөн өдөр давж заалдах гомдлыг хүлээж авахаас татгалзах тухай шүүгчийн 03326 дугаартай захирамж гаргахдаа "нэхэмжлэгч давж заалдах гомдлыг анхан шатны шүүхэд хүргүүлсэн ч улсын тэмдэгтийн хураамж төлсөн болон чөлөөлүүлэх тухай хүсэлт, холбогдох нотлох баримтыг шүүхэд гаргаагүй байна..." гэсэн үндэслэл заасан байна./хэргийн 22-23 дугаар тал/

Гомдол гаргагч С.О, түүний өмгөөлөгч Ж.С нар гомдолдоо "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.4 дэх хэсэгт заасан зохицуулалт нь тэмдэгтийн хураамжийг зохих журмын дагуу төлсөн иргэдэд үйлчлэх зохицуулалт бөгөөд харин хураамжаас чөлөөлсөн иргэдэд /58.3-т заасны дагуу улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдсөн захирамжтай учир/ дахин улсын тэмдэгтийн хураамж төлөх, чөлөөлүүлэх хүсэлт гаргах ёсгүй юм. Хуулийн 162.4, 164 дэх зохицуулалтад дахин хураамжаас чөлөөлөх хүсэлт, холбогдох баримтыг хавсаргах шаардлага огт байхгүй, мөн шүүгчийн хураамжаас чөлөөлсөн захирамж хүчин төгөлдөр байгаа бөгөөд хураамжаас чөлөөлөх захирамж анхан шатны шүүхийн, давах шатны, эсхүл хяналтын шатны шүүхийн гэх мэтчилэн тус тусад нь гаргах талаар зохицуулалт байхгүй байхад шүүгч энэ мэт хууль хэрэглээний ноцтой, хариуцлагагүй алдаа гаргаж, магадгүй санаатайгаар гомдол гаргах эрхийг хязгаарласан байх магадлалтай гэсэн байх ба уг гомдлыг хүлээж авах боломжгүй, тайлбар хуулийн үндэслэлгүй тул шүүгчийг Монгол улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн заалтыг зөрчсөн гэж үзэхгүй.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.2-т "Нэхэмжлэлд улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, эсхүл уг хураамжаас чөлөөлүүлэх тухай хүсэлт, ...хавсаргана." гэж нэхэмжлэлийн бүрдүүлбэрийн талаар заасан, хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.11-т "энэ хуулийн 62 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй байвал." нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзахаар заасан. Үүнээс үзэхэд шүүхэд нэхэмжлэл гаргахдаа нэхэмжлэгч нь хуулийн шаардлагыг биелүүлж, нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хангаж, эцэст нь нэхэмжлэгчийн нэхэмжлэл гаргах эрх нээгдэхээр хуульд зохицуулсан юм.

Нэхэмжлэгчийг улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлсөн шүүгчийн захирамж гаргаснаар шүүхэд гаргасан нэхэмжлэлийн бусад бүрдүүлбэр хангагдсан гэж шүүх үзвэл нэхэмжлэлийг хүлээн авдаг.

2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 0391 дүгээр шүүгчийн захирамжаар нэхэмжлэгчийг тэмдэгтийн хураамжаас чөлөөлсөн нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.3-т заасан “Нэхэмжлэгч төлбөрийн чадваргүй болох нь түүний тайлбар, бусад нотлох баримтаар тогтоогдсон буюу хуульд заасан бусад үндэслэл байвал түүнийг улсын тэмдэгтийн хураамж төлөхөөс шүүгчийн захирамжаар чөлөөлнө.” гэсэн заалтад нийцсэн байна.

Иймд шүүгч нь нэхэмжлэлийг хүлээж авч, иргэний хэрэг үүсгэж, нэхэмжлэгчийн “анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргахад төлөх улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлүүлэх” түүний шүүхэд гаргасан хүсэлтийг шийдвэрлэж байгаа тул тухайн шүүгчийн 0391 дүгээр шүүгчийн захирамж зөвхөн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргахад төлөх улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлсөн шийдэл болно.

Давж заалдах гомдол гаргаж буй этгээд нь шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа хэмжээгээр улсын тэмдэгтийн хураамжийг тооцон төлөх үүрэгтэй. Энэ хураамжийн талаар ирүүлсэн хүсэлтийг хүлээж авсан анхан шатны шүүхийн шүүгч хуульд заасан үндэслэлээр улсын тэмдэгтийн хураамж төлөх хэмжээг багасгах буюу хугацааг хойшлуулах, эсхүл хэсэгчлэн төлүүлж, чөлөөлж /хуулийн 55,57 дугаар зүйл/ шийдвэрлэж, хуульд заасан бусад ажиллагааг хийж, хуулийн 163.3-т зааснаар анхан шатны шүүх хэргийг давж заалдах шатны шүүхэд хүргүүлэх журамтай байдаг.

Анхан шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч давж заалдах гомдол гаргах тохиолдолд хэргийн зохигч нь хуулийн 162.4-д заасны дагуу улсын тэмдэгтийн хураамж төлөхөөс чөлөөлүүлэх талаар мөн хүсэлт гаргах эрхтэй. Хэргийн зоригчоос гаргасан хүсэлтийг хангах эсэх асуудлыг анхан шатны шүүхийн шүүгч хүсэлт болон нотлох баримтыг үндэслэн шийдвэрлэж шүүгчийн захирамж гаргаж байгаа нь давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулсан мөн хуулийн 161.2-т Давж заалдах гомдлыг шийдвэр гаргасан шүүхээр дамжуулан гаргана гэж, 162.4 -т Давж заалдах журмаар гомдол гаргаж байгаа этгээдээс энэ хуулийн 57.1, 57.4-т заасан журмаар улсын тэмдэгтийн хураамжийг урьдчилан төлүүлнэ.” гэж заасан хуулийн зохицуулалт зөрчигдөөгүй байх тул шүүгчийг санаатайгаар хууль хэрэглээний ноцтой, хариуцлагагүй алдаа гаргасан гэж үзэхгүй.

Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 15 дугаар тогтоолд 2017 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 03326 дугаартай шүүгчийн захирамжид уг гомдлыг гаргах хуулийн хугацааг нэхэмжлэгч хэтрүүлсэн тухай дурдагдаагүй. Гэвч, уг давж заалдах гомдлыг гаргасан хугацааны талаар маргаантай байгааг, мөн тус хорооны нийт гишүүдийн хуралдаанаас өмнө уг давж заалдах гомдлыг гаргасан хугацааг тодруулах зорилгоор нэмэлт шалгалт хийх нь зүйтэй гэж зааснаар нэмэлт баримтууд бүрдүүлэх ажиллагааг хийж дараах байдал тогтоогдсон болно.

Монгол шуудан гэсэн тамгатай шуудангийн дугтуйд “... өмгөөлөгч Ж.С ... П аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүхэд” гэсэн бичигтэй, тэнд дарагдсан дардсанд уг баримтыг “2017 оны 10 дугаар сарын 23-ны өдөр” хүргэж өгсөн гэж, Монгол шуудан уг баримтыг шүүхэд “2017 оны 10 дугаар сарын 24-ны өдөр” хүлээлгэж өгсөн гэсэн байгаагаас үзэхэд П аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 00979 дугаартай шүүхийн шийдвэрт нэхэмжлэгчийн өмгөөлөгч хуулийн хугацаанд 14 хоногийн дотор анхан шатны шүүхэд давж заалдах гомдлыг гаргасан ч улсын тэмдэгтийн

хураамж төлсөн болон чөлөөлүүлэх тухай хүсэлт, холбогдох нотлох баримтыг шүүхэд гаргаагүйгээс нэхэмжлэгчийн давж заалдах гомдлыг хүлээж авахаас татгалзах тухай шүүгчийн 03326 дугаартай захирамжийг шүүгч гаргасан нь хууль зөрчөөгүй, шүүгчийг шүүгчийн ёс зүйн дүрмийн холбогдох заалтыг зөрчсөн гэж буруутгах боломжгүй байна.

Шүүгч Б.Ц 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдөр 03833 дугаар шүүгчийн захирамжаар "... нэхэмжлэгчийг тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх хууль зүйн үндэслэлгүй, мөн 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр ирүүлсэн давж заалдах гомдлын хугацаа сэргээлгэх тухай хүсэлтдээ хүндэтгэн үзэх шалтгаанаа дурдаагүй байна." гэсэн үндэслэл зааж нэхэмжлэгчийн хүсэлтийг хүлээж авахаас татгалзсан захирамж гаргажээ. Мөн өдөр давж заалдах гомдлыг хүлээн авахаас татгалзах тухай 03844 дугаартай шүүгчийн захирамжийг гаргахдаа "...2017 оны 10 дугаар сарын 23-ний өдөр гомдол гаргах хугацаа дууссан. 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр 11 цагт уг гомдол шүүхэд ирсэн. Гомдол гаргах хуулийн хугацаа дууссан, давж заалдах гомдлыг анхан шатны шүүхэд хүргүүлсэн ч улсын тэмдэгтийн хураамж төлсөн болон чөлөөлүүлэх тухай хүсэлт болон холбогдох нотлох баримтыг шүүхэд гаргаагүй байна" гэжээ.

Давж заалдах гомдлыг хүлээж авахаас татгалзах тухай 10 дугаар сарын 24-ний өдрийн 03326 дугаар шүүгчийн захирамжийг шүүх 11 дүгээр сарын 01-ний өдөр шуудангаар нэхэмжлэгчид хүргүүлсэн /хэргийн 24-26 дугаар тал/ байхад нэхэмжлэгч түүний өмгөөлөгч нар давж заалдах хугацаа сэргээлгэх хүсэлтийг анхан шатны шүүхэд нэн даруй гаргаагүй, 11 дүгээр сарын 29-ний өдөр гаргахдаа, хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн тухай шалтгаан болон түүнээ нотолсон баримтыг шүүхэд гаргаагүй, нэхэмжлэгчийн өмгөөлөгч нь хуулийг буруу тайлбарлан, үйлчлүүлэгчийн эрхийг ноцтой хохироож байгаа нь буруу, тэгээд ч өнөөдрийг хүртэл хугацаанд холбогдох баримтыг бүрдүүлж, хуульд нийцүүлэн шүүхэд хүсэлт гаргаагүй байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.2-т "Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч анхан шатны шүүхийн шийдвэрийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор аймаг, нийслэлийн шүүхэд давж заалдах гомдол гаргаж болно.", 120.3-т "Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч энэ хуулийн 120.2-т заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн бол хугацаа сэргээлгэх хүсэлтийг анхан шатны шүүхэд гаргах ба хүсэлтийг хангах эсэхийг шүүгч захирамж гарган шийдвэрлэнэ." гэж заасан байна.

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааны бүрэлдэхүүний олонхын саналаар шүүгчид сахилгын шийтгэлийг дараах үндэслэлээр ногдуулж байна. Үүнд шүүгч нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.4.-т "Зохигчийн эд хөрөнгийн болон бусад байдлыг харгалзан шүүхийн шийдвэрээр улсын тэмдэгтийн хураамж төлөх хэмжээг багасгах буюу хугацааг хойшлуулах, эсхүл хэсэгчлэн төлүүлж болно." гэж хуульд зааж шүүгчид эрх олгосон байхад шүүгч нэхэмжлэгчийн ар гэрийн байдал, нэхэмжлэгчээс хэрэгт өгсөн байсан баримтуудыг харьцуулан дүгнэж чадаагүй, гомдол гаргагчийн Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т заасан "шударга шүүхээр шүүлгэх эрх"-ийг нь зүй бусаар хязгаарлахад хүргэсэн.

Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлд заасан "хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, хууль дээдлэх" зарчмууд, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй" гэх заалтыг тус тус зөрчсөн гэж үзэв.

Мөн өмгөөлөгч Ж.С-г Ёс зүйн хороонд хандаж байгаатай нь холбогдуулж нэхэмжлэгч С.О-гийн үйлдэлд нөлөөллийн мэдүүлэг хөтлөх, мөн өмгөөлөгчийн мэргэжил үйл ажиллагаандаа тэнцэх эсэх талаар Хуульчийн мэргэжлийн хариуцлагын хороонд гомдол гаргахаар тайлбар гаргаж байгаа нь гомдол гаргагч нарын гомдол гаргах эрхэд хүндэтгэлтэй хандаагүй, шүүгч нь зохисгүй байдал гаргаж болохгүй бөгөөд бусдад ийнхүү ойлгогдохоос зайлсхийнэ гэсэн Монгол улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 2.3 дугаар зүйлийн 1-д заасныг зөрчсөн байна.

Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 12-т Монгол Улсын иргэн “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй” бөгөөд “Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй.”, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д “Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн гэж үзсэн иргэн, албан тушаалтан, хуулийн этгээд шүүгчид сахилгын хэрэг үүсгүүлэхээр Ёс зүйн хороонд гомдол гаргана” гэж заасан.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д заасан шүүгч “хүний эрхийг дээдлэх” чадвартай байх шаардлага, Шүүгчийн ёс зүйн дүрмийн 13 дугаар зүйлийн 1-д заасан “хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, хууль дээдлэх, аливаа асуудалд бодитой, төвийг сахисан байр сууринаас хандах, мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх зэрэг зарчмуудыг хувийн зан чанар болгож төлөвшүүлнэ” гэсэн зарчмуудыг тус тус зөрчсөн гэж П аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Ц-д Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1-д заасан сануулах сахилгын шийтгэл ногдуулахаар тогтов.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйл, 36 дугаар зүйлийн 36.1.1, 37 дугаар зүйлийн 37.1.1, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйл, Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.1, 5.13-т заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.П аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Ц-д сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Энэ магадлалын хувийг шүүгч болон гомдол гаргагчид хүргүүлэхийг Шүүхийн Ёс зүйн хорооны Ажлын албанд даалгасугай.

3.Шүүгч, гомдол гаргагч нар магадлалыг гардан авснаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.

ДАРГАЛАГЧ

Н.ЭРДЭНЭЦОГТ

ГИШҮҮН

Ч.ОЮУНЦЭЦЭГ



ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ
МАГАДЛАЛ

2018 оны 5 сарын 16 өдөр

Дугаар 221/ЁМ2018/0015

Улаанбаатар хот

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны
2018 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн
16 дугаар магадлалын тухай

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Батбаатар даргалж, шүүгч Ц.Цогт, шүүгч Э.Халиунбаяр нарын бүрэлдэхүүнтэй, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга М.Отгондэлгэр, гомдол гаргагчийн өмгөөлөгч Ж.С нарыг оролцуулан, Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 16 дугаар магадлалыг эс зөвшөөрч шүүгч Б.Ц-гийн гаргасан гомдлоор, С.О-гийн гомдолтой, П аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Ц-д холбогдох сахилгын хэргийг шүүгч Э.Халиунбаярын илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 16 дугаар магадлалаар: П аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Ц-д сануулах сахилгын шийтгэл ногдуулж шийдвэрлэжээ.

Шүүгч Б.Ц шүүхэд гаргасан гомдолдоо: “Шүүхийн Ёс зүйн хороо 16 дугаар магадлалдаа С.О-гийн гомдолд дурдсан бүх үндэслэлийг үгүйсгэсэн.

Тухайлбал Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, 57.4, 161 дүгээр зүйлийн 161.2, 162.4-д заасан хуулийн зохицуулалт зөрчигдөөгүй байх тул шүүгчийг санаатайгаар хууль хэрэглээний ноцтой, хариуцлагагүй алдаа гаргасан гэж үзэхгүй, Шүүгчийн 00326 дугаар захирамж хууль зөрчөөгүй, шүүгчийг Шүүгчийн ёс зүйн дүрмийн холбогдох заалтыг зөрчсөн гэж буруутгах боломжгүй

Өмгөөлөгч давж заалдах хугацаа сэргээлгэх хүсэлтийг анхан шатны шүүхэд нэн даруй гаргаагүй, хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн тухай шалтгаан болон түүнээ нотолсон баримтыг шүүхэд гаргаагүй, өнөөдрийг хүртэл хугацаанд энэ талаар хуульд нийцүүлэн хүсэлтээ гаргаагүй байна гэж дүгнэсэн атлаа Шүүхийн Ёс зүйн хороо өөрийн санаачилгаар ... “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.4-д “Зохигчийн эд хөрөнгийн болон бусад байдлыг харгалзан шүүхийн шийдвэрээр улсын тэмдэгтийн хураамж төлөх хэмжээг багасгах буюу хугацааг хойшлуулах эсхүл хэсэгчлэн төлүүлж болно” гэж хуульд зааж, шүүгчид эрх олгосон байхад шүүгч нэхэмжлэгчийн ар гэрийн байдал, нэхэмжлэгчээс өгсөн байсан баримтуудыг харьцуулан дүгнэж чадаагүй, гомдол гаргагчийн Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 4-д заасан “шударга шүүхээр шүүлгэх эрх”-ийг зүй бусаар хязгаарлахад хүргэсэн гэж дүгнэсэнд гомдолтой байна.

Учир нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа “тэгш эрхийн зарчим” дээр явагдах бөгөөд нэхэмжлэгч хүсэлт гаргаагүй байхад шүүх өөрийн санаачилгаар гомдол гаргахад төлөх тэмдэгтийн хураамжийн хэмжээг багасгах, хугацааг хойшлуулах, хэсэгчлэн төлүүлэх боломжгүй болохыг Шүүхийн Ёс зүйн хороо анхаараагүйд гомдолтой байна. Өөрөөр хэлбэл шүүгчийг санаачилгаараа “улсын тэмдэгтийн хураамж” төлөхөөс чөлөөлөхийг Шүүхийн Ёс зүйн хороо магадлалаараа шаардаж, буруу жишиг тогтоохыг хүсэж байна.

Мөн Шүүхийн Ёс зүйн хороо “өөрийн санаачилгаар” шүүгчид сахилгын шийтгэл ногдуулсан гэж үзэж байна. Учир нь гомдол гаргасан иргэний бүх үндэслэлийг “хүлээн авах боломжгүй” гэж дүгнэсэн. Гэсэн атлаа өөрийн санаачилгаараа Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдаанд шүүгч миний гаргасан тайлбарыг зөрчил гэж үзээд шийтгэл ногдуулсан. Зүйрлэж хэлбэл шүүгч танхайрах гэмт хэрэгтний шүүх хурлыг хийж байхад уг этгээд шүүх хурлын танхимд хулгай хийжээ. Гэтэл шүүх танхайрах гэмт хэргийг нь хэрэгсэхгүй болон атлаа хулгайн хэрэгт нь ял шийтгэсэнтэй адил явдал болжээ. Наад зах нь мөрдөгч нь мөрдөөд, прокурор нь яллаад, шүүхэд шилжүүлээд, шүүх хурлаа хийх ёстой. Гэтэл Шүүхийн Ёс зүйн хорооны хурал дээр хэлсэн тайлбар нь таалагдсангүй гэсэн утгаар шийтгэл ногдуулж байгаа нь үндэслэлгүй. Энэ нь Шүүхийн Ёс зүйн хороо зөрчлийг гомдлын хүрээнд, гомдлыг үндэслэн шалгах ёстой байхад түүнээс хэтэрч хальсан, нөгөө талаар гомдлыг хянан шалгах бүх дарааллаа зөрчсөн гэж үзэж байна.

Дүгнэж үзэхэд

1/ Гомдлын хүрээнээс хальсан

2/ Санаачилгаараа арга хэмжээ авсан

3/ Миний эрхийг эдлүүлээгүй Шүүхийн Ёс зүйн хороо журмынхаа дагуу гомдлыг шалгадаг байсан бол наад зах нь надад холбогдуулаад байгаа “иргэний гомдол гаргах эрхийг хүндэтгээгүй” гэсэн гомдлынхоо хувийг наад гардуулаад, би түүнд нь 14 хоногт тайлбар гаргаад, эхлээд сахилгын хэрэг үүсгэх эсэхээ шийдээд, түүнд нь гомдолтой этгээд нь гомдлоо гаргаад эцэст нь хурлаа товлоод, надад товоо мэдэгдэх ёстой байсан/

16 дугаар магадлалын бас нэг дүгнэлт: “Гомдол гаргагчийн эрхэд хүндэтгэлтэй хандаагүй” гэжээ. Гомдол гаргагч иргэн надаас үл хамаараад, гомдлоо гаргаад, түүнийг нь Ёс зүйн хороо шалгаад байгаа бус уу. Би өмгөөлөгч болон С.О-д хандаж гомдлоо битгий гарга гэж шаардаагүй, саад учруулаагүй, гуйсан ятгасан, эсхүл заналхийлсэн ямар ч үйлдэл гаргаагүй. Нөгөө талаар иргэний гаргасан гомдолд “Шүүхийн Ёс зүйн хороонд гомдол гаргахад саад учруулсан, миний эрхэд хүндэтгэлтэй хандаагүй гэсэн ямар ч үг өгүүлбэр байхгүй”. Энэ үүднээсээ байхгүй гомдол дээр Шүүхийн Ёс зүйн хороо арга хэмжээ авчээ.

Жич: Өмгөөлөгч Ж.С “орон нутгийн шүүх, шүүгчид хууль хэрэглээний анхан шатны мэдлэг чадвар сул байгаа нь харагдаж байна” гэж дурдсан. Хэрвээ намайг хэлээд шүүгч Б.Ц муу муухай гэсэн бол би юу ч хэлэхгүй. Гэтэл бүх 21 аймгийн анхан, давахыг хамруулаад эрүү, иргэн, захиргааны шүүхийн бүх шүүгчдийг оролцуулаад хавтгайд нь доромжилж байгаа нь зохисгүй юм. С.О “Тэмдэгтийн хураамжаас чөлөөлөхгүй бол Шүүхийн Ёс зүйн хороонд хандана” гэсэн нь шүүх, шүүгчид нөлөөлөх оролдлого байж болзошгүй тухай би Шүүхийн ёс зүйн хуралдаанд тайлбартаа л хэлсэн. Гэтэл Шүүхийн Ёс зүйн хороо тухайн иргэн хэзээний гомдол гаргаад хуульд заасны дагуу би гомдолд нь тайлбараа хэлж байхад түүнийг “гомдолд нь хүндэтгэлтэй хандсангүй” гэж үзсэн нь өөрөө эргэлзээтэй юм. Шүүхийн Ёс зүйн хорооны 16 дугаар магадлалыг хүчингүй болгож өгнө үү” гэжээ.

ХЯНАВАЛ:

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 16 дугаар магадлалыг шүүгч Б.Ц-гийн гомдлоор хянан хэлэлцээд, шүүгчийн гомдлыг хангаж шийдвэрлэх нь зүйтэй гэж үзлээ.

Шүүхийн Ёс зүйн хороонд С.О, түүний өмгөөлөгч Ж.С нар хандах болсон үндэслэлээ “П аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 151/ШШ2017/00979 дүгээр шийдвэрт 2017 оны 10 дугаар сарын 20-ны өдөр гомдол гаргасан, гэвч шүүгч бидний гомдлыг 2017 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 151/Ш32017/03326 дугаар захирамжаар давж заалдах гомдлыг хүлээн авахаас татгалзсан нь нэхэмжлэгчийн хуулиар олгогдсон эрх ашгийг хамгаалах, давж заалдах, хяналтын шатны шүүхэд гомдол гаргах эрхийг хязгаарласан. Тиймээс шүүгчийн мэргэжлийн ур чадвар, ёс зүйн зохих хэм хэмжээг зөрчсөн гэж шүүгч Б.Ц-д зохих журмын дагуу арга хэмжээ авч, хязгаарлагдсан эрх, хууль ёсны ашиг сонирхлыг минь сэргээж өгнө үү” гэж тодорхойлон гаргасан байна.

1.С.О-оос “PPP” ХХК, захирал М.Ц-д холбогдуулан гарсан нэхэмжлэлийг П аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Ц хүлээн авч, шүүгч Б.Ц, Л.М, А.Э нарын бүрэлдэхүүнтэйгээр хэргийг хэлэлцэж 2017 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 151/ШШ2017/00979 дүгээр шийдвэрийг гаргажээ. Дүрмийг зөрчсөн, эсхүл шүүгчийн хараат бус, зарчимч, төвийг сахих байдлыг алдагдуулсан аливаа үйлдэл, эс үйлдэхүйг” гэж заажээ.

Тиймээс “...өмгөөлөгч Ж.С-ийн үйлдэл, мөн “тэмдэгтийн хураамжаас чөлөөлөхгүй бол Ёс зүйн хороонд хандана гэсэн” нэхэмжлэгч С.О-гийн үйлдэлд нөлөөллийн мэдүүлэг хөтлөх, мөн өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаандаа тэнцэх эсэх талаар Хуульчийн мэргэжлийн хариуцлагын хороонд гомдол гаргана гэж бодож байна.” гэж шүүгч Б.Ц тайлбар гаргасныг Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1.9-д заасан шүүгч зохисгүй байдалд гаргасан гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Дээрх дүгнэлт болон Шүүхийн Ёс зүйн хорооны сахилгын хэрэгт цугласан нотлох баримтуудыг шинжлэн судлахад П аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Ц-д сануулах сахилгын шийтгэл ногдуулсан нь үндэслэлгүй байна.

Иймд Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалыг хүчингүй болгож, шүүгч Б.Ц-гийн гомдлыг хангаж шийдвэрлэв.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.2, 121 дүгээр зүйлийн 121.1.1 дэх заалтыг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 16 дугаар магадлалыг хүчингүй болгож, П аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Ц-д үүсгэсэн сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгосугай.

2.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.5 дахь хэсэгт зааснаар давж заалдах шатны шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн, хууль буруу хэрэглэсэн гэж нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нар үзвэл магадлалыг гардан авсан, эсхүл хүргүүлснээс хойш 14 хоногийн дотор Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ
ШҮҮГЧ
ШҮҮГЧ

Д.БАТБААТАР
Ц.ЦОГТ
Э.ХАЛИУНБАЯР



МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЁС ЗҮЙН ХОРООНЫ МАГАДЛАЛ

2018 оны 11 сарын 16 өдөр

Дугаар 90

Улаанбаатар хот

П Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн
шүүгч М.Ц-д сануулах сахилгын шийтгэл
ногдуулах тухай

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааныг дарга Н.Эрдэнэцогт даргалж, гишүүн В.Жавхлан, Ч.Оюунцэцэг, Д..Сүнжид, А.Доржготов нарын бүрэлдэхүүнтэй, хяналт шалгалт хариуцсан референт Б.Энхбаатар, хуралдааны тэмдэглэл хөтлөгчөөр шинжээч Ч.Ханддулам, шүүгч М.Ц, гомдол гаргагч "ССС" ХХК-ийн захирал Б.Б нарыг оролцуулан, Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдааны танхимд хийж, Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн 80 дугаар тогтоолоор шүүгч М.Ц-д үүсгэсэн сахилгын хэргийг Ёс зүйн хорооны гишүүн А.Доржготовын илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Шүүхийн Ёс зүйн хороонд "ССС" ХХК-ийн захирал Б.Б гаргасан гомдол болон хуралдаанд гаргасан тайлбартаа: "ССС" ХХК нь "Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх 125/2013 тоот зөвшөөрлийн 2016 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн хугацаа сунгалтыг хүчингүй болгуулах" шаардлага бүхий нэхэмжлэлийг 2017 оны 10 дугаар сарын 16-ны өдөр гаргасан.

П захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч М.Ц нь хүлээн авч хянаад Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54.1.5-д "нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан" зааснаар нэхэмжлэлийг хүлээн авахаас 2017 оны 10 сарын 26-ны өдрийн 128/Ш32017/6795 тоот шүүгчийн захирамжаар татгалзсан.

М.Ц шүүгчийн захирамжид гомдол гаргасан бөгөөд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн тогтоолоор манай гомдлыг хангаж, П захиргааны хэргийн анхан шатны шүүхийн М.Ц шүүгчийн захирамжийг хүчингүй болгож шийдвэрлэсэн.

Гэвч М.Ц шүүгч нь 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 128/11132017/8122 тоот захирамжаар Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54-р зүйлийн 54.1.5, 54.1.6-д заасан үндэслэлээр дахин татгалзаж шийдвэрлэсэн.

П захиргааны хэргийн анхан шатны шүүхийн М.Ц шүүгчийн захирамжид дахин гомдол гаргасан. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн тогтоолоор манай гомдлыг дахин хангаж, П захиргааны хэргийн анхан шатны шүүхийн М.Ц шүүгчийн захирамжийг мөн хүчингүй болгосон.

Гэвч дахин М.Ц шүүгч нь 2018 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 128/Ш32018/0590 тоот захирамжаар Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх

тухай хуулийн 54.1.8-д заасан үндэслэлээр татгалзаж шийдвэрлэсэн. Гэвч Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн шүүх хуралдаанд хөөн хэлэлцэх хугацааны талаар хэлэлцэгдсэн байтал /шүүх хуралдааны тэмдэглэлийг хавсаргав./ хөөн хэлэлцэх хугацаа хэтэрсэн гэж татгалзсан нь үндэслэлгүй юм.

Ийм учраас М.Ц шүүгчийн захирамжид дахин гомдол гаргасан. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 221/ШТ2018/0101 тоот тогтоолоор манай гомдлыг дахин хангаж, захиргааны хэргийн анхан шатны шүүхийн М.Ц шүүгчийн захирамжийг дахин хүчингүй болгосон.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн тогтоол нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.7 дахь хэсэгт зааснаар "тогтоол нь эцсийн шийдвэр байна" гэж заасаар байтал Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54-р зүйлийн 54.1.5-д зааснаар 2 удаа, 54.1.6-д зааснаар 1 удаа, 54.1.8-д зааснаар 1 удаа нийт 3 удаа үндэслэлгүйгээр татгалзаж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 14-д заасан баталгаатай эдлэхээр олгогдсон шударга шүүхээр шүүлгэх эрхэд минь халдсан үйлдэл болж байна.

Энэ тухай Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 02 дүгээр сарын 14-ний өдрийн 221/ШТ2018/0101 тоот тогтоолын хянавал хэсэгт:

...Мөн "ССС" ХХК-аас "ТТТ" сургуулийн өргөтгөлийн барилгатай холбогдуулан тасралтгүй гомдол, нэхэмжлэл гаргаж байсан нь бодит факт бөгөөд энэ тохиолдолд нэхэмжлэгчийн нэхэмжлэл гаргах эрхийг шүүгчийн захирамжид заасан үндэслэлээр хугацаагаар хязгаарлах нь зохимжгүй.

Иймд анхан шатны шүүх тус компанийн гаргасан нэхэмжлэлээр захиргааны хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэхдээ хуульд заасан үндэслэлээр татгалзахыг урьтал болгохоос илүүтэйгээр өмнө гарсан Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн удаа дараагийн хуулийн хучин төгөлдөр тогтоол, түүнд дурдсан үндэслэл болон Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зорилт зэргийг харгалзан үзвэл зохино" гэжээ.

ССС ХХК нь 2017 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс хойш өнөөдрийг хүртэл 140 хоног нэхэмжлэлээ шийдвэрлүүлж чадахгүй байна.

П захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч М.Ц нь манай нэхэмжлэлийг хуулийн хүрээнд шийдвэрлэхгүй үндэслэлгүйгээр удаа дараалан буцааж байгаа нь манай компанийн эрх ашгийг асар ихээр хохироож байгаагаас гадна Шүүгчийн ёс зүйн дүрмийн 2.3.1. Шүүгч нь зохисгүй байдал гаргаж болохгүй бөгөөд бусдад ийнхүү ойлгогдохоос зайлсхийнэ, 3.1.2. Шүүгч хэргийн оролцогч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдтэй хувийн харилцаа тогтоох, шууд болон шууд бусаар тусламж авах, хувьдаа ашиг олох, төлбөргүй буюу хөнгөлөлттэйгөөр үйлчлүүлэх зэрэг хууль бус хангамж эдлэх зэргээр албан тушаалын нэр хүндийг ашиглан ямар нэгэн давуу байдал бий болгохыг хориглоно, 3.3.1. Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй. 3.3.2. Хэргийн оролцогчдын зүгээс шүүгчийг татгалзахад хүргэх нөхцөл байдлыг өөрийн үг яриа, үйлдлээр бий болгохоос урьдчилан сэргийлж, зайлсхийнэ. Хуульчийн мэргэжлийн уйл ажиллагаанд баримтлах дүрмийн: 1.9. "зохисгүй байдал" гэж хууль, хянан шийдвэрлэх ажиллагааны хэм хэмжээ, энэ дүрмийг зөрчсөн, эсхүл шүүгчийн хараат бус, зарчимч, төвийг сахих байдлыг алдагдуулсан аливаа үйлдэл, эс үйлдэхгүйг хэлнэ гэсэн заалтуудаас гадна Хуульчийн эрх

зүйн байдлын тухай хуулийн 25, 26, 27-р зүйлд заасан заалтуудыг зөрчиж байна.

Иймд П захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч М.Ц нь манай компанийн гаргасан нэхэмжлэлийг үндэслэлгүйгээр удаа дараалан татгалзаж байгаа нь албан тушаалдаа ашиг сонирхлоор хандаж байна гэж үзэж болохоор байгаа тул гомдол гаргаж байгааг хүлээн авч, хариуцлага тооцож өгнө үү.

Шүүгч М.Ц-д хариуцлага тооцож өгнө үү гэв.

Шүүхийн Ёс зүйн хороонд шүүгч М.Ц ирүүлсэн тайлбар болон хуралдаанд гаргасан тайлбартаа: Шүүгч М.Ц би нэхэмжлэгч "ССС" ХХК-ийн захирал Б.Б-гийн гаргасан гомдлыг хүлээн авч танилцаад доорх тайлбарыг гаргаж байна.

"ССС" ХХК-ийн захирал Б.Б-ээс "...шүүгч М.Ц нь манай нэхэмжлэлийг хуулийн хүрээнд шийдвэрлэхгүй, үндэслэлгүйгээр удаа дараалан буцааж байгаа нь манай компанийн эрх ашгийг асар ихээр хохироож, албан тушаалдаа ашиг сонирхлоор хандаж байна" гэх гомдлыг гаргажээ.

Анх "ССС" ХХК-аас Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газарт холбогдуулан ТТТ сургуульд олгосон Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх 125/2013 дугаар зөвшөөрлийн хугацааг 2016 оны 3 дугаар сарын 22-ны өдөр сунгасныг хүчингүй болгуулах" шаардлага бүхий нэхэмжлэл гаргасныг хүлээн авч нэхэмжлэл, түүнд хавсаргасан баримтууд болон өмнө нь нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан бусад материалуудыг хянан үзээд:

П захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2017 оны 10 дугаар сарын 26-ний өдрийн 128/Ш32017/6795 дугаар захирамжаар "ССС" ХХК нь ТТТ сургуулийн Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх 125/2013 дугаар зөвшөөрлийн хугацааг 2016 оны 3 дугаар сарын 22-ны өдөр сунгасан үйлдэлтэй холбогдуулан маргах эрхгүй" гэсэн үндэслэлээр Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.5-д "...нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан" гэж зааснаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан.

-Тус компаниас дахин нэхэмжлэл гаргасныг мөн шүүхийн шүүгчийн 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 128/Ш32017/8122 дугаар захирамжаар "Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх 125/2013 дугаар зөвшөөрлийн үйлчлэл дуусгавар болж, дараа нь ТТТ сургуулийн өргөтгөлийн барилгыг хүлээн авсан Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2016 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 2016/340 дүгээр актын талаар нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд гэж дүгнэсэн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн хүчин төгөлдөр шүүхийн тогтоолууд (шүүхийн 2017-01-02-ны 32, 2017-04-06-ны 250 дугаар тогтоолыг хавсаргав) байх тул Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийн хугацааг 2016 оны 03 дугаар сарын 22-ны өдөр сунгасан үйлдлээс болж одоо "ССС" ХХК-д үр дагавар үүсэх нөхцөл байдал байхгүй" гэсэн үндэслэлүүдээр Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.5, 54.1.6 дахь заалтуудад зааснаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан.

Мөн шүүгчийн 2018 оны 01 сарын 24-ний өдрийн 128/Ш32018/0590 дүгээр захирамжаар ТТТ сургуулийн Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх 125/2013 дугаар зөвшөөрлийн хугацааг 2016 оны 03 дугаар сарын 22-ны өдөр сунгасан үйлдэлтэй холбогдуулан нэхэмжлэл гаргах хөөн хэлэлцэх хугацааг хэтрүүлсэн" гэсэн үндэслэлээр Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.8-д "энэ хуулийн 14.1 -14.4-т заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хэтрүүлсэн" гэж заасны дагуу нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.1-54.1.8 дахь заалтуудад нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэлүүдийг тодорхойлсон бөгөөд хэрэв үндэслэлтэй гэж үзвэл хэд хэдэн үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах боломжтой болно. Хэдийгээр "ССС" ХХК-ийн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шалтгаан, үндэслэл, дүгнэлтүүд өөр өөр бөгөөд нэг үндэслэлээр хэд хэдэн удаа татгалзсан зүйл байхгүй.

Шүүгч нь нэхэмжлэл, түүнд хавсаргасан баримтуудыг тал бүрээс нь харьцуулан үзсэний үндсэн дээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах хуульд заасан үндэслэл байгаа эсэхийг нэг бүрчлэн шалган, захиргааны хэрэг үүсгэх эсэх асуудлыг шийдвэрлэдэг.

Ер нь тухайн асуудлыг шүүх хэрхэн үзэж байгааг шүүгчийн өөрийн дотоод итгэлд үндэслэн шийдвэрлэдэг. Шүүгчийн энэхүү үндэслэл бүхий дотоод итгэлийг хэн ч буруутгах үндэслэлгүй юм.

Харин нэхэмжлэл гаргагч нь анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжийг үндэслэлгүй гэж үзвэл эс зөвшөөрч Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1-д заасны дагуу гомдол гаргах эрхтэй бөгөөд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх нь анхан шатны шүүхийн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг үндэслэлтэй эсэхийг хянан үзэж, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан алдаа, зөрчлийг илрүүлж засуулах, захиргааны процессын хуулиар тогтоосон журмыг нэг мөр ойлгож, хэрэглэх талаар шүүхийн тогтоол гаргах бөгөөд энэхүү тогтоол нь эцсийн шийдвэр болдог.

Иймээс шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах эрх хэмжээнийхээ хүрээнд нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэснийг ёс зүйн зөрчил гэж үзэхгүй бөгөөд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө түүнийг ёс зүйн зөрчилд холбогдуулан буруутгах үндэслэл байхгүй юм.

Тухайлбал, Монгол Улсын Шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1-д "Шүүгч хуульд тусгайлан ёс зүйн зөрчил болохоор заасан болон энэ дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг ёс зүйн зөрчил гэж үзнэ", 2-т "Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй" гэж зааснаас үзэхэд "ССС" ХХК-ийн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой байх тул шүүгчийн ёс зүйн зөрчилд хамааралгүй байна.

"ССС" ХХК-ийн эрх ашгийг асар ихээр хохироож, албан тушаалдаа ашиг сонирхлоор хандаж байна гэх гомдол нь үндэслэлгүй бөгөөд бусад тайлбарыг хуралдаанд биечлэн оролцож гаргах боломжоор хангаж өгөхийг хүсье.

Иймд дээр тайлбарласанчлан шүүгч би нэхэмжлэл хянан шийдвэрлэх ажиллагааг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нийцүүлэн хэрэгжүүлж ажилласан бөгөөд хуульд ёс зүйн зөрчил болохоор тусгайлан заасан болон шүүгчийн ёс зүйн дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүй гаргаагүй ба Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 2.3 дугаар зүйлийн 1, 3.1 дүгээр зүйлийн 2, 3.3 дугаар зүйлийн 1, 2, мөн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 25, 26, 27 дугаар зүйлүүдийн заалтуудыг тус тус зөрчөөгүй байх тул "ССС" ХХК-ийн захирал Б.Б-гийн гомдлыг хэрэгсэхгүй болгож өгнө үү.

Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 80 дугаар тогтоолыг эс зөвшөөрч гаргасан тайлбараа дэмжиж байгаа тул сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү гэв.

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанаар сахилгын хэргийг хэлэлцээд ҮНДЭСЛЭХ нь:

Шүүхийн Ёс зүйн хороонд "ССС" ХХК-ийн захирал Б.Б нь шүүгч М.Ц-д холбогдуулан гомдол гаргажээ.

Шүүхийн Ёс зүйн хороо гомдол гаргагчийн гомдлын үндэслэлд: "ССС" ХХК нь "Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх 125/2013 тоот зөвшөөрлийн 2016 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн хугацаа сунгалтыг хүчингүй болгуулах" шаардлага бүхий нэхэмжлэлийг 2017 оны 10 дугаар сарын 16-ны өдөр гаргасан байна. П захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2017 оны 10 дугаар сарын 26-ний өдрийн 128/ШЗ2017/6795 дугаар захирамжаар Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.5-д "...нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан" гэж зааснаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан байна. Тус компаниас дахин нэхэмжлэл гаргасныг мөн шүүхийн шүүгчийн 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 128/ШЗ2017/8122 дугаар захирамжаар Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.5, 54.1.6 дахь заалтуудад зааснаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан байна. Мөн шүүгчийн 2018 оны 01 сарын 24 өдрийн 128/ШЗ2018/0590 дүгээр захирамжаар ТТТ сургуулийн Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх 125/2013 дугаар зөвшөөрлийн хугацааг 2016 оны 03 дугаар сарын 22-ны өдөр сунгасан үйлдэлтэй холбогдуулан нэхэмжлэл гаргах хөөн хэлэлцэх хугацааг хэтрүүлсэн" гэсэн үндэслэлээр Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.8-д заасны дагуу дахин нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан тухай дурджээ.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх нийт 3 удаа үндэслэлгүйгээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан талаар дүгнэлт хийж, шүүгчийн захирамжийг хүчингүй болгож шийдвэрлэсэн байна.

Шүүхийн Ёс зүйн хороо шүүгч нь хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, хууль дээдлэх, хуульд захирагдах зарчмыг баримталж, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг алдагдуулсан гэж үзэж "ССС" ХХК-ийн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шүүгч М.Ц-гийн захирамжийн шалтгаан, үндэслэл, дүгнэлтүүд өөр өөр боловч Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.1-54.1.8 дахь "нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл"-ийг нэг мөр хэрэглээгүй нь Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1-д заасан зарчмуудыг хувийн зан чанар болгож төлөвшүүлээгүй, 2.3 дугаар зүйлийн 1-д заасныг зөрчсөн /Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1.9-д тодорхойлсон утгаар/ үйлдэл гаргасан гэж дүгнэж, Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 80 дугаар тогтоолоор П захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч М.Ц-д сахилгын хэрэг үүсгэсэн нь үндэслэлтэй гэж үзэв.

Иймд П Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч М.Ц-д сахилгын шийтгэл ногдуулах нь зүйтэй гэж нийт гишүүдийн хуралдааны бүрэлдэхүүн дүгнэв.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1, 36 дугаар зүйлийн 36.1.1, 37 дугаар зүйлийн 37.1.1, Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5.7.1, 5.13, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйлийг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.П дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч М.Ц-д сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Энэ магадлалын хувийг шүүгч болон гомдол гаргагчид хүргүүлэхийг тус хорооны Ажлын албанд даалгасугай.

3.Магадлалыг эс зөвшөөрвөл гардан авснаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.

ДАРГАЛАГЧ

Н.ЭРДЭНЭЦОГТ

ГИШҮҮН

А.ДОРЖГОТОВ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ
МАГАДЛАЛ

2019 оны 02 сарын 21 өдөр

Дугаар 221/ЁМ2019/0010

Улаанбаатар хот

П Захиргааны хэргийн анхан шатны
шүүхийн шүүгч М.Ц-д сануулах сахилгын
шийтгэл ногдуулсан Шүүхийн Ёс зүйн
хорооны магадлалын тухай

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Батбаатар даргалж, шүүгч Э.Зоригтбаатар, шүүгч С.Мөнхжаргал нарын бүрэлдэхүүнтэй, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Б.Адилмаа, гомдол гаргагч Б.Б нарыг оролцуулан хийж, Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 90 дүгээр магадлалыг эс зөвшөөрч, шүүгч М.Ц-гийн гаргасан гомдлоор, П дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч М.Ц-д холбогдох сахилгын хэргийг шүүгч С.Мөнхжаргалын илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 90 дүгээр магадлалаар: Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1, 36 дугаар зүйлийн 36.1.1, 37 дугаар зүйлийн 37.1.1, Шүүгчийн Ёс зүйн хорооны дүрмийн 5.7.1, 5.13, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйлийг удирдлага болгон П Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч М.Ц-д сануулах сахилгын шийтгэл ногдуулжээ.

Шүүгч М.Ц давж заалдах гомдолдоо: "... Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааны 2018 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 90 дүгээр магадлалаар "нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл"-ийг нэг мөр хэрэглээгүй нь Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1-д заасан зарчмуудыг хувийн зан чанар болгож төлөвшүүлээгүй, 2.3 дугаар зүйлийн 1-д заасныг зөрчсөн (Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1.9-д тодорхойлсон утгаар) үйлдэл гэж дүгнэж, сануулах сахилгын шийтгэл ногдуулсныг дараах үндэслэлээр эс зөвшөөрч байна.

Шүүгч нэхэмжлэлийг хүлээн авч захиргааны хэрэг үүсгэх эсэх асуудлыг өөрийн дотоод итгэлд үндэслэн тухайн асуудлыг шүүх хэрхэн үзэж байгааг шийдвэрлэдэг бөгөөд шүүгчийн өөрийнх нь энэхүү үндэслэл бүхий дүгнэлт, дотоод итгэлийг хэн ч буруутгах боломжгүй юм.

Шүүхийн Ёс зүйн хороо нь Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1-д заасан зарчим, 2.3 дугаар зүйлийн 1-д заасан (Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1.9-д тодорхойлсон утга) болон дүрмээр тогтоосон ёс зүйн зөрчилд тооцогдох хэм хэмжээг буруу тайлбарлан хэрэглэж "сануулах сахилгын шийтгэл ногдуулсан" нь үндэслэлгүй, хууль бус үзэж байна.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай 54 дүгээр зүйлийн 54.1-д нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэлүүдийг тодорхойлсон бөгөөд

хуульд нэг үндэслэлээр удаа дараа нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах боломжгүй бөгөөд харин өөр өөр үндэслэл байвал хэдэн ч удаа нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах боломжтой, хориглоогүй болно.

“ССС” ХХК-ийн гаргасан нэхэмжлэлийн хувьд 54.1.1-,51.1.4-д заасан “татгалзах” үндэслэл байгаагүй, харин 54.1.5 “нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан”, 54.1.6 “нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан хуулийн хүчин төгөлдөр шүүгчийн захирамж байгаа”, 54.1.8 “нэхэмжлэл гаргах хөөн хэлэлцэх хугацааг хэтрүүлсэн” гэсэн өөр өөр үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан. (татгалзсан үндэслэлийн талаар өмнө нь тодорхой тайлбарласан)

Дээрх хуулийн 54.1.1-54.1.8 дахь заалтуудыг хэрэглэж нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзахдаа нэг мөр хамтад нь хэрэглэж болох заалт ч байна, мөн хамтад нь давхар баримталж дүгнэлт хийх боломжгүй заалтууд ч байдаг. Хэрвээ хамт хэрэглэх боломжгүй заалтуудыг хамт давхар хэрэглэвэл энэ нь өөрөө утга агуулгагүй, логикийн хувьд зөрчилтэй болно.

Учир нь нэгэнт шүүхэд 54.1.5-д заасан “нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан” гэх үндэслэл тогтоогдсон тохиолдолд 54.1.6-54.1.8-д заасан бусад нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэлүүдийг шалгах шаардлагагүй, энэ талаар давхар дүгнэлт хийх нь логикийн хувьд зөрчилтэй болно. Өөрөөр хэлбэл тухайн нэхэмжлэгчийн хувьд 54.1.5-д заасан “нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд” нэхэмжлэл гаргасан гэх үндэслэлээр татгалзах тохиолдолд бусад үндэслэл буюу урьдчилан шийдвэрлэх ажиллагаа, хөөн хэлэлцэх хугацаа хэтрүүлсэн эсэх зэрэгт дүгнэлт хийж, хуулийн заалтыг давхар (54.1.3, 54.1.8) баримтлах, хэрэглэх хууль зүйн боломжгүй байсан. “ССС” ХХК-ийн дахин гаргасан нэхэмжлэлийг өөр өөр үндэслэлээр дүгнэж татгалзсан болно.

Шүүгчийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө түүнийг буруутган, ёс зүйн зөрчил гаргасан гэж дүгнэж сахилгын хэрэг үүсгэн, сахилгын шийтгэл ногдуулж байгаа нь Монгол Улсын Шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1-д “Шүүгч хуульд тусгайлан ёс зүйн зөрчил болохоор заасан болон энэ дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг ёс зүйн зөрчил гэж үзнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд миний хувьд хууль болон дүрэмд ямар нэгэн ёс зүйн зөрчил болохоор заасан зөрчил гаргаагүй, мөн “Монгол Улсын Шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм”-ээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг гаргаагүй тул “сануулах сахилгын шийтгэл ногдуулсан” Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааны 2018 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 90 дүгээр магадлалыг хүчингүй болгож, “ССС” ХХК-ийн захирал Б.Б-гийн гомдлоор үүсгэсэн сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү” гэжээ.

ХЯНАВАЛ:

Дараах үндэслэлээр Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалыг хүчингүй болгож, шүүгч М.Ц-д үүсгэсэн сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгов.

Иргэн Б.Б-ээс Шүүхийн Ёс зүйн хороонд шүүгч М.Ц-гийн “ССС” ХХК-ийн нэхэмжлэлийг 3 удаа үндэслэлгүйгээр хүлээн авахаас татгалзсан” үйлдлийг Шүүгчийн ёс зүйн дүрэм, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийг зөрчсөн гэж үзэж гомдол гаргасныг тус хороо хүлээн авч 2018 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 80 дугаар тогтоолоор шүүгч М.Ц-д холбогдуулан сахилгын хэрэг үүсгэсэн байна.

Шүүхийн Ёс зүйн хороо “... “нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэлийг нэг мөр хэрэглээгүй” нь Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн

1 -д заасан зарчмуудыг хувийн зан чанар болгож төлөвшүүлээгүй, 2.3 дугаар зүйлийн 1-д заасныг зөрчсөн үйлдэл” гэх үндэслэлээр шүүгч М.Ц-д сахилгын хэрэг үүсгэж, сануулах сахилгын шийтгэл ногдуулсан нь үндэслэлгүй болжээ.

Учир нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1 -д заасан нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах 8 үндэслэлийг нэг мөр хэрэглэх боломжгүй.

Тухайлбал шүүгч нэхэмжлэлийг 54.1.1-д заасан “захиргааны хэргийн шүүхийн харьяаллын бус” гэж үзсэн бол дараах 7 үндэслэлийг нэг мөр хэрэглэх боломжгүй, хожим нь тухайн нэхэмжлэлийг харьяалан шийдвэрлэх шүүх, бусад байгууллагаар шийдвэрлүүлэх боломжийг хязгаарлахад хүргэнэ.

Шүүгч М.Ц нь “ССС” ХХК-ийн гаргасан нэг нэхэмжлэлийг 3 удаа хүлээн авахаас татгалзсан захирамжийг дээрх хуулийн 54.1-д заасан өөр өөр үндэслэлээр гаргасан бөгөөд давж заалдах шатны шүүхээс тухай бүр хянаж захирамжийг хүчингүй болгосон нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан мэргэжил, дадлага, туршлагатай холбоотой алдаа гэж үзэхээр байна.

Иймд Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 2-т “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй” гэж заасны дагуу шүүгч М.Ц-г ёс зүйн зөрчил гаргасан гэж үзэхгүй.

Энэ талаарх шүүгч М.Ц-гийн гомдол үндэслэлтэй байх тул Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 90 дүгээр магадлалыг хүчингүй болгож, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн үзлээ.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 114.7, 121 дүгээр зүйлийн 121.1.3-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 90 дүгээр магадлалыг хүчингүй болгож, шүүгч М.Ц-д холбогдуулан үүсгэсэн сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгосугай.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.5 дахь хэсэгт зааснаар давж заалдах шатны шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийг буруу хэрэглэсэн, шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн нь шүүхийн шийдвэр гарахад нөлөөлсөн гэж хэргийн оролцогч болон өмгөөлөгч нар үзвэл магадлалыг гардан авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.БАТБААТАР

ШҮҮГЧ

Э.ЗОРИГТБААТАР

ШҮҮГЧ

С.МӨНХЖАРГАЛ



МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЁС ЗҮЙН ХОРООНЫ МАГАДЛАЛ

2018 оны 1 сарын 26 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Ш дүүргийн Иргэний хэргийн анхан
шатны шүүхийн шүүгч О.О-д сахилгын
шийтгэл ногдуулах тухай

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааныг тус хорооны дарга Н.Эрдэнэцогт даргалж, гишүүн А.Доржготов, Н.Ганбаяр, О.Мөнхсайхан, Ч.Оюунцэцэг нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны тэмдэглэл хөтлөгчөөр шинжээч А.Энхбаатар, референт Ж.Халиун, гомдол гаргагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Н.М, шүүгч О.О нарыг оролцуулан Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдааны танхимд хийв. Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 163 дугаар тогтоолыг Шүүхийн Ёс зүйн хорооны гишүүн Ч.Оюунцэцэгийн илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Иргэн Д.Б Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан гомдолдоо: "... Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч О.О нь Я.Э-гийн нэхэмжлэлтэй "ООО" ХХК-д холбогдох иргэний хэрэгт нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хүсэлтийг үндэслэн "ООО" ХХК-ийн захирал Д.Б-д шүүхийн мэдэгдэх хуудсыг 2017.07.24-ний өдөр хүргүүлсэн боловч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр авахаас татгалзсан, улмаар шүүхийг үл хүндэтгэсэн үйлдэл гаргаж мэдэгдэх хуудсыг шүүхийн захиргааны ажилтны өмнө шидэх зэрэг үйлдэл гаргасан учраас хариуцагчийг албадан ирүүлэх, хариуцагч шүүхийг үл хүндэтгэж дуудсан цагт хүрэлцэн ирэхээс татгалзаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулж байна гэж гадаадад хувийн хэргээр зорчихгүй байхыг даалгаж 300.000 төгрөгөөр торгохоор 2017.08.01 -ний өдөр шийдвэрлэж шүүгчийн захирамж гаргажээ.

Анхан шатны шүүхээс 2017.07.24-ний өдөр хариуцагч байгууллагын удирдлагад шүүхийн мэдэгдэх хуудсыг гардуулсан гэж үзэх үндэслэлгүй бөгөөд иргэний хэрэг үүсгэсний дараа шүүхээс нэхэмжлэгчийн хариуцагчийг тодорхойлсон бүхий л хаягууд руу шүүхийн мэдэгдэх хуудсыг хүргүүлсэн боловч эзэндээ гардуулагдаагүй буцаж ирсэн. 2017.07.24-ний өдрийн 16.00 цагийн орчим Монгол улсын иргэн Д.Б намайг Т дүүргийн нутаг дэвсгэрт автомашинтай зорчиж байхад хэн нь үл мэдэгдэх хүмүүс нэхэмжлэлийн хувийг гардуулна гарын үсгээ зур гэж зүй бус авирлахад нь миний зүгээс энэхүү хууль бус шаардлагыг эсэргүүцэж тус шүүхийн шүүгчийн туслах Б.Ч, тамгын газрын бичиг хүргэгч Б.Б нарын хууль бус үйл ажиллагааны талаар холбогдох байгууллагад гомдол гаргасан.

Шүүгч О.О нь туслахдаа даалгавар өгч /хэргийн оролцогчтой хамтарсан байж болзошгүй/ Д.Б-г тухайн өдөр Т дүүргийн нутаг дэвсгэрт байгааг ямар арга замаар мэдэж туслах Б.Ч-г бичиг хүргэгч Б.Б-ийн хамт Ш дүүргийн иргэний

хэргийн анхан шатны шүүхэд ажилладаггүй шүүгч Д.Д-гийн гарын үсэгтэй шүүгчийн туслах н.А-гийн нэртэй 2017.07.24-ний өдөр гэсэн огноотой шүүхэд дуудан ирүүлэх тухай шүүхийн мэдэгдэх хуудсаар гудамжинд хууль бусаар шүүхийн үйлчилгээ үзүүлэхээр явуулсан нь гэмт хэргийн шинжтэй үйлдэл эсэх, гүйцэтгэх ажлын хууль тогтоомж зөрчиж хүнийг тагнаж, чагнасан, мөрдөж мөшгөсөн байж болзошгүй хууль бус ажиллагааг явуулаад зогсохгүй энэхүү хууль бус ажиллагааг үндэслэж Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.9-т заасны дагуу шүүхийн мэдэгдэх хуудсыг хүлээн аваагүй этгээдийг шүүхэд албадан ирүүлэхээр захирамж гаргаж байгаа нь учир дутагдалтай болжээ. Шүүгч О.О-гийн зүгээс шүүхийн захиргааны ажилтнуудад даалгавар өгч шүүхийн үйлчилгээг гудамжинд явуулахыг үүрэгдсэн үйлдэл нь шүүгчийн ёс зүйн дүрэм болоод хуулийг хэлбэрэлтгүй сахих тангаргаа зөрчсөн эсэхийг шалгуулахыг хүсэж байгаа төдийгүй шүүхийн зүгээс мэдэгдэх хуудсыг хариуцагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр авахаас татгалзсан, шүүхийг үл хүндэтгэсэн үйлдэл гаргасан гэж үзэж хариуцагчийг албадан ирүүлэхээр шийдвэрлэсэн нь үндэслэлгүй болсон гэж үзэж байгаа төдийгүй хариуцагч байгууллагын албан ёсны хаягийн лавлагаа эрх бүхий байгууллагаас 2017.08.02-ны өдөр ирсэн атал өөр иргэний хэрэгт ирүүлсэн лавлагааг үндэслэж 2017.08.01 -ний өдөр шүүгч захирамж гаргаж байгаа нь анхаарал татаж байгаа төдийгүй нэхэмжлэгчээс хариуцагчийн тодорхойлсон хаягт хамааралгүй, ямар байдлаар хаяг тогтоосон эсэх нь тодорхойгүй Д.Б-гийн түр оршин суугаа гэх Т дүүргийн ... хороо, гудамж, ... тоот хаягаас албадан ирүүлэхээр захирамж гаргаж байгаа нь /энэ хаягийг яаж, хэнээс олсон нь тодорхойгүй/ шүүгч шийдвэрийг хуульд заасны дагуу гаргасан гэж үзэх боломжгүй болгож байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 18 дахь хэсэгт заасан "... улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно" заалтыг зөрчиж иргэний хэргийн шүүх Д.Б-д улсын хилээр гарахгүй байхыг даалгаж, шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлэх эрхгүй бөгөөд шүүх процесс ажиллагааны хувьд хүний эрхэд хууль зүйн үндэслэлгүйгээр халдсан ноцтой зөрчил гаргасан гэж үзэхийн сацуу шүүгч О.О нь ийм шийдвэр гаргах эрх шүүгчид хуулиар олгогдоогүй байхад эрх мэдлээ хэтрүүлсэн үйлдлийг бас шалгуулахыг хүсэж байна. Шүүгч О.О-гийн зүгээс 2017.08.01-ний өдөр гаргасан захирамжаа Хил хамгаалах байгууллагад яаралтай хүргүүлж улмаар тус байгууллагын ажилтан, хошууч Ч.М уруу удаа дараа утсаар залгаж субъектив ашиг сонирхлын үүднээс Д.Б-д хилийн хорио яаралтай тавь, зугтаах гэж байна, Та нартай ярина шүү гэх мэтээр шүүгч ёс зүйгээ зөрчиж бусад этгээдийг дарамталсан байж болзошгүй үйлдлийн талаар ч хошууч Ч.М манай өмгөөлөгч Н.М-д мэдэгдсэн бөгөөд шүүгчийн захирамжид Хил хамгаалах байгууллагад Д.Б-д улсын хил нэвтрэх хориг тавьсан заалт байхгүй байхад шүүгчийн зүгээс захирамжийг Хил хамгаалах байгууллагад хүргүүлж эрх мэдлээ хэтрүүлэн хувийн ашиг сонирхлын үүднээс ёс зүйгээ зөрчсөн үйлдэл гаргасан гэж миний хувьд дүгнэж байна.

Иймд шүүгч О.О нь шүүгчийн захирамж гаргах нэрийдлээр эрх мэдлээ хэтрүүлж хүний эрх, эрх чөлөөнд ноцтой байдлаар халдсан, шүүхийн захиргааны ажилтнуудад хууль бус даалгавар өгч хууль бус ажиллагааг явуулсан, Хил хамгаалах байгууллагын албан хаагчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлсөн зэрэг шүүгчийн ёс зүйн дүрмийг ноцтойгоор зөрчсөн

үйлдлүүдийг удаа дараа гаргасан тул шүүгч О.О-гийн дээрх үйлдлүүдийг хянан үзэж, сахилгын хэрэг үүсгэж Ш дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч О.О-г шүүгчийн албан тушаалаас огцруулах шийдвэр гаргаж өгнө үү" гэжээ.

Шүүгч О.О Шүүхийн Ёс зүйн хороонд ирүүлсэн тайлбартаа: "...Я.Э-гийн нэхэмжлэлтэй "ООО" ХХК-д холбогдох үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгчөөр тогтоолгох тухай нэхэмжлэлийг тус шүүх 2017.07.05-ны өдөр хүлээн авч, 2017.07.06-ны өдөр хэрэг үүсгэсэн. Нэхэмжлэлд дурдсан Ф дүүрэг, ... дугаар хороо ... дугаар хороолол, ... тоот хаягаар шүүхийн мэдэгдэх хуудсыг Монгол шуудан компаниар дамжуулан явуулсан. Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс хариуцагч компанийг төлөөлөх эрх бүхий этгээд болох Д.Б Ч улсад амьдардаг шалтгаанаар байнга хилээр орж гардаг. Урьд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд удаа дараа саад учруулж байсан, уг маргаан 2008 оноос хойш явагдаж байгаа гэсэн үндэслэлүүдийг дурдаад шүүхийн мэдэгдэх хуудас болон нэхэмжлэлийг гардуулж өгөхийг хүссэн хүсэлтийг нэхэмжлэгч болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс 2017.07.05-нд, 2017.07.16-нд тус тус ирүүлсэн. Хавсаргаж ирүүлсэн "Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах тухай" Ф дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 101/Ш32017/29056 дугаар шүүгчийн захирамжид хариуцагч компани Ф дүүрэг, ... дугаар хороо, ... хороолол, ... хаягт үйл ажиллагаа явуулдаггүй болохыг, тус шүүхийн "Хэргийг хэрэгсэхгүй болгох тухай" 2017.04.24-ний өдрийн 181/Ш32017/06107 дугаар шүүгчийн захирамжид Оюуны өмч улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн лавлагаагаар компанийн албан ёсны хаяг дээрх хаяг мөн болохыг, мөн хариуцагчийг албадан ирүүлэх тухай захирамжийн дагуу ажиллагаа явуулах боломжгүй талаар цагдаагийн байгууллага шүүхэд мэдэгдсэн болохыг тус тус дурдаад Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.9-д зааснаар хариуцагчийн хаяг тодорхойгүй үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгосон байдаг.

Иймд хэрэгт авагдсан баримтуудыг судлаад шүүхийн мэдэгдэх хуудас, нэхэмжлэлийг гардуулах ажиллагааг гүйцэтгэхийг 2017.07.24-ний өдөр шүүхийн бичиг хүргэгч, шүүгчийн туслахад даалгасан. 2017.07.24-ний өдөр компанийг төлөөлөх эрх бүхий этгээд болох Д.Б шүүхийн мэдэгдэх хуудсыг хүлээн авахаас татгалзаж, улмаар шидсэн болохыг шүүхийн бичиг хүргэгч, шүүгчийн туслах баримтад тэмдэглэж баталгаажуулсан байдаг. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.7-д "зохигч мэдэгдэх хуудсыг хүлээн авахаас татгалзвал энэ тухай мэдэгдэх хуудсанд тэмдэглэж шүүхэд буцаана. Энэ нь хэрэг хянан шийдвэрлэхэд саад болохгүй" гэж заасан тул шүүхийн мэдэгдэх хуудсыг хариуцагчид мөн өдөр хуулийн дагуу гардуулсанд тооцож, улмаар нэхэмжлэгч талаас ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч, мөн хуулийн 77 дугаар зүйлийн 77.9-д зааснаар хариуцагчийг тус шүүхэд албадан ирүүлэхээр 2017.08.01-ний өдрийн 181/Ш32017/10531 дүгээр шүүгчийн захирамжаар шийдвэрлэсэн.

Шүүхийн мэдэгдэх хуудас өөр нэртэй тухайд: Миний бие 2017.06.23-ны өдрийн Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар тус шүүхэд томилогдон ирж, Шүүгчдийн зөвлөгөөнөөс шүүгч Д.Д-гийн хэрэг, нэхэмжлэлийг бүхэлд нь надад шилжүүлсэн. Шүүхийн мэдэгдэх хуудсыг ШЕЗ болон "Монгол шуудан" ТӨХК нарын хоорондох гэрээний дагуу шуудангийн программаас хэвлэж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэдэг бөгөөд уг программд нэр өөрчилж солих ажиллагааг тамгын газар болон шуудангийн компани хариуцан гүйцэтгэдэг. Томилогдон очсоноос хойш нэрийг солиулахаар өөрийн гарын үсгийн загварыг тамгын газрын хариуцсан ажилтанд өгсөн ч "Монгол шуудан" компанийн

хариуцсан ажилтан ээлжийн амралттай гэсэн шалтгаанаар удааширч 2017 оны 8 дугаар сарын дундаар солигдсон. Гарын үсгийн загвар солигдох хүртэлх хугацаанд хүлээн авсан бүх хэрэг, маргаанд шүүхийн мэдэгдэх хуудас “шүүгч Д.Д” нэртэйгээр явагдсан бөгөөд энэ нь уг хэрэгт тухайлан өөр шүүгчийн нэр ашигласан зүйл биш юм. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 77 дугаар зүйлд зааснаар шүүхэд ирвэл зохих этгээдийг ирүүлэх үүднээс шүүхийн мэдэгдэх хуудсыг хүргүүлдэг бөгөөд ийнхүү хүргүүлэхдээ шүүхийн байрнаас гадуур гарч гүйцэтгэдэг. Зохигчийн хүсэлт, хэрэгт авагдсан хүчин төгөлдөр шүүгчийн захирамжуудад дурдагдсан үйл баримтууд, бусад баримтууд болон тухайн хэргийн нөхцөл байдлыг харгалзан үзээд хариуцагчийг төлөөлөх эрх бүхий этгээдийн байгаа газарт хүргэх ажиллагааг гүйцэтгэж өгөхийг хүссэн нэхэмжлэгч талын хүсэлтийг хүлээн авсан болно. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.3-т зааснаар нэхэмжлэгч өөрөө хариуцагчийн хаяг, оршин байгаа газрыг шүүхэд тодорхойлж өгөх үүргийг хүлээдэг бөгөөд нэхэмжлэгч талаас анх нэхэмжлэлдээ хариуцагчийн хаягийг Ф дүүрэг ... дугаар хороо ... хороолол ... тоот гэж, мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэмэлтээр Т дүүрэг, ... дугаар хороо, ... гудамж, ... хаягт түр оршин суугаа гэж тус тус тодорхойлж ирүүлсэн тул албадан ирүүлэх ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай холбогдох мэдээллийг Цагдаагийн байгууллагад хүргүүлэх үүднээс нэхэмжлэгчийн тодорхойлж ирүүлсэн хаягуудыг дээрх 181/Ш32017/10531 дүгээр шүүгчийн захирамжид тусгасан. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.9 “Мэдэгдэх хуудсыг хүлээн авсан хэргийн оролцогч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүхэд ирээгүй бөгөөд түүнийг зайлшгүй ирүүлэх шаардлагатай бол шүүгчийн захирамжаар албадан ирүүлж, хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэхээр, Зөрчлийн тухай хуулийн 15.7 дугаар зүйлийн 1-д “Шүүх, прокурорын дуудсанаар хүрэлцэн ирэхээс зориуд зайлсхийсэн, татгалзсан, эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан бол гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох”-оор, мөн зүйлийн 2-т “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч шүүхэд хүрэлцэн ирэх, эсхүл шүүхэд мэдүүлэг өгөхөөс татгалзсан, зайлсхийсэн, саад учруулсан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох”-оор. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 8-д “Иргэний болон захиргааны хэргийн шүүхээр хэрэг, маргаан хянан шийдвэрлэх явцад Зөрчлийн тухай хуулийн 15.7 дугаар зүйлд заасан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд тухайн шүүх шийтгэл оногдуулах”-аар, мөн хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1.1.4-т “... шалган шийдвэрлэх ажиллагаа хэвийн явагдах нөхцөлийг хангах зорилгоор ... эрх хязгаарлах арга хэмжээ”-г авч болохоор, үүнд Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх арга хэмжээ багтахаар, түүнчлэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.5-д тодорхой үйлдэл хийхгүй байхыг хариуцагчид даалгахаар тус тус заасан. Хариуцагч “ООО” ХХК-г төлөөлөх эрхтэй этгээд болох Д.Б 2017 оны 7 дугаар сарын 24-ний өдөр шүүхийн мэдэгдэх хуудсыг хүлээн авахаас татгалзаж, шидэх үйлдэл гаргасан, дээрх үйлдлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 77.7-д зааснаар мэдэгдэх хуудагст тэмдэглэж баталгаажуулан баримтжуулсан тул хуулийн дээрх зохицуулалтуудыг үндэслэн 300 мянган төгрөгөөр торгож, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулж буй нөхцөл байдлыг арилгах хүртэлх хугацаагаар гадаадад хувийн хэргээр зорчихгүй байхыг даалгасан. Хариуцагч компаниас 2017 оны 8 дугаар сарын 03-ны өдөр итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилж, улмаар нэхэмжлэлийг хувийг гардан авснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулж буй шалтгаан арилсан гэж үзэн

2017 оны 8 дугаар сарын 04-ний өдрийн 181/ШЗ2017/10657 дугаар шүүгчийн захирамжаар дээрх захирамжийн Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлсэн хэсгийг дуусгавар болгосон. Харин шүүхийн болоод шүүгч миний зүгээс хэргийн оролцогчийг мөрдөх, мөшгөх, тагнах, чагнах болон Хил хамгаалах байгууллагатай ярьсан зүйлгүй бөгөөд зохигч өөрийн хардах эрхийн хүрээнд бичсэн гэж ойлгож байна" гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 10-р сарын 13-ны өдрийн 163 дугаар тогтоолоор шүүгч О.О-д сахилгын хэрэг үүсгэж шийдвэрлэжээ.

Шүүгч О.О Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанд ирүүлсэн нэмэлт тайлбартаа: Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 163 дугаар тогтоолыг 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдөр хүлээн авч, эс зөвшөөрч дараах нэмэлт тайлбарыг хүргүүлж байна.

Нэг. Шүүхийн мэдэгдэх хуудсыг хүргүүлэхдээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 77 дугаар зүйлд заасан журмыг зөрчсөн. Нэхэмжлэгч талын хүсэлтийг үндэслэсэн даалгавар өгсөн тухайд: Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4- т хүчин төгөлдөр шийдвэрээр нэгэнт тогтоогдсон үйл баримтыг дахин нотлохгүй гэж заасан байдаг. Урьд гаргасан тайлбарт хавсаргаж хүргүүлсэн 2016 оны 101/ШЗ2016/29056, 2017 оны 181/ШЗ2017/06107 дугаар шүүгчийн захирамжууд хуулийн хүчин төгөлдөр болсон. Дээрх хоёр удаагийн захирамжуудад Ф дүүрэг дэх хаягтаа хариуцагч байдаггүй, бүртгэх эрх бүхий байгууллагаас авсан лавлагаагаар компанийн албан ёсны хаяг Ф дүүрэг дэх хаяг байна гэдгийг тогтоосон. Шүүх нэхэмжлэлийг онцгой харьяаллаар хүлээн авсан тул хэрэг үүсгэсэн шүүгч Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д зааснаар заавал хийж гүйцэтгэх ёстой ажлын нэг нь "нэхэмжлэлийн хувийг хариуцагчид гардуулах ажиллагаа. Иймд шүүхээс нэхэмжлэлийн хувийг гардуулах ажиллагааг гүйцэтгэх үүргийнхээ хүрээнд өөрт нь холбогдуулан нэхэмжлэл гаргасныг мэдэгдэх, шүүхийн байранд ирүүлэх, улмаар нэхэмжлэлийг гардуулах үүднээс мэдэгдэх хуудсыг "шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлэх ажиллагааг 2017 оны 7 дугаар сарын 24-ний өдөр гүйцэтгэсэн. Үүний өмнө хэрэг үүсгэсний дараа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д зааснаар хариуцагч компанийн хаягаар шүүхийн мэдэгдэх хуудсыг 2017 оны 7 дугаар сарын 19-ний өдөр баталгаат шуудангаар явуулсан Энэ тухай баримтыг өмнө хавсаргаж хүргүүлсэн. Мөн зүйлийн 77.2-т мэдэгдэх хуудсыг утсаар" хүргүүлж болохоор заасны дагуу хариуцагчийг утсаар дуудахыг шүүгчийн туслахад даалгасан Шүүгчийн туслахаас нэхэмжлэлд дурдсан455,500, ...455, ...455, ...992,992 дугаарын утсаар залгахад холбогдох боломжгүй. ашиглалтад байхгүй" зэргээр утсаар мэдэгдэх боломжгүй байгаа тухай танилцуулсан. Үүнийг батлах үүднээс шүүгчийн туслахуудын дунд албанд ашигладаг078,898 дугаарын утасны 2017 оны 7 дугаар сарын 16-наас 21-ний өдрийн хоорондох гарах ярианы дуудлагыг үүрэн телефоны компаниудаас гаргуулж шалгаж үзэхийг хүсье.

Хуулийн дээрх зохицуулалтад шүүхийн мэдэгдэх хуудсыг "шүүхийн ажилтан биечлэн хүргэх ажиллагаа нь зөвхөн оршин суугаа хаяг, ажлын газрын хаягаар гүйцэтгэхээр тусгагдаагүй харин зохих этгээдэд ажилтан биечлэн хүргэж өгөх агуулгатай байна. Энэ нь хуулийн техник бичлэг дэх таслал тавьж холбосон хэсгээр илэрхийлэгдэж байна. Мэдэгдэх хуудсыг баталгаат шуудангаар утсаар мэдэгдэх ажиллагааг хийж. харин тухайн нөхцөлд хуульд заасан "өөр этгээдэд даалгах". "Хорооны засаг дарга, ажлын албанд хүргүүлэх", "холбогдох ажилтанд гардуулах" зэрэг бусад аргаар мэдэгдэх хуудсыг хүргүүлэх боломжгүй

байсан тул нөхцөл байдалд тохируулан 'шүүхийн ажилтан биечлэн хүргэх' аргаар ажиллагааг гүйцэтгэсэн. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар шүүх "зохигчийн хүсэлтээр" ажиллагааг явуулах үндсэн зарчимтай тул ажиллагааг зохигчийн хүсэлтийг үндэслэж явуулсан нь хуулийн хэм хэмжээг зөрчсөн зөрчил гэж үзэх боломжгүй Тогтоолд дурдсан энэ асуудал нь ёс зүйн гэхээсээ илүү хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой асуудал байх ба хариуцагчийн зүгээс давж заалдах гомдол гаргах байдлаар шийдвэрлүүлэх боломжтой.

Хоёр. Монгол Улсын Үндсэн хуульд хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байж, шударга шүүхээр шүүлгэх эрхтэй гэж заасан бөгөөд нэг хүний эрх, эрх чөлөө нөгөө хүний эрх, эрх чөлөөгөөр хязгаарлагддаг. Шүүх засаглал нь хүний эрхийг хамгаалах, шударга ёсны баталгаа болсон байгууллага. Шүүхээс хариуцагчид Монгол Улсын хилээр гарахгүй байхыг өөрт нь даалгах арга хэмжээ авах нөхцөл байдлыг хариуцагчийн өөрийн шүүхийг үл хүндэтгэсэн үйлдэл бий болгосон. Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа бүртгэлтэй хуулийн этгээдэд шүүхээс төлөөлөх эрхтэй этгээд нь олдохгүй гэдгээр өмнө 2016 оны 10 дугаар сараас 2017 оны 4 дүгээр сар хүртэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулаад нэхэмжлэлийн хувийг гардуулж чадахгүй хэргийг хэрэгсэхгүй болгож, дахин нэхэмжлэл гаргасныг хүлээн авч, шүүхийн мэдэгдэх хуудас хүргүүлэхээр ажилтны өмнөөс шидэж байгаа байдлыг шүүх анхаарахгүй байх ёсгүй гэж бодож байна. Энэ нь эргээд шүүхэд итгэх иргэдийн итгэл, шүүхийн нэр хүндийн асуудал. Цаашлаад өөрийн эрхээ хамгаалуулахаар шүүхийн байгууллагаар явж байгаа нэхэмжлэгч талын эрх ашиг энд мөн яригдах байх. Миний зүгээс хэрэгт хувийн сонирхлоор хандсан зүйлгүй бөгөөд шударгаар шүүлгэх эрхийн хүрээнд тухайн хэргийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, өөрийн дотоод итгэл үнэмшлээр хүсэлтийг шийдвэрлэсэн. Мөн Хил хамгаалахын ажилтан гэх хүнтэй өөрөө ярьсан, даалгавар өгсөн, дарамталсан зүйл байхгүй бөгөөд огт танихгүй, утсыг нь ч мэдэхгүй. Энэ асуудлаар Хил хамгаалах ерөнхий газарт гомдол гаргасан.

Гурав: Тогтоолд гомдолд дурдаагүй асуудлыг тусгажээ. Нэхэмжлэлийг хүлээн авахад өмнөх 3 удаагийн шийдвэр, магадлал, тогтоолууд хавсаргагдаж ирээгүй байсан тул хэрэг үүсгэхдээ мэдэх ёстой байсан гэдэг үндэслэлгүй. Энэ нь нотлох баримтаар урд хүргүүлсэн нэхэмжлэлд хавсаргасан баримтын жагсаалтыг бичсэн хэсгээс харагдана Шүүхийн шийдвэр, тогтоол, магадлалуудыг тус шүүхэд нэхэмжлэгч талаас 2017 оны 7 дугаар сарын 31-ний өдөр ирүүлсэн 89 хуудас нотлох баримтын дунд ирсэн байна. Энэ нь баримт дээрх шүүхийн архивын тамганы огноо, шүүгчийн туслахаас баримтыг хүлээн авахдаа бичсэн тэмдэглэлээс харагдаж байна. Шүүгчийн зүгээс татгалзан гарах үндэслэлээ мэдсэн даруйдаа хүсэлтээ өгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас гарах үүргээ биелүүлсэн гэж бодож байна. Нөгөөтээгүүр шүүгчийн туслах буюу шүүх хуралдааны нарийн бичгийн дарга байхдаа орсон хэрэг бүрийг санах ёстой, мэдэх боломжтой гэж үзвэл хэт өрөөсгөл, тухайн хүний санах чадвараас хамаарах зүйл байх. Мөн анх нэхэмжлэлийг хүлээн авахаас эхлүүлээд шүүгчийн даалгаснаар нэхэмжлэлийг гардуулах, хариу тайлбар авах зэргээр бүхий л ажиллагааг эхнээс нь явуулсан хэргийг санах магадлал илүү. Харин давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хүчингүй болж, дахин шийдвэрлүүлэхээр ирүүлсэн хэргийн тухайд шүүгчийн туслахын зүгээс хийх ажиллагаа анхнаас нь нэхэмжлэлийг хүлээн авч ажиллагаа хийсэн туслахтай харьцуулбал хамаагүй бага байдаг тул санах магадлал илүү бага. Иймд Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 163 дугаар тогтоолоор үүсгэсэн сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны гомдол хянан хэлэлцэх хуралдааны 2017 оны дугаар сарын 13-ны өдрийн 163 дугаар тогтоол, иргэн Д.Б-ээс Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан гомдол болон шүүгчийн тайлбар, тус хорооноос явуулсан хяналт шалгалтын ажиллагаагаар цугларсан баримтуудыг хэлэлцээд ҮНДЭСЛЭХ нь:

Иргэн Д.Б-ээс шүүгч О.О нь шүүгчийн захирамж гаргах нэрийдлээр эрх мэдлээ хэтрүүлж хүний эрх, эрх чөлөөнд ноцтой байдлаар халдсан, шүүхийн захиргааны ажилтнуудад хууль бус даалгавар өгч хууль бус ажиллагааг явуулсан. Хил хамгаалах байгууллагын албан хаагчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлсөн үйлдэл гаргаж шүүгчийн ёс зүйн дүрмийг ноцтойгоор зөрчсөн тул шүүгч О.О-д сахилгын хэрэг үүсгэж, түүнд шүүгчийн албан тушаалаас огцруулах шийтгэл ногдуулах үндэслэлтэй гэсэн гомдлыг Шүүхийн Ёс зүйн хороонд гаргаж, тус хорооны 2017 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 163 дугаар тогтоолоор гурван үндэслэлээр Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч О.О-д сахилгын хэрэг үүсгэхээр шийдвэрлэжээ.

Нэг. “2017.07.24-ний өдрийн 16.00 цагийн орчим Монгол Улсын иргэн Д.Б намайг Т дүүргийн нутаг дэвсгэрт автомашинтай зорчиж байхад хэн нь үл мэдэгдэх хүмүүс нэхэмжлэлийн хувийг гардуулна гарын үсгээ зур гэж зүй бус авирлахад нь миний зүгээс энэхүү хууль бус шаардлагыг эсэргүүцэж тус шүүхийн шүүгчийн туслах Б.Ч, тамгын газрын бичиг хүргэгч Б.Б нарын хууль бус үйл ажиллагааны талаар холбогдох байгууллагад гомдол гаргасан. Нөгөөтээгүүр шүүгч О.О нь туслахдаа даалгавар өгч /хэргийн оролцогчтой хамтарсан байж болзошгүй/ Д.Б-г тухайн өдөр Т дүүргийн нутаг дэвсгэрт байгааг ямар нэг арга замаар мэдэж туслах Б.Ч-г бичиг хүргэгч Б.Б-гийн хамт Ш дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд ажилладаггүй шүүгч Д.Д-гийн гарын үсэгтэй шүүгчийн туслах н.А-гийн нэртэй 2017.07.24-ний өдөр гэсэн огноотой шүүхэд дуудан ирүүлэх тухай шүүхийн мэдэгдэх хуудсаар гудамжинд хууль бусаар шүүхийн үйлчилгээ үзүүлэхээр явуулсан...” гэсэн гомдлыг гаргасан.

163 дугаар тогтоолд “Шүүгч О.О нь шүүхийн мэдэгдэх хуудас болон нэхэмжлэлийг “ООО” ХХК-ийн захирал Д.Б түүний оршин суугаа буюу ажлын газрын хаягаар нь хүргүүлэх талаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 77 дугаар зүйлд заасан журмыг зөрчсөн даалгаврыг шүүгчийн туслах болон бичиг хүргэгчид өгсөн, шүүгчийн туслах болон бичиг хүргэгчийн шүүхийн мэдэгдэх хуудас болон нэхэмжлэл гардуулах ажиллагаа хуульд нийцсэн эсэхэд хяналт тавиагүй, хууль зөрчиж гардуулах гэсэн ажиллагааг хүчин төгөлдөрт үзэж Д.Б-г албадан ирүүлэх захирамж гаргасан бөгөөд шүүгч О.О хуульчлагдсан журмыг зөрчсөн даалгавар өгөхдөө нэхэмжлэгч талын хүсэлтийг үндэслэснээрээ төвийг сахих зарчмыг зөрчсөн, нэхэмжлэгч талд тал зассан гэх ойлголт төрүүлсэн үйлдлээрээ шүүгч Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлд заасан “хууль дээдлэх, төвийг сахисан байр сууринаас хандах” зарчмууд, 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүгч нь хэргийн оролцогчдод эрх тэгш, төвийг сахисан, хүнлэг ёсоор хандаж, хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлэхүйц харилцааны соёлыг эзэмшсэн байна” гэх заалт, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй,” 3.3 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “Шүүгч өөрийн удирдлага дор ажиллаж байгаа алба хаагчдад ажил мэргэжилдээ үнэнч байх, чин сэтгэлээсээ хандаж ажиллахыг шаардаж, өөрийн эргэн тойронд ёс зүйн эрүүл орчныг бүрдүүлнэ” гэх заалтыг тус тус зөрчсөн” гэж дүгнэсэн байна.

Я.Э-гийн нэхэмжлэлтэй “ООО” ХХК-д холбогдох үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгчөөр тогтоолгох тухай нэхэмжлэлтэй иргэний хэрэгт шүүгч О.О

хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулсан байх бөгөөд нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Э “2008 оноос хойш одоог хүртэл шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хийлгэж, “ООО” ХХК-ийн захирал Ч улсад амьдардаг гэх, байнга хилээр орж, гарч байдаг Д.Б-ээс болж одоог хүртэл шүүхээр хэргээ эцэслэн шийдвэрлүүлж чадахгүй, ... их хохирол хүлээж байгааг харгалзан үзэж шүүхээс мэдэгдэх хуудас, нэхэмжлэлийн хувийг бичиг хэрэг хүргэгчээр хүргүүлэн гардуулж өгнө үү гэсэн хүсэлт шүүхэд хоёр удаа бичгээр гаргахдаа шүүгчийн захирамжаар удаа дараа уг нэхэмжлэлийг хариуцагчийн хаяг тодорхойгүй, ...энэ хүн Монголд амьдардаггүй, Ч, Ц улсад амьдардаг, ийм компани байхгүй гэсэн үндэслэл шалтгаанаар Я.Э-гийн нэхэмжлэлтэй “ООО” ХХК-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, нэхэмжлэлийг хүлээж авахаас татгалзаж 2015, 2016, 2017 онуудад шийдвэрлэсэн шүүгчийн захирамжуудыг шүүхэд гаргаж өгсөн байна. /хэргийн 18-25 дугаар хуудас/

Мөн нэхэмжлэгч Я.Э-гийн нэхэмжлэлтэй “ООО” ХХК-д холбогдох үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгчөөр тогтоолгох тухай маргаантай иргэний хэргийг гурван шатны шүүх шийдвэрлэж байсан байх ба 2011 оны Улсын Дээд шүүхийн 665 дугаар тогтоолоор шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасан байна. /хэргийн 73-77 дугаар хуудас/

Шүүгч хэргийг хуулийн хугацаанд шийдвэрлэх үүрэгтэй, мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх нэг нөхцөл нь хэргийн болон шүүх хуралдааны оролцогчдыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломжоор хангах явдал бөгөөд шүүхэд дуудан ирүүлэх тухай Шүүхийн мэдэгдэх хуудас нь шүүхээс ирүүлж буй албан ёсны баримт юм. ИХШХШТ Хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-т шүүхийн мэдэгдэх хуудсыг зохигч талын оршин суугаа буюу ажлын газрын хаягаар баталгаат шуудангаар, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлэхээр заасан заалт нь шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлэхдээ шүүхийн мэдэгдэх хуудсыг зөвхөн зохигч талын оршин суугаа буюу ажлын газрын хаягаар л хүргүүлэх тухай заалт биш болно. Иймд хуульд заасан журмыг зөрчсөн даалгаврыг шүүгчээс шүүгчийн туслах болон бичиг хүргэгчид өгсөн, шүүгчийн туслах болон бичиг хүргэгчийн шүүхийн мэдэгдэх хуудас болон нэхэмжлэл гардуулах ажиллагааг Т дүүргийн цагдаагийн газрын орчинд “ООО” ХХК-ийн захирал Д.Б-д гардуулах гэж оролдсон нь хуульд нийцсэн эсэх талаар хяналт тавиагүй гэж шүүгчийг буруутгах үндэслэлгүй байна.

Шүүгч өөр шүүгчийн нэр дээр мэдэгдэх хуудас бичигдсэн байгаа талаар тайлбарлахдаа “Шүүхийн мэдэгдэх хуудсыг ШЕЗ болон “Монгол шуудан” ТӨХК-ийн хооронд байгуулсан гэрээний дагуу шуудангийн программаас хэвлэж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэдэг. Уг программд нэр өөрчилж солих ажиллагааг тамгын газар болон шуудангийн компани хариуцан гүйцэтгэдэг, шүүгчийн гарын үсгийн загвар солигдох хүртэлх хугацаанд хүлээн авсан бүх хэрэг, маргаанд шүүхийн мэдэгдэх хуудас өмнө нь ажиллагаа хийж байсан шүүгч Д.Д-гийн нэртэйгээр явагдсан” гэсэн байна.

Хоёр. Иргэний хэргийн шүүх Д.Б-д улсын хилээр гарахгүй байхыг даалгаж, шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлэх эрхгүй бөгөөд шүүх процесс ажиллагааны хувьд хүний эрхт халдсан ноцтой зөрчил гаргасан, ийм шийдвэр гаргах эрх шүүгчид хуулиар олгогдоогүй байхад эрх мэдлээ хэтрүүлсэн үйлдлийг бас шалгуулахыг хүсэж байна” гэсэн гомдлыг гаргасан, Шүүхийн Ёс зүйн хорооны 163 дугаар тогтоолд уг гомдлыг үндэслэлтэй гэж үзсэн байна.

Шүүгч О.О нь 2017 оны 8 дугаар сарны 04-ний өдрийн 10657 дугаар шүүгчийн захирамжаар “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.5-д зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад

учруулж буй нөхцөлийг арилгах хүртэлх хугацаагаар Монгол Улсын хилээр гарахгүй байхыг хариуцагч Д.Б-д даалгаж, захирамжийг Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба болон Хил хамгаалах ерөнхий газарт хүргүүлэхийг шүүгчийн туслах Б.Ч-д даалгаж шийдвэрлэжээ. /хэргийн 6 дугаар хуудас/

Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах эрхийг “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлсэн шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шийдвэр байгаа бол шийдвэрт заасан хугацаагаар түдгэлзүүлнэ” гэж заасан. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах эрхийг эрхийг түдгэлзүүлэх талаар заагаагүй, шүүгчид эрхийг олгоогүй байхад шүүгч О.О 2017 оны 8 дугаар сарын 4-ний өдөр 10657 дугаартай шүүгчийн захирамж гаргаж Д.Б-г Монгол Улсын хилээр гарахгүй байхыг даалгасан нь Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлд заасан “хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, хууль дээдлэх” зарчмууд, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй” гэх заалтыг тус тус зөрчсөн гэж Шүүхийн Ёс зүйн хорооны гомдол хянан хэлэлцэх хуралдаанаас үзсэн нь зөв болжээ.

Гомдол гаргагчийн өмгөөлөгч Н.М Хил хамгаалах ерөнхий газрын ажилтан х/ч Ч.М-тэй уулзсан гэж уулзалтын бичлэг, фото зураг гэх зүйлүүдийг Шүүхийн Ёс зүйн хороонд гаргаж өгсөн байна. Шүүхийн Ёс зүйн хороос Си Ди бичлэгт үзлэг хийсэн тэмдэглэлд “Хошууч Ч.М: Шүүгч нь наад хүнийхээ хоригийг одоо тавь гэж над руу утасдаад салахгүй байсан. Шүүгч нь дарамтлаад байхаар...” гэж ярьсан гэжээ. /хэргийн 132 дугаар хуудас/ мөн хошууч Ч.М Шүүхийн Ёс зүйн хороонд өгсөн тайлбартаа “Асуулт: Шүүгч О.О тань руу ярьсан уу. Хариулт: үгүй, шүүгчийн туслах нь сандарсан байдалтай ярьсныг санаж байна.” гэсэн, Шүүхийн ёс зүйн хорооны хуралдаанаас шүүгч О.О хошууч Ч.М руу утсаар ярьсан эсэх талаарх нэмэлт шалгалтыг нийт гишүүдийн хуралдаанаас өмнө хийх нь зүйтэй гэж бүрэлдэхүүн тогтоолд тэмдэглэсэн байна.

Шүүхийн Ёс зүйн хороонд Хил хамгаалах ерөнхий газрын ажилтан х/ч Ч.М “Д.Б-тэй холбоотой асуудлаар шүүгч О.О надтай утсаар яриагүй, түүний туслах н.Ч гэдэг эмэгтэй 1 удаа ярьсан. ...шүүгч О.О нь намайг дарамталж, удаа дараа залгасан зүйл байхгүй болно.” гэсэн тайлбарыг ирүүлсэн байгаагаас үзэхэд шүүгчийг эрх мэдлээ хэтрүүлэн хувийн ашиг сонирхлын үүднээс ёс зүйгээ зөрчсөн үйлдэл гаргасан гэх гомдлыг үндэслэлгүй байна гэж үзэв.

Гурав. Шүүгч О.О хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарах үүргээ биелүүлээгүй гэсэн гомдлын талаар.

Шүүгч О.О Я.Э-гийн нэхэмжлэлтэй “ООО” ХХК-д холбогдох уг хэргийг урьд нь шийдвэрлэхэд шүүх хуралдааны нарийн бичгийн даргын хувиар оролцож байсан гэдгээ иргэний хэрэг үүсгэх үедээ мэдсэн байх ёстой байсан учраас дээрх ажиллагааг явуулахаасаа өмнө шүүгч татгалзах ёстой байжээ. Шүүгч О.О татгалзах ёстой байсан хэрэг дээрээ сар гаруй хугацаанд ажиллагаа явуулсан нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91.1.1, Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлд заасан “хууль дээдлэх, төвийг сахисан байр сууринаас хандах” зарчмууд, 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүгч нь хэргийн оролцогчдод эрх тэгш, төвийг сахисан, хүнлэг ёсоор хандаж, хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлэхүйц харилцааны соёлыг эзэмшсэн байна” гэх заалт, 3.3 дугаар зүйлийн 1 дэх

хэсгийн “Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй” гэх заалтыг тус тус зөрчсөн гэж шүүгч О.О-д сахилгын хэрэг үүсгэсэн тогтоолд дүгнэсэн байна.

Шүүгч О.О хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарах тухай хүсэлтийг 2017 оны 8 дугаар сарын 7-ны өдөр гаргахдаа “2009-2012 онд Ш дүүргийн шүүхэд шүүгчийн туслах бөгөөд шүүх хуралдааны нарийн бичгийн даргаар ажиллаж байсан. Ш дүүргийн шүүхээс 2012 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 974 дүгээр шийдвэрээр Я.Э-гийн нэхэмжлэлтэй “ООО” ХХК-д холбогдох өмчлөгчөөр тогтоолгох тухай хэргийг хянан шийдвэрлэхэд шүүх хуралдааны нарийн бичгийн даргын хувиар оролцож байсан байна” гэжээ. Энэхүү хүсэлтийг хангасан захирамж Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч гарсан байна.

Иймд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.1.1- д зааснаар энэ хэрэг хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй нөхцөл илэрч байх ба мөн хуулийн 92 дугаар зүйлийн 92.1-д зааснаар мэдсэн даруйд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарах үүрэг, Шүүгчийн ёс зүйн дүрэм болон Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэмд заасны дагуу энэ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарах хүсэлтийг хүргүүлж байна.” гэжээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91.1.1 -д шүүгч “урьд нь уг хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд ... шүүх хуралдааны нарийн бичгийн даргын хувиар оролцсон” үндэслэл байвал хэрэг хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй гэж заасан. Мөн хуулийн 92 дугаар зүйлийн 92.1-д заасан татгалзан гарах үндэслэл тогтоогдвол тухайн үед нь мэдэгдэж татгалзан гарах үүрэгтэй гэсэн заалт нь шүүгч татгалзан гарах үндэслэл бий болсныг мэдсэн даруйдаа хүсэлтээ гаргах зохицуулалт бөгөөд шүүгч нь Ш дүүргийн шүүхийн 2012 оны 974 дүгээр шийдвэртэй танилцаж өөрийгөө хэргийг хянан шийдвэрлэхэд шүүх хуралдааны нарийн бичгийн даргын хувиар оролцож байсан талаар мэдэж хүсэлтээ гаргасан гэж байгааг буруутгах боломжгүй, тухайн шийдвэр шүүгчийг нэхэмжлэлийг хүлээн авч, иргэний хэрэг үүсгэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж байхад хэрэгт авагдсан байсан тухай үйл баримт тогтоогдохгүй байх тул шүүгч О.О-г Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3, 3.2 дугаар зүйлийн 1, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн гэж үзэх боломжгүй.

Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2-т төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмын нэг бол хууль дээдлэх гэж заасан бөгөөд шүүн таслах ажиллагаа нь төрийн үйл ажиллагаа, энэ зарчмыг шүүгч биелүүлэх үүрэгтэй. Мөн хуулийн 49 дүгээр зүйлийн 1-д “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана” гэж тодорхойлсон.

Иймд шүүгч О.О Д.Б-г Монгол Улсын хилээр гарахгүй байхыг даалгасан 2017 оны 8 дугаар сарын 4-ний өдөр 10657 дугаартай шүүгчийн захирамж гаргаж, Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хуулийн заалтыг зөрчсөн нь Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1-д заасан “хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, хууль дээдлэх, аливаа асуудалд бодитой, төвийг сахисан байр сууринаас хандах, ...үүрэгт ажилдаа хариуцлагатай хандах, мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх ” зарчмууд, 3.3 дугаар зүйлийн 1-д заасан “Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй” гэсэн заалтыг тус тус зөрчсөн гэсэн дүгнэлтийг Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанаас хийж шүүгчид Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн

37.1.1-д заасан шүүгчийн сахилгын хариуцлага болох сануулах сахилгын арга хэмжээ оногдуулахаар тогтов.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйл, 36 дугаар зүйлийн 36.1.1, 37 дугаар зүйлийн 37.1.1, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2, Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.1, 5.13-т заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Ш дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч О.О-д сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Энэ магадлалын хувийг шүүгч болон гомдол гаргагчид хүргүүлэхийг Шүүхийн Ёс зүйн хорооны Ажлын албанд даалгасугай.

3.Шүүгч, гомдол гаргагч нар магадлалыг гардан авснаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ

Н.ЭРДЭНЭЦОГТ

ГИШҮҮН

Ч.ОЮУНЦЭЦЭГ

UIN.MN
СУДАЛГААНЫ САН



ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ
МАГАДЛАЛ

2018 оны 4 сарын 05 өдөр

Дугаар 221/ЁМ2018/0006

Улаанбаатар хот

Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны
шүүхийн шүүгч О.О-д сахилгын шийтгэл
ногдуулсан Шүүхийн Ёс зүйн хорооны
магадлалын тухай

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааныг шүүгч О.Номуулин даргалж, шүүгч Э.Зоригтбаатар, шүүгч Г.Билгүүн нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн дарга Н.Өнө-Эрдэнэ, гомдол гаргагчийн өмгөөлөгч Н.М, шүүгч О.О нарыг оролцуулан хийж, Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн “Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч О.О-д шийтгэл ногдуулах тухай” 01 дүгээр магадлалыг гомдол гаргагчийн өмгөөлөгч Н.М, шүүгч О.О нарын гомдлоор, шүүгч Г.Билгүүний илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 01 дүгээр магадлалаар: Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч О.О-д сануулах сахилгын шийтгэл ногдуулж шийдвэрлэжээ.

Гомдол гаргагчийн өмгөөлөгч Н.М давж заалдах гомдолдоо: “...Гомдол гаргагч иргэн Д.Б-гийн зүгээс Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч О.О-гийн шүүгчийн ёс зүйн зөрчил бүхий үйлдлүүдийн талаар Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан гомдлын дагуу Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 163 дугаар тогтоолоор шүүгч О.О-гийн ёс зүйн зөрчил бүхий гурван үйлдэлд холбогдуулан сахилгын хэрэг үүсгэсэн юм. Гэтэл 2018 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн сахилга оногдуулах нийт гишүүдийн хуралдаанаас гарсан 01 дүгээр магадлалаар дээр дурдсан 3 хууль бус үйлдлээс зөвхөн нэг үйлдэлд буюу Д.Б-г Монгол улсын хилээр гарахгүй байхыг даалгасан 2017 оны 8 дугаар сарын 04-ний өдрийн 10657 дугаартай захирамж гаргасан үйлдэлд холбогдуулан Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1-д заасан шүүгчийн сахилгын шийтгэл болох сануулах арга хэмжээ оногдуулсан нь үндэслэлгүй байна. Шүүгч О.О нь өөрийн туслахад даалгавар өгч /хэргийн оролцогчтой хамтарсан байж болзошгүй/ 2017 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн 16.00 цагийн орчим Д.Б-г Т дүүргийн нутаг дэвсгэрт байгааг ямар арга замаар мэдэж туслах Б.Ч-г бичиг хүргэгч Б.Б-гийн хамт Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Д.Д-гийн гарын үсэгтэй 2017 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн шүүхэд дуудан ирүүлэх тухай шүүхийн мэдэгдэх хуудсаар гудамжинд хууль бусаар үйлчилгээ үзүүлэхээр явуулсан ...” гэж бичсэн гомдлыг үндэслэлтэй гэж Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 163 дугаар тогтоолоор дүгнэн шүүгч О.О нь эдгээр үйлдлээрээ Шүүгчийн ёс зүйн дүрмийн

1.3 дугаар зүйл, 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг "Шүүгч нь хэргийн оролцогчдод эрх тэгш, төвийг сахисан, хуулэг ёсоор хандаж, хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлэхүйц харилцааны соёлыг эзэмшсэн байна", 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Шүүгч хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд нь хяналт тавих үүрэгтэй, 3.3 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн "Шүүгч өөрийн удирдлага дор ажиллаж байгаа алба хаагчдад ажил мэргэжилдээ үнэнч байх, чин сэтгэлээсээ хандаж ажиллахыг шаардаж, өөрийн эргэн тойронд ёс зүйн эрүүл орчныг бүрдүүлнэ" гэх заалтуудыг зөрчсөн гэж үзсэн. Гэтэл магадлалд дурдсанаар О.О-гийн дээрх үйлдлийг мэдэгдэх хуудас шүүхийн албан ёсны баримт гээд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь заалтыг Шүүхийн Ёс зүйн хороо эрх мэдлээ хэтрүүлж буруу тайлбарлан хэрэглэсэн, дээрх хуулийн заалтаар шүүхийн ажилтнаар хүргүүлэх тохиолдолд зөвхөн зохигч талын оршин суугаа буюу ажлын газрын хаягаар хүргүүлэх агуулга гэж ойлгогдож байгаа атал шүүгчээс шүүгчийн туслах Б.Ч, Ф дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн бичиг хүргэгч Т.Б нарт шүүхийн мэдэгдэх хуудас, нэхэмжлэлийг хариуцагчийн "байгаа газарт" гардуулахаар хууль бус үүрэг даалгавар өгсөн, улмаар тэд нэхэмжлэгч талтай хамтран 3 хоног хариуцагчийг хайж олж шүүхийн мэдэгдэх хуудас болон нэхэмжлэлийн хувийг Т дүүргийн Цагдаагийн газрын орчим "ООО" ХХК-ийн захирал Д.Б-д гардуулах гэж оролдсон байх бөгөөд энэ үйл баримт нь Д.Б-ээс 2017 оны 8 дугаар сарын 07-ны өдөр гаргасан "Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан гомдол, шүүгчийн туслах Б.Ч-гийн 2017 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Шүүхийн ёс хорооны референт Ж.Халиунд өгсөн тайлбар, бичиг хүргэгч Т.Б-ийн 2017 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Шүүхийн ёс хорооны референт Ж.Халиунд өгсөн тайлбар зэрэг баримтаар нотлогдож байгаа төдийгүй Шүүхийн Ёс зүйн хороо гомдлыг шийдвэрлэхдээ зөвхөн шүүхийн мэдэгдэх хуудас хүргүүлэх ажиллагаанд буруу дүгнэлт өгсөн ба нэхэмжлэлийн хувийг гудамжинд гардуулах үйлдлийг хэрхэн дүгнэсэн нь тодорхойгүй орхигдуулсан, шүүгч нь шүүхийн мэдэгдэх хуудас хүргүүлэх, нэхэмжлэлийг гардуулах зэрэг хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлал болон хуульд нийцсэн эсэхэд хяналт тавих үүргээ биелүүлээгүй гэж үзэж байна. О.О нь 2009-2012 оны хооронд Ш дүүргийн шүүхэд шүүгчийн туслах, нарийн бичгийн дарга байсан бөгөөд Я.Э-гийн нэхэмжлэлтэй "ООО" ХХК-д холбогдох уг хэргийг өмнө шийдвэрлэхэд нарийн бичгийн даргын хувиар оролцож байсан гэдгээ иргэний хэрэг үүсгэх үедээ мэдсэн байх ёстой гэж өмнөх Шүүхийн Ёс зүйн хорооны тогтоолд дүгнэснийг үндэслэлтэй гэж үзэж байна. Дээрх иргэний хэргийн хянан шийдвэрлэх ажиллагаа тухайн үед О.О-г шүүхэд ажиллаж байхад нэг жил орчим үргэлжилсэн ба Ш дүүргийн шүүхийн ихэнх шүүгчдээр дамжсан, цаг хугацааны хувьд удсан иргэний хэрэг байхад шүүгч О.О нь мэдэх бүрэн боломжтой буюу татгалзах ёстой хэрэг дээрээ сар гаруй хугацаанд ажиллагаа явуулсан нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.1.1 дэх заалт, Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлд заасан "хууль дээдлэх, төвийг сахисан байр сууринаас хандах" зарчмууд, 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Шүүгч нь хэргийн оролцогчдод эрх тэгш, төвийг сахисан, хүнлэг ёсоор хандаж, хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлэхүйц харилцааны соёлыг эзэмшсэн байна" гэх заалтыг тус тус зөрчсөн байхад шүүгч О.О-гийн хууль бус зөвхөн нэг үйлдлийг ёс зүйн зөрчилд тооцож сануулах шийтгэл ногдуулсан нь учир дутагдалтай төдийгүй сахилгын шийтгэлийн хувьд хөнгөдсөн гэж үзэж байна.

Иймд дээр дурдсан гомдлын үндэслэлүүдийг судлан үзэж Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 01 дүгээр "Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч О.О-д сахилгын шийтгэл ногдуулах тухай"

магадлалд өөрчлөлт оруулж, давж заалдах гомдлыг хангаж шийдвэрлэж өгнө үү” гэжээ.

Шүүгч О.О шүүхэд гаргасан давж заалдах гомдолдоо: “...Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 2-т “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй” гэж заасан байхад шүүхээс гарч буй эрхийн актын хууль зүйн үндэслэлийн талаар Шүүхийн Ёс зүйн хороо үнэлэлт өгч хууль зөрчсөн гэж дүгнэжээ.

Нөгөөтээгүүр 2017 оны 8 дугаар сарын 04-ний өдрийн 181/ШЗ2017/10657 дугаар шүүгчийн захирамжаар дээрх маргааны зүйл болсон 181/ШЗ2017/10531 дүгээр шүүгчийн захирамжаар шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авсан 4 дэх заалтын үйлчлэлийг дуусгавар болгосон. Өөрөөр хэлбэл Хилээр гарахгүй байхыг өөрт нь даалгасан арга хэмжээ 4 өдөр үйлчилснээс гадна тус шүүхийн 2017 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 181/ШТ2017/00355 дугаар шүүхийн тогтоолоор хариуцагчийн гомдлоор хянаж мөн хүчингүй болгож шийдвэрлэснийг анхаараагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуульд хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байж, шударга шүүхээр шүүлгэх эрхтэй гэж заасан бөгөөд нэг хүний эрх, эрх чөлөө нөгөө хүний эрх: эрх чөлөөгөөр хязгаарлагдана. Шүүхээс хариуцагчид Монгол Улсын хилээр гарахгүй байхыг өөрт нь даалгах арга хэмжээ авах нөхцөл байдлыг хариуцагчийн өөрийн шүүхийг үл хүндэтгэсэн үйлдэл бий болгосон. Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа бүртгэлтэй хуулийн этгээдэд шүүхээс төлөөлөх эрхтэй этгээд нь олдохгүй гэдгээр өмнө 2016 оны 10 дугаар сараас 2017 оны 4 дүгээр сар хүртэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулаад нэхэмжлэлийн хувийг гардуулж чадахгүй хэргийг хэрэгсэхгүй болгож, дахин нэхэмжлэл гаргасныг хүлээн авч, шүүхийн мэдэгдэх хуудас хүргүүлэхээр ажилтны өмнөөс шидэж байгаа байдлыг шүүх анхаарахгүй байх ёсгүй гэж бодож байна. Энэ нь эргээд шүүхэд итгэх иргэдийн итгэл, шүүхийн нэр хүндийн асуудал. Цаашлаад өөрийн эрхээ хамгаалуулахаар шүүхийн байгууллагаар явж байгаа нэхэмжлэгч талын эрх ашиг энд мөн яригдах байх. Миний зүгээс хэрэгт хувийн сонирхлоор хандсан зүйлгүй бөгөөд шударгаар шүүлгэх эрхийн хүрээнд тухайн хэргийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, өөрийн дотоод итгэл үнэмшлээр хүсэлтийг шийдвэрлэж 2017 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн 181/ШЗ2017/10531 дугаар шүүгчийн захирамжийг гаргасан болно. Иймд сахилгын шийтгэл ногдуулсан Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 01 дүгээр магадлалыг хүчингүй болгож өгнө үү” гэжээ.

ХЯНАВАЛ:

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 01 дүгээр магадлал хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагыг хангахгүй байна.

Гомдол гаргагч Д.Б нь Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч О.О-д холбогдуулан “...шүүгч О.О нь шүүхийн захиргааны ажилтнуудад хууль бус даалгавар өгч, шүүхийн үйлчилгээг гудамжинд үзүүлж, нэхэмжлэлийн хувь, шүүхийн мэдэгдэх хуудсыг хууль бусаар гардуулах ажиллагаа хийхийг үүрэг болгосон, ингэхдээ Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд ажилладаггүй шүүгч Д.Д-гийн гарын үсэгтэй мэдэгдэх хуудсыг ашигласан, мөн өөрт олгогдсон эрх мэдлээ хэтрүүлэн Д.Б-д улсын хилээр гарахгүй байхыг даалгах захирамж гаргаж, Хил хамгаалах газрын ажилтан Ч.М руу утсаар ярьж, хувийн ашиг сонирхлоор хандсан, шүүгч О.О нь Я.Э-гийн нэхэмжлэлтэй, “ООО” ХХК-д холбогдох хэргийг урьд нь шийдвэрлэхэд шүүх хуралдааны нарийн бичгийн даргаар оролцож

байсан хэр нь татгалзан гарах үүргээ биелүүлэлгүй, нэг сар гаруй хугацаанд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсан гэж шүүгч О.О нь "...шүүхээс хариуцагчид улсын хилээр гаргахгүй байхыг өөрт нь даалгах арга хэмжээ авах нөхцөлийг хариуцагчийн өөрийн шүүхийг үл хүндэтгэж, шүүхийн дуудсан цагт хүрэлцэн ирэхгүй байх, шүүхийн мэдэгдэх хуудсыг шидэж хүлээн авахгүй байх үйлдэл бий болгосон, нэхэмжлэгчийн хүсэлтээр шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээг авсан, өөр шүүгчийн гарын үсэгтэй мэдэгдэх хуудас явуулсан гэх гомдлын тухайд гарын үсгийн загвар солигдох хүртэл хугацаанд Д.Д шүүгчийн нэрээр мэдэгдэх хуудас хүргэгдэж байсан, Хил хамгаалах газрын ажилтан Ч.М руу утсаар яриагүй, Д.Б-д хилийн хориг тавих талаар хэлээгүй, өмнө нь тус хэрэгт нарийн бичгийн даргаар ажиллаж байсан гэдгээ мэдсэн даруйдаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарсан" гэж тус тус маргажээ.

Хэрэгт авагдсан баримтуудаас үзэхэд, Дүүргийн иргэний хэргийн анхан шатны ... дүгээр шүүхийн шүүгчийн 2015 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн 8017 дугаар захирамжаар "Я.Э-гийн нэхэмжлэлтэй, "ООО" ХХК-д холбогдох, "Ш дүүргийн ... дүгээр хороо, Л сүм музейн баруун талд байрлах "ССС" ресторан байрлаж буй 2 давхар барилгын 44 хувийн буюу "В" блокын 1 дүгээр давхрын албан ёсны хөрөнгө оруулагч, өмчлөгчөөр тогтоолгох, "ССС" рестораны 2 давхар барилга дээр нэмж, барилга барьж, хамтран өмчлөгчийн эрх ашгийг хөндөхгүй байхыг даалгах" шаардлага бүхий нэхэмжлэлтэй иргэний хэргийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.7 дахь заалтыг баримтлан хэргийг хэрэгсэхгүй болгож" шийдвэрлэжээ.

Я.Э нь дахин "ООО" ХХК-д холбогдуулан 2016 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр Ф дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хандан "Ш дүүрэг, ... хорооны нутаг дэвсгэрт байрлах Л сүм музейн баруун талд байрлах "ССС" ресторан байрлаж буй 2 давхар барилгын "В" блокийн барилгад Я.Э миний оруулсан хөрөнгийг ...000 төгрөгийн хэмжээгээр тооцож, уг барилгын нэгдүгээр давхрын 202.2 м.кв, өргөтгөл 32 м.кв тамбур, довжоо 80.4 м.кв буюу нэгдүгээр давхрын нийт 314.6 м.кв талбайн хууль ёсны өмчлөгчөөр Я.Э намайг тогтоож, өмчлөгчөөр бүртгэхийг оюуны өмч улсын бүртгэлийн газарт даалгах" шаардлага бүхий нэхэмжлэл гаргасныг Ф дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2016 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 101/Ш32016/29056 дугаар захирамжаар "хариуцагч Ф дүүрэг, ... дугаар хороо, ... дугаар хороолол, .. дугаар байрны ... тоот" хаягт бүртгэлгүй бөгөөд оршин суудаггүй байх тул үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхтэй холбоотой маргаанд тухайн үл хөдлөх эд хөрөнгийн байрлаж буй газрын харьяалах шүүхэд хандах нь зүйтэй" гэх үндэслэл дурдаж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.2, 65.1.9-д зааснаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзжээ. Ийнхүү Я.Э нь "ООО" ХХК-д холбогдуулан 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд дээрх шаардлага бүхий нэхэмжлэл гаргасныг шүүх хүлээн авч иргэний хэрэг үүсгэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байхдаа "...хариуцагч "ООО" ХХК-ийн Оюуны өмч, улсын бүртгэлийн газар болон татварын байгууллагад бүртгэлтэй хаягт мэдэгдэх хуудас хүргүүлэхэд ийм компани байхгүй гэж мэдэгдэх хуудсыг хүлээн аваагүй, Д.Б оршин суугаа хаягаар мэдэгдэх хуудас хүргүүлэхэд мэдэгдэх хуудсыг хүлээн авахаас татгалзсан, хүлээн авахгүй хэмээн буцаасан, шүүхээс хариуцагчийг албадан ирүүлэх захирамж гаргасан боловч Д.Б нь Ч улсад амьдардаг учир албадан ирүүлэх арга хэмжээ авах боломжгүй талаар цагдаагийн байгууллагаас мэдэгдсэн гэх үндэслэлээр хариуцагчийн хаяг тодорхойгүйгээс шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах боломжгүй" гэсэн үндэслэлээр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 117 дугаар зүйлийн 117.1, 65 дугаар зүйлийн 65.1.9-д зааснаар холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосон Ш

дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2017 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 181/Ш32017/06107 дугаар захирамж гарчээ.

Улмаар Я.Э нь “ООО” ХХК, гүйцэтгэх захирал Д.Б-д холбогдуулан “Ш дүүрэг, ... хорооны нутаг дэвсгэрт байрлах Л музейн баруун талд байрлах “ССС” ресторан байрлаж буй 2 давхар барилгын “В” блокийн барилгад Я.Э миний оруулсан хөрөнгийг000 төгрөгийн хэмжээгээр тооцож, уг барилгын нэгдүгээр давхрын 202.2 м.кв, өргөтгөл 32 м.кв тамбур, довжоо 80.4 м.кв буюу нэгдүгээр давхрын нийт 314.6 м.кв талбайн хууль ёсны өмчлөгчөөр Я.Э намайг тогтоож, өмчлөгчөөр бүртгүүлэхэд шаардлагатай баримт, материалыг бүрдүүлэн улсын бүртгэлд өгөхийг хариуцагчид даалгах, өмчлөгчөөр бүртгэхийг Оюуны өмч, улсын бүртгэлийн газарт даалгах” шаардлага бүхий нэхэмжлэлийг Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдөр гаргасан байх бөгөөд хариуцагч “ООО” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Б нь А хотод ирсэн, гадаад явахаас нь өмнө нэхэмжлэлийн хувийг гардуулж, мэдэгдэх хуудсыг нэн даруй хүргүүлэх хүсэлтийг нэхэмжлэлийн хамт өгсөн байх ба дахин 2017 оны 7 дугаар сарын 16-ны өдөр “... Д.Б нь улсын хилээр байнга орж, гарч байдаг тул шүүхээс мэдэгдэх хуудас, нэхэмжлэлийн хувийг шүүхийн бичиг хүргэгчээр яаралтай гардуулж өгөх” хүсэлтийг тус тус гаргасан байна.

Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхээс 2017 оны 7 дугаар сарын 19-ний өдөр Я.Э-гийн нэхэмжлэлтэй, “ООО” ХХК-д холбогдох иргэний хэрэгт хариуцагчаар “ООО” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Б-д шүүхийн мэдэгдэх хуудсыг хүргүүлэхээр Ф дүүргийн ... дугаар хороо, ... дугаар хороолол, ... тоотод орших уг хаягт бүртгэлгүй бөгөөд мэдэгдэх хуудсыг буцаажээ. Улмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Э-гийн хүсэлтээр 2017 оны 7 дугаар сарын 24-ний өдөр шүүхээс хариуцагчид нэхэмжлэлийн хувийг гардуулах, шүүхийн мэдэгдэх хуудсыг хүргэхээр Т дүүргийн Цагдаагийн хэлтсийн орчимд очиход Д.Б нь “ООО” ХХК-ийн захирал байхаа больсон, нэхэмжлэл болон мэдэгдэх хуудсыг гардаж авах ёсгүй” гээд нэхэмжлэл болон мэдэгдэх хуудсыг гардан аваагүй байна.

Хариуцагч “ООО” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Б нь мэдэгдэх хуудсыг гардан аваагүй байх тул нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Э-ээс 2017 оны 7 дугаар сарын 25-ны өдөр хариуцагчийг шүүхэд албадан ирүүлэх хүсэлт гаргаж, Д.Б-гийн түр оршин суугаа газрыг Т дүүрэг, ... дугаар хороо, ... гудамж, дугаар байр ...дүгээр давхар ... тоот гэж хүсэлтэд тодорхойлсон, 2017 оны 7 дугаар сарын 26-ны өдөр Д.Б-г шүүхэд албадан ирүүлж, түүний гадаадад хувийн хэргээр зорчих эрхийг түдгэлзүүлэх буюу хилийн хориг тавих, энэ талаар арга хэмжээ авахыг Хил хамгаалах Ерөнхий газарт даалгах хүсэлтүүдийг тус тус гаргасныг Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2017 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн 181/Ш32017/10531 дүгээр захирамжаар хангаж, Д.Б-г шүүхэд албадан ирүүлж, түүнд Монгол Улсын хилээр гарахгүй байхыг өөрт нь даалгаж, захирамжийг Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба болон Хил хамгаалах ерөнхий газарт хүргүүлэхийг шүүгчийн туслахад даалгаж шийдвэрлэжээ.

Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2017 оны 8 дугаар сарын 04-ний 181/Ш32017/10657 дугаар захирамжаар хариуцагчийн төлөөлөгч Д.Б нь дээрх шүүгчийн 2017 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн 181/Ш32017/10531 дүгээр захирамжийг хүчингүй болгох хүсэлт ирүүлснийг хүлээн авч, хариуцагч “ООО” ХХК нь итгэмжлэгдсэн төлөөлөгч томилж шүүхэд ирүүлсэн гэх үндэслэлээр “... Д.Б-д Монгол Улсын хилээр гарахгүй байхыг даалгасан” шүүгчийн 181/Ш32017/10531 дүгээр захирамжийн 4 дэх заалтын үйлчлэл дуусгавар болсонд тооцож, хариуцагч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хүсэлтийг хангахаас татгалзсан үйл баримтууд тус тус тогтоогдож байна.

Дээрхээс үзвэл, Я.Э нь “ООО” ХХК-д холбогдуулан 2008 оноос хойш нэг үйл баримттай холбоотойгоор иргэний хэргийн шүүхэд удаа дараа нэхэмжлэл гаргаж, шүүхээс хариуцагчийн хаяг тодорхойгүй буюу “ООО” ХХК-ийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх бүрэн эрхтэй этгээд болох Д.Б нь улсын бүртгэлд бүртгэлтэй хаяг дээрээ оршин суудаггүй, Ч улсад амьдарч байсны улмаас нэхэмжлэлийн хувийг хариуцагчид гардуулж чадахгүй, хариуцагчийг албадан ирүүлэх боломжгүйн улмаас нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах, хэргийг хэрэгсэхгүй болгох зэрэг шалтгааны улмаас нэхэмжлэлийн шаардлагаа шийдвэрлүүлж чадахгүй, Я.Э-гийн хөндөгдсөн гэх эрх, ашиг сонирхол шүүхээр хамгаалуулж чадахгүй нөхцөл байдал бий болжээ.

Мөн “ООО” ХХК-ийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх бүрэн эрхтэй этгээд нь Д.Б болох нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаагаар нотлогдож байх бөгөөд Д.Б нь Ч улсад амьдардаг болох нь талуудын тайлбараар тогтоогдсон, талууд энэ талаар маргаагүй байна.

Ийнхүү Я.Э нь “ООО” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Б-г А хотод ирсэн байх цаг хугацаанд буюу 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдөр Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэлээ гаргаж, нэхэмжлэлийн хувийг хариуцагчид гардуулах ажиллагааг яаралтай хийх хүсэлт гаргасны дагуу нэхэмжлэгчийн тодорхойлсон хаягт шүүхийн мэдэгдэх хуудас хүргүүлэхэд тухайн хаягт “ООО” ХХК нь оршин байрладаггүй, Д.Б нь оршин суудаггүй гэх үндэслэлээр мэдэгдэх хуудсыг гардуулж чадаагүй, улмаар нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Э нь дахин хүсэлт гаргасны дагуу “ООО” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Б байгаа газарт буюу Т дүүргийн Цагдаагийн хэлтсийн орчимд шүүхийн мэдэгдэх хуудас, нэхэмжлэлийн хувийг гардуулахаар шүүгчийн туслах болон шүүхийн бичиг хүргэгч нар очиход Д.Б нь мэдэгдэх хуудсыг хүлээн авахаас татгалзаж, автомашины цонхоороо гаргаж шидсэн болох нь хэрэгт авагдсан шүүгчийн туслах Б.Ч, шүүхийн бичиг хүргэгч Т.Б нарын тайлбараар тогтоогдож байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1- д “Нэхэмжлэлийг хүлээн авч хэрэг үүсгэсэн шүүгч дараах ажиллагааг явуулна”, 67.1.2-Т “нэхэмжлэлийн хувийг хариуцагчид гардуулах”, мөн хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-т “Шүүхийн мэдэгдэх хуудсыг зохигч талын оршин суугаа буюу ажлын газрын хаягаар баталгаат шуудангаар, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлнэ. Шаардлагатай тохиолдолд шүүхийн мэдэгдэх хуудсыг утас, факс, цахилгаан буюу олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдэгдэж болно. Ийнхүү мэдэгдсэнээ баримтжуулсан байна”, 77.5-т “Мэдэгдэх хуудсыг түүнд заасан хүлээн авагчид гардуулан өгч, гарын үсэг зуруулж, гардуулсан огноо, цагийг тэмдэглэнэ. Хуулийн этгээдэд өгөх мэдэгдэх хуудсыг удирдах албан тушаалтан буюу холбогдох ажилтанд гардуулан өгч, гарын үсэг зуруулж, гардуулсан огноо, цагийг тэмдэглэнэ”, 77.7-т “Зохигч мэдэгдэх хуудсыг хүлээн авахаас татгалзвал энэ тухай мэдэгдэх хуудсанд тэмдэглэж шүүхэд буцаана. Энэ нь хэрэг хянан шийдвэрлэхэд саад болохгүй гэж тус тус зааснаар шүүхээс нэхэмжлэлд иргэний хэрэг үүсгэн нэхэмжлэлийн хувийг хариуцагчид гардуулснаар хэргийн оролцогчдын шүүхэд мэтгэлцэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тэгш эрхтэйгээр оролцож хэн аль нь эрх, ашгаа хамгаалах, хамгаалуулах боломж бүрдэх бөгөөд энэхүү боломжийг бий болгохын тулд хариуцагчийг шүүхэд ирүүлэх, нэхэмжлэлийн хувийг гардуулах нь шүүхийн үүрэг юм.

Хуульд зааснаар хуулийн этгээдэд өгөх шүүхэд дуудан ирүүлэх мэдэгдэх хуудсыг тухайн хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдэд гардуулан өгөх ба шүүхийн мэдэгдэх хуудсыг тухайн хуулийн этгээдийн оршин байгаа хаяг, хариуцагчийн оршин суугаа буюу ажлын газрын хаягаар баталгаат шуудангаар, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлж болохоор зохицуулсан

байх бөгөөд Я.Э-гийн нэхэмжлэлтэй иргэний хэргийн хувьд хариуцагч “ООО” ХХК нь бүртгэлтэй хаягтаа үйл ажиллагаа явуулдаггүй, тухайн компанийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээд болох Д.Б нь бүртгэлтэй хаягтаа оршин суухаа больсон, Ч улсад амьдарч байгаагийн улмаас хариуцагч байгууллагын үйл ажиллагаа явуулдаг хаяг, гүйцэтгэх захирал Д.Б-гийн оршин суугаа буюу ажлын газрын хаягаар баталгаат шуудангаар мэдэгдэх хуудсыг хүргүүлэх, хариуцагчийг шүүхэд ирүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэний улмаас хариуцагчид нэхэмжлэлийн хувийг гардуулах, шүүхийн мэдэгдэх хуудсыг шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлэхээр шүүгч О.О үүрэг өгснийг буруутгах үндэслэл тогтоогдохгүй байна.

Шүүхийн мэдэгдэх хуудас хүргэх, нэхэмжлэлийн хувийг гардуулах ажиллагаа нь зөвхөн албан ёсны бүртгэлтэй гэрийн хаяг, оршин суугаа газрын хаяг, ажлын газрын хаягаар хүргэхийг шаардахгүй бөгөөд хариуцагчаар татагдсан этгээд нь нэгэнт бүртгэлтэй хаягтаа оршин байдаггүй болох нь тогтоогдсон энэ тохиолдолд хариуцагчид мэдэгдэх хуудас, нэхэмжлэлийн хувийг гардуулах боломжгүй бол шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлэх ба энэ талаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 77 дугаар зүйлийн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-т зохицуулжээ.

Шүүгч О.О нь хариуцагчид нэхэмжлэлийн хувийг гардуулах, шүүхийн мэдэгдэх хуудсыг Д.Б-гийн байгаа газарт хүргэх үүргийг шүүхийн ажилтнуудад өгсөн үйл баримт тогтоогдож байна. Харин шүүгчийн туслах, шүүхийн бичиг хүргэгч нар нь нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Э-тэй хамт Д.Б-гийн байгаа газарт очсон нь шүүгч О.О-гийн үйл ажиллагаатай хамааралгүй бөгөөд шүүхийн ажилтнуудын үйлдэлтэй холбогдуулан шүүгчийг буруутгах нь үндэслэлгүй. Мөн шүүгч Д.Д нь Т дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилогдож, түүний оронд шүүгч О.О нь Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд шилжин томилогдсон байх ба 2017 оны 6 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн шүүгч Д.Д-гийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байсан 122 хэрэгт шүүгч О.О нь ажиллагаа явуулах болжээ. Ийнхүү шилжин ирээд удаагүй, шүүхийн мэдэгдэх хуудсыг шуудангаар хүргүүлэхэд шаардагдах баталгаат гарын үсэг нь солигдож амжаагүй нөхцөлд үүнийг дагаад шүүхийн, шүүгчийн үйл ажиллагаа түр зогсох, мэдэгдэх хуудсыг хүргүүлэхгүй байх, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан ажиллагааг хийхгүй байх нөхцөл байдал үүсэх ёсгүй бөгөөд шүүн таслах ажиллагааг саадгүй үргэлжлүүлэн явуулах үүрэг нь шүүгчийн үүрэг тул баталгаат гарын үсэг солигдоогүй боловч мэдэгдэх хуудас, нэхэмжлэлийг гардуулах үүргийг туслахдаа өгсөн шүүгчийн үйл ажиллагааг хууль болон Шүүгчийн ёс зүйн дүрэм зөрчсөн гэж үзэх боломжгүй.

Түүнчлэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.3-т “Хэргийн оролцогч шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирэх үүрэгтэй”, мөн хуулийн 77 дугаар зүйлийн 77.7-д “Зохигч мэдэгдэх хуудсыг хүлээн авахаас татгалзвал энэ тухай мэдэгдэх хуудсанд тэмдэглэж шүүхэд буцаана. Энэ нь хэрэг хянан шийдвэрлэхэд саад болохгүй” гэж зааснаар мэдэгдэх хуудсыг хариуцагч хүлээн авахаас татгалзсан явдал нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад болохгүй бөгөөд 2017 оны 7 дугаар сарын 24-ний өдөр Д.Б нь шүүхэд хүрэлцэн ирэх үүрэгтэй гэдгээ мэдсэн хэдий ч шүүхийн мэдэгдэх хуудсыг хүлээн авахаас татгалзаж, шүүхийн тавьсан шаардлагыг биелүүлж, шүүхийн дуудсан цагт хүрэлцэн ирэх иргэний үүргээ биелүүлээгүй, шүүхийг үл хүндэтгэсэн нь шүүгчийн 2017 оны 8 дугаар сарын 04-ний 181/Ш32017/10657 дугаар захирамж гарах үндэслэлийг бий болгосон гэж үзэхээр байна.

Тэрчлэн Я.Э-гийн нэхэмжлэлтэй, ООО ХХК-д холбогдох иргэний хэрэг нь 2008 оноос хойш иргэний хэргийн шүүхээр хянан шийдвэрлэгдэх ажиллагаа явагдаж,

гурван шатны шүүхээр удаа дараа хянан шийдвэрлэгдэж байсан байх бөгөөд Монгол Улсын дээд шүүхээс 2011 онд, 2013 онд, Иргэний хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхээс 2014 онд тус тус хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж шийдвэрлэж байсан, хэрэг хянан шийдвэрлэх хугацаа удааширч байсан болох нь хэрэгт авагдсан баримтуудаар тогтоогдож байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.1- д “Шүүгч дараах үндэслэл байвал хэрэг хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй”, 91.1.1-д “урьд нь уг хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, эвлэрүүлэн зуучлагч, иргэдийн төлөөлөгч, шүүх

хуралдааны нарийн бичгийн дарга, гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрчийн хувиар оролцсон”, мөн хуулийн 92 дугаар зүйлийн 92.1-д “Энэ хуулийн 91 дүгээр зүйлд заасан татгалзан гарах үндэслэл байвал шүүгч, иргэдийн төлөөлөгч, шинжээч, орчуулагч хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга энэ тухайгаа шүүх хуралдаан эхлэхээс өмнө эсхүл татгалзан гарах үндэслэл шүүх хуралдааны явцад тогтоогдвол тухайн үед нь мэдэгдэж татгалзан гарах үүрэгтэй” гэж заасны дагуу Я.Э-гийн нэхэмжлэлтэй, “ООО” ХХК-д холбогдох иргэний хэргийн материалд Ш дүүргийн шүүхийн 2012 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 974 дүгээр шийдвэр авагдсан даруйд шүүгч О.О нь өөрөө хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарах үүргээ биелүүлсэн байна.

Шүүгч О.О-г Я.Э-гийн нэхэмжлэлийг хүлээн авсан даруйд урьд нь уг нэхэмжлэл бүхий иргэний хэргийн шүүх хуралдаанд нарийн бичгийн даргаар оролцож байсан гэдгээ мэдэх ёстой, мэдэх үүрэгтэй байсан гэж буруутгах боломжгүй.

Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1-д “Шүүгч хуульд тусгайлан ёс зүйн зөрчил болохоор заасан болон энэ дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг ёс зүйн зөрчил гэж үзнэ”, 2-т “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй” гэж тус тус зааснаар шүүгч О.О нь аливаа хуулийн зохицуулалтыг хэрхэн ойлгож, тайлбарлаж, хэрэглэх нь түүний бүрэн эрхийн асуудал бөгөөд шүүгчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлж захирамж гаргасны төлөө ёс зүйн зөрчилд холбогдуулан шалгах үндэслэл байхгүй. Хэрэв шүүгчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүсэлт шийдвэрлэн захирамж гаргахдаа хууль зөрчсөн гэж үзвэл хэргийн оролцогч захирамжид гомдол гаргах эрхтэй юм.

Нөгөөтээгүүр Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т “... Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй талаар заасан. Энэхүү эрхээ эдэлж, Я.Э нь өөрийн эрх, ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзэж, шүүхэд нэхэмжлэл гаргасан байх тул талуудын шүүхэд мэдүүлэх, шударга шүүхээр шүүлгэх, шүүх ажиллагаанд биечлэн оролцох эрхийг нь хангаж, нэгэнт гаргасан нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлд дүгнэлт хийж, хэрэг маргааныг эцэслэн шийдвэрлэх нь шүүхийн үүрэг юм.

Дээрхээс үзвэл; шүүгч О.О нь Я.Э-д давуу байдал үүсгэж, хэт нэг талыг баримталсан гэх үйл баримт тогтоогдоогүй төдийгүй хуульд тусгайлан ёс зүйн зөрчил болохоор заасан болон Шүүгчийн ёс зүйн дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн үйлдэл гаргаагүй байхад Шүүхийн Ёс зүйн хорооноос түүний хэрэг

хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдааг ёс зүйн зөрчилд хамааруулан түүнийг сахилгын зөрчил гаргасан гэж дүгнэн сахилгын шийтгэл ногдуулсан нь үндэслэл муутай байна.

Иймд Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 01 дүгээр магадлалыг хүчингүй болгож, гомдол гаргагч Н.М-ийн гомдлыг хангахгүй орхиж, шүүгч О.О-гийн гомдлыг хангаж шийдвэрлэлээ.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 01 дүгээр магадлалыг хүчингүй болгож, шүүгч О.О-д үүсгэсэн сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгосугай.

2.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.5-д зааснаар шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийг буруу хэрэглэсэн, хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн нь шүүхийн шийдвэр гарахад нөлөөлсөн гэж үзвэл маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нар магадлалыг гардан авсан, эсхүл хүргүүлснээс хойш 14 хоногийн дотор Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд гомдол гаргах эрхтэй.

ШҮҮГЧ

О.НОМУУЛИН

ШҮҮГЧ

Э.ЗОРИГТБААТАР

ШҮҮГЧ

Г.БИЛГҮҮН

УИХ.МН
СУДАЛГААНЫ САН



МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЁС ЗҮЙН ХОРООНЫ МАГАДЛАЛ

2018 оны 4 сарын 13 өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

Ф аймаг дахь сум дундын Иргэний хэргийн
анхан шатны шүүхийн шүүгч Б.М, К.Б нарт
сахилгын шийтгэл ногдуулах тухай

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааныг тус хорооны дарга Н.Эрдэнэцогт даргалж, гишүүн А.Доржготов, Ч.Оюунцэцэг, О.Мөнхсайхан, Д.Сүнжид, В.Жавхлан нарын бүрэлдэхүүнтэй, шүүгч Б.М, К.Б нар, /онлайнаар/ гомдол гаргагч Ф аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа С.П, /онлайнаар/ тус хорооны ажлын албаны хяналт шалгалт хариуцсан референт Б.Энхбаатар, хуралдааны тэмдэглэл хөтлөгчөөр шинжээч А.Энхбаатар нарыг оролцуулан, Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдааны танхимд хийж, шүүгч Б.М, К.Б нарт холбогдох 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 34 дүгээр тогтоолтой сахилгын хэргийг гишүүн В.Жавхлангийн илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Ф аймгийн Онцгой байдлын газрын дарга хурандаа С.П гаргасан гомдол болон хуралдаанд гаргасан тайлбартаа: “Ф аймгийн Онцгой байдлын газрын нэхэмжлэлтэй газрын маргаан бүхий иргэний хэргийг хэлэлцэн шийдвэрлэсэн тус аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 264 дүгээр шийдвэрийг 2017 оны 5 дугаар сарын 19-ний өдөр хүлээн авч танилцаад, уг шийдвэрийг эс зөвшөөрч 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 19/203 тоот албан бичгээр давж заалдах гомдол гаргасан билээ.

Гомдлыг Онцгой байдлын газрын даргын эзгүйд Газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, хошууч Б.А гарын үсэгтэй, байгууллагын тамгатай, албан бланкаар шүүхэд хүргүүлсэн болно. Уг гомдлыг хүлээн авсан шүүгч Б.М нь гомдлыг шийдвэрлэхдээ Газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, хошууч Б.А-г иргэний хэрэгт оролцож байгаагүй гэх үндэслэлээр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 161 дүгээр зүйлийн 161.1-д заасныг үндэслэн 2017 оны 6 дугаар сарын 06-нд давж заалдах гомдлыг хүлээн авахаас татгалзах тухай 1577 дугаартай шүүгчийн захирамж гаргасан болно.

Байгууллагыг төлөөлөх итгэмжлэлийг ахлах нягтлан бодогч, ахмад М.Е, Сургалт сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн, хошууч Х.У нарт олгож, Сум дундын шүүхийн анхан шатны шүүх хуралдаанд оролцуулсан юм.

Сум дундын шүүхийн анхан шатны шүүхийн 2017 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 264 дүгээр шийдвэрээр Онцгой байдлын газрын нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Энэ нь төрийн байгууллагын нэхэмжлэлийн асуудал учраас Онцгой байдлын газрын дарга эрх хэмжээнийхээ хүрээнд давж заалдах шатны шүүхэд хэнийг итгэмжлэлээр оролцуулах эсэхийг хараахан шийдээгүй байсан тул Онцгой байдлын газрын удирдлагууд давж заалдах гомдлыг л хуулийн хугацаанд гаргасан.

Тухайн үед Онцгой байдлын газрын дарга, хурандаа С.П А хотод томилолтоор ажиллаж байсан тул давж заалдах гомдолд, Онцгой байдлын газрын даргын эзгүйд орлож ажилласан Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, хошууч Б.А-гийн гарын үсэгтэй хүргүүлсэн. Давж заалдах гомдлын хугацааг хүндэтгэн үзэх шалтгаантай хэтрүүлсэн тул Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 167 дугаар зүйлийн 167.1-д заасныг үндэслэн давж заалдах гомдлын хугацааг сэргээлгэх тухай хүсэлт гаргаж байсан боловч уг хүсэлтийг хүлээж авсан шүүгч Б.М нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.2-т заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн гэдэгт хамаарагдахгүй гэж хүсэлтийг хангахаас татгалзсан 2017 оны 6 дугаар сарын 14-ний өдөр 1665 дугаартай захирамж гаргасан болно.

Түүний дараа 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдөр Сум дундын анхан шатны шүүхэд давж заалдах хугацааг сэргээж өгөх талаар дахиж гомдол гаргасан боловч хүлээн авсан шүүгч К.Б нь "гомдол гаргах эрхгүй захирамжид гомдол гаргасан байна" гэж гомдлыг хүлээн авахаас татгалзсан 2017 оны 7 дугаар сарын 03-ны өдөр 1863 дугаартай захирамж гаргасан болно.

Иймд шүүгч Б.М, К.Б нар нь удаа дараа үндэслэлгүй захирамж гарган, өөрсдийн гаргасан шийдвэрт давж заалдах гомдол гаргах Төрийн байгууллагын эрхийг хязгаарлаж шүүгчийн ёс зүйгүй байдал гаргаж, хариуцагч талд үйлчилж болзошгүй байгаа тул Төрийн байгууллага болох Онцгой байдлын газрын давж заалдах эрхийг сэргээж, ёс зүйгүй байдал гаргасан шүүгч Б.М, К.Б нарт хариуцлага тооцож өгөхийг хүсэж гомдол гаргаж байна. Гомдлоо дэмжиж оролцож байна гэв.

Шүүхийн Ёс зүйн хороонд шүүгч Б.М ирүүлсэн болон хуралдаанд гаргасан тайлбартаа: "Нэхэмжлэгч Ф аймгийн Онцгой байдлын газрын нэхэмжлэлтэй, Ф аймгийн Т сумын ... багийн иргэн Т.Е-д холбогдох "Хууль бусаар эзэмшиж байгаа 876 м.кв газрыг чөлөөлүүлэх тухай" иргэний хэрэгт Сум дундын 2 дугаар шүүхийн 2014 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн 677 дугаартай шүүгчийн захирамжаар иргэний хэрэг үүсгэснээс хойших хугацаанд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуульд заасан журмын дагуу явагдаж байсан.

Энэ хэргийг Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны Иргэний хэргийн шүүх хуралдааны 2015 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 565 дугаар тогтоолоор хэргийг дахин шийдвэрлэхээр анхан шатны шүүхэд буцаасан иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2015 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 64 дүгээр магадлалыг хэвээр үлдээсэн тул тус шүүхийн Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн хэргийг Иргэн-2014 программын дагуу тойргийн журмаар шүүгч надад хуваарилж, 2015 оны 10 дугаар сарын 05-ны өдөр хүлээлгэн өгсөн.

Хэрэгт магадлалд заасан болон бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаануудыг хийж дуусгаад шүүх хуралдаанаар хэлэлцэх үед нэхэмжлэгч Ф аймгийн Онцгой байдлын газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч Х.У-гийн гаргасан "тухайн маргаан бүхий газрын асуудлыг шийдвэрлүүлэхээр Ф аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хандах шаардлагатай байна, газрын асуудлыг шийдсэний дараа энэ хэргийг шийдүүлэх тухай" хүсэлтийг хүлээн авч энэ хэргийг Ф аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 326 дугаартай шүүгчийн захирамжаар "шүүх хуралдааныг хойшлуулж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн байсан.

Талуудын маргаан бүхий газрын асуудлын тухай захиргааны хэргийн шүүхийн эцсийн шийдвэр болох 2017 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 84 дугаартай Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол гарсан тул нэхэмжлэгч Ф аймгийн Онцгой байдлын газрын нэхэмжлэлтэй, Ф аймгийн Т сумын ... багийн иргэн Т.Е-нд холбогдох иргэний хэргийг хянан

шийдвэрлэх ажиллагааг сэргээн явуулах тухай тус шүүхийн шүүгчийн 2017 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 948 дугаартай шүүгчийн захирамж гарсан.

Нэхэмжлэгч Ф аймгийн Онцгой байдлын газрын нэхэмжлэлтэй, иргэн Т.Е-д холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээн явуулах тухай захирамж гармагц нэхэмжлэгч Ф аймгийн Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа С.П нь Иргэний хуулийн 61 дугаар зүйлийн 61.1, 62 дугаар зүйлийн 62.4-д заасны дагуу иргэний хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох эрхийг 2017 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр 19/112 дугаар албан бичгээр тус газрын Сургалт сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн, хошууч Х.У, ахлах нягтлан бодогч, ахмад М.Е нарт олгосон болно.

2017 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцээд Монгол Улсын нэрийн өмнөөс гарсан Ф аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 264 дугаартай шийдвэрийг шүүх хуралдаанд оролцсон нэхэмжлэгч Ф аймгийн Онцгой байдлын газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч Х.У, М.Е нар нь 2017 оны 5 дугаар сарын 19-ний өдөр гардаж авсан байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119.4-д заасны дагуу нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нар шийдвэрийг гардаж авсан өдрөөс шийдвэрт давж заалдах гомдол гаргах 14 хоногийн хугацаа тоологдохоор Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.2-т заасан байгаа.

Ф аймгийн Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, хошууч Б.А нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 161 дүгээр зүйлийн 161.1-д заасан давж заалдах гомдол гаргах эрх бүхий этгээд биш бөгөөд мөн Иргэний хуулийн 64 дугаар зүйлийн 64.1-д заасны дагуу нэхэмжлэгч байгууллагаас түүнд итгэмжлэл олгоогүй тул Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 164 дүгээр зүйлийн 164.3-ийг баримтлан түүний 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 19/203 дугаартай албан бичгээр ирүүлсэн "Давж заалдах гомдол"-ыг хүлээн авахаас татгалзах тухай 2017 оны 6 дугаар сарын 06-ны 1577 дугаартай шүүгчийн захирамж гаргасан болно.

Ф аймгийн Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа С.П нь 2017 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 19/214 дугаар албан бичгээр "Давж заалдах гомдлын хугацааг сэргээлгэх тухай" хүсэлт ирүүлснийг тус шүүхийн 2017 оны 6 дугаар сарын 14-ний өдөр 1665 дугаартай "Хүсэлтийг хангахаас татгалзах тухай" захирамж гаргасан.

Учир нь, нэхэмжлэгчийн шүүхэд гаргаж өгсөн Онцгой байдлын ерөнхий газраас Ф, П, К, Ш аймгийн Онцгой байдлын газрын дарга нарт хаягласан 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 1034 дугаартай "Сургалтад хамруулах тухай" 2017 оны 5 дугаар сарын 30, 31-ний өдөр А хотод зохион байгуулагдах сургалтад мал, амьтны гоц халдварт өвчин гарсан үед гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги удирдлага, зохицуулалтаар ханган ажиллах нэг албан тушаалтыг тус сургалтад оролцуулахыг хүссэн тухай албан бичиг, мөн 2017 оны 5 дугаар сарын 28-аас 2017 оны 6 дугаар сарын 04-ний хооронд А хотод байсан гэдэг нь нэхэмжлэгч Ф аймгийн Онцгой байдлын газрын давж заалдах гомдол гаргах хугацааг сэргээх үндэслэл болохгүй юм. Мөн энэ сургалтад өөрөө оролцож ирснийг хүндэтгэн үзэх шалтгаан гэж үзэх боломжгүй, нэхэмжлэгч байгууллагыг итгэмжлэгдсэн төлөөлөгч нар нь хуулийн дагуу төлөөлж байсан. (Тус нэхэмжлэгч байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгч Х.У нь 2014 оноос эхлэн оролцож байгаа болно.)

Иймээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.3-т заасныг баримтлан давж заалдах гомдол нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нарт шийдвэрийг гардуулсан 2017 оны 5 дугаар сарын

19-ний өдрөөс эхлэх 14 хоногийн хугацаанд нэхэмжлэгч хуульд заасан давж заалдах гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэхэд саад болсон, хэрэгжүүлэх боломжийг нь хязгаарласан хүндэтгэн үзэх шалтгааныг шүүхэд нотлоогүй учраас түүний уг 14 хоногийн хугацааг сэргээлгэх тухай хүсэлтийг 2017 оны 6 дугаар сарын 06-ны 1577 дугаартай шүүгчийн захирамжаар хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн юм.

Шүүгч Б.М би Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу, хуулийг чанд сахиж явуулсан бөгөөд хариуцагч талаас шүүгчид нөлөөлсөн, шүүгч ёс зүйгүй байдал гаргасан асуудал байхгүй болно. Сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү гэв.

Шүүхийн Ёс зүйн хороонд шүүгч К.Б ирүүлсэн болон хуралдаанд гаргасан тайлбартаа:

Ф аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүгч К.Б би Ф аймгийн Онцгой байдлын газрын 2017 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 19/424 дугаартай албан бичгээр гаргасан гомдолтой танилцаж дараах тайлбарыг гаргаж байна.

Ф аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 1665 дугаартай "Хүсэлтийг хангахаас татгалзах тухай" шүүгчийн захирамжийн 2 дахь заалтаар "энэ захирамжид гомдол гаргах эрхгүй болохыг дурдсугай" гэсэн байхад уг захирамжийг эс зөвшөөрч нэхэмжлэгч Онцгой байдлын газар нь тухайн шатны шүүхэд гомдол гаргасныг тус шүүхийн мэдээлэл лавлагааны мэргэжилтэн хүлээн авч, бүртгэлд оруулан хуваарийн дагуу шүүгч К.Б надад хүлээлгэн өгсөн юм.

Нэхэмжлэгч Ф аймгийн Онцгой байдлын газрын давж заалдах гомдол гаргах хугацааг сэргээхийг хүссэн хүсэлтийг шийдвэрлэсэн Ф аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 1665 дугаартай "Хүсэлтийг хангахаас татгалзах тухай" шүүгчийн захирамжид Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.3 дахь заалтыг удирдлага болгосон байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1-т "шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэр"-т тухайн шатны шүүхэд гомдол гаргах асуудлыг зохицуулсан ба дээрх шүүгчийн захирамжид удирдлага болгосон хуулийн заалтад тухайн шатны шүүхэд гомдол гаргах эрх байхгүй болно.

Нэгэнт Ф аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 1665 дугаартай "Хүсэлтийг хангахаас татгалзах тухай" шүүгчийн захирамжийн 2 дахь заалтаар "энэ захирамжид гомдол гаргах эрхгүй болохыг дурдсугай" гэсэн тул шүүгч би Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.1-д заасныг баримтлан 2017 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 1863 дугаартай шүүгчийн захирамжаар нэхэмжлэгч байгууллагын тухайн шатны шүүхэд гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзсан болно.

Иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу явагдах ба миний бие уг хуульд заасан журмын дагуу нэхэмжлэгч байгууллагын гомдлыг хүлээн авахаас татгалзсан болно.

Иймд шүүгч миний бие хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлсэн ба хариуцагч талаас надад нөлөөлсөн асуудал байхгүй, хариуцагч тал үйлчилсэн гэдгийг хүлээн зөвшөөрөхгүй Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу захирамж гаргасныг ёс зүйн зөрчил гэж үзэж байгааг хүлээн зөвшөөрөхгүй болно. Сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү гэв.

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанаар хэлэлцээд ҮНДЭСЛЭХ нь:

Гомдол гаргагч ф аймгийн Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа С.П нь ф аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М, К.Б нарт холбогдуулан удаа дараа үндэслэлгүй захирамж гаргаж, өөрсдийн гаргасан шийдвэрт давж заалдах гомдол гаргах Төрийн байгууллагын эрхийг хязгаарлаж, хариуцагч талд үйлчилж болзошгүй байгаа тул нэхэмжлэгч Онцгой байдлын газрын давж заалдах эрхийг сэргээж, шүүгчийн ёс зүйн дүрмээ зөрчиж, хариуцлагагүй, ёс зүйгүй байдал гаргасан шүүгч Б.М, К.Б нарт хариуцлага тооцож өгнө үү" гэсэн агуулга бүхий гомдлыг гаргажээ.

Шүүгч Б.М: Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулсан бөгөөд хариуцагч талаас шүүгчид нөлөөлсөн , шүүгч ёс зүйгүй байдал гаргасан асуудал байхгүй гэж;

Шүүгч К.Б: 2017 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 1863 дугаартай захирамжаар нэхэмжлэгч байгууллагын тухайн шатны шүүхэд гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзсан. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу захирамж гаргасныг ёс зүйн зөрчил гэж үзэж байгааг хүлээн зөвшөөрөхгүй гэсэн тайлбарыг тус тус гаргасан байна.

Ф аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 264 дугаар шийдвэрийг нэхэмжлэгч тал болох Ф аймаг дахь Онцгой байдлын газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч Х.У, Ш.Е нар 2017 оны 5 дугаар сарын 19-ний өдөр гардан авсан байна.

Нэхэмжлэгч талыг төлөөлөн Ф аймаг дахь Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, хошууч Б.А 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдөр давж заалдах гомдол гаргасныг шүүгч Б.М хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд огт оролцоогүй, давж заалдах гомдол гаргах эрхгүй этгээд гаргасан гэж үзэж, 2017 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 1577 дугаар захирамжаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 164 дүгээр зүйлийн 164.3-т заасныг удирдлага болгож, хүлээн авахаас татгалзжээ.

Ф аймаг дахь Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа С.П нь давж заалдах гомдол гаргах хугацаанд буюу 5 дугаар сарын 28-ны өдрөөс 6 дугаар сарын 04-ний өдөр хүртэл А хотод томилолтоор ажилласан, сургалтад хамрагдсан болохыг нотолсон болон бусад холбогдох нотлох баримтуудыг хавсарган давж заалдах гомдол гаргах хугацааг сунгуулах тухай хүсэлтийг 2017 оны 6 дугаар сарын 08-нд гаргасныг шүүгч Б.М хүлээн авсан байна.

Уг хүсэлтийг шүүгч Б.М нь нэхэмжлэгч талын удирдлагыг 2017 оны 5 дугаар сарын 28-аас 2017 оны 6 дугаар сарын 04-ний хооронд А хотод байсан гэдэг нь нэхэмжлэгч Ф аймгийн Онцгой байдлын газрын давж заалдах гомдол гаргах хугацааг сэргээх үндэслэл болохгүй. Мөн сургалтад өөрөө оролцож ирснийг хүндэтгэн үзэх шалтгаан гэж үзэх боломжгүй. Нэхэмжлэгч байгууллагыг итгэмжлэгдсэн төлөөлөгч нар нь хуулийн дагуу төлөөлж байсан гэж дүгнээд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.3-т заасныг удирдлага болгож хүлээн авахаас дахин татгалзаж, 2017 оны 6 дугаар сарын 14-ны өдрийн 1665 дугаар захирамж гаргасан байна.

Шүүгч К.Б нь нэхэмжлэгч Ф аймгийн Онцгой байдлын газрын давж заалдах гомдол гаргах хугацааг сэргээлгэхийг хүссэн хүсэлтийг хангахаас татгалзаж шийдвэрлэсэн Ф аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 1665 дугаартай шүүгчийн захирамжид гаргасан гомдлыг “ гомдол гаргах эрхгүй захирамжид гомдол гаргасан “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1-т заасан "шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэр"-т тухайн шатны шүүхэд гомдол

гаргах асуудлыг зохицуулсан ба хуулийн энэ үндэслэлд буюу 170 дугаар зүйлийн 170.1-т хамаарахгүй “ гэх үндэслэлээр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.1-д заасныг удирдлага болгож, гомдлыг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэжээ.

Шүүгч Б.М нэхэмжлэгч талд хүндэтгэн үзэх шалтгаан байсан нь нотлогдсоор байхад давж заалдах гомдол гаргах хугацааг сэргээх хуулийн тодорхой заалтууд (ИХШХШТХ-ийн 120.3)-ыг хэрэглэхээс татгалзсан захирамж гаргасан байна Нэгэнт уг захирамжид давж заалдах гомдол гаргах эрхгүйг дурдсан учраас нэхэмжлэгч тал Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 14-т тодорхой заасан "шударга шүүхээр шүүлгэх эрх." ялангуяа "шүүхийн шийдвэрийг давж заалдах" эрхээ эдлэх боломжгүй болжээ.

Нэхэмжлэгч Ф аймгийн Онцгой байдлын газар хуулийн хугацаанд давж заалдах гомдол гаргасныг шүүгч Б.М хүлээн авахаас үндэслэлгүйгээр татгалзсан, давж заалдах гомдлын хугацаа сэргээлгэх хүсэлтийн үндэслэл нь хүндэтгэн үзэх шалтгаанд тооцогдохоор байхад тооцоогүй байна. Тиймд шүүгч Б.М-г Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д заасан "мэргэжлийн ёс зүйгээ ухамсарласан,... “бусдын эрхийг дээдлэх чадвартай байх " шаардлага, Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3-т заасан "хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, хууль дээдлэх зарчим" , мөн дүрмийн 3.3-т заасан "хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх үүргийг тус тус зөрчсөн гэж үзсэн нь үндэслэлтэй байна.

Шүүгч Б.М, К.Б нар нь хуульд заасан журмын дагуу гомдол гаргагчийн давж заалдах гомдол, гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацааг сэргээлгэхийг хүссэн хүсэлтийг шийдвэрлэсэн гэж тайлбарлаж, мөн тийм мэт харагдаж байх боловч Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар зохигчийн хүсэлтийг шийдвэрлэх хуулийн зохицуулалт буюу хэрэглэвэл зохих хуулийн заалтыг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хуулийн заалтыг баримталснаас тухайн захирамжуудад гомдол гаргах эрхийг хязгаарласан, шүүгч Б.М өөрийн гаргасан шийдвэрт давж заалдах гомдол гаргах зохигчийн эрхийг 2 удаа хангахгүйгээр шийдвэрлэсэн байна. Шүүгч К.Б нь нэг шүүгч нөгөө шүүгчийнхээ гаргасан эрхийн актыг хянах, эрх зүйн дүгнэлт өгөх хуулийн зохицуулалт байхгүй байхад Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1-д заасны дагуу тухайн шатны шүүхийн шийдвэрлэх ёстой асуудлыг шийдвэрлэж, хууль зөрчжээ.

Үндсэн-хуулийн 49-р зүйлийн 1-д "Шүүгч хараат бус байж. гагцхүү хуульд захирагдана" гэж тодорхой заасан Мөн хууль дээдлэх зарчим нь процессын хуулиуд болон Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд ч тусгалаа олсон Түүнчлэн, ШЁЗД-ийн 1.3-р зүйлийн 1-д зааснаар "хууль дээдлэх" зарчмыг хувийн зан чанар болгон төлөвшүүлэхийг шүүгчид үүрэг болгоод зогсохгүй энэ дүрмийн 3.3-р зүйлд "Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй" гэж тодорхой заасан. Өөрөөр хэлбэл, шүүгч аливаа хэрэг, маргааныг дур зоргоороо биш зөвхөн хуулийг зөв хэрэглэж, хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий шийдвэрлэх үүрэгтэйг эдгээр эрх зүйн эх сурвалжид тодорхой тусгасан байх ба эдгээр зарчим, үүргийг шүүгч К.Б-г хэрэгжүүлээгүй байна гэж үзэхээр байна.

Нэр бүхий шүүгч нарын зохигчийн гомдол, хүсэлт хянан шийдвэрлэсэн ажиллагаа нь Үндсэн хуульд заасан давж заалдах гомдол гаргах зохигчийн үндсэн эрхийг зөрчсөн байна. Учир нь;

Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т зааснаар “Монгол Улсын иргэн нь Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, шүүхийн шийдвэрийг

давж заалдах эрхтэй.” Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 4 дүгээр зүйлийн 4.1.5, 16 дугаар зүйлийн 16.1-д тус тус зааснаар шүүгч нь “хүний эрх”-ийг хуулийн хүрээнд дээдлэх, хамгаалах үндсэн үүрэгтэй байна. Иймд Ф аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М, К.Б нарт түүнд сахилгын хэрэг үүсгэсэн гомдол хянан хэлэлцэх хуралдааны тогтоолыг үндэслэлтэй гэж бүрэлдэхүүн дүгнэж, сануулах сахилгын шийтгэл ногдуулахаар тогтов.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35, 36 дугаар зүйл, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйл, Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5.7.1, 5.13-т заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Ф аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М, К.Б нарт “сануулах “сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Энэ магадлалын хувийг шүүгч нарт болон гомдол гаргагчид хүргүүлэхийг тус хорооны Ажлын албанд даалгасугай.

3.Магадлалыг эс зөвшөөрвөл гардан авснаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.

ДАРГАЛАГЧ

Н.ЭРДЭНЭЦОГТ

ГИШҮҮН

В.ЖАВХЛАН

UIN.MN
СУДАЛГААНЫ САН



ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ
МАГАДЛАЛ

2018 оны 7 сарын 05 өдөр

Дугаар 221/ЁМ2018/0392

Улаанбаатар хот

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн
хорооны 2018 оны 4 дүгээр сарын 13-ны
өдрийн 30 дугаар магадлалын тухай

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Батбаатар даргалж, шүүгч Г.Билгүүн, шүүгч Д.Баатархүү нарын бүрэлдэхүүнтэй, Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн “Ф аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М, К.Б нарт сахилгын шийтгэл ногдуулах тухай” 30 дугаар магадлалыг шүүгч Б.М, К.Б нарын гаргасан давж заалдах гомдлоор, шүүгч Д.Баатархүүгийн илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 30 дугаар магадлалаар: Ф аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М, К.Б нарт “сануулах” сахилгын шийтгэл ногдуулж шийдвэрлэжээ.

Шүүгч Б.М давж заалдах гомдолдоо: “...шүүгч Б.М миний бие Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 30 дугаартай магадлалыг дараах үндэслэлээр эс зөвшөөрч байна.

Нэхэмжлэгч Ф аймгийн Онцгой байдлын газрын нэхэмжлэлтэй, Ф аймгийн Т сумын ... багийн иргэн Т.Е-д холбогдох “Хууль бусаар эзэмшиж байгаа 876 м.кв газрыг чөлөөлүүлэх тухай” иргэний хэргийг Монгол Улсын Дээд Шүүхийн Хяналтын шатны Иргэний хэргийн шүүх хуралдааны 2015 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 565 дугаар тогтоолоор хэргийг дахин шийдвэрлэхээр анхан шатны шүүхэд буцаасан Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2015 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 64 дүгээр магадлалыг хэвээр үлдээсэн тул тус шүүхийн Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн хэргийг Иргэн-2014 программын дагуу тойргийн журмаар шүүгч надад хуваарилж, 2015 оны 10 дугаар сарын 05-ны өдөр хүлээлгэн өгсөн.

Тус иргэний хэрэгт нэхэмжлэгч Ф аймгийн Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа С.П нь Иргэний хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1, 62 дугаар зүйлийн 62.4-д заасны дагуу иргэний хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох эрхийг 2017 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр 19/112 дугаар албан бичгээр тус газрын Сургалт сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн, хошууч Х.У, ахлах нягтлан бодогч, ахмад М.Е нарт олгосон болно.

2017 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцээд Монгол Улсын нэрийн өмнөөс гарсан Ф аймаг дахь сум дундын

иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 264 дугаартай Шийдвэрийг шүүх хуралдаанд оролцсон нэхэмжлэгч Ф аймгийн Онцгой байдлын газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч Х.У, М.Е нар нь 2017 оны 5 дугаар сарын 19-ний өдөр гардаж авсан.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119.4-д заасны дагуу нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нар шийдвэрийг гардаж авсан өдрөөс шийдвэрт давж заалдах гомдол гаргах 14 хоногийн хугацаа тоологдохоор мөн хуулийн 120 дугаар зүйлийн 120.2-т заасан байгаа. Ф аймгийн Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, хошууч Б.А нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 161 дүгээр зүйлийн 161.1-д заасан давж заалдах гомдол гаргах эрх бүхий этгээд биш, мөн Иргэний хуулийн 64 дугаар зүйлийн 64.1-д заасны дагуу нэхэмжлэгч байгууллагаас түүнд итгэмжлэл олгоогүй тул Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 164 дүгээр зүйлийн 164.3-ийг баримтлан түүний 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 19/203 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Давж заалдах гомдол”-ыг хүлээн авахаас татгалзах тухай 2017 оны 6 дугаар сарын 06- ны 1577 дугаартай шүүгчийн захирамж гаргасан болно.

Ф аймгийн Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа С.П нь 2017 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 19/214 дугаар албан бичгээр “Давж заалдах гомдлын хугацааг сэргээлгэх тухай” хүсэлт ирүүлснийг тус шүүхийн 2017 оны 6 дугаар сарын 14-ний өдөр 1665 дугаартай “Хүсэлтийг хангахаас татгалзах тухай” захирамж гаргасан.

Учир нь, нэхэмжлэгчийн шүүхэд гаргаж өгсөн Онцгой байдлын ерөнхий газраас Ф, П, К, Ш аймгийн Онцгой байдлын газрын дарга нарт хаягласан 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 1034 дугаартай “Сургалтад хамааруулах тухай” 2017 оны 5 дугаар сарын 30, 31-ний өдөр А хотод зохион байгуулагдах сургалтад мал, амьтны гоц халдварт өвчин гарсан үед гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги удирдлага, зохицуулалтаар ханган ажиллах нэг албан тушаалтныг тус сургалтад оролцуулахыг хүссэн тухай албан бичиг нь нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нар анхан шатны шүүхийн шийдвэрийг гардан авсны дараа ирсэн. Иймд нэхэмжлэгч давж заалдах гомдол гаргах хугацаанд А хотод сургалтад явахыг өөрөө урьдчилан мэдэж байсан ба давж заалдах гомдол гаргах эрхийг өөр этгээдэд итгэмжлэлээр олгох боломжтой байсан тул 2017 оны 5 дугаар сарын 28-аас 2017 оны 6 дугаар сарын 04-ний хооронд Улаанбаатар хотод байсан гэдэг нь нэхэмжлэгч Ф аймгийн Онцгой байдлын газрын давж заалдах гомдол гаргах хугацааг сэргээх үндэслэл болохгүй юм.

Мөн энэ сургалтад өөрөө оролцож ирснийг хүндэтгэн үзэх шалтгаан гэж үзэх боломжгүй, нэхэмжлэгч байгууллагыг итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр хуулийн дагуу төлөөлүүлж болох байсан.

Иймээс нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нарт шийдвэрийг гардуулсан 2017 оны 5 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаанд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.3-т заасан нэхэмжлэгч хуульд заасан давж заалдах гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэхэд саад болсон, хэрэгжүүлэх боломжийг нь хязгаарласан хүндэтгэн үзэх шалтгаан тогтоогдоогүй учир түүний уг 14 хоногийн хугацааг сэргээлгэх тухай хүсэлтийг 2017 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн 1577 дугаартай шүүгчийн захирамжаар хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн юм.

Нэхэмжлэгч тал давж заалдах гомдол гаргах хугацааг мэдсээр байж байгууллагын өөр ажилтан, албан тушаалтанд итгэмжлэл олгоогүй Ф аймгийн Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, хошууч

Б.А-гийн нэрээр давж заалдах гомдлыг гаргасан нь хэрэгт авагдсан нотлох баримтаар нотлогдож байгаа болно.

Харин нэхэмжлэгч давж заалдах гомдол гаргах хугацааг хэтрүүлсэнд хүндэтгэн үзэх шалтгаан байсныг нотлох баримт гаргаж өгөөгүй бөгөөд Ф аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа С.ПА хотод явсан үндэслэлээр давж заалдах гомдол гаргах хугацааг сэргээсэн тохиолдолд хэргийн нэг талд илэрхий давуу байдал олгож, үйлчилж байгаа мэт сэтгэгдэл төрүүлэхүйц явдал болох байсан.

Хэрвээ шүүгч миний бие дээрх байдалд үнэлэлт дүгнэлт өгөлгүйгээр нэхэмжлэгчийн давж заалдах гомдлыг хангасан тохиолдолд хариуцагч талын эрх ашгийг хөндөхөөр байсныг Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооноос 2018 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 30 дугаартай магадлал гаргахдаа анхаараагүй байна.

Мөн шүүгчийн Ёс зүйн хороо шүүгч миний өмнө нь гаргасан нотлох баримтуудыг үнэлж дүгнээгүй, үнэлж дүгнээгүй шалтгаанаа зааж тодорхойлоогүй байна.

Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1-д “Шүүгч хуульд тусгайлан ёс зүйн зөрчил болохоор заасан болон энэ дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг ёс зүйн зөрчил гэж үзнэ”, 2-т “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй” гэж тус тус заасан байдаг.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123, 124, 170 дугаар зүйлүүдийг шүүгч хэрхэн тайлбарлаж хэрэглэсэн, ямар тохиолдолд гомдол гаргах эрхтэй болох, гомдол гаргах эрхгүй захирамжид хэргийн оролцогчдоос гомдол ирүүлсэн бол ямар журмаар хэлэлцэх зэрэг асуудал нь Шүүхийн Ёс зүйн хорооны хянаж, дүгнэх асуудал биш харин шүүн таслах үүргээ биелүүлэх шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаа юм.

Түүнчлэн нэхэмжлэгч Ф аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа С.П давж заалдах гомдол гаргах хугацааг сэргээлгэх тухай хүсэлтийг хангахаас татгалзсан тус шүүхийн шүүгчийн 2017 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 1665 дугаартай захирамжийг 2017 оны 6 дугаар сарын 28-ны өдөр, Шүүгчийн захирамжид гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзсан тус шүүхийн шүүгчийн 2017 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 1863 дугаартай захирамжийг 2017 оны 7 дугаар сарын 06-ны өдөр гардаж авснаас хойш 5 сарын дараа буюу 2017 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Шүүхийн Ёс зүйн хороонд гомдол гаргасан бөгөөд Шүүхийн Ёс зүйн хорооны тогтоол 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдөр гарсан байна.

Энэ нь Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 5.1 дугаар зүйлийн 3-т Ёс зүйн зөрчлийг илрүүлснээс хойш 1 сар, зөрчил гаргаснаас хойш 6 сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулж болохгүй гэснийг зөрчсөн байна.

Шүүгч Б.М би Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу, хуулийг чанд сахиж явуулсан бөгөөд хариуцагч талаас шүүгчид нөлөөлсөн, шүүгч ёс зүйгүй байдал гаргасан асуудал байхгүй, шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 1-д заасан хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх үүргээ биелүүлсэн болно.

Нэгэнт нэхэмжлэгч талаас давж заалдах гомдол гаргах хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн талаар нотлох баримтаар нотолж өгч чадаагүй тул Монгол улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 4 дүгээр сарын 13-ны

өдрийн 30 дугаартай магадлалд давж заалдах гомдол гаргах хугацааг сэргээх хуулийн тодорхой заалтууд /ИХШХШТХ-ийн 120.3/-ыг хэрэглэхээс татгалзсан захирамж гаргасан гэж дүгнэсэн нь үндэслэлгүй юм.

Мөн уг магадлалд захирамжид давж заалдах гомдол гаргах эрхгүйг дурдсан учраас нэхэмжлэгч тал Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т тодорхой заасан “шударга шүүхээр шүүлгэх эрх”, “шүүхийн шийдвэрийг давж заалдах” эрхээ эдлэх боломжгүй болсон гэж дүгнэсэн нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлд зөвхөн мөн хуулийн 20.1, 38.9, 65.1.1-65.1.8, 65.1.10, 69.1, 92.4, 97.1, 100.2 дахь хэсэг, 80, 117, 124 дүгээр зүйлд зааснаас бусад үндэслэлээр шүүхэд гаргасан хүсэлтийг шийдвэрлэхэд гомдол гаргах эрхгүй гэж хуульчилсныг, шүүгч Б.М миний бие хуулийн тодорхой заалтуудыг баримталж, хуульд захирагдах үүргээ биелүүлснийг анхаарч үзээгүй байна.

Түүнчлэн нэхэмжлэгч талаас 2018 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр Ф аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 6 дугаар сарын 14-ний өдөр 1665 дугаартай “Хүсэлтийг хангахаас татгалзах тухай” захирамжийг хүчингүй болгож, 2017 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 264 дугаартай шийдвэрт давж заалдах гомдол гаргах хугацааг сэргээлгэх тухай хүсэлт гаргасан.

Уг хүсэлтийг Ф аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 130/ШТ2018/00014 дугаартай тогтоолоор нэхэмжлэгчийн хүсэлтийг хангаж Ф аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 6 дугаар сарын 14-ний өдөр 1665 дугаартай “Хүсэлтийг хангахаас татгалзах тухай” захирамжийг хүчингүй болгож, 2017 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 264 дугаартай шийдвэрт давж заалдах гомдол гаргах хугацааг сэргээж шийдвэрлэсэн ба Ф аймгийн Онцгой байдлын газрын нэхэмжлэлтэй, Ф аймгийн Т сумын ... багийн иргэн Т.Е-д холбогдох “Хууль бусаар эзэмшиж байгаа 876 м.кв газрыг чөлөөлүүлэх тухай” иргэний хэрэг Ф аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд хянагдаж байгаа тул нэхэмжлэгч хуулиар олгогдсон эрхээ эдэлж, шүүхийн шийдвэрийг давж заалдах гомдол гаргах эрхээр хангагдсан байх тул нэхэмжлэгчийн үндсэн эрх зөрчигдсэн гэх үндэслэлгүй юм.

Иймд миний бие Монгол улсын шүүхийн шүүгчийн Ёс зүйн дүрмийн холбогдох заалтуудыг зөрчөөгүй тул Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 30 дугаартай “Сахилгын шийтгэл ногдуулах тухай” магадлалыг хүчингүй болгож өгнө үү” гэжээ.

Шүүгч Б.М давж заалдах гомдолдоо: “... Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т зааснаар “Монгол Улсын иргэн нь Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхтэй” гэж заасан үндэслэлийг миний бие хязгаарласан зүйл байхгүй болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2-т “Төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмын нэг нь хууль дээдлэх” гэж заасан бөгөөд шүүн таслах ажиллагаа нь төрийн үйл ажиллагааны нэгэн хэлбэр учраас энэ зарчмыг шүүгч биелүүлэх үүрэгтэй ба энэ үүргээ би бүрэн биелүүлсэн.

Шүүгч би аливаа хэрэг маргааныг шийдвэрлэхдээ ямар нэгэн байдлаар хувийн ашиг сонирхолд хөтлөгдөөгүй ба Ф аймгийн Онцгой байдлын газрын нэхэмжлэлтэй, иргэн Т.Е-д холбогдох иргэний хэрэгт нэхэмжлэгч байгууллагын гаргасан гомдлыг гагцхүү хуульд захирагдан шударгаар шийдвэрлэсэн бөгөөд шүүгчийн ёс зүйн зөрчил гаргаагүй гэж үзэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйл ийн 1-т “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэж заасан.

Шүүгч миний бие Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шүүгчийн ёс зүйн дүрэм болон хуулийн ямар заалтыг яаж зөрчсөн талаар магадлалын үндэслэх хэсэгт тодорхой дурдаагүй сануулах сахилгын шийтгэл ногдуулсан нь үндэслэлгүй болсон байна. Ф аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М-гийн 2017 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 1665 дугаартай “Хүсэлтийг хангахаас татгалзах тухай” шүүгчийн захирамжийн 2 дахь заалтаар “энэ захирамжид гомдол гаргах эрхгүй болохыг дурдсугай” гэжээ. Уг шүүгчийн захирамжийг эс зөвшөөрч нэхэмжлэгч Ф аймгийн Онцгой байдлын газар нь тухайн шатны шүүхэд гомдол гаргасныг тус шүүхийн мэдээлэл лавлагааны мэргэжилтэн хүлээн авч, Иргэн-2014 нэгдсэн системд бүртгэн хуваарийн дагуу шүүгч К.Б надад хүлээлгэн өгсөн юм.

Нэхэмжлэгч Ф аймгийн Онцгой байдлын газрын давж заалдах гомдол гаргах хугацааг сэргээлгэхийг хүссэн хүсэлтийг шийдвэрлэсэн Ф аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 1665 дугаартай “Хүсэлтийг хангахаас татгалзах тухай” шүүгчийн захирамжид Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.3 дахь заалтыг удирдлага болгосон байх ба Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1-д “шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэр”-т тухайн шатны шүүхэд гомдол гаргах талаар зохицуулсан бөгөөд дээрх шүүгчийн захирамжид удирдлага болгосон хуулийн заалтад тухайн шатны шүүхэд гомдол гаргах эрхгүй гэж хуулиар зохицуулсныг миний бие баримталсан болно.

Дээрх Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 30 дугаартай магадлалд "... Үндсэн хуулийн 49-р зүйлийн 1-д “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана” гэж тодорхой заасан. Мөн хууль дээдлэх зарчим нь процессын хуулиуд болон Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд ч тусгалаа олсон. Түүнчлэн, шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3-р зүйлийн 1-д зааснаар “хууль дээдлэх” зарчмыг хувийн зан чанар болгон төлөвшүүлэхийг шүүгчид үүрэг болгоод зогсохгүй энэ дүрмийн 3.3-р зүйл “Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй” гэж тодорхой заасан. Өөрөөр хэлбэл, шүүгч аливаа хэрэг, маргааныг дур зоргоор биш зөвхөн хуулийг зөв хэрэглэж, хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий шийдвэрлэх үүрэгтэйг эдгээр эрх зүйн эх сурвалжид тодорхой тусгасан байх ба эдгээр зарчим, үүргийг шүүгч К.Б хэрэгжүүлээгүй байна гэж үзэхээр байна” гэжээ.

Иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу явагдах ба Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.3-т шийдвэр гаргаснаас бусад тохиолдолд хянан шийдвэрлэж байгаа асуудлаар шүүгчийн захирамжийг бичгээр гаргана...” гэж заасны дагуу Ф аймгийн Онцгой байдлын газрын гаргасан гомдолд хуулиа баримтлан гомдлын хариуг өгсөн бөгөөд шүүгч миний бие урьд өмнө Ф аймгийн Онцгой байдлын газрын нэхэмжлэлтэй, иргэн Т.Е-д холбогдох иргэний хэргийг огт шийдвэрлэж байгаагүй, зөвхөн "... гомдол гаргах эрхгүй” гэж дурдсан шүүгчийн захирамжид гомдол гаргасан байх тул шүүгчийн захирамжаар хариу мэдэгдсэн болно.

Гэтэл Монгол улсын Шүүхийн Ёс зүйн хорооноос шүүхэд гаргасан хүсэлтийг хянан шийдвэрлэсэн хэрэг маргааныг дур зоргоороо шийдвэрлэсэн мэтээр үзэж, сануулах сахилгын шийтгэл ногдуулсан нь хуулийн үндэслэлгүй болжээ. Нөгөө талаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170

дугаар зүйлд заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гомдол гаргаж болно гэж зохицуулсан нь зөвхөн мөн хуулийн 20.1, 38.9, 65.1.1-65.1.8, 65.1.10, 69.1, 92.4, 97.1, 100.2 дахь хэсэг, 80, 117, 124 дүгээр зүйлд зааснаас бусад үндэслэлээр шүүхэд гаргасан хүсэлтийг шийдвэрлэхэд гомдол гаргах эрхгүй гэдгийг уг хуулиар тодорхой зохицуулсан бөгөөд нэгэнт"... гомдол гаргах эрхгүй" гэж дурдсан шүүгчийн захирамжид гомдол гаргасан байх тул шүүгчийн захирамжаар хариу мэдэгдсэн болно.

Гомдол гаргагч Ф аймгийн Онцгой байдлын газар нь 2018 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр Ф аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 1665 дугаартай "Хүсэлтийг хангахаас татгалзах тухай" захирамжийг хүчингүй болгож, 2017 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 264 дугаартай шийдвэрт давж заалдах гомдол гаргах хугацааг сэргээлгэх тухай хүсэлт гаргасныг шүүх хүлээн авч, хүсэлтийг хангаж Ф аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 130/ШТ2018/00014 дугаартай шүүхийн тогтоол гарсан байна.

Ф аймгийн Онцгой байдлын газрын нэхэмжлэлтэй, Т сумын ... багийн иргэн Т.Е-д холбогдох "Хууль бусаар эзэмшиж байгаа 876 м.кв газрыг чөлөөлүүлэх тухай" иргэний хэрэг нь Ф аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд хянагдаж байгаа болно.

Иймд шүүгч Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 30 дугаартай магадлалыг хүчингүй болгож өгнө үү" гэжээ.

ХЯНАВАЛ:

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.3 дахь хэсэгт зааснаар хэргийг хянан үзэхэд Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хороо гомдол гаргагч болон шүүгчийн тайлбар, хэрэгт авагдсан баримтад үндэслэл бүхий дүгнэлт хийгээгүйгээс Ёс зүйн хорооны магадлал хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагыг хангаагүй байна.

Гомдол гаргагч Ф аймгийн Онцгой байдлын газрын дарга дэд хурандаа С.П-гээс Ёс зүйн хороонд "... Ф аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.М, К.Б нарт холбогдуулан удаа дараа үндэслэлгүй захирамж гаргаж, өөрсдийн гаргасан шийдвэрт давж заалдах гомдол гаргах Төрийн байгууллагын эрхийг хязгаарлаж хариуцагч талд үйлчилж болзошгүй байгаа тул нэхэмжлэгч Онцгой байдлын газрын давж заалдах эрхийг сэргээж, шүүгчийн ёс зүйн дүрмээ зөрчиж, хариуцлагагүй, ёс зүйгүй байдал гаргасан шүүгч Б.М, К.Б нарт хариуцлага тооцож өгнө үү" гэсэн гомдол гаргасан байна.

Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор "шүүгч Б.М, К.Б нарт "хүний эрх, эрх чөлөө, эрхэм чанарыг хүндэтгэх, хууль дээдлэх, үнэнч шударга байх, аливаа асуудалд бодитой, төвийг сахисан байр сууриас хандах, хараат бус байх, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандах, нууцыг задруулахгүй байх, мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх зэрэг зарчмуудыг хувийн зан чанар болгож төлөвшүүлнэ" гэснийг зөрчсөн гэсэн үндэслэлээр сахилгын хэрэг үүсгэж, Ёс зүйн хорооны 2018 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 30 дугаар магадлалаар шүүгч нарт Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 4 дүгээр зүйлийн 4.1.5, 16 дугаар зүйлийн 16.1-д зааснаар шүүгч нь "хүний эрх"-ийг хуулийн хүрээнд дээдлэх, хамгаалах үндсэн үүрэгтэй" гэснийг зөрчсөн гэж дүгнэж, "сануулах" сахилгын шийтгэл ногдуулсан нь үндэслэлгүй байна.

Ф аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 264 дүгээр шийдвэрийг шүүх хуралдаанд

оролцсон нэхэмжлэгч Ф аймгийн Онцгой байдлын газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч Х.У, М.Е нар нь 2017 оны 5 дугаар сарын 19-ний өдөр гардаж аваад 6 дугаар сарын 02-ны өдрийн дотор давж заалдах гомдлоо гаргахаар байжээ.

Гэтэл Ф аймгийн Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, хошууч Б.А нь шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргасныг шүүгч Б.М хүлээн авч хянаад, Б.А нь Иргэний хэрэг шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 161 дүгээр зүйлийн 161.1-д заасан давж заалдах гомдол гаргах эрх бүхий этгээд биш, Иргэний хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1-д зааны дагуу нэхэмжлэгч байгууллагаас түүнд итгэмжлэл олгоогүй тул 2017 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн 1577 дугаар захирамжаар хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн байна.

Ф аймгийн Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа С.П нь 2017 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 19/214 дүгээр албан бичгээр “Давж заалдах гомдлын хугацааг сэргээлгэх тухай” хүсэлт ирүүлснийг 2017 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 1665 дугаар захирамжаар хүсэлтийг хангахаас татгалзсан байна.

Дээрх хүсэлтийг хангахаас татгалзаж шийдвэрлэхдээ Онцгой байдлын ерөнхий газрын 2017 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 1034 дүгээр албан бичигт дугаар сарын 30, 31-ний өдөр сургалтад оролцохоор тусгагдсан тул нэхэмжлэгч нь 2017 оны 5 дугаар сарын 19-ний өдрөөс 2017 оны 6 дугаар сарын 02-ны өдөр хүртэл давж заалдах гомдол гаргах хангалттай хугацаа байснаас гадна, байгууллагыг итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр хуулийн дагуу төлөөлүүлж болох байсан гэсэн үндэслэл дурдсан байна.

Шүүгч заавал хүсэлтийг хангаж шийдвэрлэх үүрэггүй бөгөөд хэргийн нөхцөл байдал тухайн хүсэлтэд хавсаргагдсан нотлох баримтаар нотлогдож буй эсэхийг шүүгч өөрийн дотоод итгэлээр үнэлсний үндсэн дээр шийдвэрээ гаргах бөгөөд энэ нь шүүгчийн бүрэн эрхийн асуудал.

Хүлээн авахаас татгалзсан захирамжид хуулийн холбогдох заалтуудыг баримталснаас үзэхэд Ёс зүйн хорооны магадлалд дурдсанаар шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 4 дүгээр зүйлийн 4.1.5, 16 дугаар зүйлийн 16.1-д заасан “хүний эрх”-ийг хуулийн хүрээнд дээдлэх, хамгаалах үндсэн үүргээ зөрчсөн гэж дүгнэсэн нь үндэслэлгүй бөгөөд Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасантай нийцэхгүй байна.

Өөрөөр хэлбэл энэхүү маргаанд шүүгчийн хүлээн авахаас татгалзах тухай захирамжийн хуульд заасан үндэслэлийг, Ёс зүйн дүрмээр тогтоосон хэм хэмжээ зөрчсөн үйлдэл гэж үзэхгүй.

Харин шүүгч К.Б нь Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3, 3.3 дахь хэсгийг зөрчсөн үндэслэл тогтоогдохгүй байхад түүнд сахилгын шийтгэл ногдуулсан нь үндэслэлгүй байна.

Учир нь Шүүгч Б.М-гийн 2017 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 1665 дугаар захирамжаар хүсэлтийг хангахаас татгалзсан захирамжид гомдол гаргасныг шүүгч К.Б хуваарийн дагуу хүлээн авч шийдвэрлэхдээ нэгэнт гомдол гаргах эрхгүй захирамжид гомдол гаргасан байх тул шүүгч нь гомдол гаргах эрхгүй хуулийн заалтыг баримтлан 1665 дугаар захирамжид гаргасан гомдлыг шийдвэрлэсэн нь ёс зүйн зөрчил болохгүй юм.

Иймд Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 30 дугаар магадлалыг хүчингүй болгож, шүүгч Б.М, К.Б нарын давж заалдах гомдлыг хангах нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн үзлээ.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.2, 121 дүгээр зүйлийн 121.1.1 дэх заалтыг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсэгт заасныг баримтлан Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 30 дугаар магадлалыг хүчингүй болгож, шүүгч Б.М, К.Б нарт үүсгэсэн сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгосугай.

2.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.5 дахь хэсэгт зааснаар давж заалдах шатны шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн, хууль буруу хэрэглэсэн гэж нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч үзвэл магадлалыг гардан авсан эсхүл хүргүүлсэн өдрөөс хойш 14 хоногийн дотор Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.БАТБААТАР

ШҮҮГЧ

Г.БИЛГҮҮН

ШҮҮГЧ

Д.БААТАРХҮҮ

UIN.MN
СУДАЛГААНЫ САН



МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЁС ЗҮЙН ХОРООНЫ МАГАДЛАЛ

2018 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 74

Улаанбаатар хот

Ш дүүргийн Иргэний хэргийн
анхан шатны шүүхийн шүүгч Т.Б-д
сахилгын шийтгэл ногдуулах тухай

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааныг тус хорооны дарга Н.Эрдэнэцогт даргалж, гишүүн Д.Сүнжид, Ч.Оюунцэцэг, В.Жавхлан, А.Доржготов нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны тэмдэглэл хөтлөгчөөр ажлын албаны шинжээч Ч.Ханддулам, хяналт шалгалт хариуцсан референт А.Баасанжав нарыг оролцуулан Шүүхийн Ёс зүйн хорооны хуралдааны танхимд хийв.

Шүүгч Т.Б-д холбогдох сахилгын хэрэг болон Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 0016 дугаар магадлалын талаар Шүүхийн Ёс зүйн хорооны гишүүн Ч.Оюунцэцэгийн илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Гомдол гаргагч Д.Б Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан гомдолдоо: Миний бие Д овогтой Б нь нөхөр Д.Ч-тэй 2015.07.08-ны өдөр гэр бүл болж бидний охин 2016.12.07-ны өдөр мэндэлсэн. Хамт амьдарч байх хугацаанд заримдаа намайг хэл амаар доромжлон, гэрээсээ хөөн, архи ууж согтуурдаг байсан ба 2017 оны 6 сараас эхлэн нялх охины минь дэргэд байнга намайг хэл амаар доромжлон, зодох гэж айлгаж, амь насанд минь хүртэл заналхийлдэг болсон. Улмаар 2017.08.15-ны өдөр нялх охины минь дэргэд намайг зодож гэмтэл учруулсан ба П дүүргийн Цагдаагийн хэлтэс Д.Ч-д эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байгаа болно.

Миний бие Д.Ч-ээс гэрлэлтээ цуцлуулан өөрийн асрамжид авахаар Ш дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд 2017.09.28-ны өдөр нэхэмжлэл гаргасан ба уг нэхэмжлэл шүүгч Т.Б-д хуваарилагдсан болно. Шүүгч Т.Б нь 2017.10.26-ны өдөр над руу утсаар залгаж уулзах хэрэгтэй байна гэсэн учир 2017.10.27-ны өдөр түүнтэй уулзсан. Ингэж уулзахад шүүгч надаас “Д.Ч чамайг зодохдоо хэдэн удаа цохисон вэ, чи хаана хэнтэй хэний байранд амьдарч байгаа вэ гэж асуусан ба би асуултад нь хариулсан. Үүний дараагаар шүүгч Т.Б нь хариуцагч Д.Ч-тэй өмнө нь уулзсан тухайгаа дурдаж, миний том ах, аав хоёр одоогоос 31 болон 21 жилийн өмнө нас барсан учраас миний ээж сэтгэлийн хямралтай байж болохоос гадна намайг хүүхэд төрүүлээд удаагүй нялх биетэй байгаа болохоор мөн адил сэтгэлийн хямралтай байж болно гэж хэлээд сэтгэл зүйчтэй 2017.10.30-ны өдөр 13.30-нд уулз гэсэн.

Миний ээж Д.С нь тэргүүлэх зэрэгтэй хүний их эмч бөгөөд төрийн албанд 40 жил ажиллаад өндөр насны тэтгэвэрт гарсан. Одоо ... яаманд зөвлөх эмчээр ажиллаж байна.

Миний бие төрийн байгууллагад 6 жил ажилласан ба үүний дараагаар Дэлхийн банканд зөвлөх судлаачаар 4 дэх жилдээ ажиллаж байна.

Шүүгч Т.Б нь П дүүргийн Цагдаагийн ... хэлтэст шалгагдаж буй миний хохирогчоор оролцож байгаа эрүүгийн хэрэгтэй холбоотой асуулт асуун, миний амьдарч буй байр байдлыг тандаж, бүр цаашлаад намайг болон ээжийг минь сэтгэлийн хямралтай гэж хэлж миний болон ээжийн минь нэр хүндийг гутаасан нь түүнийг хариуцагч Д.Ч-гийн талд ажиллаж байгаа мэт сэтгэгдэл надад төрүүлсэн. Миний бие шүүгч Т.Б-г Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2.1, 3.2.2, 3.2.4-ийг тус тус зөрчсөн гэж үзэж байна.

Иймээс шүүгч Т.Б нь аль нэг талыг баримтлахгүйгээр, хараат бус байдлаа хадгалан хуулийн дагуу миний гаргасан нэхэмжлэлийг шийдвэрлэнэ гэдэгт эргэлзэж байгаа тул тус шүүгчээс татгалзах хүсэлтэй байна” гэжээ.

Шүүгч Т.Б Шүүхийн Ёс зүйн хороонд ирүүлсэн тайлбартаа: “Ш дүүргийн шүүхийн Иргэний анхан шатны шүүхийн шүүгч Т.Б би 2017 оны 4 дүгээр сараас эхлэн Гэр бүлийн хэрэг маргааныг дагнан шийдвэрлэж байгаа.

Нэхэмжлэгч Д.Б, хариуцагч Д.Ч-д холбогдох нэхэмжлэлийг 2017.09.29-ний өдөр хүлээн авч, 2017.10.06-ны өдөр Иргэний хэрэг үүсгэсэн. Хүчирхийлэлтэй гэсэн байсан учир эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагдаагүй учир ИХШХШТХ-ийн 132.4, Гэр бүлийн тухай хуулийн 14.1, Эвлэрүүлэн зуучлалын тухай 6.3 дах хэсэгт заасан ажиллагааг хийгдээгүй байхад нь иргэний хэрэг үүсгэж ажиллагааг явуулсан.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т “Шүүх талуудад эвлэрүүлэн зуучлалын талаарх мэдээллийг бүрэн өгч, шүүхэд иргэний хэрэг үүсгэхээс өмнө болон хойно эвлэрүүлэн зуучлагчийн туслалцаа авах талаар сануулах үүрэгтэй.” гэж хуульчлан заасан байгаа.

Нөгөөтээгүүр энэ нэхэмжлэлийн хувьд Гэр бүлийн тухай хуулийн 12-р зүйлийн 12.2 дахь хэсэгт зааснаар хүүхэд нэг нас хүрээгүй тохиолдолд гэрлэлтийг цуцлахыг хориглосон байгаа хэдий ч иргэний хэргийг үүсгэж ажиллагаа явуулсан. Хариуцагчид нэхэмжлэлийг гардуулж тайлбарыг авахад эвлэрэх хүсэлтэй байгаагаа туслах О.Д-д тайлбарласан байсан.

Хуульд заасан урьдчилан шийдвэрлэх ажиллагаа энэ хэргийн хувьд хийгдээгүй учир ИХШХШТХ-ийн 132-р зүйлийн 132.1-д зааснаар гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг шүүх авна гэж заасны дагуу нэхэмжлэгч, хариуцагчтай уулзсан. Эвлэрүүлэх талын асуудлыг тавьсан. Хэрэгт бол байнгын хүчирхийлэлд байдаг талаар нотлох баримтыг ирүүлээгүй. Гэр бүлийн хэргийг дагнан шийдвэрлэснээр шүүгч нар хөндлөнгийн бус байр сууринаас хандаж болохгүй гэрлэгчдийг эвлэрүүлэх арга хэмжээг авна гэж сургалт орж байгаа.

Д.Б хувийн асуудлаа яриад уйлаад байсан учир туслах О.Д-г өрөөнөөс гаргасан. Тэгээд ч туслахад өөр 2 уулзах гээд, хүүхдүүд асуулгах гээд ирсэн байсан учир хажуудаа байлгах боломжгүй байсан. Шүүгч, туслах бид 2 зөвхөн гэр бүлийн маргаан дагнан шийдвэрлэж байгаа ч гэсэн гар дээр 70-80 нэхэмжлэл байгаа. 2017 оны 11 дүгээр сарын 9, 10-ны өдрүүдэд гэр бүлийн маргаан болон “Гэр бүлийн эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцож буй мэргэжилтнүүдийг чадавхжуулах төсөл” сургалтад шүүгч гэрлэгчидтэй хэрхэн харилцах харилцааны талаар болон хэрэг хянан шийдвэрлэхэд анхаарах асуудлаар сургалт орсон.

Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судлаач-багш Л.Г-гийн 2012-2016 оны гэр бүлийн холбогдолтой хэргийн статистик жилд 4000 хэргийн тоо ердөө буурахгүй байгаа ба үүний цаана жилд 9,000-10,000 хүүхдийн хувь заяа бүрхэг үлдэж байгаад мэргэжилтнүүд эмзэглэж байгаа гэвч эцэг эхчүүд нь энэ асуудалд хариуцлагагүй хандаж байгаа.

Энэ гэр бүлийг эвлэрүүлэх үүднээс уулзсанаас Д.Ч-гийн өмнөөс тандах байдлаар уулзаагүй.

Шүүгч Т.Б эвлэрүүлэх байр сууринаас уулзсан нь үр дүнд хүрсэн гэж үзэж байна. Учир нь: 2017.11.22-ны өдөр шүүх хуралдааныг товлоход шүүх хуралдаан дээр 2 сарын эвлэрүүлэх хүсэлтийг нэхэмжлэгч Д.Б-гийн талаас хүсэлт гаргасны дагуу 2017.11.22-ны өдрийн 19942 дугаар шүүгчийн захирамжаар хэргийг 2 сарын хугацаатай түдгэлзүүлж эврүүлэх ажиллагаа явагдаж байгаа.

Д.Б нь надтай уулзаж байхдаа Д.Ч нь миний ээжийг сэтгэл мэдрэлийн өвчтэй гэж хэлдэг гэсэн үгийг хэлсэн. Сая шүүх хуралдаан дээр түүний өмгөөлөгч Д.Н-г нь Д.Ч Д.Б-гийн 70 гарсан ээжийг сэтгэл мэдрэлийн өвчтэй гэж хэлсэн гэж хуралдаан дээр хэлж байсан. Шүүгч би Д.Б-тэй бусад ярилцсан зүйлийн талаар хуралдаанд оролцохдоо тайлбарыг гаргана. Хувь хүний асуудлууд яригдсан байгаа.

Гэрлэгчидтэй уулзсан нь буруу, зөв гэхээсээ илүүтэйгээр хэрэг маргааныг шийдвэрлэхэд анхаарч буй асуудал, сургалтуудын талаарх баримтыг хавсаргав.” гэжээ.

Шүүгч Т.Б нийт гишүүдийн хуралдаанд гаргасан тайлбартаа: “Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 12-р сарын 21-ний өдрийн 198-р тогтоолыг гардан аваад, доорх тайлбарыг гаргаж байна.

Нэхэмжлэгч Д.Б-тэй уулзахад шүүгчийн туслах О.Д хамт байлцсан. Үүдэнд шүүгчийн туслахтай уулзах хүмүүс ирчихсэн, манай өрөөнд байхад иргэд гомдол гаргасан учир гараад явсан.

Залуу гэр бүл аль болох эвлэрэх хэрэгтэй, хариуцагч талаас эвлэрэх хүсэлтэй байгаа тайлбарыг ирүүлсэн гэдгийг шүүгчийн зүгээс хэлсэн. Өөр бусдаар хэргийн нөхцөл байдлыг ярьсан хэлсэн зүйл байхгүй тул сахилгын хэрэг үүсгэснийг зөвшөөрөхгүй байна. ШТК дүүргийн Иргэний анхан шатны шүүхийн 3 шүүгч айлын орон сууцны түрээсийн байранд шүүхийн 3 байранд Гэр бүлийн хэрэг маргааны дагнан шийдвэрлэж байгаа. Шүүгчийн туслах нар шүүгч нарын үүдэндээ суудаг. Хэргийн оролцогч нар үүдэнд уулзалт хийж асуудал хурцадвал шүүгч гарч асуудлыг шийдвэрлэдэг. Ажлын байрны нөхцөл байдал ийм байдаг. Тэрнээс хэргийн оролцогчтой шүүгч би өөрийн санаачилгаар уулзаагүй ажил үүргээ хуульд заасны дагуу хэрэгжүүлсэн тул хэрэгсэхгүй болгож өгнө үү.” гэжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанаар гомдлыг хэлэлцээд ҮНДЭСЛЭХ нь:

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 198 дүгээр тогтоолоор шүүгч Т.Б-д сахилгын хэрэг үүсгэжээ. Уг тогтоолыг эс зөвшөөрч шүүгч Т.Б нийт гишүүдийн хуралдаанд тайлбар гаргасан байна. Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 22 дугаартай магадлалаар шүүгч Т.Б-г шүүгчийн ёс зүйн зөрчил гаргасан хэмээн үзэж түүнд сануулах шийтгэл ногдуулсан байна. Шүүгч Т.Б тус 22 дугаартай магадлалыг эс зөвшөөрч Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд 2018 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр гомдол гаргажээ. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 221/ЁМ2018/0016 дугаартай магадлалаар Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 22 дугаартай магадлалыг хүчингүй болгож, гомдлыг дахин хэлэлцүүлэхээр тус хороонд буцаажээ. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 221/ЁМ2018/0016 дугаартай магадлалд даалгасан ажиллагааг хийж, шүүгч Т.Б-д үүсгэсэн сахилгын хэргийг дахин хэлэлцэв.

Монгол Улсын Үндсэн хуулийн 49-р зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.” гэж заасан. Хуульд захирагдаж хэрэг, маргааныг шийдвэрлэхийн тулд шүүгч нь төвийг сахих зарчмыг баримтлах ёстой. Тиймээс, шүүгч нь хэрэг, маргааны аль нэг талтай нөгөө талыг байлцуулахгүйгээр тухайн хэрэг, маргааны агуулгатай холбоотой асуудлаар харилцахыг хориглодог. Учир нь, шүүгч хэргийн нэг талтай нөгөө талыг байлцуулалгүйгээр харилцсанаар

зөвхөн нэг талын үндэслэлийг сонсох бөгөөд уг үндэслэлийг няцаах боломжийг нөгөө талд олгодоггүй. Зөвхөн нэг талын үндэслэлийг сонссоноор шүүгч хууль зүйн болон фактын асуудал дээр алдаатай шийдвэр гаргах эрсдэлийг бий болгодог. Түүнчлэн, шүүгч нь авлига эсхүл бусад зүй бус нөлөөнд автах, эсхүл тийнхүү ойлгогдох үүд хаалгыг нээдэг. Шүүгчид заримдаа маргааны аль нэг талтай нөгөө талыг байлцуулахгүйгээр уулзах нь шүүгчид итгэх олон нийтийн итгэлийг унагах нэг хүчин зүйл болдог.³⁷ Шүүгч маргааны нэг талтай нөгөө талыг байлцуулахгүйгээр уулзахыг хатуу хориглодог нь Монгол Улсад төдийгүй хууль дээдлэх ёс төлөвшсөн олон улсуудад тогтсон зарчим.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль (ШЭЗБТХ)-ийн 27.1.17-д заасны дагуу “хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах”-ыг шүүгчид хориглодог бөгөөд уулзах гэдэгт амаар болон бичгээр хийгдсэн аливаа харилцааг багтаадаг. Шүүгчийн ёс зүйн дүрэм (ШЁЗД)-ийн 3.2 дугаар зүйлд шүүгч төвийг сахих зарчмыг баримтлах үүрэгтэйг заасан бөгөөд “шүүгч хэргийн оролцогчтой ганцаарчлан уулзаж хэргийн нөхцөл байдал, гэм буруугийн талаар ярилцаж болохгүй бөгөөд хэрэв албан ажлын зайлшгүй шаардлагын улмаас хэргийн нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай уулзах бол шүүхийн туслах ажилтан байлцуулах бөгөөд уулзалтын агуулгын талаар тэмдэглэл хөтлөн хэрэгт хавсаргана.” гэж заасан.

Шүүгч Т.Б нь хариуцагч Д.Ч-г байлцуулахгүйгээр нэхэмжлэгч Д.Б-тэй 2017 оны 10 дугаар сарын 27-ны өдөр ганцаарчлан уулзсан нь гомдол болон тайлбаруудаар тогтоогдож байна. Гомдол гаргагч Д.Б “Шүүгч Т.Б нь 2017.10.26-ны өдөр над руу утсаар залгаж уулзах хэрэгтэй байна гэсэн учир 2017.10.27-ны өдөр түүнтэй уулзсан.” гэж гомдолдоо бичсэн. Шүүгч Т.Б нь хариуцагч Д.Ч-г байлцуулахгүйгээр нэхэмжлэгч Д.Б-тэй тухайн өдөр уулзсан гэдгээ хүлээн зөвшөөрсөн. Тухайлбал, шүүгч Т.Б “10 дугаар сарын 04-ний өдөр хариуцагч н.Ч-ээс хариу тайлбар ирсэн байдаг. Эвлэрэх хүсэлтэй байгаагаа илэрхийлээд хариу тайлбараа шүүгчийн туслахад өгсөн байдаг. Нэхэмжлэгч талд хариуцагч эвлэрэх хүсэлттэй гэдгийг мэдэгд гэсэн. Шүүгчийн туслах надад Д.Б ирчихээр тантай уулзъя гээд уйлаад байна гэдэг зүйлийг хэлсэн. Гараад ирэхэд Д.Б сууж байсан. За юу болсон вэ гээд туслахдаа та хоёр ороод ир гээд өрөөндөө орсон...” гэх тайлбарыг тус хорооны 2018 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн нийт гишүүдийн хуралдаан дээр хэлсэн. Мөн, Т дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн туслах О.Ц “2017 оны 10 дугаар сард Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Т.Б шүүгчийн туслах О.Д дээр Д.Б гэх эмэгтэй тайлбартай танилцана гэж ирж уулзсан. Тайлбартай танилцсаны дараа юм ярьж уйлаад байсан, юу ярьсныг нь сонсоогүй. Тухайн үед О.Д 2 хүүхдийн санал асууж байсан учир хүүхэд, өмгөөлөгч нийлээд 4-5 хүн зэрэг үйлчлүүлж байсан. Т.Б шүүгч өрөөнөөсөө гарч ирэхэд Д.Б уйлсаар шүүгчийн өрөө рүү дагаад орсон. Тухайн үед О.Д хамт орсон. Д.Б шүүгчийн өрөөнд 2 минут орчим болоод гарсан байх. Шүүгч өрөөнөөс гарч ирээд туслахын хамт хүүхдийн санал асуусан...” гэсэн тайлбарыг 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдөр гаргажээ.

Шүүгч Т.Б болон Д.Б нарын уулзалт 2-6 минут үргэлжилсэн гэж ойлгогдож байна. Т дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн туслах О.Ц, “...Д.Б шүүгчийн өрөөнд 2 минут орчим болоод гарсан байх” гэсэн тайлбарыг 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдөр гаргажээ. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаан дээр илтгэгч шүүгч “Ойролцоогоор хэд орчим минут уулзсан юм.” гэхэд шүүгч Т.Б “5-аас 6 минут болсон” гэсэн тайлбарыг хэлжээ.

³⁷ Монгол Улсын шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг сэргээхийн тулд авах арга хэмжээ дотор Шүүгчийн ёс зүйн дүрмийг шинэчлэх, ингэхдээ “маргааны нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай шүүгч уулзахыг хориглох”-ыг судлаачид 2008 онд зөвлөж байжээ.

Шүүгч Т.Б-гийн туслах О.Д ШТК дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газрын даргын 2018 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн Б/55 тоот тушаалаар өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн байх тул О.Д-ээс уг уулзалтын талаар тайлбар авах боломжгүй ажээ (Шүүхийн Ёс зүйн хорооны Хяналт шалгалт хариуцсан референт А.Баасанжавын 2018 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн тэмдэглэл). Мөн, шүүгч Т.Б нь Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаан дээр “Тухайн үед ажиллаж байсан туслахаа асуулгая гэхээр туслах ажлаас гараад гадаад явсан байгаа.” гэж хэлжээ. Тиймээс, шүүгч Т.Б Д.Б-тэй уулзахад шүүгчийн туслах О.Д хэдий хугацаанд байсан, ямар шалтгаанаар гарсан, шүүгч хэргийн оролцогч нарын уулзалт хичээн минут орчим үргэлжилсэн зэргийг О.Д-ээс тодруулах боломжгүй байна.

Шүүгч Т.Б нь хариуцагч Д.Ч-г байлцуулахгүйгээр нэхэмжлэгч Д.Б-тэй 2017 оны 10 дугаар сарын 27-ны өдөр ганцаарчлан уулзсанаараа Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль (ШЭЗБТХ)-ийн 27.1.17-д “хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах”-ыг шууд хориглосон заалтыг ноцтой зөрчжээ. Шүүгч Т.Б нь хариуцагч Д.Ч-г байлцуулахгүйгээр нэхэмжлэгч Д.Б-тэй 2017 оны 10 дугаар сарын 27-ны өдөр ганцаарчлан уулзсанаараа ШЭЗБТХ-ийн 27.1.17-д “хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах”-ыг шууд хориглосон заалтыг ноцтой зөрчсөн учраас Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1-д “Шүүгч нь хууль дээдлэх, ... мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх зэрэг зарчмуудыг хувийн зан чанар болгож төлөвшүүлнэ.” 3.3 дугаар зүйлийн 1-д “Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй.” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шүүгч Т.Б хариуцагч Д.Ч-г байлцуулахгүйгээр нэхэмжлэгч Д.Б-тэй 2017 оны 10 дугаар сарын 27-ны өдөр ганцаарчлан уулзсанаараа төвийг сахих зарчмаа бодитой зөрчих эсхүл тийнхүү ойлгогдох нөхцөлийг бүрдүүлжээ. Шүүгч Т.Б “Д.Б нь надтай уулзаж байхдаа Д.Ч нь миний ээжийг сэтгэл мэдрэлийн өвчтэй гэж хэлдэг гэсэн үгийг хэлсэн.” гэж тайлбартаа бичжээ. Гэвч, гомдол гаргагч Д.Б энэ уулзалтын үеэр шүүгч юу хэлсэн талаар ийнхүү гомдолдоо бичжээ: “Ингэж уулзахад шүүгч надаас “Д.Ч чамайг зодохдоо хэдэн удаа цохисон вэ, чи хаана хэнтэй хэний байранд амьдарч байгаа вэ гэж асуусан ба би асуултад нь хариулсан. Үүний дараагаар шүүгч Т.Б нь хариуцагч Д.Ч-тэй өмнө нь уулзсан тухайгаа дурдаж, миний том ах, аав хоёр одоогоос 31 болон 21 жилийн өмнө нас барсан учраас миний ээж сэтгэлийн хямралтай байж болохоос гадна намайг хүүхэд төрүүлээд удаагүй нялх биетэй байгаа болохоор мөн адил сэтгэлийн хямралтай байж болно гэж хэлээд сэтгэл зүйчтэй 2017.10.30-ны өдөр 13.30-нд уулз гэсэн. ... Шүүгч Т.Б нь П дүүргийн Цагдаагийн ... дугаар хэлтэст шалгагдаж буй миний хохирогчоор оролцож байгаа эрүүгийн хэрэгтэй холбоотой асуулт асуун, миний амьдарч буй байр байдлыг тандаж, бүр цаашлаад намайг болон ээжийг минь сэтгэлийн хямралтай гэж хэлж миний болон ээжийн минь нэр хүндийг гутаасан нь түүнийг хариуцагч Д.Ч-гийн талд ажиллаж байгаа мэт сэтгэгдэл надад төрүүлсэн,” Шүүгч Т.Б болон нэхэмжлэгч Д.Б нарын хооронд ямар яриа болсон эсэхийг мэдэх боломжгүй боловч шүүгч Т.Б нь Д.Б-тэй ганцаарчлан уулзсанаараа аль нэг талд ажилласан, төвийг сахиагүй мэт ойлголт төрүүлэх эсхүл тийнхүү хардагдах нөхцөлийг бий болгожээ.

Шүүгч Т.Б нь хариуцагч Д.Ч-г байлцуулахгүйгээр нэхэмжлэгч Д.Б-тэй ганцаарчлан уулзсанаараа төвийг сахих зарчмыг зөрчсөн гэж ойлгогдох нөхцөл байдлыг бий болгожээ. Иймд, шүүгч Т.Б нь Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 1-д “Шүүгч нь хэргийн оролцогчдод эрх тэгш, төвийг сахисан ... ёсоор хандаж, хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлэхүйц харилцааны соёлыг эзэмшсэн байна.” гэх заалтыг зөрчсөн гэх ойлголтыг төрүүлсэн учраас уг дүрмийн 2.3 дугаар зүйлийн 1-д “Шүүгч нь зохисгүй байдал гаргаж

болохгүй бөгөөд бусдад ийнхүү ойлгогдохоос зайлсхийнэ.” 3.3 дугаар зүйлийн 2-т “Хэргийн оролцогчдын зүгээс шүүгчийг татгалзахад хүргэх нөхцөл байдлыг өөрийн үг яриа, үйлдлээр бий болгохоос урьдчилан сэргийлж, зайлсхийнэ.” гэж заасныг тус тус зөрчжээ.

ШЭЗБТХ-ийн 27.1.17-д “хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах”-ыг шууд хориглодог боловч Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2.4-д заасан “Шүүгч хэргийн оролцогчтой ганцаарчлан уулзаж хэргийн нөхцөл байдал, гэм буруугийн талаар ярилцаж болохгүй бөгөөд хэрэв албан ажлын зайлшгүй шаардлагын улмаас хэргийн нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай уулзах бол шүүхийн туслах ажилтан байлцуулах бөгөөд уулзалтын агуулгын талаар тэмдэглэл хөтлөн хэрэгт хавсаргана.” гэж заасан байна. Шүүгч Т.Б нь хариуцагч Д.Ч-г байлцуулахгүйгээр нэхэмжлэгч Д.Б-тэй 2017 оны 10 дугаар сарын 27-ны өдөр ганцаарчлан уулзахдаа Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2.4-г мөн зөрчжээ. Учир нь, энэ уулзалтын үеэр шүүгчийн туслах О.Д-г байлцуулаагүй байна. Шүүгч Т.Б тайлбартаа “Д.Б хувийн асуудлаа яриад уйлаад байсан учир туслах О.Д-г өрөөнөөс гаргасан.” гэжээ. Хэргийн аль нэг тал хувийн асуудлаа ярьсан, уйлсан гэх шалтгаанаар шүүгч тухайн талтай туслахгүйгээр уулзахыг Шүүгчийн ёс зүйн дүрэм зөвшөөрөөгүй. Түүнчлэн, нэгэнт шүүгчийн туслахыг байлцуулаагүй учраас уг уулзалтын агуулгын талаарх тэмдэглэл үйлдэж хэрэгт хавсаргаагүй байх бөгөөд шүүгч Т.Б үүнийг нийт гишүүдийн хуралдаан дээр мөн хүлээн зөвшөөрсөн.

Шүүгч Т.Б Д.Б-тэй ганцаарчлан уулзсан явдлаа “ИХШХШТХ-ийн 132-р зүйлийн 132.1-д зааснаар гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг шүүх авна гэж заасны дагуу нэхэмжлэгч, хариуцагчтай уулзсан.” гэж зөвтгөсөн нь үндэслэлгүй юм. ШЭЗБТХ-ийн 27.1.17-ийн “хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах”-ыг шууд хориглосон заалт болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132.1-ийн “гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх арга хэмжээ” авах тухай заалт нь адил хүчин чадалтай зохицуулалтууд тул аль нэг нь нөгөөхөө үгүйсгэсэн байдлаар хэрэгжихгүй. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132.1-д “Шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ гэрлэлт цуцлах болсон шалтгааныг тогтоох ба гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг авна.” гэж заасан нь хуулийн бусад зохицуулалтад нийцэн хэрэгжих учиртай. Өөрөөр хэлбэл, гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх арга хэмжээ гэдэг нь ШЭЗБТХ болон бусад хуульд илэрхий хориглосон хориглолтыг зөрчихгүй байхыг хууль дээдлэх зарчим шаардана. Хэрэв эвлэрүүлэх бүх арга хэмжээ гэдэг нэрийн дор хуульд заасан аливаа хориглолт (тухайлбал, ШЭЗБТХ-ийн 27-р зүйлд жагсаасан 20 янзын хориглолт)-ыг зөрчихийг шүүгчид зөвшөөрвөл хууль бус дур зорго ноёлох болно.

Гомдол гаргагч Д.Б “шүүгч Т.Б-д холбогдуулан ... өөрийн гаргасан хүсэлтээ буцааж байна.” гэх хүсэлтийг 2017 оны 12 дугаар сарын 19-ний өдөр гаргасан нь шүүгч Т.Б-гийн талаарх гомдлыг хянан шийдвэрлэхэд саад болохгүй. Учир нь, Шүүхийн Ёс зүйн хороо нь ШЭЗБТХ-ийн 33.2-т зааснаар шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн гэх гомдлыг “заавал хянан үзнэ.” Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 2.1-д зааснаар “гомдлыг заавал хянан шийдвэрлэх зарчмыг мөрдлөг болгоно.” Шүүгчийн ёс зүйн зөрчил гаргасан гэх асуудал нь шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг хөсөрдүүлсэн эсэхтэй холбоотой байдаг. Тиймээс, шүүгчийн ёс зүйн зөрчил гарсан тухай гомдол гаргахад эрх, ашиг сонирхол нь хөндөгдсөн буюу зөрчигдсэн байхыг заавал шаарддаггүй бөгөөд тус хороо нь гомдол гаргагч гомдлоосоо татгалзсан эсэхээс үл хамааран тухайн гомдлыг заавал хянан шийдвэрлэж шүүгчийн ёс зүйн зөрчил гарсан эсэхийг тогтоодог.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйл, 36 дугаар зүйлийн 36.1.1, 37 дугаар зүйлийн 37.1.2, Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйл, Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.1, 5.13-т заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Т.Б-д сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Энэ магадлалын хувийг шүүгч болон гомдол гаргагчид хүргүүлэхийг Ажлын албанд даалгасугай.

3.Шүүгч, гомдол гаргагч магадлалыг эс зөвшөөрвөл гардан авснаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ

Н.ЭРДЭНЭЦОГТ

ГИШҮҮН

Ч.ОЮУНЦЭЦЭГ

UIN.MN
СУДАЛГААНЫ САН



ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ
МАГАДЛАЛ

2019 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 221/ЁМ2019/0009

Улаанбаатар хот

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны
2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн
74 дүгээр магадлалын тухай

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааныг шүүгч Э.Лхагвасүрэн даргалж, шүүгч Б.Тунгалагсайхан, шүүгч Э.Халиунбаяр нарын бүрэлдэхүүнтэй, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Н.Өнө-Эрдэнэ, гомдол гаргагч Д.Б, шүүгч Т.Б нарыг оролцуулан, Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 74 дүгээр магадлалыг эс зөвшөөрч шүүгч Т.Б-гийн гаргасан гомдлоор, Д.Б-гийн гомдолтой, Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Т.Б-д холбогдох сахилгын хэргийг шүүгч Э.Халиунбаярын илтгэснээр хянан хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 74 дүгээр магадлалаар: Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Т.Б-д сануулах сахилгын шийтгэл ногдуулж шийдвэрлэжээ.

Шүүгч Т.Б шүүхэд гаргасан гомдолдоо: "... Шүүгч санаачилгаараа хэргийн нэг талыг дуудаж уулзаагүй:

Шүүхийн Ёс зүйн хороо Т.Б намайг гомдол гаргагч Д.Б-тэй ганцаарчлан уулзсан нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.17-д "хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах"-ыг хориглосон заалтыг зөрчсөн гэх үндэслэлээр сахилгын хариуцлага тооцохдоо дараах асуудлыг нягтлан үзэж, шалган тогтоолгүйгээр шийдвэр гаргалаа.

Шүүгч Т.Б миний бие гомдол гаргагч Д.Б-тэй ганцаарчлан уулзах асуудлыг гаргаагүй. Иймд шүүгч санаачилга гаргаж хэргийн талаар асууж тодруулах ажиллагаа явуулсан уу, эсхүл гомдол гаргагч шүүгчийн өрөөнд зөвшөөрөлгүй орсон уу гэдэг ялгаа заагийг шалган тогтоож байж, шүүгч ёс зүйн зөрчил гаргасан эсэхэд дүгнэлт хийх учиртай.

Энэхүү асуудлыг нягтлан тодруулалгүйгээр "шүүгчийг нэг талтай уулзсан." гэж тулган хариуцлага тооцож буйг хүлээн зөвшөөрөхгүй байна. Тухайлбал,

Гомдол гаргагч Д.Б нь шүүгч миний өрөөнд уйлж орж ирээд нялх хүүхэдтэйгээ амьдардаг, хүчирхийлэлтэй амьдралын зовлонгоо тоочиж, бухимдалтай байх үед түүнийг тайвшруулах зорилгоор ярилцсан. Энэ нөхцөлд шүүгч яах ёстой байсан бэ? Д.Б-гийн сэтгэл хөдлөлтэй, уйлж унжсан үед шүүгчийн зүгээс өрөөнөөс гар, би чамтай уулзахгүй гэх нь харин эсрэгээрээ хүн ёсны болоод зан харьцаа, хүний эрхийг хамгаалж ажилладаг шүүхийн үйл ажиллагаанд гомдох учир аль болохоор эв зетэй, хүндэтгэлтэй харьцсан болно.

Шүүхийн Ёс зүйн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.2 дугаар зүйлд зааснаар “албан ажлын зайлшгүй шаардлагын улмаас хэргийн нэг талыг байлцуулахгүй нөгөө талтай уулзах бол шүүхийн туслах ажилтан байлцуулж, тэмдэглэл хөтлөн хэрэгт хавсаргах” заалтыг зөрчсөн гэж үзсэнийг мөн зөвшөөрөхгүй байна.

Учир нь:

а/ Шүүгч Т.Б миний зүгээс Д.Б-гийн нэхэмжлэлтэй хэрэгтэй холбогдуулан түүнтэй уулзах шаардлага огт байгаагүй.

б/ Д.Б миний өрөөнд зөвшөөрөлгүй орж ирж, уйлж элдэв зовлон ярьсан асуудалд миний бие хамааралгүй.

в/ Д.Б-гийн ярьсан зүйл нь хэргийг шийдвэрлэхэд ач холбогдолтой зүйл биш, түүний амьдралын нууцтай холбогдох асуудал байсан учир Шүүгчийн Ёс зүйн дүрэмд зааснаар тэмдэглэл бичих шаардлагагүй. Иймд шүүгчийн зүгээс санаачилгаараа гомдол гаргагчтай уулзаагүй учраас Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.17 дахь зохицуулалт нь болсон үйл явдлын харилцаанд хамааралгүй гэж үзэж байна.

Гомдлын зарим үндэслэлийг шийдвэрлээгүй орхигдуулсан тухай Д.Б-гийн гомдлын үндэслэлд “хуулийн дагуу миний гаргасан нэхэмжлэлийг шийдвэрлэнэ гэдэгт эргэлзэж байгаа тул тус шүүгчээс татгалзах хүсэлтэй байна.” гэжээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлд заасны дагуу шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шийдвэрлэдэг тул энэ асуудал Шүүхийн Ёс зүйн хороонд хамааралгүй болно. Иймд Шүүхийн Ёс зүйн хороо гомдол гаргагчийн энэхүү үндэслэл нь Шүүхийн Ёс зүйн хорооны харьяалалд хамааралгүй болох талаар магадлалдаа огт дурдаагүй, эрх зүйн дүгнэлт ч хийгээгүй орхижээ.

Өөрөөр хэлбэл, гомдол гаргагч дээрх үндэслэлийнхээ хариултыг аваагүй байна. Шүүхийн захиргааны үүргийг шүүгчийн ёс зүйд хамааруулсан асуудал.

Анхан шатны шүүхийн өнөөгийн бодит байдал Шүүгчийн Ёс зүйн хорооны гишүүдийн дүгнэж байгаа шиг боломж, нөхцөл бүрдээгүй байгаа нь хуралдааны явцад тодорхой болж нотлогдсон. Хэргийн хүмүүс шүүгчийн өрөөнд дураар ордог, учир зовлонгоо тоочихыг эрмэлздэг үзэгдлийг шүүхийн захиргааны байгууллага зохицуулж чаддаггүй үйл ажиллагааны эцсийн бурууг шүүгчид халдааж байгаад гомдолтой байна.

Бодит амьдрал дээр анхан шатны шүүхийн давчуу байранд олон хэргийн хүмүүс бужигнаж, хэвийн ажиллах нөхцөлгүй орчныг өндөр хөгжилтэй орны шүүхийн жишигт харьцуулан дүгнэлт хийж буй нь амьдралаас тасарсан хөөсрөлтийн үзэгдлийг шүүгчээс шаардаж байгаатай агаар нэг юм.

Анхан шатны шүүхийн ажлын ачаалал их, өрөө тасалгааны хүрэлцээ муу, шүүхэд ирж буй хүмүүсийн эрх зүйн ухамсар дутмаг, шүүхийн захиргааны ажилтны ажил хэрэгч байдал, мэдлэг чадвар, туршлагын хомсдолтой /одоогийн байдлаар нийт захиргааны ажилчдын 90 орчим хувь нь шинэ хүмүүс томилогдсон/ байгаагаас шүүгчийг шийдвэр гаргах түвшинд ажиллуулах боломжийг олгохгүй байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л үе шатанд, тэр ч байтугай захиргааны ажилд шүүгч оролцох, зааж зааварлаж байж процессын зөрчилгүй олон хэргийн ард гарч байгаа гэж би үздэг.

Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалд шүүхийн ажиллагаа зориулалтын бус орон сууцны байранд явуулж байгаа бурууг хүлээн зөвшөөрч, энэ талаар Шүүхийн ерөнхий зөвлөлд хаяглан анхааруулжээ. Шүүхийн ерөнхий зөвлөл Д.Б-гийн гомдолд хамаарал бүхий субъект биш учир энэхүү анхааруулгаа сахилгын хариуцлага хүлээлгэсэн магадлалд тусгах нь буруу юм. Магадлалын хувийг Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлэх дүрэм журам байхгүй. Учир нь, Шүүхийн Ёс зүйн хороо хараат бусаар ажиллах үүргээ энэхүү дүгнэлтээр зөрчжээ.

Иймд шүүхийн захиргааны байгууллагаас шүүгчийн өрөөнд хэн дуртай нь орох боломжгүй байх бүхий л арга хэмжээг авч ажиллаж чадаагүйн үр дагаврыг шүүгчид хариуцлага хэлбэрээр наалдуулах нь буруу гэж үзэж байна.

Шүүхийн шийдвэрт төвийг сахисан байр суурь тусгагдсан байх зарчим Шүүгчийн төвийг сахисан байр суурь шүүхийн шийдвэрт тусгалаа олж байж давах болон хяналтын шатны шүүхээр дүгнэгдэх учиртай. Одоогийн байдлаар Д.Б-гийн нэхэмжлэлтэй хэрэг эцэслэн шийдвэрлэгдээгүй байгаа нөхцөлд шүүгчийн төвийг сахисан эсэх асуудлыг Шүүхийн Ёс зүйн хороо шууд дүгнэх, судлаачдын зөвлөгөөг үндэслэл болгон шүүгчид хариуцлага тооцох эрх зүйн боломжгүй юм.

Ийнхүү шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нөлөөлж буй хүчин зүйлийг харгалзан үзэлгүй, Шүүхийн Ёс зүйн хорооноос шүүгчид хариуцлага тооцох чиг хандлагыг урьтал болгосноороо бодит амьдралаас тасархай шийдвэр гаргахад хүрч, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхийн төлөө цаг наргүй ачаалал дунд зүтгэн ажиллаж байгаа шүүгчийн зүтгэл, итгэлийг мохоож байна.

Шүүхийн Ёс зүйн хороо асуудлыг үндэслэлтэй, шударгаар шийдвэрлэснээрээ шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч шүүх, шүүгчийн хараат бус байдал, түүний нэр төр, ажил хэргийн нэр хүндийг хууль ёсны дагуу хамгаалах учиртай.

Гомдол ёс зүйн зөрчил хоёр шалтгаант холбоогүй болох асуудал

Гомдол гаргагч Д.Б-гийн эрх ашиг хэрхэн хөндөгдсөн асуудлыг ч мөн авч үзсэнгүй.

Шүүх Д.Б-гийн нэхэмжлэлийг хүлээн аваад, гэр бүлийн хүчирхийлэл байгаа талаарх асуудлыг нэхэмжлэлдээ тусгаснаар иргэний хэрэг үүсгэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсан. Энэ явцад нэхэмжлэгч Д.Б өөрөө хариуцагчтай эвлэрэх хүсэлт гаргасныг шүүх хүлээн авч, 2017 оны 11 сарын 22-ны өдрийн 19942 дугаар шүүгчийн захирамжаар хэргийг 2 сарын хугацаагаар түдгэлзүүлж, эвлэрүүлэх ажиллагаа явуулсан. Энэхүү эвлэрүүлэх хугацаа олгосон шүүгчийн захирамжид Д.Б ямар нэг гомдол гаргаагүй тул хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.

Шүүгчийн захирамж гаргах хүртэлх процесс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчөөгүй болно. Шүүгч хэргийн нэг талтай хувийн сонирхлоор уулзах, аль нэг талд давуу байдал олгож, хууль бус дүгнэлт гаргах зэргээр ашиг сонирхлын зөрчил гаргавал ёс зүйн зөрчилд хамаарагдана гэдгийг миний бие ойлгож ухамсарлаж байгаа. Харин хэргийн оролцогч өөрөө шүүгчийн өрөөнд зөвшөөрөлгүй орж, бухимдлаа илэрхийлчхээд, эргээд ёс зүйн зөрчил гаргалаа гэж гомдол гаргаж байгаагийн учир шалтгааныг Шүүхийн Ёс зүйн хороо мэргэжлийн талаас шалгаж тогтоосонгүй.

Гомдол гаргагчийн эрх ашиг хөндөгдөөгүй

Шүүгч ёс зүйн зөрчил гаргасны үр дагаварт гомдол гаргагч Д.Б-гийн эрх ашиг нь зөрчигдсөн байх ёстой.

Магадлалаас үзвэл, шүүгчийн гаргасан гэж үзээд байгаа зөрчил нь гомдол гаргагчийн эрх ашгийг хэрхэн хөндсөн асуудалд огт дүгнэлт хийгээгүй байна.

Түүний гомдолд дурдсанаар хариуцагч Д.Ч-гийн талд ашигтай шийдвэр гаргуулахаар шүүгч ганцаараа уулзсан гэж үзсэн бол нэхэмжлэгч хариуцагчтай эвлэрэх хүсэлтийг шүүхэд гаргахгүй байх байсан. Ийм утга агуулгын хувьд зөрчилтэй гомдлыг Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан нь чухам ямар агуулгатай, түүний эрх ашиг нь зөрчигдсөн асуудал Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалд тусгаагүй, дүгнэлт хийлгүй орхигдуулжээ. Иймээс Д.Б-гийн гомдол, шүүгчийн ёс зүйн зөрчил гэгчийн хооронд шалтгаант холбоо тогтоогдоогүй гэж үзнэ. Учир нь:

Д.Б-гийн гомдлын агуулгаас үзвэл, хариуцагч Д.Ч-тэй эвлэрэх хүсэлтийг шүүхэд гаргаахааргүй зүйл бичсэн атлаа бодит байдал дээр өөрөө эвлэрэх хүсэлтийг шүүхэд гаргаж шийдвэрлүүлсэн үйл баримт нь Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан түүний гомдол үндэслэлгүйг нотолж байна.

Д.Б нь 2017 оны 01 сарын 19-ний өдөр Ёс зүйн хороонд гаргасан гомдлоосоо татгалзсан, 2018 оны 10 сарын 19-ний өдрийг хүртэл Ёс зүйн хорооны хурал болон Захиргааны хэргийн давж заалдах шатны хуралдаанд нэг ч удаа ирээгүй.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 5 сарын 22-ны өдрийн 16 дугаар магадлалаар шүүгчийн туслахаас тайлбар аваагүй байна гэсэн дүгнэлтийг хийсэн.

Гэвч шүүгч Т.Б миний туслахаар ажиллаж байсан О.Д 2018 оны 02 сард шүүгчийн туслахын ажлаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөж нарийн бичгийн даргаар ажиллаж байгаад 2018 оны 6 сард ажлаасаа чөлөөлөгдсөн.

Тухайн хамт ажиллаж байсан Т.Г-гийн шүүгчийн туслах Д.Ц-ээс тайлбарыг бичиж авхуулсан. Туслах Д.Ц тухайн үеийн нөхцөл байдлын талаар тайлбарыг гаргаж өгсөн боловч Ёс зүйн хорооноос үүнд дүгнэлт өгөөгүй байна.

Дээрх үндэслэлээр Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 74 дүгээр магадлалыг хүчингүй болгож, шүүгч Т.Б надад арга хэмжээ авсан сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү.” гэжээ.

ХЯНАВАЛ:

Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хороо шүүгч Т.Б-гийн Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын Шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн гэх үйл баримт хангалттай тогтоогдохгүй байхад түүнд сахилгын шийтгэл ногдуулсан нь үндэслэлгүй тул магадлалыг хүчингүй болгож, шүүгч Т.Б-гийн гаргасан гомдлыг хангаж шийдвэрлэв. Иргэн Д.Б-ээс Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Т.Б-д холбогдуулан “... Шүүгч Т.Б нь 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдөр над руу утсаар залгаж уулзах хэрэгтэй байна гэсэн учир 2017 оны 10 дугаар сарын 27-ны өдөр түүнтэй уулзсан. ... Шүүгч Т.Б нь цагдаагийн хэлтэст шалгагдаж буй миний хохирогчоор оролцож байгаа эрүүгийн хэрэгтэй холбоотой асуулт асуун, миний амьдарч буй байр байдлыг тандаж, намайг болон ээжийг минь сэтгэлийн хямралтай гэж хэлж бидний нэр хүндийг гутаасан нь түүнийг хариуцагч Д.Ч-гийн талд ажиллаж байгаа мэт сэтгэгдэл төрүүлсэн...” гэсэн үндэслэлээр Шүүхийн Ёс зүйн хороонд гомдол гаргажээ.

Харин шүүгч Т.Б нь 2017 оны 10 дугаар сарын 27-ны өдөр өөрийн албан ерөөнд хэргийн оролцогч Д.Б-тэй хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр уулзсан уулзалтын талаар “...Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132 дугаар зүйлийн 132.1-д заасны дагуу энэ гэр бүлийг эвлэрүүлэх үүднээс уулзсан, Д.Ч-гийн өмнөөс тандах байдлаар уулзаагүй. Д.Б хувийн асуудлаа яриад уйлаад байсан учир туслах О.Д-г ерөөнөөс гаргасан, мөн уулзалтыг богино хугацаанд үргэлжилсэн. ...” гэж тайлбарлажээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанаас шүүгч Т.Б-гийн хэргийн оролцогч Д.Б-тэй ганцаарчлан уулзсан дээрх нөхцөл байдлыг Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.17, Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1, 2.3 дугаар зүйлийн 1, 3.2 дугаар зүйлийн 1, 4, 3.3 дугаар зүйлийн 1, 2-т тус тус заасан зөрчил гэж үзэж, сануулах сахилгын шийтгэл ногдуулсан нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.1, 37 дугаар зүйлийн 37.1.1-д заасантай нийцэхгүй байна.

Учир нь Монгол Улсын Шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1-д “Шүүгч хуульд тусгайлан ёс зүйн зөрчил болохоор заасан болон энэ дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг ёс зүйн зөрчил гэж үзнэ.” гэж заасан хэдий ч энэхүү тохиолдлын хувьд шүүгч Т.Б нь хэргийн оролцогч Д.Б руу утсаар залган дуудаж өөрийн санаачилгаар уулзсан, мөн уулзахдаа шүүгч нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль болоод Монгол Улсын Шүүхийн шүүгчийн

ёс зүйн дүрмээр хориглосон зан байдал гаргасан, хэргийн нөхцөл байдал, гэм буруугийн талаар ярилцсан гэх нөхцөл байдал тогтоогдохгүй байна.

Гэтэл Шүүхийн Ёс зүйн хороо дээрх нөхцөл байдалд шүүгч хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэхэд эргэлзэх нөхцөл байдлыг бий болгосон гэх дүгнэлт хийж, уг дүгнэлтээрээ шүүгчийг Шүүгчийн ёс зүйн дүрмийн 2.3 дугаар зүйлийн 1-д “Шүүгч нь зохисгүй байдал гаргаж болохгүй бөгөөд бусдад ийнхүү ойлгогдохоос зайлсхийнэ.”, 3.3 дугаар зүйлийн 2-т “Хэргийн оролцогчдын зүгээс шүүгчийг татгалзахад хүргэх нөхцөл байдлыг өөрийн үг яриа, үйлдлээр бий болгохоос урьдчилан сэргийлж, зайлсхийнэ.” гэж заасныг тус тус зөрчсөн, ёс зүйн зөрчил гаргасан гэж шууд дүгнэсэн нь үндэслэлгүй.

Түүнчлэн Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.17-д “хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах”-ыг шүүгчид хориглосон, харин Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132 дугаар зүйлийн 132.1-д “Шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ гэрлэлт цуцлах болсон шалтгааныг тогтоох ба гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг авна.”, Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 4-т “тодорхой тохиолдолд хэргийн нэг талтай ганцаарчлан уулзахдаа нөхцөл, шаардлагыг биелүүлээгүй бол ёс зүйн зөрчил болох”-оор заасан, эдгээр зохицуулалт нь өөр хоорондоо зөрчилтэй байхад уг хуулиар болон дүрмээр зохицуулагдсан хэм хэмжээг шүүгчийг зөрчсөн гэж дүгнэсэн нь буруу байна.

Иймд шүүгч Т.Б-г хараат бус байх, төвийг сахих зарчмуудыг зөрчиж, хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх үүргээ биелүүлээгүй гэж буруутган, сануулах сахилгын арга хэмжээ авсан Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалыг хүчингүй болгож, түүнд холбогдох сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх нь зүйтэй байна.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.2, 121 дүгээр зүйлийн 121.1.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 74 дүгээр магадлалыг хүчингүй болгож, Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Т.Б-д холбогдох сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгосугай.

2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.5-д зааснаар давж заалдах шатны шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн, хууль буруу хэрэглэсэн гэж нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нар үзвэл магадлалыг гардан авсан, эсхүл хүргүүлснээс хойш 14 хоногийн дотор Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй.

ШҮҮГЧ

Э.ЛХАГВАСҮРЭН

ШҮҮГЧ

Б.ТУНГАЛАГСАЙХАН

ШҮҮГЧ

Э.ХАЛИУНБАЯР



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ХЯНАЛТЫН ШАТНЫ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2019 он 5 сарын 06-ны өдөр
хот

Дугаар 137

Улаанбаатар

Ш дүүргийн Иргэний хэргийн анхан
шатны шүүхийн шүүгч Т.Б-д холбогдох
сахилгын хэргийн тухай

Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх
хуралдааны бүрэлдэхүүн:

Даргалагч: Танхимын тэргүүн М.Батсуурь

Шүүгчид: Л.Атарцэцэг

Г.Банзрагч

Б.Мөнхтуяа

Илтгэгч шүүгч: Х.Батсүрэн

Нарийн бичгийн дарга: Д.Долгордорж

Гомдлын агуулга: “Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2.1, 3.2.2, 3.2.4-ийг тус тус
зөрчсөн.”

Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 74 дүгээр
магадлал,

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 02 дугаар сарын
20-ны өдрийн 221/ЁМ2019/0009 дүгээр магадлалтай,

Шүүх хуралдаанд оролцогчид:

Гомдол гаргагч Д.Б, шүүгч Т.Б нарыг оролцуулж,

Гомдол гаргагч Д.Б-гийн хяналтын журмаар гаргасан гомдлыг үндэслэн
хэргийг хянан хэлэлцэв.

ТОДОРХОЙЛОХ нь:

Өмнөх шатны шүүхийн шийдвэр

1. Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 74
дүгээр магадлалаар: Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйл,
36 дугаар зүйлийн 36.1.1, 37 дугаар зүйлийн 37.1.2, Шүүхийн захиргааны тухай
хуулийн 33 дугаар зүйл, Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийн 5 дугаар зүйлийн
5.7.1, 5.13-т заасныг удирдлага болгон Ш дүүргийн иргэний хэргийн анхан шатны
шүүхийн шүүгч Т.Б-д сануулах сахилгын шийтгэл ногдуулжээ.

2. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 02 дугаар
сарын 20-ны өдрийн 221/ЁМ2019/0009 дүгээр магадлалаар: Монгол Улсын
Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 74 дүгээр
магадлалыг хүчингүй болгож, Ш дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн
шүүгч Т.Б-д холбогдох сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгосон байна.

Хяналтын журмаар гаргасан гомдол

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

3. А хот, Ш дүүргийн ... дугаар хорооны тоотод оршин суух хаягтай, иргэн Д овогтой Б миний бие Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх (ЗХШХШ) тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.6 дахь хэсэгт тус тус заасны дагуу Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн дугаар 221/ЁМ2019/0009 магадлалыг үл зөвшөөрч гомдол гаргах нь:

4. Захиргааны хэргийн давж заалдах шатны 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн шүүх хуралдаанаар шүүх бүрэлдэхүүн Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 74 дүгээр магадлалаар Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Т.Б-д ногдуулсан сануулах сахилгын шийтгэлийг үндэслэлгүй гэж үзэж дугаар 221/ЁМ2019/0009 магадлалаар Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалыг хүчингүй болгох хуульд харшилсан, шударга бус шийдвэр гаргасныг доорх агуулгын хүрээнд эс зөвшөөрч байна.

5. Миний бие гэр бүлийн хүчирхийллээс болж эрүүл мэндээрээ хохирч 2017 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нөхөр Д.Ч-ээс гэр бүл цуцлуулах, хүүхдээ өөрийн асрамжид авах нэхэмжлэл гаргасан. Нэхэмжлэл шүүгч Т.Б-д хуваарилагдсан. Шүүгч Т.Б нь 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдөр над руу утсаар залгаж хувийн шугамаар уулзах хүсэлтээ хэлсэн. Түүний хүсэлтийн дагуу уулзсан. Уулзалтаар шүүгч Т.Б нь “чи хаана хэнтэй хэний байранд амьдарч байгаа вэ”, “Д.Ч чамайг зодохдоо хэдэн удаа цохисон бэ” гэж асуун, хариуцагч Д.Ч-тэй уулзсан тухайгаа дурдаж, түүнээс аав, ах хоёр маань нас барсан тухай сонссоноо хэлж мөн намайг хүүхэд төрүүлээд удаагүй учир миний ээж болон намайг сэтгэлийн хямралтай байж болох учир сэтгэл зүйчтэй 2017 оны 10 дугаар сарын 30-ны өдөр 13:30-д тус шүүхийн байранд уулз гэсэн. Миний хувьд шүүгч Т.Б хариуцагч Д.Ч-гийн үгэнд автаж, намайг болон ээжийг минь доромжилсонд гомдолтой байсан. Миний бие гэр бүлийн хүчирхийллээс хол байх гэж гэрлэлтээ цуцлуулахаар шүүхэд хандсанаас биш олон жилийн өмнө ойр дотнын хүмүүсээ алдсанаас болж эсвэл хүүхэд гаргаснаасаа болж гэрлэлтээ цуцлуулах гээгүй. Мөн шүүгч Т.Б-д хариуцагч намайг хэрхэн зодсон талаар лавлах хэрэг огт байхгүй гэж бодсон учир шүүгчид эргэлзэж, Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хороонд гомдол гаргасан.

6. Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооноос 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн дугаар 198 дугаар тогтоолоор шүүгч Т.Б-д Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2.1 ба 3.2.4-т заасныг үндэслэн сахилгын хэрэг үүсгэсэн талаар болон үүнд шүүгч Т.Б тайлбар гаргасныг миний бие хүлээн авч, уншсан. Шүүгч Т.Б нь анхны тайлбартаа “Хуульд заасан урьдчилан шийдвэрлэх ажиллагаа энэ хэргийн хувьд хийгдээгүй учир Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132 дугаар зүйлийн 132.1-д зааснаар гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг шүүх авна гэж заасны дагуу нэхэмжлэгч, хариуцагчтай уулзсан. Эвлэрүүлэх талын асуудлыг тавьсан. Хэрэгт бол байнгын хүчирхийлэлд байдаг талаар нотлох баримт ирүүлээгүй ... Д.Б хувийн асуудлаа яриад уйлаад байсан учир туслах О.Д-г өрөөнөөс гаргасан ... шүүх хуралдаан дээр 2 сарын эвлэрүүлэх хүсэлтийг нэхэмжлэгч Д.Б-гийн талаас хүсэлт гаргасны дагуу 2017 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 19942 дугаар шүүгчийн захирамжаар хэргийг 2 сарын хугацаатай түдгэлзүүлж эвлэрүүлэх ажиллагаа явагдаж байна.” гэж бичсэн байсан.

7. Миний бие шүүгч Т.Б-гийн дээрх бодит байдлыг гуйвуулсан тайлбарыг уншаад, хэдий гомдлоосоо татгалзсан байсан ч 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдөр хариу тайлбар бичгээр гаргаж, Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хороонд хүргүүлсэн. Миний бие тайлбартаа шүүгч Т.Б-гийн дуудсаны дагуу түүнтэй уулзахад туслах нь хамт байгаагүй ба хувийн асуудал ярьж уйлаагүй гэдгээ дурдсан. Түүнчлэн, шүүгч Т.Б өөрөө хариуцагч Д.Ч-тэй уулзсан тухайгаа тайлбартаа дурдсан хэрнэ хэргийн

материалд тус тусад нь уулзсан гэх тэмдэглэл хөтөлсөн зүйл байхгүй байгаа нь Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2.4 “Шүүгч хэргийн оролцогчтой ганцаарчлан уулзаж хэргийн нөхцөл байдал, гэм буруугийн талаар ярилцаж болохгүй бөгөөд хэрэв албан ажлын зайлшгүй шаардлагын улмаас хэргийн нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай уулзах бол шүүхийн туслах ажилтан байлцуулах бөгөөд уулзалтын агуулгын талаар тэмдэглэл хөтлөн хэрэгт хавсаргана.” гэж заасныг зөрчсөн нь түүнийг хэт нэг талыг баримталсан гэж үзэхэд хүргэснийг дурдсан. Тус хэргийн хавтаст хэрэгт намайг зодож танхайрсан хариуцагчийн 2 үйлдэл Ш дүүргийн Цагдаагийн ... дүгээр хэлтэс, П дүүргийн Цагдаагийн ... дугаар хэлтэст тус тус шалгагдаж байгаа талаарх нотлох баримтыг хүргүүлсэн байсан талаар бас тайлбарт дурдсан. Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн дугаар 19942 захирамжаар хариуцагч Д.Ч-гийн хүсэлтээр тус 2 сарын эвлэрлийн хугацааг авсныг бас дурдсан. Эцэст нь миний бие Монгол улсын Шүүхийн Ёс зүйн хороонд гомдол гаргасан шалтгаан нь Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд гэрлэлтээ цуцлуулахаар гомдол гаргасан хэн нэгэн иргэнд ийм зүй бус зүйл дахин бүү давтагдаасай гэсний үүднээс мөн тус үйлдлээрээ шүүгчид ямар нэгэн байдлаар нөлөөлөх гэж үйлдсэн зүйл бус гэдгийг илэрхийлэх нь зүйтэй гэж бодож байгаагаа дурдсан байсан. Мөн миний бие хариуцагч Д.Ч-д зодуулснаас болж гэмтэл авч, эмчилгээ хийлгэж байсан учир Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанд оролцох боломжгүйгээ бичгээр мэдэгдэн миний эзгүйд хэргийг хянан шийдвэрлэх хүсэлтээ өгсөн.

8. Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн дугаар 22 дугаар магадлалыг хүлээн авч, шүүгч Т.Б-д холбогдох хууль, тогтоомжийн дагуу сануулах сахилгын шийтгэл ногдуулсан тухай мэдсэн. Уг хуралдааны үеэр шүүгч Т.Б нь “Нэхэмжлэгч Д.Б-тэй уулзахад шүүгчийн туслах О.Д хамт байлцсан. Үүдэнд шүүгчийн туслахтай уулзах хүмүүс ирчихсэн, манай өрөөнд байхад иргэд гомдол гаргасан учир гараад явсан. Залуу гэр бүл аль болох эвлэрэх хэрэгтэй, хариуцагч талаас эвлэрэх хүсэлтэй байгаа тайлбарыг ирүүлсэн гэдгийг шүүгчийн зүгээс хэлсэн.” гэж нэмэлт тайлбар гаргасныг Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн дугаар 22 дугаар магадлалаас уншсан. Үүний дараа шүүгч Т.Б нь Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн дугаар 22 дугаар магадлалаар ногдуулсан сануулах сахилгын шийтгэлтэй холбогдуулан Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж, нэмэлт тайлбар хийснийг шүүгч Т.Б-гийн гомдлыг хэлэлцсэн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн дугаар 221/ЁМ2018/0016 дугаар магадлалыг хүлээн авахдаа мэдсэн. Магадлалд дурдагдсан шүүгч Т.Б-гийн гомдол, нэмэлт тайлбарт “Хуульд заасан урьдчилан шийдвэрлэх ажиллагаа энэ хэргийн хувьд хийгдээгүй учир Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132 дугаар зүйлийн 132.1-д зааснаар гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг шүүх авна гэж заасны дагуу нэхэмжлэгч, хариуцагчтай уулзсан. Эвлэрүүлэх талын асуудлыг тавьсан ... Хэрэгт бол байнгын хүчирхийлэлд байдаг талаар нотлох баримт ирүүлээгүй ... Д.Б-г миний өрөөнд орж ирэхэд туслах О.Д хамт орж ирсэн, Д.Б хувийн асуудлаа яриад уйлаад байсан учир туслах О.Д-г өрөөнөөс гаргасан ... ажлын байрны нөхцөл байдал Шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангаагүй нөхцөл байдалд ажиллаж байгаа ... Шүүгч Т.Б миний зүгээс Д.Б-гийн нэхэмжлэлтэй хэрэгтэй холбогдуулан түүнтэй уулзах шаардлага огт байхгүй. Д.Б миний өрөөнд зөвшөөрөлгүй орж ирж, уйлж элдэв зовлон ярьсан асуудалд миний бие хамааралгүй. Д.Б-гийн ярьсан зүйл нь хэргийг шийдвэрлэхэд ач холбогдолтой зүйл биш, түүний амьдралын нууцтай холбогдох асуудал байсан

учир Шүүгчийн ёс зүйн дүрэмд зааснаар тэмдэглэл бичих шаардлагагүй ... Анхан шатны шүүхийн ажлын ачаалал их, өрөө тасалгааны хүрэлцээ муу, шүүхэд ирж буй хүмүүсийн эрх зүйн ухамсар дутмаг ... байгаагаас шүүгчийг шийдвэр гаргах түвшинд ажиллуулах боломжийг олгохгүй байна ... Шүүх Д.Б-гийн нэхэмжлэлийг хүлээн аваад, гэр бүлийн хүчирхийлэл байгаа асуудлыг нэхэмжлэлдээ тусгаснаар иргэний хэрэг үүсгэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсан ... энэ явцад нэхэмжлэгч Д.Б өөрөө хариуцагчтай эвлэрэх хүсэлт гаргасныг шүүх хүлээн авч, 2017 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 19942 дугаар шүүгчийн захирамжаар хэргийг 2 сарын хугацаагаар түдгэлзүүлж, эвлэрүүлэх ажиллагаа явуулсан.” гэж бичсэн байсан.

9. Улмаар Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн дугаар 221/ЁМ2018/0016 магадлалд нотлох баримт дутуу гэсэн шалтгаанаар Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн дугаар 22 магадлалыг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр миний гомдлыг буцаасан байсан. Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хороо 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдөр хуралдаанаар миний гомдлыг дахин хэлэлцэж, шүүгч Т.Б-г Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2.1, 2.3.1, 3.3.2, 3.2.4 дэх заалтыг тус тус зөрчсөн гэж үзэж сануулах сахилгын шийтгэл ногдуулсныг миний бие шүүгч Т.Б-гийн дахин гаргасан гомдолтой холбогдуулан Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс 2019 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн шүүх хуралдааны товыг утсаар мэдэгдэхэд олж мэдсэн.

Шүүгч Т.Б нь Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-ний дугаар 74 магадлалд гаргасан гомдолдоо Шүүгчийн эрх зүйн байдлын байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.17 дахь заалтыг зөрчсөн гэж үзсэнийг хүлээн зөвшөөрөхгүй байгаагаас өөрөө санаачилгаараа хэргийн нэг талыг дуудаж уулзаагүй, “гомдол гаргагч Д.Б нь шүүгч миний өрөөнд уйлж орж ирээд нялх хүүхэдтэйгээ амьдардаг хүчирхийлэлтэй амьдралын зовлонгоо тоочиж, бухимдалтай байх үед түүнийг тайвшруулах зорилгоор ярилцсан.” гэж тайлбарласан байсан. Түүнчлэн, Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.2 дугаар зүйлийг зөрчсөн гэж үзсэнийг үл хүлээн зөвшөөрч “Шүүгч Т.Б миний зүгээс Д.Б-гийн нэхэмжлэлтэй хэрэгтэй холбогдуулан түүнтэй уулзах шаардлага огт байхгүй, Д.Б миний өрөөнд зөвшөөрөлгүй орж ирж, уйлж элдэв зовлон ярьсан асуудалд миний бие хамааралгүй. Д.Б-гийн ярьсан зүйл нь хэргийг шийдвэрлэхэд ач холбогдолтой зүйл биш, түүний амьдралын нууцтай холбогдох асуудал байсан учир Шүүгчийн ёс зүйн дүрэмд зааснаар тэмдэглэл бичих шаардлагагүй” гэж тайлбарласан байсан. Түүнчлэн шүүгч Т.Б “Анхан шатны шүүхийн өнөөгийн бодит байдал Шүүхийн Ёс зүйн хорооны гишүүдийн дүгнэж байгаа шиг боломж, нөхцөл бүрдээгүй байгаа ... хэргийн хүмүүс шүүгчийн өрөөнд дураараа ордог, учир зовлонгоо тоочихыг эрмэлздэг үзэгдлийг шүүхийн захиргааны байгууллага зохицуулж чаддаггүй үйл ажиллагааны эцсийн бурууг шүүгчид халдааж байгаад гомдолтой байна. Анхан шатны шүүхийн ажлын ачаалал их, өрөө тасалгааны хүрэлцээ муу, шүүхэд ирж буй хүмүүсийн эрх зүйн ухамсар дутмаг ... байгаагаас шүүгчийг шийдвэр гаргах түвшинд ажиллуулах боломжийг олгохгүй байна.” гэж гомдолдоо тайлбарласан байсан. Цаашлаад шүүгч Т.Б “Шүүх Д.Б-гийн нэхэмжлэлийг хүлээн аваад, гэр бүлийн хүчирхийлэл байгаа асуудлыг нэхэмжлэлдээ тусгаснаар иргэний хэрэг үүсгэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсан ... энэ явцад нэхэмжлэгч Д.Б өөрөө хариуцагчтай эвлэрэх хүсэлт гаргасныг шүүх хүлээн авч, 2017 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 19942 дугаар шүүгчийн захирамжаар хэргийг 2 сарын хугацаагаар түдгэлзүүлж, эвлэрүүлэх ажиллагаа явуулсан ... хэргийн оролцогч өөрөө шүүгчийн өрөөнд зөвшөөрөлгүй орж, бухимдлаа илэрхийлчхээд эргээд ёс зүйн зөрчил гаргалаа гэж гомдол гаргаж

байгаагийн учир шалтгааныг Шүүгчийн Ёс зүйн хороо мэргэжлийн талаас шалгаж тогтоосонгүй.” гэж гомдолдоо тайлбарласан байсан. Эцэст нь шүүгч Т.Б “гомдол гаргагчийн эрх ашиг хөндөгдөөгүй ... Д.Б-гийн гомдлын агуулгаас үзвэл, хариуцагч Д.Ч-тэй эвлэрэх хүсэлтийг шүүхэд гаргахааргүй зүйл бичсэн атлаа бодит байдал дээр өөрөө эвлэрэх хүсэлтийг шүүхэд гаргаж шийдвэрлүүлсэн үйл баримт нь Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан түүний гомдол үндэслэлгүйг нотолж байна.” гэж гомдолдоо бичсэн байсан.

10. Түүнээс гадна Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-ний дугаар 74 магадлалд дурдсанаар Т.Б шүүгч нь “Шүүгчийн туслах надад Д.Б ирчхээд тантай уулзъя гээд уйлаад байна гэдэг зүйлийг хэлсэн. Гараад ирэхэд Д.Б сууж байсан. За юу болсон бэ гээд туслахдаа та хоёр ороод ир гээд өрөөнд орсон.” гэх тайлбарыг тус хорооны 2018 оны 3 дугаар сарын 16-ны хуралдаан дээр хэлсэн гэсэн байснаас гадна Т дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн туслах О.Ц гэгч “2017 оны 10 дугаар сард Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Т.Б шүүгчийн туслах О.Д дээр Д.Б гэх эмэгтэй тайлбартай танилцана гэж уулзсан. Тайлбартай танилцсаны дараа юм ярьж уйлаад байсан, юу ярьсныг нь сонсоогүй ... Т.Б шүүгч өрөөнөөсөө гарч ирэхэд Д.Б уйлсаар шүүгчийн өрөө рүү дагаад орсон.” гэж тайлбар гаргасан байсан.

11. Миний бие шүүгч Т.Б болон шүүгчийн туслах О.Ц гэгчийн дээрх бодит байдлыг гуйвуулсан гомдол, тайлбарыг олж уншаад, түүний гомдлыг хэлэлцсэн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 02 дугаар сарын 20-ны хуралдаанд оролцож үнэн болсон хэрэг явдал, баримтын талаар тайлбар хийсэн. Тухайлбал, миний бие хэдий гомдлоосоо өмнө татгалзаж байсан ч уг гомдлыг шийдвэрлэж байгаа байдал болон шүүгч Т.Б-гийн тайлбаруудыг шуудангаар хүлээн авч танилцахад шүүгч Т.Б-гийн тайлбарт бодит байдлыг гуйвуулсан мэдээлэл их байгаа учир тайлбар гаргахаас өөр аргагүй болсон ба миний бие шүүгч Т.Б-гийн өрөөнд дураараа ороогүй, уйлсан зүйл байхгүй, өөр шүүгчийн туслах О.Ц гэгч тухай үед миний өмсөж явсан хувцсыг ч хэлж мэдэхгүй хэрнэ худал тайлбар гаргасан, шүүгч санаачилгаараа дуудаж уулзсаныг уг уулзалтын өмнөх өдөр шүүгчийн утаснаас миний гар утас руу хийсэн дуудлагаар нотолно, миний зүгээс шүүхэд ямар нэгэн эвлэрүүлэх хүсэлт гаргаж байгаагүй нь хэргийн материалд тодорхой байгаа, хүчирхийлэлд байсныг миний нэхэмжлэлтэй иргэний хэргийн хариуцагчид гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж, миний биед гэмтэл учруулсан хоёр үйлдэлд Эрүүгийн хэргийн анхан, давж заалдах, дээд шатны шүүхийн шийтгэвэр, магадлал, тогтоол нотолно, хариуцагчийн үгэнд шүүгч автаж миний бие болон гэр бүлийг минь доромжилсонд гомдолтой байгаа, хүчирхийллээс хол байх гэж гэрлэлт цуцлуулах гэж шүүхэд хандахад хүчирхийлэгч-хариуцагчийн үгэнд автаж хохирогч-нэхэмжлэгчийг доромжлох, дарамтлах гэж оролдсон нөхцөл байдалд миний эрх ашиг хөндөгдөж байгаа. Т.Б шүүгчийг дуудсанаар түүнтэй уулзахаар очиход шүүхийн байр дэг журамтай газар байсан гэтэл шүүгч холбогдох хууль тогтоомж зөрчсөнөө ажлын байрны нөхцөлд байдалд тохоод ёс зүйгүй үйлдлийнхээ хариуцлагаас мултрахыг оролдож байна, Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны шийдвэр үндэслэлтэй зөв гарсан тул хэвээр нь үлдээх хүсэлтээ илэрхийлсэн.

12. Гэвч Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн хуралдаанаар шүүх бүрэлдэхүүн Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 74 дүгээр магадлалыг үндэслэлгүйгээр хэрэгсэхгүй болгосон. Тухайлбал: Давж заалдах шатны шүүх хуралдааны шүүх бүрэлдэхүүн “... шүүгч Т.Б-гийн хэргийн оролцогч Д.Б-тэй ганцаарчлан уулзсан дээрх нөхцөл байдлыг Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 21.1.17, Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1, 2.3 дугаар зүйлийн 1, 3.2 дугаар зүйлийн 1, 4, 3.3 дугаар зүйлийн 1, 2-т тус тус заасныг зөрчсөн гэж үзэж, сануулах

сахилгын шийтгэл ногдуулсан нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.1, 37 дугаар зүйлийн 37.1.1-д заасантай нийцэхгүй байна” гээд “... шүүгч Т.Б нь хэргийн оролцогч Д.Б руу утсаар залган дуудаж өөрийн санаачилгаар уулзсан, мөн уулзахдаа шүүгч нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд болоод Монгол Улсын Шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмээр хориглосон зан байдал гаргасан, хэргийн нөхцөл байдал, гэм буруугийн талаар ярилцсан гэх нөхцөл байдал тогтоогдохгүй байна.” гэж үзсэн нь шүүгч Т.Б-гийн түүнтэй уулзсан нөхцөл байдал, Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд байгаа миний нэхэмжлэлтэй иргэний хэргийн хавтас хэрэгт авагдсан нотлох баримтыг гуйвуулсан, орхигдуулсан, өөр хоорондоо авцалдаагүй удаа дараагийн тайлбаруудад суурилсан учир үндэслэлгүй юм.

13. Шүүгч Т.Б Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хороонд ирүүлсэн анхны тайлбартаа “Хуульд заасан урьдчилан шийдвэрлэх ажиллагаа энэ хэргийн хувьд хийгдээгүй учир Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132 дугаар зүйлийн 132.1-д зааснаар гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг шүүх авна гэж заасны дагуу нэхэмжлэгч, хариуцагчтай уулзсан.” гэж бичсэн байдаг. Мөн Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны үеэр шүүгч Т.Б нь “Нэхэмжлэгч Д.Б-тэй уулзахад шүүгчийн туслах О.Д хамт байлцсан. Үүдэнд шүүгчийн туслахтай уулзах хүмүүс ирчихсэн, манай өрөөнд байхад иргэд гомдол гаргасан учир гараад явсан. Залуу гэр бүл аль болох эвлэрэх хэрэгтэй, хариуцагч талаас эвлэрэх хүсэлтэй байгаа тайлбарыг ирүүлсэн гэдгийг шүүгчийн зүгээс хэлсэн.” гэж тайлбарласан байдаг. Бас шүүгч Т.Б нь Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн дугаар 22 дугаар магадлалаар ногдуулсан сануулах сахилгын шийтгэлийг үл зөвшөөрч Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гаргасан гомдолдоо “Хуульд заасан урьдчилан шийдвэрлэх ажиллагаа энэ хэргийн хувьд хийгдээгүй учир Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132 дугаар зүйлийн 132.1-д зааснаар гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг шүүх авна гэж заасны дагуу нэхэмжлэгч, хариуцагчтай уулзсан. Эвлэрүүлэх талын асуудлыг тавьсан ... Д.Б-г миний өрөөнд орж ирэхэд туслах О.Д хамт орж ирсэн, Д.Б хувийн асуудлаа яриад уйлаад байсан учир туслах О.Д-г өрөөнөөс гаргасан.” гэж тайлбарласан хэрнэ “Шүүгч Т.Б миний зүгээс Д.Б-гийн нэхэмжлэлтэй хэрэгтэй холбогдуулан түүнтэй уулзах шаардлага огт байхгүй. Д.Б миний өрөөнд зөвшөөрөлгүй орж ирж, уйлж элдэв зовлон ярьсан асуудалд миний бие хамааралгүй. Д.Б-гийн ярьсан зүйл нь хэргийг шийдвэрлэхэд ач холбогдолтой зүйл биш, түүний амьдралын нууцтай холбогдох асуудал байсан учир Шүүгчийн ёс зүйн дүрэмд зааснаар тэмдэглэл бичих шаардлагагүй.” мөн Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн дугаар 74 магадлалаар ногдуулсан сануулах сахилгын шийтгэлийг үл зөвшөөрч Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гаргасан гомдолдоо “гомдол гаргагч Д.Б нь шүүгч миний өрөөнд уйлж орж ирээд нялх хүүхэдтэйгээ амьдардаг хүчирхийлэлтэй амьдралын зовлонгоо тоочиж, бухимдалтай байх үед түүнийг тайвшруулах зорилгоор ярилцсан ... Шүүгч Т.Б миний зүгээс Д.Б-гийн нэхэмжлэлтэй хэрэгтэй холбогдуулан түүнтэй уулзах шаардлага огт байхгүй. Д.Б миний өрөөнд зөвшөөрөлгүй орж ирж, уйлж элдэв зовлон ярьсан асуудалд миний бие хамааралгүй Д.Б-гийн ярьсан зүйл нь хэргийг шийдвэрлэхэд ач холбогдолтой зүйл биш, түүний амьдралын нууцтай холбогдох асуудал байсан учир Шүүхийн ёс зүйн дүрэмд зааснаар тэмдэглэл бичих шаардлагагүй ... хэргийн оролцогч өөрөө шүүгчийн өрөөнд зөвшөөрөлгүй орж, бухимдлаа илэрхийлчхээд эргээд ёс зүйн зөрчил гаргалаа гэж гомдол гаргаж байгаагийн учир шалтгааныг Шүүгчийн Ёс зүйн хороо мэргэжлийн талаас шалгаж тогтоосонгүй” гэж хоорондоо харилцан авцалдаагүй тайлбарууд гаргасан байдаг.

Өөрөөр хэлбэл шүүгч Т.Б нь миний биеийг дуудаж уулзсан шалтгаанаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132 дугаар зүйлийн 132.1-д зааснаар гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг шүүх авна гэж заасны дагуу хуульд заасан урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийхийн тулд гэж анх тайлбарласнаас гадна нэхэмжлэгч Д.Б-тэй уулзахад шүүгчийн туслах О.Д хамт байлцсан, үүдэнд шүүгчийн туслахтай уулзах хүмүүс ирчихсэн, манай өрөөнд байхад иргэд гомдол гаргасан учир гараад явсан гэж тайлбарлаж байгаад дараа нь Д.Б хувийн асуудлаа яриад уйлаад байсан учир туслах О.Д-г өрөөнөөс гаргасан нь, миний зүгээс Д.Б-гийн нэхэмжлэлтэй хэрэгтэй холбогдуулан түүнтэй уулзах шаардлага огт байхгүй, Д.Б миний өрөөнд зөвшөөрөлгүй орж ирж, уйлж элдэв зовлон ярьсан асуудалд миний бие хамааралгүй, Д.Б-гийн ярьсан зүйл нь хэргийг шийдвэрлэхэд ач холбогдолтой зүйл биш, түүний амьдралын нууцтай холбогдох асуудал байсан учир Шүүгчийн ёс зүйн дүрэмд зааснаар тэмдэглэл бичих шаардлагагүй гэж тайлбарласан нь шүүгч Т.Б нэг болохоор миний биетэй нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132 дугаар зүйлийн 132.1-д заасан ажиллагаа хийхээр уулзсан эсвэл түүний зүгээс миний нэхэмжлэлтэй хэрэгтэй холбогдуулан миний биетэй уулзах шаардлага огт байхгүй гэж өөр өөр тайлбар гаргасан нь хоорондоо авцалдахгүй байна. Мөн миний биетэй уулзахдаа туслахаа байлцуулаагүй шалтгаанаа нэг бол түүний туслах өөр хүмүүс уулзахаар ирснээс гарсан өөр нэг бол миний биеийг хувийн асуудал ярьж уйлснаас гаргасан гэж бас авцалдахгүй өөр өөр тайлбар гаргасан байдаг. Дээр нь миний биетэй уулзахдаа ямар нэгэн тэмдэглэл үйлдээгүйгээ Д.Б-гийн ярьсан зүйл нь хэргийг шийдвэрлэхэд ач холбогдолтой зүйл биш учир шаардлагагүй гэсэн атлаа Д.Б нь шүүгч миний өрөөнд уйлж орж ирээд нялх хүүхэдтэйгээ амьдардаг хүчирхийлэлтэй амьдралын зовлонгоо тоочиж, бухимдалтай байх үед түүнийг тайвшруулах зорилгоор ярилцсан гэсэн нь бас л авцалдахгүй байна. Хэрэв шүүгч Т.Б Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132 дугаар зүйлийн 132.1-д заасан ажиллагаа хийхээр намайг дуудаж уулзахад үнэхээр миний бие ямар нэгэн хүчирхийллийн асуудал ярьж тавьсан бол яагаад хэрэг шийдвэрлэхэд ач холбогдолгүй болж, тэмдэглэл хөтлөх шаардлагагүй байх ёстой гэж.

14. Нөгөө талаар шүүгч Т.Б хариуцагч Д.Ч-тэй уулзсан тухайгаа тайлбартаа хүлээн зөвшөөрдөг хэрнэ хэргийн материалд энэ талаар ямар нэгэн тэмдэглэл хөтөлсөн зүйл байдаггүй, тэдний хооронд ямар зүйл яригдсан нь тодорхойгүй байдаг. Ямартай ч хариуцагч Д.Ч нь 2018 оны 3 дугаар сард шүүгч Т.Б-ээс татгалзсан нь тэдний хоорондын яриа амжилтгүй болсныг илтгэж байна.

15. Шүүгч Т.Б нь Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хороонд ирүүлсэн анхны тайлбарт болон Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн дугаар 22 дугаар магадлалыг үл зөвшөөрч Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гаргасан гомдолдоо хэрэгт бол байнгын хүчирхийлэлд байдаг талаар нотлох баримт ирүүлээгүй гэсэн байсан. Гэтэл миний бие хэдий өөрийн биеэр оролцож чадахгүй байсан ч Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хороонд 2018 оны 3 дугаар сарын 15-нд өгсөн бичгийн тайлбартаа миний нэхэмжлэлтэй иргэний хэргийн хавтаст хэрэгт намайг зодож танхайрсан хариуцагчийн 2 үйлдэл Ш дүүргийн Цагдаагийн ... хэлтэс, П дүүргийн Цагдаагийн ... хэлтэст тус тус шалгагдаж байгаа талаарх нотлох баримтыг хүргүүлсэн байсан талаар тэмдэглэсэн байсан. Дараа нь хариуцагч Д.Ч-г гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж, Д.Б миний биеийг зодож гэмтэл учруулсан хоёр үйлдэлд Ш дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 944 дүгээр шийтгэх тогтоолоор гэм буруутайд тооцож, түүний хилс хэрэгт гүтгэгдсэн гэх гомдол Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 10 дугаар сарын 2-ны өдрийн 909 дүгээр магадлал, Монгол Улсын Дээд шүүхийн

хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны 2019 оны 01 дүгээр сарын 4-ний өдрийн 4 дүгээр тогтоолоор тус тус хэрэгсэхгүй болсон байдаг.

16. Шүүгч Т.Б-гийн миний нэхэмжлэлтэй иргэний хэргийн хавтас хэрэгт байгаа нотлох баримтуудын талаар өөр нэг гуйвуулсан тайлбар нь түүний Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хороо болон Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд удаа дараа гаргасан миний биеийг өөрөө шүүхэд хариуцагчтай эвлэрэх хүсэлт гаргасан, тухайлбал Д.Б-гийн гомдлын агуулгаас үзвэл, хариуцагч Д.Ч-тэй эвлэрэх хүсэлтийг шүүхэд гаргахааргүй зүйл бичсэн атлаа бодит байдал дээр өөрөө эвлэрэх хүсэлтийг шүүхэд гаргаж шийдвэрлүүлсэн үйл баримт нь Шүүхийн Ёс зүйн хороонд гаргасан түүний гомдол үндэслэлгүйг нотолж байна гэх тайлбар юм. Миний бие шүүхэд ийм хүсэлт огт гаргаж байгаагүйг миний нэхэмжлэлтэй иргэний хэргийн материалууд нотлох бөгөөд шүүгч Т.Б-г хариуцагчийн гаргасан хүсэлтийг мушгин гуйвуулж ийм тайлбар гаргасан байна.

17. Миний бие шүүгч Т.Б-гийн дээрх бодит байдлыг гуйвуулсан, хоорондоо харилцан авцалдаагүй тайлбаруудыг залруулахаар Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хороонд бичгийн тайлбар гаргаснаас гадна Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанд оролцож тайлбарласан. Гэтэл Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хуралдааны шүүх бүрэлдэхүүн нөхцөл байдлыг зөвхөн Т.Б шүүгчийн гуйвуулсан, авцалдаагүй тайлбаруудад үндэслэн дүгнэж, хэт нэг талыг барьж Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн дугаар 74 дүгээр магадлалыг хэрэгсэхгүй болгосон нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь хэсэгт заасныг зөрчсөн гэж үзэж болохоор байна.

18. Шүүгч Т.Б нь Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гаргасан гомдол, тайлбарууддаа гомдол гаргагч буюу Д.Б миний эрх ашиг хөндөгдөөгүй гэдэг.

19. Манай улсхэдий Гэрбүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль баталж гэрбүлийн хүчирхийллийг гэмт хэрэг гэж үзэж байгаа боловч энэ төрлийн хүчирхийллийн талаарх мэдлэг ойлголт хязгаарлагдмал, уг гэмт хэргийг нэг ёсондоо өргөн хүрээнд хүлээн зөвшөөрч хүлцдэг, хүчирхийлэл үйлдэгчийг бус хүчирхийллийн хохирогчийг буруутгах хандлагатай нийгэм соёлын хэм хэмжээ давамгайлж байгааг шүүгч Т.Б-гийн миний биетэй уулзсан байдал, миний нэхэмжлэлтэй иргэний хэргийн нотлох баримтуудыг удаа дараагийн гуйвуулсан тайлбараас тодорхой харж болно. Шүүгч Т.Б нь хариуцагчийн үгэнд автаж миний биеийг дуудаж уулзаж, шүүгчийн ёс зүйгүй хандсан атлаа түүний энэ үйлдлийг баримтжуулах боломж нөхцөлийг үгүйсгэхийн тулд туслахаа байлцуулаагүй, тэмдэглэл огт хөтлөөгүй хэрнэ түүний ёс зүйгүй үйлдэлд гомдол гаргасан миний биеийг гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч болж байсныг далимдуулан түүний өрөөнд зөвшөөрөлгүй орж, хүчирхийлэл зовлонгоо уйлан ярьсан мэтээр гүтгэж байна.

20. Монгол Улсын Шүүхийн Ёс зүйн хорооноос түүний энэ ёс зүйгүй байдал нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.17-д мөн Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1, 2.3 дугаар зүйлийн 1.3.2 дугаар зүйлийн 1, 4, 3.3 дугаар зүйлийн 1, 2-т тус тус заасныг зөрчсөн гэж үзсэн нь үндэслэлтэйгээс гадна чухал ач холбогдолтой шийдвэр юм. Бусдын биед гэмтэл учруулсан хүчирхийллийн гэмт хэрэг үйлдэгдэхэд хамгийн эхэнд цагдаагийн байгууллагын бие бүрэлдэхүүн ирж хүчирхийллийн үйлдлийг таслан зогсоон, эмнэлгийн байгууллага хохирогчид үзлэг, оношилгоо хийн, бэртэл гэмтлийг тогтоож, эмчилгээ хийдэг. Дараа нь прокурорын байгууллагын хяналтад цагдаагийн байгууллага тухайн хүчирхийллийн хэргийг шалгаж, эцэст нь эрүүгийн хэргийн шүүх хүчирхийлэгчийн гэм бурууг тогтоож, хариуцлага тооцдог. Харин

уг гэмт хэрэг ямарваа эмэгтэйн эсрэг дотнын хамтрагчийн буюу нөхрийн зүгээс үйлдэгдсэн тохиолдолд гэрлэлт цуцлуулах нь тухайн хүчирхийллийг таслан зогсоох, давтагдахаас сэргийлэхэд чухал алхам болдог. Өөрөөр хэлбэл дээр дурдсан цагдаа, эмнэлэг, прокурор, эрүүгийн шүүхийн байгууллага дээр нэмээд иргэний шүүх оролцогч нэг байгууллага болдог. Гэтэл хүчирхийллийн хэргийг мөрөөр гүйцэтгэгдэж буй ажиллагаанд иргэний шүүх оролцдоггүй салангид байдаг учир хүчирхийллийн хэрэг үйлдэгдсэн байдалд авцалдаагүй үйл ажиллагаа явуулах, шийдвэр гаргахад хүргэх нь бий. Шүүгч Т.Б-гийн хохирогч нэхэмжлэгч миний биеийг дуудаж дур зоргоороо аашлан, хэргийн оролцогчтой уулзахад мөрдлөг болгодог аливаа хууль дүрэм, журмыг үл хүндэтгэсэн энэ үйл явдал нь иргэний шүүх ба хүчирхийллийн гэмт хэргийн эсрэг ажиллаж буй цагдаа, эмнэлэг, прокурор, эрүүгийн шүүхийн байгууллагуудын хооронд байгаа хийдлийг ашиглан хариуцагч Д.Ч иргэний шүүхэд буюу шүүгч Т.Б-г хохирогч миний эсрэг гүжирдлэгийн мэдээллээр хангаж, түүнд нөлөөлсөн явдлаас болсон.

21. Шүүгч Т.Б-гийн энэхүү шүүгчийн ёс зүйгүй үйлдэл, хууль дүрмийг үл хүндэтгэсэн байдал үргэлжлүүлэх юм бол дан ганц миний эрх хөндөгдөөд зогсохгүйгээр үл барам өдрөөс өдөрт нэмэгдэж буй гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч охид, эмэгтэйчүүд, хүүхдүүдийн эрх ашигт сөрөг нөлөөлөх нөхцөл байдлыг бүрдүүлж байна.

22. Иймд, шүүгч Т.Б-д ногдуулсан сахилгын шийтгэлийг хэрэгсэхгүй болгосон Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 221/ЁМ2019/0009 дүгээр магадлалыг хэрэгсэхгүй болгоно уу.” гэжээ.

ХЯНАВАЛ:

1. Давж заалдах шатны шүүхийн магадлал хэрэгт авагдаж шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн нотлох баримтуудад тулгуурлан хэрэглэвэл зохих Шүүгчийн ёс зүйн дүрмийг маргааны үйл баримтад зөв тайлбарлаж хэрэглэсэн байна.

2. Иргэн Д.Б-ээс Шүүхийн Ёс зүйн хороонд хандан “...Миний бие Д.Ч-ээс гэрлэлтээ цуцлуулан нялх охиноо өөрийн асрамжид авахаар Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан ... Шүүгч Т.Б нь П дүүргийн цагдаагийн ... хэлтэст шалгагдаж буй, миний хохирогчоор оролцож байгаа эрүүгийн хэрэгтэй холбоотой асуулт асуун, миний амьдарч буй байр байдлыг тандаж, бүр цаашлаад намайг болон ээжийг минь сэтгэлийн хямралтай гэж хэлэн миний болон ээжийн минь нэр хүндийг гутаасан нь түүнийг хариуцагч Д.Ч-гийн талд ажиллаж байгаа мэт сэтгэгдэл надад төрүүлсэн. ... Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2.1, 3.2.2, 3.2.4-г тус тус зөрчсөн.” гэх гомдлыг гаргажээ.

3. Шүүхийн Ёс зүйн хорооны 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 198 дугаар тогтоолоор Ш дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Т.Б-д сахилгын хэрэг үүсгэж, тус хорооны 2018 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 22 дугаар магадлалаар шүүгч Т.Б-д сануулах сахилгын шийтгэл ногдуулсан байна.

4. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 221/ЁМ2018/0016 дугаар магадлалаар Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 22 дугаар магадлалыг хүчингүй болгож, гомдлыг дахин хэлэлцүүлэхээр Шүүхийн Ёс зүйн хороонд буцаажээ.

5. Улмаар Шүүхийн Ёс зүйн хорооны 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 74 дүгээр магадлалаар шүүгч Т.Б-д сануулах сахилгын шийтгэл ногдуулсныг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 221/ЁМ2019/0009 дүгээр магадлалаар “Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын Шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн гэх үйл баримт хангалттай тогтоогдохгүй байна.” гэдэг

үндэслэлээр Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалыг хүчингүй болгож, шүүгч Т.Б-д холбогдох сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгожээ.

6. Хэрэгт авагдсан баримтаас үзэхэд гомдол гаргагч Д.Б нь шүүгчтэй ганцаарчлан уулзсан үйл баримт тогтоогдож байх боловч энэ уулзалтын гол зорилго нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132 дугаар зүйлийн 132.1-д “Шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ гэрлэлт цуцлах болсон шалтгааныг тогтоох ба гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг авна.” гэж заасны дагуу хийгдсэн гэж үзэхээр байна.

7. Хэдийгээр Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.17-д “хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах”-ыг хориглосон ч хэргийн үйл баримтыг үзэхэд шүүгч туслахыг байлцуулан уулзаж байсан, гомдол гаргагч хувийн асуудал ярьсан учир уулзалтын дундаас туслахыг гаргасан байдлаас үзэхэд шүүгч анхнаасаа хэргийн оролцогчтой ганцаарчлан уулзах зорилго агуулаагүй, мөн уулзалтын шалтгаан нь хэргийн аль нэг оролцогчид давуу байдал олгоход бус, харин Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэрлэгчдийг эвлэрүүлэх арга хэмжээ авахад чиглэгдсэн зэргээр Монгол Улсын Шүүхийн Шүүгчийн Ёс зүйн дүрмийг ноцтой зөрчөөгүй, харин ёс зүйн зөрчлийг хэлбэрийн төдий агуулсан алдаа гэж үзэхээр байна.

8. Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.4.2-т “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй.” гэж зааснаар шүүгчийн мэргэжил, ур чадвар, дадлага туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй байх тул ёс зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэлгүй, иймд Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалыг хүчингүй болгож шийдвэрлэсэн давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээх нь зүйтэй шүүх бүрэлдэхүүн дүгнэв.

9. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.1, 123.2.2-т зааснаар шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийг буруу хэрэглэсэн, хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн нь шүүхийн шийдвэр гарахад нөлөөлсөн бол хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч хяналтын журмаар гомдол гаргах бөгөөд дээрх үндэслэлээр гаргасан хэргийн оролцогчийн гомдлыг Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар хэлэлцүүлдэг журамтай.

10. Гомдол гаргагч Д.Б-гийн хяналтын журмаар гаргасан гомдлын бусад үндэслэл нь хуульд заасан шаардлага хангаагүй, эрүүгийн болон иргэний хэргийн маргааны үйл баримтыг дэлгэрэнгүй дурдаж гаргасан байх тул эдгээр хэсэгт хяналтын шатны шүүх дүгнэлт хийх шаардлагагүй гэж үзлээ.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.1, 127.2.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 221/ЁМ2019/0009 дүгээр магадлалыг хэвээр үлдээж, гомдол гаргагч Д.Б-гийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангахгүй орхисугай.

ТАНХИМЫН ТЭРГҮҮН

М.БАТСУУРЬ

ШҮҮГЧ

Х.БАТСҮРЭН